



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ФИЛОСОФИ, СОЦИОЛОГИ,  
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦ



ХАННС-ЗАЙДЕЛИЙН  
САН

# ҮНДСЭН ХУУЛИЙН МАРГААН

Улаанбаатар хот  
2012 он

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ФИЛОСОФИ, СОЦИОЛОГИ,  
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЦЭЦ



ХАННС-ЗАЙДЕЛИЙН  
САН

# ҮНДСЭН ХУУЛИЙН МАРГААН

*/Анхны хэвлэл/*

Улаанбаатар хот  
2012 он

DDC  
342.02  
A-516

---

---

## ҮНДСЭН ХУУЛИЙН МАРГААН

Зохиогч: Ж.Амарсанаа

Редактор: Л.Баасан  
Д.Наранчимэг  
Ц.Сарантуяа

Эрхлэн бэлтгэсэн: Р.Анар  
Д.Баянбилэг  
Э.Лхагвасүрэн  
Д.Нямбазар  
А.Түвшинтулга  
Ш.Хишигсүрэн

© Ж.Амарсанаа  
© ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн,  
Үндсэн хуулийн цэц, Ханнс-Зайделийн сан

ISBN: 978-99962-0-803-4

## **АГУУЛГА**

### **ӨМНӨХ ҮГ**

#### **1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1992.12.02 Дугаар 01**

“Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### **2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

##### **1993.01.13 Дугаар 01**

“Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### **3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1993.02.12 Дугаар 01**

Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйлийн заалт Үндсэн хуулийн заалтад харшилж байгааг хянан хэлэлцэх тухай

#### **4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

##### **1993.03.13 Дугаар 02**

Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### **5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1993.04.21 Дугаар 02**

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байгаа эсэхийг хянан хэлэлцэх тухай

#### **6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

##### **1993.05.26 Дугаар 03**

Үндсэн хуулийн цэцийн 2 дугаар дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай

#### **7. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1993.05.31 Дугаар 03**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны 52 дугаар зарлиг, мөн зарлигт өөрчлөлт оруулах тухай 5 дугаар сарын 1-ний 73 дугаар зарлигийн заалт Үндсэн хуулийн заалттай харшилж байгаа эсэхийг хянан хэлэлцсэн тухай

#### **8. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1993.12.22 Дугаар 04**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн тухай

#### **9. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

##### **1994.01.07 Дугаар 01**

Монгол Улсын Шүүхийн тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**10. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1994.02.04 Дугаар 01**

Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай

**11. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.01.12 Дугаар 02**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**12. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.01.12 Дугаар 03**

Улсын Их Хурлын гишүүн Т. Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

**13. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.02.23 Дугаар 04**

Улсын Их Хурлын гишүүн Э., Г., З. нар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

**14. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.04.15 Дугаар 05**

Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**15. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1994.11.09 Дугаар 02**

Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай харшилж байгаа эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**16. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.06.15 Дугаар 06**

Улсын Их Хурлын гишүүн З. Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай

**17. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.07.25 Дугаар 07**

Монгол Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн, Прокурорын байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**18. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.08.29 Дугаар 08**

Засгийн газрын 169 дүгээр тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**19. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1994.11.23 Дугаар 09**

Байнгын хорооны дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**20. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.01.04 Дугаар 01**

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай

**21. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1995.09.07 Дугаар 02**

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**22. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2008.01.24 Дугаар 01**

Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**23. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.01.18 Дугаар 02**

Цэцийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар

**24. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1995.05.10 Дугаар 01**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

**25. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.03.09 Дугаар 03**

Монгол Улсын Газрын тухай хууль болон Иргэний хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**26. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.07.03 Дугаар 04**

Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**27. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.08.02 Дугаар 05**

Цагдаагийн байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар

**28. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.09.04 Дугаар 06**

Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**29. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1995.12.07 Дугаар 07**

Монгол Улсын Засгийн газраас Айбекс групптэй 1993 оны 4 дүгээр сарын 17-нд байгуулсан Түншлэлийн гэрээ Үндсэн хууль зөрчсөнтэй холбогдуулан Ерөнхий сайд Ж.-г огцруулах эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**30. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.03.27 Дугаар 01**

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**31. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1996.05.15 Дугаар 01**

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

**32. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.04.10 Дугаар 02**

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар

**33. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.05.23 Дугаар 03**

Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай

**34. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1996.06.19 Дугаар 02**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

**35. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.05.29 Дугаар 04**

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**36. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.06.20 Дугаар 05**

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**37. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1996.09.11 Дугаар 04**

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**38. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.07.17 Дугаар 06**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

**39. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1996.09.07 Дугаар 03**

Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйл Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай

**40. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.09.04 Дугаар 07**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**41. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.10.30 Дугаар 08**

Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

**42. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.12.02 Дугаар 09**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**43. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1997.03.26 Дугаар 01**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**44. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1996.12.12 Дугаар 10**

Монгол Улсын Ерөнхий сайд Э. Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**45. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1997.03.29 Дугаар 02**

Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн зарим заалтыг зөрчсөн тухай

**46. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1997.02.05 Дугаар 01**

Монгол Улсын Их Хурлын дарга Г. Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**47. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1997.04.09 Дугаар 02**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**48. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1997.04.23 Дугаар 03**

Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1997 оны 3 дугаар тогтоол Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай

**49. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1997.06.21 Дугаар 04**

Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 дүгээр тогтоолын 1 дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг явуулсан байдал нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар

**50. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1997.12.17 Дугаар 03**

Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 дүгээр тогтоол, түүний анхны хэлэлцүүлгийн санал хураалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**51. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1997.06.25 Дугаар 05**



Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**52. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1997.07.05 Дугаар 06**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай

**53. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.01.28 Дугаар 01**

Банкны тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**54. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**  
**1998.06.17 Дугаар 01**

Банкны тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

**55. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.02.24 Дугаар 02**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай

**56. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.03.27 Дугаар 03**

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай

**57. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.04.27 Дугаар 04**

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн эсэх тухай

**58. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.05.06 Дугаар 05**

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай

**59. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.06.03 Дугаар 06**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн 1-ийг зөрчсөн эсэх тухай

**60. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**  
**1998.10.16 Дугаар 07**

Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**61. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1998.10.16 Дугаар 08**

Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэлсэн тухай

**62. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1998.10.23 Дугаар 09**

Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, түүнийг үндэслэн гарсан Улсын Их Хурлын тогтоолууд Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

**63. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**1998.11.24 Дугаар 02**

Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**64. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**1999.04.21 Дугаар 01**

Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**65. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2000.02.16 Дугаар 01**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

**66. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2000.03.13 Дугаар 02**

Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудын холбогдох заалтууд, эдгээрийг хэрэгжүүлэхээр гарсан Ерөнхийлөгчийн зарлигууд Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**67. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2000.09.08 Дугаар 01**

Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын үндэслэлийг хэлэлцэн иргэн М.-ийн өргөдлөөр үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**68. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2000.03.15 Дугаар 03**

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**69. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2000.11.29 Дугаар 02**

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**70. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2000.05.11 Дугаар 04**

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 176, 2000 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэхийг хянан хэлэлцсэн тухай

**71. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2001.03.23 Дугаар 01**

Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**72. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2001.12.20 Дугаар 02**

Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**73. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2002.04.03 Дугаар 01**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5, 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**74. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2002.06.05 Дугаар 01**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай

**75. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2002.04.10 Дугаар 02**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай

**76. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2002.06.06 Дугаар 02**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**77. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2002.06.26 Дугаар 03**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**78. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2002.11.13 Дугаар 03**

Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай

**79. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2002.11.27 Дугаар 04**

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**80. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

### **2003.02.19 Дугаар 01**

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж эцэслэн шийдвэрлэсэн тухай

### **81. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

2003.04.30 Дугаар 01

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын Байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **82. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

2003.06.20 Дугаар 02

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

### **83. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2003.05.21 Дугаар 02**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 2003 оны төсвийн тухай хууль, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоол, “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 5 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **84. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2003.10.29 Дугаар 03**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11, 45.7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **85. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

2004.04.21 Дугаар 01

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **86. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2004.06.07 Дугаар 02**

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **87. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2004.06.08 Дугаар 03**

Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### **88. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.03.14 Дугаар 01**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**89. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.03.31 Дугаар 02**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**90. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.04.13 Дугаар 03**

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль, Үндсэн хуулийн хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**91. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2009.05.27 Дугаар 02**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай

**92. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.06.17 Дугаар 04**

Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**93. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2005.12.14 Дугаар 02**

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**94. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.06.27 Дугаар 05**

Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**95. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.09.29 Дугаар 06**

Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**96. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2005.11.14 Дугаар 01**

Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**97. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.09.30 Дугаар 07**

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**98. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.11.16 Дугаар 08**

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн

холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**99. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2006.01.11 Дугаар 01**

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**100. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2005.12.07 Дугаар 09**

Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар хянан шийдвэрлэсэн тухай

**101. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.01.12 Дугаар 01**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**102. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.02.22 Дугаар 02**

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**103. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.03.29 Дугаар 03**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.4, 396 дугаар зүйлийн 396.3, 396.4, 396.5 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**104. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.04.12 Дугаар 04**

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**105. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2006.06.15 Дугаар 02**

Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**106. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.05.31 Дугаар 05**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**107. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.06.14 Дугаар 06**

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**108. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2006.07.05 Дугаар 03**

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн холбогдох зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**109. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.06.21 Дугаар 07**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**110. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.06.22 Дугаар 08**

Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**111. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2006.10.11 Дугаар 04**

Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

**112. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.09.20 Дугаар 09**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**113. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.12.06 Дугаар 10**

Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**114. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.12.13 Дугаар 11**

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**115. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.12.14 Дугаар 12**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**116. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2006.12.20 Дугаар 13**

Засгийн газрын “Журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**117. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол  
2007.03.17 Дугаар 01**

Засгийн газрын “Журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

**118. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.01.10 Дугаар 01**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**119. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.02.23 Дугаар 02**

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөг хуваарилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**120. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол  
2007.06.22 Дугаар 02**

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль батлахдаа 250.0 сая төгрөгийг Улсын Их Хурлын тойрог бүрт хуваарилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

**121. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.03.02 Дугаар 03**

Улсын Их Хурлын дарга Н. Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**122. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.04.18 Дугаар 04**

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**123. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.05.09 Дугаар 05**

Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**124. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.05.23 Дугаар 06**

Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**125. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.06.13 Дугаар 07**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**126. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт  
2007.06.20 Дугаар 08**



Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**127. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2007.12.13 Дугаар 03**

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**128. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2007.09.26 Дугаар 09**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**129. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2007.10.24 Дугаар 10**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**130. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2007.11.16 Дугаар 11**

Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**131. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2007.11.28 Дугаар 12**

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

**132. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2007.12.21 Дугаар 13**

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**133. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.02.15 Дугаар 01**

Улсын Их Хурал Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**134. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.02.20 Дугаар 02**

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай

**135. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.02.27 Дугаар 03**

Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

**136. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.02.29 Дугаар 04**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг

шийдвэрлэсэн тухай

**137. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2008.05.07 Дугаар 02**

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**138. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.04.16 Дугаар 05**

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай

**139. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.05.14 Дугаар 06**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

**140. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.10.10 Дугаар 07**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**141. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2008.11.19 Дугаар 03**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**142. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.10.29 Дугаар 08**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "... шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**143. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.11.05 Дугаар 09**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**144. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2008.12.17 Дугаар 10**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**145. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2009.06.10 Дугаар 03**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**146. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.03.11 Дугаар 02**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**147. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2009.05.20 Дугаар 01**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**148. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.04.15 Дугаар 03**

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**149. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.11.04 Дугаар 04**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**150. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2010.01.22 Дугаар 01**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**151. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.11.13 Дугаар 05**

Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**152. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.11.18 Дугаар 06**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**153. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2009.11.25 Дугаар 07**

Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**154. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.03.24 Дугаар 01**

Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**155. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.04.02 Дугаар 02**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**156. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2010.06.09 Дугаар 02**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**157. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.06.30 Дугаар 03**

Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**158. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.07.07 Дугаар 04**

Засгийн газрын 2009 оны 86 дугаар тогтоолын заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**159. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.10.27 Дугаар 05**

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**160. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.11.10 Дугаар 06**

Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**161. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2010.11.17 Дугаар 07**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**162. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2011.01.05 Дугаар 01**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**163. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2011.01.07 Дугаар 02**

Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**164. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2011.06.14 Дугаар 01**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**165. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2011.06.15 Дугаар 02**

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн зарим

заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**166. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2011.10.21 Дугаар 03**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**167. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2012.02.15 Дугаар 02**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**168. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2011.12.07 Дугаар 04**

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**169. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2012.02.08 Дугаар 01**

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

**170. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2011.12.27 Дугаар 05**

Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**171. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2012.01.25 Дугаар 01**

Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**172. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт**

**2012.03.28 Дугаар 02**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

**173. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол**

**2012.05.02 Дугаар 03**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

## ӨМНӨХ ҮГ

1. Монголын ардчилсан төрийн шүүх эрх мэдлийн шинэ байгууллага – Үндсэн хуулийн цэцийн хорин жилийн ойг тохион, түүхийн нэгэн зурвас үеийнх нь ажил үйлийг олонд толилуулах чин сэтгэлийн үүднээс эл номыг Танд өргөн барьж байна.

Та энэ номоос Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлттэй танилцах болно. Харин энэ удаа Үндсэн хуулийн цэцийн магадлал, Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолыг оруулаагүй болно.

Энэ номтой танилцаад та Үндсэн хуулийн цэцийн ажлын онцлог, хүрээ хязгаар, далайц, үйл ажиллагааны чиглэлийг олж харах боломжтой. Түүнчлэн иргэд төрөө жолоодох, хянахад оролцдог нэг чухал арга замыг олж мэднэ.

Би Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдийг туйлын үнэн гэж нотолж чадахгүй. Шинэ үзэгдэл, шилжилтийн үе, өсч хөгжихийн бэрхшээл зовлон, улс төрийн хийгээд эрх зүйн ухамсар, соёлын төвшний ялгаа, өөрчлөлт энд мэдрэгдэнэ.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт үндэслэн Та бас монголын өнөөгийн хууль тогтоох байгууллага, бусад эрх мэдэл бүхий субъектын үйл ажиллагааны цараа, чадавхи, алдаа оноо, ажлын арга барилыг ямар нэг хэмжээгээр дүгнэх боломжтой.

Энэ номонд би тогтоол, дүгнэлтийн эцэс болгонд “Тэмдэглэл” (Note) хийлээ. Энэ нь шүүмжлэл, онолын дүгнэлт ч юм уу, ямар нэгэн тодорхойлолт, санал биш юм.

Энэ бол ердөө л багшлах болон судалгаа, шинжилгээний ажлыг эрхэлдэг хүний хувьд шийдвэрийг уншаад төрсөн хувийн сэдэлтэй сэтгэгдэл төдий зүйл юм.

Тухайн шийдвэрийг тухлан уншихад Тань санаа оноогоо хуваалцаж байгаа, ийм ийм анхаарч ажиглах юм байна шүү гэж хэлж байгаа санаатай юм.

Оюутан, магистрант, докторант, судлаач, хуульчдад голлон зориулсан энэ номоос харахад Үндсэн хуулийн цэц хэрхэн дэвжин хөгжиж, урагшилж байгаа, нөгөө талаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг цаашид ямх ямхаар ч атугай төгөлдөршүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа юм байна гэдгийг Та анзаарах байх аа.

2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай Монгол Улсын хуульд (2006) хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамж болон бусад баримт бичиг, шүүх хуралдаан дээр хэлсэн үгийг зохиогчийн эрхээр үл хамгаалах бүтээл (8 дугаар зүйл) гэж заасан байна. Харин уг хуулийн 3 дугаар зүйлд өмнө нь бүтээгдсэн бүтээлд тулгуурлаж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, нягтруулах, орчуулах, хөрвүүлэх, хураангуйлах, эмхтгэх болон бусад хэлбэрээр өөрчилж, шинээр бий болгосон бүтээлийг үүсмэл бүтээл гэж тодорхойлжээ.

Бусадтай хамжилцан, хүч хавсран бэлтгэсэн энэ ном тэгэхээр үүсмэл бүтээлд хамаарагдаж байгаа юм. Тиймээс би энэ бүтээлийг эрхлэн гаргахдаа хуулийн дагуу нэрийнхээ өмнө нь Зохиогч гэдэг үгийг хэрэглэсэн болохыг уншигч авгай Та ойлгох биз ээ.

Энэхүү номонд 2012 оны 12 дугаар сарын 1-нээс өмнө Үндсэн хуулийн цэцээс гаргасан тогтоол, дүгнэлтийг оруулсан болно.

3. Үндсэн хуулийн цэц, Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, хамтран гаргасан энэ номыг бүтээхэд асар их хүч, хөдөлмөр, оюун ухаанаа зориулж, цаг заваа зарцуулсан Гавъяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Л.Баасан, дэд профессор Д.Наранчимэг болон Э.Лхагвасүрэн, Д.Нямбазар, Д.Баянбилэг, А.Түвшинтулга, П.Батзул, Р.Анар, Ш.Хишигсүрэн нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

***Хайртынхан Жүгнээ Амарсанаа***





## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1992.12.02 № 01

**“Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн<sup>1</sup> төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Засаг захиргааны яамны Засаг захиргааны удирдлага, зохицуулалтын тасгийн дарга М.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” 24 дүгээр тогтоол<sup>2</sup>

### **Үндсэн хуулийн<sup>3</sup> зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагыг дээрээс нь Улсын Их Хурал тогтоол гарган, Засгийн газар бодлого боловсруулан төвлөрсөн төлөвлөгөөт системийн үеийн захиргаадалтын аргаар байгуулж байгаа нь хөдөлмөрчдийн дургүйцлийг төрүүлж байна. Тухайлбал, орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг сумдад нь нэгтгэх талаар гарсан Улсын Их Хурлын тогтоол шинэ Үндсэн хуулийг бүдүүлгээр зөрчиж байна. Үнэн хэрэг дээрээ шинээр сум байгуулах, татан буулгаж өөр сумтай нэгтгэх асуудлыг хэлэлцэхээс татгалзсан атлаа 19 хот, хороодыг механикаар сумдад нь нэгтгэлээ. Миний хувьд жижиг, цөөхөн хүн амтай боловч сум нэртэй байсан нь нутаг дэвсгэрийн нэгж хэвээр үлдэж, Зүүнхараа, Тосонцэнгөл мэтийн 10 гаруй мянган хүн амтай нэгжүүд татан буугдсан явдал оновчтой сонголт болж чадсангүй гэж үзэж байна. Энэ асуудлыг гагцхүү дээрээс механикаар шийддэг, орон нутгийн хөдөлмөрчдийн саналыг тоодоггүй, газар нутгийн хилийн цэсийн маргаантай асуудлаас зайлсхийж амарчлан шийдсэн түр зуурын шинжтэй арга хэмжээ боллоо. Сэлэнгэ аймгийн Ерөө хороог Ерөө сумтай нэгтгэж, нэг сум болгохоор шийджээ. Гэтэл Ерөө хороо 4000 шахам хүнтэй, нийлж байгаа сум нь 2000 шахам хүнтэй байхад Ерөө хороог нэг баг, Ерөө сумыг 2 баг болгохоор Засгийн газар протокол гаргажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн

1 Хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн дунд, их суудлын хуралдаанд маргагч талыг төлөөлөн оролцох албан тушаалтныг томилсон шийдвэр нь “итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай” гэж байдаг ч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “...итгэмжилсэн төлөөлөгч...”, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “...итгэмжилсэн төлөөлөгчөө...” гэж заасан байдаг тул хойшид “итгэмжилсэн төлөөлөгч” гэсэн нэр томъёог энэ номонд ашиглав.

2 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 4-5-д нийтлэгдсэн

3 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 1-д нийтлэгдсэн

нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэсэн заалтыг Улсын Их Хурал тухайн нутгийн хурал, иргэдийн саналыг үндэслээгүйгээрээ зөрчиж байгаа юм биш үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг аймаг, нийслэл, сум, дүүрэг гэж заасан бөгөөд хот, хороо гэдэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж үгүй болсон. Засгийн газрын өргөн барьсан төсөл Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйл, Тавин наймдугаар зүйлийг зөрчсөн байсан ч Улсын Их Хурал энэ асуудлыг Үндсэн хуулийн дагуу шийдвэрлэх ёстой байв. Үүнд Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2-т заасныг баримтлан шийдвэрлэсэн. 7 сумыг Улсын Их Хурал бие даан байгуулах үндэслэл бүрдээгүй олон шалтгаан бий. Хамгийн гол нь хилийн цэсийг нь тэр үед тодорхойлох боломж байгаагүй. Нэгтгэсний дараа дээрх сумд асуудлаа хуулийн дагуу шийдвэрлэх боломж байгаа. Энэ тогтоолоор өөрийн нутаг дэвсгэрийн хилийн цэсгүй зөвхөн засаг захиргааны нэгж байсан хот, хороодыг сумдтай нэгтгэсэн учраас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн асуудлыг шийдвэрлээгүй юм.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 19 дүгээр зүйлийг баримтлан Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Их Хуралд ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолыг боловсруулах, батлах явцдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэсэн заалтын шаардлагыг хангаагүй байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөхдөө нэгэнт Үндсэн хуульд заасан урьдчилан судалж харгалзан үзэх, үндэслэл болгох шаардлагыг хангаагүй тул Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзлээ.

2. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг түүнийг хүлээн авсанаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1992 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 41 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцээд Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн гаргасан Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдолгүй гэж үзээд уг тогтоолыг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

## **Тэмдэглэл:**

Энэ дүгнэлт нь 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн шинэ Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан Үндсэн хуулийн цэцийн анхны шийдвэр юм.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх бүрэн эрх Улсын Их Хуралд хамаардаг боловч түүнийг тодорхой тооцоо, судалгааны үндсэн дээр эдийн засаг, хүн амын байршлыг харгалзан иргэдийн саналыг үндэслэн харгалзан хэрэгжүүлэхийг шаарддаг. Гэтэл Улсын Их Хурал 1992 оны 24 дүгээр тогтоолыг гаргахдаа орон нутгийн Хурал, иргэдийн саналыг аваагүй байна.

Үндсэн хуулийн цэцийн анхны шийдвэр болоод ч тэр үү энэхүү дүгнэлтэд “үндэслэх” хэсэг байдаггүйн зэрэгцээ Үндсэн хуулийн цэцийн хуралдаан, гишүүд зөвлөлдөх, дүгнэлт гаргах, дүгнэлтийг хэлбэржүүлэх гэх мэт Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эрх зүйн тодорхой зохицуулалтгүй байжээ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1993.01.13 № 01**

**“Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Б. ;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Б.-гийн тайлбарын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчиж гарсан Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолыг хүчинтэй хэвээр үлдээж Цэцийн хууль ёсны дүгнэлтийг хүлээж аваагүй явдалд сэтгэл дундуур байна. Үндсэн хуулийн Хавсралт хууль нь Үндсэн хуулийг засварлан хэрэглэх хууль биш баймаар юм. Тухайн нутгийн Хурал, иргэдийн санал авахгүйгээр Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөнийг Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг баримтлан шийдвэрлэсэн гэдгээр няцаах үндэсгүй юм. Үнэн хэрэг дээрээ Хавсралт хуулийг Үндсэн хуулиас дээгүүр тавьсан ажиллагаа гэж үзэхээс өөр аргагүй байна. Миний ойлгосноор Хавсралт хууль нь тодорхой үе шатанд хэрэгжээд шууд хүчингүй болох ёстой хууль юм. Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “өөрчлөх” гэдэгт “нэгтгэн харьяалуулах” гэсэн ойлголт багтах учраас Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн нь маргаангүй. Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалтууд одоо хүртэл биелэгдэхгүй байгааг анхааралдаа авах нь зүйтэй байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Цэцийн энэхүү хуралдаан нь маргааныг эцэслэн шийдвэрлэх их хариуцлагатай юм. Урьдах хуралдаанд оролцож тайлбараа тодорхой ярьсан учраас дараах асуудлыг тайлбарын чанартайгаар хэлье. Улсын Их Хурлын 1992 оны 41 дүгээр тогтоол нь зөвхөн Хавсралт хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэсэн бөгөөд Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийг хамаарч байгаа юм. Ийм ч учраас 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтад хамаарагдахгүй юм. Энэ тогтоол нь “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль” гарах хүртэл авч хэрэгжүүлсэн түр арга хэмжээ гэж ойлгож байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдолгүй” гэсэн 41 дүгээр тогтоолын заалт 24 дүгээр тогтоолтой шууд зөрчилдөж байна. Учир нь 24 дүгээр тогтоолыг Улсын Их Хурал гаргахдаа Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийг бүхэлд нь үндэслэжээ. Орон нутгийн харьяалалтай хот, хороодыг зохих суманд нь нэгтгэн харьяалуулах асуудлыг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн бүх заалтын дагуу хийх ёстой. Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийг үндэслэн гэдэг нь түүний доторхи хэсгүүд, тухайлбал 3 дахь хэсгийг үндэс болгожээ гэдэг нь ойлгомжтой юм. Ийм учраас “Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолын заалт нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалттай холбогдолгүй” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

2. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэхэд Хурал, захиргааны байнгын хороо болон Улсын Их Хурлын гишүүн Б. нараас оруулж хэлэлцүүлсэн дүгнэлт, зарим гишүүдийн хэлсэн үг, саналд: “орон нутгийн харьяалалтай хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулсан нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль гаргах хүртэл авсан түр зуурын чанартай арга хэмжээ бөгөөд Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэ асуудлыг 1992 онд багтаан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг биелүүлсэн учир Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзжээ. Үндсэн хуулийн Хавсралт хууль нь Үндсэн хуультай адил хүчин чадалтай боловч Үндсэн хууль биш. Үүнийг “БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай” Үндсэн хуулийн Хавсралт хууль гэсэн нэр нь баталж байна. Иймд Хавсралт хууль нь хуучин Үндсэн хуулиас шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдөх шилжилтийн үед Монгол Улсын Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцыг тодорхойлсон хууль мөн. Хавсралт хууль шилжилтийн үед хэрэгжээд төрийн шинэ тогтолцоо бүрнээ бүрдсэн үед түүхэн үүргээ гүйцэтгэсэнд тооцогдоно. Учир иймээс Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу уг асуудлыг хийж гүйцэтгэхээр заасан тул Үндсэн хуулийн Тавиндолдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зайлшгүй баримтлах хуулийн шаардлага гарч ирж байгаа юм.

Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн харьяалалтай хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хороог зохих аймаг, суманд нэгтгэн харьяалуулах” гэдэг нь заавал тухайн суманд нь ямар ч тохиолдолд шууд нэгтгэх гэсэн ойлголт биш байна. Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зүйл бүрт “Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу” гэж хуульчилснаас үзэхэд Хавсралт хууль нь Үндсэн хуулийн заалт, шаардлагын дагуу хэрэгжих ёстой нь тодорхой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.-гээс гаргасан тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт, шаардлагыг биелүүлээгүй зөрчсөн нь

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны хэлэлцүүлэг, хавтаст материалд авагдсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй батлагдаж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний 24 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтын 3 дахь хэсгийг хэвээр үлдээж, бусад заалтыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 24 дүгээр тогтоолыг хүчинтэй хэвээр үлдээсэн Улсын Их Хурлын 1992 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурал дээрх тогтоолыг гаргахдаа Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг байгуулах, зарим аймгийн нутаг дэвсгэрт байгаа орон нутгийн харьяалалтай хот, өөр сумын нутаг дэвсгэрт байгаа хороо, районыг зохих аймаг, суманд нэгтгэн харьяалуулах, нийслэлийн районуудыг татан буулгаж, дүүрэг, хороо, хөдөөд баг байгуулах ажлыг 1992 онд багтаан тус тус хийж гүйцэтгэнэ” гэснийг үндэслэсэн гэж тайлбарладаг. Гэвч Үндсэн хуулийн Хавсралт хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийг зөрчсөн агуулгатай болжээ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1993.02.12 № 01**

**Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйлийн заалт Үндсэн хуулийн заалтад харшилж байгааг хянан хэлэлцэх тухай**

#### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргагч - Монгол Улсын Ерөнхийлөгч О., түүний итгэмжилсэн төлөөлөгч Ерөнхийлөгчийн зөвлөх Ц.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 1992 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Татварын ерөнхий хууль<sup>4</sup>

<sup>4</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 4-5-д нийтлэгдсэн

- 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно”

- 13 дугаар зүйл “1.Татварын хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татвар төлөгчид дараах хариуцлага хүлээлгэнэ:

1/ татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлоготой тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

2/ орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу түүний тоо, хэмжээг санаатайгаар бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

3/ татвар ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, саатуулсан хоног тутам нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувийн хүү ногдуулах. Хүүгийн хэмжээ нь төлбөл зохих татварын 50 хувиас хэтэрч болохгүй;

4/ татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнгээс бодож хоног тутам 0.3 хувийн хүү ногдуулах”

- 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засгийн газар энэ хуулийн 16 дугаар зүйлийн 14-19-д заасан татварын хувь, хэмжээг тогтоож болно”

- 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Татварын байцаагч бие хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно”

2. Улсын Их Хурлаас 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын тухай хууль<sup>5</sup>

- 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө”

#### **Үндсэн хуулийн<sup>6</sup> зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”

- Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт “хуулиар ногдуулсан албан татвар төлөх”

- Хорьдугаар зүйл “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”

- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад манай улсын иргэд “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” үүрэгтэй гэж заасан билээ. Эдгээр заалт нь нэг талаар Монгол Улсын төрийн тогтолцоо, иргэдийн үүргийг тодорхойлсон заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээ, нөгөө талаар манай иргэд хуулиар ногдуулаагүй элдэв алба гувчуур төлөхгүй байх эрхийн нэг чухал баталгаа юм. Гэтэл Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хууль ёсоор хууль, түүний дотор татварын хуулиудын биелэлтийг зохион байгуулж хангах үүрэг хүлээсэн Засгийн газарт татварын хувь, хэмжээг тогтоох

5 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 1-т нийтлэгдсэн

6 Төрийн мэдээлэл эмхэтгэл, сэтгүүл, 1992 оны № 1-д нийтлэгдсэн

буюу Улсын Их Хурлаас тогтоосон албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчлөх эрх олгохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтуудад харшилж байна. Иймд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон Монгол Улсын Үндсэн хуулийн цэц уг асуудлыг авч хэлэлцэж дүгнэлт гаргахыг хүсье.

## 2. Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Ц.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулиа дээдэлж, иргэдийн эрхийн баталгааг хангах үүднээс Улсын Их Хурлаас баталсан Татварын багц хуулийн зарим заалтад бүрэн эрхийнхээ дагуу хориг тавьсныг хүлээн аваагүй тул дараах асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандсан юм. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн заалтад харшилж байгаа явдал юм. Энэ талаархи тайлбар, үндэслэлийг Цэцэд бичгээр дэлгэрэнгүй гаргасан учраас дараах товч тайлбарыг өгье. Юуны өмнө татвар, албан татвар хоёр үндсэндээ нэг ойлголт бөгөөд үүнд ихээхэн маргаан бий. Татварын тогтолцоонд албан татвар, хураамж, төлбөрийг ач холбогдлоор нь нэг түвшинд оруулан тогтоож, татварын хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг ижил тогтоосон нь буруу байна. Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар энэ хуулийн 16 дугаар зүйлийн 14-19-д заасан татварын хувь, хэмжээг тогтоож болно” гэж Засгийн газарт хууль тогтоох эрх олгож байгаа нь Улсын Их Хурал Үндсэн хуулиар өөрт нь хадгалуулсан хууль батлах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхээ Засгийн газарт шилжүүлсэн нь Үндсэн хуулийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгалуулна”, “Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэсэн заалтуудад шууд харшилж байна. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар татварын хувь, хэмжээг тогтоох, Улсын Их Хурлаас баталсан хуулийн заалтыг өөрчлөхөөр заасан нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудлыг шилжүүлсэн төдийгүй энэ нь хуульд өөрчлөлт оруулж байгаа асуудал учраас Улсын Их Хурлын бүрэн эрхэд шууд хамаарагдах ёстой. Засгийн газар нь хууль тогтоох биш, харин Улсын Их Хурлын баталсан хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үүрэгтэй. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн тухайд албан татвар ногдох жилийн орлогын хэмжээг Засгийн газар өөрчилснөөр албан татварын хувь, хэмжээ өөрчлөгдөх учир энэ нь хуулиар зохицуулагдах ёстой.

Улсын Их Хурал хууль тогтоох, өөрчлөх, хүчингүй болгох онцгой эрх мэдлийн асуудлыг гүйцэтгэх байгууллагад шилжүүлж болохгүй. Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомж гэдэг ойлголтод Засгийн газрын шийдвэр ордоггүй юм. Иймд Үндсэн хуулийн цэц Ерөнхийлөгчийн хүсэлтийг хүлээн авч зохих шийдвэр гаргаж өгнө гэдэгт найдаж байна. Үүнээс гадна Татварын багц хуульд Үндсэн хуульд харшлах хэд хэдэн заалт байгааг Цэц анхааралдаа авахыг хүсье. Тухайлбал: хууль тогтоох техник зөрчигдсөн буюу Татварын хууль гэж нэрлэсэн мөртлөө “албан татвар, төлбөр хураамж” гэж нэрлээд цаашид “татвар гэнэ” гэж тодотгосон, Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд ерөнхий хариуцлага заасан нь тохирохгүй байгаа, мөн хуулийн 17 дугаар зүйлд байгальтай харьцсаны хураамж төлөх гэсэн нь ойлгомжгүй, түүнчлэн 28 дугаар зүйлд татварын байцаагч бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх, түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар тогтооно гэснийг хянаж үзнэ үү.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Татварын тоо цөөн байхад түүний хувь хэмээг парламентаас тогтоож болдог. Харин зах зээлийн нөхцөлд татварын тоо олширч түүний заримынх нь хувь хэмээг Засгийн газар тогтоох нь дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага болж байна. Зарим хураамж, төлбөрийн хувь, хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт өгсөн нь олон улсын хандлага, жишгийг харгалзсан, гүйцэтгэх засаглал өргөн эрх мэдэлтэй ажилладаг

бөгөөд үйл ажиллагаа нь илүү шуурхай байдагт оршино. Монгол Улсын Үндсэн хуульд хуулиар ногдуулсан албан татварыг иргэд төлөх үүрэгтэй гэж заасан учраас Татварын багц хуульд албан татварын хувь, хэмжээг тогтоох, өөрчлөх, хүчингүй болгох эрх мэдэл зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдаж байгаа учраас Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн заалттай харшлахгүй гэж үзэж байна. Ийм ч учраас зарим төрлийн хураамж, төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож байхаар зааж тодорхойлсон. Нөгөө талаар Улсын Их Хурлын онцгой эрх мэдлийн асуудалд зөвхөн албан татвар хамаарах учир Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйл зөрчигдөөгүй гэж үзнэ. Албан татвар, хураамж, төлбөр нь эдийн засгийн агуулгын хувьд өөр өөрийн онцлогтой боловч эрх зүйн хэм хэмжээний хувьд нийтлэг зарчимтай, нэг хуулиар зохицуулагдаж боломжтой юм. Энэхүү онцлог шинжүүдийг тус тусын хуульд нарийвчлан тусгах бөгөөд хууль тогтоомжийн дагуу хувь, хэмжээг нь Засгийн газар, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтооно гэж заасан байгаа.

Татварын тогтолцоог Улсын Их Хурлаар хэлэлцэхэд концепцын зөрүү байсан боловч татвар гэдэг ерөнхий ойлголтод албан татвар, хураамж, төлбөр багтана гэдгийг Улсын Их Хурал эрхийнхээ дагуу шийдвэрлэсэн. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтын тухайд бол Засгийн газар албан татварын хувь, хэмжээг биш зөвхөн албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг үнийн өсөлтийн түвшинг харгалзан өөрчилж байх заалт юм. Энэ нь татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалсан заалт бөгөөд Улсын Их Хурлаас тогтоосон албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ өөрчлөгдөхгүй юм. Ийм учраас энэ нь Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдох жилийн орлогын хэмжээг өөрчилж байгаа гэсэн ойлголт биш харин инфляцийн түвшинг тогтоож үүгээр татвар төлөгчийг болзошгүй татварын дарамтаас хамгаалж байгаа гэж ойлгох нь зүйтэй юм. Дээрх тайлбараа үндэс болгож татварын багц хуулиудын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуульд харшилсан гэдэг Ерөнхийлөгчийн хүсэлтийг няцааж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дунд суудлын хуралдаанаараа хянан үзээд “Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд татварын тогтолцоо албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ” гэж заагаад тэдгээрийн тодорхойлолтыг өгчээ. Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Татварыг Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно” гэж заасанд албан татвар, хураамж, төлбөр бүгд хамаарагдах ёстой болж байна. Татвар гэдэгт түүний элементүүд, тухайлбал татварын хувь, хэмжээ хамрагдаж байж цогц ойлголт болно гэдгийг маргагч талууд санал нэгтэй нотолсон. Гэтэл 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно” гэж заасан нь 1 дэх хэсгийнхээ заалттай шууд зөрчилдөж байна. Нөгөө талаар татварын төрөл тус бүрээр хууль гаргаж, түүний хувь, хэмжээг тогтоож өгөөгүй, тогтоож болох хэмжээ, хязгаарыг заагаагүй байж “хууль тогтоомжийн дагуу” гэдэг нь ач холбогдолгүй заалт болжээ. Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд нэрлэж заасан төлбөр, хураамжийн хувь, хэмжээг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болох боловч мөн л Улсын Их Хурлаас хуульчлан тогтоосон хүрээ, хязгаарын дотор хувь, хэмжээ тогтоох нь мэдээж. Ийнхүү Улсын Их Хурал нь хууль тогтоох, хууль батлах онцгой эрх мэдлээ Засгийн газарт шилжүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчжээ. Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтад үндэслэсэн, түүнчлэн хувь, хэмжээг нь Улсын Их Хурлаас тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд тогтоох ёстой учраас Үндсэн хуулийн дээрх заалтуудыг нэгэн адил зөрчсөн гэж үзэх бүрэн үндэстэй юм.



Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө” гэж заасан нь үнийн өсөлт /инфляц/-ийн үед татвар төлөгчийг татварын дарамтаас хамгаалах чухал заалт мөн. Энэ нь үнийн өсөлтийн түвшинг Засгийн газар тогтооно гэсэнтэй санаа ижил гэж ойлгогдохоосоо мөн зүйлийн 1 дэх хэсэгт хуульчлан баталсан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчлөх тухай шууд утгыг илэрхийлж байна. Энэ нь нэг талаар Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал өөрийн онц бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх тухай Үндсэн хуулийн заалтад харшилж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Ц. иргэний хувьд Үндсэн хуулийн цэцэд хандаж хянаж өгөхийг хүссэн дараах асуудал, тухайлбал татварын хуулийг боловсруулахдаа хууль тогтоох техник зөрчигдсөн, Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд албан татвар, хураамж, төлбөрт адилхан хариуцлага тогтоосон, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж авах зэрэг нь Үндсэн хуульд харшилж байна гэж үзэх үндэслэлгүй байна. Харин Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан: “татварын байцаагч бие хамгаалах тусгай хэрэгслэлийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно” гэж заасан нь хуульд заасан үндэслэл журмаас гадуур хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглох тухай Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна. Бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг гагцхүү хуулиар тогтоох зайлшгүй шаардлагатай учраас Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас дараах ДҮГНЭЛТИЙГ ГАРГАВ:

1. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, “Улсын Их Хурал... хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэж заасан Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь “Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх”, “Улсын Их Хурал, ...хуульд өөрчлөлт оруулах... асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэсэн Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Татварын байцаагчийн бие хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн байна гэж үзэв.

4. Татварын хуулийг боловсруулахдаа хууль тогтоох техник зөрчсөн, мөн хуулийн 13 дугаар зүйлд албан татвар, хураамж, төлбөрт адилхан хариуцлага тогтоосон, 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж авах гэсэн нь ойлгомжгүй учраас Үндсэн хуульд харшилж байна гэж Ц. -гээс иргэний хувьд гаргасан асуудлыг Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ дагуу шийдвэрлэсэн учраас Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгов.

**“Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1993 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйл, заалт нь Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” үүргийг ёсчлон биелүүлнэ, мөн Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад Улсын Их Хурлын бүрэн эрхэд “... , албан татвар, ...-ын үндсэн чиглэлийг тодорхойлж...” хэмээн заасан байна. Харин Улсын Их Хурлаас 1992 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн (хүчингүй болсон) 3 дугаар зүйлд “Монгол Улсын үндэсний татварын тогтолцоо албан татвар, хураамж, төлбөр /цаашид “татвар” гэх/-өөс бүрдэнэ.”<sup>7</sup> гэж томъёолсон байна. Үндсэн хууль болон Татварын ерөнхий хуулийг хамтатган дүгнэвэл “албан татвар”-ыг Улсын Их Хурал буюу зөвхөн хуулиар, харин “хураамж”, “төлбөр”-ийг хуулиар эрх олгосны дагуу бусад субъект (Засгийн газар, холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурал) тогтоож болохоор ойлгогдож байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй буюу 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.3.9-7.3.12-т заасан татварын хувь, хэмжээг Засгийн газар тогтооно” гэж заасан байдаг.

2. Бие хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг хуулиар тогтоох шаардлагатай. Хуулиар тогтоохын үндэслэл нь:

а. Бие хамгаалах, тусгай хэрэгсэл бол бусдын эрх, эрх чөлөөнд халдах хэрэгсэл юм. Ийм хэрэгсэл хэрэглэх асуудал төрийн бодлогоор нэгдмэл шаардлага, зарчмаар хэрэгжих ёстой.

б. Бие хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэх нэгдсэн журмыг хуулиар тогтоохгүй бол хэн нэгэн эрх мэдэлтэн журам гаргах, тэр хэмжээгээр бусдын эрх, эрх чөлөө хязгаарлагдах талтай.

Одоо Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” /Гаалийн улсын байцаагчийн тусгай хэрэгсэл, түүнийг хэрэглэх, хадгалах заавар/ 573 дугаар тушаал, Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн “Шүүгч бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам батлах тухай” 12 дугаар тогтоол гэх мэт олон журам хүчин төгөлдөр үйлчилж байна.

3. Аливаа шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ урьдчилан ямарваа нэгэн шийдвэр гаргах ёсгүй, харин хуралдааны явцад цугларсан баримт нотолгоо, дотоод итгэл үнэмшилдээ тулгуурлан шийдвэр гаргадаг. Хэрэв анхааралтай уншвал Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлт “Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим зүйлийн заалт Үндсэн хуулийн заалтад харшилж байгааг хянан хэлэлцэх тухай” гэсэн нэртэй. Уг нь бол “... харшилж байгаа эсэхийг..” гэж байх учиртай.

<sup>7</sup> Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Татварын ерөнхий хуулийн (2008.5.20) 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөр /цаашид “татвар” гэх/-өөс бүрдэнэ” гэж заасан байдаг.

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1993.03.13 № 02

### Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын хуулийн зарим заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Хүсэлт гаргагч - Монгол Улсын Ерөнхийлөгч О., түүний итгэмжилсэн төлөөлөгч Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Т., шадар туслах Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Н.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Ц.-гийн тайлбарын агуулга:

Бид хүмүүнлэг нийгэм байгуулах, Үндсэн хуулиа дээдлэн сахих тухай ярьж байгаа. Хуучин бол гүйцэтгэх засаглалд түүгээр ч барахгүй нэг намд хамаг эрх мэдэл төвлөрч, бүх юмыг боймолж байсан. Одоо бол өөр. Аливаа хууль Үндсэн хуульд бүрэн нийцэж байх ёстой. Үүнийг үндэслэн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үнэхээр зөрчиж байгаа юм. Үндсэн хуулиар бол хууль тогтоох цорын ганц байгууллага бол Улсын Их Хурал байгаа. Иргэд зөвхөн хуулиар ногдуулсан албан татварыг л төлөх ёстой. Үүнээс үүдээд Засгийн газрын тогтоосон, өөрөөр хэлбэл хуулиар ногдуулаагүй татварыг төлөхгүй байх эрхтэй байж болно. Засгийн газар татварын хувь, хэмжээ тогтоосон тохиолдолд шүүгч хуулийг хэрэглэх биш тогтоолыг хэрэглэхээр болох юм.

Нөгөө талаар Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улс бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс гэдгийг анхаарах ёстой. Үүнээс үндэслээд манай улс татварын нэг нэгдсэн бодлоготой байх ёстой гэдгийг сайн бодолцох хэрэгтэй юм. Үүнийг харгалзан үзэхгүй бол цаашдаа Монгол Улсын төрийн хүчийг сулруулах алсын үр уршиг, аюултай байж болзошгүй гэсэн эмзэглэл бидэнд байгаа. Засгийн газар татварын хувь, хэмжээ тогтоох тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхгүй болчих тал гарч бас болно. Одоо би Ц.-гийн итгэмжилсний дагуу Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар байр сууриа хэлье. Энэ заалтын баталгааны ач холбогдолтойг үгүйсгэхгүй. Гэхдээ хүний эрх чөлөөнд халдаж байгаа хэрэг даруй мөн болдог. Иймээс бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг заавал хуулиар тогтоох ёстой гэж үзэж байна. Тэгэхгүй бол манай улсын нэгдэж орсон иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 9 дүгээр зүйлийн заалттай давхар харшилна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн заалтад харшилж байгаа эсэхийг шийдэх эцсийн шатанд бид ирээд байна. Бид Д.-гийн илэрхийлсэн байр суурийг дэмжсэн хэвээр байгаа. Энд нэг зүйлийг бид сайн ойлгох ёстой гэж бодож байна. “эрх олгосноор”, “хууль тогтоомжийн дагуу” гэсэн хоёр зүйлийг ойлговол эрх шилжүүлээгүй гэдэг нь ойлгогдох ёстой юм. 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ингээд шийдвэл практик талаас нь авч үзвэл Улсын Их Хурал аахар шаахар зүйлийг хийх болох юм.

Нөгөө талаар төвлөрөл ихдэж ёстой хуучинсаг байдал тогтоно. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг аваад хаячихаж болно. Үүнээс ард түмэн л хохирно. Бид бол ийм хохирол гаргуулахгүй байх зорилготой. Ер нь би асуудлыг Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7 дахь хэсгээр шийдэж өгөөч гэж хүсч байгаа юм. Бид хайгуул хиймээр байна. Жишээлбэл, яагаад Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 3 дахь хэсгийг хэрэглэж болдоггүй юм бэ гэх мэт. Үндсэн хуулийг зөрчөөгүй гэсэн байр сууриа дахин илэрхийлж байна. Цэцийн түрүүчийн хуралдаан дээр хүрсэн түвшингээс цааш явах саналтай байна.

3. Үндсэн хуулийн цэцээс томилсон шинжээчийн дүгнэлтийн агуулга:

Шинжээчдийн нэгдүгээр хэсгийг Шинжлэх ухааны академийн ЭЗХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, эдийн засгийн ухааны доктор П., Монгол Улсын Их Сургуулийн ЭЗСЭШХ-ийн санхүүгийн тэнхмийн эрхлэгч, эдийн засгийн ухааны дэд доктор Н. нарын бүрэлдэхүүнтэй байгуулж дор дурдсан эдийн засгийн асуултуудыг тавьж хариулт гаргуулав. Үүнд:

а. Үндсэн хуульд заасан “албан татвар” гэсэн ухагдахууныг “хураамж”, “төлбөр” гэсэн ухагдахуунтай нэгтгэж адилтгасан нь эдийн засгийн агуулга, арга зүйн хувьд зөв үү?

Хариулт: Албан татвар нь хураамж, төлбөрөөс зарчмын хэд хэдэн ялгаатай. Нэгд, өмчтөний орлогын тодорхой хэсгийг төрийн /нийгмийн/ хэрэгцээнд албан журмаар дайчлах утга санааг албан татвар илэрхийлдэг бол хураамж, төлбөр нь үйлчилгээний үнэ, хөлсний шинжтэй байна. Хоёрт, албан татвар нь өсөн нэмэгдэх, шууд хамааралтай, буурах шинжтэй бөгөөд энэ нь албан татварын хувь, хэмжээгээр тодорхойлогддог бол хураамж, төлбөрт ийм шинж байдаггүй. Гуравт, албан татвар ногдуулах хувь, хэмжээг тогтоох эрхийг төр эдэлдэг /буюу төр дангаар шийдвэрлэдэг/ бол хураамж, төлбөрийн хэмжээ нь үйлчилгээ, ашиглалтын хэмжээ, тухайн үеийн зах зээлийн үнэнд тулгуурлаж тогтоогддог. Дөрөвт, албан татвар бол эдийн засгийн зохицуулалтын үндсэн хэрэгсэл юм. Нийт эдийн засагт учирсан хүндрэл бэрхшээл, онцлог нөхцөл байдлаас шалтгаалан албан татварын концепцийг боловсруулж, түүнд тулгуурлан албан татварын тогтолцоог бүрдүүлдэг. Харин хураамж, төлбөр, нийт эдийн засгийн зохицуулалтын хэрэгсэл болдоггүй. Тавд, албан татвар нь хүн амын орлогыг жигдрүүлэх хэрэгсэл болдог бол хураамж, төлбөрт ийм зориулалт байдаггүй. Зургаад, албан татвар ба хураамж, төлбөрийн зорилго, үндэслэл, хэрэгжүүлэх болон хяналт тавих арга хэлбэр, хүлээх хариуцлага ч өөр байна. Энэ бүхнээс үзэхэд албан татварыг хураамж, төлбөртэй адилтгах нь эдийн засгийн агуулга, арга зүйн хувьд буруу юм.

б. Эдийн засгийн онолын үүднээс авч үзвэл албан татвар, хураамж, төлбөрийг бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох гэдэгт тэдгээрийн хувь, хэмжээ багтаж, үндсэн элемент нь болдог уу?

Хариулт: Албан татвар, хураамж, төлбөрийн аль алины хувьд тэдгээрийг төлөгч буюу субъект, татвар оногдуулах зүйл буюу объект, албан татвар, хураамж, төлбөрийн хувь, хэмжээ нь үндсэн элемент болно. Албан татварыг шинээр бий болгох, өөрчлөх, хүчингүй болгоход түүний хувь, хэмжээ нь уг албан татварын шинж чанарыг тодорхойлдог учраас түүний цөм болсон асуудал юм.

в. Үнэ өсөж, мөнгөний ханш буурахад хүн амаас хураах татвар өөрчлөгдөж байх ёстой юу?

Хариулт: Үнийн өсөлт, мөнгөний ханшны жолоодлогогүй бууралтыг харгалзан хүн амын орлогоос хураах албан татварын бодлого өөрчлөгдөж, орлогын зэрэглэл, хувийг өөрчлөх шаардлага гарч болох юм.

г. Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө” гэсэн заалт эдийн засаг, эрх зүйн хувьд зөв үү?

Хариулт: Албан татвар ногдуулах орлогын хэмжээ, шатлал ба албан татварын хувийг гагцхүү Улсын Их Хурал өөрчлөх эрхтэй. Учир нь гэвэл албан татвар ногдуулах орлого ба хувь нь эдийн засаг, нийгмийг удирдаж, зохицуулах бодлого, механизмын чанартай тулгуур том асуудал. Ард түмний аж байдалд ч шийдвэрлэх ач холбогдолтой. Энэ байр сууринаас авч үзвэл, татвар ногдуулах орлого, хувийг өөрчлөх, зохицуулах эрхийг гүйцэтгэгч байгууллагад /Засгийн газарт/ эдлүүлэх нь утгагүй хэрэг. Хэрэв энэ эрхийг Засгийн газарт шилжүүлбэл зардлаа хорогдуулахын оронд албан татварыг нэмэгдүүлж, үйлдвэрлэгчдийг хохироож, ачааллын хүндийг хүн амын нуруунд тохоход хүргэж болзошгүй юм.

Шинжээчдийн хоёрдугаар хэсгийг Цагдаагийн дээд сургуулийн ахлах багш, хууль зүйн ухааны доктор Ж., ТНСА-ийн эрдэм шинжилгээний ажилтан О., Улсын ерөнхий прокурорын туслах Б. нарын бүрэлдэхүүнтэй байгуулж хууль зүйн чанартай 3 асуулт тавьж хариу авсан. Үүнд:

а. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бие хамгаалах тусгай хэрэгсэл гэдэгт юу багтах вэ?

Хариулт: Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай хуулийн 3 дугаар зүйл, энэ зүйлийн хэм хэмжээг хэрэглэх тухай Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Цагдаагийн ерөнхий газрын даргын 1990 оны А/8 дугаар тушаал, энэ тушаал, зааварт өөрчлөлт, нэмэлт оруулсан 1991 оны б/76 дугаар тушаалд бие хамгаалах тусгай хэрэгсэлд дараах зүйлийг хамааруулжээ. Үүнд:

а/ гар, хөл, хурууны гав;

б/ хүлэг;

в/ ороох цамц /номхотгох цамц/;

г/ хаймран бороохой;

д/ ВСЛ-888, ЖА-90, 306, 6804, ГАК-1, ДИГ-1, 2, ВК-763 маркийн хүний биед цочрол үүсгэх үйлчилгээтэй цахилгаан бороохойнууд;

е/ КО-5001, Оригинал Т-1000 маркийн нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулах, амьсгал боогдуулах үйлчилгээтэй шүршигч;

ё/ олон хүнд нөлөөлөн нулимс асгаруулах, амьсгал боогдуулах хийн цэнэгтэй гар буу;

ж/ авто тээврийн хэрэгслийг албадан зогсоох төхөөрөмж;

з/ усан хөөрөг зэрэг болно.

Оросын Холбооны Улс болон бусад орнуудад утаан хөшиг /манан/ үүсгэгч бие хамгаалах тусгай хэрэгслийн тоонд ордог. Эдгээрийг цагдаагийн ажилтан гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийг таслан зогсоох, гэмт буруутай этгээдийн халдлага, довтолгооноос өөрийн болон иргэдийн амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, түүнийг дайчлан баривчлах, цагдаагийн байгууллагад албадан хүргэхийн тулд хэрэглэж байна.

б. Тэдгээрийг ямар үед хэрэглэх вэ?

Хариулт: Татварын байцаагч нь түүнийг албан үүрэгтэй нь холбогдуулан эсвэл үүргээ гүйцэтгэж байх үед нь идэвхтэй эсэргүүцэл үзүүлсэн, амь бие, эрүүл мэндэд нь халдахаар завдсан, бодит халдлага хийсэн нь халдагчийн үйл хөдөлгөөн, үг хэллэгээр батлагдаж байвал сая бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэж болно. Татварын байцаагч нь гүйцэтгэж байгаа үүргийн онцлогоос шалтгаалж зөвхөн өөрийгөө хамгаалах зорилгоор нэг хүнд нөлөөлөх нулимс асгаруулах, амьсгал боогдуулах хийн цэнэгтэй гар буу хэрэглэж болно.

в. Төрийн төлөөлөгчийн бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг прокурорын зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэх байгууллага тогтоож болох эсэх?

Хариулт: Бие хамгаалах тусгай хэрэгслийн төрөл, түүнийг хэрэглэх журмыг гүйцэтгэх байгууллага тогтоож Улсын ерөнхий прокурор зөвшөөрөл өгөх хэлбэрээр хянаж ирсэн нь “Бүх яам, албан газар, олон нийтийн болон хоршооллын байгууллага, албан тушаалтан, иргэдээс хуулийг хэрхэн биелүүлж байгаад дээд хяналтыг Улсын прокурор гүйцэтгэнэ” гэсэн хуулийн 72 дугаар зүйлийн заалт, түүнчлэн 1976 онд батлагдсан Прокурорын хяналтын хуулийн 15 дугаар зүйлийн “а” хэсэгт заасан хэм хэмжээг хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой.

Улсын прокурорын зөвшөөрснөөр Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайд /одоогийн Цагдаагийн ерөнхий газрын дарга/ бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг баталж ирсэн нь Цагдан сэргийлэх байгууллагын 1985 онд батлагдсан дүрмийн 19 дүгээр зүйлийн “номхотгох тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр батална” гэсэн заалтаас урган гарч байна. 1990 онд батлагдсан Цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэх баталгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд дээрх журмыг дахин хуульчлан баталгаажуулжээ. Дээр дурдсан хуулийн заалт нь бие хамгаалах тусгай хэрэгслийг Монгол Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр гүйцэтгэх төв байгууллагын дарга батлах замаар хүний эрхийг хязгаарлахад чиглэгдсэн эрхийн акт гаргах нөхцөл бүрдүүлж, хууль тогтоогчийн эрх эдлэхэд хүргэж байсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-д “хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэг хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн хүний эрхийн халдашгүй байдлыг хангах тухай хэм хэмжээтэй илт зөрчилдөж байна гэж үзэж байна. Төрийн төлөөлөгч албан үүргээ биелүүлж байгаа үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөг бодитой хязгаарлах, амь бие, эрүүл мэндэд нь хохирол учруулахад хүргэдэг тул Монгол Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ дагуу галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг эрх бүхий төрийн төлөөлөгчийн гүйцэтгэж байгаа албан үүргийн онцлог, хэрэгжүүлэх арга, эрх хэмжээг харгалзан тус бүрд нь ялгавартайгаар тогтоож, энэ тухай бие даасан хууль гаргах нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө” гэж заасан нь үнэ өссөн тохиолдолд иргэдийг татварын дарамтаас чөлөөлөх гэсэн агуулга бүхий чухал заалт боловч Улсын Их Хурлаас хуульчлан тогтоосон хэм хэмжээг өөрчлөх шууд утгыг илэрхийлж байгаа, ийнхүү өөрчилснөөр ногдуулах татварын хувь, хэмжээ өөрчлөгдөхгүй байх баталгаагүй, нөгөө талаар албан татвар ногдуулах орлогын хэмжээг өөрчлөх, зохицуулах эрхийг хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг хүлээсэн Засгийн газарт шилжүүлсэн зэрэг нь Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Ц. Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан дээр иргэнийхээ хувьд Татварын ерөнхий хуулийн хэд хэдэн заалт Үндсэн хуульд харшилж байна гэж албан ёсоор мэдээлэл хийж Цэц авч үзэхийг хүссэний дотор мөн хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “...бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно” гэсэн нь Үндсэн хуулийн заалтад харшилж байгаа тухай асуудлыг Цэц бүрэлдэхүүнээрээ ам магадлал гарган хүлээн авч дүгнэлт гаргасан, түүнчлэн энэхүү хуралдаанд Ц. хүндэтгэх шалтгаанаар биеэр оролцож чадаагүй учир өөрийгөө Цэцэд төлөөлөх эрхийг Т., Ц. нарт албан ёсоор /бичгээр/ олгосныг буруу гэж үзэх үндэслэлгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дээрх заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “Иргэн... халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, ... хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасныг шууд зөрчиж байгаа бөгөөд бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг хуулиар тогтоох ёстой байтал гүйцэтгэх байгууллагууд тогтоож байхаар заасан нь буруу болжээ.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх нь Цэцийн хуралдааны хэлэлцүүлэг, бусад нотлох баримтаар хангалттай нотлогдохгүй байгаа тул энэхүү хоёр заалттай холбогдох маргааны талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай гэж Цэцийн гишүүдийн дийлэнхи олонхи нь санал өгсөн тул энэ асуудлыг улс төр, хууль зүй, эдийн засгийн мэргэжил бүхий хамтарсан шинжээч томилж дүгнэлт гаргуулах замаар дахин нэмэлт шалгалт хийсний эцэст Цэц эцэслэн шийдвэрлэхээр хойшлуулах нь зүйтэй гэж үзэв.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь “Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх”, “Улсын Их Хурал... хуульд өөрчлөлт оруулах... асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэсэн Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг тус тус зөрчсөн нь Цэцийн хуралдааны хэлэлцүүлэг, хавтаст материалд авагдсан нотлох баримтуудаар хөдөлбөргүй батлагдаж байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн “...бие хамгаалах тусгай хэрэгслийнжагсаалт,түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно”, Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газар үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө” гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг үндэслэн нэмэлт шалгалт хийсний эцэст Цэц дахин хянан хэлэлцэж эцэслэн шийдвэрлэхээр хойшлуулсугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт (1997 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон) “Хуралдаанд оролцсон гишүүдийн санал хуваагдаж тэнцсэн, маргааны талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай болсон бол Цэц уг маргааныг гуч хоногийн дотор дахин хянан хэлэлцэж шийдвэрлэхээр хойшлуулж магадлал гаргана” гэсний дагуу Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэхийг эцэслэн шийдвэрлэхийг хойшлуулсан. Улмаар 1993 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар уг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 1 дүгээр магадлалын хянах, тогтоох хэсгийн агуулга:

Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хүсэлтийн дагуу Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц бүрэн бүрэлдэхүүнээрээ хоёр дахин хянан үзсэн хуралдаанаар Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн дээрх заалтуудыг Цэцийн таван гишүүн Үндсэн хууль зөрчиж байна гэж үзэж, Цэцийн дөрвөн гишүүн Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж үзжээ.

Цэцийн гишүүдийн санал хураалтын дүн нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...Цэц уг маргааныг дахин хянан хэлэлцэж хуралдаанд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтоол гаргана" гэсэн заалтын шаардлагыг хангаагүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

Ерөнхийлөгчийн хүсэлтээр үүссэн маргаан хэвээр үлдэж, Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт хэвээр үйлчилнэ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1993.04.21 № 02**

### **БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байгаа эсэхийг хянан хэлэлцэх тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга Р.-ээс ирүүлсэн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 3/369 дүгээр албан бичигт "Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм нь шинэ Үндсэн хууль болон Улсын Их Хурал байгуулагдахаас өмнө батлагдсан тул дээрх дүрэмтэй холбогдсон асуудлыг шалгах, уг асуудлаарх Цэцийн хуралдаан хийх үед Улсын Их Хурал итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулах шаардлагагүй гэж үзэж байна" хэмээн мэдэгдсэн тул хариуцагчийн талаас төлөөлөгч оролцоогүй байна.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн "Дүрэм батлах тухай" (Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм) 99 дүгээр зарлиг

- 5 дугаар зүйл "... Хөндлөнгийн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй"

- 6 дугаар зүйл "Хөндлөнгийн шүүхийн шийдвэрийг хууль ёсны үндэслэлгүй гэж үзвэл хөдөлмөрийн хамт олон шаардлагаа шийдвэрлүүлэх эцсийн арга хэмжээ болгон үйлдвэрийн газар, байгууллагын буюу тэдгээрийн салбар, нэгжийн ажлыг бүрэн буюу хэсэгчлэн түр зогсоож (ажил хаяж) болно"

- 9 дүгээр зүйл "... ажил нь тасалдсаны улмаас иргэдийн амь бие, эрүүл мэндэд аюул учирч болох бусад байгууллага, ... ажил нь зогсвол ихээхэн аюулд хүргэж



болох тасралтгүй ажиллагаатай бусад үйлдвэрийн газар, байгууллагад ажил хаяхыг хориглоно”

- 12 дугаар зүйл “Хууль бус гэж тооцсон ажил хаялтыг зохион байгуулсан, түүнд оролцсон ажилчин, албан хаагчдыг хөдөлмөрийн сахилга ноцтой зөрчсөн гэж үзэх бөгөөд тэдэнд БНМАУ-ын хөдөлмөрийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу сахилгын болон материалын хариуцлага хүлээлгэж болно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

- Дөчин долдугаар зүйл 1 дэх хэсэг “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

- Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”

- Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:**

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс 1990 онд баталсан Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байна хэмээн би үзэж байна.

Хэрэв энэхүү дүрэм Үндсэн хуульд харшилж байгаа нь үнэн бол Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг ёсоор дээрх дүрэм 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүчингүй болсон байх ёстой билээ. Гэтэл Засгийн газар ажил хаялт бүрийн эсрэг дээрх дүрмийг баримтална гэж удаа дараа мэдэгдсээр байна. Хэрэв энэхүү дүрэм Үндсэн хуульд нийцээгүй, тэр тусмаа харшилсан бол шүүх түүнийг барин хэрэг шийдвэл Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчих болно. Нэг үгээр хэлбэл энэ дүрмийг тойрон олон хүн хамарсан маргаан дэгдсээр байгаа тул Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах хүсэлтийг тавьж байна. Үүнд: БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар баталсан “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм” Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.

##### **2. Иргэн Л.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:**

Нэгдүгээрт, хамт олны хөдөлмөрийн маргааны нөгөө тал байж болох эрх зүйн этгээд, тухайлбал төрийн гүйцэтгэх дээд байгууллага энэ утгаараа тус дүрмийг хэрэглэх хүрээнд /дүрмийн 1 дүгээр зүйл/ ороогүй нь төрийн дээд өндөрлөгүүд хуулийн хяналтад байх тухай Үндсэн хуулийн гол үзэл санаанд нийцэхгүй байна.

Хоёрдугаарт, шүүхийг энэ дүрмээр байгуулж байгаа /дүрмийн 5 дугаар зүйл/ нь Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтыг шууд зөрчиж байна. Энд яригдаж байгаа хөндлөнгийн шүүхийг дүрмийн 4 дүгээр зүйлд заасан хамт олны маргаан таслах комисс мэтээр үзэх үндэс байхгүй байна. Хөндлөнгийн шүүх нь эцсийн шийдвэр гаргадаг хамт олон давж заалдъя гэвэл ажил хаях ёстой /дүрмийн 6 дугаар зүйл/ Энэ нь үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шиг Улсын дээд шүүхийн ч, Жаран долдугаар зүйлд заасан шиг цэцийн ч эрх эдэлж болох онцгой маягийн шүүх гэж ойлгогдож байна.

Гуравдугаарт, ажил хаях эрх нь хязгаарлагдсан хамт олон өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах асуудлыг төрийн дээд байгууллагад тавина. Тэр нь 14 хоногийн дотор хамт олонд хариу шийдвэр бичгээр өгнө /дүрмийн 9 дүгээр зүйл/ гэснээр асуудал шийдэгдэж байгаа нь дүрмийн нийт агуулгаас харагдаж байна. Энэ маргаан гарвал яах вэ? Маргааны нэг талын субъект, маргааныг шийдэх болчихвол яах вэ? Эндээс дүгнэвэл төрийн гүйцэтгэх дээд байгууллагад шүүх эрх мэдлийг олгосон байна. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

Дөрөвдүгээрт, дүрмийн 9 дүгээр зүйлийн эхний хэсэгт ажил хаях эрх нь хязгаарлагдсан хамт олны хүрээг байвал зохих хэмжээнээс хэт өргөтгөсөн нь Монгол Улс нэгдэн орсон, Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа олон улсын гэрээг зөрчиж, ингэснээрээ Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчиж байна. Ер нь ингэж хэт өргөн тогтоосон нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг ч зөрчихөд хүргэсэн байна.

### 3. Холбогдох газраас ирүүлсэн тайлбарын агуулга:

а/ Улсын дээд шүүхийн гишүүн Ц.-гээс ирүүлсэн 1993 оны 3 дугаар сарын 20-ны 3/346 дугаар албан бичгийн агуулга:

Тус улсын шүүхүүд нь Хөдөлмөрийн хуулийн 89 дүгээр зүйл, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар баталсан “Хамт олны хөдөлмөрийн маргаан хянан шийдвэрлэх дүрэм”-ийн дагуу 1990-1993 онд Эрдэнэт хотын Уулын баяжуулах үйлдвэр, Улаанбаатар Төмөр замын нэгдсэн эмнэлэг, Улсын төв номын сан, Савхин эдлэлийн үйлдвэр, Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын дунд сургууль зэрэг газарт хууль бус ажил хаясан тухай хэргүүдийг хянан шийдвэрлэсэн байна. Манай Улсад ажил хаях эрхийг хуульчлан баталгаажуулсан тул дээрх дүрмийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй юм. Харин уг дүрэм нь шат дамжлага ихтэй, зарим асуудлыг тусгаагүй орхигдуулсан тул хууль болгох саналыг дэмжиж байгаа болно.

### б/ Монгол Улсын Хөдөлмөрийн Яамны мэргэжилтэн И.-гийн тайлбарын агуулга:

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх дүрмийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуультай харшилсан гэж боддог. Үүнд: Хамтын маргаан шийдвэрлэх эрх бүхий хөндлөнгийн шүүх нь эрх хэмжээний хувьд шүүхийн нэгэн адил байгаа. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйл буюу Монгол Улсын Үндсэн хуулиас гадуурхи байдлаар шүүх байгуулсан мэт санааг илэрхийлж байна. Ажил хаяж үл болох субъектуудыг их өргөтгөжээ. Энэ нь манай улс нэгдэн орсон олон улсын конвенцын заалтыг зөрчсөн. Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж боддог. Харин хөдөлмөрийн хамтын маргааны субьектээр Монгол Улсын Засгийн газар оролцох ёстой гэсэн үзэл бодол байж болохгүй байх. Засгийн газар нь парламентаас байгуулагдах тул түүнд хөдөлмөрийн харилцааны асуудлаар тулгалт хийж болохгүй байх. Хэрэв үүнийг зөвшөөрвөл ажил хаялтыг зөвшөөрнө гэсэн үг болно.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн баримтуудад үндэслэн үзэхэд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн /хуучин нэрээр/ 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 99 дүгээр зарлигаар батлагдсан “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байна гэх үндэслэлтэй байна. Үүнд:

Нэг. Дүрмийн 5, 6, 12 дугаар зүйлд байгаа хөндлөнгийн шүүхтэй холбогдох заалтуудад тухайлбал “хөндлөнгийн шүүх байгуулж байгаа журам болон хөндлөнгийн шүүхийн шийдвэр эцсийн бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй” гэх мэтийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, 3-т буй

“ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно. Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна” гэсэн заалтуудыг зөрчжээ.

Чухамдаа шүүх эрх мэдлийг шүүхээс бусад байгууллагад шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

Хоёр. Дүрмийн 9 дүгээр зүйлд буй “...ажил нь тасалдсаны улмаас иргэдийн амь бие, эрүүл мэндэд аюул учирч болох бусад байгууллага, ... ажил нь зогсвол ихээхэн аюулд хүргэж болох тасралтгүй ажиллагаатай бусад үйлдвэрийн газар, байгууллагад ажил хаяхыг хориглоно” гэх мэтээр ажил хаяхыг хориглосон субъектуудыг хэт өргөтгөсөн заалтууд, энэ зүйлд заасан үйлдвэрийн газар, байгууллагад үүссэн хамт олны маргааныг хамт олны маргаан шийдвэрлэх комисс шийдвэрлэж чадаагүй бол... БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл уг асуудлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг Хөдөлмөрийн хамт олонд бичгээр мэдэгдэнэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3-т буй “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 1-д буй “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө” гэсэн заалт Монгол Улс 1974 онд нэгдэн орсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын /1966 оны/ наймдугаар зүйлийн хоёр дахь хэсгийн заалт болон Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчжээ. Монгол Улсын эрх бүхий байгууллагууд хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахдаа Үндсэн хуулийг зөрчсөн дээрх хэм хэмжээг баримтлан мөрдөж ирсэн байна. Энэ талаар Л.-ийн хүсэлт үндэслэлтэй байна. Харин Л.-ийн хүсэлтэд дурдсан “Монгол Улсын Засгийн газар хөдөлмөрийн хамтын чанартай маргааны зохигч атлаа уг маргааныг хянан шийдвэрлэж байгаа бөгөөд түүнд ямар ч хяналт байхгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй байна” гэсэн хэсгийг хангах үндэслэлгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүрэг бүхий гүйцэтгэх дээд байгууллага тул хөдөлмөрийн тодорхой харилцааны субъектээр оролцох үүрэггүй байдлаар тодорхойлогдоно гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн 5, 6, 12 дугаар зүйлд тусгагдсан хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалтууд, мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн ажил хаяхыг хориглосон субъектуудыг Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээс хэт өргөтгөсөн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд /хуучин нэрээр/ хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээ олгосон заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3, Дөчин долдугаар зүйлтэй харшилж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчингүй болох ёстой байжээ.

Харин эдгээр заалтуудыг холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаандаа одоо болтол хэрэглэж, удирдлага болгосоор байгааг харгалзан Монгол Улсын Их Хурал Үндсэн хууль зөрчсөн дээрх заалтуудыг тухайлан хүчингүй болгох нь зүйтэй гэсэн дүгнэлтийг оруулж байна.

2. Иргэн Л.-ийн гомдолд дурдсан “Хөдөлмөрийн хамтын маргааны зохигч болох Монгол Улсын Засгийн газар, түүний үйл ажиллагаанд хяналтгүй байгаа нь Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй байна” гэсэн хэсгийг хэрэгсэхгүй болгосугай.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг түүнийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1993 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 33 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан “Хамт олны маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйлд харшилж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчингүй болох ёстой байжээ гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэц уг дүгнэлтийг гаргахдаа БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигийг сайтар судлаагүй нь ажиглагдсан. Цэцийн дүгнэлтэд Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрмийн 5, 6, 12 дугаар зүйл Үндсэн хууль зөрчиж байна гэсэн боловч дээрх зүйлийг үгчлэн бичээгүй, Цэцийн дүгнэлтэд дурдагдсан 9 дүгээр зүйлийг дүрмийн эх хувийн 9 дүгээр зүйлтэй тулган харьцуулахад өгүүлбэрийн зөрүү гарсан байх тул засаж бичсэн болно.

Хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн хяналтын объектод Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэр ордоггүй. Энэ үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж болохоор байсан байна.

Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг харьяалан шийдвэрлэх эрхтэй билээ. Гэхдээ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн нь бий. Гэтэл тухайн цаг үед буюу 1992 оны 2 дугаар сард Улсын Их Хурал байгуулагдаагүй байсан бөгөөд 1992 оны 7 дугаар сарыг дуустал Улсын Бага Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлж хууль, бусад шийдвэр баталсан гэж үзвэл үүнийг Цэц харьяалан шийдвэрлэх үү гэдэг нь маргаантай байгаа юм.

Үндсэн хуульд тусгагдсан шүүх эрх мэдлийн тулгуур зарчим болсон “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэснийг хөндсөн хууль, бусад шийдвэр олон гардаг. Энэ нь Улсын Их Хурал, Засгийн газраас аливаа маргааныг “шүүн хэлэлцэх”, “шийдвэрлэх” сонирхол үе үе төрдөгтэй холбоотой. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн багагүй хэсэг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэх, эрх мэдлийн хоорондын тэнцвэрийг хадгалахад чиглэгдсэн байдаг.

Засгийн газар нь хөдөлмөрийн хамтын хэлэлцээрийн нэг тал бөгөөд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага тул хэзээ ч хөдөлмөрийн маргааныг эцэслэн шийдвэрлэгч байж таарахгүй. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1999 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн зарим маргааныг Хөдөлмөрийн маргаан таслах комисс шийдвэрлэдэг зохицуулалт бий боловч талууд 10 хоногийн дотор Хөдөлмөрийн маргаан таслах комиссын шийдвэрийг давж заалдаж болдог.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1993.05.26 № 03

## Үндсэн хуулийн цэцийн 2 дугаар дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш., Б.

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

#### 1. Иргэн Л.-ийн тайлбарын агуулга:

Би маргалдаж байгаа асуудлаар Цэцийн урьдах хуралдаан болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралд тодорхой ярьсан, түүнчлэн тайлбараа бичгээр гаргаж та бүхэнд хүргүүлсэн учраас энэ удаа цаг хэмнэж дэлгэрэнгүй ярих шаардлагагүй гэж үзэж байна. Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлээд тодруулах асуудал байвал мэтгэлцээний явцад ярилцах саналтай байна.

#### 2. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Энэ асуудлаар Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганд тодорхой ярилцсан учраас товч тайлбар хэлье. Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх үүрэг бүхий хөндлөнгийн шүүх нь Үндсэн хуульд заасан шүүхийн тогтолцоонд хамаарагдахгүй, уг хэлэлцэн шийдвэрлэх асуудал нь шүүхийн эрх мэдлийнх биш, хөндлөнгийн шүүхийн үйл ажиллагаа нь эрүү, иргэний байцаан шийтгэх хуулийн дагуу явагддаггүй. Түүнчлэн хөндлөнгийн шүүх гэсэн ойлголт дэлхийн олон улс, орны практикт байдаг байна. Ийм ч учраас Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх, хөндлөнгийн шүүхийн хоорондын зарчмын олон ялгаа байгааг байнгын хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан. Хөндлөнгийн шүүх гэдгийг шүүх гэдэг утгаар нь бус үйл ажиллагааны агуулгаар нь ойлгох нь зүйтэй учир энэ талаархи дүгнэлтийг хүлээж авах боломжгүй юм. Дүрмийн 9 дүгээр зүйлд ажил хаяж болохгүй субъектуудыг өргөтгөж заажээ гэх үндэслэлгүй бөгөөд тодорхой улс өөрийн онцлогт тохируулж тогтоож болох талтай, нэгдэн орсон олон улсын гэрээг үг үсэгчлэн биелүүлэх албагүй, ерөнхий зарчимд л таарч байх ёстой учраас Үндсэн хуульд харшлаагүй гэж үзнэ. Засгийн газар нь гүйцэтгэх дээд байгууллагын хувьд тодорхой салбар эрхэлсэн байгууллагын шийдвэрийн талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэдэг нийтлэг журамтай. Иймд “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн 5, 6, 9, 12 дугаар заалтууд Үндсэн хуульд харшлаагүй гэж үзэж байна.

### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар хянаж хэлэлцсэн баримтуудыг дүгнэж үзвэл БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан “Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм”-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Дөчин долдугаар зүйлийн заалттай нийцэхгүй байна гэж үзэх үндэстэй байна. Тухайлбал, дээрх дүрмийн 5, 6, 9, 12 дугаар зүйлд заасан хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалт нь Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн заалттай, мөн дүрмийн 9 дүгээр зүйлд ажил хаяж болохгүй субъектуудыг хэт өргөтгөсөн, түүнчлэн үйлдвэрийн газар, байгууллагад үүссэн хамт олны маргааныг хамтын маргаан шийдвэрлэх комисс шийдвэрлэж чадаагүй бол хөдөлмөрийн хамт олон өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах асуудлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд тавих бөгөөд

уг асуудлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хамт олонд хариу өгнө гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Дөчин долдугаар зүйл, Үндсэн хуулийн хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалттай тус тус нийцэхгүй байна.

Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм"-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд нь Үндсэн хуулийн зохих зүйлүүдийн заалттай зөрчилдөж байгаа учраас 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болон хүчингүй болох ёстой байжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан "Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм"-ийн 5, 6, 12 дугаар зүйлийн хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалтууд, 9 дүгээр зүйлийн "Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий... байгууллагад ажил хаяхыг хориглоно" гэснээс бусад хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1993 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Одоогоор эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шийдвэрлэдэг хөндлөнгийн, шүүхийн бус субъект бол Монголын Үндэсний Арбитр бөгөөд 1960 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 194/295 дугаар хамтарсан тогтоолоор Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэд нэг арбитрчийн орон тоотойгоор анх байгуулагдаж байсан байна. 2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хурлаас Монгол Улсын "Арбитрын тухай хууль"-ийг баталсан нь арбитрын эрх зүйн орчинд тодорхой өөрчлөлт оруулж, үйл ажиллагааг нь өргөжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурал 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд тус хуульд дээрх зөрчлүүдээ арилгасан байна. Үүнтэй холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 99 дүгээр зарлигаар батлагдсан "Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцсон байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1993.05.31 № 03

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны 52 дугаар зарлиг, мөн зарлигт өөрчлөлт оруулах тухай 5 дугаар сарын 1-ний 73 дугаар зарлигийн заалт Үндсэн хуулийн заалттай харшилж байгаа эсэхийг хянан хэлэлцсэн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д., Б.;  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч - Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Т., зөвлөх Ц.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Засгийн газрын Тамгын газрын орлогч дарга Л.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Дэлхийн Монголчуудын “Их Чуулган” зохион байгуулах тухай” 52 дугаар зарлиг<sup>8</sup>

- 1 дүгээр заалт “Дэлхийн Монголчуудын хэлхээ холбоог хөгжүүлэх, тэдэнтэй эдийн засаг, соёл, мэдээллийн талаар хамтран ажиллах таатай боломжийг бүрдүүлэх, үндэсний хэл, соёлоо өвлөн улмаар хүмүүнлэг харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн Монголчуудын их чуулганыг зохион байгуулах талаар Монголын хөгжлийг дэмжих Сан-нийгэмлэг, Монголын энхтайван найрамдлын байгууллагуудын холбооноос дэвшүүлсэн саналыг ёсоор болгох нь зүйтэй гэж үзсүгэй”

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлиг<sup>9</sup>

- “Дэлхийн Монголчуудын “Их чуулган” зохион байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлигийн 2 дугаар зүйлийг “Дэлхийн Монголчуудын “Их чуулган”-ыг 1993 оны 9 дүгээр сарын 13-наас 20-нд Улаанбаатар хотноо чулуулахад санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай”

### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”

- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт “төрийн санхүү зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах”

- Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно”

8 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 2-т нийтлэгдсэн

9 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 3-т нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Д., Б. нарын мэдээллийн агуулга:

Дэлхийн Монголчуудын “Их чуулган” зохион байгуулах тухай гарсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлигийн 1-д заасан “Дэлхийн Монголчуудын хэлхээ холбоог хөгжүүлэх, тэдэнтэй эдийн засаг, соёл, мэдээллийн талаар хамтран ажиллах таатай боломжийг бүрдүүлэх, үндэсний хэл, соёлоо өвлөн улмаар хүмүүнлэг харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн Монголчуудын их чуулганыг зохион байгуулах талаар “Монголын хөгжлийг дэмжих Сан” нийгэмлэг, Монголын энхтайван найрамдлын байгууллагуудын холбооноос дэвшүүлсэн саналыг ёсоор болгох нь зүйтэй гэж үзсүгэй” гэсэн заалт, мөн зарлигийн 2 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан 1993 оны 5 дугаар сарын 1-ний 73 дугаар зарлигт “Дэлхийн Монголчуудын “Их чуулган” зохион байгуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлигийн 2 дугаар зүйлийг “Дэлхийн Монголчуудын “Их чуулган”-ыг 1993 оны 9 дүгээр сарын 13-наас 20-нд Улаанбаатар хотноо чулуулахад санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-д заасан Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарагдах “Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”, “Төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэсэн заалтуудыг зөрчиж Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлаар зарлиг гаргасан нь буруу гэж үзэж байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлигаар 52 дугаар зарлигийн “...хөрөнгийг улсын төсвөөс гарган, ...шаардагдах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай” гэснийг “Санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Засгийн газарт чиглэл болгон” өөрчилсөн ч Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтуудад харшилж байна.

Иймд Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон Монгол Улсын Үндсэн хуулийн цэц уг асуудлыг авч үзэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

2. Иргэн Б.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлигийн 1 дүгээр заалт бол Монгол Улсын тусгаар тогтнолтой холбоотой ноцтой асуудал юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ зарлиг нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар дур мэдэн зарлиг гаргасан, Монгол Улсын нэр хүндийг гадаад орны өмнө унагасан, Монгол үндэстэн амьдарч байгаа дэлхийн бусад орны дотоод хэрэгт оролцсон, мөн Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4-т заасан “гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах”, Аравдугаар зүйлд заасан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх” гэсэн заалтууд болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарахгүй гэж бид үзэж байна.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн тайлбарын агуулга:

Гомдол гаргагч талын тайлбарыг сонслоо. Гэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7 дугаар заалтыг уг зарлиг зөрчсөн тухай ямар ч тайлбар гарсангүй. Мэтгэлцээний явцад гарах байх гэж бодож байна. Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг бол Монголчуудын хэлхээ холбоог хөгжүүлэх, эдийн засаг, үндэсний хэл, соёлоо өвлөхөд л чиглэсэн зарлиг юм.



4. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Л.-ийн тайлбарын агуулга:

Ерөнхий сайд Ерөнхийлөгчийн зарлигт гарын үсэг зурж байгаа нь Ерөнхийлөгчөөс өгсөн чиглэлийг биелүүлэх боломжтойг нотолж байгаа юм. Засгийн газар Улсын Их Хурлаас баталсан улсын төсвийг захирагчийн хувьд “Дэлхийн Монголчуудын чуулган”-ы зардлыг энэ оны төсөвт багтаан Засгийн газрын танхимын хурлаар жич шийдэх юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хянаж хэлэлцсэн нотлох баримтуудаас дүгнэлт хийж үзвэл:

“Дэлхийн Монголчуудын “Их чуулган” зохион байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг, энэ зарлигийн 2 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлигууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7 дугаар заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас дараах ДҮГНЭЛТИЙГ ГАРГАВ:

1. “Дэлхийн Монголчуудын “Их чуулган” зохион байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг, түүнд өөрчлөлт оруулсан 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлиг нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7 дахь заалт, Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчөөгүй гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэц үзэв.

2. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 3 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 3 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг, мөн оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлиг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7 дахь заалт, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчөөгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Мэдээлэл гаргагч Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргахдаа монгол үндэстэн оршин суудаг дэлхийн бусад орны дотоод хэрэгт оролцсон байна гэж өргөдөлдөө дурдсан ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг нь хууль тогтоомжид нийцэж гарсан тохиолдолд зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх хүчин чадалтай байдаг.

Ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдэлд хамаардаг, харьцангуй өргөн хүрээний эрх мэдэлтэй субъект юм. Тухайлбал:

- Улсын Их Хурлаас баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавьдаг;
- Ерөнхий сайдыг томилуулах, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгчийн санал болон зөвшилцлийг үндэслэн шийдвэрлэдэг;
- Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь хэрэгжүүлдэг;
- Бүх шатны шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилдог;
- Хууль санаачлах, хүсэлт тавих, засгийн газарт эрх хэмжээнийхээ асуудлаар чиглэл өгөх зэргээр шууд нөлөөлдөг;
- Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байдаг;
- Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татдаг;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг гэх мэт.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1993.12.22 № 04

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн С., Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Л., Т.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль<sup>10</sup>

- 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын сонгууль (энэ хуульд цаашид “сонгууль” гэнэ) бүх нийтийн байна. Санал авах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй”

- 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Саналын хуудсанд нэр дэвшигчийн овог, нэрийг нам, эвслээр бүлэглэн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар бичиж хэвлэнэ”

- 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж уг хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн бөгөөд мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийн овог нэрийн өмнөх дэс дугаарыг дугуйлан тэмдэглээд энэхүү саналын хуудсаа саналын хайрцагт хийнэ”

- 36 дугаар зүйлийн 2 дахь заалт “тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, хэсгийн хорооны тэмдэггүй”

- 38 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Сонгуулийн тойргийн хороо нэр дэвшигчдийг авсан саналын нь тоогоор дараалалд оруулна. Хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг мандатын тоогоор Улсын Их Хурлын гишүүнд сонгогдсонд тооцно”

<sup>10</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 2-т нийтлэгдсэн

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”
- Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн С.-ийн мэдээллийн агуулга:**

1992 оны Улсын Их Хурлын сонгууль нь чөлөөт ардчилсан сонгууль болж чадсангүй. Үүний учир шалтгааныг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг баталж гаргах болон уг хуулийг хэрэгжүүлэх явцад гарсан алдаа дутагдалтай холбон үзэх ёстой. Тус улсын нэгдэн орсон Иргэний ба улс төрийн эрхийн пактын 25 дугаар зүйл, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд бүх нийтэд сонгуулийн тэгш эрх эдлүүлэх, чөлөөтэй, шууд сонгох үндсэн зарчмуудыг заажээ. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд сонгуулийн тэгш эрхийн зарчим тусгагдаагүй орхигдсон юм.

Сонгуулийн хуульд тэгш эрхийн зарчмыг тусгаж өгөөгүйгээс түүнтэй холбогдсон олон харилцаа зохицуулалтгүй үлдэв. Хуульд хэдэн тойрог байх, нэг тойрогт хэдэн мандат ноогдох зэргийг тусгалгүй “Сонгуулийг олон мандаттай тойргоор зохион байгуулна. 8 дугаар зүйл”, “Сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, ногдох мандатын тоог Улсын Их Хурал тогтооно. Мөн зүйлийн 2 дахь хэсэг” гэх мэтээр тодорхой бус заалтуудыг оруулснаар хууль хэрэгжүүлэхэд алдаа гарах нөхцөлийг бүрдүүлсэн. Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулахдаа Улсын Их Хурлын 76 гишүүний мандатыг олон тойрог бүхий мажоритари системийн үндсэн дээр хуваарилан 38 тойрог, тойрог бүрт 2 мандат эсвэл 19 тойрог, тойрог бүрт 4 мандаттай байхаар зохион байгуулж болох байсан.

Гэтэл Улсын Бага Хурал сонгуулийн тойргийг зохион байгуулахдаа ердөө л засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу 26 тойргоор зохион байгуулж, 8 тойрогт 2 мандат, 12 тойрогт нь 3 мандат, 6 тойрогт нь 4 мандат хуваарилсан нь сонгогчдыг оршин суугаа газар нутгаар нь ялгаварлан үзсэн мэт болсон юм. Жишээ нь: Дорноговь аймгийн сонгогч хоёр мандатын төлөө саналаа өгөхөд Улаанбаатар хотын Октябрь дүүргийн сонгогч 4 мандатын төлөө саналаа өгч Дорноговийнхоос нэг дахин илүү эрх эдэлснийг Үндсэн хуулийг үнэхээр зөрчсөн гэхээс өөр юу гэх вэ?

Энэ хуулийн хоёр дахь томоохон зөрчил бол олон мандат бүхий мажоритари системийг сонгон авсан атлаа энэ системийнхээ онцлогийг тусгасан тусгай зарчмуудыг хэрэглээгүй, нэг мандаттай тойрог бүхий мажоритари системийн зарчмыг хольж хутгасан явдал юм. Сонгуулийн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “саналын хуудсанд нэр дэвшигчдийн овог, нэрийг нам, эвслээр бүлэглэн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар бичиж хэвлэнэ” гэж олон мандаттай мажоритари системийн нэр дэвшүүлэх зарчмыг тусгасан атлаа 35 дугаар зүйлийн 2-т “сонгогч саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн бөгөөд мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчдийн овог нэрийн өмнөх дэс дугаарыг дугуйлан тэмдэглэнэ” гэж нэг мандаттай мажоритари системийн санал хураах зарчмыг хэрэглэж онол арга зүйн бүдүүлэг алдаа гаргасан юм.

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд олон мандаттай тойрогт нэг мандаттай тойрог бүхий мажоритари системийн сонгуулийн үр дүнг тодорхойлох зарчмыг / хуулийн 38 дугаар зүйлийн 3/ хэрэглэснээр сонгуулийн үр дүнг алдаатай, буруу болгож будлиантуулах шалтгаан болсон бөгөөд нэг тойргоос хэдэн ч намын нэр дэвшигч гарах, мөн өөр хоорондоо адилгүй янз бүрийн санал авсан хүмүүс гарч болох, тэр ч байтугай нөгөө намын нэр дэвшигчээс харьцангуй бага санал бүрдсэнийг 1992 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дагавар харууллаа. 1992 оны Их Хурлын сонгуулийн үр дүнг мажоритари системийн аргаар дүгнэн тооцох ямар ч боломж, хууль зүйн үндэслэл байхгүй юм. Сонгуулийн эцсийн үр дүн нь парламентын нийт суудлын тоогоор 71-ийг Монгол Ардын Хувьсгалт Нам, 5-ыг бусад нам, сонгогчдын нийт саналын 56.9 хувийг Монгол Ардын Хувьсгалт Нам, 43.1 хувийг бусад нам, эвсэл гэсэн хоёрдмол утгатай дүн гарч байна. 71:5 гэсэн эхний дүнг Сонгуулийн ерөнхий хороо Улсын Бага Хуралд өргөн мэдүүлж Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг олгосон Улсын Бага Хурлын тогтоол гаргасан нь Үндсэн хууль зөрчсөн, хууль бус ажиллагаа болохыг нэгэнт тайлбарласан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн Улсын Бага Хурлын тогтоол, Их Хурлын сонгуулийн хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц магадлан үзэж, хүчингүй болгоно уу?

## 2. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

1992 оны Сонгуулийн хуульд сонгогчийн тоог мандатад тэгш хуваарилах коммунист аргыг хэрэглэснээс төлөөлөлтийн зарчим алдагдав. Төлөөлөлтийн шалгуур нь депутатын мөрийн хөтөлбөр бөгөөд түүний биелэлтийн шалгуурыг хуульд тусгасангүй. Сонгогчид санал гаргах явдал шахалтаар явагдав. Энэ нь зөвхөн сонгуулийн хуульд заасан зохицуулалттай холбоотой. Сонгогч саналын хуудсанд илүү нэр дэвшүүлэх, дутуу дугуйлахад уг хуудас хүчингүй болно. Иймд сонгогч саналаараа нэр дэвшигчийг сонгохгүйд хүрэв. Иймд Үндсэн хуулийн цэцээс энэ хуулийн талаарх зохих дүгнэлт гаргах, эсхүл 1994 оны 6 дугаар сард нийт ард түмний дунд:

- Улсын Их Хурлын сонгуулийн хууль Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж буй эсэх;

- Зөрчилтэй хуулиар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа эсэх асуудлаар асуулга зохион байгуулж өгөхийг хүсье.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Л., Т. нарын тайлбарын агуулга:

### а/ Сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хангах талаар

Уг зарчим нь улс төрийн тэгш эрхийн зарчмаар үндсэндээ тодорхойлогдоно. Энэ нь нэг хүн нэг санал гэсэн зарчимд тулгуурлана. Сонгуулийн эрхтэй ямар ч хүн нийгмийн байдал, хүйс, шашин шүтлэг, үндэс зэргийг үл харгалзан хуулиар тогтоосон мандатын төлөө нэг л санал өгөх бөгөөд энэ нь бусад сонгогчийн саналтай ижил үнэлгээтэй байна. Энэ талаас нь үзэхэд Улсын Их Хурлын сонгуулийн хууль иргэн бүр улс төрийн тэгш эрхтэй байх тухай Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэсгүй юм. Тухайн тойрогт нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн бүх сонгогч тэгш эрх эдэлсэн гэж болно. Нөгөө талаас мандатын тоо ойролцоо учир улсын хэмжээгээр нийт сонгогчдын тэгш эрхийг хангахад чиглэгдсэн гэж үзэж болно.

Сонгуулийн хуулийг Улсын Бага Хурлаар хэлэлцэх үед энэ асуудлыг онцгой анхаарч үзсэн юм. Сонгуулийн тойргийг тогтоохдоо засаг захиргааны нэгжийг баримтлах ёс дэлхийн олонхи оронд байдаг тул хэрэглэсэн билээ. Харин ойролцоо тооны хүмүүс сонгуулийн нэг мандатад оногдож байхаар дараах аргачлалыг хийсэн. Тэр үеийн

мэдээгээр 18 наснаас дээш насны хүмүүс 1098743 байсан. Үүнийг 76-д хуваахад нэг мандатад ногдох сонгогчийн тоо 14457 болж байв. Тойрог тус бүрийн сонгогчийн тоог энэ дундаж тоонд хуваахад уг тойрогт оногдох мандатын тоо гарч байгаа юм. Гарсан тоог ойролцоолж дээш доош нь орон дэвшүүлэх замаар бүхэл тоо болгосон. Ийнхүү нэг мандатад ногдох сонгогчдын тоо нийт тойрогт ойролцоогоор ижил байхад тойрог, тойрогт мандатын болон сонгогчдын тоо өөр өөр ч гэсэн нэг саналын хувийн жин бүх тойрогт бас ойролцоогоор ижил байдаг учраас сонгуулийн тэгш эрх огт хангагдаагүй гэж үзэх үндэслэлгүй юм.

б/ Саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар

Энэхүү эрхийн үндсэн агуулга нь сонгогчдод сонголт хийх боломжтой хувилбаруудыг санал болгож сонгогч тэндээс өөрийн хүсэл зоригоор хэний ч шахалт хавчилтгүйгээр сонголт хийх боломжтой гэж үзсэн юм. Энэ боломжийг:

- Сонгуульд чөлөөтэй, хэний ч шахалт, хавчилтгүйгээр хүсэл зоригтоо нийцсэн хүний нэрийг дэвшүүлэх;
- Тэр хүнээ сурталчлах;
- Өөрөө нэр дэвшигчийн дотроос сонгоё гэсэн хүнээ /намаа/ хэний ч албадлага, хавчилтгүйгээр сонгож саналаа өгөх талаар хангагддаг.

Харин одоогийн мөрдөж байгаа сонгуулийн хуулиар:

1/ Ухаан мэдрэл эрүүл бус, гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсоноос бусад ямар ч хүний нэр дэвшүүлэх бололцоог олгосон;

2/ Сонгуульд бүртгэгдсэн нам, тэдгээрээс нэр дэвшсэн болон бие даасан нэр дэвшигчдээс бусад сонголт хийх өргөн боломжтой;

3/ Намууд болон нэр дэвшигчдийн аль нь таалагдахгүй бол саналаа өгөхгүй байх эрхтэй;

4/ Тэр бүү хэл сонгуульд оролцох эсэх нь сонгогчийн сайн дурын хэрэг байхаар заасан;

5/ Сонгуулийн сурталчилгаа шударга, тэгш байх бололцоог бодолцсон;

6/ Сонгогчид санал өгөх үед нь нөлөөлөх, албадах, хүчээр үл нийцэх хүний төлөө санал өгүүлэх оролдлогыг хориглосон зэрэг заалт орсон юм. Энэ бүхэн нь сонгогч саналаа чөлөөтэй илэрхийлэх бололцоог бүрэн олгож байгаа юм.

Харин сонгуульд нам нэр дэвшүүлэх, санал хураахаас 24 цагийн өмнө сурталчилгааг зогсоох зэрэг болон бусад хязгаарлалтыг хийж өгсөн нь сонгуулийг цэгцтэй зөв явуулж төрөө төвхнүүлэхэд чиглэсэн, бусад аль ч оронд байдаг хязгаарлалтууд юм. Хэдийгээр Үндсэн хуульд намаас нэр дэвшүүлэх тухай заалтад өөр субъектын тухай тодорхой заалт оруулаагүй боловч заавал намын саналыг сонгогчид тулгах учиргүй гэдэг баримтлалын үүднээс бие даасан нэр дэвшигч байх боломжийг хуульд тусгасан юм. Мандатын тоогоор санал өгөх тухай заалт ч чөлөөтэй санал өгөх эрхийг хязгаарлаагүй. Учир нь:

1/ Сонгуульд олон намын олон нэр дэвшигч оролцсон нь мандатын тооноос хэд дахин илүү байсан, тэдгээрийн дундаас сонголт хийх бүрэн боломжтой.

2/ Аль нэг намаас л нэр дэвшсэн хүний төлөө саналаа өгье гэж бодсон бол уг нам мандатын тоогоор нэр дэвшүүлэх эрх олгосон учраас сонгогчийн энэхүү хүсэл хуульд тооцогдсон. Харин тухайн нэг нам өгсөн боломжийг ашиглаагүй, цөөн нэр дэвшүүлж, сонгогчийг хүнд байдалд оруулсан бол энэ нь хуулиас шалтгаалсан хэрэг биш.

3/ Сонгогч би заавал намыг харгалзахгүй хэд хэдэн намын сайн хүнийг сонгоё гэж бодсон бол түүнд тийм боломж бас олгогдсон. Намууд сэтгэлд нь тохирох хүний нэр дэвшүүлээгүй бол энэ нь бас хуулиас шалтгаалсан хэрэг биш.

4/ Сонгогчид нэг л хүн таалагдаад бусад нь таалагдахгүй байх нөхцөл бий. Тийм үед манайх шиг мандатын тоогоор дугуйлах заалттай хуулиар санал өгч буй хүн өөрийн нэг саналыг сонгох хүндээ өгөөд бусдыг сонгогдохгүй байх, бусад нэр дэвшигчдэд өгдөг.

Энэ бүхнээс үзэхэд сонгогчдод сонголт хийх олон хувилбар олон боломжийг сонгуулийн хуулиар олгож байгаа болно. Санал хураах энэхүү арга нь хамгийн шилдэг нь биш байж болох боловч, түүнийг хэрэглэснээр сонгогчийн саналаа чөлөөтэй илэрхийлэх эрх өөрчлөгдсөн гэж үзэх үндэсгүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хянан хэлэлцсэн баримтуудад үнэлэлт хийж үзэхэд Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-нд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд сонгогчдын эрх тэгш байх, чөлөөтэйгөөр сонгох эрхийг алдагдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчив гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлд сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хуульчлан заагаагүйн гадна уг хуулийг хэлэлцэн баталсан Ардын Их Хурлын хуралдааны удаа дараагийн протоколд сонгуулийн тэгш эрхийн зарчмын талаар ямар нэгэн санал гараагүй байна. Маргагч талуудын гомдолд сонгогчид өөрсдийн сонгохыг хүссэн нэр дэвшигчид нь уг тойргоос сонгох мандатын тоонд хүрэхгүй тохиолдолд сонгохыг хүсээгүй бусад нэр дэвшигчдийн төлөө хүчээр санал өгүүлж, сонгуулийн чөлөөт зарчмыг алдагдуулав гэсэн нь тодорхой баримтаар нотлогдохгүй байна.

Иргэн Б.-гээс 1994 онд сонгуулийн хууль Үндсэн хуультай харшилж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх хууль ёсны эсэх талаар ард нийтийн санал асуулга явуулж өгөхийг хүссэн нь Үндсэн хуулийн цэцийн шийдэх эрх хэмжээний асуудал биш.

Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалт, 33, 35, 36, 38 дугаар зүйлийн зарим заалтууд боловсронгуй бус байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт буй “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно” гэсэн заалтын хүрээнд хуульчлагдсан тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтаар Улсын Бага Хуралд олгогдсон хууль тогтоох эрх хэмжээнд шийдвэрлэгдсэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн зарим заалт Үндсэн хуультай харшилдав гэж үзсэн иргэн С., Б. нарын хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 3, 35 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн С., Б. нарын мэдээлэлд дурдсан гомдлыг хангах үндэслэлгүй гэж үзэв.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд боловсронгуй болгох шаардлага байгааг Үндсэн хуулийн цэц үгүйсгэхгүй байна.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг түүнийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 5 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалт нь Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн иргэн Ө.Сэргэлэн, Н.Баасанжав нарын өргөдөлд дурдсан гомдлыг хангах үндэслэлгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дүгээр заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын сонгуулийг явуулах зарчмыг шууд зааж өгөөгүй ч гэсэн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг ... , шууд ... сонгоно” хэмээн заасан байдаг. Энэ нь сонгогчид Улсын Их Хурлын гишүүнийг “шууд” буюу аль нэгэн нам эвслийн төлөө санал өгөх бус харин уг нэр дэвшигчид саналаа өгнө гэсэн утгатай гэж зарим иргэд үздэг.

Гэвч дийлэнх орон өөрийн үндсэн хуулиараа сонгуулийн тогтолцоог тогтоодоггүй бөгөөд харин сонгуулийн зарчмыг тогтоож өгдөг байна. Үүнтэй нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан “шууд сонгох эрх” нь сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр өөрөө саналаа өгөх, сонгуулийн үр дүн нь сонгогчийн саналд үндэслэгдэх гэсэн агуулгыг илэрхийлдэг байна.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.01.07 № 01**

**Монгол Улсын Шүүхийн тухай хуультай холбогдсон  
маргааныг хянан хэлэлцсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн З., Э., Ш.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш., Г.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр баталсан Шүүхийн тухай хууль<sup>11</sup>

- 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргааныг ..”

- 41 дүгээр зүйл “Шүүгчид нэр дэвшигчийг хуульд заасан шаардлагыг хангаж буй эсэхийг судалсны үндсэн дээр түүний оршин суугаа газрын шүүхийн тамгын газар, хэлтэс бүртгэнэ”

- 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байна”

- 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Сахилгын хэрэг үүсгэх эрхийг дараах шүүх бүрэлдэхүүн, байгууллага, албан тушаалтан эдэлнэ: ... 1/ ... Ерөнхий зөвлөл Монгол Улсын бүх шүүгчдэд”

<sup>11</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 2-т нийтлэгдсэн

- 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Шүүгч сахилгын шийтгэл ногдуулсан сахилгын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлд гомдол гаргаж болно”
- 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Ерөнхий зөвлөл гомдлыг хүлээн авснаас хойш нэг сарын дотор хянан шийдвэрлэнэ”
- 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг “Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”
- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... эрхтэй”
- Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”
- Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ”
- Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн З., Э. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд “Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын агуулгад нийцэхгүй болжээ. Учир нь хуулиар шүүхэд харьяалуулахгүй хэрэг маргаан гэж байна. Түүний талаар шүүхээс өөр ямарваа нэг байгууллага эцсийн шийдвэр гаргаж болно гэсэн логик санааг агуулж байна. Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлыг хуулийн дагуу байгуулагдсан шударга шүүх л шийдвэрлэх ёстой.

Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байх тухай шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт, шүүгчид сахилгын шийтгэл оноосон Сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн талаар шүүгч шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан заалтууд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтаар баталгаажсан иргэн бүхэн шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хассан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Үндсэн хуульд зааснаар хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллахтай холбоотой үүргийг биелүүлэх ёстой. Гэтэл Шүүхийн ерөнхий зөвлөл бүх шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох эрхтэй болсон нь / хуулийн 49 дүгээр зүйлийн 3, 4/ тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг болох шүүгчдийн эрх ашгийг хамгаалах явдлыг шийтгэл, арга хэмжээ авч айлгадаг чиг үүргээр сольсон байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн заалт нь шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэхдээ шүүгчээр томилох хүний болзлыг бүртгэх үед хангасан



байхаар заасан нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг агуулгыг зөрчиж байна. Шүүгчээр томилох хүний болзол Ерөнхийлөгч томилох үед л бүрэн хангагдсан байх ёстой. Ийм алдаанаас болж дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байсан Д.-г нас хүрээгүй гэдгээр, Ц.-г ажилласан жил дутуу гэдгээр тус тус бүртгэхээс татгалзсан байна. Дээрх хүмүүсийг гэрчээр асууж өгнө үү.

2. Иргэн Ш.-ийн “Эрх чөлөө” сонины 1993 оны 12 дугаар сарын 30-ны дугаараар дамжуулж гаргасан мэдээллийн агуулга:

Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дүгээр заалтад “Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, дархан эрх эдэлнэ” гэсэн заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна. Дипломат эрх, дархан эрх эдлэх асуудлыг тухайн улсын парламент зарлахгүй, олон улсын конвенцын дагуу олгох ёстой.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш., Г. нарын тайлбарын агуулга:

Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг маргаан гэж байна. Тухайлбал Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргааныг хэлж болно. Ийм учраас энэ заалтыг санамсаргүй авч хэрэглээгүй. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэг үндсэн үүрэг нь шүүгчдийг шилж сонгох явдал. Ийм учраас энэ асуудлаараа эцсийн шийдвэр гаргаж болно. Хэрэв шүүгчдийг томилох, сахилгын арга хэмжээ авах бүхэнд шүүхэд заргалдаад байна гэвэл шүүгчийг шүүх томилох, шүүгчийг шүүх шилж сонгох асуудал болно. Тэгэхээр хараат бус шүүх бүрэлдүүлэх боломжгүй болно. Сахилгын хороо бол эцсийн шийдвэр гаргадаг байгууллага биш.

Сахилгын хорооны шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах эрхгүй гэж энэ хуульд заагаагүй. Шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэж байгаа нь нэг талаас шүүгчдийн эрх ашгийг хамгаалж байгаа хэлбэр гэж үзэх үндэстэй. Хуульдаас шүүгчийг шилж олох ажлын эхний шатны нэг бол шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэхдээ Үндсэн хуулийн шаардлагыг хангасан эсэхийг хянах үүрэгтэй байх нь зүйн хэрэг. Ерөнхийлөгчөөс шүүгчдийг томилох хугацаа нь урьдаас мэдэгддэг зүйл биш. Мөн манай улсын Үндсэн хуульд ерөнхий шүүгч, шүүгчид дипломат эрх, дархан эрх эдлүүлэхийг хориглосон зүйл байхгүй юм.

4. Холбогдох бусад этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Гадаад харилцааны яамны Гэрээ эрхийн хэлтсийн дарга С.-ийн өгсөн тодорхойлолтын агуулга:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн заалт Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ гэсэн заалт нь Үндсэн хуультай нийцэхгүй байна. Энэ нь дотоодын хууль тогтоомжийг олон улсын хууль тогтоомжоос дээгүүр тавьж байгаа асуудал. Өөрөөр хэлбэл Монгол Улс тодорхой хүмүүсээ гадаадад байхад нь дипломат эрх, дархан эрх эдлүүл гэж тулгаж байгаа хэрэг. Дипломат паспорттай хүмүүсийг гадаад улсад хүндэтгэнэ.

Харин тэр дипломат эрх ямба, дархан эрх эдлүүлэх эсэх асуудал нь тухайн улсын дотоод асуудал. Энэ тухай дипломат харилцааны тухай Венийн конвенц болон олон улсын хамгаалалтыг хүлээх хүмүүс түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шүүн цээрлүүлэх тухай конвенцод тодорхой заасан. Эдгээр конвенцид Монгол Улс нэгдэн орсон юм.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын иргэн З., Э., Ш. нарын гомдолдоо дурдсан “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байна” гэсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүгчийг томилоход тавих шаардлагыг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх үед хангасан байхыг шаардсанаараа Үндсэн хуулийн агуулгад нийцээгүй байна.

Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байх тухай Монгол Улсын шүүхийн хуулийн заалт нь нэр дэвшигч иргэнийхээ хувьд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” гэж заажээ.

Гэтэл Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд сахилгын хэрэг үүсгэх /хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох /хуулийн 49 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг/ эрхтэй болгосон нь тухайн байгууллагын үндсэн чиг үүргийг хуулийн агуулгаас өргөтгөөд зогсоогүй сахилгын хороог өөрөө байгуулж, түүний шийдвэрийг хянаж өөрчилдөг эрхийг өөртөө авснаараа шүүн таслах ажиллагаанд оролцох боломжтой болжээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчид гадаад улсад зорчих, байх хугацаандаа дипломат эрх, ямба, дархан эрх эдлэх тухай заасан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын холбогдох конвенцоор зохицуулах харилцааг үндэсний хуулиар зохицуулаад зогсохгүй ийнхүү хуульчлахдаа конвенцын агуулгыг зөрчсөн байна. Энэ нь үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнээс дээгүүр тавиад зогсоогүй бусад улсад өөрийн хуулийг биелүүлэхийг тулгах хандлагатай болжээ.

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад гомдол гаргагч иргэн Э., З. нар сахилгын хорооны шийдвэрт шүүгч шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт Үндсэн хуулийг зөрчжээ гэсэн гомдлоосоо татгалзсан тул уг асуудлыг хянан хэлэлцэх шаардлагагүй гэж үзэв.

Э., З. нарын гомдолд буй “Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан гэсэн ойлголт нь Үндсэн хуулийн Арван зурдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтын агуулгатай нийцэхгүй байна” гэсэн хүсэлт нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн талаарх үзэл баримтлалын чанартай зүйл бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай нийцэж байх тул хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах ДҮГНЭЛТ:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн “Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан Ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийнх байна” гэсэн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг, Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчдэд сахилгын хэрэг үүсгэх тухай /Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1/, сахилгын шийтгэлд гомдол гаргах, сахилгын шийтгэлийн төрөл сонгох тухай /Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3, 4/ заалтууд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг, шүүгчид нэр дэвшигчдийг бүртгэх тухай Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдлэх тухай Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчжээ.

2. Иргэн З., Э. нарын “Хуулиар шүүхэд харьяалуулсан хэрэг, маргаан” гэсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчиж байна гэсэн гомдлыг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгов.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг түүнийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 9 дүгээр тогтоолын агуулга:**

Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзсэн иргэн З., Э. нарын өргөдөлд дурдсан гомдлын зарим хэсгийг хангах үндэслэлтэй гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг, Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг, Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

2. Шүүхийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 2 дахь заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэгтэй бөгөөд гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах, шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлдэг хамтын удирдлагын орон тооны бус байгууллага юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын шийтгэл ногдуулах эрх олгоогүй байна. Шүүгч нарт сахилгын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, шийтгэл ногдуулах эрх бүхий нэгж Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тусдаа байх нь зохимжтой.

2. Монгол Улсын 1966 онд нэгдэн орсон Дипломат харилцааны тухай Венийн конвенц (Vienna Convention on Diplomatic Relations - 1961), 1988 онд нэгдэн орсон Консулын харилцааны тухай Венийн конвенц (Vienna Convention on Consular Relations - 1963)-д хэн ямар дипломат эрх ямба, дархан эрх эдлэх вэ гэдгийг тодорхой зохицуулж өгсөн байдаг.

3. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу хүчингүй болсон Шүүхийн тухай хуулийн (Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр баталсан) 64 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч гадаадад зорчих, байх хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ” гэсэн заалтыг 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч нь гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба эдэлнэ” хэмээн дахин оруулж ирсэн нь хууль тогтоогчид Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үл ойшоож, Үндсэн хуулийн шийдвэрлэсэн асуудлыг дахин сэргээсэн байна. Эс бөгөөс Цэц өөрийн шийдвэрээ эргэн харах бололцоо ч бий гэдгийг тэмдэглэе.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1994.02.04 № 01

## Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн З., Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г.

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Э.-гийн тайлбарын агуулга:

Би Цэцийн урьдах хуралдаан дээр маргалдаж байгаа асуудлаар ярьсан ба тайлбараа бичгээр гаргасан. Урд гаргасан үндэслэл санал дээрээ нэмж хэлэхэд шийтгэл оноосон сахилгын хорооны шийдвэрийг өөрчилж, хэргийг буцааж байгаа нь дотроо хэргийг хөнгөрүүлж ч болно, хүндрүүлж ч болно гэсэн хоёр утгыг хоёуланг агуулж байгаа учраас Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүрэгт харшилж байна.

Шүүгчийг огцруулахыг зөвшөөрөх, шүүгчийг огцруулахыг санал болгох /хуулийн 49 дүгээр зүйлийн 5, 52 дугаар зүйл/ эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөл эдлэхээр болсон нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4 дэх заалтыг зөрчиж байна. Энэ асуудлыг өмнөх хуралдаанд тавиагүй байсан тул нэмэлт өргөдөл гаргасан гэдгээр хэлэлцүүлж өгнө үү. Хуулийн энэ зөрчил нь өмнөх хуралдаанд тавьсан асуудалтай шууд холбоотой гэдгийг дурдаж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Энэ асуудлаар өмнөх хуралдаан дээр тодорхой ярилцсан учраас товч тайлбар хэлье. Шүүгч үүргээ биелүүлэх явцдаа гаргасан сахилгын болон ёс зүйн алдааг үндэслэн сахилгын хороо шүүгчийг халах, огцруулах асуудлыг дээш нь тавьж болно гэж үзэж байна. Мэргэжил, мэдлэг хангалтгүйгээс халах, өөрчлөх асуудлыг шийдэх механизм энэ хуульд байхгүй орхигдсон. Хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Шүүхийн ерөнхий зөвлөл сахилгын шийтгэл оногдуулж байгаа нь захиргааны үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж болох байх. Сахилгын хорооны оноосон шийтгэлийг буцаахдаа зөвхөн шийтгэлийг хөнгөрүүлж буцаана гэж ойлгож хуульд хийсэн. Энэ талаар Улсын дээд шүүх тайлбар гаргаж болно. Шүүгчид сахилгын хэрэг үүсгэхдээ аль нэг талын өргөдөл, мэдээллээр л үүсгэх болохоос шүүгч, шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд оролцож байж хэрэг үүсгэхгүй.

### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35, 39, 42, 47, 49, 52 дугаар зүйлд заасан “Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгчийн сахилгын хороог байгуулах”, “Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг ерөнхий зөвлөл батална”, “Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байна”, “Шүүхийн ерөнхий зөвлөл сахилгын хэрэг үүсгэнэ”, “Сахилгын шийтгэл ногдуулсан сахилгын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий зөвлөлд гомдол гаргаж болно”, “Ерөнхий зөвлөл хуралдаанаараа сахилгын хэргийг хянан хэлэлцээд сахилгын хорооны шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөх, хүчингүй болгож, сахилгын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх буюу хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана”, “Шүүгчээс огцруулах тухай сахилгын хорооны шийдвэрийг ерөнхий зөвлөл эс зөвшөөрвөл энэ хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан шийтгэлийн аль тохирохыг ногдуулна”, “Шүүгчээс огцруулах тухай

сахилгын хорооны шийдвэрийг ерөнхий зөвлөл зөвшөөрсөн” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн “...Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 1 дугаар дүгнэлтийн тогтоох хэсгийн Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлтэй холбоотойгоос бусад заалтууд үндэслэлтэй байна.

2. Иргэн З., Э. нарын гаргасан нэмэлт гомдлоос Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх хэмжээтэй шууд холбоотой асуудлыг энэ удаагийн хуралдаанаар нэгтгэн нэгэн мөр шийдвэрлэж, бусад асуудлыг тусгаарлахаар Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад магадлал гарган шийдвэрлэв. Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон шүүгчид сахилгын шийтгэл хэрэглэхтэй холбоотой эрх хэмжээнүүд нь Шүүхийн ерөнхий зөвлөлд Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон эрх хэмжээг хэтрүүлсэн болох нь тогтоогдож байгаа бөгөөд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35, 39, 52 дугаар зүйлүүд нь маргааныг хянан шийдвэрлэх явцад Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн бусад зүйлүүдтэй шууд уялдаатай болох нь тогтоогдов.

3. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байна гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн “Шүүгчийг шилж сонгохтой холбогдож гарсан шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийн байна” гэсэн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчиж байгаа тул хүчингүй болгосугай.

2. Шүүгчийн сахилгын хороог байгуулж, дүрмийг батлах, сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцэх, сахилгын шийтгэлийн төрөл сонгох, сахилгын хорооны шийдвэрийг хянах, сахилгын шийтгэл ногдуулах эрх хэмжээг шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дараах заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэж хүчингүй болгосугай.

а/ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 49 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтууд;

б/ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий зөвлөл”, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтаас “Ерөнхий зөвлөл”, мөн зүйлийн 2 дахь хэсгээс “Ерөнхий зөвлөл”, 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс “Ерөнхий зөвлөлийн санал болгосноор”, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалтаас “Ерөнхий зөвлөл зөвшөөрсөн” гэснийг тус тус хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн заалт Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын санал аваагүй тул уг заалтыг хүчинтэй хэвээр үлдээсүгэй.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 9 дүгээр тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

5. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуульд заасны дагуу бүх шатны шүүхийн шүүгчийг Ерөнхийлөгч томилдог учир Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэр эцсийнх бус гэж үзэх хүмүүс байдаг. Гэвч нөгөө талаас Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгоогүй хүнийг Ерөнхийлөгч томилох боломжгүй юм.

Энд нэг зүйлийг онцгойлон тэмлэглэхэд бололцоо байсаар атал Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцээгүй асуудлыг Их суудлын хуралдаанаар хэлэлцсэн нь процессын алдаа гэж үзэж байна. /Шүүхийн тухай хуулийн (2002.07.04) 49 дүгээр зүйлийн 5, 52 дугаар зүйл/

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.01.12 № 02**

### **Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Г., Л., Д., А., Ц., Б., Ц., А., О. ;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., З.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль<sup>12</sup>

- 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй”

- 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг “... шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно”

- 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг “лам, санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулж..”

- 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Сүм хийд нь ... Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно”

- 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг “Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно”

- 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно”

- 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ”

<sup>12</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 6-7-д нийтлэгдсэн

- 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна”

- 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин-номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно”

- 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Энэ хуулийн 3 дугаар 5 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна”

- 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 5000-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 15 дахь заалт “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”

- Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсэг “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд... хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ...эрх чөлөөтэй”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Л. нарын хэсэг иргэдийн мэдээллийн агуулга:**

Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганаар батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “...шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн “лам, санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулж..”, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Сүм хийд нь... Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна”, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна”, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг

хориглоно” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 15 дахь заалтын “Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”, Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд... хуулиар зохих хязгаарлал тогтоож болно”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хүнийг... шашин шүтлэгээр нь... гадуурхаж үл болно”, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн нь нэг шашныг бусдаас илүүд үзэх тухай тунхагласан, буддын болон мусульман шашнаас бусад шашныг гадуурхсан санааг агуулж байна.

2. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:

Төр, сүм хийдийн харилцааны хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7; 7 дугаар зүйлийн 6; 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь уг хуулийнхаа 1 дүгээр бүлэгтэйгээ, Үндсэн хууль, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18, 19, 26 дугаар зүйлүүдтэй бүрэн зөрчилдсөн, Христэд итгэгч иргэдийн эрх чөлөөг боогдуулсан, ялгаварлан гадуурхах үзлээр дүүрэн болсон байна. Итгэгч бидний эрхийг хамгаалсан хууль гаргахад та бүгдийг тусална гэдэгт итгэж байна.

3. Иргэн А., Ц. нарын мэдээллийн агуулга:

Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчиж байна. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтыг, мөн түүнчлэн тус хуулийн 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн захиргааны шийтгэл оногдуулах тухай заалт Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн.

4. Иргэн Б., Ц., А., О. нарын мэдээллийн агуулга:

Энэ хууль Үндсэн хууль зөрчиж бидний оюун санааны эрх чөлөөг хязгаарлалаа. Энэ хуулийн заалт нэг нь нөгөөдөө харшилж байгаа бөгөөд олон заалтаараа Үндсэн хууль зөрчсөн байна.

5. Холбогдох бусад этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

а/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн шашны асуудал эрхлэх зөвлөлийн зохицуулагч Л.-ийн өгсөн тодорхойлолтын агуулга:

Энэ хуулийн төслийг хүний шүтэх, эс шүтэх эрхийг баталгаатай хангах, төр шашны байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулах үүднээс Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан гэж үздэг. Гаднаас шашныг зохион байгуулалттайгаар оруулж байгаа нь нууц биш. Үүнийг улсынхаа үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдлийг хамгаалах үүднээс түүнийг хориглох нь зүйтэй.

б/ Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.-гийн өгсөн тодорхойлолтын агуулга:

Энэ хууль зөвхөн төр, сүм хийдийнхээ харилцааг л зохицуулсан бол бидэнд маргалдах шаардлага гарахгүй байсан. Энэ харилцаанаас хэтрээд шашны олон асуудлыг хамарсан, хүн бүрийн салшгүй эрх болох шүтэх, бишрэх эрхэд зохицуулалт, хязгаарлалт тогтоох гэж оролдсоноороо уг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байна.

в/ Монголын бурхан шашинтны төв, Гандантэгчилэн хийдээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн албан бичгийн агуулга:

Бурхны шашин туурга тусгаар Монгол Улсын түүхээс үзвэл хэд хэдэн удаа төрийн шашин байсан нь үнэн бөгөөд энэ шашинтай хамт урлаг, соёл, шинжлэх



ухаан дэлгэрсэн, олон зуун жилд уламжлагдан шүтэгдэж ирсэн шашин учраас төр нь зайлшгүй хүндэтгэх нь зүйтэй. Энэ үүднээс Төр, сүм хийдийн харилцааны хууль хүн ард, сүсэгтэн олны сэтгэл санаанд нийцэж байгаа юм.

г/ Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн оюутан О., С. нарын 70 оюутан, иргэн Л. нараас ирүүлсэн захидлын агуулга:

Буддын шашны зонхилох байр суурийг төрөөс хуулиар баталгаажуулсан нь ард түмний эв нэгдэл, түүхэн уламжлал, эрх ашигт нийцсэн, энэ хууль хувь хүний шүтэх, эс шүтэх эрхийг хязгаарлаагүй. Төр, сүм хийдийн хууль хэвээрээ үлдэнэ гэдэгт найдаж байна.

6. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., З. нарын тайлбарын агуулга:

Буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэнэ гэсэн нь Үндсэн хуулийн заалтын эх үндэстэй тунхаглалын шинжтэй заалт тул Үндсэн хууль зөрчөөгүй. Монголд хамгийн хэлмэгдсэн шашин бол буддын шашин юм. Бид тэр шашны өмнө буруугаа наманчлах учир бий. Хүн амын олонхи шүтэж байгаа тул хүндэтгэнэ гэж хэлсэн юм.

Гадаадаас шашныг зохион байгуулалттай нэвтрүүлэх нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд нөлөөлөхийг үгүйсгэхгүй. Ер нь хүний эрхийг баталгаажуулсан олон улсын пактад шүтэж, бишрэх эрх чөлөөтэй байх заалтуудыг ямар нөхцөлд хязгаарлаж болохыг заасан байдаг. Маргаж буй бусад заалтуудад хийсэн хязгаарлалтууд ч үүнтэй холбоотой юм. Бид энэ хуулийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно гэсэн заалт нь сүм хийд нь Монголд байхгүй бусад сүсэгтнүүдийн шашны номлол, сургалт, сурталчилгаа явуулах эрхийг хязгаарласан агуулга илэрхийлж байна.

Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна гэдэг заалт нь шашны байгууллагын дотоод хэрэгт төрөөс оролцож байгаа агуулгатай болжээ.

Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин-номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн харьяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно гэдэг заалт тус улсад шашин-номын зорилгоор ирснээс бусад бүх гадаадын иргэн, харьяалалгүй хүний салшгүй эрх болох шашин шүтэх, шашныг сурталчлах эрхэд халдсан агуулгатай болжээ.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7, 8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэнэ үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсгийн үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх, мөн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэх

гэсэн заалтуудтай уялдан гарсан тунхаглалын шинжтэй заалт тул Үндсэн хуультай нийцэж байна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "...шашныг гаднаас зохион байгуулалттай нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалт нь үндэсний эв нэгдэл, аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, Монголын ард түмний түүхэн уламжлал, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус үйл ажиллагаатай аливаа шашны урсгалыг Монгол Улсад зориуд нэвтрүүлэх тохиолдолд хязгаарлалт болох агуулгаараа Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 18, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн "лам, санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна" гэсэн заалт, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ", 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 5000-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулах хүрээнд багтаж байгаа асуудал тул Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас дараах ДҮГНЭЛТИЙГ ГАРГАВ:

1. Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Монгол Улс дахь буддын болон мусульман, шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно", 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна", 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 15 дахь заалтыг тус тус зөрчсөн гэж үзэв.

2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7, 8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 16 дугаар тогтоолын агуулга:**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан үзэхийг хүссэн иргэн Г., Л., Д., А., Ц., Б., Цэ., Ал., О. нарын гомдлыг хянан хэлэлцээд гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 15 дахь заалтыг тус тус зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 2 дахь заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Шашин шүтэх эс шүтэх эрх нь тухайн хүнээс салгаж үл болох жам ёсны эрх бөгөөд хэн нэгнийг шашин шүт, битгий шүт хэмээн тулгаж болдоггүй. Мөн муу шашин, сайн шашин гэж байдаггүй учир аль нэгийг нь дээгүүр тавьж, аль нэгийг нь хавчин гадуурхаж болохгүй. Харин хүний амь бие, эрүүл мэнд, цаашдаа нийгэмд аюултай шашны буруу урсгалыг хязгаарлаж, хориглож болно.

Шашин шүтэх, эс шүтэх эрхийг хязгаарласан агуулгатай дээрх заалтууд нь агуулгаараа хэсэг бүлгийн сонирхолд нийцсэн байгаа нь Үндсэн хуулийн зөрчил юм. Сүм хийд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статусыг олж авах болон авсны дараа төр тэдний дотоод хэрэгт аливаа хэлбэрээр нөлөөлөх, оролцохыг хориглодог.

Монгол Улс нь Үндсэн хуульдаа “төр нь **шашнаа** хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” хэмээн заасан байдаг. Угтаа бол “төр нь **шашныг** хүндэтгэж, ..” гэсэн бол илүү оновчтой болох байсан. Учир нь Анхдугаар Үндсэн хуулийг батлах үед буюу 1992 онд Монгол Улсад Буддын шашин зонхилж байсан ба бусад шашны урсгалууд харахан дэлгэрч амжаагүй байв (Баян-Өлгий аймгийг эс тооцвол). Үүнээс үүдэн “шашнаа” хэмээн хамаатуулсан нь “Буддын шашнаа” хүндэтгэнэ гэж ойлгогддог.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Га., З. нар тайлбартаа “... Ер нь хүний эрхийг баталгаажуулсан олон улсын пактад шүтэж, бишрэх эрх чөлөөтэй байх заалтуудыг ямар нөхцөлд хязгаарлаж болохыг заасан байдаг. Маргаж буй бусад заалтуудад хийсэн хязгаарлалтууд ч үүнтэй холбоотой юм” гэсэн байдаг. Гэтэл холбогдох олон улсын пактад шүтэж, бишрэх эрх чөлөөг хязгаарласан ямар ч заалт байдаггүй байна. Үүнээс гадна төр, шашны үйл ажиллагаа салангид байх зарчим / секулирист/ гэж байдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1994.01.12 № 03

### Улсын Их Хурлын гишүүн Т. Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Г., Г., Г., З., Э., Э., Л., Э., Б.;  
Албан тушаалтан - Улсын Их Хурлын гишүүн Тө.

#### Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:

Улсын Их Хурлын гишүүн Ц. нь аж ахуйн нэгж байгуулан, банкинд харилцах данс нээлгэн ажиллаж байна.

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Г., Г., Г., З., Э., Э., Л., Э., Б. нарын мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын гишүүн Т. нь аж ахуйн нэгж байгуулан, банкинд харилцах данс нээлгэн ажиллаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн заалтыг зөрчсөн байна. Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хурлын эрхэм гишүүн Т. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Т. нь “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн хамгаалж, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээр тангараглая” гэсэн тангаргаасаа няцсан байна.

2. Иргэн Б.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

Би Т.-г ер нь танихгүй. Миний дүү М.-ээс Т., Б. нар 3 тонн ноолуур авахаар тохиролцсон үйл ажиллагаанаас үндэслэн түүнийг мэдэх болсон. Энэ хүний мууг үзье гэсэндээ биш Улсын Их Хурлын гишүүн хүн хуульд буй зохицуулалтыг зөрчиж болох уу. Энэ нь тогтоосон журамд хэрхэн нийцэж байна вэ гэдэг асуудлыг сэдэж тавьсан юм. Энэ хүн компанийн гэрчилгээ авч банкинд данс нээлгэн бусад газартай аж ахуйн гэрээ хийсэн нь аж ахуй эрхлэн байгааг илэрхийлж байна.

3. Улсын Их Хурлын гишүүн Т.-гийн тайлбарын агуулга:

1993 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл надад ямар нэгэн аж ахуй байгаагүй. Харин Д. эзэнтэй хувиараа эрхлэх аж ахуйгаар телевизийн тоног төхөөрөмж авахуулах эцсийн зорилгоор тэдний нэр дээр 10 сая төгрөг зээлсэн. Түүнийг төлөх эцсийн хугацаа нь 1992 оны 12 дугаар сарын 20 байсан боловч түүнийг төлөх бололцоо бүрдээгүй. Энэхүү зээлийг төлөхийн тулд би 1993.01.12-нд “Монголын Чөлөөт Телевиз-1” компанийн гэрчилгээ авч 10 сая төгрөгийн дансыг өөртөө шилжүүлж авсан. 1993.01.12-ноос хойш өөрийн итгэмжилсэн хүн О.-д компанийн ажлыг хүлээлгэн өгсөн билээ. “Монголын Чөлөөт Телевиз-1” компани нь аж ахуй эрхэлж байгаагүй тул би ямар нэгэн нэмэгдэл хөлс, орлого авдаггүй. Улсын Их Хурлын хуулийн 20 дугаар зүйлийн

4-т Улсын Их Хурлын гишүүн нь өөрийн ажилд үл хамаарах цалинтай ажил хавсарч үл болохыг заасан. Энэ компанийн ажлыг хавсрав гээд ямар ч цалин авдаггүй билээ. Энэ утгаараа би Үндсэн хууль, бусад хуулийн зөрчөөгүй гэж боддог. Надтай холбоотой ямар нэгэн маргаан гараагүй байхад Үндсэн хуулийн цэцээр асуудал хэлэлцэгдэх үү гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудад тулгуурлан үзэх, Улсын Их Хурлын гишүүн Тө.-тэй холбоотой энэ зүйлийг улс төржүүлж үзэхгүй байхыг хүснэ. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Улсын Их Хурлын хуулиар тодруулан тайлбарласан. Энэ талаар Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т тодорхой заасан байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлын гишүүн Т. нь 1993 оны 1 дүгээр сарын 12-нд 34/17 улсын бүртгэлтэй, 726745 регистртэй, 528.0 мянган төгрөгийн дүрмийн сантай, хоёр гишүүнтэй, Монгол даатгал банкинд төгрөгийн 330654, валютын 151254 дугаар данстай телевизийн нэвтрүүлэг бэлтгэх, солилцох, зуучлах, баримтат кино хийх, худалдах үйл ажиллагаа бүхий бүрэн бус хариуцлагатай “Монголын Чөлөөт Телевиз-1” компани байгуулан ажиллаж ирсэн болох нь Сонгинохайрхан дүүргийн болон Улаанбаатар хотын татварын албанд байгаа аж ахуйн нэгжийн бүртгэлийн материал, дээрх албанаас ирүүлсэн тодорхойлолт, Улаанбаатар хотын шүүхийн 1993 оны 142 дугаар шийдвэр, Улсын дээд шүүхийн мөн оны 52 дугаар магадлал, энэхүү маргааныг хянан шалгах явцад цугларсан бусад баримтуудаар тогтоогджээ.

Т. нь “Монголын Чөлөөт Телевиз-1” компанид ажиллаж байсан нь Улсын Их Хурлын гишүүний үүрэгт ажилтай ямар нэгэн хамааралгүй ба Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан Г., Г., Г., З., Э., Э., Л., Э., Б. нарын гомдлыг хүлээн авах нь зүйтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Ц. овогтой Т. нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” тухай заалтыг зөрчжээ гэсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж байна.

### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийн хугацаандаа хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, ялангуяа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохгүй. Монгол Улсын иргэн нь Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөхөөсөө өмнө хавсарч үл болох аливаа ажил, албан тушаалаасаа түдгэлзсэн, гарсан байх учиртай. Хуулиар Улсын Их Хурлын гишүүний хавсарч болох ажил, албан тушаалыг тогтоон өгч болох боловч тэр нь Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасан гишүүний бүрэн эрхийн хүрээнээс хальсан байж болохгүй.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцээс “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх” талаар гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцдэггүй. Өөрөөр хэлбэл дээрх асуудлаар гарсан Цэцийн дүгнэлт эцсийн шийдвэр болдог.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1994.02.23 № 04

### Улсын Их Хурлын гишүүн Э., Г., З. нар Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д., Б., Т.;  
Албан тушаалтан - Улсын Их Хурлын гишүүн Э., Г., З.

#### Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:

Улсын Их хурлын гишүүн Г., Э. нар нам, холбооны даргын ажил, албыг давхар хашиж байна, мөн Улсын Их Хурлын гишүүн З. Монголын Үндэсний Ардчилсан Намын дэргэдэх Стратеги судлалын төвийн захирал, Ардчилал-Таймс сонинд ажиллаж байна.

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Д., Б., Т. нарын мэдээллийн агуулга:

Улсын Их хурлын гишүүн Э. Монголын ардчилсан холбооны даргаар ажиллаж байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна. Улсын Их хурлын гишүүн Г., Э. нар нам, холбооны даргын ажил, албыг давхар хашиж байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг ноцтой зөрчиж байна. Улсын Их Хурлын гишүүн Э. Монголын ардчилсан холбооны дарга, Монголын ардын аж ахуйтны холбооны ерөнхийлөгчөөр, З. МҮАН-ын дэргэдэх Стратеги судлалын төвийн захирал, Ардчилал таймс сонинд ажилладаг нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

2. Улсын Их Хурлын гишүүн Э.-гийн тайлбарын агуулга:

Миний бие 1993 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Монголын ардчилсан холбооны дэд зохицуулагчийн шийдвэрийн дагуу Улсын Их Хурлын гишүүний цалингийн нэмэгдлийг мөнгөний ханш, байгууллагын цалингийн сүлжээний өөрчлөлтийн дагуу Монголын ардчилсан холбооноос он дуустал надад өгч байсан. 1994 оноос нэмэгдэл авахаа больсон. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн Үндсэн хуулийн заалт нь Улсын Их Хурлын гишүүний үүрэгт нь хамаарах ажил, албан тушаалыг цалинтай ч, цалингүй ч ямар нэг хэлбэрээр хавсарч болохыг зөвшөөрсөн гэж үзэж байгаа учир хууль тогтоох, ард түмний элч байх үүргээ үр бүтээлтэй хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц Монголын ардчилсан холбооны даргын ажил хавсарч байгаагаа Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн хууль тогтооход оролцох эрхээ үр бүтээлтэй хэрэгжүүлэх, ард түмний элч байх үүргээ гүйцэтгэхэд тус дэм болохуйц улс төр, олон нийтийн болон судалгааны байгууллагад сонгууль үүрэг гүйцэтгэх, орон тооны бус ажил, албан тушаал хашихыг Үндсэн хуулийн тухайн заалтаар хориглоогүй учраас миний бие Монголын ардчилсан холбооны даргын ажил хавсарч байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### 3. Улсын Их Хурлын гишүүн Г.-гийн тайлбарын агуулга:

Парламентын суудлыг улс төрийн намын тэргүүний ажилтай хослуулж буй нь Үндсэн хуулийг зөрчиж байгаа хэрэг биш, харин намуудын баримтлах ёстой хэв ёс гэж үзэж байна. Намын даргын үүрэгт ажлыг Улсын Их Хурлын гишүүний ажилтай хослуулан гүйцэтгэж байгааг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэхгүй байна. Учир нь манай намын хувьд гэвэл улс орны хувь заяанд зарчмын ач холбогдолтой аль ч асуудлаар нэгдмэл байр суурьтай байдгийн илрэл нь Парламентын суудлыг намын удирдлагын суудалтай хослуулж буй явдал юм.

### 4. Улсын Их Хурлын гишүүн З.-гийн тайлбарын агуулга:

Стратеги судалгааны төв гэж албан ёсоор бүртгэлтэй байгууллага байхгүй. Гэвч энэ төвийн нэрээр төрийн зүтгэлтэн, судлаачийн хувьд хууль тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд холбоотой хэд хэдэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Одоо ч ийм юм хийхээр төлөвлөж байна.

### 5. Холбогдох этгээдээс ирүүсэн тайлбарын агуулга:

а/ МҮАН-ын ерөнхий нягтлан бодогч Д.-гийн өгсөн тодорхойлолтыг агуулга:

Г. нь МҮАН байгуулагдсан үеэс тэргүүнээр сонгогдон ажиллаж байгаа нь үнэн. 1993 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн МҮАН-ын Ерөнхий зөвлөлийн тогтоолын дагуу тэргүүний цалингийн 20 хувийн нэмэгдэл 2500 төгрөгийг мөн оны 7 дугаар сар хүртэл авсан. Түүнээс хойш цалин аваагүй.

б/ Монголын ардчилсан холбооны ерөнхийлөгч Б.-гийн өгсөн тодорхойлолтын агуулга:

Э. 1993 оны 11 дүгээр сарын 11-нд Ерөнхий зохицуулах зөвлөлийн шийдвэрээр Монголын ардчилсан холбооны даргаар сонгогдон ажиллаж байна. Монголын ардчилсан холбооноос нэмэгдэл авдаг байсан. 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс өгөхийг зогсоосон захирамж гаргасан. Э. Монголын ардчилсан холбооны даргын ажил хийж байгаа нь Г.-гийнхтэй адил юм.

в/ “Ардчилал таймс” сонины сурвалжлагч Б.-гийн өгсөн тодорхойлолтын агуулга:

Манай сонины газар бол 1993 оны 8 дугаар сараас байгуулагдсан бие даасан чөлөөт хэвлэл юм. З. манай сонинг санаачлагчдын нэг болохоос биш энд ямар нэг ажил эрхэлдэггүй.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

МҮАН бол хууль ёсоор бүртгэгдсэн, намын тэргүүн нь намын дээд удирдлагыг гүйцэтгэж намыг төлөөлдөг байна. Улсын Их Хуралд суудал бүхий МҮАН-ын тэргүүний албан тушаал нь Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь харшлах зүйлгүй байна. Улсын Их Хурлын гишүүн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулахын тулд Парламентын үйл ажиллагаатай холбоо бүхий асуудлаар судалгаа, шинжилгээний чанартай байгууллагыг ашиглан онол практикийн бага хурал, семинар зохион байгуулах зэрэг ажил хийж байгаа нь Улсын Их Хурлын гишүүний үүрэгт хамаарч байна.

Монголын ардчилсан холбоо нь Монгол Улсын Улс төрийн намуудын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэм хэмжээгээр нэгэнт хуульчлагдсан улс төрийн үйл ажиллагаа явуулдаг улс төр олон нийтийн байгууллага тул уг байгууллагын даргын албан тушаал хаших нь улс төрийн үйл ажиллагаа учраас Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь харшлахгүй байна.

Э. Улсын Их Хурлын гишүүн болохоосоо өмнө 1991 оны 11 дүгээр сарын 1-нд Монголын ардын аж ахуйтны холбооны хоёрдугаар хурал дээр өөрөө татгалзаж уг холбооны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Г. МҮАН-ын тэргүүний албан тушаал хашиж байгаа болон Улсын Их Хурлын гишүүн З. Стратеги судлалын төвийг удирдаж байгаа бөгөөд “Ардчилал таймс” сониныг үүсгэн байгуулалцсан, Улсын Их Хурлын гишүүн Э. Монголын ардчилсан холбооны даргын албан тушаал хашиж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж байна.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 3 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 6 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙ ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.04.15 № 05**

### **Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н., В.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай<sup>13</sup> хууль

- 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт “Багануур, Багахангай дүүргийн шүүх”
- 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт “Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх”
- 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалт “Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх”
- 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт “Хан-Уул, Туул дүүргийн шүүх”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно”

<sup>13</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 3-т нийтлэгдсэн



## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгүүдэд “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Монгол Улсын дээд шүүх, аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ” гэж заасан. Гэтэл дүүргүүдийн шүүхийг байгуулахдаа нийслэлд 12 дүүрэг байхад 8 дүүргийн шүүх байгуулж, 4-ийг нь дүүрэг дундын шүүх /Хан-Уул, Туул дүүргийн, Баянзүрх, Гачуурт дүүргийн, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн, Багануур, Багахангай дүүргийн/ болгон байгуулжээ. Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд “дүүргийн шүүх” гэж заасан байтал Шүүх байгуулах тухай хуулиар “дүүрэг дундын шүүх” байгуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна. Монгол Улсын 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар байгуулсан “дүүрэг дундын” шүүхүүдийн тамга, тэмдэг, хаяг, албан бичгийн маягт нь хүртэл дүүрэг дундын шүүхийн хэлбэрээр хийгдэж одоо ашиглагдаж байгаа ба мөн Монгол Улсын нэрийн өмнөөс гаргаж буй шийдвэр, тогтоол, магадлалууд нь “дүүрэг дундын” шүүх маягтайгаар бичигдэж байгаа болно. Үнэхээр “дүүрэг дундын” шүүх байгуулах шаардлагатай байсан юм бол Үндсэн хуулийн заалтыг өөрчилж дээрх дүүргүүдийн Засаг дарга нарыг “дүүрэг дундын” Засаг дарга болгон томилох шаардлага гарах ёстой.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н., В. нарын тайлбарын агуулга:**

Улсын Их Хурал дүүрэг дундын шүүх байгуулаагүй бөгөөд хуучин ажиллаж байсан хэсэг, район /нийслэлийн/, орон нутгийн хотын шүүхийг сум болон сум дундын, дүүргийн шүүх болгон өөрчлөн байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосон юм. Ингэхдээ хоёр дүүргийг нэг шүүхэд /анхан шатны шүүхийн эрхтэй/ харьяалуулж, тэдгээрийг “Багануур, Багахангай дүүргийн шүүх” гэх мэтээр нэрлэсэн болно. Үүнийг өргөдөл гаргагч дүүрэг дундын шүүх байгуулсан гэж буруу ойлгосон бололтой.

Шүүх байгуулах тухай хууль болон шүүгчийн орон тоо батлах тухай Улсын Их хурлын 1993 оны 45 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтад чухамхүү “дүүргийн шүүх” гэсэн нэр томъёо хэрэглэсэн бөгөөд тэнд “дүүрэг дундын шүүх” гэсэн үг үсэг байхгүй. Үндсэн хуульд зааснаар сум, дүүрэг нь ижил эрхтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн үндсэн нэгжүүд бөгөөд тэрээр сум дундын шүүх байгуулж болохыг заасан юм. Энэ нь хоёр буюу хэд хэдэн дүүргийг нэг шүүх харьяалан ажиллах боломжийг хаагаагүй харин ч агуулгаараа зөвшөөрч байгаа хэрэг гэж үзэж байна. Шүүхийн харьяалал нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт захирагдах ёсгүй бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дагуулан шүүх байгуулах тухай хуулийн заалт байхгүйг дурдах нь зүйтэй.

Иймд Шүүх байгуулах тухай хуулийн дүүргийн шүүх байгуулах заалт нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг дагуулан байгуулах шаардлагагүй, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал хэргийн байдал, байгууллагын тоо зэргийг харгалзана. Дэлхий нийтэд шүүхүүдийг засаг захиргааны нэгжээр биш бүсчилж байгуулдаг. Үүнийг удирдлага болгосон. Ер нь үйл ажиллагааны харьяаллаар тойргийн зарчмаар шүүх байгуулсан. Шүүхийн нэр нь Үндсэн хуульд заасан нэрээрээ дүүргийн шүүх байгаа. Сум, дүүрэг хоёр ижил эрхтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж учир сум дундын шүүх байж болох юм чинь дүүрэг дундын шүүх байж болно.

### **3. Холбогдох байгууллага, этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:**

а/ Шүүх байгуулах, тэдгээрийн байршил, харьяалал, шүүгчийн орон тоог тогтоох талаар гарсан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 1993 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн дүгнэлтийн агуулга:

Шүүхийн ерөнхий зөвлөл нь Улаанбаатар хотын Жаргалант дүүргийг Сонгинохайрхан дүүргийн шүүхэд, Туул дүүргийг Хан-Уул дүүргийн шүүхэд, Багахангай дүүргийг Багануур дүүргийн шүүхэд тус тус харьяалуулан ажиллуулж орон тоо, төсөв зардал хэмнэх санал оруулсныг зөвшөөрөхгүй байна. Хэрэв ийм байдлаар шийдвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дүгээр заалтуудыг зөрчих болно. Иймд нийслэлийн 12 дүүрэгт тус бүр анхан шатны шүүх байгуулах нь зүйтэй гэж үзэв. Анхан шатны шүүхүүдийг байгуулахад одоогийн орон тооны бололцоо болон улс орны эдийн засгийн байдлыг харгалзахгүйгээр зайлшгүй шаардлагатай газруудад шүүхийг байгуулах нь зүйтэй ба энд Засаг дарга нарын саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

б/ Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.-гийн бичгээр өгсөн тайлбарын агуулга:

Нийслэлийн зарим шүүхийг хоёр дүүргийн шүүх байхаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулж Монгол Улсын Их Хуралд оруулахдаа Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх байгуулахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хэрэг, маргааны гаралтын түвшинг харгалзан үзнэ” гэж заасныг удирдлага болгосон юм. Нийслэлийн дүүргийн зарим шүүхийг хоёр дүүрэгт байгуулснаар Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийг зөрчөөгүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Шүүх байгуулах тухай 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын хуулиар Багануур, Багахангай дүүргүүдийн дунд, Баянзүрх, Гачуурт дүүргүүдийн дунд, Хан-Уул, Туул дүүргүүдийн дунд, Сонгинохайрхан, Жаргалт дүүргүүдийн дунд тус бүр нэг шүүх байгуулсан нь нэрийн хувьд “дүүргийн” гэж томъёологдсон боловч үнэн хэрэг дээрээ хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан агуулгыг илэрхийлж байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дүүрэг бүр өөрийн шүүхтэй байх тухай заалтыг зөрчжээ. Энэ талаар иргэн Б.-гийн Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан гомдлыг хүлээж авах үндэстэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. Шүүх байгуулах тухай 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх, Хан-Уул, Туул дүүргийн шүүх” гэсэн 1, 3, 5, 7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 5 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 52 дугаар тогтоолын агуулга:**

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Багануур, Багахангай дүүргийн шүүх, Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх, Хан-Уул, Туул дүүргийн шүүх” гэсэн 1, 3, 5, 7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан хэлэлцээд гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**Тэмдэглэл:**

Үндсэн хуулиар шүүхийн тогтолцоог:

1. Улсын дээд шүүх
2. аймгийн шүүх, нийслэлийн шүүх
3. сум буюу сум дундын, дүүргийн шүүх хэмээн тогтоосон байна.

Гэтэл Улсын Их Хурал төсөв мөнгө хэмнэх зорилгоор 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Шүүх байгуулах тухай” хуулиар хоёр дүүргийн дунд 1 шүүх буюу “дүүрэг дундын” шүүхийг байгуулж байсан байна.

1995 оны 2 дугаар сард Нийслэлийн Гачуурт, Жаргалант, Туул дүүргийг татан буулгасан бөгөөд:

Гачуурт дүүргийг - Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо  
Жаргалант дүүргийг - Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо  
Туул дүүргийг - Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо болгосон байна.

Сонирхуулахад, Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар хурал, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаас “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай дүрэм”-ийг баталж 5 аймаг, 3 хот, 71 хошуунд анхан шатны шүүхийг байгуулах тухай шийдвэр гарч байжээ. Мөн Засгийн газрын 1926 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 48 дугаар хурлаас Улсын дээд шүүхийг байгуулж, 1927 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажиллуулахаар тогтоосон байна.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1994.11.09 № 02**

**Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалтууд  
Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай харшилж  
байгаа эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н.

**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал аваагүй атлаа 1994 оны 7 дугаар сарын 8-нд Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулж дүүргийн шүүхийг дугаарлах зохицуулалт буй болгожээ. Ер нь Цэцийн дүгнэлтийг аваагүй нь орон тоо,

төсөв хэмнэх, нийслэлд дүүргүүдийг байгуулахдаа хүн ам, нутаг дэвсгэрийн байршлыг харгалзаагүй гэсэнтэй холбоотой байна.

Ерөнхийлөгч О. хүний эрхийг хамгаалах болон шүүхийн ажилд төсөв зарцуулахад гар татаж болохгүй гэснийг Улсын Их Хурал анхаарсангүй. Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны хууль мөн чанартаа Үндсэн хуулийг зөрчсөн бөгөөд энэ нь:

а/ Засаг захиргааны нэгж болох дүүргүүд дунд шүүх ажиллах мөн чанар нь хэвээр байгаа.

б/ Үндсэн хуулийн заалтаар “дүүргийн шүүх” гэсэн агуулга байгаагаар тайлбарлагдана.

Иймд Улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 14-нд гаргасан Шүүх байгуулах тухай хууль, мөн хуульд өөрчлөлт оруулах 1994 оны 7 дугаар сарын 8-ны хуулиуд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байгааг хянан үзэж зохих шийдвэр гаргахыг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:

Шүүх байгуулах нэгэн үндэслэл бол тойргийн зарчим болно. Энэ зарчмын дагуу Улсын Их Хурал шүүх байгуулах хуульд өөрчлөлт оруулан нийслэлийн дүүргийн шүүхүүдийг тойргийн системээр байгуулсан. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж байх үед Цэцийн хуралдаан даргалсан Б. Улаанбаатар хотод шүүхийг тойргоор байгуулах тухай үзэл ярьсан. Энэ бол шүүх байгуулах асуудлаар Улсын Их Хурлын үзэл бодолтой нийцсэн үйл ажиллагаа мөн. Иймээс Цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй. Шүүх байгуулах тухай хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Улсын Их Хурлаас баталсан хуулиуд нь Үндсэн хуультай зөрчилдөөгүй байна.

**Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Шүүх байгуулах тухай Монгол Улсын 1993 оны хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1, 3, 5, 7 дугаар заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэж үзсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэсэн Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны 52 дугаар тогтоол үндэслэлгүй байх тул хүчингүй болгох шаардлагатай байна.

2. Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хууль Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай зөрчсөн эсэх асуудлаар Цэцийн хуралдаанд оролцсон нийт гишүүдийн гуравны хоёрын санал аваагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол нь гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Хуралдааны явцад “Сум, дүүрэг нь хоёулаа анхан шатны шүүхийн нэгж. Иймд сум дундын шүүх гэж байдаг тул дүүрэг дундын шүүх гэж байх нь Үндсэн хуулийн зөрчил биш юм” гэсэн логик гарч байсан. Гэхдээ Үндсэн хууль болон Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэнэ гэсэн ойлголт байдаггүй. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэхээр тодорхой зааж өгсөн бөгөөд үүнтэй холбоотой дүүрэг дундын шүүх гэсэн заалтыг оруулаагүй. Үндсэн хуулийн үзэл санаа нь дүүрэг болгон шүүхтэй байхаар ойлгогддог.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1994.06.15 № 06

## Улсын Их Хурлын гишүүн З. Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., О.;  
Албан тушаалтан - Улсын Их Хурлын гишүүн З.

### Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:

Улсын Их Хурлын гишүүн З. нь “Стратеги судалгааны төв” хэмээх олон нийтийн байгууллага байгуулан Худалдаа хөгжлийн банкинд валютын, Монгол даатгал банкинд төгрөгийн данс нээлгэн үйл ажиллагаа явуулж байна.

### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй”

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

#### 1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын гишүүн З. нь “Стратеги судалгааны төв хэмээх” олон нийтийн байгууллага байгуулан Худалдаа хөгжлийн банкинд валютын 151584, Монгол даатгал банкинд төгрөгийн 305033 данс нээлгэн үйл ажиллагаа явуулжээ. Энэ төв Хууль зүйн яаманд бүртгэлгүй боловч тамга тэмдэгтэй болж, банкинд данс нээлгэн аж ахуйн ажиллагаа явуулсан нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөд зогссонгүй цаашид аж ахуйн нэгжийн хууль, бусад хуулиудыг зөрчжээ. Мөн тамга, тэмдгийн дүрэм, заавар зөрчсөн нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул эдгээр байдлуудыг шалгаж өгөхийг хүсье. Улсын Их Хурлын гишүүн З. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийг зөрчсөн эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 2 дугаар сарын 23-ны хуралдаанаар дутуу хянаж шийдвэрлэсэн.

#### 2. Иргэн О.-гийн мэдээллийн агуулга:

а/ З. Нь Стратеги судалгааны төвийн захирлын албан тушаалыг хашиж байгааг;  
б/ Ардчилал таймс, Экспресс таймс, Нөлөөгүй толь сонины үйл ажиллагааг;  
в/ Стратеги судалгааны төвийн 207034, 305033 дансны мөнгөний тооцооны баримтуудад нэгдүгээр гарын үсгийг З., хоёрдугаар гарын үсгийг Бя. зурсан зэргийг, мөн З. нь УБЗ 00-99 дугаарын мерседес машины татварыг төлсөн эсэхийг;  
г/ З. нь сонгогчдын итгэл найдварыг хөсөрдүүлэн Улсын Их Хурлын чуулганыг /1372 цаг/ тасалсан асуудлыг шалгаж өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын хэд хэдэн гишүүн Үндсэн хууль, Монгол Улсын бусад хуулиудыг зөрчсөн, Улсын Их Хурлын хуралдаан тасалсан асуудал бий. Энэ талаар Улсын Их Хуралд хэд хэдэн удаа бичиж зохих санал хүсэлт гаргасан боловч шийдвэрлэж өгөөгүй. Иймд хуулиа дээдлэн ажиллах Цэцийн гишүүдэд хандаж асуудлыг шалгаж өгөхийг хүссэн болно. Улсын Их Хурлын гишүүн Э. Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаанд холбогдолгүй Монголын ардчилсан холбооны даргын үүрэг гүйцэтгэсэн, Улсын Их Хурлын гишүүний итгэлийг алдаж чуулган /429 цаг/ тасалсан, ардын аж ахуйтны холбооны зориулалттай 1.3 сая төгрөгийг хууль бусаар зарцуулсан, мөн холбооны шугамаар Ло овогт Зу.-тай хэлцэл хийсэн асуудлыг шалгаж өгнө үү.

### 3. Улсын Их Хурлын гишүүн З.-гийн тайлбарын агуулга:

Стратеги судалгааны төвийг 1991 онд Монголын ардчилсан холбоо, МҮЭ-ийн Төв Зөвлөл хамтран байгуулсан бөгөөд энэ үед тус байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлага байгаагүй. Энэ тухай хууль тогтоомж байсангүй. Одоо ч байхгүй байна. Энэ төв санхүүжилттэй тул үйл ажиллагаа нь зогссон. Би Улсын Их Хурлын гишүүний хувьд өөрийн албатай бөгөөд тэр нь судалгаа шинжилгээний ажил хийж, эрдэм шинжилгээний хурал, маргааныг удаа дараалан зохион байгуулж ирэв. Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн өмнөх хуралдааны материалд тодорхой бий. Тус ажлын алба нь дээрх ажиллагааг явуулахдаа Стратеги судалгааны төвийн нэрийг ашигладаг юм. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн ажлын аппараттай байж болохыг ямар ч хуулиар хориглоогүй болохыг дурдъя. Аливаа байгууллага үйл ажиллагаа явуулахын тулд данс, тэмдэгтэй байх нь ердийн үзэгдэл ба данс, тэмдэгтэй бол аж ахуйн ажиллагаа явуулах ёстой гэсэн мэдээлэл гаргагчийн санааг ойлгохгүй байна.

### 4. Маргааныг шалгах явцад тогтоосон нөхцөл байдал:

а/ Маргааныг шалгах ажиллагааны явцад Стратеги судалгааны төвийн аж ахуйн гүйлгээний дансны талаар лавлагаа авахад уг төв нь Худалдаа хөгжлийн банкинд төгрөгийн 280007 /одоо 206001/ данстай байсан ба 1991-1992 онд 1998448=00 төгрөгийн орлого орж, 1995259 төгрөг 80 мөнгөний зарлага гарч одоо 3188 төгрөг 20 мөнгөний үлдэгдэлтэй байна.

б/ Тус банкинд валютын 151584 /одоо 286047/ дансанд 1992 оны 4 дүгээр сарын 16-нд 3000 ам.доллар орсон ба түүнийг мөн оны 5 дугаар сарын 13-нд авч одоо 5 доллар 75 центийн үлдэгдэлтэй байна. Тус төв 1991 оны 8 дугаар сард Худалдаа хөгжлийн банкнаас валютын зээл авч төлөөгүй учир шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

в/ Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүх 1993 оны 12 дугаар сарын 21-нд 867 дугаар шийдвэр гарган Стратеги судалгааны төвөөс 5187 доллар 20 цент, Улсын тэмдгийн хураамж 102447 төгрөгийн хамт гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

г/ Стратеги судалгааны төв нь 1992 оны 11 дүгээр сарын 17-нд Монгол даатгал банкинд 305033 /шинэ 207034/ данс нээлгэн нийтдээ 51 удаа гүйлгээ хийж орлого 9710821 төгрөг 25 мөнгө, зарлага 9689095 төгрөг 72 мөнгөөр тодорхойлогдсон байна.

д/ Стратеги судалгааны төв нь 1992 оны 4 дүгээр сарын 16-нд Төв ази банкнаас 900000 төгрөгийг 3 сарын хугацаатайгаар зээлэн авч 1993 оны 3 дугаар сарын 30-нд эгүүлэн тушаасан байна.

е/ Монгол Улсын Хууль зүйн яаманд буй бүртгэлээс үзэхэд Ардчилал таймс сонин 1993 оны 8 дугаар сарын 9-нд, Экспресс таймс сонин 1994 оны 6 дугаар сарын 3-нд бүртгүүлсэн бөгөөд Нөлөөгүй толь гэдэг сонин бүртгэлгүй байна. Эдгээр сонин эрхлэгчээр өөр хүмүүс ажиллаж байгаа тул 3-тэй холбогдолгүй байна.

ё/ Улсын Их Хурлын гишүүн З.-гийн санаачлан удирдаж буй Стратеги судалгааны төвийн Монгол даатгал банкин дахь мөнгөн гүйлгээ нь ашиг олох зорилгогүй бөгөөд энэ нь аль ч байгууллагад байж болох үйл ажиллагаа гэдгийг Монгол даатгал банкны ня-бо Н., Хоршоодын холбооны төв зөвлөлийн ажилтан М. нар тодорхойлсон байна.

### 5. Холбогдох этгээдээс ирүүлсэн тодорхойлолтын агуулга:

а/ Сангийн яамны ажилтан Л., О. нарын өгсөн тодорхойлолтын агуулга:

305033 дугаар дансны үйл ажиллагааг бичсэн түүврээс үзэхэд аж ахуйн үйл ажиллагаа явуулсан байна. Тухайлбал бусдаас зээл авсан, бусдад зээл олгосон, цалин, шагналд зарцуулсан, хоорондын тооцоогоор аж ахуйн ажиллагаа явуулсан, материал, валют худалдан авсан, хандив өргөсөн, худалдааны татвар төлсөн зэрэг нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсний илрэл юм. Хүн амын орлогоос хураалгасан татварыг төсвийн орлогод оруулах, олгосон цалингийн 13.5 хувьтай тэнцэх хэмжээний нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх журмууд зөрчигдсөн байна.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Нэг. Улсын Их Хурлын гишүүн З.-тэй холбогдох маргааны талаар:

Иргэн Б., О. нарын гомдлын дагуу шинэ нөхцөл байдал илэрсэнтэй холбоотойгоор явуулсан шалгалтаар Улсын Их Хурлын гишүүн З. нь Стратеги судалгааны төвийг үүсгэн байгуулсан, тэр нь Монгол даатгал банкинд төгрөгийн 305033, Худалдаа хөгжлийн банкинд валютын 151584, төгрөгийн 280007 данстай, түүгээр зохих гүйлгээ хийдэг болох нь тогтоогдов. Стратеги судалгааны төв нь Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаанд зохих нөлөө бүхий судалгааны байгууллага бөгөөд байгуулагдсанаас хойш Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, хүний эрх, шүүх эрх мэдэл, нутгийн өөрөө удирдах ёс гэх мэт асуудлаар онол арга зүйн хурал, семинар, ярилцлага зохион байгуулах, мэргэжилтнүүд ажиллуулах, олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоох гэх мэт Улсын Их Хурлын гишүүний үүрэгт шууд хамаарах үр нөлөө бүхий ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Гэхдээ Стратеги судалгааны төв нь судалгааны ажлын хамт аж ахуйн үйл ажиллагаа зэрэгцүүлэн явуулж иржээ. Үүнийг Монгол даатгал банкинд буй 305033 дансны гүйлгээ, тэдгээрийн зорилго, чиглэлээр, стратеги судалгааны төв нь Худалдаа хөгжлийн банк, Төв ази банкнаас валют, төгрөгийн зээлийн гэрээ хийж байсан, тэдгээрийн зарим үүргүүд биелэгдэхгүй өнөөг хүрсэн, банкны гүйлгээнүүд нь стратеги судалгааны төвийн үйл ажиллагааны чиглэлтэй тэр бүр нийцэхгүй байгаагаар тодорхойлогдож байна.

Энэ нь гомдол гаргагчдын тайлбар, Монгол даатгал банкнаас хийгдсэн гүйлгээний шинж, төрөл, стратеги судалгааны төвөөс банкны байгууллагуудтай валют, төгрөг авахаар байгуулсан гэрээ, аж ахуйн маргаанд тал болж оролцож эд хөрөнгийн хариуцлага хүлээх болсон зэрэг баримтуудаар тогтоогдов.

З. нь стратеги судалгааны төвийг удирдахдаа аж ахуйн харилцаанд оролцож байгаа нь Улсын Их Хурлын гишүүний үүрэгт шууд хамаарахгүй байна. Энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийн 3.той холбоотой хэсгийг хүчингүй болгон зохих өөрчлөлт оруулах үндэслэлтэй байна.

Гомдол гаргагч Б., О. нарын гомдолд дурдсан “Улсын Их Хурлын гишүүн З. албан татварын хууль зөрчсөн, Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй, сонгогчдын итгэл найдварыг алдагдуулан чуулганы хуралдаан тасалсан гэх мэтийн шаардлагууд” нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хамаарах маргаан биш тул хүлээн авч хангах үндэслэлгүй байна.

Хоёр. Э.-д холбогдох маргааны талаар:

Э. нь Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 2-ны 41 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын гишүүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн байх тул энэ талаархи маргааныг хянан хэлэлцэж Цэцийн дүгнэлт гаргах хууль зүйн үндэслэлгүй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн З. нь Стратеги судалгааны төвийн захирлаар ажиллахдаа аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчжээ гэсэн дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийн 3.-д холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3. Гомдол гаргагч Б., О. нарын гомдолд буй “Улсын Их Хурлын гишүүн З. нь албан татварын хууль зөрчсөн, Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй. Ардчилал таймс, Экспресс таймс, Нөлөөгүй толь сонинуудыг удирдан гаргадаг, сонгогчдын итгэл найдварыг алдагдуулан чуулганы хуралдаан тасалсан зэргийг магадлан шалгахыг хүссэн” зэрэг шаардлагуудыг хэрэгсэхгүй болгосугай.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуульд Цэцийн дүгнэлтийг дүгнэлтээр хүчингүй болгох талаар шууд зохицуулалт байдаггүй. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг тогтоолоор буюу Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Цэц Их Суудлын хуралдаанаар уг асуудлыг дахин хянан шийдвэрлэж хүчингүй болгож болох юм.

Үндсэн хуулийн цэцийн тогтоол “эцсийн” шийдвэр гэдгийг бид мэднэ. Гэтэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас, эсхүл Цэцийн гишүүдийн олонхи санал гаргаж уг маргааныг дахин эхнээс нь хянан шийдвэрлэх үед “эцсийн шийдвэр”-т гар хүрч, дахин өөрчилж болно.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.07.25 № 07**

**Монгол Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн,  
Прокурорын байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн  
тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Албан тушаалтан - Улсын ерөнхий прокурор Г.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г.

#### **Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:**

Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж, иргэний өргөдөлд хариу өгөөгүй, хэрэг үүсгэн прокурорт шилжүүлсэн байна

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 4 дугаар сарын 23-ны өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хууль<sup>14</sup>

- 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт “хэрэг бүртгэх мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох”

<sup>14</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 3-т нийтлэгдсэн



- 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

- Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын дагуу намайг эрүүгийн хариуцлагад татсан үндэслэлийг шалгуулах болон үндэслэлгүй гаргасан шийдвэрээ хүчингүй болгох асуудлыг Улсын ерөнхий прокурор Г.-д 1994 оны 5 дугаар сарын 27-нд тавьсан юм. Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж, надад хариу өгөхгүйгээр миний тавьсан асуудлыг хэрэг үүсгэн прокурорт шилжүүлснээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэн миний эрхийг зөрчсөн гэж үзэж Улсын ерөнхий прокурорын үйлдэлд зохих үнэлэлт өгөхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсч байна.

Миний эсрэг үүсгэсэн үндэслэлгүй хэргийг Прокурорын байгууллага санаачлан мөрдөн байцаах ажиллагааг прокурор А. явуулах оролдлого хийлээ. Энэ нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчсөнтэй холбоотой гэж үзэж байна. Энэ асуудлыг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

Монгол Улсын ерөнхий прокурор өөрт нь өргөн барьсан баримт материалаас прокурорууд мөрдөн байцаалт явуулж байгааг болон тэр нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байгааг мэдэж байсан гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улсын ерөнхий прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчсөн тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхийг хүсье.

Улсын ерөнхий прокурор 1993 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/46 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан “Алт, дилерийн хэрэг” гэдгийг мөрдөх үүрэг өгч, ийм шийдвэр гаргаснаараа Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчиж, өөртөө мөрдөн байцаах бүтэц бий болгосон. Прокурор А. мөрдөн байцаах ажиллагаа явуулсан бөгөөд гурван удаагийн уулзалтын эцэст 1994 оны 6 дугаар сарын 24-нд “Би хэргээ мөрдсөн” гэж мэдэгдсэн. Төрийн төв хэвлэл “Ардын эрх” сонины 1994 оны 5 дугаар сарын 25-ны дугаарт намайг хэрэгт татсан тухай мэдээг “Улсын ерөнхий прокурорын газарт” гэсэн хаягаар нийтэлсэн бөгөөд мөн сонины 6 дугаар сарын 25-ны дугаарт мөн ийм хаягаар гарсан мэдээнд Улсын ерөнхий прокурорын орлогч Ч. тайлбар өгч, ярилцлага өгөхдөө прокурор мөрдөн байцаалт явуулсныг шууд болон шууд бусаар нотолсон. Улсын ерөнхий прокурор надад хариу өгөөгүйгээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтыг давхар зөрчсөн юм.

Прокурор А.-гийн хууль бус ажиллагааны талаар Улсын ерөнхий прокурор ноён Г.-д өргөдөл бичиж түүнийг зогсоохыг хүссэн. Харин Улсын ерөнхий прокурор надад хариу өгөөгүй. Миний бичсэн өргөдлийг А.-д өгч хавтаст хэрэгт хадгалуулсан. А. “Улсын ерөнхий прокурор таны өргөдөлд бичгээр хариу өгөхгүй, хавтаст хэрэгт нь хий.

Хэрэгт татагдсан үндэслэлээ тайлбарлаж өгөөрэй” гэж хэлсэн гэсэн юм. Ингэснээрээ Улсын ерөнхий прокурор Г. төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх, нотлох баримтыг шалгуулах иргэн миний эрхийг зөрчсөн юм. Монгол Улсын Үндсэн хуульд прокурорын байгууллагын чиг үүргийг тодорхой заасан. Гэтэл прокурорын байгууллага эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулж, энэ тухайгаа төрийн хэвлэлээр зарлан мэдээлсэн нь тодорхой. 1994 оны 5 дугаар сарын 24-нд А. хэрэгт татсан тогтоолоо уншиж өгөөд гарын үсэг зур гэсэн боловч би эсэргүүцсэн. Д.-г цагдаагийн мөрдөн байцаагч гэдгийг танилцуулаагүй учир би мэдээгүй. Сая л тогтоолоос мэдлээ. Прокурор А.-гийн үйл ажиллагаа бол Үндсэн хуульд заасан эрхээ хэтрүүлсэн явдал мөн. Улсын ерөнхий прокурор энэ үйл ажиллагааг мэдэж, бүр цаашилбал удирдан чиглүүлж байснаараа тэр Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчиж байна гэж үзэх үндэстэй. Дөрвөн удаагийн уулзалтын үеэр байцаалтыг А. гардан явуулсан. Сүүлчийн удаа А. “мөрдөн байцаалт ингээд дууслаа” гэж хэлсэн. Би протоколд гарын үсэг зураагүй.

Улсын ерөнхий прокурор өөрийн тушаалаар мөрдөн байцаах ажлын хэсэг байгуулах замаар хуульд заагаагүй эрх эдлэх боломжийг прокуроруудад олгож Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчсөн нь эргэлзээгүй юм. Прокурорын байгууллага тухайлбал прокурор А. Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу хүчингүй болсон хууль хэрэглэж мөрдөн байцаалт явуулсныг таслан зогсоох талаар миний тавьсан хүсэлтийг ойшоогоогүй юм.

Үндсэн хуулийн цэцтэй харьцахад намайг “яллагдагч” хэмээн нэрлэсэн, одоо ч нэрлэсээр байгаа нь Улсын ерөнхий прокурор өөрөө энэ гүтгэлгийн хэрэгт шууд оролцогч нь болж байгааг нотолж байна. Миний бие Улсын ерөнхий прокурор Г.-д өгсөн өргөдөлдөө Засгийн газрын үйл ажиллагааны тайланг 1992 оны 1 дүгээр сард Улсын Их Хурал хэлэлцэх үед арбитражийн гүйлгээний алдагдал, уг асуудалд Засгийн газар хэрхэн хандсан тухайг дэлгэрэнгүй хэлэлцээд 1992 оны 1 дүгээр сарын 22-нд тогтоол гаргаж Засгийн газарт итгэх шийдвэр гаргасныг анхаарахыг хүссэн. Үүнийг эс анхаарснаар Улсын ерөнхий прокурор Монгол Улс 1974 онд нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 15-ын 1 дүгээр зүйлийг зөрчиж миний иргэний эрхийг хөсөрдүүлсэн юм.

## 2. Улсын ерөнхий прокурор Г.-гийн тайлбарын агуулга:

Надад ирүүлсэн Б.-гийн өргөдлийг хүлээн авч танилцаад дараа өдөр нь “Б.-гийн өргөдлийг хэргийн материалд нь хавсаргах, харин яллагдагчаар татсан үндэслэлээ түүнд сайн танилцуул” гэсэн ам хариуг Б.-г яллагдагчаар татсан прокурор А.-д өгсөн болно. Төрийн албан тушаалтны хувьд надад ирүүлсэн гомдолд хуулийн дагуу хариу өгөх ёстой.

Б.-г нэгэнт яллагдагчаар татагдсан учраас түүний гомдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар зохицуулах ёстой гэж бодож байна. Нотлох баримт шалгуулах тухай Б.-гийн хүсэлтийг ажлын хэсэг авсан гэж ойлгож байна. “Алт, дилерийн” гэгдэх хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг Улсын Бага Хурлаас өгсөн чиглэлийн дагуу Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын дор мөрдөн байцаах газартай хамтран шалгаж дуусгаж байна. Энэ хэргийг гол нь мөрдөн байцаах газар мөрдөн байцаалт явуулж, Прокурорын байгууллага мөрдөн шалгах зарим ажиллагаанд оролцож байгаа юм. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих гэдэг нь энэ талаар тодорхой шийдвэр гаргана гэсэн үг. Шийдвэр гаргахгүй бол хяналт тавьж чадахгүй. Анх “Алт, дилерийн” гэгдэх энэ хэргийг хуучин эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьяаллын дагуу шалгаж эхэлсэн. Улсын дээд шүүхээс 1993 онд Улсын ерөнхий прокурорын газарт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаасан. Тэгээд ч цагдаагийн удирдлага энэ хэргийг аваагүй байна. Нэгэнт эхэлсэн хэргийг цаг алдалгүй шуурхай дуусгах, нөгөө талаас нь мөрдөн байцаалтыг мөрдөн байцаах газартай хамтарч дуусгах нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд харшлахгүй гэж үзсэн.

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох гэдэг нь тэдгээрийг хуулийн дагуу явуулж байгаа эсэхийг хянахын тулд хэргийн газрын үзлэгт оролцох, нүүрэлдүүлэн байцаахад байлцах гэх мэт үйл ажиллагааг хэлнэ. Прокурорын байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болно. Прокурорын байгууллага мөрдөн байцаалт явуулсан нь Цэцийн авч хэлэлцэх асуудал биш юм. Прокурор хяналт тавьж байж үндэслэлтэй шийдвэр гаргана. Прокурорын байгууллага мөрдөн байцаалт явуулах талаар миний бие зохион байгуулалтын шинжтэй тушаал гаргасан. Б. өргөдөлд хариу өгөөгүй гэж Цэцэд гомдол гаргасан. Б.-г байцаасан асуудал бол шийдвэр биш бөгөөд нотлох баримтыг цуглуулж байгаа асуудал юм. Б.-г яллагдагчаар татсан учир түүний гомдлыг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой. Яллагдагч бүрийн гомдлыг Улсын ерөнхий прокурор авч шийдвэрлэхгүй. Би Б.-гийн өргөдлийг хүлээж аваад бичгээр цохолт хийж хяналт тавьж байсан прокурор А.-д шилжүүлсэн. Би зохих журмын дагуу хариу өгсөн. Б.-гийн гаргаж байгаа гомдлыг шүүх дээр л ярьж шийдэх асуудал юм. Б.-гийн эрхийг хязгаарласан үйл ажиллагаа явуулаагүй. Тэр сонин хэвлэлээр бичиж байсан. Харин Б. мөрдөн байцаалтын нууцыг задрүүлсан.

### 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 2 дахь хэсгийн заалтууд нь бүхэлдээ хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хангах Прокурорын хяналтын чухал арга юм. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хууль зөрчигдөх явдлыг таслан зогсооход ач холбогдолтой үйл ажиллагаа учраас Прокурорын тухай хуулийн дээр дурдсан заалтууд Үндсэн хууль зөрчөөгүй нь тодорхой байна.

### 4. Холбогдох этгээдээс өгсөн тайлбарын агуулга:

а/ Мөрдөн байцаагч Д.: “Миний бие 1993 оны 10 дугаар сарын 25-наас Х. нарт холбогдох хэрэгт мөрдөн байцаагчаар ажиллаж байна. 1994 оны 5 дугаар сарын 24-нд Б.-д ял сонсох тогтоолыг би үйлдсэн. Түүнээс хойшхи уулзалтад би оролцоогүй болно” гэсэн байна.

б/ Прокурор А. Цэцэд өгсөн тодорхойлолтдоо: “Ерөнхий прокурорын 1994 оны А/13 дугаар тушаалаар Х. нарт холбогдох хэргийг мөрдөх ажлын хэсэгт орж С., Г., Б. нартай холбоотой асуудлыг мөрдөн шийдвэрлэх чиглэлтэй мөрдөн байцаалт явуулсан. Мөрдөн байцаалт явуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалт, Прокурорын хуулийн 1 дэх хэсгийн 6, 2-ыг удирдлага болгодог. Би 5 дугаар сарын 24-нд Б.-г яллагдагчаар татсан. Мөрдөн байцаах ажиллагааг би гардан явуулсан. Үндсэн хуульд байгаа хяналт тавих гэдэг бол мөрдөн байцаалт явуулахгүй гэсэн үг биш юм. Прокурорын хуульд мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно гэж заасан. Энэ бол мөрдөн байцаалт явуулахыг хэлж байгаа юм. Б.-г 5 дугаар сарын 24, 6 дугаар сарын 8, 20, 22-ны өдрүүдэд дөрвөн удаа байцаасан” гэсэн байна.

### Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

Нэг. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 2 дахь хэсэгт заасны дагуу прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагаа явуулахад оролцох, хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь халдашгүй, чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг хязгаарлахыг хориглох зэрэг Үндсэн хуульд заасан иргэний эрхийг баталгаажуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хууль ёс зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн Прокурорын хяналтын арга учир Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байх тул энэ талаар гаргасан иргэн Б.-гийн гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Хоёр. Монгол Улсын ерөнхий прокурор Г. төрийн албан тушаалтныхаа хувьд иргэн Б.-гээс доод шатны прокурорын тодорхой үйл ажиллагаатай холбогдуулан түүнд ирүүлсэн гомдлыг хүлээн авсан атлаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэж, хариу өгөөгүй байгаа нь тогтоогдсон тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуульд шүүх засаглалын хүрээнд Прокурорын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг нарийвчлан тогтоож өгсөнтэй уялдан Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Прокурорт мөрдөн байцаах эрх олгож, түүнийг хяналтын үүрэгт нь багтааж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль батлагдсан үеэс хүчингүй болсон, мөн түүнчлэн Улсын Бага Хурлын 1992 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 36 дугаар тогтоолын дагуу Прокурорын мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт 1992 оны 7 дугаар сарын 1-ний дотор Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлэх замаар Прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлсэн бодит нөхцөл байдлыг үл хайхран Ерөнхий прокурор Г. “Алт, дилерийн” гэгдэх эрүүгийн хэргийг мөрдөх ажлыг зохион байгуулан явуулах, түүнд хяналт тавих ажлын хэсгийг 1993 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/46 дугаар тушаалаараа байгуулан ажиллуулснаар прокурорууд мөрдөн байцаалтын тодорхой үйл ажиллагааг биечлэн явуулах улмаар прокурорын хяналтын агуулга алдагдах болсон нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүрч болзошгүй гэсэн иргэн Б.-гийн гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байна.

Дөрөв. Иргэн Б. Үндсэн хуулийн цэцэд хандаж Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан “...нотлох баримтыг шалгуулах...” тухай иргэн миний эрхийг зөрчлөө гэсэн гомдол гаргасан нь түүнд эрүүгийн хэрэг үүсгэсэнтэй холбоотой асуудал тул шүүхийн журмаар хянан шийдвэрлэгдэх учраас түүнийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаас дараах ДҮГНЭЛТИЙГ ГАРГАВ:

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6-гийн “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэв.

3. Иргэн Б.-гийн өргөдөлд байгаа Улсын ерөнхий прокурор Г. нотлох баримтыг шалгуулах тухай миний хүсэлтийг үл хэрэгсэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчлөө гэсэн гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

4. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулганы ажиллагаа эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн, Прокурорын байгууллагын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 2 дахь заалт Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Уг нь тодорхой албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан шийдвэрийг Улсын Их Хурал авч хэлэлцэх эрхгүй байдаг. Гэтэл Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн байна гэж гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байна. Ийм ч учир Үндсэн хуулийн цэц 1995 оны 2 дугаар тогтоолоороо дээрх “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг хүчингүй болгосон байдаг.

2. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцдог боловч хуульд заасан зарим тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй юм. Тухайлбал:

- Гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт, орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, түүнчлэн хуурамч эд мөрийн баримт, тэмдэглэл, баримт бичгийг үндэслэж тогтоол, магадлал гаргасан нь тогтоогдсон;

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь эрх хэмжээгээ хортойгоор урвуулан ашигласан нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоолоор тогтоогдсон;

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих явцад хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл мөрдөн шалгах ажиллагаа явуулж болдог байна.

\* \* \*

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.08.29 № 08**

**Засгийн газрын 169 дүгээр тогтоолтой холбогдсон  
маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Р.;  
Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. БНМАУ-ын Бага хурлаас 1991 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Өмч, хувьчлах тухай хууль

- 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үйлдвэрийн газрын эд хөрөнгийг хувьчлах талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ тухай гомдлоо уул шийдвэрийг гаргасан байгууллагыг харьяалах дээд байгууллагад нь шийдвэр хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гаргана”

- 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Хувьчлалтай холбогдон үүссэн эд хөрөнгийн маргааныг шүүх шийдвэрлэнэ”

2. Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоол

- 2 дугаар хавсралтын 4 дүгээр бүлгийн 12 дахь заалт “...БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийнх болно”

- 5 дугаар хавсралтын 6 дугаар бүлгийн 17 дахь заалт “...БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийнх болно”

3. Улсын дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан Өмч хувьчлах тухай хуулийн тайлбарын 3 дахь хэсгийн заалт

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

- Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”

- Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх”

#### **Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр, суурь:**

1. Иргэн Р.-ийн мэдээллийн агуулга:

Өмч хувьчлах тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4 дүгээр бүлгийн 12 дахь заалт, 5 дугаар хавсралтын 6 дугаар бүлгийн 17 дахь заалтууд болон Улсын дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан Өмч хувьчлах тухай хуулийн тайлбарын 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2, 3, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудад тус тус харшилж байгаа тул хянан үзэж шийдвэрлэж өгнө үү.

Засгийн газрын 169 дүгээр тогтоол, Улсын дээд шүүхийн тайлбарын дээр дурдагдсан заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх” гэснийг зөрчиж байгаа юм. Ингэснээр төрийн захиргааны байгууллагуудын хууль бус ажиллагаа, иргэдийн эрхийг хохироосон албан тушаалтнуудын талаар шүүхэд гомдол мэдүүлэх боломжийг хааж, “шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчихөд хүргэж байна. Хувьчлалын үр дүнд өмч хөрөнгөтэй болох явдал нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Иргэн хүн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг эдлэх”-д орших бөгөөд энэхүү эрх нь

зөрчигдсөн тохиолдолд шүүхэд хандах боломжийг 169 дүгээр тогтоолын хавсралтад байгаа дээрх заалтууд хааж байна. Хэдийгээр Өмч хувьчлах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар шүүхэд гомдол мэдүүлэх эрхийг хууль зүйн хувьд шууд хаагаагүй боловч уг зүйлийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбарын 3 дахь заалт нь хуулийн дээрх заалтыг гажуудуулж улмаар Үндсэн хуульд харшилж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ" гэж заасан хэдий боловч энэ нь амьдралд хэрэгжихгүй байгааг харгалзан Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Улсын дээд шүүхэд албан ёсоор шилжүүлэн шийдвэрлүүлж өгөхийг мөн хүсч байна.

2. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Засгийн газрын 1991 оны 169 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4 дүгээр бүлгийн 12 дахь заалт, 5 дугаар хавсралтын 6 дугаар бүлгийн 17 дахь заалтууд нь төр өөрийн өмчийг бусдад худалдахдаа эзэн нь хөрөнгөнийхөө худалдах үнэ, арга хэлбэрээ өөр хүнээс асуухгүйгээр сонгон хэлж байгаа хэрэг юм. Худалдан авах хүн уг үнээр авах эсэх нь тухайн сонирхогч талын хүсэлт юм.

Иргэд бүх төрлийн гомдол маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй боловч тухайн нөхцөлд бусдын өмч хөрөнгийг хямд үнээр худалдан авах хүсэлтээ шүүхэд гаргах, уг асуудлыг шүүх хянан эцэслэн шийдвэрлэх хууль зүйн үндэслэл үгүй байх. Иймд уг тогтоолд төрийн өмчийн үнэлгээ болон хувьчлах арга хэлбэрийн талаархи асуудлыг Засгийн газраас эрх олгосон байгууллага болох Засгийн газрын өмч хувьчлалын комисс эцэслэн шийдвэрлэхээр тусгасаныг Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Шүүх эрх мэдэл" гэдэгт уг зүйл хамаарахгүй болов уу гэж үзэж байна.

3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.-гийн тайлбарын агуулга:

Өмч хувьчлах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "үйлдвэрийн газрын эд хөрөнгийг хувьчлах талаар холбогдох байгууллагаас гаргасан шийдвэр..." гэдэг нь төр өөрийн ямар эд хөрөнгийг яаж хувьчлахыг заасан шийдвэр байх тул үүний талаар гаргасан гомдол нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д заасан иргэдийн гомдолтой холбоогүй болно. Өөрөөр хэлбэл, өмчлөгч өөрийнхөө ямар эд хөрөнгийг ямар хэмжээгээр, ямар арга хэлбэрээр хувьчлахыг заасан төрийн захиргааны байгууллагын шийдвэр мөн. Иймээс өмч хувьчлах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх заалт Үндсэн хуулийг зөрчөөгүй байна. Энэ хуулиар дуудлагын болон үнэлгээний журмыг Засгийн газар тогтоохоор заасан тул энэ журмыг шүүх хуулийн нэгэн адил дагаж мөрдөнө гэж ойлгож байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Өмч хувьчлах тухай хуулийн 10 дугаар зүйлийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэсэн хүсэлтээ маргагч иргэн Р. Цэцэд бичгээр өгсөн тайлбартаа буцааж авснаа илэрхийлсэн тул энэ асуудлыг Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцэх үндэслэлгүй болно.

2. Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны 169 дүгээр тогтоолоор батлагдсан 2 дугаар хавсралтын 4 дүгээр бүлгийн 12, 5 дугаар хавсралтын 6 дугаар бүлгийн 17 дахь хэсэгт буй "...БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийнх болно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад буй "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй", мөн Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", "Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно"

гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба энэ талаар иргэн Р-ийн гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байна.

3. Улсын дээд шүүхийн бүгд хурлын 1993 оны 25 дугаар тогтоолоор баталсан Өмч хувьчлалын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын тайлбарын 3 дахь заалт нь утга агуулгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан иргэдээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг бэхжүүлсэн заалттай харшилсан байна. Гэвч Улсын дээд шүүхийн бүгд хурлын тайлбар Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн тухай маргаан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн харьяаллын асуудал биш бөгөөд Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэсэн заалтыг баримтлан энэ асуудлыг Улсын дээд шүүхэд шилжүүлэн хянуулах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үйлдвэрийн газрын хувьчлах эд хөрөнгийн үнэлгээний журам”-ын 4 дүгээр бүлгийн 12 дахь хэсгийн “...БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийн болно”, мөн тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 17 дахь хэсгийн “...БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын шийдвэр эцсийн болно” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг Монгол Улсын Их Хуралд оруулж байна.

2. Иргэн Р-ийн гомдолд дурдсан “Улсын дээд шүүхийн Бүгд хурлын 1993 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан Өмч хувьчлалын тухай хуулийн зарим зүйл, хэсэг заалтын тайлбарын 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудад харшилж байна” гэсэн хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн Улсын дээд шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлсүгэй.

3. Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 89 дүгээр тогтоолын агуулга:**

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 169 дүгээр тогтоолын зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 169 дүгээр тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 8 дугаар дүгнэлтийн дүгнэх хэсгийн 1-д заасныг хүлээн зөвшөөрсүгэй.



## **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 3 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааны хүрээ нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хязгаарлагддаг. Цэц энэхүү хүрээнээс давсан маргааныг хянан шийдвэрлэхээс татгалздаг боловч тухайн маргааныг харьяалан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх тохиолдол гардаг. Мөн аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлж болдог байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1994.11.23 № 09**

### **Байнгын хорооны дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргагч - Монгол Улсын Ерөнхийлөгч О.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., З.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Монгол Улсын Ерөнхийлөгч О.-гийн хүсэлтийн агуулга:

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>1</sup> дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх, шийдвэр гаргах, хариу өгөх журмыг тодорхой заасан. Гэтэл Улсын Их хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурал Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу одоо хүртэл хэлэлцээгүйгээр үл барам Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхийн оронд уг асуудлаар Хууль зүйн байнгын хорооны гаргасан дүгнэлтийг л хэлэлцдэг боллоо.

“Байнгын хорооны дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгөхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс хүсч байна.

2. Ерөнхийлөгчийн итгэмжилсэнтөлөөлөгч Ц.-гийн тайлбарын агуулга:

Ерөнхийлөгчөөс хориг тавих, түүнийг Улсын Их Хурлаас хэлэлцэх нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын хоорондын шууд харилцааны нэг хэлбэр. Ерөнхийлөгчийн хоригийг хуулиар тогтоосон журмын дагуу хэлэлцэхгүйгээр байнгын хорооноос Ерөнхийлөгчийн хоригийн талаар гаргасан санал дүгнэлтийг бие даасан асуудал болгон хэлэлцэж байгаа нь Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчиж байгаа хэрэг.

Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд Ерөнхийлөгчөөс тавьсан хориг хуульд заасан хугацаандаа тавигдсан эсэх тухай асуудал анхаарлын голд байгаа юм. Энэ асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхийн байр суурь зарчмын зөрүүтэй байгаа. Амралтын цагийг хасч тооцвол Ерөнхийлөгч Улсын Их Хурлын 66 дугаар тогтоолыг хүлээн аваад 54 цаг 20 минутын дараа буюу хориг тавих хугацаа дуусахаас 17 цаг 40 минутын өмнө уг хоригийг тавьсан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Бага Хурлаас баталсан Улсын Их Хурлын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Бага Хуралд танилцуулахаас өмнө энэ хуулийн зарим заалт, тухайлбал 52 дугаар зүйлд заасан 72 цагийн хугацаа нь ямар үндэслэлтэй вэ? Хагас сайн, баяр, амралтын өдрийн өмнө тохиовол яаж тооцох вэ? гэсэн асуудлаар тайлбар өгөхийг Улсын Бага Хуралд албан ёсоор хүссэн юм. Үүний хариу болгож Улсын Бага Хурлын дарга Г. албан бичгээр хариу өгөхдөө “Хэрвээ 72 цагт хагас сайн, амралт, баярын өдөр тохиовол түүнийг хасч тооцох нь зүйтэй гэж үзнэ” гэсэн юм. Энэ бол хууль тогтоогчоос тухайн зүйлийг батлахдаа ямар агуулга шингээснийг тод харуулж байгаа нэг баримт юм.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэнтөлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 70 дугаар тогтоол Үндсэн хуулийн Гучин гуравдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Улсын Их Хурлын шийдвэрийг Ерөнхийлөгчид илгээснээс хойш 72 цагийн дотор тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьж болохыг хуульчилсан. Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх заалт ёсоор 72 цагийн дотор Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд хориг тавиагүй байна. Нэгэнт хуулийн хугацаанд багтааж Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавиагүй байх тул энэ удаагийн хоригийг хориг гэж үзэх хууль зүйн үндэсгүй юм. Маргааны гол зүйл нь 72 цагийн асуудал юм. Монгол Улсад өнөөдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид хугацааг цагаар заасан зүйл, заалт олон байгаа. Энэ нь ямар ч тайлбаргүйгээр хугацаа эхэлсэн мөчөөс тасралтгүй тоолно гэсэн хуулийн хоёрдмол утгагүй ойлголт. Ерөнхийлөгчийн хориг хугацаандаа тавигдаагүй тул зүй нь байнгын хороогоор ч хэлэлцэхгүй буцаж болох байсан. Бид хүндэтгэл үзүүлж хэлэлцсэн юм. Цаг тоолох нэг л журам Монгол Улсын хуульд байгаа. Аливаа хугацааг цагаар тодорхойлсон бол тэр нь тасрахгүй тоолно гэдэг нь тайлбар шаардахгүй ойлгомжтой зүйл. Улсын Их хурлын 70 дугаар тогтоол бол үндсэндээ 72 цаг гэдгээ агуулгаар нь тайлбарлаж байгаа юм.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч З.-гийн тайлбарын агуулга:

Хугацаа тоолох журам хуулийн практикт тогтсон зүйл. 72 цаг гэсэн хугацааг тасралтгүй тоолох ёстой гэдэг нь ойлгомжтой. Үндсэн хуулийн цэц хуулиа баримталж асуудлаа шийднэ гэдэгт найдаж байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66 дугаар тогтоолд тавьсан хориг нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан хугацаанд тавигдаагүй тул “Байнгын хорооны дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны тогтоолын заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. “Байнгын хорооны дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

#### **Тэмдэглэл:**

1. Хууль, Улсын Их Хурлын шийдвэрт Ерөнхийлөгчөөс хориг тавих хугацаа тогтоож өгсөн нь Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдсон хориг тавих бүрэн эрхийг хязгаарласан гэж ойлгож болохгүй юм.

“Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” Улсын дээд шүүхийн 1994 оны 8 дугаар сарын 11-ний 86 дугаар тогтоолд Ерөнхийлөгч хориг тавих эрх бүхий 72 цагийн хугацаа нь ажлын бус цагт дуусаж байвал энэ хугацаа нь түүний дараагийн ажлын өдрийн мөн цаг, минутад дуусгавар болно” гэсэн байхад Үндсэн хуулийн цэц “...Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан хугацаанд тавигдаагүй тул” гэсэн нь анхаарал татаж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй, 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”-ийн 53 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Энэ хуулийн 53.5-д заасны дагуу илгээсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Ерөнхийлөгч тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн байна. Өөрөөр хэлбэл 1993 онд 72 цагийн дотор хориг тавих журамтай байсан бол одоо ажлын 5 өдөрт багтаан хориг тавьдаг байхаар хуульчилсан байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1995.01.04 № 01**

### **Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ч., Г.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>15</sup>

- 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “... Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ”

<sup>15</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 6-7-д нийтлэгдсэн

- 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй”

- 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “... Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараах шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1/ Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2/ Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх;

3/ Ерөнхийлөгч бүрэн эрхээ зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх”

- 45<sup>2</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Үндсэн хуулийн цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна”

- 45<sup>2</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч, санал, дүгнэлт гаргаж болно”

- 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана”

- 45<sup>2</sup> дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна”

- 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... Уг илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсоно”

- 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “... , хэрэв Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг заавал сонсоно”

- 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тооцоолуураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тооцоолуур ашиглан явуулна. Тухайн хуралдаанд оролцсон 5-аас доошгүй гишүүний шаардсанаар, эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хурааж болно. Ийнхүү нэрээр санал хураахдаа хуралдаан даргалагч цахим тооцоолуур дээр бичигдсэн, эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг танилцуулна”

- 54 дүгээр зүйл 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, Байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ”

- 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг зөвхөн уг ажлыг эрхлэх ажилтан эсхүл архивчийн дэргэд үзэж, сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно”

- 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Дараах тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;

2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл гаргасан”  
- 19 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргана”

3. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоол

- 2 дахь хэсэг “Монгол Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй”<sup>16</sup>

**Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”

- Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна”

- Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”

- Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1/ хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх.

2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх”

- Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна”

- Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй”

- Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ”

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”

16 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 1-т нийтлэгдсэн

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “...Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ” гэсэн заалт Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн нэг дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан маргаан нь Үндсэн хууль, бусад хуулийг сахиулахтай холбогдон гарч болох бөгөөд энэ тухай Цэцийн буюу аль нэг шатны шүүхийн шийдвэр гарч болно.

Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...Уг илтгэлийг сонссоны дараа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсоно...”, 38 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн “...хэрэв Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл гараагүй нөхцөлд Цэцээс дүгнэлт гарахгүй тул Цэцийн дүгнэлтийг шууд дуудан сонсох хууль зүйн үндэслэл байхгүй юм.

Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараах шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1/ Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2/ Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх;

3/ Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх” гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт болон Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна” гэсэн заалтуудыг зөрчиж байна. Учир нь Үндсэн хуулийн холбогдох заалтууд ёсоор Ерөнхийлөгчийг огцруулах буюу эгүүлэн татах

үндэслэл байгаа нь Цэцийн дүгнэлтээр нэгэнт тогтоогдсон үед л энэ асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцэх бөгөөд хэлэлцэх явцад Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх ёсгүй. Гэтэл хэлэлцэхээр хуульчилсан нь Үндсэн хуулийн дээрх хоёр заалтыг зөрчиж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна” гэсэн заалтаас өөр Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай заалт энэ хуульд ороогүй байна. Тодруулж хэлбэл, Улсын Их хурлын авч хэлэлцэх ёстой Цэцийн арван төрлийн дүгнэлтээс хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэрхэн авч хэлэлцэхийг дээрх зүйлд тодорхой заасан боловч үлдсэн найман төрлийн дүгнэлтийг хэрхэн хэлэлцэх талаар Улсын Их Хурлын тухай хуульд заагаагүй байна. Улсын Их Хурлаар хэлэлцэх ёстой Цэцийн дүгнэлт ийнхүү өрөөсгөл тусгагдсан атлаа Улсын Их Хурлаар хэлэлцэх ёсгүй Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт /3, 4-т/ заасны дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхээр хуульчилсан тухай дээр өгүүлсэн билээ. Улсын Их Хурлын Байнгын хороо /Дотоод асуудлын/ 1994 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хурлаараа гишүүн Ц.Төрмандах Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзэж, энэ дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулжээ.

Гишүүд Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж эцсийн шийдвэр гаргах эрхтэй эсэх талаар маргалдсан боловч ганц ч удаа санал хураагаагүй бөгөөд дараа нь энэ асуудлаар тайлбар гаргахаар болж уг асуудлыг хаажээ. Харин 3. Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар дахин хүчтэй маргаан өрнүүлсний эцэст санал хурааж Цэцийн дүгнэлтийг зөвшөөрчээ. Ийнхүү Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар цаашдаа Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх эсэх тухай санал хурааж шийдэж байна гэсэн жишиг тогтлоо гэж гишүүд үзжээ. Улсын Их Хурлаас Ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэсэн /88 дугаар/ тогтоол гаргасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн шийдвэр гаргана гэдгээ эрх зүйн актын хэмжээнд албан ёсоор илэрхийлсэн анхны тохиолдол юм.

Үндсэн хууль зөрчсөн шийдвэрт хүрэх тулгуур нь Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь заалт болсон нь дээрх хоёр баримтаас харагдаж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Дараах тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх буюу эгүүлэн татна:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон;
2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсч өргөдөл гаргасан”, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эгүүлэн татах шийдвэр гаргана” гэсэн заалтаас өөр Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах тухай заалт энэ хуульд байхгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын үйлчилгээг зогсоож, эсхүл Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт зөрчигдөж байна. Учир нь Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу Улсын Их Хурлын даргыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар Цэцээс дүгнэлт гаргах шаардлагатай болох үед Улсын Их Хурлын тухай хуулиас баримтлах заалт олдохгүй тул Цэц Үндсэн хуулийг

сахиулах баталгаа болохынхоо хувьд Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу, Үндсэн хууль болон зарим хуулийн заалтыг төсөөтэй хэрэглэн огцруулах буюу эгүүлэн татах үндэслэл байна гэж тогтоогоод Улсын Их Хуралд оруултал энэ өргөдлийн 4-т дурдсан тохиолдолтой адил Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд Цэц Улсын Их Хурлын тухай хууль зөрчжээ гэсэн дээр санал хурааж баталгаажуулаад энэ санал хураалтаа эрх зүйн баримт болгон үйлдэх шаардлагагүй гэж үзэж болох юм.

Ийм тохиолдолд Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт зөрчигдөж байгаа нь ойлгомжтой бөгөөд энэ санал хураалтын дүнг Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хүрээнд хамруулахгүй бол Үндсэн хууль зөрчигдсөн хэвээр хоцорч Үндсэн хуулийг сахиулах баталгаанд хохирол учирна. Хэрэв хамааруулбал Үндсэн хууль зөрчигдсөнийг залруулах боломж үлдэнэ.

Улсын Их хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалт Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Улсын Их Хурлын тухай хуульд заасан ёсоор Улсын Их хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах албан тушаалыг цалингүйгээр эрхэлж болохоор заажээ.

Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэжээ.

Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана” гэсэн заалтыг би урьд нь уг зүйлийн 1-д заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн тухай гарсан Цэцийн дүгнэлтийн тухай асуудал гэж ойлгосон нь буруу байжээ. Учир нь Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь заалтын 3, 4 дэх заалтын дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг зөвшөөрөх эсэх тухай санал хураах байдлаар эцсийн шийдвэр гаргаж болох эрх зүйн үндэслэл нь чухамхүү 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсэг болох нь Улсын Их Хурлын хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс тодорхой байна. Ийнхүү 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн: “... цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг... хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын 2-т “Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал тухайн асуудлаар санал хураалт явуулж чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Энэ хууль болон бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж эсхүл цахим тооцоолуураар, нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тооцоолуураар ашиглан явуулна. Тухайн хуралдаанд оролцсон



5-аас доошгүй гишүүний шаардсанаар эсхүл хуралдаан даргалагчийн санаачилгаар ил санал хураалтыг нэрээр хурааж болно. Ийнхүү бичигдсэн эсхүл гар өргөсөн гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал болон санал хураалтын дүнг танилцуулна” гэсэн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зөрчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь цахим тооцоолуураар санал хураахыг ил санал хураалт ч мөн, нууц санал хураалт ч мөн гэж үзээд хурал даргалагчийн хувьд хэн яаж саналаа өгсөн нь мэдэгдэж байдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Ийнхүү нууц санал хураалтын утга учрыг алдагдуулсны шалтгаан нь ил саналыг нуун далдлах зорилго тавьсанд оршино. Энэ нь нэрээр санал хураах гэсэн ойлголт, түүнтэй холбогдсон заалтуудаар /Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 6 дахь заалт, 55 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг/ нотлогдож байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4-ийн “... хэрэв нэрээр санал хураавал Улсын Их Хурлын гишүүн нэг бүрийн нэр, өгсөн санал”-ыг хуралдааны явцын тэмдэглэлийг гараар бичихдээ заавал тусгахаар заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчиж байна. Учир нь зөвхөн нэрээр санал хураасан тохиолдолд гишүүдийн санал өгсөн байдал гишүүн бүрээр гарч байхаар заасан, цаг хожихын тулд санал хураалт үндсэндээ компьютерээр явагддаг, компьютерээр явагдсан санал хураалтын дүнг хуралдааны явцын тэмдэглэлд тусгахгүй байгаа нь Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэрт гишүүн хэрхэн санал өгч байгааг мөн чанартаа нууц болгож байна.

Ингэснээр тухайн гишүүн өргөсөн тангарагтаа хэр зэрэг үнэнч байгааг сонгогчдын зүгээс бодитой хянах хамгийн чухал хөшүүргийг ажиллахгүй болгожээ. Үүгээр төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад үл хамаарах асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг Монгол Улсын иргэн баталгаатай эдэлнэ гэсэн Үндсэн хуулийн заалт зөрчигджээ.

Улсын Их Хурлын гишүүний санал өгөлтийн талаар бодитой мэдээ цацагдахгүй байгаа нь нам болон гишүүний зүгээс сонгогчдыг элдвээр төөрөгдүүлэх өргөн бололцоо бий болгож улмаар засгийн эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалт эцсийн дүнд хоосон уриа болоход хүрнэ. Мөн Улсын Их Хурлын үйл ажиллагаа сонгогчдынхоо өмнө ил тод байх тухай ардчилсан ёсны хамгийн чухал зарчим алдагдаж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, байнгын хорооны хуралдааны явцыг албан ёсоор дэс дараалан тэмдэглэн авах, уг тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д заасан иргэдийн төр, түүний байгууллагаас хууль ёсоор хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчиж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан “Хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон дуутай дүрс бичлэгийг зөвхөн уг ажлыг эрхлэх ажилтан, эсхүл архивчийн дэргэд үзэж сонсох бөгөөд тэдгээрийг олшруулах, хувилахыг хориглоно” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчиж байна.

Учир нь Улсын Их Хурал болон байнгын хороодын хуралдааны явцын тэмдэглэлийг хориг саадгүй үзүүлдэг байлаа ч гэсэн уг тэмдэглэлийн талаар эргэлзээ гарч болно. Энэ тохиолдолд сонирхсон иргэн, зохих албан тушаалгүй л бол эргэлзээгээ тайлах бололцоо Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан ёсоор бүрэн хаагдсан байгаа нь Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг албан тушаалаар нь ялгаварлаж болохгүй гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт зөрчигдөж байна.

## 2. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:

Шинэ Үндсэн хуулиар төрийн дээд байгууллагуудын эрх, үүргийг зааглан өгч, гагцхүү хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байхаар тогтоосон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх дүгнэлтийг гагцхүү Үндсэн хуулийн цэц гаргах эрхтэй. Өөр ямар нэг байгууллага, түүний дотор Улсын Их Хуралд энэ эрх хуулиар олгогдоогүй юм.

Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг энэ тогтоол зөрчлөө. Уг зүйлд “Прокурор нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэжээ. Улсын Их Хурал тогтоол гаргаж, Улсын ерөнхий прокурорын газраас явуулсан мөрдөн байцаах ажиллагааг хамгаалснаараа Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчлөө. Иймд Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын талаар зохих шийдвэр гаргаж өгнө үү.

## 3. Иргэн Л.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Би Цэцэд гаргасан өргөдлийн шаардлагаа дэмжиж байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Улсын Их Хурлаар эцэслэн шийдвэрлүүлэхээр заасан маргаан нь зөвхөн ажил төрлийн бус хуулийн асуудлаар ч гарсан маргаан байж болно. Ийм маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэвэл шүүх засаглалд хохирол учирна. Мөн Улсын Их Хурлын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд үнэхээр иргэний Үндсэн хуулиар олгогдсон мэдээллийн эрх чөлөөг хаан боогдуулж байна. Улсын Их Хурлын чуулган, Улсын Их Хурлын гишүүдийн ажлын зөвлөлгөөн, Байнгын хорооны хуралдааны явцын тэмдэглэлийг ашиглах, хадгалах ажлыг Ерөнхий нарийн бичгийн даргын тогтоосон журмын дагуу Тамгын газар эрхлэн гүйцэтгэх, тэдгээрийг зөвхөн Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр үзүүлж байхаар тогтоосон энэ асуудлыг нэг албан тушаалтны гарт оруулж иргэдээс төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг баталгаагүй болгосон гэж үзнэ. Өөрийн гомдолд дурдсан шаардлагуудтай холбогдуулан Улсын Их хурлын ямар зүйлийн ямар заалт Үндсэн хуулийн ямар заалтыг зөрчиж байгаа, бүр цаашилбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын шууд холбогдох ямар заалтыг зөрчиж байгаа тухай дэлгэрэнгүй хүснэгт үйлдсэнийг танилцуулах нь зүйтэй.

## 4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ч., Г. нарын тайлбарын агуулга:

Иргэн Л., Ц. нарын Цэцэд хандаж гаргасан өргөдлийн дагуу болох Цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын талаас биднийг оролцуулах болсонтой холбогдуулан бид мэргэжлийн хүмүүсийн хамт дээр нэр дурдсан иргэдийн Цэцэд удаа дараалан ирүүлсэн өргөдөлд дурдсан үндэслэлүүдийг судлан үзсэн ба одоо ч үзсээр байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг улам боловсронгуй болгох, Ерөнхийлөгчийн Засгийн газрын болон Шүүхийн тухай хуулиудтай уялдуулах, зарим зүйлийг тодруулах шаардлага байгаа бөгөөд энэ талаар Монгол Улсын Их Хурал тусгай ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна. Ийнхүү Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явцад иргэн Л.-ийн саналд ч Улсын Их Хурлын гишүүд анхааралтай хандана гэдэгт итгэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэж заасан атал “цалинтай” гэсэн тодотгол оруулсан зэрэг эргэж харах зүйл байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэн олон зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа дээрх иргэдийн саналтай санал нийлэхгүй байгаа бөгөөд энэ тухай үндэслэлээ бид Цэцийн хуралдаан дээр дэлгэрэнгүй тайлбарлах боломж олдоно гэдэгт итгэж байна. Гомдол гаргагч нарын гаргасан үндэслэлүүдтэй танилцлаа.

Улсын Их Хурлын 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй. Энэ бол ажил төрлийн маргааны тухай асуудал бөгөөд Улсын Их Хурлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т чухамдаа Засгийн газарт асуулт тавьж, өмнө тавьсан асуулгын хариуг сонсоно гэж маш тодорхой заасан.

Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Үндсэн хуулийг бас зөрчөөгүй. Учир нь дээрх зүйлүүдэд дурдагдсан асуудлыг шийдвэрлэхдээ Улсын Их Хурал Цэцдээ хүндэтгэл үзүүлж дүгнэлтийг нь сонссоны дараа л уг асуудлыг шийдвэрлэнэ гэсэн утгатай юм. Түүнээс биш Цэцэд тулгасан зүйл бол байхгүй.

Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь боловсронгуй биш боловч энэ нь Үндсэн хуулийн холбогдох заалт нь өөрөө хоёрдмол утгатай, дотоодын зөрчилтэйгээс үүдэлтэй. Үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхгүй байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйл бол урьд өмнө огт зохицуулагдаагүй процессын ажиллагаа зохицуулах зорилгоор сүүлд нэмэлт өөрчлөлтөөр орсон зүйл. Үүнийг боловсруулж батлахдаа бид үнэхээр дутуу харжээ. Гэхдээ энэ бол хийдэл мөн бөгөөд энэ тохиолдолд хуулийг төсөөтэй хэрэглэж болно гэж үзэж байна. Бид энэ зүйлийг одоо Улсын Их Хуралд оруулах, уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр боловсронгуй болгоно. Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт үнэхээр хуулийн хийдэл байна. Энэ бол Үндсэн хуулийн зөрчил биш. Хуулийн хийдлийг арилгах олон зам бий. Тухайлбал тайлбар гаргах, заалтыг боловсронгуй болгох гэх мэт. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгээс зөрж байгаа. Гэхдээ амьдрал дээр хэцүү байдаг. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн яагаад цалингүйгээр, өөрийн чөлөө заваар өөр ямар нэг сонгуульт ч юмуу үүрэг хүлээж болдоггүй юм бэ? Бүрмөсөн хааж болохгүй гэж бодож байна.

Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоол Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэж байна. Ерөнхий прокурорын газраас мөрдөн байцаалт бус мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт иргэдийн зарим эрх чөлөөг боогдуулж байгаа тухай асуудлаар гарсан гомдол нь миний гарт хожуу ирсэн учраас би сайтар танилцаж амжаагүй. Манай удирдлагаас энэ асуудлаар төлөөлөл гүйцэтгэхийг албан ёсоор даалгаагүй тул миний бие энэ асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцох боломжгүй.

Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох, зүйл заалтууд Үндсэн хуулийн зүйл, заалтыг зөрчөөгүй гэдэг дээр санал нэг байна. Тухайлбал, Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт бид их учиртай хандах ёстой. Улсын Бага Хурлаас энэ хуулийг батлах үед энэ талаар их яриа гарсан. Улсын Их Хурлын гишүүдэд, үүрэгт нь л хамаараагүй бол ямар ч ажил эрхлэхийг хориглох юм бол хүний эрх ч хөндөгдөж болзошгүй. Тухайлбал, яагаад Улсын Их Хурлын гишүүн багшилж болдоггүй юм бэ? Яагаад нэг сайн дурын байгууллагад сонирхлоороо нэгдэж, түүнд сонгуульт үүрэг хүлээж болдоггүй юм бэ?

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт иргэдийн эрх, эрх чөлөөг боогдуулсан гэдэгтэй санал нийлэхгүй байна. Ер нь төрийн аль ч байгууллагын үйл ажиллагаанд ил тод байх зарчмыг хангах нь зүйн асуудал. Гэхдээ байгууллага дотоод дэг журамтай байх ёстой. Тэгж байж л тухайн байгууллагын хэвийн ажиллагаа хангагдах учиртай. Дотоод дэг журмын асуудал бол манайд Ерөнхий нарийн бичгийн даргын хариуцлагын асуудал. Ийм ч учраас тэмдэглэлийг хадгалах, ашиглах зэрэг зарим журмыг ерөнхий нарийн бичгийн дарга тогтоож байгаа нь буруу биш. Харин үйл ажиллагаандаа хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлсэн, материал үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол өөр хэрэг.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулахын баталгаа болохын хувьд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гарсан Цэцийн дүгнэлт эцсийн байх бөгөөд түүнийг Улсын Их Хурал хэлэлцэх тухай Үндсэн хуульд ч Улсын Их Хурлын тухай хуульд ч заагаагүй байна. Харин эдгээр албан тушаалтны талаар гарсан Цэцийн дүгнэлт Улсын Их Хуралд хянагдахгүй, гагцхүү шийдвэр гаргах үндэслэл болно гэсэн агуулга эдгээр хуулийн зохих заалтуудаар нотлогдож байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд, зөвхөн энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэх тухай заасан нь агуулгаараа Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасны дагуу гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй гэсэн санааг илэрхийлсэн байгаа юм.

Мөн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна” гэжээ.

Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...хэрэв Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэл байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг заавал сонсоно...” гэж заасан байна. Мөн түүнчлэн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гарсан Цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх журмыг зохицуулсан Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлд энэ тухай заалт байхгүй байна. Тодорхой албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх хууль зүйн үндэслэлгүй байхад Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийг төсөөтэйгээр хэрэглэн Улсын Их Хурлын гишүүн З., Улсын ерөнхий прокурор Г. нарын талаар гарсан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж санал хураах замаар шийдвэрлэж байгаа нь Үндсэн хууль, Улсын Их Хурлын хуулиар олгоогүй эрх хэмжээг Улсын Их Хурал хэрэгжүүлэхэд хүргэж байна. Иймд зохицуулсан Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын 2 дахь заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцэх тухай Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйл нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан, Улсын Их Хурлаас хэлэлцэх Цэцийн дүгнэлтээс зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхээр сугалан авч, зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Цэцээс гаргах дүгнэлтийг хэлэлцэхийг орхигдуулан Үндсэн хуулийн заалтыг хэт явцууруулсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэх тухай заалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд асуулт, асуулгын талаар гарч болох аливаа маргаан нь эрх зүйн шинжтэй болсон тохиолдолд Улсын Их Хурлын гишүүн, маргагч тал аль аль нь шүүх, Үндсэн хуулийн цэцэд хандаж хөндөгдсөн эрхээ хамгаалуулах боломжоо алдахад хүргэж болох учир дээрх заалт Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн тухай иргэн Л.-ийн гомдлыг хангах үндэслэлтэй байна.

4. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтын дагуу Улсын Их Хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаалыг цалингүйгээр эрхлэх боломж нээгдэж байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй.

5. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, гишүүдийн ажлын зөвлөлгөөн, байнгын хороодын хуралдааны явцын тэмдэглэлийг хөтлөх, ашиглах, хадгалах журмыг Улсын Их Хурлын тухай хуулийн зохих заалтын дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар батлагдсан заавраар зохицуулж байгаа нь аль ч байгууллагын дотоод үйл ажиллагааны нийтлэг журам юм. Улсын Их Хурлын хуралдааны явцын тэмдэглэлтэй иргэд, албан тушаалтнаас танилцахад зарим саад бэрхшээл учирч байгаа бодит байдал нь энэ үйл ажиллагааны зохион байгуулалт, зарим ажилтны үйл ажиллагаатай холбоотой байгаа учир улсын нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрх зөрчигдсөн гэх, түүнчлэн мөн санал хураалтын журам ч Үндсэн хуулийн зохих заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

6. Улсын Их Хурлын хуралдаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг сонсох нь танин мэдэх агуулгатай зүй ёсны асуудал болохын сацуу Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон нөхцөлд эгүүлэн татах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлд заасан байх тул иргэн Л.-ийн өргөдөлд буй "Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна" гэсэн шаардлагыг хангах үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 19 дүгээр зүйлийг баримтлан дор дурдсан ДҮГНЭЛТ ГАРГАВ:

Нэг. Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "... Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт, асуулгын талаар гарсан маргааныг Улсын Их Хурал эцэслэн шийдвэрлэнэ" гэсэн заалт Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ", Жаран дөрөвдүгээр зүйлийн нэг дэх хэсгийн "... Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэсэн заалтуудыг;

Хоёр. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Үндсэн хууль, энэ хууль бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалт Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн бүрэн

эрхийнхээ хугацаанд хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг;

Гурав. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хэлэлцэхдээ дараах шалтгаан, нөхцөлийг заавал тогтоосон байна:

1. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт үнэн зөв эсэх;

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн үндэслэл, шалтгааныг зөв тогтоосон эсэх;

3. “Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн хүрээ, нөхцөл байдлыг зөв тогтоосон эсэх...” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж, Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна” гэсэн заалтыг;

Дөрөв. Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын шийдвэрийн талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, эсхүл түүний итгэмжилснээр Үндсэн хуулийн цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна”, 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг танилцуулсны дараа тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, хариулт авч, санал дүгнэлт гаргаж болно”, 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай тогтоол гаргана”, 4 дэх хэсгийн “Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хянан хэлэлцээд уг дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тухайн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1. Хууль зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2. Ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүнийг ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” гэсэн заалтыг;

Тав. Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын “Монгол Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй” гэсэн хоёр дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”, мөн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар

буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Зургаа. Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 51, 54, 55 дугаар зүйлүүдийн 1 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна гэсэн иргэн Л.-ийн өргөдөлд дурдсан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолын агуулга:**

Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн 1 дүгээр дүгнэлтэд дурдсан Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэн нэг дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Хоринесдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байна гэсэн хоёр дахь хэсгийг тус тус хүлээн зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хэсгийн гурав, дөрөв, тав дахь заалтуудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцийн зарим дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулганд хэлэлцүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлаас 1993 онд баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох зүйл, заалт нь Үндсэн хуулийн холбогдох долоон зүйл, заалтыг зөрчсөн байдаг юм. Тэдгээр нь гол төлөв Үндсэн хуулийн цэц, Улсын Их Хурал хоёрын хоорондын харилцааг зохицуулсан зүйл, заалт байдаг ба тэдгээрээс нэлээдгүй нь шүүх эрх мэдэлд халдсан утга агуулгатай байдаг.

\* \* \*

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1995.09.07 № 02**

**Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолын заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Л., А.

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Л.-ийн тайлбарын агуулга:**

Цэцээс дүгнэлт гаргасны дараа би өөрийн хүсэлт хангагдсан эсэхийг шалган тулгахад Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 1-ээр нэхэмжлэл гаргаагүй, 54 дүгээр зүйлийн 4-ийн 4-өөр нэхэмжлэл гаргасан, 55 дугаар зүйлийн 2, 3-ын заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлтэнд дурдаагүй, Цэцээс дүгнэлт гаргаагүй байна. Энэ талаар Байнгын хорооны дүгнэлтэд үндэстэй дурджээ. Би Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдох асуудлаар өргөдөл гаргасан юм. Би өргөдлийнхөө шаардлагыг тодруулах зорилгоор үүнийг тайлбарлаж байна.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч А.-гийн тайлбарын агуулга:**

Иргэн Л. Үндсэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой чухал асуудлууд хөндөж тавьсанд талархалтай байгаагаа илэрхийлье.

Үндсэн хуулийн цэцээс 1994 оны 12 дугаар сарын 16-нд Улсын Их Хурлын даргын нэр дээр ирүүлсэн албан бичиг, түүнд иргэн Л.-ийн зарим өргөдлийг хавсарган ирүүлсэн. Тэр өргөдөлд Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн талаар гомдол гаргаагүй юм билээ. Гэтэл Цэц дүгнэлт гаргасан харагдсан байна. Цэцийн дүгнэлтийн 6 дахь хэсгийн талаар Улсын Их Хурал хэлэлцсэн боловч Үндсэн хуулийн цэц нэгэнт хянан шийдвэрлэсэн. Иймд энэ асуудлаар тусгайлан тогтоол гаргах, тогтоолд заалт оруулах шаардлагагүй гэж үзсэн. Гишүүн Б. санал гаргасан. Гишүүдийн саналаар тусгайлан акт гаргахгүйгээр дээрх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэсэн болно.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд зааснаар 21 асуудлаар дүгнэлт гаргах ёстой. Энэ дотроос зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаар Цэц дүгнэлт гаргасан үед Улсын Их Хурал түүнийг яаж хэлэлцэх вэ гэдэг журмыг Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлд заасан. Энэ зүйлд Цэцээс дүгнэлт гаргах бүх асуудлыг багтаагаагүй. Энэ бол Улсын Их Хурлын тухай хуульд оруулах өөрчлөлтөөр зохицуулагдах зүйл юм. Энэ талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй. Учир нь Цэц дүгнэлт гаргасан үед Улсын Их Хурал түүнийг сонсоод Ерөнхийлөгчийг огцруулна гэдэг асуудал байж болохгүй.

Улсын Их Хурлын 88 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэдэг асуудал бий. Энэ талаар Улсын Их Хуралд гурван янзын практик бий. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-ын 3, 4-т заасан асуудлаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэрхэн хэлэлцэх вэ? Эсхүл хэлэлцэхгүй юу? гэдэг асуудал одоогоор эрх зүйн зохицуулалтгүй байгаа болно. Энэ бол хуулиар зохицуулбал зохих асуудал болно. Энэ талаар Улсын Их Хуралд оруулсан Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан болно.

### **3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Л.-гийн тайлбарын агуулга:**

А. гишүүний тайлбарыг дэмжинэ. Үндсэн хуулийг амьдралд хэрэгжүүлэх асуудлаар иргэн Л. олон удаа хүсэлт гаргасан, Цэц хэд хэдэн удаа дүгнэлт гаргажээ. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан механизм ажиллаж байгаагийн илрэл болно.

Гэхдээ Улсын Их Хурлын тухай хуулийг боловсронгуй болгох асуудал бий. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйл Үндсэн хуулийг зөрчөөгүй юм шүү. Яагаад гэвэл Улсын Их Хурал бол Үндсэн хууль тайлбарлах эрхийнхээ дагуу Үндсэн хуулийг амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийг Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлд дэлгэрүүлэн тодотгосон байна.



Мөн хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйл, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоол аль аль нь Үндсэн хуулийг тодотгох зорилгоор гарсан зүй ёсны актууд мөн. Нэгэн зүйл дээр нэмж тайлбарлахад Ерөнхийлөгчийг огцруулах тухай Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал сонсоод асуудал шийдвэрлэнэ гэвэл Их Хурал маань компьютер болно биз дээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төрийн тогтолцоо бол бат бэх байх ёстой. Үүнийг бэхжүүлэх талаас нь Цэц цаашид дүгнэлт гаргахдаа бодолцоно байх гэдэгт найдаж байгаагаа илэрхийлье.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн материалаас үзвэл Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 1994 оны 88 дугаар тогтоолын 2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн болох нь тогтоогдов.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар үүссэн маргааны талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж, уг дүгнэлтийн хууль зүйн үндэстэй эсэхийг шийдвэрлэх тухай заалт Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлд тусгагдсан ба эл зохицуулалтын дагуу Улсын Их Хурлын гишүүн С., Улсын ерөнхий прокурор Г. Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэж, Улсын ерөнхий прокурор Г. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт, мөн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоол гаргажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д буй “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэсэн заалт, мөн зүйлийн 2-т буй “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна” гэсэн заалт, мөн хуулийн 2-т буй “Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар огцруулна” гэсэн заалт, мөн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3-т буй “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана” гэсэн заалтаас үзэхэд Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан үндэслэлээр гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэхгүй нь тодорхой байна.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т дурдсан асуудлаар гарах Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж зөвшөөрөх эсэх тухай асуудал бол Цэцээс Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрхийг үгүйсгэх буруу практик тогтож байна.

Хоёр. Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх тухай заахдаа зөвхөн Улсын Их Хурлын шийдвэрийн талаарх Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх агуулга тусгагдсан байна. Гэвч уг зүйлийн гурав дахь хэсэг нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 4-т заасан асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн бүх дүгнэлтүүдийг хэлэлцэхэд хэрэглэх практик тогтох үндэслэл болсон нь Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад нотлогдов.

Гурав. Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтэд иргэн Л.-ийн Цэцэд хандаж тавьсан хүсэлт буюу Улсын Их Хурлын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн талаар тодорхой шийдэл гаргаагүй байна. Иймд Цэцийн 1 дүгээр дүгнэлтийн 6 дахь хэсэгт зохих өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Дөрөв. Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлтийн 6 дахь хэсгийг хүлээн авсан эсэхийг заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, мөн хуулийн 45<sup>2</sup> дугаар зүйлийг бүхэлд нь;

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1994 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 88 дугаар тогтоолын хоёр дахь заалтыг, Улсын Их Хурлын 1995 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 51 дүгээр тогтоолын хоёр дахь заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

3. Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтийн “Зургаа” гэсэн хэсгийг “Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2, 38 дугаар зүйлийн 1, мөн хуулийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4, 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна” гэж өөрчлөн найруулсугай.

4. Энэхүү тогтоол гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахдаа иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийн шаардлагад дурдагдсан зүйл, заалт болгонд хариу өгөх учиртай. Гэтэл Үндсэн хуулийн цэц иргэн Л.-ийн мэдээллийн шаардлагад дурдагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлтэд огт дурдаагүй байна. Эндээс их ойлгомжгүй байдал үүснэ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийг зөрчсөн, эсхүл Үндсэн хуулийг зөрчөөгүй талаар Улсын Их Хурал тааварлаж чадахгүй учир хэлэлцэж мөн чадахгүй юм.

Эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн бөгөөд түүнийг огцруулах үндэслэл байна хэмээн Цэцийн шийдвэр гарсан тохиолдолд Улсын Их Хурал уг шийдвэрийг хэлэлцэж хүлээн зөвшөөрөх, хүлээн зөвшөөрөхгүй талаар шийдвэр гаргах эрхгүй юм. Харин зөвхөн огцруулах эсэх асуудлыг л хэлэлцэх учиртай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2008.01.24 № 01

### Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч -Улсын Их Хурлын гишүүн Г., О.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

1/ Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас гаргасан шийдвэрийг Улсын Их Хурал хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхэд халдаж, Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан байна. Улсын Их Хурлын дарга тодорхой хуулиудад засвар хийсэн нь огцруулах үндэслэл бүхий Үндсэн хууль зөрчсөн үйлдэл болох тухай иргэдийн өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн их суудлын хуралдаанаараа уг асуудлыг хянан хэлэлцээд “хууль засварласан нь Үндсэн хууль зөрчиж, энэ нь огцруулах үндэслэл мөн” гэсэн дүгнэлтийг гаргасан билээ.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх тухай бус, харин Үндсэн хуулийн цэцийн “Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэл мөн” гэсэн дүгнэлт Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэл болох эсэх тухай” хэлэлцэн огцруулах үндэслэлгүй гэсэн шийдвэрийг нууц санал хураалтаар гарган Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр оруулсан байна. Улсын Их Хурал 2007 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцээд Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 заалтыг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хорооны шийдвэрийг “дэмжих, дэмжихгүй” гэсэн асуултаар нууц санал хураалт явуулан олонхийн саналаар Улсын Их Хурлын даргыг огцруулахгүй байх шийдвэрт хүрсэн байна. Энэ нь Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй, Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4-т заасан үндэслэлээр 10.2-т “...бүрэн эрх нь дуусгавар болно” гэж зааснаар нэгэнт дуусгавар болсон бүрэн эрхийг “сэргээсэн” шийдвэр болж Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхэд халдан, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 3, Жаран долдугаар зүйл, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2/ Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5-ын “Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн заалтын “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн нь Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалттай агуулга зарчмын хувьд адил байгаа тул миний нэхэмжлэлдээ дурдсан Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг мөн адил зөрчсөн гэж үзэж байгаа тул Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5 заалтын “... Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн хэсгийг хүчингүй болгож өгөхийг уламжилж байна.

3/ Үндсэн хуулийн цэцээс огцруулах үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах асуудал нь зөвхөн Улсын Их Хурлын дарга, гишүүдээр хязгаарлагддаггүй болно. Энэ асуудлаар урьд нь Үндсэн хуулийн цэц тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Улсын Их Хурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3 заалтууд, 45

дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн болохыг тогтоон дүгнэлт гаргасан байна. Гэтэл Улсын Их Хурлаас батлан гаргасан Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд Үндсэн хуулийн цэцээс зарим албан тушаалтнуудыг Үндсэн хууль зөрчсөн болон огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлтийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заалтууд Үндсэн хууль зөрчсөн байх тул өргөдлийнхөө нэхэмжлэлтэй хамтад нь хянан хэлэлцүүлж нэг мөр эцэслэн шийдвэрлүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

а/ Дээрх хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9-д “Цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэсэн дүгнэлт гаргасан бол түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг энэ хуульд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд харин Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхи дэмжсэн бол энэ тухай хууль батална” гэсэн заалтын “...тухайн албан тушаалтныг ...түүнийг огцруулах, эгүүлэн татах асуудлыг энэ хуульд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэх...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Жаран долдугаар зүйлийг;

б/ Мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, түүнчлэн Цэц Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол эдгээр шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороо Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана” гэсэн заалт, мөн 35 дугаар зүйлийн 2-д “Нэгдсэн хуралдаан шүүхийн тогтоол, Цэцийн дүгнэлт, Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхи дэмжсэн бол Ерөнхийлөгчийг огцруулах тухай хууль батална” гэсэн заалтын “...шүүхийн тогтоол... Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны санал дүгнэлтийг...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 3, Жаран долдугаар зүйлийг;

в/ Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-д “Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хуралдаж Байнгын хорооны, хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батална” гэсэн заалтын “... хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг...” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Жаран долдугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., О. нарын гаргасан тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-ийг зөрчөөгүй талаар:

Иргэн Х. 2007 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд гарсан өргөдөлдөө Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн нь тус тус Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-ийг тус тус зөрчсөн байна гэжээ. Ийнхүү зөрчсөн гэсэн үндэслэлээ “Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т зааснаар гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авах, эсэх тухай эрх Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдоогүй бөгөөд зөвхөн хэрэгжүүлэх үүрэгтэй”, Улсын Их Хурлын дарга, гишүүнийг огцруулах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргавал Улсын Их Хурлын дарга, гишүүний бүрэн эрх шууд дуусгавар болно гэж үзэж тайлбарлажээ.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлыг хэлэлцдэггүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, түүнийг хэлэлцэх журмыг тогтоосон заалтуудаас энэ нь тодорхой харагдаж байна. Тухайлбал, уг хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4-т “нэгдсэн хуралдаан холбогдох албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа уг албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг хэлэлцэх эсэх, тухай зөрчлийг арилгуулах талаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэнэ”, мөн зүйлийн 32.2.9. “Цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэж дүгнэлт гаргасан бол түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг энэ дэгд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх” гэснээс харахад Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцээс албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх болон огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар гаргасан дүгнэлтийн зөв, бурууг дүгнэж, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх талаар шийдвэр гаргахгүй, Цэц дүгнэлт гаргасныг үндэслэн Улсын Их Хурал албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Харин иргэн Х.-гийн өргөдөлд Улсын Их Хурлын дарга, гишүүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй талаар гаргасан “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн нь Улсын Их Хурлын бүрэн эрх, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдах, цаашилбал, хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын бие даасан байдлыг хөндөж байна. Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж төрийн 3 институцэд хуваарилсан нь энэхүү 3 институцыг “хооронд нь харилцан хамаарал, хяналт, тэнцэлтэй болгох гэсэн зорилготой” юм. Нөгөө талаар энэ 3 эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага хуульд заасан чиг үүргээ, хуулиар олгосон эрхийн хүрээнд, хуульд заасан журмаар бие даан хэрэгжүүлдэг байх ёстой.

Улсын Их Хурал бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг, төлөөллийн байгууллага бөгөөд түүний гишүүнийг Үндсэн хуульд зааснаар “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд, нийтээрээ, чөлөөтэй, шууд” сонгодог ба өөрийн легитим шинжээ ардчилсан замаар “олж авдаг” төрийн эрх барих дээд байгууллага билээ. Харин хууль тогтоох эрх мэдлийн байгууллага нь өөрийн бүрэн эрхийг хяналтгүйгээр, дур зоргоор эдлэх боломжийг хязгаарлахын тулд шүүх болон Үндсэн хуулийн цэц нь түүнд болон түүний гишүүн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн эсэхэд хяналт тавьж байдаг. Нөгөө талаар хууль тогтоох байгууллага өөрийн бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлж, бодлогын шийдвэр гаргахад түүний гишүүний халдашгүй байдал нэг баталгаа нь болж байдаг.

Иймээс Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэцийн харилцан хамаарлыг нэг тал нь нөгөөгөө бүрэн хянах давуу байдал олгохгүйгээр, Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдалд нөлөөлөх боломжгүйгээр, Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчсөн бол зөрчлийг арилгаж байхаар хуульчилж өгсөн байдаг. Ингэхдээ Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан асуудлыг хэлэлцэж дүгнэлт, хэрэв Улсын Их Хурал энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол эцсийн шийдвэр гаргадаг бөгөөд харин 3, 4-т заасан асуудлаар тухайлбал, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх, тэднийг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулдаг байхаар харин дүгнэлт гарсныг үндэслэн Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах, Улсын Их Хурлын даргыг огцруулах эсэх асуудлыг Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхэд хадгалан шийдвэрлэдэг байхаар Үндсэн хуульд тусгажээ.

Түүнчлэн энэ нь нөгөө талаар Үндсэн хуулийн цэц улс төрийн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах замаар улс төрийн үйл ажиллагаа, нөлөөлөлд орохоос

сэргийлсэн бас аливаа албан тушаалтныг эгүүлэн татах буюу огцруулах асуудлаар түүнийг анх томилсон буюу бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн субъект эцсийн шийдвэр гаргана гэсэн агуулга давхар явж байгаа гэж үзэж байна. Харин иргэн Х.-гийн бичсэнээр бол, Үндсэн хуулийн цэц нь Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүнийг огцруулах, эгүүлэн татах эрхтэй болж байна. Ингэснээр бидний дээр хэлсэн төрийн эрх мэдлийн байгууллагуудын харилцан хяналт, тэнцвэртэй байдал алдагдаж, өөрийгөө төлөөлүүлэхээр сонголт хийсэн иргэний эрх зөрчигдөж, хууль тогтоох байгууллагын төлөөллийн чанар үгүй болж, Үндсэн хуулийн суурь зарчим эвдэгдэнэ.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц нь хууль, зарлиг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, ард нийтийн санал асуулга Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлыг хэлэлцэн дүгнэлт гаргаж, уг дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргадаг. Харин мөн зүйлийн 3, 4-т Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар тус тус дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулахаар гэжээ.

Үндсэн хуулийн энэ заалтын дагуу дээрх 3, 4-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын дарга, гишүүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй эсэх асуудлаар зөвхөн дүгнэлт гаргахаар байна. Эндээс Цэц Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар эцсийн шийдвэр гаргахгүй юм байна, нөгөө талаар эцсийн шийдвэрийг өөр субъект бүрэн эрхийнхээ дагуу гаргана гэсэн логик дүгнэлт гарч байна. Харин тэрхүү эцсийн шийдвэр гаргах эрхийг Үндсэн хуульд Улсын Их Хурал болон эрх бүхий бусад албан тушаалтанд тусгайлан олгосон байна. Улсын Их Хурал энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ тэднийг эгүүлэн татах, огцруулах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасныг үндэслэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын дарга, гишүүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэдэг.

“Улсын Их Хуралд оруулсан” албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлтийг Улсын Их Хурлын тухай хуулийн Үндсэн хуулийн зөрчилтэй гэж өргөдөл гаргагчийн үзэж буй 6.6.5, 10.2.4 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2.9, 35.1, 38.2 дахь хэсгийн дагуу хэлэлцдэг юм. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь заалтаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1 дэх хэсгээр зохицуулсан ба ингэхдээ “хүлээн зөвшөөрсөн” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Харин Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтаар гарсан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын тухай хуулийн 6.6.5, 10.2.4-т “хүлээн авсан” гэсэн нэр томъёогоор буюу агуулга өөр тул өөр өөр нэр томъёог хэрэглэн хуульд тусгасан байна.

Үндсэн хуулийн Цэцээс Улсын Их Хурлын даргыг албан тушаалаас нь огцруулах үндэслэлтэй гэсэн 2007 оны 6 дугаар дүгнэлтээ гаргахад Улсын Их Хурлын тухай хуулийн 6.6.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.2 дахь хэсгийн дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг хэлэлцээгүй бөгөөд Улсын Их Хурлын даргыг огцруулах эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргаснаас эдгээр хуулийн заалтууд нь албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар болон түүнийг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй эсэх талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг зохицуулаагүй гэдэг нь тодорхой байна.

Харин энд дурдахад иргэн Х. өргөдөлдөө Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 6 дугаар дүгнэлт нь Улсын Их Хурлын даргыг огцруулах

үндэслэл болох эсэх тухай хэлэлцэн огцруулах үндэслэлгүй гэсэн шийдвэр гаргасан, түүнийг Улсын Их Хурал дэмжинэ, дэмжихгүй гэсэн санал хураан шийдвэрлэсэн гэсэн нь үнэнд нийцэхгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаан дээр “Улсын Их Хурлын дарга Н.-ийг албан тушаалаар нь огцруулна: дэмжинэ, дэмжихгүй” гэсэн саналын хуудсаар нууц санал хураалт явуулсан юм. Иймээс Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

3/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийг зөрчөөгүй талаар:

Дээрх хуулийн заалтууд Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийн “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно” гэснийг зөрчсөн байна гэж иргэн Х. үзэж түүнийгээ албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэлтэй гэж гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гармагцаа хүчин төгөлдөр болж шууд хэрэгждэг, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалтан огцорч байх ёстой гэж тайлбарлажээ. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4-т “Хууль зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль зарлиг, батламж хүчингүй болно” гэжээ. Эндээс үзэхэд Цэц шийдвэр гаргасан тохиолдолд холбогдох Үндсэн хуулийн зөрчилтэй эрх зүйн акт хүчингүй болох бөгөөд харин Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т заасанчлан Цэц дүгнэлт гаргаж байгаа тохиолдолд Үндсэн хуульд нийцээгүй гэж Цэц үзсэн хууль, бусад шийдвэр хүчингүй болдоггүй билээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц дүгнэлтээрээ аливаа хууль тогтоомжийг хүчингүй болгодоггүй. Иймд Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4-т заасан Улсын Их Хурлын даргыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах, бусад албан тушаалтныг огцруулах үндэслэлтэй талаар Цэцийн гаргасан дүгнэлт нь эцсийн шийдвэр биш байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлийг зөрчөөгүй гэж үзэж байна.

4/ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2 дэх хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчөөгүй талаар:

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 нь хууль, зарлиг, Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр тус тус Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээр оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргах тухай заалт юм. Харин өргөдөл гаргагчийн бичсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг нь бүгд албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурал хэрхэн шийдвэр гаргах процессыг журамласан зүйл, заалтууд байгаа тул дээрх Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгтэй хамааралгүй, түүнийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

5/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1 дэх, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийг зөрчөөгүй талаар:

Дээр дурдсанчлан Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1 дэх, 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаа тул Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн дагуу “Үндсэн хуульд хууль, зарлиг... бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэнтэй нийцэж, түүнийг зөрчөөгүй гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. 1992 онд батлагдсан Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйл, заалтад Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх, тэдгээрийг огцруулах болон эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцэхээр заасныг Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлт, мөн оны 2 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн зөрчил мөн гэж үзэж Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосон байна.

“Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5-д “Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан”; 10 дугаар зүйлийн 10.2.4-т “Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан” гэж тус тус заасны “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн нь холбогдох албан тушаалтны талаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал агуулгын хувьд хянан хэлэлцэж, уг дүгнэлтийг хүлээн авах эсэх асуудлыг шийдвэрлэх тухай зохицуулалт болсон байна” гэж өргөдөл гаргагч үзсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон хуулийн заалтыг Улсын Их Хурал ийнхүү агуулгаар нь дахин сэргээсэн байж болох тул энэхүү маргааныг Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцэж хяналтын журмаар эцэслэн шийдвэрлэх үндэслэл бүрдсэн байна.

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9; 35 дугаар зүйлийн 35.1, 2; 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн зарим заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргаантай ижил агуулга бүхий маргааныг өмнө нь Үндсэн хуулийн цэц их суудлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж байсан тул уг маргааныг дээрх асуудалтай нэгтгэн Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Цэцийн гишүүн 2008 оны 4 дүгээр тогтоол гаргасан байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5, 10 дугаар зүйлийн 10.2.4-ийн “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн хэсэг нь Улсын Их Хурал уг асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж санал хураах тухай ойлголтыг төрүүлэхүйц болсон байна.

Гэвч энэхүү маргааныг Цэцийн их суудлын хуралдаанд бэлтгэх болон хуралдааны явцад Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., О. нарын гаргасан тайлбар, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалт, өнөөгийн Улсын Их Хурлын практикаас харахад Цэцийн тогтоолоор хүчингүй болсон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.



2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9-т “Цэц тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэл байна гэсэн дүгнэлт гаргасан бол түүнийг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлыг энэ хуульд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэх”, 35 дугаар зүйлийн 35.1-ийн “Ерөнхийлөгч гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор нотлогдсон, түүнчлэн Цэц Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол эдгээр шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороо Ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана”, 35 дугаар зүйлийн 35.2-ын “Нэгдсэн хуралдаан шүүхийн тогтоол, Цэцийн дүгнэлт, Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхи дэмжсэн бол Ерөнхийлөгчийг огцруулах тухай хууль батална”, 38 дугаар зүйлийн 38.2-т “Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хуралдаж Байнгын хорооны, хэрэв Цэц дүгнэлт гаргасан бол түүний дүгнэлтийг сонсож илээр санал хураалт явуулж гишүүдийн олонхи дэмжсэн бол огцруулах тухай тогтоол батална” гэсэн нь Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлт, 2 дугаар тогтоолд хамааралгүй байна.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, мөн хуулийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООЛ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.5-ын “Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан”, 10 дугаар зүйлийн 10.2.4-ийн “Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн авсан” гэж тус тус заасны “...Улсын Их Хурал хүлээн авсан” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлт, 2 дугаар тогтоолоор хүчингүй болгосон Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээн батлаагүй байна гэж үзсүгэй.

2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.9, 35 дугаар зүйлийн 35.1, 2, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлт, 2 дугаар тогтоолтой хамааралгүй гэж үзсүгэй.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар дүгнэлтээр шийдвэрлэсэн маргааныг агуулгаар нь дахин сэргээсэн гэж үзэн хяналтын журмаар шийдвэрлэсэн 2009 оны 2 дугаар тогтоолтой маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно” гэж заасан байдаг.

Иргэн Х. Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл, заалтаар Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр дүгнэлт, мөн оны 2 дугаар

тогтоолоор эцэслэн шийдвэрлэгдсэн маргааныг агуулгаар нь дахин сэргээсэн гэж үзэж мэдээлэл гаргасны дагуу Цэцийн гишүүн тогтоол гаргаж хяналтын журмаар хянан шийдвэрлэжээ. Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар бус харин агуулгаар нь дахин сэргээсэн маргаанд хамаарах эсэх талаар шийдвэр гаргасан нь учир дутагдалтай байна.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995.01.18 № 02

### Цэцийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн тухай маргааны талаар

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Их Хурлаас 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль<sup>17</sup>

- 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Иргэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3-т заасан албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ”

- 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурал... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналд үндэслэж гаргана”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Иргэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3-т заасан албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ” гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар... хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Цэцийн тухай хуулийн дээрх заалт ёсоор иргэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх заалтын дагуу л өргөдөл, мэдээлэл ирүүлэх болсон байна. Хэрэв энэ заалтыг баримталбал хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол

17 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 3-т нийтлэгдсэн

Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэхгүй байгаа тухай иргэнээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэц авч хэлэлцэх ёсгүй болж байна. Гэтэл Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна” гэж заасны дагуу ийм эрх иргэнд олгогдсон нь ойлгомжтой байна.

Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурал... хүсэлтээ чуулган буюу хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналд үндэслэж гаргана” гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг Улсын Их Хурлын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Улсын Их Хурал шийдвэрээ олонхиор гаргадаг бөгөөд гаргасан шийдвэрээ хамгаалах зүй ёсны сонирхол тухайн шийдвэрийг гаргасан олонхид бий. Гэтэл Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гарч болох ба энэхүү зөрчлийг шийдвэр гаргасан олонхи ямар нэг шалтгаанаар /хуулийн сүлжээг дутуу ашиглах, тухайн үеийн улс төрийнхөө сонирхолд хөтлөгдөх зэргээр/ олж харахгүй, нэгэнт гаргасан шийдвэрээ Цэцээр хянуулаад олох юмгүй тул Цэцэд хүсэлт гаргах сонирхол төрөхгүй. Ийнхүү хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн тухайн заалтын үйлчилгээг хаасан байна. Энэ нь Үндсэн хуулийг дээдлэх хэвийн үйл ажиллагаанд ч муугаар нөлөөлж болно. Төрийн ардчилсан тогтолцоотой улсуудад харьцангуй цөөн тооны гишүүн хамтран эсвэл намын бүлэг Үндсэн хууль зөрчигдсэн тухай маргаан үүсгэж Үндсэн хуулийн шүүхдээ хандах эрхийг хуулиар урьдчилан олгосон байдаг нь парламент алдаагаа өөрөө засах, хууль тогтоох үйл ажиллагаанд нямбай хандах, төрийн тогтвортой байдлыг хангах хөшүүрэг болж өгдөг байна. Цэцийн тухай хуулийн энэ заалт нь зарим үед парламент дахь улс төрийн тэмцлийг гудамжинд түлхэн гаргах өдөөн хатгалгын үүрэг гүйцэтгэж ч мэдэх юм.

## 2. Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг намын бүлэг, аль эсвэл Улсын Их Хурлын тодорхой тооны гишүүн хамтран Улсын Их Хурлын хүсэлтийг гаргаж болдог байхаар өргөтгөвөл Үндсэн хуулийн тодорхой заалтын үйлчилгээг хааж байгаа дээрх зөрчил арилна. Ийм боломж нээгдсэнээр Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хууль дээдлэх хамтран ажиллах явдалд ахиц гарах, төрийн эрхийн төлөө намуудын хоорондох улс төрийн тэмцэл илүү соёлтой болох нь дамжиггүй. Миний өргөдөлд бичигдсэн Үндсэн хууль зөрчигдөж байгаа тухай маргааныг анхааралтай хянан шийдвэрлэж өгнө гэдэгт гүнээ найдаж байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдсөн юм байхгүй. Цаана нь иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх нээлттэй байгаа гэж үзэж байна. Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт ч мөн Үндсэн хуулийг зөрчөөгүй. Улсын Их Хурал бол хамтын хариуцлагын байгууллага учраас шийдвэрээ олонхийн саналд үндэслэн гаргадаг ёстой.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай аль ч асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах тухай иргэдэд Үндсэн хуулиар нэгэнт олгогдсон эрхийг хэт хязгаарлаж, зөвхөн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтанд хамруулж уг эрхийг эдлүүлэх болгосноор Үндсэн хуулийг илэрхий зөрчихөд хүргэсэн байна.

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөвхөн Улсын Их Хурлын баталсан хуулиуд хийгээд түүний бусад шийдвэрүүдтэй холбон явцууруулж ойлгох нь учир дутагдалтай тул энэ хэсгийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Иймээс энэ талаархи иргэн Л.-ийн гомдлыг хангах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байгаа тухай иргэн Л.-ийн үүсгэсэн маргааны талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаас одоог хүртэл Үндсэн хуулийн цэцэд Улсын Их Хурлаас хүсэлт ирж байсан тохиолдол гараагүй байна. Энэ нь Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын иргэнийхээ хувьд Үндсэн хуулийн цэцэд хандах боломжтой байдагтай холбоотой болов уу.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1995.05.10 № 01

### Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурал итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн Л.-ийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын хуралдаанаар Цэцийн дүгнэлтийг авч хэлэлцсэн байдлаас үзэхэд Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг дараах байдлаар тайлбарлаж байгаа нь нотлогдож байна. 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргаануудаас Цэцийн харьяалалд хамаарах хэсгийг тогтоож өгч байгаа юм. Иймээс Улсын Их Хурлын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс Цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэц харьяаллын дагуу шүүх зэрэг байгууллагад шилжүүлэх ёстой. Цэц бол Үндсэн хуулийн шүүх биш зөвлөх шинжтэй байгууллага юм.

Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн заалтад үл хамаарах Үндсэн хууль зөрчсөн асуудлаар Улсын Их Хуралтай нэг удаа зөвшилцөх боловч эцсийн шийдвэр гаргах эрхээ хадгална гэсэн агуулгатай Үндсэн хуулийн заалтаас зөвлөгд биш, шүүхэд илүү ойр тогтолцоо болох нь харагдаж байгаа бөгөөд Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар Цэцэд хандах эрх бүхий субъектуудын хувьд цорын ганц ялгааг Үндсэн хуулиар тогтоосон юм. Энэ нь Цэц иргэнээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг өөрийн санаачилгаар, бусад субъектээс ирүүлсэн хүсэлтийг заавал хэлэлцэж шийдвэрлэх ёстой гэж Үндсэн хуульд зааснаар давхар нотлогдож байгаа билээ. Гэтэл Цэцийн тухай хуульд Үндсэн хуулийн энэ тодорхой заалтыг иргэний эрхийг хохируулах замаар шийдсэн нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх заалт төдийгүй, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2-ыг давхар зөрчихөд хүрнэ.

Цэцийн дүгнэлтэд Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь заалт Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэн миний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Цэцийн бүх гишүүдийн хуралдааны тухай 1995 оны 5 дугаар сарын 2-нд “Ардын эрх” сонинд нийтлэгдсэн зарлалаас үзэхэд миний Цэцэд хандаж тавьсан гомдлыг бүхэлд нь хянах агуулга харагдаж байна. Иймд:

Аль ч тохиолдолд нэхэмжлэгч, хариуцагч тодорхой байх ёстой бөгөөд Цэц тэдгээрийн хооронд шүүхийн байр сууринаас хандах ёстой. Цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан эдгээр заалт нь Улсын Их Хурал өөрөө нэхэмжлэгч байх зөвхөн тэр тохиолдолд тохирч байгаа юм. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч, хариуцагч нь тодорхой болсон Үндсэн хуулийн маргааныг шийдэж өгөх хүсэлтийг зарим тохиолдолд гаргах тухай урьдчилан хуулиар тохирч болох юм. Ялангуяа Улсын Их Хурал дахь намын бүлэг буюу тодорхой тооны гишүүдэд Улсын Их Хурлын хүсэлтээр Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх олгох нь илүү зохимжтой байх болно.

#### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д бий “Иргэд энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтан Үндсэн хуулийг

зөрчсөн тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1-д буй “Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээлийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчиж Үндсэн хуулийг зөрчсөн тухай аль ч асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандах тухай иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хязгаарласан байна.

Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1995 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоол хууль зүйн үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн Цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... энэ хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан тушаалтан” гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанд Улсын Их Хурлаас оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Д. томилогдсон боловч хуралдаанд оролцоогүй юм. Маргагч тал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Цэцийн хуралдаанд хүрэлцэн ирээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болдоггүй.

Үндсэн хуулиар тунхаглагдсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн тохиолдолд уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхийг нь хэрхэвч хязгаарлаж болохгүй юм.

\* \* \*

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1995.03.09 № 03**

**Монгол Улсын Газрын тухай хууль болон Иргэний хуультай  
холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш., Н.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр баталсан Иргэний хууль<sup>18</sup>

<sup>18</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 1-д нийтлэгдсэн

100 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ бүлэгт заасан “газар өмчлөгч” гэснийг “төр” гэж ойлгоно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”
- Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно”
- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх, ... эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно..”

#### **Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “...Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан гаргана”

##### **1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийг хуулиар хамгаалалгүй орхисон болон Улсын Их Хурлаас баталсан Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн Хавсралт хуулийн дараах заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан гаргана” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь газар бол үл хөдлөх хөрөнгө мөн бөгөөд иргэд газрыг өмчлөх эрхтэй болсноор хувийн өмч эдийн засгийн үндсэн баталгаагаар хангагдсан билээ. Ийнхүү өмчлөгчийн эрхийг хамгаалах, Үндсэн хуульд заасан эрхийг баталгаажуулсан Үндсэн хуульд заасан хэмжээнд хязгаарлахын тулд юуны түрүүн Газрын тухай хуулийг гаргах ёстой байсан бөгөөд Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор Улсын Бага Хурлын тогтоолын хавсралтад “Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэн тэргүүнд шаардлагатай дараах хуулиудыг батлан гаргах гэсэн хэсэгт Газрын тухай хуулийг 1992 оны 2 дугаар сарын 7-нд багтаан гаргах”-аар заажээ. Энэ үүрэг тухайлбал, Газрын тухай хуулийг өмнө тэмдэглэсэн агуулгаар 1993 онд багтаан батлах үүрэг Улсын Их Хуралд шилжсэн билээ. Гэтэл Улсын Их Хурлаас 1994 оны эцэст батлан гаргасан Газрын тухай болон Иргэний хуулийн нь агуулгын хувьд иргэд газар өмчлөх эрхийг дахин устгаж байгаа учир хамгаалалгүй орхисон ба хугацааны хувьд бүтэн 2 жил гаруй хугацаа алджээ.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалтыг зөрчиж байна. Монгол Улсын иргэд Монгол Улсдаа газар өмчлөх эрхтэйг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн атал энэ эрхийг мөн чанартаа устгаж байгаа учраас хамгаалах аргагүй байдалд хүрсэн байна. Ийнхүү Газрын тухай хуульд Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг хамгаалахгүй орхисон болон үүнийгээ Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтаар баталгаажуулсан явдал Үндсэн хуулийн энэ заалтыг зөрчиж байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх, эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Монгол Улсын иргэн үл хөдлөх хөрөнгө өмчилж буй тохиолдолд газрыг ч өмчлөх эрхтэй бөгөөд энэ эрхээ

баталгаатай эдэлнэ гэж Үндсэн хуульд давхар заасаар байтал энэ эрхийг Газрын тухай хуульд хамгаалахгүй орхисон болон энэ эрхийг ямар хугацаагаар устгасан тухай Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчиж байна.

Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэдэд өмчлүүлж болно” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь хэрвээ Монгол Улсын иргэн хүсвэл газар өмчлөх эрхтэй бөгөөд зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлэх хязгаарлалтыг хангахын тулд газар төрийн хамгаалалтанд байна гэсэн Үндсэн хуулийн заалтын дагуу газрын аливаа хөдөлгөөнийг төрөөс бүртгэн хянах ёстой юм. Түүнээс гадна Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар ...төрийн өмч мөн” гэсэн заалтаар давхар өмчлөл гэсэн хууль зүйн талаасаа утгагүй зүйл тусгагдаагүй юм. Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн дээрх заалт чухамхүү ийм утга санаагаар батлагдсан болохыг Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” бүлэг дэх Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт ч давхар нотолж байгаа юм.

Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд газар өмчлөх эрхийг устгасан хууль гаргах эрхтэй боловч үүнийгээ эрх зүйн соёлтой хийх үүрэгтэй билээ. Үүний тулд Үндсэн хуульд иргэний өмчийн эрхэд халдана гэсэн утга бүхий өөрчлөлт оруулахаас эхлэх ёстой.

## 2. Иргэн Л.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийг хуулиар баталгаажуулаагүй орхисон болон Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт зөрчсөн гэсэн нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзаж байна. Үндсэн хуулиар шийдчихсэн асуудлыг шийдэгдээгүй мэтээр Улсын Их Хурал үзэж байгаа нь харамсалтай байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н., Ш. нарын тайлбарын агуулга:

Иргэн Л.-ийн Үндсэн хуулийн цэцэд гаргасан гомдол, өргөдөл дурдсан үнэлэлт, дүгнэлтийг зөвшөөрөх хууль зүйн ямар ч үндэсгүй гэж үзэж байна. Хамгийн их бодож боловсруулж байж, буурь суурьтай шийдвэрлэх асуудал бол газрыг хувь хүнд өмчлүүлэх эсэх тухай асуудал юм. Үндсэн хуульд “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэснийг хууль зүйн хувьд хэрхэн ойлгохоос эхлэх нь зөв болов уу? Иргэн Л. дээрх заалтыг тайлбарлахдаа иргэнд газар өмчлүүлэхийг хоёрдмол санаагүй шийдвэрлэсэн гэснийг бид зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна.

Үндсэн хуульд “...газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлнэ” гээгүй. Харин “... өмчлүүлж болно” гэсэн шүү дээ. Энэ хоёр үг утга агуулгаараа ихээхэн ялгаатайг мартаж болохгүй. Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг энэ удаа Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээгүй нь нэгдүгээрт, газрын гол гол харилцаа батлан гаргасан бусад хуулиудад багтаж тодорхойлогдсон, хоёрдугаарт газрыг иргэнд өмчлүүлэх нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн бэлтгэл манай оронд хараахан бүрэлдээгүй, гуравдугаарт олон түмний санаа бодлыг үндэс болгож Улсын Их Хурлын чуулган энэ асуудлыг хойшлуулсан нь цаг үеэ олсон зүй зохистой шийдвэр болсон гэж үзэж байна. Улсын Их Хурал ийм шийдвэр гаргаснаар Үндсэн хуулийг зөрчөөгүй бөгөөд өөрийн эрх хэмжээний хүрээнд ажилласан гэж үзэж байна. Улсын Их Хурал “Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” гаргахыг хойшлуулж, энэ асуудалд хандах бодлогоо тодорхойлсон болохоор дараа нь гарсан зарим хуульд орсон тодорхой заалтыг ч дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор авч үзэж ойлгох ёстой. Тухайлбал, Улсын Их Хурлын 1994 оны намрын чуулганаар хэлэлцэн баталсан “Иргэний хуулийн” 100 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл / үүнийг бид онцлов/ энэ бүлэгт заасан “газар өмчлөгч” гэдгийн дор “төр”-ийг ойлгоно



гэж заасан юм. Иргэний хуульд ийм заалт оруулсан нь хуулийг хэрэглэгч болон жирийн иргэдэд түүнийг нэг мөр ойлгоход туслах зорилго агуулсныг хэлэх нь зүйтэй болов уу.

Улсын Их Хурал нь эрх хэмжээнийхээ хүрээнд аливаа асуудлыг, тухайлбал, хуулийн төслийг хянан шийдвэрлэхдээ тухайн хууль болон асуудлын талаар шийдвэр гаргах нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бусад нөхцөл байдал бүрдээгүй, эсвэл хэрэгжих боломжгүй, эх орон ард түмний нийтлэг эрх ашиг, сонирхолд нийцэхгүй байх зэрэг шалтгаан байвал хэлэлцэхийг орхих, хойшлуулах, дахин боловсруулахыг холбогдох байгууллага, хүмүүст үүрэг болгож буцаах эрхтэй. Энэ л бүрэн эрхийн хүрээнд дээрх төсөлд хандсан болно. Дээрх байдлаас үзэхэд Иргэний хуулийн энэ заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэсгүй. Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу шийдвэрлэсэн асуудалд хөндлөнгөөс оролцож, ийм хуулийг заавал гаргах ёстой. Эсвэл хуульд ийм заалт заавал орох ёстой гэж хүчээр зүтгэх нь эрх зүйн соёлгүй, бүдүүлэг явдал гэж ойлгож байна. Аливаа хууль бус асуудлыг Улсын Их Хуралд тулган хүлээлгэх, тулган шийдвэрлүүлэх гэсэн оролдлогыг таслан зогсоох ёстой.

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт манай улсад хэрэгжиж байгаа болоод газрыг иргэдэд өмчлүүлэх асуудал нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... газрыг зөвхөн Монгол Улсын иргэдэд өмчлүүлж болно" гэж заасны дагуу /өмчлүүлж болно гэдэг нь агуулгаараа өмчлүүлж ч болох, өмчлүүлэхгүй ч байж болох/ манай улсад нээлттэй үлдэж байгаа юм.

Үндсэн хуулийн хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас баталсан хуваарийн дагуу батлан гаргана" гэсэн нь үнэн. Гэтэл Үндсэн хуулийн Тав, Зургадугаар зүйлүүдийг анхааралтай уншиж үзвэл "иргэнд газар өмчлүүлэх асуудлыг гагцхүү хуулиар зохицуулна" гэсэн болон иймэрхүү агуулгатай зүйл, заалт байхгүй байна. Газрын тухай хууль болон Иргэний хуулийг хэлэлцсэн Монгол Улсын Их Хурлын хуралдааны протоколыг судлан үзэхэд Үндсэн хуулийн цэцэд хандсан дээрх асуудлуудаар Үндсэн хууль зөрчсөн эсэхтэй холбогдож маргаан гарч байсан байна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн үед 1994 оны 11 дүгээр сарын 17-ны хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Ч. хэлэхдээ "Үндсэн хуулийн бэлэн байгаа заалтын учрыг бид янз бүрээр мушгин тайлбарлаж болохгүй. Яагаад гэвэл Үндсэн хууль бол нэг намын сонирхлын хууль биш, аль ч намын сонирхлын хууль биш ээ. Бүх намууд бүх улс төрийн хүчний балансыг илэрхийлдэг хууль. Ердийн хууль буюу урсгал хууль бол тухайн ялсан улс төрийн хүчний сонирхлыг дагаж гарч ирдэг, зарим талаараа оросоос оруулбал дур зорго орж болдог хууль байж болдог. Тэрийг Үндсэн хуулиар хязгаарладаг ёстой юм. Үндсэн хуулиа буруу тайлбарлаад мушгиад байх юм бол тэр Үндсэн хууль гэж байхын хэрэггүй болж байгаа юм. Хуулиа хэлэлцүүлээд өмчлүүлэх бэлтгэлийг 5 жилийн дотор хангах, юм шийдээгүй байж бэлтгэлийг хангана гэж байхгүй.

#### 4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг хязгаарласан, хойшлуулсан зүйл байхгүй. Газар өмчлөх эрх нээлттэй байгаа бөгөөд иргэнд газар өмчлүүлэх тухай хууль гартал л иргэдийн газар өмчлөх эрх хязгаарлагдмал байгаа гэж үзэж болно. Улсын Их Хурал иргэнд газар өмчлүүлэх асуудлыг хойшлуулахдаа соёл иргэншлийн асуудлыг болон Монголын төрт ёсны түүхэнд газрыг өмчлүүлж байсан явдал байхгүй байгаа зэргийг харгалзсан болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Одоогийн дагаж мөрдөж байгаа Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт ёсоор Монгол Улсын иргэд газар өмчлөх үндсэн эрхтэй болохыг Цэцийн хуралдааны явцад санал нэгтэй нотолсныг тэмдэглэж байна. Улсын Их Хурал

хууль тогтоох эрх мэдлийнхээ дагуу Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх асуудлыг тусгай хуулиар зохицуулахаар шийдвэрлэхдээ иргэний газар өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Газрын болон Иргэний хуульд заасныг үндэслэсэн байна.

Энэ нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрын зөвхөн Монгол Улсын иргэдэд өмчлүүлж болно”, Газрын хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Иргэдэд газар өмчлүүлэхтэй холбогдсон харилцааг зохих хуулиар зохицуулна” гэсэн заалтуудаар батлагдаж байна.

Иймд Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ бүлэгт заасан “газар өмчлөгч” гэснийг “төр” гэж ойлгоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай асуудлыг хуулиар зохицуулах тухай заалт Монгол Улсын Үндсэн хуульд байхгүй бөгөөд Улсын Бага Хурлаас 1993 онд багтаан батлан гаргах хуулиудын жагсаалтад Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль биш, Монгол Улсын газрын тухай хууль орсон байна. Иймд Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан Иргэний газар өмчлөх эрхийг үгүйсгэсэн, түүнчлэн Үндсэн хуулийн Хавсралт хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Газрын тухай хуулиудаар иргэдийнхээ газар өмчлөх эрхийг хуулиар хамгаалалгүй орхисон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл, Үндсэн хуулийн бусад заалтыг зөрчжээ гэсэн иргэн Л.-ийн гомдлын шаардлага тодорхойгүй байгаа учраас иргэн Л.-ийн энэ талаархи хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй тул Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс магадлал гарган шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Зургадугаар зүйлийн 3, Арван зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Өмчлөх эрх нь хүний салшгүй, жам ёсны эрх болохын хувьд түүнийг хүн бүхэн бүрэн дүүрэн утгаар нь эдлэх эрхтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл туйлын бие даасан эрх юм. Нэгэнт өөрийн өмч болгон авсан тохиолдолд түүнийг хэрхэн эзэмших, захиран зарцуулах нь тухайн өмчийн эзний бүрэн эрхийн асуудал байдаг. Гэхдээ газар бол онцгой өмч бөгөөд түүн дээр бүрэн эрх чөлөө хэрэгждэггүй. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэн Үндсэн хуульд заасны дагуу газар өмчилж болох боловч түүнийг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд худалдах, бэлэглэх, барьцаалах эрхгүй байдаг гэх мэт.

Газар нутаг нь аливаа улсын бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолын баталгаа, хэмжүүр болж байдаг тул Үндсэн хуулиар тогтоож, баталгаажуулж өгсөн байдаг.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995.07.03 № 04

## Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т., Б.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр баталсан Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хууль<sup>19</sup>

- 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг гурван талт эвлэрүүлэх хороогоор болон шүүхээр хянан шийдвэрлэх шатанд ажил хаяхыг хориглоно”

- 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн хүн тээвэр, улс, хот, хоорондын болон цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагад ажил хаях нь улс орны аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно”

### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно”

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Санал зөрүүтэй асуудлаар хэлэлцээ хийх, хамтын маргааныг гурван талт эвлэрүүлэх хороогоор болон шүүхээр хянан шийдвэрлэх шатанд ажил хаяхыг хориглоно”, 3 дахь хэсгийн “Цахилгаан, дулааны эрчим хүч, нийтийн усан хангамж, хотын нийтийн хүн тээвэр, улс, хот, хоорондын болон цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагад ажил хаях нь улс орны аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн дурдсан заалтууд нь хөдөлмөрчид ажлын таатай нөхцөлөөр хангуулахын төлөө тэмцэх, тухайлбал тэдний ажил хаях эрхийг онц болон дайны байдал зарлаагүй нөхцөлд ч, зарим тохиолдолд хуулиар бус Засгийн газрын шийдвэрээр хязгаарлаж болохыг зөвшөөрсөн байна. Хуулийн энэхүү хоёр заалт Үндсэн хууль зөрчиж байгаа тухайн миний өргөдлүүдийг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье. Үндсэн хуульд маш тодорхой нөхцөл байдалд хүний эрхийг хязгаарлаж болно гэж заасан. Гэтэл Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн маргаж буй

19 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 6-7-д нийтлэгдсэн

заалтад ийм нөхцөл, болзолгүйгээр, зөвхөн Засгийн газрын үзэмжээр хүний ажил хаях эрхийг хязгаарлах боломж нээж байгаа нь хүний эрхэд аюултай заалт мөн. Цахилгаан станц зэрэгт ажил хаях нь улс орны аюулгүй байдалд хохирол учруулахуйц хүнд байдал бий болгож болно. Энэ нөхцөлд онц байдал зарлаж хуулиар ажил хаялтыг зогсоож болно шүү дээ.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна гэж үзжээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөдөлмөрийн арбитрын болон сайн дураар эвлэрэх тухай 92 дугаар зөвлөмжийн 4-д “Хэрэв санал зөрүүтэй асуудлаар харилцагч талууд эвлэрэх тухай тохиролцсон байвал талуудад ажил хаях, локаутыг эвлэрэх үйл ажиллагаа явагдаж буй хугацаанд зогсоох нь зүйтэй” гэж заасан байна. Энэ байдлаас авч үзвэл энэ заалт нь хүний эрхийг хязгаарласан бус харин талууд харилцан зөвшилцөлд хүрэхэд саад болохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд харин зөвшилцөлд хүрч чадахгүй бол цаад талд нь ажил хаях эрх нь хадгалагдаж байгаа гэж ойлгох нь зүйтэй болов уу.

Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзжээ. Уг асуудлыг Улсын Их Хурал ихээхэн анхааралтай хэлэлцэж, төсөлд ажил хаялтыг хориглох заалт байсныг Засгийн газраас тодорхой арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор: “... 1 сарын хугацаагаар хойшлуулж болно” гэж хуульчилсан юм. Бидний үзэж байгаагаар энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлийн заалттай нийцэж байна гэж үзэж байна. Иймд Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтууд нь иргэдийн ажил хаях эрхийг хязгаарлах юмуу хориглоход бус, харин маргагч талуудыг эвлэрүүлэх, нэгэнт гарсан хамтын маргааныг зохицуулахад чиглэгдсэн процессын ажиллагаа тусгасан заалтууд байна.

2. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэсэн заалттай Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд агуулгаараа нийцэж байна.

3. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг нь үйлчлэх хүрээний хувьд гагцхүү онц болон дайны байдал зарласан тохиолдлыг хамрах нь уг хэсгийн агуулгаас харагдаж байна. Иймд Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь заалтууд нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилж байна”

**Тэмдэглэл:**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А(XXI) тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын<sup>20</sup> 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зэвсэгт хүчин, цагдаагийн газар, төрийн захиргааны бүрэлдэхүүнд орсон этгээдийн ажил хаях эрхийг хязгаарлаж болох тухай дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл, ажил хаях эрх нь огт хязгаарлаж болохгүй тийм эрх биш бөгөөд дээрх тохиолдолд Засгийн газар ажил хаях эрхийг зөвхөн хамгийн уртдаа 1 сараар хязгаарлахаар зохицуулалт хийсэн байна.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1995.08.02 № 05**

**Цагдаагийн байгууллагын тухай хууль Үндсэн  
хууль зөрчсөн тухай маргааны талаар**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль<sup>21</sup>

- 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална”
- 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална”

**Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно..”
- Хорьдугаар зүйл “...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”

20 Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.

21 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 8-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Э.-гийн мэдээллийн агуулга:**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т “Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх журмыг Монгол Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж тус заасан нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын “... хэнийг ч дур мэдэн баривчилж буюу цагдан хорьж болохгүй... хуулиар тогтоосон үндэслэл, журмаас бусад аль ч тохиолдолд хэнийг ч хорьж болохгүй... хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, түүний орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууцад дур мэдэн, хууль бусаар халдах, мөн түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй”, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн “... хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно... иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хуулийн 45 дугаар зүйлд “... хамгаалах тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийн жагсаалт, бүх төрлийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг Цагдаагийн төв байгууллагын дарга дангаараа буюу Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална” гэсэн заалт нь хүний эрх, эрх чөлөөг тодорхой тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болох, түүнчлэн хууль тогтоох эрхийг зөвхөн Улсын Их Хуралд хадгалах тухай Үндсэн хуулийн эрхийг зөвхөн Улсын Их Хуралд хадгалах тухай Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “... хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэсэнтэй зөрчилдөж байгаа юм.

### **2. Иргэн Э.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:**

Би Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан гомдолдоо хуульд огт байхгүй зүйлийг нэмж бичээгүй ч төсөл байхаас өөрчлөгдсөн зарим заалтуудыг андуу ташаарсан талтай. Ийм ч учраас өргөдөлд дурдсан цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэсэн нэхэмжлэлээсээ татгалзаж байна. Харин хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт болон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай” олон улсын пактын холбогдох заалтуудыг зөрчжээ. Ер нь хүний эрх, эрх чөлөөнд халдсан ямарваа харилцааг хуульд тулгуурласан нэрийдлээр заавар, журмаар зохицуулж болохгүй байх. Цагдаагийн байгууллагын хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу гарсан заавар, журмуудад нэр бүхий заалтуудаас агуулгын хувьд хальсан гэж үзэх зүйлүүд цөөнгүй тохиолдож байна. Энэхүү баримтаас ч үзсэн Цагдаагийн байгууллагын хууль Үндсэн хууль зөрчиж байгаа юм биш үү. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтууд хуультай адил хэм хэмжээ тогтоож өгчээ. Тэрхүү зааврууд нь техник, технологийн биш, агуулгын шинж чанартай болжээ.

### **3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг урьд нь зарлиг, тогтоол, тушаалаар зохицуулж байсан бол 1993 онд Улсын Их Хурлаас баталсан хууль нь анхны хууль болж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуультай нийцүүлэхэд чухал алхам болсон. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж иргэн Э.-гийн гаргасан өргөдөл үндэслэлтэй бус болох нь дараах байдлаар нотлогдож байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх/тагнах/ ажлын журмыг Цагдаагийн төв байгууллага батална” гэсэн үг байхгүй. /Төрийн мэдээлэл эмхтгэл, 1993, № 8, 944 дэх тал/, атал тэр нэмж бичээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд явуулсан.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлыг хуулиар зохицуулна” гэсэн үгийг иргэн Э. “Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх/тагнах/ ажлын журмыг Цагдаагийн төв байгууллага батална” гэж өөрчлөн найруулсан. Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах үндэслэл, журмыг эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиар зохицуулдаг нь хэн хүнд ойлгомжтой баймаар.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Цагдаагийн байгууллага нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас дээр дурдсан хуульд заасны дагуу цагдан хорих, баривчлах, албадан саатуулахаар шилжүүлсэн хүмүүсийг хүлээн авч, холбогдох шийдвэрийг биелүүлэх агуулгатай юм. Харин хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэг нь зөвхөн шийдвэрийг биелүүлэх, тухайлбал, байр сууц, хоол унд, ариун цэвэр, эрүүл мэнд, хувцас, харуул хамгаалалт, төлбөрт үйлчилгээ, ном хэвлэл ашиглах, телевиз, радио, хүлээн авагчтай, тоглоом тоглох зэргийг эл журмаар тогтоосон байна. Эдгээрээс үзэхэд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байна.

Иргэн Э. хуулийн 45 дугаар зүйлд “...хамгаалах тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгслийн жагсаалт, бүх төрлийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга дангаараа буюу Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална” гэсэн заалт нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзжээ. Гэтэл энэ нь хуулийн заалтаас өөр болсон.

Хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж заажээ. Хуулийн 40, 41, 42, 43, 44, 46 зэрэг зүйлд цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх үндэслэл, тавигдах хууль ёсны шаардлага, журмыг нарийвчлан тогтоож зохицуулсан юм. Харин галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгслийн ашиглалт, хадгалах зэрэг техникийн шинжтэй асуудлыг энэ хуулийн хүрээнд зохицуулах эрхийг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын даргад олгосон. Хүлэг, ороох цамц, усан хөөрөг, гар хурууны гав, бороохой гэх мэт нь ямар стандартчилал, технологитой байх нь хууль тогтоох бус харин цэвэр техникийн шинжтэй асуудал билээ.

Хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж заажээ. Энэ нь тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэлтэй хамт ороогүй, зөвхөн хамгаалах тусгай хэрэгсэл. Хуулийн 41 дүгээр зүйлд цагдаагийн тусгай хэрэгслийн нэгэн төрөл нь хамгаалах тусгай хэрэгсэл болохыг тогтоожээ. Ингэснээр хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдах учиргүй бөгөөд гагцхүү амь дүйсэн үед цагдаа өөрийгөө гэмт хэрэгтний халдлага довтолгооноос хамгаалахад зориулагдсан юм. Өнөөдөр соёлт хүн төрөлхтөн цагдаагийн амь нас, эрүүл мэнд золиослогдохоос аврахад чиглэгдсэн бамбай, өмсгөл зэрэг олон арга хэрэгслийг бий болгожээ. Ийм хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг баталж байх эрхийг хуулиар Цагдаагийн төв байгууллагын даргад олгосон. Энэ нь Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлээ бусдад шилжүүлсэн гэж үзэх үндэслэл болж чадахгүй.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Нэхэмжлэл гаргагч иргэн Э. зарим нэхэмжлэлээсээ татгалзаж байгаа юм байна. Гэтэл тэр үндэслэл нь төрийн сонин хэвлэлд нийтлэгдсэн учраас олон түмний дотор цагдаагийн байгууллагад дураар ашилдаг тухай ойлголт төрөхөд нэмэрлэсэн. Энд, Цэцийн хурал дээр нэхэмжлэлээсээ татгалзах нэг хэрэг. Хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд Үндсэн хууль зөрчиж байна, зөрчих үүд хаалгыг нээж өглөө гэсэн гомдлыг үндэслэлгүй зүйл гэж үзэж байна. Хуульд хорих, баривчлах, албадан саатуулах, зэвсэг хэрэглэх бүхий л үндэслэлийг зааж өгсөн байдаг. Тэрхүү шийдвэр, үндэслэлд тулгуурлан цагдаагийн байгууллага зөвхөн биелүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Тэр нь тодорхой журамд орж байна. Боловсронгүй болох үүднээс цааш нь хууль тогтоох, гүйцэтгэх байгууллага нэлээд зүйл хийх нь ойлгомжтой. Ялангуяа Улсын Их Хурлын гаргасан хуулийн дагуу гаргаж байгаа журмууд хууль зөрчиж байгаа эсэхэд сайн хяналт тавьж байх шаардлагатай болох нь хуралдааны явцад ажиглагдлаа. Дээрх хуулийн заалтууд Үндсэн хууль зөрчөөгүй.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалт нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гагцхүү хуульд тулгуурлан цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэр гаргаж шилжүүлсэн хүмүүсийг цагдаагийн байгууллага хүлээн авч тэрхүү шийдвэрийг хэрхэн биелүүлэх нийтлэг журам тогтооход чиглэгдсэн учраас Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Иргэн Э. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь заалт болон Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх, тагнах ажлын талаар гаргасан нэхэмжлэлээс Цэцийн хуралдаан дээр татгалзсан учраас тэрхүү маргааныг тухайлан авч хэлэлцэн шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзэв.

3. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх заалтыг мөн хуулийн 40, 41, 42, 43, 44, 46 дугаар зүйлүүдтэй уялдуулан авч үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдсонгүй гэж үзэв.

4. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу Цагдаагийн ерөнхий газраас гаргасан журам заавруудад Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хэм хэмжээ тогтоосон зарим заалт байгаа боловч уг журам заавар нь Үндсэн хуулийн цэцийн хяналтын объект биш учир хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2, 45 дугаар зүйлийн 1 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.



2. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах чиг үүрэгтэй байгууллага болохынхоо хувьд гэмт хэргийг шуурхай илрүүлэхийн тулд гүйцэтгэх ажиллагаа, хойшлуулшгүй ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно..” гэж заасан байдаг. Энэ нь хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуулиар л хязгаарлаж болно гэсэн утга санаатай.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дүгээр дүгнэлтийн тогтоох хэсгийн 3 дахь хэсэгт “Татварын байцаагчийн бие хамгаалах тусгай хэрэгслийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын Татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзэв” гэсэн боловч 1995 оны дээрх дүгнэлтээрээ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална”, мөн хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй байна гэжээ. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дүгээр дүгнэлт, 1995 оны 5 дугаар дүгнэлтүүд өөр хоорондоо зөрчилдсөн байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1995.09.04 № 06**

**Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар  
зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Монгол Улсын Их Хурлаас 1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр баталсан Иргэний хууль<sup>22</sup>

100 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх журмыг хуулиар тогтоох хүртэл энэ бүлэгт заасан “газар өмчлөгч” гэснийг “төр” гэж ойлгоно”

2. Монгол Улсын Их Хурлаас 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр баталсан Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хууль<sup>23</sup>

<sup>22</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 1-д нийтлэгдсэн

<sup>23</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 6-7-д нийтлэгдсэн

9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Цахилгаан, дулааны эрчим хүч,нийтийн усан хангамж, хотын нийтийн хүн тээвэр, улс, хот, хоорондын болон цахилгаан холбоо, төмөр замын хөдөлгөөний албаны аж ахуйн нэгж, байгууллагад ажил хаях нь улс орны аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироохоор байвал Засгийн газар уг арга хэмжээг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт, Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т байгаа онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэсэн заалтыг зөрчиж байгааг хянан үзэхийг хүсье.

Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хуульд заасан иргэний эрхийг хязгаарласан, дордуулсан байна. Энэхүү хязгаарлалтыг онц болон дайны байдал зарласан үед хийж болох асуудлыг, ердийн нөхцөлд хийсэн учраас Иргэний хуулийн энэхүү заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчиж байна. Энэ томъёоллоор дараах байдлаар танилцуулъя:

а/ Онц болон дайны байдал зарлалсан тохиолдолд иргэний эрх хуулиар хязгаарлагдах ёстой. Гэтэл ийм байдал гараагүй үед Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нь иргэний эрх, чөлөөг дордуулж, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна.

б/ Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг энэхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хориглоно. Монгол Улсын Үндсэн хуульд харшлагагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаархи заалт зөрчилдвөл уул гэрээний заалтыг баримтална” гэж заасан. Учир нь хүний эрхийг дордуулсан Монгол Улсын хуулийн заалтыг 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөх болсон. Гэтэл хүний эрхийг дордуулсан БНМАУ-ын хуулиуд, тэдгээрийн заалтыг 1992 оны 2 дугаар сарын 12-ноос хэрэглэхийг хорьжээ.

в/ Улсын Бага Хурлаас 1990 оны 12 дугаар сарын 6-нд баталсан “БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-аар бол Монгол Улсын иргэн 1990 оноос 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл газар өмчлөх эрхтэй байсан боловч 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс энэхүү эрх хасагдах болов.

г/ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлийн 1-д хүн бүр эд хөрөнгийг хувьдаа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй, 2-т хэний ч эд хөрөнгийг дураар хураан авч болохгүй гэсэн олон улсын хэм хэмжээтэй Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт нийцэхгүй байгаа юм. Эдгээр нь Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөж байгааг тодорхойлох нөхцөл болно. Эцэст нь хүсэлт болгоход Монгол Улсад иргэн газар өмчлөх эрхтэй эсэхийг Үндсэн хуулийн цэц дүгнэлтдээ хэлж өгөхийг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн тайлбарын агуулга:

Юуны өмнө Цэцийн хуралдаанд урьд нь оролцож чадалгүй хуралдаан хойшлуулах шалтгаан болгосондоо хүлцэл өчье. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц газрын тухай хуультай холбоотойгоор 3 удаа хуралджээ. Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэх үед манай хоёр гишүүний гаргасан тайлбар бол Улсын Их Хурлын тайлбар биш, тэдгээрийн өөрсдийн нь санал бодол болно. Иргэн Л. газар өмчлүүлэх асуудлаарх түүхэн асуудлыг хөнджээ. Монголд газар өмчлөх асуудал өнөө үед байсан зүйл биш Хүннүгийн үеийн асуудал юм шүү. Энэ талаар судлаачид бичжээ. Иргэн газар өмчлүүлэх асуудал Монгол Улсын Үндсэн хуульд тодорхой асуудал болно. Цэцийн хуралдаанд хэлэлцэж буй гомдолтой холбоотойгоор зарим тайлбар хийе.

а/ Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлд онц ба дайны байдал зарласан үед хүний зарим эрхийг хуулиар хязгаарлах тал бий. Энэ заалт бол иргэн Л.-ийн үзэж байгаа шиг иргэнд газар өмчлүүлэх, өмчийн харилцаатай холбоотой асуудал биш. Нөгөө талаар Улсын Их Хурал бол хуулиа тайлбартайгаар хийх эрхтэй бөгөөд энэ талаар олон улсын эдийн засаг, нийгэм соёлын тухай пактаар зөвшөөрсөн асуудал. Энэ чиглэлээр Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт гарчээ.

б/ Улсын Их Хуралд газар зохион байгуулалтын ба кадастрын гэх мэт иргэнд газар өмчлөхтэй холбоотой хуулийг Засгийн газраас оруулж ирсэн боловч Улсын Их Хурал төслийг буцаасан. Энэ нь газартай холбоотой урьдчилан шийдвэрлэгдэх газрын үнэлгээ, бусад тооцоо гэх мэт асуудалтай холбоотой. Газрын үнэлгээ гаргах, судалгаа явуулах зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагаанд Монгол Улсын одоогийн нэг жилийн төсөв зарцуулагдах гэх мэт асуудал бий. Ийм нөхцөлөөс болоод иргэнд газар өмчлүүлэх асуудлыг Улсын Их Хурал авч хэлэлцээгүй хойшлуулсан. Энэ агуулгаар Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт гарсан ба энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийг зөрчсөн гэж үзэхгүй байна.

в/ Өнөөдрийн хуралдаанд тавигдаж буй улс төрийн чанартай асуултуудад хариу өгөхгүй гэж бодож байна. Энэ бол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн эрх хэмжээний асуудал биш болно.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэдийн газар өмчлөх эрх эдлэх нь нээлттэй байгаа бөгөөд энэхүү эрхийг хэрэгжүүлэх журмыг хуулиар баталж мөрдөөгүй байна. Ийм нөхцөлд газар өмчлөлтэй холбоотой харилцаанд төр газрын өмчлөгчийн үүргийг хэрэгжүүлж байхаар Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4-т хуульчилсныг Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг хязгаарласан гэх үндэслэлгүй байна.

2. Монгол Улсад иргэн газар өмчлөх эрхтэй болох тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 3 дүгээр дүгнэлтийн хяналтын хэсэгт санал нэгтэй тэмдэглэсэн.

3. Иргэн Л.-ийн гаргасан гомдолтой холбогдох асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан дүгнэлтийн хяналтын хэсэгт Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж тэмдэглэсэн байна.

Иймд иргэн Л.-ийн хүсэлтийг хангах үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзсүгэй.

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн тухай маргааныг Үндсэн хуулийн цэц 1995 оны 7 дугаар сарын 4-нд шийдвэрлэн 4 дүгээр дүгнэлт гаргасан болохыг дурдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1995 оны намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариуг манайд ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилж байна.

#### **Тэмдэглэл:**

1. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр батлан гаргасан боловч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг 5 жилийн дараа буюу 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталсан байдаг. Дээрх хугацаанд тодорхойгүй олон асуудал гардаг байсны нэг нь Үндсэн хуулийн цэцэд 1 асуудлаар 1 иргэн 2 удаа хандаж 2 удаа дүгнэлт гаргуулсан явдал юм.

Тухайлбал: Иргэн Л.-ийн гомдлын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1995 оны 3 дугаар сарын 9-нд Монгол Улсын Иргэний хуулийн 100 дугаар зүйлийн 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Зургадугаар зүйлийн 3, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчөөгүй байна гэсэн 3 дүгээр дүгнэлт, 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн 4 дүгээр дүгнэлтийг тус тус гаргасан байна.

Учир нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтад зааснаар “уг маргааны талаар Цэцийн урьд гаргасан дүгнэлт, тогтоол хүчинтэй байгаа” тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах зохицуулалт тухайн үед байгаагүйтэй холбоотой.

2. Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 3 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тайлбарыг харьцуулан үзнэ үү.

3. Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 4 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тайлбарыг харьцуулан үзнэ үү.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1995.12.07 № 07

**Монгол Улсын Засгийн газраас Айбекс групптэй 1993 оны 4 дүгээр сарын 17-нд байгуулсан Түншлэлийн гэрээ Үндсэн хууль зөрчсөнтэй холбогдуулан Ерөнхий сайд Ж.-г огцруулах эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., З., Г.;  
Албан тушаалтан - Монгол Улсын Ерөнхий сайд Ж., түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч П., С., У.

### **Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:**

Түншлэлийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гарын үсэг зурагдсан болон энэхүү хууль зөрчсөн үйл ажиллагааг Ерөнхий сайд Ж. хууль бус аргаар хамгаалж, ийм төрлийн үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”  
- Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна”  
- Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л., З. нарын мэдээллийн агуулга:

Маргааны объект бол Монгол Улс болон Монголын Засгийн газрыг төлөөлөн шадар сайд П., Айбекс группийг төлөөлөн Х. нар хүлээн зөвшөөрч 1993 оны 4 дүгээр сарын 17-нд гарын үсэг зурсан Түншлэлийн гэрээ бөгөөд энэ баримт бичиг болон түүнтэй холбогдсон асуудлуудад Ерөнхий сайд Ж. Үндсэн хуулиар оногдсон үүргээ хөсөрдүүлж хөндсөөр ирсэн баримт нь түүнийг огцруулах үндэслэл болж байна хэмээн бид үзэж байгаа юм. Анхнаасаа зөвхөн англи хэл дээр үйлдсэн энэхүү баримт бичгийг бид Түншлэлийн гэрээ гэж нэрлэж байгаа бөгөөд энэ нь чухам юу гэсэн нэртэй байх, хүчин төгөлдөр эсэх, олон улсын гэрээ мөн эсэх зэргээс бидний өргөдөл дэх нэхэмжлэл хамаарахгүй юм шүү, өөрөөр хэлбэл аль ч тохиолдолд Үндсэн хуулийн дурдсан заалтууд ёсоор бидний нэхэмжлэлийг Цэц хянан шийдвэрлэх хууль зүйн үндэслэл байгаа юм. Энэ түншлэлийн гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн бөгөөд энэхүү зөрчсөн байдал нь түүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улс оролцох боломжгүй байгаа нь ноцтой юм. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид Түншлэлийн гэрээг гэрээ мөн гэж үзсэн. Улсын Их Хурлын 64 дүгээр тогтоолын 2 дахь заалт бол Айбекс групптэй байгуулсан гэрээнүүдэд байтугай Ж. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд байгуулагдсан Засгийн газарт хамаарах аливаа гэрээ, хэлэлцээрт хамаарахгүй болох нь Засгийн газрын танилцуулга, байнгын хорооны дүгнэлт, Улсын Их Хурлын хуралдааны тэмдэглэлээс тодорхой байна. Ийнхүү 64 дүгээр тогтоол нь хэлэлцсэн асуудлынхаа талаар мөн чанартаа юу хэлээгүй, ингэснээр Улсын Их Хурал, Засгийн газрын хариуцлагагүй байдалтай эвлэрсэн юм.

Өргөдөлд бичсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг ноцтой зөрчсөн Түншлэлийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гарын үсэг зурагдсан болон энэхүү хууль зөрчсөн үйл ажиллагааг хууль бус аргаар хамгаалж, ийм төрлийн үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа Ерөнхий сайд Ж. нь энэ бүх үйлдлээрээ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их хурлын өмнө хариуцна”, 2 дахь хэсгийн “Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана” гэснийг тус тус ноцтой зөрчсөн тул Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу Ерөнхий сайд Ж.-г огцруулах үндэслэл хангалттай байна.

## 2. Ерөнхий сайд Ж.-гийн тайлбарын агуулга:

П. 1993 оны эхээр Америкийн Нэгдсэн Улс явахынхаа өмнө Монголд гадаадын компаниудын хөрөнгө оруулахад зуучлах компани, пүүс, хүн эрж сурвалжилж байгаа тухайгаа ярьсан. Бололцоо олдвол тэр хүнтэйгээ уулзаж магадгүй гэж хэлж байсан. Би хоёр зүйлд анхаарахыг сануулж байсан. Нэгд зуучлагч, санаачилга гаргаж байгаа хүнээ сайн судлах, хоёр урьд өмнө манайхыг санаачилга гаргаагүйд итгэж, алдаж байсан тохиолдол байсныг анхаарах, ингэхдээ ерөнхий зүйл ярих хэрэггүй. Зөвхөн тодорхой төсөл хэрэгжүүлэхэд зуучлуулахыг ярихыг бодоорой гэж зөвлөсөн юм. П. гэрээ байгуулах гэж ердөө яриагүй. Тэнд очоод л шууд англи дээр зурсан байдаг юм. Энэ үйлдлийг яриа хэлэлцээ хийх, бичиг баримт боловсруулах горим журмыг зөрчсөн алдаа гэж үзэж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Засгийн газраас танилцуулга шаардсан. Тэгэхэд манайд ямар ч материал байгаагүй тул П.-гээс материал авч өгсөн. Энэ асуудлыг Засгийн газарт огт яриагүй байсан учир танилцуулгын тухай яриа байгаагүй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бэлтгэл дутуу хэлэлцсэн тал байгаа юм. Энэ бол Монгол Улсын олон улсын гэрээ биш юм.

Засгийн газар шийдвэрлэх аливаа асуудлыг асуудал боловсруулах журмын дагуу хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэдэг. Харин гаргасан шийдвэрийн тогтоол, захирамжийн хэлбэрээр илэрхийлдэг. Олонхийн саналаар шийдсэн асуудлын биелэлтийг Засгийн газрын тодорхой гишүүн биечлэн хариуцна. Гаргасан шийдвэрийнхээ талаар Засгийн газар хамтын хариуцлага хүлээнэ. Засгийн газрын тодорхой гишүүд өөрийн үйл ажиллагааны хүрээнд судлах боловсруулах асуудлыг бие даан хариуцаж шаардлага хангагдлаа гэж үзсэн үедээ Засгийн газарт оруулна. Энэ шат хүртэлх Засгийн газрын тодорхой гишүүд бие даан ажиллах үедээ алдах, онохын алин ч байсан Засгийн газрын болон Ерөнхий сайдын хариуцлагын асуудал биш юм.

## 3. Шадар сайд П.-гийн гаргасан тайлбарын агуулга:

Ийм бичиг баримт боловсруулж гэрээ байгуулахдаа шилжилтийн үед дан ганц Засгийн газруудын шугамаар орж ирж байсан зээл тусламж хүрэлцээтэй бус байсныг харгалзсан юм. Улс орноо эдийн засгийн хүнд байдлаас гаргах бололцоотой бүх арга замыг эрэлхийлж байсантай холбоотой юм. Түншлэлийн гэрээг байгуулахыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төслийн зөвлөх Х. гэдэг Америкийн Нэгдсэн Улсын иргэн зөвлөсөн. 1993 оны 4 дүгээр сарын 5-нд Америкийн Нэгдсэн Улсад суугаа элчин сайдын яамнаас явуулсан судалгаагаар Айбекс групп нь Нью-Жерси хотын Форт Лес гудамжны 07024 гэсэн хаягтай 2016803838 дугаартай утастай ерөнхий худалдаа эрхэлдэг хувийн компани бөгөөд бүртгэлийн дугаар нь DUNS602128890. Ерөнхий захирал нь Х. 1991 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа хүн юм. Миний бие энэ бичиг баримтыг хэлцэл, протоколыг урьдчилсан бичиг баримт гэж ойлгож байсан. Тодорхой төсөл хэрэгжүүлэх бэлтгэл шатанд нөгөө талын хэн болохыг таних боломж бүрдэнэ гэж найдаж байсан. Энэ бичиг баримтыг төсөл, урьдчилсан бичиг баримт гэж ойлгож байсан учраас тийм ач холбогдол өгч гарын үсгээ зурсан. “Түншлэлийн гэрээ” гэгчийг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр хүчингүй болгосон юм. Энэ баримт бичиг төсөл учир Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл болохгүй юм.

4. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч У., С. нарын тайлбарын агуулга:

Дээрх иргэдийн өргөдөлд “Түншлэлийн гэрээ” гэгч нь Монгол Улсын олон улсын гэрээ мөн тохиолдолд л Үндсэн хуулийн цэцээр хянагдан шийдвэрлэгдэх нь зүйн хэрэг юм. Түншлэлийн гэрээ байгуулагдах үед үйлчилж байсан “БНМАУ-ын олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай хууль”-д БНМАУ-ын Олон улсын гэрээнд гадаад улс, олон улсын байгууллагатай тусгайлан олгогдсон гэрээ хэлэлцээр хийх, гарын үсэг зурах бүрэн эрхийн дагуу байгуулна гэж заасан бөгөөд хуулийн 9 дүгээр зүйлд төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн болон Гадаад явдлын яамны сайд нь тусгайлан бүрэн эрх авахгүйгээр олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхтэй тухай шууд заасан байна. Өргөдөлд дурдсан Түншлэлийн гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхийг шадар сайд П.-д аль ч байгууллага олгоогүй, ер нь энэ “гэрээ”-ний талаар Засгийн газар, Ерөнхий сайд ямар нэгэн шийдвэр гаргаагүй болно. Гэрээнд гарын үсэг зурсан хоёр дахь этгээд олон улсын гэрээний эрх зүйн харилцааны субъект биш юм. Манай улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яамнаас судалгаа хийж 1993 оны 4 дүгээр сарын 5-нд ирүүлсэн албан бичигтээ “Айбекс” групп нь ерөнхий худалдаа эрхэлдэг хувийн компани юм. Бүртгэлийн дугаар нь DUNS602128890 гэж тодорхойлжээ. Энэ групп нь худалдааны эрх зүйн харилцааны жирийн субъект бөгөөд өөрөөр хэлбэл түүний үйл ажиллагааны төлөө ямар ч улсын Засгийн газар, ямар ч олон улсын байгууллага хариуцлага хүлээхгүй нь тодорхой байна. Манай улс 1988 онд нэгдэн орсон “Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын хоёрдугаар зүйлийн 1-ийн “а”-д гэрээ гэж олон улсын эрх зүйгээр зохицуулагдан улсуудын хооронд бичгээр байгуулсан олон улсын хэлэлцээрийг хэлнэ гэж тодорхойлсон байна. Олон улсын гэрээний субъект нь юуны өмнө улс байна гэдэг нь дэлхий нийтэд нэгэнт тодорхой болсон зүйл юм. Мөн конвенцын 7 дугаар зүйлд “...гэрээг заавал биелүүлэх улс гүрний зөвшөөрлийг илэрхийлэх зорилгоор тухайн этгээд холбогдох бүрэн эрхийн үнэмлэхээ үзүүлэх”, 7 дугаар зүйлд “улсаа төлөөлж гэрээ байгуулахтай холбогдсон үйлдэл хийх эрхтэй гэдэг нь 7 дугаар зүйлийн үндсэн дээр тогтоогдоогүй этгээд ийм үйлдэл хийсэн бөгөөд уг үйлдлийг дараа нь тухайн улс нотлохгүй бол хуулийн ач холбогдолгүйд тооцно” гэж заасан байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд “Түншлэлийн гэрээ” гэгч нь хууль тогтоомжид заасан журмаар байгуулагдсан олон улсын гэрээ биш бөгөөд “Түншлэлийн гэрээ” нь Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасан, ёслол байгуулагдсан олон улсын гэрээ биш, нөгөө талаас “Түншлэлийн гэрээ”-г байгуулахад Ерөнхий сайд оролцоогүй. Засгийн газраас ямар нэг шийдвэр гаргаагүй зэрэг нь Ерөнхий сайд Ж.-г огцруулах хуульд заасан үндэслэл алга байгааг нотолж байна.

5. Итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Энэ гэрээний нэг субъект “Айбекс” гэдэг хувийн компани байгаа юм. Олон улсын гэрээний субъект бол улсууд, олон улсын байгууллага байдаг. Энэ утгаар Түншлэлийн гэрээ Цэцээр хянагдах Монгол Улсын олон улсын гэрээ биш юм. Энэ гэрээний талаар Монгол Улс, Засгийн газар ямар нэг хариуцлага хүлээхгүй. Энэ гэрээ нь олон улсын гэрээ биш учир Ж.-г үүнтэй холбогдуулан огцруулах үндэслэл байхгүй юм.

6. П.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Би энэ бичиг баримтыг боловсруулж Айбекс групптэй гэрээ байгуулахдаа шилжилтийн үед дан ганц Засгийн газруудын шугамаар орж ирж байсан зээл тусламж хүрэлцээтэй бус байсан, мөн улс орноо эдийн засгийн хүнд байдлаас гаргах бололцоотой бүх арга замыг эрэлхийлэх бодит шаардлагыг үндэслэсэн юм. Энэ бичиг баримтыг урьдчилсан бичиг баримт гэж ойлгож, тодорхой төсөл хэрэгжүүлэх бэлтгэл шатанд нөгөө талын хэн болохыг таних боломж бий болно гэдэгт найдаж, ойлгож байсан учраас тийм ач холбогдол өгч гарын үсгээ зурсан. “Түншлэлийн гэрээ” гэгчийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр цуцалсан юм. Энэ бол гэрээ бус төсөл учир Ерөнхий сайд Ж.-г огцруулах шалтгаан болохгүй.

7. Холбогдох этгээд, байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийн агуулга:

а/ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 1995 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа: “Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс АНУ-ын Айбекс групптэй байгуулсан гэрээ, хэлцлүүд нь Монгол Улсын ашиг сонирхол, эдийн засгийн аюулгүй байдал, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх тухай асуудлыг хэлэлцэж, энэ түншлэлийн хэлэлцээр болон бусад гэрээ хэлцэл нь тэдгээр компани, корпорацийг Монгол Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт дангаар нь удаан хугацаагаар ноёрхох сөрөг үр дагавартай бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчиж, үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа болсон байна” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

б/ Монгол Улсын Засгийн газар уг асуудлыг хуралдаанаараа авч хэлэлцээд Улсын Их Хуралд өгсөн танилцуулгадаа: “Монгол Улсын шадар сайд П. АНУ-ын Айбекс групптэй 1993 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр “Түншлэлийн гэрээ”-нд тус группийн зөвлөлийн дарга Х.тэй Сан-Франциско хотноо гарын үсэг зурсан байна. Энэхүү “Түншлэлийн гэрээ”-г монгол хэлэнд орчуулалгүйгээр англи хэл дээр байгуулжээ. “Түншлэлийн гэрээ”-нд тусгагдсан асуудлуудаас эхнийх нь амжилттай хэрэгжих хүртэл уг гэрээг төсөл гэж үзэх, аль нэг салбарт анхны төсөл хэрэгжиж эхэлсний дараа түүнийг Улсын Их Хуралд оруулж соёрхон батлуулахаар тохиролцож, энэ тухай протокол байгуулсан нь нотлогдов. Түмэн голын бүсийн хөгжлийн хөтөлбөрийн зөвлөх АНУ-ын иргэн Х.-гийн зөвлөснөөр хөрөнгө оруулалтын асуудлаар зуучлах саналаа илэрхийлсэн АНУ дахь Айбекс групптэй холбоо тогтоож, түүгээр зуучлуулан Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хэрэгжүүлж болох төслүүдийн талаар ярилцаж дээрх баримт бичгийг тохирсон байна. Уг баримт бичигт “Энэхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна”, “Айбекс”-д хамаарах төслүүдэд олгосон болон энэ гэрээнд тусгасан бүх нөхцөл, эрх ашгийг Монгол Улс, Монголын Засгийн газар батлан хангаж гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон цаашдын үйл ажиллагаагаар, түүнчлэн аливаа хууль тогтоомжоор өөрчилж, засаж, буцаажгүй, Монголын хувьд хуулийн хүчин төгөлдөр дагаж мөрдөх үүрэг гэсэн Монгол Улсын хууль тогтоомжид нийцэхгүй заалт орсон байв. Энэ нь зах зээлийн харилцаанд шилжсэн орнуудтай хамтран ажиллах туршлага дутмаг байсан, гадаадын хөрөнгө оруулж, улсын эдийн засгийн хүндрэлтэй байдлыг богино хугацаанд гэтлэх гэсэн эрмэлзэлд хөтлөгдөж, хэт яарч, гэрээг ч газар дээр нь шууд байгуулсан, уг гэрээг хуульд нийцүүлэх талаар нарийвчлан авч үзээгүй, ийм гэрээ байгуулсан тухайгаа Засгийн газар /танхим/, холбогдох байгууллагуудад шуурхай мэдээлээгүй, улмаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн дагуу тодорхой ажиллахгүй хугацаа алдсантай холбоотой болохыг Засгийн газрын хуралдаан тэмдэглэж, шадар сайд П.-д хатуу анхааруулав. Айбекс групптэй “Түншлэлийн гэрээ” байгуулсантай холбогдуулан хийсэн хавсралт протокол уг түншлэлийн гэрээний анхны төсөл амжилттай хэрэгжих хүртэл уг гэрээ нь төслийн хүрээнд байна гэж ойлгогдохын гадна, гэрээгээр тодорхойлсон аль нэг салбарт анхны төсөл хэрэгжиж эхэлсний дараа зохих журмын дагуу батлуулахаар тусгагдсан, гэрээ албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй учир энэхүү “Түншлэлийн гэрээ”-тэй холбогдож санхүү, мөнгөний ямар ч хохирол учраагүй байна. АНУ-ын Айбекс групптэй байгуулсан “Түншлэлийн гэрээ”-г цуцлах, хүчингүй болгох тухай протоколыг шадар сайд П., Айбекс группийн зөвлөлийн дарга Х. нар 1995 оны 3 дугаар сарын 14-нд хийж нотолсон байна. Ийнхүү “Түншлэлийн гэрээ”-нээс ямарваа үр дагавар цаашид гарахгүй нь тодорхой боллоо” гэж тэмдэглэсэн байна.

в/ Түншлэлийн гэрээний тухай Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 1995 оны 3 дугаар сарын 8 болон 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хоёр удаа хэлэлцээд олонхийн саналаар уг асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэж дүгнэлт санал гаргажээ. Тухайн дүгнэлтэд: “Түншлэлийн гэрээг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 95 дугаар зарлигаар батлагдсан “БНМАУ-ын олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай”



хуулийн 3 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 10 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 26 дугаар зүйлийг баримтлалгүйгээр байгуулжээ. Тухайлбал, Хуулийн дээрх зүйл, хэсгээр бас гэрээг байгуулах саналыг Засгийн газарт Гадаад харилцааны яам тогтоосон журмын дагуу өргөн мэдүүлэх, Засгийн газраас гэрээ хэлэлцээ хийх, гарын үсэг зурах тухай шийдвэр гаргах, гэрээ хэлэлцээ хийх, гарын үсэг зурах бүрэн эрхийг Засгийн газар, Гадаад харилцааны яамнаас авах, гэрээг монгол хэлээр үйлдэх, гэрээг холбогдох байгууллагаар батлуулах, Засгийн газрын тусгай хэвлэлд нийтлэх, зохих байгууллагад бүртгүүлэх ёстой байтал энэ бүхэн зөрчигджээ. Энэ гэрээг улс ёсчлон байгуулсан бөгөөд түүний хуулийн хүчин төгөлдөр дагаж мөрдөх үүрэг гэсэн заалтуудыг тусгасан нь Монгол Улсын төрийн эрх барих хууль тогтоох дээд байгууллагын бүрэн эрхийг хөндөж хязгаарласан, гэрээ байгуулагч өөрийн эрх мэдлээ хэтрүүлсэн үйл ажиллагаа болжээ” гэж дурдсан байна.

г/ Улсын Их Хурлын хуралдаан дээр уг түншлэлийн гэрээг хэлэлцэх үед гишүүд өөр өөр санал дүгнэлт гаргасан байна:

Улсын Их Хурлын гишүүн З.: “Монгол Улсад шууд ба шууд бусаар хохирол учруулсан гэдэг нь тодорхой. Дэмий шуугиан үүсгэсэн гэж байгаа бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мөн дүгнэлт гаргасан бүх шинжээч нарт арга хэмжээ авах хэрэгтэй. Зөвлөмж гаргасан Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга гурвуулаа шал дэмий шуугиан тарьсан гэдэг нэрийн дор арга хэмжээ авагдах ёстой. Иймэрхүү маягаар яваад байх юм бол ямар ч хариуцлагагүй төр, хариуцлагагүй Засгийн газар, Засгийн газраа хянаж чаддаггүй Улсын Их Хурал гарч ирж байна. Ерөнхий сайд анхнаасаа мэдэж байсан, тийм буруу гэж байсан юм бол хоёр жил юу хийж явсан юм, яагаад гэнэт цуцлах болов. Энэ бүх зүйлүүдэд хариу өгөх хэрэгтэй. Иймд тодорхой хүмүүст арга хэмжээ авах хэрэгтэй” гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Г.: “Гэрээг харсан хэн ч энд ямар нэгэн тайлбар, нэмэлт протокол байгаа тухай ишлэл болохгүй учраас энэ гэрээг хэн ч хаана ч бариад явсан үнэхээр хүчин төгөлдөр байгуулчихсан, гарын үсэг зурагдсан ийм гэрээ хэн ч итгүүлж чадахаар тийм баримт бичиг байгаа юм. Ерөнхий сайд Улсын Их Хурлын өмнө энэ асуудлаар хариуцлага хүлээх ёстой” гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Т.: “Тусгайлан бүрэн эрх олгохгүйгээр гэрээ, хэлэлцээр байгуулах хүн гэвэл Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга, Гадаад явдлын яамны сайд энэ гурав байгаа. Иймд шадар сайд түүнд тусгайлан эрх олгоогүй байхад шууд гарын үслэг зурах эрх байхгүй. Шадар сайд П. Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурсан бол Засгийн газраар заавал хэлэлцүүлж байж тусгай эрх олж байж гарын үсэг зурах ёстой байсан. Энд хүчингүй болгох тухай асуудал байхгүй, томьёоллын хувьд буруу байж болно. Хамгийн гол нь энд бол төслөөсөө татгалзах тухай асуудал байхгүй юу, гол юм энд байх ёстой” гэсэн байна.

Ерөнхийлөгч О.: “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр гэрээ мөн гэж үзсэн юм. Ингэхдээ Монгол Улс 1998 онд нэгдсэн 1969 оны конвенцын 3-ын “а”-ын заалтыг үндэслэсэн юм. Тэр гэрээ, протокол хоёр бол цаг хугацааны хувьд хоёр өөр юм. Хэрэв хоёр тусдаа хийгдсэн баримт бичиг нэг асуудалд хамаарч байгаа бол аль нэгэн дээр нь хоёр дахь энэ энэхүү гэрээний гэдэг юмуу протоколын гэдэг юмуу салшгүй хэсэг гэж бичдэг юм. Тэгэхлээр аль ч учир нь тэгж байхгүй. Тийм учраас энэ хоёр чинь хоёр өөр баримт байхгүй юу. Энэ гэрээ юм бол Монгол Улсын хуулийн юу юу нь зөрчигдсөнийг Улсын Их Хурал хэлж өгөх ёстой. Тэгэхээр гэрээ бол гэрээ болоод байгаа юм. Гэрээнд бол гарцаагүй бушуухан түүнийг цуцалж авсан явдал амжилт гэж үзэх ёстой” гэсэн байна.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс шадар сайд П. АНУ-ын Айбекс групптэй байгуулсан түншлэлийн гэрээнд “Энэхүү гэрээ байгуулсан өдрөөс хойш 99 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Айбекст хамаарах төслүүдэд олгосон болон энэ гэрээнд тусгасан бүх нөхцөл, эрх ашгийг Монгол Улс, Монголын Засгийн газар батлан хангаж, гэрээний хугацаанд тэдгээрийг Засгийн газрын тухайн үеийн болон цаашдын үйл ажиллагаагаар түүнчлэн аливаа хууль тогтоомжоор өөрчилж, засаж буцаахгүй” гэсэн Монголын хууль тогтоомжид нийцэхгүй заалт орсон, түүнчлэн гэрээ байгуулагч гадаадын хөрөнгө оруулж улс орны тухай үеийн хүндрэлтэй байдлыг богино хугацаанд гэтлэх гэсэн эрмэлзэлдээ хөтлөгдөн гэрээг хэт яарч газар дээр нь шууд байгуулсан, уг гэрээг хуульд нийцүүлэх талаарх асуудлыг нарийвчлан авч үзээгүй, ийм гэрээ байгуулсан тухайгаа Засгийн газар, холбогдох байгууллагуудад шуурхай мэдээлээгүй зэрэг нь гадаадын компани, корпорацийг Монгол Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдолтой салбарт дангаараа удаан хугацаагаар ноёрхох, Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчиж, үндэсний аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулахад хүргэж болзошгүй үйл ажиллагаа байжээ.

2. Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн конвенцод /Монгол Улс 1988 онд нэгдэн орсон/ зааснаар олон улсын гэрээ гэж “нэг буюу хоёр, эсхүл өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа бөгөөд түүний тодорхой нэрээс хамаарахгүйгээр улсуудын хооронд бичгээр байгуулсан, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын гэрээ байгуулах, биелүүлэх, цуцлах журмын тухай 1985 оны хуулийн 2 дугаар зүйлд “БНМАУ-ын Олон улсын гэрээг гадаад улс, олон улсын байгууллагатай БНМАУ, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар, Яам, Улсын хороо, тусгай газрын нэрийн өмнөөс тус тус байгуулна” гэж ямар субъектуудын хооронд байгуулагдах ёстойг заажээ.

Монгол Улсын олон улсын гэрээний тухай 1993 оны шинэ хуульд дээрх тодорхойлолтын үндсийг хадгалж, агуулгыг шинэ Үндсэн хуульд нийцүүлж “Олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Дээр дурдсан олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг, Монгол Улсын хууль тогтоомжийн заалтаас үзэхэд Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасан Үндсэн хуулийн цэцээр авч хэлэлцвэл зохих Монгол Улсын олон улсын гэрээ гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Энэ нь шинжээч нарын дүгнэлтээр давхар нотлогдож байна.

3. Түншлэлийн гэрээг байгуулах болон түүнээс хойшхи үйл ажиллагаанд Ерөнхий сайд Ж. шууд оролцож байсан нь нотлогдохгүй байгаа тул Ж.-г Ерөнхий сайдын албан тушаалаас огцруулах талаар маргагч талын тавьж буй гомдлын шаардлагыг хангах үндэслэлгүй байна. ДҮГНЭЛТ:

1. АНУ дахь Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээ нь Монгол Улсын олон улсын гэрээ биш болох нь тэр үед болон одоо үйлчилж байгаа хууль тогтоомж, шинжээч нарын дүгнэлт, маргалдагч талуудын хүлээн зөвшөөрсөн байдал болон бусад нотлох баримтаар тогтоогдож байгаа тул уг гэрээ нь Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргаан биш байна. Иймд иргэн Л., З., Г. нарын өргөдөлдөө бичсэн “Түншлэлийн гэрээ” Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн эсэх гэсэн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Айбекс групптэй байгуулсан Түншлэлийн гэрээтэй холбогдох Ерөнхий сайд Ж.-гийн үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх нь нотлогдохгүй байгаа тул Ж.-г энэ шалтгаанаар Ерөнхий сайдын албан тушаалаас огцруулах үндэслэл болохгүй байна.

3. Энэ дүгнэлтийг Монгол Улсын Их Хуралд оруулсугай.

**Тэмдэглэл:**

Тухайн үед Ж.-гийн толгойлсон Засгийн газарт Шадар сайдын албан тушаал хашиж байсан П.-гийн байгуулсан гэрээний талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүд, Олон улсын эрх зүйгээр мэргэшсэн шинжээчид, Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яам гэх мэт байгууллага, албан тушаалтан, иргэд өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн байна. Энэхүү түншлэлийн гэрээ нь тухайн үеийн буюу шилжилтийн үеийн Монгол төрийн зохион байгуулалтгүй, хяналтгүй, харилцан уялдаагүй байдлыг илчилсэн гэхэд болно.

Үндсэн хуулийн цэцэд энэхүү маргааныг шийдвэрлэхэд “Түншлэлийн гэрээ” нь Олон Улсын гэрээ мөн эсэхийг тогтоох шаардлага гарсан. Хэрэв мөн бол Цэцийн харьяалан шийдвэрлэх маргааны хүрээнд орно, хэрэв биш бол Үндсэн хуулийн цэц маргааныг шийдвэрлэх боломжгүй байсан. Олон улсын гэрээ бол Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай бичгээр үйлдсэн тохиролцоо юм. Харин дээрх түншлэлийн гэрээний нэг тал нь Монгол Улсын Засгийн газар мөн боловч нөгөө тал нь АНУ-ын компани байсан. Энэ бол диагоналт контракт юм. Нөгөө талаас тусгайлан бүрэн эрх авахгүйгээр Монгол Улсын Олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий этгээд нь тухайн үед Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга, Гадаад явдлын яамны сайд нар байсан. Гэтэл шадар сайд П.-д тусгайлан эрх олгогдоогүй байсан байна.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1996.03.27 № 01**

**Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын  
хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн  
эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1994 оны 7 сарын 7-ны өдөр баталсан Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль<sup>24</sup>

- 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалт “... сэтгэцийн өвчтөй хүмүүс, бага насны хүүхдийг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байх, ...”

24 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 оны № 9-д нийтлэгдсэн

- 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт “бага насны хүүхэд болон сэтгэцийн өвчтэй хүнийг дагуулж явахгүй”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй “Жагсаал, цуглааныг зохион байгуулагч нь сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлийн “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямарч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Энэ утгаар аливаа төрлийн ялгаварлан гадуурхлыг хуулиар хориглосон байх ёстой бөгөөд хуулиар хүн бүр ямарч шинж тэмдгээр тухайлбал арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэс буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахын эсрэг тэгш, үр нөлөөтэй хамгаалалтыг баталгаатай болгоно” гэсэн заалтыг, мөн пактын 2 дугаар зүйлийн 1-ийн “Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчиж тухайлбал бусад нөхцөл гэсэнд хамаарах эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхаж байгаа учраас Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн дээрх заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д байгаа “Монгол Улсын иргэн тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй байх” заалтыг зөрчиж байна. Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д “Цуглааныг зохион байгуулагч бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1-ийн 4-т “Цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь хүүхдийн эрхийн тухай конвенцын 15 дугаар зүйлийн 1-ийн дотор байгаа “Оролцогч улсад тайван замаар хуран цуглах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтыг зөрчиж байгаа учраас Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-ын “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна. Иймд миний өргөдлийг хянан шийдвэрлэж хуульд заасан хугацаанд багтаан хэрэг үүсгэж маргааныг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагаа юм. Энэ заалттай холбогдолгүй сэдвээр иргэдээс зохион байгуулж байгаа спорт, урлаг, уран сайхан, баяр наадам болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээг зохион байгуулахад энэ хууль үйлчлэхгүй тухай 5 дугаар зүйлд бий. Өөрөөр хэлбэл бага насны хүүхдүүд энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2-т заасан асуудлаар жагсаал, цуглаан зохион байгуулж болох боловч тэдгээр нь энэ хуулиар зохицуулагдахгүй. Хэрэв зохицуулагдахаар хийвэл зөвшөөрөл авах, хариуцлага тооцох, албадаж тараах гэх мэт насанд хүрэгсдэд тавигдах бүхий

л шаардлага хүүхдэд тавигдахаар байсан тул асуудлыг ийнхүү зохицуулсан юм. Жагсаал, цуглаан зохион байгуулахад бага насны хүүхдийг оролцуулахгүй байх тухай заалт нь хүүхдийн эрхийг хязгаарлах бус харин тэдний амь нас, эрүүл мэнд, сэтгэхүйн онцлог, эрх ашгийн аливаа муу нөлөөллөөс хамгаалах зорилготойгоор тусгасан юм.

а/ Хүүхдийн нас, оюун ухаан, сэтгэлгээний онцлогийг төрийн болон хэсэг бүлгийн тэмцэлд ашиглуулахгүй байх;

б/ Хууль бусаар зохион байгуулсан жагсаал, цуглааныг цагдаа, дотоодын цэргийн хүчээр албадан тараахад хүүхдийн амь бие, эрүүл мэндийг хохироохгүй байх;

в/ Бага насны хүүхэд захиргааны хариуцлагын субъект болдоггүйг харгалзах;

г/ Жагсаал, цуглааны явцад нийгмийн хэв журам зөрчигдөх, эмх замбараагүй байдал бий болох магадлал ихтэй тул тэдгээрээс гарч болох сөрөг үр дагавраас бага насны хүүхдийг хамгаалах;

д/ Жагсаал, цуглааны явцад гардаг аливаа сөрөг үзэгдлээс бага насны хүүхдийн хүмүүжил, ёс суртахууныг хамгаалах.

Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байх тухай хуулийн заалт нь энэхүү тайлбарын 2-т заасан зорилгын зэрэгцээгээр тэдгээрийг эмх замбараагүй байдал үүсгэх шалтаг үүсгэхэд ашиглуулахгүй байхад чиглэсэн юм. Түүнчлэн сэтгэцийн өвчтэй хүмүүс эрхийн чадамжаа бүрэн алдсан буюу хязгаарлагдмал чадамжтай байдгаасаа шалтгаалан иргэний эрх, үүрэг нь үндэсний хууль тогтоомжоор хязгаарлагдсан байдгийг харгалзсан юм.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хууль бол улс төрийн зорилгоор тайван журмаар жагсаал, цуглаан хийх асуудлыг зохицуулжээ. Олон улсын пактад “хуран цуглах” гэсэн нэр томъёо байгааг анхаарах. Олон улсын конвенц, пактад нийгмийн хэв журам хамгаалах бусад зорилгоор улс орнууд жагсаал, цуглаан хийх асуудлаар зарим хязгаарлалтыг тогтоож болох журам бий. Жагсаал, цуглаанд бага насны хүүхэд, сэтгэцийн өвчтэй хүмүүсийг оролцуулахгүй байх эрхийг жагсаал, цуглааныг зохион байгуулагчдад олгосон. Нөгөө талаар сэтгэцийн өвчтэй хүмүүс, насанд хүрээгүй хүмүүс чинь иргэний эрх зүйн бүрэн чадамжгүй хүмүүс тул улс төрийн үйл ажиллагаанд оролцох уу гэдгийг бодолцох. Тэгэхдээ эдний жагсах, хуран цуглах эрхийг хассан биш түүнийг зохион байгуулагчдад энэ талаар эрх олгосон байна. Олон улсын пактанд эрүүл мэндээр нь хязгаарлах гэх мэт заалт шууд байхгүй. Нэгдсэн Үндэстэний Байгууллагын Хүүхдийн эрхийн хороонд Монгол Улсын Засгийн газраас явуулсан илтгэлийн 99 дүгээр зүйлд байгаа агуулга нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн үзэл баримтлалаас зөрүүтэй байгаа болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монголд Улс 1990 онд нэгдэж орсон Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц нь Монгол Улсын Үндсэн хуультай харшлаагүй байх тул Монгол Улсын хууль тогтоомжийн нэгэн адил хүчинтэй болох нь тогтоогдов. Энэ утгаар нь авч үзэхэд жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т буй “цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь тайван замаар хуран цуглах хүүхдийн эрхийг хассан байх тул энэ талаар иргэн Л.-ийн хүсэлт үндэслэлтэй байна.

2. Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг эрх зүйн чадамжгүйд тооцох тул тэднийг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байхаар Монгол Улсын хуулиар зохицуулсан нь үндэслэлтэй байх тул энэ талаархи хүсэлтийг хүлээн авах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т буй “цуглаанд оролцогч нь бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйл, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийг зөрчсөн байна.

2. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь... сэтгэцийн өвчтэй хүнийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолын агуулга:**

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүргийг хүлээнэ” мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйл, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Иргэн Л.-ийн мэдээлэл, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хуульд байгаагаас нь өөрөөр бичиж, томьёолсон байсныг “Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр” хэсэгт засаж бичсэн болно.

2. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх хэсэгтэй би санал нийлдэггүй юм. Зарим эрх, үүрэг тодорхой насанд хүрснээр эхэлдэгтэй нэгэн адил (Жишээ нь: Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчид санал өгөх эрх 18 наснаас эхэлдэг бол Улсын Их Хурлын гишүүнд сонгогдох эрх 25 наснаас эхэлдэг г.м.) зарим жагсаал, цуглаан хийх эрх тодорхой наснаас эхлэхэд буруудаад байх зүйлгүй.

2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Сүхбаатарын талбайд “тайвнаар” эхэлсэн жагсаал, цуглаан сүүлдээ юу болсныг бид сайн мэдэж байгаа.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд “бага насны хүүхэд” гэдэгт яг хэдээс хэдэн насны хүүхдийг ойлгох юм гэдгийг тодорхой зааж өгөөгүй байдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1996.05.15 № 01

### Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н.

#### 1. Иргэн Л.-ийн тайлбарын агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1-ийн 4-т “цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд яах аргагүй хүүхдийн тайван замаар хуран цуглах эрхийг шууд хасаж байгаа юм.

#### 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулиар хүүхдийн хуран цуглах эрхийг хязгаарласан гэж үзэхгүй байна. Учир нь энэ хуулийн заалт нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс орсон учраас Үндсэн хууль, хүүхдийн эрхийн конвенцын заалтуудад харшлахгүй юм.

#### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д буй “цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т буй “...цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль, тус улс албан ёсоор нэгдэн орсон хүүхдийн эрхийн тухай олон улсын Конвенцийг зөрчсөн байна. Ингэснээр хүүхдийн тайван замаар хуран цуглах эрхийг хязгаарлажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан “бага насны хүүхэд”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “бага насны хүүхэд болон...” гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

## **Тэмдэглэл:**

Жагсаал цуглаанд хүүхдийг оролцуулахгүй байх нь хүүхдийг хамгаалсан заалт юм. Өөрөөр хэлбэл дээрх хуулиар хүүхдүүд спорт, урлаг, уран сайхан, баяр наадмын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээг зохион байгуулж жагсаал, цуглаан хийх эрх нь нээлттэй байгаа юм. Хэрэв ингэж хүрээ хязгаар тогтоож өгөхгүй бол улс төр, нийгэм, эдийн засаг гэх мэт асуудлаар иргэд жагсаал, цуглаан хийн, уур бухимдлаа илэрхийлэхдээ бага насны хүүхдийг ашиглах, турхирах, хүчээр дагуулж явах асуудал гарахыг ч үгүйсгэх аргагүй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1996.04.10 № 02**

### **Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Ш.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>25</sup>

- 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн, дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно”

- 2/21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг “Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн нутаг дэвсгэрийн нэгжид хуваагдана”

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”

- Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй”

<sup>25</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 4-т нийтлэгдсэн



## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчсөн байна. Учир нь манай улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах бөгөөд хүн бүр өөрийн оршин суугаа газрынхаа төрийн байгууллагуудад шууд болон төлөөллийн аргаар хандаж, төр нийгмийн хэргийг удирдахад оролцох өргөн боломжтой байдаг. Нөгөө талаас бүх иргэн эрхээ хэрэгжүүлэх ижил эрх тэгш боломжоор хангагдсан байх эрхтэй. Дээрх нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт нь агуулгын хувьд энэхүү эрхтэй зөрчилдөж байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь заалтад “Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтыг зөрчсөн байна.

### **2. Иргэн Ц.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:**

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт нь зөвхөн сонгуулийн насны хүний тоог өрөөсгөлөөр гол шалгуур болгосон байна. Нэгэн нутагт оршин буй иргэдэд хууль тогтоох дээд байгууллагаа сонгох, төрийн хэрэгт оролцоход нь ялгаатай нөхцөл үүсгэж, тэдний хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулж өөр орон нутагт нэр дэвшигчийн төлөө санал өгөхийг шаардахад хүрч байна. Үүний сөрөг үр дагавар их бөгөөд сонгууль чөлөөтэй байх Үндсэн хуулийн заалтыг ч зөрчиж байна. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн хэлээд байгаа шиг сонгуулийн нутаг дэвсгэр гэсэн ойлголт Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй. Төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд дагнасан сурталчилгаа хийхийг хориглож болох юм. Хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хааж боох нь тэдний улс төрийн болон бусад эрх чөлөөг илтэд хаахад хүрч байна.

### **3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., Ш. нарын тайлбарын агуулга:**

Улсын Их Хурлын гишүүн нь тодорхой нэг тойргоос сонгогдож, улмаар зөвхөн тэр л тойргийнхоо хүмүүсийн санаа бодлыг илэрхийлж, тэр л сум, аймгийнхаа нийгэм, эдийн засаг, соёл, улс ардын аж ахуйн том, жижиг асуудлыг хөөцөлдөж Ардын Их Хурлын чуулганд очиж хуралдаж байсан урьдын депутат бишээ. Улсын Их Хурлын гишүүн нь хууль тогтоох эрх мэдлийг хадгалсан төрийн эрх барих дээд байгууллагад нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж, сонгуулийн хугацаандаа байнга ажилладаг ард түмний элч юм. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүн нь тодорхой тойргоос сонгогдох боловч түүний үйл ажиллагаа нь улсын хэмжээнд гэдгийг мартаж болохгүй. Иймд “аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно” гэсэн заалт нь иргэдийн эрхээ хэрэгжүүлэх ижил тэгш боломжийг хаан боогдуулж байгаа явдал биш бөгөөд хууль тогтоох дээд байгууллагаа сонгох, төрийн хэрэгт оролцоход нь ялгаатай нөхцөлийг үүсгээгүй, тэдний хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулсан явдал бишээ. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн байгуулагдах, өөрчлөгдөх зарчим, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд өөрийн сум, аймгийн төрийн байгууллагатай харьцах харилцааны асуудлыг Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах зарчимтай хольж хутган ойлгох ёсгүй.

Нөгөө талаар Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль”-ийн 6 дугаар зүйлийн 2-т “Аймагтай адилтгах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хэрэв Улсын Их Хурлын гишүүний нэг мандатад ногдох улсын дунджаас цөөн хүн амтай бол зэргэлдээ аймагтай нь нэгэн тойрог болгоно” гэсэн заалт байгаа бөгөөд энэ заалтыг л агуулгын хувьд баяжуулж улам боловсронгуй болгоход анхаарч нэмэлт, өөрчлөлт хийсэн болохоос биш Улсын Их Хурал цоо шинээр заалт хийгээгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Дээрх заалттай хуулийг удирдлага болгон 1992 оны сонгууль амжилттай явагдаж сонгууль нь Монголын сонгуулийн эрх бүхий нийт иргэдийн сонгох эрхийг бүх талаар хангасан, ардчилсан байдлаар болж өнгөрлөө гэсэн дүгнэлтийг гадаад орнуудын хэвлэлд хийж, уригдан ирсэн гадаадын ажиглагчид санал нэгтэй байсныг бид мартах учиргүй. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт агуулгын хувьд иргэдийн сонгох эрхтэй зөрчилдөөгүй гэдгийг хэлэх байна.

Олон улсын сэтгүүлчдийн практик ажиллагаанаас харахад аливаа дангаар ноёрхлыг арилгаж нийгэм дэх олон үзэл бодлыг аль болох өргөн тусгасан сонин хэвлэл бололцооны хэрээр гаргах зарчим баримталдаг. Нөгөө талаар чөлөөт хэвлэл нэг талыг баримтлахаас үргэлж зайлсхийдэг жамтай. Энэ бүгдээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан хуулийн заалт нь олон улсын сэтгүүлчдийн тавьдаг ерөнхий шаардлагатай нийцэж байна. Чухамдаа аливаа хэвлэл нэг талыг барих асуудлаас зайлсхийснээр нэр дэвшигч болон сонгогчид аль болох олон радио, телевиз, сонин хэвлэлд хандах боломжийг нээж байгаа юм гэжээ. Төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэлд дангаар сурталчилгааг хориглосноор бүх төрлийн хэвлэлд нэр дэвшигчдийг адил тэгш сурталчлах бололцоог нээж байгаа юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн, дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно” гэсэн заалт сонгуулийн тойрог бүрт сонгогчдын тоо харьцангуй тэнцүү байх нийтлэг зарчимд харшлаагүй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах нөхцөлийг алдагдуулсан, сонгогчдын хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулсан, сонгуульд оролцоход нь ялгаатай нөхцөл үүсгэсэн гэх үндэслэлгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь заалт “Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно” гэсэн заалт нь сонгуульд өрсөлдөгчийн адил тэгш нөхцөлийг хангахад чиглэгдсэн бөгөөд хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Энэ талаар гаргасан иргэн Ц.-гийн хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн

нэг тойрог байгуулж болно” гэсэн заалт, мөн хуулийн нэгдүгээр зүйлийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

2. Цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилъя.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт нь Үндсэн хуулиар баталгаажсан сонгуулийн зарчим, эрх, эрх чөлөөг зөрчсөн бус харин ч бэхжүүлсэн зохицуулалт байсан. Хуулиар хориглоогүй ч гэсэн аливаа телевиз, сонин, сэтгүүл гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгсэл аливаа улс төрийн хүчний харьяалалд байх нь хөгжиж буй ардчилалд аюултай үзэгдэл.

1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нь 2005, 2012 онуудад шинэчилэн найруулагдсан ба 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.8 дахь хэсэгт “Олон нийтийн радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нэвтрүүлэг /цаашид “сурталчилгааны нэвтрүүлэг” гэх/-ийг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлэх ба төлбөртэй нэвтрүүлэхийг хориглоно”, мөн зүйлийн 35.11 дэх хэсэгт “Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна”, 35.12 дахь хэсэгт “Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ” хэмээн заажээ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1996.05.23 № 03**

### **Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ч.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Ш.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>26</sup>

<sup>26</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 4-д нийтлэгдсэн

5/36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “санал огт тэмдэглээгүй” хуудсыг хүчингүйд тооцох тухай заалт

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ..., чөлөөтэй..., сонгоно”
- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “Монгол Улсын иргэд төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Ч.-гийн мэдээллийн агуулга:**

Одоо мөрдөгдөж байгаа парламентын сонгуулийн хууль нарийн авч үзвэл ихээхэн дутагдал, согогтой байна. Улсын Үндсэн хууль зөрчсөн заалт ч бас оржээ. Нэр дэвшсэн хүмүүсээс хэнийг ч сонгох хүсэлгүй иргэдийн саналын хуудсыг хүчингүйд тооцох нь тэр хүний сонгуулийн эрхийг хассантай ижил юм. Ийм тохиолдолд сонгогч саналын хуудсаа огт тэмдэглэхгүйгээр хайрцганд хийх үү, эсвээс нэр дэвшигчийн нэрсийг дарах уу гэдгийг хуулиар тогтоосон байх ёстой. Татгалзсан санал бүхий хуудсыг хүчингүй хуудсанд тооцож хасаад байвал нэр дэвшигчийн авсан саналын хувь, хэмжээ зохиомлоор өсөх болно. Сонгуульд оролцсон л бол заавал хэн нэг хүний төлөө саналаа өгөх ёстой гэж сонгогчийг шахаж болохгүй. Үндсэн хуульд заасан “Чөлөөтэй гэдэг зарчмын нэг тал нь эс сонгох эрх чөлөө мөн. Ингэхлээр бүрэн татгалзсан саналыг хүчингүйд тооцсон заалтын талаар ул үндэстэй дахин бодож үзээд түүнийг хүчинтэй саналд тооцохоор хуульчилж, Улсын Их Хурлын сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж өгөхийг хүсье.

Бүх нэр дэвшигчийн хувьд татгалзсан санал өгч болохгүй гэх юмуу, эсвээс заавал хэн нэгийг нь дэмжиж санал өг гэж сонгогчийг шахаж болохгүй. Ингэхлээр 36 дугаар зүйлийн 3-т байгаа “Санал огт тэмдэглээгүй” хуудсыг хүчингүйд тооцох тухай заалт сонгогчийн сонгох ба эс сонгох эрх, Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2-т заагдсан сонгогчийн чөлөөтэй сонголт хийх эрхийг зөрчиж байна. Ерөнхийлөгчийн сонгуульд 1 хүн нэр дэвшжээ. Ийм тохиолдолд татгалзсан саналыг хүчингүйд тооцвол ердөө 3-хан хүний санал авсан ч 100 хувийн санал авснаар тооцогдох болно. Татгалзсан санал, хүчингүй санал, хүчингүй саналд тооцогдох юунд хүргэдгийг харагтун.

##### **2. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Ш. нарын тайлбарын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д “Монгол Улсын иргэд төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг... сонгоно” гэж заасан байна. Эдгээр нь сонгуулийн үндсэн зарчим, нэр дэвшүүлэн сонгох нь сонгуулийн бас нэг чухал зарчим байдаг билээ. Нэр дэвшээгүй хэнийг ч сонгодоггүй чухамхүү энэ утгаар нь сонгогч нэр дэвшигдсэн хүмүүсээс аль нэгийг нь сонгох ёстой. Хэрэв эдгээр нэр дэвшигчийн хэнийг нь ч сонгох хүсэлгүй байвал сонгуульд оролцохгүй байх, эсхүл сонгуулийн хуульд заасны дагуу хуудас хүчингүй болох ёстой.

Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан чөлөөтэй сонгох зарчим нь дараах механизмаар хэрэгжинэ. Үүнд:

а/ Сонгуульд оролцох эсэх нь тухайн иргэний хүсэл зоригийн хэрэг

б/ Саналаа гаргахад нь нууцыг алдагдуулахгүй, ямар нэгэн байдлаар шахалт үзүүлэхгүй байхыг хэлнэ.

“Чөлөөтэй” гэдэг нь иргэдийг сонгуульд оролцоход ямар нэгэн дарамт шахалт үзүүлж болохгүй гэсэн утга болно. Гэхдээ энэ бол ямар нэг хувь хүний өмчилсөн дархан эрх биш. Аливаа эрх бол ухаалаг хязгаарлалттай байдаг. Сонгуулийн хуульд энэ мэт

хязгаарлалтыг тогтоожээ. Иймд Улсын Их Хурал хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу сонгуулийн журмыг хуулиар тогтоосныг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 5/36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “санал огт тэмдэглээгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т заасан “чөлөөт” гэсэн сонгуулийн зарчмыг зөрчжээ. Иймд иргэн Ч.-гийн гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “санал огт тэмдэглээгүй бол... саналын хуудсыг хүчингүйд тооцно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хянан хэлэлцэж энэ тухай хариуг ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилъя.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 3 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр тогтоолын агуулга:**

Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Санал огт тэмдэглэхгүй байх нь “алийг нь ч сонгохгүй” гэсэн санал өгч буй хэрэг гэж зарим хүн үздэг. Хоёр хүний мандаттай тойрог байна гэж үзвэл 1-ийг нь тэмдэглэсэн хүний санал хүчингүй болж байхад, хоёуланг нь тэмдэглээгүй хүний санал хүчинтэй байж болж байна уу гэдгийг бодолцох нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг Их суудлын хуралдаанаараа дахин хянан хэлэлцээд уг дүгнэлтийг хэвээр үлдээсэн байдаг. Гэхдээ уг тогтоолын үндэслэл хэсэгт тодорхой тайлбар огт хийгээгүй бөгөөд зөвхөн “чөлөөтэй” гэсэн зарчмыг зөрчиж байна хэмээсэн байдаг. Гэтэл сонгуулийн “чөлөөтэй” гэх зарчим нь огт өөр байдлаар буюу санал өгөх, эсхүл санал эс өгөхийг шаардсан, тулгасан идэвхтэй үйлдлээр илэрдэг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1996.06.19 № 02

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ч.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:  
Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд эс сонгох тухай асуудлыг хөндөөгүй болно. Ер нь ч сонгох, сонгогдох эрхийн асуудлыг үйлдэл, эс үйлдэлтэй адилтган үнэмлэхүй утгаар авч үздэггүй практик байдаг. Санал огт тэмдэглээгүй хуудсыг хүчинтэй хуудсанд тооцвол санал хураалтыг будлиантуулах, сонгууль олон газар дахин явагдах, нэр дэвшигчдийн төлөө өгсөн саналын эзлэх хувийг зохиомлоор бууруулах болно. Цэцийн 3 дугаар дүгнэлтэд дурдсан “санал огт тэмдэглээгүй” гэдэг бол иргэдийн сонгох эрхийг хөндсөн зарчмын асуудал биш. Гагцхүү санал тоолох аргачлалыг л тодорхойлсон техник ажлын чанартай санаа тул энэ заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт үндэслэлгүй гэж зарим гишүүд үзсэн.

#### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “санал огт тэмдэглээгүй буюу” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “чөлөөт” гэсэн сонгуулийн зарчмыг зөрчиж иргэдийн сонгох, эс сонгох эрхийг хязгаарласан байна. Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 23-ны 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр тогтоол хууль зүйн үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар өөрчлөлт оруулсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “санал огт тэмдэглээгүй буюу” гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны 41 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно

## **Тэмдэглэл:**

Санал авах хуудсанд нэр бичигдсэн нэр дэвшигчдийг бүгдийг нь тэмдэглээгүй нь “бүгдийг нь дэмжихгүй байна” гэсэн санал гэж үзвэл уг хуудсыг хүчингүйд тооцох нь буруу. Гэхдээ сонгуульд оролцох утга учир нь өөрийн дэмжиж буй нэр дэвшигчийн төлөө санал өгөх, хэрэв хэнийг нь ч дэмжихгүй байгаа бол сонгуульд оролцохгүй байж болно. Сонгогч “хэн нэгний нэрийг тэмдэглээгүй сонгуулийн хуудас”-ыг хүчинтэйд тооцох нь сонгуулийн будлиан гарах эрсдэлийг ямар нэгэн хэмжээгээр нэмэгдүүлдэг гэдгийг ухамсарлан сонгуульд оролцох нь зүйтэй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1996.05.29 № 04**

**Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай  
Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх  
хэсгийн заалт, Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол,  
Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146 дугаар тогтоол  
Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч – Монгол Улсын иргэн Ц., Д., З., Д., Б., Г., Ж.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т., Г., Б.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын нийгмийн даатгалын Ерөнхий газрын дарга С.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 1995 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталсан Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль<sup>27</sup>

- 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “... гавьяат цолтон, ... төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан... орон сууцны байрны /талбай, халаалт, цэвэр, бохир усны/ хөлсний 50 хувь, гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол жилд 1 удаа 4 шоо метр түлээ, 4 тонн нүүрсний үнэ /тээврийн хөлсийг оруулж тооцсон/-ийн 50 хувийг тус тус нөхөн олгоно”

2. Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 60 дугаар тогтоол  
- 1 дэх хэсэг “1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тогтоогдсон цэргийн тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, цэргийн алба хаасны тэтгэвэрт шинээр гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулах арга хэмжээг 1997 онд багтаан хэрэгжүүлэх”

3. Улсын Их Хурлын 1994 оны 61 дүгээр тогтоол  
- 1 дэх хэсэг “1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тогтоосон тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, шинээр өндөр насны тэтгэвэрт гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээг төсвийн хуульд жил бүр тусгах замаар 1997 онд багтаан хэрэгжүүлэх”

<sup>27</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 3-т нийтлэгдсэн

4. Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 104 дүгээр тогтоол  
- 1 дүгээр хэсэг “1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн 1997 онд хүрсэн байвал зохих сарын дундаж хэмжээг 1997 онд багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосугай”

5. Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Цэргийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 105 дугаар тогтоол

6. Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 146 дугаар тогтоол

7. Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн “Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 100 дугаар тогтоол

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”

#### **1. Иргэн Ц., Д. нарын өргөдлийн агуулга:**

Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтад 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тогтоогдсон тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, шинээр өндөр насны тэтгэвэрт гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээг төсвийн хуульд жил бүр тусгах замаар 1997 онд багтаан хэрэгжүүлэх гэж заажээ. Энэ тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд гарч 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхдээ 1997 онд хүрсэн байвал зохих хэмжээг тогтоов. Монгол Улсын Засгийн газрын 104 дүгээр тогтоолд зааснаар 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгогчид 1997 онд сард 7200 - 14400 төгрөгийн тэтгэвэртэй болох юм. Энэ нь 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгогчдоос даруй 2-4 дахин бага байхаар тогтоогджээ. Энэхүү утгаар нь үзэхэд Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд нь тэтгэврийн насны иргэдийг 1995 оноос өмнөх ба хойшхи гэх мэт хугацаагаар ялгаварлан өөр өөр хэмжээтэй тэтгэвэр тогтоож, иргэд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна. Улсын Их Хурлаас 1996 онд батлан гаргасан Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “... төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настанд орон сууцны талбай, халаалт, цэвэр бохир усны хөлсний 50 хувь, гэр, ердийн халааттай сууцанд амьдардаг бол жилд нэг удаа 4 м.куб түлээ, 4 тонн нүүрсний үнийн (тээврийн хөлсийг оруулж тооцсон) 50 хувийг тус тус нөхөн олгоно” гэсэн заалт нь өндөр настан тэтгэвэр авагчдыг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхсан үзэл мөн тул Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ. Үндсэн хууль зөрчсөн эдгээр зөрчлийг хянан үзэж албан ёсны шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

#### **2. Иргэн З.-гийн өргөдлийн агуулга:**

Монгол Улсын тэтгэврийн хуулийн 2 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэйчүүд, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудад 45 нас хүрсэн эрэгтэйчүүд, 40 нас хүрсэн эмэгтэйчүүд гэх мэт нас, хүйсээр нь ялгаварласан нь Үндсэн хуулийг зөрчсөн байна. Монгол Улсын



Засгийн газрын 1995 оны 104 дүгээр тогтоолын 2 дахь заалтад 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн 1997 онд авбал зохих тэтгэврийн түвшинг тогтоон хавсралтаар баталжээ. Энэ тогтоолоор 55, 60-аас дээш насны эмэгтэй, эрэгтэйчүүд гэж ялгаа зааг тогтоосон нь тэтгэврийн насны хүмүүсийг насаар нь ялгаварлажээ. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай 1996 оны хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настанд орон байрны болон түлээ, нүүрсний хөнгөлөлтийг тогтоохоор заасан нь ажил, албан тушаалаар нь иргэдийг ялгаварлан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд эдгээр асуудлыг хууль зүйн үүднээс хянан үзэж, зохих дүгнэлт гаргаж өгөхийг хүсье”

### 3. Иргэн Д.-гийн өргөдлийн агуулга:

Тэтгэврийн насны хүмүүсийг Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолоор 1995 оноос өмнөх ба хойшхи гэсэн цаг хугацаагаар зааглан хоёр ялгаатай тэтгэвэр тогтоож 1995 оноос өмнөх үед тэтгэвэр тогтоолгогчид бага тэтгэвэр авах болов. Улсын Их Хурлаас 1996 онд баталсан ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуульд зааснаар гавьяат цолтон, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан өндөр настанд орон сууцны болон бусад хөнгөлөлт тогтоожээ. Ингэснээр “гавьяат цолтон болон төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан өндөр настанд хөнгөлөлт эдлүүлэх тухай” заалт нь тэтгэврийн иргэдийг алдар цол, албан тушаалаар нь ялгаварлажээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байна. Иймд миний хүсэлтийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Энэ бол зөвхөн миний хүсэлт биш өргөн олон түмний хүсэлт болно.

### 4. Иргэн Г.-гийн өргөдлийн агуулга:

Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 123 дугаар тогтоолд 55, 60-аас дээш насны тэтгэвэр авагчдад 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс 300 төгрөг, 4 дүгээр сарын 1-нээс 500 төгрөг нэмэгдүүлж олгохоор заасан нь тэтгэврийн хуульд заасан үндэслэлээр 50, 55 насандаа тэтгэвэр тогтоолгосон хүмүүст хамаарахгүй болжээ. Энэ утгаар дээрх тогтоол нь тэтгэврийн насны иргэдийг насаар нь ялгаварлаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд буй “иргэд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг зөрчжээ. Засгийн газрын 1993 оны 184 дүгээр тогтоол гарч 55, 60 наснаас дээш тэтгэврээс өөр орлогогүй хүнд 800 төгрөг нэмэн олгохдоо нэг өрхөд 20-оос доошгүй толгой малтай буюу өрхийн орлого жилд 180.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байх журмыг баримтлахаар зохицуулжээ. Энэ нь иргэдийг нас, эд хөрөнгө, малтай эсэхээр ялгаварлажээ. Засгийн газрын 1995 оны 146 дугаар тогтоолоор 70 ба түүнээс дээшхи насны хүмүүсийн тэтгэврийг 1997 онд хүрсэн байх түвшингээр 1995 оны 12 дугаар сарын 1-нээс эхлэн нэмэгдүүлжээ. Ингэснээр 55, 60-аас 70 хүртэл настай өндөр настнууд тэтгэврийн хувьд ялгаатай хэвээр үлджээ. Засгийн газрын 1996 оны 71 дүгээр тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээ нэмэгдэхэд 50-иас дээш насны эмэгтэй, 55-аас дээш насны эрэгтэйчүүд зэрэг 226.4 мянган өндөр настнууд 1997 онд хүрвэл зохих тэтгэврийн түвшинд хүрч чадсангүй. Эдгээр тогтоолууд нь иргэдийг насны байдлаар ялгаварлан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгааг хянан үзэхийг хүсье.

### 5. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:

1995 оноос өмнө тогтоогдсон тэтгэврийг 1995 оноос хойшхи тэтгэвэртэй уялдуулан нэмэх асуудлыг Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоолоор шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль тус улс нэгдэн орсон олон улсын хэм хэмжээг зөрчиж, ялгаатай, тэгш бус байдал тогтоожээ. 1995 оноос хойш тогтоогдсон тэтгэвэр үүнээс өмнөх үеийнхээс илүү тогтоогдсон, Засгийн газраас тэтгэврийн зөрүүг арилгахаар гаргасан тогтоолоор тогтоосон хэмжээ нь 1995 оныхоос хойшхи тэтгэврийн хэмжээнд хүрэхгүй байна. Эдгээр тогтоолууд нь ялгаатай зохицуулалт, хууль буцаан хэрэглэх зарчмыг зөрчсөнөө бүрхэгдүүлэх гэсэн оролдлого мөн.

6. Иргэн Ж.-гийн өргөдлийн агуулга:

Улсын Их Хурлын 1994 оны 61 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн заалтаар 1995 оноос өмнө насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг 1995 оноос хойш тогтоогдсон тэтгэвэртэй харьцуулан нэмэгдүүлэхдээ насны байдлаар тэтгэврийн хэмжээгээр нь ялгаа заагтай болгожээ. Жишээ нь: Засгийн газрын 104 дүгээр тогтоолоор 1997 онд хүрвэл зохих тэтгэврийн түвшин нь 1995 оноос хойшхи тэтгэврийн хэмжээнээс доогуур болжээ. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... гавьяат цолтон, ... төрийн өндөр албан тушаал хашигчдад орон сууцны болон бусад хөнгөлөлт олгохоор" заасан байна. Энэ нь зарим нэгэн гавьяат баймааргүй хүнд, эсвэл төрөөс олгоогүй /МБТ спортын төв зөвлөлөөс олгосон/ гавьяатан, эсвэл төрийн алба хашсан өндөр цалинтай байсан хүнд хөнгөлөлт тогтоон иргэдийг ялгаварлажээ. Засгийн газрын 104 дүгээр тогтоол болон Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн дээрх актуудыг хянан үзэхийг хүсье.

7. Иргэн Ц., Б., Ж. нарын нэмэлт тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын 60, 61 дүгээр тогтоолоор 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүсийг ялгаварлах бодлогын эхийг тавьсан. Тэгэхдээ 1997 онд багтаах бодлого үүссэн гэж үздэг. Үүнээс уламжлаад 104 дүгээр тогтоол гарч 1997 онд хүрэх гэсэн арга түвшинг зохицуулсан. Бидний бодлоор бол 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш бүх тэтгэвэр авагчид ижилхэн хангамжтай байх ёстой. Өөрөөр хэлбэл байгаа мөнгөө хуваагаад өгөх ёстой гэж үздэг. Насаар нь ялгаварлан гадуурхсан нь буруу. 1995 оноос хойшхи нь их өндөр тэтгэвэртэй болоод байгаа юм. Энэ ялгааг арилгахад доорх арга бий. Үүнд:

а/ 1995 оноос мөрдөгдсөн тэтгэврийн хуулийг хүчингүй болгон түүнээс өмнөх хуулийг мөрдүүлбэл бид хуулийн өмнө тэтгэврийн хувьд адилхан болно.

б/ Хөрөнгийн эх үүсвэр олж 1995 оноос өмнөх хүмүүсийн тэтгэврийг 1995 оноос хойшхи хэмжээнд хүргэж нэмэх.

в/ Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл буюу эрх тэгш байх гэдэг зарчмаас ухарч түүнийг хүчингүй болгон олон улсын гэрээнээс гарах ёстой. Ингэвэл бид маргах эрхгүй болно. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гавьяат цолтон, төрийн өндөр албан тушаалтанд хөнгөлөлт олгох тухай заасан нь тэтгэврийн хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хэрэг гэж үзэж байна. Ялангуяа өндөр албан тушаалтан гэдэг нь тодорхой ойлгогдох байх, тэд хөрөнгө зорьтой улс шүү дээ.

8. Иргэн З.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Ахмад настангуудыг нас, тэтгэвэр тогтоолгосон байдлаар нь ялгаварлан зааг ялгаатай тэтгэвэр тогтоосон нь Үндсэн хуультай зөрчилдөж байна. Би өргөдлөө тэтгэвэр тогтооход насаар нь ялгав гэсэн хүсэлт гаргасан. Үүнээ буцаан татаж авлаа. Цэцэд гаргасан өргөдөлдөө дурдсан бусад шаардлагаа дэмжиж байна. Ер нь тэтгэврийн насны хүмүүсийг тэтгэврийн хувьд ялгаатай журам тогтоосныг анхаарч үзэхийг хүснэ. 1995 оноос хойш цэргийн тэтгэвэр тогтоолгогчдод нэг удаагийн тэтгэмж болгон тэдний 18-36 сарын цалинг олгодог байхад үүнээс өмнөх үед тэтгэвэрт гарагчдад энэ журам байхгүй. Энэ бол тэтгэврийн хүмүүсийг ялгасны баталгаа мөн.

9. Иргэн Д.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Би Улсын Их Хурал, Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгчдийн тайлбарыг хүлээн авах боломжгүй байна. Бидний эмзэглэсэн зүйл бол 1995 оноос өмнөх тэтгэвэр 1995 оныхоос 2-оос 4 дахин бага байгаад оршино. Ер нь төрөөс хүмүүсээ тэтгэврийн хувьд адилхан байлгах зарчмыг баримтлах нь чухал.

10. Иргэн Б.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас 60, 61 дүгээр тогтоолыг гаргахдаа тус улс нэгдэн орсон олон улсын хэм хэмжээг ноцтой зөрчиж тэтгэвэр авагч иргэдийг 1995 оноос өмнөх ба хойш гэж ялгаа заагтай журам тогтоожээ.

11. Иргэн Ц.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Нийгмийн даатгалын багц хуулиуд батлагдаж гарснаар тэтгэврийн хүмүүст 2 өөр хууль үйлчлэх боллоо. Хууль буцаан хэрэглэх олон улсын түгээмэл зарчим байдаг. Шинээр гарч байгаа хуулийн эерэг заалт бүхэн тухайн харилцаанд хамаарагдаж байгаа бүх хүнд адилхан тусах ёстой. Тэгээд ч шинэ хууль 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн болохоор тэтгэвэр, тэтгэмж авдаг бүх хүнд адил тусаж олгогдох нь зарчмын асуудал юм. Гэтэл энэхүү хүмүүнлэг зарчмыг "Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 7-ны 60, 61 дүгээр тогтоолуудын 1 дүгээр заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно", Арван зургадугаар зүйлийн 1 дэх заалтын "амьд явах эрхтэй" гэснийг зөрчиж, тэр тусмаа өндөр настан, тэтгэвэр авагчдыг ялгаварлах, алагчлах, хууль зөрчих боломж нөхцөлийг тавьж өгсөн гэж үзэж тайлбар гаргаж байна. Би өргөдөлдөө бичсэн бүх хүсэлтээ дэмжиж байна"

12. Улсын Их Хурлын гишүүн Т., Г. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын 1995 оны 61 дүгээр тогтоолыг би хувьдаа Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй гэж хувь хүний хувьд үздэг тул өөрийн үзэл бодлын эсрэг Улсын Их Хурлыг төлөөлөх боломжгүй. Харин Засгийн газрын баримт бичгүүд Улсын Их Хурлын дээрх тогтоолтой нийцэж гарсан тул хэлэх юм алга. Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгээд байгаа иргэдийн тэтгэврийг ялгаатай байхаар /1997 он хүртэл/ тогтоосон Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын заалтыг зөвшөөрч чадахгүй байгаа юм. Ийм учир шалтгааны улмаас энэ асуудлаар Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн үүргийг биелүүлэх боломжгүй байгааг анхааралдаа авч шинээр хүн томилох арга хэмжээ авахыг хүсье.

13. Улсын Их Хурлын гишүүн Б., Т. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Засгийн газрын 104, 105 дугаар тогтоол нь Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын дагуу гарсан боловч 1997 онд шинээр тогтоолгох хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдсан эсэхэд эргэлзэх зүйл бий. Ер нь ижил төрлийн ажил, албан тушаал эрхэлж байсан хүмүүс хэдийд ч тэтгэвэр тогтоолгосон, адил тэтгэвэр авах зарчим баримтлах нь шударга ёсонд нийцнэ. Хэрэв энэ зарчимд нийцэж байвал Үндсэн хууль зөрчсөн гэх үндэсгүй. Засгийн газрын 1995 оны 146 дугаар тогтоолоор 70-аас дээш насны хүмүүс, тэтгэвэр авдаг хамгийн эмзэг хэсэгт нь эхний ээлжинд тэтгэврийг нэмсэн нь шударга ёсонд нийцэхгүй гэх үндэсгүй. Нэгэнт эх үүсвэр нь хангалтгүй байгаа бол ийм алхам хийх нь эмзэг хэсгээ өөд татахад эрх биш тус нэмэр болно. Харин ийм хүмүүстэйгээ барьцаж Үндсэн хууль зөрчсөн гэх нь шударга ёс биш байх. Улс орондоо гавьяа байгуулсан алдар цолтнууд, эрхийг нь хуулиар хязгаарладаг төрийн өндөр албан тушаалтнуудад нэмэгдэл хөнгөлөлт үзүүлдэг нь гадаадын ардчилсан улс орнуудын жишиг байдаг. Иймээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхгүй байх. Засгийн газраас тэтгэврийг нэмэгдүүлэх талаар гарсан шийдвэрүүд нь нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолын 1 дүгээр заалттай уялдаж байгаа юм.

14. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

а/ Улсын Их Хурлын 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 104, 105, 146 дугаар тогтоолууд Үндсэн хууль зөрчсөн эсэх тухайд авч үзвэл Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тус улсын иргэд тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй байна гэж заасан. 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдсөн нийгмийн даатгалын багц хуулиуд нь зөвхөн даатгалын шинэ харилцааны онцлог зарчмыг тусгасан учраас 1990 оны тэтгэврийн хуулиар тогтоогдсон тэтгэврийг шинэ хуулийн дагуу өөрчлөн нэмэгдүүлэх чиглэлийг Улсын Их Хурлын 60, 61 дүгээр тогтоолоор Засгийн газарт өгсөн. Үүний дагуу Засгийн газрын 104, 105, 146 дугаар тогтоолоор бүх тэтгэврийг 20 хувиар /цэргийн тэтгэврийг 40 хувиар/ нэмэгдүүлж, 1995 оноос өмнө тогтоогдсон тэтгэврийг 1997 онд хүрвэл зохих түвшинг тогтоосон. Эдгээрийн дотроос 70-аас дээш настангууд, бусдын асрамжинд байдаг хүмүүсийн тэтгэврийг 1995 оны 11 дүгээр сараас эхлэн 1997 онд хүрвэл зохих түвшингээр нэмэгдүүлсэн. Эдгээр нь Засгийн газар 1995 оноос өмнөх тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлого бөгөөд энэ нь Засгийн газрын 104, 105, 146, 71 дүгээр тогтоолоор 1995 оны өмнөх тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлсэн үйл ажиллагаа болно. Ийм учраас 1995 оноос өмнө тогтоогдсон бүх хүний тэтгэврийг хавтгайруулан цөөн хэдэн төгрөгөөр нэмэгдүүлэхийн оронд өндөр настай ахмадууд, хортой, халуун, газрын доорх нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэд амжиргааны түвшингөөс доогуур орлоготой иргэдийн тэтгэврийг тэргүүн ээлжинд нэмэгдүүлсэн нь тэтгэвэр авагсдыг насаар нь ялгаварласан бодлогыг хуульчлан тогтоогоогүй болно.

б/ Улс оронд онцгой гавьяа байгуулсан хүмүүсийг дэмжих зорилгоор хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмадуудад орон сууцны зарим хөнгөлөлтөлгохоор Нийгмийн халамжийн багц хуульд тусгагдсан. Энд одон медалиар шагнагдсан ахмадууд хамаараагүй.

в/ 1995 оноос өмнөх үед тогтоогдсон тэтгэврийг хөдөлмөрийн хөлсний өсөлтийг харгалзан индексжүүлэн нэмэгдүүлсэн. 1991 онд хөлсний доод хэмжээ цагт 3 төгрөг 59 мөнгө байсан бол одоо 49 төгрөг 23 мөнгө бөгөөд үүнээс үндэслэн 13.71 гэсэн индекс баримталсан болно.

15. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Сү.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Хуралдаанд хэлэлцэж буй гомдлууд нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн тэтгэвэр авах эрхтэй холбоотой. Тэтгэврийн 1991 оны болон 1995 оны хуулиудаар тэтгэвэр бодох хувь ижилхэн. Үнийн өсөлтийн дагуу индекс хэрэглэхэд 1995 оноос өмнөх ба хойшхи тэтгэврүүд ойролцоо болно. Улсын Их Хурлын 60, 61 дүгээр тогтоолд зааснаар 1995 оноос өмнө тогтоогдсон тэтгэврийг үнийн өсөлттэй холбогдуулан нэмэгдүүлэх чиг бодлого баримталжээ. Засгийн газар энэ арга хэмжээг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн. Ингэхдээ иргэдийн нас, амьдралын нөхцөл, бусад байдлыг нь харгалзан хэрэгжүүлж ирсэн. Эдгээр нь хөрөнгөнөөс хамаарах тул Монгол Улсын Засгийн газар 1995 оноос өмнөх тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлж ирсэн. Иймд Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоолууд Үндсэн хуулийг зөрчиж байна гэх үндэслэлгүй байна.

16. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Хэлэлцэж буй асуудал бол эмзэг асуудал. Улсын Их Хурал ахмадуудаа ялгаварлан үзээгүй бөгөөд эцсийн үр дүнд хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолууд бол өндөр настнуудыг тэтгэврийн хувьд адилхан болгоход чиглэсэн арга хэмжээ болно. 1996 онд батлан хамгаалахад 11 тэрбум төгрөг гаргаж байна. Гэтэл тэтгэвэр тэтгэмжид мөн 11 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ бол төрөөс тэтгэврийн хүмүүсийн талаар авч буй арга хэмжээний төрөл мөн. Эдгээр байдлуудыг харгалзан үзэхэд Улсын Их Хурлын 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын

104, 105, 146 дугаар тогтоолууд, "Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн тухай хууль" Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна. Өнөөдрийн хуралдаанд тавигдаж байгаа асуудал бол шийдвэл зохих асуудал мөн үү гэвэл мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Нэг. Улсын Их Хурал Нийгмийн даатгалын багц хуулиудыг баталж мөрдүүлэх, 1995 оноос өмнөх үед тэтгэвэр тогтоолгогсдын тэтгэврийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ иргэдийг нас, тэтгэвэр тогтоолгосон цаг хугацааны байдлаар нь ялгаварлахад хүргэсэн, хууль тогтоох эрх мэдлийн асуудлыг Монгол Улсын Засгийн газарт хэрэг дээрээ шилжүүлсэн агуулгатай болсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Хорьдугаар зүйлийн зохих заалтуудыг зөрчжээ.

Улсын Их Хурлын энэхүү үйл ажиллагаанаас шууд шалтгаалан Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146 дугаар тогтоол гарч иргэдийг нас, тэтгэвэр тогтоолгосон цаг хугацаагаар нь ялгаварласан байдлыг бий болгожээ. Энэ талаар гаргасан иргэн Ц., Д., З., Б., Да., Г., Ж. нарын гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байна.

Хоёр. Иргэн Г.-гийн гомдолд байгаа "55, 60 нас хүрээгүй иргэдийг тэтгэврийн нэмэгдлийн хувьд ялгаварлан үзэж Монгол Улсын хууль зөрчсөн байгааг хянан үзэхийг хүсье" гэсэн шаардлагыг хангах үндэслэлгүй байна.

Гурав. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтад буй "...төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан... орон сууцны талбай, халаалт, цэвэр, бохир усны 50 хувь, гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол жилд нэг удаа дөрвөн шоо метр түлээ, 4 тонн нүүрсний үнийн /тээврийн хөлс оролцуулан тооцсон/ 50 хувийг тус тус нөхөн олгоно" гэсэн заалт нь тэтгэврийн насны иргэдийг урьд хашиж байсан албаны байдлаар ялгаварласан агуулгатай болжээ.

Энэ хуулийн дагуу гарсан Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2, 5 дахь заалтууд нь Төрийн албаны хууль, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн тул энэ талаархи гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. а/ Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д буй "... төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан..." гэсэн заалт;

б/ Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 60 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн "1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тогтоогдсон цэргийн тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, цэргийн алба хаасны тэтгэвэрт шинээр гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулах арга хэмжээг 1997 онд багтаан хэрэгжүүлэх" гэсэн заалт;

в/ Улсын Их Хурлын 1994 оны 61 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн "1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тогтоосон тэтгэврийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, шинээр өндөр насны тэтгэвэрт гарах хүмүүсийн тэтгэврийн хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээг төсвийн хуульд жил бүр тусгах замаар 1997 онд багтаан хэрэгжүүлэх" гэсэн заалт;

г/ Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 1 дүгээр заалт буюу "1995 оны 1 дүгээр сарын 1- нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн 1997 онд хүрсэн

байвал зохих сарын дундаж хэмжээг 1997 онд багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосугай” гэсэн заалт, уг тогтоолын 1 дүгээр хавсралт;

д/ Цэргийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 22-ны 105 дугаар тогтоол, түүгээр батлагдсан хавсралт;

е/ Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 21-ний 146 дугаар тогтоолын 1 дүгээр заалт;

ж/ Нийгмийн халамжийн хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 1-ний 100 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн заалтаар батлагдсан тус тогтоолын 2 дугаар хавсралтын “Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, түүний нөхцөл, хамрах хүрээ” гэсэн 1 дэх хэсгийн 2-ын “... төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан...” гэсэн заалт, мөн хэсгийн 5 дахь хэсгийн 1, 2 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д буй “... гавьяат...” гэсэн заалт Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 123, 184, 1996 оны 71 дүгээр тогтоолуудын зохих заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1996 оны хаврын чуулганы завсарлага дууссанаас хойш 10 хоногт багтаан хянан хэлэлцээд хариуг манайд ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай”

**“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 69 дугаар тогтоолын агуулга:**

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146, 1996 оны 100 дугаар тогтоолын зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэж үзсэн иргэн Ц., Д., З., Да., Б. нарын гомдлын талаар гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх хэсгийн “б”, “в”, “г”, “д” заалт болон 2 дахь хэсгийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх хэсгийн “а”, “е”, “ж” заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Өндөр настан болгон харилцан адилгүй хугацаагаар, харилцан адилгүй цалинтай ажил хийж байсан нь тэтгэврийн зөрүүг бий болгоход нөлөөлдөг нь зүйн хэрэг боловч тэтгэвэрт гарсан оноос нь шалтгаалан итгэлцүүрийн хэмжээг ялгавартай тогтоож байгаа нь улам их зөрүүг бий болгосон байна. Залуу нас, ажил хөдөлмөрөө улс эх орондоо зориулсан өндөр настны хувьд “тэтгэвэр” гэдэг нь орлогын эх үүсвэр байдаг төдийгүй хамгийн эмзэг сэдэв нь тул нухацтай хандах нь чухал. Төгрөгийн ханшны хэлбэлзэл, инфляцийн түвшин зэргээс шалтгаалан тэтгэвэрт гарагсдын тэтгэврийн зөрүү их байх явдал бий. Гэхдээ тэр аль болох тэтгэврийг тэнцвэржүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

2. Ахмад дайчин гэх мэт улс эх орны өмнө гарамгай гавьяа байгуулсан ахмад настнуудад хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлж болох боловч эрхэлсэн ажил, албан тушаалаас нь хамааран илүү хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлнэ гэдэг нь алагчилж буй хэрэг мөн.

3. Монгол Улсын Их Хурлын 1996 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай” 69 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх хэсгийн “а”, “е”, “ж” заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй” гэж үзсэн байтал Үндсэн хуулийн цэц дээрх асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна. Өөрөөр хэлбэл дээрх маргааныг эцэслэн шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаан хуралдаагүй байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1996.06.20 № 05**

**Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Е., Б., Н.;  
Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч - Д., М.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр тогтоол

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”
- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н., Б. нарын өргөдлийн агуулга:

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор Н., Б. нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10-т байгаа “Монгол Улсын иргэн... сонгогдох эрхтэй... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний

төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны дээрх шийдвэр нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд буй “сонгогчдоос хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломж хангасан сонгуульд сонгогдох” гэсэн заалтыг зөрчсөн учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалт зөрчигдөж байна. 1996 оны 6 дугаар сарын 30-нд болох Улсын Их Хурлын сонгуульд сонгогдох эрхээ эдлэх, нэр төрөө хамгаалахын тулд энэхүү өргөдлийг бичив. Асуудлыг Үндсэн хуулийн дагуу шийдвэрлэж өгөхийг хүсч байна. Өргөдөлтэй холбоотой тайлбар, хууль зүйн үндэслэлийг Цэцийн хуралдааны үед гаргах боломж олдоно гэдэгт найдаж байна.

## 2. Иргэн Е.-гийн өргөдлийн агуулга:

Би МАХН-ын гишүүн байхаас сайн дураараа татгалзаж гишүүнээс чөлөөлж өгөх тухай өргөдлөө 1996 оны 5 дугаар сарын 10-нд бичиж өөрийн харьяалах намын үүрийн тэргүүлэгч Д.-д өгсөн. Тэрхүү өргөдлийг миний харьяалах намын үүрийн нарийн бичгийн дарга Л. авсан бөгөөд 1996 оны 5 дугаар сарын 16-ны өглөө 8.20 цагт ажилд явахынхаа өмнө Л.-ийн гэрт очиж намын гишүүний бат илэрхийлэхээ өгч, намын гишүүний асуудлыг шуурхай шийдвэрлэхийг хүссэн бөгөөд миний бие МУНН-аас Улсын Их Хуралд нэр дэвших учраа нуухгүйгээр танилцуулсан. Би Сонгуулийн болон Улс төрийн намуудын тухай хуулиудыг мэдэж байсан учир намын харьяаллыг шийдвэрлүүлэх шаардлагатай байсан. Миний бие энэ асуудлыг тогтоосон журмын дагуу тавьсан бөгөөд асуудал зохих ёсоор шийдэгдсэн гэж ойлгосон. МУНН-аас 1996 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшүүлэх хурал 5 дугаар сарын 17, 18-нд болж эцсийн шийдвэр 5 дугаар сарын 18-нд гарч Е. миний бие Улсын Их Хурлын 6 дугаар тойрогт нэр дэвшигдсэн болно. Энэ өдрийн маргаашаас эхлэн энэ тойрогт МАХН-аас нэр дэвшсэн Б.-г дэмждэг З. мэтийн хүмүүс манай намын дарга Ж.-д Е-г татаж авахгүй юу, Б.-д өгөх санал хуваагдана гэж шаардлага тавьж эхэлсэн. Миний өргөдөлд 5 дугаар сарын 18-нд хүлээн авсан гэсэн цохолт хийжээ. Би үүнийг зөвшөөрөхгүй. Би сонгуульд нэр дэвшихээсээ өмнө МАХН-ын үүрт гишүүнээс гарах өргөдлөө өгсөн байхад МАХН-аас гараагүй атлаа өөр намын өмнөөс Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэв гэсэн нь үндэслэлгүй бөгөөд энэ үндэслэлээр Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасныг зөрчсөн байна. Үндсэн хуулийн цэц энэхүү асуудлыг ул суурьтай үзэж, үнэн зөв шийдвэр гаргана гэдэгт итгэж байна. Би МАХН-аас гарах өргөдлөө 1996 оны 5 дугаар сарын 10-нд өгсөн. Би 1996 оны 6 дугаар сарын 20 гэхэд Улсын Их Хурлын гишүүнээр нэр дэвшигчээр бүртгүүлсэн. Энэ үед би МАХН-аас гарсан байв. Би бодохдоо 1996 оны 5 дугаар сарын 10-наас эхлэн МАХН-аас гарсан гэж үзнэ. Учир нь энэ өдрөөс эхлэн би МАХН-ын үйл ажиллагаанд оролцохоо больсонтой холбоотой.

## 3. Иргэн Н., Б. нараас гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

Миний бие болон МАХН-ын байгууллага хооронд үүссэн маргааныг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх журмын тухай хуулийн 138 дугаар зүйлийн 1-д тус тус зааснаар шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар зохицуулахын оронд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд нэг талыг баримталж шийдвэрлэв. Ингэхдээ Улс төрийн намуудын тухай хуулийн 4<sup>1</sup> дүгээр зүйлд зааснаар эрх зүйн хэм хэмжээг баримтлах, Төрийн албаны хуулийн 13 дугаар зүйлд буй Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх гэсэн заалтуудыг биелүүлсэнгүй.

Нөгөө талаар Улс төрийн намуудын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 1996 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон учир 1996 оны 4 дүгээр сарын 28-нд МҮАН - МСДН, Ардчилсан холбоо эвслээс миний биеийг нэр



дэвшүүлсэнд хамаарахгүй болов уу. Үндсэн хуулийн цэц Сонгуулийн ерөнхий хорооны адил МАХН-ын дүрмийг баримтлахгүй шүүх Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэх эрхгүй гэсэн заалтыг мөрдөнө гэж найдаж байна.

4. Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

а/ Н. нь МАХН-д гишүүнээр элссэн баримт байгаа боловч МАХН-аас гарсан баримт байхгүй, бас МСДН-ын гишүүнээр элссэн баримт бий. Үүнээс үзэхэд Н. хоёр намын гишүүн байх тул Сонгуулийн ерөнхий хороо асуудлыг шийдвэрлэсэн. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 2 дугаар зүйлийг үндэслэсэн. Тэгэхдээ Сонгуулийн ерөнхий хороо шүүх эрх мэдлийг авч хэрэгжүүлээгүй. МАХН-ын тухайн үеийн дүрмийг баримталсан болно. Сонгуулийн ерөнхий хороо хууль зүйн дагуу асуудлыг шийдвэрлэсэн болно. Иймд иргэн Н.-ийн хүсэлт үндэслэлгүй. Тэрээр МАХН-ын тухайн үеийн дүрмийг баримталж гишүүнээс албан ёсоор гараагүй болно гэв.

б/ Б. гуайтай холбоотой асуудал бол Н.-ийнхтэй адилхан. Учир нь Б. МАХН-аас гишүүний хувьд гарсан гэдэг баримт байхгүй байдаг оршино. Тэрээр МАХН-д гишүүн байсан баримтууд бий. Иймд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр үндэслэлтэй болно гэв.

в/ Е.-гийн хувьд авч үзэхэд МАХН-аас гарах өргөдөл бий. Өргөдлүүдэд цохолт хийсэн байна. 1996 оны 5 дугаар сарын 17 гэхэд МАХН-ын гишүүний асуудал шийдэгдээгүй байжээ. Хууль зүйн фактуудыг үндэслэн үзэхэд Е.-гийн МАХН-ын гишүүний асуудал нэр дэвших үед шийдэгдээгүй байна. Бид Улсын Их Хурлын гишүүнээр нэр дэвшүүлэх гэдгийг аль нэг намаас анх шийдвэр гарснаар тооцох ёстой. Е. нь 1996 оны 5 дугаар сарын 17-нд нэр дэвшсэн болно гэж энэ талаарх тогтоолыг танилцуулав. Иймд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр үндэслэлтэй.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсэг:**

Иргэн Н., Б., Е. нар 1987, 1975, 1983 онд Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүнд элссэн нь тухайн үеийн баримтаар нотлогдож байна.

Иргэн Н., Б., Е. нар Улсын Их Хурлын гишүүний сонгуульд Монголын Социал Демократ Нам, Монголын Үндэсний Ардчилсан Нам, Монголын Уламжлалын Нэгдсэн Намаас нэр дэвших үедээ өөрсдийн элссэн Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүнээс гараагүй болох нь Сонгуулийн ерөнхий хорооноос хийсэн шалгалтын явцад нотлогджээ.

Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэл маргааныг хянан шалгах явц болон Цэцийн хуралдааны явцад тогтоогдсонгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр тогтоолын Н., Б., Е. нартай холбоотой заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 24 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

**Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт “Иргэн Н., Б., Е. нар 1987, 1975, 1983 онд Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүнд элссэн нь тухайн үеийн баримтаар нотлогдож байна” гэсэн байдаг. Энэ нь Н., Б., Е. нар тус бүр 3 удаа МАХН-ын гишүүнээр элссэн гэж ойлгогдохоор байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “... сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заажээ. Эвлэлдэн нэгдэх эрхтэй бол эсрэгээрээ мөн гарах эрхтэй юм. Гэвч нэг намын гишүүн байж нөгөө намаас нэр дэвших нь боломжгүй зүйл юм.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1996.09.11 № 04**

**Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий хорооны  
1996 оны 9 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх  
тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Н., Б., Е.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О.;  
Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч - Д.

**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О.-гийн тайлбарын агуулга:

Сонгуулийн ерөнхий хороо нэр бүхий иргэдийн асуудлыг шийдвэрлэхдээ нэр дэвшигч тухайн үед ямар үзэл бодолтой, аль намын гишүүн болсон, аль намын батлах гар дээр нь байсан бодит байдлыг харгалзахгүйгээр хүсэлгүй хүнийг заавал МАХН-ын гишүүн байхыг тулгах замаар шийдвэрлэсэн нь агуулгаараа улс төрийн хүчирхийлэл юм. Энэ утгаар нь авч үзвэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж тайлбарлах байна. Ер нь МАХН-аас гарах тухай хүсэлтээ гаргаад байгаа гишүүнийхээ асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлээгүй намын байгууллагын буруутай ажиллагаанаас иргэн хүн хохирч байх ёсгүй.

2. Иргэн Е.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн цэц асуудлыг шийдвэрлэхдээ миний нэрийг дэвшигчээр бүртгэсэн үе, нэр дэвшиж үнэмлэх авсан цаг үеийг харгалзаж шийдэхийг хүсч байна. Сонгуулийн ерөнхий хороо хүний эрхийн асуудлыг ул үндэс муутай, өөрөөр хэлбэл

миний биеийг Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүн байсан гэдэг нэгэн урсгалд багтаан шийдвэрлэсэн. Монгол Ардын Хувьсгалт Намын ажилтнуудыг хариуцлагагүй ажиллагааны үр дагаврыг МАХН-аас гарч буй гишүүн үүрэх ёсгүй. Сонгуулийн ерөнхий хороо хүний эрхийг ноцтой зөрчсөн юм.

**3. Иргэн Н.-ийн тайлбарын агуулга:**

Сонгуулийн ерөнхий хороо шүүхийн шийдвэр гаргуулаагүйгээр улс төрийн намаас тухайлбал, МАХН-аас бүрдүүлсэн материалыг туйлын үнэн зүйл гэж түүнийг баримтлан шийдвэр гаргаснаар миний сонгогдох, бусад хүмүүсийн сонгох эрхийг зөрчсөн юм. Сонгуулийн ерөнхий хороо намайг МАХН-аас гарсныг мэдэх хүмүүстэй болон надтай уулзаж тодотгохгүйгээр Ц. гэдэг хүний тодорхойлолтыг үндэслэн асуудлыг шийдсэнээр Үндсэн хууль зөрчсөн юм.

**4. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Л.-ээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарын агуулга:**

Б., Н., Е. нар МАХН-ын гишүүнээр элссэн, гишүүн байсан нь нотлох баримтаар нотлогддог. Харин эдгээр хүмүүс МАХН-аас дүрэмд заасны дагуу албан ёсоор гарсан нь тогтоогдоогүй юм. Иймд Б., Н. нар “МҮАН–МСДН-ын Ардчилсан холбоо” эвслээс, Е. МУНН-аас Улсын Их Хурлын гишүүнээр нэр дэвшүүлсэн нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна.

**5. Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:**

Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Намуудын тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэж зохих шийдвэр гаргасан тул Сонгуулийн ерөнхий хороо Үндсэн хууль зөрчөөгүй. Н., Б., Е. нар нь МАХН-аас гарсан гэдэг нь шалгалтаар нотлогдоогүй.

**Үндсэн хуулийн цэцийн тогтоолын Үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 5 дугаар дүгнэлтийг хэлэлцээд гаргасан 24 дүгээр тогтоолдоо уг дүгнэлтийг хүлээж авахгүй байх үндэслэлээ заагаагүй байна.

Иргэн Н., Б., Е. нар Улсын Их Хурлын гишүүний сонгуульд МСДН, МҮАН, МУНН-аас нэр дэвших үедээ өөрсдийн элссэн МАХН-ын гишүүнээс гараагүй болох нь Сонгуулийн ерөнхий хорооноос хийсэн шалгалтын явцад нотлогджээ.

Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэл маргааныг хянан шалгах явц болон Цэцийн хуралдааны явцад тогтоогдсонгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

**Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн холбогдох Дунд суудлын хуралдаанаас Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэсэн шийдвэрийг гаргасан байна. Одоогийн байдлаар “Зөрчөөгүй” гэсэн Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурлаас хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн анхны тохиолдол нь энэ юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996.07.17 № 06

### Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т., Г.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1993 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>28</sup>

- 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй”

- 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын Байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй”

- 22 дугаар зүйлийн 3 дахь заалт “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа тогтооно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүний тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг, тухайлбал “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг зөрчиж байна. Өмнөх Засгийн газарт тохиолдсон энэхүү алдааг давтахгүй байх үүднээс миний өргөдлийг Засгийн газрын шинэ Ерөнхий сайд, бусад сайдыг томилогдохоос өмнө хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Цэцээс гүнээ итгэмжлэн хүсч байна.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална, Хорин тавдугаар зүйлд хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах,

28 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 6-7-д нийтлэгдсэн

хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах асуудлыг Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж заасан. Эдгээр заалтаар Улсын Их Хурлын, улмаар Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүргийн зонхилох хэсэг тодорхойлогдож байгаа учраас Улсын Их Хурлын гишүүнтэй холбоотой аливаа хууль үндсэн үүргийн энэхүү зонхилох хэсэгт хохирол учруулах ёсгүй гэж үзэж байна. Гэтэл Улсын Их Хурлын гишүүнийг Ерөнхий сайд буюу Засгийн газрын гишүүн байхыг хуулиар зөвшөөрсөн нь тухайн гишүүнд хууль хэрэгжүүлэх, хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтийг хянах гэсэн хоорондоо сонирхлын зөрчил бүхий хоёр үүргийг оногдуулж байна.

Практик талаасаа нэг хүн Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүний үүрэгт ажлыг давхар гүйцэтгэх боломжтой гэх үндэслэл бага бөгөөд энэ байдлыг хүлээн зөвшөөрсөн нь Улсын Их Хурлын тухай хуулийн зүйл 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт байгаа “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалингийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа зохицуулна” гэсэн заалтаар нотлогдож байна.

Сонирхлын зөрчил нь эрх мэдлийн хуваарилалтад хохирол учруулж байгаагаараа ноцтой бөгөөд түүнийг Улсын Их Хурлын тухай хуулийн зүйл 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол Улсын Их Хурлын болон бусад байнгын хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй” гэсэн заалтаар ч засах боломжгүй гэж үзэж байна. Цэцээс миний өргөдлийг хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэх тохиолдолд Улсын Их Хурлын тухай хуулийн зүйл 22 дугаар зүйлийн 2 ба 3 дахь хэсгийн заалтыг нэгэн адил хамтад нь хүчингүй болгож өгөхийг гүнээ хүсье.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн тайлбарын агуулга:

Энэ асуудал бүр 1991 оны 12 дугаар сард Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед яригдаж байсан. Ардын Их Хурлын депутат Х. “Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд болон зарим гол гол яамдын сайдаар хавсран ажиллаж болно” гэсэн санал гаргаж хэлэлцүүлжээ. Түүнийг нь депутатуудын олонхи дэмжээгүй нь үнэн. Дараа нь депутат Б., Д. нар “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн томъёоллоор 2 удаа санал хураалгахад 82 хувиар төслийн томъёоллыг зөвшөөрсөн байна лээ. Хэдий тийм боловч Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж шууд үзэх үндэслэл муутай санагдана. Зөрчсөн, зөрчөөгүй гэж хэлэх хуулийн үндэслэл тодорхой биш учраас Үндсэн хуулийн цэц асуудлыг тал бүрээс нь нягтлан үзэж зөв шийдвэр гаргана гэж найдаж байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар чуулганаар Монгол Улсын Их Цаазын төслийг хэлэлцэж байх үед Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгээс Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн гэсэн үгийг хасаж шийдвэрлэсэн нь Улсын Их хурлын гишүүн дээрх албан тушаалыг хавсран ажиллаж болохыг үгүйсгээгүй юм. Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хавсран ажиллаж байгаа нь Засгийн эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалттай нийцэж байна. Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх заалт нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн агуулгад багтаж байгаа учраас энд Үндсэн хуулийн зөрчил гараагүй гэж үзэх үндэстэй.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурал, түүний гишүүний үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн Хорьдугаар зүйл, Хорин гуравдугаар зүйл, Хорин тавдугаар зүйл, Хорин есдүгээр зүйлд тодорхой заажээ.

2. Засгийн газрын гишүүний албан тушаал нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт байгаа "...хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал" гэсэн ойлголтод хамаарахгүй болох нь хуралдааны явцад цугларсан нотлох баримтуудаар батлагдаж байна.

3. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна гэсэн иргэн Л.-ийн гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

Нэг. Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн:

1. "Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа тогтооно" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчиж байна.

Хоёр. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай"

## **"Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 6 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 1996 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 6 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчиж байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

## **Тэмдэглэл:**

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч О. “Засгийн газар бол Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллага. Тэгэхээр тайлагнадаг байгууллагын гишүүн өөрөө тайлагнуулдаг байгууллагынхаа гишүүн болчихоор өөрөө өөрийнхөө өмнө ажлаа тайлагнана гэсэн үг” хэмээн нэгэнтээ хэлж байжээ.

Эрх мэдэл хуваарилах онолыг хөгжүүлэхэд Д.Локк, Ш.Монтескье нар чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Ш.Монтескье “Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг этгээдэд буюу байгууллагад нэгтгэвэл эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, хэрэгжүүлэх аюул тулгарна” гэж томъёолсон байдаг.

Эрх зүйт төрийн нэг шинж нь эрх мэдлийн оновчтой хуваарилсан байдал юм. Монгол Улс шинэ Үндсэн хуулиа 1992 онд баталж хууль тогтоох эрх мэдлийг Улсын Их Хуралд, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч, Засгийн газарт, шүүх эрх мэдлийг Үндсэн хуулийн шүүх, шүүх байгууллагад харьяалуулсан. Гэтэл Улсын Их Хурлын гишүүд өөртөө ашигтай хууль батлаад, түүнийгээ өөртөө ашигтайгаар хэрэгжүүлэх сонирхолдоо хөтлөгдөн “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн байж болно” гэсэн мэргэн санааг олсон ч Үндсэн хуулийн цэц энэ санаагаа гүйцэлдүүлэхэд нь тухай бүр саад болж байв. Улсын Их Хурал 2000 онд Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн нэмэлт өөрчлөлтийг оруулсан түүхтэй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1996.09.07 № 03**

### **Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйл Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д., А.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын 1996 оны 7 дугаар сарын 30-ны 23 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэхээр шийдвэрлэжээ. Энэ тогтоолыг батлахад 57 гишүүн санал хураалтанд оролцсоноос нэр бүхий 35 гишүүн зөвшөөрсөн, 22 гишүүн татгалзсан санал өгчээ. Хуралдаанд 19 гишүүн оролцоогүй байна. Улсын Их Хурал төрийн байгууллага болохынхоо хувьд “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй” гэсэн хэлбэрээр Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх, дахин хянан үзэхийг хүсч байгаагаа илэрхийлэх ёсгүй билээ.

Бүх нийтээр хэлэлцүүлэхээр 1991 оны 6 дугаар сард нийтэлсэн Үндсэн хуулийн анхны төслийн 32 дугаар зүйлд “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад албан тушаал хавсран эрхэлж болохгүй” гэсэн заалт;

Улсын Бага Хурлаар 1991 оны намрын чуулганаар хэлэлцээд Ардын Их Хуралд оруулсан Үндсэн хуулийн төслийн Хорин есдүгээр зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин хангамж хүртэх бөгөөд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний болоод хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалт;

Ардын Их Хурлаас анхдугаар хэлэлцүүлгээр баталсан Үндсэн хуулийн төслийн Хорин есдүгээр зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалт тус тус тусгагджээ.

1991 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанд оролцсон 342 депутатын 251 нь Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг хавсарч болохгүй гэсэн заалтыг зөвшөөрч, 78 нь татгалзаж, 13 нь түдгэлзэж байжээ.

Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байх эсэх асуудлаар дэлхий дахинд гурван хандлага үйлчилдэг байна. Нэгдүгээрт, Засгийн газрын гишүүн /сайд/-ий бүрэн эрх нь парламентын гишүүн байхтай нийцдэггүй гэж үздэг нэр бүхий 25 улс байна. Хоёрдугаарт, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийг нэг дор нэгтгэх замаар зөвхөн төвлөрүүлээд зогсохгүй парламент, Засгийн газрын хоорондын холбоог хүчирхэг болгох гэсэн хандлага бөгөөд нэр бүхий 24 улс байна. Гуравдугаарт, сайдын бүрэн эрх парламентын гишүүний бүрэн эрхтэй нийцэх тухай асуудлаар дээрх хоёрын хандлагын хоорондох байр суурийг баримталсан хандлага болно. Энэ чиглэлийн 34 улс байна.

1996 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулсан хуулиар Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийг “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол бүрэн эрхээ хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй” гэж өөрчлөн найруулсан нь Цэцийн дүгнэлтийн эсрэг хандсан заалт болжээ. Энэ заалтыг Цэцийн шийдвэр гаргах хуралдаанаар нэг мөр авч хэлэлцэхийг гүнээ хүсч байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй хэмээн үзэж тогтоол гаргахдаа дараах зүйлийг баримталсан болно.

а/ Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалт нь Улсын Их Хурлын гишүүний үүргийг хуулиар тогтооно гэсэн агуулга бөгөөд энэ үүргийг Улсын Их Хурлын тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд тодорхойлон тогтоож өгчээ. Ингэснээр Засгийн газрын гишүүний албан тушаал нь Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт хамаарахгүй биш харин шууд хамаарах болохыг тодорхойлж, ингэснээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн гол үндэслэлийг үгүйсгэж байна.

б/ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн бас нэгэн үндэслэл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1-ийн 1-д заасан “Хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” мөн зүйлийн 1-ийн 8-д заасан “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах нь” Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалагдана гэсэн заалтуудаас



хууль хэрэгжүүлэх, хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтийг хянах гэсэн хоорондоо сонирхлын зөрчил бүхий хоёр үүргийг ногдуулжээ хэмээн дүгнэжээ. Парламентын засаглалтай орнуудад сонгуульд тодорхой намууд оролцож ялсан нам нь Засгийн газраа бүрдүүлж, сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд парламентын дэмжлэгийг өөртөө авахын тулд гишүүдээрээ уламжлан бодлогоо явуулдаг билээ. Ийм сонгуульд улс төрийн намуудын лидерүүд оролцож сонгогдоод ялсан намын тэргүүн нь Ерөнхий сайд болж улс төрийн нөлөө бүхий бусад лидерүүдийн дунд Засгийн газрын суудлын хуваарилалт болдог. Ийм тогтолцоонд хяналтын үүргийг парламентад цөөнх болсон нам нь гүйцэтгэхээс биш ялсан олонхи өөрийн төрүүлж буй болсон Засгийн газраа хянана гэж хэзээ ч үгүй гэдэг нь ойлгомжтой.

Манай орны хувьд Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, мөн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 6-д заасан заалтаас үзэхэд парламентын засаглалтай орон гэдэг нь нотлогдож байгаа билээ.

Бүрэн эрхийн хугацаа 1996 оны 7 дугаар сарын 18-нд эхлэх ёстой Улсын Их Хурал анхдугаар чуулганаасаа Засгийн газраа байгуулах хариуцлагатай үед Үндсэн хуулийн цэцээс энэхүү дүгнэлтийг гаргасан нь Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүнээр нэгэн зэрэг ажиллаж байсан өмнөх парламентын уламжлал, мөн дэлхий нийтийн парламентын туршлагад тогтсон зэргийг харгалзан үзэхгүй шууд улс төрийн утга агуулгатай, тодорхой бүлэг хүмүүст үйлчилсэн шийдвэр мэт ойлгогдож байна.

Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарт буй зарим ангилал бол шинжлэх ухааны үүднээс хандсан асуудал биш байна. Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын шийдвэрийг дахин нягтлан үзэж Үндсэн хуулийн заалт, агуулгадаа нийцсэн шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлаас 1996 оны 8 дугаар сарын 26-ны өдөр баталсан хуулиар Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийг өөрчилсөн заалтыг Үндсэн хуулийн цэцээр эцэслэн шийдвэрлэхээр хянан хэлэлцэж буй Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйл Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай хамтатган шийдвэрлэх нь зүйтэй байна.

2. Монгол Улсын Засгийн газрын гишүүний албан тушаал түүний үүргийг Улсын Их Хурлын гишүүний үүрэгт хамааруулан үзэх хууль зүйн үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоогдоогүй байна.

Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч, хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч парламентын бүрэлдэхүүн болох тухай заалт Монгол Улсын Үндсэн хуульд тусгагджээ. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгалах нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг тодорхой албан тушаалтан зэрэгцүүлэн хэрэгжүүлэх агуулгатай байна.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар Засгийн газрын нийт гишүүний гуравны хоёроос хэтэрч болохгүй гэсэн хэм хэмжээ тогтоосон нь Үндсэн хуулийн маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээр хянан хэлэлцэж, эцсийн шийдвэр гаргах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн болох нь тогтоогдов.

Эдгээр байдлуудаас үндэслэн үзэхэд Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн зохих заалтыг зөрчжээ гэж Үндсэн хуулийн цэцээс гаргасан 1996 оны 6 дугаар дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

Нэг. Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн:

“1/ Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй. /Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт/

2/ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг нь гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй.

3/ Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн тогтооно” гэсэн заалтуудыг;

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 1996 оны 7 дугаар сарын 30-ны 23 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэр нь эцсийн бөгөөд гармагц хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Дээрх асуудлаар гарсан Цэцийн дүгнэлт, тогтоол нэлээдгүй байгаа бөгөөд бүгд нэг л байр суурьтай байгаа. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн байх нь эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй гэсэн шийдвэрийг Үндсэн хуулийн цэц 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 15 дугаар дүгнэлт, 1996 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 6 дугаар дүгнэлт, 1998 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 9 дүгээр дүгнэлт, 2000 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 3 дугаар дүгнэлт, 1995 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоол, 1998 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 2 дугаар тогтоол, 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2 дугаар тогтоолоор тус тус гаргаж байсан.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996.09.04 № 07

### Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Г.;  
Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Б.;  
Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Хууль Зүйн Яамны  
терийн нарийн бичгийн дарга С.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын  
Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

- 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалт “Монгол Улсын хууль зүйн  
сайд Засгийн газрын гишүүний хувьд “шүүхийн байгууллагын зохион байгуулалт,  
санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээ”-ний хүрээний стратегийн төлөвлөлт,  
бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт-шинжилгээ /  
мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг эрхэлнэ”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Дөчин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие  
даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”

- Дөчин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх,  
шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульдаас шүүгчдийг  
шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр  
хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ”

- Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион  
байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн Г.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтад “Шүүхийн байгууллагын  
зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээ”-г хууль зүйн сайд  
эрхлэхээр тусгасан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Шүүгчийн хараат бус,  
шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.  
Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажилд оролцохгүйгээр гагцхүү  
хуульдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийн бие даан  
ажиллах нөхцөлийг хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ. Шүүхийн ерөнхий  
зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн Дөчин  
есдүгээр зүйлийг бүдүүлгээр зөрчиж буй нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

Үндсэн хуулиар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг шүүх өөрөө л  
хангахаас гүйцэтгэх засаглал, тэр тусмаа ямагт төсөв хөрөнгөө барьж байдаг Засгийн  
газрын байгууллага хангахгүй. Нөгөө талаар төсөв хөрөнгөөр барьцаалж Засгийн  
газар шүүх, хуулийн гадна үлдэх боломжийг бий болгож байна. Шүүгчийн хараат бус,

шүүхийн бие даасан байдлын баталгаа болсон Ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох Үндсэн хуулийн заалтыг зөрчиж хуулиас дээгүүр дүрэм /яамны/ гаргаж түүний зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулж эхлэхэд хүрч байна. Нэг эрх мэдлийн бие даасан байдлыг нөгөө эрх мэдэл хангана гэж үгүй. Нөгөө талаар хэрэв үнэхээр л шүүхийн ерөнхий зөвлөлийг Засгийн газрын бүтцэд байгуулж, шүүхийн зохион байгуулалт, санхүү, боловсон хүчний асуудлыг хариуцуулах байсан бол Үндсэн хууль юу гэж шүүх эрх мэдлийн тухай бүлэгтээ энэ асуудлуудыг авч үзэх билээ. Ийм болохоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн сайд байх тухай заалт ч угтаа Үндсэн хууль зөрчиж байгаа юм. Шүүхийн зохион байгуулалтын асуудлыг Хууль зүйн сайд эрхэлснээр хуулиар байгуулагдах учиртай шүүхийг Засгийн газар байгуулж, дуртай үедээ, дуртай газраа, дуртай хүмүүсээс бүрдсэн, дуртай асуудлаа шийддэг шүүх байгуулахад хүргэхгүй гэх үндэсгүй юм. Иймд Үндсэн хуулийн баталгаа болсон Монгол Улсын Үндсэн хуулийн цэц олон талаас нь нягтлан үзэж, нухацтай шударга шийдвэр гаргана гэдэгт найдаж байна.

Улс төрийн нэг нам засгийн эрхэнд гармагцаа шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээг хариуцах эзнийг өөрчлөөд байвал төрийн ялын бодлогод ч ноцтой нөлөөлж болох юм.

2. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Засгийн газрын хууль, Засгийн газрын 1994 оны 46 дугаар тогтоолын дагуу Хууль зүйн сайд хуульч боловсон хүчнийг сургах, давтан бэлтгэх асуудлыг хариуцаж байгаа бөгөөд шүүгчдийн эрх ашгийг хамгаалахад хөндлөнгөөс илүү бодитой хандаж оролцох үндэслэлтэй. Үүнээс гадна Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн олонхийг хуучны адил шүүгчид бүрдүүлэх юм. Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах механизмыг хуулиар бий болгосон ба түүнийг зөвхөн шүүхдээ байна гэдгийг тогтоосон хууль байхгүй. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн төлөөлөгчийг оролцуулан, Зөвлөлийн дарга дээрх газрын төлөөлөгчдөөс хэн нь ч байх боломжийг хуульд тусгасан үүнийг нотолж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Хууль зүйн сайд болсноор энэ байгууллага Засгийн газрын байгууллага боллоо гэж дүгнэх хууль зүйн үндэслэл байхгүй байна. Учир нь бүрэлдэхүүн болон зөвлөлийн бүрэн эрх нь иргэн Г.-гийн гомдол гаргахаас өмнөх байдлаас өөрчлөгдөөгүй байна. Шүүхийн төсвийг Засгийн газар биш Улсын Их Хурал баталдаг бөгөөд төсвийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөл урьдах бүрэлдэхүүнээрээ боловсруулж, холбогдох газар оруулах учир төсвийг Засгийн газар мэдэж түүгээрээ барьцаалан шүүхийн гадна үлдэнэ гэсэн дүгнэлт нь хууль зүйн үндэслэлгүй, гүтгэлгийн шинжтэй дүгнэлт болжээ. Шүүхийн санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохицуулалт, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх гэдэг нь шүүх, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын “дундын” шинжтэй байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боловсруулсан бодлого чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын гүйцэтгэх байгууллага хариуцахаас шүүх өөрөө хариуцах тухай ойлголт байж болохгүйтэй холбоотой. Иймд эдгээр заалтыг шүүхийн хараат бус, бие даасан байдлыг зөрчсөн гэх үндэслэл байхгүй болно.

Дээд шүүх, орон нутгийн шүүхүүд өөрийн Тамгын газартай байх бөгөөд энэ нь зөвхөн шүүхдээ л байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт хуулийн хэлтэс гэж байгуулагдахгүй. Энэ нэмэлт өөрчлөлтөөр харин шүүх аж ахуйн хангамж муу байвал сайжруулах талаар Засгийн газарт хүсэлт шаардлага тавих эрх зүйн үндэстэй болж байгаагаараа хараат бус бие даасан байдал нь баталгаажиж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын аппарат нь Хууль зүйн сайдын дэргэд байхаар Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, Хууль зүйн сайдын бүрэн эрх хоёр ялгаатай. Шүүх шүүн таслах үйл ажиллагаа явуулахдаа л хараат бус бие даасан байх болохоос аж ахуйн хангалтын асуудлаа өөрсдөө хийснээр хараат бус бие даасан байдал нь баталгаажна гэж үзэж болохгүй”

3. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Засгийн газрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь Монгол Улсын шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн Дөчин долоо, Дөчин найм, Дөчин ес, Тавьдугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй болно. Монгол Улсын хууль тогтоомжоор Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн эрхлэх асуудал, үйл ажиллагааны хүрээ, заагийг ялгаатай болохыг баталгаажуулсан болно. Ийм учраас шүүх болон гүйцэтгэх эрх мэдэл нэг нь нөгөөгөөсөө хараат болсон тухай ойлголт нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Шүүхийн төсөв, үйл ажиллагааг явуулах эдийн засгийн баталгааг төрөөс хангаж, шүүхийн төсвийг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 60 дугаар зүйлд тус тус заасан бөгөөд Засгийн газрын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэхэмжлэлд дурдсан дээрх заалтуудтай зөрчилдөөгүй болно. Улсын Их Хурлын 1996 оны 7 дугаар сарын 26, 29-ний хуульд орсон өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн үүргийг давхардуулаагүй. Ерөнхий зөвлөлийн үүрэг хуулийн дагуу яваандаа хэрэгжих л болно. Засгийн газрын болон Шүүхийн тухай хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй.

4. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

а. Монгол Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч Д. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа: “Шүүхийн байгууллагын зохион байгуулалт гэдэгт шүүхийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршил, орон тоог тогтоох, шүүгчийг шилж олох, шалгаруулах, бэлтгэх, давтан сургах зэрэг ажил ордог билээ. Гэтэл тэдгээрийг Хууль зүйн сайдын эрхлэх ажилд хамруулснаар Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн байгууллагын бүрэн эрхийн асуудлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлж, Үндсэн хуулийн байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийг Засгийн газрын нэг сайдын ажлын албаны хавсарга болгоход хүргэсэн байна. Түүнчлэн Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг үндэслэн Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Ерөнхий зөвлөлийн ажлын албаны бүтэц зохион байгуулалтыг Засгийн газар тогтоохоор заасан нь Ерөнхий зөвлөл гүйцэтгэх засаглалын хараат байдалд орж шүүхийн хараат бус байдлыг хангах Үндсэн хуулийн байгууллага бус, Хууль зүйн сайдын эрх үүргийг хэрэгжүүлэгч нэг механизм, ор нэрийн төдий, Хууль зүйн яамны аппаратын хавсарга байгууллага болж буй нь бүр ч тодорхой харагдаж байна. Энэ бүхэн нь шүүх, шүүгчийн бие дааж хараат бусаар ажиллах тухай Үндсэн хуулийн заалт зарчмыг ноцтой зөрчсөн гэж үзэж болох бүрэн үндэстэйг баталж байх тул Засгийн газрын хуульд өөрчлөлт оруулах тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийг Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон дүгнэлт гаргаж өгөхийг хүсч байна. Шүүх өөрөө хараат бус байдлаа буюу санхүү, материал-техникийн хангамж үйлчилгээгээ өөрөө хариуцан шийдэж байгаа биш Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар л хариуцаж байгаа юм. Энэ асуудлыг Хууль зүйн сайд эрхлэхээр болсон нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн хийх ажлыг Хууль зүйн сайд эрхлэхээр боллоо гэж хувьдаа ойлгож байна. Энэ хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх, үүргийг Хууль зүйн сайдад давхардуулан шилжүүлснээр Үндсэн хууль зөрчөөд байгаа юм” гэсэн байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3-т “... шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээ...”-ний хүрээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг Хууль зүйн сайд эрхлэхээр оруулсан нь Үндсэн хуульд заасан Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх үүргийг Засгийн газарт шилжүүлсэн бус Шүүхээс зөвхөн шүүн таслах эрх мэдлээ хэнээс ч хараат бус бие даасан байдлаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангахад чиглэгдсэн байна.

Иймээс энэ талаархи иргэн Г.-гийн гомдлыг хангах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ГАРГАХ ДҮГНЭЛТ:

1. "Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 3-т Монгол Улсын Хууль зүйн сайдад шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээг Монгол Улсын Засгийн газрын гишүүний хувьд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг хариуцсаны хувьд эрхлүүлсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай"

**"Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 7 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 1996 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 48 дугаар тогтоолын агуулга:**

Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан заалтын талаар Үндсэн хуулийн цэцээс гаргасан 7 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг "Монгол Улсын хууль зүйн сайд Засгийн газрын гишүүний хувьд "шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал-техникийн хангамж, үйлчилгээ"-ний хүрээний стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулалт, хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлж дүгнэх ажлыг эрхэлнэ" гэж өөрчилсөн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Гүйцэтгэх эрх мэдлийн төлөөлөл болох Хууль зүйн сайдын эрхлэх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг багтаасан нь алдаа байсан юм. Хууль зүйн сайд 2000-2004 он тухайн үед бүр шүүхийн шүүн таслах ажилд хэтэрхий хутгалдан оролцож эхэлсэн тул энэ байдлыг Үндэсний аюулгүй байдлын Хууль зүйн сайд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга байх шаардлагагүй гэсэн агуулгатай зөвлөлөөр тусгайлан хэлэлцэж зөвлөмж гаргаж байжээ.

Хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн Дунд суудлын хуралдаанаас "зөрчөөгүй байна" гэсэн дүгнэлт гаргасан боловч 2004 оны 4 сарын 15-ны өдрийн Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд "20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтын "шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ" гэснийг тус тус хассугай" гэж 1996 оны 7 дугаар сарын 29-ний өдөр баталсан нэмэлт, өөрчлөлтөө эргэн хассан байна.

Цэцийн алдаатай шийдвэрээс болж Хууль зүйн сайд 8 жил "шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ" байтугай асуудлыг хариуцан зохион байгуулж явсан байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996.10.30 № 08

### Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Т.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдөр баталсан Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жар, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай хууль<sup>29</sup>

Монголын тулгар төрийг үүсгэн байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлсэн нь

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “хүнийг ... нас, хүйс, ...-ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”
- Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан “Эмэгтэйчүүд, хүүхэд, 60-аас дээш насны хүмүүст” Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж, уг төслийг Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлж баталсан юм. Үүнтэй холбогдуулж уучлал үзүүлэх, өршөөл үзүүлэх гэсэн ойлголтын цар хүрээг бодох нь зүйтэй. Хэрвээ бүх ялтныг хамааруулахгүй, цөөн тооны хүмүүсийг өршөөх асуудал тавьж байгаа бол Улсын Их Хурал өршөөл үзүүлэх тухай хууль биш, Ерөнхийлөгч уучлал үзүүлэх тухай зарлиг гаргах ёстой. Өршөөл үзүүлж байгаа бол хорих байгууллагад хоригдож буй бүх ялтныг хамруулах нь зүйтэй. Өршөөл үзүүлэхдээ ингэж “60-аас дээш насны эрэгтэйчүүд” гэсэн хязгаар тогтоож байгаа явдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заагдсан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн “хүнийг... нас хүйсээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалт, Арван зургадугаар зүйлийн 11-д заагдсан “Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”, “гэр бүл, эх нялхас хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалтуудыг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хууль зөрчиж байна гэж үзлээ. Иймд Өршөөлийн тухай хуульд 18-60 насны эрэгтэй хоригдлуудыг бусад хоригдлуудтай адилгаж хүний эдлэх ёстой эрхийг нь Үндсэн хуульд зааснаар эдлүүлэх шаардлагатай гэж үзээд Улсын Их Хурлын дээрх хуулийн заалт Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзэж байгаа тул энэ асуудлыг хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж өгнө үү.

29 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 10-т нийтлэгдсэн

2. Иргэн Х.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Өршөөл үзүүлж байгаа явдал нь ял ногдуулж байгаагаас эрс ялгаатай бөгөөд энэ хоёрыг адилтгаж болохгүй. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт Эрүүгийн хуулийн заалтыг ишлэл болгон авсан нь энэхүү өршөөл үзүүлэхэд огт хамааралгүй зүйл юм. Хэрэв Ерөнхийлөгч өршөөлийн зарлиг гаргасан бол Үндсэн хууль зөрчсөн гэж би үзэхгүй, Улсын Их Хурал хууль гаргасан нь Үндсэн хууль зөрчиж байгаа юм. Хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байгаа тул ялтан ч адилхан хүн гэдгийг ойлгох ёстой. Би энэ хуулийг дутуу зохицуулалттай хууль гэж үзэхгүй, Үндсэн хууль зөрчсөн хууль гэж үзэж байгаа тул Үндсэн хуулийн Цэцэд хандсан юм.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Т. нарын тайлбарын агуулга:

Эрүүгийн хуулиар гэм буруутай этгээдийн хувийн байдал, хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэх нь ял оногдуулах нийтлэг зарчим юм. Гэм буруутай этгээдийн хувийн байдал гэдэгт түүний нас, хүйс, гэр бүлийн байдал зэрэг асуудал хамаардаг болно. Тийм ч учраас эрүүгийн хуулийн дагуу ял ногдуулахдаа дээрх үндэслэлийг харгалзан үздэг. Тухайлбал:

а/ Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд 18 нас хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлсэн этгээд, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял ногдуулахгүй байх;

б/ Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд дээрх хүмүүст 15-аас дээш жил хорих ял ногдуулахгүй байх;

в/ Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйлд насанд хүрээгүй хүмүүсийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахаар тогтоосон байдаг.

Ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдсэн, 7 хүртэл насны хүүхэдтэй буюу жирэмсэн эмэгтэй гэмт хэрэг үйлдсэнийг хамруулан үзэхээр Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд заасан. Ялаас хугацааны нь өмнө чөлөөлөх, хөнгөн ялаар солих үндэслэл нь гэмт хэргийн хүнд, хөнгөн байдал, ялтны засрал, хүмүүжил, ялын хугацаа, төрөл зэрэг асуудлыг хамардаг. Мөн насанд хүрээгүй этгээдийн хувьд тусад нь ялгамжтай зохицуулж өгсөн. Иймд ялаас чөлөөлөх нэг хэлбэр болох өршөөл үзүүлэх тухай хууль нь ял оногдуулах болон ялаас чөлөөлөх үндсэн зарчмын дагуу гарсан тул энэ үндэслэлээр хууль, шүүхийн өмнө иргэд тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг зөрчөөгүй гэж үзэж байна. Өршөөлийн хууль бол онцлог хууль. Ерөөсөө эрх нь хязгаарлагдсан хүмүүст хандаж байгаа учраас тодорхой хязгаарлалтыг заавал шаарддаг. Энэ хуулийг батлахдаа хууль санаачлагчийн өргөн барьсан төслийн үндсийг Улсын Их Хурал хадгалах бодлого баримталсан юм. Ялтан гэдэг бол эрх нь онцгой хязгаарлагдсан хүмүүс гэдгийг санах ёстой. Энэ агуулгаараа Өршөөлийн хууль Үндсэн хууль зөрчөөгүй юм.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга: .

Өршөөл үзүүлэхдээ бүх хоригдлыг хамруулах тухай хуулийн ямар ч заалт манайд байхгүй. Иймд тодорхой хязгаар тогтоох эрхтэй. Энэ нь тогтсон практик юм. Энэ нь манай төрийн хүнлэг энэрэнгүй бодлогын нэг илрэл юм. Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай ял оногдуулахаар тодорхой үндэслэлүүд заасан байдаг. Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүд, 60-аас дээш насны хүмүүст хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг заасан нь хуулийн бас нэг үндэслэл юм. Өршөөлийн хувьд Улсын Их Хурал тогтоол гаргаж болохгүй. Энэ бол хүний эрхтэй холбоотой учир зөвхөн хууль гаргах ёстой.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар дугаар зүйлийн 14-т зааснаар Өршөөл үзүүлэх шийдвэр гаргах эрх нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарагдаж байна. Улсын Их Хурал энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн цаг



үеийн нөхцөл байдлаас болж ямар үзүүлэлтийг гол шалгуураа болгох нь мөн түүний бүрэн эрхэд хамаарах юм гэж үзэх үндэслэлтэй байна. Монголын тулгар төр үүсгэн байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Их Хурал Өршөөл үзүүлэх тухай хууль гаргахдаа эмэгтэйчүүд, хүүхэд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд гэсэн үзүүлэлтүүдийг ялаас чөлөөлөх буюу хөнгөрүүлэх гол шалгуур болгосон нь хууль тогтоох дээд байгууллагын эрх хэмжээний асуудал бөгөөд өршөөлд хамрагдаагүй ялтны эрхийг хязгаарласан заалт байхгүй тул үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд энэ талаар гаргасан иргэн Х.-гийн гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монголын тулгар төрийг үүсгэн байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хууль Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй байна.

2. Цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай”

**“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 64 дүгээр тогтоолын агуулга:**

Өршөөл үзүүлэх тухай 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын хуулийн заалтын талаар Үндсэн хуулийн Цэцээс гаргасан 8 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup>, 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монголын тулгар төрийг үүсгэн байгуулагдсаны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Анхны өршөөлийн хуулийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдээс 1929 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Ардын хувьсгалын баярыг тохиолдуулан гаргаж байжээ.

Өршөөл үзүүлэхэд тухайн гэмт этгээдийн хувийн байдал, засрал зэрэг үзүүлэлтийг шалгуур болгодоггүй ба тодорхой болзол хангасан тохиолдолд үйлчлэх шинжтэй байна. Жишээ нь: Насанд хүрээгүй, жирэмсэн эмэгтэйчүүд, хөнгөн хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн, болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдсэн, 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд гэх мэт болзол зонхилдог. Өршөөлийг ойр ойрхон үзүүлэх нь тийм ч таатай зүйл биш бөгөөд энэ нь гэмт хэрэг нэмэгдэх нэг шалтгаан нөхцөл болдог байна.

Харин уучлалыг нь тодорхой болзол хангасан этгээдэд бус харин тодорхой нэр заан үзүүлдэг. Уучлалыг хэдийд ч ямар ч үед, бүр онц хүнд гэмт хэрэгтэнд үзүүлж болдог нь сонирхолтой, судлууштай юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996.12.02 № 09

### Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Б., Б.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1992 оны 8 дугаар сарын 18-ны өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль<sup>30</sup>

- 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд... томилно”

- Арван зургадугаар 10 дахь заалт “... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Н.-ийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно” гэсэн хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, түүний дараах заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Гуравдугаар зүйлийн нэг дэх хэсэгт буй “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэснийг;

- Арван зургадугаар зүйлийн 9-т “хүн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэж тогтоосныг;

- Нэгдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “Ардчилсан ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг;

- Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум,

30 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 4,5-д нийтлэгдсэн

дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд... томилно” гэж заасныг;

- Арван зургадугаар зүйлийн 10-т “Аль нэг нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Ийнхүү Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчмаас ухарч ард түмэн өөрсдийн сонгосон төлөөлөгчдийнхөө байгууллагаар уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхийг илтэд хязгаарлаж, төрийн үйл ажиллагааны ардчилсан ёсны зарчмыг ноцтой хөсөрдүүлж, өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчмыг гуйвуулж, нутгийн өөрөө удирдах байгууллагаас Засаг даргад нэр дэвшүүлсэн шийдвэрийг Ерөнхий сайд хүндэтгэн, нэр дэвшигчийг томилж, түүнд төрийн төлөөлөгчийн эрх хэмжээ олгоход саад учруулж, нэр дэвшигчийг нэг удаа татгалзаж болох Үндсэн хуулийн үзэл баримтлалыг “зөвшилцөх” нэрийдлийн дор Ерөнхий сайдад Хурлаас дэвшүүлсэн Засаг даргад нэр дэвшигчийг зөвхөн намын харьяалал, үзэл бодлоор нь гол шалгуур болгон татгалзах, томилох зэргээр дур зоргоороо авирлах боломжийг олгож, орон нутгийн сонгуульд Монголын ард түмний хийсэн сонголтын үр дүнг үл ойшоон уландаа гишгэх нөхцөлийг бүрдүүлснээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн олон заалт нэгэн зэрэг зөрчигдсэн тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг бүхэлд нь хүчингүй болгох зорилгоор энэхүү өргөдөл, тайлбарыг гаргав.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Засаг даргыг сонгож нэр дэвшүүлэх үү, тэднийг дээрээс нь томилох уу гэдэг үзэл баримтлалын үндэслэлийг Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж байсан баримтаар тайлбарлая. Энэ хуулийг батлахад Б., Б., Б. нар оролцсон болохоор асуудлыг сайн мэдэж байгаа. Үндсэн хууль хэлэлцсэн протоколоос үзэхэд аль ч шатны Засаг даргыг Хурлаас ямагт нэр дэвшүүлэх дараа нь томилох үзэл баримтлал бий. Гэтэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т “томилох” гэсэн утга тусгагдсан. Хуулийн дээрх заалтаас шалтгаалан Монгол Улсын Ерөнхий сайд Э. Үндсэн хууль зөрчихөд хүрч байна. Үүнийг Н. М. нарыг аймгийн Засаг даргад ажиллуулахаас татгалзаснаар тайлбарлаж болно. Би асуудалд улс эх орны эрх ашгийн үүднээс хандсан гэдгийг Цэцийн эрхэм гишүүд анхаараасай гэж хүсч байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Б., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Н.-ийн өргөдөлд дурдсан шаардлагууд нь үндэслэлгүй байна. Үүнийг дор дурдсан тайлбаруудаар тодорхойлж болно. Үүнд:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн заалт зөрчигдөөгүй болох талаар.

Үндсэн хуульд Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн, Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн, Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна, Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана гэж заасан. Ард түмэн сонгосон Улсын Их Хурал түүнээс томилсон Засгийн газар, Засгийн газрын Ерөнхий сайдын томилсон аймаг, нийслэлийн Засаг дарга, мөн шат дараалан томилсон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нар төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Энэ нь Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэсэн заалтыг хэрэгжүүлж байна гэж ойлгодог.

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д “хүн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэсэн заалт зөрчигдөөгүй талаар.

Бүх шатны Засаг даргын албан тушаал нь төрийн улс төрийн томилолтын албан тушаал юм. Иймд Үндсэн хуулийн энэ заалт нь тухайн асуудалтай шууд холбогдолгүй болно.

в/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шудрага ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалт зөрчигдөөгүй болох талаар.

Улсын Их Хурлын сонгуульд ялсан нам, эвсэл нь өөрийн Засгийн газрыг байгуулж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг Монгол Улсын засаг захиргааны аль ч нэгжид хэлбэрэлтгүй биелүүлэхийг иш үндэс болгон ажиллаж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалттай бүрэн нийцэж байгаа юм.

г/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд... томилно” гэсэн заалт зөрчигдөөгүй болох талаар.

Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална” гэж заасан. Энэ нь Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга нар нь томилохоос татгалзах эрхийг бүрэн зөвшөөрснөөр Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг зөрчигдөж байна гэдэг үндэслэлгүй юм. Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үйл явц хэдэн ч удаа үргэлжилж болох юм. Үүнээс яаж гарах вэ гэдэг асуудал Үндсэн хуульд зохицуулалтгүй орхигджээ. Энэхүү зохицуулалтгүй орхисон хэм хэмжээг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д нарийвчлан хуульчлахдаа Үндсэн хуульд тусгалаа олсон зөвшлийн зарчмыг төсөөтэйгээр ашигласан нь Үндсэн хуульд нийцсэн түүний заалтыг зөв зүйтэйгээр баяжуулсан гэж үзэх бүрэн үндэстэй.

д/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “Аль нэг нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй болох талаар.

Монгол Улсад төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, түүнээс төрийн алба хаах болзол, журам, баталгаа тогтоох асуудлыг Төрийн албаны тухай хуулиар зохицуулдаг. Уг хуулиар тогтоосон төрийн албаны ангилалын нэг нь улс төрийн алба бөгөөд улс төрийн албан тушаалд Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Их Хурлын дэд дарга, гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, бүх шатны Засаг дарга багтдаг. Энэ нь Монгол Улсын төрийн нийт албан хаагч 141.5 мянган хүний 1.6 хувь буюу нийт 2300 хүн байдаг бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээс шалтгаалан өөрчлөгдөх ёстой юм. Иймээс төрийн улс төрийн албан тушаал болох бүх шатны Засаг даргын томилолтын асуудал нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасан заалттай шууд холбогдолгүй болно.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт буй “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөх” гэх мэтийн зохицуулалтуудыг тус тус буй болгосон байна.

2. Засаг даргыг зөвшилцөн томилох тухай хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна. Энэ утгаар нь авч үзвэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн холбогдох заалтуудыг зөрчжээ гэж үзэх үндэслэлтэй байна.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн Н.-ийн гомдлын энэ талаарх хэсгийг хүлээн авах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай”

## **“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 9 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 11 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” Үндсэн хуулийн Цэцийн 9 дүгээр дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup>, 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 9 дүгээр дүгнэлтийг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-д Үндсэн хуулиар тодорхой зохицуулалтгүй орхигдуулсан харилцааг нарийвчлан зааж өгсөн нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй учир хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

## **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуульд Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг чухам хэдэн удаа татгалзаж болох талаар тодорхой заагаагүй нь “томилгооны” энэхүү гацааг бий болгож байна.

Нэгэнт Үндсэн хуульд Засаг даргыг тухайн шатны Хурлаас нэр дэвшүүлэн **сонгоно** гэж тогтоогоогүй, харин дээд шатны Засаг дарга **томилно** хэмээсэн тул ямар нэгэн хэмжээгээр зөвшилцөлд хүрч байж томилно гэсэн үг. Үндсэн хуулиар тогтоосон журмыг үзэхэд Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг томилохоос хэдэн ч удаа татгалзаж болохоор ойлгогддог. Өөрөөр хэлбэл, хэдэн удаа татгалзаж болох хязгаарыг Үндсэн хуульд зааж өгөөгүй.

2. “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын өмнөх тогтоолуудыг бодвол Улсын Их Хурлын 1997 оны 11 дүгээр тогтоол нь Цэцийн дүгнэлтийг яагаад хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээ тайлбарлах гэж оролдсон тогтоол байснаараа онцлогтой.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1997.03.26 № 01**

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэсэн зарчим үйлчлэх ёстой билээ. Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь орон нутгийн сонгуулиар бий болдог нутгийн өөрөө удирдах байгууллага буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулахыг хэлж байгаа юм. Эрх баригч хүчнээс сонгуулийн дүнг хүндэтгэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгуулагдах, тэдгээрийн даргыг сонгоход ямар нэгэн байдлаар оролцсон явдал байхгүй болно.

Төрийн удирдлага гэдэг нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ”, түүнчлэн Жаран нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Засаг дарга засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, харьяалах дээд шатны Засаг даргын өмнө хариуцах” зэрэг зарим утга агуулгаар тустус илэрхийлэгдэж

байна. Эдгээрээс дүгнэж үзэхэд Засаг даргын томилгооны асуудал нь Үндсэн хуулийн агуулгаар бол тухайн үед засгийн эрхийг авсан олонхийн Засгийн газрын Ерөнхий сайдын эрх хэмжээний асуудал болох нь тодорхой. Дээрх үндэслэлтэй холбоотой Н.-ийн гаргасан өргөдөл нь хууль зүйн үндэслэлгүй болно. Өнөөдрийн томилогдон ажиллаж буй аймгийн Засаг дарга нарын намын гишүүнчлэлийг үзвэл МҮАН-аас 11, МАХН-аас 7, МСДН-аас 4 хүн байна. Эхний удаа Ерөнхий сайд аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас нэр дэвшүүлснээс 7 хүнийг татгалзсаны 6 нь МАХН, 1 нь МҮАН-ын гишүүд байсан. Эдгээрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр дахин нэр дэвшүүлж томилсон байгаа. Энэ бүгдээс үзэхэд Ерөнхий сайдын зүгээс гагцхүү түүний Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх чадвар бүхий хүнийг өөрийн багтаа авч ажиллуулах зарчим голлосон болох нь тодорхой. Үндсэн хуулийн утга санаа, үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд түүний гол баталгаа болох Үндсэн хуулийн Цэц шударга шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

**2. Иргэн Н.-ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:**

Миний бие өргөдөл гарган хэлэлцүүлээд 6 сар өнгөрлөө. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн өргөдлөөсөө татгалзаагүй. Иймд Үндсэн хуулийн Цэц шийдвэрлэнэ гэж итгэж байна.

**Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т буй “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 3-т буй “Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга, доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна. Дээд шатны Засаг дарга нь зөвшилцөх зарчмаар доод шатныхаа Засаг даргыг томилох тухай хэм хэмжээ Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна.

Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 9 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн Цэцийн 9 дүгээр дүгнэлтийн тухай” 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 11 дүгээр тогтоол, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно” гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Энэхүү шийдвэр нь гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Үндсэн хууль ёсоор бол Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг томилохоос татгалзах эрхтэй бөгөөд хэдэн удаа татгалзаж болох талаар хязгаарлалт оруулаагүй байна. Мөн тухайн шатны Хуралтай “зөвшилцөн” томилох талаар ямар нэгэн утга санаа ороогүй байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996.12.12 № 10

### Монгол Улсын Ерөнхий сайд Э. Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Г., Д., А.;

Албан тушаалтан - Монгол Улсын Ерөнхий сайд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч С.

#### Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:

Монгол Улсын Ерөнхий сайдын “Засаг даргын үүрэг гүйцэтгэгч томилсон тухай” 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж гаргасан нь

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд... томилно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Г.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Ерөнхий сайд Э. нь 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр захирамж гаргаж, Нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан Н.-ийг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилж Б.-г Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд...” мөн зүйлийн 3 дахь хэсгийн “...дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална” гэснийг тус тус зөрчиж байна.

Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан нийслэлийн Хурлаас нэр дэвшсэн хүнийг томилох ёстой болохоос Засаг даргаар нэр дэвшээгүй хүнийг үүрэг гүйцэтгэгчээр томилох нь Үндсэн хуулийн зөрчил юм. Засаг даргаа орлох бүрэн эрхтэй Нийслэлийн Засаг даргын орлогч үйл ажиллагаагаа явуулж буй байтал үүрэг гүйцэтгэгч томилох ёсгүй. Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт Засаг даргыг... томилохоос үүрэг гүйцэтгэгч томилохгүй. Эндээс үзэхэд “үүрэг гүйцэтгэгч” нь Засаг даргын бүрэн эрхийг “бүрэн” хэмжээгээр хэрэгжүүлэх субъект болж чадахгүй байна. Б. даргыг нэгэнт хавсран гүйцэтгэх боломжгүй албан тушаалд сонгогдсон учир түүнийг Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн нь буруугүй гэж үзэж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал олонхийн саналаар нэр дэвшүүлсэн тогтоол гаргаагүй. Зүй нь хэлэлцэж байгаа асуудлаар Хурал тогтоол гаргах ёстой. Тогтоол нь олонхийн саналаар батлагдсан байх ёстой. Ийм тогтоол гараагүй учир нэр дэвшээгүй гэж үзэж байна. Хуульд заасан журмын дагуу нэр дэвшигдэн санал болгоогүй хүнийг үүрэг гүйцэтгэгчээр томилсон Ерөнхий сайдын захирамж Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтад харшилж байна гэж үзэж байна.

2. Иргэн Д., А. нарын мэдээллийн агуулга:

Хурлын төлөөлөгчид ярилцаж тогтсоны дагуу хамгийн олон санал авсан Н., Г. нарын нэрийг саналын хуудсыг бичиж энэ хоёрын аль илүү санал авсныг Нийслэлийн



Засаг даргад нэр дэвшүүлж, тогтоол гаргаж, түүнийгээ олонхийн саналаар батлах ёстой байсан. Хуулийн тодорхой заалтыг зөрчсөн ийм процедур нь Нийслэлийн Засаг даргыг хууль зүйн үндэслэлгүй томилох шалтгаан болсныг хянан хэлэлцэж өгнө үү. Н., Г. нарын нэрийг саналын хуудсыг дахин бичиж, санал хураалгаж, энэ хоёрын аль илүү олон санал авсан нь Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлж, хуралдаанаас тогтоол гаргаж, түүнийгээ олонхийн саналаар батлаад Ерөнхий сайдад өргөн барих байсан. Хурал ямар ч тогтоол, шийдвэр гаргаагүй. Үүрэг гүйцэтгэгчийг тавих болсон нь хууль зүйн үндэслэлгүй бөгөөд Нийслэлийн Засаг даргыг чөлөөлсөн, огцруулсан бол түүний бүрэн эрхийг Засаг даргын орлогч хэрэгжүүлэх учиртай. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаанаа дуусаагүй байхад процессыг тасалдуулан Засаг даргын үүрэг гүйцэтгэгчийг томилсон. Учир нь тодорхой хүний нэрийг дэвшүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төлөөлөгчдийн шийдвэр олонхийн саналаар батлагдсан, энэ тухай Ерөнхий сайдад санал болгосон байх ёстой атал тэдгээрийн аль нь ч хийгдээгүй. Үүнээс үзэхэд нэр дэвшүүлэх ажиллагаа хийгдээгүй гэх бүрэн үндэстэй юм.

**3. Ерөнхий сайд Э.-гийн тайлбарын агуулга:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдааны үйл ажиллагаа сунжирч, Нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлсэн үйл ажиллагаанд маргаан гарч, зогсонги байдалд орж, хугацаа алдсанаас ажил хохирох нөхцөл байдал үүсч байгааг анхааран үзэж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийслэлийн Засаг даргад нэр дэвшин өрсөлдөгчөөс харьцангуй хамгийн олон санал авсан байдлыг үндэслэн Н.-ийг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон юм.

**4. Ерөнхий сайдын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн анхдугаар хуралдаанаас Н.-ийг Засаг даргад нэр дэвшүүлсэн гэж үзэж байна. Тогтоол гараагүй нь үнэн. Үүрэг гүйцэтгэгч бол Засаг даргатай адил бүрэн эрхтэй. Ийм учраас адилхан журмаар томилогдох ёстой. Ерөнхий сайдад Н.-ийг Засаг даргаар томилуулах албан ёсны санал ирээгүй. Гэхдээ иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нэр дэвшсэн хүмүүсээс хамгийн олон санал авсан хүн бол Н. мөн тул түүнийг Ерөнхий сайд томилох нь буруугүй.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Б. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдсоны учир хавсран ажиллах боломжгүйг харгалзан түүнийг Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн Ерөнхий сайд Э.-гийн үйл ажиллагаа Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн холбогдох хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Түүнчлэн өргөдөл гаргагч Г. нь Б.-г Нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн нь Үндсэн хууль зөрчсөн тухай гомдлын шаардлагаа Цэцийн хуралдааны явцад татаж авлаа.

2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан нийслэлийн Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайд нийслэлийн Засаг даргад нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас албан ёсоор нэр дэвшүүлж, санал болгоогүй Н.-ийг нийслэлийн Засаг даргын хууль ёсны орлогч ажил үүргээ гүйцэтгэсээр байхад нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр захирамж гарган томилсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль ёсоор нэр дэвшүүлж, санал болгоогүй байхад Н.-ийг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар

захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн “Засаг даргыг тухайн аймаг, нийслэлийн... Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд... 4 жилийн хугацаагаар томилно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Энэ дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 10 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхсайхан Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>2</sup>, 50 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхий сайдын “Засаг даргын үүрэг гүйцэтгэгч томилсон тухай” 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар дүгнэлтийг “аймаг, нийслэлийн Засаг даргыг томилох тухай” асуудлыг зохицуулсан Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай холбогдолгүй байна гэсэн үндэслэлээр уг дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Дээрх маргаан нь 1996 оны 9 дүгээр дүгнэлт бүхий маргаантай агуулгын хувьд ойролцоо маргаан. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй” гэсэн нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй гацааг арилгах гэж оролджээ. Гэхдээ энэ нь Ерөнхий сайд, эсхүл дээд шатны Засаг даргын “томилохоос татгалзах” бүрэн эрхийг хязгаарласан зохицуулалт болсон байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн тодорхой албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай дүгнэлтийг зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн талаар шийдвэр гаргах эрхгүй байтал Улсын Их Хурал “Цэцийн 1996 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн авах боломжгүй байна” гэсэн тогтоол гаргасан байна. Түүгээр ч үл барам Үндсэн хуулийн цэц Улсын Их Хурлын дээрх тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцсэн Их суудлын хуралдааныг хийсэн байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 9 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тайлбарыг харьцуулан үзнэ үү.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1997.03.29 № 02

**Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн зарим заалтыг зөрчсөн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Б.;  
Ерөнхий сайдын итгэмжлэгдсэн төлөөлөгч - С.

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Д., А. нарын тайлбарын агуулга:

Бид нэхэмжлэлээ буцааж авахгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 1997 оны захирамж гарч, урьдах нь үйлчлэхээ больсон. Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн хууль зүйн үндэслэл бүхий 10 дугаар дүгнэлтийг хүлээж авахгүй байх учиргүй. Дүгнэлтийн заалт нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2-т заасан заалттай “үүрэг гүйцэтгэгч” гэдэг үг байхгүйгээр холбогдолгүй болно гэж байхгүй. Хууль зүйн үр дагаварын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж хүчингүй болох ёстой.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Б. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын тайлбарыг Үндсэн хуулийн Цэцэд урьд нь бид гаргаж өгсөн ба түүнийгээ дэмжиж байна. Үндсэн хуулийн дээрх заалттай холбогдолгүй байна гэсэн үндэслэлээр хүлээж авах боломжгүй гэж байгаагаа дахин илэрхийлье.

### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж Улсын Их Хурлаас 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр гаргасан 12 дугаар тогтоолын хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн болох нь Цэцийн хуралдааны явцад болон бусад нотлох баримтаар батлагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль ёсоор нэр дэвшүүлж санал болгоогүй байхад Н.-ийг Нийслэлийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр томилсон Монгол Улсын Ерөнхий сайдын 1996 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 132 дугаар захирамж нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 10 дугаар дүгнэлтий тухай Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолын хүчингүй болгосугай.

3. Энэ шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно

### Тэмдэглэл:

Монгол Улсын хууль тогтоомжид “үүрэг гүйцэтгэгч” гэдэг албан тушаал байгаагүй ба Ерөнхий сайд Э. захирамжаараа “үүрэг гүйцэтгэгч” хэмээх албан тушаалыг бий болгосон байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1997.02.05 № 01

### Монгол Улсын Их Хурлын дарга Г. Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ц.;  
Албан тушаалтан - Улсын Их Хурлын дарга Г., түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц., Э.

#### Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:

Монгол Улсын Их Хурлын дарга Г. банкны байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийсэн нь

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”
- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”
- Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:

Монгол телевизээр 1996 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Ардын эрх сонины 1996 оны 12 дугаар сарын 14-ний дугаарт Улсын Их Хурлын дарга Г.-гийн хийсэн мэдэгдлээс үзэхэд тэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг ноцтой зөрчсөн ажиллагаа явуулж байна. Г. “Ард, Даатгал банкуудыг татан буулгаж, түүний оронд Төрийн өмчийн хадгаламжийн банк, Сэргээн босголтын банк, Өр барагдуулах алба шинээр байгуулагдаж байна. Эдгээр банкинд хөрөнгө байршуулсан харилцагч байгууллагууд алдагдал хүлээх болно” гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэжээ. Ард, Монгол даатгал банкууд нь 100 хувь төрийн өмчийн банк биш бөгөөд тухайлбал Ардын банкны дүрмийн сангийн 62.0 хувь нь төрийн бус өмчийнх, олон мянган харилцагч нар, хадгаламж эзэмшигчтэй билээ. Улсын Их Хурлын дарга банк татан буулгах ажиллагаанд оролцож, түүнийгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нотолж байгаа нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг зөрчиж, банкны хувь нийлүүлэгчид, хөрөнгөө байршуулсан иргэд, хуулийн этгээдүүдийн өмчлөх эрхийг зөрчсөн ажиллагаа явуулан зориудаар алдагдалд оруулж байна. Дээрх банкуудын харилцагч нарт хандаж Засгийн газрын байгуулсан банктай харилцахыг тулгаж, цагдаагийн болон Монголбанкны ажилтнууд эдгээр банкны ажилтнуудын өрөөнд нь хууль ёсны шийдвэргүйгээр орж өрөө, албан өрөө, ширээ, шүүгээг битүүмжилж, утсаар ярих, гадагш гарах, гэртээ харихыг нь хориглосон, ажлаас гарах шаардлага тавих зэрэг ажиллагаа явуулсан байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэснийг дээрх ажиллагаа нь зөрчиж байгаа юм. Улсын Их Хурлын дарга Г. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх” заалтыг мөн зөрчиж, одоо хүчин төгөлдөр байгаа хэд хэдэн хуулиудыг зөрчлөө. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын даргын Үндсэн хууль зөрчиж байгаа ажиллагааг хянан үзэж, хуулийн дагуу зохих шийдвэр гаргахыг хүсье.

Миний бие Улсын Их Хурлын даргыг Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар өмгөөлөгчийн хувьд бус харин Монгол Улсын иргэний хувьд гомдол гаргасан юм. Улсын Их Хурлын даргын радио, телевизээр хэлсэн үгийн дагуу явуулсан ажиллагаатай нь холбогдуулан, түүнчлэн түүний хуулиар өгөгдсөн эрх хэмжээтэй холбогдуулж гаргасан 1996 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 104 дүгээр захирамжийн зорилго, хүрээ зэргийг хамруулж гомдол гаргасан юм. Улсын Их Хурлын дарга нь банкуудыг хуулиас гадуур татан буулгах ажиллагааг удирдсан байна. Ард болон Даатгал банкуудыг булаан авах ажиллагаа 1996 оны 12 дугаар сарын 13-ны 15 цагийн орчимд цагдаа, татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны болон Монголбанкны ажилтнуудын хамтын “довтолгоо”, хүч хэрэглэсэн байдлаар хэрэгжиж эхэлсэн юм. Дээрх хоёр банкны ажилтнуудыг үүргээ хэвийн байдлаар гүйцэтгэж байхад гэнэт дайран орж, өрөөнөөс нь хөөн гаргаж, үүд хаалгыг лацдан, түлхүүрүүдийг нь булаан авч “бид нартай ажиллах нь түр гэрээнд гарын үсэг зур, зурахгүй нь яв” гэх зэргээр загнаж, хууль бус баримтад хүчээр гарын үсэг зуруулжээ. Түүнчлэн банкны ажилтнуудыг гадагш гарах, утсаар ярих, хоолонд орох зэргийг хязгаарлаж, ширээ, шүүгээг нэгжин лацдаж, зарим газар бие засах, хоолонд ороход нь ч цагдаагийн болон Монголбанкны ажилтнууд харгалзан явж байжээ. Зарим хүмүүсийг ажлаас нь хөөн явуулжээ. Энэ ажиллагаа явагдаж байхад Улсын Их Хурлын эрхэм дарга телевизээр үг хэлж, төрийн өмчийн хоёр банк байгуулсан, Ард, Даатгал банкуудыг татан буулгасан, тэдгээр банкинд хөрөнгөө байршуулсан харилцагч байгууллагууд алдагдал хүлээх, 1996 оны 12 дугаар сарын 16-наас Төрийн өмчийн банкууд хэвийн ажиллах тухай мэдэгдэж, дээр дурдсан хүний эрх, хууль зөрчсөн бузар ажиллагааг зөвтгөж хаацайлсан үг хэлсэн билээ. Улсын Их Хурлын дарга Г.-гийн гаргасан захирамж, хэлсэн үгийн цаана чухамхүү Ард болон Даатгал банкуудын эд хөрөнгө, харилцагч, хадгаламж эзэмшигчид, хувь нийлүүлэгчдийн эд хөрөнгө, эрхийг Үндсэн хууль, бусад хуулийг зөрчин төрийн өмчийн Сэргээн босголт, Хадгаламжийн болон бусад банкны мэдэлд булаан авах ажиллагаа байсан юм. Улсын Их Хурлын даргын ажиллагаа нь ямар нэг хуулийн дагуу явагдаагүй бөгөөд харин Үндсэн хууль болон бусад олон хууль зөрчсөн юм. Төрийн эрх барих байгууллагын толгойд байгаа албан тушаалтны Үндсэн хууль зөрчсөн дээрх ажиллагааг Үндсэн хуулийн цэц зөвтгөн хаацайлах аваас хүний эрх, эрх чөлөө төрийн тэргүүнд гарсан улс төрийн хүчин, хувь хүний хүсэл зорилго, дураар авирлалтын золиос болж, хүн байнга хохирох нь мэдээж билээ.

2. Улсын Их Хурлын даргын итгэмжилсэн төлөөлөгч Ц., Э. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын даргын захирамж нь хуулийн дагуу түүнд олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд нийцсэн, түүний хэлсэн үг нь үйл явдлыг үнэлж дүгнэсэн, хуулийн заалтын ач холбогдлыг тайлбарлаж ойлгуулахад чиглэгдсэн бөгөөд хууль зөрчөөгүй байна. Төр хууль гаргаж өмчлөгчийн эрх ашгийг баталгаажуулж, зохицуулах боловч, улс орны үндэсний аюулгүй байдлын хэмжээнд тавигдсан тийм үед бусад иргэдийн эрх ашгийг мөн хуулиараа хамгаалах учиртай. Харин ч бидний энд маргаж, хэлэлцэж буй дээрх зөвлөл, мэдэгдэл, иргэдийн эрх ашиг хамгаалах үүднээс хийгджээ. Банкны эрх хүлээн авах үед болсон үйл явцад оролцсон, түүнийг зааж зааварласан гэх нотолгоо Улсын Их Хурлын даргын захирамжийн хүрээ, агуулга, үг, үсэг, түүний мэдэгдлийн санаанаас огт харагдахгүй байгаагийн гадна нэг талаас зөвлөл байгуулсан, мэдэгдэл хийсэн субъект, нөгөө талаас нэр бүхий банкуудыг татан буулгахад иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэх субъект өөр өөр байгаа бөгөөд тэдгээрийн

үйл ажиллагаанд шалтгаант холбоо үгүй байна. Ард, Даатгал банкуудыг татан буулгахтай холбогдуулж, Улсын Их Хурлын дарга Г.-гийн хийсэн мэдэгдэл нь Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний учир холбогдлыг үнэлж, дүгнэх, мөн хүмүүсийн сонирхож байсан хуулийн заалтын дагуу хийгдэх зарим алхмыг тайлбарласан байна. Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлд Улсын Их Хурлын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргах эрхтэй. Улсын Их Хурлын дарга нь Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйг заасан байна.

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад заасан “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох...” онцгой бүрэн эрхийг хадгалсан Улсын Их Хурлын бүрэн эрхээс урган гарч байгаа юм. Энэ бүхнээс дүгнэж үзвэл, Ард, Даатгал банкуудыг татан буулгаж, банкны эрх хүлээн авагчийг томилсонтой холбогдуулж, Улсын Их Хурлын дарга Г.-г Үндсэн хуулийн дээр дурдагдсан заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын аюулгүй байдлын зөвлөл банкны системд өөрчлөлт хийхийг зөвлөсөн шийдвэр гаргасны дараа, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг банкны байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулж Улсын Их Хурлын дарга Г. хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийснийг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчжээ гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Зохицуулах зөвлөл байгуулах тухай Улсын Их Хурлын даргын 1996 оны 12 дугаар сарын 11-ний 104 дүгээр захирамжийг Ард, Даатгал банкыг татан буулгах үйл ажиллагаатай холбогдуулж гаргасан гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын дарга Г.-гийн гаргасан захирамж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр банкны өөрчлөлттэй холбогдуулж хийсэн мэдээлэл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэ дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Зарим тохиолдолд Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд буусан “Цэцийн шийдвэр”, “Цэцийн эцсийн шийдвэр” гэх нэр томъёо ойлгомжгүй байдал үүсгэдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж **эцсийн шийдвэр** гаргана” гэсэн байдаг. Гэтэл Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц **шийдвэр** гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно” гэсэн нь бий. 4 дэх заалтаас үзвэл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарвал зохих хууль, зарлиг гэх мэт нь шууд хүчингүй болохоор байна. Харин Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлд Цэцийн **шийдвэр** гэдэгт

дүгнэлт, тогтоол, магадлалыг оруулсан байдаг. Гэтэл Цэцийн **шийдвэр** болох дүгнэлт, тогтоол, магадлалын үйлчлэх хүчин чадал Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтаас ялгаатай байдаг.

Зүй нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц **шийдвэр гаргавал...**” гэх бус, харин “Үндсэн хуулийн цэц **эцсийн шийдвэр гаргавал**” гэж оруулж өгөх, эсвэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд эцсийн шийдвэр, шийдвэр хоёрын ялгааг тодорхой болгож өгөх шаардлагатай байсан байж мэднэ.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1997.04.09 № 02

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Т.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Б., Х.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

1. Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>31</sup>

- 1 дүгээр зүйл “Тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ”

2. Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль<sup>32</sup>

- 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт “тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын... тэтгэврийг зогсоосугай”

31 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 3-т нийтлэгдсэн

32 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 3-т нийтлэгдсэн

## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, ... тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”
- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...эрхтэй”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д заасан “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах... тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 4-т заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Хуульд заасан болзлыг хангаж тэтгэвэр авах эрх нэгэнт үүссэн бол тэтгэврээ тогтоолгон авах эрх хэрэгжих нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хөдөлмөр, төлсөн шимтгэлийн үр дүн нь тэтгэвэр тогтоолгон авах эрх юм. Түүнийг ямар нэгэн үндэслэлээр өөрөө хүсээгүй тохиолдолд зогсоож болохгүй, нөгөө талаар өөрийн амьдрал ахуйд нэмэр болох, амьжиргаагаа өөд татахын тулд хэрдээ таарсан ажил хийхэд түүний тэтгэвэр авч байгаа нь саад болохгүй. Хөдөлмөрийн гэрээг хоёр талын сайн дурын үндсэн дээр байгуулдаг. Цалин хөлс нь нийгмийн даатгалын санд огт хамаагүй юм. Хуульд заасан үндэслэлээр тэтгэврээ тогтоолгон авч байгаа хүмүүсээс ажил, албан тушаал эрхлээгүй хэсэг нь тэтгэврээ авч байхад албан хаагч, эсхүл хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад урьд тогтоолгосон тэтгэврээ зогсоолгох нь иргэдийг ажил, албан тушаалаар нь ялгаварлаж буй явдал мөн. Өндөр насны тэтгэвэр нь төрөөс иргэнд үзүүлж буй хайр хишиг биш. Иргэн хүн өндөр насалсан үедээ амьдралд хүрэлцэхүйц тэтгэвэр авна гэж тодорхой эрсдэлтэйгээр даатгуулж, зохих шимтгэл төлж байгаа болно. Энэ бол нэг ёсны даатгалын байгууллагатай байгуулсан гэрээ, болзол, журмынхаа дагуу тэтгэврээ авч байгаа явдал мөн. Хуулиар хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад, төрийн алба хашигчдын тэтгэврийг зогсоож байгаа нь тэр хүний тэтгэврийн мөнгийг нийгмийн даатгалын санд ашиг болгон үлдээж, уг иргэнд орох ёстой байсан мөнгөн орлогыг дайчлан авч байгаа явдал билээ. Энэ утгаараа Монгол Улсын Үндсэн хуульд буй “...хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө” гэсэн заалтыг зөрчжээ. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц асуудалд бодитой хандаж, маргааныг шийдвэрлэнэ гэдэгт итгэж байна.

### **2. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тэтгэвэр тогтоолгогсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол тэтгэврийг нь зогсоох заалт орсон нь агуулгаараа өндөр настнуудыг ажлаа хий гэсэн агуулгатай болж Монгол Улсын Үндсэн хуульд буй “хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэсэн заалттай зөрчилдөж байна. Энэ хуулийн зохицуулалт нь тэтгэвэр авах, хөдөлмөрлөх хоёрын аль нэгийг сонго гэсэн утгыг илэрхийлснээрээ “иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, ...амрах эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна. Мөн Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд буй “хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэсэн заалт зөрчигдөж байна. Зах зээлийн харилцааны өнөө үед хэн чадвартай нь



хөдөлмөрлөж байж амьдрах эрхтэй. Нэгэнт хөдөлмөрлөж байгаа бол хаана ажиллаж байгаагаас үл хамааран Үндсэн хуульд заасан эд мөнгөний тусламж авах эрхийг эдлэх ёстой. Улсын Их Хурал, Засгийн газар ард түмний томоохон хэсэг болж буй ахмад настнуудыг тэтгэвэр, тэтгэмжийн хувьд ялгаварлах байдлаар хандах, хэсэг бүлэг хүмүүсийг ажилгүй болгож, хүний эрхэд халдаж буй ноцтой асуудалд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд та бүхнийг нухацтай хандаж ихээхэн нөлөө бүхий шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга: Иргэн Б.-гийн гомдлыг хүлээн авахгүй байх доорхи үндэслэлтэй байна. Үүнд:

а/ Нийгмийн даатгалын багц хууль бүхэлдээ тус улсын иргэдийн тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Гомдолд дурдсан заалтууд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д заасан “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах... тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг баталгаажуулан хуульчилжээ.

б/ Дээрх хэм хэмжээ үйлчилснээр иргэдийн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хязгаарлагдахгүй. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5-д заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалт нь энд заагдсан эрхүүдийг зэрэг эдлэх тухай ойлголт биш. Тухайн эрхүүдийг тус тусын хуулиар баталгаажуулан зохицуулдаг.

в/ Иргэд санаачлан, эсхүл тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан гэдэг үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай одоо мөрдөгдөж буй Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд заасан. Энэ бол иргэдийн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хуульчилж өгсөн заалт болно.

г/ Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 3, 4-т Монгол Улсын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан болзол нөхцөлийг хангасан иргэдийг захиргаа санаачлан ажлаас чөлөөлөх тухай заажээ. Энэ бол нийгмийн даатгалын шинэ хуулиудад тусгагдсан тэтгэвэр тогтоох болзол гэсэн утгаар ойлгогдох болов уу.

д/ Өргөдөлд дурдсан иргэд өөрсдийн амьдрал ахуйд нэмэр болох, амьжиргаагаа өөд татахын тулд хэр тохирсон ажил хийхэд саад болохгүй гэдэг асуудал бол цаашид анхаарвал зохих зүйл бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийг шинэчлэхэд шийдвэрлэх боломж бий.

е/ Цалин хөлс нь нийгмийн даатгалын санд огт хамаагүй гэж бичсэн нь харьцангуй ойлголт. Учир нь нийгмийн даатгалын сангийн багагүй хэсгийг Засгийн газар улсын төсвөөс бүрдүүлдэг болно.

Нийгмийн даатгалын багц хууль бол нийгмийн даатгалын тогтолцоог шинэ систем, журамд шилжүүлэхэд чиглэсэн. Иргэд өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос хойш төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр хөдөлмөрлөх эрх нээлттэй байгаа. Ийм нөхцөлд тогтоогдсон тэтгэврийг зогсоохоос өөр арга байхгүй.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Х.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг ямар цаг үед хэлэлцсэн гэдэг талаар тайлбарлая. Үүнийг манай улсад тэтгэврийн хууль тогтоомж хөгжиж ирсэн түүх, бусад орны тогтолцоотой холбон үзэх нь чухал. Манай улсад тэтгэвэр, тэтгэмжийн санг улс хариуцдаг системийг өөрчилж, ажил олгогч, ажилтан өөрсдөө сан байгуулдаг шинэ системийг буй болгох зорилгоор нийгмийн даатгалын багц хуульд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн юм. Өөрөөр хэлбэл, Герман улсад үүсч буй болсон эв нэгдлийн /солидарность/ тогтолцоог тус улсад нэвтрүүлэх зорилгыг нийгмийн даатгалын багц хуульд тусгах зорилт тавьсан. Өнөөдөр тэтгэвэр тогтоолгосон хүмүүс төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нь тэд хөдөлмөрөө шинээр үнэлж, хөдөлмөрийн чадвартай гэдгээ нотолж байх тул тэдний тэтгэврийг зогсоохоос өөр аргагүй. Учир нь тэтгэврийг Үндсэн хуульд зааснаар иргэд хөдөлмөрийн чадваргүй байгаа тохиолдолд олгодог.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Иргэдийн тэтгэвэр авах эрх нь хуульд заасан болзол, журмыг хангасны үндсэн дээр үүсдэг Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрх тул энэ эрхийн харилцааг нэгэнт үүссэний хойно хөдөлмөр эрхэлсэн гэх үндэслэлээр зогсоож болох хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Насны тэтгэвэр тогтоолгосноор иргэдийг хөдөлмөрлөх чадваргүй гэж үзэх үндэслэлгүйн зэрэгцээ иргэдийн тэтгэвэр авах болон ажил, албаа чөлөөтэйгөөр сонгох зэрэг Үндсэн хуульд заасан иргэдийн эрхүүдийн нэг нь хэрэгжсэнээр нөгөөг нь зогсоох, эсвэл эдгээр эрхүүд тус тусдаа хэрэгжинэ гэсэн зохицуулалт үйлчилж болохооргүй байна.

Тэтгэвэр бүхий иргэд төрийн алба хаших, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах үед хуульд заасан боллоор зайлшгүй хэрэгжих тэтгэврийг зогсоох нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн тэтгэвэр авах болон хөдөлмөрлөх эрхийг хязгаарласан шинжтэй байна.

3. Монгол Улсын Тэтгэврийн хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дотор хөдөлмөрийн харилцааны субъект байж чадах хөдөлмөрлөх чадвар бүхий иргэд цөөнгүй байгаагаас гадна тэтгэвэр бүхий ихэнх хүмүүсийн амьжиргааны түвшин, тэтгэврийн хэмжээ нь тэтгэврээ авахын сацуу хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, төрийн алба хаших, хувиараа аж ахуй эрхлэх зэргээр зайлшгүй хөдөлмөрлөхийг аяндаа шаардах болжээ.

Эдгээр байдлаас үндэслэн үзэхэд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны хуулийн 1 дүгээр зүйлд буй “тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын тэтгэврийг зогсоосугай” гэсэн заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн “Даатгуулагчийн тэтгэвэр авах эрх” хэрэгжих гэсэн 4<sup>1</sup> дүгээр зүйлд буй “Тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5-д буй “иргэд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, өндөр наслах... хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна. Энэ талаар иргэн Б., Т. нарын гаргасан гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 3-т буй “Тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын...тэтгэврийг зогсоосугай” гэсэн заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 4<sup>1</sup> дүгээр зүйлийн “тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ” гэсэн

заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1997 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 28 дугаар тогтоолын агуулга:**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэж үзсэн иргэн Б., Т. нарын гомдлыг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 3-т буй “тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч”-дын тэтгэврийг зогсоох гэсэн заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн “тэтгэвэр авах эрх үүсэх үед болон үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтуудыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан зохих хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 1997 оны 5 дугаар сарын 15-ны дотор багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Э.-д/ т даалгасугай.

#### **Тэмдэглэл:**

Нэгэнт хуульд заагдсан болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн нөхцөлд, эсвэл тэтгэвэрээ аваад ажил битгий хий, эсхүл тэтгэвэр авалгүйгээр ажил хийгээд цалин ав гэж тулгаж болохгүй юм. Энэ нь олимпын аваргын болзол хангаж алтан медаль авсны дараагаар спортоо орхилоо гэсэн шалтгаанаар медалийг нь буцаан авахтай адил юм. Хэрэв ажил олгогч голохгүй, өндөр насны тэтгэвэр авагчийн хөдөлмөрлөх чадвар, боломж байгаа л бол тэтгэвэрээ аваад хажуугаар нь хөдөлмөрлөөд цалин хөлс авах нь Үндсэн хуульд харшлахгүй юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1997.04.23 № 03

### Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1997 оны 3 дугаар тогтоол Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д., Д.;  
Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч - Сонгуулийн ерөнхий  
хорооны гишүүн Д., Б.;  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч - Д., Б., Э.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Сонгуулийн Ерөнхий Хорооны “Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгох тухай” 1997 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоол

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэг “Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:

О. нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 1990-1993 онуудад сонгогдож бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгч болох нь тодорхой байхад Сонгуулийн Ерөнхий хороо 1997 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 3 дугаар тогтоол гаргаж, О.-г Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгосон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийг заалтыг зөрчсөн байна. О. бол 1990 онд Ерөнхийлөгчөөр сонгогдож, тангараг өргөж Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ эдэлсэн билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Ерөнхийлөгчийг 4 жилийн хугацаагаар сонгоно, мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно” гэж зааснаас үзэхэд Ерөнхийлөгч нийтдээ 8 жил дараалан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх Үндсэн хуулийн агуулга байна. Одоо 3 дугаар тогтоолоор сонгогдвол 11 жил Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх болж байна.

##### 2. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:

Одоогийн Ерөнхийлөгч О.-гийн нэрийг дахин нэр дэвшүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна. БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль-ийн 13 дугаар зүйлийн 4-т “Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно” гэсэн заалт байгаа нь одоо дагаж мөрдөж байгаа Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэгтэй ижил байна. О. 1990.03.21-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаар, 1990.09.03, 1993.06.17-нд Ерөнхийлөгчөөр тус тус сонгогджээ. О. 1993 онд улиран сонгогдож байна гэдгээ хүлээн зөвшөөрч байжээ. Тухайлбал 1993 оны сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “улиран сонгогдвол” гэжээ. Ер нь Үндсэн хуульд /шинэ, хуучин хууль/ Ерөнхийлөгчийг сонгох журмын ялгааг харгалзан үзэж, 3 дахь удаагаа сонгож болно гэсэн ямар нэг хоёрдмол санаа үгүй байна.

3. Иргэн Д., Д. нарын Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга: 1990, 1993 онд сонгогдсон Ерөнхийлөгч эрх мэдлийн хувьд зарчмын ялгаагүй. О. хоёр удаа Ерөнхийлөгчөөр сонгогдсон, тухайлбал хоёр удаа тангараг өргөсөн, Үндсэн хуульд заасан бүрэн эрхийг 1993 оны 6 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн. Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар зөвхөн нэг удаа улиран сонгогдож болно” гэж хоёрдмол утгагүй заасан. Иймд О.-г Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгох тухай Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна. Үндсэн хуулийн цэц шударга шийдвэр гаргана гэдэгт итгэж байна.

4. Сонгуулийн Ерөнхий хорооны итгэмжилсэн төлөөлөгч Д., Б. нарын тайлбарын агуулга:

О. нь 1990 онд БНМАУ-ын Ардын Их Хурлаас, 1993 онд шинэ Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд заасан зарчим, журмаар сонгогдож БНМАУ-ын болон Монгол Улсын Ерөнхийлөгч болсон билээ. Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан заалт нь Ардын Их Хурлаас сонгогдсон БНМАУ-ын Ерөнхийлөгчид хамаарахгүй гэсэн дүгнэлтийг иш үндэс болгон Сонгуулийн ерөнхий хороо шийдвэрээ гаргасан болно.

5. Сонгуулийн Ерөнхий хорооны итгэмжилсэн төлөөлөгч Д., Б. нарын тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалт нь Ардын Их Хурлаас сонгогдсон БНМАУ-ын Ерөнхийлөгч болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг 1992 оны 2 дугаар сарын 12-ноос 1993 оны 6 дугаар сарын 18 хүртэл хэрэгжүүлж байсан БНМАУ-ын Ерөнхийлөгчид хамаарахгүй гэдэг үндэслэлийг иш үндэс болгож, Сонгуулийн Ерөнхий хороо шийдвэрлэн гаргасан юм. Энэ шийдвэр Үндсэн хууль зөрчөөгүй.

6. Нэр дэвшигч О.-гийн итгэмжилсэн төлөөлөгч Д., Б., Э. нарын тайлбарын агуулга: Монгол Улсын Үндсэн хууль 1992 оны 2 дугаар сарын 13-наас дагаж мөрдөгдсөн учир шинэ Үндсэн хуулиар зохицуулсан харилцааг мөн 13-наас эхлэн тоолно. БНМАУ-ын Үндсэн хуулийн шилжилтийн тухай хуулиар бататган бүрдүүлсэн төрийн дээд байгууллагуудыг тус тусын шинэ сонгууль хүртэл ажиллуулахаар хүлээн зөвшөөрсөн юм. Өмнөх төрд Ерөнхийлөгчөөр сонгогдож байсан хүн дахин сонгогдож болохгүй гэж байхгүй. БНМАУ-ын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхийлөгч хоёр сонгогдох, эрх хэмжээний хувьд ялгаатай. Ерөнхийлөгчийн тухай хуулийн тодорхойлолтоос харагдаж байна. Тухайлбал, БНМАУ-ын Ерөнхийлөгч АИХ-аас сонгогдсон, Монгол Улсын Ерөнхийлөгч бол бүх ард түмнээс сонгогдсон. Одоогийн Ерөнхийлөгч бол шинэ Үндсэн хуулийн дагуу анх удаа сонгогдсон гэж үзэж байна. Иймд О. хоёр дахь удаагаа нэр дэвшиж байгаа юм. Ерөнхийлөгчийн ярьж хэлж байсныг хуулийн заалттай хутгаж болохгүй. Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалт эргэж үйлчлэх хүчингүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1990 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд заасан БНМАУ-ын Ерөнхийлөгч, Монгол Улсын шинэ Үндсэн хуульд заасан Монгол Улсын Ерөнхийлөгч нь хэрэгжүүлэх бүрэн эрх болон сонгогдох зарчмынхаа хувьд хоорондоо эрс ялгаатай байна.

2. Нэр дэвшигч О. нь нийт ард түмнээс Ерөнхийлөгчөөр сонгогдохоор хоёр дахь удаагаа нэр дэвшиж байна.

3. Сонгуулийн Ерөнхий хорооноос нэр дэвшигч О.-г Ерөнхийлөгчид нэр дэвшүүлснийг бүртгэж авсан 1997 оны 3 дугаар сарын 27-ны 3 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий хорооны 1997 оны 3 дугаар сарын 27-ны 3 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилъя.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталсан шинэ Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлээр Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой харилцаа тусгагдсан ба 1993 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар дэлгэрүүлэн зохицуулсан. О. нь Үндсэн хууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар тогтоосон сонгуулийн журмын дагуу анх сонгогдсон болно. Иймд 1997 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоёрдугаар сонгуульд нэрээ дэвшүүлэх бүрэн эрхтэй байна.

#### **Тоо баримт дурдвал:**

- 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Л.Түдэв, П.Очирбат нар өрсөлдсөнөөс Л.Түдэв 397061 санал (38.7%), П.Очирбат 592836 санал (57,78%) авсан бөгөөд П.Очирбат Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдож байжээ.

- 1997 оны Ерөнхийлөгчийн сонгуульд П.Очирбат, Ж.Гомбожав, Н.Багабанди нар өрсөлдсөнөөс П.Очирбат 292896 санал (29,81%), Ж.Гомбожав 65201 (6.64%) санал, Н.Багабанди 597573 (60.81%) санал авсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр Н.Багабанди сонгогдож байжээ.

- 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Н.Багабанди, Р.Гончигдорж, Л.Дашням нар өрсөлдсөнөөс Н.Багабанди 581381 санал (58,13%), Р.Гончигдорж 365363 санал (36.54%), Л.Дашням 35425 санал (3.54%) авсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр Н.Багабанди улиран сонгогдож байжээ.

- 2005 онд Н.Энхбаяр, М.Энхсайхан, Б.Эрдэнэбат, Б.Жаргалсайхан нар өрсөлдсөнөөс Н.Энхбаяр 497491 санал (53.44%), М.Энхсайхан 186646 санал (20.05%), Б.Эрдэнэбат 105497 санал (11.33%), Б.Жаргалсайхан 128784 санал (13.83%) авсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр Н.Энхбаяр сонгогдож байжээ.

- 2009 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж нар өрсөлдсөнөөс Н.Энхбаяр 520948 санал (47.41%), Ц.Элбэгдорж 562718 санал (51.21%) авсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр Ц.Элбэгдорж сонгогдож байжээ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1997.06.21 № 04

### Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 дүгээр тогтоолын 1 дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг явуулсан байдал нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн З.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., Улсын  
Их Хурлын Тамгын газрын орлогч дарга Э.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн З.ийн мэдээллийн агуулга:

Импортын барааны гаалийн татварын тухай 1997 оны 4 дүгээр сарын 18-ны Монгол Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолын нэг дэх хэлэлцүүлгийн санал хураалтыг 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48 минутад явуулсан байдал нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүдийн дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийднэ” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48 минутад явуулсан санал хураалтад оролцсон гишүүдийн нэрсийн жагсаалтыг цахим тооцоолуураас авч үзэхэд Америкийн Нэгдсэн Улсад томилолтоор явж байсан гишүүн Д. санал хураалтад оролцсоноор гарчээ. Үндсэн хууль зөрчиж гаргасан тогтоолыг хүчингүй болгож, шинээр хэлэлцүүлэг явуулан батлуулах, цаашдаа Улсын Их Хурлын хуралдааныг зөвхөн хуулийн хүрээнд явуулж байх нь хуулийг дээдлэх ажлыг төр өөрөөсөө эхэлж, нийт иргэддээ үлгэр дууриал болох юм.

##### 2. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

а/ Улсын Их Хурлын гишүүн Ч.-гийн Үндсэн хуулийн цэцэд бичгээр ирүүлсэн тодорхойлолтод:

“Миний бие тухайн хуралдаанд оролцож байсны хувьд хуралдаан 51 хүний ирцтэй байсныг тоолсон билээ. Эзгүй байсан гишүүний товчлуур дарагдсан тухайд бол Д. гишүүний товчлуурыг миний бие санамсаргүйгээр дарсан бөгөөд ингэхдээ өөрийн товчлуурыг дараагүй болно. Иймээс тус чуулганы хуралдааныг хуулийн дагуу явагдсан гэж үзэж байгаа бөгөөд шаардлагатай бол энэ тухай гэрчлэхэд бэлэн байгаагаа мэдэгдье” гэсэн байна.

б/ Улсын Их Хурлын гишүүн Г.-гийн Үндсэн хуулийн цэцэд бичгээр ирүүлсэн тодорхойлолтод:

“Улсын Их Хурлын чуулганы энэ оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд миний бие оролцсон нь үнэн бөгөөд харин цахим тооцоолуурын ирц дээр хуралдаанд оролцоогүйгээр тэмдэглэсэн байна. Өнгөрсөн хугацаанд татварын багц хуулийн төслийн Төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хорооны ажлын хэсгийн ахлагчаар томилогдон ажилласан бөгөөд албан үүргийнхээ дагуу уг асуудлыг хэлэлцэж байх үед хуралдаанд оролцохгүй байх эрх надад байхгүйг болгооно бизээ. Цахим тоолуур, Тамгын газрын ажилтан хоёрын бүртгэсэн ирц зөрж байгаа нь техникийн алдаанаас болсон нь тодорхой” гэсэн байна.

в/ Улсын Их Хурлын гишүүн Ч.-гийн тайлбарын агуулга:

Би арын эгнээний 3 дахь суудалд Д. гишүүний суудал дээр суугаад Г. гишүүнтэй ярьж сууж байгаад санал хураалт явуулах үед Д. гишүүний товчлуурыг дарсан, өөрийнхийгөө дараагүй. Энэ санал хураалт нэрээр хураасан санал хураалт биш байсан.

г/ Улсын Их Хурлын гишүүн Г.-гийн тайлбарын агуулга:

Би татварын хуулийн ажлын хэсгийн ахлагч байсан учир хууль хэлэлцэж, санал хурааж байхад ороогүй байх нөхцөл байхгүй. Би энэ санал хураалтад оролцож байсан. Ирц хүрэхгүй бол Р. хурал даргалагчид мэдэгдэх ёстой.

д/ Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Тэр өдрийн хуралдаан хуульд заасан ирцтэй явагдсан. Өвчтэй, чөлөөтэй 23 гишүүн байж, 53 гишүүн оролцсон. Г. нарын 4 гишүүн хуралд байж санал хураалтад оролцон саналаа өгснөө нотолцгоож байна. Хоёрхон минутын дараа явагдсан санал хураалтад 53 гишүүн оролцсон. Санал хураалт явуулдаг компьютерийн системийн согогтойг нотолсон нотлох баримтыг Цэцийн хуралдаанд өгсөн. 76 компьютерийн гар бүгд масстай учир скочоор боосон байдаг бөгөөд хажуугаар нь чангахан гишгээд өнгөрөхөд л зарим гар нь ажиллаж эхэлдэг тухай техникийн ажилчид баталж байгаа. Хажуу талынхаа гишүүдийн кнопыг дарах явдал хааяа байдаг. 51 гишүүн хүрээгүй тохиолдолд дэг сахиулагч хуралдаан даргалагчид заавал мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тухай үед ингээгүй нь ирц бүрэн байсныг нотолж байна.

3. Иргэн 3.ийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Цахим тооцоолуур үнэн ажилладаг гэж үзэж байсан учраас одоо болтол компьютерийн системийг солиогүй гэж үзэж байгаа юм. Энэ гурван гишүүний хувьд техникийн буруу биш, хариуцлагын асуудал гэж үзэж байна. Хуралдааны ирц бүрэн эсэхийг хурал даргалагч бүрэн хянаж байх ёстой. Тухайн өдрийн 15 цаг 30 минутанд дээрх 4 гишүүн байсныг Р.-ийн бүртгэл нотолж байгаа бол 16 цаг 48 минутад дээрх 4 гишүүн байхгүй байсныг компьютерээс авсан жагсаалт нотолж байна. Энэ гишүүд байсан гэж би итгэж чадахгүй. Их Хурлын бүх санал хураалт шийдвэрлэх санал хураалт байна. Компьютер алддаг гэж үзвэл Их Хурлын баталсан бүх хууль хүчингүй буюу Үндсэн хууль зөрчиж гарсан гэж үзэх үндэстэй.

### **Маргааныг хянан шалгах явцад илэрсэн нөхцөл байдал:**

Улсын Их Хурлын гишүүн Г. 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр уг тогтоолын төслийн талаарх Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хорооны дүгнэлтийг 16 цаг 11 минутын орчимд уншиж танилцуулжээ. Улсын Их Хурлын чуулганы 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны протоколоос үзвэл Импортын барааны гаалийн татвар тэг байх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураахад 27 гишүүн зөвшөөрч, 24 гишүүн татгалзаж, бүгд 51 гишүүн оролцон, 52.9 хувийн саналаар уг асуудал дэмжигджээ. Энэ тогтоолын төслийн эхний хэлэлцүүлгийг дуусгаж, хоёрдугаар хэлэлцүүлэгт бэлтгэе гэсэн томьёоллоор санал хураахад 34 гишүүн зөвшөөрч 19 гишүүн татгалзаж, 64.2 хувийн саналаар батлагдан 16 цаг 50 минутад уг асуудлыг хэлэлцэж дуусчээ.

Чуулганы энэ өдрийн хуралдааны протокол болон Тамгын газрын ажилтнуудын ирцийн бүртгэлээс харвал Д. нарын 18 гишүүн чөлөөтэй, О. нарын 5 гишүүн өвчтэй гэж бүртгэгджээ. 1997 оны 4 дүгээр сарын 11-ний 16 цаг 48, 16 цаг 50 минутад явагдсан 2 санал хураалтын жагсаалтыг цахим тооцоолуураас авч харахад О., Д. нар санал хураалтад оролцон зөвшөөрсөн санал өгсөн, Ч., Г., Т., Б. нарын гишүүд санал хураалтад оролцоогүй гэж гарсан байв.



## **Үндсэн хуулийн цэцийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Импортын барааны албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 16 цаг 48 минутад хэлэлцүүлэх үед гадаад улсад томилолтоор ажилласан, өвчтэй байсан гишүүдийг хуралд оролцож, санал өгснөөр тооцон бүрэн бус бүрэлдэхүүнтэйгээр санал хураалгасан, мөн өдрийн 16 цаг 50 минутад гишүүн О., Д. нарыг хуралд хүрэлцэн ирснээр дахин санал хураалгасан зэрэг нь Улсын Их Хурал хуралдааныхаа явцад Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийг зөрчсөн болох нь тогтоогдов.

Хуралд оролцоогүй гишүүдийн өмнөөс санал хураалтын товчлуурыг дарсан нь Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх, халдашгүй байдалд харшилж Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна. Иргэн З.-гийн энэ талаархи гомдлыг хүлээн авах нь зүйтэй байна.

2. Улсын Их Хурал Импортын барааны албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх явцдаа хуралдааны журам, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг зөрчиж байсан боловч энэ талаархи эцсийн шийдвэр гаргахад хуралдааны ирц бүрэн байсан тул Импортын барааны гаалийн албан татварын тухай Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн<sup>33</sup> 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их хурлын 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 16 цаг 48 минутын хуралдааны санал хураалтын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зүйлийг тус тус зөрчжээ.

2. Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуульд заасны дагуу 15 хоногийн дотор хянан хэлэлцэж, хариуг манайд ирүүлэхийг уламжилсугай.

### **“Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1997 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 76 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 4 дүгээр дүгнэлтийн 1 дэх хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлтийн 2 дахь хэсгийг хүлээн зөвшөөрсүгэй.

### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааны хүрээг тодорхой тогтоож өгсөн байдаг. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулагдах учиртай

<sup>33</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 6-д нийтлэгдсэн

асуудлыг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэжээ. Иймд номын Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр, Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт гэсэн хэсэгт бичилт хийгээгүй, хоосон орхисон болно.

2. Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 9 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

3. Энэхүү маргааныг хянан шийдвэрлэхээс 1 сар гаруй хугацааны өмнө Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль батлагдан гарсан байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1997.12.17 № 03**

**Импортын барааны гаалийн татварын тухай Монгол Улсын Их Хурлын 1997 оны 24 дүгээр тогтоол, түүний анхны хэлэлцүүлгийн санал хураалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн З.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Э.

1. Иргэн З.-гийн тайлбарын агуулга:

Би өмнөх өргөдөл, тайлбараа дэмжиж байгаа тул дахин бичгээр тайлбар гаргах шаардлагагүй гэж үзлээ. Нэгэн зүйл нэмж тайлбарлахад Улсын Их Хурал хууль хэлэлцэж байхдаа эхний хэлэлцүүлгээрээ хууль зөрчсөн. Хууль батлах процесс зөрчигдөхөд хууль хүчинтэй байж болох уу, үгүй юу?

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С., Э. нарын тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд тодорхойлон заасан асуудлаар дүгнэлт гаргах учиртай. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” асуудлаар дүгнэлт гаргадаг. Улсын Их Хурлын тогтоол нь Үндсэн хуульд нийцэж байхад дүгнэлтийнхээ нөгөө хэсэгт Улсын Их Хурлын хуралдааны санал хураалтын үйл ажиллагаа /процессын ажиллагаа/ нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргасан нь ойлгомж муутай байгаа юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэц өөрийнхөө дүгнэлт гаргах зүйлд хамаарагдахгүй асуудлаар дүгнэлт гаргажээ гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Импортын барааны гаалийн татварын тухай Улсын Их хурлын 1997 оны 24 дүгээр тогтоолын төслийг Улсын Их Хурлын хуралдаанаар хэлэлцсэн анхны хэлэлцүүлэг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, энэ талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 4 дүгээр дүгнэлтийн нэг дэх заалт үндэслэлтэй байх тул Улсын Их Хурлын 1997 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 76 дугаар тогтоолын нэг дэх заалтыг хүчингүй болгох нь зүйтэй байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлтийн хоёр дахь заалтыг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн байх тул энэ талаархи маргааныг Үндсэн хуулийн цэц дахин хянан хэлэлцэж тогтоол гаргах үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1997 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 76 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

2. Цэцийн энэхүү тогтоол нь гармагц хүчинтэй болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь хууль батлах процесс Үндсэн хуулийг зөрчсөн үү гэдэг талаар шийдвэр гаргах нь хэр зохимжтой юм бол? Харин уг хууль нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргавал илүү оновчтой байж мэднэ.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1997.06.25 № 05**

**Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн  
1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн  
16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн эсэх маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн П.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Тамгын газрын хуулийн зөвлөх Ө.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Бага Хурлаас 1991 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль<sup>34</sup>

- 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт “мэргэжил, чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон”
- 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт “БНМАУ-ын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзол хангасан”

**Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалтын агуулга:**

- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”

<sup>34</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1991 оны № 2-т нийтлэгдсэн

- Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт“ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн П.-гийн өргөдлийн агуулга:

Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дэх заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчиж байна. Үүнээс болж аж ахуйн нэгж байгууллага нь тэтгэвэртэй буюу тахир дутуу хүнийг зохих тэнцэх ажил байсан ч ажилд авдаггүй, ажилд авсан нэг нь дуртай цагтаа Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дэх заалтаар ажлаас халдаг боллоо. Иймд Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дугаар заалттай нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, хянан шийдвэрлэж өгнө үү. Үндсэн хуулиар олгогдсон ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн чадвар алдах, хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй гэж боддог. Гэтэл энэ эрх маань яагаад эрхэлж чадаж байгаа ажил, хөдөлмөрөө эрхлэх боломжгүй болгож байгаа юм бэ? Амьдрал дээр тэтгэврээ аваад ажил хийгээд байгаа хүн олон байгаа юм. Энэ хоёр эрхийг зөрчилдүүлэн хууль гаргаснаас намайг ажлаас халахад хүргэлээ.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтууд иргэдийн ерөнхий эрхийг хуульчилж заасан агуулгатай. Тиймээс энэ заалтыг Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн заалтуудтай шууд тулган харьцуулж болохгүй юм. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах тухай хуулийн заалтын үндсэн зарчим нь тэтгэвэр авах болзол хангасан иргэн хүсэлтээ гаргах нь үндсэн ажлаа цаашид үргэлжлүүлэн хийх боломжгүй боллоо гэдгээ илэрхийлж, цалингийнхаа оронд тэтгэврээ авъя гэсэн утгыг агуулсан юм. Энэ нь тухайн иргэний ажил хөдөлмөр эрхлэх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг огт хязгаарлаагүй. Өөрөө хүсэлт тавьж, ажлаас гарсан, өөр ямар ч ажил, мэргэжил эрхлэх эрх нь нээлттэй байгаа. Гагцхүү уг ажил, мэргэжилдээ тэнцэх эсэх, тухайн байгууллага хөдөлмөрийн гэрээ байгуулах эсэх нь Үндсэн хууль болон өөр хуулиар тулгаж болохгүй асуудал юм.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдсөн Монгол Улсын Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалт хүчингүй болсон боловч уг заалт Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т хүчинтэй хэвээр байна.

2. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон гаргах ДҮГНЭЛТ:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 5 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 82 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 5 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 2 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэц нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу маргааныг хянан шалгадаг билээ. Үүний нэг дутагдалтай тал нь тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн ирүүлсэн шаардлагын хүрээнд л маргааныг хянан шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, нэг хуульд буй Үндсэн хуулийн зөрчил арилсан ч яг адилхан зөрчил өөр хуульд хүчин төгөлдөр үйлчилж байдаг.

Уг нь бол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу зөвхөн маргаанаар хянан шалгагдсан хуулийн зүйл, заалтыг Үндсэн хуульд нийцүүлэх бус тухайн хуулийн дотор нь мөн бусад хууль тогтоомжид буй адил зөрчлийг ч хуулийн хийдэл, зөрчил, давхардлыг цэгцлэх үүднээс Үндсэн хуульд нийцүүлэх ажлыг хийж байвал зүйтэй юм.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1997.07.05 № 06**

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг  
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч - А.  
**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

“Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг<sup>35</sup>

**Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

35 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 5-д нийтлэгдсэн

- Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт “өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н.-ийн мэдээллийн агуулга:

“Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэтрүүлэн гаргажээ. Төрийн өмчийн тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлд заасан нийтийн зориулалттай өмчид Хар хорин суманд буй Эрдэнэзуу музей багтдаг ба энэхүү өмчийг ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал эдэлдэг байна. Гэтэл Эрдэнэзуу музейг шашны байгууллагын өмчид шилжүүлэх асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шийдвэрлэжээ. Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 3-т төрийн өмчид байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг язгуур зориулалтаар ашиглахыг хоригложээ. Энэхүү заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг зөрчсөн байна.

Эрдэнэзуу музей бол цогцолбороороо түүх соёлын дурсгалт зүйлд багтах төрийн нийтийн зориулалттай өмч болно. Энэхүү өмчийг захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал эдэлдэг. Гэтэл энэ эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч эдэлсэн тул түүнийг Үндсэн хуулийг зөрчиж эрхээ хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч А.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Ерөнхийлөгч 1997 онд 71 дүгээр зарлиг гарган Хархорин дахь Эрдэнэзуу музейг шашны нийтийн өмчлөлд шилжүүлэх асуудлыг чиглэл болгон шийдвэрлэсэн нь Эрдэнэзуу хийдийн тэргүүн хамба Н. нарын хүмүүс гарын үсэг зурсан хүсэлт, Улсын Их Хурлын гишүүн Б., Өвөрхангай аймгийн Засаг дарга Ба., Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Бат., Гандантэгчилэн хийдийн хамба лам Ч., Монгол сүсэгтний холбоо, Монголын шашинтны ардчилсан нам зэрэг төрийн ба төрийн бус байгууллага, албан тушаалтны санал, хүсэлтийг харгалзан үзсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4-т буй “Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно” гэсэн заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн “ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна” гэсэн заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 3-т “Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрхтэй. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэсэн заалт, Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-т буй “...Эртний хэрэм, цайз... сүм дуган, хийд... байшин барилга зэрэг уран барилгын дурсгалыг... түүх соёлын дурсгалт зүйлд хамааруулах” тухай заалт, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 4-т буй сүм хийд, шашин номын ажиллагаа эрхлэн явуулахад нь шаардлагатай музей, номын сан дахь түүх, соёлын дурсгалт зүйлийг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд заасны дагуу хэрэглэх асуудлыг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ” гэсэн заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4-ийн 2-т буй “...түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал төрийн нийтийн зориулалттай өмчид хамаарна” гэсэн заалт, мөн зүйлийн 4-т буй “төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно”, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 1-д буй “төрийн өмчийн эд хөрөнгийг...хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно”, мөн хуулийн 30 дугаар

зүйлийн 2-т буй “төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамаарснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр... шилжүүлж болно” гэсэн заалтуудыг тус тус үндэслэсэн болно.

Хууль тогтоомжийн эдгээр заалтуудыг үндэслэл болгон Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан зарлигаар Эрдэнэзуу музейг “орон барилга” бусад холбогдох сан хөмрөгийнх нь хамт шашны нийтийн өмчид шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Засгийн газарт чиглэл болгосон учир Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Харин Засгийн газар энэ чиглэлийг хүлээн аваад хууль зүйн дагуу хэрхэн шийдвэрлэх нь түүний бүрэн эрхийн асуудал билээ.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсэг:**

Монгол Улсын Ерөнхийлөгч О. 1997 оны 4 дүгээр сарын 30-нд зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай 71 дүгээр зарлиг гарган Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Эрдэнэзуу музейг шашны байгууллагын нийтийн өмчлөлд шилжүүлсэн нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд шууд хамаарагдаагүй, өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын эрх мэдлийн төрийн нийтийн өмчийн асуудлыг шийдвэрлэсэн;

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 3-т зааснаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх агуулгаас хальж зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах, төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах утгаар гарсан;

3. Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг Монгол Улсын Засгийн газар албан ёсоор хүлээн авч шийдвэрлээгүй байхад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 71 дүгээр зарлиг гарснаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т буй “ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна” гэсэн заалтыг төрийн өмчийн эд зүйлсийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбон үзэх үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар дугаар зүйлийг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 6 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 46 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

“Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ойлгомжгүй гарсан. Яагаад гэвэл дүгнэлтийн тогтоох хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийг зөрчсөн байна” гэж зааж өгсөн. Гэтэл Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйл нь бүхэлдээ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зохицуулсан зүйл бөгөөд эдгээр бүрэн эрхийн 11 нь тухайн маргаанд огт хамааралгүй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1998.01.28 № 01**

**Банкны тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ц., Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1996 оны 9 сарын 3-ны өдөр баталсан Банкны тухай хууль<sup>36</sup>

- 37 дугаар зүйл “Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож, банк, түүний удирдлагын бүрэн эрх болон банкны өөрийн хөрөнгийг өмчлөх эрхийг банкны эрх хүлээн авагчид шилжүүлэн банкиг албадан татан буулгах үйл ажиллагааг банкны эрх хүлээн авах гэнэ”

- 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт “энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,3-т заасан үндэслэл Монголбанкны тодорхойлсноор бий болох нь зайлшгүй болсон”

- 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “банк, түүний удирдлагын бүрэн эрх болон банкны өөрийн хөрөнгийг өмчлөх эрх нь банкны эрх хүлээн авагчид шилжинэ”

- 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт “тухайн банк бусад этгээдээс өмч, хөрөнгө, төлбөр хүлээн авах эрхийн хугацаа дуусаж байгаа буюу дуусах хугацаа нь 6 сараас доош хугацаагаар дөхсөн бол банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш уг эрхийг 6 сараар шууд сунгагдсанд тооцно”

- 40 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Банкнаас хийгдсэн төлбөр, шилжүүлэг нь зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүтэйд үзсэн шинжтэй бол банкны эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 3 сарын дотор хийгдсэн төлбөрийг, хэрэв төлбөр хүлээн авагч нь банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан, тэдгээрт холбогдох этгээд байвал банкны эрхийг хүлээн авах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор хийгдсэн бүх төлбөрийг дор дурдсанаар бусад тохиолдолд тус тус хүчингүйд тооцно:

<sup>36</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны №11-т нийтлэгдсэн



1/ холбогдох хадгаламж эзэмшигчид төлсөн төлбөр нь тухайн үед нэг хадгаламж эзэмшигчид төлөхөөр Монголбанкнаас тогтоосон хязгаараас хэтрээгүй;

2/ бусдад шилжүүлсэн эд хөрөнгө нь уг эд хөрөнгийн зах зээлийн үнээр төлөгдсөн;

3/ банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд олгосон цалин хөлс нь тэдгээрт урьд нь олгож байсан цалин хөлсний ердийн хэмжээнээс хэтрээгүй /шагнал, бусад тусгай нэмэгдэл үүнд хамаарахгүй/”

- 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дараах этгээд шүүхэд гаргах эрхтэй:

1/ Банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн;

2/ Банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;

3/ Банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч”

- 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “ энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд гомдол гаргасан нь банкны эрх хүлээн авагчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох үндэслэл болохгүй”

### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Ц., Д. нарын мэдээллийн агуулга:

Банкны тухай хуулийн 37 дугаар зүйл, 38 дугаар зүйлийн 1-ийн 4 дэх заалт, 40 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 болон 2, 3 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэснийг болон Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалт бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-ын “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр хууль зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 14-т байгаа “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул хянан үзэж, хэлэлцэж өгнө үү.

2. Иргэн Ц., Д. нараас ирүүлсэн нэмэлт тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт нь хүний өмчлөх эрхийг дээд түвшинд баталгаажуулж өгсөн заалт. Гэтэл Банкны тухай хуулийн 37-41 дүгээр зүйл нь бүхэлдээ Монголбанкинд хүний энэхүү эрхэд өөрийн үзэмжээр халдах боломжийг олгож байна. Монголбанкны үйл ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд тавих

хяналтыг үндсэнд нь үгүй болгож, банкны хувь нийлүүлэгч болох гишүүдийн өмчийг шууд хураан авахаар заасан байна. Өөрөөр хэлбэл, банк татан буугдсан тохиолдолд түүний үлдэх эд хөрөнгө бусад зүйлсийг өмчлөгч нь Монголбанк болж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалттай харшилж байна. Банкны тухай хуулиар зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах эрхийг зөвхөн тодорхой хувь эзэмшигчдэд олгосон нь бусад хувь нийлүүлэгч гишүүдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх хохироход хүргэж байна. Ингэснээрээ хүнийг хөрөнгө чинээний байдлаар ялгаварлан гадуурхаж үл болох тухай Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг давхар зөрчлөө. Ер нь Ардын банкныг татан буулгах үндэслэл байхгүй. Тийм учраас Монголбанкны Ерөнхийлөгчийн 1996 оны 359, 362 дугаар тушаалуудыг хүчингүй болгохоор шүүхэд гомдол гаргасан. Гэтэл шүүх Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн бидний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлд “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, Иргэний хуулийн 134 дүгээр зүйлд “...эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй хурааж болно”, Иргэний хуулийн 139 дүгээр зүйлийн 3, 4, 6 дахь заалтад “хуульд заасан үндэслэлээр өмчлөх эрхээ алдах”, “өмчлөгч болох хуулийн этгээд татан буугдсан” бол өмчлөх эрх нь дуусгавар болно гэсэн заалтуудтай Банкны тухай хуулийн 37-40 дүгээр зүйлүүд Үндсэн хуулийн зөрчилтэй гэж гомдол гаргагчид үзсэн хэсгүүд нийцэж байна.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, Иргэний хуулийн 22 дугаар зүйлд “хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэн, хуулийн этгээдийн эрхийг заасан үндэслэл, журмын дагуу иргэн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж болно” гэсэн заалтуудтай Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтууд мөн нийцэж байгаа тул хуулийн зөрчил байхгүй. Ер нь Монголбанк Улсын Их Хурлаас баталсан төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны найдвартай байдлыг хангахын тулд тэдний үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Тийм ч учраас Төв банкны хуулийн дагуу “Банк байгуулах, банкны үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгох, хязгаарлалт хийх, шаардлага тавих, хяналт шалгалт хийх, банкинд онцгой дэглэм тогтоох, банкны эрх хүлээн авах эрхтэй бөгөөд өмчлөгчдийн хувьд банкны гишүүд банкны үйл ажиллагаанд өөрсдийн хяналтыг тавих ёстой юм.

4. Иргэн Ц., Д. нарын Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Банкны хуулийн 7-р бүлэг бүхэлдээ Үндсэн хуулийн зөрчилтэй. Учир нь банкны эрх хүлээн авна гэдэг нь хэрэг дээрээ Монголбанкны эрх хэмжээг Үндсэн хуулийн дээр гаргаж тавьсан, Үндсэн хуулийн хямралд хүргэж болзошгүй бүлэг болжээ. Банкныг татан буулгаж, өмчийг нь эрх хүлээн авагчид /өмчлөх эрхтэйгээр/ шилжүүлж буй ажиллагаа нь наанадаж нэг эрх мэдэлтэй, цаана нь Монголбанк өмчлөгчийн эрхийг өөрийн дураар эдлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэхүү хууль бус ажиллагааг Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтаар өмгөөлөн хааж зөрчигдсэн эрхээ хамгаалан сэргээх хууль эрхийн үндэслэлгүй болгожээ. 7 дугаар бүлгийн бусад заалтуудыг Монголбанкны дураар аашлах боломжийг бүрдүүлсэн дээрх заалтуудаас салгаж үзэх боломжгүй юм. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөн тэр бүлгийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлагатай. Энэ байдлыг Цэц анхааран үзэж дүгнэлтээ гаргана гэж найдаж байна.

5. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Монголбанк Банкны тухай хуулиар улсын санхүүгийн болон мөнгөний тогтвортой байдлыг хадгалж, эдийн засгийн амьдралыг найдвартай болгох онцгой үүрэг хүлээсэн

Төв банкны хариуцлага өндөр байх ёстой юм. Тийм ч учраас Төв банкинд хуулиар хүлээх хариуцлагатай нь дүйцэх эрх олгохоос өөр аргагүй. Төв банк өөрөө Монгол Улсын Их Хурлын хяналтанд байдаг учраас Үндсэн хуулиас давсан эрх бүхий байгууллага гэж үзэхгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь банкны эрх хүлээн авагчийг томилсонтой холбогдуулан хадгаламж эзэмшигчид, харилцагчдын шүүхэд гомдол гаргах эрхийг хөрөнгө чинээний байдлыг харгалзан хувь тогтоох замаар хязгаарласан нь хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх болон зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах тухай Үндсэн хуулийн заалтыг зөрчихөд хүргэжээ. Банкны тухай хуулийн 7 дугаар бүлгийн бусад зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дараах этгээд шүүхэд гаргах эрхтэй:

1/ Банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн;

2/ Банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;

3/ Банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч”

гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар 14 дэх заалтыг зөрчсөн байна.

2. Банкны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар бүлгийн бусад зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан зүйл, заалтыг зөрчөөгүй байна.

Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дараах этгээд шүүхэд гаргах эрхтэй:

1/ Банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн;

2/ Банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;

3/Банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 1 дүгээр

сарын 28-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийн 1 дэх заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Банкны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар бүлгийн бусад зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан зүйл, заалтыг зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтийн 2 дахь заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Дээрх зохицуулалт нь банкны хувь нийлүүлэгчдийг эзэмших хувь, хэмжээгээр нь алагчилсан зохицуулалт болсон байна. “25-аас доош” хувь эзэмшигч өөрийн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхгүй болжээ. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Банкны тухай хуулиар (2010.01.28-ны өдөр батлагдсан) банкны эрх хүлээн авагч томилсонтой холбоотойгоор шүүхэд хандах эрхийг эзэмших хувь, хэмжээнээс нь хамааруулж ялгавартай тогтоогоогүй бөгөөд бүгд шүүхэд хандах эрхтэй байхаар зохицуулжээ.

2. Арилжааны банкууд дахь хяналтыг Монголбанкнаас хэрэгжүүлдэг. Банкны хэвийн үйл ажиллагаа алдагдсан гэж үзвэл Монголбанкны шийдвэрээр банкны хэвийн үйл ажиллагааг хангах, санхүүгийн байдлыг нь сайжруулах зорилгоор удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн болон холбогдох бусад арга хэмжээг цогцолбороор авч хэрэгжүүлэхийн тулд онцгой дэглэм тогтоодог. Ийнхүү онцгой дэглэм тогтоосноор тодорхой үр дүнд хүрээгүй бол банкны эрх хүлээн авагчийг томилдог байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**1998.06.17 № 01**

### **Банкны тухай Монгол Улсын хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Д.-гийн тайлбарын агуулга:

Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1-ийн заалт нь хувь эзэмшигч, хадгалагчийн эрхийг яах аргагүй зөрчсөн юм. Ухаан нь Ардын банкныг дампууруулсан асуудал дээр хадгаламж, дансандаа 700-гаас доошгүй сая төгрөгтэй байж заргалдах эрхтэй болно гэсэн үг. Үүнийг хөрөнгө чинээгээр хязгаарлаж байна гэж үзэхээс өөр аргагүй.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

Банкны тухай хуулиар босго тавьж байгаа нь банкны үйл ажиллагааг тогтвортой байлгахад чиглэгдсэн, банкны өвөрмөц байдалд тохирсон шийдвэр болсон гэж үзэж байна. Энэ босгыг хангасан хүмүүс тэр хэмжээгээр хариуцлага хүлээдэг тул шүүхэд хандах эрхийг эдлэх нь зүйтэй болов уу. Ийм босго тогтоохдоо өмчлөгчийн эрхийг

хязгаарлаж болно гэсэн хуулийн заалтыг үндэслэсэн. Ер нь банкны хоёр шатлалын системд шилжих шилжилтийн үед зарим нэг хязгаарлалт байх нь зайлшгүй болов уу.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь банкны эрх хүлээн авагчийг томилсонтой холбогдуулан хадгаламж эзэмшигчид, харилцагчдын шүүхэд гомдол гаргах эрхийг банкны дүрмийн сангийн эзэмшсэн хувь, нийт хадгаламжийн эзэмшсэн хувь, түүнчлэн банкны төлөх бусад төлбөрийн эзэмшсэн хувь, хэмжээгээр хязгаарласан нь угтаа тэдгээрийг хөрөнгө чинээний байдлаар ялгаварлахад хүргэсний дээр хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх болон зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчихөд хүргэжээ.

Иймд Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийг зөрчиж байна гэж үзсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийн 1 дэх хэсгийг хүлээн авах боломжгүй гэж шийдвэрлэсэн Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1 дэх хэсэг үндэслэлгүй болох нь тогтоогдов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийн заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Банкны тухай Монгол Улсын хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Банкны эрх хүлээн авагчийг томилсон нь үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлыг банкны эрх хүлээн авагчийг томилогдсоноос хойш 30 хоногийн дотор дараах этгээд шүүхэд гаргах эрхтэй.

1/Банкны дүрмийн сангийн 25-аас доошгүй хувийг эзэмшсэн гишүүн;  
2/ Банкны нийт хадгаламжийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч;  
3/ Банкны төлөх бусад төлбөрийн 25-аас доошгүй хувийг эзэмшигч” гэсэн заалтууд

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийг зөрчиж байгаа тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

### **Тэмдэглэл:**

Шүүхэд хандах эрхэд босго тавьж болохгүй, хязгаарлаж болохгүй. Чухамхүү эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээдийн уг эрх, эрх чөлөөгөө хамгаалах, сэргээлгэхээр шүүхэд хандах эрхийг нээлттэй болгох нөхцөл, боломжийг бүрдүүлж байх нь эрх зүйт төрийн чухал үүрэг юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.02.24 № 02

**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Д., Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., О.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>37</sup>

- 1 дүгээр зүйл.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: “5. Өндөр насны тэтгэвэр авагч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол түүний тогтоолгосон тэтгэврийг дор дурдсан хувиар тооцож олгоно:

1/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс бага бол 100 хувиар;

2/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс их бол 60 хувиар;

3/ тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс их бол 40 хувиар”

- 2 дугаар зүйл.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“41 дүгээр зүйл. Тэтгэвэр тогтоолгох эрх хэрэгжих

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосон нөхцөлд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь хэрэгжинэ”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт “Иргэд... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хууль

37 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 3-д нийтлэгдсэн

нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтыг зөрчсөн байна. Энэхүү хуулийг дагаж мөрдсөнөөр өндөр насны тэтгэврээ аваад хөдөлмөрлөж буй хүмүүсийн тэтгэврийг орлого олж байгаа гэсэн шалтгаанаар хасах болсон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д буй “өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг ноцтой зөрчиж байна. Хуульд заасан болзлыг нэгэнт хангаад тогтоолгож буй тэтгэврийг хуульд өөрчлөлт оруулах гэдэг нэрээр хасч байгаа нь буруу байна. Нөгөө талаар дөнгөж хүрэлцэж ядаж буй тэтгэвэр дээрээ арга буюу амьдралаа зогоохын тулд хөдөлмөр эрхэлж хэдэн төгрөг нэмэрлэх нь хувь хүний эрхийн асуудал мөн. Ямар ч хүнд /хичнээн ядарч хөгширсөн ч гэсэн/ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т буй “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах эрхтэй” гэсэн заалт хамаарагдах ёстой гэж үзэж байна. Тэтгэвэр тогтоолгосон хэн боловч ажиллах, хөдөлмөрийн хөлс авах эрхтэй тул энэхүү эрхээ хэрэгжүүлж, хөдөлмөрийн хөлс авсан нь нэгэнт тогтоогдсон болзлын дагуу олгох тэтгэвэр авахад нь саад болох үндэслэл болохгүй.

## 2. Иргэн Д., Ц. нарын өргөдлийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар баталсан хуульд насны тэтгэвэр тогтоолгоод хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдад авч байгаа хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээг шууд харгалзан тэтгэврийг нь ялгаатайгаар олгох журам тогтоосон нь: Монгол Улсын Үндсэн хуулийн “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэнэ” гэсэн заалтыг, мөн хуулийн Тавдугаар зүйлийн 4-т буй “төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшил болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгаа зохицуулна” гэсэн заалт; мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д буй “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалт, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т буй “хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, албан ажил, мэргэжил, хөрөнгө мөнгө, үзэл бодлоор нь үл ялгаварлах” гэсэн заалт, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д буй “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөнтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалт, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Долдугаар зүйлийн 3-т буй “хүний эрхийг дордуулсан заалт бүхий хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2, 3, 6, 7, 8, 22, 23 дугаар зүйлийн 3 дахь заалт болон 25 дугаар зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус зөрчжээ.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Одоо Монгол Улсад 242 мянган хүн тэтгэвэр авдаг бөгөөд эдгээрийн 43 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаа. Эдгээр тэтгэвэр авагчдад олгох тэтгэврийн сангийн 71 хувь нь нийгмийн даатгалын сангаас 29 хувь нь улсын төсвөөс бүрэлддэг.

Өнөө үед ажил эрхлээгүй хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай хүмүүсийг ажил албанд ажиллуулах уу?, тэтгэвэр тогтоолгогсдыг ажиллуулах уу? гэдэг төрийн бодлого бий. Эдгээр асуудлыг төрийн бодлогоор зохицуулахын тулд Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-нд хууль гаргасан болно. Энэ хууль Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөгүй.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Иргэдийн тэтгэвэр авах эрх нь хуульд заасан болзол, журмыг хангасны үндсэн дээр үүсэх Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрх мөн тул тэтгэвэр тогтоолгосноос хойшхи хугацаанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гэдэг үндэслэлээр тогтоогдсон тэтгэврийг зогсоох, багасгаж хорогдуулах хууль зүйн үндэслэлгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 1997 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр гаргасан 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авч 1997 оны 5 дугаар сарын 2-нд 28 дугаар тогтоол гаргасан, улмаар тэтгэврийн эрх нь хэрэгжиж байгаа төрийн албан хаагч хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тэтгэврийг зогсоох тухай 1997 оны хуулийн зарим заалтыг хүчингүй болгосноор өнөө үед насны тэтгэврээ тогтоолгоод төрийн алба хашиж байгаа, эсхүл иргэний эрх зүйн гэрээгээр ажиллагсад насны тэтгэврээ бүрэн авч байна.

Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-нд баталсан хууль нь насны тэтгэврээ тогтоолгогсдыг ажил, албан тушаал, амьжиргааны түвшин, хөдөлмөрийн хөлсөөр нь ялгаатай авч үзэж тэтгэврийг өөр өөр байдлаар олгох үндэслэлийг бүрдүүлжээ.

3. Насны тэтгэврээ тогтоолгоод хөдөлмөрийн гэрээ болон бусад хэлбэрээр хөдөлмөр эрхлэх нь тэдний амьжиргааны түвшин, эрэлт хэрэгцээ, хөдөлмөрийн эрх, хөдөлмөрийн чадвар, улс, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах хүсэл, зорилго зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Эдгээр байдлуудаас үндэслэн үзэхэд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээ, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд буй заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчжээ гэж үзэх үндэслэлтэй байна. Энэ талаар бичсэн иргэн Б., Ц., Д. нарын гомдлыг хүлээн авах үндэслэлтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээ, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврээ, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: “5. Өндөр насны тэтгэврээ авагч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол түүний тогтоолгосон тэтгэврийг дор дурдсан хувиар олгож тооцно.

1/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс бага бол 100 хувиар;

2/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс их бол 60 хувиар;

3/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс их бол 40 хувиар” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Иргэд... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг тус тус зөрчжээ.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1998 оны хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 38 дугаар тогтоолын агуулга:**



Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна гэж үзсэн иргэн Б., Ц., Д. нарын гомдлын дагуу гаргасан Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийн:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг: “5. Өндөр насны тэтгэвэр авагч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол түүний тогтоолгосон тэтгэврийг дор дурдсан хувиар олгож тооцно.

1/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс бага бол 100 хувиар;

2/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс их бол 60 хувиар;

3/ Тухайн сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс их бол 40 хувиар” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Иргэд... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг тус тус зөрчжээ гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 2 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 4 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

3. Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үл ойшоодог, урьд нь гаргасан алдаагаа дараа дараагийн хууль тогтоомжид дахин давтан оруулдаг жишээ олон бий. Үүний адилаар Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр гаргасан 2 дугаар дүгнэлт бүхий маргаанаар шийдвэрлэгдсэн асуудлыг 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуульд дахин хуульчилжээ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.03.27 № 03

**Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйл,  
Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг,  
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2  
дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн  
эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Г.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль

- 362 дугаар зүйл “Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолд; Улсын дээд шүүхийн шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй.

Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй”

2. Улсын Их Хурлаас 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>38</sup>

- 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэлсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй”

3. Улсын Их Хурлаас 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хууль<sup>39</sup>

- 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт “анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр хуульд нийцээгүй гэж үзвэл эсэргүүцэл бичих”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “...тэгш байдал, ... хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

38 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 оны № 8-д нийтлэгдсэн

39 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 3-т нийтлэгдсэн

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

- Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Г.-гийн мэдээллийн агуулга:**

Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Дээд шүүхийн магадлалд эсэргүүцэл бичих тухай Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн “...тэгш байдлыг... хангах нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн”, Арван есдүгээр зүйлийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг бүрдүүлэх...үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ”, Тавин зургадугаар зүйлийн “Прокурор...шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтуудтай дараах үндэслэлээр зөрчилдсөн гэж үзэж байна. Үүнд: Прокурор шүүхтэй харьцах ганцхан нөхцөл нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд зааснаар прокурор, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох явдал юм. Энэ нь Прокурор зөвхөн шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үүрэгтэй гэж ойлгогдож байгаа бөгөөд хууль тогтоогч энд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэрт эсэргүүцэл бичих тухай ойлголт оруулаагүй байна. Прокурорт эсэргүүцэл бичих эрх хэмжээ олгохоор хуульчилсан нь Үндсэн хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнээс хальсан, түүний шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох үүрэгт хамаарахгүй асуудал болжээ. Ийнхүү шүүхийг прокурорын байгууллага хянадаг байсан социализмын үеийн хуучин тогтолцоог уламжлал болгон батламжилснаар шүүх прокуророос хараат байдалтай хэвээр үлдлээ.

Шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэрт эсэргүүцэл бичих эрхийг зөвхөн прокурорт олгосноор төрийн шүүхийн үйл ажиллагааны тэгш байдлыг хангах зарчим алдагдаж, төрийг төлөөлж байгаа прокурор нь иргэн хүнээс давуу эрх эдэлж, асуудлыг өөрийн үзэмжээр шийдвэрлүүлэхээр санал тавих боломжтой болж байгаа бөгөөд энэ нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүргэж байна. Эрүү, иргэний хэрэгт бичсэн прокурорын эсэргүүцлийг заавал шүүх хурлаар хянан хэлэлцэхээр, бусад оролцогчдын өргөдлийг шүүх зөвхөн хянан үзэж, үзэмжээрээ шийдвэрлэхээр хуульчилсан нь мэтгэлцэх зарчмыг алдагдуулж байна. Шүүх эрх мэдэл гэдэг ойлголтод шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэрт эсэргүүцэл бичих ажиллагаа хамаарахгүй гэж үзэж байна. Иймд хуулийн эдгээр заалт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өргөдөл гаргав.

#### **2. Иргэн Г.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:**

Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д зааснаар Ерөнхий прокурор өөрийн санаачилгаар анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэрт эсэргүүцэл бичихийг хуульчилсан нь, дараа нь энэ заалт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд баталгаажих үндэслэл болсноороо Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн. Төр, иргэн хоёр эрхийн хувьд тэгш бус байгааг арилгаж, прокурорын эсэргүүцэл бичих давуу эрхийг хүчингүй болгох шаардлагатай.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Шүүх хуралдаанд оролцсон прокурор ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан бөгөөд прокурор шүүх хуралдааны бусад оролцогчдын нэгэн адил эрх эдэлж байгаагаас биш өөр давуу эрх эдлэхгүй. Прокурор шүүх хуралдаанд нэг тал болон оролцож байгаагийн хувьд бусад оролцогчдын адил эрх эдэлж, давж заалдах ёстой. Ийм учраас анхан шатны шүүх хуралдаанд оролцсон прокурор давж заалдах журмаар эсэргүүцэл бичих эрхийг эдлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан явдал Үндсэн хуулийн заалтад харшлахгүй байгаа болно. Прокурор нэгэнт төрийг төлөөлөн шүүх хуралдаанд оролцож байгаа тохиолдолд бодит байдал болон хуульд нийцээгүй гэж үзсэн шүүхийн шийдвэр тогтоолын талаар дуугүй суух эрхгүй гэдгийг хуульчилж өгсөн нь туйлын зөв. Прокурорын эсэргүүцэл гэдэг нь шүүхийн үнэн чанартаа оролцогч нэг талын санал хүсэлт юм.

Шүүхээс гаргаж байгаа шийдвэрт эсэргүүцэл бичихгүй бол утгагүй зүйл юм. Прокурорын эсэргүүцэл нь шүүхийн ажилд гарч болох алдааг засахад онцгой ач холбогдолтой учир Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362, Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад иргэн Г. Цэцэд хандсан гомдлын дотроос “Прокурорын давж заалдах эсэргүүцэл бичихтэй холбоотой” хэсгийг өөрөө татаж авсан бөгөөд түүний гомдлын шаардлагын бусад хэсгийг хангах үндэслэл тогтоогдохгүй байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын талаар иргэн Г. Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад хүсэлт гаргасан боловч уг асуудлыг анхлан тавиагүйгээс маргаан хянан шалгах ажиллагаа үүсээгүй, энэ талаар Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс ямар нэгэн тайлбар ирүүлээгүй тул уг асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйлийн “Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолд; Улсын дээд шүүхийн шүүгч, сум буюу сум дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн шүүхийн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд хэргийн оролцогчийн гомдлоор буюу өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй.

Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй”, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор давж заалдах

болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын 1998 оны хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 3 дугаар дүгнэлтийн тухай” 1998 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 93 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйлийн “Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй”, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Прокурорын байгууллагын тухай энэ хуулийг 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар хүчингүйд тооцсон.

2. Үндсэн хуулийн цэц 1963 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж буй эсэх талаар шийдвэр гаргах эрхгүй юм. Учир нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн байдаг.

3. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтан юм. Тэрээр энэхүү онцгой чиг үүргээ хэрэгжүүлэх нэг арга хэрэгсэл нь прокурорын эсэргүүцэл бичих явдал мөн. Прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч шатанд буюу шүүхийн өмнөх шатанд, шүүхийн шийдвэр гарсны дараа эсэргүүцэл бичих эрхтэй. Эхнийх нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах зорилготой бичдэг бол хоёр дахь нь шүүхийн шийдвэр буруу гарсан гэж үзэж байгаа бол бичдэг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.04.27 № 04

### Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн заалтыг зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга Ж.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

“Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох” тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол<sup>40</sup>

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:

Ашигт малтмалын тухай, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд хэрэгжих явцад Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны 235 дугаар тогтоол гарсан нь дээр дурдсан хуулиудыг ноцтой зөрчсөн байна. Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “1997 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө олгогдсон хайгуулын буюу ашигт малтмал ашиглах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор энэ хуульд заасны дагуу шинэчлэн бүртгэнэ” гэсэн заалтын дагуу аж ахуйн нэгжүүд 1997 оны 10 дугаар сарын 1-ний дотор лицензийн шинэчилсэн бүртгэл хийлгэх ёстой юм.

Засгийн газар “Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох” тухай 235 дугаар тогтоолыг гаргахдаа Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7, 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг үндэслэсэн нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалттай зөрчилдөж байна. Ингэснээрээ Засгийн газрын 235 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн Дөчин тавдугаар зүйлийн заалтыг зөрчжээ. Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлохдоо эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, захиран зарцуулах эрхтэй гэж заасан байдаг. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлд эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцийг тодорхойлж өгсөн байдаг.

Эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцөд үйлдвэрлэгч, хангагчид нийтлэг хэрэглэдэг тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл, нүүрс, шингэн түлш зэрэг нөөц хадгалагдана гэж заажээ. Энэхүү хуулийн заалтаар бол зөвхөн олборлосон нүүрс болон боловсруулсан шингэн түлш нь эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцөд орох болон хадгалагдах тул нүүрсний орд газрыг нөөцөд авах үндэслэлгүй юм. Иймд Засгийн газрын 1997 оны 235 дугаар тогтоол нь хуулийн үндэслэлгүй, Монгол

40 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 12-д нийтлэгдсэн

Улсын Үндсэн хууль болон бусад хуулиудыг ноцтойгоор зөрчсөн байгаа тул хүчингүй болгоно гэдэгт найдаж байна.

2. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Ж.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Тогтоол нь Эрчим хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7, 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтуудыг үндэслэн гарсан. Эрчим хүчний нөөцөд олборлосон нөөц төдийгүй олборлоход бэлэн буй нүүрс орно гэдэг нь тодорхой байна. Нүүрс нь удаан хугацаагаар хадгалах боломжгүй түргэн хугацаанд илчлэг чанараа алддаг тул удаан хугацаагаар нөөцлөн хадгалж болдоггүй. Өвлийн ачаалалтай улиралд эрчим хүчний нөөцгүй болох нь улс орны эдийн засаг, хүн амын амьдрах нөхцөлд ноцтой байдал үүсгэж болзошгүй байдлыг харгалзан Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ юм.

Засгийн газрын 235 дугаар тогтоол Ашигт малтмалын хуультай зөрчилдөөгүй. Хуулийн хугацааг Засгийн газар өөрчилсөн гэж үзэхгүй байгаа юм. Засгийн газрын тогтоолоор Ашигт малтмалын хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн хугацааг сунгах үндэслэл нь Эрчим хүчний тухай хуулийн холбогдох заалтууд юм.

3. Ерөнхий сайд Э.-гийн тайлбарын агуулга:

Хууль зөрчилдөхгүй, процедурын хувьд ингэх ёстой юм. Тэд мөнгөө төлж чадахгүй байна гээд уул нь та нар Засгийн газар дээр тэр мөнгийг нь төлүүлэх гээд орж ирэх ёстой байсан юм. Би бол зөрчсөн юм олж харахгүй байгаа юм. Хуулийг нь би өөрөө зөрчих вий гэж мөргүүлж харсан юм. Ганцхан болно гэсэн өгүүлбэр байгаа. Нүүрсний ордыг Засгийн газар захиран зарцуулах бүрэн эрх эдлэх эрхтэй гэж Эрчим хүчний хуулиар тайлбарлаж болох юм байна. Захиран зарцуулах эрхээрээ Ашигт малтмалын хуулийн үйлчлэлд хөндлөнгөөс оролцож болно. Болж л байна. Тийм учраас би энэ тогтоолыг гаргахад болно гэж ойлгоод байна.

4. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаан дээр Сангийн сайд Ц.: “Эрчим хүчний хуульд ч, Ашигт малтмалын тухай хуульд ч ийм заалт байхгүй шүү дээ? Тэгвэл хуулиа өөрчилбөл яасан юм бэ? Хуулиас дээгүүр тогтоол гаргадаг хуучин арга руугаа эргэн орж байна. Хууль биелүүлээгүйн төлөө Засгийн газар хуультай зөрчилдсөн тогтоол гаргахад хүрч байна шүү дээ!” гэсэн байна.

Мөн энэ хурал дээр Хууль зүйн сайд А.: “Лицензийн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол лиценз нь хүчингүй болж байгаа юм. Лицензээ шинэчлээгүй, төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол лиценз өөрөө автоматаар хүчингүй болчихоод байхад зориуд байлгаад юмыг нь найруулаад, юмаа хураагаад цаашаа эвхээд, хашаан дотроо зөөгөөд байж болохгүй. Улсын Их Хурлаас Засгийн газрын хууль зөрчсөнийг хараад хэд хоногийн дараа энэ тогтоолыг хүчингүй болгоно шүү дээ.” гэсэн байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн “Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох тухай” 235 дугаар тогтоол нь Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 6, 8 дахь хэсгийн ашигт малтмал ашиглах лицензийг гагцхүү Кадастрын албаны шийдвэрээр олгож байх тухай заалтууд, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 6 дугаар зүйлийн уг хуульд заасан хугацаанд лицензээ шинэчлэн бүртгүүлэх, лицензийн төлбөрөө төлөх, хэрвээ энэ хугацаанд шинэчлэн бүртгүүлэх өргөдлөө гаргаагүй, төлбөрөө төлөөгүй бол лиценз хүчингүй болох тухай заалтуудыг тус тус зөрчиж байгаа нь тогтоогдов.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорьдугаар зүйлийн заалтуудыг тус тус зөрчиж байх тул энэ талаар гаргасан иргэн М.-ийн хүсэлтийг хүлээн авах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 235 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-д буй “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 76 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

“Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох” тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 3-ний өдрийн 235 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1997 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу 1997 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө олгогдсон хайгуулын буюу ашигт малтмал ашиглах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн биеэр буюу итгэмжилсэн төлөөлөгчөөр дамжуулж Геологи, уул уурхайн кадастрын албанд гаргахаар зохицуулалтыг хууль тогтоогч хийсэн байна.

Гэтэл үүнтэй зэрэгцүүлэн Монгол Улсын Засгийн газар “Нүүрсний уурхайнуудын лицензийг шинэчлэн олгох тухай” тогтоолыг гаргасан байна. Өөрөөр хэлбэл “лиценз шинэчлэх” талаар хуулиар тогтоосон журмаас гадуур өөр журам тогтоосон байна. Мэдээж Засгийн газрын тогтоол Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх учиртай.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.05.06 № 05

### Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Ш., Ш., Г., Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Л., Б., З.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

“Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоол<sup>41</sup>

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”
- Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”
- Тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална”

#### Маргагч талуудын тайлбар, байр суурь:

1. Иргэн Ш., Ша. нараас ирүүлсэн өргөдлийн агуулга:

Манай сум 1955 онд Архустайн сангийн аж ахуй нэрээр анх байгуулагдаж, 1969 онд Архустайн тэжээлийн аж ахуй, 1976 онд хороо, 1981 оноос Төв аймгийн Архуст сум гэх мэтээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон үүсч хөгжиж ирсэн бөгөөд сум нутаг дэвсгэрийн хилийн цэсийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн /тэр үеийн нэрээр/ 1982 оны 131 дүгээр зарлигаар тогтоосон юм. Тус сум 547 өрх, 2047 хүн, 49080 толгой малтай, газар тариалан эрхлэх 2 компанитай, өндөр хүчдэлд холбогдсон, төмөр замын сүлжээтэй, дэд бүтэц харьцангуй хөгжсөн сум болно.

Гэтэл Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо тус сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигийг хүчингүй болгожээ. Ингэснээр Архуст сум нутаг дэвсгэргүй болж, манай зэргэлдээх Эрдэнэ, Баяндэлгэр, Баянжаргалан сум урьд өмнө нь манай суманд шилжүүлсэн нутгаа буцааж авна гэсэн хандлага үүсгэж, малчид, иргэд хооронд хэрүүл маргаан үүсч ноцтой байдал бий болоод байна.

Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3-т заасан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэсэн заалтыг; мөн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1, 2-т заасан “Аймаг, сум, дүүрэг бол

41 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 7-д нийтлэгдсэн

хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засгийн цогцолбор мөн”, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална” гэсэн заалтуудыг; мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, 4 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчиж, тус сумыг үндсэнд нь нутаг дэвсгэргүй болгосон буруу шийдвэр гэж үзэж байна. Иймд Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолыг хянан үзэж, уг тогтоолын 3 дугаар заалтыг хүчингүй болгож, манай сумын нутаг дэвсгэрийг 1982 онд тогтоосон хуучин байдлаар нь үлдээж өгөхийг хүсье.

2. Иргэн Г., Д. нараас ирүүлсэн өргөдлийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоохдоо Эрдэнэ сумын 1, 2 дугаар багийн нутаг Туул, Тэрэлжийн гол, Элстэй, Горхины амны сав газрын 49.5 мянган га газрыг шилжүүлж, уг шийдвэрийг хэрэгжүүлж байгаа юм. Улсын Их Хурлын дээрх шийдвэр нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулахтай холбогдсон Монгол Улсын Газрын тухай хуулийн 21, 25 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Газар зохион байгуулалтын журам”-ын 9, 20, 21 дүгээр зүйлийн заалтыг тус тус зөрчсөн байна. Засгийн газар дээрх шийдвэрийг гаргуулахдаа зохих мэргэжлийн байгууллагын санал болон тогтоолынхоо дагуу ажлын хэсэг гарган зохих материал бүрдүүлэхгүйгээр дангаараа санал боловсруулан асуудлыг шийдвэрлүүлсэн. Энэхүү шийдвэр нь:

а/ Тус сумын 2 багийн 74 өрхийн 225 иргэн, 85 өвөлжөө, хаваржаа болон суурин хашаа, байшин 6000 гаруй мал хамрагдаж буй газрыг нийслэлд шилжүүлснээрээ нутгийн иргэдийг олон зуун жилийн туршид амьдарч ирсэн нутгаас нь салгаж, ахуй амьдралд нь муугаар нөлөөлж байна.

б/ Сумын төсвийн орлогын 70 хувийг оруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, амралт, аялал жуулчлалын 10 гаруй аж ахуйн нэгж цаашид бие дааж ажиллах боломжгүй болох ба ингэснээр тус сум эдийн засгийн хувьд бие даан оршин тогтнох боломжоо алдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дүгээрт заасан “Сум... бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэсэн заалт зөрчигдөж байна.

в/ Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дугаар зүйлд буй “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухай нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчиж манай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутгийн иргэдийн саналыг авахгүйгээр асуудлыг шийдвэрлэсэн юм.

Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоолыг 1 дэх заалт нь тус сумын хоёр багийн иргэдийг нутаггүй болгож, Улаанбаатар хотын иргэд, нутгийн уугуул иргэдийн хооронд нутгийн маргаан үүсгэж, уугуул иргэдийн санаа сэтгэгдлийг алдагдуулж байгааг харгалзаж үзэж, Улсын Их Хурлын 24 дүгээр тогтоол Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байгаа тул шийдвэрлэж өгөхийг хүсье.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Л., Б. нараас иргэн Ш., Ш. нарын өргөдөлтэй холбогдуулан ирүүлсэн тайлбарын агуулга:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газар санаачлан Улсын Их Хуралд оруулсан. Нийслэлд хэт төвлөрөл бий болж, нутаг дэвсгэрийн хүрэлцээ муудсанаас хотод оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажил улам бэрхшээлтэй болсон, Төв аймгийн нутагт нийслэлийн харьяалалд багтах захиргааны нэгжүүд бий болж, Үндсэн хууль зөрчигдөж байсан болон бусад шаардлагын дагуу дээрх тогтоолын төсөл боловсрогдсон ба Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны хуралдаанаар хэлэлцэгдэж, 79.6 хувийн

саналаар батлагдсан. Уг тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Энэ тогтоолоор газар нутгийн хилийн цэсийг тогтоосон болохоос биш нэгэнт тогтсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг хөндөөгүй байна. Улсын Их Хурал нь нийслэл, түүний дүүргүүдийн хилийн цэсийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэсэн гэж үзэж байна.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Л., Б. нараас иргэн Д., Г. нарын өргөдөлтэй холбогдуулан ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын энэхүү тогтоол нь газар нутгийн хилийн цэсийг тогтоосон болохоос биш нэгэнт тогтсон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг хөндөөгүй байна. Төв аймгийн Эрдэнэ сум, нийслэлийн Налайх дүүрэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд өөрчлөлт ороогүй. Улсын Их Хурал нийслэл түүний дүүргүүдийн хилийн цэсийн төслийг батлахдаа Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэсэн гэж үзэж байна.

Улсын Их Хурлын энэ тогтоол нь Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дүгээр заалтанд буй “Аймаг, нийслэл, сум, дүүрэг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэсэн хэм хэмжээг зөрчөөгүй. Эрдэнэ сум нь 1996 онд энэ тогтоол гарсны дараа 3.5 мянган хүн амтай 57.0 мянган толгой малтай, 865.0 мянган га газар нутагтай, үүнээс 433.0 мянган га нь хөдөө аж ахуйн зориулалтын газартай байв. Эрдэнэ сумаас нийслэлд 48.9 мянган га газар шилжүүлсэний 30.8 мянган га нь бэлчээрийн эдэлбэр, 12.0 мянган га нь тариалангийн эдэлбэр газар бөгөөд Улсын Их Хурлын баталсан дээрх нутагт одоо Налайх дүүргийн 22.0 мянган хүн, 54.0 мянган мал, нийслэлийн 49 албан байгууллага, аж ахуйн нэгжийн 20.0 гаруй мянган толгой мал, Тэрэлж амралт, Жуулчдыг үйлчлэх газар, Болор зуслан, Чингисийн өртөө, Нарлаг, Жавхлант зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд байдаг юм. Энэ нутагт 1996 оны байдлаар 300 гаруй ерх хаваржиж байсан бөгөөд үүнээс 270 гаруй нь Налайх дүүргийн, 30 гаруй нь Эрдэнэ сумын харьяат айл байна. Мөн энэ нутаг дэвсгэрт 106 өвөлжөө, хаваржаа байгаагаас 20 гаруй нь Эрдэнэ сумынх, бусад нь Налайх дүүрэг, Улаанбаатар хотын иргэдийнх юм.

Шилжүүлэхээр шийдвэрлэсэн нутгийн хилийн цэсийн гадна талд Эрдэнэ сумын нутагт Налайх дүүргийн Шохойн хоёр уурхай, Ар Жанчивлан болон тэр орчмын 226 өрхийн 724 хүн, 59 өвөлжөө, хаваржаа, 11.2 мянган толгой мал үлджээ.

5. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч З.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь заалт, мөн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 2 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн.

Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолын 3 дугаар заалтад БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 6 дугаар сарын 1-ний 131 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон нь нэгд “зарлигийг” гэснийг тогтоол гэж алдсан, хоёрт бүхэл бүтэн Архуст сумыг хууль бусаар татан буулгасан буруу шийдвэр болсон.

Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 3 дахь заалт болох сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон ард олноос ямар ч санал аваагүй ганц тал болох Нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр Засгийн газар Улсын Их Хуралд оруулж, туйлшруулан шийдсэн буруу тогтоол болсон.

Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоол нь газар зохион байгуулалтын журам зөрчиж хилийн цэс тогтоох комисс Засгийн газраас томилж ажиллуулаагүй, газар

зохион байгуулалтын асуудлыг Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас эрх олгосон байгууллагаар дамжуулан хэрэгжүүлээгүй зэргээр Монгол Улсын Газрын тухай хууль, Засгийн газраас баталсан газар, зохион байгуулалтын журмыг зөрчсөн. Иймд Улсын Их Хурлын 1996 оны 24 дүгээр тогтоолыг хүчингүй болгож өгнө гэдэгт гүнээ итгэж, Үндсэн хуулийн цэцэд хандаж байгааг анхааралдаа авах болов уу.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурал нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална” гэсэн заалтыг баримталсан тул Төв аймгийн Эрдэнэ сумын иргэн Г., Д. нарын гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэх асуудлыг боловсруулахдаа Монгол Улсын Газрын хууль, Монгол Улсын Засгийн газраас тогтоосон газар зохион байгуулалтын журам зөрчсөн тухай гомдол нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын асуудал биш болох нь тогтоогдов.

2. Улсын Их Хурлын 1998 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 42 дугаар тогтоолоор Төв аймгийн Архуст сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг хуучин байдлаар нь / БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 131 дүгээр зарлигаар/ тогтоосон учир иргэн Ш., Ша. нар Үндсэн хуулийн цэцэд гаргасан гомдлоосоо татгалзсан тул энэ талаар Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргах хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, мөн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хянан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 5 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 77 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай Улсын Их хурлын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн

нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, мөн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 5 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1992 оны 1 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмлэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Дээрх тохиолдолд Улсын Их Хурал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөөгүй харин хилийн цэсийг баталсан байна. Хилийн цэсийг батлахад тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг авах шаардлагыг Үндсэн хуулиар тавиагүй байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1998.06.03 № 06**

### **Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 9, 14 дүгээр зүйлийн 1-ийг зөрчсөн эсэх тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Я.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Э.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1996 оны 8 дугаар сарын 27-ны өдөр баталсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль<sup>42</sup>

- 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “...иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна”

- 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “...иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “...засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. ...ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”

42 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1996 оны № 10-д нийтлэгдсэн

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Я.-гийн мэдээллийн агуулга:

Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1-д “...төлөөлөгчдийн тоо нь гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна” гэсэн заалт нь Үндсэн хуулиар олгосон иргэний эрхийг /дээр дурдсан/ хааж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан эрх дараах байдлаар хэрэгждэг гэж би ойлгодог. Үүнд:

а/ Өөрийн итгэж, найдвар хүлээлгэж чадах хүнээ өөрөө мэдэж, чөлөөтэй, шууд сонгох, эгүүлэн татах явдал мөн;

б/ Төр засгийн болон орон нутгийн удирдлагад сонгосон байнгын төлөөлөгчтэй байж, тэдэнд санал бодлоо илэрхийлэх замаар төрийн хэрэгт оролцох ёстой;

в/ Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч болон орон нутгийн Хурал, удирдлагаа шууд сонгох;

г/ Төлөөллийн тоог тодорхой хэмжээгээр хуульчлан тогтоож байгаа нь иргэний эрх, хуулийн өмнө тэгш байх зарчмыг баталгаажуулсан хэм хэмжээ мөн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтад заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн байна. Архангай аймгийн Батцэнгэл сумын 262 иргэн нөхөн сонгууль явуулж өгөөч гэсэн хүсэлтийг удаа дараа гаргасан боловч тэдний хүсэлтийг хуулийн дээрх заалт хааж байна.

Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бол төрийн хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг, төрөөс баталсан хуулиар сонгогдож байгуулагддаг ийм л байгууллага. Төрийн дээд болон бусад байгууллагатай иргэдийг холбож байдаг ганц байгууллага юм шүү. Хэрэв төрийн биш байгууллага юм бол бүх ажиллагааг нь хуульчлалгүй бидэнд эрхийг нь өгөхгүй яасан юм бэ? Тоог нь хуулиар тогтоосон атлаа хасагдахаар нь нөхөж болдоггүйн учир юу вэ?

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Э. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Тус хуулийн үзэл баримтлал нь сонгууль явуулахдаа пропорциональ зарчмыг илүү эрхэмлэсэн тул сонгуулийн үед намын жагсаалтад багтаж байсан нэр дэвшигчдийг автоматаар нөхөн сонгох онцлогтой гэдгийг тусгайлан анхаарах нь зүйтэй бөгөөд сум бүрээс заавал тогтмол төлөөлөлтэй байна гэсэн хатуу зарчмыг аль ч хуульд мөрдлөг болгож баримталдаггүй болохыг анхааран үзэхийг хүсье.

Нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчимд тулгуурлаж, сонгогчийн идэвхтэй, идэвхгүй эрхийг хэрэгжүүлэх бололцоогоор хангагддаг. Ер нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль маань хувь тэнцүүлсэн пропорциональ системээр хийгдсэн. Түүнийг энэхүү хуулийн 17, 18, 29, 32, 35 дугаар зүйлүүд ч үүнийг баталсан. Сонгуульд оролцогч иргэн хоёр санал өгч байгаа нь үнэн. Нам, эвслийн нэрийн жагсаалтаар орон нутаг, нэгжийн төлөөлөл хангагдсан. Сонгуулийн эцсийн үр дүн намуудад өгсөн саналаар пропорциональ тогтолцооноос хамаарч байгаа юм.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль нь иргэд өөрсдийн төлөөлөгчдийг сонгох пропорциональ системд үндэслэсэн нь тогтоогдов.

2. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь заалтууд “Төрийн хэрэгт шууд оролцох / сонгогдож/ эсхүл төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах хэрэгт оролцох, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зэрэг иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн зохих заалтуудыг зөрчсөн гэж үзсэн иргэн Я.-гийн хүсэлтийг хангах үндэслэлгүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “... иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна” гэсэн заалт Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

## **“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 6 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 78 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “...Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна” гэсэн заалт Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

### **Тэмдэглэл:**

Энэ нь тухайн үеийн хууль тогтоомж боловсронгуй бус байсантай холбоотой үүссэн маргаан. Монгол Улс нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулаад удаагүй байсан үе. Энэхүү зохицуулалтын гол агуулга бол хууль тогтоогч Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэлдэхүүн нь гуравны хоёр байх тохиолдолд үйл ажиллагаагаа хэвийн явуулах бололцоотой, харин бүрэлдэхүүн нь гуравны хоёроос доош орсон тохиолдолд нөхөн сонгууль явуулж болохоор зохицуулалтыг хийсэн байна. Угтаа иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүн бүрэн байж гэмээнэ тухайн нутгийн ард иргэдийн эрх ашиг илүү хангагдах учиртай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.10.16 № 07

### Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

1. Улсын Их Хурлаас 1992 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Татварын ерөнхий хууль<sup>43</sup>

- 10 дугаар зүйлийн 6 дахь заалт “аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх”

2. Улсын Их Хурлаас 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хууль<sup>44</sup>

- 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт “...түүнд ногдуулан суутгасан татварын хэмжээг...”

- 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнд олгосон дараах орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулж дундын суутгал хийнэ”

- 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг иргэний цалин, хөдөлмөрийн хөлсөнд ногдох албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага сарын эцэст суутган авна”

- 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Аж ахуйн нэгж, байгууллага хувь хүнд олгосон дараах орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулж дундын суутгал хийнэ”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ: ... 3/ хуулиар ногдуулсан албан татвар төлөх”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулиар хүлээлгэсэн үүргийг иргэн хэн боловч өөрөө ёсчлон биелүүлэх ёстой. Гэтэл хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч иргэний албан татвар төлөх үүргийг / тодруулбал орлого болон төлөх татварын хэмжээг зөв тогтоох, хуулийн хугацаанд төсөвт шилжүүлэх зэрэг/ ажил олгогчоор гүйцэтгүүлэхээр хуульчилсан нь Үндсэн хууль

43 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 4-5-д нийтлэгдсэн

44 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны № 1-т нийтлэгдсэн



зөрчиж байгаа хэлбэр мөн. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч иргэн бусдаар татвараа тооцуулж, тушаалгаж, түүнээс үүсэх хариуцлагыг нь ажил олгогчид хуулиар үүрүүлж байхад бусад байдлаар ажил, үйлчилгээ үзүүлж байгаа, худалдаа наймаа хийж, орлого олж байгаа иргэн бүх үүргийг өөрөө биелүүлж, түүнээс үүсэх хариуцлагыг өөрөө хариуцаж байгаа нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн заалт зөрчиж байна. Иргэн хэн боловч татварын албанд бүртгэлтэй, жил бүр биечлэн тооцоо хийдэг нэгдсэн нэг журам тогтоовол дээр дурдсан заалтууд Үндсэн хуульд нийцэх болно.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван долдугаар зүйлийн 1-ийн 3-т заасан заалтуудыг зөрчсөн Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4-ийн "...түүнд ногдуулан суутгасан татварын хэмжээ..." гэсэн заалт, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 5-д "Аж ахуйн нэгж, байгууллага хувь хүнд олгосон дараах орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулж дундын суутгал хийнэ" гэсэн заалт, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д "...гэрээгээр ажилладаг иргэний цалин, хөдөлмөрийн хөлсөнд ногдох албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага сарын эцэст суутган авна" гэсэн хэсэг, мөн зүйлийн 5, 6 дахь заалтуудыг тус тус хүчингүйд тооцож өгнө үү.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т "хуулиар ногдуулсан албан татвар төлөх", Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах" гэж тус тус заасан нь бүхэлдээ албан татварын харилцааг салбар хуулиудаар тогтооно гэсэн утгатай болохыг тодорхой зааж өгснийг харуулж байгаа юм. Хүн амын орлогын татварыг өөр этгээд төлсөн гэдэг нь татварыг ногдуулан авч байгаа нэг арга юм. Татвар төлөх, ногдуулах аргачлалыг салбар хуулиудаар тодорхойлдог. Энэ гомдол бол Үндсэн хуулийн цэцийн асуудал биш. Татварын орлогыг бүрэн авах үүднээс энэ асуудал тогтоогдсон юм. Иймд иргэн Д.-гийн дурдсан татварын харилцаанууд нь бүгд хуулиар тогтоогдож, Улсын Их Хурлаар тухайн үедээ батлагдсан байх тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй юм.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 6, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 5, 10 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгийн заалтууд нь хүн амын орлогын албан татварыг ногдуулах, татвар төлүүлэх хууль зүйн механизмыг тодорхойлжээ. Албан татвар ногдуулах, татвар төлүүлэх асуудлыг хууль зүйн хүрээнд хэрхэн зохицуулах нь хууль тогтоогчийн эрх хэмжээний асуудал байх тул дээрх заалтуудыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 6, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалт, 7 дугаар зүйлийн 5, 10 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаан үргэлжилж эхэлснээс хойш 15 хоногт багтаан авч хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 116 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 6, Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5, 7 дугаар зүйлийн 5, 10 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Дундын суутгал гэдэг нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас иргэдэд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах болон хуульд заасан бусад орлогод уг орлогыг олгож буй этгээд нь татварын хууль тогтоомжид заасны дагуу татварыг нь ногдуулан суутган авч төсөвт шилжүүлэхийг ойлгодог. Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх үүргийг хуулиар хүлээсэн этгээдэд үүргээ гүйцэтгэснийх нь төлөө ямар нэг урамшуулал олгодоггүй.

Дундын суутгал нь татвар төлөгч, татварын алба хоёрын аль алиных нь ажлыг хөнгөвчилдөг татвар хураах үр дүнтэй арга хэрэгсэл юм. Татвар төлөгч өөрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хүн амын орлогын албан татвараа төлөх гэж сар бүр татварын албанд дугаарлаж зогсох нь амьдралд үнэхээр нийцэхгүй асуудал.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1998.10.16 № 08**

**Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн зарим заалт  
Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаархи  
маргааныг хянан шийдвэрлэлсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталсан Өмгөөллийн тухай хууль<sup>45</sup>

- 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Өмгөөлөгчдийн байгууллага нь өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллага бөгөөд дараах бүтэцтэй байна:

<sup>45</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 3-д нийтлэгдсэн

1/ Монголын өмгөөлөгчдийн холбоо;

2/ аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөл.

- 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэн өмгөөлөл явуулж буй хэлбэрээс үл хамааран өмгөөлөгчдийн олон нийтийн байгууллагад нэгдэнэ”

- 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “... тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулалтад орж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан Монгол Улсын иргэн өмгөөлөгчөөр ажиллаж болно. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь уул албан тушаалаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно”

- 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан, сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол Улсын иргэнд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно”

- 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Өмгөөлөгчийн хөдөлмөрийн хөлсний 6 хувийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд, 4 хувийг өмгөөлөгчийн хариуцлагын даатгалд төвлөрүүлнэ”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”

- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Д.-гийн өргөдлийн агуулга:

Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тул хүчингүй болгож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Иргэн Д.-гийн гаргасан өргөдлийн хувьд Өмгөөллийн тухай хууль нь Үндсэн хуультай зөрчилдөөгүй гэж үзэж байна. Энэ хууль бол нэлээд онцлог харилцаа зохицуулж байгаа. Төрийн тусгай алба хашиж байсан этгээдийн хувьд тусгайлсан хязгаарлалт байх нь нийтлэг зүйл. Иймд “шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь уул албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалт нь Үндсэн хуультай зөрчилдсэн гэж үзэхгүй байна.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монголын өмгөөлөх байгууллага нь төрийн зохицуулалттай мэргэжлийн өмгөөллийн эрхээ иргэн нь төрөөс авдаг зэрэг бие даасан онцлогтой тул түүний эрх зүйн зохицуулалтад ялгамжтай зүйлүүд байх нь зайлшгүй юм. Иймд иргэн Д.-гийн гомдол гаргасан Өмгөөллийн тухай Монгол Улсын хуулийн 4, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь уул албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Өргөдөл гаргагч иргэн Д. өөрийн өргөдөлд дурдсан Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулалтад орж”, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “сонгон шалгаруулалтад тэнцсэн” гэсэн заалтууд Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн өргөдлийн шаардлагаасаа татгалзсан тул дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь уул албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10, Арван зургадугаар зүйлийн 3, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулган үргэлжилж эхэлснээс хойш 15 хоногт багтаан авч хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

## **“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 117 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нь уул албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10, Арван зургадугаар зүйлийн 3, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг зөрчөөгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

## **Тэмдэглэл:**

Урьд нь эрхэлж байсан ажил, албан тушаалаас шалтгаалан зарим ажил, албан тушаалд орж болохгүй байх хугацааг тогтоосон зохицуулалт бусад хуульд ч элбэг байдаг. Энэ нь Үндсэн хуулийн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хөндөөгүй юм. Учир нь: 1/ Тухайн этгээдэд тодорхой хугацаанд хориглосноос бусад ажил, албан тушаал эрхлэх эрх, боломж нь нээлттэй байгаа; 2/ Уг этгээд нь тухайн ажил, албан тушаалыг эрхлэхдээ сүүлд гарах үр дагавар буюу хязгаарлалтыг мэдэж, хүлээн зөвшөөрсний үндсэн дээр сайн дураараа сонгон ажилладаг; 3/ Уг хязгаарлалт нь хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсний дараа арилдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1998.10.23 № 09

### Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, түүнийг үндэслэн гарсан Улсын Их Хурлын тогтоолууд Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Г., Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Э.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдөр баталсан Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль<sup>46</sup>

- 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох, улс төрийн нам болон төрийн бус байгууллагад сонгуульт ажил, албан тушаал эрхлэх, сургалт, эрдэм шинжилгээний ажил хийхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй”

- 8 дугаар зүйлийн 8.2.11 дэх заалт “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах үндсэн үүрэгтэй”

- 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын болон түүний гишүүний үндсэн үүргийг Үндсэн хуулийн Хорь, Хорин гурав, Хорин тав, Хорин ес зэрэг зүйлд тодорхой заажээ. Иймээс Улсын Их Хурлын гишүүнд бусад хуулиар эрх үүрэг олгож байгаа бол тэр нь Үндсэн хуулиар оноогдсон үүрэгт нь хохирол учруулахгүй тийм л эрх үүрэг байх ёстой нь ойлгомжтой. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарснаас болж Засгийн газар нь огцорсон мөртлөө энэхүү огцорсон явдалд хууль зүйн үүднээс буруутай хүмүүс нь дараагийн Засгийн газраа байгуулах эрхтэй мэт ёс суртахуунгүй байдал тохиолдож байна. Улсын Их Хурлын гишүүн дээрх албан тушаалуудыг хавсарч байгаагаас Засгийн газар Улсын Их Хурлын хяналтаас гарч, эрх барьж буй олонхийн дотор энэхүү хэмжээгүй эрх дархыг олж авахын төлөө эрүүл бус өрсөлдөөн гаарлаа. Энэ их эрх мэдэл, эдэлж байгаа хүндээ нэг талаас сайхан байдаг байж болох боловч нөгөө талаас оногдсон давхар давхар үүргийг биелүүлэх боломжгүй байдаг нь Улсын Их Хурлын практик дээр нотлогдсон зүйл юм. Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл төрийн эрх мэдэл ард түмнээс үүсэлтэй. Төрийн эрх мэдлийг хууль тогтоох,

46 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 4-т нийтлэгдсэн

гүйцэтгэх, шүүх гэсэн гурван хэсэгт тэнцвэртэй, харьцангуй бие даасан, ялангуяа хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл нь харилцан хяналттай байхаар хуваарилах нь зүйтэй гэж үздэг байна. Үндсэн хуулийн бүх нийтээр хэлэлцүүлсэн төсөл, Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд оруулсан төсөл, Ардын Их Хурлын анхны хэлэлцүүлгийн дүнг тусгасан төсөлд Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна, Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн заалт тусгагдсан билээ. Энэ заалтаас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон гэсэн 7 үгийг хасч бичихээр тохирсон нь эдгээр нэр дурдсан албан тушаалыг Улсын Их Хурлын гишүүн хавсарч болохыг зөвшөөрсөн утгыг агуулаагүйгээр үл барам шууд зөвшөөрөөгүй утгаар нь ийм томъёоллоор санал хурааж, уг саналыг 87 хувь нь дэмжсэн зэрэг бусад нотлох баримтуудыг Үндсэн хуулийн цэцэд гаргаж өгсөн билээ.

Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайдын буюу Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байсан бөгөөд Засгийн газар огцорсноос хойш тухайн албан тушаалтны үүрэг гүйцэтгэгчийн ажлыг хавсарч байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн заалтыг зөрчиж байна.

### 2. Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын гишүүн нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн үзэл баримтлал Үндсэн хуулийг боловсруулах бүх шатны төсөлд тусгагдсан юм. Мөн Ардын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг батлахдаа Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн зэрэг албан тушаалыг Улсын Их Хурлын гишүүний үүрэгт ямар нэг байдлаар хамааруулахыг зөвшөөрөөгүй юм. Энэ нь дараах баримтуудаар нотлогдож байна. Ардын Их Хурал дээр Улсын Бага Хурлаас оруулсан төслийн 29 дүгээр зүйлийн 1 дээр бүхэлд нь санал хураахад төслийн заалт дараах дүнтэйгээр дэмжигдсэн байна. Төслийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөвшөөрсөн 251, татгалзсан 78, түдгэлзсэн 13, бүгд 342 бөгөөд 80 хувийн дүнтэй батлагджээ. Монгол Улсын Үндсэн хуулийг 2 сар гаруй хугацаанд ардчилсан ёс журмын дагуу чөлөөтэй хэлэлцэн баталсан тул 430 тойргийг төлөөлсөн бүрэн эрхт депутатуудынхаа саналыг хуурч авсан ганц заалт Үндсэн хуульд маань байхгүй билээ.

Үндсэн хуульд заасан ёсоор Улсын Их Хурал нь хууль тогтоохоос гадна хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүрэгтэй билээ. Гэтэл Улсын Их Хурлын дахь олонхийг бүрдүүлэгч намын дарга нар болон Улсын Их Хурлын удирдлагын гарт гүйцэтгэх эрх мэдэл шууд шилжихээр сонирхлын зөрчил улам хүчтэй болж, улмаар Улсын Их Хурал хяналтын үүргээ гүйцэтгэхэд бэрхшээлтэй болдог, Засгийн газар нь огцорсон нөхцөлд огцорсон Засгийн газар нь дараагийн Засгийн газраа байгуулах үүрэг хүлээдэг ёс суртахуунгүй байдал үүсдэг.

### 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Г., Э. нарын тайлбарын агуулга:

1996 оноос эхэлсэн уг маргаантай асуудлын талаар болж өнгөрсөн зарим зүйлийг эргэн санах нь зүйтэй гэж үзэж байна. Үндсэн хуулийн цэцээс 1996 оны 7 дугаар сард Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг зөрчиж байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Цэцийн энэ дүгнэлтийг Улсын Их Хурал авч хэлэлцээд хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй гэж үзсэн. Үүний дараа Үндсэн хуулийн цэц уг асуудлыг бүрэн бүрэлдэхүүнээр дахин хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дээрх заалтууд Үндсэн хууль зөрчсөн тул хүчингүй болгосон шийдвэр гаргасныг бид мэдэж байгаа билээ. Үндсэн хуулийн цэцээс

хянаж, хуулийн эдгээр заалтуудыг хүчингүй болгосон үндэслэл нь “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдон ажиллах нь хуулиар тогтоосон үндсэн үүрэгт нь хамаарагдаагүй байна” гэсэн билээ.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэрийг хүндэтгэж “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах болох” тухай заалтыг Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэгт нь шууд хамааруулж, нэмэлт болгон оруулсан хуулийг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан юм. Энэ хууль Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн бүлгийн зөвшилцлөөр 93 хувийн саналаар батлагдсан юм. Энэ нь Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцээс өмнө гаргасан шийдвэр, түүний агуулгыг харгалзаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хууль батлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд хийсэн үйл ажиллагаа юм. Уг хуулийг Улсын Их Хурлын нийт гишүүд санал бүрэн нийлж, их өндөр хувийн саналаар баталсан нь зарим хүмүүст эргэлзээтэй санагдаж байсан. Үндсэн хуулийн холбогдох заалтад Улсын Их хурлын зүгээс хууль тогтоох эрхээ хэрэгжүүлэх замаар тайлбар хийсэн гэж ойлгож болно.

Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулахдаа Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндэслэж “Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг” гэсэн 8 дугаар зүйлд 3 дахь хэсэг болгож, мөн “Улсын Их Хурлын гишүүн дараах үндсэн үүрэгтэй.” гэсэн хоёр дахь хэсэгт нь “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах тухай” заалтыг нэмсэн юм. Цэцээс хүчингүй болгосон өмнөх хуулийн заалтууд нь Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн байж болохыг агуулгаараа хуульчилж өгсөн байсан боловч Цэц үүнийг 1996 онд хангалтгүй гэж үзсэн билээ. Ийм учраас Улсын Их Хурлаас “Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдон ажиллах” тухай заалт Улсын Их хурлын гишүүний үндсэн үүрэг гэсэн хуулийн тухайлсан зүйл, хэсэгт тусгагдаагүй байна гэж үзэж байсныг анхаарч, Үндсэн хуулийн заалт, Цэцийн шийдвэрт шууд нийцүүлэх зорилгоор Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1-д заасныг үндэслэж “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үндсэн үүрэг” нь шууд хамааруулж хуульчлан тогтоосон юм.

Иймд иргэн Д.Ламжаваас гаргасан Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, 8 дугаар зүйлийн холбогдох хэсэг, заалтууд болон Улсын Их Хурлын бусад холбогдох тогтоолууд Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэж үзсэн нь хууль зүйн үндэслэлгүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүний албан тушаал, түүний үүргийг Улсын Их Хурлын гишүүний үүрэгт хамааруулан үзэх хууль зүйн үндэслэл Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоогдохгүй байна.

2. Улсын Их Хурлын гишүүний үүрэгт Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч болохоор хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн утга агуулгатай зөрчилдсөн байна.

3. Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 8 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх талаар гаргасан Улсын Их Хурлын тогтоолууд нь уг хуулийн заалт хүчинтэй эсэхээс шууд хамаарах тул тухайн тогтоолуудын талаар тусгайлан дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно” гэсэн заалтууд ба 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байгаа “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 9 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11-д “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно” гэсэн заалтууд ба 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байгаа “Улсын Их Хурлын гишүүний хуулиар тогтоосон үүрэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил албан тушаал хавсарч болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 9 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Тэмдэглэл:**

1. Хууль тогтоогчид эрх мэдэл хуваарилах онолоос гажсан шийдвэрийг дахин гаргажээ. Энэхүү онолыг мэдэхгүйдээ, эрх мэдлийн тэнцвэрт бус байдал юунд хүргэдгийг мэдээгүйдээ ийм зохицуулалтыг хуульд оруулаад байгаа юм биш. Харин энэ нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээс гадна Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэсэн зарим гишүүдийн санаархал хуульд туссан нь энэ.

2. Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 6 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1998.11.24 № 02

**Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Г., Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Э.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ийн тайлбарын агуулга:

Парламентад бүх эрх төвлөрснөөр хүчтэй төртэй болно гэж бодвол иргэний нийгмийг биш дарангуйлагч нийгмийг санагдуулах бус уу. Засгийн газар хүчтэй байх шалгуур нь тэрээр парламент дахь олонхийн итгэл дэмжлэгийг л хүлээсэн байхад оршдог бөгөөд энэ шалгуур Үндсэн хуульд суусан байна. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилохтой холбогдож гарсан Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудыг Үндсэн хуулийн цэц энэ хуралдаанаар авч хэлэлцэж шийдвэр гаргана гэж найдаж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Г., Э. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүндэтгэж Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллаж болох тухай заалтыг хуулиар үндсэн үүрэгт нь шууд хамааруулсан юм гэжээ. Иймд Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэхгүй байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлын гишүүнийхээ үүргийг хуульчлан тогтоох эрхтэй боловч энэхүү эрх нь Үндсэн хуулийн зарчим, зүйл, агуулгаар хязгаарлагдах ёстойг үл харгалзан Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

2. Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсран ажиллаж болох тухай Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн ялгаа зааг, харилцан бие биедээ хяналт тавих Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын агуулгатай зөрчилдөж байна.

3. Иргэн Л.-ийн өргөдөлд дурдсан Улсын Их Хурлын тогтоолууд нь Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтууд хүчинтэй эсэхээс шууд хамаарах тул хамтатган эцэслэн шийдвэрлэх шаардлагагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заадтад “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдвол хавсран ажиллах”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн

Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж болно”, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт байгаа “Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр томилогдох” гэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 9 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэр нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Кабинетийн дарангуйлал нь Парламентын гишүүн нэгэн зэрэг Засгийн газрын гишүүн байх үед л тогтдог гэсэн онол байдаг. Парламентын дээд, доод танхимтай оронд дээд танхимын гишүүн нэгэн зэрэг доод танхимын гишүүн байхыг нь ч хориглосон байдаг. Ийнхүү эрх мэдэл дотор нь ийм хязгаарлалт байхад өөр эрх мэдэл рүү халтирсан үед хязгаарлалт байх нь зүйн хэрэг юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**1999.04.21 № 01**

**Гүйцэтгэх ажлын тухай Монгол Улсын хуулийн зарим  
заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т., Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан Гүйцэтгэх ажлын тухай хууль

- 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаархи төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ гүйцэтгэх ажил явуулна”

- 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Гүйцэтгэх байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд дор дурдсан ажиллагаа явуулахад прокурор бичгээр урьдчилан зөвшөөрөл өгнө”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Д.-гийн өргөдлийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “Иргэний... орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлд иргэний орон байрны халдашгүй эрхэд халдаж нууц үзлэг хийхээр болон түүний хэмжээ хязгаарыг нарийвчлан заагаагүй байхад мөн хуулийн 23 дугаар зүйлд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд иргэний орон байранд прокурорын зөвшөөрөлтэйгөөр нууц үзлэг хийж болохоор хуульчлахдаа иргэний орон байрыг барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлтэй адилтган нэг зиндаанд авч үзжээ. Ингэснээр орон байр халдашгүй байх тухай Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан. Гэтэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “өөрт байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ гүйцэтгэх ажил явуулах тухай заалт нь гүйцэтгэх байгууллага, ажилтан өөртөө мэдээлэл байсан ч, эс байсан ч, бодитой үндэслэлтэй, үндэслэлгүйг үл харгалзан өөрийн тааллаараа, санааныхаа дур зоргоор хуульд заасан үндэслэл журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч мөрдөн мөшгиж, гүйцэтгэх ажил зохиож, тагнаж болохоор хуульчилж өгсөн нь Үндсэн хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн эдгээр заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөнийг хянаж үзэхийг хүсье.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн тайлбарын агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтын дагуу Гүйцэтгэх ажлын тухай хууль гаргаж гүйцэтгэх ажил явуулах үндэслэлийг тодорхойлж өгсөн. Тухайлбал, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Тагнуул, сөрөг тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаархи төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээр явуулна” гэж заасан. Энэ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаас өмнөх шатанд зохиох гүйцэтгэх ажилд хамаарч байгаа бөгөөд эрх бүхий байгууллагууд нь гадны байгууллагын зөвшөөрөлгүйгээр холбогдох мэдээллийг үндэслэн явуулна гэсэн хэрэг юм. Дээр дурдсан мэдээлэл нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар “Үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгод чиглэсэн байх ёстой. Тэгээд ч хуульд заасан үндэслэлгүйгээр гүйцэтгэх ажил явуулж, иргэн хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон бол хуулийн хариуцлага хүлээлгэх заалт ч бий. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нууцлалын шаардлагаас холбогдох бүх хэм хэмжээг нэг бүрчлэн заах бололцоогүй бөгөөд гүйцэтгэх ажлын зааварт нууц үзлэг явуулах үндэслэл, журмыг нарийвчлан зааж өгсөн байдаг.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Нэхэмжлэгч иргэн Д.-гийн өргөдөлд дурдсан Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн иргэний орон байранд нууц үзлэг хийж болох тухай заалт, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн гүйцэтгэх ажлыг өөрт нь байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ явуулах гэсэн заалтуудад хууль зүйн хувьд боловсронгуй болгох зүйл байгаа боловч уг асуудал нь Үндсэн хуулийн цэцийн шууд харьяалан шийдвэрлэх асуудал биш болохыг дурдсугай.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Тагнуул, сөрөх тагнуул, цэргийн тагнуулын ажлыг эдгээр ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, энэ талаархи төрийн бодлогын үндсийг удирдлага болгон өөрт байгаа болон ирсэн мэдээллийг үндэслэн өөрийн үзэмжээрээ гүйцэтгэх ажил явуулна” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур, дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг, мөн Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд иргэний орон байранд прокурорын зөвшөөрөлтэйгөөр нууц үзлэг хийж болох тухай заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-д буй “...орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 1999 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 37 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Гүйцэтгэх ажлын онцлог нь хурдан, шуурхай байх явдал. Харин гүйцэтгэх ажлын хурдан, шуурхай байх бүх бололцоог хууль тогтоомжоор олгох хэрэгтэй. Гүйцэтгэх ажлыг явуулахад нэг талаас хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж болзошгүй боловч нөгөөтэйгүүр мөн л хүний эрх, эрх чөлөө, амь нас, цаашлаад Үндэсний аюулгүй байдлыг хамгаалж байгаа онцлогтой.

Гүйцэтгэх ажлыг хууль тогтоомжоор эрх олгогдоогүй байгууллага, албан тушаалтан, хувь хүн явуулахыг хориглосон байдаг бөгөөд мөн гүйцэтгэх ажилд хэрэглэгддэг тоног төхөөрөмжийг ч хуулиар эрх олгогдоогүй этгээд ашиглахыг хориглодог. Мөн эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасан үндэслэл журмаас гадуур гүйцэтгэх ажиллагаа явуулсан тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэдэг байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2000.02.16 № 01

### Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааны талаар

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн С. ;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Х.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Цагдаагийн байгууллагын тухай хууль<sup>47</sup>

- 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “ Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн”

- 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар цагдаагийн төв байгууллагыг удирдаж, үйл ажиллагааг нь шалгаж, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулна”

- 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Цагдаагийн төв байгууллага нь үйл ажиллагаагаа Засгийн газрын өмнө хариуцна”

- 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Засгийн газар цагдаагийн төв байгууллагын дүрэм, бүтцийг баталж, дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө.

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн С.-ийн мэдээллийн агуулга:

Эрүүгийн процессын энэ бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч субъектүүдийн аль нэг нь зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрийн хувьд шүүх эрх мэдлээс ангид байхаар хуульчлагдах нь гэм бурууг тогтоох ажиллагааг хэрэгжүүлэх явцад хуульд захирагдахгүй байх, энэ утгаараа шүүх шударга шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа болно. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэгтэй субъектүүдийн тогтолцоог Үндсэн хууль, бусад хуулиар зохицуулжээ. “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг боловсруулж, батлан гаргахдаа төрийн эрх мэдэл хуваарилах Үндсэн хуулийн концепцийг умартан онол арга зүйн ноцтой алдаа гаргаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагыг бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэрийн хувьд төрийн гүйцэтгэх эрх мэдлийн шууд хяналтан дор байхаар хуульчилсан нь шүүх эрх мэдэл нь гэм бурууг тогтоох эхний шатнаасаа, гүйцэтгэх эрх мэдлийн тодорхой албан тушаалтнуудын хууль бус ашиг сонирхолд нийцэж байхаас аргагүйд хүрэх, тэдний сонголт, томиллолтоор үйл ажиллагаа нь хөтлөгдөн явах, улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлийн хүрээнд хууль үйлчлэхгүй байж болох эрх зүйн сөрөг орчинг бүрдүүлж, энэ нь коррупци, авилгалын гэмт хэрэг гарч нийгмийн бүхий л хүрээг хамарч байх ёстой зүйл, жирийн үзэгдэл мэт болтлоо өргөжиж, улс орныг мөхөлд ч хүргэж болох аюулыг нүүрлэж байна.

47 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны №8-д нийтлэгдсэн

Иймд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх заалт Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-ийг зөрчиж буйг хянан үзэж шийдвэрлэж өгнө үү.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад нэхэмжлэгч С. өөрийн өргөдөл дэх “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 1, 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгтэй холбогдож гаргасан гомдлын шаардлагаасаа татгалзсан болно.

2. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт буй “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг Монгол Улсын Цагдаагийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-д буй “Засгийн газар Монгол Улсын Хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө” гэсэн заалт зөрчсөн тухай үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-т буй “Засгийн газар Монгол Улсын Хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө” хэмээх заалт Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт буй “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 35 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Засгийн газар Монгол Улсын Хууль зүйн сайдын саналыг үндэслэн цагдаагийн төв байгууллагын бүтцийг баталж, даргыг томилж, чөлөөлнө” гэсэн заалт Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Энэхүү дүгнэлт нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т заасан Цэцийн шийдвэр хууль ёсны байх шаардлагыг хангасан хэдий ч уг хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т заасан маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, гарах дүгнэлтийг нотлох баримтуудаар хангалттай баталсан нөхцөлд үндэслэлтэй байх шаардлагыг бүрэн хангаагүй болох нь ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, дүгнэлтийн үндэслэл хэт хураангуй, нотлох баримтыг шинжлэн судлах, түүнд өгсөн үнэлэлт, дүгнэлт дутмаг маргаж буй хуулийн зүйл, заалт нь Үндсэн хууль зөрчөөгүй

байна гэсэн дүгнэлтийг гаргах болсон хууль зүйн үндэслэл, нотолгоог нарийн гаргаагүй байна.

Цэцийн шийдвэрүүдээс харахад, иргэд өргөдөл, мэдээллийн шаардлагаасаа татгалзсанаас шалтгаалан Цэц тухайн асуудлаар шийдвэр гаргаагүй байх тохиолдол ажиглагддаг. Энэ дүгнэлтэд бас л энэ жишиг давтагдсан байна. Цэцийн хувьд хуулиар олгогдсон талуудын эрхийг хангах боломжийг олгох нь зүйн хэрэг ч, нэгэнт Цэцийн гишүүний тогтоолоор маргаан үүсгэж Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа өргөдөл, мэдээллийн шаардлагаасаа татгалзах “зайлшгүй” шаардлага байгаа эсэхэд иргэд анхаарлаа хандуулах учиртай.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2000.03.13 № 02**

**Шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулиудын холбогдох заалтууд, эдгээрийг хэрэгжүүлэхээр гарсан Ерөнхийлөгчийн зарлигууд Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Х., Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын нэгдүгээр орлогч Н.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр баталсан Шүүхийн тухай хууль

- 24 дүгээр зүйлийн 5 дахь заалт “Танхимын тэргүүн шүүгчийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно”

2. Улсын Их Хурлаас 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<sup>48</sup> хууль

- 251 дүгээр зүйл. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн бүрэн эрх

3. Улсын Их Хурлаас 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>49</sup>

- 4 дүгээр зүйл “... 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгч” гэснийг “Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч”; 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шүүгчийн” гэснийг “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн” гэж тус тус өөрчилсүгэй”

48 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 12-т нийтлэгдсэн

49 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 оны № 21-д нийтлэгдсэн

4. Холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхээр гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигууд

**Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”
- Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ”

**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:

а/ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан “Танхимын тэргүүн шүүгчийг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно” гэсэн заалт, мөн хуульд 1995 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуульд 251 дүгээр зүйл нэмж “Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн бүрэн эрх” гэсэн зүйл бий болгосон зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ”, Тавин нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар... Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үзэл баримтлалаар Монгол Улсын дээд шүүх нь албан тушаалын хувьд Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ гэдгийг хоёрдмол утгагүйгээр заасан. Гэтэл Шүүхийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр эрүү, иргэний хэргийг даргынхаа өмнө хариуцах албан тушаалтан бий болгож, түүнийг Ерөнхий шүүгч өөрөө санал болгон Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилохоор заасан явдал нь шүүхийн шүүн таслах ажиллагаанд шүүгчдийн бие даан ажиллах явдлыг үгүй болгож, үнэн чанартаа Ерөнхий шүүгч, түүний саналаар тавигдсан тэргүүн шүүгч гэсэн албан тушаалтнуудад эрх олгожээ. Эдгээр байдал нь албан тушаалтан, иргэд хэн боловч шүүгчдээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй, тийм оролцоогүй шударга шүүхээр шүүлгэх тухай хүний эрхийн олон улсын эрх зүйн баримт бичиг, Үндсэн хуулийн заалт зөрчигдөхөд хүрч байна. Иймээс Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 251 дүгээр зүйл, эдгээрийг хэрэгжүүлэхээр гаргасан Ерөнхийлөгчийн зарлигуудыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү.

б/ “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсгүүдэд заасан заалтууд Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна. Улсын дээд шүүхийн шүүгч...оролцогчдын гомдлоор ба өөрийн санаачилгаар эсэргүүцэл бичих эрхтэй болгожээ. Дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалт болон мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...буюу байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүхээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж шүүхийн байгууллагын албан тушаалтан болох Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч нараас Улсын дээд шүүхийн шүүгчээс хэрэг хянах үйл ажиллагаанд шууд оролцож, иргэдийн гомдол хүсэлтийн дагуу хэргийг шүүгч өөрийн итгэл үнэмшилд тулгуурлан Улсын дээд шүүхэд оруулж хэлэлцүүлэх боломжгүй болгожээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх эрх нь Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд хэргийг Улсын дээд шүүхэд хянах эсэхийг шүүхийн албан тушаалтанд олгоогүй байна. Дээрх хууль гарснаар



Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн эрх зүйн байдлыг ялгаатай болгож, эрүүгийн хэргийг хянахад Дээд шүүхийн шүүгч эсэргүүцэл бичих эрхтэй байхад, иргэний хэргийг Улсын дээд шүүхийн бүрэн эрхийн дагуу хянахад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн шүүгч бусад шүүгчдээс давуу эрх эдлэхээр тогтоосон нь буруу болжээ. Иймд дээрх хуулийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн болохыг тогтоож, эдгээр заалтыг хүчингүй болгож өгөхийг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-ийн тайлбарын агуулга:

Шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна. Энэ нь зохион байгуулалтын асуудлыг тодорхойлсон юм. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд иргэн М.-ийн гаргасан гомдлыг хүлээн зөвшөөрч байна.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Х.-гийн тайлбарын агуулга:

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд Үндсэн хууль зөрчөөгүй, Шүүхийн тухай хуулийн хувьд Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч байгаа нь зохион байгуулалтын шинжтэй зүйл учраас уг хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчөөгүй.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Иргэн М.-ийн мэдээлэлд дурдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 251 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч” гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдөж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 251 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 251 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийн Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд томилогдон оролцож байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгчид нэгдмэл нэг ойлголт, үзэл санаагаар хууль тогтоогчийн болон шийдвэр гаргагчийн байр суурийг илэрхийлэх нь Цэц маргааныг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч “хариуцагч” тал болох Улсын Их Хурлын байр суурийг ийнхүү хоёрдмол утгаар илэрхийлж байгааг Улсын Их Хурлын гэхээсээ илүүтэйгээр тухайн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн хувийн үзэл бодол хэмээн дүгнэж болмоор.

Бас нэг анхаарал татсан асуудал нь маргаан үүсгэсэн Цэцийн гишүүний тогтоолд дурдсан асуудлын заримыг Цэцийн хуралдаанаар хэлэлцэлгүй орхигдуулсан байх магадлалтай. Учир нь, дүгнэлтийн агуулга болон иргэний мэдээллийн шаардлагаас харахад М. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийг томилсон Ерөнхийлөгчийн зарлигууд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Цэцэд хандсан байх бөгөөд Цэц уг асуудлаар маргаан үүсгэж, дунд суудлын хуралдаанаараа хэлэлцсэн мэт. Гэвч Цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсэгт тэр талаар огт хөндсөнгүй. Уг нь Цэцийн шийдвэрт Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцээд тогтоосон нөхцөл байдал болон Цэцээс маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль, шийдвэрийн Үндсэн хууль зөрчсөн гэх заалт тус бүрийг тусгасан байх хуулийн шаардлага тавигддаг.

Хуулиар “танхимын тэргүүн” гэх албан тушаалтныг буй болгосон нь шүүгчийг мэргэжлийн удирдлагаар хангах, шүүн таслах ажлын чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын улмаас оруулсан зохион байгуулалтын шинжтэй зохицуулалт уу, эсхүл “шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдах, ...хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож үл болох” тухай Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байна уу гэдгийг Цэц анхаарч үзсэн бол маргааныг илүү үндэслэлтэй шийдвэрлэх боломжтой байсан болов уу.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2000.09.08 № 01

Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн  
36 дугаар тогтоолын үндэслэлийг хэлэлцэн иргэн М.-ийн өргөдлөөр  
үүссэн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

#### 1. Иргэн М.-ийн тайлбарын агуулга:

Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүний хувьд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ гэдэг нь ойлгомжтой. Үндсэн хуульд эрүү, иргэний танхимтай байх талаар ямар нэг заалт байхгүй. Иймд Улсын дээд шүүх нь эрүү, иргэний танхимтай байх хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Шүүхийн тухай хуулийн 25<sup>1</sup> дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 7-д зааснаас үзвэл танхимын тэргүүн шүүгч албан тушаалтан болчихоод байна. Иймд танхимын тэргүүн шүүгч Улсын дээд шүүхийн тэргүүн шүүгчээс давуу эрх эдлэхээр гарсан хуулийн нэмэлт заалтуудыг хүчингүйд тооцох учиртай. Би танхимтай байхыг үгүйсгэхгүй. Харин дарга нь албан тушаалтан болчихоод байна. Ерөнхийлөгч томилох шаардлагагүй. Шүүгчид өөрсдөө сонгож болох юм.

#### 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Улсын дээд шүүх нь иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн гэсэн хоёр танхимтай. Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3-т иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн танхимын чиг үүргийг тодорхой зааж өгсөн. Үүнд танхим нь: нэгд шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх; хоёрт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй болно. Танхимын тэргүүн шүүгчийн албан тушаалыг бий болгохдоо дээрх хоёр танхимын ажлыг удирдан зохицуулах, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэйгээр бий болгосон. Танхимын тэргүүн шүүгч бусад шүүгчдийн адил бүрэн эрхээ эдлэх ба шүүхийн шүүн таслах ажиллагаанд шүүгчдийн бие даан ажиллах явдлыг үгүй болгож, үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцож байгаа явдал биш юм.

#### 3. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Дээд шүүхийн ерөнхий шүүгч Г. бичгээр ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Шүүхийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шүүн таслах ажлын чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын улмаас авсан зохион байгуулалтын арга хэмжээ бөгөөд коллеги, танхимын зохион байгуулалтгүй байсан нэг жилийн хугацаанд шүүн таслах ажлын бодлого, шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажил тарамдан хариуцах эзэнгүй болоход хүрсэн юм. Хуулиар танхимын тэргүүн шүүгчид илүү эрх дарх эдлээгүй бөгөөд зохион байгуулалтын удирдлагын хувьд уг ажлыг нэг гарт төвлөрүүлсэн болно. Иймд хуулийн дээрх заалт Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй гэж үзэж байна” гэсэн байна.

### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25<sup>1</sup> дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалттай зөрчилдөж байна гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Иймд Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 36 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүлээн авах боломжтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, мөн хуулийн 25<sup>1</sup> дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү тогтоол нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран долдугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гармагцаа хүчин төгөлдөр болох боловч шууд биелэгдэх хүчинтэй биш. Энэ нь Үндсэн хууль болон процессийн бусад хуулиар Улсын Их Хуралд хууль тогтоох дээд байгууллагын хувьд баталсан хууль нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж, хүчингүй болгох эсэхээ шийдвэрлэх эрхийг олгосноор тайлбарлагдана. Цэц маргааныг хэлэлцэж дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулах, Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Цэц маргааныг дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргадаг Үндсэн хуулийн шүүх бүхий гадны бусад оронд байдаггүй энэхүү процессийн хэм хэмжээ нь хууль тогтоогч болон Цэц хоёрын харилцаан дахь онцлог шинж яриангүй мөн.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын тогтоолыг Цэц Их суудлын хуралдаанаараа хүлээн зөвшөөрсөн тохиолдол Цэцийн түүхэнд тэр бүр олон гараагүйг энд дурдах нь зүйтэй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2000.03.15 № 03**

**Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Н., Х., Б., Ч., Ж;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Г., Л., Н.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн дараах заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн эрх бүх ард түмний мэдэлд байна” гэсэн заалтыг ноцтой зөрчжээ. Энэ нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын гишүүд 1999 оны 12-р сарын 23-ны өдөр Улсын Их Хурлын дарга Г.-д өргөн барьж, мөн өдрийн маргааш нь үдээс өмнө хэлэлцэж шууд баталсан, эл асуудал энэ удаагийн чуулганы хэлэлцэх эргийн төлөвлөгөөнд огт тусгагдаагүй зэргээр нотлогдож байна.

2/ Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг илэрхийлнэ” гэж заасныг ноцтой зөрчсөн нь дараах байдлаар нотлогдож байна:

а/ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшилцлийг хийх эрх Улсын Их Хуралд суудалтай гурван намд байгаа гэж үзсэн нь өрөөсгөл юм.

б/ Өнөөгийн Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намууд нийт иргэн, улсын ашиг сонирхол, үндэсний эрх ашгийг бүрэн төлөөлж чадахгүй байгаа билээ.

3/ Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурал яаран сандран, хуйвалдааны замаар нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэг буюу иргэд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэсэн заалтыг ноцтой зөрчжээ. Улсын Их Хурлын гишүүд энэхүү нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа сонгогчдынхоо санал хүсэлтийг огт авалгүй хийснээр нотлогдоно.

4/ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг иргэд, сонгогчдод шүүн тунгаах цаг хугацааны ямар ч боломж олгохгүйгээр Улсын Их Хурал хэлэлцэж баталсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх эрхэд ноцтой халдаж зөрчжээ.

5/ Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй саналаар батална” гэж заасныг зөрчжээ. Энэ удаагийн Улсын Их Хурал хичнээн гишүүнтэй болсон, хэдэн гишүүн санал хураалтад оролцсоноос үзэхэд тодорхой болж байгаа юм.

6/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлд “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэж заажээ. Гэтэл Улсын Их Хурал энэ удаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэц саналаа гаргах эрхийг зөрчжээ. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөлгүй өөрчлөлт оруулсан

явдал Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” гэж заасныг зөрчсөн хэрэг юм.

7/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчжээ. Энэ нь Үндсэн хуулийн цэцээс санал аваагүй, Ерөнхийлөгчтэй зөвшилцөөгүй, сонгогчид, олон нийтээр хэлэлцүүлээгүй зэргээр нотлогдож байна.

8/ Иргэд болон улс төрийн бусад намын саналыг аваагүй нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна” гэж заасан эрхийг зөрчсөн байна.

9/ Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн утга агуулгаас үзэхэд “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгын талаархи саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэж заасан байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа учраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрхтэй болох нь тодорхой байна.

10/ Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа Үндсэн хуулийн Жаранесдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй саналаар батална” гэж заасныг зөрчсөн байна. Үүнээс үзэхэд Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ирцийн бүрдэл хүрээгүй байхад Улсын Их Хурал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж баталсан байна.

11/ Нэмэлт, өөрчлөлт бүхэлдээ Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл /Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална/, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг /Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална/ зөрчжээ. Энэ нь:

а/ Улсын Их Хурлын чуулганы ирцийг бууруулсан өөрчлөлт Үндсэн хуульд оруулснаар Улсын Их Хурлаас гаргах шийдвэрт нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн тусгахад сөргөөр нөлөөлөх эрх зүйн үндсийг тавьжээ;

б/ нэмэлт, өөрчлөлтөөр 50-иас доошгүй хоног хуралдах болсон нь Улсын Их Хурлын хууль тогтоох болон төлөөлөгчдийн байгууллагын шинж нь алдагдах боллоо;

в/ 45 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэж чадахгүй нөхцөлд Улсын Их Хурлыг тарааж байхаар тогтсон нь төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлыг тогтворгүй болгож, улс төрийн аливаа сөрөг хүчин буюу төр засгийн эрх мэдлийг улайран булаалдагч улс төрийн хүчнүүд сонгуулийн үр дүнг бусниулахад ашиглах сиймхий буй болгожээ;

12/ Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур үндэс нь тус хуулийн Гуравдугаар зүйл бүлгээс үзэхэд төрийн эрх мэдлийг хуваарилсанд оршино. Гэтэл эл үзэл баримтлалаас ухарч, хууль тогтоох ба гүйцэтгэх эрх мэдлийг нэгтгэх алхам Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан өөрчлөн найруулгаар буй болж байна. Энэ нь утгаа Үндсэн хуулийн Хорь, Гучин наймдугаар зүйлийн заалт зөрчигдснийг харуулж байна.

13/ Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг нууцаар саналаа гаргаж сонгох тухай нийтлэг үндэслэлтэй Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1, Хорин зургадугаар зүйлийн 6 дахь хэсэгт оруулсан өөрчлөлт нь /нууц санал хураалтыг ил болгосон/ зөрчилдөж байгаа юм.

Түүнчлэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчжээ. Энэ нь бас Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн төдийгүй Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага мөн гэсэн Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд харшилж байна.

2. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь хууль санаачлагчдын хувьд санаачилгаа Үндсэн хуулийн цэцэд уламжлахаар хязгаарлагдаж, Улсын Их Хуралд оруулах нь Үндсэн хуулийн цэцийн эрхэд хамаарсан эрх мэдэл юм. Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн эрхэд халдсан нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн хэрэг юм. Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтыг авч үзвэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хууль санаачлагчдын санаачилга гаргах эрх мэдлийг хөндөөгүй бөгөөд харин хууль санаачлагчдын саналыг Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх эрхийг Үндсэн хуулийг чандлан сахиулагч Үндсэн хуулийн цэцэд олгосон байна.

3. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль санаачлах, батлах эрхийг Улсын Их Хурлын гишүүдэд олгосон бөгөөд харин өөрчлөлтийн саналыг өргөн барих эрхийг Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд олгожээ. Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын ба дэгийн тухай хуулийг зөрчиж Үндсэн хуульдаа дур зоргоороо нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалт болон Далдугаар зүйлийн 1 дэх заалттай зөрчилдөж байна.

4. Иргэн Ч.-гийн мэдээллийн агуулга:

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд хугацааны хязгаарлалт /5 хоног, 7 хоног/ тогтоох бусармаг аргаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн зарчмыг төгс бус эрх болгож өөрчилжээ. Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүх талыг хугацааны хязгаарлалтад оруулж 5 ба 7 хоног өнгөрмөгц түүний эрхийг өөр субъект шилжүүлэн авч эдлэхээр хуульчилжээ. Улсын Их Хурлын чуулах хугацааг 50 өдөр болгосон нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол... нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлана” гэсэн заалтад харшилж байна.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд “... Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ” гэсэн нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1, 1 дүгээр зүйлийн 2-т харшлах юм. Нам, эвслийн бүлэг бүр дэд даргатай байхаар хийсэн өөрчлөлт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 9, 10-ыг зөрчжээ.

Үндсэн хуулийн “... түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах” гэсэн Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд хамаарах чухал заалтыг мөн орхигдуулжээ. Энэ нь төрийн дээд өндөрлөгүүдийн харилцан хяналт тавих бүтэн системийн чухал нэгэн шинжийг тасдаж, төрийн машинд тавих шаардлага, хяналтын мөрөөр авах арга хэмжээг үгүйсгэж байна.

Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 2-т өмнө нь байсан “... түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах” гэсэн онц чухал хэсгийг мөн дагалдуулан хасаж, чингэснээр Ерөнхий сайдыг томилох, мөн Засгийн газрыг огцруулах тухай санал оруулах Ерөнхийлөгчийн эрхийг хязгаарлажээ. Ингэснээр Улсын Их Хурлын гишүүн хүн нэгэн намын заавар, удирдамжийг ягштал сахигч, намын удирдлагын албат, хараат хүн болж хувирч байна. Гэтэл Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан. Гэтэл саналыг илээр гаргуулах болсон нь Үндсэн хуулийн гол чухал зарчим, заалтын агуулгад харшилж, зөрчиж байна.

Улсын Их Хурлын дарга, дэд даргыг саналаа илээр гаргаж сонгох, дэд даргыг зөвхөн нам, эвслийн бүлэг тус бүрээс сонгох тухай заасан нь намын бүлэгт ороогүй гишүүдийн хувьд хүний эрхийг зөрчсөн шийдэл болжээ. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг... үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж, мөн Арван зургадугаар зүйлийн 9-д “Монгол Улсын иргэн... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэж заасныг зөрчжээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга бүрийг нягтлан үзээд өөрчлөх шаардлага байна гэж тогтвол дэлгэрэнгүй үндэслэл бүхий саналаа Улсын Их Хуралд зөвхөн Цэц л өргөн мэдүүлэх учиртай. Үндсэн хуульд яг ингэж зааж, ийм механизмыг суулгаж өгсөн атал түүнийг Улсын Их Хурлын хууль санаачилсан гэгдэх гишүүд ноцтой зөрчжээ.

5. Иргэн О.гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэжээ. Гэтэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэхдээ тойргийн сонгогчидтойгоо уулзаж тэдний санаа бодлыг сонсоогүй нь дээрх заалтыг зөрчжээ. Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1-д: “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэж заасныг зөрчсөн гэж үзэж байна.

6. Иргэн Ж.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга гаргаад Улсын Их Хуралд оруулахын оронд Үндсэн хуулийн цэцэд өгч хянуулах журам тогтоожээ. Ийнхүү Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгайлан авч үзэж, Үндсэн хуулиар хууль санаачлагчдын эрх мэдлийг тодорхой хэмжээгээр хязгаарлан тодорхойлжээ гэж үзэж болно. Гэтэл Улсын Их Хурал “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт”-ийг хууль санаачлагчдын шууд оруулснаар авч хэлэлцэн баталсан байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно” гэж заажээ. Улсын Их Хурал ард нийтийн санал асуулга явуулах асуудлыг шийдээгүй байж уг нэмэлт, өөрчлөлтийг батлан гаргасан нь Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж үзэх үндэстэй байна.

7. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч нарын тайлбарын агуулга:

Иргэдийн мэдээллээс үзэхэд “Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн” гэх маргаан нь анхаарал татахуйц, бусад нь Цэцийн харьяалалд үл хамаарах асуудал гэж үзэж зөвхөн Цэцэд харьяалагдах асуудлаар тайлбар өгөх нь зүйтэй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтын талаар дараах тайлбарыг өгч байна.

а/ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гагцхүү хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд түүнийг Улсын Их Хурал ямар ч дамжлагагүйгээр шууд хүлээн авч хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

б/ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Үндсэн хуулийн цэц бие даан, тэгэхдээ санаачлагчийн санал авахгүйгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ саналыг хэлэлцэх эсэх нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байхаар Үндсэн хуульд заажээ. Иймд хууль санаачлах эрх бүхий санаачлагчийн



Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санаачилсан төслийг урьдчилан хүлээн авах, хэлэлцэх, уг төслийн талаар санал дүгнэлт гаргах, түүнийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зохистой эсэхийг шийдвэрлэх эрхийг Цэцэд Үндсэн хуулиар олгоогүй байна.

Дээр дурдсан баримт үндэслэлд тулгуурлан Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг Үндсэн хуулийн цэцэд оруулж байна.

**8. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н.-гийн тайлбарын агуулга:**

Санаачилсан бол дамжлагагүйгээр, өөрөөр хэлбэл Цэцээр оруулахгүйгээр шууд Их Хурал аваад хэлэлцэх эрхтэй, тэр санал гэдэг нь шууд Цэцэд хамааралтай заалт, Цэц хуулийн маргааныг хэлэлцэх явцад Үндсэн хуулийн дотор зөрчил байна, ийм асуудлыг ингэж цэгцэл, ингэж өөрчил гэх юм бол тэр тухай санал боловсруулан Улсын Их Хуралд шууд оруулна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн нэг хэсэг, энэ нь Үндсэн хуулийн хяналт тавих харьяаллын асуудал биш юм. Хууль санаачлах гэдэг бол заавал хэлэлцэх үүргийг хууль тогтоох байгууллагад бий болгодог ийм төсөл, хуулийн санал гэдэг бол ердийн хуулиудын хувьд хууль санаачлагчаар дамжуулж, Улсын Их Хуралд хууль санаачлагдсан хэлбэршил рүү орж байж хэлэлцдэг зүйл. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн санал нь харин Цэцийн зүгээс шууд Улсын Их Хуралд өргөн баригдахаар ингэж тогтоогдсон байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх заалтад нийцээгүй байна.

2. Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн цэцэд олгоогүй байна.

3. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жаран наймдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэн иргэн Н., Х., Б., Ч., О., Ж. нарын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жаран наймдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгээс бусад зүйл, заалтын талаар иргэдээс гаргасан гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.

3. Энэ дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногт багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 3 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын 2000 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд чуулганы уг хуралдаанд Цэцийн гишүүн А. оролцож Цэцийн дүгнэлтийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүд санал бодлоо илэрхийлсэн билээ.

Улсын Их Хурлаар уг асуудлыг хэлэлцэх явцад Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хууль, Цэцийн тухай болон Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан өөрийн бүрэн эрхэд үл хамаарах асуудлаар дүгнэлт гаргасан тул түүний 3 дугаар дүгнэлтийн талаар хүлээн зөвшөөрөх, зөвшөөрөхгүй байх тухай Улсын Их Хурлын ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ямар ч эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй гэж Улсын Их Хурал үзсэн байна.

2. Нэр бүхий иргэдээс гаргасан мэдээлэлд “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” гэх баримт бичигт тусгагдсан заалт бүрээр, тэдгээрийн агуулга нь Үндсэн хуулийн суурь зарчимтай зөрчилдсөн, мөн төрийн эрх мэдлийн хуваарилалтыг сарниулсан зэрэг олон үндэслэлийг тоочсон ч Цэц маргааныг хянан хэлэлцэхдээ нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг бус гагцхүү Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа процессийн алдаа гаргасан эсэхийг л голлон нягталж дүгнэлт гаргасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг хэрхэн ойлгох талаар хууль тогтоогчдын болон Цэцэд мэдээлэл гаргасан иргэдийн үзэл бодол, байр суурийг энэхүү дүгнэлтээс тодорхой харж, мөн харьцуулж ч болно. Хамгийн гол нь Цэц маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хуулийн дээрх заалтыг нэг мөр хэрхэн ойлгох талаар онолын тайлбарыг гаргасан болохыг л анхаарах ёстой. Үндсэн хуулийн хэм хэмжээ тодорхой байх эсэх нь түүний бичвэрийн томъёолол, зорилго, чиг үүргээс ихээхэн хамааралтай.

Нөгөө талаар Үндсэн хуулийг аливаа нэг нам, улс төрийн хүчин, түүний бодлогод хамааруулж биш, зөвхөн хууль зүйн байр сууриас тайлбарлах нь тухай хэм хэмжээ, заалтын туга санааг зөв тодорхой гаргах үндэс болно.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2000.11.29 № 02

### Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Ч., Ж.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

##### 1. Иргэн Ж.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг шалгах, хэлэлцэх явцад хуулийн ямар ч заалт зөрчөөгүй өөрийн бүрэн эрхээ л хэрэгжүүлсэн. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн олон заалтыг зөрчсөн болох нь тал бүрээсээ батлагдаж байгаа. Энэ тухай би өргөдөлдөө тодорхой хэлсэн. Харин нэмж хэлэхэд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалыг олон талаар зөрчиж байна. Улсын Их Хурал Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцэх өөрчлөлтийг цаашид ч хийх эрхгүй гэдгийг хэлэх байна.

##### 2. Иргэн Б.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах, дүгнэлт гаргах ямар ч эрх Үндсэн хуулийн цэцэд байхгүй мэт ярьж байгаа нь ямар ч үндэслэлгүй юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэж зааснаар батлагдаж байна. Миний бие Үндсэн хуулийн цэц хууль зөрчсөн гэдгийг олж харахгүй байна. Харин Улсын Их Хурал Үндсэн хууль, бусад хуулийг зөрчиж байгааг олон зүйл дээр харж байна.

##### 3. Иргэн Ч.-гийн тайлбарын агуулга:

Би Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж 8 зүйлээр анх гомдол гаргасан. Миний энэ гомдлын агуулга өөрчлөгдөөгүй байгаа. Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийнхаа үзэл санаанд буцаж орсон ухралтын шинжтэй байна. Эл Үндсэн хуульд “Монгол Ардын Хувьсгалт Нам бол төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч мөн” гэсэн заалт байсныг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд яг үгээрээ ороогүй ч утга санаагаараа үндсэндээ тусгагдсан гэж бүрэн хэлж болохоор байна. Үндсэн хуулийн энэ өөрчлөлт бол үндсэндээ ухралтын шинжтэй өөрчлөлт болсон байна.

#### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

1. Монгол Улсын Их Хурал 1999 оны 12 дугаар сарын 24-нд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх заалтад нийцээгүй байна.

2. Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн Жаран наймдугаар зүйлийн 1 дэх заалтыг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн Цэцэд олгоогүй байна.

3. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жаран наймдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэн иргэн Н., Х., Б., Ч., О., Ж. нарын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул Улсын Их Хурлын 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосугай.

2. 1992 оны 1 дүгээр сарын 13-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн бүх заалт хүчинтэй болохыг дурдсугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн энэхүү шийдвэр нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хуульд заасан хугацаанд хэлэлцэхгүй, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг “гацаах”, Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн хэрнээ түүнийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар тогтоол гаргахгүй протокол үйлдэх зэргээр хууль тогтоогч хуулиа умартаж өөрсдийн явцуу эрх ашгийн төлөө Цэцийн нэр хүндэд халдах, Цэцийн дарга, гишүүдийг гутаан доромжлох зэрэг шуудхан хэлэхэд увайгүй гэмээр үйлдлийг Улсын Их Хурлын зарим гишүүдийн зүгээс гаргаж байсан.

Миний бие Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд танилцуулж, улмаар гишүүдэд “байцаагдаж” байсны хувьд тухайн үеийн уур амьсгалыг одоо ч сайн санаж байна. Нийгэм тэр чигээрээ Цэцийн шийдвэрийг анхааралтай чагнаж хүлээж байсан тэр халуухан үед Цэцийн бүрэлдэхүүн Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах хүндтэй, хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлсэн болохыг дурдууштай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2000.05.11 № 04

### Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 176, 2000 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа эсэхийг хянан хэлэлцсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ч.;  
Монгол Улсын Засгийн газар - итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцоогүй.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, шийдвэр:

1. “Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх туршилтын тухай” Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 176 дугаар тогтоол
2. “Туршилтын хугацааг сунгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 22 дугаар тогтоол
3. “Туршилтын хугацаанд мөрдөх цалингийн сүлжээ батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 23 дугаар тогтоол

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”
- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна”
- Дөчин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана”
- Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Ч.-гийн мэдээллийн агуулга:  
Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 176 дугаар тогтоолын 1, 3, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн “а”, “б” заалт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг илт зөрчсөн байна. Тухайлбал, Засгийн газрын 1999 оны 176 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлээр “Батлагдсан төсвийнхөө зардлын зүйл, ангийг... шилжүүлэн зарцуулж байх” эрхийг Монгол Улсын бүх төсөвт байгууллагаас төсөв, санхүүгийн болон шийдвэр гаргах эрх мэдэлд ойрхон байдаг зөвхөн хоёрхон байгууллага, Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт олгож, тэрчлэн мөн тогтоолын 5 дугаар зүйлийн “а”-д

“Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сар бүрийн санхүүжилтийг хагас сар тутамд жилийн нийт төсвийн 1/24-тэй тэнцэх хэмжээгээр дүнгээр нь бодож олгож байх”, мөн зүйлийн “б”-д Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт “...төсвийн хэмнэлтийг өөрт нь бүрэн үлдээж байхын зэрэгцээ хэмнэлт гаргасныг нь дараа оны төсвийг бууруулах үндэслэл болгохгүй байх” онцгой эрх эдлүүлэхийг Сангийн сайдад үүрэг болгосон байна. Бүх төсөвт байгууллагаас хоёрхон байгууллагыг сонгон авч төсөв захиран зарцуулах хэмжээлшгүй их эрх мэдэл олгосон нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг зөрчиж байгаагийн нэг баталгаа мөн.

Засгийн газрын 1999 оны 176 дугаар тогтоолын 3 дугаар зүйлээр Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4 болон мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1, 2, 3, 4, мөн зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу тогтоож, улс орон даяар мөрдөгдөж байсан “Төрийн албан хаагчдад нэмэгдэл олгох журам батлах тухай” Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5 дугаар хавсралтад заасны дагуу олгох нэмэгдлүүдийн хэмжээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамны аппаратад ажиллаж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад “О” байхаар, мөн тогтоолын 4 дүгээр зүйл, 2000 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлээр Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 4, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 1, 2, 3, 4, мөн зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу тогтоож, улс орон даяар мөрдөж байгаа “Төрийн албан хаагчдын цалингийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 1999 оны 154 дүгээр тогтоолыг Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамааруулахгүй байхаар тус тус тогтоосон нь Үндсэн хуулиар олгосон “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах” үндсэн бүрэн эрхээ Засгийн газар хэрэгжүүлэхээ умартаж, Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасныг зөрчиж байна.

Засгийн газрын 1999 оны 176 дугаар тогтоол болон 2000 оны 23 дугаар тогтоол нь төрийн жинхэнэ албан хаагчийн “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн өргөсөн тангарагтай зөрчилдөж, тэдэнд хууль бус шийдвэрийг биелүүлэх явдлыг тулгаж байгаагаараа Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж байна.

Төрийн албаны тухай хуулиар тогтоосон төрийн албан хаагчийн зарим ажиллах нөхцөл баталгааг Засгийн газар өөрийн тогтоолоор зохицуулах оролдлого хийснээр Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт буй “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгааг хуулиар тогтооно” гэсэн заалтыг зөрчиж байна. Тэрчлэн Засгийн газрын 2000 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар зүйлээр “...сарын цалингийн 60 хүртэл хувьтай тэнцэх урамшуулалт цалин олгох...” гэсэн ямар нэгэн хуулиар зохицуулагдаагүй эрхийг Засгийн газар дур мэдэн өөртөө олгосон байна.

Засгийн газар нь хуулиар тогтоосон эрх мэдлээ хэтрүүлж, хууль зөрчин хуулиас илүү “хүчтэй” тогтоол гаргаснаараа хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү өөртөө хадгалдаг төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын эрх мэдэлд шууд халдсан байна гэж үзэх үндэслэлтэй байна.

## 2. Засгийн газраас бичгээр ирүүлсэн тайлбарын агуулга:

“Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх туршилтын тухай” Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 176 дугаар тогтоол нь Сангийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт туршилт хэрэгжүүлэх хугацаанд батлагдсан төсвийнхөө зардлын зүйл ангийг байгууллагынхаа үйл ажиллагааны зориулалтаар шилжүүлэн зарцуулж байх эрхийг олгосон бөгөөд энэхүү тогтоол болон “Туршилтын хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2000 оны 22, “Туршилтын хугацаанд мөрдөх

цалингийн сүлжээ батлах тухай” Засгийн газрын 2000 оны 23 дугаар тогтоолууд нь Улсын Их Хурлаас баталсан дээрх хуультай зөрчилдөөгүй тул Засгийн газар Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг Засгийн газар тогтооно” гэсэн бөгөөд уг зүйлийн 7, 8 дахь хэсэгт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно” гэж заасан байна. Иймээс 1999 оны 176 дугаар тогтоолоор туршилт хэрэгжиж байгаа байгууллагын хувьд Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан дээрх нэмэгдлүүдийн хэмжээг “0” байхаар тогтоосон, 2000 оны 23 дугаар тогтоолоор туршилтын хугацаанд эдгээр байгууллагад мөрдөх цалингийн сүлжээг баталсан нь Засгийн газар асуудлыг өөрийн бүрэн эрхийн хэмжээнд шийдвэрлэсэн юм.

“Засаглалын шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан бөгөөд энэхүү гэрээг Улсын Их Хурлаас соёрхон баталсан болно. Уг гэрээний дагуу авах зээлийн хөрөнгийг төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгох, үр ашгийг нь дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулах юм. Энэхүү гэрээг соёрхон баталсан нь төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой арга хэмжээг Улсын Их Хурлаас дэмжиж байгааг нотолж байгаа бөгөөд уг гэрээний дагуу зарим байгууллага, тухайлбал, Төрийн захиргааны албаны зөвлөл, Үндэсний статистикийн газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн хянан шалгах хороо, Үндэсний татварын ерөнхий газар Азийн хөгжлийн банкнаас нийт 5 сая ам.долларын зээл авч төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр туршилт хэрэгжүүлж эхлэх гэж байна.

Олон улсын санхүүгийн байгууллагаас ямар нэгэн зээл авалгүйгээр Сангийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь үргүй зардлыг хэмнэх, өндөр өртөгтэй үйлчилгээнээс татгалзах зэрэг замаар өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд ажиллагчдынхаа цалинг туршилтын хугацаанд нэмсэн нь Үндсэн хууль зөрчсөн асуудал биш бөгөөд энэ талаар гарсан Засгийн газрын шийдвэрүүд Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдаагүй гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9, 12 дугаар зүйлд Засгийн газар нь иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч, төрийн албаны ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үүрэгтэй болохыг тус тус заасан болно. Засгийн газрын 1999 оны 176 дугаар тогтоолын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь нэмэлт хөрөнгө гаргахгүйгээр төсвийн сахилгыг дээшлүүлж, зардлыг хэмнэх замаар төрийн албан хаагчдын амьдралын баталгааг сайжруулах шат дараалсан ажлын эхлэл юм. Монгол Улсын Засгийн газар энэхүү туршилттай холбоотой асуудлыг 2000 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд амжилттай болсон гэж үзэн түүнийг улсын хэмжээнд туршин хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд үүнтэй холбоотой хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болно. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр иргэдийн орлогыг нэмэгдүүлэн аж амьдралыг нь дээшлүүлэх бололцоотой болох юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор 1999 оны 10 дугаар сарын 27-нд “Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх туршилтын тухай” 176 дугаар тогтоол, 2000 оны 2 дугаар сарын 8-нд “Туршилтын хугацааг сунгах тухай” 22 дугаар тогтоол, “Туршилтын хугацаанд мөрдөх цалингийн сүлжээ батлах тухай” 23 дугаар тогтоолыг туршилтын тодорхой хугацаа заан баталжээ.

2. Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 176, 2000 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 22, 23 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1999 оны “Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх туршилтын тухай” 176, 2000 оны “Туршилтын хугацааг сунгах тухай” 22, “Туршилтын хугацаанд мөрдөх цалингийн сүлжээ батлах тухай” 23 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин зургадугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Цэцийн хуралдаанд Засгийн газраас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцоогүй нь процессийн зарим ажиллагаа тухайлбал, талууд мэтгэлцэх, талуудын шаардлага, татгалзал, хариу тайлбараас Цэцийн бүрэлдэхүүн асуух, тодруулга авах боломжийг хязгаарласан. Энэ нь процессийн оролцогчид болон маргааныг хянан хэлэлцэж байгаа Цэцийн бүрэлдэхүүнд эерэг гэхээсээ илүүтэйгээр сөрөг үр дагаврыг бий болгодог.

Тухайн шийдвэр гаргасан субъектийн байр суурь зөвхөн бичгээр тайлбар өгснөөр тодорхойлогдох бус, харин ч Цэцийн хуралдаанд биечлэн оролцож аман тайлбар гаргаж байж гэмээ нь сая өргөдөл, мэдээлэл гаргасан иргэд, маргааныг хэлэлцэж байгаа Цэцийн бүрэлдэхүүнд илүү тодорхой, илүү шийдвэр гаргахад дөхөмтэй болох учиртай.

Энэ маргааны хувьд Засгийн газраас ирүүлсэн тайлбарт Үндсэн хууль зөрчсөн гэх тогтоолуудыг “туршилтын тодорхой хугацаа зааж” баталсан, цаашлаад төрийн албан хаагчдын амьдралын баталгааг хангах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй шат дараатай арга хэмжээ мэтээр тогтоолоо “хамгаалсан” байр суурь илтэд туссан. Цэц ч дээрх үндэслэлийг иш болгон дүгнэлтээ гаргасан байна. Уг нь Засгийн газар тэдгээр тогтоолыг батлахдаа Улсын Их Хурлын хууль тогтоох онцгой бүрэн эрхэд халдсан эсэх, хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлсэн эсэхэд Цэц тодорхой дүгнэлт гаргасан бол илүү хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргах байсан.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2001.03.23 № 01

### Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О.

#### Үндсэн хуулийн зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

- Улсын Их Хурлын 1993 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн “Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь заалтыг тайлбарлах тухай” 27 дугаар тогтоол<sup>50</sup>
- Улсын Их Хурлын 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн “Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг тайлбарлах” тухай 10 дугаар тогтоол<sup>51</sup>

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Хоринтавдугаар зүйл 1 дэх хэсгийн 1 дэх заалт “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”
- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”
- Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”
- Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах”
- Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”
- Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:  
Монгол Улсын Үндсэн хууль батлагдснаас хойш өнөөдрийг хүртэл хугацаанд Улсын Их Хурал, Үндсэн хуульд хоёр удаа тогтоол гарган тайлбар хийсэн билээ.

а/ Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь заалтыг тайлбарлах тухай Улсын Их Хурлын 1993 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 27 дугаар тогтоолд:

1”... сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан... “ гэдгийг Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураах өдрөөс өмнөх хуанлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй 6 сараас дээш хугацаагаар гадаад улсад оршин суугаагүй гэж ойлгоно.

50 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны №2-д нийтлэгдсэн

51 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2000 оны №29-д нийтлэгдсэн

2. "... Монгол Улсын уугуул иргэн .." гэж Монгол Улсын харьяат эцэг, эхээс төрж, түүнээс хойш Монгол Улсын харьяат хэвээр байгаа хүнийг ойлгоно".

б/ Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг тайлбарлах тухай Улсын Их Хурлын 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолд:

"1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийг:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно" гэж заасныг Үндсэн хуулийн цэц эдгээр асуудлаар маргааныг эцэслэн хянан шийдвэрлэж тогтоол гаргамагц зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно гэж ойлгоно;

2/ "Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай холбогдох хууль, зарлиг, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуулийн цэцийн тогтоол гартал хүчин төгөлдөр үйлчилнэ гэж ойлгоно" гэсэн нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Дөчин долдугаар зүйлийн 1, 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Улсын Их Хурал ийм байдлаар Үндсэн хуульд тайлбар хийж байгаа нь уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран Үндсэн хуулийн дээрх заалтуудыг зөрчиж байна.

2. Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

Улсын Их Хурал Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийж байгаа нь (уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран) өргөдөлд иш татсан Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудаас гадна, Үндсэн хуулиар тодорхойлсон Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн тухай Хорин тавдугаар зүйлийг зөрчиж, эрх мэдлээ хэтрүүлж байгааг нотлон тайлбарлая:

Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх тухай асуудал Үндсэн хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх явцад хууль тогтоогчдын анхаарлыг татсаар ирсэн. Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрхийг Цэцэд олгохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн төв эрчимтэй зөвлөсөн боловч тэр үеийн парламент уг эрхийг Цэцэд олгоогүй, мөн бусад этгээдэд олгоогүй түүхтэй. Энэ нь нэг талаас нэгэнт байнгын ажиллагаатай парламенттай болсон тул шаардлагатай үед хуулийн аргаар шийдвэрлэх бүрэн боломжтой болсныг тооцсон, нөгөө талаас Үндсэн хуулийн шүүх болох Цэц гэгч энэ шинэ этгээдэд албан ёсны тайлбар хийх эрхийг олгохоос болгоомжилсонтой холбоотой байх. Үндсэн хуульдаа албан ёсны тайлбар хийхийг зөвшөөрдөггүй улс бол ганц Монгол биш. Австри зэрэг нэлээд улс байдаг юм байна. Улсын Их Хурал Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийж байгаа нь түүнд олгогдоогүй бөгөөд хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх үүднээс олгогдох ёсгүй эрхийг эдэлж байна. Тайлбарын үлдсэн хэсэгт бүрэн эрхээ ийнхүү хэтрүүлсэн явдал нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчихөд хүргэсэн гэдгийг нотлох болно.

"Хувь хүн хуулиар хориглоогүй зүйлийг, төрийн байгууллага хуулиар зөвшөөрсөн зүйлийг хийж болно" гэсэн гүнзгий агуулгатай эрх зүйн зарчим байдаг. Энэ зарчим нь нэг талаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн, нөгөө талаас төрийн бүрэн эрхийг хязгаарлахад чиглэсэн байдаг. Үндсэн хууль болон бусад хуулийг хийсэн техник ч энэ зарчимд нийцэж байх ёстой байдаг. Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхтэй

гэж Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заажээ. Энэ нь хуулийн албан ёсны тайлбарт хамаарах Үндсэн хуулийн цорын ганц ил заалт юм. Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг ямар ч этгээдэд олгоогүй байхад Үндсэн хуулийн албан ёсны тайлбар гарч байгаа нь уг тайлбар Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг, улмаар “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна.

Парламент Үндсэн хуулийг албан ёсоор тайлбарлах нь ямар муу үр дагаварт хүргэж болохыг Улсын Их Хурлын 2000 оны 10 дугаар тогтоолын жишээнээс харж болно. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч асуудлыг санаачлан хэлэлцэж болохыг заагаад түүний онцгой бүрэн эрхийг дэлгэрэнгүй тооцсон бөгөөд энд Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийхийг зөвшөөрсөн заалт үгүй байна. Энэ нь Үндсэн хууль бол бусад хуульд албан ёсны тайлбар хийх бүрэн эрхийг өгдөг юм бол Үндсэн хуулийн шүүх болох Цэц буюу Улсын дээд шүүхээс өөр этгээдэд өгөх ёсгүй гэсэн Үндсэн хуулийн төрийн бүрэн эрхийг хуваарилах зарчмаас урган гарч буй зүй ёсны үр дагавар юм. Ийнхүү Үндсэн хуулийн албан ёсны дээр дурдсан хоёр тайлбар нь Үндсэн хуулийн Далдугаар зүйл болон Хорин тавдугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчиж байна.

### 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т “Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхтэй” гэсэн заалт нь Улсын дээд шүүхэд Үндсэн хууль тайлбарлах эрх олгоогүй болохыг тодорхойлж байна. Нөгөө талаас хэдийгээр бусад хуулийн талаар тайлбар гаргах эрхийг Улсын дээд шүүхэд өгсөн ч гэсэн тэдгээр хуулийн талаар ч шаардлагатай бол Улсын Их Хурал өөрөө тайлбарыг гаргах эрхээ хадгалж үлдэнэ.

Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” гэсэн заалтыг нэхэмжлэлд иш татаж, Үндсэн хуулийн энэ заалт зөрчигдөж байгаа гэсэн нь ойлгомжгүй, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих үүрэгтэй энэ байгууллагын үүргийг тов тодорхой заасан бөгөөд энэ заалтыг Улсын Их Хурал Үндсэн хуулийн тайлбар гаргасан асуудалтай шууд холбож үзэх үндэсгүй.

Улсын Их Хурлаас тогтоолын хэлбэрээр гаргасан тайлбар нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Цэц өнөөдөр шүүн хэлэлцэж байгаа нь үүргээ гүйцэтгэж Үндсэн хуулийн хяналтаа хэрэгжүүлж байгаагийн илрэл шүү дээ.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын Улсын Их Хурал “хууль батлах, нэмэх, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхтэй”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна” гэсэн заалтыг зөрчсөн гэсэн нь хуулийг эсрэг утгаар нь тайлбарлахыг оролдсон, эдгээр заалтууд нь харин ч Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн хувьд өөрөө аутент тайлбар гаргах субъект гэдгийг нотолсон заалтууд байх юм.

Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарлах үүргийг Үндсэн хуулийн цэцэд ч, Улсын дээд шүүхэд ч олгоогүй нь тодорхой. Ийм тохиолдолд Үндсэн хуулийн Гуравдугаар

бүлгийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байдаг. Шийдвэр гаргасан байгууллага нь тухайн шийдвэрээ тайлбарладаг эрх зүйн онолын ерөнхий ойлголтын үүднээс асуудалд хандах ёстой. Иймд Үндсэн хуулийг тайлбарлах эрх Улсын Их Хуралд хадгалагдаж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлыг тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйл болон Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой Үндсэн хуулийн бусад заалтаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрх хэмжээ Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2. Иймд Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийж байгаа нь уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран Үндсэн хууль зөрчиж, олгогдоогүй эрх хэмжээг Улсын Их Хурал эдлэж байна гэсэн иргэн Л., Х. нарын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

3. Иргэн Л., Х. нарын өргөдөлд дурдсан Улсын Их Хурал Үндсэн хууль тайлбарлахдаа Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 1-ийн 4 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хуралд Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байх тул Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тайлбарласан Монгол Улсын Их Хурлын 1993 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 27 дугаар тогтоол, 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйл, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурал Үндсэн хууль тайлбарлахдаа Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 1-ийн 4, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул иргэн Л., Х. нарын дээрх зүйлтэй холбоотой гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

3. Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 64 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай Улсын Их Хурлын 1993 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 27 дугаар тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай Улсын Их Хурлын 2000 оны 7 дугаар сарын

26-ны өдрийн 10 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйл, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийг тайлбарлах субъектийн талаар онолын хувьд, нөгөө талаар Үндсэн хуулийн шүүх бүхий ардчилалын олон жилийн уламжлалтай орнуудын хувьд нэгдмэл ойлголт хэдий нь буй болсон ч энэ нь манай улсын хувьд маргаантай төдийгүй, Үндсэн хууль зөрчих хэмжээнд хүртэл тавигдсан асуудал болсны бодит жишээ. Улсын Их Хурал хүртэл Үндсэн хууль тайлбарлах үүргийг Цэцэд ч, Улсын дээд шүүхэд ч Үндсэн хуулиар олгоогүй, тиймээс хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч болохын хувьд энэ эрхийг өөртөө хадгална гэх санаархлыг дотроо агуулсаар ирсэн нь “эмгэнэлтэй”.

Цэцийн бүрэн эрхийг судалж үзэхэд, нэгдүгээрт өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар маргааныг магадлан шийдвэрлэхдээ тайлбар өгөх эрхтэй байх, хоёрдугаарт эрх бүхий субъект хүсэлт гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн хэм хэмжээг тайлбарлах үүрэгтэй байдаг. Үндсэн хуулийг тайлбарлах нь түүнийг хамгаалахад чиглэсэн шүүх эрх мэдлийн “дээд ангилал”-ын байгууллагын эрх зүйн үйл ажиллагааны “онцгой” төрөл. Үндсэн хууль болон бусад хуулиар Цэцэд олгогдсон бүрэн эрхийн язгуур чанар нь утгаа Үндсэн хуулийг тайлбарлах шаардлагыг зүй ёсоор бий болгодог.

Үндсэн хууль өөрөө нэгдмэл, цогц баримт бичиг бөгөөд түүний бүх заалт нь нарийн системчлэгдсэн, харилцан хамааралтай уялдаатай байдаг. Энэ ч утгаараа Үндсэн хуулийг тайлбарлах эрх нь улс төрийн ашиг сонирхол бүхий намуудад бус, Үндсэн хуулийн шүүхийн эрх мэдлийн төрөлжсөн, тусгай байгууллага болох Цэцэд хадгалагдах нь зүйн хэрэг. Цэцэд улс төрийн аливаа дарамт, шахалтаас чөлөөтэй, “тусгаар” байх эдийн засаг, хууль зүйн баталгааг Үндсэн хууль, бусад хуулиар тогтоож өгсөн. Энэ нь Цэцийн гишүүнээс Үндсэн хуулийн хэм хэмжээг тайлбарлахдаа бодит үнэний зарчмыг баримтлах үндэс, эрх зүйн хамгаалалт болж байдаг.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2001.12.20 № 02**

**Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б. ;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталсан Захиргааны хариуцлагын тухай хууль<sup>52</sup>

52 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992 оны № 4,5-д нийтлэгдсэн

- 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг “баривчлах”
- 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “баривчлах”
- 18 дугаар зүйлийн 7 дахь хэсэг “баривчлах”
- 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “баривчлах”
- 21, 22, 23, 24 дүгээр зүйл “баривчлах”
- 30 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг “баривчлах”
- 30<sup>1</sup> дүгээр зүйл “баривчлах”
- 30<sup>2</sup> дугаар зүйл “баривчлах”
- 30<sup>3</sup> дугаар зүйл “баривчлах”
- 30<sup>4</sup> дүгээр зүйл “баривчлах”
- 31, 32 дугаар зүйл “баривчлах”
- 45 дугаар зүйлд тусгагдсан “баривчлах”

2. Улсын Их Хурлаас 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль<sup>53</sup>

- 1, 3, 4, 5, 6 дугаар зүйлүүдэд тусгагдсан “баривчлах”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батлагдсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-д а/ “Баривчлах” гэдэг үг нь эрх зүйн зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн буюу эрх бүхий ямар нэг байгууллагын шийдвэрээр этгээдийг саатуулахыг хэлнэ. б/ “Саатуулагдсан этгээд” гэдэг үг нь эрх зүйн зөрчил үйлдэж, шийтгүүлснээс бусад хувийн эрх чөлөөгөө хасуулсан аливаа этгээдийг хэлнэ гэсэн заалтуудад “Баривчлах” гэдэг ойлголт нь агуулгын хувьд тухайн этгээдийг албадан саатуулах буюу цагдан хорихын өмнө эрх зүйн зөрчил үйлдсэн болон үйлдсэн байж болзошгүй этгээдийн чөлөөтэй зорчих, бусадтай чөлөөтэй харьцах зэрэг халдашгүй байх хувийн эрхийг нь хязгаарлаж, эрх бүхий албан тушаалтны хяналтад орсон үеэс эхлэн зохих байгууллагад хүргэх хүртэлх ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл “Баривчлах” ажиллагаа нь тодорхой эрх бүхий албан тушаалтны хяналтад орсон үеэс эхлэн зохих байгууллагад хүргэх хүртэлх ажиллагааг хамаарах бөгөөд үүний дараагаар албадан саатуулах, цагдан хорих болон хорих шийтгэлүүд тодорхой үе шаттайгаар явагддаг билээ.

Иймд “Баривчлах” гэдэг ойлголт нь шийтгэл биш, харин шийтгэх эсэхийг нь хянан шалгаж, тодруулахын тулд эрх бүхий байгууллагаас явуулж буй тодорхой төрлийн ажиллагааг илэрхийлж, өөртөө агуулсан ойлголт, нэр томъёо юм. Гэтэл энэ ойлголт нэр томъёог “шийтгэл” хэмээн буруугаар тайлбарлан ойлгож, салбар хуулиудад тусгасан буруу гажуудал оршоор байна.

<sup>53</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2000 оны № 6-д нийтлэгдсэн

Захиргааны хариуцлагын тухай хуульд “баривчлах” гэсэн ойлголт, нэр томьёо нь үндсэн агуулга, утга санаанаасаа гажуудаж олонтаа тусгагджээ. Мөн Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд: /2000 он/ “Баривчлах” гэдэг нэр томьёог шийтгэл гэсэн ухагдахуунаар буруу тодорхойлсон байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан “баривчлах” гэдэг ойлголт, нэр томьёоны агуулгыг буруу, гажуудуулж тусгасан хуулиуд болох Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйл, 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 30 дугаар зүйл, 31 дүгээр зүйл, 30<sup>1</sup> дүгээр зүйл, 30<sup>2</sup> дугаар зүйл, 30<sup>3</sup> дугаар зүйл, 30<sup>4</sup> дүгээр зүйл, 32 дугаар зүйл, 45 дугаар зүйлүүдэд тусгагдсан “баривчлах” гэсэн нэр томьёонууд мөн Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3, 4, 5, 6 дугаар зүйлүүдэд тусгагдсан “баривчлах” гэсэн нэр томьёо нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад байгаа нэр томьёо, ойлголтын агуулгыг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.

2. Иргэн Б.-гийн гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

а/ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 63 дугаар зүйл: Шүүгчийн халдашгүй эрх;

б/ Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйл, Хууль зүйн баталгаа;

в/ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-ын 6, 3-ын 4 дэх заалт;

г/ Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 10, 13 дугаар зүйл;

д/ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгүүд;

е/ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 23 дугаар зүйлүүдээс үзвэл тухайн албан тушаалтнуудыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийн нь нотлох баримттайгаар баривчилсан бол тэр тухай холбогдох байгууллага албан тушаалтанд нь тодорхой хугацааны дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд зохих зөвшөөрөлгүйгээр цагдан хорих түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно” гэсэн нийтлэг агуулга илэрч байгаа бөгөөд үүнд баривчлах болон шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах гэдэг ойлголтуудыг өөр өөр агуулгаар тайлбарлажээ.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т заасан заалт нь нэг талаас бусдын эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахыг үүрэг болгосон заалт бөгөөд нэгжих, баривчлах, хорих зэрэг хэлбэрүүд нь хүний эрх чөлөөг хязгаарлах ойлголтуудыг багтааж байна. Үүнээс үүдэн “баривчлах” гэсэн нэр томьёог зөвхөн саатуулан баривчлах гэсэн нэг утгаар тайлбарлахаас гадна эрх чөлөөг хязгаарласан захиргааны шийтгэл гэсэн өөр утгаар зарим хуульд хэрэглэснийг буруу гэж үзэх үндэслэлгүй юм. Түүнчлэн Үндсэн хуулийн ойлголтыг бусад хуулиар тодруулан тайлбарлаж хэрэглэж байгаа бөгөөд энэ нь тухайн хуулиудад хэрэглэсэн нэр томьёогоор ойлгогдож, тодорхой хуулиудад өөр өөр утгаар хэрэглэгдэхийг ч үгүйсгэхгүй юм. Иймд Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтыг агуулгын үүднээс авч үзвэл хүний эрх чөлөөг хязгаарлах нэг хэлбэр болж байгаа “баривчлах” гэсэн нэр томьёо нь дээрх өргөн утгыг агуулж байгаа тул дурдсан хуулиудаар тодорхой этгээдийг саатуулан баривчлах буюу захиргааны журмаар ногдуулж байгаа баривчлан саатуулах шийтгэлийг хэрэглэж байгааг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэхгүй байна. Харин цаашид хууль хэрэглэхэд хялбар дөхөм болгох, нэр томьёог нэг мөр жигдлэх, боловсронгуй болгох үүднээс анхаарал хандуулах асуудал байхыг үгүйсгэхгүй юм.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Захиргааны хариуцлагын тухай хууль болон захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай Монгол Улсын хуульд заасан “баривчлах” гэдэг ойлголт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Хууль тогтоогч өөрийн эрх хэмжээний хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад байгаа “баривчлах” гэсэн ойлголтын үндэслэл, журмыг хуульчилан тогтоосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 33 дугаар зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Захиргааны хариуцлагын тухай хууль, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн “баривчлах” гэсэн ойлголт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т буй “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор авч хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **“Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 15.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Захиргааны хариуцлагын тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн “баривчлах” гэсэн ойлголт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т байгаа “...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

### **Тэмдэглэл:**

Цэцийн дүгнэлтийг үзэхэд шийдвэрийн “хянавал” болон “тогтоох” хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна”, эсхүл “...үндэслэл тогтоогдож байна” гээд тухайн эрх зүйн хэм хэмжээний зүйл, заалтыг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг дүгнэдэг бичиглэлийн “хэлбэршил” нийтлэг байв. Шийдвэр гарах болсон үндэслэлийг тайлбарлахаас татгалзах жишиг байсан нь бодит зүйл байсан ч 2000 оноос хойш гаргасан шийдвэрүүддээ мэр сэр үндэслэлээ тайлбарлах оролдлого хийж, ингэснээрээ Цэц шийдвэрээрээ Үндсэн хуулийг тайлбарладаг гэх ойлголтод тэмүүлсэн томоохон алхам тавьсан.

Тухайлбал, дүгнэлтийн “хянавал” хэсгийн 2 дахь заалтаас Цэцийн шийдвэрийн ололттой үндэслэлийг харах болно. Өөрөөр хэлбэл “баривчлах” гэсэн ойлголтын үндэслэл, журмыг хууль тогтоогч өөрийн бүрэн эрхэд хамаарах хүрээнд хуульчилсан болохыг Цэц дүгнэлтээрээ баталгаажуулсан явдал. Мөн Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар, түүний үндэслэл, мөн хуралдааны явцад хэлэлцэгдсэн асуудал ч Цэц шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой байдаг.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2002.04.03 № 01

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн  
92 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5, 177 дугаар зүйлийн  
2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг  
зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., Д.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

1. Улсын Их Хурлаас 1994 оны 5 дугаар сарын 9-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>54</sup>

- 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн нь

2. Улсын Их Хурлаас 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>55</sup>

- 177 дугаар зүйлийн 177.2 дахь хэсэг “Улсын ерөнхий прокурор давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоолд, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй”

- 184 дүгээр зүйлийн 184.5 дахь хэсэг “Хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна”

### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...шударга шүүхээр шүүлгэх”

- Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно”

- Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “шүүгч хараат бус байх”

- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

54 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 оны № 8-д нийтлэгдсэн.

55 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1995 оны № 10-11-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:

1/ Уг хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэж хориглон заасны дараа 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж нэмсэн нь анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон Улсын дээд шүүхийн шүүгч Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд уг хэргийг хэлэлцэхэд оролцохдоо өмнө саналаа дэмжин үндэслэж байх бололцоог олгож зөвшөөрсөн нь:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т буй “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчин шүүхэд иргэний журмаар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шүүхийн доод, дээд шатны хуралдаанаар нь болон шүүгчээр нь ялгаварлан зүйлчилж хуульчилсан;

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “... шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах..” гэсэн иргэний эрхийн байдлыг алдагдуулж, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд уг хэргийг өмнө нь шийдвэрлэхэд оролцож байсан Улсын дээд шүүхийн хувийн сонирхол сэдэлттэй шүүгчийг татгалзах, түүний өмнө нь гаргаж байсан үндэслэлгүй саналаар шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах эрхгүйгээр эцэслэгдэж байгаа;

в/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалттай зөрчилдөж Улсын дээд шүүхэд өмнө нь Улсын дээд шүүхийн шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнээр хянан хэлэлцээд шийдсэнээс хойш түүний эсрэг санал гаргаж хууль зүйн дагуу шийдвэрлэх гээд байхын хэрэггүй гэсэн хараат байдал бусад шүүгчдийг оруулахад хүргэсэн;

г/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “Давж заалдах болон хяналтын шатны журмаар доод шатны шүүхийн шийдвэрлэсэн шийдвэрийг хянаж үзэх” гэсэн заалтын агуулгыг алдагдуулсан зөрчлүүд байгаа болно.

2/ Мөн хуулийн 184 дүгээр зүйлийн 5-д “Хуралдаанаас тогтоол гаргах ба түүнд хуралдаан даргалагч, хуралдаанд оролцсон бүх шүүгч гарын үсэг зурна” гэж заасныг “хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна” гэж өөрчилсөн нь мөн л дээр дурдагдсан Үндсэн хуулийн заалтуудын эсрэг өөрчлөлт болсны зэрэгцээ:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д “...дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж хориглосныг;

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1-д “Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж тогтоосныг үгүйсгэж Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн гаргаж буй тогтоолыг хуралдаан даргалагч, бүх бүрэлдэхүүн бус зөвхөн Улсын дээд шүүхийн хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурснаар хүчинжүүлж байгаа нь тухайн шүүгч хяналтын шүүх хуралдааныг хувийн хэрэгцээгээ хэрэгжүүлэхэд ашиглахад хүргэж байна.

3/ Дээрх хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй” гэж заасныг “Улсын ерөнхий прокурор давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоолд, давж заалдах

журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй” гэж өөрчилсөн нь:

а/ Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д “Прокурор... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасныг зөрчиж, Улсын ерөнхий прокурор Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд оролцох буюу түүнээс гарсан тогтоолд эсэргүүцэл бичих эрхгүй болгосон;

б/ Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанаас хуульд харшлан гаргасан тогтоолд прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болсон тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187 дугаар зүйлийн 2-т зааснаар Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нэг удаа эсэргүүцэл бичиж хэлэлцүүлэх эрхтэй гэснээр прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд тавих хяналтгүй болж хэрэв Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч хувийн үзэмжээрээ эсэргүүцэл бичихгүй л гэх юм бол тэр нь эцсийн шийдвэр буюу хуулиас дээгүүр хүчинтэй болж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2-т “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн заалттай харшилж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С., Д. нарын тайлбарын агуулга:

Нэг. Улсын Их Хурлаар 2002 оны 1 дүгээр сарын 10-нд хэлэлцэн баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар Улсын дээд шүүх зөвхөн хяналтын шатаар л хэрэг шийдэхээр тогтоож, уг хуулийн 84 дүгээр зүйлд “Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах, хяналтын шат болон дахин анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэж заасан, прокурор иргэний хэрэгт зөвхөн зохигчийн хувиар оролцох ба Улсын дээд шүүхийн хяналтын журмаар шийдвэрлэсэн хэрэгт хяналтын эсэргүүцэл бичих эрхгүй байхаар хуульчилсан бөгөөд энэ хууль нь 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Иймээс иргэн Д.-гийн өргөдөлд дурдсан эхний хоёр асуудлыг Улсын Их Хурал өөрийн эрх хэмжээний хүрээнд нэгэнт шийдвэрлэжээ. Мөн түүний Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна гэж заасан нь Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн гомдол нь хэрэг хянан шийдвэрлэх үйл явц, шийдвэрийг албан ёсны болгох үе шат хоёрын зааг ялгааг ойлгоогүйтэй холбоотой гарсан байж болзошгүй байна. Улсын Их Хурлын шийдвэрт түүний 76 гишүүн гарын үсэг зурдаггүй юм.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж уг гомдлоор үүссэн хэргийг хэрэгсэхгүй болгохыг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсье.

Хоёр. Дээрх хууль 5 сарын дараа үйлчилж эхлэх учир энэ хооронд үүсч болох зарим асуудлыг авч үзвэл:

а/ 5 сарын дараа хүчингүй болох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь нийгэмд болон иргэн Д.-д ямар ч ашиггүйн дээр тийм хууль зүйн шаардлага байхгүй байна.

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд “Шүүхийн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ” гээд энэ 3 шатны шүүх зэрэг үйл ажиллагаа явуулах нь ойлгогдож байна. Энэ тохиолдолд анхан шатны болон давж заалдах журмаар хэрэг шийдэхэд оролцсон Улсын дээд шүүхийн 17 гишүүнээс хасаад байхад Улсын дээд шүүх хяналтын журмаар хэрэг шийдэхэд 4 шүүгч оролцох тооцоо гарч байна. Иймээс Үндсэн хуулийн өөрийнх нь заалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаар оруулсан нэмэлт юм. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 81 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын дээд шүүх нийт шүүгчдийн олонхийн /9-өөс доошгүй/ бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ гэсэн заалтыг ингэж хэрэгжүүлнэ.

в/ Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж заасны дагуу Улсын дээд шүүх хяналтын журмаар шийдвэрлэсэн хэрэг шүүхийн эцсийн шийдвэр, түүнд ерөнхий прокурор болон Үндсэн хуулийн Дөчин

есдүгээр зүйлийн 2-т заасан ямар ч албан тушаалтан хөндлөнгөөс оролцож болохгүй. Харин прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцоно гэсэн заалт одоо ч шүүх хуралдааны мэтгэлцэх зарчимд нийцсэн хэлбэрээрээ хэрэгжиж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсэг:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоолд давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг ба Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан “Хуралдаанаас тогтоол гаргах ба түүнд хуралдаан даргалагч, хуралдаанд оролцсон бүх шүүгч гарын үсэг зурна” гэж заасныг “Хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гарна. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна” гэж өөрчилсөн нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д заасан “...Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно”, Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1-д заасан “Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Анхан болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн заалтын дараа 1995 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж нэмсэнийг шүүгчийг шүүх хуралдаанаас татгалзан гаргах олон улсын жишиг, эрх зүйн нийтлэг зарчмыг үндэслэн авч үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн “Шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчиж байна гэсэн нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн заалтын дараа “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан “шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5 дахь заалтууд, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байх тул иргэн Д.-гийн энэ талаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

3. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.6 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсний дараа “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн “шүүгч хараат бус байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, 2, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Тодорхой хугацааны дараа Үндсэн хуулийн зөрчилтэй хуулийн заалт хүчингүй болно гэх үндэслэлээр Үндсэн хуулийн зөрчлийг хүлээн зөвшөөрөх буюу дүгнэлт гаргахгүй байх эрх Цэцэд хуулиар олгогдоогүй. Нөгөөтэйгүүр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид “...2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд иргэний мэдээлэлд дурдсан зарим шаардлагыг хууль тогтоогч өөрийн эрх хэмжээний хүрээнд нэгэнт шийдвэрлэсэн болно” гэсэн нь холбогдох хуулийн зүйл, заалт Үндсэн хуулийн зөрчлийг агуулсан болохыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2002.06.05 №01**

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С.

**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:  
Монгол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Г.-гээс Үндсэн хуулийн цэцэд

ирүүлсэн 2002 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Цэцийн дүгнэлтийн тухай” 1/1856 дугаар албан бичгийн агуулга:

Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь Улсын дээд шүүхийн 17 шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанд бүгд оролцсон бол уг хэргийг Улсын дээд шүүх давж заалдах шатаар дахин хянах үед бүрэлдэхүүнгүй болох, Улсын дээд шүүхийн давж заалдах шатаар хоёроос дээш удаа орсон эрүү, иргэний хэргийн хувьд Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан бүрэлдэхүүнгүй болох буюу эсхүл 4-5 шүүгч оролцож эрүүгийн хэргийг иргэний хэргийн танхимын шүүгчид, иргэний хэргийг эрүүгийн хэргийн танхимын шүүгчид шийдвэрлэх зэрэг сөрөг нөлөө бий болж нэг ёсны гацаанд орж байсантай холбоотой юм.

Улсын дээд шүүхийн давж заалдах болон хяналтын шатаар 2001-2002 оны 3 дугаар сарын байдлаар хянагдсан эрүү, иргэний хэрэгт судалгаа хийж үзэхэд Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн хэргээс 14 хэргийг дахин хэлэлцүүлэхээр аймаг, нийслэлийн шүүхэд буцаахад 12-16 шүүгч хяналтын шүүх хуралдаанд оролцжээ. Мөн эрүүгийн 14 хэргийг мөрдөн байцаалтад болон аймаг, нийслэлийн шүүхэд буцаасан хуралдаанд 12-17 шүүгч оролцсон байна. Дээрх хэргүүдийг Улсын дээд шүүх давж заалдах шатаар хэлэлцэх болоход оролцох шүүгч байхгүй болно гэсэн үг юм.

Судалгаанаас үзэхэд 2000-2002 онд Улсын дээд шүүхийн давж заалдах шатаар хянасан иргэний хэргээс 17 хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байх бөгөөд үүнээс 3 хэрэг давах шатаар 3 удаа, 8 хэрэг тус бүр 2 удаа хянагдаад Иргэний хэргийн танхимын 6-8 шүүгч оролцож, хэрэв энэ хэргүүд хяналтын шатаар хэлэлцэгдэх бол тус танхимын бүх шүүгчид оролцож чадахгүйд хүрч байна. Эрүүгийн хэргийн хувьд ч байдал адилхан бөгөөд 2001-2002 онд Улсын дээд шүүхийн давж заалдах шатнаас 61 хэргийг урьдчилсан мөрдөн байцаалт болон шүүхэд буцааснаас нэг хэрэг 4 удаа, 2 хэрэг 3 удаа, 15 хэрэг тус бүр 2 удаа хэлэлцэгдэхэд тус танхимын 6-8 шүүгч, зарим үед иргэний хэргийн танхимын шүүгчдийг оролцуулсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулиуд энэ оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж, давах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн хоорондоо зааг ялгаатай болж байгаа нь зарчмын зөв зүйл боловч, Улсын дээд шүүхийн хувьд Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” гэж заасны дагуу эрүү, иргэний хэргийн танхим давж заалдах журмаар, Улсын дээд шүүхийн нийт шүүгчид оролцсон хуралдаан хяналтын журмаар тодорхой хэргүүдийг хэлэлцсээр ирсэн тул эдгээр хэргээс мөрдөн байцаалт болон шүүхэд дахин хэлэлцэгдэхээр буцсан хэрэг Улсын дээд шүүхээр эцэслэн хянагдаж дуустал одоогийн журмыг шилжилтийн байдлаар хэсэг хугацаанд мөрдөх шаардлага гарахыг үгүйсгэх аргагүй байгаа юм.

## 2. Улсын Их хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өгсөн тайлбараас зарчмын өөр тайлбар байхгүй байна. Харин Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй үндэслэлийн талаар тайлбар хэлье.

1/ Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг Үндсэн хууль зөрчиж байна гэж хүчингүй болгосноор Улсын дээд шүүхээс шүүн таслах ажлаа хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээл учирч буй бөгөөд энэ талаар дунд суудлын хуралдаан дээр ярьсан. Улсын дээд шүүх тодорхой тайлбар өгсөн байгаа.

2/ Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд заасан 3 шатны шүүх тус бүр Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болж болзошгүй байдлыг анхаарна уу.

3/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдсөнөөр зөрчил гарахгүй болох юм.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Анхан болон давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсний дараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1995 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн нэмэлт оруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх..”, Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн “... шүүгч хараат бус байх” гэснийг зөрчсөн болох нь дараахи үндэслэлүүд тогтоогдож байна.

1. Хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж эхлэхээс өмнө хэргийн болон шүүхээс гарах шийдвэрийн талаар шүүгчид урьдчилан тодорхой итгэл үнэмшил төрөөгүй байх нь шүүх шударга шийдвэр гаргах гол үндэслэл хэмээн үзэж тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцохыг хуульчлан хориглодог нь олон улсын хэмжээнд нэгэнт хэвшиж тогтсон нийтлэг зарчим болно. Өөрөөр хэлбэл нэг хэрэгт нэг шүүгч нэг удаа оролцох гэсэн нийтлэг зарчим үйлчилж байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д урд нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч /хэлмэрч/-ийн хувиар, өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах үндсэн үүрэгтэй бусаар оролцсоны дараа уг маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцвол урд бий болсон итгэл үнэмшил нь нөлөөлнө гэсэн үндэслэлээр хориглосон байхад шүүхийн шийдвэрийг биечлэн гаргасан шүүгчид түүнийг хамааруулахгүй байх үндэслэл муутай байна.

3. Ийнхүү урд нь анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэж өөрөө шийдвэр гарган, хэргийн талаар тодорхой итгэл, үнэмшилтэй болсон шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанд дахин оролцсоноор бусад шүүгчдээс шийдвэр гаргахад ямар нэг байдлаар нөлөөлж, шүүгчийн хараат бус байдлын зарчимд харшлах бүрэн үндэслэлтэй байна. Хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа шүүгчдэд нэг ижил зарчим үйлчлэх ёстой атал Улсын дээд шүүхийн шүүгчдэд давуу эрх хуульчлан тогтоож тэгш байдлын зарчмыг алдагдуулсан байна.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн заалтын дараа “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх..”, Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн “...шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтын үндэслэл батлагдахгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй “Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа “Энэ нь Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан “шүүгч хараат бус байх” заалтыг тус тус зөрчсөн байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна” гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. “Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн тайлбарт дурдсан үндэслэл нь бодитой ч Цэц маргааныг дахин хянаж эцэслэн шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хуулийн суурь зарчмыг мөрдлөг болгосон. Шүүх шударга шийдвэр гаргах гол нөхцөлийн нэг нь тухайн хэрэг, маргааны талаар шүүгчид урьдчилан тодорхой итгэл, үнэмшил төрөөгүй байх явдал. Тийм учраас тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцохыг хуулиар хориглодог нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчим.

Улсын дээд шүүхэд энэ зарчмыг мөрдөх бодит боломж байхгүй, гацаанд орох нөхцөл үүсч байна гэдэг үндэслэлээр Үндсэн хууль зөрчин Улсын дээд шүүхийн шүүгчдэд давуу эрхийг хуульчлан тогтоож байгаа нь хууль тогтоогч эрх мэдлийнхээ хүрээнд асуудлыг шийдвэрлэж чадаагүйн илрэл юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2002.04.10 № 02**

**Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Цагдаагийн байгууллагын тухай хууль<sup>56</sup>

- 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална”

<sup>56</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1993 оны №8-д нийтлэгдсэн



## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч... баривчлах, ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно"

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад "...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалт бий. Гэтэл 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсхүл хамгаалах хүнд хүлээлгэн өгнө", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэж тус тус заасан.

Эрүүлжүүлнэ гэдэг бол тухайн этгээдийн эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй үйл ажиллагаа билээ. Тодруулбал эрүүлжүүлэх ажиллагаа нь процессын эрх зүйн ажиллагаануудын 2 хэсгээс бүрддэг бөгөөд үүнд:

1/ Тухайн согтуу этгээдийг баривчлах буюу цагдаагийн албан хаагч хяналтандаа оруулж, барьж авч эрүүлжүүлэх байранд хүргэх үйл ажиллагаа;

2/ Тухайн согтуу этгээдийг албадан саатуулах буюу эрүүлжүүлэх байранд тодорхой хугацаагаар хорих үйл ажиллагаануудаас бүрддэг онцлогтой.

Ийнхүү согтуу этгээдийг эрүүлжүүлэх буюу баривчлах, эрх чөлөөг нь хязгаарлах үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл журмаар хийгдэх ёстой билээ. Эрүүлжүүлэх үндэслэлийг Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт олон нийтийн газар согтуугаар хэвийн бус яваа хэмээн заасан байна. Харин эрүүлжүүлэх журмыг тус хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт цагдаагийн төв байгууллагын дарга батална гэж заасан байна.

Энэ нь хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа буюу эрүүлжүүлэх ажиллагаа явуулах үндэслэлийг хуулиар тогтоож, тодорхойлсон боловч эрүүлжүүлэх журмыг тодорхой нэг албан тушаалтны эрх зүйн хэм хэмжээний актаар зохицуулж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчиж байна.

Дээрх заалтыг үндэслэн хүний эрх чөлөөг хязгаарлах журмыг хуульчилж хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Согтуурах, мансууран донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль зэргийг нэрлэж болно.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчиж буй Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон уг заалт дээр үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 1994 онд батлагдсан нийтээр дагаж мөрдөгдөж байгаа эрүүлжүүлэх журмыг хүчингүй болгож, эрүүлжүүлэх журмыг хуульчлан хэлбэршүүлэхийг Улсын Их Хуралд үүрэг болгосон шийдвэр гаргаж өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М.-ийн тайлбарын агуулга:

а/ Эрүүлжүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т заасан "...баривчлах, хорих, ...эрх чөлөөг нь хязгаарлах" албадлагын арга хэмжээнээс агуулгын хувьд өөр юм.

б/ "Эрүүлжүүлэх" үндэслэлийг Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Олон нийтийн газар согтуугаар хэвийн бус явбал" гэж заасан гэсэн иргэн Б.-гийн тайлбартай санал нэг байна. Харин мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "эрүүлжүүлэх журмыг Цагдаагийн төв байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах"-аар заасныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна.

в/ "Эрүүлжүүлэх" гэдэг нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас хэвийн бус яваа этгээдийн амь насыг хамгаалах, түүнийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэхээс, өөрөөр хэлбэл, согтуурлын улмаас өөрийгөө жолоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан этгээд гэмтэж бэртэх, осолдох, хүйтний улиралд осгох, бусдын хууль бус үйлдэлд өртөж хохирох, бусдад гэмтэл учруулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан танхайрахаас сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллага, албан тушаалтны зүгээс авч байгаа урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, эрүүлжүүлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон үйл ажиллагаа биш, харин ч хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийж байгаа ажиллагаа юм.

г/ Эрүүлжүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний амьд явах эрхийг баталгаажуулж байгаагийн зэрэгцээ нэг хүний эрх, нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг ардчилсан нийгмийн зарчимд бүрнээ нийцэж байгаа гэж үзэж байна.

д/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 74 дүгээр тушаалаар "Эрүүлжүүлэх журам"-ыг баталсан ба уг журмаар эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах шаардлага, эрүүлжүүлэх байранд хүлээн авах, түүнээс гаргах, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд тавих хяналт зэрэг зөвхөн процедурыг зааж өгсөн байна. Иймд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, түүнийг үндэслэн гаргасан Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүлжүүлэх журам" нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчөөгүй байна гэж үзэж байна.

3. Иргэн Б.-гийн гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

Үндэслэл гэдэг бол тухайн үйл ажиллагааг явуулах шалтгаан, нөхцөл байдал. Журам гэдэг бол тухайн үйл ажиллагаа болон түүнд оролцогчдын баримтлах дэг горимыг тогтоож, уг ажиллагааны дэс дарааллыг зохицуулж буй процессын шинжтэй үйл ажиллагаа байдаг. Журам нь эрх зүйн онолын үүднээс аваад үзвэл үйлчлэх хүчин чадлынхаа хувьд хууль, хуульчилсан актын хэлбэрээр илэрч хэлбэрждэг.

Хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа буюу үндэслэл, журам нь гагцхүү хуулиар илэрч хэлбэржсэн байх ёстой гэсэн агуулга, утга санааг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан "...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалт нь өөртөө агуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа явуулах үндэслэл, журмыг хуульчилсан актаар биш, гагцхүү хуулиар хэлбэршүүлэхийн зорилго нь хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа нь их нарийн бөгөөд төвөгтэй үйл ажиллагаа учир үүнийг дан ганц албан тушаалтан болон түүнийг тойрсон хэсэг зөвлөхүүдийн хүрээнд баталж шийдвэрлэх биш, харин Улсын Их Хурлын 76 гишүүн хамтаар хянан хэлэлцэж баталж буй нь хүний эрх, эрх чөлөөг төрөөс хэтрүүлэн зөрчихөөс хамгаалж, сэргийлэх ач холбогдолтой. Үүнийг ч Үндсэн хуулийн өмнө нь дурдсан заалт хангаж, үйлчилж байгаа юм.

Тийнхүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагаа болох "Эрүүлжүүлэх журам"-ыг Улсын Их хурлаас биш, харин Цагдаагийн ерөнхий газрын дарга баталж,

мөрдүүлж буй нь Үндсэн хууль зөрчиж буй хэрэг мөн. Тодруулбал, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн ерөнхий газрын даргын гаргасан тушаалыг үндэслэн 1994 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн нийтээр дагаж мөрдөж буй “Эрүүлжүүлэх журам” нэртэй хуульчилсан актын агуулга нь Үндсэн хууль зөрчиж байгаагаас үл хамааран, харин түүний хэлбэржсэн байдал болон батлах субъектэд тавигдах шаардлагыг хангаагүй байдал нь Үндсэн хуулийг зөрчиж байгаа болно.

Энэхүү зөрчлийг арилгахын тулд эрүүлжүүлэх ажиллагаа явуулах журмыг хуулийн хэлбэрт оруулах ёстой бөгөөд, жишээ нь: эрүүлжүүлэх ажиллагаа явуулах журмыг Цагдаагийн байгууллагын тухай хууль, эсхүл Захиргааны хариуцлагын тухай хуульд тусгай нэг бүлэг болгон хуульчлах, эсхүл тусдаа бие даасан нэг хууль болгон хэлбэршүүлж болох юм.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Эрүүлжүүлэх нь согтуугийн улмаас өөрийгөө жолоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан хүнийг юуны өмнө өөрийг нь хамгаалахад чиглэсэн арга хэмжээ. Нөгөөтэйгүүр хамгаалах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж буй хуулиар зөвшөөрсөн захиргааны албадлагын арга хэмжээний нэгэн төрөл учир хүний эрхийг тодорхой хэмжээнд зайлшгүй хөнддөг шинж чанартай байна.

2. Эрүүлжүүлэх нь согтуугаар яваа хүнийг цагдаагийн албан хаагчийн хяналтанд албадан авах, зориулалтын байранд хүлээн авах арга хэмжээ бөгөөд хэдийгээр хүнийг өөрийг нь элдэв ослоос хамгаалах зорилготой боловч хүний халдашгүй, чөлөөтэй байх тухай Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн хүрээг хөндөж, хязгаарлаж байдаг. Дээр дурдсан үндэслэлүүдэд тулгуурлан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр “Эрүүлжүүлэх журам”-ыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батлахаар тогтоож эрхийг шилжүүлсэн явдал Үндсэн хуулийг зөрчсөн байна гэх үндэслэл тогтоогдож байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт мөн зүйлийн бусад хэсэгтэй харьцуулахад “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн давхар хамгаалалттай байгаа учир Цагдаагийн байгууллагын тухай хуулийн дээрх заалт Үндсэн хуулийг зөрчиж байна гэх үндэслэл тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу мэдэгдэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон Улсын Их Хуралд уламжилъя.

### **Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 2 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн арван тавын 15.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-ын “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Цэцийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг энэ дүгнэлтээс харж болно. Цэц Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлээ тайлбарлахаас “татгалздаг” хэвшмэл байдлаасаа хэдий нь салсан болох нь эндээс мэдрэгдэнэ. Мөн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад хүний эрх, эрх чөлөөний “давхар хамгаалалт” тусгагдсан болохыг ч мэдэрнэ.

Хүний халдашгүй чөлөөтэй байх Үндсэн хуулиар олгогдсон эрхэд гагцхүү хуульд заасан журмын дагуу халдаж тэрхүү эрхийг тодорхой хэмжээнд хязгаарлах боломжтой гэдэг Үндсэн хуулийн үзэл баримтлал Цэцийн дүгнэлтээр батлагдсан байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 1 дүгээр дүгнэлт, 1995 оны 5 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2002.06.06 № 02**

### **Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын зарим гишүүд Цэцийн дүгнэлтийг хүлээгээд авчих юм бол эрүүлжүүлэх үйл ажиллагаа зогсчихно гэсэн ойлголттой байх шиг байна. Тийм зүйл байхгүй. Журмыг хууль болготол хуучин жишгээрээ байж болно. Энэ журам бол хуульд заасан журам биш. Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүйд гайхаж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Дунд суудлын хуралдаанд М. гишүүний гаргасан тайлбартай санал нэг байна. Одоогийн мөрдөгдөж буй эрүүлжүүлэх журам бол хуулиар тогтоосон журам юм гэж Улсын Их Хурал үзсэн. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт хуульд заасан журам мөн. Харин энэ журмыг л зөрчихгүй байх ёстой. Цагдаагийн хуулийн төсөлд эрүүлжүүлэх журмыг Эрүүл мэндийн сайд, Хууль

зүйн сайд, Улсын ерөнхий прокурор зөвшилцөн гаргана гэж томьёологдон батлагдсан. Эрүүлжүүлэх журам боловсрогдож байгаа.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “... Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч... баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Эрүүлжүүлэх гэдэг бол нэг талаас согтуугийн улмаас өөрийгөө жолоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан хүнийг өөрийг нь хамгаалж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэх, бусдад гэм хор учруулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан танхайрахаас урьдчилан сэргийлж буй арга хэмжээ боловч нөгөө талаас дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хүний халдашгүй чөлөөтэй байх тухай Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн хүрээг хөндөж хязгаарлаж буй албадлагын арга хэмжээ юм.

2. Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэг хэмжээгээр хязгаарлаж буй эрүүлжүүлэх үйл ажиллагааг хуулиар биш Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын даргын баталсан журмаар зохицуулахаар хуульд заасан нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлах тухай Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцэхгүй байна.

3. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “... Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолын хууль зүйн үндэслэл батлагдахгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 2 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү тогтоол нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

## **Тэмдэглэл:**

Хуульд заасан журам гэдэгт тухайн журмыг батлах сүбъектыг тодорхойлон хуульчилсныг ойлгох уу, журам бүхэлдээ хуулиар хэлбэршсэн буюу парламентаас батлагдсан байхыг ойлгох уу гэдэг асуудал энд зүй ёсоор үүснэ. Асуудлын хариу Цэцийн дээрх тогтоол.

Цэцийн дүгнэлт, тогтоолын дагуу Улсын Их Хурал 2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийг баталсан байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2002.06.26 № 03**

**Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., М., Л.;  
Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., С.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр баталсан Компанийн тухай хууль<sup>57</sup>

- 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг ...хязгаарлагдмал компанийн дүрмээр хязгаарлаж болно”

- 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй”

- 58 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй. Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцааг худалдан авах саналыг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ. Энэ саналд хяналтын багц хувьцааг худалдан авсан этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, хаяг, тэдгээрийн

<sup>57</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 оны № 34-д нийтлэгдсэн

эзэмшилд байгаа хувьцааны тоо, худалдан авах үнийн санал болон саналыг хаах эцсийн хугацаа зэргийг тусгасан байна”

- 58 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацаа нь хувь нийлүүлэгчдэд саналаа явуулснаас хойш 30 ба түүнээс дээш хоног байхаар тогтооно”

- 58 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал нь энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана”

- 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй”

- 83 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”

- 83 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Компани болон түүний энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компани болон өөрт учирсан хохирлыг энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 6-д заасан этгээдээр нөхөн төлүүлэхээр энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”

- 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”

- 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно..”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

## Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн А., М. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн заалт нь Үндсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байгаа тул энэ заалтын талаар дүгнэлт гаргуулахаар өргөдөл гаргаж байна. 1999 онд Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдсан Компанийн тухай хуулийн зарим заалт нь хувьцаат компаниудын эрх зүйн харилцааг зохицуулах чадваргүй, Үндсэн хуульд заасан хүний эрх, ялангуяа хүний хувийн өмчийн халдашгүй эрхийг зөрчсөн, хувьцаа эзэмшигч нарын дунд маргаан үүсгэсэн, нэг хэсэг хувьцаа эзэмшигч эсрэг саналтай багц хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус өмчлөх эрхтэй холбогдсон эрх, эрх чөлөөг шууд хасаж дураар авирлах ноцтой нөхцөл байдал үүсгэж байна. Ингэснээр хувьцаат компаний хувьцаа эзэмшигчид Үндсэн хуульд заасан өмч, түүнтэй холбогдсон эрхээ хамгаалахаар тэмцэж заримдаа энэ нь улс орныг, хэвлэл мэдээллийг талцуулан маргалдуулж, ихээхэн сөрөг үр дагавар гарч нийгэм, улс төрийн таагүй нөхцөл байдал үүсгэж болзошгүй байна. Одоо Монгол Улсын Үнэт цаасны хороонд бүртгэлтэй 300 гаруй компанид ийм байдал бүрэлдээд байгаа бөгөөд цаашид компанийн удирдлагын төлөө тэмцэл, маргаан үүсгэх, энэ нь төр засгийн нэр хүндэд хохиролтой, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдлүүд үргэлжлэн гарах, Үндсэн хууль зөрчигдсөөр байхад хүргэж байна.

АПУ ХК-ны хувьд гэхэд 51 хувийн хувьцаа эзэмшигч нөгөө 49 хувийн хувьцаа эзэмшигч болох 4000 шахам хувьцаа эзэмшигч нарын хувьцааг өмчлөх, өмчтэй холбогдсон бусад эрх, компанийн удирдлагад сонгох, сонгогдох эрхийг нь Компанийн хуулийн 58 дугаар зүйлээр шалтаглан хасаж, дураар авирлах, хууль завхруулах, өөртөө шүүхийн таслан шийдвэрлэх, хууль тайлбарлах эрхийг олгож нийгмийн бухимдал, зөрчил үүсгэж байна.

Компанийн хуулийн 58.1-д “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй”. Мөн 58.2-д “Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58.1-д заасан саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй” гэж заасан. Мөн 58.4-т “Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол энэ хуулийн 58.1-д заасан заалт үйлчлэхгүй” гэж тогтоосон. Энэ нь:

1/ Төрөөс хувьчлагдсан багц хувьцаа эзэмшигчдэд нэг талын, илт давуу байдал олгон Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн “Монгол Улсад хууль ёсоор суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна” гэсэн заалтыг зөрчсөн.

2/ Үнэт цаасны хорооноос Компанийн хуулийн 58 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, хяналтын багцыг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд гэдгийг хэн тодорхойлох, мөн бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах журмыг өнөөг болтол гаргаагүй, Монголын 300 гаруй хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигчдийн нэг нь ч бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаа худалдан авахаар хэвлэл мэдээллээр зарлаагүй, хууль хэрэгжсэнээс хойш 2 жилийн дараа Үнэт цаасны хороо сая л анхааруулга сонинд нийтэлж байна.

3/ Компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч саналын зөрчилтэй хэд хэдэн хэсэг болж бие биенийгээ үгүйсгэн “саналын эрхгүй” болгож, энэ тохиолдолд компанийн эрх барих дээд байгууллага болох хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх бүх асуудалд санал өгөх, компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн Удирдах



Зөвлөл, Хяналтын зөвлөлд сонгох, сонгогдох, үнэт цаасаар гэрчлэгдсэн компанийн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжгүй болгож байна. Ингэж хувьцааг “саналын эрхгүй” гэж хувь хүний өмчлөх эрхийг хэн нэг этгээд шууд дур мэдэн хассан нь сонирхогч этгээдийн хүсэлт, нэхэмжлэлээр шүүх авч хэлэлцэх Үндсэн хуулийн заалтыг зөрчиж, хэн ч хамаагүй этгээд, түүний дотор хэд хэдэн хувьцаа эзэмшигчид хуйвалдааны замаар бусад хувьцаа эзэмшигчдээ хохироон асуудлыг шийдвэрлэж болох утга санаатай хуулийн заалт байгаа нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3-т “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, мөн Дөчин долдугаар зүйлийн 2-т “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэсэн заалт зөрчигдөхөд хүргэж байна.

4/ Компанийн хувьцааны хяналтын багц хувьцааг эзэмшигч хэд, хэдэн этгээд байвал тэднийг нэгдмэл сонирхолтой этгээд мөн гэдгийг хэн, хэрхэн тооцох /нэг компанийн албан тушаалтан байтугай нэг гэр бүлийн гишүүд эсрэг тэсрэг сонирхолтой байдаг ба Үндсэн хууль, Иргэний хуулиар гэр бүлийн гишүүд хуваарьт өмчөө өөрөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй/, төрийн өмчтэй компани /төрийн болон орон нутгийн өмчийн хууль/-иар хувьчлагдах 58 дугаар зүйл үйлчлэх эсэх мөн хувьцааны “саналын эрх” хасагдах нь хэзээ, ямар нөхцөлд эргэж “сэргээгдэх” хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан заалттай зөрчилдөж энэ нь компанийн 33.3 хувиас дээш хувьцаа эзэмшигчийн хувьцаа нь хэн нэг булхайтай этгээдийн луйвраар “хэзээ ч” саналын эрх эдлэхгүй, багц хувьцаа эзэмших утга учраа алдах, хэдэн зуун сая, тэрбумаар тоологдох өмч хөрөнгө, үнэт цаас түүнтэй холбогдон үүсэх өмчлөгчийн эрх үүрд байхгүй болохоор байна.

5/ Компанийн хуулийн 97 дугаар зүйлд “нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр, 18 насанд хүрээгүй хүүхэд, нэг компанийн албан тушаалтан орно” гэж зааж, 58 дугаар зүйлд зааснаар бусдын хувьцааг худалдан авах саналыг зөвхөн “зарлаагүй”-н төлөөх хариуцлагыг гэр бүлийн бүх гишүүдэд, насанд хүрээгүй хүүхэд, хамт ажилладаг гэдгээр албан тушаалтанд хүртэл тулган хүлээлгэж, өмчлөх эрх, санал өгөх, сонгох, сонгогдох эрхийг хасах нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан заалттай зөрчилдөж байна.

Компанийн хуулийн 58 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”, 5 дугаар зүйлийн 2-д “...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасантай утга агуулгаараа зөрчилдөж, Монголын 300 орчим компанийн 33.3 хувиас дээш хувьцаа эзэмшигч олон арван хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасаар гэрчлэгдсэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө юу ч биш, зөвхөн Хөрөнгийн биржид бүртгэлтэй цаас болгож, хүний эрх, түүний дотор хүний өмчийн эрх ноцтой зөрчигдөж байх тул Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн дагуу энэ асуудлыг хянан шийдвэрлэж, Компанийн хуулийн 58 дугаар зүйлийг хүчингүй болгож өгнө үү. Тэгээд ч Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3-т “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэх эрхгүй” заалтын дагуу бүх шатны шүүх Компанийн хуулийн 58 дугаар зүйлийг баримтлан хувьцаа эзэмшигчдийн маргааныг шийдвэрлэх боломжгүй тул энэ нэхэмжлэлийг аль болох шуурхай шийдвэрлэж өгөхийг хүсье.

## 2. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “...хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, 2 дахь хэсгийн “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно”, 3 дахь хэсгийн “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож болохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Иймд энэхүү өргөдөлд дурдсан нэхэмжлэлээр Үндсэн хуулийн маргаан үүсгэж, хянаж шийдвэрлэж өгөхийг гүнээ хүсье.

Мөн Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4, 67 дугаар зүйлийн 1 дэх заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван есдүгээр 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна.

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 2, 93 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “...хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Мөн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С., С. нарын тайлбарын агуулга:

Хувьцаа гаргагч түүнийг худалдан авагчийн хоорондын харилцаа нь анхдагч зах зээлийн хүрээнд гарч ирж байгаа зүйл. Өмнөх парламентын үед батлагдсан Компанийн тухай хууль нь нийгмийн шударга ёсыг тогтооход чиглэгдсэн байх бөгөөд энэ утгаараа Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж ойлгож байна, гэхдээ уг хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсэг боловсронгуй биш байж болох юм. Аливаа тэгш байдал нь тэгш биш байдлыг бий болгодог. Байгалиас хүн хүний чадвар өөр учир тэгш байдал олгосны дараа тэгш биш байдал бий болдог. Үүнийг нийгэм анхаарч тэгш байдлыг бий болгох хуулийн зохицуулалт хийдэг. Хөрөнгийн зах зээлд орж ирснээр үнэт цаасаар гэрчлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах буюу арилжааны харилцаанд орж, өмчлөх эрх шинээр бий болж байна. Компанийн тухай хуулийг боловсруулах хэлэлцэж батлахдаа эхнээсээ цөөн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зорилго тавьсан юм. Өмчлөх эрх абсолют эрх боловч газар, орон сууц, компани зэрэг тодорхой асуудлаар олон хүн нийлж өмчлөх тохиолдолд өмчлөх эрхийг хязгаарлаж болно. Энэ хуулийн хувьд саналаа нийтэд зарлаагүйн төлөө хариуцлага болгож эрхийг нь хязгаарлаж байгаа юм. Энэ бол үүргээ биелүүлсэн бол эрх нь үүсэх болзолт факт юм. Хуулиар оноосон үүргээ биелүүлмэгц түүнийг сэргээж болно. Иргэний хуулийн 162 дугаар зүйлийн 7, Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн заалтыг энд дурдах шаардлагатай. Төрийн өмчийг хувьчилж байгаа үед тусгай болзол тавихгүй байх нь зөв юм.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсэгт:

1. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэснээс бусад заалт, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Түүнчлэн Компанийн тухай хуулийн дээрх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэсэн заалтыг зөрчөөгүй байна. Мөн дээрх заалтууд нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пактын 4 дүгээр зүйл, холбогдох бусад зүйлийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл үгүй байна.

2. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт, 83 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зохих заалтыг зөрчсөн болох нь дор дурдсан үндэслэлээр тогтоогдож байна.

1/ Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр" гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2/ Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 1 хүртэлх хувийн хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байхаар заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", 2 дахь хэсгийн "Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн "Банкны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцсэн тухай" Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдөр гаргасан шийдвэрээрээ Монгол Улсын иргэн ямарваа хязгаарлалтгүйгээр зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг нотолсон билээ.

3/ Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн үндэслэл тогтоогдож байна. Аливаа хууль Үндсэн хуульд харшлахгүй байх нь Үндсэн хуулийн чухал шаардлага, зарчим юм.

3. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны мэтгэлцээний явцад иргэн Л. Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйл Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэлээсээ татгалзсан тул энэ талаар дүгнэлт гаргах шаардлагагүй гэж үзэв.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн зөвлөлдөх тасалгаанд болсон хуралдааны үед Цэцийн гишүүд Компанийн тухай Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн заалт Үндсэн хууль зөрчөөгүй ч боловсронгуй болоогүй тухай олонтаа тэмдэглэснийг дурдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно” гэсэн заалтын “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэснээс бусад заалт, 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй”, 2 дахь хэсгийн “Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргаагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй. Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцааг худалдан авах саналыг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ. Энэ саналд хяналтын багц хувьцааг худалдан авсан этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, хаяг, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо, худалдан авах үнийн санал болон саналыг хаах эцсийн хугацаа зэргийг тусгасан байна”, 3 дахь хэсгийн “Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацаа нь хувь нийлүүлэгчдэд саналаа явуулснаас хойш 30 ба түүнээс дээш хоног байхаар тогтооно”, 4 дэх хэсгийн “Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол энэ хуулийн 58 дугаар зүйлийн 1-д заасан заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал нь энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана”, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно” гэсэн заалтын “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалтыг зөрчиж байна.

3. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Компани болон түүний энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компани болон өөрт учирсан хохирлыг энэ хуулийн 81 дүгээр зүйлийн 6-д заасан этгээдээр нөхөн төлүүлэхээр энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалт, түүнчлэн 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь

эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалтуудад байгаа компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”; “Хүнийг... хөрөнгө чинээгээр... нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

4. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн байна.

5. Энэхүү дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 3 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэснээс бусад заалт, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, мөн хуулийн 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна”, “Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг, мөн хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийн холбогдох заалтуудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Иргэн ямар ч хязгаарлалт, шахалтгүйгээр зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Эзэмшиж буй хувьцааны тоо, хэмжээнээс хамааран хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, компанийн өмнө хүлээх хариуцлага өөр өөр байдаг ч энэ нь тухайн хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлэгчдийн хуралдаанд зарим асуудлаар санал гаргах болон зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхийг хязгаарлах ёсгүй. Тэр тусмаа хуулиар бус хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр тухайн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил гэж үзэж болно.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2002.11.13 № 03

### Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., М., Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Б.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь өмчлөгчийн эрхийг зөрчсөн бус харин хувь нийлүүлэгчид тодорхой асуудлыг шийдвэрлэх арга замаа өөр хоорондоо харилцан тохиролцож түүнийгээ дүрэмдээ тусгах замаар цаашид тухайн асуудлыг шийдвэрлэх боломжийг хуулиар нээж өгч байгаа зохицуулалт юм. Харин Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтууд нь хувь нийлүүлэгч тус бүр нь удирдлагаас гаргасан шийдвэр бүрийн талаар компанийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаад байх нь шийдвэр гаргах, бие даан үйл ажиллагаа явуулах зэрэгт хүндрэл үүсгэдэг тул дээрх хоёр хүчин зүйлийг тэнцүүлэх үүднээс энгийн хувьцааны нэгээс дээш хувийг эзэмшиж буй хувь нийлүүлэгчид энэхүү эрхийг эдлэхээр хуульчилсан юм.

#### Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:

Нэг. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалт, түүнчлэн 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалтууд нь компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн компанид учирсан хохирлыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Хоёр. Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэсэн заалт, 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...болон өөрт.” гэсэн заалт, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр...” гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалт, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна. Учир

нь Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэсэн заалт нь гагцхүү хуулиар хязгаарлагдахаар Үндсэн хуульд заасан иргэдийн өмчлөх эрхийг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлахаар болжээ.

2. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...болон өөрт...” гэсэн өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарласан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлаж үл болно” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна” гэсэн заалт нь Компанийн тухай хуулийг бусад хуулиас дээгүүр тавьж, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн хууль байсан ч компанийн хуультай л харшлаагүй бол хүчин төгөлдөр байж болох мэт ойлгогдохоор хуульчилсан нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2,4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна гэж үзсүгэй.

2. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно” гэсэн заалтын “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр...” гэсэн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн заалтыг зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “...хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр” гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

3. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “...болон өөрт...” гэсэн заалтад байгаа компанийн энгийн хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна”, “Хүнийг... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн

байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... болон өөрт..." гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

4. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн байх тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

5. Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

6. Энэ тогтоол эцсийн шийдвэр бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Цэцийн 2002 оны 3 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2002 оны 72 дугаар тогтоолд Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн үндэслэл байхгүй. Ер нь Үндсэн хууль зөрсөн тухай Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхийг хэлэлцсэн Улсын Их Хурлын бусад тогтоолд ч энэ талаар тусгадаггүй. Цэц, Улсын Их Хурлын харилцаан дахь тодорхойгүй, "зөрчилдөөнт" байдал ч үүгээр илэрдэг.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2002.11.27 № 04**

**Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний тухай хууль<sup>58</sup>

- 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..."

- 3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг "Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ"

58 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны №5-д нийтлэгдсэн



## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч... гагцхүү хуульд захирагдана”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж мөн оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний шинэ хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Хуульд заасан тохиолдолд Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны энэ хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг хэрэглэж болно” гэсэн заалтыг мөн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ” гэсэн заалтуудыг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалтын “гагцхүү хуульд захирагдана” гэсэн хэм хэмжээг зөрчсөн байна.

Учир нь шүүгч гагцхүү хуульд захирагдана гэдэг нь хуулийг бүх нийтээр дээдлэх, хуульд хэн боловч адил тэгш захирагдах ёстой гэсэн өргөн багтаамжтай ойлголтын хүрээнд юуны түрүүнд шүүгч өөрөө багтаж байгааг илэрхийлдэг төдийгүй шүүгчийн бүхий л үйл ажиллагаа, эдлэх эрх, гүйцэтгэх үүрэг хуулиар тодорхойлогдож “зөвхөн хууль буюу парламентын баталсан актыг баримтална гэсэн үг юм”. Нэгэнт хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа нь тэдний үйл ажиллагааны үндсэн хэсэг учраас энэ ажиллагаа мөн л хуульд захирагдана. Хууль нь шийдвэр гаргахад баримтлах ганц хэмжүүр нь болж, тэнд шүүгч зөвхөн хууль хэрэглэж хэрэг маргааныг шийдвэрлэж байдаг. Харин өөр бусад эрх зүйн акт хэрэглэвэл хатуу чанд үйлчлэх Үндсэн хууль түүний зарчим зөрчигдөх нь гэдэг нь маргаангүй мэт санагдана. Ийнхүү шүүгч зөвхөн хууль хэрэглэснээрээ л хуульд захирагдсан болох бөгөөд хуульд захирагдсанаараа л хараат бус байгаа нь харагддаг гэж бодож байна. Иймд Иргэний хуулийн дээр дурдсан заалтууд Шүүхийг өөр бусад эрх зүйн акт хэрэглэж болно хэмээн зааснаараа Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн үзэл баримтлалд нийцэхгүй байгаа бөгөөд “Шүүгч... гагцхүү хуульд захирагдана” гэсэн хэм хэмжээг шууд зөрчсөн байна.

Шүүх Засгийн газар, эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны эрх зүйн актыг бус /цаашид хуулийн дэд акт гэж нэрлэнэ/ зөвхөн хууль хэрэглэх нь юун түрүүн төрийн эрх мэдэл хуваарилах зарчимтай холбоотой. Эл зарчмыг хүний эрх, эрх чөлөөг төрийн засаглалын дур зоргоос хамгаалах, ардчилсан төр засаг өөрөө туйлын зохион байгуулалттай байх шаардлагын язгуур үндэс бөгөөд хийх ажил, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн хил хязгаарыг туйлын тодорхой тодорхойлсон “Цааз” төдийгүй бас дээрх эрх мэдлүүд нь Үндсэн хуулиар тогтоогдсон өөрийн статусын үндсэн дээр органик хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд ажил хэргийн нарийн уялдаатайгаар төрийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ гэсэн ойлголтуудыг илэрхийлдэг гэж үздэг. Мөн түүнчлэн эрх мэдлүүд нь бие даасан байдалтай, бие даасан байдал нь хязгаартай байх ёстой. Өөрөөр хэлбэл хууль тогтоох эрх мэдлээс хуулийг зөвхөн тогтооно, гүйцэтгэх эрх мэдлээс зөвхөн хэрэгжүүлнэ, шүүх зөвхөн хууль хэрэглэнэ гэсэн агуулгатай зарчим гэж нийтэлсэн нь элбэг байдаг.

Хэрэв шүүгч гагцхүү хуульд захирагдах зарчимтай холбоотойгоор шүүхээс хууль хэрэглэх зарчим урган гардаг юм бол Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-ээс Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэг урган гарсан байх ёстой гэсэн нэгдэх дүгнэлтийг хийж болно. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д “Шүүгч...гагцхүү хуульд захирагдана” гэсэн нь хуулиас өөр ямар нэгэн эрх зүйн актад захирагдахгүй гэсэн санаа байгаа нь маргаангүй тул тэр нь Тавьдугаар зүйлийн 3-т заавал илрэх ёстой бөгөөд ийнхүү илрэхдээ мөн л өөр ямар нэг эрх зүйн акт хэрэглэхгүй гэсэн

санаа тэнд гарсан байх ёстой гэсэн логик дүгнэлт хийхэд хүргэж байна. Тиймээс ч зөвхөн хууль хэрэглэх ёстойг бичиж үлдээгээгүй, харин хэвшил болсон ойлголт дээрээ үндэслэн түүний шалгууруудыг шууд тоочин нэрлэсэн байна.

Иймд шүүх маргааныг шийдвэрлэхдээ легитемт шинж чанартай Парламентаас баталсан эрх зүйн актыг баримталж шударга ёс, хүний эрх, эрх чөлөөний баталгаа болж байдаг гэсэн тэрхүү сонгодог ойлголтыг Үндсэн хуулийн цэц шийдвэрээрээ дахин нэг тунхаглах байх гэж найдаж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

1/ Хууль тогтоогч Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийг иргэний эрх зүйн аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхэд байнга тохиолддог асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгасан. Зарим маргааныг шийдвэрлэхэд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хуульд тодорхой заагаагүй, төсөөтэй хэрэглэх хуулийн заалт байхгүй байх тохиолдол олонтаа гардаг. Нөгөө талаар иргэний эрх зүйн харилцааг бүхэлд нь хуулиар зохицуулах боломжгүй тул хуулиар шууд зохицуулаагүй харилцааг төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан актаар зохицуулах зайлшгүй шаардлагатай. Тийм ч учраас Иргэний хуульд дээрх заалтуудыг тусгаснаас гадна 380 дугаар зүйлийн 2-т “Зорчигч буюу ачаа, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд нийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрмээр тодорхойлогдоно” гэж заасан. Эдгээр журам нь хуульд нийцсэн байх ёстой бөгөөд хэрэв хуульд нийцээгүй бол эрх зүйн актыг хэрэглэж болохгүй нь ойлгомжтой.

2/ Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5-д зөвхөн “нийтээр дагаж мөрдөх” эрх зүйн актыг хэрэглэж болохоор заасан бөгөөд энэ нь “хуульд нийцсэн байх” ёстой. Засгийн газрын 1997 оны 178 дугаар тогтоолоор “Яам, тохируулагч агентлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичгийг хянаж бүртгэх журам”-ыг баталсан бөгөөд уг журмын Нэгийн 2-т “Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичиг гэдэг нь яам, тохируулагч агентлагаас хуулиар олгогдсон бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан тухайн салбарын болон улсын хэмжээнд байнга дагаж мөрдүүлэх заалт бүхий эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг /тушаал, тогтоол/-ийг хэлнэ” гэж заасан байна.

Түүнчлэн яам, тохируулагч агентлаг нь зөвхөн хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон нөхцөлд нийтээр дагаж мөрдүүлэх эрх зүйн баримт бичиг гаргах ба нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичигт тусгайлан эрх олгосон хууль тогтоомж болон Засгийн газрын тогтоолын заалтыг үндэслэл болгон заавал дурдаж байх юм. Яам, тохируулагч агентлаг нь нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан эрх зүйн баримт бичгийнхээ эх хувийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж хуульд нийцсэн эсэхийг хянуулах үүрэгтэй бөгөөд хэрэв уг акт бүхэлдээ буюу аль нэг заалт нь Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн байвал Хууль зүй, дотоод хэргийн яамны дүгнэлтийн дагуу уг баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах ёстой. Иймд хуулийн заалтыг үндэслэн, хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг шүүх хэрэглэснийг “хуульд захирагдсангүй” гэж үзэх үндэслэлгүй юм.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хэт хавтгайруулсан, шүүхээс хэрэглэх хэм хэмжээний хүрээ Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдсөн байна. Мөн заалтад хуульд заасан тохиолдолд Засгийн газар эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрх олгогдсоныг Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдөөгүй гэж үзлээ. Үндсэн хуулиар тодорхойлогдсон хууль дээдлэх зарчмын агуулгад хууль хэрэглэх үйл ажиллагаа бүрнээ нийцэж байх ёстой. Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж буй эрх зүйн акт шүүхэд маргаан шийдвэрлэх явцад нотолгооны ач холбогдолтой хэрэгсэл болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..." гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч... гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 4 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..." гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч... гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Цэц Иргэний хуульд "Засгийн газарт эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрх олгогдсоныг Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдөөгүй байна" гэж дүгнэснээ илүү тодорхой тайлбарлах шаардлагатай байсан. Яагаад гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагаас Иргэний хуульд нийцүүлэн гаргасан, иргэний эрх зүйн хэм хэмжээ агуулсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг шүүгч хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэж болох талаар дүн шинжилгээ хийх ёстой.

Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан эрх зүйн акт шүүхэд хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нотолгооны ач холбогдолтой гэж үзсэн нь хүлээн зөвшөөрөхүйц боловч тэдгээрийг "хэрэгсэл" гэж томъёолсон нь тайлбар шаардаж байна. Нотолгооны хэрэгсэл нь олон төрөл, хэлбэр байдаг бөгөөд шүүх нотолгооны хэрэгслийг үнэлсний эцэст нотлох баримт болдог. Нэр томъёог оновтой сонгож, зөв хэрэглэх нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий гарахад чухал ач холбогдолтой.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2003.02.19 № 01

**Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт  
Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх  
тухай маргааныг дахин хянаж эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т., Б.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### 1. Иргэн Б.-гийн тайлбарын агуулга:

Засгийн газар, төрийн байгууллага, албан тушаалтны баталсан эрх зүйн актыг шүүх хэрэглэдэг болчихвол шүүх эдгээр байгууллагын шийдвэр, хүсэл зоригийг хэрэгжүүлэгч хэрэгсэл болж төрийн эрх мэдлийн нэг бие даасан салаа мөчир гэсэн чанарыг алдана. Иймээс шүүгчийг гагцхүү хуульд захируулахаар Үндсэн хуульд зааж, тэр захирч буй хуульд тавигдах шаардлагыг мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 3-аар тодорхойлсон юм. Иймд Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байна.

#### 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т., Б. нарын тайлбарын агуулга:

Иргэний эрх зүйн харилцааны бүх асуудлыг ганцхан хуулиар зохицуулах боломж байхгүй. Ийм учир эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж болох тухай заалт оруулсан юм. Гагцхүү хуульд захирагдана гэсэн нь гагцхүү хууль хэрэглэнэ гэсэн үг биш. Нөгөө талаар өргөдөл гаргагч Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг хүлээн зөвшөөрч байгаа нь нэг утгатай 3 дугаар зүйлийн 5 дахь заалтыг ч хүлээн зөвшөөрч байна гэсэн логик дүгнэлт гарч байна. Иймд Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь иргэний эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хэт өргөжүүлэн хавтгайруулсан байна. Ингэснээрээ шүүхээс хууль тогтоомж хэрэглэх эрх хэмжээ, Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдсөн байна. Үндсэн хуулиар тодорхойлсон хууль дээдлэх зарчим болон шүүгч асуудлыг шийдэхдээ зөвхөн хуульд захирагдах тухай суурь ойлголтод хууль хэрэглэх үйл ажиллагаа бүрнээ нийцэж байх ёстой.

Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргаж буй эрх зүйн акт шүүхэд маргаан шийдвэрлэх явцад нотлох баримтын ач холбогдолтой хэрэгсэл болно.

Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтан" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэсэн Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр сарын 4 дүгээр тогтоол үндэслэлгүй болох нь хуралдааны явцад тогтоогдов.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд Маргаан

хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "...эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтыг зөрчиж байгаа тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах нь шүүх эрх мэдлийн талаархи Үндсэн хуулийн чухал зарчим.

Нэг талаас хууль тогтоогчид иргэний эрх зүйн харилцааг гагцхүү хуулиар зохицуулах боломжгүй тул эрх бүхий байгууллага, албан тушаалтны хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж болно гэж үзэж байгаа нь утга шүүгч хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хуулийн зүйл заалтыг бус, албан тушаалтны гаргасан эрх зүйн актыг удирдлага болгон шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Нөгөө талаас амьдралд иргэний эрх зүйн бүх маргааныг зөвхөн хуулиар зохицуулах боломж, магадлал байхгүй. Зах зээлийн үеийн аж ахуйн харилцаа дэндүү өргөн тул хуулийн дагуу, түүнтэй нийцсэн бусад эрх зүйн ба эрх зүйн бус хэм хэмжээг шүүх шийдвэр гаргахдаа анхаарч үзэх хэрэгтэй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2003.04.30 № 01**

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон  
Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Х.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О., Б.

#### **Үндсэн хуулийн зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>59</sup>

59 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 8-д нийтлэгдсэн

- 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Төрийн нэрийн өмнөөс оролцоно”

- 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн 65.1.1 дэх заалт “шүүхэд харьяалагдахгүй”

- 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн 65.1.6 дахь заалт “...эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан”

- 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсэг “Энэ хуулийн 20.2; 38.9;65.1.1-65.1.3;65.1.6-65.1.10 дахь заалт; 74, 75, 76 дугаар зүйл, 106.5; 129, 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй”

2. Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хууль<sup>60</sup>

- 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ”

- 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ”

- 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг “Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэг “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг “Монгол Улсын иргэн... шударга шүүхээр шүүлгэх, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй”

- Арван есдүгээр зүйл 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө”

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”

- Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”

- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

60 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 29-д нийтлэгдсэн

- Дөчин есдүгээр зүйлийн 2 “төр, ...бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

1/ 2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт мөн хуулийн 170 дугаар зүйл 170.3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйл 1, 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн заалтад тусгагдсан төрийн ашиг сонирхол гэдэгт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудын ашиг сонирхол хөндөгдсөн байж болох ойлголт хамрагдах бөгөөд эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны талаарх асуудал хөндөгдөж байгаа нь тэдгээрт ажилладаг ажилтан, албан тушаалтан /иргэд/ нарын үйл ажиллагаанаас үүдэлтэй байх нь тодорхой. Тийм нөхцөлд тухайн ажилтан, албан тушаалтан шүүхийн өмнө бусад иргэний адил эрхтэй байхыг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтаар баталгаажсан бөгөөд үүнд хөндлөнгийн оролцоо байж болохгүйг Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтаар хориглосон болно.

Төрийн байгууллагын /хэн нэгэн албан тушаалтны/ хүсэлтээр тэдгээрийг төлөөлөн прокурорын байгууллага хөндлөнгөөс оролцох нь прокурорын хяналтыг үгүйсгэж албан тушаалтны төлөөлөгч болж Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

3/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйл 170.3 заалтаар иргэний цаашид гомдол гаргах эрхийг хязгаарласан нь шүүх, шүүгчийн гаргаж болох /хуулийг буруу хэрэглэсэн, бусдын нөлөөнд автсан гэх мэт/ алдаатай шийдвэрийг хянах боломжийг хааж иргэдийг хохироох, чирэгдүүлэх нөхцөлийг бий болгож байна. Ийнхүү хүний эрхийг хязгаарлаж буй нь шүүхийн анхан шатанд иргэний зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, итгэл үнэмшилтэй байх, цаашид төрийн байгууллага /шүүх/, албан тушаалтанд хандах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1, 170 дугаар зүйл 170.3 хэсгийн заалтуудыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү.

2. Иргэн Х.-гийн гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасныг Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.1-д “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ”, 16.2-т “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 16.6-д “Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй” хэмээн зааж баталгаажуулсан байна.

Миний бие Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх улс нийгмийн /төрийн/ өмч хөрөнгөд багагүй хохирол учрах зэргээр хууль зөрчигдөх нь төрийн ашиг сонирхол хохирох гэсэн ойлголтод хамрагдана гэж үзэж байгаа бөгөөд прокурорын байгууллага, прокурор аль нэг байгууллага, албан тушаалтны хүсэлтээр тэдгээрийг төлөөлөн өмгөөлөн хамгаалах үүрэгтэйгээр бус харин иргэдийнхээ зөрчигдсэн эрхийг сэргээх, улс нийгэмд учирсан хохирлыг арилгуулах гэх мэт хуулийн зөрчлийг таслан зогсоох зорилгоор төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэгчээр оролцож болохыг үгүйсгэхгүй байгаа болно.

Дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн прокурор төрийн байгууллагын / албан тушаалтан/ хүсэлтээр тухайн байгууллагыг төлөөлөн өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэн оролцох нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай тухай хуулийн 36.5.3-д “Өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд...прокурор... оролцож болохгүй” гэсэн заалттай зөрчилдөж байгаагийн зэрэгцээ хууль хяналтын байгууллагаар төлөөлүүлэх, өмгөөлөн хамгаалуулах давуу эрхийг төрийн байгууллага /албан тушаалтан/-д олгож байгаа нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхахгүй байх, Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн төр, бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Дээрх байдлаас дүгнэн үзээд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Дөчин есдүгээр зүйлийн 2, Тавьдугаар зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйл 16.1, 16.2, 16.6 дэхь хэсгийн заалтуудыг тус тус хүчингүй болгож өгнө үү.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О., Б. нарын тайлбарын агуулга:

1/ Прокурор Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд заасан шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргээ хэрэгжүүлж шүүх хуралд зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр зохигч буюу тэдний төлөөлөгчөөр өмгөөлөгчийн эрхтэй оролцох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг зохигч нөгөөхөөсөө олон хүн оролцуулснаар давуу тал эдлэхгүй юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэдэн ч өмгөөлөгч оролцож болохыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39.3-д тодорхой заасан юм. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсоноор ямар нэг давуу эрх эдлэх биш зөвхөн өмгөөлөгчийн эрхийг л эдэлнэ. Үүнийг Улсын дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолд тодорхой тайлбарласан. Эдгээр нь харин ч Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна гэсэн заалтыг хангаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ”, 26.4-д “зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрх эдэлнэ гэж тус тус заасны дагуу шүүх хуралдаан зохигчдын чөлөөтэй мэтгэлцэх зарчим”-аар явагдаж, зохигчид тэгш эрх эдлэх нөхцөл боллоцоогоор хангагдаж байна. Прокурор аль нэг талыг төлөөлснөөр шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байгаа хэрэг биш. Ингэж оролцсоноороо шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргээ л хэрэгжүүлж байгаа. Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн



31.1-д заасан прокурорын оролцооны тухай заалт нь 36.5.3-д заасан хязгаарлалттай зөрчилдөж байгаа гэж үзэж байгаа бол Үндсэн хуулийн цэцийн хэлэлцэх асуудал биш, Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ дагуу хянан шийдвэрлэх зүйл тул өргөдөл гаргагч Улсын Их Хуралд хандах нь зүйтэй юм.

2/ Тухайн асуудал шүүхэд харьяалагдахгүй тохиолдолд түүнийг давж заалдах шаардлага гарахгүй, тэгээд ч хуулийн 65.2-д заасны дагуу шүүгч захирамждаа уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, шүүх хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгснөөр хүний эрх зөрчигдөх нөхцөл үүсэхгүй. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг төр энэ үүргээ зөвхөн шүүхээр дамжуулан хэрэгжүүлнэ гэж өрөөсгөл ойлгож болохгүй юм. Маргааныг гагцхүү шүүх л шийдвэрлэнэ гэж ойлгох нь Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж зааснаас өөр ойлголт юм. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтаас ч энэ нь тодорхой харагдаж байна.

4. Иргэн Х.-гийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар бол прокурор нэг хурал дээр нэг болохоороо өмгөөлөгч болж, нөгөө болохоороо төрийг төлөөлсөн прокурор болж хувьсаж болохоор тодорхойлсныг би ер ойлгохгүй байна. Прокурор, өмгөөлөгч хоёр аль аль нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын суурь дээр төрөөс тогтоосон хууль цаазын үндсэн дээр өөр, өөрийн өвөрмөц эрх, үүрэгтэй, онцлог статустай. Ингэж хольж болдог юм уу. Нэртэйгээр нь тэгвэл өмгөөлөгч-прокурор гэдэг албан тушаал гаргавал яасан юм бэ? Төр гэдэг чинь ерөнхий ойлголт. Тэгэхлээр иргэн төртэй заргалдана гэвэл байгууллагатай л заргалдана гэсэн үг. Тэгээд бас байгууллагатай заргалдана гэдэг чинь “байшинтай” заргалдахгүй, тэр байгууллагын албан тушаалтантай заргалдана гэсэн үг. Ингэхлээр прокурор төрийг өмгөөлж хуралд оролцоно гэдэг чинь эцэстээ аль нэг тодорхой албан тушаалтныг өмгөөлнэ гэсэн үг. Ингэхээр шүүхийн өмнө очиж байгаа албан тушаалтан, иргэн хоёр тэгш бус байдалтай болж байна. Яагаад гэвэл албан тушаалтан болохоор үнэгүй /хөлс авдаггүй/, бас цол хэргэмтэй, төрийн том албан тушаалтан болох прокуророор өмгөөлүүлдэг, иргэн болохоор хөлс төлж жирийн өмгөөлөгч авдаг. Ийм байж яаж болох вэ?

5. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О., Б. Нарын Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбарын агуулга:

Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд прокурор өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ гэж заасан нь шүүх хуралд оролцсон прокурор төр гэж давамгайлахгүй, прокурор гэж давамгайлахгүй, хурлын бусад оролцогчдын л нэгэн адил, тухайлбал жирийн өмгөөлөгчийн л нэгэн адил эрхтэй оролцоно гэсэн санаа юм. Энэ нь харин тэгш бус байдлыг бий болгох биш, тийм байдлыг арилгаж байгаа юм. Харин ч прокурорын нэр хүнд, эрх дархыг хумьж байгаа юм. Иймд шүүхийн өмнө бүгд тэгш байх Үндсэн хуулийн заалт зөрчөөгүй.

Шүүх хуралд прокурор төрийн нэрийн өмнөөс оролцоно гэж заасан. Тэгэхлээр төрийн байгууллагыг төлөөлнэ гэдэг ч Үндсэн хууль зөрчөөгүй. Төлөөлөхгүйгээр яаж төрийн нэрийн өмнөөс оролцох юм бэ? Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын гомдол гаргах эрхийг хязгаарласан заалт хийсэн нь буруу биш. Шүүхээс гарч буй шийдвэрийн төрөл, утга агуулгаас үндэслэлд давж заалдаад байх шаардлагагүй олон зүйл бий. Тэднийг л 170.3-т нэрлэсэн. Иймд үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл муутай.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3-д шүүхээс нэхэмжлэлийг хянах явцад гаргасан зарим тогтоол, захирамжийг

давж заалдах гомдол гаргаж болохгүйгээр хуульчлан заажээ. Тухайлбал, Арбитр харьяалагдах хэрэг байна гэж буцаах /20.2/; нотолгооны ач холбогдолгүй хамааралгүй, эсвэл нууцад хамаарагдах зүйл гэж баримт сэлтийг нотлох баримтаас хасах, шаардан авахаас татгалзах /38.9/; шүүхэд болон тухайн шүүхэд харьяалагдахгүй гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.1, 65.1.2/; шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам зөрчсөн гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.3/; тухайн асуудлын талаар урд нь шүүх арбитрын шийдвэр гарсан гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.6/; маргаж байгаа зүйлийн талаархи хэргийг өөр шүүхэд шийдвэрлэж байгаа, тухайн асуудлыг эрүүгийн журмаар шалгаж байгаа, хариуцагчийн хаяг тодорхойгүй, хариуцагч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.7, 65.1.8, 65.1.9, 65.1.10/ зэрэг тогтоол захирамжийг давж заалдахгүй гэж хуульчилсан нь шүүх, шүүгч эдгээр асуудлаар алдах ёсгүй, цаашид дахин ярих шаардлагагүй гэсэн утга аястай болжээ. Гэтэл алдаагүй, ямагт зөв шийддэг асуудал гэж байдаггүй.

Нөгөө талаар шүүхийн ямар ч шийдвэрийг зохигчид хэрэв хүсвэл давж заалдах, дахин хянуулах зарчим зохигчдын хувьд үргэлж нээлттэй байх учиртай. Энэ нь шударга шүүхийн үйл ажиллагааны гол нөхцөл юм. Чухамхүү давж заалдах зарчим чөлөөтэй хэрэгжсэнээр шүүхийн шийдвэрийн үнэн зөв байх нөхцөл бүрэлдэнэ. Энэ ч учраас Монгол Улсын Үндсэн хуульд иргэд асуудлаа “шударга шүүхээр шүүлгэх”, “шүүхийн шийдвэрийг давж заалдах” гэсэн ойлголтуудыг иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний томоохон үзүүлэлт болгож оруулсан гэж үзэж болно. Энэ үүднээс авч үзвэл өргөдөл гаргагчийн эдгээр асуудлын талаар гаргасан хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

2. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тоочиж тодорхойлсон. Тухайлбал, энд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх, үүрэгтэй гэж ойлгож болно. Тэгэхлээр “өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэсэн нь Үндсэн хуульд томъёолсон прокурорын эрхийг хэт өргөжүүлэн үндэслэл муутай тайлбарлаж хуульчилсан байна. Прокурор шүүх хуралд оролцохдоо прокурорынхоо л эрх үүргийг оролцогчийн хувьд эдлэхээс биш /оролцогчийн эрх үүрэг буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх үүргийг эдлэх гэдэг нь нээлттэй бөгөөд энэ тухай прокурорын байгууллагын тухай хуульд ч заачихсан байгаа/ аль нэг өөр оролцогчийн, тухайлбал өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэх нь зохимжгүй юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд хуралд оролцсон прокурорт хэрэгтэй байж болох бүх эрх, үүрэг хуульчлагджээ. Мөн Прокурорын байгууллагын тухай хуулийг тайлбарласан Улсын дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны 2 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 3-д “Өмгөөллийн тухай хуулийн 16.3 дугаар зүйлд прокурор ажлаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон тул прокуророор ажиллаж байх үедээ Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэхгүй” гэж заасныг энд анхаарч үзэх нь зүйтэй байна.

3. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 6-д: “Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй” гэж заажээ.

Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцоно гэж заасан нь прокурорын үйл ажиллагааны нэг гол чиг үүргийг тодорхойлжээ. Иймээс энэ чиг үүргийг биелүүлэхээс татгалзаж болохгүй тухай прокурорын хуульд тодотгож заасныг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх боломжгүй байна.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.6-д зааснаар шүүгч иргэний нэхэмжлэлийг хянаж үзээд тухайн нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх асуудал шүүхэд харьяалагдахгүй буюу эсвэл уг асуудлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж урьд нь гарсан байвал хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргаж шийдвэрлэх нь буруу биш. Учир нь:

а/ шүүхэд харьяалагдахгүй асуудал, гомдол, санал гэж байдаг бөгөөд бүх зүйл, маргаан бүр зөвхөн шүүхээр хэлэлцэгдэн шийдвэрлэгдэх ёстой гэж үзэх боломжгүй. Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн нь маргасан, эргэлзсэн, гомдсон бүх зүйлийг шүүхээр “тасалж өгнө” гэсэн ойлголт биш юм.

б/ тухайн тодорхой нэхэмжлэлийг урьд нь хүлээж авахаас татгалзсан захирамж байгаад тэр нь хүчин төгөлдөр байгаа үед хүлээж авахаас татгалзах захирамж дахин гаргах нь иргэний өргөдөл гомдлыг шүүх ерөөсөө авч хэлэлцэхгүй орхиж байгаа хэрэг биш бөгөөд авч үзээд хуулийн дагуу шийдэж байгаа нэг хэлбэр юм. Нэхэмжлэлийг “хүлээн авахаас татгалзах” гэсэн нь байцаан шийтгэх ажиллагааны өвөрмөц хэллэг / томъёолол/ болохоос биш “шүүхийн хаалгаар битгий оруул” гэх маягтай утга биш юм. Иймээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тухай шүүгч захирамж гаргаж байгааг иргэний төрийн байгууллагад гомдол гаргах Үндсэн хуулийн эрхийг хязгаарлаж байна, төр иргэдийн гомдлыг шийдвэрлэх Үндсэн хуулийн үүргээ биелүүлээгүй байна гэж ойлгож болохгүй. Иймд энэ асуудлын талаар гаргасан өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй байна гэж үзлээ.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсэгт “Энэ хуулийн... 74, 75, 76, 106.5 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргаж болохгүй гэсэн нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэх үндэслэл харагдахгүй байна. Учир нь эдгээр зүйл нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан бөгөөд хэргийн зохигчид буюу гол оролцогч нэхэмжлэгч, хариуцагчид эвлэрэн хэлэлцэж, тохирсон тохиолдолд гарах тогтоол, захирамжийн тухай заажээ. Нэгэнт зохигчид бүгд эвлэрч тохирсон, хариуцагч үүргээ сайн дураараа биелүүлсэн бол шүүхийн энэ эвлэрлийг баталгаажуулсан тогтоол шийдвэрийг давах асуудал гарахгүй бөгөөд тэгэхээр аливаа хууль, тэгэх тусмаа Үндсэн хууль зөрчсөн асуудал энд яригдах учиргүй нь ойлгомжтой байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсэгт “Энэ хуулийн ...129, 130 дугаар зүйлүүдэд заасан тогтоол, захирамжид гомдол гаргаж болохгүй” гэжээ. 129, 130 дугаар зүйлд шүүх гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг хуульчилж өгсөн байна. Энэ нь хэргийг эцэслэн шийдэж байгаа биш, шийдэхийн өмнө насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, зохигчдын эвлэрлийн талаар хугацаа заах гэх мэтцаг алдалгүй авах зарим арга хэмжээг заажээ. Энэ нь түр арга хэмжээ бөгөөд хэргийг эцэслэн шийдвэрлэснээр дуусгавар болдог учир давж заалдаад байх шаардлагагүй юм. Иймд энд шүүхийн шийдвэрийг давж заалдах иргэний Үндсэн хуулийн эрх зөрчигдсөн байна гэж үзэх үндэслэлгүй байна.

6. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд тодорхойлсон “Прокурор... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн нь эрүү, иргэний болон бусад шүүх хуралд оролцож болохыг тодорхойлсон байна.

7. Үндсэн хуульд шүүх хуралд “төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн нь нэгэн утгаараа төр, түүний байгууллагыг төлөөлнө гэсэн үг гэж ойлгон тайлбарлаж болохоор

байна. Төр, түүний эрх ашиг нь төрийн тодорхой байгууллага, тэдгээрийн эрх ашгаар илэрдэг гэсэн хууль цаазын утга зохиолд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн томъёолол байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Иймд Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 1-д прокурор төрийн байгууллагын төлөөлөгчөөр оролцохоор заасан нь Үндсэн хууль зөрчиж байна гэж үзэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32, 33 дугаар зүйлүүдийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.1-65.1.3; 65.1.6-65.1.10 дахь... зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “Монгол Улсын иргэн... шударга шүүхээр шүүлгэх, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “... өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-д заасан “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн заалтыг зөрчсөн байна.

3. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16-ийн 6-д заасан: “Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах эрхгүй” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчөөгүй байна.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 651.1-д заасан “шүүхэд харьяалагдахгүй”, 65.1.6-д заасан “...эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан...” гэсэн заалт нь Үндсэн хууль зөрчөөгүй байна.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3-д заасан “Энэ хуулийн ...74, 75, 76 дугаар зүйл, 106 дугаар зүйлийн 5; 129; 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байна.

6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалт Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байна.

7. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан: “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож...” гэсэн заалт, мөн зүйлийн 2-д заасан “Прокурор энэ хуулийн 16-ийн 1-д заасан ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

8. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5; 15.1.6-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3-т заасан “Энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.1-65.1.3; 65.1.6-65.1.10 дахь... зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй” гэсэн заалт, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “...өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн... 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “Монгол Улсын иргэн...шударга шүүхээр шүүлгэх, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй” гэсэн заалт, Тавин зургадугаар зүйлийн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 1 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.1-д заасан “шүүхэд харьяалагдахгүй”, 65.1.6-д заасан “...эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан...”, 170.3-д заасан “Энэ хуулийн... 74, 75, 76 дугаар зүйл, 106.5; 129, 130 дугаар зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид зохигч гомдол гаргахгүй”, 31.1-д заасан “прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтууд, Прокурорын байгууллагын тухай хуулийн 16.6-д заасан “Төрийн байгууллага хүсэлт гаргасан бол иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос прокурор татгалзах ёсгүй”, 16.1-д заасан “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно...” гэсэн заалт, мөн зүйлийн 2-т заасан “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 1 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хууль хоорондын зөрчилдөөнгүй хийгээд Үндсэн хуульд нийцсэн байх зарчмыг мөрдлөг болгох ёстой. Гэтэл Өмгөөллийн тухай хуульд прокурор ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 3 жилийн дотор өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон атлаа Прокурорын байгууллагын тухай хуульд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо өмгөөллийн бүрэн эрх эдэлнэ хуульчилсан нь дээрх зарчим зөрчигдөхөд хүргэсэн байна. Эрх зүйн шинжлэх ухаанд прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох явдал зөвхөн эрүүгийн процесст л байх боломжтой гэж үздэг.

Гэвч шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд прокурор эрүүгийн хийгээд иргэний хэрэг, маргаан шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэгт төрийн эрх ашгийг хамгаалан оролцох утга агуулагдаж байдаг. Прокурор иргэний хэрэгт оролцохдоо хуулиар олгогдсон хэргийн оролцогчдын эрхийг эдэлж, үүргийг биелүүлэх боломж нээлттэй байтал заавал нэмж өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлүүлэхээр хуульчлах болов. Өмгөөлөл гэдэг биеэ даасан эрх зүйн үйл ажиллагаа, прокурор бас л Үндсэн хуульд чиг үүргийг нь тодорхойлсон Үндсэн хуулийн институт.

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд тусгайлсан шалгалтад орж, эрх авдаг болохыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд маш тодорхой заасан байдаг. Өөрөөр хэлбэл хичнээн сайн өмгөөлөл хийдэг чадвартай, мэдлэгтэй байлаа ч тэрхүү эрхийг аваагүй тохиолдолд шүүх хуралдаанд өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэх боломж байхгүй. Өмгөөлөл хийх, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэх гэдэг нь утга зүйн талаас ч, хууль зүйн хувьд өөр өөр ойлголт, үр дагаврыг агуулдаг болно.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2003.06.20 № 02**

**Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д., Б.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Иргэний эрх зүйн маргаан л шүүхэд харьяалагдах ёстой. Иргэний эрх зүйн маргаан биш л бол шүүхэд харьяалагдахгүй. Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзана гэдэг нь иргэний байцаан шийтгэхийн процессын өвөрмөц үйл ажиллагаа болохоос иргэдийг шүүхийн хаалгаар дахин оруулахгүй гэсэн үг биш. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6 дахь заалт нь давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах эрхийг нь хязгаарлаагүй болно.

2. Иргэн Х.-гийн тайлбарын агуулга:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.6 дахь заалтаар анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн талаар дээд шатны шүүхэд гомдол гаргах иргэний эрх хаагдаж байгаа юм.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.3-т шүүхээс нэхэмжлэлийг хянах явцад гаргасан зарим тогтоол, захирамжийг давж заалдах гомдол гаргаж болохгүйгээр хуульчлан заажээ. Тухайлбал, Арбитрт харьяалагдах хэрэг байна гэж буцаах /20.2/, нотолгооны ач холбогдолгүй хамааралгүй, эсвэл нууцад хамаарагдах зүйл гэж баримт сэлтийг нотлох баримтаас хасах, шаардан авахаас татгалзах /38.9/, шүүх болон тухайн шүүхэд харьяалагдахгүй гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.1, 65.1.2/, шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам зөрчсөн гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.3/, тухайн асуудлын талаар урьд нь шүүх арбитрын шийдвэр гарсан гэж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.6/, маргаж байгаа зүйлийн талаархи хэргийг өөр шүүхэд шийдвэрлэж байгаа, тухайн асуудлыг эрүүгийн журмаар шалгаж байгаа, хариуцагчийн хаяг тодорхойгүй, хариуцагч иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн

авахаас татгалзах /65.1.7, 65.1.8, 65.1.9, 65.1.10/ зэрэг асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг давж заалдахгүй гэж хуульчилсан нь шүүх, шүүгч эдгээр асуудлаар алдах ёсгүй, цаашид дахин ярих шаардлагагүй гэсэн утга агуулгатай болжээ. Гэтэл алдаагүй, ямагт зөв шийддэг асуудал гэж байдаггүй.

Нөгөө талаар шүүхийн ямар ч шийдвэрийг зохигчид хэрэв хүсвэл давж заалдах, дахин хянуулах зарчим зохигчдын хувьд үргэлж нээлттэй байх учиртай. Энэ нь шударга шүүхийн үйл ажиллагааны гол нөхцөл юм. Чухамхүү давж заалдах зарчим чөлөөтэй хэрэгжсэнээр шүүхийн шийдвэрийн үнэн зөв байх нөхцөл бүрэлдэнэ. Энэ ч учраас Монгол Улсын Үндсэн хуульд иргэд асуудлаа “шударга шүүхээр шүүлгэх”, “шүүхийн шийдвэрийг давж заалдах” гэсэн ойлголтуудыг иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний томоохон үзүүлэлт болгож оруулсан гэж үзэж болно.

2. Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэж заасан нь Үндсэн хуулийн заалт зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд прокурорын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тоочиж тодорхойлсон. Тухайлбал энд зааснаар прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох л үндсэн эрх үүрэгтэй гэж ойлгож болно. Тэгэхлээр “өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэсэн нь Үндсэн хуульд томьёолсон прокурорын эрхийг хэт өргөжүүлэн үндэслэл муутай тайлбарлаж хуульчилсан байна. Прокурор шүүх хуралд оролцохдоо прокурорынхоо л эрх үүргийг оролцогчийн хувьд эдлэхээс биш /оролцогчийн эрх үүрэг буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан эрх, үүргийг эдлэх гэдэг нь нээлттэй бөгөөд энэ тухай прокурорын байгууллагын тухай хуульд ч заачихсан байгаа/ аль нэг өөр оролцогчийн, тухайлбал өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэх нь зохимжгүй юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд хуралд оролцсон прокурорт хэрэгтэй байж болох бүх эрх, үүрэг хуульчлагджээ. Мөн Прокурорын байгууллагын тухай хуулийг тайлбарласан Дээд шүүхийн 2003 оны 2 дугаар сарын 20-ны 2 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 3-т “Өмгөөллийн тухай хуулийн 16.3 дугаар зүйлд прокурор ажлаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон тул прокуророор ажиллаж байх үедээ Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан өмгөөлөгчийн бүрэн эрхийг эдлэхгүй” гэж заасныг энд анхаарч үзэх нь зүйтэй байна.

Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.3 дахь хэсгийн “...энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.3; 65.1.6; 65.1.10 дахь ...зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй” гэсэн заалт, мөн Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэсэн заалтын “... өмгөөлөгчийн бүрэн эрх эдлэнэ” гэсэн хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтын “...34 дүгээр” гэсэн хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын иргэн... шударга шүүхээр шүүлгэх... шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолын 1 дүгээр заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн Цэцийн 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 болон 16.2 дахь хэсгийн заалтад доорх байдлаар өөрчлөлт орсон нь хүчин төгөлдөр үйлчилж байна.

16.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцоно.

16.2. Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2003.05.21 № 02**

**Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, 2003 оны төсвийн тухай хууль, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоол, “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н., Б., Ч., Б., Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Т.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Санхүү, эдийн засгийн сайд У.,  
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2002 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль<sup>61</sup>

- 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь улсын төсвийн бүрэлдэхүүн байна”

61 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 44-д нийтлэгдсэн



2. Улсын Их Хурлаас 2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хууль<sup>62</sup>

- 1 дүгээр зүйлийн 1.1.1.ж заалт “нийгмийн даатгалын шимтгэл”
- 2 дугаар зүйлийн 2.1.19 дэх заалт “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багц”

3. Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоол<sup>63</sup>

- Хавсралтын 25 дахь заалт “Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар Хөдөлмөр эрхлэлтийн газар”

4. Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 272 дугаар тогтоолын 2 дугаар заалт

- “Нийгмийн даатгалын сангуудыг төрийн нэгдсэн санд 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс байршуулж тэтгэвэр, тэтгэмж тавьж олгох ажлыг тасалдалгүй зохион байгуулан журам гарган ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд У., Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Б. нарт даалгасугай”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”
- Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”
- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н., Б., Ч., Б., Э. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 1.1.1.ж, 2.1.19 дахь заалт, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад дурдсан хүснэгтийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн баганын 25, “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дугаар заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь... өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь... аж ахуйн бүх хэвшлийн... хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, ... хөрөнгө..., эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах... -ыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна гэж үзэж байна.

62 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 44-д нийтлэгдсэн

63 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 28-д нийтлэгдсэн

1/ Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 1.1.1.ж, 2.1.19 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчиж байна.

а/ 1995 онд батлан гаргасан нийгмийн даатгалын багц хуулиуд болон 1999 онд нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу нийгмийн даатгалын сангууд нь өмчийн бүх хэвшлийн байгууллагууд, түүнчлэн ажилтан, албан хаагчид цалингаасаа шимтгэл төлж бүрдүүлдэг холимог өмчийн сан болсон билээ. Иймд нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нь улсын төсвийн хөрөнгө биш, харин холимог өмчийн хөрөнгө юм. Энэхүү холимог өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцааг зохицуулсан нийгмийн даатгалын багц хуулиуд байсаар байтал төсөв, санхүүгийн тухай хуулиудаар уг харилцааг давхар зохицуулж байгаа нь нийгмийн даатгалтай шууд холбогдсон хуулиудаа дээдлэн үзэж хэрэгжүүлэхгүй байгаа хэрэг мөн. Нийгмийн даатгалын тухай багц хуулиудыг ийнхүү төсөв, санхүүгийн тухай хууль тогтоомжоор үгүйсгэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчсөн байна.

б/ Нийгмийн даатгалын сангууд нь холимог өмчийн хөрөнгө гэдгийг Улсын Их Хурал, Засгийн газар хүлээн зөвшөөрөхгүй байна. Энэ нь нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг улсын төвлөрсөн төсвийн орлого, зарлагад хамааруулан үзэж төвлөрсөн төсвийн хуульд тусгаснаар нотлогдсон юм. Ийм учраас Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 1.1.1. ж, 2.1.19 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасныг зөрчсөн байна.

в/ Нийгмийн даатгалын тогтолцоо нь гурван талт өөрийгөө удирдах удирдлагатай, холимог өмчийн хэвшилд хамрагдах өвөрмөц байгууллага хэлбэрээр хөгжиж байгаа билээ. Энэ нөхцөлд төр нь олон арван тэрбум төгрөгөөр үнэлэгдэх хөрөнгө бүхий нийгмийн даатгалын сангуудыг холимог өмчийн өвөрмөц хэлбэрийнх нь хувьд хөгжүүлэх зорилгоор зохицуулалт хийх үүрэгтэй. Гэтэл нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг улсын төвлөрсөн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүнд хамааруулж улмаар төрийн өмч байдлаар ашиглах, нийгмийн даатгалын байгууллагыг төрийн захиргааны байгууллага хэлбэрээр хөгжүүлэх зохицуулалт хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасныг зөрчсөн байна.

г/ Нийгмийн даатгалын шимтгэл нь ирээдүйд тохиолдож болох эрсдэлээс хамгаалах зорилгоор нийгмийн даатгалын санд хадгалуулж буй даатгуулагчийн хувийн өмч учир энэхүү өмчөө даатгуулагчид нь эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй. Гэтэл Засгийн газар нийгмийн даатгалын сангуудыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулснаар уг хөрөнгийн чөлөөт үлдэгдэл болон хуримтлалыг эзэмших, ашиглах, зориулалтын бус зүйлд зарцуулах бололцоотой болж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

2/ Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад дурдсан “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн баганын 25 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчиж байна.

а/ Улсын Их Хурал, Засгийн газар нь нийгмийн даатгалын сангуудыг холимог өмчийн хэлбэрт шилжүүлснийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Нийгмийн даатгалын байгууллага нь улсын нэгдсэн төсөв болон орон нутгийн төсвөөс санхүүждэггүй бөгөөд өөрийгөө санхүүжүүлэх зарчмын хүрээнд буюу дээр дурдсан холимог өмчийн сангуудаас үйл ажиллагааны зардлаа бүрэн нөхөж ажилладаг учир тэрээр төрийн захиргааны байгууллагад хамаарагдах ёсгүй. Иймээс Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгож баталсан дээр дурдсан тогтоолын хавсралтын 25 дугаар заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасныг зөрчсөн байна.

б/ Нийгмийн даатгалын байгууллага нь холимог өмчийн хэвшилд хамаарагддаг, өөрийгөө удирдах удирдлагатай үйлчилгээний байгууллага болох чиглэлээр хөгжиж байна. Гэтэл Улсын Их Хурал, Засгийн газраас нийгмийн даатгалын тогтолцоог төрийн захиргааны төсөвт байгууллага байдлаар хөгжүүлэх зохицуулалт хийж дээр дурдсан тогтоолд тусгажээ. Иймд дээр дурдсан тогтоолын хавсралтын 25 дугаар заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасныг зөрчсөн байна.

в/ Улсын Их Хурлын тогтоолын дагуу нийгмийн даатгалын байгууллагыг төрийн захиргааны байгууллагад хамааруулж, улмаар нийгмийн даатгалын сангуудыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулснаар энэхүү холимог өмчийг өмчлөгч даатгуулагчдын уг өмчөө эзэмших, ашиглах, өмчлөх эрхэд нь халдах бололцоотой болж байна. Энэ нь дээр дурдсан тогтоолын хавсралтын 25 дугаар заалт нь мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөнийг харуулж байна.

3/ Монгол Улсын Засгийн газрын “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дугаар заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчиж байна.

а/ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна”, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нэг төрлийн сангийн хөрөнгийг өөр төрлийн санд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэж заасан байдаг. Гэтэл “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах” нэрийн дор хуулийн эдгээр заалтыг зөрчиж Монгол Улсын Засгийн газраас 272 дугаар тогтоол гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчсөн байна.

б/ Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 2002 оны 58 дугаар тогтоол, “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоол зэргийг үндэслэж Нийгмийн даатгалын байгууллагуудын дансан дахь болон банкинд хадгалуулсан хуримтлалын хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд албадан шилжүүлэх гэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасныг зөрчсөн байна. Ер нь нийгмийн

даатгалын холимог өмчийн хэлбэрийг Засгийн газар хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь банк, санхүүгийн талаар дэс дараалан боловсруулж гаргасан дээр дурдсан хууль, тогтоолуудаас ил тод харагдаж байгаа юм.

в/ Нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын 5 төрлийн сангийн хөрөнгийг ямар банканд хадгалуулахыг өөрөө шийдвэрлэж ирсэн. Гэтэл Засгийн газар нь төрийн сангийн нэгдсэн дансанд нийгмийн даатгалын сангуудыг хүчээр байршуулж Нийгмийн даатгалын байгууллагын дээр дурдсан эрхийг хязгаарлаж түүний цаашдын хөгжлийг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна. Ийм учраас Засгийн газрын 272 дугаар тогтоолын 2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасныг зөрчсөн байна.

г/ Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулснаар даатгуулагч иргэдийн хөдлөх хөрөнгөө эзэмших, ашиглах, өв залгамжлуулах эрх зөрчигдөж тэдний хөрөнгийг Засгийн газар зориулалтын бус зүйлд дайчлах бололцоотой болж байна. Ийм учраас Засгийн газрын 272 дугаар тогтоолын 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., Т. нарын тайлбарын агуулга:

Нэгдүгээрт, Социализмын үеийн нийгмийн даатгал нь нийгмийн хангамжийн үндсэн хэлбэрийн нэг болж байсан бөгөөд энэ нь хөдөлмөрчдөөс өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, болон тэдгээрийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн материаллаг хангамжийн төрийн систем байв. Эдгээр арга хэмжээг албан байгууллага, үйлдвэр зэрэг бусад байгууллагаас заавал оруулах шимтгэл болон улсын төсвийн татаасаар байгуулагддаг сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлдэг байв. Нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг үйлдвэр, албан газар, байгууллага нь шимтгэлийг бүрэн төлж, хөдөлмөрчдийн цалин хөлснөөс эдгээртэй холбоотой аливаа суутгал хийдэггүй байв. Социализмын үеийн нийгмийн даатгалын удирдлагыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд хэрэгжүүлж байв. Өөрөөр хэлбэл тухайн нэг үйлдвэр, албан газар дээр ажиллаж байгаа бүх хүний нийгмийн даатгалын асуудлыг тухайн байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороо хариуцдаг байсан.

Одоо манай улсад 1995 оноос нийгмийн даатгалын шинэ тогтолцоо бүрэлдэж тогтсон билээ. Тухайлбал, өндөр насалсан, хөдөлмөрийн чадвараа алдсан, тэжээгчээ алдсан, ажилгүй болсон зэргээс шалтгаалан цалин хөлсгүй болсон тохиолдолд ажилчдад үзүүлэх нийгмийн халамжийн үндсэн хэлбэр мөн. Гол зарчим нь даатгуулсан ажилтны цалин хөлснөөс даатгалын зохих хувийг шимтгэлийг суутган авч даатгалын санд төвлөрүүлэх явдал билээ. Энэхүү даатгалын сангийн хөрөнгө нь даатгуулагчаас төлсөн шимтгэл, тухайн ажилтныг ажиллуулж байгаа үйлдвэр, албан газар, байгууллагаас төлсөн шимтгэл болон төрөөс олгосон татаас байна.

1/ Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх нь Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө /1995 оны 1 дүгээр сарын 1-нээс/ үүссэн үүргийн дагуу тэтгэврийн даатгалын санд Монгол Улсын төсвөөс жил бүр санхүүжилт өгч байгаа бөгөөд төсвийн санхүүжилтийн хэмжээ Монгол Улсын Засгийн газраас тэтгэвэр, тэтгэмж авагчдын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй шууд уялдаатайгаар жил бүр өгч байна. Улс орны үйлдвэрийн хөгжил, эдийн засаг сул өнөө үед тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг дан ганц нийгмийн даатгалын орлогын өсөлтөөр хангах боломж үгүй юм. Ийм үед иргэдийн ялангуяа тэтгэвэр, тэтгэмж авагчдынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс төрийн бодлоготой хандаж хяналт тавьж байх явдал зайлшгүй болж байгаа юм.

2/ Хэрэв нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, бүрдүүлэлтийн асуудлыг төр, засгийн хэрэгжүүлэх чиг үүргээс хамааралгүй болговол төрөөс тэтгэвэр тэтгэмж нэмэгдүүлэх бодлого хэрэгжихгүй, зөвхөн нийгмийн даатгалын сангийн хуримтлалын хэмжээнд нийгмийн бодлого явагдах болно. Ийм нөхцөлд төрөөс тэтгэвэр авагчдын эрх ашгийг хамгаалах тэдний амьжиргааг дэмжих боломжгүй болж ядууралд өртөх боломж тэтгэвэр тэтгэмж авагчдын дунд буй болох юм.

3/ Нийгмийн даатгалын сангийн жил бүрийн орлого, зарлага улсын нэгдсэн төсвийн тэнцэлд тусгагдаж байгаа нь улс орны хэмжээнд хүн амын гар дээр очиж байгаа мөнгөн орлого, зарлагын урсгалыг тооцож иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох, ядуурлаас хамгаалах, мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах эдийн засгийн олон чухал арга хэмжээ юм.

4/ Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 заалтад “Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд харимтлуулан хуваарилж зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэнэ” гэж тодорхойлсон. Нийгмийн даатгалын сангийн тодорхой хэсэг нь төсвийн хөрөнгө болохын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүнд орж орлого, зарлага нь улсын төсвийн тэнцэлд тусч батлагддаг.

Хоёрдугаарт, 1994 оны 5 дугаар сарын 31-нд баталсан Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн зэрэг 5 төрлийн даатгалын сан байгаа бөгөөд мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн орон тооны бус гишүүдээс бүрдсэн Улсын Их Хурлаас байгуулагдсан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталж байх заалт мөрдөгдөж байгаа болно.

Нийгмийн даатгалын тухай Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлд нийгмийн даатгалын төв байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний удирдлага дор ажиллаж, нийгмийн даатгалын төв байгууллагын даргыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилох, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 1 дүгээр зүйлд Засгийн газрын гишүүн нь харьяа яам болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байхаар тус тус заасны дагуу нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн буюу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нь нийгмийн даатгалын төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч юм.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд улсын төсвийн төсөлд төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг тусгаж, төсвөөс санхүүжиж байгаа бүх байгууллагын төсөв аль нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамрагдах, 33 дугаар зүйлд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт улсын төсвөөс төлөх тэтгэвэр, тэтгэмж, бусад зарлагыг төрөл, анги бүрээр, улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төрөл бүрээр тусгахаар тус тус заасныг үндэслэн Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 2.1.19 дэх заалтад нийгмийн даатгалын сангийн зардлыг эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган баталсан юм.

Тухайлбал:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчөөгүй, учир нь нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулсан асуудлыг илүү нарийвчлан тодруулж өгсөн болно.

б/ Нийгмийн даатгалын сангуудыг төвлөрсөн төсвийн хуульд тусгасан явдал нийгмийн даатгалын орлого нь татварын орлого биш харин нийгмийн даатгалын шимтгэлийг төсвийн орлого гэж тооцож, төсвөө баталж ирсэн байдаг тул Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэснийг зөрчөөгүй билээ.

в/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг буюу “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заалтыг зөрчөөгүй, учир нь нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг улсын төвлөрсөн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүнд хамааруулсан нь нийгмийн даатгалын орлого нь татварын орлого биш, харин нийгмийн даатгалын шимтгэлийг төсвийн орлого гэж тооцож, төсвөө баталж ирсэн уламжлалтай, гэхдээ өмнө дагаж мөрдөж байсан төсвийн тухай хууль тогтоомжоор зүйлчлэн заагаагүй байлаа. Иймд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь төсвийн орлого гэж урьд нь байсан одоо ч байгаа болно.

г/ Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 14.1-д заасны дагуу Монгол Улсын төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ улмаар төрийн сангийн дансыг Монголбанк, түүний харьяа салбарууд болон гэрээний үндсэн дээр арилжааны банкуудад байршуулж болно гэж заасны дагуу хөрөнгийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалыг эзэмших, ашиглах, зарцуулалтын асуудал банкнаас харилцагчтай харилцдаг журмаар явагдах тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй болно.

Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад дурдсан “Засгийн газрын хэрэгжүүлэгч” агентлаг гэсэн баганын 25 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийг зөрчсөн тухайд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 1-д “Монгол Улсын яам, төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна” гэж заасны дагуу 1993 оны 5 дугаар сарын 6-ны өдөр баталсан Засгийн газрын тухай хуулийн 18.2.1-ийн Засгийн газар үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн бүдүүвчийн дагуу байгуулж ажиллуулж болно, мөн Төсвийн удирдлага, санхүүжилтийн тухайхуулийн 7.2-д “Засгийн газар агентлаг байгуулах саналыг тухайн агентлагийн нийлүүлэх бүтээгдэхүүн нь төрийн чиг үүрэгт хамаарч байгаа; хуульд заасан болон уг бүтээгдэхүүнийг тухайн агентлагаар хийж гүйцэтгүүлэхээр Засгийн газар тодорхойлсон бол Улсын Их Хуралд гаргана” гэсэн заалтыг удирдлага болгосон билээ.

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8-д зааснаар Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын бодлого орж байгаа тул Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагт хамааруулсан болно.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь нийгмийн даатгалын төв байгууллага /Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар/ орон нутгийн салбар, нэгж /төлөөлөгч, байцаагч/-ээс бүрдэж байгаа бөгөөд 24 дүгээр зүйлд зааснаар нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, нийгмийн

даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж үйлчилгээг сайжруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Өмнө нь дагаж мөрдөж байсан Улсын Их Хурлын шийдвэрүүдэд тухайлбал, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 2000 оны 32 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 3 дахь баганын 23, мөн “төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай” 1996 оны 40 дүгээр тогтоолоор баталсан 3 дахь баганын 33-т Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байхаар тус тус баталж байжээ.

3. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч У. Б. нарын тайлбарын агуулга:

“Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дугаар заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх талаар:

1/ Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “Монгол Улсын төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ” гэж заасан болон “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолын дагуу төрийн сангийн нэгдсэн сангийн тогтолцоонд шилжсэнээр улсын төсвийн орлого, зарлагатай холбогдолтой Засгийн газрын гадаад, дотоод бүх төлбөр тооцооны гүйлгээ Төрийн сангаар дамжин гүйцэтгэгдэж байна. Өөрөөр хэлбэл төрийн сан нь зээлийн үйл ажиллагаа явуулдаггүй боловч улсын төсөвтэй харилцаж төсвөөс санхүүждэг байгууллагууд, Засгийн газрын тусгай зориулалтын сангууд болон Засгийн газрын агентлагуудын харилцах дансыг байршуулж төрийн өмнө банкны үйлчилгээ үзүүлэх үүргийг хүлээж байна.

2/ “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын 2-т “Нийгмийн даатгалын сангуудыг төрийн нэгдсэн санд 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс байршуулж тэтгэвэр, тэтгэмж тавьж олгох ажлыг тасалдалгүй зохион байгуулан журам гарган ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд У., Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Б. нарт даалгасугай” гэж заасан нь Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “Монгол Улсын төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ”, 9 дүгээр зүйлийн 9.3 хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого улсын төсвийн бүрэлдэхүүн байна”, “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох...”, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, улсын хяналт шалгалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ”, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8 дахь заалтад “Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд: -нийгмийн даатгалын бодлого” гэж тус тус заасныг үндэслэн шийдвэрлэжээ.

3/ Нийгмийн даатгалын сангуудыг төрийн санд байршуулснаар уг сангуудыг эрсдлээс хамгаалах, тухайн сангуудаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээг нийгмийн даатгалын багц хуулиудын дагуу цаг хугацаанд нь зохих ёсоор нь гүйцэтгэх боломж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ сангийн хөрөнгийн зарцуулалт, удирдлага, санхүүжилтийг Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу хараат бусаар, бие дааж явуулах эрх нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын төв байгууллагад хадгалагдаж байна.

4/ Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоол батлагдахаас өмнө нийгмийн даатгалын сангуудын харилцах данс нь арилжааны банкинд байршиж, орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээ нь арилжааны банкаар дамжин гүйцэтгэгдэж байсан бөгөөд арилжааны банкууд нь аж ахуйн нэгж, байгууллага, нийгмийн даатгалын сангуудын харилцах данс, иргэдийн хадгаламжийн хөрөнгөөр зээл олгож ашиг олж байсан юм. Харин төрийн сан нь зээл олгодоггүй учир нийгмийн даатгалын сангийн хувьд эрсдэлд өртөхгүй байх баталгааг бүрдүүлж байна.

5/ Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дахь заалтын дагуу Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нь төв, орон нутгийн төрийн сангуудад нийгмийн даатгалын сан тус бүрээр тухайн даатгалын байгууллагын нэрээр тусгай дансанд байршиж байгаа нь Нийгмийн даатгалын тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь ...мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна”, 10 дугаар зүйлийн 2, “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нэг төрлийн сангийн хөрөнгийг өөр төрлийн санд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь улсын төсвийн бүрэлдэхүүн байна” гэж заасныг нийгмийн даатгалын орлого улсын санхүүгийн нэгдсэн системд тусгалаа олно гэж өргөн утгаар тайлбарлах боломжтой. Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэмд /1994/ зааснаар нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг шимтгэлийн орлогоос санхүүжүүлдэг боловч энэ нь иргэний эрх зүйн хуулийн этгээд биш юм. Нийгмийн даатгалын бүх шатны байгууллага жилийн орлого, зарлагын төсөвтэй. Мөн улсын төвлөрсөн төсвөөс нийгмийн даатгалын сан, тухайлбал тэтгэврийн даатгалын санд олгох хөрөнгийг жил бүр тогтоох талаар Нийгмийн даатгалын тухай хуулиар /1994/ зохицуулсан байдаг. Төсөв бол мөнгөн орлого, зарлагын нэгдсэн гүйлгээний тэнцэл бөгөөд улсын төсөв нь улсын хэмжээний хүрээнд үйлчлэх мөнгөн хөрөнгийн нэгдсэн баланс юм. Нийгмийн даатгалын шимтгэл нь зөвхөн хуульд заасан тодорхой зориулалтаар ашиглагдах ёстой холимог өмчийн хөрөнгө мөн боловч улсын хэмжээнд гүйлгээнд байгаа нийтийн мөнгөн хөрөнгийн бүрдүүлбэрт багтана. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг улсын хэмжээний мөнгөн хөрөнгийн нэгдсэн тэнцэлд тусгаж байгаа нь тус хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах харилцаанд нөлөөлөх хууль зүйн үндэслэлийг бий болгохгүй. Иймд Нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь улсын төсвийн бүрэлдэхүүн байна” гэсэн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийг төсвийн орлогод хамааруулахаар хуульд тодорхойлсон нь энэ шимтгэлийг өргөдөл гаргагчдын ойлгож байгаа шиг төсвийн дутууг нөхөхөд зарцуулж болно гэсэн ойлголт биш бөгөөд гагцхүү төсвийн орлого, зарлагын тэнцлийн бүрдлийг задлан харуулах гэсэн зорилттой гэж Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч тайлбарлаж байгааг хүлээн авах үндэслэлтэй байна. Нөгөө талаар даатгалын шимтгэл нь татварын нэгэн өвөрмөц хэлбэр гэж эдийн засаг, хууль зүйн утга зохиолд тайлбарладаг үзэл онол байдгийг ч анхаарахад илүүдэхгүй. Иймд нийгмийн даатгалын шимтгэлийг төсвийн орлогын хэлбэрт оруулсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн /2002/ 2.1.19-д зааснаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багцыг Монгол Улсын 2003 оны төсвийн зарлагын нийт дүнд оруулан тооцсон байна. Төсвийн багцыг нийт 18



байгууллага, сан бүрдүүлэх ба үүнд нийгмийн даатгалын сан мөн хамаарч байна. Хууль тогтоогч Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар /1993/ Засгийн газрын бүрэлдэхүүнийг батлан Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээг тогтоохдоо нийгмийн даатгалын бодлогыг Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалуулжээ. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг улсын хэмжээний мөнгөн хөрөнгийн нэгдсэн тэнцэлд тусган улмаар төсвийн бүрэлдэхүүнд хамааруулж байгаа, мөн төрийн хөгжлийн шилжилтийн үе шатанд нийгмийн даатгалын тогтолцоонд өөрөө удирдах ёсны зарчим үүсч хэрэгжих хүртэл нийгмийн даатгалын бодлогыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцдаг нийтлэг жишиг байдгийг үндэслэн Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 2.1.19 дэх заалтаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багцыг Монгол Улсын 2003 оны төсвийн зарлагын нийт дүнд оруулан баталсныг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтад дурдсан “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн баганын 25 дахь заалт Үндсэн хуулийг зөрчиж байгаа эсэхийг шалган үзэхэд, нийгмийн даатгалын тогтолцоо нь хөрөнгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, даатгалын үйлчилгээ үзүүлэх тохиолдол зэргээр дан ганц улсын төсвийн хөрөнгөөс санхүүждэг нийгмийн халамжийн өмнөх тогтолцооноос үндсээрээ ялгаатай байна. Гэхдээ нийгмийн даатгалын байгууллага өөрөө удирдах ёсны зарчмаар ажиллах нөхцөл бүрэлдэн тогтож, нийгмийн даатгалын төлбөр тооцоо хийх журам олон улсын стандартад нийцэн, даатгалын сангуудын зарцуулалтад тавих бүх төрлийн хяналтын механизмыг шинэчилж дуусах хүртэл Нийгмийн даатгалын ерөнхий газар Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлаар ажиллаж байгааг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

5. Монгол Улсад одоо хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын тогтолцоо нь төрийн даатгалын тогтолцоо бөгөөд хувийн даатгал биш юм. Энэ нь даатгалын шимтгэл түүний хэмжээ, даатгал олголтын хэмжээ журам нь бүгд төрийн хуулиар тодорхойлогддог илэрнэ. Нөгөө талаар даатгалын тохиолдлын төлбөр болон байж болох бүх эрсдэлийг төр дангаараа үүрч хариуцдаг нь нийгмийн даатгал нь төрийн үйл ажиллагаа гэдгийг харуулж байна. Нийгмийн даатгалын хөрөнгө нь нийтийн өмч бөгөөд төрийн эзэмшилд байж, түүний шийдвэрээр зөвхөн даатгалын зориулалтаар зарцуулагддаг. Иймд Засгийн газар даатгалын хөрөнгийг төвлөрүүлж, хяналтыг тодорхой болгох, аливаа эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч байгаа Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нь улсын төсвийн бүрэлдэхүүн байна” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуулийн 1.1.1.ж-д зааснаар албан татварын орлогод нийгмийн даатгалын шимтгэлийг хамааруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын 2003 оны Төсвийн тухай хуулийн 2.1.19 дэх заалтаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багцыг төсвийн зарлагын нийт дүнд хамааруулан баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хөдлөх үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

4. Улсын Их Хурлаас 2002 онд баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоолын хавсралтын 25 дахь заалтаар Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагт хамааруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

5. Монгол Улсын Засгийн газрын “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дугаар заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хөдлөх, үл хөдлөх, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

6. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн

авснаас хойш 15 хоногийн дотор авч хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 25 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалт, 2003 оны Төсвийн тухай хуулийн 1.1.1.ж, 2.1.19 дэх заалт, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүлчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын 2002 оны 58 дугаар тогтоолын хавсралтын 25 дахь заалт, Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолын 2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

1. 1990-ээд оны дунд үеэс нийгмийн даатлагын тогтолцоо бий болж, холбогдох шийдвэр гарч эхэлсэн. Жишээ нь, 2002 оны 6 дугаар сард Засгийн газраас 119 дүгээр тогтоол гарган нийгмийн даатгалын хөрөнгийг улсын төсвөөс ангид байлгах, өөр хэлбэл аль болох салгах чиг хандлага барьсан байдаг. Гэсэн атлаа Засгийн газраас тэр ондоо 272 дугаар тогтоол гарган өмнөх тогтоолын үзэл баримтлалаас 100 хувь эсрэгээрээ буюу нийгмийн даатгалын хөрөнгийг буцаагаад төсвийн нэгдсэн дансанд шилжүүлэх шийдвэр гаргасан. Энэ нь нэлээд маргаантай олон талаас нь бодож судалж үзэх асуудал байсан.

Тиймээс ч Цэц маргааныг шалгаж, шийдвэрлэхдээ ОХУ, БНХАУ, ХБНГУ зэрэг гадаад орны туршлагыг сонирхож, нийгмийн даатгал, даатгалын сонгодог загвар, түүний мөн чанарыг илрүүлэхийг зорьж байсан. Шилжилтийн үед төрийн оролцоогүйгээр зөвхөн даатгуулагчдын төлсөн мөнгөн хуримтлалаар нийгмийн халамж, үйлчилгээг бүрэн хангах боломжгүй болох нь олон орны туршлагаас тодорхой байсан. Нийгмийн даатгалын тогтолцоо сонгодог гольдрилоороо явах хэтийн нөхцөлд даатгалын мөнгөн хөрөнгийг төсвөөс салгах чиглэл өөрөөр нь өөрийг нь санхүүжүүлэх, нийгмийн даатгалын санг аажмаар биеийг даалгах нь зүйн хэрэг.

2. Сонгодог утгаар нь авч үзвэл Нийгмийн даатгалын шимтгэл бол Улсын төсвийн бүрэлдэхүүн биш юм. Дээр дурдсан шийдвэр хэрэгжиж эхэлсэн үеэс Нийгмийн даатгалын байгууллага, ажилтнууд төрийн албаны статуст хамрагдах болсон гаж тогтолцоо үүссэн. Угтаа бол Нийгмийн даатгалын үндсэн асуудал Иргэний эрх зүйгээр зохицуулагдах учиртай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2003.10.29 № 03

### Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11, 45.7 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль<sup>64</sup>

- 5 дугаар зүйлийн 5.1.11 дэх заалт “Гэр бүлийн гишүүн” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг”
- 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг “Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх...”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Н.-ийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-д зааснаар Монгол Улсын иргэн нь “өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх” үндсэн эрхтэй.

Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7-д “Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэж хуульчлан тогтоож, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасныг өргөтгөн тайлбарлаж зөрчсөн гэж үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.14-д “Төрөл, садангийн хүн” гэж нэг гэр бүлд хамт амьдардаггүй эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, ач зээ, гуч, жич, төрсөн ах, эгч, дүү авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хэлнэ хэмээн тайлбарлав. Энд төрөл, садан гэх дундаа таслалтай хоёр өөр үгийг нэг ижил агуулгаар тайлбарласан нь буруу байх ба тайлбарын агуулга нь хэт механик субъектив шинжтэй, төрөл саданг ойлгох ард түмний үндсэн ойлголттой зөрчилдөж байна. Энэ шалтгаанаар үл төгсөх маргаан үүсэх, төрөл, садангийн тоо төрөл /хуульд заасан/ улам өсөх нээлттэй байдлыг бий болгосон байж болзошгүй байна.

Төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөвхөн гэрчид олгоод, процессын бусад оролцогчид, тухайлбал хохирогч, сэжигтэн, яллагдагч нарт үл хамааруулж, үл олгосон нь /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 35, 36, 42/, Үндсэн хуульд тунхагласан тэгш эрхийг зөрчиж тухайн тодорхой эрхийг нийт иргэдэд олгосныг

64 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны №6-д нийтлэгдсэн

зөрчиж явцуу болгосон байна. Ингэснээрээ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шударга ёс, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн заалтыг давхар зөрчиж байна.

Монгол орны иргэдийн ахуй амьдрал бусад орнууд ялангуяа европын суурьшсан орны иргэдийнхээс огт өөр малчид хоёр, гурван гэрээрээ хот суурин газарт хашаанд мөн л 2-3 гэрээрээ гол төлөв хамт амьдардаг. Эдгээр нь эцэг, хүү, хүргэн, төрсөн ах дүүсийнх гээд ойр төрөл садангууд байдаг. Орон сууцанд ч гэсэн, орон байрны боломж муутайгаас эцэг эх, үр хүүхдүүд олноороо хамт амьдрах нь түгээмэл. Монголд хүмүүс айлаар чөлөөтэй орж гардаг, ийм учраас ахуйн шинжтэй хэрэг зонхилж гардаг. Хэрэг илрүүлэх арга, техник төдий л хангалтгүй байгаа одоо үед төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх имунитетийг гэрч-оролцогчид олгож, Үндсэн хуулийн хэм хэмжээг өргөтгөсөн нь хэрэгт гэрчээр асуугдах хүн үл олдох, улмаар хэрэг илрэх боломж багасч, хууль үл хэрэгжих, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зорилго үл хэрэгжих, эмх журамгүй анархи байдал бий болох хэтийн муу балагтай гэж үзэж байна. Ийнхүү Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим байх заалт давхар зөрчигджээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-д "Гэр бүлийн гишүүн-сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ хэмээн зааж тогтоосон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "Монгол Улсын иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй" гэснийг дараах байдлаар зөрчиж байна.

Бүх оролцогчид бус зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хамааруулж гэр бүлийн гишүүн гэдэг ойлголтыг тайлбарлаж, бусад оролцогчид хамааруулж хэрэглэх боломжгүй болгож, Үндсэн хуулийн тухайн хэм хэмжээг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд явцуу утгатайгаар, буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Энэ үндэслэлийг няцаах өөр хэм хэмжээ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байхгүй байна.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М.-ийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад иргэдээс эрх, эрх чөлөөгөө шүүхээр хамгаалуулах эрхийн тухай заасан байдаг. Тэр дундаа гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд оршиж байна гэж үзэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэрч голлох үүрэг гүйцэтгэдэг, өөрөөр хэлбэл гэрч нь болсон үйл явдлыг үнэн бодитойгоор сэргээн тогтоох, гэмт этгээдийг олж илрүүлэхэд чухал үүрэг бүхий эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч юм. Гэрч нь гэмт хэрэг болсон нөхцөл байдал ба гэм буруутай этгээд, эсхүл хохирогчийн талаар хэрэгт ач холбогдолтой мэдээлэл өгч чадах боловч гэр бүл, эцэг эх, үр хүүхэд, ураг төрлийн хоорондын харилцааг хүндэтгэн хамгаалах үүднээс өөрийн гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй байхаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7-д хуульчилсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "Монгол Улсын иргэн... гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх... эрхтэй" гэснийг өргөтгөн тайлбарласан гэж үзэх үндэслэлгүй байна гэж үзэж байна.

Эрх зүйн онолд Үндсэн хуулийн тухайн заалтыг өөр хуулиар тайлбарлах арга байдаг бөгөөд хууль тогтоогч Үндсэн хуулийн "гэр бүлийн гишүүд" гэдгийг Гэр бүлийн тухай хуульд гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг, "Төрлийн хүн" гэж гэрлэгчийн эцэг эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг, "садангийн хүн" гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг ойлгоно гэж тодорхойлон тайлбарласан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн “гэр бүлийн гишүүн” гэдэг тодорхойлолтын “төрөл, садангийн хүн” гэдэг нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй хамт амьдарч байгаа, өөрөөр хэлбэл, албан ёсоор нэг өрхийн бүртгэлтэй байгаа ач, зээ, гуч, жич, төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хамааруулсан ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-д “гэр бүлийн гишүүн” гэдэг нэр томъёонд “төрөл, садангийн хүн”-ийг хамааруулан тайлбарласан. Энэ тайлбар Гэр бүлийн тухай хуулийн “төрлийн хүн”, “садангийн хүн” гэсэн ойлголтыг тайлбарласантай нийцэж байгаа тул Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ойлголтыг буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэлгүй юм.

2/ Гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчим эрүүгийн эрх зүйд үйлчилдэг бөгөөд хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг тогтоох, түүнд зохих шийтгэлийг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй буюу эрүүгийн ял оногдуулахгүй байхад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа чиглэгддэг билээ. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчоор тодорхойлж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэр бүлийн гишүүд тэдний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй байгаа нь эдгээр хүмүүсийн хоорондын ураг төрлийн болон амьдралын хамгийн ойр дотны харилцааг харгалзсан хуулийн энэрэнгүй байх зарчимтай холбоотой гэж үзэж байна.

Иймд хууль тогтоогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэр бүлийн гишүүн гэдэг ойлголтыг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид илүү хамааруулсан нь зөв юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2002 он 1 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр дагаж мөрдөгдсөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д “Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэж заасны “...гэр бүлийн гишүүн, эцэг, эх үр хүүхэд, төрөл, садан...” гэсэн үгүүд өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийн хэлбэрээр, холбогдох хүмүүсийг тоочин тодорхойлж бичсэн нь гэр бүлийн гишүүн биш “төрөл, садан”-г хамруулсан ойлголт болсон байх бөгөөд ингэснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх...” гэсэн заалтыг агуулгын хувьд дэлгэрүүлэн тайлбарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д “гэр бүлийн гишүүн” гэдгийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдуулан тодорхойлсон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байж болох” тухай заалтыг тухайн хуулиар зохицуулж, салбар эрх зүйн харилцааны зарим гол субъектыг тухайлан зааж хуульчилсан байна. Үндсэн хуулийн дээр дурдсан заалтаар олгосон эрхийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчдээс бусад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид эдлэхийг хязгаарласан, хориглосон зүйл үгүй бөгөөд Үндсэн хуулийн тухайн хэм хэмжээг Эрүүгийн байцаан шийтгэх хууль явцуу утгатайгаар буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийн “Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй” гэсэн заалтын “төрөл, садангийн хүний” гэсэн нь Монгол

Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-ийн "Гэр бүлийн гишүүн" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**"Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 3 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 2003 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 47 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45.7 дахь хэсгийн "Гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй" гэсэн заалтын "төрөл, садангийн хүний" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 3 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.11-ийн "Гэр бүлийн гишүүн" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрөл, садангийн хүнийг хэлнэ" гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх,..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 3 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Хүн ам зүйн үүднээс төрөл, садан гэдэг өөр өөр ойлголт, тухайлбал төрөл гэдэг цусан талаа, садан гэдэг цусан төрлийн биш хүмүүсийг тодорхойлдог. Энэ маргаан нь хэл зүйн, эсхүл үг үсгийн жижиг асуудлыг хөндөөд байгаа юм шиг боловч хууль зүйн шинжлэх ухаан түүний практикт чухал үр дагавар бий болгох томоохон маргаан байсан юм. Хууль тогтоогч "гэрч нь гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхэд, төрөл, садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй" гэж хуульчилсныг Үндсэн хуулийн заалтыг шууд дэлгэрүүлэн "тайлбарласан" байна гэх бүрэн үндэстэй.

Өөрөөр хэлбэл, гэр бүлийн гишүүн бус төрөл, садангийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг гэрчид олгосноороо мэдүүлэг өгөхгүй байх гэрчийн эрхийг хэт хавтгайруулж, Үндсэн хууль зөрчихөд хүргэсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэр бүлийн гишүүн "төрөл, садан", гэр бүлийн гишүүн бус "төрөл, садан" гэх ойлголт байгаа болохыг Цэц энэ дүгнэлтээрээ нарийн зааглаж тодорхойлж өгсөн.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2004.04.21 № 01

### Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>65</sup>

- 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно”
- 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад 3 өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг ...эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”
- Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэг “...Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”
- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, ...хууль зүйн туслалцаа авах, ...шүүхээр шүүлгэх, ...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхтэй”
- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”
- Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Бүх шатны шүүх, хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж заасан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлд шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргааны тухай зохицуулсан байдаг

65 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны №8-д нийтлэгдсэн



бөгөөд тэдгээрээс бусад хэргийг шүүх, бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг. Харин уг хуулийн дээр дурдсан 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалтад дүн шинжилгээ хийж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүнд буй 3 шүүгч 3 өөр санал гаргах боломжийг хуулиар олгосон байна. Гэхдээ шүүх хуралдаан даргалагчийн саналыг нөгөө хоёр шүүгчийн саналаас илүүд авч үзэж 3 өөр санал гарсан бол хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх тухай заалтын агуулгыг зөрчиж байна. Учир нь тухайн шүүх хуралдаан даргалагч бол уг шүүх хурлыг удирдаж, түүний хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн байдгаараа л шүүх бүрэлдэхүүнд байгаа нөгөө хоёр шүүгчээсээ ялгаатай бөгөөд бусад байдлаараа тухайн асуудал, хэрэгт нэг л санал өгөх эрхтэй шүүгч юм.

2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл, садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэсэн заалтад дүн шинжилгээ хийж үзвэл эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхдээ зөвхөн хоёрхон арга замыг ашиглах эрхийг нь олгожээ. Өөрөөр хэлбэл, тухайн иргэн шүүхэд хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх үедээ нэгдүгээрт, өөрийнхөө гэр бүлийн гишүүн төрөл садангаараа, эсвэл хоёрдугаарт, өмгөөлөгчөөр тус тус өөрийгөө төлөөлүүлж эрх, ашгаа хамгаалуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах болж байгаа бөгөөд дээрх хоёр арга замаас өөр боломжийг иргэнд олгоогүй байна. Тодруулбал, эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй байна. Уг төлөөлөх хүн нь тухайн иргэний итгэлийг хүлээсэн бөгөөд эрх, ашгийг хамгаалж чадах хэн ч байж болно.

Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ” гэж төлөөллийн харилцаа үүсэх үндэслэлийг заажээ. Харин уг хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно” гэж заасан бөгөөд уг заалтын агуулгыг үзвэл аливаа хүн /төлөөлүүлэгч/ иргэний эрх зүйн зарим чадамжтай болон иргэний эрх зүйн чадамжгүй иргэнээс бусад хэнээр ч өөрийгөө төлөөлүүлж болохоор байна. Мөн Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт бичгээр олгосон итгэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна. Ер нь аливаа төлөөллийн харилцаа нь Иргэний хуульд заагдсан дээрх зохицуулалтын хүрэнд явагдах учиртай. Хэдийгээр салбар эрх зүйн онцлог гэж байх боловч шүүх иргэний хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа л юм бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд төлөөллийн харилцааг зохицуулахдаа Иргэний хуульд заасан төлөөллийн талаархи үндсэн зохицуулалтыг хэт явцууруулж тусгах ёсгүй билээ.

“...өөрийгөө өмгөөлөх...” эрхийн хувьд иргэн өөрийнхөө эрх, ашгийг хамгаалахдаа өмгөөлөгч авч ч болно, авахгүй ч байж болно. Энэ бол түүний үзэмжийн асуудал юм. Иргэний хэргийг шүүхээр шийдвэрлүүлж буй иргэн өмгөөлөгч авахгүй гэж үзэн, өөрийгөө өмгөөлж, өөрийнхөө эрх ашгийг өөрөө хамгаалж болох бөгөөд энэ эрх нь тухайн хэрэг, маргаанд уг иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож чадахгүй болсон тохиолдолд өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсвэл өөрийн итгэл хүлээсэн, эрх ашгийг нь хамгаалж чадах хүнээр өөрийгөө төлөөлүүлж, шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх байдлаар илрэх ёстой гэж бодож байна. Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэнийг өөрийгөө шүүхэд төлөөлүүлэхдээ нэг бол гэр бүлийн болон төрөл садангийн хүнээр төлөөлүүл, эсвэл заавал өмгөөлөгчөөр төлөөлүүл, өмгөөлөгч ав, өөр сонголт, боломж байхгүй гэсэн агуулгатай байгаа бөгөөд энэ нь иргэн хүний “өмгөөлөгч авах эсэх эрх”-ийг өмгөөлөгч зайлшгүй авах үүрэг болгосон шинжтэй заалт

болжээ. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуульд заасан “өөрийгөө өмгөөлөх” гэсэн эрхийг зөрчиж байна.

“...хууль зүйн туслалцаа авах...” эрхийн илрэх хэлбэрүүдийн нэг нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн иргэн итгэл хүлээсэн, мэргэжлийн хүнээр өөрийгөө төлөөлүүлэх хууль зүйн боломжтой байх явдал юм. Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэн мэргэжлийн хүнээс буюу бусдаас /өмгөөлөгчөөс биш/ “хууль зүйн туслалцаа авах эрх”-ийг боогдуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж буй хэрэг мөн.

“...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох...” эрхийн хувьд авч үзвэл тухайн иргэн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох эрх эдлэхийн хувьд тийнхүү оролцох эсэх нь бас л түүний үзэмжийн асуудал билээ. Хэрэв тухайн иргэн иргэний хэргийн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох боломжгүй, шаардлагагүй гэж үзвэл оролцохгүй байх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд эрх ашгийг нь хамгаалж чадах хэнээр ч өөрийгөө төлөөлүүлж, шүүх ажиллагаанд оролцуулж болох билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлж буй тухайн иргэнд хоёрхон сонголт олгосон бөгөөд тэдгээр нь өмнө дурдсанчлан “гэр бүлийн гишүүн, төрөл, садангаараа, эсвэл өмгөөлөгчөөр төлөөлүүлэх” байдлаар тусгагдсан нь агуулгын хувьд хэрэв тухайн иргэн дээр дурдсан 2 сонголтыг хэрэглэхгүй гэж шийдвэл түүнд шүүх хуралдаанд өөрөө биеэрээ оролцох ёстой болох /нөгөө эрх нь бараг үүрэг болж хувирсан/, эсвэл шүүх ажиллагаанд болон хуралдаанд биеэрээ оролцохгүй гэвэл эрх ашгаа хамгаалж чадахгүй болж, нэхэмжлэл нь шүүхээс буцаагдах нөхцөл байдал бий болж байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуульд заасан “хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох” эрхийг гажуудуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох, мөн зүйлийн 4 дэх хэсэгт эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл, садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлж болох тухай заажээ. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх төлөөлөгчийг оролцуулж байгаа институт нь хоёр талтай.

Нэгдүгээрт, иргэн, хуулийн этгээдэд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалахад тусалж байна. Хоёрдугаарт, хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоох, түүнийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд шүүхэд тус дөхөм болж байгаа билээ. Төлөөлөл нь хуульд

зааснаар, эсхүл сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байх ерөнхий зарчим энэхүү хуульд тусгагдаж, төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлөгчөөс олгосон итгэмжлэл, бусад бичиг баримтаар тодорхойлно. Мөн дээр дурдсан хуульд 18 насанд хүрээгүй этгээд, эсхүл эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй этгээд төлөөлөгчөөр оролцож болохгүй талаар хуульчилсан юм. Ийнхүү эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөхөд нэгдүгээрт, гэр бүлийн гишүүн, төрлийн эсхүл садангийн хүн нь сайн дураараа оролцоно, хоёрдугаарт Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний үндсэн дээр төлөөлж болно. Үүнээс гадна эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо мэргэжлийн үндсэн дээр хамгаалуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Өмгөөллийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгчөөр төлөөлүүлнэ.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.1-д заасанчлан иргэн өөрийн биеэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь тухайн хэрэгтээ төлөөлөгчийг давхар оролцуулах эрхийг нь хязгаарлаагүй болно. Энэ нь Иргэний хуулиар тогтоосон төлөөллийн ерөнхий зарчим, агуулгад нийцэж байгаа юм. Иймд 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэж заасан заалтыг явцуу утгаар нь тайлбарлан ойлгож байгаа нь үндэслэлгүй гэж үзэж байна.

2/ Хэрэг, маргааныг хамтран хянан хэлэлцсэн шүүх шийдвэрээ гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114.3-т заасны дагуу олонхийн саналаар шийдвэрээ гаргана. Харин 3 шүүгч гурван өөр саналтай байгаа тохиолдолд гарах нэг гарц болгон шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргахаар 114.4 дэх заалтыг хуульчилсан билээ. Иймд хуулийн дээр дурдсан заалт нь Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Шүүх хамтын журмаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэг нь хэргийг хэд хэдэн шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх, хуралд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж хэлэлцэж буй асуудлаар тэдний санал бодлыг авч шийдвэрт тусгах агуулгыг гол нь илэрхийлж байгаа юм. Үүнийг шийдвэр гаргахдаа зөвхөн олонхийн саналаар гаргана гэсэн утгаар тайлбарлах нь өрөөсгөл зүйл болно гэв. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэсэн заалт нь Үндсэн хуульд заасан иргэн хүн хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлэхдээ аль болох мэргэшсэн, энэ асуудлыг эрхэлдэг хүнээс авах нь зохимжтой, ингэвэл ажил хэрэгч, эрхээ хамгаалж буй иргэнд ч илүү тустай, үр дүнтэй гэсэн агуулгаар бичигдсэн зүйл юм. Ингэж хуульд бичигдсэнээр иргэний эрх, эрх чөлөө хязгаарлагдаад, Үндсэн хууль зөрчигдөөд байна гэж үзэх үндэс байхгүй.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж заасан нь 3 буюу түүнээс дээш бүрэлдэхүүнээр асуудлыг шүүх авч хэлэлцэж шийдвэрлэхдээ 1 хүний саналаар биш, оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэр гаргана гэсэн утгыг тодорхой илэрхийлсэн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан нь аль ч төрийн байгууллага асуудлыг хянаж шийдвэрлэхдээ ганцаар захирах, шийдэх ёсыг бус олонхийн саналыг харгалзаж, түүнд үндэслэж асуудлыг шийдэх зарчмыг баримтлах санааг илэрхийлсэн байна. Олонхийн саналаар асуудлыг шийдэх энэ зарчим маргаантай хэрэг, асуудлыг таслан шийдвэрлэдэг хараат бус, шудрага шүүхийн үйл ажиллагаанд бүр ч тод томруунаар илэрч байх учиртай.

3. Олонхийн зарчмаар асуудлыг ийнхүү шийдэх энэхүү зарчим Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль зэрэг процессын бүх хуулиудад тодорхой тусгагджээ. Энд хэлэлцэж буй маргааны зүйл болсон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн тухайд гэхэд л энэ зүйлийн 3-т “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байгаа бол олонхийн саналаар шийдвэр гаргана” гэж шууд, тодорхой хэлсэн атлаа мөн тэр дороо энэ зүйлийн 4-т: “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана” гэж зааж агуулгын илэрхий зөрчил гаргасан байна.

Мөн Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана” гэсэн нь хууль тогтоогч Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлогдсон “хамтын зарчим” гэсэн ойлголтын гол агуулга нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн утга гэдгийг салбар хууль гаргахдаа тодруулан зааж өгчээ гэж ойлгогдож байна.

Эдгээрээс үзвэл хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх үед 3 өөр санал гарсан бол хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсгийн агуулга, олонхийн саналаар шийдвэр гаргах зарчмыг зөрчсөн нь харагдаж байна.

4. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж Иргэний хэргийн байцаан шийтгэх ажиллагааны төлөөлөлтийн хэлбэрийг тоочиж тодорхойлохдоо төлөөлөлтийн зарим боломж, хэлбэрийг орхигдуулж явцууруулсан тал харагдаж байгаа боловч үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх шууд үндэслэл тогтоогдохгүй байна.

5. Иргэн Б. мэдээлэлдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 12, 14 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хүлээж авах боломжгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад 3 өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх, хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл, садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 27 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 15.1.5, 15.1.6-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл, садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэдэг нь Үндсэн хуулийн гол зарчим юм. Хамтын зарчмаар шийдвэр гаргахдаа шүүх бүрэлдэхүүн хуралдаан даргалагчийн бус гагцхүү олонхийн саналыг л үндэслэх ёстой. Хамтаар хэлэлцэх, олонхийн саналаар шийдвэр гаргах хоёрыг бие биеэс нь салгаж үл болох зарчмууд. Зөвлөлдөх тасалгаанд шүүгчийн гаргасан санал нэг л саналын эрхтэй. 3 шүүгч гурван өөр санал гаргах тохиолдол шүүхийн практикт тохиолдохыг үгүйсгэх аргагүй.

Гэвч Улсын Их Хурал гарах гарцыг Үндсэн хууль зөрчих байдлаар зохицуулж үл болно. Хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргахаар хуульчилсан нь бусад 2 шүүгчийн саналын эрхийг үгүйсгэж, шүүхийн шийдвэр ганц шүүгчийн саналаар шийдвэрлэхэд хүргэх үр дагавартай. Шүүн таслах ажиллагаанд шүүгч бүр адил тэгш эрхтэй оролцох бөгөөд тэдгээрийн саналыг ямар ч шалгуураар “үгүйсгэх” ойлголт ардчилсан эрх зүйт төрд байх учиргүй.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2004.06.07 № 02

**Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Н., Г., Б.;  
Албан тушаалтан - Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Г.

### **Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:**

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. дангаараа хянан шийдвэрлэсэн болон бусад үйлдэл

### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”

- Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ”

- Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н., Г., Б. нарын өргөдлийн агуулга:

“Монполимет” ХХК нь 2001 онд “Эрэл” ХХК-тай худалдааны гэрээ байгуулсан юм. Гэтэл “Эрэл” ХХК энэ гэрээгээр манайд шилжүүлсэн техникээ хүчээр татан авч хууль бус үйлдэл гаргасан тул 2001 оны 10 дугаар сарын 10-ны өдөр “Монполимет” ХХК Хан-Уул дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, уг маргааныг Хан-Уул дүүргийн шүүх 2002 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хянан хэлэлцэж 64<sup>а</sup> дугаартай шийдвэр, мөн энэхүү шийдвэрийг давж заалдах шатны шүүх 2003 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр авч хэлэлцээд 13 дугаар магадлал гаргасан. Дээрх шийдвэр, магадлалыг хяналтын журмаар Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим 2003 оны 3 дугаар сарын 21-ний өдөр хянан хэлэлцээд 182 дугаар тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоор “Монполимет” ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг авч хэлэлцсэн Хан-Уул дүүргийн шүүхийн 64<sup>а</sup> дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 13 дугаар магадлалыг

тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан билээ. Гэтэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. нь анхан шатны шүүхийн 64<sup>a</sup> дугаартай шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 13 дугаартай магадлал нь хууль зөрчөөгүй байна, Улсын дээд шүүхийн хяналтын шатны 182 дугаар тогтоол үндэслэлгүй гэсэн илт хууль болон бодит байдалд үндэслэлгүй дүгнэлт бичиж, улмаар 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Улсын дээд шүүхийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж 19 дүгээр тогтоол гаргуулсан.

Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон “Комацу” компанийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын 126 дугаар бичигт дурдсан үнэ нь түрээсийн жишиг үнэ биш, харин лизингийн үнэ болох нь мэдэгдсэн, мөн анхан шатны шүүхийн шийдвэр гарах үед маргагч талууд мэдээгүйн улмаас шүүхэд гаргаж өгөөгүй, тухайн хэрэгт нотлох баримтын ач холбогдолтой, бусад уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хооронд гарсан маргаанд баримталж байсан Дэд бүтцийн сайдын 1996 оны 359 дүгээр тушаалаар баталсан жишиг үнэ байдаг зэрэг нь мэдэгдсэн тул бид дээрх лизингийн үнэ болон энэ тушаалд заагдсан тарифыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэж тооцон Улсын дээд шүүхэд хэргийг хянуулах тухай хүсэлт гаргасан билээ. Гэтэл бидний хүсэлтийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. дангаараа шийдвэрлэж 2003 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 1/2909 дүгээр албан бичгээр хариу ирүүлсэн билээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 181 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ”, 4 дэх хэсэгт “Шүүх хуралдаанаар шинээр илэрсэн нөхцөл байдлыг баталж байгаа шинэ нотлох баримтыг үндэслэн шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох, уг нөхцөл байдал нь шийдвэрийг гаргахад хэрхэн нөлөөлсөн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ” гэж заажээ.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтыг зөрчиж, шинээр илэрсэн нөхцөл байдлыг хянуулах тухай хүсэлтийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. ганцаараа хянаж хариу өгснөөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ”, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа тул Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.

2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 1/996 дугаар албан бичгээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн Цэцийн гишүүний тогтоолын үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул дахин хянаж өгөхийг хүссэн тухай гомдлын агуулга:

Уг албан бичигт нэхэмжлэгчээс гаргасан өргөдөлд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгснийг эс зөвшөөрч нэхэмжлэгч Га., түүний өмгөөлөгч Н. нар “иргэний” хувиар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасныг үндэслэн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэсэн нь үндэслэлгүй болжээ. Энэ маргаан нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад ердийн хуулийг хэрэглэхтэй холбоотой асуудал учир Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргаан биш билээ.

Түүнчлэн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсэгт заасан 3 төрлийн үндэслэл байвал хийгдэж болох ажиллагаа юм. Энэ нь уг хуулийн мөн зүйл, заалтын “Хүчин төгөлдөр шүүхийн

шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэсэн заалтаас тодорхой ойлгогдоно. Энэхүү “болно” гэж зөвшөөрсөн заалтыг “шүүх, түүний ерөнхий шүүгчид уг хэргийг заавал хуралдаанаар хянах”-ыг үүрэг болгосон заалт гэж ойлгоход хэцүү.

Хэрэв ингэж ойлговол маргалдагч талууд “шинээр илэрсэн нөхцөл байдал”-ын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт ээлжлэн гаргасаар, шүүх түүнийг нь дараалан авч хэлэлцсээр байх жишиг тогтоож, хэрэг, маргаан эцэслэж шийдвэрлэгдэхгүйд хүргэх болно. Ийнхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван долдугаар бүлгийн “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах”-тай холбогдсон маргаантай асуудал нь Үндсэн хуулийн маргаан биш учраас Цэцэд харьяалагдан шийдвэрлэгдэх бус харин уг ердийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу эрх бүхий байгууллагаас албан ёсны тайлбар гаргах замаар шийдвэрлэгдэх учиртай.

Хэрэв Үндсэн хуулийн цэц энэ асуудлыг авч хэлэлцвэл өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан “Монгол Улсад шүүх эрх мэдлийг шүүх гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, 2-т заасан “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, Дөчин есдүгээр зүйлийн 2-т заасан “...төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, Тавьдугаар зүйлийн 2-т заасан “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчихөд хүрнэ гэдгийг анхааралдаа авахыг хүсье.

### 3. Иргэн Н., Б. нарын гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянуулах тухай хэргийн оролцогчдын хүсэлтийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. дангаар хянан шийдвэрлэх явдал сүүлийн үед гарч эхэлж байгаа бөгөөд үүнийгээ Ерөнхий шүүгч Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсгийн “Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэсэн заалтыг барин тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, хуульд заасан үндэслэл байвал “шинэ нөхцөл байдал”-аар хэргийг хянаж ч болно, хянахгүй байж ч болно гэж үздэг. Харин мөн хуульд “Хүсэлтийг шийдвэрлэх” гэсэн 181 дүгээр зүйл байгааг Ерөнхий шүүгч “олж хардаггүй” юм. Энэ зүйлийн 181.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ” гэж заасны дээр мөн зүйлийн 181.5 дахь хэсэгт “Шүүх хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлээд түүнийг хангах, эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргана” гэсэн байгаа.

Хэрэв Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн хууль зөрчсөн өнөөгийн практикаар “шинэ нөхцөл байдал”-аар хянуулах хүсэлтийг Ерөнхий шүүгч хүлээн аваад, “шинэ нөхцөл байдал” мөн эсэхийг дангаараа шийдвэрлээд эхлэх юм бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “181 дүгээр зүйл” энэ хуульд байх шаардлага байна уу? гэдэг асуулт аяндаа гарч ирнэ. Тэгээд ч Ерөнхий шүүгч “шинэ нөхцөл байдал” биш гээд л нэгэнт шийдвэрлэчихсэн бол хэргийг Улсын дээд шүүх дахин хянан үзэх хуулийн механизм байхгүй байгаад хамаг “аюул” нь оршиж байгаа юм. Бид Үндсэн хуулийн цэцэд хандахдаа “Монполимет”, “Эрэл” компанийн хооронд үүссэн маргааныг ямар нэгэн байдлаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй, харин Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч бидний хүсэлтийг хянахдаа дээр дурдсанаар Үндсэн хууль зөрчсөн



асуудлыг хянуулах хүсэлт гаргасан. Иймд энэ ажиллагаа нь Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Үндсэн хуулийн цэц хөндлөнгөөс оролцсон хэрэг болохгүй гэдэгт бид итгэлтэй байна.

4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ч. нь иргэн Н., Г., Р. нарын өргөдлийн дагуу Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэснийг үндэслэлгүй, энэ нь Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргаан бус харин иргэний тодорхой хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад нотлох баримтыг хэрхэн үнэлэх, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай зэрэг ердийн хуулийг хэрхэн ойлгож хэрэглэхтэй холбогдсон, ердийн шүүхүүд шат шатандаа хэнээс ч хараат бус, бие даан шийдвэрлэж байхаар хуулиар тогтоосон харьяалалтай хэрэг, маргаан гэж үзэж байгаа тухай тайлбараа Дээд шүүхийн 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 1/996 дугаар албан бичгээр өмнө нь танайд хүргүүлсэнд Цэцийн эрхэм гишүүд анхаарлаа дахин хандуулна уу гэж хүсэж байна.

“Монполимет” ХХК-ийн нэхэмжлэлтэй, “Эрэл” ХХК-д холбогдох иргэний хэргийг манай улсын бүх шатны шүүхүүд зохих журмын дагуу хянан хэлэлцэж, улмаар Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчид оролцсон хяналтын шатны хуралдааны 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор эцэслэн шийдвэрлэсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ” гэсэн заалтын дагуу Улсын дээд шүүхээс иргэний тодорхой хэргийн талаар гаргасан 2003 оны 19 дүгээр тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр бөгөөд заавал биелэгдэх учиртай. Гэтэл иргэний уг хэргийн нэхэмжлэгч Г., түүний өмгөөлөгч Н. нарын зэрэг хүмүүс “иргэний” хувиар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж Дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт бичсэн, хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтэд албан бичгээр хариу өгснийг Үндсэн хуулийн цэцээр хянуулж дүгнэлт гаргуулах замаар шүүх, шүүгчид эргэж нөлөөлөх, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийхийг оролджээ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсэгт заасан 3 төрлийн үндэслэл байвал хийгдэж болох хуулиар зөвшөөрөгдсөн ажиллагаа болохоос бус иргэний хэрэг болгонд, эсхүл хүсэлт гаргах болгонд заавал хийгдэж байх хуулиар үүрэг болгосон ажиллагаа биш юм. Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэсэн заалтаас тодорхой ойлгогдоно. Энэхүү “болно” гэж зөвшөөрсөн заалтыг “шүүх, түүний ерөнхий шүүгч нарт уг хэргийг заавал хуралдаанаар хянах”-ыг үүрэг болгосон заалт гэж ойлгох боломжгүй. Учир нь энэ асуудлаар хууль тогтоох байгууллага болон Улсын дээд шүүхээс албан ёсны тайлбар гараагүй, тиймээс шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах хүсэлтийг хүлээн аваад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсэгт нэрлэсэн 3 төрлийн үндэслэл байхгүй нь илт тохиолдолд хүсэлтэд албан бичгээр хариу өгдөг практик шүүхэд мөрдөгдөж байгаа билээ.

Шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон эдгээр нотлох баримт “хуурамч” гэх буюу шинжээчийн үйлдэл эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон гэх үзэхүйц Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.2-д заасан үндэслэл илрээгүй

болно. Ийнхүү “Монполимет” ХХК-аас шүүхэд гаргасан хүсэлт, “нэмэлт баримтад” Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.1, 179.1.2, 179.1.3-д заасан 3 төрлийн үндэслэл байгаагүй учир Дээд шүүхийн 2003 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 1/2909 дугаартай албан бичигт Ерөнхий шүүгч гарын үсэг зурж зохих хариуг хүсэлт гаргагчид өгсөн бөгөөд ингэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1 дэх хэсгийн “... дараах үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэсэн заалтад захирагдаж, эдгээр 3 үндэслэл байхгүй учир хянан үзэх боломжгүйг тайлбарласан хариуг өгсөн болно.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль мөрдөгдөх хугацаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх одоогийн болон өмнөх хуулийн шүүхүүд шинээр илэрсэн нөхцөл байдал байхгүй нь илт тохиолдолд хүсэлтэд бичгээр хариу өгдөг практикийг мөрдөж ирсэн бөгөөд Улсын дээд шүүх сүүлийн 4 жилд энэ журмаар 16 хэрэгт бичгээр хариу өгсний зарим хариуг баримт болгон хавсаргав. Шинэ нөхцөл байдал нь хэдийд ч илэрч болох учир тодорхой нэг хүсэлт нь хэргийг дахин хянах үндэслэл биш байхад дараагийн удаад гаргасан хүсэлтэд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1-д дурдсан үндэслэл байвал дахин хянагдаж болох юм. Үүгээрээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургадугаар бүлэгт заасан хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдана. Гэтэл өргөдөл гаргагч тал шинэ нөхцөл байдал биш гээд нэгэнт шийдвэрлэчихсэн бол шинэ нөхцөл байдал дахин илэрч болохгүй мэт ойлгосон байдал тайлбараас нь харагдаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван долдугаар бүлгийн “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах”-тай холбогдсон заалтуудыг хэрхэн тайлбарлан, хэрэглэхтэй холбогдсон маргаантай асуудал нь Үндсэн хуулийн маргаан биш учраас Цэцэд харьяалагдан шийдвэрлэгдэх бус харин Улсын Их Хурал уг ердийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж зохицуулалтыг нь тодорхой болгох, эсхүл Улсын дээд шүүх албан ёсны тайлбар гаргах замаар шийдвэрлэгдэх учиртай. Түүнчлэн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1.1, 179.1.2, 179.1.3 дахь хэсгүүдэд заасан үндэслэл байхгүй байсан учир мөн зүйлийн 179.1 дэх хэсэгт “...болно” гэж заасны дагуу шийдвэрлэсэн учир хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй билээ.

#### **Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 3/05 дугаар магадлалын агуулга:**

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г.-гийн Үндсэн хуулийн цэцэд гаргасан гомдлын дагуу Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаан 2004 оны 5 дугаар сарын 5-ны өдөр болж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн Цэцийн гишүүний тогтоол, мөн энэхүү тогтоолыг дахин хянуулах тухай Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г.-гийн гомдлыг хянан хэлэлцсэн бөгөөд энэ хуралдаанд өргөдөл гаргагч Га., Н., Б. мөн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. нар биеэр оролцож, маргааны талаар өөрийн байр суурийг илэрхийлсэн байна. Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдаанаас Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудал нь Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх харьяаллын маргаан байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн тухай Цэцийн гишүүний 2004 оны 5/90 дугаар тогтоолыг хэвээр үлдээж, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г.-гийн гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцсэн дүнгээс үзэхэд нэхэмжлэгч тал шинээр илэрсэн нөхцөл байдалтай холбогдох асуудлаа бүрэн үндэслэлтэй нотолж

тавиагүй байхад Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

2. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179, 181 дүгээр зүйлийн заалтыг хэрэглэж байгаа шүүхийн буруу практикт дүгнэлт хийж тэдгээрийг зөв хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс зохих тайлбар гаргах нь зүйтэй гэж үзэв.

3. Өргөдөл гаргагч шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэж байгаа үндэслэл, нотлох баримтаа тодруулан бүрдүүлж Улсын дээд шүүхэд дахин хандах эрх нь нээлттэй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг баримтлан ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Г. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэ дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хуралд хүргүүлсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц урьд нь нэг бус удаа хянан шийдвэрлэж байсан ч Цэцээр шийдвэрлэгдэж байгаа Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй холбоотой анхны маргаан энэ байлаа. 2012 оныг хүртэл иргэдээс Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Цэцэд нийтдээ 8 удаа хандсан статистик баримт байна. Эдгээрийг судалж үзэхэд иргэд Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргаад, уг гомдлыг шийдвэрлэсний дараа, эсхүл хэргийг хянан шийдвэрлэж буйтай холбогдуулан Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн гэж Цэцэд хандах явдал гарч байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай зохигчдоос гаргасан хүсэлтийн дагуу дүгнэлт бичих эрх нь Ерөнхий шүүгчид олгогдсон процессийн ганц эрх юм. Энэ хүрээнд Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц хянах эсэх, хянах тохиолдолд ямар хүрээг хамрах зэргийг Цэц нарийн тодорхойлох, жишиг тогтоох ёстой. Өөрөөр хэлбэл, иргэд Цэцийг Дээд шүүхийн дараах шат маягаар ойлгон шүүхээр шийдвэрлэсэн хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлт гаргах эрхтэй холбогдуулан Цэцээр хянуулах хандлага байгааг анхаарах шаардлагатай. Цэцийн дүгнэлтээрээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохих заалтыг хэрэгжүүлж байгаа шүүхийн практик буруу явагдаж байгаа болохыг Цэц тогтоосон.

Мөн Ерөнхий шүүгчийн гомдлын дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн Цэцийн гишүүний тогтоол үндэслэлтэй эсэхийг Цэцийн бага суудлын хуралдаанаар хянан хэлэлцсэн анхны тохиолдол байв. 1992-2012 хүртэлх хугацаанд маргаан үүсгэсэн гишүүний тогтоолд талуудаас гомдол гаргасан тохиолдол үүнээс өөр гараагүй байна. Цэцийн бага суудлын хуралдаанаар гишүүний тогтоолын үндэслэлийг хэлэлцдэг бөгөөд тэнд ямар нэгэн мэтгэлцээн явагддаггүй. Гэтэл уг хуралдаанд гомдол гаргасан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Цэцэд хандсан нэр бүхий иргэдийг оролцуулсан нь Цэц процессийн алдаа гаргасан гэх үндэслэлтэй. Логикийн хувьд маргагч талуудыг Цэцийн бага суудлын хуралдаанд оролцуулах тохиолдолд тухайн тогтоолыг гаргасан Цэцийн гишүүнд ч энэ боломжийг олгох шаардлага ч зүй ёсоор тавигдана.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2004.06.08 № 03

### Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М., Д., тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хууль<sup>66</sup>

- 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт “хайгуулын лиценз эзэмшигч нь хайгуулын эдэлбэрийн хилийн дотор энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх онцгой эрхтэй”
- 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт “энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмал ашиглах лиценз авах онцгой эрхтэй”
- 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг “ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч нь тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах онцгой эрхтэй”
- 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “уурхайн эдэлбэрийн хүрээнд бүх төрлийн ашигт малтмалын хайгуул явуулах онцгой эрхтэй”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн М., Д. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан. Монгол Улсын газрын хэвлий, түүний баялгыг төр өмчлөх нь Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх бөгөөд бусад хуульд тусгагдах төрийн онцгой эрх юм. Гэтэл Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийн заалтад ашигт малтмал хайх, ашиглах лиценз эзэмшигч нь онцгой эрхтэй гэж тус тус тодорхойлсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Энэхүү зөрчил нь ашигт малтмал хайх, ашиглахтай холбоотой харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулж ирсэн үр дүн болон Монгол Улсын газрын хэвлий, түүний баялгыг өмчлөх эрхээ Монгол Улсын төр эдлэх, түүнчлэн энэ онцгой эрхээс үүсэн гарах өмчөө захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байгаа өнөөдрийн нөхцөл байдлаар давхар нотлогдож байна. Энэ тухай бидний нэхэмжлэлийг хянан шийдвэрлэж өгөхийг гүнээ хүсье.

66 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1997 оны № 7-д нийтлэгдсэн

## 2. Иргэн М., Д. нарын гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

Ашигт малтмал хайх, ашиглахтай холбоотой харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулж ирсэн үр дүнг тодорхой харуулах жишээгээр эхлэхийг хүслээ.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг 6.1.1-д паркт зориулан олгох газрын хил заагийг тогтоож, газар эзэмшигчийг тодорхойлж төрөөс дэмжлэг үзүүлэх тухай заасан. Энэ дагуу “Монгидрометаллурги” ХХК нь Чойрын бүс дэх Шинэ усны нүүрсний ордыг түшиглүүлэн Нүүрс химийн үйлдвэр “Энерги-технологийн парк” байгуулах тухай хүсэлт гаргасан боловч энэ асуудал нь “Гурван сайхан” ХХК-тай зөвшилцсөний үндсэн дээр шийдэгдэх болоод байна.

Улсын төсвөөс хайгуул хийж, үйлдвэрийн ашиглалтад хүлээлгэж өгсөн газрын хэвлий буюу олон ордууд байна. Жишээлбэл Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Төмөртолгойн төмрийн орд газрыг ашиглах хүсэлтэд Геологи, уул уурхайн кадастрын албанаас энэ орд нь хайгуулын лицензтэй учир ашиглуулах боломжгүй гэсэн шийдвэр гаргасан эцсийн шийдвэр байдаг. Төр өөрөө хайгуул хийчихсэн орд газраа мэдэж шийдэх онцгой эрхгүй юм гэхэд ядаж ердийн лиценз эзэмшигчээс давуу эрхтэй байж чадахгүй болсон байгааг энэ жишээнээс олж үзэж болно. “Онцгой эрх”-ийн тухай мэдээлэл, ойлголт авах зорилгоор Монгол Улсын бусад хууль болон Улсын дээд шүүхийн холбогдох тайлбаруудаас ийм үг үсэг бүхий заалтуудыг хайж судлахад “Зохиогчийн эрхийн тухай” болон “Патентийн тухай” хуулиудад “онцгой эрх” гэсэн ойлголт байгаа бөгөөд тухайлбал “Зохиогчийн эрхийн тухай” хуулийн 9 дүгээр зүйлд зохиогч бүтээлийнхээ хувьд бүтээл ашиглах “онцгой /эд хөрөнгийн/ эрх” эдэлнэ гэснээс өөр заалт тайлбар алга байна. Харин газар, газрын хэвлий бол төрийн үндэс бөгөөд энэ онцгой шинж чанар нь газрын хэвлийтэй холбоотой харилцааг зохицуулах аливаа хуульд “онцгой эрх”-ийн тухай заалт орох ёстой бол энэ нь зөвхөн төрийн “онцгой эрх” байх хэрэгтэй. Ийнхүү Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байгаагаас Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага Засгийн газар Үндсэн хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үүргээ биелүүлж чадахгүй байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчдийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан нь нэр бүхий иргэдийн өргөдөлд дурдсанчлан “газрын хэвлий, түүний баялгийг төр өмчлөх “онцгой” эрх”-ийг илэрхийлж байгаа нь үнэн юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад төр, түүнээс эрх олгосны дагуу Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Ашигт малтмалын тухай, Газрын төлбөрийн тухай түүнчлэн Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу өмчийнхөө газрыг бусдад ашиглуулах, эзэмшүүлэх шилжүүлэх нь нээлттэй байдаг.

“Өмчлөх эрх” гэдэг нь өмчлөгч этгээд уг өмчөө өөрөө мэдэж эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах тухай асуудал байдаг нь Иргэний хуулийн 101.1-д “өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй”, 101.6-д “Өмчлөгч энэ зүйлд заасан эрхээ бусдад шилжүүлж болох бөгөөд эрх шилжүүлэн авсан этгээдэд эд юмсыг өмчлөгчийн зөвшөөрсөн зориулалт, өөрийн үйл ажиллагааны зорилго, дүрмийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй” гэснээс ихээхэн тодорхой харагдана. Эндээс үзвэл төр өмчлөгчийнхөө хувьд тодорхой газрыг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд лиценз буюу тусгай зөвшөөрлөөр олгож, тодорхой хугацаа, гэрээтэйгээр эзэмшүүлж, ашиглуулах хууль зүйн боломж бүрэн байгаа нь харагдаж байна. Ийнхүү тодорхой этгээдэд газар

эзэмшүүлж, ашиглуулах нь нээлттэй тул Үндсэн хуулийн дээрх заалт зөрчигдсөн гэж үзэх үндэсгүй юм.

2/ Нөгөө талаас Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, ...эрхтэй” гэж заасны дагуу аж ахуй эрхлэгч буюу ашигт малтмалын лиценз эзэмшигч этгээдэд хууль тогтоомжийн дагуу газар эзэмшиж, ашиглах эрх нь нээлттэй. Ийнхүү хууль тогтоомжийн дагуу тодорхой газрыг нэгэнт эзэмшиж, ашиглаж байгаа бол уг газартаа төрөөс тогтоосон хэмжээ хязгаарын дотор үйл ажиллагаагаа явуулах үүрэг хүлээдэг. Тиймээс лиценз эзэмшигч төрөөс олгогдсон газартаа хайгуул хийх, ашигт малтмал олборлох онцгой эрхтэй байдаг нь дээр дурдсан Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэсгүй байна.

3/ Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хайгуулын эдэлбэрийн хилийн дотор энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх онцгой эрх”, мөн хэсгийн 2-т “энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмал ашиглах лиценз авах онцгой эрх”-ийг хайгуулын лиценз эзэмшигч, 16 дугаар зүйлийн 1-д “тухайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах онцгой эрх”, мөн зүйлийн 4-т “уурхайн эдэлбэрийн хүрээнд бүх төрлийн ашигт малтмалын хайгуул явуулах онцгой эрх”-ийг ашигт малтмалын лиценз эзэмшигч тус тус эдлэхээр туссан. Энд дурдсан “лиценз эзэмшигчийн эдлэх ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулах онцгой эрх” нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т заасан “газрын доорх баялгийг өмчлөх төрийн “онцгой” эрх”-ийг хөндөхгүй бөгөөд энэ нь огт хоёр өөр ойлголт гэдгийг онцгойлон анхаарах нь чухал юм. Өөрөөр хэлбэл, төр газрыг өмчлөгчийнхөө хувьд хууль тогтоомжийн дагуу тодорхой нөхцөл, болзолтойгоор тодорхой этгээдийн өмчлөлд биш гагцхүү тодорхой хугацаатайгаар эзэмшүүлж, ашиглуулж байгаа үйл ажиллагаа тул Үндсэн хуулийн зөрчил болохгүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4 дэх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул иргэн М., Д. нарын гомдлын шаардлагыг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “хайгуулын лиценз эзэмшигч нь хайгуулын эдэлбэрийн хилийн дотор энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх онцгой эрхтэй”, 2-ын “энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмал ашиглах лиценз авах онцгой эрхтэй”, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч нь тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах онцгой эрхтэй”, 4 дэх хэсгийн “уурхайн эдэлбэрийн хүрээнд бүх төрлийн ашигт малтмалын хайгуул явуулах онцгой эрхтэй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **Тэмдэглэл:**

Аливаа лиценз буюу зөвшөөрөл тодорхой орон зай, цаг хугацааны хязгаартай, мөн лиценз эзэмшигчид тодорхой нөхцөл, шаардлага тавигддаг. Ашиг малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосноор төрийн өмчлөх эрх хязгаарлагдаж байна гэж үзэх нь учир дутагдалтай юм. Жишээ нь, Ашигт малтмалын тухай хуулиар нөхөн төлбөр төлөх хэлбэрээр тухайн лиценз бүхий талбайг тусгай хэрэгцээнд авах эрх нь төрд бий. Мөн лиценз эзэмшигч үүргээ биелүүлээгүй тохиолдолд лицензийг цуцлах, хураах эрх нь ч төрд хадгалагдана.

Хуульд “онцгой эрх” гэх нэмэлт тодотгол оруулсан эсэхээс үл хамааран тухайн хайгуулын болон ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулах боломж нь лиценз эзэмшигчэд хуулиар олгогдсон байна. Өөрөөр хэлбэл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулахыг Ашигт малтмалын тухай хуулиар хориглосон нь лиценз эзэмшигчийн хайгуул хийх, ашиглалт явуулах эрхэд хөндлөнгөөс хэн ч халдаж болохгүй болохыг баталгаажуулсан хэрэг. “Онцгой эрх” гэж тусгайлан тодотгосон хэсгийг Цэц хүчингүй болгосон ч хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигчийн хуулиар олгогдсон эрх ямарваа хэлбэрээр хөндөгдөхгүй. Нөгөө талаас Цэц Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг л хянан шийдвэрлэх болохоос бус хууль батлах, өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэлд халдах ёсгүй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.03.14 № 2/01**

**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>67</sup>

- 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

67 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 8-д нийтлэгдсэн

- Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж заасан байдаг. Үндсэн хуульд заагдсан “хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх” зарчим бол тухайн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх явдлыг ойлгодог билээ. Энэ ойлголтыг баталгаажуулж Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана” гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан байдаг бөгөөд “ардчилсан ёс” гэсэн ойлголт нь “аливаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх” гэсэн ухагдахууныг өөртөө агуулдаг билээ. Шүүх байгууллага бол төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үйлчилж байдаг байгууллагуудын нэг тул түүний үйл ажиллагаанд “ардчилсан ёсны зарчим буюу асуудлыг олонхиор шийдвэрлэх” зарчим үйлчлэх ёстой. Энэ нь шүүх хэрэг, маргааныг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үед тод илрэх учиртай.

Гэтэл 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ. Шүүгчдийн зөвлөлгөөн тухайн шүүхийн шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон тохиолдолд хүчинтэй байна. Шүүгч бүр тэгш эрхтэй оролцоно” гэж заасан байдаг бөгөөд дээрх заалтын “...Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ” гэсэн нь Үндсэн хуулийн дээр дурдсан Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалт, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх заалт тус бүрийг зөрчиж байна. Тодруулбал, тухайн шатны шүүгчдийн зөвлөлгөөний бүрэлдэхүүн тэгш тоотой хуралдаж байх үед энэ заалт хамаарах бөгөөд шүүгчдийн санал тэнцвэл буюу 50х50 хувийн харьцаатай болвол Ерөнхий шүүгч нь аль талд орсон байна, уг талын гаргасан санал нь шийдвэр болж хувирах боломжтой байна. Энэ нь шүүх аливаа асуудлыг олонхийн саналаар буюу 51х49 хувийн харьцаатайгаар шийдвэрлэх ёстой гэсэн Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудыг шууд зөрчсөн заалт болжээ. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “...Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тул уг заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргаж, улмаар хүчингүй болгож өгнө үү.

Энэ мэдээлэлтэй агуулга ижил мэдээллийг миний бие 2004 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гарган, улмаар Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 1 дүгээр дүгнэлт гарч, миний өргөдлийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд Цэцийн уг дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр хууль гаргаж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг хүчингүй болгосон билээ.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

1/ Шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаан дахь ардчилсан ёсны зарчмыг улам бүр гүнзгийрүүлэх үүднээс Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын



4-ний өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлд Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчдийн зөвлөлгөөн ажиллахаар хуульчилсан билээ. Шүүгчдийн зөвлөлгөөнийг жилд 2-оос доошгүй удаа хийлгэнэ. Шүүгчдийн зөвлөлгөөн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг томилох хуваарийг тогтоох, түр эзгүй шүүгчийн ажлыг хуваарилах, шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн сонгогчдын нэрсийн жагсаалтаас сонгон авах журам тогтоох, тухайн шүүхийн тамгын газар, хэлтэс, албаны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх зэрэг тухайн шүүхтэй холбогдсон дотоод зохион байгуулалтыг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй юм. Шүүгчдийн зөвлөлгөөнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч товлон зарлаж, удирдан хуралдуулж байхаар заажээ.

Улмаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн дагуу тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох асуудлыг тодруулан зохицуулсан юм. Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэхээр заасан Үндсэн хуулийн энэхүү зарчим нь иргэнээс гаргасан нэхэмжлэлийг шүүхэд хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахаас биш тухайн шүүхээс дотоод зохион байгуулалтын асуудлаа хэрэгжүүлдэг шүүгчдийн зөвлөлгөөний үйл ажиллагаанд холбогдолгүй гэж үзэж байна.

2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ” гэсэн заалт нь шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдолгүй учраас Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй байна. Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-нд баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний нэхэмжлэлийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч хуваарилдаг байсан өмнөх зарчмыг үндсээр нь өөрчилж шүүгч бүрт урьдчилсан байдлаар тухайн жил, хагас жилд тус шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс хуваарилж байхаар тогтоосон юм. Ингэснээр хэрэг шийдвэрлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг хааж, шүүгчийн хараат бус байх зарчим буюу Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүгчдийн зөвлөлгөөнийг Ерөнхий шүүгч удирдана. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ” гэж заажээ.

Дээрх заалт нь: 1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн нь шүүхээс хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тусгасан байна. Шүүгчдийн зөвлөлгөөнийг шүүхийн дотоод зохион байгуулалтын ажлыг зохицуулахаар хуульчилсан байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүгчдийн зөвлөлгөөнөөр асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхий шүүгчийн саналаар шийднэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалт, Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан энэхүү дүгнэлтийг хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Хэрэг, маргааныг хамтын зарчмаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргах нь Үндсэн хуулийн суурь зарчмын нэг. Шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцэх асуудлыг хуульд нэр заан тогтоосноос дүгнэхэд энэхүү зохион байгуулалтын бүтэц нь маргааныг шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүнээс зарчмын ялгаатай, “захиргааны” шинжтэй тогтолцоо болох нь харагдана. Урьд нь хэргийг Ерөнхий шүүгч нь хуваарилдаг тогтолцоо манай процессийн хуульд байсан. Бусад гадаад орны тухайд ч Ерөнхий шүүгч хэрэг хуваарилах жишиг нэлээдгүй байдаг. Зарим оронд хэргийг шалгах шүүгчээ “шодох” байдлаар тогтоох арга ч үйлчилдэг. “Шүүгчдийн зөвлөгөөн” болон “шүүх бүрэлдэхүүн” нь хэлэлцэх асуудал, чиг үүрэг, шийдвэрийн хууль зүйн үр дагавар зэргээрээ огт өөр бүтэц. Шүүгчдийн зөвлөгөөн нь үндсэндээ удирдлага, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцдэг тул Үндсэн хуулийн зарчим зөрчигдсэн гэх үндэслэлгүй.

2. Үндсэн хуулийн цэцийн 2004 оны 1 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.03.31 № 2/02**

**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М., Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э., Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>68</sup>

68 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003 оны №3-д нийтлэгдсэн

- 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт "Монгол Улсын Засгийн газар"
- 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт "Сонгуулийн ерөнхий хороо"

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн"
- Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно"
- Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх"

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:

1/ Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн.

Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1-д Засгийн газар нь "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" бүрэн эрхтэй гэж заасан. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлд "1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. 2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана", Дөчин тавдугаар зүйлийн 2-т "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж хуульчилсан.

Энэ нь Улсын Их Хурал, Засгийн газар /бас Үндсэн хуулийн цэц/-аас өөр субъект Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгохгүй гэдгийг шууд тодорхойлсон хэрэг бөгөөд үүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан Үндсэн хуулийн бусад зүйл, хэсгийн заалтаас ч харж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 2-т "Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж заасан ба энэхүү үзэл баримтлалын дагуу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд Ерөнхийлөгчийн баталсан шийдвэрийг хамааруулаагүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т "Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно" гэж заасан байна.

Эндээс үзэхэд Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх гэсэн Үндсэн хуульд заагдсан эдгээр байгууллагуудын шийдвэрүүдийг хүчингүй болгохтой холбогдсон дээрх заалтууд нь угтаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн салаа мөчир тус бүрийн эрх мэдлийн харилцан зааг хязгаар, хариуцлагыг тогтооход чиглэгдсэн байна.

2/ Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан. Сонгууль бол төлөөллийн ардчилал, улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын баталгаа, иргэний сонгох, сонгогдох эрхийн илэрхийлэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэх маргааны нэг төрөл болгон “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”-д Үндсэн хуулийн цэц хяналт тавихыг оруулж заасан нь нэг талаас, Монгол Улсын иргэний сонгуулийн /сонгох, сонгогдох/ буюу тус Улсын Үндсэн хуулиар олгосон улс төрийн эрхийг Үндсэн хуулийн эрх зүйн өндөр төвшинд хамгаалуулах боломжийг Монгол Улсын иргэдэд олгох, нөгөө талаас, Монгол Улсын төрийн эрх барих болон бусад дээд байгууллагыг сонгож байгуулах, түүний нийтийг засаглах дээд эрх мэдлийн хууль ёсны шинжийг хүлээн зөвшөөрүүлэхтэй холбоотой.

Сонгуулийг зохион явуулах үүргийг сонгуулийн байгууллагууд хариуцах ба сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үүрэгтэй сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн үнэн зөв, эргэлзээгүй байдлаас хамаарч нийт сонгогчдын хүсэл зориг шударгаар илэрхийлэгдэж чадах эсэх нь тодорхойлогдох, сонгуульд оролцогч бусад этгээдийн эрх зүйн байдал /статус/-д өөрчлөлт ороход хүргэдэг, мөн сонгуулийн баталгаажсан үр дүнгээр засаг төрийн тогтвортой залгамж чанар хадгалагдах, үндэсний эв нэгдэл хангагдах, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг хууль ёсоор эмхлэн байгуулах зэрэг төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх үндэс болж байдаг. Ийм ч учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна.

Манай улсын хууль тогтоомжоор өдгөө сонгуулийн байгууллагууд захиргааны журмаар сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж байгаагаас гадна сонгуулийн тодорхой зөрчилтэй буюу сонгуулийн өмнөх ухуулга сурталчилгааны журам зөрчсөн зэрэг хэргүүдийг захиргааны шийтгэл ногдуулах журмаар ердийн шүүхийн шүүгч хяналт тавьж хариуцлага хүлээлгэдэг, харин сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар гомдлоо хэсгийн хороонд гаргаад, гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл шууд ердийн шүүхэд хандаж, иргэний процессын журмаар шийдвэрлүүлдэг бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмаар хянан үзэх эрх зүйн журам үйлчилж байна. Гэтэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтаар Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хамааруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн харилцаанд оролцогч сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцохоо Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор илэрхийлж бүртгүүлсэн нам, эвсэл зэргийн хооронд үүсч болох нийтийн эрх зүйн аливаа маргааныг нь захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг олгосон байна.

Энэ нь нэгд, сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, нэр дэвшүүлсэн нам, эвслийн Үндсэн хуулийн эрх зүйн статусыг хөндсөн, хоёрт, сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн байхад ч тодорхой нэгэн этгээдийн эрх ашигт нийцүүлж уул шийдвэрийг хүчингүй болгож байх бүрэн эрхийг Захиргааны хэргийн шүүхэд олгосон, гуравт, сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянан үзэх талаарх халдашгүй байдлын хүрээг ийнхүү хумиснаар хэн боловч өөрийн эрх зөрчигдсэн нэрийдлээр сонгуулийн байгууллагын хууль ёсны шийдвэрийн биелэлтийг

түдгэлзүүлж зогсоох, сонгуульд оролцогчдын хоорондох зөрчилдөөнийг хурцатгах, сонгуулийн дараа ч гэсэн шүүхийн арга замаар ялах “горьдлого” төрүүлэх, шүүхийн процесст сонгуулийн байгууллагууд нэг нэгнийхээ эсрэг нотлох баримт гаргах, хэргийн аль нэг талд гэрчээр оролцох зэргээр “ажиллах”, мөн сонгуулийн байгууллагууд шат шатандаа захиргааны урьдчилан шийдвэрлэх журмаас болж олон гомдол, өргөдөлд дарагдаж сонгуулийг богино хугацаанд багтааж шийдвэрлэж чадахгүй байх, шийдвэрлэсэн ч шүүхээс түүнийг тухай бүр өөрчлөх, эсхүл сонгууль зохион явуулах үндсэн үүргээсээ хазайж хөрөнгө хүч, цагийг маргаан шийдвэрлэхэд зориулах, түүнчлэн шүүх олон нэхэмжлэлд дарагдаж, сонгуулийн маргаантай хэргүүдийг шийдвэрлэх явц хэт сунжрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, сонгогчдын эрх хохирох байдалд хүрэхэд дээрх Үндсэн хуулийн бус заалтын сөрөг үр дагаврууд түлхэж байна.

Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн Нийслэлийн захиргааны хэргийн шүүх Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хянан үзэж байгаа нь ч хууль зүйн хяналтын статус, төвшний хувьд илтэд тохирохгүй байна. Ийм жишиг практик ч олон улсад байдаггүй. Хэрэв Үндсэн хуулийн цэцээс гадна бусад шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянаж байх ёстой гэж үзвэл Улсын дээд шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн заримыг хууль зүйн агуулга, эрх зүйн маргааны шинж онцлогийн хувьд Үндсэн хуулийн эрх зүйн бус маргаан бол хуулиар нарийвчлан тодорхойлсон нөхцөлд хянаж шийдвэрлэж байх нь Үндсэн хуулийн хяналтаас тусгаарлах үндэслэл болох ёстой. Үүнээс гадна захиргааны хэргийн шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг нэхэмжлэлийн дагуу хүлээн авч хянан үзэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмыг мөрдсөн байхыг Сонгуулийн ерөнхий хорооноос шаардахаар хуульд заагдсан байгаа. Гэтэл нөгөө талаар сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцэд хянагдах бол захиргааны хэрэг бус Үндсэн хуулийн маргаантай хэрэг болдог. Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ерөнхий хороо заавал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх албагүй мэт. Тэгэхээр нэг бол сонгуулийн төв байгууллагын аливаа шийдвэрийн талаар Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүхийн алинд нь ч нэхэмжлэл очихыг үл харгалзаж гарсан маргааныг Сонгуулийн ерөнхий хороо “захиргааны хэрэг” мэт үзэж сонгуулийн хуулиас гадна Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар урьдчилж шийдвэрлэж байх, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар гомдол гаргагч Үндсэн хуулийн цэцэд эхэлж “зарга” мэдүүлж, дараачаар нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын маргаан бус байвал сая Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байх гэх мэт Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүх хоорондын маргааны харьяалал, шалгуур журмыг тодотгож Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоож өгөөгүй нь Захиргааны хэргийн шүүхэд Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тодорхойлох боломжийг олгож байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн практикаас үзэхэд Сонгуулийн ерөнхий хорооны Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хянан шийдвэр гаргаж байна. Жишээ нь: Улсын Их Хурлын сонгуулийн 24, 59 дүгээр тойргийн сонгуулийн дүн, дахин санал хураалттай холбоотой маргааныг энд дурдаж болно. Хэрэв уг маргаан Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй бол Сонгуулийн ерөнхий хорооны өөр ямар ч шийдвэр Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй гэдэг нь тодорхой. Сонгуулийн ерөнхий хорооны Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэр хууль зүйн агуулгаараа ч тэр, Үндсэн хуулийн үндэслэлээр ч тэр Үндсэн хуулийн цэцийн хяналтын шууд объект болж чадна. Сонгуулийн ерөнхий хорооны тухайн шийдвэр нь зөвхөн тодорхой нэгэн хувь этгээдийн эрх ашгийг хөндсөн, түүнд холбогдох асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн захиргааны байгууллагаас гаргасан нэг удаагийн чанартай захирамжилсэн акт төдий биш учраас Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэрүүд нь өргөн утгаараа

сонгогчийн субъектив эрх, нэр дэвшигч болон түүнийг дэвшүүлсэн нам, эвслийн эрх ашиг, сонгуулийн объектив дэг журмыг хамгаалах нийтийн ашиг сонирхлын зүй ёсны шаардлага, үндэсний эв нэгдлийг хангах зэргийг бодолцож хууль ёс, зүй ёсны дагуу гарах ёстой шийдвэрүүд байдаг. Чухамдаа эдгээр шийдвэрийг Үндсэн хуулийн заалт түүний үзэл санааны дагуу Цэц л авч үзэж залруулж, нийгэм-төрийн үйл ажиллагаанд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчмыг чандлан сахиулах учиртай. Эдгээрийг харгалзан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье.

2. Иргэн М., Э. нарын ирүүлсэн нэмэлт тайлбарын агуулга:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын “Ерөнхий сайд” гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх заалтын адил Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцээгүй байгаа тул уул асуудлыг өмнө гаргасан хүсэлтийн хүрээнд магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье. Учир нь Ерөнхий сайдын шийдвэр / захирамж/ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрын шийдвэрт хамаардаг юм. Гэтэл Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын шийдвэрт хамааруулсан нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудад шууд харшилж байна.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э., Б. нарын тайлбарын агуулга:

1/ Захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан, иргэн, хуулийн этгээдийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн олон тооны шийдвэр гаргаж байгаа боловч практикт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргасан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянах механизмыг оновчтой тогтоох зорилгоор Засгийн газраас 2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүн / Ерөнхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Сонгуулийн ерөнхий хороо гэх мэт нийтийн эрх зүйн 17 субъекттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан байв. Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчөөс эрх зүйн үр дагавар шууд бий болгодог захирамжилсан шийдвэр гаргах явдал бараг тохиолдохгүй мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэсэн заалтыг хасч, харин гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болсон Засгийн газрын шийдвэр нь шүүхийн журмаар хянагдаж байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөлд хэвээр үлдээжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2-ын “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа, хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна. Практикт дээр дурдсан журмаар Засгийн газрын тогтоол, захирамжийг хүчингүй болгосон явдал тохиолдохгүй байна. Нөгөө талаас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актын талаархи нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтныг харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан

шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан барагдуулах боломжгүй юм.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцын, тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн Наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй” гэсэн Хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газрын гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан. Хэрэв Засгийн газрын шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн статус /эрх зүйн байдал, төвшин/ нь тохирохгүй байна гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ. Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Засгийн газраас гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

2/ Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээгээр эрхлэн явуулах үүрэгтэй байнгын байгууллага бөгөөд бүрэлдэхүүнийг нь 5 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас томилж, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга нь ажлын шаардлагыг харгалзан бүтэн буюу хагас /хавсарсан/ орон тоогоор ажиллаж байхаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуульчилжээ. Мөн Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарахаар заасан билээ. Иймд Сонгуулийн ерөнхий хороо бол парламентаас байгуулагдаж, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах, сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх зэргээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн байгууллага мөн.

Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэр нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “захиргааны акт” гэсэн тодорхойлолтод бүрэн нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр нь захиргааны байгууллагаас гаргасан захирамжилсан шийдвэр, нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан, эрх зүйн үр дагавар шууд бий болгосон, гадагшаа чиглэсэн зэрэг шинжээрээ захиргааны актад хамаарна. Харин өргөдөл гаргагч нарын тайлбарласан шиг Үндсэн хуулийн шинжтэй акт биш юм. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалтын дагуу шүүгч захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн маргаан бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Үндсэн хуулийн цэцэд шилжүүлэхээр хуульчилсан юм. Иймд өргөдөлд дурдсан “Үндсэн хуулийн бус эрх зүйн харилцааны хүрээнд захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг захиргааны хэргийн шүүхэд олгосон байна” гэсэн саналыг зөвшөөрөх боломжгүй юм.

Мөн “сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна” гэж өргөдөлд дурдсаныг зөвшөөрөх боломжгүй. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан билээ. Үүнээс үзэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэртэй холбогдсон маргаан Үндсэн хуулийн цэцэд хамаарахгүй бөгөөд энэ нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдаж байна. Сонгуулийн ерөнхий хороо нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа нийтийн эрх зүйн субъектын хувьд тус улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдгээр хууль тогтоомжийн нэгийг зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд биш захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.1-ийн “Монгол Улсын Засгийн газар” гэсэн заалт Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.6-ийн “Сонгуулийн ерөнхий хороо” гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна.

Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна. Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2. Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай



хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.2 заалтад “Ерөнхий сайд” гэж оруулсан нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн асуудлаар Монгол Улсын иргэн М., Э. нар өргөдөл гаргаагүй харин нэмэлт тайлбартаа дурдсан бөгөөд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй учир дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтыг, мөн 4.1.6-д “Сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан энэхүү дүгнэлтийг хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 28 дугаар тогтоолын агуулга:**

“Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 15.1.5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.1. Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтыг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

## **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн үүрэг нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хянах байдаг бол Захиргааны хэргийн шүүх нь гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хянах явдал юм. Эндээс Цэц, Захиргааны хэргийн шүүхийн нийцэл ба ялгарал харагдах учиртай. Үндсэн хуульд зааснаар Засгийн газар, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Сонгуулийн ерөнхий хороо Цэцэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “хариуцагч” болдог бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөн эдгээр субъектүүдийг Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцагч байхаар хуульчилсаныг би хувьдаа бүрэн хүлээн зөвшөөрч байна.

Хамгийн гол нь хуулийн төвшинд ийм субъектын давхцлаас “Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан” хийгээд “Захиргааны хэрэг”-ийн ялгаа зааг, огтлолцлыг нарийн олж шүүн тунгаах нь 2 шүүхийн ажлын зааг ялгааг зөв тогтоох чухал шалгуур юм. Өөрөөр хэлбэл, дээрх субъектүүд Үндсэн хууль зөрчсөн үү, ердийн хууль зөрчсөн үү, тэрхүү зөрчил нь Үндсэн хуулийн төвшинд хэлэлцэгдэх маргаан уу, эсхүл ердийн хуулийн төвшинд яригдах асуудал уу гэдгийг тогтоох нь Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн ч, Үндсэн хуулийн цэцийн гишүүний ч чадвар, туршлага, мэдлэг сорьсон сорилт юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.04.13 № 2/03**

**Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Т.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>69</sup>

- 3 дугаар зүйл “Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж “эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам.доллар, импортын литр пиво тутамд 0.50 ам.доллар”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

69 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2004 оны № 47-д нийтлэгдсэн

## **Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зөрчигдсөн гэх зүйл заалт:**

- Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурал 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн билээ. Энэхүү хуулийн зарим заалт, тухайлбал, уг хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсгийг, түүнчлэн Үндсэн хуулийн хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн хэмээн үзэж байна.

Тухайлбал, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-ийн 6 дахь заалтад эх орны үйлдвэрийн 1 литр пиво тутамд 0.20 ам.долларын, харин импортын 1 литр пиво тутамд 0.50 ам. долларын онцгой албан татварыг ногдуулахаар заажээ. Эндээс үзэхэд эх орны үйлдвэрийн пиво болон гадаад улс орны бараа бүтээгдэхүүн болох импортын пивонд ногдуулах онцгой албан татварыг харилцан адилгүй, ихээхэн ялгамжтайгаар хуульчлан тогтоосон нь тодорхой харагдаж байгаа юм. Монгол Улс 1996 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэн орж, Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт нэгдэн орсон. Энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т гэрээнд оролцогч аль нэг талын газар нутгаас нөгөө талын газар нутагт импортолсон бараа бүтээгдэхүүнийг тухайн улсын дотоодын бүтээгдэхүүнд шууд болон шууд бус замаар ногдуулдаг дотоодын татвар ба бусад төлбөрүүдээс илүү хэмжээний дотоодын татвар ба бусад төлбөрийг шууд болон шууд бус замаар ногдуулахгүй байхаар заажээ. Үүний зэрэгцээ “Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоолд Монгол Улсын хууль тогтоомжийг Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрүүдэд нийцүүлэх тухай тодорхой зааж өгсөн байдаг.

Монгол Улсад импортолж буй пивоны ихэнх хувийг БНСУ-аас оруулж ирдэг бөгөөд бусад хувийг нь Чех, ХБНГУ, Сингапур, Нидерланд, Бельги, Япон, Австрали зэрэг оронд үйлдвэрлэсэн пиво тус тус эзэлдэг байна. Эдгээр улс орнууд нь бүгд Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт нэгдэн орсон гишүүн орнууд мөн болно. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ...” хэмээн тус тус заасан байдаг. Түүнчлэн Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж заасан.

Иймд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт нь импортолсон бараа бүтээгдэхүүн буюу импортын пивонд ногдуулах онцгой албан татварыг дотоодын бараа бүтээгдэхүүн буюу пивонд ногдуулдаг онцгой албан татварын хэмжээнээс илт илүү, 1.5 дахин их, өндөр хувь, хэмжээгээр тогтоосон учир Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт буюу Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэсэн заалтыг илтэд зөрчсөн хэмээн үзэж байгаа болно. Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтуудаас үзэхэд Монгол Улс нь Дэлхийн худалдааны

байгууллагад элсэн орж, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт нэгдэн орсон тул уг хэлэлцээрээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх үүрэгтэй. Энэхүү үүрэгт дээрх хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт нэгэн адил хамаарч байна. Гэтэл дотоодын болон импортын пивонд харилцан адилгүй татвар ногдуулахаар хуульчлан тогтоосноороо манай орон Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчлөө.

Нөгөө талаар Үндсэн хуульд заасан ёсоор Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж эхэлдэг. Тэгвэл Дэлхийн худалдааны байгууллагад хэлэлцээрт нэгдэн орсон 1996 оноос эхлэн уг хэлэлцээр нь манай дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байгаа нь ойлгомжтой. Үндсэн хуулийн хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж заасан байдаг. Энэ үүднээс авч үзвэл Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт болон Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт өөр хоорондоо зөрчилдөж байгаа үед Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн заалтыг баримтлах ёстой.

Тэгэхээр дотоодын болон импортын пивонд ногдуулсан онцгой албан татварын хувь, хэмжээтэй холбоотойгоор маргаан үүссэн тохиолдолд шүүх Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг бус, харин Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг баримтлах, түүнийг удирдлага болгон асуудлыг шийдвэрлэх хууль зүйн бүрэн үндэслэлтэй. Эндээс дүгнэж үзэхэд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг шүүх, эрх бүхий бусад байгууллагууд хэрэглэх боломжгүй байна.

Ийм учраас хэрэглэх боломжгүй бөгөөд Үндсэн хуульд харшилсан дээрх хуулийн заалтыг хүчингүй болгох, улмаар дотоодын болон импортын пивонд ногдуулах онцгой албан татварын хэмжээ адил байхаар хуульчлагдах ёстой хэмээн үзэж, дараах шаардлагыг Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байна.

Нэгдүгээрт, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт нь импортын пивонд ногдуулах онцгой албан татварыг дотоодын пивонд ногдуулдаг онцгой албан татварын хэмжээнээс илт илүү, 1.5 дахин өндөр хувь, хэмжээгээр тогтоосноороо Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг шууд зөрчиж, улмаар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх тухай Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн болохыг тогтоох;

Хоёрдугаарт, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “0.50 ам.доллар” гэсэн хэсгийг Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт нийцүүлэх арга хэмжээг авч өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э., Засгийн газрын гишүүн, Сангийн сайд А. нарын тайлбарын агуулга:

1/ Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээрийг манай улс тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орох асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж, улмаар Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орох тухай хуулийг баталсан байна.

Улсын Их Хурал 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэ хуулийн 3 дугаар зүйлээр Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, эх орны үйлдвэрийн пивоны литр тутамд 0.20, импортын пивоны литр тутамд 0.50 ам долларын онцгой албан татвар ногдуулан 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн юм.

Хуулийн дээрх заалт нь Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-ын “Хэлэлцэн тохиролцогч аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохиролцогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолсон бараанд дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хураамжаас илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын бусад хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй” гэсэн заалтыг зөрчсөн мэт харагдаж байгаа боловч энэхүү Ерөнхий хэлэлцээрт дотоодын үйлдвэрлэлийн тодорхой салбарт шаардлагатай тарифын хамгаалалтыг хэрэглэж болохуйцаар тарифын бүтцээ аль болох уян хатан байлгах боломжийг хөгжиж буй орнуудад олгосон байна. Тухайлбал, Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2-т “Хэлэлцэн тохиролцогч талууд өөрсдийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор импортод нөлөөлөх хамгаалалтын буюу бусад арга хэмжээг авах шаардлагатай байж болох бөгөөд тухайн арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох учраас тэдгээрийг зүй ёсны гэж хэлэлцэн тохиролцогч талууд мөн хүлээн зөвшөөрч байна” гэж заасан.

Иймд Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар эх орны үйлдвэрийн болон импортын пивонд онцгой албан татварын хэмжээг ялгавартай тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй бөгөөд энэ нь үндэсний пиво үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилготой, Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалтын арга хэмжээ юм.

2/ Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийн өмнө эх орны үйлдвэрийн болон импортын пивонд ногдуулах онцгой албан татварын хэмжээний талаар Дэлхийн худалдааны байгууллагад албан ёсоор мэдэгдэж амжаагүй боловч 2005 оны 3 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд Женев хотноо болж өнгөрсөн, Дэлхийн худалдааны байгууллагад Монгол Улсын худалдааны бодлогыг хянах хэлэлцүүлэгт үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор хамгаалалтыг богино хугацаанд хадгалах гарцаагүй шаардлагын улмаас эх орны үйлдвэрийн болон импортын пивонд ногдох онцгой албан татварын хэмжээг ялгавартай тогтоосныг тайлбарлан цаашид ялгавартай нөхцөлийг арилгах чиглэл баримтлан ажиллахаа мэдэгдсэн бөгөөд энэ талаар Дэлхийн худалдааны байгууллагаас ямар нэгэн санал, зөвлөмж гаргаагүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, “эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам.долларын, импортын литр пиво тутамд 0.50 ам.долларын онцгой албан татвар ногдуулахаар заасан нь Монгол Улсын Үндсэн

хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн удиртгал хэсгийн “Тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх” гэсэн заалт болон 1 дүгээр зүйлийн “Үндэсний нэн тааламжтай нөхцөл”, 3 дугаар зүйлийн “Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл”-ийг зөрчсөн байна.

2. Монгол Улс 1997 онд нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 2 дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн 2-т заасан “Хэлэлцэн тохиролцогч аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохиролцогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортолсон бараанд дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хураамжаас илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын бусад хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй”, 18 дугаар зүйлийн 2-т заасан “Хэлэлцэн тохиролцогч талууд өөрсдийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор импортод нөлөөлөх хамгаалалтын буюу бусад арга хэмжээг авах шаардлагатай байж болох бөгөөд тухайн арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох учраас тэдгээрийг зүй ёсны гэж хэлэлцэн тохиролцогч талууд мөн хүлээн зөвшөөрч байна. Иймээс тухайн хэлэлцэн тохиролцогч талууд дор дурдсан нэмэлт боломжийг эдлэх ёстой хэмээн тохиролцсон бөгөөд ингэснээр дараах боломжийг хангана. (а)үйлдвэрийн тодорхой салбарыг байгуулахад шаардлагатай тарифын хамгаалалтыг хэрэглэж болохуйцаар тарифын бүтцээ аль болох уян хатан байлгах, (б)эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрөөс үүдэлтэй импортын эрэлт хэрэгцээний өндөр түвшинг хэвээр хадгалах зорилтыг анхааралдаа бүрэн авах замаар төлбөрийн тэнцвэрийн зорилгод нийцүүлэн тооны хязгаарлалтыг хэрэглэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай протокол”-ын 1 хэсгийн 3 дахь заалтад “Ажлын хэсгийн илтгэлийн 13 дахь заалтад дурдсан үүрэг, амлалтыг Нарийн бичгийн дарга нарын газарт жил бүр мэдэгдэж байх”-аар заажээ. Монгол Улс нэгдэн орох асуудлаархи ажлын хэсгийн илтгэлийн 13 дахь заалтад “1997 оны 1 дүгээр сарын 1-нээс Монгол Улс нь импортолсон болон дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний аль алинд нь дээрх 11 дүгээр хэсэгт дурдсан барааны төрөл бүрт болон бусад аль ч бараанд ногдуулах онцгой татвар (тусгайлсан, эсхүл, үнийн дүнгээс бодсон)-ын түвшингийн тухайд үндэсний нөхцөлийг хэрэглэх болно гэж монголын төлөөлөгч мэдэгдсэн. Монгол Улс нь 1997 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн импортолж байгаа нийт барааны тухайд худалдааны татварыг хэрэглэхтэй холбогдсон ялгаварлан гадуурхах явдлыг устгах болно гэж монголын төлөөлөгч мэдэгдсэн. Ажлын хэсэг эдгээр үүрэг амлалтыг анхааралдаа авсан” гэжээ.

4. Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааны бодлого хянах байгууллага 2005 оны 3 дугаар сарын 15, 17-нд “Монгол Улсын худалдааны бодлогыг хянасан тухай” Хурлын Тэргүүлэгчийн хаалтын тэмдэглэлд зарим нэг бараанд ногдуулж буй онцгой албан татварыг үндэсний нөхцөлөөр мөрдүүлэхийг гишүүн орнууд Монгол Улсаас хүссэнийг тэмдэглэжээ.

5. Сангийн сайд А. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2004 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан дээр өгсөн хариултдаа, мөн Үйлдвэр, худалдааны сайд Б. 2005 оны 3 дугаар сарын 30-нд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн 1/780 дугаар албан бичигтээ Монгол Улс гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнийг хүлээн зөвшөөрчээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж “эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам.долларын, импортын литр пиво тутамд 0.50 ам.долларын онцгой албан татвар ногдуулахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалт, Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж “эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам долларын, импортын литр пиво тутамд 0.50 ам. долларын” онцгой албан татвар ногдуулахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм, журам мөн уг байгууллагын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн арга хэмжээ байсан тул энэ талаар Дэлхийн худалдааны байгууллагад мэдэгдээгүй гэдгийг ч энэ асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн Цэцэд ирүүлсэн тайлбартаа тодорхой дурдсан.

Онцгой албан татварыг ялгавартай оногдуулах байдал хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө бас л мөрдөгдөж байсан ба Дэлхийн худалдааны байгууллагаас энэхүү ялгаатай татвар оногдуулж байгаа явдлаа зогсоохыг Монгол Улсад сануулдаг, зөвлөдөг байсан. Гэвч хууль тогтоогч Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ зөрчиж, пивонд ногдуулж буй татварын ялгавартай байдлаа зогсоогоогүй. Дэлхийн худалдааны байгууллагаас баталсан Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт бараа бүтээгдэхүүний гарал үүслээс үл хамааран татварын хувь, хэмжээг гишүүн орнууд дотооддоо адил тогтоох ёстой гэсэн зарчим үйлчилдэг байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 10 дугаар дүгнэлт, 2008 оны 1 дүгээр дүгнэлтэй маргаан, холбогдох тайлбарыг харьцуулан үзнэ үү. Агуулга адилхан буюу Онцгой албан татварын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүд хоорондоо зөрчилтэй байдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2009.05.27 № 02

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., З.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга: .

Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Онцгой албан татварын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг өөрчлөн найруулж “эх орны үйлдвэрийн литр пиво тутамд 0.20 ам долларын, импортын литр пиво тутамд 0.50 ам долларын онцгой албан татвар ногдуулах”-аар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим хэсгийг зөрчсөн тухай нэр бүхий иргэний гомдлоор Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянан шийдвэрлэгдэж, Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар 3 дугаар дүгнэлт гарсан.

Уг дүгнэлтээр “эх орны үйлдвэрийн болон импортын пивоны татварын хувь, хэмжээг ялгамжтай ногдуулахаар хуульчилсан”-аар Монгол Улс 1997 онд нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын “Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр”-ийн удиртгал хэсгийн “Тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх” гэсэн заалт, 1 дүгээр зүйлийн “Үндэсний нэн тааламжтай нөхцөл”, 3 дугаар зүйлийн “Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл”-ийг зөрчсөн, ингэснээр Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж дүгнэсэн байна. Улмаар Монгол Улсын Их Хурал 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 36 дугаар тогтоолоороо Үндсэн хууль зөрчсөн болохоо хүлээн зөвшөөрч Үндсэн хуулийн цэцийн 3 дугаар дүгнэлтийг авснаар цэцийн дүгнэлт эцсийн шийдвэр хүчин төгөлдөр болсон.

Гэтэл Улсын Их Хурал 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталж, Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж татварын хувь, хэмжээг нэмэгдүүлэн хуульчилж эх орны болон импортын пивоны татварын хувь, хэмжээг харилцан адилгүй, ялгамжтай тогтоосноороо Монгол Улсын Үндсэн хуулийн 2005 оны 3 дугаар дүгнэлтээр хүчингүй болгосон Онцгой албан татварын тухай хуулийн хүчингүй болсон заалтыг татварын хувь, хэмжээг нь өөрчлөх замаар агуулгаар нь шууд сэргээсэн байна.

Монгол Улсын Их Хурал дээрх Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн дахин зөрчсөн төдийгүй Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэрийг үл ойшоосон хариуцлагагүй үйлдэл гаргасан байна.



Мөн түүнчлэн Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1.2-д заасан “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” болох тухай заалт, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Жаран долдугаар зүйлийг агуулгаар нь зөрчсөн байх бөгөөд төрийн эрх барих дээд байгууллага нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа, илтэд санаатай зөрчсөн шийдвэр гаргаж эх орны үйлдвэрийн болон импортын бараа бүтээгдэхүүнд татварын ялгамжтай, тэгш бус нөхцөл тогтоосноороо Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улс орнуудын өмнө тэр дундаа Монгол Улсад пиво импортлогч гишүүн орнуудын өмнө хариуцлагагүй, хууль тогтоомжийн хувьд тогтворгүй гэсэн сөрөг үр дагавар бүхий үнэлэлтийг авчрахаар үйлдэл гаргасан байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., 3. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Улсын Их Хурал 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэ хуулийн 1 дүгээр зүйлээр импортын пивонд харгалзах онцгой албан татвар “0.20” байсныг “0.35” гэж өөрчилсөн юм.

Хуулийн дээрх заалт Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-ын “Хэлэлцэн тохиролцогч аливаа талын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй, хэлэлцэн тохиролцогч аль нэг өөр талын нутаг дэвсгэрт импортлосон бараанд дотоодын үйлдвэрлэлийн ижил бараанд шууд буюу шууд бус ногдуулдаг татвар, хураамжаас илүү хэмжээгээр дотоодын татвар, эсхүл аливаа төрлийн дотоодын бусад хураамжийг шууд буюу шууд бусаар ногдуулахгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна гэж үзэж иргэн Б. өргөдөл гаргажээ.

Энэхүү Ерөнхий хэлэлцээрт дотоодын үйлдвэрлэлийн тодорхой салбарт шаардлагатай тарифын хамгаалалтыг хэрэглэж болохуйцаар тарифын бүтцээ аль болох уян хатан байлгах боломжийг хөгжиж буй орнуудад олгосон байдаг. Тухайлбал, Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2-т “Хэлэлцэн тохиролцогч талууд өөрсдийн ард түмний амьдралын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор импортод нөлөөлөх хамгаалалтын буюу бусад арга хэмжээг авах шаардлагатай байж болох бөгөөд тухайн арга хэмжээ нь энэхүү хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох учраас тэдгээрийг зүй ёсны гэж хэлэлцэн тохиролцогч талууд мөн хүлээн зөвшөөрч байна” гэж заасан байна. Энэ нь хөгжлийн түвшин доогуур, эсхүл, хөгжиж эхэлж байгаа улс дэлхийн худалдааны байгууллагын дүрмийг ягштал биелүүлэх шаардлагагүй гэсэн санааг агуулж байна гэж үзэж байна. Иймд Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар импортын пивонд онцгой албан татварын хэмжээг ялгавартай тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй бөгөөд энэ нь үндэсний пиво үйлдвэрлэгчдийг хамгаалах зорилготой, Тариф, худалдааны тухай Ерөнхий хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалтын арга хэмжээ гэж үзэж байна. Нөгөө талаар Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр нь “олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоо байгуулах” үндсэн зорилготой байдаг, түүнчлэн мөн хэлэлцээрээр барааг “аль нэг өөр орноос гарал үүсэлтэй, эсхүл, түүн рүү илгээж буй аливаа бараанд олгосон давуу тал, хөнгөлөлт, дархан эрх ямба нь хэлэлцэн тохирогч бусад бүх Талын нутаг дэвсгэрээс гаралтай эсхүл эдгээр нутаг дэвсгэр рүү илгээж буй ижил бараанд ямар нэг болзолгүйгээр тэр даруй олгогдоно” гэдгийг хэлэлцэн тохирогч талууд зөвшөөрсөн байдаг. Энэ нь тодорхой төрлийн барааны хувьд аливаа улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж буй татварын хэмжээ хэлэлцэн тохирогч бусад улсынхтай ойролцоо буюу хэт зөрүүгүй байх гэсэн санааг агуулж байна гэж үзэж байна. Гэтэл манайд пиво импортлогч орнуудын

пивонд ногдуулж буй татварын хувь, хэмжээ манай улсад мөрдөгдөж буй татварын хувьд хэмжээнээс зарим талаар хэт өндөр байна.

Нэмж хэлэхэд, дэлхийг хамарсан санхүүгийн хямралын нөхцөлд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд уг асуудлыг ялгавартайгаар тогтоосон бөгөөд импортоор оруулах пивоны онцгой албан татварыг нэмэгдүүлэхдээ дотоод зах зээлээс гадагш тэмүүлж байгаа валютын урсгалыг аль болох хумих бодлогын хүрээнд уг асуудлыг авч үзсэн болно. Нөгөө талаар импортын пиво тээвэрлэлтийн явцад халах, хөрөх зэргээр чанар нь муудаж борлуулах явцад хадгалах хугацаа нь дуусах гэх мэтээр хэрэглэгчийн эрх ашгийг хохироох явдал гардаг. Иймд дотооддоо хямд үнэтэй, чанартай, шинэ пиво үйлдвэрлэн зах зээлийн хэрэгцээг хангах явдлыг татварын бодлогоор зохицуулах нь хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн арга хэмжээ юм. Ер нь Онцгой албан татварын хууль маань бүхэлдээ импортлогч, дотоодын үйлдвэрлэгч нарт ялгавартай татварын тариф тогтоох зохицуулалттай бөгөөд пивоноос гадна хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнд ийнхүү татварын ялгамжтай тариф хэрэглэснийг энд дурдах нь зүйтэй байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд ялгавартай татвар ногдуулсан нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 3 дугаар дүгнэлт гарснаас хойш 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлах хүртэл хугацаанд Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээрүүд болон Монгол Улсаас тус байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудад өөрчлөлт ороогүй байхад Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн болох нь Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨСТОГТООХ нь:

1. 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн “...5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж... өөрчилсүгэй” гэж эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд онцгой албан татварыг ялгавартайгаар ногдуулахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн байх тул 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “...5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж” өөрчилсөн хэсгийг хүчингүй болгосугай.

2. Улсын Их Хурлаас 2006 оны 6 дугаар сарын 29-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 5 дахь заалт хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

## **Тэмдэглэл:**

Эдийн засаг талаасаа бол хууль тогтоогчийн баримталсан үзэл санаа зүйтэй юм. Өөрөөр хэлбэл дотооддоо сайн хийж чаддаг зүйлээ гадаадын ижил төрлийн бараа бүтээгдэхүүнээс хамгаалах хэрэгтэй юм. Тэр дундаа пиво бол хадгалалтын хугацаа богино, амархан мууддаг бүтээгдэхүүн.

Улсын Их Хурал асуудлыг зөв гаргаж ирж, зөв зохицуулалт хийсэн боловч судалгаа шинжилгээ муу хийсэн тул Үндсэн хуулийн цэцийн өмнө асуудлаа хамгаалж, сайн тайлбарлаж чадаагүй юм шиг санагддаг. Уг нь мэдээлэл гаргагч иргэн Б.-гийн үндэслэл болгоод байгаа Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрт гарц нь байж байсан юм.

Монгол Улсаас бусад бүх орны төрийн бодлогод дотоодын бараа, бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч нарыг татварын бодлогоор хамгаалах бодлого заавал багтдаг байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.06.17 № 2/04**

**Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн  
22 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг  
зөрсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Б., Д.;

Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд С., Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын газрын дарга Д., Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоол

- 2 дахь заалт “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Гучин наймдугаар зүйлийн 7 дахь хэсэг “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг...нас, ...эрхэлсэн ажил, албан тушаалаар нь... ялгаварлан гадуурхаж үл болно”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:**

2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын Засгийн газар “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоол гаргажээ. Уг тогтоолд 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай гэжээ. Тогтоолын энэ заалтыг тэтгэвэрт байгаа иргэний хувьд тэтгэврийн насныхныг 1998 оноос өмнө, хойно гэж хоёр хувааж ялгавартай хандсан бодлогын шинжтэй үйлдэл гэж үзэж байна. Яагаад гэвэл 1998 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүс бол одоо өндөр настай болсон, түргэн хорогдох замдаа орсон, эдгээр хүмүүсийн ихэнх нь социалист нийгмийн үед хөдөлмөрлөж байсан, одоогийн нийгэмд онцын хэрэггүй гэж үзсэн бололтой.

#### **2. Иргэн Б.-гийн өргөдлийн агуулга:**

Миний бие 1952 оноос хойш Сангийн яам, Улаанбаатар хотын захиргаа, Намын хороо зэрэг байгууллагуудад тасралтгүй ажилласан билээ. Би 1990 оны 6 дугаар сард өндөр насны тэтгэврээ тогтоолгоход сарын дундаж цалин 1193 төгрөг болж, 38 жил ажилласнаар тэтгэврийг тогтоосон юм. Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолоор итгэлцүүрийг 100-аар тогтоож тэтгэврийн зөрүүг багасгах, тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлсэн нь төр засгаас өндөр настнуудад үзүүлж байгаа баярлууштай арга хэмжээ боллоо.

Гэтэл энэ тогтоолын 2 дахь хэсгийн заалт нь сарын тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосноос болж, миний ажил хөдөлмөр хийж авсан сарын дундаж цалин 119300 төгрөг нь тогтоолд заасан 120000 төгрөгийн хэмжээнд хүрэхгүй байхад автоматаар хасч 106000 төгрөг болгож тэтгэвэр олгосноос гадна 7.5 хувиар тэтгэврийг нэмээгүй, давхар давхар хохирож байгаа нь Үндсэн хуулиар олгосон эрхээ ч эдэлж чадахгүй болсон нь гомдол гаргах гол шалтгаан болж байна.

Миний дундаж цалин 119300x72 хувиар бодоход 85896 төгрөг дээр 7.5 хувийн 5016 төгрөг бүгд 90912 төгрөгийн тэтгэвэр авах ёстой байхад 76320 төгрөгөөр тогтоож 14592 төгрөг дутуу, үүн дээр 2, 3 дугаар сард дутуу авсан 19152 төгрөг бүгд 33744 төгрөгөөр тэтгэврээ дутуу авч хохирлоо.

Иймээс миний хохирсон, дутуу олгосон тэтгэврийг нөхөн төлүүлэхийн тулд Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудад илтэд харшилж байгаа учир Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 22 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болгож, Үндсэн хуулиар эдлэх ёстой эрхийг бүрэн эдлүүлэх асуудлыг Цэцийн хуулийн дагуу хэрэг үүсгэж, хурлаараа хэлэлцэн ядарч, хохирч яваа хөгшчүүл бидэнд гүн туслалцаа үзүүлэхийг хүсье. Миний энэхүү гомдол хүсэлт нь над шиг хохирч яваа 65 мянган өндөр настны хууль ёсны эрх ашигтай шууд холбоотой учир туйлын анхааралтай хандана гэдэгт итгэж байна.

### 3. Иргэн Д.-гийн өргөдлийн агуулга:

Монгол Улсын төр, засаг минь иргэн биднийгээ тэтгэвэрт гарсан он, нас, хүйсээр нь ялгаварлан гадуурхаж 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийн мөнгийг дутуу олгож 10 жилийн турш бие сэтгэлийн хүнд дарамт учруулж хохироож байна. 1995 оноос өмнө нийт 250 мянган иргэд тэтгэвэр тогтоолгож тэтгэврээ дутуу авч олон тэрбум төгрөгөөр хохирсон төдийгүй тэднээс энэ хугацаанд 170 мянга нь хорвоог орхин одсон бөгөөд одоо 80 хүрэхгүй мянга нь үлджээ. Өөрөөр хэлбэл жилд 17000, сард 1510, хоногт 47-48, цагт 2 тэтгэвэр авагч насан эцэслэж байна. Тухайлбал энэ асуудлаар бидний хамт гомдоллон тэмцэж өргөдөл бичиж хөөцөлдөж явж байсан өндөр настан Б. өргөдлийнхөө эцсийн хариуг ч сонсож чадалгүй насан өөд боллоо.

Ийм учраас Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчиж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээр хуулийн дагуу хэлэлцэж зохих дүгнэлт гарган шийдвэрлэж өгөхийг хүсч байна. Бид энэ хүсэлтээ дараах үндэслэлээр тайлбарлаж байна.

а/ тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 1998 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон хүмүүст 400 мянган төгрөгөөр бодож зарим хүмүүст өндөр тэтгэвэр олгож байна. Гэтэл Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 22 дугаар тогтоолоор 1998 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн сарын цалингийн дээд хэмжээг 120.0 мянган төгрөг болгож, олон ахмадын тэтгэврийг хасч ялгаварлан үзэж гомдоолоо.

б/ 1995 оноос хойших жилүүдэд тэтгэвэрт гарсан хүмүүс, тэтгэвэр тогтоолгосноос хойш ажилласан жилүүдийг тэтгэвэр бодох жилийн тоонд оруулж тэтгэврээ нэмж бодуулдаг. Харин 1995 оноос өмнөх жилүүдэд тэтгэвэр тогтоолгосон хүмүүст тэтгэвэрт орсноос хойш ажилласан жилүүдийг тэтгэвэр бодох жилийн тоонд оруулж, тэтгэврийг нэмж олгодоггүй. Энэ бол ялгаварлан үзэж байгаагийн баримт мөн.

в/ 2005 оны улсын төсвийн хуулиар мөнгөний ханш буурч, бараа, үйлчилгээний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулж 2005 онд цалин тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэх эх үүсвэрийг улсын төсөвт тусгасны дагуу эхний ээлжинд өндөр насны тэтгэврийг 2 дугаар сарын 1-нээс 7.5 хувиар нэмэгдүүлсэн билээ. Гэтэл тэтгэвэр бодох итгэлцүүрийг 100 болгосноор тэтгэвэр нь нэмэгдсэн хүмүүст 7.5 хувийг олгосонгүй. Мөн л ялгаварлан үзэж хохироолоо. Уг нь дутуу олгосон тэтгэврээ нөхөн олгож нэмэгдүүлсэн тэтгэврийн дүнгээс 7.5 хувийг нэмж олгох нь хууль зүйд нийцэх байсан юм.

г/ 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 250000 ахмадуудад сүүлийн 10 жилд ойролцоогоор 150 тэрбум төгрөгийн тэтгэврийг дутуу олгож хэлмэгдүүлсэн явдалдаа Монголын төр засаг уучлалт гуйж нөхөн олговор олгох ёстой. Дутуу олгосон тэтгэвэртээ зөрүү гэж гоё нэр өгч, тэтгэврийн зөрүүг үе шаттай, ээлж дараатай арилгана гэж хуурсаар хэдэн жил боллоо. Ийм байдлаар төр засгаас арга саам хийх аваас тэтгэврээ дутуу авч хохирсоор байгаа, одоо үлдсэн 80 шахам мянган тэтгэвэр авагчид энэ 4 жилд үхэж дуусах нь өнгөрсөн 10 жилийн үйл явц баталж байна. Ийм учраас бидний тэтгэврийн дутууг амьд сэрүүнд минь олгож өгөхөд гүн туслалцаа үзүүлнэ үү. Үүний тулд тэтгэвэр бодох цалинг өсгөх, индексийг 140 болгох шаардлагатай байна.

д/ одоо мөрдөгдөж байгаа өндөр насны тэтгэврийн хууль нь 1994 оны 6 дугаар сард батлагдаж 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж үйлчилнэ гэж хуульдаа заасан байдаг. Гэтэл түүхийн тодорхой нөхцөлд 10-20 жилийн өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг энэ хуулиар бодож, буцаж үйлчилснээс олон хүний тэтгэврийг хасч хохироож байгаа юм. Анх тогтоогдсон тэтгэврийг одоогийн мөнгөний ханшид шилжүүлж олговол ямар нэгэн гомдолгүй шударга болохсон билээ.

Эцэст нь хэлэхэд социалист нийгмийн үед ажиллаж, тэтгэврээ тогтоолгосон олон мянган ахмадуудын эрх ашиг хохирч байгаа нь олон баримтаар нотлогдож байгаа тул Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоохыг хүсч байна. Иргэдээ социализмын ба эдийн засгийн чөлөөт зах зээлийн үед тэтгэвэрт гарснаар нь төр засаг нь ялгаварлаж боломжгүй байна.

#### 4. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 1995 оноос өмнө, хойно тогтоогдсон тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээг дэс дараатай авахаар тусгагдсаны дагуу Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг өсгөж, иргэдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Энэхүү тогтоолоор нийт иргэдийн тэтгэврийг шинэчлэн тогтоохдоо 1990 ба түүнээс өмнөх онуудын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 100 дахин, 1991-2003 онуудын хөдөлмөрийн хөлсийг 50.0-1.00 дахин нэмэгдүүлэн тооцсон.

Итгэлцүүрийг шинэчлэн тогтоосноор одоо авч байгаа тэтгэвэр нь 7.5 хувиас илүү хэмжээгээр нэмэгдсэн 35.4 мянган хүний тэтгэврийн нэмэгдэлд сард 269.8 сая төгрөг, шинэчлэн тогтооход нэмэгдэл нь одоо авч байгаа тэтгэврийн 7.5 хувьд хүрэхгүй байгаа 18.9 мянган хүний тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэхэд 58.1 сая төгрөг, тэтгэврийг шинэчлэн тогтооход одоо авч байгаа тэтгэврийн хэмжээнээс буурсан 221.7 мянган хүний тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэхэд сард 532.1 сая төгрөг нийтдээ сард 860.0 сая төгрөг нэмж зарцуулж байна. Тогтоолыг хүчингүй болгосноор 276.0 мянган иргэний 860.0 сая төгрөгийн тэтгэврийн /нэг сарын/ нэмэгдэл олгогдохгүй болно. 22 дугаар тогтоолын 2 дахь заалт ахмадуудыг оны ялгаа гарган зааглаж байна гэж үзсэн байна.

Уг заалтаар Засгийн газрын 1996 оны 80 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалд шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 1998 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон бүх хүнд 80.0 мянган төгрөг байсныг иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор 120.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Монгол Улсын Их Хурлаас 1994 онд баталсан Нийгмийн даатгалын тухай багц хуулийг 1995 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд тухайн үед уг хуульд даатгуулагчийн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тусгаагүй байсан нь даатгуулагчид тэтгэвэр тогтоолгохын өмнө өндөр цалин хөлс зохиомлоор авах, аж ахуйн нэгж, байгууллагуудад ч үндэслэлгүйгээр өндөр цалин хөлс, шагнал олгуулж их хэмжээний тэтгэвэр авах сонирхлыг хөхиүлэн дэмжих хандлагатай болсон нь нийгмийн даатгалын сангийн ачааллыг зохиомлоор хүндрүүлэх бодит нөхцөлийг бий болгосон юм.

Үүнээс үүдэн Улсын Их Хурлаас 1996 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд “Шимтгэл ноогдуулах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ” тогтоохоор заасан. Даатгуулагчийн шимтгэл төлсөн дундаж цалин хөлснөөс тэтгэвэр боддог тул энэхүү дээд хэмжээ нь тэтгэврийн дээд хязгаарыг хуулиар тогтоосон гэсэн үг юм.

Энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор гаргасан Улсын Их Хурлын 1996 оны 10 дугаар тогтоол, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг тогтоохыг Засгийн газарт даалгасны дагуу “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 1996 оны 80 дугаар тогтоолоор даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 80.0 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд уг тогтоолд 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хууль хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд даатгуулагчийн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс дээгүүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэврийг энэ тогтоолоор тогтоосон дээд хэмжээнээс хэтрээгүй цалингаас нь тэтгэврийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авсны дагуу 1995 оноос өмнө тогтоогдсон бүх хүмүүст үйлчилж байсан. Энэхүү 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 80.0 мянган төгрөг байсныг 2005 оны 22 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар 120.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэхдээ тухайн үеийн хөдөлмөр хөлсний доод хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан иргэдийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ зэргийг баримталсан юм. Ийнхүү өөрчилсөн нь 80.0 мянган төгрөгөөс дээш, төгрөгийн цалин авч байсан иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх нөхцөл болсон.

Засгийн газрын 1998 оны 92 дугаар тогтоолоор даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар шинэчлэн тогтоож, 1998 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж хэрэгжүүлснээр энэхүү хязгаар 120.0 мянган төгрөг болсон юм.

Нийгмийн даатгалын санг бүрдүүлэхдээ тухайн үед 120.0 мянган төгрөгөөс дээш цалин хөлс, орлогоос шимтгэл авдаггүй тул энэхүү дээд хэмжээнээс илүү гарсан цалин орлогоос тэтгэвэр бодох нь шударга хуваарилалтын зарчимд сөрөг нөлөөлнө. Ийнхүү иргэдийн тэтгэвэр тогтоолгосон сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар журамлаж байгаа нь 1990 оноос өмнө 1200-аас дээш төгрөгийн цалин хөлс авч байсан цөөн хүмүүсийн тэтгэврийг хязгаарлалттай тогтооход хүргэсэн тал байгаа ч 1995 оноос хойш сард 120.0 мянган төгрөгөөс дээш цалин авсан хүний тэтгэвэр бодох цалинг ч мөн энэ хязгаараас хэтрүүлэхгүй байгаа нь ахмадуудын оны ялгаа гарган зааглаж байгаа хэрэг гэж үзэхгүй байна.

Энэ заалтыг хүчингүй болговол 1998 оноос өмнө цалингаар тэтгэвэр тогтоолгосон бүх хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох дээд хэмжээ 80000 төгрөг болж олон хүний тэтгэврийн хэмжээ буурахад хүргэнэ.

Иргэн Ба. гуайн хувьд анх тэтгэвэр тогтоолгосон дундаж цалин хөлс нь 119300 төгрөг байсан. Шинэчлэгдсэн итгэлцүүрээр сар бүрийн цалинг нэмэгдүүлэхэд 60 сарын дундаж цалин хөлс нь 106000 төгрөг болсон байна. Энэ асуудлыг нарийвчлан судалсны үндсэн дээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2005 оны 80 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын сангаас Засгийн газрын 2005 оны 22 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тогтоож, нэмэгдүүлэхэд баримтлах аргачлал”-д өөрчлөлт оруулж сар бүрийн дунджийг 120000 төгрөгөөр хязгаарлаж байсныг өөрчилж 60 сарын дундаж нь 120000 төгрөгөөс хэтрэхгүй байхаар шийдвэрлэсэн юм. Иймд Ба. гуайн тэтгэврийг 119300 төгрөгийн дундаж цалингийн 72 хувиар шинэчлэн тогтоох боломжтой юм. Харин энэ нэмэгдлийн хэмжээ нь 7.5 хувиас өндөр байгаа тул дахин 7.5 хувь өсгөх боломжгүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар өргөдөл гаргасан иргэд, Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгчдийн тайлбар, санал хүсэлтийг сонсож, мэтгэлцээний явцад үүссэн асуулт, хариултуудын агуулгыг нягтлан үзэж маргааныг урьдчилан шалгахад цугласан материал, мэргэжилтнүүдийн үзэл бодол, уг асуудалд холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын удаа дараагийн тогтоолууд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын аргачлал, түүний өөрчлөлт зэрэг шаардлагатай бичиг баримтуудыг нягтлан нотолгооны баримтын чанартайгаар шинжлэн судалж үнэлэлт өглөө. Үүний үндсэн дээр хянавал:

1. а/ 1990 он ба түүнээс өмнөх онуудаас Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг наад зах нь 140-өөр тогтоох шаардлагатай;

б/ Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлсийг шинэ итгэлцүүрээр бодож нэмэгдүүлж гаргасан тэтгэврийг дахиад 7.5 хувийг нэмэх ёстой, гэтэл итгэлцүүрээр өсгөж бодоод нэмэгдсэн дүн нь 7.5 хувьд хүрч байвал тэтгэврийг 7.5 хувиар нэмэх заалтыг хэрэглэхгүй байгаа нь буруу, иймд үүнийг залруулах;

в/ Тэтгэврийн зөрүү, худалдан авах чадварын уналтаас шалтгаалж дутуу олгогдсон тэтгэврийг нөхөн олгох ёстой гэсэн утгатай нэхэмжлэлийн шаардлагууд нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэх асуудал биш учир хүлээн авах боломжгүй болно. Өргөдөл гаргасан иргэд энэ тухай асуудлаа төрийн зохих байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

## 2. Нэхэмжлэгчдийн өргөдөлд дурдсан:

а/ 1995 оноос эхлэн мөрдсөн Тэтгэврийн хуулиар 20-иос дээш жил ажилласан бол жил тутамд 1.5 хувийн нэмэгдэл олгодог журмыг 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүст хэрэглэхгүй байгааг засах;

б/ Засгийн газрын 22 дугаар тогтоолын тэтгэвэр бодох 60 сарын дундаж цалинг 120.0-аас хэтрүүлж болохгүй гэсэн агуулгыг практикт гуйвуулж тэтгэвэр тогтоолгохоор сонгож авсан сар бүрийн цалинг 120.0-оос хэтрүүлэхгүй гэсэн журмаар хасаж тайрч байгаа нь буруу байна гэсэн утгатай нэхэмжлэлийн шаардлагууд нь хууль болон тогтоолд заасан утгаараа хэрэгжиж, зарим гажуудал байсан нь засагдсан нь тогтоогдож байгаа бөгөөд үүнийг хуралд оролцогч маргагч талууд харилцан ойлголцсоныг тэмдэглэж байна.

3. Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийг нэмэгдүүлэх талаар Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолоор тогтоосон одоогийн тоо хэмжээг Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Нэхэмжлэгчдийн өргөдөлд дурдсан, Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн “1998 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөлийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалт нь Үндсэн хууль зөрчиж байгаа тул хянаж өгнө үү гэсэн шаардлагыг хүлээн авах үндэслэлтэй байна. Учир нь энэ заалт нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн заалтыг буцаан хэрэглэж өмнө нь тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн эрхийг хязгарласнаараа уг хууль гарснаасаа хойш үйлчлэх үндсэн агуулга болон сүүлийн хуулийн заалт нь тухайн зохицуулж буй харилцаанд оролцогчдын эрх ашгийг сөргөөр хөндөж байвал буцаан хэрэглэж болдоггүй тухай эрх зүйн ерөнхий зарчимтай зөрчилдөж, ингэснээрээ иргэдийг тэтгэвэрт гарсан он, сараар ялгаж “...эрхэлсэн ажил, албан тушаал, нас...” зэрэг үзүүлэлтээр иргэдийг ялгаварлаж болохгүй, хүн бүр хуулийн өмнө тэгш байна гэсэн Үндсэн хуулийн заалтуудад харшилж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” тогтоолын тэтгэврийг шинэчлэн бодох болон шинээр тэтгэвэр тогтоолгоход хэрэглэх итгэлцүүрийг тогтоосон; шинэ итгэлцүүрийг хэрэглээд тооцоход итгэлцүүрээр нэмэгдсэн хэмжээ нь



7.5 хувиас бага байгаа иргэдийн одоо авч байгаа тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэх тухай заалтууд буюу Засгийн газрын 2005 оны 225 дугаар тогтоолын 1, 3, 4 дэх заалтууд нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 3, Арван есдүгээр зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн дээр нэр дурдсан 22 дугаар тогтоолын 2 дахь заалтын “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/04 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 61 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн “Илтгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоолын “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэсэн 2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/04 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. 1995 онд Нийгмийн даатгалын багц хуулиуд батлагдаж мөрдөгдөж эхэлснээс хойш тэтгэвэрийн зөрүүтэй байдлыг арилгах, тэрхүү зөрүүг аль болох багасгах чиглэлээр Засгийн газар олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байсныг дурдах нь зүйтэй. Цэцийн дүгнэлтээр Засгийн газар иргэдийг тэтгэвэрт гарсан оноор нь ялгаварлаж байгааг тогтоосон. Засгийн газарт хүндрэлтэй байж болно. Гэвч Цэцийн хувьд эрх нь зөрчигдөж байгаа хүн нийт тэтгэвэр авагчдын хэдэн хувийг эзэлж байна гэдгээс үл хамааран Үндсэн хуулийн суурь зарчмыг сахиулах үүрэгтэй. Хуулийг буцаан хэрэглэж, 1997 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн эрхийг хязгаарлан, тэдгээрийн эрх ашгийг зөрчих байдлаар тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах гэсэн Засгийн газрын тогтоол Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоосон байна.

2. Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 4 дүгээр дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2005.12.14 № 1/02

### Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Д., Б;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., Э.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Нийгмийн хамгааллын асуудал доторх нилээд томоохон асуудал тэтгэврийн харилцааны асуудал байгаа. Энэ чиглэлээр нилээд эгзэгтэй гэсэн тодорхой тоо хязгаар дээр хүмүүс гомдол гаргаж үүнийг Үндсэн хуулийн цэц их суудлаараа авч хэлэлцэж байгааг би өнөөгийн тулгамдсан бэрхшээлүүдтэй уялдуулж авч үзэх нь зүйтэй юм болов уу гэж бодож байгаа юм. Улсын Их Хурал дээр шийдвэр гаргахдаа нийт ахмадуудын хүрээнд асуудлыг яаж авч шийдэх ёстой юм, гарсан шийдвэр нь хаанаас гарч явсан юм, цаашид гарах үр дагавар нь юу юм бэ гэсэн байдлыг нэлээд дэлгэрэнгүй авч үзсэн. Харамсалтай нь энд шүүмжлэлтэй хэсэг нь тодорхой тэр үндэслэлүүд Цэцэд гаргаж, ирээгүй юм байна би энийг уучлалт гуйгаад сая бас чадах чинээгээрээ Их Хурлын нэрийн өмнөөс тайлбар хийсэн гэж ингэж бодож байна.

Шийдвэр гаргахад нийт тэтгэврийг он онд нь хязгаартай, түрүү нь Ба. гуай ялгавартай гэж яриад байна, тодорхой хязгаартай хэмжээнүүд бариад тэрэнд нь хамааруулж өөрөөр хэлбэл тэтгэврийг зохицуулах, тэгшитгэх маягаар тогтоож ирснийг бид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэрний цаана энэний нөхцөл байдлыг нийтэд нь ойлгохгүйгээр шууд хязгаарыг авч хаях юм бол доод тэтгэвэр, дунд хэмжээний тэтгэвэр, өндөр хэмжээний тэтгэвэр авч байгаа гэсэн тэтгэвэр авагчдын маргаан, бие биенийгээ өндөр бага тэтгэвэртэй гэж ялгаварласан байдлаар ийш тийш нь хандаж байгаа өнөөгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэсэн ийм байдлыг хэлье гэж бодож байгаа юм.

Ялангуяа өнөөдөр тэтгэвэр авагчид юу гэж хэлж байна вэ гэхлээр тэтгэвэр авагч 80000 орчим буюу нийт тэтгэвэр авагчдын 82 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байгаа, 0.5 орчим хувь буюу цөөн хүмүүс 80000 дээш төгрөгийн тэтгэвэр дээр байгаа гэсэн тоо хэмжээ байдаг. Энэ дотор гол масс тэтгэврийн бодлогыг шийдэх асуудал тулгамдсан зорилт болсон. Би түрүүн зориуд А. гишүүний асуултад хариулсан. Монгол Улсын Их Хурал энд анхаарал тавьж хандаж байна. Улсын Их Хурлын даргын захирамж гарч, арван хэдэн хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн байгууллагууд, Улсын Их Хурал, Засгийн газар оролцсон ажлын хэсэг ажиллаж байна. Тэтгэврийг он гарангуут нэмэгдүүлэх арга хэмжээг шийдвэрлэнэ. Энэний өмнө бид энд нэлээд цэгцтэй бодлогыг тодорхойлж гаргая гэсэн ийм байр суурьтай байгаа юм.

Хэрвээ болдогсон бол энэ 120.0 гэсэн энэ хязгаарыг хөдөлгөх гэж байна гэдэг энэ асуудал улсын хэмжээнд, тодорхой мэргэжлийн хүмүүсийн хүрээнд, төр засгийн удирдлагад Монгол Улсын Их Хурлын хэмжээнд энэ тодорхой яригдсан асуудал учраас энэ асуудлыг хэрвээ одоо түдгэлзэж болдог бол энэ хүрээнд нь бид энэ хүмүүстэй хамтарч ажиллаад энэ дээд, доод хэмжээний асуудал, тэтгэврийг нэмэх асуудлыг нэг мөр шийдэхгүй бол бас өрөөсгөлөөр энэ бодлогыг авч яваа бүхэл бүтэн хөдөлгөөн хэсэг бүлэг хүмүүс байгаа гэдгийг энд хэлэх хэрэгтэй. Бид ийм байдлаар Улсын Их

Хурал дээр холбогдох тооцоог хийж байгаа хүмүүс дээр нэлээд нухацтай авч үзэж байгаа гэдгийг энд хэлье энэ бол Үндсэн хуулийн цэцээс гарах шийдвэрт нөлөөлөх гэсэн санаа биш.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засгийн газрын “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын тэтгэврийг шинэчлэн бодох болон шинээр тэтгэвэр тогтоолгоход хэрэглэх итгэлцүүрийг тогтоосон, шинэ итгэлцүүрийг хэрэглээд тооцоход итгэлцүүрээр нэмэгдсэн хэмжээ нь 7.5 хувиас бага байгаа иргэдийн одоо авч байгаа тэтгэврийг 7.5 хувиар нэмэгдүүлэх тухай заалтууд буюу Засгийн газрын 2005 оны 22 дугаар тогтоолын 1, 3, 4, дүгээр заалтууд нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 3, Арван есдүгээр зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна.

2. Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалт нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн заалтыг буцаан хэрэглэж өмнө нь тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн эрхийг хязгаарласнаараа хууль гарснаасаа хойш үйлчлэх үндсэн агуулга болон хуулийн заалт нь тухайн зохицуулж буй харилцаанд оролцогчдын эрх ашгийг сөргөөр хөндөж байвал буцаан хэрэглэж болдоггүй тухай эрх зүйн ерөнхий зарчимтай зөрчилдөж, ингэснээрээ иргэдийг тэтгэвэрт гарсан он, сараар ялгаж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг... нас, ...эрхэлсэн ажил, албан тушаалаар нь... ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ Улсын Их Хурлын 2005 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 61 дүгээр тогтоолд заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Засгийн газрын “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын 2 дахь заалтын “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, ...-ийн өмнө эрх тэгш байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг... нас, ...эрхэлсэн ажил, албан тушаалаар нь... ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/04 дүгээр дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2005 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Авдаг цалин, эрхэлж байсан ажил, төлсөн шимтгэл зэргээс хамаарч тэтгэвэр харилцан адилгүй ялгавартай байх нь зүй ёсны үзэгдэл боловч ажил, мэргэжил нь ойролцоо, цалин хөлс нь ижил хүмүүсийг оны ялгаагаар зааглаж, өөр өөр тэтгэвэр тогтоосон нь Үндсэн хуулийн зөрчил мөн. Цэцэд хандсан иргэд хууль зүйн мэдлэг, боловсрол дутмагаас шалтгаалан зарим тохиолдолд Үндсэн хуулийн зөрчигдсөн заалтыг тэр бүр өргөдөл, мэдээлэлдээ бүрэн тусгахгүй байх нь бий. Цэц гаргаж байгаа шийдвэрээрээ маргаж буй асуудалд хамааруулан Үндсэн хуулийг тайлбарладаг тул Үндсэн хуулийн зөрчигдсөн зүйл, заалтыг өргөдөл, мэдээллийн хүрээнд хязгаарлалгүй өргөн хүрээнд шалгах эрх нь Цэцэд хадгалагдах учиртай.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.06.27 № 2/05**

**Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Э.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их хурлаас 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хууль<sup>70</sup>

- 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг “Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан хэрэгт мөрдөн байцаалт явуулна”

- 12 дугаар зүйлийн 12.3-ын “Хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна”

**Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах...ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

- Тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”

70 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны №29-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Д.-гийн мэдээллийн агуулга:**

Прокурорын байгууллагын тухай хуульд “хохилогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна”, мөн “Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1-д “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах...ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасныг зөрчиж байна. Энэ нь прокурорт өөрийн үзэмж, санаачилгаараа мөрдөн шалгах эрхийг олгосон төдийгүй Улсын ерөнхий прокурорын мэдлийн мөрдөн байцаалтын үйл ажиллагааны ажилтан буюу албаны тогтолцоог бий болгож Үндсэн хуулиар тогтоосон прокурорын чиг үүрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг эрхлэх болгон нэмэгдүүлсэн нь Үндсэн хуулийн дээрх заалт төдийгүй мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Үндсэн хуулийн заалтыг ноцтойгоор зөрчиж мөрдөн байцаах ажиллагааг прокурорын хяналтад, тэр тусмаа Улсын ерөнхий прокурорын мэдэлд шууд үйлчилж байхаар заасан нь нэгдмэл төрийн байгууламжтай Монгол Улсын хувьд тусгайлсан эрх, чиг үүрэг бүхий прокурорын байгууллагад, түүнийг төлөөлж байгаа Ерөнхий прокурорын мэдэлд хүч болгон хуульчилсан нь нэн гайхалтай байна. Иймд Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчиж буй Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Улсын ерөнхий прокурорын дэргэд мөрдөн байцаах алба ажиллуулахтай холбогдсон заалт болон уг хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “хохилогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна” гэсэн заалтыг Үндсэн хуульд нийцүүлэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “мөрдөн шалгах ажиллагаа” гэснийг өргөдөлд “мөрдөн байцаах ажиллагаа” гэж бичсэний учир нь мөн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д Улсын прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба мөрдөн байцаах ажиллагаа явуулахаар хуульчилсантай холбоотой, нөгөө талаар Үндсэн хуульд Прокурорын байгууллагыг мөрдөн байцаах ч бай, мөрдөн шалгах ч бай аль аль үйл ажиллагааг явуулах эрх зүйн үндсийг тодорхойлоогүй, мөн Прокурорын байгууллагын тухай 1993 оны хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн талаарх Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар дүгнэлт Үндсэн хуульд илт нийцээгүй гарсан юм.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:**

Прокурорын хяналтын нэг гол хэлбэр нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах юм. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах бүрэн эрх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл, журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 195 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т тодорхой хуульчлан өгсөн. Прокурорын мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь нэгэнт хийгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дээр дурдсан хуулийн дагуу дахин Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааг явуулах замаар уг ажиллагаа нь хууль зүйн үндэслэлтэй эсэхийг шалган тогтоох ажиллагаа юм. Түүнээс Прокурор мөрдөн байцаалтын ажиллагаанд хутгалдан орж байгаа гэсэн үг биш.

Мөрдөн байцаалтын ажиллагаа гэдэг нь эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөх явцад гэмт хэрэг гарсан эсэхийг тогтоох зорилгоор тодорхой Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эхнээс нь явуулж хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шинээр

цуглуулж бэхжүүлдэг үйлдэл юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн байцаалтыг зохих харьяаллын дагуу зөвхөн мөрдөн байцаагч явуулах ба мөрдөн байцаах ажиллагааны бүх асуудлыг бие даан шийдвэрлэж хэргийг шалгаж дуусах үүрэг хүлээдэг.

Прокурорын мөрдөн шалгах ажиллагаа нь өмнө нь явагдсан тодорхой Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг /гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийг биечлэн байцаах, шинжээч дахин томилох, үзлэг, нэгжлэг, туршилтыг/ давтан явуулдгаараа мөрдөн байцаалтаас ялгаатай болно. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулахын тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 195.1-д заасан дараах нөхцөл зайлшгүй байх шаардлагатай:

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 357.1.1-д заасан “гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт, орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, түүнчлэн хуурамч эд мөрийн баримт, тэмдэглэл, баримт бичгийг үндэслэж тогтоол, магадлал гаргасан нь тогтоогдсон”, 357.1.2-т заасан “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь эрх хэмжээгээ хортойгоор урвуулан ашигласан нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоолоор тогтоогдсон” нөхцөл байдал илэрсэн;

2/ эсхүл хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих явцад хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй;

3/ мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл.

Прокурор дээрх нөхцөл байдал байгаа эсэхийг мөрдөн шалгах ажиллагаа явуулснаар тогтооно. Прокурор нь Үндсэн хуулийн чиг үүргийнхээ дагуу эрүүгийн мөрдөн шалгах байгууллагын хүрээнд хамаардгийн хувьд эрүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаанд ихээхэн үүрэгтэй оролцдог. Прокурор эрүүгийн хэрэг үүсгэх, мөрдөн байцаалт явуулах, шүүхээр хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх процессын нарийн түвэгтэй ажилд хууль хэрхэн биелүүлж байгааг анхнаас нь тасралтгүй хянаж, хууль ёсыг хамгаалах төрийн үүргийг гүйцэтгэдэг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн “Мөрдөн байцаалт явуулах байгууллага” гэсэн 27 дугаар зүйлийн 27.2-д “Прокурорын байгууллагын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэж заасан. Энэ албаны бүтэц, зохион байгуулалтыг нь Прокурорын байгууллагын тухай хуулиар тодорхой болгосон юм.

Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь:

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.2-д заасан харьяаллын хэрэгт мөрдөн байцаалт явуулна;

2/ Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28 дугаар заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ;

3/ Мөрдөн байцаах алба нь Прокурорын байгууллагын тухай хуулийн 10.4-д зааснаар захиргааны удирдлага, аж ахуй, санхүү, боловсон хүчний хувьд бие даасан байна.

Үүнээс үзэхэд прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь захиргааны удирдлага, аж ахуй, санхүү, боловсон хүчний хувьд бие даасан, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч албан тушаалтан болох цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулдаг, хараат бус, төрийн тусгай албаны байгууллага болно.

Улсын ерөнхий прокурор нь зөвхөн Прокурорын байгууллагын тухай хуулийн 10.3-д зааснаар Мөрдөн байцаах албаны бүтэц, дүрмийг баталж, албаны дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө.

Мөрдөн байцаах алба нь үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль бусад хуулийг удирдлага болгон ажилладаг бөгөөд прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 30 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох ба байцаан шийтгэх ажиллагаанд оролцоходоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193, 195 дугаар зүйлд заасан болон хуулиар олгосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Иймд иргэн Д.-гийн өргөдөлд дурдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийг зөрчсөн гэх үндэслэлгүй болно.

**3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:**

Иргэн Д. нь “мөрдөн шалгах ажиллагаа”, “мөрдөн байцаах ажиллагаа”-г ялгаж ойлгоогүй байна. Мөн Улсын ерөнхий прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба ажиллуулах тухай хуулийн заалт нь Үндсэн хууль зөрчөөгүй тул Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн заалтыг зөрчөөгүй гэсэн дүгнэлт гаргаж өгнө үү.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Прокурорын байгууллагын тухай 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-ын “Хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна” гэсэн заалт нь 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно” гэсэн заалттай агуулгын хувьд адил байна.

Улсын Их Хурлаас 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх асуудлаар иргэн Б.-гийн өргөдлөөр үүсгэсэн маргааныг Үндсэн хуулийн цэц 1994 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хянан хэлэлцээд “прокурор... хуульд заасан үндэслэл журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь халдашгүй, чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг хязгаарлахыг хориглох зэрэг Үндсэн хуульд заасан иргэний эрхийг баталгаажуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хууль ёс зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн прокурорын хяналтын арга учир Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна” гэж 7 дугаар дүгнэлт гаргажээ.

Прокурорын байгууллагын тухай хуучин, шинэ хуулиудын дээр дурдсан хоёр заалтын ялгаа нь Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар дүгнэлтийн үндэслэлийг өөрчлөх шалтгаан болохгүй байна.

2. Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба нь прокурорын байгууллагын бүтэц, тогтолцоонд хамаардаггүй, зохион байгуулалтын удирдлага, боловсон хүчин, санхүү, эдийн засгийн талаар тусгаар байж үйл

ажиллагаагаа бие даан, хараат бусаар явуулахаар хуульчлан тогтоосон байна. Нөгөө талаар Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд эрх хэмжээ, цалин хангамж, баталгааны хувьд цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчидтай адилтгагдсан мөрдөн байцаагчид ажилладаг, прокурорын байгууллага нь тэдний дотоод аливаа үйл ажиллагаанд оролцдоггүй, гагцхүү холбогдох хууль тогтоомжид заасны дагуу прокурорын хяналт тавих журмаар харилцаж хуулийн дээрх заалтуудыг зохих ёсоор хэрэгжүүлэн ажилладаг байна.

Цагдаа, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн хэрэгт мөрдөн байцаалт явуулах чиг үүрэгтэй мөрдөн байцаах албыг Улсын ерөнхий прокурорын дэргэд байгуулснаар прокурорын байгууллага мөрдөн байцаах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг гэх хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Прокурорын байгууллагын тухай 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-ын “Хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзвэл прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулна”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-ийн “Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Прокурорын байгууллагын тухай хуучин хуульд Прокурор хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй байсан ба 1994 онд нэр бүхий иргэний мэдээллээр Цэц уг заалтыг хэлэлцэж, Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн шийдвэр гаргасан байдаг. Хэдийгээр уг хууль хүчингүй болсон ч Цэцийн шийдвэрлэсэн хуулийн заалт дараагийн хуульд адил утга агуулгатай тусгагдсан, мөн энэ Цэцийн дүгнэлт хүчин төгөлдөр байгаа тул Цэц маргааныг дахин хянан хэлэлцэх шаардлагагүй байсан.

Прокурорын мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллагаас гардан явуулж буй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаатай хууль зүйн хувьд бүрэн адилтган үзэж болохгүй. Мөрдөн шалгах ажиллагаа нь тухайн эрүүгийн хэргийг шалгах ажиллагаа бус харин уг хэргийг шалгаж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас хууль бус аргаар нотлох баримт цуглуулсан, хэргийн оролцогч нарыг дарамтах, сүрдүүлэх зэрэг хууль зөрчсөн ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж тогтооход чиглэсэн прокурорын хяналтын нэг арга хэлбэр юм.

Ерөнхий прокурорын дэргэд мөрдөн байцаах алба байгуулсан нь прокурор мөрдөн байцаах чиг үүрэгтэй болсон гэх хууль зүйн үндэслэлгүй. Мөрдөн байцаах албаны бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор уг албан бүтэц, дүрмийг баталж, дарга, дэд дарыг томилж, чөлөөлөх эрхийг Ерөнхий прокурорт олгосон. Мөн уг алба нь Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын нэгжид хамаарахгүйгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар харьяалуулсан чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2. Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 7 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005.09.29 № 2/06

### Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн С.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О., Г.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр баталсан Улсын төрийн намын тухай хууль<sup>71</sup>

- 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно”

- 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэг “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэг “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

- Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн С.-ийн мэдээллийн агуулга:

1/ Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-д “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно” гэж заасан нь Үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс авч үзвэл, хүн хэрвээ өөрийн үзэл бодлын үүднээс эвлэлдэн нэгдсэн нам нь үйл ажиллагаагаа зогсоосон /дахин тухайн үзлийг нийгэмд хэрэгжүүлэхгүй нь/, эс бөгөөс өөр бусад намтай нийлэн нэгдэж өөрчлөн байгуулагдсан /өөрчлөгдсөн гэдэг нь мөн үзэл санаанд өөрчлөлт гарсан байх нь/, түүнийг тараасан

71 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2005 оны № 7-д нийтлэгдсэн

/анх нам байгуулагдахдаа шударга ёс, хуулийн дагуу байсан учраас мэдээж Улсын дээд шүүх бүртгэсэн боловч үзэл санаанаасаа гажиж, улмаар хууль зөрчсөнөөр Улсын дээд шүүх тараах шийдвэр гаргасан/ тохиолдолд дахин эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх эрхтэй бөгөөд өөрийн үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдэж байсан намынхаа нэрийг дахин хэрэглэх эрхтэй юм. Нөгөө талаар намын нэр нь үзэл санааны хураангуйлсан хэлбэр бөгөөд үзэл санааны үндсэнд эвлэлдэн нэгдсэн намын гишүүдийн оюуны өмч учраас төр намын асуудалд хөндлөнгөөс оролцож, энэхүү эрхэд халдаж, цаг хугацааны хязгаарлалт хийж байгаа нь эвлэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг хааж байна.

Мөн төр намын хэрэгт оролцон, түүний дотоод асуудлыг хуульчилж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх...эрх чөлөөтэй” гэснийг зөрчсөн байна. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-ыг шинжлэн судалбал, нам үзэл санаа, үйл ажиллагаагаа зогсоосон, эсвэл бусад намтай нэгдэх замаар үзэл санаа үйл ажиллагааны хувьд өөрчлөн байгуулагдсан, эсвэл үзэл санаанаасаа ухарч хууль зөрчсөний улмаас Улсын дээд шүүх намыг тараасан тохиолдолд, Монгол Улсын иргэн “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, итгэл үнэмшил, үзэл бодлын үүднээс нам байгуулан, сайн дураараа эвлэлдэн нэгдэж”, дахин өөрийн намын бүтэн болон товчилсон нэрийг хэрэглэх эрхгүй болсон байна. Намын нэр гэдэг нь намын гишүүдийн үзэл санааны илрэл, тэдний оюуны өмч учраас Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2-т заасан “Төр нь...өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн энэхүү заалтыг мөн зөрчиж, намын асуудалд хөндлөнгөөс оролцож, тэдний эрхийг хязгаарласан байна.

Ийнхүү хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласнаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Аравдугаар зүйлийн 3-т заасан “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2/ Монгол Улсын Улс төрийн намуудын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д “Нам үүсэн байгуулагдаж, Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болох бөгөөд энэ заалт өөрчлөн байгуулагдаж, шинээр бүртгүүлсэн намуудад хамаарахгүй” гэж заасан нь хүн бүр тайван замаар, сайн дурын үндсэн дээр, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхээс гадна сонгуулийн тэгш эрхийн үндсэн дээр сонгох, сонгогдох тэгш эрхтэй бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд цаг хугацаа, орон зай, нутаг дэвсгэр, илэрхийлэх арга, хэлбэрийн хувьд төр хязгаарлалт хийх ёсгүй. Хэрвээ хязгаарлалт хийвэл ардчилсан ёс, үндсэн хуульт ёсноос ухарч буй хэрэг болно. Хүний эрхийг хүлээн зөвшөөрч байгаа бол энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд эрх зүйн бус хязгаарлалт хийж болохгүй юм.

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д заасан иргэд нам үүсэн байгуулж, Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох эрхтэй байгаа Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, 10 дугаар зүйлд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалтыг зөрчихөөс гадна тэгш эрхийн зарчмыг зөрчсөн байна.

Ийнхүү хүн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр нэгдэн нам байгуулан, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласнаар Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 10 дугаар зүйлийн 3-т заасан “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн заалтуудыг мөн зөрчсөн байна.

Улс төрийн намын тухай хуулийн дээрх заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль төдийгүй Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын холбогдох заалтыг зөрчсөн байна.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О., Г. нарын тайлбарын агуулга:

1/ Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам оноосон нэртэй байх”-аар заахдаа намын нэр нь түүний үзэл санааны хураангуй байхаар тогтоогоогүй юм. Намын нэр бусад намын нэртэй адил байхыг хуулиар хориглосон. Нөгөө талаар барууны, эсхүл зүүний үзэл баримтлалтай нэг чиглэлийн намууд байлаа ч адил нэртэй байх боломжгүй билээ. Иймд намын нэр үзэл санааны хураангуй байх ёстой гэх, түүнчлэн намын нэрээс шалтгаалан эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг хаасан гэх үндэслэлгүй болно.

Монгол Улсын иргэнд “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй байх зэрэг иргэний эрхийг Монголын төр Үндсэн хууль болон бусад хуульдаа заан эрх зүйн зохицуулалттай болгож баталгаажуулж өгсөн. Нөгөө талаар ямар ч хязгаарлалтгүй эрх хэмжээ, абсолют эрх гэж байдаггүй, байх ч боломжгүй, аливаа эрхийг тодорхой эрх зүйн зохицуулалтын хүрээнд эдлэх тухай ардчилсан зарчим олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд энэ хязгаар, зохицуулалтыг Үндсэн хуульд нийцсэн хуулийн зохицуулалтаар тогтоодог. Энэ ч үндэслэлээр Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалт, тухайлбал, Аравдугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3-т заасан “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Улс төрийн нам нь хуулийн этгээд болохын хувьд түүнтэй холбогдсон зарим харилцааг холбогдох бусад хуультай, тухайлбал, Монгол Улсын Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудтай нийцүүлэх, уялдуулах шаардлага бодитойгоор байсан юм. Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д хуулийн этгээд өөрийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан нэртэй байх, 27.3-т хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” байх, 27.4-т хуулийн этгээдийн нэрийг бусад этгээд хууль бусаар ашиглахыг хориглох, 27.5-д хуулийн этгээд нэрээ хуульд заасан /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/ журмын дагуу бүртгүүлж байхаар тус тус заасантай бүрэн нийцүүлж баталсан юм.

Тиймээс 6.3 дахь хэсгийн заалт нь сайн дураараа эвлэлдэн нэгдэх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрхийг хязгаарлаж байгаа асуудал биш гагцхүү “хуулийн этгээд” болохын хувьд Иргэний хуулийн дээрх ерөнхий нөхцөлтэй нийцүүлсэн намын нэртэй холбогдсон эрх зүйн харилцааны зохицуулалт юм. Түүнчлэн гадаад улс орны, тухайлбал ардчилалд шинээр нэгдсэн орнуудын энэ төрлийн хуулиар намын нэрийг тусгайлан зүйл, заалт болгон тусгаж зохицуулсан жишгийг ч харгалзан үзсэн хэрэг.

Тухайлбал ОХУ, Украин, Беларусь, Казахстан зэрэг улсын Улс төрийн намын тухай хуульд намын нэртэй холбогдсон тодорхой хязгаарлалтууд тусгагдсан байна. ОХУ, Беларусьт шүүхээр татан буугдсан намын нэрийг дахин хэрэглэхийг бүр мөсөн хориглосон байна. Харин Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн холбогдох заалтад “24” жилийн хугацаанд л хязгаарлаж байгаа юм.

2/ Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн заалт нь Монголын улс төрийн тогтолцооны өнөөгийн төлөвшил, иргэд, улс төрчдийн улс төрийн мэдлэг боловсрол, соёлын түвшинтэй холбогдож зайлшгүй шаардлагаар урган гарсан зохицуулалт болно. Манай орны улс төрийн амьдралын өнгөрсөн арав гаруй жилийн практикаас үзэхэд иргэд нь жинхэнэ өөрсдийн улс төрийн үзэл бодол, ашиг сонирхлоороо эвлэлдэн нэгдэх, түүндээ итгэл үнэмшилтэй, тууштай байж, улс төрийн амьдралд идэвхтэй байнга оролцож, улс төрийн үзэл бодол, намын зорилт, зорилгоо бодитойгоор хэрэгжүүлж, тогтвортой ажиллахын тулд бус гагцхүү тухайн сонгуульд нэрээ дэвшүүлж оролцох гэсэн хэн нэгэн буюу цөөн хэдэн хүмүүс өөрсдийн ашиг сонирхлын үүднээс бусдын тодорхой нэгэн хараат байдал /сургуулийнхаа суралцагсад, үйлдвэр, компанийхаа ажилтнаа/-ыг ашиглан, тэдний улс төрийн үзэл бодол, ашиг сонирхол, итгэл үнэмшлийг үл харгалзан нэрийн жагсаалт үйлдэж нам байгуулдаг, тэр нь цаашдаа дараа дараагийн сонгуульд оролцох зэргээр тогтвортой үйл ажиллагаа явуулах сонирхол, зорилгогүй байдаг нь харагдаж байгаа юм.

Энэ нь 1990 онд Улс төрийн намуудын тухай хууль батлагдсанаас хойш 20 гаруй нам улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч ихэнх намын байршил, хаяг, утас нь тодорхойгүй, удирдлага нь ч олдохгүй, үйл ажиллагаа нь ч тодорхойгүй, зарим нь бүр ор нэрийн төдий байгаагаар нотлогдож байгаа юм.

Бүртгэлийн байгууллага ч тэр бүр хяналт тавьж чадахгүй, хариуцлага тооцох механизм ч байхгүй байдал үргэлжилсээр байгаа юм. Энэ байдал нь тухайн намын гишүүдийн эрх ашгийг хөсөрдүүлж байгаа хэрэг гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Бий болсон энэхүү нөхцөл байдлыг арилгах, намуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрийн төлөвшлийн байдлыг харгалзан үзэж энэ заалтыг 1 жил 6 сарын хугацаагаар тусгасан. Гэхдээ энэ нь нам сонгуульд оролцох эрхийн асуудлыг анх удаа зохицуулж байгаа хэрэг биш гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам буюу намуудын эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй” байхаар хязгаарлалт тогтоосон байдгийг дурдахад хангалттай юм.

Дээрх үндэслэлүүдээр Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй, түүнчлэн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон хязгаарлалт хийсэн нь иргэдийн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхэд халдсан шинжийг агуулжээ.

2. Аливаа нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байхад түүнийг 18 сарын дараа төрийн сонгуульд оролцуулахаар хуульчилсан нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна.

3. Улс төрийн намын тухай хуулийн дээрх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Өргөдөл гаргагч С. Цэцийн дунд суудлын хуралдааны явцад Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэсэн өргөдлийн шаардлагаасаа татгалзсан болно.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтыг зөрчөөгүй байна.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр тогтоосугай.

5. Энэхүү дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/06 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн

дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”, Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 2/06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

### **Тэмдэглэл:**

Намын нэрийг оноосон нэр гэж үзээд давхардуулахгүй үүднээс 24 жилээр хязгаарласан гэж тайлбарлах тохиолдолд 24 жилийн дараа давхардаж болдог гэсэн логик байж болохгүй л дээ. Давхардуулахгүй байх утгаар нь намын нэрийг хэрэглэхийг хориглож байгаа бол энэ хязгаарлалтад хугацаа заах шаардлага байсан уу, үгүй юу. Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн хувьд иргэний сонгох, сонгогдох мөн эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж байгаа хэрэг. Одоогийн хууль ёсоор намаас нэр дэвших тохиолдолд тухайн нам нь зөвшөөрөгдөөгүй буюу улс төрийн сонгуульд оролцох эрх нь үүсээгүй байна гэх шалтгаанаар 18 сар тухайн нэр дэвшигчийн эрх хязгаарлагдахад хүрнэ.

Сонгогдох эрх хязгаарлагдахаар нэр дэвшигчийг сонгох сонгогчийн эрх ч мөн хязгаарлагдах үр дагавартай. Улс төрийн намын туйлын зорилго нь төрийн эрх барьж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжийг олох явдал гэж тайлбарлаж болно. Нэлээд хэдэн жилийн өмнө АНУ-ын Харвардын Их сургуулиас зохион байгуулсан чөлөөт зах зээлтэй орнуудын 80 гаруй улс төрийн намыг хамарсан хөндлөнгийн судалгаагаар “улс төрийн нам гэдэг нь төрийн эрх мэдлийг авах зорилготой бүлэг хүмүүсийн нэгдэл” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Төрийн эрх барихын тулд нам Улсын Их Хурлын ээлжит сонгуульд өрсөлдөх зүй ёсны шаардлага. Иймд намыг Улсын дээд шүүхэд албан ёсоор бүртгүүлснээс хойш улс төрийн бүхий л үйл ажиллагаанд оролцох эрхийг нээлттэй болгох нь зүйтэй. Тэр тусмаа сонгуульд оролцох эрхийг нь тодорхой хугацаагаар хуулиар хязгаарлах нь төрийн эрх барьж буй улсын төрийн намын дарангуйлал тогтоох уршигтай. Хугацааны хувьд 18 сар байна уу, 2 жил байна уу тэр чухал бус, гагцхүү ийнхүү хязгарлаж байгаа нь Үндсэн хуулийн зөрчил.

Нам нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, мөрийн хөтөлбөр нь нийгмийн зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг хангасан, нэр дэвшигч нь ард түмний итгэлийг дааж, төрийн бодлого тодорхойлох мэдлэг, чадвартай, мөн сонгуульд өрсөлдөх санхүүгийн чадвартай бол сонгуульд оролцох эрхийг нь нээгээд л өгөх хэрэгтэй. Улс төрийн намын сонгуульд оролцох эрхийг хуулиар хязгаарласан эсэхээс үл хамаараад сонгогчид тэдэнд эцсийн хариуг өгдөг ардчилсан нийгмийн зүй тогтол байдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2005.11.14 № 1/01

### Улс төрийн намын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн С.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О., Г.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., О. нарын тайлбарын агуулга:

1/ Иргэний эвлэлдэн нэгдэх эрх нь эвлэлдэн нэгдсэн бусад этгээдүүдийн эрхийг хөндөхгүй байх эрхээр хязгаарлагддаг ерөнхий зарчим нь ардчиллын үндсэн зарчмуудын нэг байдаг. Иргэний эрхийн тодорхой эрх зүйн зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулагдаж байгаа жишээ олныг дурдаж болохоор байна. Тухайлбал, иргэний амьд явах эрхийг ч хязгаарлаж болох тухай заасан заалт нь үүний нэг жишээ юм. Монгол Улсын Үндсэн хуульд иргэний амьд явах эрхийг заасан бөгөөд Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулдаг. Хэдийгээр сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийнхээ дагуу улс төрийн намыг иргэд байгуулдаг боловч ийнхүү байгуулсан “нам”-ыг зохион байгуулалтын нэгдэл гэж үзэн хуулийн этгээд болохын хувьд тэдгээрийн нэртэй холбогдуулан тавих нийтлэг шаардлагын хүрээнд зохицуулж байгаа асуудал юм.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийн нэг нь түүний дүрэм байдаг. Намыг үүсгэн байгуулах хурлаар тухайн намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбааны загварыг батлах зэрэг намын дотоод зохион байгуулалттай холбогдолтой асуудлаа хэлэлцэх бөгөөд ийнхүү хэлэлцэхдээ ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэж, намын дүрэмдээ тусгахаар заасан. Энэ утгаар авч үзвэл тухайн намын нэрний асуудал нь эвлэлдэн нэгдэх эрхийн асуудалтай холбогдолгүй байх бөгөөд гагцхүү түүний гишүүдийн хамтаар хэлэлцэн олонхоороо шийдвэрлэх асуудал тул намын нэрээс шалтгаалан эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх боломжийг хаасан гэх үндэслэлгүй байна.

Нөгөө талаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуулийн этгээдийн бүртгэлийн жагсаалтад тусгах мэдээлэлд тухайн хуулийн этгээдийн нэрийг тусгахаар онцлон зааж, мөн хуулийн 16.1.6-д хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллагаас шалгуулж баталгаажуулсан баримтыг ч давхар бүрдүүлэн өгөх шаардлага тавьсан. Энэ нь хуулийн этгээдийн нэр нь өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй байх ерөнхий зарчмыг баримталсан хэрэг юм. Хуулийн дээрх зохицуулалт нь сайн дураараа эвлэлдэн нэгдэх иргэний эрхийг хязгаарлаж байгаа асуудал биш харин хуулийн этгээд болохын хувьд өөрөөр хэлбэл “байгууллага”-д хязгаарлалт тогтоож байгаа асуудал гэж үзэх бүрэн үндэслэлтэй. Энэ асуудалтай жишиж авч үзэж болох хуулийн тодорхой зохицуулалт ч манайд үйлчилж байгаа. Тухайлбал, Улсын Их Хурлын 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 103 дугаар тогтоолоор “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ” сонин, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, яам, агентлаг, түүнтэй адилтгах байгууллагын дэргэдэх радио, телевиз, сонин, сэтгүүлийг 1999 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс татан буулгаж, тэдгээрийн нэрийг 5 жилийн хугацаанд дахин хэрэглэхийг хязгаарласан

юм. Түүнчлэн Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар зарим зүйлийг барааны тэмдгээр бүртгэхгүй байх, түүнчлэн зарим барааны тэмдгийг бүртгэхгүй байхаар хязгаарлалт тогтоосон байна. Энэ нь нэр хэрэглэхтэй адил төсөөтэй хуулийн хязгаарлалт гэж үзэж болно.

2/ Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалт нь улс төрийн намын байгууллагад тавьсан шаардлага гэж ойлгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, нам нь улс төрийн үйл ажиллагаа явуулах гол зорилгын үүднээс байгуулагдаж байдаг бөгөөд нам байгуулах, улс төрийн тогтолцоонд өөрийн гэсэн байр сууриа эзэлнэ гэдэг нь үндсэндээ сонгогчдын өмнө хүлээх хариуцлагыг өөртөө бий болгох чадамжийг бүрдүүлсэн байх шаардлагатай юм. Дурын хүн, дурын бүлэг нам байгуулдаггүй. Онолчдын тайлбарласнаар нам байгуулах /нам болох/, улс төрийн үйл ажиллагаанд оролцох гол шалгууруудыг ерөнхийд нь авч үзвэл тодорхой хэмжээний гишүүд дэмжигчдээс гадна онолын суурь дэвсгэр, тэр онолд тулгуурлан гаргасан улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн байдалд хийсэн үнэлэлт, дүгнэлт, улс орныг цогцолбороор хөгжүүлэх үзэл баримтлал зайлшгүй байх шаардлагатай гэж үздэг байна. Энэхүү үзэл баримтлалыг тусгасан гол баримт бичиг нь намуудын мөрийн хөтөлбөр болдог. Иргэд, сонгогчид эдгээрийг үндэслэн, өөрөөр хэлбэл ямар мөрийн хөтөлбөртэй оролцож байгааг үндэслэн улс төрийн намуудыг хооронд нь ялгаж, сонгуульд ямар намын нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхөө шийддэг нийтлэг жишиг дэлхийн улс орнуудад үйлчилж байна. Манай орны хувьд ч энэхүү нийтлэг жишгээр явж байгаа билээ.

Тийм ч учраас Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлд нам нь Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байхаар тусгагдсан. Сонгуульд оролцож байгаа намууд ч өөрийн мөрийн хөтөлбөртэйгээ оролцож байдаг. Сонгох, сонгогдох эрхийн “сонгох” иргэний эрх нь суурь эрх, нийтийн эрх гэж ойлгодог бөгөөд харин “сонгогдох” иргэний эрхэд хуулиар хязгаарлалт тогтоосон байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийн сонгогдох эрхийг насаар хязгаарласнаас гадна, Монгол Улсын уугуул иргэн байх, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх нөхцөлүүдээр хязгаарласан. Улс төрийн намын төлөвшил, хүлээх хариуцлага нь сонгогчдын эрх ашигтай ийнхүү шууд холбоотойгоор гарч ирдэг, энэ ч утгаараа Үндсэн хуулийг сахин хамгаалах, Үндсэн хуулийн хүрээнд төрийн буюу ард түмний эрх мэдлийг тогтвортой баталгаатай хангах, төрийн эрх барих дээд байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох иргэд, сонгогчдын эрхийг /суурь эрх, нийтийн эрхийг/ хамгаалахад чиглэгдсэн чухал заалт гэж үзсэн. Дээрх үндэслэлүүдээр Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалтыг зөрчөөгүй байна гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон хязгаарлалт хийсэн нь иргэдийн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхэд халдсан шинжийг агуулжээ. Намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж үзвэл дээрх хуулиар тогтоосон хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон байна.



2. Аливаа нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй байхад түүнийг 18 сарын дараа төрийн сонгуульд оролцуулахаар хуульчилсан нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна. Улс төрийн намууд Улсын дээд шүүхэд бүртгүүлж гэрчилгээ авснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд энэхүү үйл ажиллагааны гол хэсэг нь улс төрийн сонгуульд оролцох явдал мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Нам үүсэн байгуулагдаж Улсын дээд шүүхэд бүртгүүлснээс хойш 18 сарын дараа Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

3. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/06 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 58 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

4. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг өөрөө 2 төрлийн алдаа агуулж байна. Нэгдүгээрт, 24 жилийн хугацааг өмнө дуусгавар болсон намын нэртэй холбож үзсэн. Хоёрдугаарт, тараагдсан намтай холбож байна. Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, нэрээ өөрчилсөн, түүнийг тараасан бол гэдэг нь хууль зүйн өөр өөр ойлголт бөгөөд тэдгээрийг ялгалгүйгээр бүхэлд нь хязгаарлалт тавьсан байна. Гэтэл намыг тараах процедур шүүхийн, харин нам нэрээ өөрчлөх процедур нь тухайн намаас шийдвэр гаргах журмаар явагддаг билээ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005.09.30 № 2/07

### Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Т., Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Б.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>72</sup>

- 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд дангаараа 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох бөгөөд намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно”

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “Аль нэг нам...-ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:

1/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн “...намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно” гэсэн заалт нь эрх зүйн нэг статустай, нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа Улсын Их Хурлын тухай хуулийн хүчин төгөлдөр үйлчилж буй бусад заалт, үүнд: Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т заасан “Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж байгаа гишүүд... аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэх бол тухайн нам, эвслийн бүлэгт нэгдэн орох хүсэлтээ тавина”, мөн зүйлийн 3-т заасан “Аль нэг намын бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно”, мөн зүйлийн 4-т заасан нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох тухай заалтуудтай зөрчилдөж, хуульд зэрэгцсэн зөрчилдөөнтэй зохицуулалтыг бий болгож, улмаар Үндсэн хуулийн 1.2-т заасан “Хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

72 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2005 оны № 30-д нийтлэгдсэн

Мөн энэхүү заалт нь Улсын Их Хурлын гишүүдийн дунд эрх зүйн ялгаварлал бий болгож тодорхой зарим гишүүд, тухайлбал 8-аас дээш суудал бүхий намын Улсын Их Хуралд сонгогдсон гишүүний “бүлгийн харьяаллаас татгалзан гарч өөр бүлэгт нэгдэн орж болох”, бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүний “аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох” зэрэг эрхээ эдлэх боломжгүйд хүрч Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...тэгш байдал... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “Аль нэг нам...-ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэснийг зөрчиж байна.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хуралд 8-аас доош суудал бүхий нам, 8-аас дээш суудал бүхий нам, бие даан нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд шударга ёсны өөр өөрийн тодорхой онцлогтой аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэн орох, гарах хүсэлт тавих, нөгөө талаас нам эвслийн бүлгүүд тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч өөрийн бүлэгт нэгтгэх эсэхээ улс төр, хууль зүйн шахалт, хавчилтгүйгээр хэлцэн шийдэх нь чөлөөт ардчилсан парламент дахь зүй ёсны асуудал бөгөөд энэхүү зүй ёсны байдал Улсын Их Хурлын тодорхой нэг бүлэг, тодорхой хэсэг гишүүдэд хамааралгүй болж, хуулиар хязгаарлагдсан нь Үндсэн хуулийн 1.2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

2/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулсан хуулийн үйлчлэлийг тодорхойлсон “Энэ хууль Улсын Их Хурлын 2004 оны 4 дэх удаагийн ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйлчилнэ” гэсэн заалт нь Үндсэн хуулийн хууль дээдлэх ёсны зарчимд үндэслэдэг “хууль нийтлэг нөхцөлөөр тодорхойлогдсон байх ёстой бөгөөд тодорхой нэг субъект, тодорхой нэг тохиолдолд зориулагдах ёсгүй” гэсэн эрх зүйт төрийн суурь зарчим, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дээрх заалтыг зөрчиж байна.

Тодорхой хуулийн хүрээнд сонгуульд эвсэл байгуулж оролцоод сүүлд нь өөрсдөдөө зориулсан хууль гаргаж мөрдүүлэх нь ардчиллын ёс зүйд нийцэхгүй, Үндсэн хууль бусад хуулийн дагуу Улсын Их Хурлын үйл ажиллагаагаа явуулах, хуулийн бусад заалтууд хэвийн үйлчлэхэд сөрөг нөлөөтэй, ээлжит сонгуулиар сонгогчдын өгсөн саналыг үл хүндэтгэсэн, улс төрийн намуудын хариуцлагыг сулруулсан хууль болсон байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хууль нь Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.

Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэж орж байсан нам... бүлэг байгуулж болохоор заасан нь “Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг бий болох тухай” Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байна.

## 2. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

1/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэж орж байсан нам... бүлэг байгуулж болох”-оор заасан нь Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг бий болох тухай Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж байна. Мөн энэхүү заалт нь “Эвсэл байгуулсан намууд сонгуульд болон шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох”-оор хуульчилсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2/ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд “намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно” гэсэн нь Улсын Их Хурлын сонгуулийн хуультай зөрчилдөж улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад

шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3/ Уг хуулийн 2 дугаар зүйлд “Энэ хууль Улсын Их Хурлын 2004 оны 4 дэх удаагийн ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйлчилнэ” гэж заасан нь аливаа хууль нийгэмд тэгш, тогтвортой үйлчлэх суурь зарчмыг алдагдуулж, тодорхой хэсэг, бүлгийн ашиг сонирхлыг хамгаалж, ялгавартай хандсан байна. Тодорхой субъектэд зориулж хууль гаргасан байна гэж үзэж байна.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам /эвсэл/ бүлэг байгуулж болохоор заасан боловч эвсэл цуцлагдсан тохиолдолд эвсэлд багтаж байсан 8-аас доошгүй суудалтай нам бүлэг байгуулж болох эсэх нь тодорхой бус, үүнээс шалтгаалж Улсын Их Хурлын 2004 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан “Эх орон-Ардчилал” эвсэл цуцлагдахад 8-аас дээш суудалтай Ардчилсан нам бие даасан бүлэг байгуулах бололцоогүй байсан билээ.

Энэ байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “...Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн заалтыг дараах үндэслэлээр хэрэгжүүлэх замыг бүрхэг болгож байна гэж үзсэн юм:

а/ хуулийн тодорхой бус заалтаас шалтгаалан “Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь ардчилсан төрийг төлөвшүүлэх, ард түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулан хэрэгжүүлэх зарчимд үндэслэнэ” гэсэн заалт амьдралд хэрэгжих боломжийг хаасан.

б/ Парламентын засаглалыг Үндсэн хуулиараа баталгаажуулсан манай орны хувьд парламентат ёсыг бэхжүүлэх нь чухал зорилт билээ. Энэ зорилтын хэрэгжилт Улсын Их Хурлын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтаас шууд хамааралтай. Эвсэл цуцлагдсан тохиолдолд намын бүлэг байгуулж болохгүй байх нөхцөл байдал нь тухайн эвсэлд багтаж байсан 8-аас доошгүй суудалтай намыг дэмжиж, саналаа өгсөн сонгогчдыг төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох боломжгүй болгосон.

в/ Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлийг бүхэлд нь зөрчиж, уг хуулийн тодорхой зарим заалт хэрэгжих боломжгүй байдал бий болсон.

Дээрх нөхцөл байдал нь иргэний төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхийг хязгаарлаж, ингэснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн “... хүнийг ялгаварлан гадуурхахыг... хориглоно” гэсэн 10 дахь заалтыг мөн зөрчиж байгаа юм.

Ийм учраас сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох Үндсэн хуульд заасан иргэний /сонгогчийн/ эрхийг хангах үүднээс “Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох”-ыг хуульчилсан.

2/ Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт ийнхүү нэмэлт оруулахдаа “...намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно” гэсэн нь эвсэл цуцлагдсантай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, уг бүлэгт үйл ажиллагаа нь дуусгавар болсон эвслийн бүлэгт багтаж байсан

намуудаас сонгогдсон гишүүн, бие даан нэр дэвшсэн гишүүн нэгдэн орж болохгүй гэсэн агуулгатай. Нэгэнт намууд эвслээ цуцалсан тохиолдолд тухайн эвсэлд багтаж байсан зөвхөн 8-аас доошгүй суудалтай намд бүлэг байгуулж болох эрхийг олгож байгаа тул ийм зохицуулалт хийхээс өөр аргагүй юм. Ийм хязгаарлалт хийхгүй бол “эвсэл”-ийн дайтай бүлэг байгуулагдах нөхцөл боломж бий болно гэсэн үг юм.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

1/ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй” тул иргэдийн өргөдөлд дурдсан ийм асуудлуудад тайлбар өгөх шаардлагагүй юм. Дашрамд дурдахад хууль хоорондоо зөрчигдсэн гэх үндэслэл байхгүй гэж үзэж байгаа.

2/ Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын дэд даргыг сонгосонтой холбогдсон болохоос бүлэг бий болгохтой холбогдолгүй юм. Сонгуулийн үр дүнд Улсын Их Хурлын бүрэн эрх эхлэхэд зохион байгуулагдсан бүлэг, Улсын Их Хурлын бүрэн эрхийн явцад бий болж болох бүлгүүдийн ялгааг салгаж ойлгох шаардлагатай.

Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу Улсын Их Хурлын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлээрээ зохицуулан хэрэгжүүлдэг юм. Үүний дагуу Улсын Их Хурал дахь нам /эвслийн/ бүлгийн талаар хуулийн зохицуулалт хийгдсэн, хийгдэж байна, мөн хийгдэх шаардлагууд бий. Эхлэл нь энэхүү хуулийн нэмэлт болж байна. Цаашид нөхөн сонгуулиар суудлын тоо 8 хүрч бүлэг байгуулах, сонгуулийн дараа эвсэл байгуулж нэгдсэн бүлэг байгуулах тухай гэх мэт. Тухайлбал, Эх орон-Ардчилал эвсэл тарсны дараа эвслийн Засгийн газраа байгуулан улс төрийн хүчнүүд нэгдсэн эвслийн бүлэг байгуулж болохгүй байсан тул нэгнийхээ бүлэгт бусад нь нэгдэж ажиллаж байсан нь ийм зохицуулалтыг шаардаж байгаа юм.

3/ Үндсэн хуулийг зөрчсөн гэх бусад гомдлууд нь Улсын Их Хурлын тухай хуульд оруулсан нэмэлтийн тухай хуулийн заалтууд биш, суурь хуулийн заалтуудад холбогдох тул үүсгэсэн маргаанд хамааралгүй болно.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлаас 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Улсын Их Хурлын тухайн сонгуулийн үр дүнд бий болсон, нам, эвслийн бүлэг” гэсэн үзэл чиглэлийг Үндсэн хуульд тусгаж өгсөн байна. Энэ үүднээс авч үзвэл Улсын Их Хурлын тухай хуульд тухайн сонгуулийн дүнг үл харгалзан намын бүлэг байгуулж болохоор оруулж буй нэмэлт нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг бүрэн агуулж байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ардчилсан ёс, шударга ёс, ...тэгш байдал, ...-ийг хангах, хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “... Аль нэг нам...-ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн “Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд дангаараа 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох бөгөөд намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг байгуулж болох тухай заалтыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 10, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2005 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын намрын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/07 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 59 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас 2005 оны 8 дугаар сарын 4-ний өдөр баталсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн “Эвслийн бүлгийн үйл ажиллагаа хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд эвсэлд нэгдэн орж байсан нам Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд дангаараа 8-аас доошгүй суудал авсан бол бүлэг байгуулж болох бөгөөд намын бүлэгт зөвхөн тухайн намаас нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн орно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд нам, эвслийн бүлэг байгуулж болох тухай заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 2/07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг “тухайн сонгуулийн үр дүнгээр байгуулагдана” гэсэн үзэл баримтлалыг оруулсан байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн үр дүнгээс шалтгаалж парламентад бүлэг байх эсэх нь тодорхойлогдох ёстой гэсэн Үндсэн хуулийн санааг Цэц шийдвэрээрээ баталсан хэрэг. Үнэндээ тухайн үеийн парламент үүссэн улс төрийн нөхцөл байдалдаа “тохируулан” хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

Цэц эрх зүйн шийдвэр гаргадаг, гэвч зарим тохиолдолд шийдвэрлэж байгаа хуулийн зохицуулалтаас шалтгаалан Цэцийн шийдвэр улс төрийн үр дагаврыг зарим тохиолдолд зайлшгүй бий болгодог. Энэ ч утгаараа өөрт таалагдаагүй Цэцийн шийдвэрийг улс төржүүлэх сонирхол улс төрчдөд байдаг нь нууц биш.

Улсын Их Хурал уг нэмэлт, өөрчлөлтөө зөвхөн энэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд үйлчилнэ гэж зааснаараа хуулийг хэрхэн хэрэглэхийг хуулиар тайлбарласан “үзэгдэл” болсон. Угтаа шүүхэд олгогдсон эрхийг булаан авч хэрэглэсэн үйлдэл гаргасан.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005.11.16 № 2/08

**Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Я.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М., З.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль<sup>73</sup>

- 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн Улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ”
- 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана”

### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Я.-гийн мэдээллийн агуулга:

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн болон барьцааны гэрээ байгуулсан зээлдэгч зээлийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэсэн заалттай харшилж байгаа юм.

73 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2005 оны №31-д нийтлэгдсэн

Учир нь Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2 дахь хэсэгт зааснаар “Шүүх энэ хуулийн 27.1-т зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гээд 27.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ” гэснээр зээлийн барьцаанд тавьсан үл хөдлөх эд хөрөнгийг зээлдүүлэгч шууд өмчлөлд авах үндэслэл болсон гэрээний эрх зүйгээс үүдэлтэй маргааны талаар гомдол гаргах боломжгүй, зөвхөн эрхийн улсын бүртгэлийн алба бүртгэлийг шилжүүлэн хийх үйл ажиллагааны талаар л гомдол гаргах хязгаарлалттай болсон байна.

Гэтэл гэрээний талууд анх гэрээ байгуулахдаа хүсэл зоригоо харилцан зөв ойлголцож, үйлдлийнхээ хууль зүйн үр дагаврыг бүрнээ ухамсарласан эсэх, ийнхүү ухамсарлах эрх зүйн чадамжтай байсан эсэх, гэрээний нэг тал өөрт ашигтай, нөгөө талдаа хэт шударга бус нөхцөл тулган хүлээлгэсэн эсэх, ерөөс гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцсэн эсэх, стандарт нөхцөл хүчин төгөлдөр болсон эсэхийг гагцхүү шүүхийн байгууллага хянаж тогтоох эрхтэй. Энэхүү хяналтыг дээрх шинэ хуулиар хасах нь Үндсэн хуульд нийцэхгүй. Шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй гэсэн зарчмыг ном сурах бичигт томъёолохдоо “Хүн бүр өөрт нь тулгасан иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, үүргийг нь тодорхойлоход хуулийн дагуу байгуулсан эрх мэдэл бүхий, бусдын нөлөөнд автагдаагүй, гагцхүү хуульд захирагдах шүүхээр хэргээ нээлттэй, шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй” гэсэн байдаг.

Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын байгуулж буй зээлийн гэрээнүүд гэрээний нэг тал санал болгодог, стандарт нөхцөл агуулдаг. Тэдгээрт зээлийн байгууллагууд өөрсдийн эрх ашгийн үүднээс барьцааны хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай заалт оруулж өгөх нь дамжиггүй. Хууль хэрэгжиж эхэлсэн 2005 оны 9-р сарын 1-нээс эхлэн гэрээг ийнхүү байгуулж эхэлсэн. Гэтэл гэрээнд тавих шүүхийн хяналтыг хассанаар юуны өмнө зээлдэгч иргэдийн эрх ашиг хохироход хүрч байна. Арилжааны банкууд томоохон хуулийн этгээдүүдтэй хийх хэлцэлд ийм заалт оруулж, улмаар шүүхийн хяналтаас гаргах боломжтой. Учир нь гэрээний талууд аль аль нь зах зээл дээр мэргэжлийн шинжтэйгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө хуулийн этгээдүүд, бизнесийн үйлдлийнхээ учир холбогдол, эрх зүйн үр дагаврыг сайтар мэдэж байх ёстой гэж тэднээс шаардах бололцоотой, нөгөө талаас мэргэжлийн хуульчдыг ч ажиллуулдаг. Харин хувиараа эрхлэх гэр бүлийн аж ахуй, тэр тусмаа иргэн хүний хувьд ийнхүү шүүхийн хяналтаас гаргахыг эрх зүйт төрд хүлээн зөвшөөрдөггүй.

Иргэний хууль нь эрх зүйн этгээдүүдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах гол хууль бөгөөд иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэдэг. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах зарчмын агуулга нь:

1/ Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид нь эрх, үүргээ хэрэгжүүлэх адил боломжоор хангагдсан байх, өөрөөр хэлбэл, субъект нь хэн байхаас үл шалтгаалан тухайн харилцаанаас бий болох эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Эрх зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага нь адил тэгш байдаг.

2/ Харилцаанд оролцогч эрх бүхий этгээдийн шаардах эрх нь үүрэг бүхий этгээдийн үүрэгтэй “эквивалент” шинжтэй, өөрөөр хэлбэл, аль нэг тал нь нөгөөгийнхөө эрх, ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эсхүл нэг тал нь хэт давуу эрхтэй байж болохгүй.



Иргэний хуулийн 2.1-д зааснаар Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Иргэний хууль тогтоомжийн системд иргэний эрх зүйн зарим төрлийн харилцааг дагнан зохицуулдаг олон хуулиуд багтдаг. Гэвч Иргэний хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр талуудын тэгш эрхийн үндсэн дээр үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болж буй эдийн болон эдийн бус баялагтай холбоотой бүхий л харилцааг зохицуулна. Энэ утгаараа Иргэний хууль нь иргэний эрх зүйн үндсэн эх сурвалж болдог тул тусгай хуулиуд Иргэний хуулийн суурь зарчмыг зөрчөөгүй байх ёстой байдаг.

Иргэний хуулийн 189.4-т “Тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ, эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааныхаа хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй” гэсэн байдаг. Арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагуудыг санхүү, зээлийн үйлчилгээгээр зах зээлд давамгайлж буй этгээдүүд гэж үзэх бүрэн үндэстэй. Мөн тэдний үйлчилгээг /хүү нь бусад санхүүгийн байгууллагаас арай бага байдаг тул/ иргэдийн зүгээс авахаас өөр аргагүй байдаг. Иймд банк, санхүүгийн байгууллагууд иргэдэд тэгш бус нөхцөл тулгахыг ийнхүү тусгай хууль гарган хүлээн зөвшөөрч болохгүй. Өнөөгийн нөхцөлд шүүхийн журмаар зээлийн барьцааны хөрөнгийг банкууд худалдан борлуулж, учирсан хохирлоо гаргуулж байгаа. Энэ нь тодорхой хугацаа шаарддаг ч шүүх гэрээг бүхэлд нь хянасны эцэст ихэнх тохиолдолд хохирлыг нь гаргуулан шийдвэрлэж байгаа. Энэ тодорхой хугацаанаас болж зээлийн хүү өндөр байгаа, бууруулах боломжгүй байгаа зэрэг нь асуудлын гол шалтгаан бус шалтаг юм. Зээлийг угаасаа барьцаа харж олгох ёсгүй, гагцхүү явуулах гэж буй үйл ажиллагааных нь эдийн засгийн ашиг, тооцоо судалгааг харж байж олгох ёстой.

Цаашилбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1-д зааснаар хэрэглэгч гэж бараа, ажил үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг, худалдагч гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчдэд бараагаа борлуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг хэлнэ. Зээлийн үйлчилгээгээ хэрэглэгчдэд худалдаж буй худалдагч гэж банк, санхүүгийн байгууллагыг үздэг. Иймээс гэрээний талууд аль аль нь худалдааны эрх зүйн субъект байх харилцаанд дээрх хуулийн зохицуулалт байж болох авч, энгийн хэрэглэгч буюу иргэнтэй байгуулсан гэрээний хувьд шүүхээр хамгаалуулах хэрэглэгчийн эрхийг хангаж өгөх ёстой. Шүүхээр хамгаалуулах хэрэглэгчийн эрх гэсэн 8 дугаар зүйлд “Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй”, Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг гэсэн 12 дугаар зүйлийн 12.9-д “Бараа, ажил үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрх ашгийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно” гэж заасан байдаг.

Түүнчлэн Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 4.1.1-д бараа бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлж байгаа бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг хэлэх ба 5.1-д “Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ” гэсэн байдаг. Давамгай байдалтай аж ахуйн нэгжид гэрээний зүйлд хамаарахгүй болон гэрээт талд ашиггүй нөхцөлийг гэрээнд тусгахыг тулган шаардахыг хориглодог. Хуулийн эдгээр заалт зөрчигдсөн эсэхийг шүүхийн хяналтаар л илрүүлнэ. Ийнхүү Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын үзэл санаа салбар хуулиудад мөн суусан байтал банк, банк бус санхүүгийн

байгууллагаас иргэдтэй байгуулсан гэрээ шүүхийн хяналтаас гадуур үлдэж, банк, банк бус санхүүгийн байгууллагууд давуу эрх эдлэх нь эрх зүйт төрийн үндсэн зарчим болох тэгш байх зарчмыг гажуудуулна. Өнөөдөр манай иргэдийн дийлэнх нь газар хувьчилж аваагүй байгаа, харин орон сууцны 98 хүртэл хувь нь хувьчлагдсан байгаа билээ. Тиймээс ч зээлийн барьцаанд тавьдаг гол зүйл нь орон сууц бөгөөд амьжиргааны наад захын зайлшгүй эх сурвалж болсон орон байраа барьцаанд тавих гэрээ байгуулсан үйл ажиллагааг шүүх хянахгүй байх нь Үндсэн хуульд нийцэх эсэхийг мэргэн оюундаа тунгаан болгооно уу.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М.-ийн тайлбарын агуулга:

1/ Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзэж үндэслэлээ тайлбарласан байна.

Тухайлбал, “Гэрээ байгуулсан хүсэл зориг, үйлдлийнхээ үр дагаврыг бүрэн ухамсарласан эсэх, гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцсэн эсэхийг гагцхүү шүүхийн байгууллага хянаж тогтоох эрхтэй. Энэхүү хяналтыг дээрх шинэ хуулиар хасах нь Үндсэн хуульд нийцэхгүй”. Түүнчлэн дээрх хуулийг баталснаас үүдэн энэ төрлийн хэлцэл “шүүхийн хяналтаас гарах боломжтой, ийнхүү шүүхийн хяналтаас гаргахыг эрх зүйт төрд хүлээн зөвшөөрдөггүй” гээд холбогдох хуулийн “заалт зөрчигдсөн эсэхийг шүүхийн хяналтаар л илрүүлнэ” гэжээ. Өөрөөр хэлбэл, талуудын хооронд маргаан гарсан эсэх, маргагч тал шүүхэд хандсан эсэхээс үл хамааран гэрээний аль нэг тал нь давамгайл байдалтайгаар иргэний эрх зүйн харилцаанд оролцож байвал шүүх тухайн хэлцэлтэй холбогдсон асуудлыг заавал хянаж үзэх ёстой, харин Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь энэ хяналтыг тавих боломжийг хаасан буюу хязгаарласан гэсэн үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзжээ.

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу шүүх нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд “шүүх эрх мэдэлд нэгдүгээрт, эрүү, иргэний төдийгүй, эрх зүйн бусад бүх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх; хоёрдугаарт, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор хөндлөнгийн хяналт тавьж хэрэгжүүлэх” чиг үүрэг хамаардаг. Харин шүүх гэрээний аль нэг тал нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандсанаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд хөндлөнгөөс, өөрийн үзэмжээр оролцдог байгууллага биш бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ хэлцлийг хуулийн дагуу байгуулсан, эсхүл эрх үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаар өөрийн үзэмжээр тухай бүр шалгадаг, хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага огтхон ч биш юм.

2/ Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэх бөгөөд гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу барьцаанд тавьсан үл хөдлөх хөрөнгийг шүүхийн оролцоогүйгээр худалдан борлуулахтай холбогдсон асуудлыг зохицуулсан процессын шинжтэй хууль юм. Хэрэв талуудын хооронд аливаа хэлбэрээр гэрээ, хэлцэл байгуулаагүй, тухайн гэрээ хэлцлийг хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй, энэ талаар ямарваа нэгэн нотолгоо, баримт байхгүй бол ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэхгүй. Дээр дурдсанчлан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах харилцаа нь талуудын сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээнд үндэслэн үүсэх бөгөөд энэ харилцаа үүсэхэд төр аливаа хэлбэрээр оролцохгүй. Өөрөөр хэлбэл, энэ харилцаа нь иргэний эрх зүйн субъектуудын хооронд үүсч буй гэрээний эрх зүйн харилцаа юм. Харин иргэн Я.-гийн гаргасан өргөдөлд дурдсанчлан Үндсэн хуулиар олгосон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх асуудал нь зөвхөн төр, иргэний хооронд үүсдэг онцлог харилцаанд тооцогддог байна.

Энэ талаар Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид “Хүний үндсэн эрх, эрх чөлөөний гол онцлог шинж нь жирийн хүмүүсийн хоорондын харилцаанд биш, төр нийгэмтэй харилцахад буюу нэг талд нь хүн, хүмүүсийн нэгдэл, нөгөө талд нь засаг төр гэсэн нарийн төвөгтэй харилцаанд хамаарч, илэрч хэрэгждэг, зөрчигддөг” хэмээн бичсэн байна. Түүнчлэн зээл болон барьцааны гэрээ, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон иргэний эрх зүйн харилцааны үед “зээлдэгч” ба “зээлдүүлэгч” хэмээх этгээдүүдийн “субъектив эрх”-ийн асуудал яригдах ба энэ нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө буюу “объектив эрх”-ээс тусдаа, өөр ойлголт юм. Энэ ч утгаараа Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуультай холбогдсон асуудал нь гэрээний эрх зүйн асуудал гэж үзэж байна.

З/ Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө нь хүний эдэлж болох зан үйлийн боломж юм. Үүнийг үнэт зүйлсийн дэс дарааллыг тогтоосон каталоги гэж үзэх нь ч бий. Үндсэн хуулийн эрх зүйн онолын үүднээс хүний эрх, эрх чөлөөг 2 үндсэн хэсэгт хамааруулан ойлгож ирсэн. Үүнд:

- төрсөн цагаас нь эхлэн хүн бүрт тэгш хамаарах, хагацаж үл болох эрх буюу жам ёсны эрх /natural right/;
- жам ёсны эрхийг хангах үүднээс Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид хуульчлан бататгасан /төрөөс тогтоосон/ хүний бусад эрх буюу позитив /үүсмэл/ эрх /positive right/

Жам ёсны эрхийг ямарваа нэгэн хязгааргүйгээр эдэлдэг бол позитив буюу үүсмэл эрхийн хувьд хуулиар тогтоосон зохих хязгаартай байх бөгөөд бусад хүний эдлэх эрх, эрх чөлөөтэй харилцан холбоотой, түүгээр нөхцөлдсөн байдаг. Түүнчлэн хүн позитив эрхээ хэрэгжүүлэхээс тодорхой нөхцөлд өөрийн үзэмжээр татгалзаж болдог ба үүнийгээ өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр илэрхийлдэг. Харин ийнхүү татгалзахад нь төрөөс аливаа хэлбэрээр нөлөөлөх ёсгүй байдаг юм байна. Жишээлбэл, хүн сонгох эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах боломжтой бөгөөд энэ нь сонгуулийн санал хураалтад оролцохгүй байх эс үйлдэхгүйгээр илэрхийлэгдэнэ. Энэ тохиолдолд төр тухайн хүнээс эрхээ хэрэгжүүлэхийг заавал тулгаж, шаардаж болохгүй. Харин жам ёсны эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах эсэх асуудал нь өнөөг хүртэл маргаантай хэвээр байна (тухайлбал, амьд явах эрхээсээ татгалзаж болох эсэх). Тэгвэл шүүхэд хандах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах нь нэгдүгээрт, шүүхэд гомдол гаргахгүй байх идэвхтэй хэлбэрээр; хоёрдугаарт, гэрээтэй холбогдсон асуудлын хувьд маргааныг шүүхийн бус журмаар /шүүхийн оролцоогүйгээр/, эсхүл үл маргах журмаар шийдвэрлэхээр харилцан тохиролцсон үйлдэл буюу идэвхтэй хэлбэрээр илэрч болно. Үүний нэг жишээ нь арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх замаар шүүхэд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах явдал гэж үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, мөн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “бүх шатны болон дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж тус тус заасан. Иймээс арбитраар маргааныг хянан шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” байхаар заасныг зөрчсөн гэж үзэх үү гэсэн асуудал үүсэх нь зайлшгүй. Гэвч арбитр нь талууд хэлэлцэн тохиролцсон тохиолдолд л маргааныг шийдвэрлэдэг бөгөөд энэ талаар Арбитрын тухай хуулийн 6.1-д “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т заасны дагуу талууд арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон маргаан арбитрын харьяалалд хамаарна” гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл талууд өөрийн “шүүхэд гомдол гаргах эрх”-ээ тухайн тохиолдолд хэрэгжүүлэхгүй байхаар тохиролцон, маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхээр

зөвшөөрч, энэ талаараа гэрээ хэлцэлдээ тусгасан тохиолдолд тэдгээрийн маргааныг арбитр шийдвэрлэдэг. Харин нэгэнт арбитраар маргаанаа шийдвэрлүүлсэн тохиолдолд талууд арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй байдаг.

4/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлд заасны дагуу “талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн тохиолдолд” холбогдох журмын дагуу шүүх шийдвэрийг баталгаажуулан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулдаг. Энэ нь талууд гэрээгээр харилцан тохиролцсон “шүүхэд гомдол гаргах эрх”-ээ хэрэгжүүлэхээс сайн дурын үндсэн дээр татгалзах боломжийг хуульчилсан заалт юм.

5/ Талууд үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа шүүхийн бус журмаар (шүүхийн оролцоогүйгээр) асуудлыг шийдвэрлэхээр анх гэрээ байгуулахдаа зөвшөөрч, харилцан тохиролцсон тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүснэ. Нэгэнт гэрээг талууд сайн дурын үндсэн дээр байгуулсан, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар (шүүхийн оролцоогүйгээр) худалдан борлуулахыг зөвшөөрч харилцан тохиролцсон бол уг ажиллагааны үед “шүүхэд хандах эрх”-ийг зөрчсөн эсэх асуудал яригдахгүй. Харин дээр дурдсан нөхцөл нь зөвхөн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан тодорхой үе шатанд хамаарах тул гэрээний аль нэг тал нь уг ажиллагаа үүсэхээс өмнө шүүхэд аливаа асуудлаар хандах эрхтэй. Түүнчлэн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар / шүүхийн оролцоогүйгээр/ худалдан борлуулахаар тохиролцсон ч зээлдүүлэгч, эрхийн улсын бүртгэлийн алба ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч тухайн асуудлаар шүүхэд хандах эрхтэй. Энэхүү эрх нь Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.1 дэх хэсгээр баталгаажсан болно. Мөн хуулийн 27.2 дахь хэсгийн заалт нь зөвхөн зээлдэгчид хамаарах тул зээлдэгч эрхийн чадамжгүй байсан, эсхүл хуульд заасан журмын дагуу зохих зөвшөөрөл аваагүй зэрэг үндэслэлээр өөрийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөгөө хамгаалуулахаар гуравдагч этгээд шүүхэд хандах эрх нь нээлттэй байна.

6/ Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг түргэн шуурхай, зардал багатайгаар худалдан борлуулах сонголт бүхий боломжийг бүрдүүлж байгаа. Нэгэнт гэрээний талуудад үүргийн гүйцэтгэлийг шүүхийн бус журмаар хангуулах нь ашигтай хэмээн үзэж байхад төрөөс тухайн асуудалд оролцон талуудад ашигтай бус хувилбарыг тулгах нь гэрээний эрх чөлөөнд ноцтойгоор халдаж буй хэрэг юм. Энэ нь гэрээний талуудын эрх ашгийг хөндөөд зогсохгүй, улс орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэн, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад хүргэдэг юм байна. Тухайлбал, Германд үл хөдлөх хөрөнгө, орон сууцтай холбогдсон эрх зүйн зохицуулалт нь нарийн төвөгтэй, төрийн байгууллагаас үл хөдлөх хөрөнгийн зах зээлд нөлөөлөх боломж өндөр байдгаас үүдэн тус улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь амьжиргааны түвшин, хүн амын орлогоор ижил төсөөтэй бусад улстай харьцуулахад харьцангуй доогуур байдаг юм байна. Гэрээний эрх чөлөө нь эрх зүйн утгаараа талуудад өөрсдөө сайн дураараа, хүсэл зоригоо илэрхийлэн хууль зүйн тодорхой үр дагавар бий болгох эрх чөлөөг олгож, гэрээгээр эдлэх эрх, хүлээх үүргээ иргэний эрх зүйн зохицуулалтын диспозитив аргаар тодорхойлох боломжийг хангахад чиглэсэн байдаг бол эдийн засгийн утгаараа талуудын хооронд баялгийг бүтээхэд чиглэсэн төрөл бүрийн харилцааг чөлөөтэй үүсгэх үндсэн суурь болж өгдгөөрөө чухал ач холбогдолтой ухагдахуун юм. Ийм ч учраас эдийн засгийг хөдөлгөгч үндсэн хөдөлгүүр болсон гэрээний эрх чөлөөний зарчмыг тууштай баримтлах нь зөв болов уу.

3. Иргэн Я.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

1/ Шүүхийн байгууллагыг өөрийн үзэмжээр иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хоорондын гэрээг хянадаг байгууллага гэж өргөдөлд огт дурдаагүй, ингэх

боломжгүй. Гагцхүү иргэний эрх зүйн харилцаанаас эрх нь зөрчигдсөн этгээдийн, эсвэл түүний хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжлэл, хүсэлтээр зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүрэгтэй байгууллага гэдгийг хуульч мэргэжил эзэмшсэн хүн бүр мэднэ.

2/ Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй” гэсэн заалтыг чухамхүү Улсын Их Хурлын баталсан дээрх хуулийн 27.1, 27.2 дахь хэсгийн заалтаар, тодруулбал “шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан нь хуулиараа зөрчиж байгаа юм. Улсын Их Хурал нь эрх мэдэл хуваах онолын дагуу хууль тогтоох засаглалын дээд байгууллага гэдэгтэй эрх биш маргахгүй байх.

3/ Талууд сайн дурын үндсэн дээр гэрээний харилцаанд ордог нь үнэн. Гэхдээ өнөөдөр Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны 17 банк, түүний дээр олон тооны банк бус санхүүгийн байгууллагууд нь хамтдаа зээлийн үйлчилгээний гуравны нэг буюу түүнээс дээш хувийг үзүүлдэг. Банкны зээлийн хүү хамгийн бага байдаг зүй тогтолтой. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн зах зээлд ноёрхох байдал хэмээх 5 дугаар зүйлийн 1-д зааснаар “Зах зээлд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын гуравны нэгээс дээш хувийг дагнан буюу бусад этгээдтэй хамтран хийж байвал давамгайлах байдалтай гэж үзнэ” гэсэн байна. Энд санхүүгийн байгууллага гэж зээлийн болон даатгалын байгууллага, түүнчлэн үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн зуучлагчийг, бараа бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлж байгаа бүр төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг хэлнэ. Зээлийн үйлчилгээ нь иргэн, хуулийн этгээдүүд хариу төлбөртэйгээр буюу хүү төлж авдаг үйлчилгээ юм. Товчоор банк, банк бус санхүүгийн байгууллагууд нь хамтдаа санхүүгийн зах зээл дээр давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд болно. Иргэний хуулийн 189.4-т зааснаар тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

4/ Арбитр талуудын хэлэлцсэн тохиролцсон тохиолдолд л маргааныг шийдвэрлэдэг нь үнэн. Гэхдээ арбитрын гаргаж буй шийдвэр чанарын хувьд шүүхийнхтэй адил байх ёстой, энэ ч шаардлагад арбитрын байгууллага нийцүүлэн ажилладаг. Гэрээний талууд тэгш эрхтэйгээр гэрээ байгуулах процесст оролцсон, өөрөөр хэлбэл эрхийн хувьд тэгш байдалтай байж чадсан тохиолдолд талууд маргаанаа шүүхээр бус арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцох бүрэн бололцоотой. Талуудын энэ хүсэл зоригийг хүндэтгэх үүднээс шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг билээ. Харин нэг талд нь давамгай байдалтай банк, банк бус санхүүгийн байгууллага, нөгөө талд нь жирийн хэрэглэгч буюу иргэн хүн гэрээ байгуулж буй банкны зээлийн харилцаанд банкны боловсруулсан зээлийн гэрээнд иргэн хүн өөрчлөх бололцоогүйгээр, зөвхөн гарын үсгээ зурах л үлддэг. Энэ гэрээнд банк өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс барьцааны үл хөдлөх хөрөнгийг худалдах шүүхийн бус аргыг сонгох нь дамжиггүй, ингэж ч байгаа. Тэгш байдал хараахан олгогдоогүй талууд гэрээ хийж буй нөхцөлд маргаж буй шинэ хуулийн дагуу зээлдэгч шүүхэд хүртэл хандах эрх нь хаалттай байх нь зүйд нийцэх үү?

5/ Гэрээний эрх чөлөөний зарчим нь иргэний эрх зүйн суурь зарчим гэдэгтэй маргахгүй. Гэхдээ энэ зарчимд ч гэсэн хэмжээ хязгаар байдаг. Гэрээний эрх чөлөөний зарчим 3 элементтэй.

а/ Гэрээ байгуулах эсэхээ шийдэх эрх чөлөө

б/ Гэрээг хэнтэй байгуулахаа харилцан өөрсдөө шийдэх эрх чөлөө

в/ Гэрээг агуулгын хувьд өөрсдөө чөлөөтэй тодорхойлох эрх чөлөө

Гэрээний эрх чөлөөний зарчмын хэмжээ хязгаар нь хууль, тэр дундаа Үндсэн хууль. Тэгш бус байдалтай этгээдүүд гэрээ байгуулчихаад, тухайн гэрээгээр шүүхийн бус аргыг нэг тал нь нөгөөдөө “тулгаж” сонгоод, энэ үйл ажиллагаанд үйлчилдэг хуулиар /бүр хуулиар шүү/ шүүхэд хандах эрхийг нь хасаж байгаатай хуульч хүн хувьд санал нийлэх үү?

6/ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба нь Засгийн газрын нэг л агентлаг болохоос өмчлөх эрхийг зээлийн барьцааны гэрээг үндэслэн дуусгавар болгодог, өмчлөх эрхэд халддаг байгууллага биш. Эндээс барьцааны гэрээг л бүртгэх ёстой. Зөв буруу, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх үндэслэл, талууд эрх, үүргээ хэрхэн биелүүлсэн, эрх сэргээх арга зэргийг тогтоох эрхийг Үндсэн хуулиар гагцхүү шүүхийн байгууллагад олгосон байдаг юм. Иргэн хүний ийнхүү шүүхээр эрхээ сэргээлгэх эрхийг Улсын Их Хурал хууль гаргаж хаах ёсгүй.

4. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн төсөлд Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад ирүүлсэн саналд:

1/ Монгол Улсын Иргэний хуулийн ипотека буюу үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зохицуулалт нь (танилцуулгад дурдсанаар) орон сууцны зээлд ямар нэгэн байдлаар садаа болох учиргүй юм.

2/ Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг зайлшгүй боловсруулан гаргах ямар шаардлага бий болсон нь ойлгомжгүй байна. Танилцуулгад дурдсанаар хүчин төгөлдөр үйлчилж буй Иргэний хуулийн ипотека холбогдсон зүйл заалт өөр хоорондоо зөрчилтэй, зарим асуудал нь тодорхой бус байгаа бол энэхүү хуулийг боловсронгуй болгох асуудал тавигдахаас биш энэ хуулийн үндсэн санаанаас гадуур, өөр үзэл баримтлал бүхий хууль гаргах шаардлагагүй гэж үзэж байна.

Нөгөө талаар Иргэний хуулийн ипотека холбоотой зүйл, заалтууд нь хоорондоо зөрчилтэй байдал шүүхээс уг хуулийг хэрэгжүүлэх явцад ажиглагдаагүй байгаа юм. Харин ипотека холбоотой ажиллагаа, тухайлбал, худалдан борлуулах ажиллагаа боловсронгуй биш, хугацаа их шаардагддаг гэх мэт шалтгааныг энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллагын ажлыг сайжруулсанаар арилгаж болох талтай. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зорилт нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүрэгтэй холбогдуулан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж төсөлд заажээ. Гэтэл зээлийн гэрээний харилцааг Иргэний хууль зохицуулдаг ба энэхүү харилцааг өөр ямар ч хууль зохицуулахгүй нь хэнд ч ойлгомжтой зүйл юм.

3/ Иргэний эрх зүйн харилцааны үндсэн зарчмуудын нэг нь тухайн харилцааны тэгш эрхийн зарчим байдаг бөгөөд зээлийн гэрээний харилцаанд буюу өмчлөх эрх шилжих гэрээнд ялангуяа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих тохиолдолд гэрээний аль нэг оролцогчид бусдаас илүү, давуу эрх олгох нь иргэний эрх зүйн дээрх зарчмыг зөрчихөд хүргэнэ.

4/ Үүний зэрэгцээ хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх Үндсэн хуулийн зарчим ч ноцтойгоор хөндөгдөж болзошгүй юм. Яг ижил гэрээний харилцаанд оролцож буй өөр өөр этгээдийн эрх, үүрэг өөр өөр байх нь энэ зарчимд нийцэхгүй гэж бид үзэж байна. Зээлийн гэрээний харилцааг Иргэний хууль зохицуулсаар байхад энэ гэрээний үндсэн шинж буюу гэрээний хугацаа, үүргээ биелүүлээгүйгээс шаардлага тавих эрх зэргийг хуулийн төсөлд (4.1., 5.1.) тусгасан нь ойлгомжгүй байгаагаас гадна хууль тогтоомжийн шатлан захирах ёсыг зөрчиж Иргэний хуульд заагдаагүй зүйл тусгагдсан байна.

5/ Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зорилтоос үзэхэд улсын бүртгэлийн алба нь өмчлөх эрхийн улсын бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хийх эрх бүхий байгууллага байна. Гэтэл Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай хуулийн төсөлд улсын бүртгэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх шийдвэр гаргах эрх бүхий этгээд болж хувирч байна.

6/ Манай улсад үл хөдлөх эд хөрөнгийн ойлголт жинхэнэ утгаараа дөнгөж бий болж байгаа өнөө үед үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой аливаа харилцааг хөнгөн гоомой, Иргэний хуулийн зохицуулалтаас гадуур, иргэний эрх зүйн харилцааны оролцогч аль нэг субъектын эрх ашгийг илүүд үзэж шийдвэрлэх нь төдийлөн зохимжгүй байгаагаас гадна ер нь хууль тогтоомжийн шатлан захирах ёс, иргэний эрх зүйн шинжлэх ухаанд харш юм.

7/ Монгол Улсын иргэний өмчлөх эрхийг хөндөх асуудлыг зөвхөн шүүх шийдвэрлэж байх нь Үндсэн хуульд нийцэх тул энэхүү хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн саналтай байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ”, 27.2 дахь хэсэгт “Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй гэж заасан нь иргэдийн хувийн халдашгүй эрхийг шударга шүүхээр хамгаалуулах үндсэн баталгаа юм. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт “Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан нь зээлдэгчийн шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хууль гарган шууд хязгаарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Харин Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн Улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан Улсын Их Хурлын чуулганаар хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

5. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр тогтоосугай.

**"Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/08 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 75 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Шүүх 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй" гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн жишээ болгон дурдсан ХБНГУ, АНУ, Швейцарь зэрэг оронд хөгжилтэй орнуудад хүний эдийн засгийн нөхцөлийг бодитоор хангаж өгсөн учраас хүн бүр өөрийн зөрчигдсөн эрхийг шүүхээр хамгаалуулах шаардлагагүй байдаг юм байна. Гэтэл манай улсын хувьд өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалах эдийн засгийн суурь бүрдээгүй байгаа үед, ялангуяа хүний жам ёсны эрхийг ямар нэг байдлаар хязгаарлаж болохгүй. Өмчлөх, үл хөдлөх эд хөрөнгөтэй байх нь хүний суурь эрхийн нэг юм.

Иргэдийн шүүхэд хандах эрх хуулиар нээлттэй байх нь нэг талдаа шүүх шардга шийдвэр гаргах нөхцөлийг бий болгох, нөгөө талаас зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах иргэний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь эдлүүлэх боломжийг хангах эерэг талтай. Эрх зүйн харилцаанд оролцогчдыг ямарваа хэлбэрээр ялгаварлах, гэрээний чөлөөт байдлыг алдагдуулах, хүн бүр шүүхээр хамгаалуулах эрхийг хязгаарлах зохицуулалт хийх нь эцэстээ Үндсэн хуулийн зөрчлийг бий болгоно.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2006.01.11 № 1/01

### **Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Я.;

Улсын Их Хурал - итгэмжлэгдсэн төлөөлөгчгүй хуралдаан явуулж өгөх хүсэлтийг Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М., З. Нар гаргасан байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т “Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан нь зээлдэгчийн шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх тухай Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь шууд хязгаарласан гэх үндэслэлтэй байна.

2. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.1-д “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол шүүхэд гомдол гаргаж болох”-оор хуульчилсан атлаа уг хуулийн 27.2-т зээлдэгчийн шүүхэд гомдол гаргах эрхийг зөвхөн дээрх үндэслэлээр хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх, ...эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

3. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ Улсын Их Хурлын 2005 оны 75 дугаар тогтоолд заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.2-т “Шүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/08 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

## **Тэмдэглэл:**

1. Ипотекийн зүйлтэй холбоотой маргааныг шүүхээс гадуур шийдвэрлэж байхаар зохицуулсан нь Үндсэн хуулийн зөрчил байсан юм. Үнэндээ Цэцийн дүгнэлтээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тэрхүү заалт нь тус хуулийн “амин” заалт байсан. Өөрөөр хэлбэл, энэхүү заалтыг Цэцийн тогтоолоор хүчингүй болгосон тохиолдолд Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах тухай хуулийг цаашид хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэх асуудал хөндөгдөх нь дамжиггүй. Ер нь энэ хуулийг гаргах болсон үндэслэл нь гадаадын хөнгөлөлттэй зээлээр иргэдийг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас урт хугацааны хөнгөлөлттэй зээл аваад түүнийгээ арилжааны банкуудаар дамжуулж иргэдэд олгох явдал байсан. Өнгөц дүгнэхэд иргэдийг орон сууцаар хангах төрийн бодлогыг Цэц тогтоолоороо “гацаасан” мэт. Гэвч шүүхэд хандах иргэний эрхийг шүүхийн журмаар баталгаажуулсан Цэцийн тогтоолыг тухайн үед янз бүрийн шалтгаанаар “улс төржүүлэх” байдал үүсч байсан ч цаг хугацааны явцад Цэцийн шийдвэр үндэслэлтэй байсныг иргэд, тэр ч бүү хэл улс төрчид ойлгосон билээ.

2. Дээр дурдсанчлан Улсын Их Хурлаас 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийг 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2005.12.07 № 2/09**

**Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэлгаргагч - Монгол Улсын иргэн М.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай 29 дүгээр тогтоол<sup>74</sup>

- Тогтоолын хавсралтын “б” хэсгийн 16-д “Далай буян”, 17-д “Их өртөө” компанийн нийт хувьцааны тус тус 30 хувийн ногдол хувь, хувьцаа”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”

<sup>74</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 оны № 29-д нийтлэгдсэн

## Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

### 1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар тогтоолоор Үйлдвэрийн барилга трест /одоогийн “Хаш-Орд” ХК/-ийг хувьцаат болон бүрэн бус хариуцлагатай найман компани болгон зохион байгуулж “Их-Өртөө”, “Өргөө”, “Зэв” зэрэг компаниудын дүрмийн сангийн 30 хувь болох нийт 81554 ширхэг хувьцааг “Хаш-Орд” ХК эзэмшиж байхаар тус тус тогтоосон байна. Дээрх тогтоол болон Өмч хувьчлалын комиссын 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 39 дүгээр тогтоолын дагуу “Их-Өртөө”, “Өргөө” компаниудын нийт хувьцааны 30 хувь болох “Хаш-Орд” ХК-ийн эзэмшиж байгаа 81554 ширхэг хувьцаа нийтэд “Хаш-Орд” ХК-ийн нэр дээр арилжаалагдсан байна. “Их-Өртөө”, “Өргөө” компаниудын дүрмийн сангийн 30 хувь болох “Хаш-Орд” ХК-ийн эзэмшиж байгаа хувьцааны 49 хувь буюу 39961 ширхэг хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр баталгаажуулж хувьцаа эзэмшигчид авсан байдаг тул хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөж байгаа юм.

Иймд “Их-Өртөө” ХК, “Өргөө” /Далай буян/ ХХК-ийн тус тус 30 хувийг 1999 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолын холбогдох хавсралтаас хасаж, БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 33 дугаар тогтоол, 39 дүгээр тогтоолуудыг хүчинтэй болох, мөн Улаанбаатар хотноо барилгын үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг “Хаш Орд” ХК-ийн эзэмшиж буй хувийг 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчлөлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэр нь өмч хоёр эзэнтэй болгоход хүргэсэн байна гэж үзэж байгаа тул Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор үнийг төлнө” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул хянан шийдвэрдэх өгнө үү.

### 2. Иргэн М.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

Үнэт цаасны хоёрдахь зах зээл эхлэх үеэс хөрөнгийн биржээс “Их-Өртөө”, “Хаш-Орд” ХК-ийн хувьцааг худалдан авснаар “Их-Өртөө” ХК-ийн 34 хувь, “Хаш-Орд” ХК-ийн 20 гаруй хувийг гэр бүлийн хамт эзэмшсэн. Биднийг хувьцаа авахад “Хаш-Орд” ХК нь “Их-Өртөө” ХК, “Далай буян” буюу /Өргөө/ ХК-ийн 30, 30 хувийг Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12 дугаар сарын 14-ний 33 дугаар тогтоол, мөн Өмч хувьчлалын комиссын 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор толгойлох компанийн хэлбэрээр “Хаш-Орд” ХК эзэмшинэ гэснийг судалсны үндсэн дээр хувьцааг давхар эзэмшсэн нь зөв юм гэж шийдэн хувьцааг төвлөрүүлэн эзэмшсэн юм.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 29 дүгээр тогтоол гарснаар толгойлох “Хаш-Орд” хувьцаат компани болон нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдсэн. Улсын Их Хурлын дээрх тогтоол гарснаас хойш өдийг хүртэл Нийслэлийн өмчийн газраас өмчийн төлөөлөл хэрэгжүүлэхээр удаа дараа маргалдсан бөгөөд тухайн үед Төрийн өмчийн хорооны дарга З. 1999 оны 10 дугаар сард “Хаш-Орд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хүсэлтээр Нийслэлийн өмчийн газарт албан бичиг явуулсан юм. Уг албан бичигт “Өргөө”, “Их-Өртөө” компаниудын нийт хувьцааны 30, 30 хувь буюу 63515 ширхэг хувьцаа “Хаш-Орд” ХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлж, энэхүү нэмэгдсэн хувьцааны 49 хувь нь холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу “Хаш-Орд” хувьцаат компанийн нэр дээр арилжаалагдсан гэж ойлгох нь зүйтэй. Улсын Их Хурлын 29 дүгээр тогтоолын дагуу “Их Өртөө”, “Өргөө” компанийн нийт хувьцааны 30 хувийг Нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай асуудлыг Төрийн өмчийн хороо авч хэлэлцээд дээрх үндэслэлээр

маргаантай гэж үзэж байгаа болно. Цаашид дээрх асуудлын талаар тайлбар үндэслэл гаргасны үндсэн дээр Улсын Их Хуралд танилцуулж холбогдох шийдвэр гаргах болно. Иймд дээрх хоёр компанийн 30, 30 хувийн хувьцааны төлөөллийг “Хаш-Орд” компани хэрэгжүүлж байгааг анхааралдаа авахыг хүсье.

### 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт батлах тухай Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар “Далай буян”, “Их-Өртөө” гэсэн хуулийн этгээдийн төрд ногдох 30 хувийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн юм. Засгийн газрын 1991 оны 33 дугаар тогтоолоор “Их-Өртөө” /хуучин нэрээр Өртөө/, “Далай буян” /хуучин нэрээр “Өргөө”/ “Зэв” компанийн гаргасан хувьцааны 30 хувийг “Хаш-Орд” ХК-нд /хуучин нэрээр Үйл бар/ эзэмшүүлэхээр шийдвэрлэж, улмаар Засгийн газрын 1993 оны 39 дүгээр тогтоолоор дээрх 3 компанийн 30 хувийн оролцоо буюу 8155.4 мянган төгрөгөөр “Хаш-Орд” компанийн дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлж энэхүү нэмэгдсэн хөрөнгийн 49 хувийг нийтэд арилжаалахаар шийдвэрлэжээ.

Дээрх шийдвэрийн дагуу 30 хувийн оролцооны 49 хувь нь нийтэд арилжаалагдаж хувийн өмчид шилжсэний хамт, “Хаш-Орд” ХК-ийн хувьцааны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулан бүртгэжээ. Засгийн газраас Улсын Их Хурлын тогтоолын төслийн холбогдох заалтад дээрх өөрчлөлтийг тусгалгүйгээр өргөн мэдүүлж, улмаар энэ хэвээр төслийн заалтыг Улсын Их Хурлаас батлан гаргасан нь иргэн М.-ээс өмчлөх эрх зөрчигдсөн гэж үзэж гомдол гаргах үндэслэл болсон гэж үзэж байна. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолын хавсралтад “Далай буян”, “Их-Өртөө” компанийн төрд ногдох 30 хувийг нийслэлийн өмчлөлд шилжүүлсэн байдал нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн гэсэн иргэн М.-ийн өргөдлийг хүлээн авах үндэслэлтэй байна.

### Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан “Төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах” бүрэн эрхийнхээ хүрээнд 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдөр “Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” 29 дүгээр тогтоол гаргасан хэдий ч уг тогтоолын хавсралтад буй шилжүүлэх ногдол хувь, хувьцаа гэсэн “Б” хэсгийн 16-д “Далай буян”, 17-д “Их-Өртөө” компанийн нийт хувьцааны тус тус 30 хувийн ногдол хувь, хувьцааг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхдээ компанийн дүрмийн сангийн хэмжээг нарийвчлан тогтоогоогүй нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн төдийгүй Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэн заалтыг зөрчсөн болох нь дараах байдлаар тогтоогдож байна.

1. БНМАУ-ын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Үйлдвэрийн барилга трестийг хувьчлах тухай 33 дугаар тогтоолд “Өртөө” ХК /одоогийн “Их-Өртөө”/, “Өргөө” ББХК /одоогийн нэрээр “Далай буян”-ийг/ хувьчилсан байдал, 1992 оны 8 дугаар сарын Монголын хөрөнгийн биржийн Клирингийн албанд “Өртөө” /Их өртөө ХК/ компанийн үнэт цаасыг хадгалуулсан зөвшөөрөл /дугаар 104/, мөн 1997 онд Засгийн газрын 160 дугаар тогтоолоор Хувьчлах үйлдвэр, аж ахуйн жагсаалтыг батлахдаа дээрх 2 хувьцаат компанийг төрийн өмчийн оролцоотой компанийн тоонд оруулсан нь алдаатай шийдвэр болсныг Төрийн өмчийн хороо 1998 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 225 дугаар тогтоолоор залруулсан зэргээс дүгнэхэд “Их өртөө”, “Далай буян” ХК-ийн нийт хувьцаанд төрийн мэдлийн хувьцаа байхгүй, эдгээр компаниуд нь төрийн оролцоогүй хувьцаат компани болох нь нотлогдож байна.

2. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолын хавсартад буй “Их-Өртөө”, “Далай буян” компанийн нийт хувьцааны 30 хувийг Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 33, 1993 оны 39 дүгээр тогтоолын дагуу “Хаш-Орд” ХК-д эзэмшүүлж, мөн тэр хэмжээгээр нь тус компанийн дүрмийн санг нэмэгдүүлэн энэхүү нэмэгдсэн хөрөнгийн 49 хувийг “Хаш-Орд” компанийн нийт гаргасан хувьцаан дээр нэмж нийтэд арилжаалах, харин үлдэх 51 хувь нь уг компанийн төрийн мэдлийн хувийг нэмэгдүүлсэн болох нь Төрийн өмчийн хорооны 1998 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 225, мөн хорооноос Монголын хөрөнгийн биржид явуулсан 1998 оны 2/537 дугаар албан бичиг, Үнэт цаасны хорооны 1998 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 49 дүгээр тогтоолд тодорхой тусгагджээ. Тухайлбал, “Хаш-Орд” ХК-ийн гаргасан нийт хувьцаа, үүнээс төрийн мэдэлд байгаа хувьцааны бүрдүүлбэрээс үзэхэд төрийн мэдлийн хувьцаа нь “Их-Өртөө”, “Далай буян” ХК-д бус харин холдинг компани болох “Хаш-Орд” ХК-д байдаг болох нь тодорхой байна.

3. “Хаш-Орд” ХК-д дээрх 2 компаниас нэмэгдсэн хөрөнгө нь төрийн мэдлийнх байсан бол түүнд ногдох хувьцаа нь толгой компанийн нэрээр хөрөнгийн биржээр арилжаалагдах ёсгүй болно. Нэгэнт нэмэгдсэн хөрөнгө нь тус компанийн дүрмийн санг бүрдүүлж, улмаар нийт хувьцааны 49 хувь нь арилжаалагдсан болох нь Хөрөнгийн биржийн арилжааны тухай мэдээнд тусгагдсан зэргээс үзэхэд иргэдийн хувийн өмчлөлд шилжсэн хөрөнгийг төрийн мэдлийн гэж тооцож, түүнийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

4. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчин иргэдийн өмчлөх эрхэд халдаж, олон жилийн турш иргэдэд эд хөрөнгийн хохирол учруулсаар ирснийг Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн албан бичиг болон шинжээчдийн дүгнэлт, гэрч нарын тодорхойлолт нотолж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн ДҮГНЭЛТ гаргах нь:

1. Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” 29 дүгээр тогтоолын хавсартад буй шилжүүлэх ногдол хувь, хувьцаа гэсэн “Б” хэсгийн 16-д “Далай буян”, 17-д “Их-Өртөө” компанийн нийт хувьцааны тус тус 30 хувийн ногдол хувь, хувьцааг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхээр тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолын холбогдох заалтын үйлчлэлийг 2005 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэн, зохих хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/09 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 83 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.5-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолын хавсралтын “Шилжүүлэх ногдол хувь, хувьцаа” гэсэн “Б” хэсгийн 16-д “Далай буян”, 17-д “Их-Өртөө” компанийн нийт хувьцааны тус тус 30 хувийн ногдол хувь, хувьцааг нийслэлийн өмчлөлд шилжүүлэхээр тогтоосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 2/09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Үндсэн хуульд заасан иргэний өмчлөх эрхийг Улсын Их Хурал тогтоол гарган 6 жил гаруйн хугацаанд зөрчиж ирснийг Цэц тогтоож, Үндсэн хуулийн нэрийн өмнөөс өмчлөх эрхийг нь сэргээсэн шийдвэр болсон. Дунд шатны байгууллагууд нь алдаатай төсөл оруулж ирсэнийг Улсын Их Хурал нягтлалгүйгээр баталснаас улбаалан иргэн хүний өмчлөх эрхэд халдсан. Хэдийгээр Улсын Их Хурал Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргах эрхтэй боловч тухайн шийдвэрийг гаргахдаа 1997 оны тооллогын дүнг үндэслэсэн нь алдаа болжээ.

Учир нь “Их-Өртөө”, “Өргөө” компаниудын төрийн мэдлийн 30, 30 хувь нь Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 39 дүгээр тогтоолын дагуу “Хаш-Орд” ХХК-ийн дүрмийн санд шилжсэн бөгөөд “Хаш-Орд” ХХК нь 1998 онд Төрийн өмчийн хорооны 747 дугаар тогтоолын дагуу битүүмжлэгдсэн дуудлага худалдаагаар худалдагдсан тул Улсын Их Хурлын тогтоол нь үндэслэлгүйгээр хувийн өмчид халдсан хууль бус хэм хэмжээ болсон юм. Эцсийн дүндээ Улсын Их Хурлын нэрийн өмнөөс тогтоол гаргасан тул хариуцлагыг Улсын Их Хурал хүлээх ёстой. Өргөдөл гаргагч өнгөрсөн хугацаанд хууль ёсны өмчлөх эрхээ хэрэгжүүлж чадаагүйгээс хэдий хэмжээний хохирол хүлээсэн болохоо шүүхээр тогтоолгож, Улсын Их Хурлаар хохирлоо төлүүлэх боломжтой.

Харин Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Цэцэд ирүүлсэн тайлбартаа Улсын Их Хурлын тогтоол Үндсэн хууль зөрчсөн болохыг хүлээн зөвшөөрсөнийг талархууштай. Үндсэн хуульд онцгойлон анхаарсан нэг асуудал нь хүний эрх, эрх чөлөөний асуудал. Цэц үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд хүний зөрчигдсөн эрхийг Үндсэн хуулийн өмнөөс хамгаалах, сэргээх явдал билээ. Цэцийн шийдвэрийг шинжлэн үзэхэд тэдгээрийн 30 орчим хувь нь хүний эрхтэй шууд ба шууд бусаар холбогдсон маргааныг шийдвэрлэсэн байдаг. Энэ дүгнэлтийн Цэцийн бусад шийдвэрүүдээс ялгагдах онцлог нь үйлчлэлийн төдийгүй хууль зүйн үр дагаврын хувьд нийтлэг бус шинжтэй буюу тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн зөрчигдсөн эрхийг хамгаалсанд оршино.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.01.25 № 2/01

### Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Ү.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>75</sup>

- 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “...Ерөнхий сайд...”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”
- Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно”

#### 1. Иргэн Б., Ү. нарын мэдээллийн агуулга:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-ын “.../Ерөнхий сайд/..” гэсэн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актыг Захиргааны хэргийн шүүх магадлан хянаад, тус хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэсэн 38 дугаар зүйлийн 1, “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчиж байгаа үндэслэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Үндсэн хуулийн “Монгол Улсын төрийн байгуулал” гэсэн Гуравдугаар бүлэгт төрийн эрх мэдлийг Улсын Их Хурал /хууль тогтоох/, Засгийн газар /гүйцэтгэх/, шүүх эрх мэдэл гэсэн хуваарийн дагуу эрх мэдлийн салаа мөчир болгон тус тусад нь бүрэн эрхийг зааглан тодорхойлсон. Энэхүү хуваарилалт нь эрх мэдлийн салаа мөчир бүрт Үндсэн хуулиар хязгаарлалт тогтоож буйн илэрхийлэл бөгөөд эрх мэдлүүд нь бие биенээ тэнцвэржүүлж, улс төр, эрх зүйн хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд ямар нэгэн логик зөрүү үүсэхгүйгээр зохион байгуулагдах ёстой гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасан нь Засгийн газрын шийдвэр болох Ерөнхий сайдын захирамжийг хүчингүй болгох эрх бүхий байгууллагыг шууд тодорхойлсон заалт бөгөөд үүнтэй адил зохицуулалтыг Үндсэн хуулийн бусад зүйл, заалтуудаас харж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их

75 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2003 оны № 3-д нийтлэгдсэн

Хурал хүчингүй болгоно”, мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэжээ. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх гэсэн Үндсэн хуулийн байгууллагууд буюу эрх мэдлийн харилцан зааг хязгаар, эрх хэмжээ, хариуцлагыг Үндсэн хуульд хуульчлан тогтоож өгсөн заалт юм.

Дээрх байдлыг нотлон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.1, 4.1.6 нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт гаргаж, улмаар уг хуульд Улсын Их Хурал өөрчлөлт оруулжээ.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь хэсгийн “.../Ерөнхий сайд./” гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх /Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2 дугаар дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаас хүчингүй болгосон/ хэсгийн заалтын нэгэн адил Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалттай нийцэхгүй байгаа тул Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын “.../Ерөнхий сайд./” гэснийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” гэсний дагуу захирамжид Ерөнхий сайд, сайд гарын үсэг зурж баталгаажуулдаг хамтын шийдвэр бөгөөд Ерөнхий сайдын захирамж нь Засгийн газрын шийдвэр юм. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “...Засгийн газрын шийдвэр..”, мөн Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд “...Засгийн газрын шийдвэр..” гэж тус тус заасан бөгөөд зарим маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхдээ Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол сүүлийн үед гарах болсон нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, ... хуулийг хэрэглэх эрхгүй” гэсэн заалт мөн адил зөрчигдөхөд хүргэж байна.

Иргэн Б., Ү. нарын нэмэлт тайлбарын агуулга:

1/Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1-д зааснаар Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг тусгайлан тогтоосон. Улсын Их Хурал, Засгийн газар энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэр шийдвэрлүүлж болох нь нээлттэй. Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянахаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан хэрэг болж байна. Өөрөөр хэлбэл, Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээг Үндсэн хуулиар олгоогүй гэж үзэж байна.

Ер нь, төрийн дээд байгууллагуудын шийдвэрийн халдашгүй байдлын хүрээ буюу “дархлаа” гэж байдаг. Засгийн газар нь шийдвэрээ хууль биелүүлэх зорилгоор хуульд нийцүүлэн гаргадаг ба тэр нь тодорхой хувь иргэнд шууд чиглэх биш улс орны тодорхой хүрээ, салбарт үйлчлэхээр гардаг. Тэр утгаараа Засгийн газар, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч зэрэг байгууллагын шийдвэрийн дархлаа, баталгаа нь нийтийн ашиг сонирхол байдаг. Хэрэв Засгийн газар үнэхээр хууль тогтоомжид нийцэхгүй шийдвэр гаргавал Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийнхээ дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, улс төрийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн: “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна”, “Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана”



гэснээр тодорхойлогдож байна. Тэрчлэн Ерөнхий сайд тодорхой хувь этгээдийн ашиг сонирхлыг зөрчсөн шийдвэр гаргадаггүй нь “Ерөнхий сайдын бүрэн эрх” гэсэн Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлээс тодорхой байгаа билээ.

2/ Засгийн газрын шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй гэж иргэн, хуулийн этгээд үзвэл Засгийн газарт өөрт нь, эсхүл Улсын Их Хурлын гишүүнд буюу шууд Улсын Их Хуралд өөрт нь хандан шийдвэрлүүлэх эрх Үндсэн хууль, бусад хуулиар иргэдэд нээлттэй юм. Хэрэв хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох эрхийг Улсын Их Хуралд хүлээлгэсэн байна. Үүнээс гадна, Засгийн газар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг үндэслэн Засгийн газрын хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг Үндсэн хуулийн цэцэд хандан шүүхийн журмаар шийдвэрлүүлэх боломжтой юм.

3/ Монгол Улсын иргэн Засгийн газрын хууль бус шийдвэрийн талаар Засгийн газар, Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэцэд гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй байгаа тул Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх хязгаарлагдсан гэдгийг зөвшөөрөх боломжгүй байна, нөгөө талаас, бидний өргөдлийн агуулга нь эл үндсэн эрхийг хязгаарласан тухай биш, харин Засгийн газрын шийдвэрийг Үндсэн хуулиас гадуур журмаар хүчингүй болгох эрхийг захиргааны шүүхэд олгосон тухай асуудал юм.

4/ Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” гэж зааснаас харахад Ерөнхий сайдын захирамж нь хамтаар гаргаж буй Засгийн газрын шийдвэр юм.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа, хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна.

Өргөдөл гаргагч нар өргөдөлдөө төрийн эрх мэдлийг хууль тогтоох /Улсын Их Хурал/, гүйцэтгэх /Засгийн газар/, шүүх эрх мэдэл гэсэн салаа мөчирт хуваарилан тодорхойлсон талаар дурдахдаа шүүх эрх мэдлийг засгийн гурван салааг хооронд нь тэнцвэржүүлэгч хүч болдог талаар анхаарахыг хүссэнгүй. Захиргааны аливаа байгууллага зөвхөн хуулиар олгосон бүрэн эрхийн дотор шийдвэр гаргаж байна. Харин хүний эрхийн хүрээнд хөндлөнгөөс оролцож, хуулийг өөрчилж ч, зөрчиж ч болохгүй юм. Ийнхүү дэлхийн улс орнуудад захиргааны шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд /хөндлөнгийн/ шүүхийн хяналт тогтоож, хэрэг маргааныг шийдэж, улмаар хүний эрхийг хамгаалах, байгууллага, албан тушаалтнаас хууль ёсыг сахин биелүүлэхэд чиглэсэн механизм болгох явдал түгээмэл байна. Шүүхийн хяналт бол захиргааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай процессын эрх зүйн хэлбэр мөн бөгөөд ийнхүү хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын /нэг талаас гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага нөгөө талаас иргэн, хуулийн этгээд/ тэгш байдлыг хангаж байна.

Практик дээр иргэний гаргасан гомдлын дагуу Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байсан тохиолдол нэг ч гараагүй болно. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актын талаархи

нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтныг харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан барагдуулах боломжгүй юм.

2/ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцын тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй..” гэсэн хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг захиргааны хэргийн шүүхээс хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан билээ. Хэрэв Монгол Улсын Ерөнхий сайдаас гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн байдал нь тохирохгүй гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ.

3/ Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу “Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ”... үйл ажиллагаагаа танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ. Танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан мөн”. Мөн Үндсэн хуулийн Дөчинтавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргана”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлд “Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана” гэж тус тус заажээ. Үүнээс үзэхэд Ерөнхий сайдын захирамж заавал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлаар гарах шаардлагагүй байна.

Өөрөөр хэлбэл, Ерөнхий сайдын захирамж нь нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар захиргааны албан тушаалтнаас бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр /захиргааны акт/ болж байна. Иймд иргэн, хуулийн этгээд хууль бус захиргааны акттай холбоотой нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргаж зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй болох нь дор дурдсан үндэслэлээр тогтоогдож байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан 2/02 дугаар дүгнэлтдээ “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан” гэсэн 4 дүгээр зүйлийн “...дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д “Монгол Улсын Засгийн газар” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага

мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна” гэж заажээ.

2. Дээрх дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-ийн “Монгол Улсын Засгийн газар” гэснийг хүчингүй болгосон байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-д “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах..”, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1-д “Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана” гэж заажээ.

4. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын тухай хууль болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн холбогдох заалт ёсоор Засгийн газрын шийдвэрт тогтоол, захирамжийг хамааруулан ойлгоно.

5. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-ын “/..Ерөнхий сайд.../” гэсэн заалтад уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5, 3.1.6 дахь заалт нэгэн адил хамаарч байна. Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд эрх хэмжээнийхээ хүрээнд захирамжаас гадна амаар буюу бичгээр захиргааны акт, мөн Түүнчлэн эрх зүйн үр дагавар шууд бий болгодог нэг удаагийн захирамжилсан бусад арга хэмжээ / үйлдэл, эс үйлдэхүй/-г явуулж болохоор хуульчилсан тул дээрх хуулийн 4.1.2-т заасан “/..Ерөнхий сайд.../” гэснийг хүчингүй болгох үндэслэлгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “/...Ерөнхий сайд.../” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Цэцийн шийдвэрүүд хэдийгээр өөр асуудлаар гарч, өөр хоорондоо ялгаатай маргаанд холбогдуулсан хийсэн тайлбар болж байдаг ч тэдгээрийн нийцэл, харилцан уялдаа холбоог хангаж байх нь Үндсэн хуулийн хөгжилд чухал хувь нэмэртэй. Тэр ч бүү хэл урьд гаргасан шийдвэрийнхээ үндэслэлээс дараагийн шийдвэрүүдэд иш татах, заах шаардлага гардаг. Иргэдийн зүгээс Цэц өмнө гаргасан дүгнэлтээрээ Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас “хассан” болохоор Ерөнхий сайдыг мөн адил хасах ёстой гэсэн үндэслэлээр Цэцэд хандсан гэж ойлгож болно.

Үндсэн хуульд зааснаар Засгийн газар тогтоол, захирамж гаргадаг. Үүнийг Засгийн газрын тухай хууль болон хуралдааны дэгээр нарийвчлан зохицуулж Засгийн газрын тогтоолыг хуралдаанаар хэлэлцэж гаргахаар, харин захирамжийг Ерөнхий сайд гаргахаар тус тус журамласан.

Цэцийн шийдвэрийн уялдаа холбоог хангаж байна гэх ядмаг үндэслэлээр Ерөнхий сайдыг мөн адил Захиргааны хэргийн шүүхийн харьяаллаас гаргах боломжгүй юм. Засгийн газраас нийтээр дагаж мөрдөх тогтоол гаргахдаа холбогдох хуулийн зүйл, заалтыг удирдлага болгох ёстой. Гэтэл Ерөнхий сайд захирамж гаргахаас гадна илүү эрх эдлэх боломж бий. Ер нь Цэц энэ шийдвэрээ дахин эргэж нэг харахад илүүдэхгүй байх.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.02.22 № 2/02

### Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн О., Э., Ц., Б.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн  
бичгийн дарга С.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 209 дүгээр  
тогтоол

- 3 дахь хэсэг “Геронтологийн төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн  
байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн  
хороо /Э./, Эрүүл мэндийн сайд Г.-д тус тус үүрэг болгосугай”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш  
байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны  
үндсэн зарчим мөн”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн  
аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны  
өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал,  
шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр  
эрх зүйн этгээд байна”

- Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт “эрүүл мэндээ хамгаалуулах,  
эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх  
болзол, журмыг хуулиар тогтооно”

- Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт “Төрийн байгууллага, албан  
тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага,  
албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц  
эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх  
чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ  
өмнө хариуцна”

- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Үндсэн хууль, бусад  
хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”

- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь хэсэг “шинжлэх ухаан,  
технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл,  
улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж,  
гарсан шийдвэрийг биелүүлэх”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн  
байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ  
нийцсэн байвал зохино”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн О., Э. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2001 оны 76 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийг байгуулж, эмнэлгийн үйлчилгээг нэг дороос чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах үүднээс хувийн хэвшлийн нэр бүхий 15 эмнэлэг хариуцан, ажлын байрыг яамнаас түрээсийн гэрээний үндсэн дээр эзэмшүүлж, ашиглуулахаар зохицуулж, үйл ажиллагаагаа явуулах болсноор 5 дахь жилийнхээ нүүрийг үзэж 180000 гаруй байнгын үйлчлүүлэгчтэй болж, үйл ажиллагаа нь өргөжиж байна.

Нэр бүхий 15 эмнэлгийн байгууллага 5 жилийн хугацаанд байрны ашиглалтыг сайжруулж, засвар үйлчилгээг хариуцан, төлбөрийг цаг хугацаанд нь тогтмол төлж ирсэн. Уушигны мэс засал, эмэгтэйчүүд, дотор, мэдрэл, уламжлалт эмнэлэг, мэс засал, судас шамбарам зэрэг нарийн мэргэшсэн чиглэлээр эмнэлгийн 100 гаруй ажилтан / үүнээс 50 гаруй хувь нь мэргэжлээрээ 20-иос дээш жил ажилласан/ иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг найдвартай, түргэн шуурхай явуулж, орчин үеийн түвшинд хүргэхийг зорьж байна. Гэтэл Эрүүл мэндийн сайд Г. нь 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 230 дугаартай тушаал гэнэт гаргаснаар бидний хууль ёсны эрх ашгийг зөрчиж, хувийн хэвшлийн эдгээр 15 эмнэлгийн байгууллагыг бүгдийг нь төрийн өмчийн эмнэлгүүдийн нэг нэг өрөөнд тараан байршуулахаар зааж, эмчлэгч болон үйлчлүүлэгч нарын хэн хэнийнх нь эрх ашгийг ноцтой зөрчсөн шийдвэр гаргасан. Энэ тушаалын дагуу манай эмнэлгүүд нэг нэг өрөөнд орох аваас урьд үзүүлж байсан эмнэлгийн үйлчилгээ бүрэн зогсож, хүний даралт үзэх, чагнахаас хэтрэхгүй байдалд хүрэх юм.

Бид Эрүүл мэндийн сайд Г.-гийн дээрх хууль бус ажиллагааг таслан зогсоож өгөхийг хүссэн өргөдлөө Засгийн газарт 2005 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр өгсөн боловч Засгийн газраас бидний өргөдөл, хүсэлтийг шалгаж үзэлгүй, хариу өгөлгүй байсаар 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр 209 дүгээр тогтоол гаргалаа. Энэ нь сайд Г.-гийн хууль бус шийдвэрийг нягтлан шалгаж үзэлгүйгээр, өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дугаар заалт, 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөнөөр Засгийн газар нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгааварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчлөө.

Сайд Г.-гийн саналыг үндэслэн насжилтыг судлах төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд оруулахаар гаргасан Засгийн газрын дээрх тогтоол хэрэгжих аваас эмнэлгийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор төв болж байсан хувийн хэвшлийн 15 эмнэлгийн байгууллага байргүйгээс ажиллах боломжгүй болж түүнд хэвтэн үйлчлүүлэгч нарын эрх ашиг зөрчигдөхөд хүрэх юм. Засгийн газар нь эмнэлгийн үйлчилгээг хувийн, улсын гэж ялган үзэж, Улсын Их Хурлаар 2004 онд баталсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилт, тухайлбал, “...иргэддээ үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага, чадавхийг дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах, хувийн салбарын өсөлтийн гол хөдөлгөгч хүч болгох, эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг ханган, мэдлэг, мэдээлэлд тулгуурласан шинэ зах зээл нээхийг дэмжих”, мөн “Нийгмийн бодлого” бүлгийн 5 дахь заалтын “...Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, улсын болон хувийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний

чадавхийг сайжруулах, ялангуяа орчин үеийн иж бүрэн оношлогооны төвийг нийслэл хот болон бүсийн төвүүдэд байгуулах санаачлагыг дэмжинэ, Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн менежментийг боловсронгуй болгох” зэргийг хэрэгжих боломжгүй болгож байна. Энэ нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэснийг зөрчлөө.

2. Иргэн О., Э. нарын нэмэлт тайлбарын агуулга:

Нэр бүхий 15 эмнэлгийн байгууллагын гаргасан нэхэмжлэлийн дагуу Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2005 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 137 дугаартай шүүгчийн захирамжаар Эрүүл мэндийн сайд Г.-гийн 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 230 дугаартай тушаал хүчингүй болсныг баталснаар дээрх тушаал хууль илтэд зөрчсөн болох нь шүүхээр нотлогдсон. Засгийн газрын дээрх үйл ажиллагаа нь Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалт, Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг тус тус зөрчлөө. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалтын “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй...” гэснийг зөрчин, иргэдийн энэ эрхийг нь хөндөн Засгийн газар Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 4.2.2 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчиж Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь заалт, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” гэснийг тус тус зөрчлөө.

3. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ахмадад зориулан үйлчилгээ үзүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах талаар тусгагдсан заалтууд, “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 1998 оны 130 дугаар тогтоолын Геронтологийн төв байгуулах тухай заалт, Ерөнхий сайд Э.-гээс “Настнуудын аж байдлыг сайжруулах тухай” 2005 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн ЗГ/74 дугаар албан бичгээр өгсөн үүрэг зэргийг хэрэгжүүлэхийн тулд Геронтологийн төв байгуулах асуудлыг Эрүүл мэндийн сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5, 6, 7-д заасны дагуу санаачлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Дээрх асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулсан, хэлэлцсэн үйл ажиллагаа Засгийн газрын тухай хууль, журамд нийцсэн тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дугаар заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байр нь төрийн өөрийн өмч тул хувийн хэвшлийн эмнэлгүүдийн өмчийн асуудлыг Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоол хөндөөгүй юм. Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байр нь хувийн хэвшлийн эмнэлгүүдийн байр биш, уг байгууллагууд нь зөвхөн төрийн өмчийг түрээслэгчид юм. Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, төрийн өмчийн байрыг тэдгээр эмнэлгүүд нь өнөөдрийг хүртэл чөлөөлөхгүй байгаа нь төрийн өмчлөх эрхийг зөрчиж байгаа үйлдэл мөн. Геронтологийн төв байгуулах тухай Засгийн газрын тогтоол нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан шийдвэр бөгөөд Засгийн газрын тухай хуулийн 7.2 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл болохгүй байна. Дээрх тогтоол нь Засгийн газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хуулийн хүрээнд гарсан. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт нь Засгийн газрын 2005 оны Геронтологийн төв байгуулах тухай 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт буюу Геронтологийн төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /Э./, Эрүүл мэндийн сайд Г.-д тус тус үүрэг болгосугай гэсэн заалттай огтхон ч хамааралгүй байна. Иймээс Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоол нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль, тогтоомжийн дагуу боловсрогдож гарсан учир Үндсэн хуулийн 38.2.2 дахь заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг хохироож болохгүй” гэж заасан бөгөөд Геронтологийн төвийн байранд байрлаж байгаа хувийн хэвшлийн эмнэлгүүд нь /нэхэмжлэгч тал/ зохих шийдвэр, гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээ цуцлах мэдэгдэл, байрлах байрыг нь олж өгсөөр байтал Засгийн газрын тогтоол, Төрийн өмчийн хорооны шийдвэрийг үл хүндэтгэн Төрийн өмчийн байрыг суллахгүй байгаа нь ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, монгол хүний хөгшрөлтийн шалтгаан, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах зэрэг зорилгоор Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Геронтологийн төвийн үйл ажиллагаа тасарч олон зуун мянган ахмадуудын болон улс орны эрх ашигт ноцтой хохирол учрахад хүрээд байна.

Иргэн О., Э. нарын өргөдөлд “...Засгийн газар нь 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хэрэгжүүлснээс гарах үр дагаврыг шийдвэрлээгүй юм” гэсний хувьд Геронтологийн төв байгуулах тухай Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтаас гарах үр дагаврыг урьдчилан тооцож үзсэний үндсэн дээр Эрүүл мэндийн үйлчилгээний 2 дугаар төвд байрлаж байсан нэр бүхий 15 эмнэлэгт байр олж өгөх зорилгоор Эрүүл мэндийн сайдын Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг байршуулах тухай 2005 оны 230 дугаар тушаал гарсан. Нэгэнт хувийн хэвшлийн эмнэлгүүд нь өөрсдийн эрх ашгийг хамгаалж гаргасан тушаалыг хүчингүй болгуулахыг хүссэн учир Эрүүл мэндийн сайд энэхүү тушаалаа өөрөө хүчингүй болгосон. Тэдний эрх ашиг, үйлчлүүлэгч нарын эрх ашгийг хамгаалах зорилгоор гаргасан Эрүүл мэндийн сайдын 230 дугаар тушаалыг өөрсдөө тухайн үед нь хүлээн зөвшөөрөөгүй атлаа Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө... хувийн хэвшлийн 15 эмнэлгийн байгууллага байргүйгээс ажиллах боломжгүй болж, гудамжинд гарах, түүнд хэвтэн үйлчлүүлэгч нарын эрх ашиг зөрчигдөхөд хүрэх, мөн Засгийн газар Геронтологийн төв байгуулах тухай 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтаас гарах үр дагаврыг тооцож үзээгүй гэсэн нь Засгийн газраас шалтгаалаагүй. Энэ нь иргэдээс өндөр төлбөр авч үйлчилгээ үзүүлж буй хувийн байгууллагын өөрсдийн шийдвэрлэх ёстой асуудал гэж үзэж байгаа ба Үндсэн хуулийн 19.1 дэх заалтын “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй байна.

Иймд дээрх хууль, тогтоомжийн холбогдох заалтуудаас үзэхэд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засгийн газрын “Геронтологийн төв байгуулах тухай” 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3-т “Геронтологийн төвийг эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /Э./, Эрүүл мэндийн сайд Г.-д тус тус үүрэг болгосугай” гэж заажээ.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн XI хорооны нутагт байрлах Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байшин нь төрийн өмчийн байр болох нь Төрийн өмчийн хорооны дарга С.-ийн 2006 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 1<sup>а</sup>/211 дүгээр албан бичгээр ирүүлсэн тодорхойлолт, барилгын хувийн хэрэг бусад нотлох баримт, түүнчлэн өргөдөл гаргагч иргэн О., Э. болон Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С. нарын хүлээн зөвшөөрч байгаагаар нотлогдож байна.

Дээр дурдсан болон хэргийн материалд авагдсан бусад нотлох баримт, маргагч талуудын тайлбарт дүгнэлт хийж үзэхэд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь: 1/ Хэн нэг өмчлөгчийн эрхийг зөрчөөгүй, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө, чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаагүй, хүн бүр эрх зүйн этгээд байх болон эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах талаарх иргэний эрхийг зөрчөөгүй байна.

2. "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах болон шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" тухай Засгийн газрын бүрэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Монгол Улсын Засгийн газар дээр дурдсан 209 дүгээр тогтоолд заасан асуудлыг хуралдаанд оруулж хэлэлцэн шийдвэр гаргахдаа Засгийн газрын тухай хуулийн 2 дахь хэсгийн 6, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн болох нь тогтоогдоогүй, ингэснээр Засгийн газар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

4. Монгол Улсын Засгийн газар Монгол хүний хөгшрөлтийн шалтгаан, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, нийгэм, хамт олонд тулгуурласан сэргээн засах төвийг байгуулж, түүнийг төрийн өмч болох Эрүүл мэндийн үйлчилгээний II-р төвийн байранд байршуулахаар шийдвэрлэснийг хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар иргэнийхээ өмнө хариуцах үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

5. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар сайдын тушаалыг хүчингүй болгох тохиолдолд Ерөнхий сайд захирамж гарган шийдвэрлэх үндэслэлтэй байна. Энэ утгаараа өргөдөл гаргагч нарын Эрүүл мэндийн сайдын 2005 оны 230 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай хүсэлтийг Засгийн газар шийдвэрлэж өгөөгүй гэсэн нь Ерөнхий сайдын эрх мэдэлд хамаарах асуудал бөгөөд өргөдөл гаргагч иргэдээс Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гаргасан өргөдлийн агуулгатай давхцсан, Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2006 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 5/10 дугаар тогтоолоор шийдвэрлэгдсэн асуудал болох өөрөөр хэлбэл, уг асуудлаар Үндсэн хуулийн цэцийн урьд гарсан хүчин төгөлдөр шийдвэртэй байгаа нь тогтоогдож байна.

Харин Засгийн газрын "Геронтологийн төв байгуулах тухай" 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх явцад иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөнөөс нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахад хүргэсэн байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:



1. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын “Геронтологийн төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /Э.-д/, Эрүүл мэндийн сайд Г.-д тус тус үүрэг болгосугай” гэсэн 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 6, 12, Арван есдүгээр зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ төрийн байгууллагууд аливаа асуудлыг шийдвэрлэхдээ тооцоо, судалгаа, үндэслэлээ сайн боловсруулж, үүсч болох үр дагаврыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсны үндсэн дээр шийдвэрээ гаргах ёстой. Төр гэдэг хүчтэй субъект. Энэ ч утгаараа бодлогоо зөв тодорхойлох учиртай. Төр бодлогоор хувийн хэвшлийн эмнэлгийг нэгтгэн байршуулсан атлаа “Геронтологийн төв” байгуулах нэрээр өмнө гаргасан шийдвэрээ үгүйсгэж байгаа нь Засгийн газар бодлого тодорхойлох, хууль хэрэгжүүлэх тогтвортой шийдвэр гаргадаг байх шинжээ алдаж байгаагийн нэг илрэл.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.03.29 № 2/03**

**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.4, 396 дугаар зүйлийн 396.3, 396.4, 396.5 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Х.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Х.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль<sup>76</sup>

- 389 дүгээр зүйлийн 389.4 дэх хэсэг “Хууль бус ажиллагаатай холбогдож гарсан шууд бус хохирлыг төр хариуцахгүй”

- 396 дугаар зүйлийн 396.3 дахь хэсэг “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана”

- 396 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно”

<sup>76</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 6-д нийтлэгдсэн

- 396 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Энэ хуулийн 396.3, 396.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол сонирхогч этгээдийн өргөдлөөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, эсхүл шүүх сэргээж болно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг “...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

#### **Үндсэн хуулийн Хавсралт хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Долдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий БНМАУ-ын хууль болон олон улсын гэээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэрэглэхийг хориглоно. Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаарх заалт зөрчигдвөл уул гэрээний заалтыг баримтална”

- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Х.-гийн өргөдлийн агуулга:**

Монгол Улсын Их Хурлаас 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Шүүх, прокурор, мөрдөн байцаах хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай” Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 44 дүгээр бүлэг болгон нэгтгэн найруулан батлахдаа 396 дугаар зүйл 396.3, 396.4, 396.4.5-д хөөн хэлэлцэх хугацааг шинээр 1-3 жилээр нэмэн тогтоон хохирогчийн эрхээ сэргээх эрхийг хязгаарласан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйл, түүний олон улсын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах заалтуудтай зөрчилдөж байна.

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийн 396 дугаар зүйлийн 396.3-т “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана”, 396.4-т “Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно”, 396.5-д “Энэ хуулийн 396.3.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол сонирхогч этгээдийн өргөдлөөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эсхүл шүүх сэргээж болно” гэж хуульчилсан юм.

2/ Энэ заалтууд Үндсэн хуулийн хүний эрх хамгаалах заалттай зөрчилдөж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэхтэй, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн Долдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын Үндсэн хуульд тодорхойлсон хүний эрхийг дордуулсан заалт бүхий БНМАУ-ын хууль болон олон улсын гэрээ, тэдгээрийн заалтыг мөнхүү Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш

хэрэглэхийг хориглоно. Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын хууль ба олон улсын гэрээний хүний эрхийн талаарх заалт зөрчигдвөл уул гэрээний заалтыг баримтална”, Тавдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно” гэжээ. Үндсэн хуулийн дээрх заалтууд болон манай улсын нэгдэн орсон олон улсын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гэрээ, конвенци, пактуудад хүн зөрчигдсөн эрхээ сэргээх хугацааг хязгаарласан нэг ч заалт байхгүй байна.

3/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэг 396 дугаар зүйл 396.3, 396.4, 396.5 хэсгийн заалт нь Үндсэн хуулийн дээрх заалттай ийнхүү зөрчилдөж байгаа учраас хилс хэрэгт шийтгүүлж цагаатсан цөөн ч гэсэн хохирогчид хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн гэдгээр хохирлоо арилгуулж эрхээ сэргээлгэж чадахгүй байгаа хүмүүсийн нэг нь Х. би юм. Мэдээллээс хол хөдөө орон нутагт амьдардаг малчин, тариачин, ажилгүйчүүд, ядуучууд болон бичиг үсэг мэддэггүй нийгмийн давхаргад энэ хуулийн заалт үнэхээр хүнд тусаж байгаа юм. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийн 396 дугаар зүйл 396.3, 396.4, 396.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргаж өгнө үү. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлд заахдаа байцаан шийтгэх ажиллагааны явцад иргэнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгах, тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон нь хохирол нөхөн төлүүлэх эрх үүсэхээр тогтоож өгсөн нь уг эрхийг баталгаатай болгоход чухал ач холбогдолтой. Харин хууль бус ажиллагаатай холбогдож гарсан шууд бус хохирлыг төр хариуцахгүй гэсэн заалт Үндсэн хуулийн учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх болон хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэний өмнө хариуцах төрийн үүрэгтэй нийцэхгүй байна. Үндсэн хуульд хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тусгахдаа шууд буюу шууд бус хохирол гэж ялгаагүй ба тэр тусмаа төрийн хувьд ямар нэгэн ялгавар хөнгөлөлтийг заагаагүй билээ. Иймд 389 дүгээр зүйлийн 389.4 дэх хэсгийн заалтыг 396.3, 396.4, 396.5 дахь хэсгийн зүйлтэй хамт нэг мөр хянаж өгнө үү.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Хү.-гийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу Улсын Их Хурал 2002 онд баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмыг процессын хуульд нэг мөр тусгаж өгсөн нь хохирогчийн учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээх эрхийг баталгаатай болгоход чиглэгдсэн. Аливаа процессын үйл ажиллагаа хуулиар тогтоосон хугацаа, журмын хүрээнд явагддаг тул хууль тогтоогч хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор, бусад эрхийг сэргээх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болохоор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3, 396.4-т заан хуульчилсан нь эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус зарим эрх, үүрэг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох хууль зүйн фактыг тодорхой болгож өгсөн бөгөөд энэ бол хуулиар тогтоосон хугацаа юм. Эд хөрөнгийн эрхээ хамгаалуулах буюу эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх асуудал нь иргэний эрх зүйн харилцааны объект бөгөөд иргэний эрх зүйд ихэнх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тодорхой заасан байдаг. Өөрөөр хэлбэл, маргаантай нөхцөл байдлуудыг урт удаан хугацаа өнгөрсний дараа шаардлагатай хэмжээнд үнэн бодитойгоор тогтооход хүндрэлтэй байдаг тул энэхүү хөөн хэлэлцэх хугацааг тодорхой заасан. Ингэснээр хөөн хэлэлцэх хугацаанд гаргасан нэхэмжлэлийн шаардлагын талаархи нотлох баримтууд цаг хугацааны хувьд хадгалагдах илүү баталгаатай байдаг.

2/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396.3, 396.4-т заасан хугацааг иргэн мэдсэнээс хойш тооцохоор заасан нь тухайн иргэний эрхийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна. Харин ч шүүх тухайн асуудлыг үнэн зөвөөр шийдвэрлэх нөхцөл баталгааг бүрдүүлж өгч байгаа явдал юм. Нөгөөтэйгүүр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396.5-д дээр дурдсан хөөн хэлэлцэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн тохиолдолд сонирхогч этгээдийн өргөдлөөр шүүх сэргээж болохоор заасан.

3/ Хөөн хэлэлцэх хугацаа нь ерөнхий ба тусгай хөөн хэлэлцэх хугацаа гэж байдаг. Иргэний хуулиар Ерөнхий хугацааг 10 жил байхаар тогтоосон. Тусгай хугацаа нь ерөнхий хугацаанаас богино байдаг бөгөөд хууль тогтоогч энэхүү тусгай хугацааг 3 жил, 1 жилээр тогтоож өгсөн. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396.3, 396.4, 396.5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Иргэний хуулийн 75 дугаар зүйлд зааснаар хөөн хэлэлцэх ерөнхий хугацаа 10 жил байдаг ба хуульд тусгайлан заасан тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацааг хэрэглэж болдог. Гэхдээ Монгол Улсын Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд хөөн хэлэлцэх тусгай хугацаа үйлчилнэ:

75.2.1. гэрээний үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил;

75.2.2. үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой гэрээний үүрэгт шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан жил;

75.2.4. бусдын эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүсэх үүрэгтэй холбоотой шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа таван жил... гэх мэтээр тусгай хугацаа тогтоосон байна.

Түүнчлэн мөн хуулийн 74.2-т “хуульд өөрөөр заагаагүй бол хөөн хэлэлцэх хугацаа эдийн бус хөрөнгөд хамаарахгүй”;

74.3-т “хуульд тусгайлан заасан бол эд хөрөнгийн зарим эрхэд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй” гэж заасан нь тухайн харилцааны онцлогт тохируулан хөөн хэлэлцэх хугацаа тогтоодгийг харуулж байна.

Иргэний эрх зүйн харилцаанд сайн дураараа хүсэл зоригоо илэрхийлэн тэгш эрхийн үндсэн дээр оролцож байгаа эрх зүйн этгээдүүдийн зөрчигдсөн эрхийг сэргээх хөөн хэлэлцэх хугацаатай харьцуулахад төр, иргэн хоёрын хоорондох нэг нь нөгөөдөө захирагдах тэгш бус харилцаанд төрийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн эрх нь зөрчигдсөн иргэний эрхийг сэргээх хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон, тэгэхдээ иргэний эрх зүйн харилцааны ерөнхий хөөн хэлэлцэх хугацаанаас ч бага байхаар тогтоосон нь үндэслэлгүй бөгөөд харин ч төр иргэндээ эрхээ хамгаалуулах илүү боломж олгох ёстой.

Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн зэрэг үйлдэл нь төрийн албадлагын үйлдэл учраас хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгах ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

Гэтэл төр иргэндээ гэм хор учруулах замаар эрхийг нь зөрчөөд эргээд зөрчигдсэн эрхийг сэргээхдээ дээрх эрхийг хөөн хэлэлцэх хэт богино хугацаагаар хязгаарласан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3, 396.4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002 оны/ шинэчлэгдэн батлагдахаас өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан “Шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай” Монгол Улсын хуульд /1990 оны/ зөрчигдсэн эрхийг сэргээх хөөн хэлэлцэх тусгай хугацаа заагаагүй байсан бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны журмыг баримталж байсан байна.

2. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.5 дахь хэсгийн заалт нь хөөн хэлэлцэх хугацааг сэргээх асуудлыг зохицуулсан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 389 дүгээр зүйлийн 389.4 дэх хэсгийн заалт нь төр үйл ажиллагааныхаа улмаас учруулсан гэм хор, хохирлыг л хариуцах үүрэгтэй тул Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3 дахь хэсэгт “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана”, 396.4 дэх хэсэгт “Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.5-д “Энэ хуулийн 396.3, 396.4-т заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол сонирхогч этгээдийн өргөдлөөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, эсхүл шүүх сэргээж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг, 389 дүгээр зүйлийн 389.4-т “Хууль бус ажиллагаатай холбогдож гарсан шууд бус хохирлыг төр хариуцахгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт, мөн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” гэсэн хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

3. Өргөдөл гаргагчийн өргөдөлдөө үндэслэл болгосон Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Долдугаар зүйлийн 3 дахь хэсэг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3, 396.4, 396.5 дахь хэсэгт холбогдолгүй байна.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3, 396.4 дэх хэсгийн заалтын үйлчлэлийг 2006 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/03 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 396 дугаар зүйлийн 396.3 дахь хэсэгт “Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдлийг цагаатгах тогтоол, хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлалыг хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гаргана”, 396.4 дэх хэсэгт “Бусад эрхийг сэргээлгэх тухай өргөдлийг тухайн иргэнд эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор гаргаж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 2/03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Тэмдэглэл:**

Хөөн хэлэлцэх хугацаа гэдгийн зөвхөн процессийн хугацаагаар хязгаарлан ойлгох нь учир дутагдалтай. Иймд хөөн хэлэлцэх хугацаа гэдгийг материаллаг эрх зүйн хугацаа, зөрчигдсөн эрхийг хамгаалах боломжит хугацаа, үүрэг биелүүлэх хугацаа, эрхээ хэрэгжүүлэх хугацаа гэж өргөн утгаар авч үзэх ёстой. Нэгэнт үүссэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа тодорхой хугацаанд баригддаг, тэр хугацаанд ажиллагаа явагддаг юм гэхэд нөгөө талдаа зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах материаллаг хугацааг хуульд оновчтой тусгах шаардлагатай.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаа бага байна, их байна гэж хууль тогтоох эрхэд халдаж байгаа мэт боловч Цэцийн шийдвэрээр иргэн хүний зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах бодит бололцоог хуулиар хэт хязгаарласныг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн. Хугацаа байх, эсэх тухай асуудал нь Цэцийн эрх хэмжээнд хамаарахгүй. Ер нь хөөн хэлэлцэх хугацаагүй байхаар хуульчилсан зохицуулалт нэлээд байдаг.

Харин 2002 оны Иргэний хуулийн 75 дугаар зүйлд хөөн хэлэлцэх ерөнхий хугацааг 10 жил байхаар хуульчилсан. Өөрөөр хэлбэл хуульд тусгайлан заагаагүй л бол энэ ерөнхий хугацааг баримтлах ёстой. Гэхдээ хуульд заасан тусгай хугацаа гэдгийг Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үзэж байгаагаар заавал ерөнхий хугацаанаас богино байна гэж ойлгож үл болно. Тусгай хугацаа ерөнхий хугацаанаас ч урт байж болно. Ялангуяа төр иргэнийхээ өмнө хариуцлага хүлээх харилцааг зохицуулж байгаа энэ тохиолдолд тусгай хугацааг тухайн хуулиар тусгайлан бүр уртаар ч тогтоож болно.

Үндсэн хуульд иргэнийхээ хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр хариуцахаар заасан атал ийнхүү хэт богино хугацаа тогтоон Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс “зайлсхийж” байгаа нь өөрөө Үндсэн хуулийн зөрчил юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.04.12 № 2/04

### Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Хүсэлт гаргагч - Монгол Улсын дээд шүүх, итгэмжилсэн төлөөлөгч Иргэний танхимын тэргүүн шүүгч А.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль<sup>77</sup>

- 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалт “Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ...”

- 154 дүгээр зүйлийн 154.4 дэх заалт “Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ”

- 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалт “Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй”

- 174 дүгээр зүйлийн 174.3 дахь заалт “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх ...эрхтэй”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх...эрхтэй”,

- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

- Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Монгол Улсын дээд шүүхийн хүсэлтийн агуулга:

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсантай холбогдуулан Монгол

<sup>77</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гарч, Иргэний хуульд 154.3, 154.4, 174.3, 174.4 гэсэн хэсгүүдийг нэмж, 171 дүгээр зүйлийн 171.3, 174 дүгээр зүйлийн 174.2, 453 дугаар зүйлийн 453.2-т үг, өгүүлбэрүүд нэмжээ.

Иргэний хуульд орсон дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийн зарим нь утга агуулгаараа иргэний эрх зүйн үндсэн ойлголт, зарчмыг үгүйсгэн зөрчсөнөөс гадна Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж Улсын дээд шүүх үзэж, энэ талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэх тухай тогтоол гаргасан. /Улсын дээд шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр тогтоол/

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлж байна.

1/ Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж заасан нь утга агуулгаараа ойлгомжгүй бөгөөд өмчлөгчийн эрхийг зөрчсөн гэж үзэж байна.

Аливаа хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь бусдын гүйцэтгэх үүрэгт өөрийн өмчлөлийн зүйлийг барьцаалж болно, гэхдээ үүний тулд өмчлөх эрхээ тэрхүү үүрэг гүйцэтгэгчид шилжүүл гэсэн утгатай зохицуулалт болжээ. Өмчлөх эрх нь тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэлбэрээр хэрэгждэг билээ. Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах эрх нь эд хөрөнгө захиран зарцуулах эрхийн нэг хэлбэр мөн. Гэтэл хуулийн энэхүү заалтаар өмчлөгч нь өмчлөх эрхээ захиран зарцуулах хэлбэрээр хэрэгжүүлэхийн тулд өмчлөх эрхээсээ татгалзах ёстой гэсэн утгатай зохицуулалт харагдаж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан Монгол Улсын иргэн “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй” гэсэнтэй нийцэхгүй байна гэж Улсын дээд шүүх үзэж байна.

2/ Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т “Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж заасан нь утгын алдаатайгаас гадна Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

Ирээдүйд бий болох эд хөрөнгийг барьцаалж болохоор хуульчилсан атлаа энэхүү эд хөрөнгийг бий болсон үед л барьцаална гэсэн утгын зөрчил нь хуулийн энэ заалтыг хэрэглэхэд хүндрэл үүсгэж болзошгүй байгаагаас гадна өмчлөгч өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах хэлбэрээр захиран зарцуулж, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл өмчлөх эрхээсээ татгалзаж, бусдад шилжүүлэх шаардлагатай болж байгаа тул хуулийн энэ заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй” гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхүүдийн нэгийг зөрчсөн гэж үзэж байна.

3/ Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана” гэсэн нь нэгдүгээрт иргэний эрх зүйн талуудын тэгш эрхийн зарчим, хоёрдугаарт, “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан зарчим, гуравдугаарт, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэг буюу “эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.



Барьцааны гэрээний харилцаа бол иргэний эрх зүйн харилцаа мөн бөгөөд барьцаалагч этгээд иргэн, хуулийн этгээдийн алин ч байсан адил зарчим үйлчилдэг билээ. Гэтэл хуулийн энэхүү заалтаар барьцаалагч нь банк, банк бус санхүүгийн байгууллага байвал өөр зарчим үйлчилснээр "...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан зарчим хөндөгдөж байна. Иргэн Б хөрөнгө чинээ ихтэй тул банк бус санхүүгийн байгууллага ажиллуулах боломжтой болжээ, иргэн А их хэмжээний хөрөнгөгүй. Хэн алин нь бусдад мөнгө зээлдүүлэх эрхтэй ба зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах зорилгоор бусдын эд хөрөнгийг барьцаалах эрхтэй. Хэн алин нь Иргэний хуульд зааснаар зээлийн болон барьцааны гэрээ байгуулна. Гагцхүү банк бус санхүүгийн байгууллага ажиллуулдаг Б барьцааны эд хөрөнгөнөөс өөрийн шаардлагыг шүүхийн ч, шүүхийн бус ч журмаар хангуулах боломжтой бол хөрөнгө чинээ нь арай дутмаг А зөвхөн шүүхийн журмаар шаардлагаа хангуулах боломжтой байна. Ингэснээр хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчим хэрэгжих боломжгүй болж байна.

Нөгөө талаар, банк болон банк бус санхүүгийн байгууллага нь барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах шаардлагатай болсон тохиолдолд шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах эрхтэйгээр хуульд заасан нь шүүхийн шийдвэрлэх тодорхой нэг ижил асуудлыг бүртгэлийн байгууллага адилхан шийдвэрлэх боломжтой гэсэн утгатай болжээ. Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэх явдал нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй нэг хэлбэр билээ. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан "... шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн зарчим дээрх хуулийн заалттай буюу шүүхийн шийдвэрлэх асуудлыг бүртгэлийн байгууллага мөн л адил шийдвэрлэдэг зохицуулалттай илтэд нийцэхгүй байна. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт буюу "...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг Иргэний хуулийн дээрх заалт зөрчсөн гэж Улсын дээд шүүх үзнэ.

Түүнчлэн, банк, банк бус санхүүгийн байгууллага нь шүүхийн бус журмаар ипотекийн зүйлийг худалдан борлуулахаар бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргахад эд хөрөнгийн өмчлөгч энэхүү ажиллагаа, эд хөрөнгийн үнэлгээ зэрэг асуудлаар эрх нь зөрчигдлөө гэж үзвэл хаана хандах вэ? Ипотекийн шаардлага бүхий этгээд болох банк, банк бус санхүүгийн байгууллага л шүүхийн бус журмыг сонгосон бол иргэний эрх зүйн тухайн харилцаанд тэгш эрхийн зарчмаар оролцож буй өмчлөгчийн шүүхэд хандах эрх хаагдах ёстой гэж хэрхэвч үзэж болохгүй гэдэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэгт тов тодорхой туссан байна. "Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх"-ээр Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон эрх иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нөгөө талын хүсэлт зоригоор биеллээ олж чадахгүй байх боломжийг бүрдүүлсэн хуулийн дээрх заалт Үндсэн хуультай нийцэхгүй байна.

4/ Хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3 "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй", 174 дүгээр зүйлийн 174.2-т "Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн нь дээр дурдсан үндэслэлүүдээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт буюу "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр заалт буюу "... эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... шудрага шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ" гэж зааснаар тухайн хэм хэмжээний үндсэн агуулгыг тодорхойлсон бөгөөд барьцаалагдсан үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахад

өөр журам хуулиар тогтоохыг хязгаарлаж, өөр журам тогтоосон тохиолдолд ч Иргэний хуулийн зохицуулалтыг даган мөрдөхийг заасан байхад зарчмын ач холбогдолтой энэ өгүүлбэрийн дараа “энэ заалт банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллагад хамаарахгүй” гэж нэмсэн нь Иргэний хуулийн тухайн зохицуулалтын утгыг алдагдуулж, иргэний эрх зүйн харилцааны оролцогч хуулийн этгээдэд хуулиас гадуур, бусдаас илүү эрх олгож буй нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт буюу “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн зарчимтай нийцэхгүй байна гэж Улсын дээд шүүх үзэж байна. Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.3, 174.2-ын хоёр дахь өгүүлбэр нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

1/ Улсын дээд шүүх Иргэний хуулийн 154.3 дахь хэсгийн заалт нь “...бусдын гүйцэтгэх үүрэгт өөрийн өмчлөлийн зүйлийг барьцаалж болно, гэхдээ үүний тулд өмчлөх эрхээ тэрхүү үүрэг гүйцэтгэгчид шилжүүл гэсэн утгатай зохицуулалт болжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “Монгол Улсын иргэн “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй” гэсэнтэй нийцэхгүй байна гэжээ.

Энэ зохицуулалт нь хэн нэг гуравдагч этгээд бусдын гүйцэтгэх үүрэгт өөрийн хөрөнгийг барьцаалах асуудал биш юм. Улсын дээд шүүхийн ойлгож буй тохиолдлын хувьд гуравдагч этгээд өөрөө барьцаалагчтай /өөрийн нэрийн өмнөөс/ гэрээ байгуулахаас биш үндсэн үүрэг гүйцэтгэгч түүний хөрөнгөөр барьцаалагчтай барьцааны гэрээ байгуулахгүй. Энэ заалтын агуулга нь хэн нэг барьцаалах хөрөнгөгүй иргэн орон сууц авах зорилгоор зээл авахыг хүсчээ гэвэл /барьцааны гэрээ байгуулах үед барьцааны хөрөнгөгүй байсан ч/ уг зээлээр худалдан авах сууцаа эргүүлэн барьцаа болгох зохицуулалт юм. Нэгэнт барьцаа нь талууд харилцан тохиролцох замаар байгуулдаг үүргийн эрх зүйн харилцаа тул барьцааны ямар зүйлийг хүлээн зөвшөөрөх нь барьцаалагчийн эрсдэлийн асуудал гэж үзнэ. Иймд “Барьцааны зүйл бусдын өмчлөлийн эд хөрөнгө байж болно” гэдгийг хэн нэгний хөрөнгийг өмчлөлдөө шилжүүлсний дараа барьцаал гэж биш, харин тухайн гэрээний үр дүнд, ирээдүйд өмчлөлдөө шилжүүлэх хөрөнгөө эргүүлэн барьцаанд тавьж болно гэсэн агуулгаар ойлгох нь зүйтэй. Нөгөөтэйгүүр, барьцаалагчийн шаардах эрх нь гагцхүү барьцаалуулагчид өмчлөх эрх бий болсноор хэрэгжихээр заасан нь бусад өмчлөгчдийн эрхийг хөндсөн бус, эсрэгээр хамгаалсан зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, өмчтэй болно гэсэн амлалт биелүүлээгүйн төлөөх эрсдэлийг барьцаалагч /барьцааны зүйлийг хүлээн зөвшөөрсний хувиар/ хүлээх ба хэн нэгний өмчид халдахгүй гэсэн үг юм.

2/ Иргэний хуулийн 154.4 дэх хэсэг нь дээрх заалттай агуулгын хувьд төстэй юм. Дээр тайлбарласанчлан ирээдүйд өмчлөлдөө бий болгох /барьцааны гэрээ байгуулах үед барьцаалуулагчийн өмчлөлд байхгүй/ хөрөнгийг барьцаалах боломжийг нээж өгч байгаа юм. Энэ нь бусдын өмчлөх эрхийг мөн дээрхийн адил хөндөхгүй. Учир нь шаардах эрх нь Иргэний хуулийн 154.3 дахь хэсгийн мөн адил тухайн ирээдүйд бий болох хөрөнгө нь бий болж, үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд шилжсэн нөхцөлд үүснэ. Үүнд тодруулбал, хэдийгээр ирээдүйд бий болох хөрөнгө бий болсон боловч барьцаалуулагчийн өмчлөлд шилжээгүй бол шаардах эрх нээгдэх боломжгүй байгаа. Ингэснээр бусад хууль ёсны өмчлөгчдийн эрх мөн адил хамгаалагдаж байгаа юм.

3/ Иргэний хуулийн 174.2 дахь хэсгийн “Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн 2 дахь өгүүлбэр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасныг зөрчсөн байна гэжээ. Тэгш эрхийн зарчим нь гагцхүү ижил тэгш субъектуудын хооронд л яригддаг. Өөрөөр хэлбэл, ижил биш талуудын хооронд тэгш эрхийн асуудал хэзээ ч яригддаггүй. Жишээлбэл, банк болон банк бус санхүүгийн байгууллага аль аль нь иргэний эрх зүйн субъектууд боловч эрх зүйн статусын хувьд өөр өөр бөгөөд үүнтэй холбогдуулан өөр өөр эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Банк

хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байхад банк бус санхүүгийн байгууллага хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрхгүй байдаг гэх мэт. Хэрэв бүх этгээдүүд тэгш эрхтэй байдаг гэж үзвэл банк, банк бус санхүүгийн байгууллага, компани, төрийн бус байгууллага, цаашилбал, иргэн хүртэл хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрх нь нээлттэй байх ёстой нь дамжиггүй юм.

4/ Иргэний хуулийн 174.3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-ын "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14-ийн "эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шудрага шүүхээр шүүлгэх эрхтэй", Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна гэжээ.

Бүртгэлийн байгууллага нь барьцааны зүйлийг худалдан борлуулах эсэх асуудлыг шийддэг, шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага огтхон ч биш юм. Харин хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүхийн бус журмаар аливаа этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө этгээдэд учруулсан хохирлыг тогтоох, түүнийг гаргуулах, талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх зэрэгтэй холбоогүй бөгөөд гагцхүү тухайн барьцаалсан үл хөдлөх хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулж байгааг, ийнхүү хангуулах ажиллагаа нь хуульд заасан процедурын дагуу явагдаж байгаа гэдгийг л гэрчлэн бүртгэж буй үйлдэл юм. Уг ажиллагааны нэг онцлог нь ажиллагаанд оролцогч талууд аливаа хэлбэрээр маргаан гаргаагүй байх ёстой. Хэрэв талуудын аль нэг нь гэрээний талаар, эсхүл ажиллагааны явцад эрх нь зөрчигдсөн гэж үзэн маргаан үүсгэсэн тохиолдолд уг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ. Хэдийгээр Иргэний хуулийн 174.3 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг шүүхийн бус журмаар шийдвэрлэх ч шүүхийн бус шатанд шийдвэрлэх явцад хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааны аль ч шатанд, хэдийд ч шүүхэд хандан зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой юм. Энэ нь Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн 27.1 дэх хэсэгт заасан байгаа. Түүнчлэн нэгэнт хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрх нь нээлттэй байна. Иймээс Иргэний хуулийн 174.3 дахь хэсгийн заалт нь хэн нэгнийг шүүхэд хандахаас хязгаарлах бус, гагцхүү аливаа этгээдийн эрх, эрх чөлөө нь зөрчигдөөгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг шүүхийн оролцоогүйгээр хангуулах эрх зүйн үндсийг бий болгож өгсөн шинжтэй заалт юм.

Иймд Иргэний хуулийн 154 дүгээр зүйлтийн 154.3, 154.4 дэх хэсэг, 174 дүгээр зүйлийн 174.3 дахь хэсэг, 174.2 дахь хэсгийн хоёрдахь өгүүлбэр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### 3. Улсын дээд шүүхээс нэмэлт тайлбарын агуулга:

1/ Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4-т туссан зохицуулалтын талаар.

Зах зээлийн эдийн засгийн үед барьцааны гэрээний төрлүүдээс маш чухал ач холбогдолтой төрлийг Улсын Их Хурлын төлөөлөгч тайлбартаа дурдсан байгааг юуны өмнө нь тэмдэглэх нь зүйтэй байна. Энэ нь ирээдүйд өөрийн өмчлөлд ирэх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах асуудал юм. Энэ төрлийн барьцаа нь:

а/ Бодит байдалд бий болчихсон боловч барьцаалуулагчийн өмчлөлд хараахан шилжиж ирээгүй, энэхүү барьцаагаар хангагдах үүргийн үр дүнд өмчлөлд нь шилжих бодит боломж бүрдсэн үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа юм. Орон сууц худалдан авах хүсэлтэй этгээд бусдаас зээл авахдаа худалдах-худалдан авах гэрээний дагуу өмчлөлд нь шилжиж ирэх орон сууцыг өмчлөлдөө шилжээгүй буюу бусдын өмчлөлд байхад нь тухайн зээлийн үүрэгт барьцаалдаг.

б/ Бодит байдлаар бий болоогүй хэдий ч барьцаагаар хангагдах үүргийн дагуу олж авсан хөрөнгөөр ирээдүйд бий болгох үл хөдлөх эд хөрөнгийг уг эд хөрөнгийг бий болгох зорилгоор хүлээж буй үүрэгт барьцаалах. Байшин барилга барих хүсэлтэй этгээд энэ хүслээ биелүүлэхийн тулд бусдаас мөнгө зээлж авахдаа ирээдүйд бий болох, одоогоор бий болоогүй, өмчлөх эрх нь үүсээгүй үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалдаг.

Дээрх хоёр төрлийн барьцааны талаар Иргэний хуульд огт тусгагдаагүй биш харин бүдэг тусгагдсан гэж үзэхээр байна. Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3-т “Барьцаа үүсэх үед тодорхойлж болох, ирээдүйд бий болох, болзол тавьсан шаардлагыг хангахад барьцааг хэрэглэж болно” гэж заасныг зөвхөн барьцаагаар хангагдах шаардлагад биш харин барьцааны зүйлд хамааруулж ойлгох боломжтой юм. Өөрөөр хэлбэл, одоогоор өмчлөх эрх нь үүсээгүй хэдий ч ирээдүйд үүсэх боломжтой нь тодорхой болсон эд хөрөнгийн талаар өмчлөх эрх үүссэн тохиолдолд барьцааны шаардах эрх үүсэхээр болзол тавьсан барьцааны гэрээ байгуулж болохоор тусгагдсан байна. Энэ заалтыг илүү дэлгэрэнгүй болгох нь чухал ач холбогдолтой хэдий ч Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4-т оруулсан нэмэлтүүд нь дээр дурдсан харилцааг харамсалтай нь зохицуулж чадаагүй байна. Хуульд тусгагдсан одоогийн хэлбэр нь барьцааны гэрээний онцлог төрлийг тодотгож өгөөгүйгээс гадна харин бүр барьцааны гэрээний энгийн хэлбэрийг ч ойлгомжгүй болгосон байна. Үүнийг доорхи үндэслэлээр тайлбарлаж байна.

а/ Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэснийг үгийн шууд утгаар нь тайлбарлахад “барьцааны зүйл болох эд хөрөнгө нь бусдын өмчлөлд байгаа хэдий ч ирээдүйд барьцаалуулагчийн өмчлөлд шилжих бодит бололцоо бүрдсэн тохиолдолд барьцааны зүйл байж болно. Энэ тохиолдолд өмчлөх эрх барьцаалуулагчид шилжсэнээр барьцааны эрх үүснэ” гэж ойлгогдохгүй байна. Ямар нэгэн тодотголгүйгээр бусдын өмчлөлийн зүйлийг барьцаалж болно гэж тусгаж орхисноор тухайн эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг зөрчөөгүй гэж үзэх үндэслэл харагдахгүй байна. Энд тухайн өмчлөгчийн хүсэл зоригийн илэрхийлэл биш юмаа гэхэд ядаж зөвшөөрөл байх тухай чухал заалт огт хэрэггүй мэт орхигджээ.

б/ Барьцааны зүйл ирээдүйд барьцаалуулагчийн өмчлөлд шилжих боломжтой байх нь бусдын өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах цорын ганц тохиолдол биш юм. Барьцааны эд хөрөнгийн өмчлөгч, барьцаагаар хангагдах шаардлагыг биелүүлэх ёстой үүрэг гүйцэтгэгч хоёр өөр этгээд байх тохиолдол нь барьцааны гэрээгээр үүрэг үүсэх хамгийн түгээмэл тохиолдол билээ. “Барьцааны зүйл бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно” гэсэн зохицуулалт энэ тохиолдолд хамааралгүй гэж үзэх үндэслэл байхгүй байна. Энэ утгаар нь өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг бусдын үүрэгт барьцаалах хэлбэрээр захиран зарцуулахыг хүсвэл өмчлөх эрхээсээ татгалзаж, үүрэг гүйцэтгэгийг барьцаалуулагч болго гэсэн утга санаатай болсон хуулийн зохицуулалтыг Улсын дээд шүүх Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө...өмчлөх эрхтэй” гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзсэн юм.

в/ Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно” гэж зааснаар үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих асуудал зохицуулагдсан байна. Өмчлөх эрх шилжинэ гэдэг нь хэн нэгэнд үүсчихсэн өмчлөх эрх ямар нэгэн хэлцлийн үндсэн дээр бусдад шилжихийг хэлдэг байх. Гэтэл Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т “барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ”

гэсэн зохицуулалтыг өмчлөх эрх шинээр үүсэх тохиолдолд хамааруулж ойлгох нь учир дутагдалтай байна. Өөртөө барилга, байшин барих хүсэлтэй этгээд зээл авахдаа энэ мөнгөөр барих үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалж болно. Энэ тохиолдолд шинээр бий болсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх үүсэх асуудал яригдахаас биш өмчлөх эрх шилжих асуудал тавигдахгүй юм. Энэ утгаараа ирээдүйд бий болох тухайн эд хөрөнгө мөн л үүрэг гүйцэтгэгчийнх биш харин түүний хүлээх үүрэгт ирээдүйд бий болох өөрийн эд хөрөнгийг барьцаалсан гуравдагч этгээдийн өмчлөлийн эд хөрөнгө байхаар харагдаж байна. Тийм ч учраас өөрийн ирээдүйд бий болох эд хөрөнгийг бусдын гүйцэтгэх үүрэгт барьцаалах хэлбэрээр захиран зарцуулсан этгээд өмчлөх эрхээсээ татгалзаж, үүрэг гүйцэтгэгчийг барьцаалагч болго гэсэн утга санаа байна гэж Улсын дээд шүүх үзсэн юм.

г/ Барьцааны эрхийн зохицуулалт нь Иргэний хуулийн Арван гуравдугаар бүлэгт тусгагдсан ба энэ бүлэг нь гурван дэд бүлгээс бүрдэж байна. Нэгдүгээр дэд бүлэгт барьцааны нийтлэг зохицуулалт, хоёрдугаар дэд бүлэгт хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тусгай зохицуулалт, гуравдугаар дэд бүлэгт үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/-наас үүсэх харилцаа тус тус зохицуулагдсан байна. Барьцааны нийтлэг зохицуулалт нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн болон эрхийн барьцааны хувьд адил үйлчлэх бөгөөд тухайн дэд бүлгүүдэд тусгайлсан зохицуулалт байхгүй бол нэгдүгээр дэд бүлэгт туссан нийтлэг зохицуулалт үйлчилдэг билээ. Гэтэл бусдын өмчлөлд одоогоор байгаа боловч ирээдүйд үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд шилжих бодит бололцоо бүрдсэн барьцааны зүйл нь ирээдүйд бий болох эд хөрөнгө ч мөн адил зөвхөн үл хөдлөх эд хөрөнгөд хамааралтай юм. Учир нь эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэхийн зэрэгцээ барьцааны гэрээг ч бүртгүүлэх боломжтой болдог ба улсын бүртгэл нь үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагчийн хувьд шаардах эрхийн гол үндэслэл болдог. Хөдлөх эд хөрөнгийн хувьд болон эрхийн барьцаанд дээрх тохиолдол хамаардаггүй байхад хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны алинд ч хамааралтай нийтлэг зохицуулалтын хэсэгт тухайн зохицуулалт орох боломжгүй юм.

2/ Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т туссан “үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ” гэсэн заалт банк болон банк бус санхүүгийн байгууллагын хувьд хамаарахгүй байхаар Иргэний хуульд нэмэлт оруулсныг Улсын дээд шүүх Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш” байх зарчмыг зөрчсөн гэж үзэж, тайлбар гаргахдаа иргэн болон банк, банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн ерөнхий байдлыг ижил гэж үзээгүй болно.

Банк, банк бус санхүүгийн байгууллага нь иргэдээс эрх зүйн байдлаар өөр болох нь хэнд ч ойлгомжтой зүйл юм. Түүгээр ч зогсохгүй зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан үүрэг бүхий этгээдийн хувьд эдгээр байгууллагуудаас зээл олгох харилцааг иргэд хоорондын болон бусад хуулийн этгээд хоорондын зээлийн харилцааг зохицуулснаас өөрөөр зохицуулдаг билээ. Гагцхүү аливаа хуульд, тухайлбал, Иргэний хуульд зохицуулсан нийтлэг үндэслэлийн шинжтэй тусгайлсан зохицуулалт нь тухайн харилцаанд орж буй субъект болгонд ижил үйлчлэлтэй байх асуудлыг тайлбарласан билээ.

Жишээлбэл, иргэний эрх зүйн чадамж, хөөн хэлэлцэх хугацаа, хугацаа тоолох журам, үл хөдлөх эд хөрөнгийн ойлголт, үл хөдлөх эд хөрөнгө үүсэх үндэслэл гэх мэт ойлголтууд нь иргэнд ч, хуулийн этгээдэд ч хамааралтай ба тухайн этгээдийн эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж, түүний эрх зүйн чадамжийг өөрөөр тогтоох, хөөн хэлэлцэх хугацааг өөрөөр тоолох үндэсгүй юм. Түүнтэй ижил барьцааны эрх, барьцааны гэрээ байгуулах журам, барьцааны эд хөрөнгөөр шаардлага хангах ажиллагаа зэрэг нь иргэний эрх зүйн, тодруулбал эдийн болон эдийн бус баялгийн

эрхийн томоохон хэсэг бөгөөд эдгээр зохицуулалт нь үүргийн бусад төрөлд хамаарагдах тохиолдол бүрт тусгайлсан зохицуулалт болдог билээ. Банк зээлийн харилцаанд барьцааны гэрээ байгуулахдаа иргэд хоорондын зээлийн харилцаанаас өөр журмыг баримталдаггүй юм. Үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тухайн харилцаанд тавих шаардлагыг илүүтэй тодорхой болгох боломжтой хэдий ч Иргэний хуульд заасан хэм хэмжээтэй нийцэх учиртай юм.

Үл хөдлөх эд хөрөнгийг худалдах журмыг Иргэний хуульд заасан тохиолдолд барьцааны гэрээний харилцаанд орсон аливаа субъект энэ журмын дагуу үйл ажиллагаа явуулах нь тусгайлсан зохицуулалтын тухай хууль хэрэглээний дээрх зарчимд тулгуурлаж байгаагаас гадна Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т өөрт нь "... энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ" гэж зориудаар тодотгосон заалтад үндэслэгдэнэ. Ийм тодотгол байгаагүй ч үйлчлэх учиртай хууль хэрэглээний зарчмыг мөн хуульд өөрт нь заасан императив шинжтэй хэм хэмжээг зөрчин байж банк, банк бус санхүүгийн байгууллагын хувьд барьцааны үл хөдлөх эд хөрөнгийг худалдах өөр журам тогтоосныг зөвхөн тухайн субъектын эрх зүйн байдлаар тайлбарлах нь хэтэрхий гэнэн зүйл юм. Улс орныг батлан хамгаалах онцгой үүрэг бүхий этгээдийн хувьд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдгийг Иргэний хуульд зааснаас өөрөөр тайлбарлах, эрүүл мэндийн байгууллагын хувьд эрүүл мэндэд учирсан хохирол гэдгийг өөрөөр, барилгын байгууллагад бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг өөрөөр зохицуулахгүй гэдэгт эргэлзээ төрөхгүй байна. Аливаа ижил төрлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь хэн нэгэнд давуу эрх олгох, эсхүл эрхийг хязгаарласан агуулгатай байх учиргүй гэсэн үүднээс Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "хүн бүр хуулийн... өмнө эрх тэгш байна" гэсэн зарчмыг зөрчсөн гэж Улсын дээд шүүх үзсэн болно.

3/ Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т заасан зохицуулалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан зарчмуудыг зөрчөөгүй гэж үзэхдээ Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч бүртгэлийн байгууллагыг шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага биш гэж тодорхойлсонтой санал нэг байна. Гагцхүү хуулийн тухайн зохицуулалтаар энэ байдал хэрхэн тодорхойлогдож байгааг анхааралтай авч үзэх нь чухал юм.

Барьцааны эрх нь Иргэний хуулийн 87 дугаар зүйлд зааснаар барьцаагаар хангагдаж буй шаардлагын эрхээс салгаж үл болох эрх юм. Тийм ч учраас үндсэн үүргийн дагуу шаардах эрх байгаа эсэх, энэхүү үүргийн хэмжээ ямар байгааг эхлээд тогтоосны эцэст ямар хэмжээний үүргийг барьцааны зүйлийн үнээс гаргуулах вэ гэдгийг шүүх шийдвэрлэдэг. Барьцааны гэрээ байгуулагдсан л бол үндсэн үүргийн хүчин төгөлдөр байдал, түүний хэмжээ хамаагүй гэж үзэх боломжгүй юм. Барьцааны гэрээний өөрийнх нь хүчин төгөлдөр байдлыг ч шүүх тогтоосны эцэст барьцааны зүйлээс шаардлагыг хангуулах эсэхийг шийдвэрлэдэг. Бүртгэлийн байгууллага энэ байдлыг тодорхойлох эрхгүй бөгөөд үүрэггүй билээ. Тийм ч учраас барьцааны зүйл болох эд хөрөнгийг худалдан борлуулахад үүрэг гүйцэтгүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах эрхтэйгээр хуульд тусгасныг Үндсэн хуулийн "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн зарчмыг зөрчсөн гэж Улсын дээд шүүх үзсэн юм. Бүртгэлийн байгууллага нь хууль ёсны ч, хууль бус ч шаардлагын дагуу барьцааны үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг явуулахгүй байх. Энэ талаар зайлшгүй дүгнэлт хийх нь ойлгомжтой. Бүртгэлийн байгууллагын эрх зүйн талаар хийх дүгнэлтийн цар хүрээ нь шүүхийн эрх мэдлийн асуудал мөн гэдэгт гол анхаарлаа хандуулах нь чухал. Нөгөө талаар, "шүүхийн бус журмаар ипотекийн зүйлийг борлуулах ажиллагаанд оролцогч талууд ямар ч маргаангүй байх учиртай", эс тэгвээс шүүхэд хандах эрх нь нээлттэй гэж тайлбарт дурдагдсан байна.

Үүргийн харилцааны оролцогч талууд болон барьцааны гэрээний оролцогч талууд үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах талаар ямар ч маргаангүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах шаардлага байхгүй юм. Учир нь Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д “Ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй” гэж заасан нь үүрэг гүйцэтгүүлэгч банк нь өмчлөгчид шаардлага тавьж, тэрээр энэ шаардлагыг хүлээн зөвшөөрсөн / маргаангүй/ тохиолдолд шүүхийн ч, бүртгэлийн ч оролцоогүйгээр үл хөдлөх эд хөрөнгийн худалдах-худалдан авах гэрээгээр асуудлыг зохицуулах боломжтой юм. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн дагуу албадан дуудлага худалдаа явуулна гэж хуулийн 175 дугаар зүйлийн 175.1-д заажээ. Шүүхийн бус журмаар үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах нь нээлттэй гэж тайлбарт дурджээ. Оролцогч талуудын шүүхэд хандах эрхийг бүрмөсөн хаагаагүй нь үнэн. Гэхдээ Иргэний хуулийн энэ заалт Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэхдээ Улсын дээд шүүх тухайн харилцаанаас үүсэх сөрөг үр дагавар талаас нь биш харин хуулийн зохицуулалт сөрөг үр дагаврыг үүсгэх боломж бүрдүүлж байгаа талаас нь асуудлыг дэлгэсэн юм.

Монгол Улсын иргэний өмчид төр л хуульд заасан үндэслэлийн дагуу халдах эрхтэй ба энэ тохиолдолд ч нөхөн төлбөр олгох үүрэгтэй байдаг. Тэгвэл төр өөрийн баталж буй хуулиар төрийн хяналтад байдаггүй субъект болох банканд бусдын өмчлөлд халдах эрхийг олгож буй нь Үндсэн хуулийг зөрчсөн явдал гэж үзэж байна. Банк үндсэндээ багахан хэмжээний төлбөртэй байсан ч бусдын үл хөдлөх эд хөрөнгийг шууд, чөлөөтэй бөгөөд зөвхөн өөрийн төлбөрөө гаргуулах төдий үнээр буюу бодит үнээс доогуур худалдах боломжтой болно. Банк үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөтэй худалдах эрхтэй байгаа тохиолдолд зах зээлийн бодит үнээр зарагдах баталгаа байхгүй юм. Аливаа шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг төр эсвэл дор хаяж төрөөс эрх олгогдсон ямар нэгэн байгууллага шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэдэг ба үл хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрөө худалдан борлуулах боломжтой болгосноор Үндсэн хуульд тусгагдсан өмчлөх эрхийн баталгааг тойрч гарч байгаа арга гэж үзэх ч үндэстэй юм.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэжээ.

Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд хөрөнгөө шилжүүлэхгүйгээр өөрийн өмчлөлийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангаад үлдсэн хэсэгтээ өөрөө өмчлөгч хэвээр үлдэх, үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс үүргийг гүйцэтгээд барьцааны үүргээс чөлөөлөгдөж, өмчлөлийн зүйлээ өөрийн өмчлөлд хэвээр хадгалах, барьцааны зүйлийг хариу төлбөртэй буюу төлбөргүйгээр үүрэг гүйцэтгэгч бус өөр гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх замаар барьцааны үүргийг шинэ өмчлөгчид шилжүүлэх зэрэг эрхүүд нь барьцаалуулагчид нээлттэй байдаг. Энэ нь иргэний эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Иймд Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын хоёрдахь өгүүлбэр нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх... эрхтэй” гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

2. Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т “Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ. Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэжээ.

Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол Иргэний хуулиар зохицуулсан барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах журам огт хамаарахгүй гэж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол, үүрэг гүйцэтгэгч, эсхүл барьцаалуулагч болох үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч Иргэний хуульд заасан журмын дагуу барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах, шүүхийн шийдвэрийн дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах хүсэлт гаргасан ч гэсэн Иргэний хуулийн 175 дугаар зүйлд заасан журмыг баримтлах заалтыг хамаарахгүй гэж хуульчилсан учраас үүрэг гүйцэтгэгч болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

Иймд Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т "...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна..." гэснийг зөрчиж байна гэсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

3. Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т "Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй" гэжээ.

Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т зааснаар үүргийн нэг тал болох үүрэг гүйцэтгүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага дангаараа эрхээ хамгаалуулах этгээдийг өөрийн үзэмжээр сонгохоор зааж, харин үүргийн нөгөө тал болох үүрэг гүйцэтгэгч буюу үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч-барьцаалуулагчид сонгох боломж олгоогүй байгаа ба ийнхүү иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш оролцогч субъектуудын хувьд ялгавартай зохицуулсан нь тэгш эрхийн зарчим зөрчигдсөний зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...", Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан "...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно", Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй...", түүнчлэн талуудын шүүхэд хандах эрхийг нь хязгаарлан бүртгэлийн байгууллагад бүртгүүлж ипотекийн зүйлийг худалдан борлуулахаар заасан нь Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан "...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", мөн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан "...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсэгт "Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно", 154.4 дэх заалт "Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэсэн ийм тохиолдол байж болох бөгөөд хэн нэгний өмчлөх эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна" гэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн заалтын "Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх...эрхтэй"



гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалтын “Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, 174.3 дахь хэсгийн заалтын “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх...эрхтэй”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”, Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн заалтын “Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно”, 154.4 дэх хэсгийн заалтын “Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ...өмчлөх...эрхтэй” гэснийг зөрчөөгүй байна.

3. Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-ын “Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ...” гэсэн заалт, 174 дүгээр зүйлийн 174.2-ын “...барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн заалт болон 174 дүгээр зүйлийн 174.3-ын “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн заалтын үйлчлэлийг 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/04 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 30 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн заалтын “Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх...эрхтэй” гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн заалтын “Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, 174.3 дахь заалт “Үүрэггүйцэтгүүлэгч нь банк,

банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүллгэх...эрхтэй”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”, Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2/04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

### **Тэмдэглэл:**

Улсын Дээд шүүх Цэцэд хүсэлт гаргах эрхтэй субъектүүдийн нэг. Үүрэгтэй ч гэж ойлгож болно. Шүүх хууль Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэх эрхгүй. Өөрөөр хэлбэл аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэх явцдаа тухайн хэрэглэж буй хууль нь Үндсэн хууль зөрчсөн байх магадлалтай байвал зохих журмын дагуу хүсэлт гарган Үндсэн хуулийн цэцэд хандах үүрэгтэй. Энэ үүргээ Цэцэд хүсэлт гаргах эрхтэй субъектүүд дотроос харьцангуй сайн биелүүлж байгаа нь Улсын Дээд шүүх билээ. Үндсэндээ Улсын Дээд шүүхээс гаргасан хүсэлтийн 90-ээс дээш хувь нь Цэцийн дүгнэлтээр баталгааждаг. Учир нь, Улсын Дээд шүүхийн хүсэлт мэргэжлийн хуульчдын хамтын шийдвэрт үндэслэгддэг, хүсэлтийн үндэслэл нь оновчтой, хууль зүйн үр дагаврыг онолын болоод практиктай хослуулан гаргадаг.

Эд хөрөнгийн барьцаалах, ирээдүйд өмчлөх эрх нь бий болох өмчлөх эрх нь шилжиж ирэх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах гэдэг нь байж болох зүйл төдийгүй энэ талаархи зохицуулалтыг 1994 оны болон 2002 оны Иргэний хуульд зохицуулчихсан харилцаа. Хууль тогтоох замаар өмнө байсан харилцааг илүү боловсронгуй, илүү нарийвчилсан, хоёрдмол утгагүйгээр зохицуулж, нийгмийн харилцаандаа уялдуулж шинэчлэх нь Улсын Их Хурлын бүрэн эрх ч энэ тохиолдолд урьд байснаасаа дордуулж, Үндсэн хууль зөрчсөн зохицуулалт хийсэн байна. Материаллаг эрх зүйн харилцаанд үндэслэсэн процессийн хэм хэмжээ үүсдэг нь эрх зүйн суурь онол. Гэтэл Улсын Их Хурал материаллаг эрх зүйн харилцаагаа зохицуулсан ипотекийн хуулиа батлаагүй атлаа процессийн шинжтэй тодруулбал, ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах хуулийг баталж, улмаар процессийн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь хууль тогтоох ажиллагаа системгүй, шат дараалалгүй явагдаж байгаагийн нотолгоо юм.

Мөн хууль тогтоогчийн дурдаад байгаа “гэрээний эрх чөлөө” гэдэг ойлголт бас хязгааргүй эрх чөлөөг илэрхийлдэггүй. Тэрхүү эрх чөлөөний хязгаар нь тухайн гэрээг байгуулах буюу гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хүртэл байна. Харин түүнээс цааш гэрээний эрх чөлөө бус гэрээний эрх, үүрэг талуудад үүсдэг зүй тогтолтой.

Цэц Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-ын “Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлт шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэсэн хэсгийг үндсэн хууль зөрчсөн байна гэж дүгнэсэн хэрнээ уг зүйлийн 154.4-ийн “Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэснийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнэсэн нь Цэцийн дүгнэлт учир шалтгаан, үр дагавар, хууль зүйн үндэслэлийн хувьд авцалдаа муутай, үндэслэлгүй болсон гэж үзэж байна. Хууль зүйн томъёолол талаас нь хүртэл 154.4-т буй “...бий болж...” гэснээс бусдад нь 154.3-тай ижил бичиглэлтэй байгааг харж болно.

Үндсэндээ Цэц агуулгын хувьд ижил хуулийн заалтад хоёр өөр дүгнэлт гаргасан. Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн Цэцийн дүгнэлтийн үндэслэл ч хүлээн зөвшөөрөхөд бэрхшээлтэй болох нь анзаарагдана. Үндэслэл хэсгийн 4-т "...тохиолдол байж болох бөгөөд энэ нь хэн нэгний өмчлөх эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна" гэсныг Та тогтоод уншаад үзээрэй. Энэхүү дүгнэлтээс Цэц хэн нэгний өмчлөх эрх нь зөрчигдсөн бодитой факт байгаа тохиолдолд л холбогдох хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шийдвэрлэнэ гэсэн логик гаргалгаа үүсэхийг ч үгүйсгэхгүй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2006.06.15 № 02**

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргагч - Улсын дээд шүүх, түүнийг төлөөлж Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн А., Улсын дээд шүүхийн шүүгч Д.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

Дэлхийн улс орнуудын жишгээс харахад ипотекийн зүйлийг шүүхийн болон шүүхийн бус журмаар худалдан борлуулдаг хоёр арга байдаг бөгөөд манай улсын хувьд Иргэний хуульд заасны дагуу ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах аргыг хэрэглэж ирсэн. Практикт ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахад дунджаар нэг жил орчим хугацаа зарцуулахын зэрэгцээ зардал их гардаг ба энэ нь зээлдэгч болон зээлдүүлэгчийн аль алинд нь ашиггүй байдаг байна. Учир нь зээлдүүлэгч нь энэ хугацаанд зээлсэн мөнгөө эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй болдог ба зээлдэгч нь ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулах ажиллагааны явцад гарах тэмдэгтийн хураамж, шийдвэр гүйцэтгэлийн урамшуулал, хөрөнгийн үнэлгээ хийлгэх зэрэгтэй холбогдсон бүхий л зардлыг төлөх шаардлагатай болдог байна.

Иймд талуудын аль алиных нь эрх ашгийг харгалзан зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор зээлдэгчийн барьцаалуулсан үл хөдлөх хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах зардал багатай, шуурхай аргыг бий болгох үзэл баримтлалаар боловсрогдсон Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж, уг хуулийг баталсан бөгөөд түүнд нийцүүлсэн Иргэний хуульд холбогдох өөрчлөлтийг оруулсан юм.

Түүнчлэн Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, орон сууцны үндэсний хөтөлбөр, үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг төрийн бодлогын баримт

бичгүүдэд тусгагдсан гэр бүлд зориулсан үл хөдлөх эд хөрөнгө, ялангуяа орон сууцны зээлийн тогтолцоог бүрдүүлэх, урт хугацааны зээл, ипотекийн аргыг нэвтрүүлэх замаар иргэдээ орон сууцаар хангах зорилтыг шийдвэрлэх, нөгөө талаар нийгэмд нэгэнт үүсээд байгаа харилцааг зохицуулахад Иргэний хуульд оруулсан ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахтай холбогдсон нэмэлт, өөрчлөлтүүд нь чухал ач холбогдолтой гэж Улсын Их Хурал үзэж байна.

2. Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч нарын тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд гаргасан тайлбараа дэмжиж байна. Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд гаргасан хүсэлтийн нэг гол агуулга бол хүн бүр эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрх нээлттэй байх ёстой. Энэ эрхийг хязгаарлах эрх хэнд ч байх ёсгүй гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэжээ.

Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд хөрөнгөө шилжүүлэхгүйгээр өөрийн өмчлөлийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангаад үлдсэн хэсэгтээ өөрөө өмчлөгч хэвээр үлдэх, үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс үүргийг гүйцэтгээд барьцааны үүргээс чөлөөлөгдөж, өмчлөлийн зүйлээ өөрийн өмчлөлд хэвээр хадгалах, барьцааны зүйлийг хариу төлбөртэй буюу төлбөргүйгээр үүрэг гүйцэтгэгч бус өөр гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх замаар барьцааны үүргийг шинэ өмчлөгчид шилжүүлэх зэрэг эрхүүд нь барьцаалуулагчид нээлттэй байдаг. Энэ нь иргэний эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Иймд Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн заалтын хоёр дахь өгүүлбэр нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх... эрхтэй” гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

2. Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т “Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ. Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэжээ.

Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол Иргэний хуулиар зохицуулсан барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах журам огт хамаарахгүй гэж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол, үүрэг гүйцэтгэгч, эсхүл барьцаалуулагч болох үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч Иргэний хуульд заасан журмын дагуу барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах, шүүхийн шийдвэрийн дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах хүсэлт гаргасан ч гэсэн Иргэний хуулийн 175 дугаар зүйлд заасан журмыг баримтлах заалтыг хамаарахгүй гэж хуульчилсан учраас үүрэг гүйцэтгэгч болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

Иймд Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн заалтын “...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...” гэснийг зөрчиж байна гэсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

3. Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т “...Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан

борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэжээ.

Иргэний хуулийн 174 дүгээрзүйлийн 174.3-т зааснаар үүргийн нэг тал болох үүрэг гүйцэтгүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага дангаараа эрхээ хамгаалуулах этгээдийг өөрийн үзэмжээр сонгохоор зааж, харин үүргийн нөгөө тал болох үүрэг гүйцэтгэгч буюу үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч-барьцаалуулагчид сонгох боломж олгоогүй байгаа ба ийнхүү иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш оролцогч субьектүүдын хувьд ялгавартай зохицуулсан нь тэгш эрхийн зарчим зөрчигдсөний зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...”, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “... хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “... эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй...”, түүнчлэн талуудын шүүхэд хандах эрхийг нь хязгаарлан бүртгэлийн байгууллагад бүртгүүлж ипотекийн зүйлийг худалдан борлуулахаар заасан нь Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан “... шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, мөн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсгийн “... Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх ...эрхтэй” гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн “...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, мөн хуулийн 174.3 дахь хэсгийн “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14-д заасан “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх ...эрхтэй”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”, Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 2/04 дүгээр дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

## **Тэмдэглэл:**

Цэцийн их суудлын хуралдаанаар маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэхийн сацуу Улсын Их Хурлын тогтоолын үндэслэлийг давхар хянаж үздэг. Энэ тохиолдолд Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж хүлээн зөвшөөрөх эсэх тухай тогтоол гаргахдаа процедурын алдаа гаргасан. Учир нь, Цэцийн 2006 оны 4 дүгээр дүгнэлтийн 2 дахь хэсэгт Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4 дэх хэсгийн заалтыг бүхэлд нь Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж шийдвэрлэсэн боловч дүгнэлтийн энэ хэсгийг хүлээн зөвшөөрсөн эсэх нь Улсын Их Хурлын тогтоолд тусгагдаагүй болно. Уг тогтоол 1 заалттай бөгөөд тэрхүү заалтын төгсгөлийн хэсэгт "... Цэцийн 2006 оны 4 дүгээр тогтоолыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" байна. Эндээс дүгнэхэд Улсын Их Хурлын, Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн Цэцийн дүгнэлтийн холбогдох заалтыг ч хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн мэт.

Цэцийн энэхүү тогтоол нь эрх зүйн хамгаалалтын шүүхийн бус хэлбэрийг үгүйсгэж байгаа хэрэг бус. Улс бүрт л энэ хэлбэрийг эрх зүйн систем, өөрийн улс орны онцлог, түүх, заншилдаа хослуулан адил хийгээд ялгаатай байдлаар хуульчилсан нь бий. Эрх зүйн хамгаалалтын шүүхийн хэлбэр бол ойлгомжтой. Энэ бол мэдээж шүүх. Харин шүүхийн бус хэлбэрт арбитр, зарим орны хөндлөнгийн шүүх болон шүүхээс өмнө эвлэрүүлэн зуучлах төв зэргийг дурдаж болно. Үнэндээ нотариатын үйл ажиллагаа ч бас л энэ хэлбэр рүү илүү ойр. Гэхдээ аль ч оронд эрх зүйн хамгаалалтын шүүхийн хэлбэрийг хамгийн баталгаатай, хамгийн найдвартай, хамгаалалтын хэлбэр гэж үздэг байна. Тийм ч учраас ардчилсан орон бүр иргэний шүүхэд хандах, шударга шүүхээр шүүллэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг Үндсэн хуульдаа тусгайлан хуульчилж баталгаажуулдаг билээ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.05.31 № 05**

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай  
хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн  
хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Э.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль<sup>78</sup>

- 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг "Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана"

78 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

- 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг “Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ”

- 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг “Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ”

- 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг “Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 26.3-т заасны дагуу нам, эвслийг бүртгэхээс татгалзсан асуудлаар гарсан маргааныг 14 хоногийн дотор, тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, 30.10-т заасны дагуу нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, тойргийн хороо 30.17, 30.18, 37.18, 40.7, 41.9-д заасны дагуу нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүнчлэн санал хураалтыг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус эцэслэн шийдвэрлэнэ”

- 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсэг “Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум буюу сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”

- Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ”

- Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Э.-гийн мэдээллийн агуулга:

1/ 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтын дагуу холбогдох сонгуулийн хороодын гаргасан шийдвэр нь Улсын Их Хурлын сонгуультай холбогдсон зарим маргааны хувьд эцсийн шатны шийдвэр байх агуулгаар

зохицуулагдсан нь, мөн уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн заалтаар иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд органик хуулиар тавигдаж буй нийтлэг шаардлага болон захиргааны журамтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэрийн талаарх маргааныг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт нь иргэн, хуулийн этгээд, өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандах үндсэн эрхийг ямарваа нэгэн хэлбэрээр, тэр дундаа Үндсэн хуулийн бус үндэслэлээр хууль гаргаж хязгаарлах, хасахыг хориглосон Үндсэн хуулийн баталгаа мөн.

Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтаар, тухайлбал иргэний сонгох эрхтэй холбогдсон гомдол нь холбогдох сонгуулийн хороонд гомдлоо гаргаснаар хязгаарлагдаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасны дагуу шүүхэд хандах эрхээ хасуулахад хүргэж байна.

Мөн энэхүү заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын Монгол Улсын иргэн “төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэснийг зөрчсөн. Учир нь Улсын Их Хурлын сонгуулийн шинэчилсэн хуулийн 57 дугаар зүйлийн “Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргааныг шийдвэрлэх харьяалал” гэсэн малгай гарчгийн дор багтаж буй 57.1 дэх хэсгийн заалтад иргэний сонгох эрхтэй холбогдсон гомдлыг холбогдох сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэх хүрээнд хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан иргэний сонгох эрхийг зарим талаар хязгаарлахад хүрч байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан эрх нь сонгуулийн хороодын шийдвэрээр зөрчигдсөн гэж үзвэл Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасны дагуу шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг нь хассан байна.

2/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн заалт зөрчигдсөн тухай маргаан бус харин органик хуулийн нэн тодорхой заалт зөрчигдсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д “Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн” хэмээн заасан. Үүнтэй холбогдуулан Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих гэдэгт юуг хамааруулж ойлгох талаар зайлшгүй хөндөх шаардлага гарч байна. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих гэдэгт юуны өмнө уг маргаан нь Үндсэн хуульд өөрт нь заасан ёсоор хууль зүйн хамгийн дээд хүчин чадалтай акт болох Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай маргаан байх, маргааны хэмжүүр нь гагцхүү Үндсэн хууль өөрөө байх, түүнчлэн маргааны зүйл нь төрийн хамгийн дээд байгууллага, түүний өндөр зиндааны албан тушаалтны үйл ажиллагаа байх гэсэн үзүүлэлтүүд хамаарна. Энэ шалгуурт тэнцэж байвал Үндсэн хуулийн биелэлтэд тавьж буй дээд хяналт болно гэж үзэж байна. Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтаар Үндсэн хуулийн цэцийн маргааны хэмжүүр нь Үндсэн хуулийн зүйл, заалт бус, зөвхөн



органик хуулийн маш тодорхой зүйл, заалтаар хэмжүүр хийх зайлшгүй шаардлагыг Цэцэд тулгасан байна. Учир нь маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах шаардлага, шалгуур, журам нь Үндсэн хуульд бус харин органик хуульд өөрт нь маш дэлгэрэнгүй агуулагдаж байгаад оршино. Энэ нь ч зүйн хэрэг. Тэдгээр нь ердийн хуульд байвал зохих нийтлэг шаардлага, журам учраас түүнтэй холбогдсон маргаан нь үнэн хэрэгтээ Үндсэн хуулийн бус маргаан юм. Ийм шинж бүхий маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийн дээд хяналтын ач холбогдлыг бууруулахад хүргэх бөгөөд ингэснээр Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болох шинжээ алдахад хүрнэ.

Ийм болон бусад үндэслэлээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн байна. Үүн дээр нэмж Цэцийн өөрийнх нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй” хэмээн тов тодорхой заасныг Цэцийн жишиг хэмээн үзэж иш татан нотолгоо болгож байна.

3/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь заалтаар Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан шийдвэрийн талаарх маргааныг бүхэлд нь Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар харьяалуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг болон мөн зүйлийн 2 дахь хэсгийн эхний заалтыг тус тус зөрчсөн. Учир нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т буй “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”-ийг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргах үндэслэл нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний заалтын дагуу Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан байх явдал юм.

Энэ шаардлага нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн “Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналт” гэсэн 8 дугаар зүйл болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн “Маргааны харьяалал” гэсэн 13 дугаар зүйлд тус тус Үндсэн хуульд заасны дагуу зохих ёсоор хуульчлан баталгаажсан байна. Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5 дахь заалтад Үндсэн хуулиар үг, үсэгчлэн хэлж, зориуд тогтоосон Үндсэн хуулийн цэцэд харьяалагдах маргааны гол шалгуур болох “Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан” гэдэг шаардлагыг органик хуулийн энэ заалтад гээж, орхигдуулжээ. Үүний улмаас Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг Сонгуулийн ерөнхий хороо зөрчсөн тухай өргөдлийг Үндсэн хуулийн цэц хүлээн авахаас өөр замгүй болгож байгаа нь энэ заалтын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл мөн гэж үзэж байна. Ингэснээр Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн бус маргааныг шилжүүлж байгаа хэрэг болох бөгөөд үүний улмаас Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтууд давхар зөрчигдөж байна.

Дээрх үндэслэлүүдийг анхааран үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт болон мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9; Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний догол мөрийн заалтад тус тус нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье.

4/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т буй “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсний, “шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн.

Үндсэн хуулийн эл заалт хууль тогтоох эрх мэдлийн үйл ажиллагаанд ч нэгэн адил баримтлагдах учиртай Үндсэн хуулийн суурь зарчим мөн.

Хууль дээдлэх зарчим нь парламентаас баталсан хуулийг нийтээр дагаж мөрдөх болон хууль нэг мөр хэрэгжих ёстой гэх ойлголтоос илүү өргөн хүрээтэй буюу хууль нь бодит зүй тогтолд тулгуурласан, түгээмэл шинжийг агуулж байх, хууль хүлээн зөвшөөрөгдөхүйц, итгэл үнэмшил төрүүлэхүйц байх ёстой гэдэг гүн гүнзгий утга агуулгыг шингээсэн ойлголт болно. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь заалт нь хуулийн бодит зүй тогтолд тулгуурлаагүй, түүний түгээмэл шинжийг алдагдуулсан байх бөгөөд томъёолол нь хууль тогтоогчийн дур зоргын илрэл байх шинжийг агуулж байгаагаараа хуулийн бодит чанарыг олоогүй байна. Үүнд тухайлбал, уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь хэсгийн заалтуудаар Улсын Их Хурлын сонгуультай холбоотой эрх зүйн зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх журам, хэргийн харьяаллыг буюу аль шүүх хянан шийдвэрлэхийг шууд, нэг бүрчлэн заан тогтоосон нь хуулийн бодит чанарыг алдагдуулж, түүний түгээмэл зүй тогтлыг зөрчсөн байна. Хэрэг, маргааны харьяаллыг тухайн процессын гол хуульд нь зааж, үүнтэй холбогдон үүссэн шүүх хоорондын маргааныг дээд шатных нь шүүх түүнчлэн Үндсэн хуулийн цэц зохих хууль, журмын дагуу шийдвэрлэдэг нь хуулийн бодит чанар мөн бөгөөд дэлхий нийтэд тогтсон түгээмэл зүй тогтол болно. Гэтэл хууль тогтоогч үүнийг анхаараагүй нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэдэг дүгнэлтэд хүргэж байна. Үүнийг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсгийн заалтад ч нэгэн адил хамааруулж байна.

Дээрх үндэслэлийг анхааран үзэж Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.6 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтад тус тус нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

1/ Олон улсын Хүний эрхийн Пакт, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан иргэний улс төрийн гол эрх буюу “сонгох, сонгогдох” эрхийн баталгааг хангах, иргэнээс энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, түүнийг гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар зохицуулдаг билээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийг зохион байгуулж явуулдаг байгууллагын гол үүрэг бол Үндсэн хуулиар заасан иргэний улс төрийн эрхийн баталгааг бүрэн ханган биелүүлэх явдал юм. Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн хороодыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар ханган ажиллахдаа захирах, захирагдах зарчим буюу доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шатлан захирагдах төрийн захиргааны эрх зүйн ерөнхий зарчмыг иш үндэс болгодог тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10-т “Хуульд өөрөөр заагаагүй бол хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ”, 57.1-д сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргаж байхаар хуульчилсан.

Сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан асуудалтай холбогдсон гомдолтой холбогдуулан зохих шатны сонгуулийн хорооноос гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Үндсэн хуульд заасан эрхийнхээ дагуу иргэн шүүхэд хандах эрх нь нээлттэй байгаа болно. Өөрөөр хэлбэл, хуулийн 57.1 дэх заалтаар шүүхэд гомдол гаргах иргэний эрхийг ямар нэг байдлаар хязгаарлаагүй, зөвхөн доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийг дээд шатны сонгуулийн хороо хянан шийдвэрлэх харьяаллыг тогтоож өгсөн юм.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”-тэй холбогдсон маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.5-д Монгол Улсын Үндсэн хуульд заасан “сонгуулийн төв байгууллагын шийдвэр” гэдэгт юуг хамааруулахыг нарийвчлан зохицуулсан юм.

Сонгуулийн ерөнхий хороо бол Улсын Их Хурлаас байгуулагдаж, сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан бүх шатны сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах, Улсын Их Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох, тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн асуудлаар гаргасан өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байгууллага билээ.

Түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны талаар заасан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцээс 2005 онд гаргасныг анхаарч үзсэн. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалтыг хийсэн болно. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.1, 57.5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж товлосон цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийг улс даяар нэгэн зэрэг саадгүй явуулах үндэс болдог хэмээн үздэг. Иймд сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэг өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуулийн дагуу Сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил үүссэн бол сонгуулийн төв байгууллагын шийдвэр гаргал сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргааныг шүүх, эсхүл хөндлөнгийн өөр нэг байгууллага авч хэлэлцэхгүй байх нь дээрх ерөнхий үзэл баримтлалд нийцэх юм.

Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 3/83 дугаар албан бичигт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1.1-д заасан “аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн албан тушаалтнаас” гэсний “байгууллага” гэдэгт Сонгуулийн ерөнхий хороог хамааруулахгүй байх үндэслэлгүй юм. Сонгуулийн ерөнхий хороонд холбогдох, Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн талаар гаргасан иргэдийн гомдлыг ерөнхий харьяаллын дагуу шүүх хянан шийдвэрлэх боломжтой гэж үзнэ гэжээ. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д байгаа, сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гарган, улмаар Сонгуулийн ерөнхий хорооноос гарсан Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн шийдвэрийг шүүхийн журмаар хянуулах боломж нээлттэй байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал харьяаллын дагуу

шийдвэрлэхээр уг хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, 57.5 дахь хэсэгт заасан нь өнөөгийн практикт шүүхийн харьяаллын давхардлыг үүсгэхээс сэргийлсэн заалт байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Хөрөнгийг улсын орлого болгох тухай шийдвэрийг Сонгуулийн төв байгууллага шууд гаргаж байгаа нь бусдын өмчлөх эрхэд шүүхийн бус замаар халдсан шинжийг агуулжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.5 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийн “Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум буюу сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсгийн заалтын үйлчлэлийг 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

5. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 5 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 58 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.6 дахь хэсгийн “Энэ хуулийн 41.9, 42.8-д заасан хөрөнгийг улсын орлого болгох шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргах ба энэ талаар гомдол гарвал сум буюу сум дундын, дүүргийн шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 5 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

## **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлаас баталсан хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэх Цэцийн хуралдаанд маргагч тал болох хууль тогтоогч өөрийн байр сууриа илэрхийлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Гэтэл төрийн эрх мэдэл хуваарилах онолын нэг салаа болох гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу Засгийн газрын албан тушаалтан хууль тогтоогчийн байр сууриас маргаанд оролцож байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй.

Сонгуулийн ерөнхий хороо доод шатны сонгуулийн хороодын зохион байгуулалт удирдлагаар хангадаг байгууллага. Тойргийн болон хэсгийн хорооноос гаргасан шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гэж үзэх үндэслэлгүй. Тэгээд ч Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан Үндсэн хуулиас бусад хууль зөрчсөн эсэх тухай шийдвэрийг шүүх ерөнхий харьяаллын дагуу хянан шийдвэрлэх боломжтой байна.

Сонгох, сонгогдох эрх аль аль нь Үндсэн хуулиар олгогдсон иргэний улс төрийн эрх. Иймд сонгох, сонгогдох эрхийн талаархи Сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэрийг Үндсэн хуульд харьяалуулсны дагуу Цэц хянан хэлэлцэх ёстой. Түүнээс сонгогдох эрх нь зөрчигдсөнөөс үүссэн маргааныг Цэц, харин сонгох эрх зөрчигдсөнөөс үүссэн маргааныг ердийн шүүх шийдвэрлэдэг байж хэрхэвч таарахгүй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.06.14 № 06**

**Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргагч - Улсын дээд шүүх, түүний итгэмжилсэн төлөөлөгч Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б., шүүгч Б., Иргэний хэргийн танхимын тэргүүн А., Захиргааны хэргийн танхимын тэргүүн З.;

Хүсэлт гаргач - Улсын ерөнхий прокурор, түүний итгэмжилсэн төлөөлөгч - Улсын ерөнхий прокурорын туслах мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч- Улсын Их Хурлын гишүүн Д.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн бацаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай хууль<sup>79</sup>

<sup>79</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

- 1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дараахь зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/178 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“178.4.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хөнгөн гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 4 хоногт, хүндэвтэр гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 7 хоногт багтаан явуулна”

2/225 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“225.5.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамжийг хэрэг шүүхэд ирснээс хойш 3 хоногийн дотор гаргана”

3/233 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“233.2.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарсан өдрөөс эхлэн 3 хоногоос хэтрүүлэхгүйгээр шүүх хуралдаанаар хэлэлцэнэ”

4/302 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“302.4.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар гарсан шийтгэх ба цагаатгах тогтоолын хувийг уншин сонсгосон өдөрт нь багтаан прокурор, шийтгүүлсэн буюу цагаатгагдсан этгээд, хохирогчид гардуулан өгнө”

5/304 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“304.4.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаархи шүүхийн тогтоолд давж заалдах гомдол, эсэргүүцлийг 3 хоногт багтаан гаргана”

6/309 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“309.4.Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хэргийг хүлээн авсан өдрөөс эхлэн 5 хоногийн дотор хянан хэлэлцэнэ”

7/346 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“346.4. Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг шүүх хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ”

- 2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай / шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

- 1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/166 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“166.7.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай шүүгчийн шийтгэврийн талаархи болон сонгуулийн холбогдолтой хэрэгт давж заалдсан гомдлыг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ”

2/174 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“174.2.Сонгуулийн холбогдолтой хэргийг хяналтын шатны шүүх хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль / шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль

- 1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн дараахь зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, зүйл нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“11.6.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шалгах ажиллагааг шүүгч 7 хоногт багтаан явуулна”

2/19 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“19.8.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэрт 3 хоногийн дотор гомдол гаргаж болох ба давж заалдах гомдлыг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасны дагуу хянан шийдвэрлэнэ “

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Монгол Улсын ерөнхий прокурор А.-гийн хүсэлтийн агуулга:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 178 дугаар зүйлийн 178.1-д хэрэг бүртгэх ажиллагааг хөнгөн гэмт хэрэгт 14 хоног, хүндэвтэр гэмт хэрэгт 30 хоногт явуулна гэж заасан атал Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай хуулиар уг хуулийн 178 дугаар зүйлд “Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хөнгөн гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 4 хоногт, хүндэвтэр гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 7 хоногт багтаан явуулна” гэсэн 4 дэх хэсэг нэмсэн нь байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нарын хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласнаас гадна хэрэг бүртгэлт явуулах үндсэн хугацаатай нийцээгүй байна.

Өөрөөр хэлбэл хөнгөн буюу хүндэвтэр ангилалд хамаарах гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч нь хэрэг шалгах хугацааны дотор эрх, үүргээ хэрэгжүүлэх ижил нөхцөл, боломжтой байх эрхийг боогдуулж алагчлал ялгавартай тогтоосон шинжтэй болжээ.

Нийт хөнгөн, хүндэвтэр хэргүүдээс тусад нь зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 130 дугаар зүйлд заасан “Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх”, 131 дүгээр зүйлд заасан “Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах” гэмт хэргийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг хэт багасгаж бууруулснаар Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчөөд зогсохгүй хэргийн байдлыг тал бүрээс нь бодитойгоор тогтоож шийдвэрлэх боломжгүй гэж үзэж байна.

## 2. Улсын дээд шүүхийн хүсэлтийн агуулга:

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт буюу уг хуулийн 225 дугаар зүйлийн 225.5, 233 дугаар зүйлийн 233.2, 302 дугаар зүйлийн 302.4, 304 дүгээр зүйлийн 304.4, 309 дүгээр зүйлийн 309.4, 346 дугаар зүйлийн 346.4-т Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар хэрэг бүртгэлт явуулах, уг хэргийн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх, шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг хэт багасган тогтоосон нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой зүйл, заалтад шинээр оруулсан нэмэлтийг ижил төрлийн харилцааг зохицуулж буй мөн зүйлийн тухайн зүйл хэсэгтэй харьцуулан үзвэл жишээ нь, бусдад эд зүйлээ дээрэмдүүлсэн хэргийн хохирогч "А"-гийн гомдлоор эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 309 дүгээр зүйлийн 309.1-д зааснаар давж заалдах шатны шүүх 30 хоногийн дотор, харин сонгогдох эрх нь зөрчигдсөн гэх хэргийн хохирогч буюу нэр дэвшигч, эсвэл Сонгуулийн хорооны гишүүний гомдлоор "Б"-гийн хэргийг шинээр оруулсан нэмэлт буюу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 309 дүгээр зүйлийн 309.4-д зааснаар давж заалдах шатны шүүх 5 хоногийн дотор хэлэлцэх журамтай болжээ.

Ийнхүү Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан дээрх нэмэлтүүд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэнтэй зөрчилдөж байна.

2/ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтийн дагуу тухайлбал, хэрэг бүртгэгч хөнгөн гэмт хэрэг бүртгэлтийг 4 хоногт багтаан явуулах ба харин анхан шатны шүүх уг хэргийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарсан өдрөөс эхлэн 3 хоногоос хэтрүүлэхгүйгээр шүүх хуралдаанаар хэлэлцэх болсон нь Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тэдгээрийн өмгөөлөгч нотлох баримт шалгуулах хүсэлтээ гаргах боломжийг хязгаарлаж байгаагаас гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос ийм хүсэлт гаргасан тохиолдолд ч хэрэг бүртгэгч болон шүүх цаг хугацааны хувьд уг хүсэлтийг хүлээн авч хангаж чадахгүйд хүргэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтийн дагуу Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт явуулах, шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх маш богино, хязгаарлагдмал хугацааг тогтоосон нь хэргийн бодит үнэнийг тогтоох гэсэн зарчмыг хэрэг бүртгэлт хийгээд шүүхийн үйл ажиллагаанаас ангид байлгаж, улмаар тухайн иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхээ бодитой эдлэх боломжийг хязгаарлах нөхцөлийг бий болгож байна. Ийм учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан дээрх нэмэлтүүд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэн заалтыг зөрчиж байна.

3/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлд "Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай шүүгчийн шийтгэврийн талаарх болон сонгуулийн холбогдолтой хэрэгт давж заалдсан гомдлыг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан шийдвэрлэнэ" гэсэн нэмэлтийг уг зүйлийн 7 дугаар хэсэг болгон оруулжээ.

Захиргааны хариуцлага хүлээлгэх тухай анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргах журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлүүдэд тусгагдсан ба шүүгчийн шийтгэвэрт 10 хоногийн



дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргахаар зохицуулагдсан байдаг. Энэ гомдлыг нь тухайн шатны шүүх 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж, тогтоол гаргах ба уг тогтоол нь эцсийн шийдвэр байхаар заасан байна. Үүнээс гадна, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т “энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ” гэж заажээ. Түүнчлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлд давж заалдах шатны шүүхээр хэлэлцэгдэх гомдлын хүрээ хязгаарыг тодорхойлохдоо “анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрт... давж заалдах гомдол гаргах”-аар тусгасан бөгөөд аймаг, Нийслэлийн давж заалдах шатны шүүхүүд захиргааны хариуцлага хүлээлгэсэн анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэврийг давж заалдах журмаар хянадаггүй билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлд орсон дээрх нэмэлт сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдийн зөрчилд захиргааны шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэврийг хянах журмыг бусад төрлийн захиргааны зөрчлийн талаар гарсан шийтгэврийг хянах журмаас өөрөөр тогтоосон ба энэ нь шүүгчийн шийтгэврийг хянах шүүхийн тогтолцоог эвдэж, мөн хуулийн бусад зүйл, заалттай зөрчилдөж байгаагаас гадна Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Захиргааны зөрчил гаргаж, шүүгчийн шийтгэврээр шийтгэл хүлээсэн аливаа этгээдийн гомдлыг анхан шатны шүүх хэлэлцдэг байхад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн гомдлыг аймаг, нийслэлийн шүүх хэлэлцэх ямар үндэслэл байгаа нь ойлгомжгүй болжээ. Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчлийг бусад хуулийн зөрчлөөс илүү чухал гэж үзэх, эсхүл тухайн зөрчил гаргагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч буюу түүнийг дэмжигч тул бусад зөрчил гаргагчдаас илүү ач холбогдолтой гэж үзэх нь “хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал, ... үзэл бодлоор нь... ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмыг хөндөж байна гэж Улсын дээд шүүх үзнэ.

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай шүүгчийн шийтгэвэрт гарсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171, 161, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т заасан зохицуулалтыг баримталж, анхан шатны шүүх хэлэлцэх, эсхүл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7-д заасны дагуу давж заалдах шатны шүүх хэлэлцэх нь ойлгомжгүй байгаагаас Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “шүүгч... гагцхүү хуульд захирагдана” гэсэн зарчмыг шүүх бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломжгүй болж байна.

4/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлд “сонгуулийн холбогдолтой хэргийг хяналтын шатны шүүх хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ” гэсэн нэмэлтийг 2 дахь хэсэг болгон оруулжээ. Хяналтын шатны шүүх нь өөрийн эрх хэмжээний хүрээнд иргэний хэргийг 30 хоногийн дотор хянахаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д заажээ.

7 хоног гэдэг нь 30 хоногт багтах хугацаа хэдий ч хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх хугацааны дээд хязгаарыг зөвхөн сонгуулийн холбогдолтой хэрэг маргаанд доошлуулж тогтоосноор тухайн хэргийн оролцогчдын эрх, шүүхээс хэргийг үл үндэстэй шийдвэрлэх боломжид муугаар нөлөөлөөд зогсохгүй угтаа “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

Нөгөө талаар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим хугацаатай харьцуулж үзвэл иргэний бүх төрлийн хэргийг давж заалдах журмаар 30 хоног, хяналтын журмаар 30 хоногийн дотор хянан хэлэлцэхээр тогтоосон байхад сонгуулийн холбогдолтой хэргийг 7 хоногт хянан шийдвэрлэх нь хэтэрхий бага хугацаа гэдэг нь ойлгогдоно. Түүнчлэн хэргийн оролцогч шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш давж заалдах гомдлыг 14 хоногийн дотор, хяналтын гомдлыг 30 хоногийн дотор гаргадаг байхад хяналтын шатны шүүх /давж заалдах шатны шүүх ч мөн адил/ хэргийн оролцогчийн гомдол бичих хугацаанаас даруй 2-4 дахин богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй болж байна.

Сонгуулийн холбогдолтой хэрэг маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх шаардлага нь сонгуулийн өөрийн хугацаатай холбоотой болох нь ойлгомжтой ч хугацааны энэхүү шахуу байдлыг шүүх өөрийн ажлын дотоод зохион байгуулалтаар хянан тохируулах боломжтой байхад хэргийн оролцогчдын хуульд заасан эрхийг хязгаарласан нь процессын хуулийн нэгдмэл агуулгыг ч алдагдуулж, Үндсэн хуулийн зарчмыг ч зөрчсөн гэж үзэхээр байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т “сонгуулийн холбогдолтой хэргийг” гэж заасан хэдий ч хуулийн 166 дугаар зүйлийн 166.7-д сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн шүүгчийн шийтгэврийг давж заалдах шатны шүүх хянахаар туссан ба давж заалдах шатны шүүхийн магадлалд мөн хуулийн 167 дугаар зүйлийн 167.5-д зааснаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах боломжтой тул захиргааны шийтгэл хүлээлгэсэн шүүгчийн шийтгэврийг хяналтын шатны шүүх хянах үүрэгтэй болж байна.

Энэ утгаараа хяналтын шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7, 167 дугаар зүйлийн 167.5, 174 дүгээр зүйлийн 174.2-т заасныг баримталвал захиргааны шийтгэл ноогдуулсан шийтгэврийг хянаж, мөн хуулийн 170, 171 дүгээр зүйл, 172 дугаар зүйлийн 172.1-ийг баримталбал шийтгэврийг хянахгүй байхаар болжээ.

Уг тохиолдолд нэг асуудлыг хоёр өөрөөр зохицуулсан адилхан хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зүйл, заалтын нэгийг нь баримталж, нөгөөг нь зайлшгүй зөрчих тул шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагаа мухархалд орж, “...шүүгч гагцхүү хуульд захирагдана” гэсэн Үндсэн хуулийн шаардлага хэрэгжих боломжгүй болно” гэсэн байна.

5/ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “11.6.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шалгах ажиллагааг шүүгч 7 хоногт багтаан явуулна” гэсэн нэмэлт оруулжээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар захиргааны зөрчлийг эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн, зөрчлийг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор явуулах, энэ хугацаанд дуусгах боломжгүй бол тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хоногоор сунгаж, зөрчлийн тухай тэмдэглэл хөтлөх, үзлэг шинжилгээ хийх, шаардлагатай эд зүйл, баримт бичгийг түр хураах, зөрчил гаргасан этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, албадан саатуулах зэрэг цогц ажиллагаанууд хийгдэх ёстой билээ.

Гэтэл сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг шүүгч өөрөө 7 хоногийн дотор хянан шалгаж, нотлох баримтыг өөрөө цуглуулж, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авах эсэхээ шийдвэрлэхээр болж байгаа нь талуудын тэгш эрхийн зарчмыг алдагдуулж байгаа төдийгүй, захиргааны зөрчил гаргасан этгээдийн зөрчлийг хянан шалгах хугацааг 2 өөрөөр хуульчилж, тухайн хуульд заасан боломжит хугацааг хэт багасгаснаар захиргааны зөрчил гаргасан этгээдийн эрхээ хамгаалуулах боломжийг

алдагдуулж байна. Энэ нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн заалттай зөрчилдөж байгаагаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзнэ. Мөн хуулийн "Захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, гомдол гаргах" гэсэн 19 дүгээр зүйлд "19.8. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэрт 3 хоногийн дотор гомдол гаргаж болох ба давж заалдах гомдлыг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасны дагуу хянан шийдвэрлэнэ" гэсэн нэмэлт оруулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч нар захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэврийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргаж, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол давж заалдах гомдлыг эрх бүхий албан тушаалтан хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хянан шийдвэрлэхээр Захиргааны хариуцлагын тухай хуульд заажээ.

Гэтэл захиргааны зөрчил гаргасан этгээдэд шийтгэл ногдуулсан анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргах журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлүүдийн дагуу зохицуулагдсан ба шүүгчийн шийтгэвэрт 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргахаар өөрөө заагджээ. Энэ заалт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн "Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дунд, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ" гэсэн заалттай нийцэж байхад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэрт 3 хоногийн дотор гомдол гаргаж болохор хуульчлан зааж, гомдол гаргах хугацааг багасгаж, бусад захиргааны зөрчилд шийтгэл ногдуулсан шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргаж болох хуульд заасан хугацаанаас өөрөөр тогтоосон нь дээрх хуулийн заалтуудтай зөрчилдөж байгаагаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "шүүгч... гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн захиргааны зөрчилтэй хэргийн оролцогчдоос захиргааны зөрчилд шийтгэл ногдуулсан анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргахдаа дээд шатны шүүхэд нь гомдол гаргах Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа өнөөгийн нөхцөлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7 дахь хэсгийн дагуу давж заалдах шатны шүүх гомдлыг үндэслэн шийтгэврийг хянахаар байгаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 57 дугаар зүйлийн 57.2, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлийн заалтуудтай зөрчилдсөн, аль хууль нь Үндсэн хуульд нийцэж байгааг тодорхойлох боломжгүй, дээрх хуулиудад нэг үйл баримтыг хоёр өөрөөр зохицуулсан зэрэг нь "шүүгч... гагцхүү хуульд захирагдана" гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг шүүн таслах ажиллагаанд хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа юм.

### 3. Улсын Их Хурлын иргэмжлэгдсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурал 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар Улсын Их Хурлын сонгуулийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө зарлахаар хуульчилж, сонгуулийн үйл ажиллагааны үе шатны ажлуудын хугацааг богиносгон тогтоосонтой холбогдуулж, Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хэрэг бүртгэх ажиллагаа явуулах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шүүхийн шийдвэрийн хувийг холбогдох этгээдэд

гардуулах, давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргах, хяналтын журмаар уг хэргийг хянан шийдвэрлэх, түүнчлэн сонгуультай холбогдсон иргэний хэргийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэхтэй холбогдсон хугацааг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндсэн хугацаанаас багаар тусгайлан тогтоосон өөрчлөлтийг эдгээр хуульд оруулсан. Түүнчлэн Захиргааны хариуцлагын тухай хуульд ч дээрхтэй адил өөрчлөлт оруулсан.

Сонгуультай холбоотой маргаан сонгуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүй байх явдал өмнөх сонгуулийн үед гарч байсан тул сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотой асуудлыг сонгууль зохион байгуулах хугацаанд шийдвэрлэж байх шаардлагын үүднээс ийнхүү тогтоосон бөгөөд энэ нь сонгуулийн холбогдолтой хэрэг, маргааныг шалган шийдвэрлэхэд богино хугацаа тогтоосноор асуудлыг тухайн цаг үед нь хянан шийдвэрлэх замаар оролцогчдын эрхийг ханган баталгаажуулах боломж бүрдүүлнэ гэж хууль тогтоогч үзсэн юм. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуультай холбогдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Хэрэг бүртгэх ажиллагааг явуулах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх, шийтгэх ба цагаатгах тогтоолын хуулбарыг гардуулан өгөх, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэргийг хянан хэлэлцэж, захиргааны зөрчлийг хянан шалгах, захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, гомдол гаргах хугацааг дээрх хуулиудын ерөнхий хугацаанаас богиносгож тогтоосноор процессын нэгдмэл нэг журам, хэлбэрээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг байх нийтлэг зарчмыг зөрчжээ.

Үүний улмаас байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод төрөөр баталгаажсан адил тэгш эрх, үүрэгтэй байх боломж алдагдсан байна. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод хэрэглэж буй хууль ижил, нэгдмэл байх нь хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байх гол болзол бөгөөд энэхүү болзлыг мөн зөрчсөн байна. Хугацааг ялгавартайгаар тогтоож богиносгосноороо хэргийн бодит үнэнийг тогтоох, дүгнэлт гаргах, нотлох баримтыг шалгуулах, шүүхээр хамгаалуулах боломжийг хязгаарласан байна.

Ийнхүү хугацааг богиносгосноор эрх бүхий байгууллага асуудалд хөнгөн, хуумгай хандаж, хүний эрхийг зөрчиж иргэдийг хохироох хууль зүйн үндэслэл бий болгосон байна.

2. Улсын Их Хурлаас баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн зохих заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл / Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 178.4; 225.5; 233.2; 302.4; 304.4; 309.4; 346.4 дэх хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 166.7; 174.2 дахь хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг /Захиргааны хариуцлагын тухай хуульд 11.6; 19.8 дахь хэсэг нэмсэн/ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээр дурдсан хуулийн холбогдох заалтууд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, мөн Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтын үйлчлэлийг 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 178.4; 225.5; 233.2; 302.4; 304.4; 309.4; 346.4 дэх хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166.7; 174.2 дахь хэсэг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11.6; 19.8 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан сонгуультай холбоотой маргааныг тухайн сонгуулийн хугацаанд шийдвэрлэх зорилгоор хууль тогтоогч Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд тус тус өөрчлөлт оруулсан байдаг.

Эдгээр өөрчлөлтийг оруулах болсон гол шалтгаан, шаардлага нь хууль тогтоогчийн тайлбарласнаар сонгуулийн маргааныг сонгуулийн хугацаанд нь хянан шийдвэрлэх замаар оролцогчдын эрхийг хангах боломжийг бүрдүүлэх явдал гэж үзсэн.

Хууль тогтоогчийн санааг хүлээн зөвшөөрч болох хэдий ч түүнийг хэрэгжүүлж байгаа зохицуулалт, үүсэх нөхцөл байдал нь тэр бүр гаргасан тайлбартайгаа нийцэхгүй байна. Жишээ нь, сонгуулийн эцсийн дүн гарахаас 2 хоногийн өмнө нэр дэвшигч эрүүгийн хэрэгт холбогджээ гэж бодъё. Байж болох л тохиолдол. 2 хоногт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагдаж дуусахгүй нь хэнд ч ойлгомжтой. Нөгөө талаас, хууль тогтоогч зөвхөн анхан шатны шүүхийн процесст хугацааны хязгаарлалт хийж байгаа нь асуудлыг бүрэн цогцоор нь шийдвэрлэж байгаа хэрэг биш юм. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг 3 хоногт багтаан шийдлээ ч гэсэн цаана нь давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, түүнийг хэлэлцэх хуулийн хугацаа байж л байгаа.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2006.07.05 № 03**

**Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргач - Улсын дээд шүүх, түүний итгэмжилсэн төлөөлөгч Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн А., шүүгч Д.;

Хүсэлт гаргач - Улсын ерөнхий прокурор, түүний итгэмжилсэн төлөөлөгч Улсын ерөнхий прокурорын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Хэрэг бүртгэх ажиллагааг явуулах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх, шийтгэх ба цагаатгах тогтоолын хуулбарыг гардуулан өгөх, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэргийг хянан хэлэлцэж, захиргааны зөрчлийг хянан шалгах, захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, гомдол гаргах хугацааг дээрх хуулиудын ерөнхий хугацаанаас богиносгож тогтоосноор процессын нэгдмэл нэг журам, хэлбэрээр хэрэг

маргааныг хянан шийдвэрлэдэг байх нийтлэг зарчмыг зөрчжээ. Үүний улмаас байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод төрөөс баталгаажсан адил тэгш эрх, үүрэгтэй байх боломж алдагдсан байна.

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод хэрэглэж буй хууль ижил, нэгдмэл байх нь хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байх гол болзол бөгөөд энэхүү болзлыг мөн зөрчсөн байна. Хугацааг ялгавартайгаар тогтоож богиносгосноороо хэргийн бодит үнэнийг тогтоох, дүгнэлт гаргах, нотлох баримтыг шалгуулах, шүүхээр хамгаалуулах боломжийг хязгаарласан байна. Ийнхүү хугацааг богиносгосноор эрх бүхий байгууллага асуудалд хөнгөн, хуумгай хандаж, хүний эрхийг зөрчиж иргэдийг хохироох хууль зүйн үндэслэл бий болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл / Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 178.4; 225.5; 233.2; 302.4; 304.4; 309.4; 346.4 дэх хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 166.7; 174.2 дахь хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг /Захиргааны хариуцлагын тухай хуульд 11.6; 19.8 дахь хэсэг нэмсэн/ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх ч парламентын гишүүдийн дотор мэргэжлийн хуульчдын эзлэх хувь хэд билээ. Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц эцэслэн шийдвэрлэдэг ч, мэргэжлийн хууль зүйн байгууллагуудаас гаргасан хүсэлтийг хууль тогтоогч ийнхүү эс зөвшөөрч, Үндсэн хуулийн зөрчил биш хэмээн тайлбарлах нь зохимжгүй.

Тэгээд ч процессийн хуулийн хугацааг богиносгосон нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах боломжгүй болгож, талуудын хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хааж байгаа хэрэг юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.06.21 № 07

### Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их хурлын тухай хууль<sup>80</sup>

- 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт “өөрийг нь Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын, дэд, түр хорооны дарга, Засгийн газрын гишүүнээр сонгох, томилох санал хураалтын үед”
- 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт “өөрийнх нь бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах эсэх асуудлаар санал хураах үед”
- 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт “өөрийг нь гэмт хэрэгт холбогдуулан шалгах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад өгөх асуудлаар санал хураах үед”
- 7 дугаар зүйлийн 7.3.5 дахь заалт “өөрийг нь сэжигтнээр албадан саатуулах, цагдан хорих, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн өөрт нь шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад өгөх асуудлаар санал хураах үед”
- 7 дугаар зүйлийн 7.3.6 дахь заалт “Засгийн газарт итгэл үзүүлэх, түүнийг огцруулах асуудлаар санал хураах үед Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”
- Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын эрх ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”
- Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6 гэсэн таван заалт Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчиж байна. Улсын Их Хурлын аливаа бүрэн эрхийн асуудлаар шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох нь ард түмний элч мөний хувьд Улсын Их Хурлын гишүүнд Үндсэн хуулиар олгогдсон, анхдагч гэж хэлж болох, бүрэн эрх юм. Хэдэн жилийн өмнө Харвардын Университетээс зохион байгуулсан чөлөөт зах зээлтэй улсуудын наяд улс төрийн намыг хамарсан хөндлөнгийн судалгаагаар “улс

80 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 8-д нийтлэгдсэн



төрийн нам гэдэг бол төрийн эрх мэдлийг авах үндсэн сонирхол бүхий бүлэг хүмүүс” гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Төрийн эрх мэдлийн төлөө нам бүлгүүдийн хооронд бие биенээ унагах гэсэн улс төрийн тэмцэл өрнөж байдаг Улсын Их Хурал шиг ийм байгууллагад гишүүний энэхүү анхдагч эрхийг хязгаарлах нь зарим тохиолдолд Улсын Их Хурлын сонгуулиар буй болсон албан ёсны олонхийг үгүйсгэх, улмаар хууль зүйн үндэслэлгүй сэдэлтийг өөгшүүлэх, Улсын Их Хурлаас нийгмийн нийтлэг эрх ашигт буюу ард түмний хүсэл зоригт нийцээгүй шийдвэр гарахад нөлөөлж болох юм. Энэхүү хязгаарлалтыг нам, эвслийн үндсэн сонирхол, түүнтэй холбоотой сонирхлын зөрчлөөс жижиг хувийн сонирхлын зөрчлөөр тайлбарлах ёсгүй. Ийнхүү Улсын Их Хурлын гишүүний таслах эрхийг хуулиар хязгаарлах нь гишүүний халдашгүй байдлыг хөндөн Үндсэн хуулийн дээрх заалтуудыг зөрчиж байна.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбарт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэдгийг “Улсын Их Хурлын гишүүд өөрсдийгөө сонгогдсон тойргийнхоо сонгогчдын төлөөлөгч мэтээр ойлгож, тойргийнхоо эрх ашгийг улсын эрх ашгаас дээгүүр тавих эрхгүй, харин Үндсэн хууль, түүнтэй нийцэн гарсан бусад хуулиа дээдлэх ёстой. Гэхдээ нийт иргэн, улсын ашиг сонирхол бүхнийг хуульчлагдсан байна гэж үзэж болохгүй. Монголын ард түмний ёс заншил, өв уламжлал, эх орноо гэх сэтгэл, шударга үнэнийг эрхэмлэх ёсон зэрэг зүйлийг Улсын Их Хурлын гишүүн хүн эрхэмлэн баримтлах учиртай” гэж тайлбарласан байна.

Энэхүү тайлбарыг 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн батлахад биечлэн оролцсон хуульчид хийсэн бөгөөд Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу хийгдсэн тайлбар гэж үзэх үндэслэлтэй.

Улсын Их Хурлын чуулганаар Улсын Их Хурлын гишүүн өөрийг нь Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны даргаар сонгох, Засгийн газрын гишүүнээр томилох, өөрийг нь гэмт хэрэгт холбогдуулан шалгах болон сэжигтнээр албадан саатуулах, цагдан хорих, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийх, шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагад өгөх асуудлаар, түүнчлэн Засгийн газрын гишүүнээр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Засгийн газарт итгэл үзүүлэх, түүнийг огцруулах асуудлаар санал хураах явцад холбогдох гишүүнийг тухайн санал хураалтад оролцуулах эсэх асуудлаар маргаан багагүй үүсдэг байсан. Иймээс Улсын Их Хурлын гишүүн ийнхүү таслах эрхгүй байх заалтуудыг 2001 оноос эхлэн дагаж мөрдөж байгаа болно.

Өөрөөр хэлбэл, албан тушаалд сонгох, томилох, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх, өөрт нь итгэл хүлээлгэх эсэх гэх мэт Улсын Их Хурлын гишүүний хувьд зөвхөн өөрт нь холбогдох асуудлаар санал хураахад таслах эрхгүй байхаар заасан. Энэ нь нэг талаасаа Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр заасан Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын гишүүн гагцхүү шударга үнэнийг эрхэмлэн дээдэлж ажиллах, аливаа сонирхлын зөрчилгүй байх талаас нь харгалзсан хэрэг юм. Нөгөө талаар Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч болж нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж бодлого тодорхойлох аливаа асуудлаар санал хураалтад оролцох эрхийг хасаж байгаа явдал биш гэж үзсэн.

Аливаа хүний эрх нь нөгөө хүний эрхийг хохироох үндэслэл болохгүй байх, нөгөө талаас ёс зүйн талаас хандаж хуулиар тодорхой хязгаарлалт тогтоож болох ерөнхий зарчмыг баримтлахыг шаарддаг. Дэлхийн ихэнх оронд энэ зарчмын хүрээнд парламентын гишүүдийн зарим үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тогтоон мөрдүүлдэг. Тухайлбал, парламентын улс орнуудын нийтлэг жишгээр Улсын Их Хурлын гишүүний албаны үйл ажиллагаа, албан томилт, шагнал, бэлэг дурсгалын зүйлийг

хүлээн авах, сонгуулийн үйл ажиллагаа явуулахад хуулиар тодорхой хязгаарлалтуудыг тогтоосон. Үүний нэгэн адилаар хандаж Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхол, түүний нийгмийн болон албаны үүрэгтэй нь харшилдах байдал гаргахгүй байх үндэслэлээр зөвхөн өөрт нь холбогдох асуудлаар санал хураах үед таслах эрх эдлэхгүй байхаар хуульчилсан.

“Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн Үндсэн хуулийн заалт нь Улсын Их Хурлаас нийтийн эрх ашигт хамаарах аливаа асуудлыг шийдвэрлэхэд Улсын Их Хурлын гишүүд зөвхөн тойргийнхоо эрх ашгийг бус, нийт улсын эрх ашгийн үүднээс асуудалд хандах зарчмаар илэрхийлэгдэж байгаа, түүнчлэн Парламентын гишүүний бүрэн эрхэд дээр дурдсанаар хязгаарлалт тогтоож болох ерөнхий зарчим үйлчилдэг тул зөвхөн өөрт нь холбогдох асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй байхаар заасан нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байгаа болно.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал бол түүнээс эрх, үүргээ саадгүй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх явдлыг хангасан Үндсэн хуулийн чухал зарчмын нэг юм. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, тайлбар зэрэгт Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглохыг хэлнэ гэж тайлбарласан байна.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд иргэний “халдашгүй эрх чөлөөтэй байх” гэдэг өргөн хүрээгээр авч үзвэл хүний хувийн чөлөөт байдал, эд хөрөнгө, орон сууц, захидал харилцааны нууцад хуульд заасан журмаас гадуур хэн ч халдахгүй байхаар тайлбарладаг. НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүү шүүлт болон бусад харгис, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэлийн эсрэг олон улсын гэрээ /1948/, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэгт хуульчлан заасны дагуу хууль бусаар нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглохыг ойлгодог. Энэ ойлголт нь ийнхүү олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн халдашгүй байдлын ойлголт байна. Ийнхүү Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал гэдэг нь улс орнуудын нийтлэг жишгээр Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан”, 34 дүгээр зүйлийн 34.7-д “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно” гэсэн заалтуудаар илэрхийлэгдэж байгаа тул Улсын Их Хурлын гишүүний таслах эрхийг хязгаарласан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

### 3. Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 7.3.1, 7.3.6 заалт нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно”, мөн хуулийн 7.3.3, 7.3.4, 7.3.5 заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүний санал өгөх эрхийг у

гишүүний сонирхлын зөрчлөөр тайлбарлан хязгаарлах нь түүнээс ч илүү хүчтэй бүлгийн сонирхлын зөрчлийг өөгшүүлэх тул Улсын Их Хурлын тухай хуулийн дээрх заалтуудыг хувь гишүүний сонирхлын зөрчлийг хязгаарлах үүднээс тайлбарлах үндэслэл байхгүй. Хувийн хэвшлийн байгууллагын удирдлага нь хувийн сонирхлоороо нэгдсэн хүмүүсээс буюу тийм этгээдүүдийн төлөөлөгчдөөс бүрдсэн байдаг тул санал өгөх эрхэд зөөлөн хязгаарлалт байж болдог. Жишээ нь, удирдах зөвлөлийн гишүүн хэлэлцэж байгаа асуудлын талаар сонирхлын зөрчилтэй байгаа тул би санал хураалтад оролцохгүй гэж болдог. Гэтэл Улсын Их Хурлын тухай хуульд тас хориглосон байна. Маргаан үүсгэгдсэн өргөдлийн тайлбарт ч Улсын Их Хурлын гишүүний санал өгөх бүрэн эрхийг хязгаарлаж болохгүй тухай тайлбарласан. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болоогүй, эсвэл энэхүү эрхийг түдгэлзүүлээгүй буюу зохих зөвшөөрлийг аваагүй байгаа үед тухайн гишүүний санал өгөх эрхийг хасч байгаа нь дээр иш татсан Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Хорин гуравдугаар зүйлийн 1, 2, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Парламентын гишүүдийн санал өгөх, таслах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлахыг хуулиар хориглодог нь ардчилсан эрх зүйт төрийн үндсэн зарчим болно. Бусад салбар хуулийн хувьд тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн санал өгөх эрх нь нээлттэй байдаг.

2. "Ашиг сонирхлын зөрчилтэй", мөн "зөвхөн өөртэй нь холбогдолтой асуудлыг хэлэлцэх" гэх мэт үндэслэлээр Улсын Их Хурлын гишүүний санал өгөх эрхийг хуулиар хязгаарласан нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдсан шинжийг агуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1, 2, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.3, 7.3.4, 7.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Хорин гуравдугаар зүйлийн 1, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6 дахь заалтын үйлчлэлийг 2006 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 72 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.3.1, 7.3.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1.2, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн

заалтыг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.3.3, 7.3.4, 7.3.5 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Хорин гуравдугаар зүйлийн 1, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй”

#### **Тэмдэглэл:**

Энэ нь Улсын Их Хурлын халдашгүй эрхэд бодитоор халдсан хуулийн зохицуулалт юм. Санал өгөх гэдэг нэг талаасаа эрх боловч Улсын Их Хурлын гишүүний хувьд үүрэг ч гэж үзэх боломжтой. Парламентын гишүүний төдийгүй иргэдийн санал өгөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлахыг хуулиар хориглодог нь ардчилсан эрх зүйт төрийн үндсэн зарчим юм. Улсын Их Хурлын гишүүнийг нэгжих, баривчлах, албан саатуулах зэрэг албадлагын арга хэмжээ авах тохиолдолд бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудал Улсын Их Хуралд тавигддаг. Төрийн өндөр албан тушаалтны хувьд импичментийн иймэрхүү зохицуулалт Парламентын засагтай дийлэнх оронд үйлдчилдэг.

Улсын Их Хурлын гишүүн А.-г Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, уг асуудлыг хэлэлцэх үеэр А өөрөө санал өгөлгүйгээр гараад явсан тохиолдол гарч байсан. Тухайн үед Улсын Их Хурлын гишүүний санал өгөх эрхийг хязгаарласан зохицуулалт байгаагүй. Өөрөөр хэлбэл хуулийн ямар нэгэн хязгаарлалтаас бус, зөвхөн нэр дэвшигч өөрөө л санал хураалтад оролцохгүй гээд гарсан хэрэг. Бүрэн эрх гэдэг тунхаг биш, харин бүрнээ хэрэгжиж байх ёстой.

Улсын Их Хурал сонирхлын зөрчлийг гаргуулахгүй байх үүднээс энэхүү хязгаарлалтыг оруулсан гэж байгаа ч угтаа үүнийг хөхиүлэн дэмжиж, ийм боломжийг бүр 2000 онд Үндсэн хуулиараа нээж өгчихсөн. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсарч болно гэдэг бол сонирхлын зөрчлийг хуулиар бий болгож байгаа хэлбэр биш гэж үү.

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.06.22 № 08**

### **Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Даатгалын тухай хууль<sup>81</sup>

- 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно”

81 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2004 оны № 20-д нийтлэгдсэн

## **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Хорьдугаар зүйл “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”
- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

1/ Даатгалын тухай хуулийн 22.1-д “Даатгалын компанийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 500 сая төгрөг байна” хэмээжээ. Энэ нь хууль тогтоогчийн зүгээс эрх зүйн хэм хэмжээг харьцангуй тодорхой гипотезоор буюу шууд тогтоосон байдлаар 500 сая төгрөг байна хэмээн зохицуулсан. Уг зохицуулалт ёсоор даатгалын үйл ажиллагаа эрхлэхийн тулд дээрх болзлыг л биелүүлэх гэх байдлаар ойлгогдоно. Түүнчлэн эрх зүйн ойлголт дотор байна гэх нэр томьёо өөрөө аливаа зүйлийг шууд тогтоосон түүнийг өөрчлөх боломжгүйгээр ойлгогдон хэрэглэгддэг. Ийм учраас хуулиар Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шууд тогтоож өгсөн байдал харагдаж байна. Гэвч уг хуулиар тогтоосон зүйлийг өөрчлөх эсэх асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо гэх байгууллагад эрх олгосон хэм хэмжээгээр шилжүүлсэн. Энэ нь өөрөө парламентын буюу Улсын Их Хурлаас батлан гаргасан, нэгэнт хуулиар зохицуулчихсан зүйлийг өөрчлөх эрхийг уг байгууллагад олгож байна. Иймээс эрх мэдлийг шилжүүлсэн гэх үндэслэлийг бүрдүүлж өгчээ. Онолын хувьд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага эрх зүйн хэм хэмжээг тогтоохгүй, харин хуулийг биелүүлэх ажлыг эрхлэх ёстой. Хэрэв шилжүүлж буй бол энэ нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчим хийгээд парламентад ёсны үндсэн зарчмуудыг зөрчиж буй үйлдэл. Онолын хувьд зөвшөөрөх асуудал биш юм.

2/ Хэдийгээр Даатгалын тухай хууль 2005 оны 7 дугаар сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болсон хэдий ч Улсын Их Хурлаас 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасан бөгөөд үүнээс өмнө уг байгууллага чухам ямар эрх зүйн статустай байгууллага болох нь тодорхойгүй байсан юм. Иймд нэгэнт уг хууль батлагдан гарснаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн статус нэгэнт тодорхой болжээ. Ингэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1-д “Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” хэмээн тогтоожээ. Үүнээс үзэхэд Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүргүүдээс нь уг байгууллага эрх зүйн нэг институт болох хувьдаа төрийн эрх мэдлийн гурван салааны гүйцэтгэх эрх мэдэлд илүүтэйгээр хамаарахаар харагдаж байна. Үүнийг нотолж буй зүйл нь хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих гэх байдлаар тогтоогдоно. Энэ нь шинжлэх ухааны судалгааны үүднээс бол гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүрэгт хамаарч байдаг нь нэгэнт шийдэгдчихсэн зүйл. Иймд уг байгууллагад парламентаас батлан гаргасан хуулиар нэгэнт тогтоогоод өгчихсөн зүйлийг өөрчлөх бүрэн эрхийг олгосон байгаа нь өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт болох Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” хэмээх зохицуулалтыг зөрчсөн байна.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:**

1/ Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн зохицуулалт нь 22.1-т “даатгалын компанийн дүрмийн сан нь мөнгөн

хөрөнгөнөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 500 сая төгрөг байна” гэсэн буюу хууль тогтоогчоос хуулиар шууд тогтоож өгсөн зүйлийг өөрчлөх эрхийг уг байгууллагад олгож байна. Иймээс эрх мэдлийг шилжүүлсэн гэх үндэслэлийг бүрдүүлж өгчээ.

Даатгалын тухай хуулийн 22.1 дэх хэсгийн заалтад даатгалын үйл ажиллагаа эрхлэхийн тулд компани доод тал нь 500 сая төгрөгийн дүрмийн сантай байхаар хэм хэмжээ тогтоосон. Аливаа компани даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол дүрмийн сангийн хувьд заавал хангах хөрөнгийн доод хэмжээг хуульчилсан болно. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохын ач холбогдол нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсч болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах, даатгалын үйл ажиллагааг эрхлэх болон даатгагчийн хувьд даатгалын эрсдлийг хариуцах чадвартай, даатгалын үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулахад хүрэлцэхүйц хэмжээний дүрмийн сангаас бүрдсэн өөрийн хөрөнгөтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.

Хуулийн Санхүүгийн зохицуулах хороо “даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-т заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн 22.2 дахь хэсгийн заалт нь тухайн компанийн эрхэлж байгаа даатгалын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан даатгуулагч иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалахад илүү анхаарал, нэмэлт зохицуулалт шаардлагатай нөхцөлд Санхүүгийн зохицуулах хороо шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй байхад оршиж байгаа юм. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Банкны тухай хуульд ч Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлтэй ижил, зүйл, заалт байдаг. Банкны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2-т “Дүрмийн сан нь банкны хувь нийлүүлэгчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 1 тэрбум төгрөг байна. Дүрмийн сангийн хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханш уналт, тухайн банкны төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Монголбанк нэмэгдүүлэн тогтоож болно” гэж заажээ.

Банк болон Даатгалын тухай хуулиудын эдгээр заалт нь иргэн, хуулийн этгээдийн их хэмжээний мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж, үйл ажиллагаа явуулдаг банк, санхүүгийн үйлчилгээний онцлогоос шалтгаалан тухайн төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тусгай шаардлага, нөхцөл тогтоож байгаагаараа ач холбогдолтой юм. Ийм зохицуулалтыг гадаад орнуудын /Индонези гэх мэт/ хууль тогтоомжоор ч мөн тогтоосон байдаг.

2/ Даатгалын тухай хуулийн 22.2 дахь хэсгийн заалт даатгагчийн дүрмийн санг тогтооход Санхүүгийн зохицуулах хороо анхаарах гурван зүйл байна:

- а/ Хороо нь дүрмийн сангийн доод хэмжээг тодорхой этгээдэд зориулж тогтоох;
- б/ Тухайн компанийн дүрмийн сангийн Хорооноос тогтоосон хэмжээ нь 22.1-д заасан хэмжээ буюу 500 саяас их байх;
- в/ Дүрмийн сангийн хэмжээг тогтоохдоо даатгагчийн даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээг харгалзан үзэх.

Даатгалын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт зааснаар тодорхой компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоосон Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр нь зөвхөн тухайн компанид хамаарах бөгөөд компаниуд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоож байгаа буюу Улсын Их Хурлаас тогтоосон доод хэмжээг өөрчилж байгаа явдал биш юм. Санхүүгийн зохицуулах хороо ийнхүү тодорхой компанийн дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх тохиолдолд Даатгалын хуулийн 22.1 дэх хэсгийн “дүрмийн сангийн доод хэмжээ 500 сая төгрөг байх” заалт хөндөгдөхгүй, хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд нөгөө талаар Улсын Их Хурлын бүрэн эрх ч хөндөгдөхгүй билээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох, “даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих” бүрэн эрхтэй гэж заажээ. Эдгээр заалтаар Улсын Их Хурал нь Санхүүгийн зохицуулах хороонд хуулийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргах эрх олгожээ. Төрийн байгууллага бүр тодорхой чиг үүрэгтэйгээр байгуулагддаг бөгөөд үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулдаг. Төрийн байгууллагын бүрэн эрхийг анхдагч болон хоёрдогч буюу эрх шилжих үндсэн дээр бий болсон байдлаараа ялгаатай авч үздэг.

Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэж заасан байдаг. Ийнхүү ард түмний мэдэлд байгаа учраас засгийн эрх мэдэл нь хуваагдашгүй зүйл бөгөөд харин түүнийг төрийн тодорхой эрх мэдлээр дамжуулан хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэж заасан. Үүний зэрэгцээгээр Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн...”, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрхийг хуулиар тогтооно” гэж заасны дагуу хуулиар Улсын Их Хурлын шинэ бүрэн эрхийг тогтоох эрх Улсын Их Хуралд нээлттэй байгаа билээ. Үүний нэг тод илрэл нь, хууль тогтоох байгууллага хэм хэмжээ тогтоох эрх мэдлээ төрийн гүйцэтгэх эрх мэдлийн болон бусад байгууллагад шилжүүлэх эрх бөгөөд үүнийг Үндсэн хуулиар хориглоогүй билээ. Энэ тохиолдолд онолын дагуу хууль тогтоох эрх мэдлийг хуулиар шилжүүлэх нь дэлхийн олон улс оронд нэгэнт тогтсон жишиг бөгөөд ганцхан Монгол Улсын парламентын тухайд бий болсон алдаатай ажиллагаа биш юм.

Санхүүгийн зохицуулах хороо тодорхой компанийн дүрмийн сангийн доод хэмжээг хуулийн хүрээнд тогтоох нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа явдал мөн гэж үзэхгүй байна. Харин хуульд заасан үндэслэлээр нэг удаагийн шийдвэр гаргаж байгаа бөгөөд энэ шийдвэрийг Улсын Их Хурлын хяналтын дор, хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо эрх мэдлээ хэтрүүлсэн, хууль зөрчсөн, Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан шийдвэр гаргавал Улсын Их Хурал шууд хүчингүй болгох буюу хүчингүй болгохыг шаардах эрхтэй юм. Иймд Даатгалын тухай хуулийн 22.2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### 3. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Б.-гийн тайлбарын агуулга:

Бидний үзэж байгаагаар Даатгалын тухай хуулийн 22.1 болон 22.2-ыг салган авч үзэх шаардлагатай юм. Уг хуулийн 22.1-д хууль тогтоогч өөрийн онцгой бүрэн эрхийг эдлэн даатгалын компанийн дүрмийн сан нь 500 сая төгрөгөөс доошгүй байна гэж хуульчилсан. Харин уг хуулийн 22.2-т “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн нь хууль тогтоогч өөрөө уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг тус Зохицуулах хороо гэдэг байгууллагад олгосон бус харин хуулиар дүрмийн сангийн хамгийн доод хэмжээг тогтоож, шаардлагатай бол цаашид энэ хэмжээг хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар биш энэ хуулийн эрх олгосон хэм хэмжээг хэрэгжүүлэх замаар, өөрөөр хэлбэл эрх зүйн акт гаргах замаар өөрчилж болно гэсэн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгож хуульчилж өгсөн байна. Иймд Даатгалын тухай хуулийн 22.2-ыг хэрэгжүүлэх, түүнд үндэслэн эрх зүйн акт гаргах нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд

хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахыг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэсэн зүйл, заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байна. Энэ нь хууль тогтоох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа асуудал огтхон ч биш юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцааг төрөөс зохицуулах арга механизмын нэг гол хэлбэр болсон Засгийн газрын дэргэд бус, хууль тогтоох байгууллагаас байгуулагдаж, түүнд ажлаа тайлагнадаг, эрх мэдэл, үйл ажиллагааных нь журмыг хууль тогтоох байгууллагаас баталдаг төрийн байгууллагын бүтэц дэлхий нийтэд нэгэнт хэвшмэл болсон зүйл юм. Ийм байгууллагын жишээ нь АНУ-ын Холбооны худалдааны комисс, АНУ-ын Үнэт цаасны комисс гэх мэт байгууллага болон манай улсын хувьд өмнө ажиллаж байсан Үнэт цаасны хороо, Монголбанк гэх мэт байгууллагууд юм. Үнэт цаасны хорооны үйл ажиллагаа шинэ эрх зүйн орчны хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд шилжин ирсэн ба энэ хандлагыг удирдлага болгон үзвэл манай улсад байгуулагдан ажиллаж байгаа Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар ч шууд утгаараа Засгийн газраас хараат бус ажиллах ёстой юм. Эдгээр байгууллагын гол шинж нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын аль алиных нь шинжийг өөртөө агуулсан байдаг оршино. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлыг авч үзвэл хорооны гишүүд нь Улсын Их Хурлаас томилогддог, хороо нь Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, хорооны дүрмийг Улсын Их Хурал баталдаг гэх мэт зохицуулалтын шинжээрээ Засгийн газрын биш, бие даасан статустай төрийн байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тус хорооны бүрэн эрхийг:

- санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;
- бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоох;
- санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг шалгах;
- тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;
- тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх;
- хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, биелэлтэд нь хяналт тавих гэх мэтээр хуульчилж өгсөн байна.

Дээр дурдсанаас үзвэл тус хороо нь засаглалын бүх хэлбэрийг харьцангуй түвшинд хэрэгжүүлдэг бие даасан төрийн байгууллага болох нь харагдаж байна. Зах зээлийн харилцаа өөрчлөгдөх, мөнгөний ханш унах, санхүүгийн системд өөрчлөлт гарах бүрт л хууль тогтоох байгууллагаас хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй юм. Энэ үүднээсээ Улсын Их Хурал хуулиар одоо шаардагдах хэм хэмжээг нь тогтоолоо, цаашид танай байгууллага шаардлагатай бол эрх зүйн акт гаргах замаар /хууль гаргах бус, одоо байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бус/ өөрчлөн тогтоох боломжтой гэж үзэж эрх олгосон заалтыг хуульд суулгаж өгсөн байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Их Хурал Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 500 сая төгрөг байна” гэж нэгэнт тогтоосон атлаа 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Зохицуулах хороо... тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 21.1-д заасан хэмжээнээс



дээгүүр тогтоож болно” гэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийн бүрэн эрхээ Санхүүгийн зохицуулах хороонд олгосон байна. Ингэснээрээ Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдлийг бусдад шилжүүлсэн болох нь тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн заалтын үйлчлэлийг 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 73 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлаас тодорхой тохиолдолд нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоох эрхийг хуулиар бусдад шилжүүлэх эрхтэй. Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-оор Улсын Их Хурал өөрийн эрх мэдлээ Санхүүгийн зохицуулах хороонд шилжүүлж олгосон байна. Энэ хуулиар даатгалын үйл ажиллагаа явуулах дүрмийн сангийн доод хэмжээг 500 саяар тогтоосон хэрнээ даатгалын үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанараас шалтгаалан доод хязгаарыг ихэсгэх эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгож байгаа нь хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлсэн болохыг нотолж байна.

Хуулиар доод хэмжээ тогтоохын эрх зүйн үр дагавар чухам юунд байна вэ? 500 саяыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд тухайн компани даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч чадахгүй нь ойлгомжтой. Энэ бол эрх зүйн үр дагавар.

Тэгвэл Санхүүгийн зохицуулах хороо А компанид үйл ажиллагааны цар хүрээнээс хамаараад дүрмийн сангийн доод хэмжээг 700 сая байлгах шаардлага гаргасан байна гэж бодъё. Энэ тохиолдолд А компани Даатгалын тухай хуулийн дагуу хуульд заасан дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлсэн тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх бүрэн боломжтой байна.

Өөрөөр хэлбэл Санхүүгийн зохицуулах хороонд хуульд зааснаас дээгүүр хэмжээ тогтоох эрхийг олгосон ч тэрхүү шаардлагыг биелүүлээгүйгээс үүсэх эрх зүйн үр дагавар байхгүй. Харин хуульд заасан доод хэмжээг өөрийн үзэмжээр өөрчлөх эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгосон нь даатгалын компаниудын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх үр дагавартай.

Улсын Их Хурал хуулиар хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт гаргах эрхийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар, бусад байгууллагад шилжүүлдэг. Дүрмийн санг хуульд зааснаас нэмэгдүүлэн тогтоохдоо даатгалын компани тус бүрээр нэг бүрчлэн тогтоох уу, эсхүл үйл ажиллагааны төрлөөр нь ангилж хэм хэмжээ тогтоосон актаар ерөнхийлөн тогтоох уу гэдэгт Улсын Их Хурал, Санхүүгийн зохицуулах хороо аль аль нь нэгдмэл байр суурьгүй болох нь Цэцийн хуралдаанд илэрхий байсан билээ. Эрх зүйн онолын хувьд нэг бүрчилсэн акт гаргах байдлаар эрх хэмжээг шилжүүлж болдоггүйг хууль тогтоогч анхаарч үзээгүй нь харамсалтай.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2006.10.11 № 04**

### **Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргач - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани доод тал нь 500 сая төгрөгийн дүрмийн сантай байх тухай Даатгалын тухай хуулийн /22.1 дэх хэсгийн/ заалт нь тухайн төрлийн санхүүгийн үйл ажиллагааг эрхлэх бүх компани хангавал зохих шаардлага юм. Цаашид санхүүгийн зах зээл дээр даатгалын компаниудын үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо тодорхой компанийн дүрмийн сангийн хэмжээг хуулиар тогтоосон доод хэмжээг баримтлан нэмэгдүүлэн тогтоож байх нь илүү уян хатан зохицуулалт болох юм. Энэ тохиолдолд эрх шилжүүлж байгаа учир онолын хувьд даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг өөрчлөх эрх нь Улсын Их Хуралд хадгалагдсаар байх бөгөөд гагцхүү ийнхүү тодорхой компанийн дүрмийн сангийн доод хэмжээг Улсын Их Хурал өөрчлөх нь Санхүүгийн зохицуулах хорооноос өөрчлөхтэй харьцуулахад дэгийн хувьд хугацаа их шаардагдах бөгөөд Улсын Их

Хурал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх хугацаанд даатгуулагч иргэний эрх аль хэдийн зөрчигдчихсэн байж болох талтай тул ач холбогдол багатай байх талтай нөгөө талаар ийнхүү нэг компанийн дүрмийн сангийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон шийдвэр нь эрх зүйн хэм хэмжээ тогтоож байгаа биш харин зөвхөн зохицуулалтын шинжтэй учраас ийм шийдвэрийг хууль тогтоогч гаргах нь учир дутагдалтай болох юм. Дүрмийн сангийн хэмжээг Даатгалын хуулийн 22.2-т зааснаар өөрчлөх нь нэгдүгээрт, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хоёрдугаарт, даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаа гарахаас урьдчилан сэргийлж, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, гуравдугаарт, даатгалын үйл ажиллагааг эрхлэх болон даатгагчийн хувьд даатгалын эрсдлийг хариуцах бодитой чадвартай, санхүүгийн боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх юм.

## 2. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Санхүүгийн зохицуулах хорооны тайлбарын агуулга:

Даатгалын тухай хуулийн 22.2 дахь заалт нь хууль тогтоогч өөрөө уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг тус Зохицуулах хороо гэх байгууллагад олгосон бус харин хуулиар дүрмийн сангийн хамгийн доод хэмжээг тогтоож, шаардлагатай бол цаашид энэ хэмжээг хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар биш, харин энэ хуулийн эрх олгосон хэм хэмжээг хэрэгжүүлэх замаар, өөрөөр хэлбэл эрх зүйн акт гаргах замаар өөрчилж болно гэсэн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгож хуульчилж өгсөн байна. Зах зээлийн эдийн засгийн харилцааг төрөөс зохицуулах арга механизмын нэг гол хэлбэр болсон Засгийн газрын дэргэд бус, хууль тогтоох байгууллагаас байгуулагдаж, түүнд ажлаа тайлагнадаг, эрх мэдэл, үйл ажиллагааных нь журмыг хууль тогтоох байгууллагаас баталдаг төрийн байгууллагын бүтэц дэлхий нийтэд нэгэнт хэвшмэл болсон зүйл юм. Ийм байгууллагын жишээ нь Америкийн Нэгдсэн Улсын Холбооны худалдааны комисс, Америкийн Нэгдсэн Улсын Үнэт цаасны комисс гэх мэт байгууллага болон манай улсын хувьд өмнө ажиллаж байсан Үнэт цаасны хороо, Монголбанк гэх мэт байгууллагууд юм. Үнэт цаасны хорооны үйл ажиллагаа шинэ эрх зүйн орчны хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд шилжин ирсэн ба энэ хандлагыг удирдлага болгон үзвэл манай улсад байгуулагдан ажиллаж байгаа Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар ч шууд утгаараа Засгийн газраас хараат бус ажиллах ёстой юм. Эдгээр байгууллагын гол шинж нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын аль алиных нь шинжийг өөртөө агуулсан байдагт оршино.

Зах зээлийн харилцаа өөрчлөгдөх, мөнгөний ханш унах, санхүүгийн системд өөрчлөлт гарах бүрт л хууль тогтоох байгууллагаас хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжгүй юм. Энэ үүднээсээ Улсын Их Хурал хуулиар одоо шаардагдах хэм хэмжээг нь тогтоож, шаардлагатай бол эрх зүйн акт гаргах замаар өөрчлөн тогтоох боломжтой гэж үзэн тус хороонд эрх олгосон заалтыг хуульд суулгаж өгсөн байна.

## 3. Иргэн Б.-гийн хариу тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч болон Санхүүгийн зохицуулах хорооны тайлбарын аль алинд Даатгалын тухай хуулийн 22.2-т зохицуулсантай адил зохицуулалт Банкны тухай хуульд зохицуулсан гэжээ. Тэгвэл үүнээс үүдэлтэйгээр Банкны тухай хууль нь өөрөө Үндсэн хууль мэтээр ойлгогдоход хүргэж байна. Учир нь нэгэнт өмнө хуулиар зохицуулсан байна хэмээн явцууруулж үзэх нь агуулгын хувьд алдаатай зүйл. Өөрөөр хэлбэл өмнө батлагдан гарч хэрэгжиж буй хууль нь хэдийгээр Үндсэн хуульдаа нийцээгүй байсан ч өмнө зохицуулж байсан гэх үндэслэлээр Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд харшлах зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх нь буруу юм.

Үндсэн хуулийг өнгөц байдлаар буюу жирийн хүн уншихад эрх мэдэл хуваарилах зарчмыг Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарлаж буйчлан “эрх мэдэл шилжүүлэхийг хориглоогүй” гэх өгүүлбэр байхгүй боловч хуулийг уншихын тулд түүнийг үзэл баримтлал, зарчмаар нь л унших ёстой. Тиймээс л эрх мэдэл хуваарилах зарчим

хийгээд, парламентат ёсны үндсэн зарчмуудыг зөрчиж буй үйлдэл болно. Түүний зэрэгцээгээр орчин үед парламент өөрийн эрх мэдлийг зарим нэг талаар шилжүүлж буй ч ийнхүү эрх мэдлээ шилжүүлэхэд нь түүний онцгой бүрэн эрх болох хууль тогтоох нь үл шилжих парламентат ёсны зарчмыг үл хөндөнө. Тайлбарт Даатгалын тухай хуулийн 22.1-т зохицуулсан Даатгалын компанийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 500 сая төгрөг байна гэх зохицуулалтыг төдийлөн хөндсөнгүй. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчийн зүгээс эрх зүйн хэм хэмжээг харьцангуй тодорхой гипотезоор буюу шууд тогтоосон байдлаар 500 сая төгрөг байна хэмээн зохицуулсан.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурал Даатгалын тухай хуулийн 22-ын 1 дэх хэсэгт Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 500,0 сая төгрөг байна гэж нэгэнт тогтоосон атлаа 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зохицуулах хороо... тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийн бүрэн эрхээ Санхүүгийн зохицуулах хороонд олгосон байна. Ингэснээрээ Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдлийг бусдад шилжүүлсэн болох нь тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Даатгалын тухай Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Зохицуулах хороо даатгалын үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс хамааран тухайн даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнээс дээгүүр тогтоож болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, мөн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Улсын Их Хурлын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол нь гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөхийг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй ч Цэцийн их суудлын хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч хуралдааны явцад Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн заалтаар Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлээ Санхүүгийн зохицуулах хороонд шилжүүлсэн болохоо хүлээн зөвшөөрсөн юм. Үндсэн хуульд хууль тогтоох, нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байхаар хуульчилсан байдаг. “Онцгой” гэж тодотгохын хууль зүйн үндэс нь хэнтэй ч хуваахгүй, зөвхөн өөртөө хадгалж хэрэгжүүлэх хэмээн ойлгож болно. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Улсын Их Хурлын тогтоолд үндэслэлээ огт дурдаагүй ч Цэцийн дүгнэлтийг хэлэлцэхдээ Улсын Их Хурал асуудлыг энэ талаас нь огт авч хэлэлцээгүй болох нь хуралдааны тэмдэглэлээс тодорхой. Хуулиар даатгалын үйл ажиллагаа эрхлэх дүрмийн сангийн доод хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно гэсэн зохицуулалт хийгээд энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо дүрмийн санг тогтоосон бол энэ Үндсэн хуулийн зөрчил биш. Гэтэл Улсын Их Хурал хуулиар доод хэмжээгээ тогтоож өгсөн атлаа түүнийг өөрчлөх эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд шилжүүлж байгаа нь хууль тогтоох эрх мэдэлд халдсан Үндсэн хуулийн ноцтой зөрчил юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.09.20 № 09

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,  
ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр  
зүйлийн 14.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох  
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Ж.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль<sup>82</sup>

- 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг “Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээд зургаагаас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендер нь шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шудрага ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... хөрөнгө чинээ, ... ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”

- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

82 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2005 оны № 48-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалтад тусгасан хязгаарлалт нь хуулийн этгээд болох аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгж байгуулан үйл ажиллагаа явуулах Монгол Улсын иргэн хуулийн хүрээнд, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэн шударгаар чөлөөтэй өрсөлдөн, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг хязгаарлан хориглож буйгаараа Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж байна.

Дээрх заалт нь мөн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай хууль, Шударга бус өрсөлдөөний тухай хуулийн заалтуудтай зөрчилдөж, улмаар уг заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн төв болон орон нутгийн байгууллагууд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг зөрчихөд хүргэж байгаагаараа ноцтой юм. Жишээлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15.3.4-т “Тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төсөвтэй бараа, ажил үйлчилгээний жилийн борлуулалтын талаархи мэдээлэл” мөн 16.1.2, 16.1.3-т “сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төсөвтэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт”-ыг үндэслэн тендерт оролцогчийг үнэлнэ гэж заасан.

Үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн явуулж, бараа үйлчилгээнийх нь чанар, нэр хүнд зах зээл дээр тодорхой хүндлэл хүлээж, байр сууриа олсон шударга компани, аж ахуйн нэгжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалт нь үндэслэлгүйгээр зах зээл дээрх томоохон хэрэглэгч болох төрийн худалдан авах үйл ажиллагаанд орохыг хязгаарлаж хориглоход цаана нь зөвхөн шинээр байгуулагдсан, жижиг аж ахуйн нэгжүүд үлдэж байгаа юм. Эдгээр шинэ аж ахуйн нэгжүүд нь тус хуулийн 15.3.4, 16.1.2 болон 16.1.3 дахь заалтуудын шаардлагыг хангаж чадахгүй нь тодорхой.

Хуулийн энэхүү заалт хэрэгжсэнээр улсын эдийн засагт тэргүүлэх чиглэлийн болон хүн амд нэн шаардлагатай бараа, үйлчилгээний чанарыг доройтуулж, улмаар түүнийг ашиглан хүн амд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, утга учрыг алдагдуулах байдалд хүрч, эцсийн дүнд улсын төсвийг үр ашиггүй зарцуулахад хүргэж байна. Нөгөөтэйгүүр аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэл, борлуулалтыг бууруулах, өрсөлдөх чадварыг бууруулан улмаар тус улсын эдийн засаг, хүн амд нэн хэрэгтэй байгаа ажлын байрыг үгүйсгэх сөрөг үр дагаврууд гарч болзошгүй болоод байна.

Аж ахуйн үйл ажиллагааны практикаас харахад нэг компани жилдээ 20-30 тендерт оролцож улмаар наад зах нь 6-10 тендерт ялж байж үйл ажиллагааны зардлаа нөхөн, ажилтан ажилчдаа цалинжуулж, цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах хэмжээний ашиг орлоготой ажилладаг байна. Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалтын улмаас:

а/ дараалан 6 ба түүнээс дээш тендерт оролцож, амжилт олохгүй байх нь нийтлэг үзэгдэл тул олон аж ахуйн нэгж тухайн жилдээ бизнес явуулах боломжгүй болох,

б/ төрийн болон орон нутгийн хөрөнгөөр нэг удаа худалдан авч буй хэмжээ нь бага байдаг тул 3 удаа тендерт ялсан ч компани үйл ажиллагаагаа тогтвортой хэмжээнд явуулах тодорхой орлого ашиг олж чадахгүй,

в/ шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, компани хуулиар нэмж тавьсан шаардлагыг хангахгүй тул тендерт оролцох боломжгүй болж байна.

Иймд нөхцөл байдалд шинээр компани байгуулан шалгуур хангаагүй байж тендерт оролцох, хуучин компаниуд дээрх хязгаарлалтыг үл харгалзан тендерт оролцоор байх, эцэст нь тендерийг удирдан зохион байгуулж буй төрийн байгууллагууд хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх бололцоогүй, бололцоотой байсан ч хэрэгсэхгүй өнгөрөөх улмаар энэ нь авилгал, хээл хахуульд хүргэх нөхцөл бүрэлдүүлж байна.

Монгол Улсын том, жижиг аж ахуйн нэгж, байгууллагууд ийнхүү зах зээлээс шахагдсан тохиолдолд зөвхөн гадаадын нийлүүлэгчид дээрх хуулиар заасан шаардлага, шалгуурыг хангах болж байгаа бөгөөд хэдийгээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциор /тухайлбал Дэлхийн худалдааны байгууллагын олон талт гэрээ, хэлэлцээрүүдээр/ Монгол Улс нь зах зээлээ нээлттэй байлгах үүрэг хүлээсэн ч уг зах зээл дээр шударгаар өрсөлдөх нөхцөлийг мөн хангах үүрэгтэй. Дээрх хуулийн заалтууд нь харин эсрэгээр, төрөөс шударга өрсөлдөөнийг саатуулсан алхам болжээ. Гадаадын аж ахуйн нэгж байгууллагууд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд орох эрх нь нээлттэй боловч харин бусадтай шударгаар буюу бараа үйлчилгээнийхээ чанар, үнээр өрсөлдөх ёстой болохоос Үндсэн хуульд заасан “хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх” зарчмыг зөрчсөн заалт бүхий хуулиар Монгол Улсын аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс илт давамгай эрх эдлэх ёсгүй юм. Иймд Үндсэн хуулийн заалтыг зөрчиж буй Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалтыг энэхүү нэхэмжлэлээр Үндсэн хуулийн маргаан үүсгэн хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 3.1-д “Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв гэнэ” гэж заасан байдаг. Мөн Улсын төсвийг батлах асуудал Монгол Улсын Их Хурлын, бүрдүүлж, зарцуулах асуудал Засгийн газрын бүрэн эрхэд тус тус хамаардаг. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь санхүүгийн зах зээлийн харилцаа бөгөөд энэ харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулж байгаа билээ. Төр эдийн засаг, санхүүгийн зах зээлийн харилцааг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн” зохицуулдаг билээ.

1/ Ардчилсан ёс гэдэг бол аль нэг буюу хэсэг бүлэг этгээдийн бус ард түмний олонхийн санал зоригийг хэрэгжүүлэхэд оршдог бол шударга ёс нь төр, засгийн байгууллага, түүний албан хаагчдын үйл ажиллагаанд танил тал харах, хээл хахуульд автах, эрх мэдлээ урвуулан ашиглах ажиллагааг хязгаарлахад, тэгш байдал, эрх чөлөөний зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд төрөөс харьяат этгээдэд /хувь хүн, хуулийн этгээд/ үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх, хууль шүүхийн өмнө адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг хангахад оршдог билээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсэг нь “хязгаарлалт” гэхээсээ “зах зээлд шударга өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн” заалт гэвэл илүү тохиромжтой гэж үзэж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах явцад урьд өмнө мөрдөж байсан журам, баримталж байсан бодлогыг харгалзан нэгдүгээрт, аль нэг этгээд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан

авах бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх ажиллагаанд дангаар ноёрхох, улмаар бараа, ажил үйлчилгээг хугацаанд нь худалдан авахад саад учруулахгүй байх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хязгаарлаж, өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжүүдийг шударгаар өрсөлдүүлж илүү чадавхитай, хугацаанд нь биелүүлэх боломжтойг нь сонгох авах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримталсан болно.

Улсын Их Хурал эрх барих дээд байгууллагын хувьд үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах бүрэн эрхийнхээ хүрээнд шударга ёсыг тогтоох, тэгш байдлыг хангах үүднээс ижил боломжийг олгох зорилгоор зарим давуу эрх бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хязгаарлах, өөрөөр хэлбэл, давамгайл байдлаа шударга өрсөлдөөнд харшаар ашиглахаас хамгаалж, бусад этгээдэд боломж олгох нөхцөлийг бүрдүүлсэн учраас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

2/ Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт /болон хууль бүхэлдээ/ нь тендер шалгаруулалтад оролцогчийн өмчийн хэлбэрийн талаар тухайлан заагаагүй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжид хамаарах учир эдгээр заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Нөгөө талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд “Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байна” гэж заасан байдаг. Иймээс төрийн өмчийг өмчлөгчийн хувьд Улсын Их Хурал төсвийн хөрөнгийг захиран зарцуулах хүрээнд тогтоосон энэ хязгаарлалт нь Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэсэн заалтын агуулгад 14.2 дахь хэсгийн заалт бүрэн нийцэж байгаа гэж үзэж байна. Монгол Улсын бүх иргэн, хуулийн этгээд өөрсдийн орлогоос төлсөн татварын мөнгөнөөс бүрдэж бий болдог улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа гүйцэтгэгчийг оновчтой сонгож, бараа, ажил, үйлчилгээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, ингэснээр төрийн байгууллагууд, төрөөс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг хугацаанд нь, чанартай үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлийн харилцаанд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа өмчийн бүх төрлийн этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх ижил нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримталсан бөгөөд хэсэг бүлэг аж ахуйн нэгжид санхүүгийн зах зээлд давамгайлан оролцох боломж олгох буюу төсвийн хөрөнгийг цөөн хэсэг аж ахуйн нэгж давуу эрхийн үндсэн дээр ашиглах боломжийг хуулиар олгох нь буруу бөгөөд өмнө мөрдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг дагаж мөрдөх явцад гарч байсан зарим сөрөг практикийг харгалзан хуульд 14.2 дахь хэсгийн заалтыг тусгасан билээ.

3/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна. Учир нь энэ тухайд болон бусад бүх заалтын тухайд ерөнхийдөө зөрчсөн гэсэн үндэслэл нь тодорхой бус байна. Одоогоор Монгол Улс тендерт оролцогчийн тухайд ямар нэг хязгаарлалт тавихгүй байх талаар олон улсын аль нэг гэрээгээр үүрэг хүлээгээгүй байна.

4/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 ба 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 4 дэх заалтуудыг зөрчсөн гэсний тухайд:



Үндсэн хуулийн эдгээр заалт нь “хувь хүн, иргэн” гэсэн субъектэд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, хүний салшгүй эрхийн асуудал юм. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт нь зөвхөн хуулийн этгээдэд хамаарч байгаа бөгөөд Иргэний хуулийн 26.9-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана” гэж заасан нь хууль тогтоогчид хязгаарлалт тогтоох эрхийг олгосон бас нэг үндэслэл нь мөн.

5/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэжээ. Хууль болон төрийн байгууллагын аливаа шийдвэр нь бүх сонирхогч этгээдийн ашиг сонирхолд нэгэн зэрэг нийцэх боломжгүй, нөгөөтэйгүүр хууль бүх этгээдийн “эрхийг хязгаарлахгүй” байх боломж нь ч мөн хязгаарлагдмал бөгөөд тодорхой тохиолдолд төр, нийгмийн ашиг тусын тулд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах болон бусад тодорхой зорилгоор хэсэг бүлэг этгээдийн эрхийг хязгаарладаг. Аливаа эрх нь бусдын эрхээр хязгаарлагдаж байдаг. Үүнийг хууль тогтоогч тодорхой хууль батлах замаар тэнцвэржүүлж, хамгаалдаг билээ. Мөн хууль тогтоох байгууллага төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай гэж үзвэл хуулиар иргэн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах явдал ч байдаг.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт нь төрийн тодорхой бодлогыг хэрэгжүүлэхэд, өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахаас урьдчилан сэргийлэх, өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2 дахь хэсгийн заалт нь аж ахуйн нэгжүүдийг ялгаварлаж шинээр байгуулагдсан, чадваргүй, шаардлага хангахгүй нь тодорхой аж ахуйн нэгжид илүү боломж олгох бодлогыг биш харин нийт ард иргэдийн ашиг сонирхлын үүднээс төрийн үйл ажиллагааг зохих хэмжээнд явуулах, түүнд төсвөөс хуваарилсан мөнгөн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, эцсийн дүнд төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэх бодлогыг баримталсан бөгөөд ингэхдээ нийт аж ахуйн нэгжүүдэд төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх ижил боломж олгосон гэж үзэж байна. Хуулийн төслийг хэлэлцэх явцад чадвар, туршлагатай цөөн аж ахуйн нэгжид нэг төрлийн бараа нийлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгэх хэд хэдэн гэрээг байгуулах нь ажил, үүргийг хугацаанд нь, чанартай биелүүлэх магадлал буурч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, эцсийн дүнд төрөөс иргэд, бусад этгээдэд үзүүлэх үйлчилгээ тасалдах сөрөг үр дагавартай болно.

Иргэн Б.-гийн мэдээлэлд туссан санал нь хэт туйлширсан, өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжүүд зөвхөн төрийн байгууллагад бараа, ажил, үйлчилгээ нийлүүлж түүнээс олсон ашгаар амьдрах, үгүй бол дампуурах юм шиг, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дээрх заалт нь аж ахуйн нэгж болон иргэдийг өмч хөрөнгөөр нь ялгавартай хандсан, өмчлөгчийн эрхэд халдсан, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэхэд саад болох, шинээр байгуулагдсан жижиг аж ахуйн нэгжүүд хуульд заасан шалгуурыг хангахгүйгээр тендерт оролцож болох мэтээр бичсэн байна. Ер нь цаашид том компаниуд хувь хүнээр дамжуулан төрийн бодлогыг эсэргүүцсэн, хуулийн бүх этгээд нэгэн адил дээдлэх зарчмыг зөрчсөн ийм үйл ажиллагаа явуулж байгаа буруу практикийг Үндсэн хуулийн цэц шийдвэртэйгээр таслан зогсоох нь зүйтэй гэж үзэж байна.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээдээс 6-аас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендерт шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно” гэсэн хязгаарлалт нь төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн гэж үзэх үндэстэй байна.

2. Хуулийн дээрх заалтаар тендер шалгаруулалтад оролцогчийг хөрөнгө чинээгээр ялгаварласан, өмчлөгчийн эрхэд халдсан, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр тухайн жилд зарлагдсан тендер шалгаруулалтад хуулийн этгээдээс 6-аас дээшгүй удаа оролцож болох бөгөөд үүнээс 3 удаад тендерт шалгарсан бол тухайн жилд дахин тендер шалгаруулалтад оролцохыг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 4, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 3, 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэснийг хүлээн авах боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 1-д заасан “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, 2-т заасан “Төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, 4-т заасан “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Аравдугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2-т заасан “Хүнийг... хөрөнгө чинээ, ...ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”, 4-т заасан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”, Далдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын намрын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **Тэмдэглэл:**

Цэцийн энэхүү дүгнэлтийг та нэг анхаарахад илүүдэхгүй. Тендер өөрөө шударга өрсөлдөөний зарчимд үндэслэн явагддаг. Үүнд ямар нэг алагчилах, ялангуяа урьд өмнө оролцож байсан үзүүлэлтээр дахин тендерт орох эрхийг нь хязгаарлах ёсгүй бөгөөд ийнхүү хуулийн хязгаарлалт тавьсан нь Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээ зөрчсөн үйлдэл болсон. 1997 онд манай улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэн орж тус байгууллагын нийтдээ 20 орчим олон талт худалдааны гэрээнд нэгдсэн.

Үүнээс Төрийн худалдан авах үйл ажиллагааны талаархи болон худалдан авалтад техникийн саад учруулахгүй байх гэрээнүүдэд өрсөлдөөнийг аль болох дэмжих, шударгаар өрсөлдүүлэх, ямар нэгэн хиймэл хязгаарлалт тогтоохгүй байх, гадны байгууллага, аж ахуйн нэгж оролцох эрхийг чөлөөтэй болгох гэсэн заалтууд тусгагдсан байдаг.

Гэтэл хууль тогтоогч шударгаар өрсөлдөх байдлыг дэмжих, тендерийг дамлан худалдаалахыг зогсоох, тендерт хэдхэн том компани оролцдогийг хязгаарлах, хээл хахууль, авлигыг зогсоох зорилгоор энэхүү зохицуулалтыг оруулсан гэж байгаа нь Олон улсын гэрээний заалтыг илтэд зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.12.06 № 10**

### **Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Л.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн П., Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2006 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Онцгой албан татварын тухай хууль<sup>83</sup>

- 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь заалт “эх орны үйлдвэрийн 40 хүртэл хатуулгатай бүх төрлийн архины 1 литр тутамд “аймагт 1.6 ам доллар, нийслэлд 2.0 ам доллар”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

83 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 26-д нийтлэгдсэн

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна”

### **Маргагч талуудын тайлбар, байр, суурь:**

1. Иргэн Д., Б. нарын мэдээллийн агуулга:

Онцгой албан татварын тухай хуулийн 6.1 хэсгийн хүснэгтийн 2-т эх орны үйлдвэрийн 40 хүртэл хатуулгатай, бүх төрлийн архины 1 литр тутамд, тухайн үйлдвэр нь аймагт эсвэл нийслэлд харьяалагдаж байгаагаас нь хамааран, эхнийхэд нь 1,6 ам долларын, хоёр дахид нь 2,0 ам долларын хэмжээний онцгой албан татвар /20 хувь зөрүүтэй/ ногдуулжээ. Энэ нь Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын холбогдох зүйлийг зөрчиж байна.

Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэж үзэж байгаа тул Цэцийн хуралдаанаар хянан шийдвэрлэж өгөхийг гүнээ итгэн, та бүхнээс хүсэж байна.

2. Иргэн Л.-ийн нэмэлт тайлбарын агуулга:

1/ Засгийн газар санаачилсан Онцгой албан татварын хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад бидний өргөдлийн объект болоод байгаа, 6.1.2 гэж товчилсон энэхүү тоон зохицуулалтыг Улсын Их Хурлын гишүүн Р. санал болгожээ. Төсвийн Байнгын Хорооны анхны хэлэлцүүлэг дээр Р. гишүүн саналынхаа үндэслэлийг “хөдөө орон нутаг дахь архины үйлдвэрийг хүнсний үйлдвэр гэдэг утгаар нь дэмжих нь зүйтэй. Энэ бол орон нутгийн үйлдвэрлэгчдийн, бас энд тэндээс яриад байгаа санал, орон нутгийн төсвийг бүрдүүлэх санааны үүднээс тавигдаж байгаа зүйл. Манай Дундговьд Онги архийг АПУ цохиод байна” гэх байдлаар илэрхийлжээ.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг дээр гишүүн Б. “Р. гишүүний 6.1-ийн хүснэгтийн 2 дээр гаргасан саналыг би дэмжиж л байна л даа, гэхдээ манайх чинь татварын босоо тогтолцоотой, орон нутаг гэж ялгах юм байхгүй, нэгдсэн байдлаар явж байгаа. Тийм учраас би юу гэж ойлгож байна вэ гэвэл, энэ 40 хүртэл градустай архийг Улаанбаатарт үйлдвэрлэсэн, орон нутагт үйлдвэрлэсэн гэж ялгахгүйгээр Р. гишүүний саналаар 1.6 ам доллар боллоо гэж ойлгож байна. Энэ зөв үү?” гэж асуусанд хурал даргалагч Л. “Энэ ер нь Цэцэд очиж мэдэхээр л юм байна. Тэндээ очоод ярина биз. Хот, хөдөөгөөр нь ялгаварласан, илүү чанартай юм хийж болохгүй юу? Дархан, Зүүнхарааг ямар учраас хотоос дор гэж үзсэн бэ? гэх мэтчилэнгээр яривал ярих юм байна” хэмээн хариулжээ. Цаашид энэ талаар маргаан, мэтгэлцээн гарсангүй явсаар хууль батлагдсан байна.

2/ Өргөдлийн объект болоод байгаа 6.1.2 дахь тоон зохицуулалт нь Улаанбаатарын харьяалалгүй дотоодын архины үйлдвэрт Улаанбаатарынхаас илүү хамгаалалтыг бий болгосон байна. Ингэснээрээ, төр өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан зарчмыг удирдлага болгон хуулиар хамгаалах тухай Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчиж байна. 6.1.2 дахь тоон зохицуулалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна.

3/ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлд заасан өмчлөх эрхээ хэрэгжүүлж буй аргуудын нэг нь аж ахуйн нэгж мөн бөгөөд тэдгээр нь хуулийн этгээд болохын хувьд хуулийн өмнө эрх тэгш байх тухай Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт аж ахуйн нэгжүүдэд үйлчлэх ёстой. 6.1.2 дахь тоон зохицуулалт нь Үндсэн хуулийн өргөдөлд иш татсан Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн

заалтыг зөрчиж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17 дугаар зүйлд заасан хүний өмчлөх эрхийг энэхүү тунхаглалын долдугаар зүйлд болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2-т заасан эд хөрөнгийн байдал зэрэг, ямар нэг алагчлалгүйгээр хангах үүргийг Монгол Улс энэхүү пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу хүлээдэг. Гэтэл бүтээгдэхүүний стандартын шалгуурт ямар ч холбогдолгүй эд хөрөнгийн байдлыг, тухайлбал, архины үйлдвэр нь аймагт эсвэл Улаанбаатарт харьяалагдаж байгааг шалгуур болгон онцгой албан татварыг 20 хувийн зөрүүтэй тогтоосон байна. Ийнхүү 6.1.2 дахь тоон зохицуулалт нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна. Олон улсын гэрээний эрх зүйн тухай венийн конвенцын хорин зургадугаар зүйл (Pacta sunt servanda) “Аливаа хүчин төгөлдөр гэрээг түүнд оролцогчид заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд түүнийг үнэнч шударгаар хэрэгжүүлнэ”, хорин долдугаар зүйл. “Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно” гэсэн заалтуудын дагуу, мөн Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтын дагуу Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт нь Онцгой албан татварын хуулийн 6.1.2 дахь тоон зохицуулалтыг давж үйлчлэх хуультай. Хэрэв энэхүү тоон зохицуулалтыг дагаж мөрдвөл Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчих болно. Ийнхүү 6.1.2 дахь тоон зохицуулалт нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна”

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч П., Б. нарын мэдээллийн агуулга:

Онцгой албан татварын тухай хуулийн 6.1.2 дахь заалт Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчөөгүй талаар дараах дэлгэрэнгүй тайлбар өгч байна:

1/ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна” гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд, маргааны сэдэв болж байгаа тэгш байдал, тэгш эрхийн зарчим нь Үндсэн хуулийн оршилд заасан шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд мөн тэнд заасан эх орондоо хүмүүнлэг... нийгэм хөгжүүлэх эрхэм зорилгыг үндэс болгосон төрийн үйл ажиллагааны гол тулгуур юм. Татварын бодлогын хувьд тэгш шударга байх зарчим нь гэдэг нь төлж буй татварын хэмжээг татвар төлөгчийн татвар төлөх чадвартай уялдуулахыг ойлгодог билээ. Тийм учраас зах зээл, ардчиллын орнуудад татвар төлөх чадвар, орлого нь нэмэгдэх тутам төлөх татварын хувь, хэмжээг өсгөн нэмэгдүүлдэг нийтлэг жишиг нэгэнт тогтсон байна.

Онцгой албан татвар бол үйлдвэрлэлд гаргасан зардал олсон орлого хоёрын харьцаа хэт өндөр байгаа үед оногдуулдаг татварын нэгэн онцгой төрөл бөгөөд орон нутагт архи үйлдвэрлэх, борлуулах зардал нь нийслэлийнхээс ихээхэн өндөр байгаа тэгш бус байдлыг зөөлрүүлэх зорилгоор татварыг нь харьцангуй багаар тогтоосон юм. Мөн алслагдсан нутгийн хэрэглэгчид өндөр үнэтэй архи хэрэглэж буй тэгш бус явдлыг засаж залруулахад чиглэгдэж байгааг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй.

2/ Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2-т заасан “Төр нь өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд, энэхүү заалтыг дараагийн заалт буюу Тавдугаар зүйлийн 3-т “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж заасантай ч нягт уялдаатай авч үзэх шаардлагатай. Татвар авч байгаа нь өмчлөгчийн эрхэд халдаж байгаа асуудал биш, Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1.3-т “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүрэгтэй” гэж заасан заалтыг хэрэгжүүлж байгаа хэрэг билээ.

3/ Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд, өргөдөлд дурдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактуудад Монгол Улс нэгдэн орсон бөгөөд дотоодын хуулийн нэгэн адил үйлчилж байгаагийн дээр тунхаглал, пактыг зөрчсөн гэх асуудал гараагүй болно.

Мөн тунхаглалын арван долдугаар зүйлийн “Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй” гэсэн заалтыг өргөдөлд иш татжээ. Энэ хуульд тусгагдсан татварын хувь, хэмжээ нь төрийн татварын бодлого, үзэл баримтлал, үндсэн зарчимд нийцсэн бөгөөд харин өргөдлийн тайлбарт дурдсан зарим компанийн татвар өөр өөр тогтоогдсон асуудал нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрлэх асуудал биш хууль амьдралд хэрэгжиж засаж залруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд л Улсын Их Хурлын зүгээс анхаарч авч үзэж болох талтай асуудал гэж ойлгогдож байна.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улсын татварын практик олон улсынхаас огт жааагүй бөгөөд харин ч хувь, хэмжээний хувьд бага байгааг бүгд мэдэж байгаа. Энэ нь төрөөс татварын талаар баримталж буй нэг гол бодлого болох татвар бууруулах үзэл баримтлалтай нягт уялдаж байна.

4/ Нийслэлийн үйлдвэрийн архинд оногдуулж байгаа 2.0 ам долларын татвараас 0.40 ам доллараар бага татварыг орон нутгийн үйлдвэрийн архинд ногдуулсан нь хөдөө орон нутгийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийг төвөөс алслагдсан эсэхээс үл хамааран тогтвортой жигд хөгжүүлэх төрийн бодлого бөгөөд дараах хууль, Улсын Их Хурлын тогтоолоор тодорхойлогдож байна. Үүнд:

а/ Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийн 4.1.2, 4.1.3-т “бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн нэгдмэл орчныг бүрдүүлэх, хүн амын нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, соёл, боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор нь аймаг, орон нутгийн чадавхад түшиглэн цогцолбороор шийдвэрлэх” зарчмыг тусгасан байна.

б/ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын 3.4-т “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд, эдийн засгийн бүс, бүс нутаг, хот хөдөөгийн хөгжлийн харилцан уялдсан нэгдмэл тогтолцоо, эдийн засгийн бүсүүдийн хэмжээнд, бүс нутаг, хот-хөдөөгийн хөгжлийн харьцангуй бие даасан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ үйл явцыг төрөөс нэгдсэн болон нутаг дэвсгэрийн ялгавартай бодлогоор дэмжин зохицуулна” гэж заасан.

5/ Орон нутгийн эдийн засгийг дэмжин хөгжүүлэх зорилгоор малаас авах татварыг газар нутгийн байршил, төвөөс алслагдсан байдлыг харгалзан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3-т малд ногдуулах албан татварыг баруун 5 аймагт хонин толгой тутамд 50 төгрөг, төвийн 4 аймагт 100 төгрөг, бусад аймагт 75 төгрөгөөр тус тус ялгавартай тогтоосон байгааг дурдах нь зүйтэй. Түүнчлэн өмнө мөрдөгдөж байсан Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Эх орны үйлдвэрийн хүнсний спирт, бүх төрлийн архи, дарсанд ногдуулах онцгой албан татварын хувь, хэмжээг уг бүтээгдэхүүний ашигт ажиллагааны түвшин, зах зээлийн эрэлт нийлүүлэлт, хэрэглээний байдлыг харгалзан Засгийн газар 20 хүртэл нэгжээр хорогдуулж болно” гэж зааж байсан жишээ ч байгаа билээ.

Ийнхүү архины онцгой албан татварыг 1.6 ба 2.0 ам доллар байхаар шийдвэрлэсэн нь эдийн засгийн бодлогын хувь орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэлийг дэмжих, зах зээлийн тэгш, шударга байдлыг хангах, үйлдвэрлэгчдийн тэгш эрхийг хангах зорилготой тул Онцгой албан татварын тухай хуулийн 6.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаагаа үүгээр тайлбарлаж байна.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Татварыг ялгавартай тогтоох нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал тул Онцгой албан татварын тухай хуулийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 2-т “эх орны үйлдвэрийн 40 хүртэл хатуулгатай архины 1 литр тутамд тухайн үйлдвэр нь хаана харьяалагдаж байгаагаас хамааран аймагт 1.6 ам доллар, нийслэлд 2.0 ам долларын онцгой албан татвар ногдуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт хэдийгээр Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй боловч шударга бус өрсөлдөөн бий болохоос урьдчилан сэргийлэх үүднээс уг заалтыг боловсронгуй болгох нь чухал юм.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлаас 2006 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 2-т эх орны үйлдвэрийн 40 хүртэл хатуулгатай бүх төрлийн архины 1 литр тутамд аймагт 1.6 ам доллар, нийслэлд 2.0 ам долларын онцгой албан татвар ногдуулахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, ...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2-т заасан “Төр нь... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Аравдугаар зүйлийн 3-т заасан “Монгол Улсын Олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг 15 хоногийн дотор хэлэлцэж хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Цэцийн шийдвэрүүд тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэсэн жишиг болох хандлагатай байдгаараа Цэцийн гишүүдээс нарийн мэдрэмж, мэргэшил шаарддаг төдийгүй, шийдвэрүүд нь өөр хоорондоо нийцэлтэй байх шинжийг агуулсан байх ёстой. Цэцийн дийлэнх шийдвэр энэхүү шаардлагыг хангасан байдаг ч зарим учир дутагдалтай, хоорондын авцалдаа багатай гарсан цөөн хэдэн шийдвэрийн нэг нь энэ билээ.

Цэцийн урьд шийдвэрлэсэн шар айрганд ногдуулсан онцгой албан татвар Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээний заалтыг зөрчсөн гэх дүгнэлт болон архинд ногдуулсан ялгавартай онцгой албан татварыг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх хэмээн үзэж Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн хоёр дүгнэлтээс Цэцийн байрь суурийг тодорхойлоход нэн бэрхшээлтэй. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүдийн уялдаа холбоо Үндсэн хуулийн хөгжилд чухал ач холбогдолтой. Цэцийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон хуулийн зүйл, заалтыг агуулгаар нь дахин батлах эрхгүй ч Улсын Их Хурал энэ тохиолдолд Цэцийн хүчин төгөлдөр хоёр шийдвэрийн алийг нь дагаж мөрдөх нь хууль тогтоогчийн хувьд эргэлзээ төрүүлсэн сорилт болсон юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.12.13 № 11

### Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн З.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль<sup>84</sup>

- 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хассаны дараа үлдсэн орлогыг ойлгоно”
- 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт “хуулиар ногдуулсан албан татвар төлөх”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлаас 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулиар алт, зэсийн хүдэр болон баяжмалын үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод албан татвар ногдуулахаар зохицуулсан. Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон “хууль тогтоох” онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд нийгэм, эдийн засгийн ямар ч асуудлыг зохицуулсан хууль, эрхийн акт гаргах эрхтэй ч ийнхүү батлагдаж буй хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх ёстой. Гэтэл дээрх хуулийн “Татвар ногдуулах орлогыг тодорхойлох” гэсэн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалтад “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно” гэж заажээ. Хуулийн энэхүү заалт нь үнийн өсөлтийн албан татвар ногдуулах гэж буй бүтээгдэхүүн болох “алт”-наас уул татварыг тооцож авахдаа Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч улмаар үлдэж буй орлогоос нь 68 хувийн татвар авна гэсэн үг. Дэлхийн зах зээл дээр энэ төрлийн ашигт малтмал, өнгөт металл арилжаалдаг олон бирж байдаг ч ийнхүү Лондонгийн металлын биржийг сонгосон нь мөн дээр дурдсанчлан хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал гэж харагдахаар байгаа хэдий ч “Лондон”-гийн гэх металлын бирж нь анх байгуулагдсан цагаасаа эхлээд өнөөдрийг хүртэл нэг ч удаа “алт” гэх бүтээгдэхүүнийг арилжаалаагүй байна. Нэгэнт алт арилжаалдаггүй металлын биржийг хууль тогтоогч сонгосон нь хуульд

84 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 20-д нийтлэгдсэн



заасан 500 ам.долларыг чухам ямар ханшнаас хасах нь ойлгомжгүй болж, эцэстээ 1 унци алтнаас үнийн өсөлтийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох боломжийг хууль зүйн хувьд хаасан гэж үзэж болно. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалт нь зөвхөн хуулийг батлагдсаны дараа ч бус мөн батлагдахын өмнө тухайлбал, Улсын Их Хурлын хууль санаачлах, боловсруулах, батлах ажиллагаанд нэгэн адил хамаарах атал ийнхүү илтэд үндэслэлгүй, тооцоо судалгаагүй, хэрэгжих боломжгүй "хууль бус" гэж дүгнэж болохоор заалт оруулсан нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй юм. Мөн энэхүү заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, ...нийт байгууллагын үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг мөн адил зөрчсөн байна. Дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т буй "Лондонгийн металлын бирж" гэсэн нь хууль зүйн үндэслэлгүй зохицуулалт болохыг Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 119 дүгээр тушаалаар батлагдсан "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал"-аас ч харж болно. Уг аргачлалд алтанд ногдуулах үнийн өсөлтийн албан татварын орлогыг тодорхойлохдоо хуульд заасан "Лондонгийн металлын бирж"-ээс бус харин Монголбанкнаас зарладаг алтны зах зээлийн дундаж үнийг баримтлахаар журамласан. Өөрөөр хэлбэл Лондонгийн металлын биржид алт арилжаалдаггүй гэдгийг Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 5/1399 дүгээр албан бичгээр Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан тайлбарт тодорхой дурдсан байна.

**2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч 3.-гийн тайлбарын агуулга:**

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалт нь хууль санаачлагчдын зүгээс хуулийн хүрээнд нийцэж гарсан бөгөөд гагцхүү тус заалт болох "Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно" гэсэн нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэхээсээ илүү нөхцөл байдлыг дутуу тооцоолсон эрх зүйн дутуу зохицуулалт болсон гэж үзэж байна. 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Зарим барааны үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн 1 дүгээр зүйлд "дэлхийн зах зээл дээрх алтны үнэд үндэслэж Төв банк /Монголбанк/-наас зарласан 1 унци алтны үнээс ..." гэж тусгасан байгаа нь дээрх эрх зүйн зөрчилтэй байдлыг арилгахад чиглэсэн бөгөөд одоогоор хэлэлцүүлгийн шатандаа явж байна. Иймд Зарим барааны үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна" гэжээ.

**3. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:**

Үндэсний татварын ерөнхий газраас бичгээр ирүүлсэн тайлбарын агуулга:

Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 119 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал"-ын 4.1.3 дахь заалтыг боловсруулахдаа Лондонгийн металлын бирж алтны үнийг зарладаггүйтэй холбогдуулан 1 унци алтнаас үнийн өсөлтийн албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо хуульд зааснаас өөрөөр журамласан хэдий ч Хууль зүй, дотоод хэргийн яамны 2006 оны 1/1663 дугаар дүгнэлтээр уг зохицуулалтыг хууль нийцүүлэхийг мэдэгдсэний дагуу холбогдох өөрчлөлтийг оруулсан болох, түүнчлэн Лондонгийн металлын бирж нь алт, мөнгө зэрэг үнэт металлын арилжаа эрхэлдэггүй, мөн тэдгээрийн үнэ ханшийг зарладаггүй болохыг холбогдох эх сурвалжийн хамт гаргав.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т "алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого" гэж Лондонгийн металлын бирж

дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хассаны дараа үлдсэн орлогыг ойлгоно”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх зарчим”-ыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Монголбанкнаас Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1991 дүгээр албан бичгээр ирүүлсэн хариу, мөн Үндэсний татварын ерөнхий газрын 2006 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 2а/1721 дүгээр албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар болон холбогдох бусад эх сурвалжаас үзэхэд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд заасан “Лондонгийн металлын бирж” нь алт арилжаалдаггүй болох нь тодорхой байна.

2. Улсын Их Хурал Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Лондонгийн металлын бирж” нь алт арилжаалдаг эсэх, мөн алтны үнийн өсөлтийн албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо өмнөх төсөлд тусгагдсан зэстэй адил “Лондонгийн металлын биржийн үнээс... тооцно” гэж томъёолж болох эсэх талаар тухайн үед уг хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох мэргэжлийн байгууллагаас санал, дүгнэлт авалгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн баталсан байна.

3. Улсын Их Хурал Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн “Татвар ногдох орлогыг тодорхойлох” гэсэн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно” гэж шууд заасан атал Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 119 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-ын 4.1.3-т “Алтны үнийн өсөлтийн албан татвар ногдуулах орлогыг алтыг борлуулсан тухайн өдрийн Лондонгийн биржийн болон “Bloomberg.com” цахим хуудсаар зарлагдсан үнээс унци /31.1035 гр/ алт тутамд 500 ам.доллар хасч тодорхойлно” гэж, мөн уг аргачлалд Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 122 дугаар тушаалаар нэмэлт оруулан “Лондонгийн биржийн болон “Bloomberg.com” цахим хуудас, Ройтерс агентлаг зэрэг эх сурвалжуудын мэдээлэлд үндэслэн Монголбанкнаас зарласан нэг унци алтны үнээс...” гэж тус тус өөрчлөн баталсан нь нэг талаас Улсын Их Хурлын “хууль тогтоох” бүрэн эрхэд халдсан төдийгүй, нөгөө талаас хуулийн дээрх заалт нь хэрэгжих үндэслэлгүй зохицуулалт болсны нотолгоо болж байна.

4. Түүнчлэн Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 131 дүгээр тушаалаар дээрх аргачлалд “...Лондонгийн металлын биржээс...” гэж дахин өөрчлөн баталсан боловч өдгөө Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд заасан алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод ногдуулж буй албан татварыг хуулиар бус харин Үндэсний татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тогтоон мөрдүүлж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан “Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хассаны дараа үлдсэн орлогыг ойлгоно”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам.доллар хасч тооцно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг, мөн дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэснийг зөрчсөн байна.

2. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалтын үйлчлэлийг 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 11 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 94 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4.1.4 дэх заалт, 6.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг, мөн 6.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлын Тамгын газраас Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын болон холбогдох байнгын хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг гаргуулсан. Эдгээр тэмдэглэлийг судлан үзэхэд 1 унци алтнаас үнийн өсөлтийн албан татвар ногдуулахдаа “Лондонгийн металлын бирж”-ийг сонгосон нь хэр үндэслэлтэй болох, уг металлын бирж алт арилжаалдаг эсэх талаар ямар нэг асуулт, хариулт явагдаагүй бөгөөд энэ талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй болох нь харагдаж байна. Лондонгийн металлын бирж нь алт арилжаалдаггүйг хууль тогтоогчид судалж мэдээгүй нь инээдтэй ч юм шиг. Харин Улсын Их Хурлын зарим гишүүд тухайлбал, Н., Г. нар хуульд ийм нарийвчилсан тодорхойлолт оруулж болох эсэх, мөн Лондонгийн бирж гэж бичих шаардлагагүй гэж хэлсэн зэрэг нь тэмдэглэлд тусгагджээ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006.12.14 № 12

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн И.,  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль<sup>85</sup>

- 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг “Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна”
- 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсэг “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 14-ийн “... гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн И.-гийн мэдээллийн агуулга:

Манай улсын хувьд жирэмсэн эмэгтэйчүүдэд ял оногдуулах, ял эдлүүлэх талаархи заалтууд Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад тусгагдсан байдаг. Жирэмсэн эмэгтэй нь нэг биш хоёр хүн, өөрөөр хэлбэл хүүхэдтэй хүн гэсэн ойлголтыг агуулж байдаг. Хүүхэд нь тухайн эмэгтэйн гэр бүлийн гишүүн болж байдаг.

Эхийн хэвлийд байгаа хүүхэд болон эхээс төрөөд иргэний эрхийн чадвартай болж байгаа хүүхэд хоёрын хоорондын ялгаа нь зөвхөн цаг хугацааны асуудал л байдаг. Иймд эхийн хэвлийд байгаа хүүхдийг эхтэй нь хорьж болдог, эхээс нэгэнт төрчихсөн байгаа хүүхдэд ялыг халдаан хэрэглэж болохгүй гэдэг хууль эрхийн акт нь үнэхээр буруу ойлголт юм. Ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно гэсэн Үндсэн хуулийн заалт нь тухайн ялыг ялтны аав, ээж, ах, дүү, хүүхэд, хамаатан садан цаашлаад хэнд ч халдаан хэрэглэж болохгүй гэсэн ойлголт юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон Эрүүгийн хуулиудад жирэмсэн эмэгтэйчүүдэд хорих ял оногдуулах, хорих ял эдэлж байгаад төрсөн эмэгтэйг хүүхэдтэй нь цуг байлгаж болох талаархи заалт нь ялыг гэр бүлийн гишүүнд нь халдаан хэрэглэж байгаа явдал юм.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлд зааснаар эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэх, жирэмсэн эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна гэж заажээ. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Ял эдэлж байх хугацаандаа

85 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 8-д нийтлэгдсэн

амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэж заажээ. Жирэмсэн эмэгтэйчүүдэд хорих ял оногдуулах, түүнчлэн ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэсэн заалтыг шууд зөрчиж байна. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчин жирэмсэн эмэгтэйчүүдийг хэвлийдээ тээж байгаа хүүхэдтэй нь хорихоор хуульчилсан нь эх хүнийг үр хүүхэдтэй нь хорьж байгаа явдал юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгаа Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь хэсгийн заалт мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн жирэмсэн эмэгтэйчүүдэд ял оногдуулахтай холбогдолтой заалтуудыг хүчингүй болгож өгнө үү.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан билээ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид, хүүхдийг гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно, Хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эхээс нь тусгаарлаж болно гэсэн бол, Гэр бүлийн тухай Монгол Улсын хуульд зааснаар хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээс зайлсхийсэн, эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, хүүхдийн эрүүл мэнд, хүмүүжилд муугаар нөлөөлсөн хүмүүсийн эцэг, эх байх эрхийг нь шүүхийн шийдвэрээр хасч болно гэж тус тус заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно гэж заасныг тус хуулийн үзэл баримтлалын дагуу хоёр талтай ойлгож болно.

Нэгдүгээрт, үйлдсэн хэрэг нь хүндэвтэр, эсхүл хүнд, түүнийг анх удаа үйлдсэн бол жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэйн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн дагуу 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж байгаа билээ.

Хоёрдугаарт, Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх хамаарахгүй байгаа тул онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бөгөөд ял эдэлж байх хугацаандаа амаржсан эмэгтэй ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт түр хугацаанд байлгаж болохоор хуульд тусгасан юм. Дээр дурдсан хугацаанаас хойш тухайн хүүхдийг эцгийн, эсхүл бусад төрөл садангийн нь асрамжид шилжүүлнэ. Энэ нь өөрөө манай төрийн энэрэнгүй бодлоготой нийцэж байгаа юм.

Мөн төрөөс хүн амын талаар баримтлах бодлого нь хүүхдийг эцэг, эхийн ивээл хайр асрамжинд нь эсэн мэнд бойжиход нь чиглэгдэнэ, мөн хүүхдийг хөхөөр хооллох, бие, сэтгэлийн хөгжилд тохирсон хоол хүнсээр хангах, бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжилд нь хяналт тавихыг бүх талаар дэмжихэд чиглэгдэнэ гэж заасныг анхаарахгүй байж болохгүй. Энэ зорилт Улсын Их Хурлаас батлагдсан бусад хууль тогтоомжид ч тусгалаа олсон билээ. Тухайлбал, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулийн дагуу хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллоно гэж заасан юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн “жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна” гэсэн заалт нь эрх чөлөө нь хасагдсан насанд

хүрээгүй хүмүүсийг хамгаалах НҮБ-ын дүрэм, насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн журам/-ын зарчим, үзэл санаанд нийцэж байгаа заалт болно. Үүнээс гадна НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр баталсан Аливаа хэлбэрээр баривчлагдсан болон хоригдсон этгээдүүдийг хамгаалах зарчмууд гэсэн 47/173 дугаар шийдвэрийн дагуу үндэсний хууль тогтоомжийн хүрээнд бөгөөд эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, түүнчлэн хүүхэд, насанд хүрээгүйчүүд, ахмад настан, тахир дутуу хүмүүсийн эрх, онцгой байдлыг хамгаалах зорилгоор авсан бүх арга хэмжээг ялгаварлан гадуурхсан буюу эрхийг нь зөрчсөн арга хэмжээ хэмээн үзэхгүй гэж байдаг.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц болон түүний үзэл санааны дагуу батлагдсан Хүүхдийн эрхийн тухай Монгол Улсын хуулийн дагуу төрснөөс хойш 18 нас хүртэлх хүн бүрийг хүүхэд гэдэг ойлголтод хамааруулахаар хуульчилсан юм. Харин жирэмсэн эмэгтэйн хэвлийд байгаа нь ураг гэж тооцогдоно. Иймд дээд дурдсан олон улсын эрх зүйн баримт бичиг болон үндэсний хууль тогтоомжийн дагуу жирэмсэн эмэгтэй нь хүүхдийнхээ хамт хоригдож байна гэж үзэх үндэслэл үгүй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт “Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна”, 111.5 дахь хэсэгт “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчсөн гэх үндэслэл байхгүй болно” гэсэн байна.

### 3. Холбогдох этгээдээс ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга Б.-гийн тайлбарын агуулга:

2002 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсэгт “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт шинээр орж мөрдөгдөж ирлээ. Энэхүү заалтыг хэрэгжүүлж жирэмсэн болон хүүхэдтэй эхчүүдийн байрыг шинээр бий болгон засварлаж, тохижуулан хүүхдийн амрах, тоглох зэрэг шаардлагатай нөхцөлийг нь бүрдүүллээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.1.2-т “... шийтгүүлсэн этгээд жирэмсэн бол төрөхөөс өмнө 45 хоног, төрснөөс хойш 1 жилээс илүүгүйгээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болно” гэж заасан боловч мөн зүйлийн 332.2 дахь хэсэгт “Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдийн талаар гарсан тогтоол биелүүлэх явдлыг хойшлуулж болохгүй” гэсэн заалтыг үндэслэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтныг хууль тогтоомжийн дагуу 0-1 насны хүүхдийн хамт байлгаж байна. Өнгөрсөн хугацаанд тус хорих ангид ял эдэлж байсан эмэгтэйчүүдээс 35 ялтан амаржсанаас 24 нь төрөхөөс өмнө 45 хоног, амаржсаны дараа 1 жилийн хугацаагаар ял хойшлуулж, 4 нь 0-1 насны хүүхдийн хамт ял эдэлж байгаад ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдаж, 2 хүүхдийг ялтны ар гэрт нь, 2 хүүхдийг 1 нас хүрэхэд нь Нялхсын клиник сувилалд тус тус хүлээлгэн өгч шийдвэрлэсэн ба өнөөдрийн байдлаар 0-1 насны хүүхэдтэй 3 ялтан ял эдэлж, тэдгээр хүүхдүүдийн эрүүл мэндэд анхааран холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

### 2/ Хүний эрхийн үндэсний комиссын даргын тайлбарын агуулга:

Дархан-Уул аймгийн иргэн И.-гийн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдлийн зарим үндэслэлийг Хүний эрхийн үндэсний комисс дэмжиж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсгийн “ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэнтэй санал нэг байна. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг Үндсэн хууль зөрчсөн гэдэгтэй санал нийлэхгүй байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн, тус комиссоос Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа эмэгтэйчүүдийн 407 дугаар ангид 2006 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хийсэн шалгалтын тайланд “нярай хүүхэдтэй эхчүүдийн байрны өрөө гэрэлгүй, харанхуй”, “нярай хүүхэдтэй эхчүүдийн тасгийн угаалгын өрөө нь гал тогоог хөшгөөр тусгаарлаж хийсэн байсан нь эрүүл ахуйн шаардлагад огт нийцэхгүй байсныг онцлон тэмдэглэж байна.

**Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Иргэний хуульд зааснаар болон иргэний эрх зүйн шинжлэх ухааны ойлголт ёсоор иргэний эрх зүйн чадвар нь хүний төрсөн үеэс эхэлж, нас барснаар дуусгавар болдог учир эхийн хэвлийд байгаа ураг нь эрх зүйн харилцааны субъект байх үндэслэлгүй байна. Мөн гэр бүлийн гишүүд, төрөл, садны тухай ойлголтыг “Гэр бүлийн тухай” болон “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д тодорхой хуульчилсан бөгөөд тэдгээрт эхийн хэвлийд байгаа урагийг гэр бүлийн гишүүнд тооцохоор заагаагүй байна. Иймд хорих ял эдэлж байгаа жирэмсэн ялтны хэвлийд буй урагийг ял эдэлж буй мэтээр үзэх, өөрөөр хэлбэл ял эдэлж байгаа жирэмсэн ялтны ялыг түүний гэр бүлийн гишүүнд халдаан хэрэглэхээр хуульчилсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсгийн “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт нь Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.2 хэсгийн заалттай холбож хэрэглэгддэг зохицуулалт байна.

Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиудын дээрх заалтуудаас үзэхэд зөвхөн санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа амаржвал 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болохоор байна.

Хуулийн энэ зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-ийн “...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалтад нийцсэн, хүний эрхийн талаарх олон улсын баримт бичгийн заалтаар зөвшөөрөгдсөн хүрээнд байна.

Харин хорих ял эдэлж байгаа жирэмсэн эмэгтэйчүүд байрлах, тэднийг төрүүлэх, хорих ял эдэлж байгаа эхтэйгээ хамт байгаа 0-1 насны хүүхдийн байрлах байр, тэдгээрийн нөхцөлийг энэ талаарх олон улсын баримт бичигт заасан стандарт хэмжээнд хүргэн сайжруулах асуудлыг төрийн зүгээс анхааран хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-ын “Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна”, 111.5-ын “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “...гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2-т заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Хуулийг хэрэгжүүлэх шатанд Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа явдал нь Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд үл хамаарна. Тухайлбал, орчин нөхцөл нярай хүүхдийн өсөлт бойжилтод сөргөөр нөлөөлж байна гэдэг үндэслэл. Хэрэв Цэц иргэний мэдээллийн шаардлагыг хангаж Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл харин ч эсрэгээрээ хүүхдийн эрх ашгийг зөрчих нөхцөлийг бий болгох магадлалтай. Эмэгтэй ялтан хэдийгээр үйлдсэн гэмт хэрэгтээ ялаа эдэлж байгаа ч түүний эх байх эрхийг нь хязгаарлах эсэхэд хууль тогтоогч зөв зохицуулалт хийсэн гэх үндэслэлтэй. 0-1 настай нярай хүүхдэд эхийн сүү, эхийн хайр, энхрийллээс илүүтэй шаардлагатай зүйл гэж байхгүй нь хэн ч тодорхой. Хүндэвтэр болон хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн зориуд ял эдлүүлэх хугацааг нь хойшлуулаад хүүхдийг эхтэй нь байлгах явдлыг хангаж байгаа. Харин онц хүнд гэмт хэрэгтний хувьд ялыг нь хойшлуулах ямар ч боломж байдаггүй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2006.12.20 № 13**

**Засгийн газрын “Журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Э.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Эрүүл мэндийн дэд сайд О., Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Н.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх хэсэг “Засгийн газар... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”  
- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, захирамж гаргах”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Э.- гийн тайлбарын агуулга:  
Засгийн газраас 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Журам батлах



тухай” 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-ийн “Олимпийн наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах” гэсэн заалтыг зөрчин зөвхөн олимпийн наадамд ордог спортын төрлийн тамирчдад шагнал олгохоор хуулийг засварласан байдалтай гарсан нь олимпод ордоггүй спортын төрлийн тамирчдын хувьд тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргавал хөдөлмөрийнхөө үр шимийг үзэх, нийгмийн баталгаагаар хангагдах эрх нь хязгаарлагдаж, улмаар Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 болон Үндсэн хуулийн дараах заалтуудыг зөрчсөн шийдвэр болж байна.

Дээрх тогтоолоор Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д заасан “...тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчид Засгийн газрын мөнгөн шагнал авах” эрх, баталгаа нь олимпод ордоггүй спортын төрлийн тамирчдын хувьд хэрэгжих боломжгүй болж байгаа нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-ийн “Засгийн газар ... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” тухай заалтыг зөрчиж байна. Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор гарсан Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь хуулийнхаа заалттай ийнхүү зөрчилдөж байгаа нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-ийн “Засгийн газрын тогтоол хууль тогтоомжид нийцсэн байх” тухай заалтыг зөрчиж байна. Уг тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтуудыг засварлаж өөрчилсөн байдалтай гарсан нь “Хуульд өөрчлөлт оруулах тухай” Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг Засгийн газар зөрчсөн шинж чанартай байна. Мөн олимпийн наадамд ордог, ордоггүй гэдэг хандлага байдлаар спортын салбарынхныг эрхэлсэн ажил, сонгосон спортын төрлөөр нь ялгаварлан үзэх байдал бий болгосон нь олимпод ордоггүй спортын төрлийнхний хувьд сонирхлынхоо дагуу спортын төрлөө сонгон хөдөлмөрлөх, үр шимийг нь үзэх, хөдөлмөрөө үнэлүүлэх тэдний хууль ёсны эрхийг хязгаарлаж эрхэлсэн ажил, мэргэжлээрээ ялгаварлагдан гадуурхагдахгүй байх тухай Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх аятай нөхцлөөр хангагдах, хөдөлмөрөө үнэлүүлэх” тухай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу энэхүү тогтоолыг хуульд нийцүүлэн өөрчлөх, олимпийн бус төрлийнхний зөрчигдсөн эрхийг сэргээх, учруулсан хохирлыг арилгуулах талаар Засгийн газарт бүтэн жил санал, хүсэлт, шаардлага тавьж ирсэн ч асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа учраас асуудлыг шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хандаж байна. Иймд Үндсэн хуулийн дээрх заалтуудыг зөрчиж байгаа Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоолыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү.

## 2. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч О., Н. нарын тайлбарын агуулга:

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Улсын Их Хурлаас баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гарсан тогтоол юм. Афины олимпийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Олимпийн наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2001 оны 187 дугаар тогтоол гарч, уг тогтоолоор амжилт гаргасан тамирчдад мөнгөн шагнал олгох тухай журам батлагдсан боловч Афины олимпийн тоглолт дууссан, Биеийн тамир, спортын тухай хууль батлагдсантай холбогдуулан дээрх 187 дугаар тогтоолыг хүчингүй болгох шалтгаан болсон.

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолын агуулгыг хэт хавтгайруулан Үндсэн хуулийн олон заалтыг зөрчсөн мэтээр үзэх нь хууль зүйн үндэслэлгүй. Энэхүү тогтоолоор баталсан “Мөнгөн шагнал олгох журам” нь олимпод ордоггүй спортын

төрлийн тамирчдад хамааралгүй юм. Яагаад гэвэл Засгийн газар Биеийн тамир, спортын тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу “Мөнгөн шагнал олгох тухай” журам баталсан тогтоол гаргахдаа бүх спортын төрөлд олговол ямар нөхцөл үүсч болохыг судлан үзсэн. Өөрөөр хэлбэл Олимпийн Харти ёсоор Олимпийн хөтөлбөрт эрэгтэйчүүдийн оролцох спорт нь 4 тивийн 75-аас доошгүй оронд, эмэгтэйчүүд оролцох спорт нь 4 тивийн 50-иас доошгүй оронд, өвлийн наадамд 3 тивийн 25-аас доошгүй оронд өргөн дэлгэр хөгжсөн спорт орох боломжтой байдгийг харгалзсаны дүнд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн өргөн дэлгэр хөгжиж Олимпийн хөтөлбөрт орсон төрлүүдийг эхний ээлжинд хамруулахаар шийдвэрлэсэн.

Биеийн тамир, спортын салбарын эрхэм зорилгын нэг нь тамирчдын амжилтыг олимпийн түвшинд хүргэх явдал юм. Иймд олимпид орсон спортын төрлийг түлхүү хөгжүүлэх, түүгээр хичээллэж амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулахыг илүү анхаарсан. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол болон түүгээр баталсан “Мөнгөн шагнал олгох журам” нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1, Засгийн газрын тухай хуулийн 30.6, 30.8 дахь заалтууд болон Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тэдгээрт нийцүүлэн гаргасан учир хэлбэр, агуулгын хувьд хууль зөрчөөгүй. Түүнчлэн тогтоолыг гаргахад мэргэжлийн хуульчид, агентлаг, яам, Засгийн газрын түвшинд хянан үзсэн. Улсын Их Хурлаас олгосон бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газрын тухай хуулийн 30.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дэх заалтуудад нийцүүлэн Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор “Мөнгөн шагнал олгох журам” баталсан нь Засгийн газар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргасан учир бүхэлдээ Үндсэн хуулийн ямар ч заалтыг зөрчөөгүй, харин ч Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа болно.

Засгийн газар Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно” гэж Засгийн газрын тухай хуулийн 30.2-т заасны дагуу Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2005 оны 208 дугаар тогтоолоор “Мөнгөн шагнал олгох тухай” журам баталж түүгээрээ “олимпийн наадамд орох спортын төрөл” гэж тодотгосон нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон гэж үзэх үндэстэй байна. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дүгээр заалтад заасан Олимпийн наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдад мөнгөн шагнал олгож байгаа.

Тухайлбал, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол гарснаас хойш зөвхөн 2006 онд Оюутны дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Дэлхийн цомын аварга шалгаруулах буудлагын тэмцээн, Дэлхийн аварга шалгаруулах буудлагын тэмцээн, Оюутны дэлхийн аварга шалгаруулах боксын тэмцээн, Насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Ази тивийн хүндийн өргөлтийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн, Ази тивийн залуучуудын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээн, Өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Залуучуудын Азийн аварга шалгаруулах боксын тэмцээн, Өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах боксын тэмцээнд амжилт гаргасан тамирчдад Засгийн газрын мөнгөн шагнал олгосон.

Манай улсад Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй спортын 70 гаруй холбоо, 400 гаруй спортын клубууд үйл ажиллагаагаа явуулж байна. Хэрэв Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор мөнгөн шагнал авах тамирчдын спортын төрлийг тодотгож заагаагүй бол дээрх холбоод, клубууд нь өөрийн спортын төрлөөр цөөхөн хэдэн орны ижил төрлийн холбоодтой хамтран тив, дэлхийн тэмцээн зохион байгуулж медальт байранд шалгарсан тамирчин бүрт Засгийн газрын мөнгөн шагнал олгохоор бол улсын төсвөөс хэр хэмжээний мөнгө гарах нь тодорхой байгаа юм.

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоос өмнө тамирчдад олгож байсан мөнгөн шагналын судалгааг харуулбал,

2001 онд олимпын 3 спортын төрлийн 5 тамирчинд 23.7 сая төгрөгийн, олимпын бус 3 спортын төрлийн 44 тамирчинд 93.2 сая төгрөгийн, 2002 онд олимпын 6 спортын төрлийн 23 тамирчинд 96.2 сая төгрөгийн, олимпын бус 12 спортын төрлийн 104 тамирчинд 175.2 сая, 2003 онд олимпын 6 спортын төрлийн 29 тамирчинд 88.5 сая төгрөгийн, олимпын бус 6 спортын төрлийн 89 тамирчинд 136.2 сая төгрөгийн, 2004 онд олимпын 4 спортын төрлийн 111 тамирчинд 184.2 сая төгрөгийн шагналыг тус тус олгосон байна.

Зөвхөн 2001-2004 онд олгосон мөнгөн шагналын судалгаанаас үзэхэд нийт 874.5 сая төгрөг олгогдсоноос 603.7 сая төгрөг буюу 69.0 хувь нь олимпын бус төрөлд амжилт гаргасан тамирчдад олгосон байна. Мөн олимпын болон олимпын бус төрлийн дэлхий болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон улс орныг авч үзэхэд олимпын төрлийн дэлхийн аваргын тэмцээнд 30-100 орон хамрагдаж байгаа бол олимпын бус төрлийн тэмцээнд 15-20 орон, олимпын төрлийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 15-42 орон хамрагддаг бол олимпын бус төрлийн тэмцээнд 5-8 орон хамрагддаг нь судалгаагаар батлагдаж байна. 2001-2005 оны 9 дүгээр сар хүртэл мөрдөж байсан журмаар олгож байсан мөнгөн шагнал нь хэт хавтгайрсан, тамирчдын олимпын төрөлд амжилт гаргах сонирхлыг бууруулсан, Биеийн тамир, спортын салбарын “тамирчдын амжилтыг олимпын түвшинд хүргэх” зорилго алдагдах болсон зэрэг шалтгаанаас шалгуур үзүүлэлт зайлшгүй хэрэгтэй байсан нь эхний ээлжинд олимпын төрөлд багтдаг спортын төрөлд мөнгөн шагнал олгох шаардлагатай болсон явдал юм.

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 22.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж байна гэж үзэж байна. Тухайлбал, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Мөнгөн шагнал олгох тухай журам”-ын дагуу 2005 оноос хойш олимпын төрөлд багтдаг спортын төрлөөр тив, дэлхийн тэмцээнд амжилт гаргасан 66 тамирчинд 290.8 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 22.2.1 дэх заалтын дагуу тамирчид Засгийн газраас мөнгөн шагнал авах гэсэн баталгааг хангасан байна. Иймд Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-ийн “Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах”, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д “тамирчин олимпын наадам, дэлхий, тивийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлбэл Засгийн газраас мөнгөн шагнал... авах” гэсэн заалтыг “олимпод багтах спортын төрөл”-өөр гэж явцууруулж, мөн олимпын бус төрлөөр дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медаль авсан тамирчны хуульд заасан шагнал авах эрхийг хассан байна.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтыг зөрчсөнөөрөө Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-ийн “Засгийн газар... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин тавдугаар зүйлийн 1

дэх хэсгийн “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, захирамж гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн шинжтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолын үйлчлэлийг 2007 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай” гэсэн байна.

**“Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 13 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоолын агуулга:**

1. Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 208 дугаар тогтоолыг Биеийн тамир, спортын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, гаргасан шийдвэрээ Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар /Э.-д/-т даалгасугай.

#### **Тэмдэглэл:**

Олимпын болон олимпын бус төрөлд амжилт гаргасан тамирчдад олгох мөнгөн шагналын хэмжээг ялгаатай тогтоох эрх нь Засгийн газарт бий. Мөн спортын төрлийг олимпын, олимпын бусаар нь ангилж, төрийн бодлогоор спортын төрлийг түлхүү хөгжүүлдэг нь дэлхийн жишиг.

Хууль хоорондын зөрчил Үндсэн хуулийн зөрчил биш, тиймээс энэ талаархи маргааныг Цэц хянан шийдвэрлэхгүй гэсэн үзэл баримтлал Цэцийн практикт нэлээд зонхилсон байдаг. Маргаан үүсгэхээс татгалзсан Цэцийн гишүүний тогтоолд, мөн Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн Цэцийн зарим шийдвэрт ч энэ үндэслэл дурдагдсан байдгийг харж болно. Тэгвэл Засгийн газрын шийдвэр хуультай зөрчилдөх асуудал Үндсэн хуулийн зөрчил мөн үү. Логикийн хувьд төдийгүй дээрх үзэл баримтлал талаас нь шинжлэн судлахад энэ нь Үндсэн хуулийн зөрчил биш. Иймд Засгийн газрын шийдвэртэй холбоотой маргааныг Цэц цаашид хэлэлцэхдээ тухайн шийдвэр нь Үндсэн хуулийг шууд зөрчиж байна уу, эсхүл хууль зөрчих байдлаар Үндсэн хууль зөрчиж байна уу гэдэгт онолын тайлбар гаргах шаардлагатай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2007.03.07 № 01

### Засгийн газрын “Журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Н., Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх Т.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Н., Тамгын газрын зөвлөх Т. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурал 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа Засгийн газраас баталсан “Журам батлах тухай” 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 208 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 13 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн билээ. Нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулт, гаргасан саналыг судлан үзэхэд Засгийн газраас баталсан “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг бус Биеийн тамир, спортын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Тухайлбал, Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4-т “олимпийн наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах журмыг Засгийн газраас батлах,” мөн 22.2.1-д тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчид шагнал, урамшил авах эрхтэйг хуульчилсан юм.

Гэтэл Засгийн газар шийдвэрээ зөвхөн олимпийн наадмын тоглолтод багтдаг спортын төрлөөр уралдаан, тэмцээн, наадамд амжилт гаргасан тамирчдад урамшил олгож байхаар явцууруулан, хуулийн үзэл баримтлалыг зөрчиж гаргасан байна гэж Улсын Их Хурлын гишүүдийн олонхи үзжээ. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасны дагуу энэ асуудлыг Засгийн газар өөрөө, эсхүл Улсын Их Хурал хэлэлцэж хүчингүй болгох ёстой байтал, Үндсэн хуулийн цэц энэ асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргасан явдал Цэц өөрт нь үл харьяалагдах маргааныг хянан шийдвэрлэсэн байна гэж Улсын Их Хурал үзэж энэ үндэслэлээр 2007 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоол гарган “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 208 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Үүнд нэмж тайлбарлахад Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй” гэж зааснаас үзэхэд Засгийн газраас баталсан 2005 оны 208 дугаар тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх маргааныг Үндсэн хуулийн цэц хүлээн авч хянан шийдвэрлэх үндэслэлгүй байна.

2. Иргэн Э.-гийн тайлбарын агуулга:

1/ Үндсэн хуулийн цэц Засгийн газрын “Журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоол Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх маргааныг хянаж дүгнэлт гаргасныг Улсын Их Хурлын 2007 оны 4 дүгээр тогтоолд “... Үндсэн хуулийн цэц өөрт нь үл харьяалагдах маргааныг шийдвэрлэсэн байх тул...” гэсэн нь үндэслэлгүй байна. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Цэцээр харьяалагдан шийдвэрлэгдэх маргаануудыг нэр заан тогтоосон байх бөгөөд иймд Засгийн газрын тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн эсэх нь Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн. Харин Засгийн газрын шийдвэр хууль зөрчсөн тохиолдолд хүчингүй болгох асуудлыг Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2-т заасан субъектүүд хүсэхгүй бол маргаантай асуудлыг эрх бүхий субъектүүд Цэцэд хандан шийдвэрлүүлэх, Цэц асуудлыг авч хэлэлцэн дүгнэлт гаргах эрх үүргийг хязгаарлах гэсэн шинжтэй байна.

2/ Улсын Их Хурлын тогтоолд “... Засгийн газрын тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн тодорхой заалтуудыг зөрчсөн гэж дүгнэсэн нь үндэслэлтэй байна” гэж Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн үндэслэлийг хүлээн зөвшөөрчихөөд “Үндсэн хуулийн цэцийн 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй” гэсэн нь ойлгомжгүй байна.

3/ Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол гарсан 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс хойшхи 1 жил 6 сарын хугацаанд хохирсон иргэд, байгууллагын удаа дараагийн санал шаардлага, Цэцийн дүгнэлтийг үндэслэн Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг хэрэгжүүлэх хангалттай хугацаа өнгөрсөн ч тогтоолыг хүчингүй болгох, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хүсэл зориг Улсын Их Хурал, Засгийн газарт өнөөг хүртэл үгүй байна. Иймд Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар “Журам батлах тухай” Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолыг хүчингүй болгож өгнө үү.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-ийн “Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах”, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д “тамирчин олимпын наадам, дэлхий, тивийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлбэл Засгийн газраас мөнгөн шагнал... авах” гэсэн заалтыг “олимпод багтах спортын төрөл”-өөр гэж явцууруулж, мөн олимпын бус төрлөөр дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медаль авсан тамирчны хуульд заасан шагнал авах эрхийг хассан байна.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтыг зөрчсөнөөрөө Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-ийн “Засгийн газар... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, захирамж гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн шинжтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д зааснаар Засгийн газрын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай асуудлыг Үндсэн хуулийн цэцэд хянан шийдвэрлэхээр харьяалуулсан байдаг. Засгийн газрын

аливаа шийдвэр хууль зөрчсөнөөрөө Үндсэн хуульд нийцэхгүй байх, эсхүл шууд Үндсэн хуультай зөрчилдсөнөөрөө Үндсэн хуульд нийцэхгүй байх асуудлын аль аль нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан Засгийн газрын шийдвэр Үндсэн хуульд нийцсэнэсэх тухай маргаанд хамаарах учиртай.

Иймд Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 13 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн Улсын Их Хурлын 2007 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан “Журам батлах тухай” 208 дугаар тогтоол Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байх тул Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 13 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Улсын Их Хурлын 2007 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол нь гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөхийг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Энэхүү тогтоолоор Цэц урьд гаргасан дүгнэлтээ баталгаажуулснаас гадна цаашид Засгийн газрын шийдвэрийг хэрхэн хянах тухай зарчмын шинжтэй маргааныг хагалсан байдаг. Улсын Их Хурлын 2007 оны 4 дүгээр тогтоолд Засгийн газрын тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийг зөрчсөн гэж Цэц дүгнэснийг хүлээн зөвшөөрөх боломжтой гэсэн атлаа Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн логикгүй, заалтууд нь хоорондоо авцалдаагүй тогтоол гаргасан.

Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх үед ч, мөн их суудлын хуралдааны үед ч Улсын Их Хурлын гишүүд, итгэмжлэгдсэн төлөөлөгч нар Цэц өөрт үл хамаарах маргааныг хянан шийдвэрлэж байна, Засгийн газрын шийдвэр хуультай зөрчилдсөн явдал Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан бус, энэ тохиолдолд Засгийн газар өөрөө болон Улсын Их Хурал тухайн шийдвэрийг хүчингүй болгох хуулийн зохицуулалт байгааг тайлбарлаж, байр сууриа илэрхийлж байсан. Гэвч Цэцийн тогтоолын “тогтоох” хэсэгт Засгийн газар хууль зөрчсөн байна гэж Цэц дүгнээгүй. Харин Засгийн газрын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн болохыг нотлох байдлаар “үндэслэл” хэсэгтээ дурдсан байна.

Цэц тогтоолоороо “Засгийн газрын шийдвэр хууль зөрчих байдлаар Үндсэн хуульд нийцэхгүй байх, эсхүл шууд Үндсэн хуульд нийцэхгүй байх аль аль нь Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарна” гэж Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-ийн “...Засгийн газрын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх” гэсэн заалтыг тайлбарласан болно. Маргааныг хянан шийдвэрлэсэн Цэцийн шийдвэр Үндсэн хуулийн тайлбар болдгийн жишээ энэ буюу.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.01.10 № 01

## Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн П., Б.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль<sup>86</sup>

- 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг “Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө”

### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын 2004 оны мэдээний дагуу 100 тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа хувь хүний нэр дээр импортлогдон Монгол Улсын хилээр орж ирсэн. Энэ 100 тэрбум төгрөгийн импортын бараанд 15.75 тэрбум төгрөгийн НӨАТ-ыг дээрх иргэд улсын нэгдсэн төсөвт эрх бүхий байгууллагаар дамжуулан төвлөрүүлжээ. Харин дээрх иргэдэд “НӨАТ-ын буцаан олголтын сан”-гаас нэг ч төгрөгийн буцаан олголт хийгдээгүй байна. НӨАТ тайлагнагч 3873 этгээдээс зөвхөн 13 нь иргэн байна.

НӨАТ бол хувь хүн дээр шууд оногддоггүй харин тухайн хүнд үйлчилсэн үйлчилгээ ба бараанд оногдуулсан шууд бус хэлбэрийн татвар юм. Онолын хувьд НӨАТ бол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогчдын бараа эсвэл үйлчилгээнд нэмэгдүүлсэн өртөгт ноогдсон татвар. Гэхдээ НӨАТ нь хэрэглээнд оногдох татвар бөгөөд НӨАТ-ыг төлөгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгөөр худалдан авч байгаа эцсийн худалдан авагч. Үйлдвэрлэгч эсвэл борлуулагч нь зөвхөн НӨАТ-ыг эцсийн хэрэглэгчдээс хураан авч улсад тушааж байгаа тайлан гаргагч болно. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгч болон борлуулагч нь НӨАТ-ыг аваад өөрийнхөө дамжлагад төлсөн НӨАТ-аа тэр цуглуулсан

86 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 40-д нийтлэгдсэн



НӨАТ дээр нэмээд улсад тушаана гэсэн үг. Хэрвээ илүү төлсөн бол улсаас буцаан авч болно.

НӨАТ нь эцсийн дүндээ аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэг тайлан баланст оруулдаг, сүүдрийн эдийн засаг буюу хар зах зээлийг арилгах, багасгах, мөнгөний урсгалыг төр өөрийн хяналтад байлгаж, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах механизм юм. Монгол Улс нь 1998 оны 1 дүгээр сарын 8-наас эхлэн Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг мөрдөж эхэлсэн бөгөөд 2006 оны 7 сард дахин шинэчлэн боловсруулж 2007 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж гэж байна. Манай улсад НӨАТ-ыг хэрэглэхдээ 10.0 сая ба түүнээс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн НӨАТ төлөгч байна гэж зааж өгсөн нь НӨАТ-ын үндсэн мөн чанарыг гажуудуулж Үндсэн хуулийн үзэл баримтлал, тодорхой зүйл, заалтыг зөрчихөд хүргээд байна. Манай улс өнөөдрийн байдлаар ойролцоогоор 4000 субъект л НӨАТ тайлагнагч буюу төлөгч. Үлдсэн 28000 аж ахуйн нэгж, байгууллага, хэдэн арван мянган иргэд /хувиараа хөдөлмөр эрхлэгчид/ нь НӨАТ төлөгч биш. Эдгээр иргэдийн нэрээр орж ирсэн барааны гааль дээр төлсөн НӨАТ нь улсын төсөвт шууд орсон боловч энэхүү иргэд маань НӨАТ төлөгч биш гэсэн ангилалд хамаарагдан НӨАТ-ын буцаан авалтын сангаас хүртэх эрхгүй юм. Жишээ нь, 2003 оны байдлаар дөнгөж 13 иргэн НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн байна.

Хамгийн гол нь энэхүү барааг цааш нь авч дамжуулан борлуулж байгаа этгээд болон үйлдвэрлэлдээ түүхий эд материал болгон хэрэглэж байгаа үйлдвэрлэгч нар тухайн анхны иргэд нь НӨАТ-ын падан бичиж өгөөгүй гэдэг үндэслэлээр тэдгээрийн гааль дээр төлөгдсөн НӨАТ-ын зардлыг өөрөө төлөх НӨАТ-аасаа хасч чаддаггүй. Иймд тухайн барааны гааль дээр төлөгдсөн НӨАТ дээр дахин НӨАТ-ын татвар нэмж улмаар 2 удаа давхардсан НӨАТ-тайгаар эцсийн худалдан авагчид борлуулж тэдгээрийг хохироож байна. Эсвэл тухайн барааг борлуулалтаа оруулалгүйгээр орлогоо нуун дарагдуулж хуурамч тайлан баланс гаргах хууль бус үйлдэл рүү түлхэж байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд энэхүү 10 сая төгрөгийн борлуулалтын орлогоны доогуур орох гэж чармайх нь бүгдийг гэмт хэрэгтэн болгох хууль зүйн үндэслэлийг бүрдүүлж байна. Ямар шалтгаанаар эцсийн худалдан авагч төлдөг НӨАТ-аас аж ахуйн нэгж, иргэд айгаад байна вэ. НӨАТ-ын тайлан гаргах процессыг Татварын ерөнхий хууль, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн зохицуулалтын хүрээнд хэт хамааруулсанаас болж НӨАТ-ын тайлан гаргах явц нь хууль зүйн алдаанд хүргэсэн. Өөрөөр хэлбэл Татварын ерөнхий хуульд заасны дагуу НӨАТ-ын тайланг мөнгөн сууриар тайлагнах уу, эсхүл Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан бэлтгэн нийлүүлэгч, борлуулагч “нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар тайлангаа гаргах уу гэдэг нь ойлгомжгүй болсон.

Гэтэл Англи, АНУ-д НӨАТ төлөгч нь анх аж ахуйн нэгжээ бүртгүүлэхдээ НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг. Гэхдээ “мөнгөн суурь”, эсвэл “аккруэл суурь”-ийн аль нэгийг сонгодог. Мэдээж бүх аж ахуйн нэгж мөнгөн суурийг сонгохыг оролддог боловч ямар үйл ажиллагаа эрхлэхээс нь хамаараад татварын газар аль нэгээр нь сонгуулдаг. Өөрөөр хэлбэл энэ хоёр суурьт алинд нь хамаарахаас шалтгаалж НӨАТ-ын гэрчилгээнд тухайн сонгосон суурийн кодыг тавиулж, НӨАТ-ын тайлан гаргах хугацааг 2, 3, 6, 12 сар гэх мэтээр нарийн тодорхой зааж өгдөг. Харин Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд мөнгөн болон аккруэл суурийн аль алиныг нарийвчлан тодорхойлоогүй, яаж хэрэглэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь нэг талаас хууль хэрэглэх эрх бүхий албан тушаалтан өөрийн дур зоргоор авирлах хууль зүйн боломжийг олгож байгаа, нөгөө талаас хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага орлогоо нуун дарагдуулах зэргээр хар зах зээл бий болох хууль зүйн болон эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх үндэслэл болсон НӨАТ-ын тухай хуулийн 9.3-ын “Жилийн 10 сая ба түүнээс доош төгрөгийн татварын ноогдох борлуулалтын орлоготой үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. Энэ заалт импортлогчдоод хамаарахгүй” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгүүдийг тус тус зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч П., Б. нарын тайлбарын агуулга:

Иргэн Л., Б. нар Үндсэн хуулийн цэцэд өгсөн нэмэлт тайлбартаа “Манай улсад нэмэгдсэн өртгийн албан татварыг хэрэглэхдээ 10 сая ба түүнээс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна гэж зааж өгсөн нь нэмэгдсэн өртгийн албан татварын мөн чанарыг гажуудуулж Үндсэн хуулийн үзэл баримтлал тодорхой зүйл заалтыг зөрчихөд хүргээд байна” гэж үзжээ. Татварын бодлогын хувьд тэгш байдал, тэгш эрхийн зарчим алдагдсан, ялгаварлан гадуурхах байдлыг бий болгож байгаа тухай асуудлыг хөндөн тавихдаа уг ялгаатай хандсан нөхцөл байдлын үндэслэлийг хууль зүйн талаас нь тодорхойлох ёстой.

Ижил бөгөөд харьцуулж болох нөхцөлтэй этгээдүүдийн хувьд хуулиар тэгш бус байдал, ялгаварлыг бий болгосон бол түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Бидний нөхцөлд тухайлбал 50 /10 саяын босгоос дээш/ сая төгрөгт бизнес явуулж байгаа болон 5 /10 саяын босгоос доош/ сая төгрөгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийг хооронд нь ижил бөгөөд харьцуулж болох түвшинд байна гэж үзэхгүй. Тиймээс тэдэнд үйл ажиллагааны цар хүрээ болоод өрсөлдөх чадварыг нь харгалзан хуулиар татварын өөр нөхцөлийг бий болгосон нь Үндсэн хуулийн оршилд заасан шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй юм. Татвар төлөгчдийн эрхэлж байгаа үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, хэмжээнээс хамаарч татварын ялгамжтай бодлогыг татвар төлөгчдөд хөнгөлөлт, чөлөөлөлт хэлбэрээр эдлүүлэх, татварын хувь, хэмжээг ялгавартай тогтоодгийг хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим зөрчигдлөө, хөрөнгө чинээ, ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхлаа гэж үзэж болохгүй.

Түүнчлэн аливаа татвар төлөлт, ногдуулалт, тайлагналтын процесс нь өөрөө татвар төлөгчид хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай ойлгомжтой, хялбар, үр ашигтай, зардал бага байх зарчимд тулгуурладаг. Татварын бодлого зөв байх дээр дурдсан үндсэн ойлголтуудад үндэслэгдэн татварыг ялгамжтай тогтоох, түүний дотор 10 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Дашрамд дурдахад нэмэгдсэн өртгийн албан татварын ийм хөнгөлөлт, чөлөөлөлт дэлхийн бүх оронд мөрдөгдөж байгаа билээ.

Иргэн Л., Б. нараас Үндсэн хуулийн цэцэд гаргасан нэмэлт тайлбарт 10 сая төгрөгөөс доош хэмжээгээр бараа импортлосон этгээдэд албан татварын буцаан олголт хийхгүй байгааг дурджээ. Импортлогч нь хилээр оруулсан бүтээгдэхүүндээ нэмэгдсэн өртгийн татварыг төлж байгаа хэдий ч цааш худалдан борлуулахдаа нэмэгдсэн өртгийн татвартай үнээр худалддаг тул нэмэгдсэн өртгийн татвар ногдуулснаас эдийн засгийн хувьд импортлогчдод хүлээх алдагдал байхгүй. Мөн өргөдөлд “...импортлоход төлсөн нэмэгдсэн өртгийн татварыг үйлдвэрлэгчийн төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасалт хийхгүй байгаа, энэ байдлаас тайлан гаргахаас зайлсхийдэг, хууль бус үйлдлээ нуун дарагдуулдаг, нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан гаргахад Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигддөгөөс татвар төлөгчдийг хохирч байгаа нь энэхүү эрх зүйн орчинтой холбоотой” тухай дурджээ. Энэ нь дээрх хуулийн заалттай шууд холбоотой бус харин хуулийг хэрэгжүүлэх шатанд гарч байгаа алдаа дутагдалтай, ажил хариуцсан хүмүүсийн үйл ажиллагаатай холбоотой гэж үзэж байна. Хэрэв өргөдөлд дурдсан байдлаар татвар төлөгчдийг хохироож байгаа бол хуулийн дагуу асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх ёстой.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд тодорхой хязгаарлалт тогтоож татвар төлөгч зарим этгээдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал байх тул Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /

импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, Арван хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Харин хязгаарлалт тогтоохдоо сүүдрийн эдийн засгийг бууруулах, санхүүгийн илүү оновчтой тогтолцоог бий болгох, татвар төлөгчдийн хувьд илүү шударга нөхцөл байдлыг бүрдүүлэх явдалд Улсын Их Хурал цаашид анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2-т заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурал албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засгийн үндсэн чиглэлийг тодорхойлох бүрэн эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, нэмэгдсэн өртгийн албан татварыг тогтоох, нэмэгдсэн өртгийн албан татвараас хэнийг чөлөөлөх зэрэг нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарах юм.

Дашрамд дурдахад НӨАТ нь 1754-1755 онд “Улсын нийтийн татвар” /латинаар “accise”/ нэртэйгээр үүссэн гэж үздэг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.02.23 № 02

**Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөг хуваарилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Х.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., О.

### **Үндсэн хуулийн зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр батласан Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль<sup>87</sup>

- Хоёрдугаар бүлгийн 7 дугаар зүйл
- Дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар зүйл
- Дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 1 дэх заалт
- Дөрөвдүгээр бүлгийн 2 дугаар хавсралтад заасан “2007 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
  - Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно”
  - Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”
  - Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт “...улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх”
  - Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”
  - Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”
  - Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно”
  - Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

87 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 47-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Х.- гийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын 2007 оны нэгдсэн төсвийг хэлэлцэн батлахдаа, төсвийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд оруулах Засгийн газрын онц эрхийг зөрчин зарим гишүүд санаачлан Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөг хуваарилан шадар сайдын багцад суулган, Улсын Их Хурлын гишүүдийн эрх мэдлээр захиран зарцуулах анхны санаачилга олон нийтийн ихээхэн эсэргүүцэлтэй тулгармагц “зүсийг нь буруулж, зүгийг нь даялуулан” Улсын Их Хурлын гишүүдээр жагсаалт гаргуулан, сайд нарын багцад тараан байршуулах замаар биеллээ олж батлагдсан байна. Ийнхүү олон нийтийн төдийгүй Улсын Их Хурлын гишүүдийн хувьд ч маргаантай байсаар байгаа асуудлыг нэг мөр эцэслэн шийдвэрлүүлж, Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулах нь зүйтэй хэмээн үзэж байна. Анхлан 10 саяар эхэлж, өнгөрсөн жил 100 сая, өдгөө 250 сая болтлоо өсөн, үржиж хэвийн үзэгдэл, жишиг болон тогтож Үндсэн хуулиар тогтоосон Засаг төрийн эрх мэдэл хуваарилсан зарчим ноцтойгоор зөрчигдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Засаг төрийн гүйцэтгэх болон орон нутгийн өөрийн удирдлагын бүрэн эрхэд халдан Улсын Их Хурлын төсвийн байнгын хороогоор хэлэлцэн Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт, Улсын Их Хурлын гишүүн бүрт 250 сая, бүгд 19 тэрбум төгрөгийг хуваарилан, гишүүдийн гаргасан жагсаалтаар сайд нарын багцад суулган баталсан Улсын Их Хурлын 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүдийн гаргаж өгсөн жагсаалтаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хэлэлцэж Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийг хуваарилан салбар хариуцсан сайд нарын 2007 оны төсөвт оруулж баталсан /бүгд 19 тэрбум төгрөг/ Улсын Их Хурлын 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн шийдвэрийг хянан хэлэлцэж, хүчингүй болгож, Үндсэн хуулийг чандлан сахиулахыг хүсье.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., О. нарын тайлбарын агуулга:**

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн Хоёрдугаар бүлгийн 7, Дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар зүйл, дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дугаар хавсралтад заасан 2007 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй талаар дараах дэлгэрэнгүй тайлбарыг өгч байна:

1/ Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчсөн тухайд:

Монгол төрийн үйл ажиллагааны нэг үндсэн зарчим нь шударга ёс юм. Шударга ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга бол аливаад алагчлахгүй хандаж шийдвэрлэх явдал билээ. Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаандаа Үндсэн хуулийн энэ заалтыг гуйвалтгүй мөрдөн ажиллаж байгааг энэ дашрамд тэмдэглэх нь зүйтэй юм. Төрийн үйл ажиллагаанд тэгш байдлын зарчим нь юуны өмнө төр, иргэн хоёр харилцан тэгш үүрэг хариуцлага хүлээх байдлаар хэрэгждэг. Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим нь хууль тогтоомжийг боловсруулах, батлах үйл ажиллагаанд Үндсэн хуулийг дээдлэх явдал гэж үзэж байна. Монгол Улсын Их Хурал 2006 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан билээ. Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийн төслийг хэлэлцэн батлахдаа Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийг дээдлэн, хуулийн холбогдох заалтыг иш үндэс болгосон юм. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд энэ зүйлийн 7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэж заасан байдаг бөгөөд энэ бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурал төсвийн төслийг хэлэлцэн баталсан. Мөн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33 дугаар зүйлд Улсын Их Хурал улсын төсөв батлахдаа төсвийн дор дурдсан баримт бичиг, хуулийн төслийг хэлэлцэн батална гэж заасан. Үүнд:

“33.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт дараах зүйлийг тусгана:

33.2.1. улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, бусад этгээдээс худалдаж авах бүтээгдэхүүнийг анги бүрээр;

33.2.2. улсын төсвөөс төлөх тэтгэвэр, тэтгэмж, бусад зарлагын төрөл, анги бүрээр;

33.2.3. өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад зардлыг зардлын төрөл бүрээр;

33.2.4. улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын төсөл бүрээр”.

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалтын хуваарилалтыг хийхдээ орон нутгийн санал, ард түмний элч, иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлагч Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзсан нь тэдгээрийн сонгогчдын шууд эрх ашгийг нь хамгаалах, хүн амын тоог харгалзсан нь нийт иргэдэд төсвийн хөрөнгө тэгш шударгаар хуваарилагдах зарчмаас урган гарч байгаа бөгөөд ингэснээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэгш байдал, шударга ёсны зарчимд нийцэж байгаа болно.

2/ Гуравдугаар зүйлийн 2-т “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар завдах гэдэг нь уг эрх мэдлийг хууль бусаар авах зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг ойлгодог билээ. Ийм үйл ажиллагааны хэлбэр нь төрийн эрх мэдлийг авах зохион байгуулалттай ажиллагаа хийсэн тухайлбал, бослогод бэлтгэх, олон нийтийг хамарсан самуун дэгдээх, засгийн эрх мэдлийг авах ажиллагааг удирдан зохион байгуулсан зэрэг үйл ажиллагаа байдаг. Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийг хэлэлцэн батлах үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн энэ заалтад хамаарах ямар нэг үйл ажиллагаа болоогүй бөгөөд гагцхүү Үндсэн хуулиар олгогдсон онц бүрэн эрхийнхээ дагуу ажилласан болохыг тэмдэглэн хэлэх байна.

3/ Гучин наймдугаар зүйлийн 2.2-т “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэж заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Засгийн газар нь Үндсэн хуулийн энэ заалтад заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад хуульд заасан тодорхой эрхийг хэрэгжүүлдэг. Энэ дагуу Улсын Их Хурлаас баталсан 2007 оны төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2007 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа эдийн засагт гарсан таатай нөхцөл, гадаад зах зээлийн үнэ ханшийн өсөлтийн улмаас бий болж байгаа санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг хуримтлуулж, бодит салбарыг хөгжүүлэх дэд

бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалт хийх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан төсвийн бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг индексжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, түүний хүртээмж, тоо чанарыг ахиулахад анхаарсан юм.

Улсын Их Хурал Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийг батлан гаргахдаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33.2.4-ийг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2007 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж бүрээр жагсаалтыг баталсан. Энэ ажиллагаа нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн биш харин Үндсэн хуулийн энэ заалтын хүрээнд явагдсан ажиллагаа гэж үзэж байна.

4/ Жаран хоёрдугаар зүйлийн 1-д “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”, Жаран хоёрдугаар зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж тус тус заасныг зөрчсөн гэсэн тухайд:

Монгол Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх тодорхой хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийг Улсын Их Хурлын гишүүд болон аймаг, нийслэлийн ИТХ-ын саналыг үндэслэн төсөв захирагчдын багцаар дамжуулан баталсан нь төсвийн харилцааг зохицуулсан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль болон хууль тогтоомжийн хүрээнд нийцэж байгаа юм. Аливаа сонгогчид өөрийн мандатаар дамжуулан эрх ашиг, сонирхлоо илэрхийлдэг нь дэлхий нийтэд тогтсон жишиг юм. Улсын Их Хурлын гишүүд ч тухайн тойргийнхоо бүс нутгийн хөгжил, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр тодорхой санал гаргаж Улсын Их Хурлаар дэмжүүлэн батлуулж байгаа нь энэхүү жишгийг дагасан хэрэг болно.

Монгол Улсын 2007 оны төсвөөр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ийнхүү баталж байгаа нь нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдэж байгаа бус гагцхүү Улсын Их Хурал өөрт Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн байна. Ийм учраас Үндсэн хуулийн энэ заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл байхгүй байна.

5/ Далдугаар зүйлийн 1-д “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн тухайд:

Дээр дурдсан тайлбаруудаас үзвэл Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7, дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар зүйл, дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дугаар хавсралтад дурдсан 2007 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтууд нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд улсын төсвийн байгууллага, ард иргэдийн эрх ашигт бүрэн нийцсэн хэрэгжих бүрэн үндэстэй шийдвэр гэж үзэж байна.

Энэ бүхнээс үзэхэд Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн заалтууд Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай

хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль болон бусад хуулиудад нийцэж байгаа бөгөөд Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдсэн асуудал тул Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байгаагаа үүгээр тайлбарлаж байна.

3. Иргэн Х.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын гишүүн бүрийн гаргасан жагсаалттай танилцаагүй боловч “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийг батлахдаа гишүүн бүр тойрогтоо 250.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалт нэрээр салбарын сайд нарын /төсвийн ерөнхийлөн захирагчдын/ багцад тараан байрлуулж баталсан нь миний өргөдөлдөө дурдсан баримтууд болон Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчдийн тайлбараас тодорхой байна.

1/ “Шударга ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга бол аливаад алагчлахгүй хандаж шийдвэрлэх явдал” гэснийг зөвхөн үүгээр хязгаарлан, хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай юм. “Засаг төр бол Үндсэн хууль хийгээд бусад хуулийг ягштал мөрдөж, түүний “хүрээнд” биш яг зааснаар нь ажилладаг /заалтаас гажвал эрхээ хэтрүүлсэн, үүргээ умартсан хэрэг болно/ Иргэд бол хуулиар хориглоогүйг хийж чөлөөтэй амьдардаг” байх нь Үндсэн хуулиар тунхаглан тогтоосон Улсын Их Хурлаас үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ардчилсан ёс, шударга ёсны зарчим бөгөөд аливаа хуулийг зөрчөөгүй, зөрчихгүй байх нь шударга ёсны үнэлэмж гэж үзэж байна.

2/ “Төрийн үйл ажиллагаанд тэгш байдлын зарчим нь юуны өмнө төр, иргэн хоёр харилцан тэгш үүрэг хариуцлага хүлээх байдлаар хэрэгждэг” гэснийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү юм. Учир нь төр, иргэн хоёр нь Үндсэн хууль болон бусад хуулиар өөр өөр үүрэг хүлээж, эрх эдэлдэг бөгөөд тэр л эрх үүргийнхээ дагуу хариуцлага хүлээдгийг ингэж хялбарчилж боломгүй.

3/ “Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим нь хууль тогтоомжийг боловсруулах, батлах үйл ажиллагаанд Үндсэн хуулийг дээдлэх явдал гэж үзэж байна” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Энд төр гэдэгт зөвхөн Улсын Их Хурал ч хамаардаг бус гэдгийг ойлгоогүй эсвэл ойлгохыг хүсээгүй бололтой. Хууль дээдлэх гэдэг нь зөвхөн хууль боловсруулах, батлах үйл ажиллагаанд төдийгүй түүнийг хэрэгжүүлэх, хянах бүхий л үйл ажиллагаанд хуулийг дагаж мөрдөх, ягштал биелүүлэх тухай ойлголт гэж үзэж байна.

4/ Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг хэлэлцэж болох” гэж заасан нь өөрийн эрх мэдэлд хамаарахгүй асуудлыг булаан авч шийдвэрлэж болох тухай ойлголт биш харин алдаа, оноог хэлэлцэн эрх мэдлийн бусад байгууллага шаардлагатай гэж үзвэл төсөл, шийдвэртээ тусгаж байх тухай ойлголтоос ангид авч үзэх боломжгүй юм. Мөн зүйлийн 7-д “... улсын төсөв... батлах” гэсэн заалт нь Засгийн газарт хамаарах Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2-ын “... улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэсэн эрхэд халдан улсын төсвийг зохиож батлах гэсэн ойлголт биш юм. Харин Засгийн газраас боловсруулан оруулсан төслийг хэлэлцэн шаардлагатай гэж үзсэн саналыг Засгийн газар төсөлдөө тусган дахин боловсруулах замаар эцэслэгдсэнийг батлах тухай ойлголт юм. Энэ үүднээс миний бие Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-ын 2 дахь заалтыг зөрчин Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо 250.0 сая /бүгд 19.0 тэрбум/ төгрөгийн төсөв боловсруулан, жагсаалт гаргаж, сайд нарын багцад тараан байрлуулж батлан гүйцэтгэх эрх мэдэлд халдсаныг зохион байгуулалттайгаар Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг... хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа юм.



5/ Аймгийн Засаг дарга нарын уулзалт дээр “Зарим аймаг Улсын Их Хурлын гишүүдтэй ярилцсан зүйл ч байна. Ярилцаж амжаагүй ч байна. Үүнийг орон нутгийн иргэдийн хүсэн хүлээгээд байгаа зүйл рүү Засгийн газар чиглүүлсэн нь дээр байх. Улсын Их Хурлын гишүүний мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, цухалзсан байгаа юм болов уу. Улсын Их Хурлын гишүүний санаачилга гэхээсээ аймаг, орон нутаг, Засгийн газрын хэрэгжүүлэх ажил болгон тавимаар байна. Болж өгвөл ерөнхий дүнг Улсын Их Хурал баталж өгөөд орон нутаг оновчтой ажиллах зарчмыг бүгдээрээ хөөцөлдвөл яасийм”. Эндээс авч үзвэл Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчид тайлбартаа “орон нутгийн саналыг харгалзан” гэж бичсэн нь чухамдаа 2000 онд Үндсэн хуульд дахин халдахдаа “ард түмний захиалга” нэрийн дор урьдчилан бэлтгэсэн “талархлын бичиг”-т “дуулгавартай” хэдэн сэхээтний гарын үсэг зуруулж, нийтлүүлж байсантай агаар нэгэн “амташсан хэрээ 13 дахиын” үлгэрийг үзүүлэн яаруу, сандруу санал солилцсон дүр эсгэж, олон түмнийг төөрөлдүүлэх арга мэх гэж үзэж байна.

6/ Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчид тайлбартаа “төрийн эрх мэдлийг хууль бусаар авахаар завдах гэдэг нь уг эрх мэдлийг хууль бусаар авах зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг ойлгодог билээ. Ийм үйл ажиллагааны хэлбэр нь төрийн эрх мэдлийг авах зохион байгуулалттай ажиллагаа хийсэн тухайлбал, бослогод бэлтгэх, олон нийтийг хамарсан самуун дэгдээх, засгийн эрх мэдлийг авах ажиллагааг удирдан зохион байгуулсан зэрэг үйл ажиллагаа байдаг” гэсэн байна.

Эдгээр нь хэлбэрийн хувьд дээрх заалтад хамаарах боловч хууль зүйн талаасаа иргэний эрх зүйн бус эрүүгийн эрх зүйн зохицуулалтаар шийдвэрлэгдэх хэлбэр юм. Харин Улсын Их Хурлын гишүүд тойрогтоо 250.0 сая төгрөг хуваарилахаар санаачилга гарган шийдвэрлэсэн нь зохион байгуулалттай хийгдсэн учир “зохион байгуулалттай үйл ажиллагаа гэдэг” гэсэнтэй санал нэг байна. Миний өргөдөлд дурдсан нэхэмжлэлийн шаардлага нь Үндсэн хуулиар эрх мэдэл хуваарилан тогтоосон бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчдийн зүгээс зохион байгуулалттайгаар гүйцэтгэх эрх мэдлийн улсын төсөв боловсруулан Улсын Их Хуралд өргөн хэлэлцүүлж, батлуулах эрхэд 19.0 тэрбум төгрөгийн хязгаарт халдан, авч хэрэгжүүлсэн тухай мөн дараагийн сонгуульд давуу байдлыг урьдчилан бүрдүүлж “сонгууль /санал/ луйвардах” замаар хууль тогтоох эрх мэдлийг авахаар завдсан байж болох асуудал гэдгийг ойлгохыг хүсээгүй, ойлгосон ч “бултах” арга зам хайж, хаацайлах гэсэн тайлбар гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч хоригтоо “...дараагийн Улсын Их Хурлын сонгууль тэгш эрхийн үндсэн дээр шударга явагдах боломж алдагдах нөхцөлийг урьдчилан бүрдүүлсэн” гэсэн бол хууль цаазын утга зохиолд тэмдэглэснээр “төр засагт хамаатай хамаагүй юм амлаж өр тавьчихаад салам нэхэгддэг занганд орж... амласандаа хүрдгээ харуулах, нөгөөтэйгүүр ирэх сонгуулийн барьцаа болгож төсвийн хэдэн төгрөгийг учир зүггүй өрсөлдөн тарааж... сонгууль /санал/ луйвардах нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авахыг завдах гэсэн Үндсэн хуулийн заалтад хамаатай” болохыг тодорхойлсонтой нийцэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Нэг. Монгол Улсын Их Хурал “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийн төслийг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын зарим гишүүдийн гаргасан саналын дагуу гишүүдээр жагсаалт гаргуулж Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагч нар болон шадар сайдын багцад тараан байршуулж, хөрөнгө оруулалтын жагсаалтыг хавсралтаар баталсан болох нь Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2006 оны 10 дугаар сарын 26, 27, мөн 11 дүгээр сарын 21, 26, 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан, Улсын Их Хурлын 2006 оны намрыг ээлжит чуулганы Төсвийн байнгын хорооны 2006 оны 11 дүгээр сарын 20, 29-ний өдрийн хуралдаан, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 186 дугаар тэмдэглэлүүд,

Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.-гийн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө оруулалтын саналын жагсаалт зэргээс тодорхой харагдаж байна. Тухайлбал:

1/ Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О. хэлэхдээ: “Орон нутагт өгч байгаа 500 саяа больё гэсэн. Сумдад 10 сая өгдөгөө хэвээр нь байлга. Харин 500 саяа Улаанбаатар хотын 20 гишүүнээ нэмээд 76 гишүүнээ бүгдийг нь оруулаад 250, 250 саяар тойрог болгонд өгье. Гэхдээ томьёоллын хувьд юу гэсэн бэ? гэхээр түрүүн бид нар 100 сая дээр хориг авч байсан, шүүмжлэлд өртөж байсан учраас ерөөсөө бүс нутгийн хөгжлийн асуудалд зориулсан багцаа шадар сайд дээр хийчихээд, гишүүдтэйгээ зөвлөөд явдгаар ийм зохицуулалт хийе гэснийг манай гишүүд онцгой анхаарчих хэрэгтэй. Бид нар хоригт ороод эвгүй байдалд орчих вий гэж бодож байна. Ерөөсөө гишүүдэд, 76 хүнд 250 сая, 250 саяар бодоод, тэгээд тойргийнхоо тоогоор очно биз. Тэр 250 саяынхаа хүрээнд тохирьё гэсэн ийм л зүйл ярьсан” гэжээ.

Мөн хуралдаан дээр Сангийн сайд Б. хэлэхдээ: “2006 оны төсвийн чөлөөт үлдэгдэл 100 тэрбум төгрөгийг Улсын Их Хурлаас гарч ажилласан 2 ажлын хэсгийн санал болгож байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах нь зүйтэй гэж ярьсан. Байнгын хороод дээр яригдсан саналуудыг нэг бүрчлэн шүүж үзлээ. Ерөнхийдөө Улсын Их Хурлын гишүүдэд 250, 250 сая төгрөгөөр тооцож шадар сайдын төсвийн багцад 19 тэрбум төгрөгийг суулгая гэж шийдсэн учраас бид аймаг руу хандсан, тусгай тойрог руу хандсан саналуудыг 250-д нь багтаах чиглэлээр ажиллахаас өөр ямар ч арга байхгүй. Орон нутгийн хөгжлийг дэмжихэд 10 тэрбум төгрөг байгаа, 76 гишүүнээрээ бодохоор 19 тэрбум төгрөг шаардлагатай болж байгаа. Тийм учраас нэмж 9 тэрбумыг суулгалаа” гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Б. хэлэхдээ: “Нийт саналуудыг нь шүүгээд үзсэн чинь 70, 80 хувь нь дандаа тойрог руу хандсан ийм саналууд байсан. Бид тэрийг шүүж үзээд Их Хурлын гишүүн болгонд 250, 250 саяыг өгье. Ер нь тэгээд тойрог руу хандсан саналуудаа татъя гэсэн зарчим дээр ажлын хэсэг дээр ярьсан” гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн, МАХН-ын бүлгийн ахлагч И.: “Тэгэхээр энийгээ нэг гишүүнд дунджаар 250 сая гэж бодоод, ингэж нийтэд зарлахгүй, орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт гэж нэрлээд 76 гишүүнд тус бүр 250 сая гэж бодоод 19 тэрбум болж байгаа юм. 9 тэрбум төгрөгөөр орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт нэмэгдэнэ” гээд санал хураалгаж 100 хувь дэмжигдсэн байна.

2/ Монгол Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б., Төсвийн байнгын хорооны дарга У.-гаас асуухдаа: “250 сая төгрөгийн тухайд нийгмийн санаа бодол их таагүй байгаа, энийг Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэж байхдаа анхаарч үзсэн үү. Яагаад гэвэл наадах чинь Төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг зөрчиж орж ирээд байгаа зүйл шүү дээ. Тэр 250 сая төгрөг чинь төсвийн ерөнхийлөн захирагч нараар дамжилгүйгээр шууд Улсын Их Хурал дээр ороод ирсэн байхгүй юу” гэхэд У.: “хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг хянаж үзээд тэгээд эцсийн шийдвэр гаргахдаа хуульдаа нийцүүлээд эрх захирагч нэг бүрээр нь одоо ингээд заагаад объектой, төсөлтэй нь батлаад өгчихнэ гэж тогтсон юм” гэсэн байна.

3/ Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн О. хэлэхдээ: “Гишүүд одоо аймгийнхаа, бүс нутгийнхаа саналуудыг өгсөн. Зөвлөл, бүлгээрээ өгсөн байгаа. За бусад гишүүд ер нь бүх гишүүд өгчихөж байгаа. Тэгэхээр тэрнийг шадар сайдын багц

дээр өмнөх жилүүдэд бичиж ирсэн. 2006 онд 7.6 тэрбум төгрөг бичээд, тэгээд тэр 7.6 тэрбум төгрөгийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нартай яриад гишүүдийн саналыг аваад ингээд зарцуулаад ирсэн.

Одоо 19.0 тэрбум төгрөгийг 2006 он шигээ шадар сайдын багц дээр бичихгүйгээр вариант оруулж ирж байгаа. Тэр нь төсвийн ерөнхийлөн захирагчдын багцууд дээр гишүүдийн саналыг жагсаалтаар нь оруулчихаж байгаа. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтаар хориг тавьсан юм билээ, ноднин. Яг тэр заалтын дагуу одоо бол болж байгаа” гэжээ.

Хөрөнгө оруулалтын жагсаалтыг гаргаж өгөөгүй гишүүд хичнээн байгаа бол? гэсэн Б. гишүүний асуултад О.: “гадаадад явж байгаа, томилолттой байгаа 7, 8 хүн байсан. Одоо тэрнээс 2, 3 хүн нь өөрсдөө утсаар саналаа өгчихөөд байгаа. 5, 6 хүн л үлдээд байгаа юм шиг байна. Тэд нарын багцыг /250 сая төгрөгийг/ аймгаар нь шадар сайдын багц дээр хийчихээд 2006 ондоо 7.6 тэрбумаа ашигласан тэрүүгээрээ явчихъя л гэсэн тийм санаа л оруулж ирж байгаа” гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга У. хэлэхдээ: “250 саяыг тойрсон асуудлууд яригдаад ажлын хэсэг төсвийн эрх захирагчдад нь төсөв рүү хийж өгье гэж танилцууллаа шүү дээ. Төсвийн 4 дүгээр хэлэлцүүлгийн явцад төсвийг эрх захирагч нэг бүрээр баталдаг. Тэгэхээр тэр төсөв дотор нь одоо эрх захирагч болгонд суулгаж өгнө. 4 дүгээр хэлэлцүүлгийн өмнө хэн хэний төсөв дээр хичнээн юм яаж тусав гэдгийг бид нар сонсоод дөрөвдүгээр хэлэлцүүлэгт орох бололцоотой гэсэн байна.

4/ 2007 онд Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын талаар гаргасан зарим гишүүдийн санал, жагсаалт.

Үндсэн хуулийн цэцээс шаардсаны дагуу Улсын Их Хурлын гишүүн Г., Ж., О., З. нар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд гаргасан хөрөнгө оруулалтын санал, жагсаалтаа ирүүлсэн ба МАХН-ын бүлэг, ардчилсан намын зөвлөл гишүүдийнхээ гаргасан санал, жагсаалтыг удаа дараа шаардсаар байхад Үндсэн хуулийн цэцэд ирүүлээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ. Дээрх нэр бүхий гишүүдийн гаргасан санал, хөрөнгө оруулалтын жагсаалт нь “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр хавсралтын ХҮII.1.39, ХҮI.1.1.72, ХҮIII.1.16, ХҮI.2.3.9, ХҮI.1.1.76, IX.2.7, ХХIII.1.42, ХҮI.1.2.4, ХҮI.1.2.51, ХҮI.1.2.5, ХҮI.2.1.15, ХҮI.1.2.6, ХҮII.4.6, ХХIII.1.42, ХҮI.1.2.7, IX.2.8, ХҮI.2.1.16, ХҮI.1.2.8, Х.1.3.2, ХХIII.1.18, IX.1.5, ХҮI.2.1.21, ХҮI.1.2.1.8-д бүрэн тусгагдсан, Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн даргын 2007 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 26 дугаар албан бичигт: “Улсын Их Хурлын гишүүд нь өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд улсын төсөвт дээр дурдагдсан хөрөнгө оруулалтын талаар Улсын Их хурлын холбогдох байнгын хороогоор дамжуулан асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэж байна” гэсэн зэргээс харахад санал, жагсаалт өгсөн бусад гишүүдийн хөрөнгө оруулалтын санал ч дээрх жагсаалтад, санал өгөөгүй цөөн гишүүдэд хуваарилагдсан 250 сая төгрөг нь шадар сайдын багцад нийт дүнгээрээ 750 сая төгрөг гэж тусгагдсан гэх үндэстэй байна.

Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-т зааснаар: “улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” ...бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төслийг боловсруулах” бүрэн эрхтэй юм.

Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан “Монгол Улсын 2007 оны төсвийн төсөл”-д Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийн хөрөнгө төсөвлөгдөөгүй байхад Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэх явцдаа Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд халдаж төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2007 оны төсвийн багцыг сонгуулийн тойрог харгалзан нэмэгдүүлж, Улсын Их Хурлын гишүүдийн саналыг хөрөнгө оруулалтын жагсаалтаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад тараан байрлуулан баталсан байх ба ингэхдээ ижил төрлийн хөрөнгө оруулалтын объектод санхүүжилтийн дүнг өөр өөрөөр тусгасан, нэг үйл ажиллагааны санхүүжилтийг 2 дахин давхардуулан тусгасан, төрийн санхүүгийн бодлогын хүрээнд шийдвэрлэгдэхээргүй асуудлыг төсвийн хуулийн хавсралтаар баталсан зэргээс үзэхэд Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг механикаар төсөвт суулгасан болох нь “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр хавсралтын IX.1.10, IX.1.11, IX.1.28, IX.1.4, IX.1.24, ХҮI.2.1.15, ХХҮIII.1.16 зэргээр тогтоогдож байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Хоёр. Мэдээлэл гаргагч иргэн Х. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт заасан Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурал үл ойшоон хүлээн аваагүй учир дээрх асуудлыг Үндсэн хуулийн цэцээр хянуулахаар мэдээллийн нэмэлт шаардлага болгон ирүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2006 оны 12 дугаар сарын 18-нд Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд тавьсан хоригийн агуулга:

1/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан зөвхөн сонгууль явуулахын тулд зохион байгуулагддаг сонгуулийн нутаг дэвсгэрийг баримтлан хөрөнгө оруулахаар төсөвлөсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цолцолбор мөн” гэсэн заалтыг зөрчиж төсвийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг баримтлан зарцуулах зарчмыг алдагдуулсан,

2/ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж дараагийн Улсын Их Хурлын сонгууль тэгш эрхийн үндсэн дээр шударга явагдах боломж алдагдах нөхцөлийг урьдчилан бүрдүүлсэн,

3/ Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаална” гэсэн заалтыг зөрчиж “сонгуулийн нутаг дэвсгэрийн” явцуу эрх ашгийг хичээж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн онцлог нөхцөл байдлыг үл харгалзан тэгшитгэн хуваарилах зарчмаар нэмэлт хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна гэж үзжээ.

Эл асуудлаар Улсын Их Хурлын зарим гишүүд өөрийн үзэл бодлоо илэрхийлж байсан нь дараах баримтаар нотлогдож байна. Үүнд:

1/ Монгол Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б. хэлэхдээ: “Их ноцтой асуудал яваа шүү дээ. Энэ чинь яг үнэндээ О. гишүүний хэлж байгаагаар бол энд сууж байгаа 76 гишүүний тойрог дээр хөрөнгө оруулалт хийх, цаад утгаараа бол 2008 оны сонгуульд хийж байгаа хөрөнгө оруулалт байгаа байхгүй юу. Улс төрийн хөрөнгө оруулалт шүү дээ. Энэний цаана чинь ардчилсан сонгууль, чөлөөт ардчилсан

сонгууль гэдэг чинь устаж байгаа гэдгийг бид нар мэдэж байгаа шүү дээ. Одоо удахгүй 500 сая болно. Удахгүй 1 тэрбум болно. Одоо жишээ нь надтай 2008 онд хэн үзэлцэх юм” гэжээ.

Мөн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн Б. хэлэхдээ: “Хамгийн гол зарчим нь бол их олон хууль, их олон зарчим алдагдаж байгаа юм л даа. Их олон хуульд нөгөө сонгуульд нэр дэвшигчид бол эрх тэгш, нэг гараанаас ижил хэмжээтэйгээр өрсөлдөнө гэсэн зарчим маань алдагдахад хүрнэ гэж би үзэж байгаа юм. Хоёрдугаарт, одоо гадуур та нар өнөөдрийн сонин хэвлэлийг үзсэн байх. Өөрсөддөө зориулж мөнгө баталж авдаг Улсын Их Хурал гээд шуугиад байна шүү дээ. Энэ арай дэндүү байгаа байхгүй юу. Хичнээн тайлбарлаад ч энэ чинь ямар ч тайлбар хэрэггүй ээ гэдгийг хэлмээр байна” гэсэн байна.

2/ Улсын Их Хурлын гишүүн Г. хэлэхдээ: “Тэгэхээр 250 сая төгрөгийн саналыг бол Ард түмний нам дэмжихгүй байгаа. Яагаад 250 саяыг бид эсэргүүцээд байгаа юм бэ гэхээр энэ бол ерөөсөө Улсын Их Хурлын гишүүдэд өгч байгаа хахууль шүү дээ.

Улсын Их Хурлын гишүүд гэдэг чинь хөрөнгө мөнгийг төсөвлөж баталдаг хүмүүс болохоос биш энэнийг зарцуулдаг этгээд биш ээ. Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр тойрог дээрээ очоод тэр 250 сая төгрөгийг нааш нь цааш нь хийснээрээ ажил хийсэн болохгүй ээ. Их Хурлын гишүүн ард түмэнтэйгээ уулзаж ярьж тэдний санаа сэтгэлийг ойлгож тэдний хэрэгтэй тэр хуулийн төслийг эрх зүйн орчинг нь бүрдүүлж Монгол Улсын парламентад батлуулахыг л ажлаа хийсэн гэдэг юм. Засгийн газраа хянаж ажиллахыг ажлаа хийсэн гэдэг юм. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд та нар энэ зүйл дээрээ татгалзмаар байна” гэжээ.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1-д: “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан.

Гэтэл Улсын Их Хурлын гишүүд зөвхөн өөрийн сонгогдсон Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн явцуу эрх ашгийн үүднээс сонгуулийн тойрог бүрт 250 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх жагсаалт гарган хөрөнгө оруулалтын санхүүжилтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зарчмаар бус, Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн зарчмаар хуваарилан тэгшитгэж, түүнийгээ халхавчлан төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад суулган хуульчлан баталсан, ингэснээрээ Улсын Их Хурлын сонгуульд оролцох намууд болон нэр дэвшигчдэд тэгш бусаар өрсөлдөх нөхцөлийг бий болгосон, төсвийн ерөнхийлөн захирагч нар Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан тэдэнтэй зөвшилцөж хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийхээр болсон, мөн “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” Монгол Улсын хуульд Улсын Их Хурлын 76 гишүүний тойрог тус бүрт 250.0 сая төгрөгөөр тооцож нийт 19.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлан шатанд, энэ талаар хуулиар тогтоосон журмыг Улсын Их Хурал хэрэгжүүлээгүй зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Тавин наймдугаар зүйлийн 1, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

4/ Улсын Их Хурлын гишүүдийн зөвхөн хувь хувийн бодлоор хөрөнгө оруулалтын санал өгөгдсөн тул ижил объектуудыг барихад зарцуулах зардлын хооронд ялгаа их гарч шударга ёс, тэгш байдлын зарчим зөрчигдөхөд хүрсэн байна. Үүнийг зөвхөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дээрх жишээгээр авч үзэхэд тухайлбал, багийн Засаг даргын конторын барилгыг Дорнод аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр багт барихад 20.0 сая, Сэлэнгэ аймгийн Шаамарт барихад 50.0 сая, Төв аймгийн Бүрэн суманд барихад 70.0 сая төгрөг төсөвлөгдсөн байна. Мөн сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг Өвөрхангай аймгийн Уянга суманд барихад 250.0 сая, Сүхбаатар аймгийн Уулбаян суманд барихад 25.0 сая төгрөг зарцуулах зэргээр төсөвт тусгагджээ.

Аймаг, нийслэлийн Засаг даргын багцад зарим гишүүд сонгогчдынхоо хувьчлагдсан орон сууцны байрны засварыг төсвийн хөрөнгөөр засуулахаар төсөвлөсөн байна. Тухайлбал, Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт.

Мөн зарим сайдын эрхлэх ажлын хүрээнд үл хамаарах ажлыг Улсын Их Хурлын гишүүдийн саналаар хүчээр байршуулсан байна. Тухайлбал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад Булган, Чойбалсан, Өвөрхангай, Арвайхээрийн гэрэлтүүлэг, Ховд, Жаргалантын гэр хорооллын автобусны зогсоол зэрэг асуудлууд тусгагдсан нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх хэмжээнд халдсан шинжийг тус тус агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулиар Улсын Их Хурлын гишүүдийн тус тусын тойрогтоо хөрөнгө оруулахаар гаргасан санал, жагсаалтыг үндэслэн Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн журмаар тойрог тус бүрт тэгшитгэн хуваарилж, зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тараан байршуулсан 250 сая төгрөг буюу нийт дүнгээрээ төсөвт туссан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”, мөн Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2/-ын “...улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх”, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”, Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн дээр дурдсан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд байршуулсан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт

заасны дагуу Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн гэх Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэхэд дор дурдсан нөхцөл байдал тогтоогдож байна.

1. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 185 дугаар тогтоолд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн хөтөлбөр, төсөл болон зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж 760.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахаар шийдвэрлэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн” гэсэн иргэн М.-ийн өргөдлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн У. хянаж, 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолыг гаргахдаа “Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн гэж үзэх шууд үндэслэл тогтоогдохгүй байна. ... нотолгоо хангалттай биш” гэсэн дүгнэлт хийж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан, уг тогтоолыг Үндсэн хуулийн цэц 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдөр давж заалдах гомдлоор хэлэлцэж Үндсэн хуулийн цэцийн гишүүний 35 дугаар тогтоолыг хэвээр баталж уг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1 дүгээр магадлал хүчинтэй байхад уг шийдвэр гарснаас 4 жилийн дараа дээрхтэй ижил агуулга, үндэслэл бүхий өргөдлийг хянахдаа Үндсэн хуулийн цэц шууд маргаан үүсгэж урьд гаргаснаасаа өөр шийдвэр гаргасан байна.

Бодит байдал, Үндсэн хуулийн цэцийн урьд гаргасан шийдвэр ийм байхад Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга /тухайн үед даргаар ажиллаж байсан/ Ж. Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулахдаа дээр дурдсан иргэн М.-ийн өргөдлийг хянаж гаргасан Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолыг “Цэцийн шийдвэр биш” хэмээн хууль бус тайлбар хийж, улмаар уг тогтоолыг “давж заалдаагүй тул шийдвэр гаргаагүй” хэмээн төрийн эрх барих дээд байгууллагад худал мэдээлэл өгсөн.

2. Үндсэн хуулийн цэц 2007 оны 2 дугаар дүгнэлтийг гаргахдаа “... хөрөнгө оруулалт...” нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байхын зэрэгцээ энэхүү дүгнэлт нь “...улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, ...улсын төсөв батлах” Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан байна.

3. Улсын Их Хурал Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийг батлахдаа “сонгуулийн тойрог” гэсэн нэр томъёо хэрэглээгүй, тийм зарчим ч баримтлаагүй.

4. Үндсэн хуулийн цэц “тойрог тус бүрт тэгшитгэн хуваарилж, зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тараан байршуулсан 250.0 сая төгрөг буюу нийт

дүнгээрээ төсөвт туссан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь Үндсэн хуулийг зөрчсөн” гэж дүгнэхдээ Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн ямар зүйл, заалт Үндсэн хууль зөрчсөнийг, 19.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг түдгэлзүүлэхдээ чухам ямар төсөл, арга хэмжээний санхүүжилтийг түдгэлзүүлэхийг тус тус заагаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалт болон дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2007 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын төсвийг батлахдаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарчмаар бус сонгуулийн тойргийн зарчмаар хөрөнгө хуваарилж, хөрөнгө оруулалт, зарцуулалтыг Улсын Их Хурлын гишүүдийн саналаар баталж Засгийн газрын бүрэн эрхэд бүдүүлгээр халдсан хууль бус үйл ажиллагаа болсон. Ерөнхийлөгч хуулиар олгогдсон эрхийн хүрээнд энэ хуульд хориг тавьсан байдаг. Энэ асуудлыг хэлэлцэж байхад Улсын Их Хурал маш олон хууль тухайлбал, Засгийн газрын тухай, Хот, тосгоны тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль зөрчсөн нь ажиглагддаг. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд “хууль дээдлэх” зарчим алдагдаж, Улсын Их Хурал дахь намууд, намын бүлгүүд хоорондоо хэлэлцэж, тохиролцож байгаад л түүнийгээ Улсын Их Хурлаар батлуулах байдал үүссэн нь нууц биш.

Үндсэндээ намын бодлогоор асуудалд ханддаг болсон. Улсын Их Хурлын бүх ажиллагааг Улсын Их Хурлын гишүүд мэтгэлцэж, олон олон санааг уралдуулан явуулах зарчим үгүй болж Намын удирдах байнууллага, Улсын Их Хурал дахь намын бүлэг яаж хандана, тэр чиглэлээр асуудал зохицуулагддагийн нэг жишээ бол төсвийн энэ маргаан болно. Цаашид Улсын Их Хурлыг удирддаг намын дарангуйллыг зогсоох шаардлагатай. Зүй нь намын бүлгийн шийдвэр зөвлөмжийн агуулгатай байх ёстой болов уу. Улсын Их Хурлын зарим гишүүд чуулганд хэлэлцэж буй асуудлаар намын бүлгээс өөрөөр санал өгөх тохиолдолд түүнд зэмлэл, хариуцлага тооцох хандлага ажиглагддаг. Цэц маргааныг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын Тамгын газраас удаа дараа гишүүдийн гаргасан саналыг шаардсан боловч бүрэн гаргаж өгөөгүй байна. Цэцийн гишүүний ажиллагаанаас гадна хариуцагч тал холбогдох нотлох баримт бичгийг, тэр ч бүү хэл Цэцээс шаардсан баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2007.06.22 № 02

**Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хууль батлахдаа 250.0 сая төгрөгийг Улсын Их Хурлын тойрог бүрт хуваарилсан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7, дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар заалт, 4 дүгээр бүлгийн 11 зүйлийн 1, 2 дугаар хавсралтад дурдсан 2007 оны санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтууд нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчөөгүй талаар Үндсэн хуулийн цэцэд 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдөр гаргасан тайлбар хэвээр байгаагаа дахин нотолж байна.

1/ Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргахдаа зөвхөн Үндсэн хуулийг л барих ёстой. Гэтэл Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл мэдээллийн дагуу өөрийн санаачлагаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хууль, зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын Олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээр дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулна гэж заасан байдаг. Ийм учраас Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар дүгнэлтэд хөрөнгө оруулалт Үндсэн хууль зөрчсөн гэж байгаа нь өөрөө Үндсэн хуультайгаа зөрчилдөж байна гэж үзэж байна.

2/ Улсын Их Хурлаар Монгол Улсын 2007 оны төсвийн хуулийг хэлэлцэн батлах үйл ажиллагаа нь Засгийн газрын төсвийн төслийг төлөвлөдөг, саналаа Улсын Их Хуралд оруулж ирдэг, Улсын Их Хурал улс орны эдийн засгийн байдал, санхүүгийн нөөцийг тооцон үзсэний үндсэн дээр гишүүдээс гаргасан саналыг байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэн олонхийн дэмжлэг авсан саналуудыг төсвийн төсөлд суулгаж өгч баталдаг. Энэ үйл ажиллагаа нь Монгол Улсын Их Хурлын хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу явагддаг гагцхүү Үндсэн хуулиар Улсын Их Хуралд олгогдсон онц бүрэн эрхийнхээ дагуу ажилласан болохыг тэмдэглэн хэлэх байна.

3/ Улсын Их Хурал Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг батлахдаа аймаг, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нар болон орон нутгаас ирүүлсэн саналыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан Монгол Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2007 онд хийгдэх хөрөнгө оруулалт, их засварын төсөл арга хэмжээний саналыг объект нэг бүрээр гарган төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад суулган баталсан бөгөөд “сонгуулийн тойрог” гэсэн нэр томъёог Улсын Их Хурлаас гаргасан шийдвэрт хэрэглээгүй болно.

4/ Маргаан шийдвэрлэж байгаа нэг асуудалд Үндсэн хуулийн цэцээс гаргаж байгаа шийдвэрүүд өөр байдалтай гарч байгаа нь Үндсэн хуулийн цэц хуулиа

баримтлахгүй гадны нөлөөнд автаж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Хөрөнгө гаргах тухай 185 дугаар тогтоолд “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн хөтөлбөр, төсөл болон зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж 760.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахаар шийдвэрлэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн иргэн М.-ийн мэдээллийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн У. хянаж, 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолыг гаргахдаа “Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн гэж үзэх шууд үндэслэл тогтоогдохгүй байна. ... нотолгоо хангалттай биш” гэсэн дүгнэлт хийж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан, уг тогтоолыг Үндсэн хуулийн цэц 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдөр давж заалдах гомдлоор хэлэлцэж Үндсэн хуулийн цэцийн гишүүний 35 дугаар тогтоолыг хэвээр баталж уг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1 дүгээр магадлал хүчинтэй байхад уг шийдвэр гарснаас 4 жилийн дараа дээрхтэй ижил агуулга, үндэслэл бүхий өргөдлийг хянахдаа Үндсэн хуулийн цэц шууд маргаан үүсгэж урьд гаргаснаасаа өөр шийдвэр гаргасан байна.

Дээр дурдсан тайлбаруудаас үзвэл Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7, дөрөвдүгээр бүлгийн 10 дугаар зүйл, дөрөвдүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дугаар хавсралтад дурдсан 2007 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтууд нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд улсын төсвийн байгууллага, ард иргэдийн эрх ашигт бүрэн нийцсэн хэрэгжих бүрэн үндэстэй шийдвэр гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурал “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” хуулийн төслийг хэлэлцэхдээ Улсын Их Хурлын зарим гишүүдийн гаргасан саналын дагуу гишүүдээр жагсаалт гаргуулж Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагч нар болон шадар сайдын багцад тараан байршуулж, хөрөнгө оруулалтын жагсаалтыг хавсралтаар баталсан болох нь Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2006 оны 10 дугаар сарын 26, 27, мөн 11 дүгээр сарын 21, 26, 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан, Улсын Их Хурлын 2006 оны намрын ээлжит чуулганы Төсвийн байнгын хорооны 2006 оны 11 дүгээр сарын 20, 29-ний өдрийн хуралдаан, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Хувьсгалт Намын бүлгийн 2006 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 186 дугаар тэмдэглэлүүд болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О., Б. нарын гаргасан тайлбар, Улсын Их Хурлын гишүүдийн хөрөнгө оруулалтын саналын жагсаалт зэрэгт тодорхой тусгагдсан болохыг Цэцийн 2 дугаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан билээ.

2. Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийн тогтоох хэсгийн 2-т заасны дагуу 2007 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг Цэцийн дүгнэлт гарсан өдрөөс эхлэн түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Сангийн сайд Б. 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 3-S/971 дүгээр албан бичгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт хандаж холбогдох барилга, байгууламж, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг даруй зогсоохыг мэдэгдсэн байна.

Уг албан бичгийн хавсралтад дурдсан жагсаалтад Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан дараах төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийг тус тус түдгэлзүүлжээ. Үүнд:

-Монгол Улсын Ерөнхий сайдын багцаас 48.0 сая төгрөг буюу VII.5.1.2-т заасан хөрөнгө оруулалтын, -Монгол Улсын Шадар сайдын багцаас 750.0 сая төгрөг буюу VIII.4-т заасан хөрөнгө оруулалтын; -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас 1381.0 сая төгрөг буюу IX.1.1-IX.1.29-д заасан хөрөнгө оруулалтын, 268.5 сая төгрөг буюу IX.2.2-IX.2.22-д заасан их засварын, 363.0 сая төгрөг буюу IX.3.2-IX.3.17 заасан тоног төхөөрөмжийн; -Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас 24.0 сая төгрөг буюу X.1.1.5-X.1.1.8-д заасан хөрөнгө оруулалтын, 15.0 сая төгрөг буюу X.1.2.8-д заасан их засварын, 21.0 сая төгрөг буюу X.1.3.1, X.1.3.2-т заасан тоног төхөөрөмжийн; -Түлш, эрчим хүчний сайдын багцаас 871.0 сая төгрөг буюу XIII.1.3.1-XIII.1.3.8-д заасан эрчим хүчний, 6.5 сая төгрөг буюу XIII.1.4.1-д заасан сэргээгдэх эрчим хүчний, 56.0 сая төгрөг буюу XIII.2.4-т заасан түлшний; -Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын багцаас 20.0 сая төгрөг буюу XIV.1.5, XIV.1.6-д заасан хөрөнгө оруулалтын, 5.0 сая төгрөг буюу XIV.3.2-т заасан тоног төхөөрөмжийн; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын XVI.1-д заасан "Боловсрол"-ын багцаас 652.0 сая төгрөг буюу XVI.1.1.45-XVI.1.1.52, 49.0 сая төгрөг буюу XVI.1.1.53, 2208.0 сая төгрөг буюу XVI.1.1.54-XVI.1.1.77 тус тус заасан хөрөнгө оруулалтын, 1617.0 сая төгрөг буюу XVI.1.2.1-XVI.1.2.51, 20.0 сая төгрөг буюу XVI.1.2.56-д тус тус заасан их засварын, 286.0 сая төгрөг буюу XVI.1.3.3-XVI.1.3.21-д заасан тоног төхөөрөмжийн; XVI.2-т заасан "Соёл"-ын багцаас 50.0 сая төгрөг буюу XVI.2.1.7, 1345.0 сая төгрөг буюу XVI.2.1.14-XVI.2.1.28-д тус тус заасан хөрөнгө оруулалтын, 42.0 сая төгрөг буюу XVI.2.2.1-XVI.2.2.3, XVI.2.2.5-д заасан тоног төхөөрөмжийн, 844.6 сая төгрөг буюу XVI.2.3-т заасан засварын; -Эрүүл мэндийн сайдын багцаас 100.0 сая төгрөг буюу XVII.1.9, 1186.9 сая төгрөг буюу XVII.1.24-XVII.1.41-д тус тус заасан хөрөнгө оруулалтын, 386.1 сая төгрөг буюу XVII.3.8-XVII.3.21-д заасан тоног төхөөрөмжийн, 546.5 сая төгрөг буюу XVII.4-т заасан эмнэлгийн байгууллагуудын их засварын; -Үйлдвэр, худалдааны сайдын багцаас 50.0 сая төгрөг буюу XVIII.2-т заасан хөрөнгө оруулалтын, 430.0 сая төгрөг буюу XVIII.3-аасан жижиг, дунд үйлдвэрлэл, худалдааг дэмжих хөрөнгө оруулалтын; -Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцаас 128.0 сая төгрөг буюу XIX.1.8-XIX.1.15-д заасан хөрөнгө оруулалтын, 65.5 сая төгрөг буюу XIX.2.1-XIX.2.3-т заасан их засварын; -Байгаль орчны сайдын багцаас 13.0 сая төгрөг буюу XX.1.6-д заасан хөрөнгө оруулалтын; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцаас 568.0 сая төгрөг буюу XXI.1.3-XXI.1.19-д заасан хөрөнгө оруулалтын, 130.0 сая төгрөг буюу XXI.4.1-XXI.4.4-т заасан тоног төхөөрөмжийн, 20.0 сая төгрөг буюу XXI.4.5-д заасан тоног төхөөрөмжийн; -Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын багцаас 60.0 сая төгрөг буюу XXII.1.3.3, 1075.7 сая төгрөг буюу XXII.1.3.6-XXII.1.3.26-д тус тус заасан дотоодын хөрөнгөөр баригдах зам, гүүрийн; -Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 11.0 сая төгрөг буюу XXIII.1.9, 1294.2 төгрөг буюу XXIII.1.17-XXIII.1.42-т тус тус заасан хөрөнгө оруулалтын, 73.0 сая төгрөг буюу XXIII.2-т заасан их засварын, 100.0 сая төгрөг буюу XXIII.3-т заасан тоног төхөөрөмжийн; -Аймаг, нийслэлийн Засаг даргын багцаас 1714.0 сая төгрөг буюу XXVIII.1.5-XVIII.1.26-д заасан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг тус тус түдгэлзүүлжээ.

Үндсэн хуулийн цэцээс шаардсаны дагуу Улсын Их Хурлын гишүүн У., Г., Ж., О., З., Ж., Б. нарын гаргасан санал, хөрөнгө оруулалтын жагсаалт нь 2007 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт болон Сангийн сайдын түдгэлзүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалттай тохирч байна.

Энэ бүхнээс дүгнэхэд санал, жагсаалт өгсөн бусад гишүүдийн хөрөнгө оруулалтын санал ч дээрх жагсаалтад, санал өгөөгүй цөөн гишүүдэд хуваарилагдсан 250.0 сая төгрөг нь шадар сайдын багцад нийт дүнгээрээ 750.0 сая төгрөг гэж тусгагдсан гэх үндэстэй байна.

Нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд, Үндсэн хуулийн цэцийн дунд, их суудлын хуралдаанд бэлтгэх шатанд Улсын Их Хурлын гишүүдийн 250.0 сая төгрөгөөр тойрогтоо хийх хөрөнгө оруулалтын талаар гаргасан санал, жагсаалтыг гаргуулахаар Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурал дахь МАХН-

ын бүлэг, Ардчилсан намын зөвлөлөөс удаа дараа шаардсаар байхад эдгээр санал, жагсаалтыг шалтгаангүй Үндсэн хуулийн цэцэд ирүүлээгүй болно.

Тухайлбал, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ахлагч И. Үндсэн хуулийн цэцэд 2007 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн хариундаа "...орон нутагт хийх хөрөнгө оруулалтын жагсаалтын тухай асуудлаар манай бүлэг хэлэлцээгүй бөгөөд гишүүд тийм санал гаргаагүй, 250.0 сая төгрөгөөр орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтын талаар Улсын Их Хурал, холбогдох байнгын хороо, ажлын хэсэгт жагсаалт гаргаж өгөөгүй болно" гэсэн хэдий ч энэ нь Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэгт харьяалагдах Улсын Их Хурлын зарим гишүүн 250.0 сая төгрөгөөр өөрийн тойрогтоо хийх хөрөнгө оруулалтын санал, жагсаалтаа гаргаж өгсөн зэргээр няцаагдаж байна.

3. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийн тухай 2007 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолдоо Үндсэн хуулийн цэцийн тухайн хуралдаанаар хэлэлцсэн маргаантай холбогдолгүй, өөрөөр хэлбэл, маргааны зүйл хийгээд, объектын хувьд эрс ялгаатай асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаар гарсан Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, бага суудлын хуралдааны магадлалыг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй тухай үндэслэл болгон заасан нь хууль бус болжээ.

4. Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2-т зааснаар: "...2/ ...улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; ...бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т зааснаар "...Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд үндэслэсэн улсын төсвийн төслийг боловсруулах; "...бүрэн эрхтэйгээс гадна 29, 30, 31 дүгээр зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2-т Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн үндэслэл, тавигдах шаардлага, Засгийн газарт өргөн мэдүүлэх, Засгийн газар төсвийн төслийг хэлэлцэх, Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурал улсын төсвийг батлах хугацаа журам зэргийг тодорхой хуульчлан тогтоожээ.

Монгол Улсын Засгийн газраас 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан "Монгол Улсын 2007 оны төсвийн төсөл"-д Улсын Их Хурлын сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөгийн хөрөнгө төсөвлөгдөөгүй байхад Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэх явцдаа Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд халдаж төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2007 оны төсвийн багцыг сонгуулийн тойрог харгалзан нэмэгдүүлж, Улсын Их Хурлын гишүүдийн саналыг хөрөнгө оруулалтын жагсаалтаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад тараан байрлуулан баталсан байх ба ингэхдээ ижил төрлийн хөрөнгө оруулалтын объектод санхүүжилтийн дүнг өөр өөрөөр тусгасан, нэг үйл ажиллагааны санхүүжилтийг 2 дахин давхардуулан тусгасан, төрийн санхүүгийн бодлогын хүрээнд шийдвэрлэгдэхээргүй асуудлыг Төсвийн хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

5. Улсын Их Хурлын гишүүд зөвхөн өөрийн сонгогдсон Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн явцуу эрх ашгийн үүднээс сонгуулийн тойрог бүрт 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийх жагсаалт гарган хөрөнгө оруулалтын санхүүжилтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зарчмаар бус, Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн зарчмаар хуваарилан тэгшитгэж, түүнийгээ халхавчлан төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад оруулж хуульчлан баталсан, ингэснээрээ Улсын Их Хурлын сонгуульд

оролцох намууд болон нэр дэвшигчдэд тэгш бусаар өрсөлдөх нөхцөлийг бий болгосон, төсвийн ерөнхийлөн захирагч нар Улсын Их Хурлын гишүүний саналыг харгалзан тэдэнтэй зөвшилцөж хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийхээр болсон, мөн “Монгол Улсын 2007 оны төсвийн тухай” Монгол Улсын хуульд Улсын Их Хурлын 76 гишүүний тойрог тус бүрт 250.0 сая төгрөгөөр тооцож нийт 19.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлан шатанд, энэ талаар хуулиар тогтоосон журмыг Улсын Их Хурал хэрэгжүүлээгүй зэрэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Тавин наймдугаар зүйлийн 1, Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2007 оны Төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтад зарим сайдын эрхлэх ажлын хүрээнд үл хамаарах ажлыг Улсын Их Хурлын гишүүдийн саналаар байршуулсан байна. Тухайлбал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад Булган, Чойбалсан, Өвөрхангай аймгийн Арвайхээрийн гэрэлтүүлэг, Ховд аймгийн Жаргалантын гэр хорооллын автобусны зогсоол зэрэг асуудлууд тусгагдсан нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх хэмжээнд халдсан шинжийг тус тус агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурал Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийг батлахдаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсгийн заалтуудаар тогтоосон журам, зарчмыг үл харгалзан Улсын Их Хурлын гишүүдээс тус тусын тойрогт хийх хөрөнгө оруулалтын санал, жагсаалтыг үндэслэн, Улсын Их Хурлын сонгуулийн тойрог тус бүрт тэгшитгэн 250.0 сая төгрөг буюу нийт дүнгээрээ 19.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад байршуулан хуваарилсан Монгол Улсын 2007 оны Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлээр баталсан 1 дүгээр хавсралтын холбогдох заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”, мөн Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын “...улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх”, Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”, Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн “2007 онд Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” гэсэн

Нэгдүгээр хавсралтад дурдсан –Монгол Улсын Ерөнхий сайдын багцаас 48.0 сая төгрөг буюу VII.5.1.2-т заасан хөрөнгө оруулалтын, –Монгол Улсын Шадар сайдын багцаас 750.0 сая төгрөг буюу VIII.4-т заасан хөрөнгө оруулалтын; –Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцаас 1381.0 сая төгрөг буюу IX.1.1-IX.1.29-д заасан хөрөнгө оруулалтын, 268.5 сая төгрөг буюу IX.2.2-IX.2.22-д заасан их засварын, 363.0 сая төгрөг буюу IX.3.2-IX.3.17 заасан тоног төхөөрөмжийн; –Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас 24.0 сая төгрөг буюу X.1.1.5-X.1.1.8-д заасан хөрөнгө оруулалтын, 15.0 сая төгрөг буюу X.1.2.8-д заасан их засварын, 21.0 сая төгрөг буюу X.1.3.1, X.1.3.2-т заасан тоног төхөөрөмжийн; –Түлш, эрчим хүчний сайдын багцаас 871.0 сая төгрөг буюу XIII.1.3.1-XIII.1.3.8-д заасан эрчим хүчний, 6.5 сая төгрөг буюу XIII.1.4.1-д заасан сэргээгдэх эрчим хүчний, 56.0 сая төгрөг буюу XIII.2.4-т заасан түлшний; –Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын багцаас 20.0 сая төгрөг буюу XIV.1.5, XIV.1.6-д заасан хөрөнгө оруулалтын, 5.0 сая төгрөг буюу XIV.3.2-т заасан тоног төхөөрөмжийн; –Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын XVI.1-д заасан “Боловсрол”-ын багцаас 652.0 сая төгрөг буюу XVI.1.1.45-XVI.1.1.52, 49.0 сая төгрөг буюу XVI.1.1.53, 2208.0 сая төгрөг буюу XVI.1.1.54-XVI.1.1.77 тус тус заасан хөрөнгө оруулалтын, 1617.0 сая төгрөг буюу XVI.1.2.1-XVI.1.2.51, 20.0 сая төгрөг буюу XVI.1.2.56-д тус тус заасан их засварын, 286.0 сая төгрөг буюу XVI.1.3.3-XVI.1.3.21-д заасан тоног төхөөрөмжийн; XVI.2-т заасан “Соёл”-ын багцаас 50.0 сая төгрөг буюу XVI.2.1.7, 1345.0 сая төгрөг буюу XVI.2.1.14-XVI.2.1.28-д тус тус заасан хөрөнгө оруулалтын, 42.0 сая төгрөг буюу XVI.2.2.1-XVI.2.2.3, XVI.2.2.5-д заасан тоног төхөөрөмжийн, 844.6 сая төгрөг буюу XVI.2.3-т заасан засварын; –Эрүүл мэндийн сайдын багцаас 100.0 сая төгрөг буюу XVII.1.9, 1186.9 сая төгрөг буюу XVII.1.24-XVII.1.41-д тус тус заасан хөрөнгө оруулалтын, 386.1 сая төгрөг буюу XVII.3.8-XVII.3.21-д заасан тоног төхөөрөмжийн, 546.5 сая төгрөг буюу XVII.4-т заасан эмнэлгийн байгууллагуудын их засварын; –Үйлдвэр, худалдааны сайдын багцаас 50.0 сая төгрөг буюу XVIII.2-т заасан хөрөнгө оруулалтын, 430.0 сая төгрөг буюу XVIII.3 заасан жижиг, дунд үйлдвэрлэл, худалдааг дэмжих хөрөнгө оруулалтын; –Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцаас 128.0 сая төгрөг буюу XIX.1.8-XIX.1.15-д заасан хөрөнгө оруулалтын, 65.5 сая төгрөг буюу XIX.2.1-XIX.2.3-т заасан их засварын; –Байгаль орчны сайдын багцаас 13.0 сая төгрөг буюу XX.1.6-д заасан хөрөнгө оруулалтын; –Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцаас 568.0 сая төгрөг буюу XXI.1.3-XXI.1.19-д заасан хөрөнгө оруулалтын, 130.0 сая төгрөг буюу XXI.4.1-XXI.4.4-т заасан тоног төхөөрөмжийн, 20.0 сая төгрөг буюу XXI.4.5-д заасан тоног төхөөрөмжийн; –Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын багцаас 60.0 сая төгрөг буюу XXII.1.3.3, 1075.7 сая төгрөг буюу XXII.1.3.6-XXII.1.3.26-д тус тус заасан дотоодын хөрөнгөөр баригдах зам, гүүрийн; –Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 11.0 сая төгрөг буюу XXIII.1.9, 1294.2 төгрөг буюу XXIII.1.17-XXIII.1.42-т тус тус заасан хөрөнгө оруулалтын, 73.0 сая төгрөг буюу XXIII.2-т заасан их засварын, 100.0 сая төгрөг буюу XXIII.3-т заасан тоног төхөөрөмжийн; –Аймаг, нийслэлийн Засаг даргын багцаас 1714.0 сая төгрөг буюу XXVIII.1.5-XVIII.1.26-д заасан хөрөнгө оруулалтын санхүүжилт хийхээр заасан заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Улсын Их Хурлын 2007 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсан өдрөөсөө хүчин төгөлдөр мөрдөгдөхийг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Энэ маргааныг хянан хэлэлцэхэд Цэц “мөрдөн шалгах” зарчмыг хэрэгжүүлсэн гэхэд хилсдэхгүй. Яагаад гэвэл Улсын Их Хурал, Засгийн газраас Цэцийн гишүүний шаардсан баримт бичиг, нотолгоог гаргаж өгөхөөс татгалзах /эс үйлдэхүй/ хандлага илт байсан. Нийтдээ 10-аад гишүүдийн саналд тулгуурлан Төсвийн тухай хуулиас гишүүдийн тойрогтоо төсөвлөсөн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүрийг

хөдөлбөргүйгээр тогтоосон байна. Үнэндээ Улсын Их Хурлын гишүүдийн саналаар тухайн тойрогт хөрөнгө хуваарилж байгаа нь Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Засгийн газрын тухай зэрэг олон хуулийг зөрчсөн төдийгүй Улсын Их Хурлын гишүүд эрх мэдлээ хэтрүүлж байна ч гэж үзэхэд хилсдэхгүй.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэх үед Улсын Их хурлын гишүүн Б.-гийн хэлсэнчлэн цаашид 250,0 сая төгрөг нь 500,0 сая, 1,0 тэрбум төгрөгт хүрнэ гэж байсанчлан өнөөдөр “Улсын Их Хурлын гишүүдийн мөнгө” 3,0 тэрбум төгрөгт хүрчихээд байгаа билээ.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.03.02 № 03**

### **Улсын Их Хурлын дарга Н. Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Л., Б., Б., Х., А., Ц., Б. нар;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга М., Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л., нарийн бичгийн дарга Н.

#### **Албан тушаалтны үндсэн хууль зөрчсөн гэх үйлдэл:**

Улсын Их Хурлын дарга Н. 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар баталсан Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг хянахдаа хуулийн бодлого, зарчим, агуулгыг алдагдуулсан засвар хийсэн үйлдэл

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Хорьдугаар зүйл “... хуультогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”
- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Батлагдсан хуульд хийсэн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд сонсгосны дараа Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр засвар хийдэг, эсвэл найруулгыг Улсын Их Хуралд сонсгодоггүй. Ийм нөхцөл үүсээд байхад Улсын Их Хурлын дарга уг хуулийг ёсчилдог хууль бус үйл ажиллагаа нэг бус удаа тохиолдох боллоо. Энэхүү хууль бус үйл ажиллагаа нь хуралдаан даргалагчийн зүгээс өөрийн бүрэн эрх, чиг

үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй явдалтай шууд холбоотой байна. Энэ нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал нь хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн доторх “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчиж байна, хянаж өгнө үү.

## 2. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Авлигын эсрэг хууль 2006 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурснаар ёсчлогдсон бөгөөд уг хууль нь мөн оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 35 дугаарт албан ёсоор хэвлэгдэн гарчээ. Улсын Их Хурлын чуулганаар батлан эцсийн найруулга хийсэн 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулийг 9 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурж, ёсчилсон хуультай харьцуулахад редакцын шинжтэй хуулиар зөвшөөрөгдсөн засвараас гадна хуулийн агуулга, бодлого, зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн зүйлийг ноцтой зөрчсөн байна гэж үзэж байна. Үүнийг хуулийн хувийн хэрэгт авагдсан материалууд, Улсын Их Хурлын гишүүдэд тараасан болон “Төрийн мэдээлэл” сэтгүүлд албан ёсоор хэвлэгдсэн эхээс харж болно.

Энэ нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.1, 51.2 дахь хэсгийн заалтыг зөрчжээ. Үүнд, “Улсын Их Хурлын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ дэгийн 51.1.1, 51.1.2 дахь заалтад заасны дагуу эцсийн найруулгыг хянахдаа түүний агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрлага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж болно” гэж заасан эрх мэдлийг хэтрүүлэн агуулга, зарчмын өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “Улсын Их Хурал... “хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах” эрхийг өөрийн онцгой эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэснийг тус тус зөрчиж Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан гэж үзэж байна. Мөн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Хуульд агуулга, зарчмын өөрчлөлт оруулж, бие даасан хараат бус байх ёстой байгууллагыг Улсын Их Хурлын даргын бүрэн эрхэд харьяалуулж болохоор болгожээ. Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын даргын бүрэн эрхэд:

“11.1.6. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах;

11.1.16 хуульд заасан бол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох санал гаргаж байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх” гэж заасан байдаг.

Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ, Авлигатай тэмцэх газрыг байгуулахдаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэнэ гэж заасан. Гэтэл хуульд хийсэн өөрчлөлт нь уг байгууллагын дарга, дэд даргыг томилох саналыг Улсын Их Хурлын дарга гаргахаар болгожээ.



Төрийн албан хаагч гэсэн тодорхойлолтод бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг оруулж мөн хуулийн бусад заалтыг өөрчилснөөр төрийн албанд ороогүй сонгуульд нэр дэвшигчийг мөрдөн мөшгөх заалт болгон хувиргажээ.

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагад байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон, цалинтай болон цалингүй ажилладаг, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаал эрхэлдэг, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, сонгуульд нэр дэвшигчид энэ хууль хамаарна” /4.1/ гэж байсныг цалинтай, цалингүй ажилладаг гэдэг нь хасагдаж ОНРТВ-ийн Үндэсний зөвлөлийн дарга, ерөнхий захирал нэмэгдсэн байна. Цалинтай ба цалингүй ажилладаг төрийн албан хаагчид хуулийн үйлчлэлд хамаарна гэж Монгол Улс нэгдэн орсон НҮБ-ын авлигын эсрэг конвенцын тодорхойлолтод заасан байдаг. Мөн Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхэд хэрэг бүртгэлт нэмэгдсэн байна.

### 3. Иргэн Б., Х., А., Ц., Б. нарын мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан: “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “...хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрх Улсын Их Хурлын мэдэлд хадгална” гэснийг тус тус зөрчин өөрийн эрх мэдлээ хэтрүүлэн Улсын Их Хурлын чуулганаар 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр эцэслэн баталсан Ашигт малтмалын тухай хуульд дур мэдэн ихээхэн өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, энэ хууль анх батлагдахдаа 40 хуудас, 10 бүлэг, 70 зүйлтэй байсан бол Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурсны дараа 43 хуудас, 11 бүлэг, 66 зүйлтэй болсны гадна Улсын Их Хурлын гишүүдийн баталсан 27 заалтыг хасч, гишүүдээр хэлэлцэгдээгүй 24 заалтыг нэмж оруулсан байна. Уг хуулийн 5.5 дугаар хэсгийн заалтад орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухай байсан бол Улсын Их Хурлын даргын засварласнаар орд эзэмшигч болон хувирч төрийн өмчийн эзэн болсон мэт ойлголт төрүүлж байгаа нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т харшилсан агуулгатай болсон гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд, мөн л цөөнгүй засварыг нэгэнт баталсны дараа оруулжээ. 1997 оны хуулийн дагуу бусдад тараагаад олон жил болсон хайгуулын болон ашиглалтын лицензийг эздэд нь хэвээр үлдээх зорилгоор, нэгэнт хүчингүй болгосон 1997 оны хуулийг буцаан үйлчлүүлэх шийдвэр гаргасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтын агуулгыг зөрчсөн үйлдэл болжээ. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар баталсан хуулийг Улсын Их Хурлын дарга ингэж засварлах нь Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэд халдсан, эрх мэдлээ хэтрүүлэн, албан тушаалаа урвуулан ашигласан гэж үзэж байгааг хянан хэлэлцэж, зохих шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

### 4. Монгол Улсын Их Хурлын дарга Н.-ийн тайлбарын агуулга:

1/ Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийн 51.1, 51.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг хянаж, Улсын Их Хуралд танилцуулсны үндсэн дээр ёсчилдог. Ийнхүү эцсийн найруулгыг хянах явцад Улсын Их Хурлын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хуулийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрууллага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийх эрхтэй.

2/ Нэр бүхий иргэдийн өргөдөлд дурдсан Авлигын эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хурлын 2006 оны хаврын чуулган өндөрлөх үеэр нэгдсэн хуралдаанд танилцуулахад миний бие дээр дурдсан бүрэн эрхийнхээ хүрээнд эдгээр хуулийн эцсийн найруулгыг үргэлжлүүлэн хянаж

засварлах шаардлагатайг мэдэгдсэний үндсэн дээр хуулийн агуулга, зарчим, бодлогыг өөрчлөхгүйгээр зохих засварыг хийж ёсчилсон болно. Эдгээр хуулийн хувийн хэрэгт миний биечлэн засвар хийсэн тэмдэглэл байгааг Цэцэд хүргүүлсэн материалаас тодорхой танилцах боломжтой. Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын засвар хийсэн тэмдэглэл ч тодорхой байгаа.

3/ Дээр дурдсан хуулиудын эцсийн найруулгад засвар хийснээр нэр томъёог жигдэлсэн, хуулийн зүйл, заалтуудын хоорондын логик холбоо, уялдааг хангасан, үг хэллэгийн найруулгыг сайжруулсан, зүйлийн гарчигтай агуулгыг нийцүүлсэн, хоёрдмол санааг арилгасан, шаардлагатай зүйл, заалтын ишлэлийг татсан, бүтцийн хувьд ойлгомжтой, дэс дарааллыг нь цэгцтэй болгосон бөгөөд чингэхдээ хуулийн зохицуулалтын бодлогыг чанд хадгалж чадсан гэдэгт бүрэн итгэлтэй байна.

4/ Дээрх хуулиудын найруулгыг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасны үндсэн дээр Улсын Их Хурлын чуулганы 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанд дахин танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс хуулиудын талаар зарчмын шинжтэй санал гараагүй болно.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийн төслийн санаачлагчаас оруулсан бодлого, үзэл баримтлал, төслийн хэлэлцүүлгийн явцад орсон өөрчлөлт, Улсын Их Хурлын холбогдох байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хэлэлцсэн тэмдэглэл, эцсийн найруулгыг хийсэн баримт материалыг хянан үзэж, бодлого, зарчмыг хадгалсан байдлыг онцлон анхаарахыг хүсье. Энэхүү маргааныг Цэцийн хуралдаанд хэлэлцэн шийдвэрлэхэд намайг төлөөлөн оролцох итгэмжилсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л., Нэгдүгээр нарийн бичгийн дарга Н. нарыг томилж байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

5. Улсын Их Хурлын даргын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л., Нэгдүгээр нарийн бичгийн дарга Н. нарын гаргасан нэмэлт тайлбарын агуулга:

1/ Ашигт малтмалын тухай болон Авлигын эсрэг хуулийн эцсийн найруулгыг 2006 оны 7 дугаар сарын 20-нд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулсан. Энэ өдрийн хуралдаанд хаврын чуулганаар баталсан 40 гаруй хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулгыг танилцуулсан бөгөөд цаг хугацааны хувьд олон том хуулийн эцсийн найруулгыг нэгэн зэрэг хийх боломжгүй байсан. Энэ байдлыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд танилцуулж, эдгээр хууль, шийдвэрийн төслийн эцсийн найруулгыг ажлын хэсгийн ахлагч, Байнгын хорооны дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр хийх эрх авсан.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 51.2-т заасан эрх болон 7 дугаар сарын 20-ны нэгдсэн хуралдаанаас олгосон эрхийн хүрээнд найрлага, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй засвар хийж Ашигт малтмалын хуулийн эцсийн найруулгыг ажлын хэсгийн ахлагч О., гишүүн Д. нарт, Авлигын эсрэг хуулийн эцсийн найруулгыг хууль санаачлагч Улсын Их Хурлын дэд дарга Л., Байнгын хорооны дарга М. нарт танилцуулж өөр саналгүй гэсэн тул ёсчилсон.

Ер нь хууль, шийдвэрийн эцсийн найруулга хийх, танилцуулах ажиллагааг хуулиар биш, Улсын Их Хурлын тогтоолоор баталсан чуулганы хуралдааны дэгээр зохицуулдаг бөгөөд энэхүү ажиллагаа нь хууль тогтоох үйл ажиллагааны техникийн горим тул энэ талаар гарах саналын зөрөлдөөн нь Үндсэн хуулийн цэцээр хянан шийдвэрлэгдэх маргаан биш, Улсын Их Хурал дотооддоо хэлэлцэж шийдвэрлэх асуудал юм. Иймд Үндсэн хуулийн цэц өөрт нь үл харьяалагдах асуудлыг хэлэлцэж аливаа шийдвэр гаргахгүй гэдэгт найдаж байна.

2/ Авлигын эсрэг болон Ашигт малтмалын тухай хуульд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд зааснаар эхний ээлжийн засварыг Улсын Их Хурлын Тамгын газар /Ерөнхий нарийн бичгийн дарга/ хийж эцсийн хувилбарыг Улсын Их Хурлын даргад өгсөн. Энэхүү хувилбар дээр Улсын Их Хурлын дарга ажилласан. Иймд аль засварыг хэн хийснийг нарийвчлан ялгаж тогтоох шаардлагатай. Тухайлбал Тамгын газрын хийсэн засварыг Улсын Их Хурлын дарга хийсэн гэж үзэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргаж болохгүй гэж үзэж байна.

3/ Эдгээр хуулиудад хийсэн засвар, найруулга нь Улсын Их Хурлаас хуулийг батлахдаа баримталсан агуулга, бодлого, зарчимтай зөрчилдсөн гэдгийг зөвхөн Улсын Их Хурал, түүний гишүүд дүгнэх бүрэн эрхтэй. Авлигын эсрэг болон Ашигт малтмалын тухай хуулийг 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд дахин танилцуулсан бөгөөд энэ үеэр дээрх хуулийн эцсийн найруулга /редакци/-ын талаар гишүүдээс нэг ч гомдол, санал гараагүй. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал болон гишүүд хуулийн эцсийн найруулга Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг, 7 дугаар сарын 20-нд олгосон эрхийн хүрээнд явагдсан, эдгээр хуулиудад агуулга, бодлого, зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй гэдгийг эцэслэн хүлээн зөвшөөрсөн болно.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуульд нэг заалт орхигдон ёсчлогдсон тухай асуудлыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын Зөвлөлөөс бичгээр Улсын Их Хуралд хандан тавьж, ийнхүү орхигдсон заалтыг хуульд нэмж оруулах санал тавьсныг Улсын Их Хурлын 2007 оны 1 дүгээр сарын 31-ний нэгдсэн хуралдаанд танилцуулж, Ашигт малтмалын тухай хуулийг ёсчилсон байдлаар нь орхигдсон заалтыг нэмж оруулан Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасны үндсэн дээр гишүүд судалж, тодорхой санал байвал дараагийн хуралдаанд авч үзэхээр шийдвэрлэсэн юм. Энэ үеэр мөн Хууль зүйн байнгын хорооны даргын саналаар Авлигын эсрэг хуулийг ч энэ маягаар авч ярихаар болсон. Үүний дагуу уг хуулиудыг Улсын Их Хурлын гишүүдэд 2007 оны 1 дүгээр сарын 31-нд хувиран тарааж, танилцуулан Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн. Энэ үеэр Улсын Их Хурлын гишүүдээс эдгээр хуулийн талаар агуулга, бодлого, зарчмын шинжтэй засвар хийсэн тухай ямар нэг санал шүүмжлэл гараагүй болно.

4/ Өргөдөл гаргагчаас Үндсэн хуулийн цэцэд нэмж гаргасан “Ашигт малтмалын хуульд Улсын Их Хурлын дарга Н.-ийн хийсэн засвар ба түүнээс үүдсэн үр дагавар” гэсэн нэртэй хүснэгтийн 1 дэх баганын 3-8 дахь мөрөнд бичсэн бүх заалтууд Улсын Их Хурлын гишүүдэд тараасан эцсийн найруулгын заалтаас өөр болсон байна. Хуулийн эцсийн хэлэлцүүлгийн төсөл, эцсийн найруулгын төслийн аль алинд нь ийм заалт байгаагүй бөгөөд зарим заалтыг өргөдөл гаргагчид санаанаасаа зохион бичиж агуулгыг өөрчилжээ.

Тухайлбал, уг хуулийн 4 дэх мөрөнд “Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгүүлснээс хойш ажлын 3 өдөрт дараах шийдвэрийн аль нэгийг гаргана” гэжээ. Гэтэл эцсийн хэлэлцүүлэг болон эцсийн найруулгын төсөлд “өргөдлийг бүртгүүлснээс хойш” гэсэн үг өгүүлбэр байхгүй байна. Өөрөөр хэлбэл өргөдөл гаргагчид чухам ямар төслүүдийг харьцуулан ийм зүйл бичсэнийг ойлгох аргагүй байна. Иймд хуулийн зарим зүйл, заалт алга болсон, огт байхгүй зүйл нэмэгдсэн, зарчмын шинжтэй засвар оруулсан гэдгийг Цэцэд хүргүүлсэн үндсэн материалаас нягтлан үзэхийг хүсье.

5/ Өргөдөл гаргагчид Ашигт малтмалын тухай хуулийн 1 дүгээр зүйлээс “хайгуулын талбай болон уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай” гэсэн заалтыг хассан гэжээ. Эдгээр үгүүдийг хассан нь үнэн бөгөөд энэ нь дараах шалтгаантай юм. Үүнд:

а/ Хуулийн зорилтод ийм үгүүд оруулсан боловч хуулийн бусад зүйл, заалтад “хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай” холбогдсон ямар нэгэн зүйл, заалт, зохицуулалт байгаагүй тул хассан. Хуульд “уурхайг хаах үед тавигдах шаардлага” гэсэн 45 дугаар зүйл байгаа боловч энэ зүйлд “уурхайн эдэлбэр орчинг хамгаалах” тухай ямар ч заалт алга.

б/ “Хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах” асуудал нь бүхэлдээ ашигт малтмал ашиглахтай холбоотойгоор гардаг олон төрлийн эрх зүйн харилцааны өчүүхэн хэсэг байдаг тул тэдгээрийг хуулийн зорилт гэсэн зүйлд онцгойлон заавал оруулах шаардлагагүй, “ашиглах” гэсэн ойлголт дотроо багтаж зохицуулагддаг гэсэн утгаар нь үг хэллэгийн засвар хийсэн.

б/ 1997 онд батлагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 21-ний 61 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.14-т “Эцсийн хэлэлцүүлгээр баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг хэлэлцүүлэг дууссанаас хойш ажлын 6 өдөрт багтаан Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна” гэж тус тус заасан байсан бөгөөд энэхүү заалтын хүрээнд холбогдох засварууд байнга хийгдэж ирсэн. Ийм найруулгын засвар урьд өмнө батлагдаж мөрдөж байсан бүх хуулиудад хийгдэж байсан бөгөөд үүнийг Улсын Их Хурлын архивт хадгалагдаж байгаа хууль, шийдвэрийн “хувийн хэрэг”-тэй танилцан магадлаж болно.

Өөрөөр хэлбэл найруулгын засвар зөвхөн энэ Улсын Их Хурал, Н. даргын үед шинээр бий болсон зүйл биш, 1990 оноос хойшхи бүх Бага, Их Хурал, тэдгээрийг удирдаж байсан дарга нарын үед хийгдэж ирсэн, хууль тогтоох ажлын нэгэнт уламжлагдан тогтсон практик гэдгийг тэмдэглэж байна” гэжээ. Иргэн Л., Б. нар Үндсэн хуулийн цэцэд анх гаргасан мэдээлэлдээ Улсын Их Хурлын дарга Н.-ийг Улсын Их Хурлын даргаас огцруулах үндэслэлтэй талаар дурдсан боловч энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй, нөгөө талаар иргэн Б., Х., А., Бо. нар 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт мэдээлэлдээ Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай дүгнэлт гаргахын зэрэгцээ түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулах хүсэлт тавьсантай холбогдуулж дараах зүйлийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар... хянан шийдвэрлэнэ”, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Иргэд Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ” гэж тус тус заасныг үндэслэн иргэдийн өргөдөл, мэдээллээр Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан албан тушаалтнуудыг огцруулах, эгүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн хэлэлцэх үндэслэлгүй гэж үзсэн болно.

Иргэн Б., Х., А., Б. нар 2007 оны 3 дугаар сарын 1-ний өдөр ирүүлсэн дээрх нэмэлт тайлбартаа Улсын Их Хурлын дарга Н. хуульд засвар хийсэн үйлдлээр Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр 93.0 хувийн саналаар баталж, 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсан Авлигын эсрэг Монгол Улсын хуульд 2006 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр, мөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн

хуралдаанаар 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр 83.7 хувийн саналаар баталж, 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсан Ашигт малтмалын тухай хуульд 2006 оны 8 дугаар сарын 5-ны өдөр тус тус агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дараалал, бүтцийн чанартай олон тооны засвар, өөрчлөлтийг Улсын Их Хурлын дарга Н. хийсэн нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл болон эдгээр хуулийн хувийн хэрэг дэх баримтууд, бусад нотлох баримтаар нотлогдож байна.

Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-ийн “Улсын Их Хурал... хуралдаанаар хуулийн төсөл, ... хэлэлцэх, ... батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална”, мөн Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн Тавин нэгдүгээр зүйлийн 51.4-ийн “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг энэ дэгийн 51.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Ийнхүү Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн холбогдох заалтыг зөрчсөнөөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудал болох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргах асуудлыг Үндсэн хуулийн цэц эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хэлэлцэх тул өргөдөл гаргагч иргэдийн энэ талаар тавьсан хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Авлигын эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засвар, өөрчлөлтийг хийснээрээ Улсын Их Хурлын дарга Н. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудал болох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Цэцийн хувьд Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн анхны маргаан энэ байв. Хуулийн эцсийн найруулгыг хийсний дараа дахин засвар оруулж, түүнийгээ танилцуулалгүй ёсчилсон үйлдэл бол яах аргагүй Үндсэн хуулийн эсрэг байж болшгүй ноцтой зөрчил. Цэц маргааныг хэлэлцэхдээ нэгд, Улсын Их Хурлын даргад хуульд засвар хийх эрх хэмжээ Улсын Их Хурлын дэгээр олгогдсон эсэх, хоёрт, Улсын Их Хурлын даргын оруулсан засвар найруулгын шинжтэй байсан уу, эсхүл зарчмын, агуулгын шинжтэй байсан уу, гуравт, Улсын Их Хурлын даргад хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа түүнд засвар оруулах эрхийг “амаар” олгох хуулийн зохицуулалт, практик, жишиг байж болох эсэх зэргийг харгалзан үзсэн.

Найруулга, үг үсэг, бүтцийг мэр сэр сайжруулсан засвар байгаагаас гадна хуулийн агуулга, бодлогыг өөрчилсөн зарчмын гэмээр засварууд ч цөөнгүй байсан. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгад уг хуулийн зорилтыг “ашигт малтмалын эрэл хайгуул хийх, хайгуулын талбай болон уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна” гэсэн атал Улсын Их Хурлын дарга засвар оруулан “эдэлбэрийн орчныг хамгаалах” гэсэн хэсгийг хассан. Өөрөөр хэлбэл байгаль орчныг хамгаалах талаар төрийн бодлогыг энэ заалтыг хассанаар үгүй хийж байгаа хэрэг. Мөн хуульд төлбөр авах, бүтээгдэхүүний борлуулалтаас орлогын албан татвар авахаар заасныг төлбөрийг нь үлдээж, татварыг нь хассан засвар хийсэн. Энэ мэтчилэн Улсын Их Хурлын дарга зөвхөн найруулгын бус агуулгын засвар оруулсан болох нь олон заалтаар батлагдана.

Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд сонсгож төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэний дараа буюу нэгэнт хүчин төгөлдөр болсон хуульд Улсын Их Хурлын дарга засвар оруулж байгаа нь өөрөө оруулсан засвар найруулгын шинжтэй байсан эсэхээс үл хамааран Үндсэн хуулийн эсрэг том зөрчил. Энэ бол тухайн албан тушаалтны эрх зүйн онолын мэдлэг дутмаг, төрийн албаны ёс зүйн доголдолтой, ер нь эрүүл саруулаар сэтгэж бодож чадаж байна уу гэдэгтэй холбоотой гэж ярилцдаг юм билээ.

Дүгнэлтийн үндэслэх хэсгийн 2-т иргэдийн хүсэлтээр албан тушаалтныг огцруулах эсэх асуудлыг хэлэлцэх боломжгүй гэж зааснаараа Цэц өөрөө Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг ноцтой зөрчсөн. Үндсэн хуулийн дээрх заалтад хэн, ямар асуудлаар Цэцэд хандаж болохыг тодорхой заасан атал Цэц ийнхүү дүгнэснээрээ Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээгээ бүрэн ойлгоогүй, асуудалд улс төрийн байр сууриас хандаж, Үндсэн хуульд заасан иргэдийн өргөдөл, мэдээлэл гаргах эрхийн хүрээ хязгаарыг тодорхойлох чадвар дутмаг байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр арга үгүй.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.04.18 № 04

### Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.,  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Их Хурлын гишүүн Д., З.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль<sup>88</sup>

- 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг”
- 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно”
- 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг “Энэ хуулийн..., 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68 хувиар тооцож албан татвар ногдуулна”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “шударга ёс, тэгш байдал...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт “хуулиар ногдуулсан албан татвар төлөх”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлаас 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсгийн “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-ын “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэсэн заалтуудыг, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Энэ хуулийн..., 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “..., хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг тус тус зөрчсөн байна.

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн шударга ёс, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ” гээд 17.1.3-т “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” талаар хуульчилсан.

Хуулиар ногдуулсан албан татвар төлөх гэдэгт “албан татварыг хуулиар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэх, татварын хувь, хэмжээ, татвар ногдох орлогыг хуулиар тогтоох” зэрэг ойлголт хамаарах бөгөөд ийнхүү тогтоосон татварыг төлөх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг мөн.

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна” мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Татварыг Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж хүчингүй болгоно”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан татварын хувь, хэмжээг тогтооно” гэжээ. Татварын ерөнхий хуулийн Улсын татвар гэсэн 16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсэгт “Монгол Улсын Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай” 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар “зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар” гэж оруулсан. Ингэснээр зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хувь, хэмжээг төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурлаас тогтоох хууль зүйн үндэс бүрдсэн байна. Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 3-т заасан “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэдэг нь юуны өмнө татварын хувь, хэмжээг болон татвар ногдох орлогыг хууль батлах замаар тодорхойлно гэсэн утгыг илэрхийлдэг.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтнаас 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг, 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэснийг зөрчсөн болох нь дараах хууль зүйн үндэслэлүүдээр нотлогдож байна.

а/ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон нэмэгдэл орлого буюу алтны үнийн өсөлтийг “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанк тогтоох”-оор болсон боловч дэлхийн зах зээлийн үнэ гэж хууль зүйн ямар ойлголт болох, мөн энэхүү үнийг яаж тодорхойлох нь тодорхойгүй байна. Дэлхийн зах зээлийн үнэ гэдэгт юуг ойлгох, Олон Улсын ямар байгууллагуудаас зарласан алтны үнэ ханшийг баримтлан дэлхийн зах зээлийн алтны үнийг тодорхойлох талаар хуульчлаагүй байна. Ингэснээр алтны үнийн өсөлтийн орлогын хувь, хэмжээг тогтоох үндэслэл болох дэлхийн зах зээлийн үнийг буюу татвар ногдуулах орлогыг тогтоох эрхийг Монголбанканд олгосон байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу татвар бий болгох, татвар ногдуулах, татварын хувь, хэмжээг тогтоох нь гагцхүү төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуулиар шийдвэрлэдэг асуудал болно.

б/ “Дэлхийн зах зээлийн үнэ”-ийг харгалзан үзэх гэдэгт ямар шалгууртай, яаж тогтоосон үнийг баримтлах талаар хуульчлан тогтоогоогүй тул Монголбанк Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдан татвар ногдох орлогыг тодорхойлж “Дэлхийн зах зээлийн үнэ”-ийг тогтоохоор болсны зэрэгцээ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4.1.4 дэх заалт, 6.2 дахь хэсэгт “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанк” зарлах талаар хуульчилсан. Дэлхийн зах зээлийн үнийг шууд баримтлан 1 унци алтны үнийг Монголбанк зарлана гэж хуульчлалгүйгээр “зах зээлийн үнийг харгалзан” гэснээр Монголбанк дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр, эсхүл доогуур



алтны үнийг зарлах нөхцөл бүрдээд байна. Дэлхийн зах зээлийн үнийг харгалзан зарласан үнэ гэдэг нь шууд баримтална гэсэн үг биш бөгөөд татвар ногдох орлогыг тодорхойлох нь Монголбанкны эрх хэмжээний асуудал болох үр дагавар үүснэ.

в/ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6.2 дахь хэсэгт “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан” 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэж хуульчилснаар “хуулиар ногдуулсан албан татвар” төлөх тухай Үндсэн хуулийн 17.1.3 дахь заалтыг зөрчсөн дараах сөрөг үр дагаврууд шууд үүсч байна. Тухайлбал,

- Нэгэнт хуулиар тодорхойлоогүй тул Монголбанк дэлхийн зах зээлийн үнийг өөрийн үзэмжээр тогтоох замаар татвар ногдох орлогыг тодорхойлж “хуулиар татвар ногдуулах” Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан;

- Улмаар дээрх үнийг Монголбанк шууд баримтлан алтны ханшийг зарлах талаар хуульд тусгаагүй бөгөөд “харгалзан Монголбанк зарлах” талаар хуульчилсан тул дэлхийн зах зээлийн үнээс дээгүүр, эсхүл доогуур тогтоох нь Монголбанкны эрх хэмжээний асуудал болсон;

- Ингэснээр татвар төлөгчдийн хууль ёсны эрх ашигт Монголбанк шууд халдан татвар ногдох орлогыг тодорхойлох бүрэн эрхийг эдлэх болсон зэрэг сөрөг үр дагаврууд шууд бий болно. Алтны ханшийг тодорхойлдог олон улсын бирж, агентлагуудаас хамгийн өндөр ханш зарласан нэг буюу хэд хэдэн байгууллагын үнийг Монголбанк дэлхийн зах зээлийн үнэ гэж үзэн түүнийг харгалзах нэрийдлээр /шууд баримтлах талаар хуульд тусгаагүй/ алтны ханшийг улам дээгүүр тогтоон бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар ногдох орлогыг тодорхойлж татвар төлөгчдийн эрх ашгийг зөрчих хууль зүйн боломж бий болсон байна.

Төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь өдөр бүр алтны ханшийг зарлаж тодорхойлохгүй нь тодорхой боловч татвар ногдох орлого гэж юу болохыг тодорхой хуульчлан тогтоолгүйгээр энэ эрхээ бусдад шилжүүлсэн хууль баталснаар Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.

Татвар төлөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангаж, тэдний өмчлөх эрхэд хууль бусаар халдахгүй байх үүднээс татварыг зөвхөн төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлаас баталсан хуулиар ногдуулдаг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Үндсэн хуулийн 17.1.3 дахь хэсэгт “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэж хуульчилсныг Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4.1.4, 6.2 дахь хэсгийн “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан” 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцон татвар ногдох орлогыг тодорхойлох тухай заалт нь дээр дурдсан үндэслэлээр шууд зөрчсөн байна.

2/ Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын шийдвэр үйл ажиллагаа нь “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн дагуу явагддаг.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3.1.4 дэх заалтад “... Улсын Их Хурлын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын, Түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх”, 10.1.4 дэх заалтад Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн талаар “... Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлогод хэрхэн нийцэж байгаа, түүнчлэн энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан эсэх талаар энэ хуулийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газрын өгөх санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын

хуралдаанд хэлэлцүүлэх” талаар хуульчилсан байна. Гэтэл Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь дээрх хууль зүйн шаардлагуудыг бүхэлд нь зөрчсөн бөгөөд хууль санаачлагч нь санаачилсан хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын болон хууль хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий байгууллагуудаас холбогдох санал, дүгнэлтийг аваагүйн зэрэгцээ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь уг хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцэж байгаа, түүнчлэн Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нийцэж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийн төсөл бэлтгэж Засгийн газрын хуралдаанд хэлэцүүлээгүй болно.

Үндсэн хуулийн 1.2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх зарчим нь “төрийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах” гэсэн агуулгыг илэрхийлдэг бөгөөд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” 2006 оны 12-р сарын 21-ний өдрийн хуулийг батлахдаа Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд заасан журмыг зөрчсөн болох нь дээрх хууль зүйн үндэслэлүүдээр батлагдаж байна.

а/ Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн Үндэсний татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх гэсэн 21 дүгээр зүйлийн 21.6.6 дахь заалтад “орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээний төсөлд санал өгөх” талаар хуульчилсан.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68.0 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэж заасан бөгөөд мөн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан үнийн өсөлтийн орлого гэдэг нь ...дэлхийн зах зээлийн дундаж үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцсоны дараа үлдэх орлого юм.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод ногдуулдаг 68 хувийн албан татвар нь хуулиар ногдуулдаг бусад албан татварын төрлүүдтэй давхардсан болохыг дараах жишээгээр тайлбарлая. Тухайлбал, дэлхийн зах зээлийн дундаж үнийг харгалзан Монголбанкнаас 1 унци алтны үнийг 600 ам.доллараар зарласан гэж үзье. Энэ тохиолдолд:

а/ Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3 дахь заалтад заасны дагуу 600 ам.долларын орлогод ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болох 5 хувийн улсын татвар ногдуулах ба ингэснээр үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод үнийн өсөлтийн албан татвараас гадна нөөц ашигласны татвар давхар ногдоно,

б/ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 500 ам.доллараас дээш гарсан орлогод 68 хувийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар ногдуулснаас үлдэх орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар давхардуулан ногдуулна /дээрх тохиолдолд 32 ам.долларт татвар давхардан ногдуулна/

Өөрөөр хэлбэл зарим бүтээгдэхүүний буюу тухайлбал алтны үнийн өсөлтөөс шууд шалтгаалан үүссэн нэмэгдэл орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг татварууд давхардан ногдож байгаа болно.

Татварын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.6 дахь заалтад “орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас

урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээний төсөлд санал өгөх” нь Үндэсний татварын ерөнхий газрын даргын бүрэн эрх болох талаар хуульчилснаар нэгдүгээрт, хөрөнгийн болон орлогын албан татварыг давхардуулан ногдуулахгүй байх талаар олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулах, нөгөөтэйгүүр татварын бодлогын хувьд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгийн болон орлогын албан татварыг давхардуулан ногдуулахгүй байх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна. Гэтэл Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод 68 хувийн албан татвар ногдуулснаар орлогын татварын төрлүүд болох Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар зэргийг давхардуулан ногдуулж татвар төлөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалт нь хууль тогтоомж өөр хоорондоо агуулгын болоод хэлбэрийн хувьд зөрчилгүй байх гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд татвар давхардуулан ногдуулахгүй байх талаар Татварын ерөнхий хуульд хуульчилсан байтал Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулиар бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод 68 хувийн албан татварыг давхардуулан ногдуулахаар хуульчилсан байна.

## 2. Иргэн Б.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

1/ Дэлхийн зах зээл дээр алтны арилжаа хийгдэж, алт арилжаалагдах үнийг тодорхойлдог томоохон бирж, мэдээллийн агентлагуудын талаар дурдсан. Тухайлбал, Токиогийн бараа таваарын бирж, Нью-Йоркийн худалдааны бирж, Дубайн алт болон бараа таваарын бирж зэрэг томоохон арилжааны төвүүд үйл ажиллагаа явуулж алтны биржийн арилжааны 90 орчим хувийг эзэлдэг байна. Алтны арилжааны үнийн талаар тогтмол мэдээллэдэг Ройтерс агентлаг, Блумберг мэдээллийн агентлаг зэрэг томоохон мэдээллийн агентлагууд үйл ажиллагааныхаа хүрээнд алтны арилжаалагдаж буй үнийн талаар мэдээлэл хүргэж ажилладаг.

Дээрхээс үзэхэд Монголбанк алтны дэлхийн зах зээлийн үнэ гэдэгт Токиогийн бараа таваарын бирж, Нью-Йоркийн худалдааны бирж, Дубайн алт болон бараа таваарын бирж гэсэн гурван бирж Ройтерс агентлаг, Блумберг мэдээллийн агентлаг гэсэн 2 мэдээллийн агентлагаас буюу нийт 5 сонголтоос дэлхийн зах зээлийн үнийг өөрийн эрх хэмжээний хүрээнд тодорхойлох, эсхүл 2 буюу түүнээс дээш бирж болон мэдээллийн агентлагийн алт арилжаалагдах дундаж үнийг дэлхийн зах зээлийн үнэ гэж тодорхойлох боломжтой болж байгаа болно. Эдгээр бирж, агентлагууд нь алтны арилжаалагдаж буй үнийн талаар харилцан адилгүй үнэ зарладаг.

Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогоос бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар ногдох орлого шууд тодорхойлогдох тул Монголбанк дээрх бирж болон агентлагуудаас алт хамгийн өндөр үнийн дүнтэй арилжаалагдаж байгааг нь сонгох, улмаар түүнийг харгалзах нэрийдлээр 1 унци алтны үнийг дээгүүр зарлаж татвар төлөгчийн эрх ашгийг зөрчих эрх зүйн үндэс бүрдээд байгаа болохыг дахин дурдъя. Монголбанк өнөөдөр алтны үнэ зарлахдаа баримталж буй бирж, агентлагаа солих, түүнчлэн зарлаж буй үнээ өөрчлөх эрх нь хуулиар нээлттэй байна.

2/ Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4.1.1, 6.2 дахь хэсгүүдэд алтны үнийн өсөлтийг тодорхойлохдоо “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан” 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг үнийн өсөлтийн нэмэгдэл орлого гэж үзэн татвар ногдох орлогыг тодорхойлсон байна.

Энэхүү заалтаас үзэхэд татвар ногдох орлогыг хуулиар тогтоосон мэт харагдавч бодит байдал дээр татвар ногдох орлогыг тодорхойлох Улсын Их Хурлын эрхийг

Монголбанкинд буюу бусдад шилжүүлж эрх олгосон хуулийн заалт юм. Татвар ногдох орлогыг Улсын Их Хурал хуулиар тодорхойлсон бус харин тодорхойлох эрхийг Монголбанкинд олгосныг хуулиар татвар ногдуулсан гэж үзэж болохгүй юм. Өөрөөр хэлбэл татвар ногдох орлогыг тодорхойлох онцгой бүрэн эрхээ бусдад шилжүүлчихээд ийнхүү эрх шилжүүлсэн хуулийн заалтаа татвар ногдуулах орлогыг тодорхойлон хуульчилсан гэж үзэх нь хууль зүйн үндэслэлгүй.

3/ Өмнө гаргасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг давхардуулж ногдуулж байна гэсэн өөрийн өргөдлийн шаардлагаасаа татгалзсан.

4/ Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн дагуу нийт 24 төрлийн татвар /албан татвар, хураамж, төлбөр гэсэн ангилалтайгаар/ үйлчилж байна.

Энэхүү татваруудыг ногдуулахдаа “хуулиар татвар ногдуулах” тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу татвар ногдох хувь, хэмжээ, мөн татвар ногдох орлогыг хуулиар тодорхойлсон байх боловч зөвхөн Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, тухайлбал алтны үнийн өсөлтөөс үүсэх нэмэгдэл орлогыг тодорхойлох эрх нь хууль тогтоох байгууллагад бус Монголбанкинд шилжсэн байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд зэсийн үнийн өсөлтийн албан татвар ногдох нэмэгдэл орлогыг “Лондонгийн металлын бирж дээрх зэсийн суурь үнийг баримтлан” тодорхойлох талаар хуульчилсан боловч алтны үнийн өсөлтийн албан татвар ногдох нэмэгдэл орлогыг Монголбанкнаас зарласан ханшийг баримтлан тодорхойлохоор хуульчилснаар уг хуульд татвар ногдох орлогыг Улсын Их Хурал нарийвчлан тодорхойлсон /зэсийн үнийн өсөлтийн нэмэгдэл орлого/, мөн татвар ногдох орлогыг тодорхойлох бүрэн эрхээ Улсын Их Хурал Монголбанкинд шилжүүлсэн /алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого/ зөрчилтэй зохицуулалтууд орсон байна.

3. Иргэн Б.-гийн мэдээллийн нэмэгдүүлсэн шаадлагын агуулга:

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шударга ёс... тэгш байдал...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн “шударга ёс... тэгш байдал...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалт нь ижил бөгөөд харьцуулж болохуйц нөхцөлтэйгээр эрх зүйн харилцаанд оролцогчдод алагчлалгүй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг төрийн зүгээс бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулна гэсэн агуулгатай байдаг. Энэ ч үүднээс тэгш байдал нь төр харьяат субъектүүдээ хууль болон шүүхийн өмнө адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг хангахад үйл ажиллагаагаа бүрэн чиглүүлснээр хэрэгжинэ.

Алт олборлох үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хувьд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварыг давхардуулан төлдөг атал бусад иргэн, аж ахуйн нэгжийн хувьд татварыг давхардуулан ногдуулахгүйгээр орлогоос нэг төрлийн татварыг эхлэн төлүүлж, улмаар төлсөн татварыг орлогын суурь үнээс хассанаас үлдэх үнийн дүнгээс дараагийн татварыг төлүүлэх замаар татвар ногдуулдаг. Ашигт малтмалын тухай хуулиар ашигт

малтмалын нөөц ашигласны төлбөрийг түүний борлуулалтын нийт дүнгээс шууд суутгаж ногдуулахаар хуульчилсан байна.

Гэтэл Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэж татвар ногдох орлогыг тодорхойлохдоо дээрх нөөц ашигласны төлбөрийг хасч тооцох талаар дурдаагүй болно. Дээрх татварын төрлүүдийг давхардуулан ногдуулж байгаа нь Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2006 оны 119 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-аас тодорхой харагдана. Татварыг давхардуулан ногдуулахгүй байх талаар татварын багц хуулиудад хуульчилсан бөгөөд тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг дурдаж болно.

#### 4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч З.-гийн тайлбарын агуулга:

Хуулиар ногдуулсан албан татвар төлөх гэдэгт “албан татварыг хуулиар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэх, татварын хувь, хэмжээ, татвар ногдох орлогыг хуулиар тогтоох” зэрэг ойлголт хамаарах бөгөөд ийнхүү тогтоосон татварыг төлөх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг мөн, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4.1.4, 6.2 дахь хэсэгт “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэж хуульчилснаар “хуулиар ногдуулсан албан татвар төлөх тухай Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг зөрчсөн” гэсний тухайд:

Аливаа татварыг юуны өмнө төрийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хувь хүн болон хуулийн этгээдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд ногдуулж, төсөвт хураадаг бөгөөд “эдийн засгийн нийлүүлэлтийн” гэх мэт татварын эрх зүйн зарим онол татварыг эдийн засгийн хөгжил болон зохицуулалтын үндсэн гол хүчин зүйлийн нэг гэж үздэг байна.

Тодорхой төрлийн татварын хуулиар уг татварыг юунд ногдуулах өөрөөр хэлбэл “хөрөнгөд ногдуулах” эсвэл “орлогод ногдуулах”-ын алин болох, мөн тухайн татвар ногдох “хөрөнгө, орлогын хүрээг тодорхойлдог улс орнуудын болон өөрийн орны өмнөх хуулиудын жишгээр Улсын Их Хурал 2006 оны 5 дугаар сарын 12-ны “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар”-ыг Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 16 дугаар зүйлд 9 дэх хэсгийн заалтаар нэмж, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг баталсан.

Энэ хуулийн 6.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох ерөнхий зарчмыг “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэж заасан бөгөөд энд “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнэ” гэдэг нь бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс олсон орлого буюу тухайн албан татварыг ногдуулах орлогыг тодорхойлоход хэрэглэх 1 унци алтны үнийг Монголбанк зарлахаар заасан болно.

Мөн хуулийн 7 дугаар зүйлд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хувь, хэмжээг “энэ хуулийн 6.1, 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68 хувиар” тооцож албан татвар ногдуулахаар тогтоосон байна. Гэтэл иргэн Б. “Монголбанк нь алтны ханшийг өөрчлөн зарлаж татвар ногдуулах нэмэгдэл орлогыг тодорхойлох

замаар Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаж байна” гэсэн нь үндэслэлгүй буруу бөгөөд алтны үнэ /Монголбанкнаас зарласан/ болон үнийн өсөлтөд ногдуулах татварын хувь, хэмжээг мөн “үнэ ханш зарласан” үйл ажиллагааг “албан татвар тогтоохтой” хооронд нь эндүүрсэн хоёр өөр зүйлийг жишиж холбосон нь ойлгомжгүй байна.

“Дэлхийн зах зээлийн үнэ” -гэснээр Монголбанк нь дэлхийн хэмжээнд үнэ зарладаг хэд хэдэн том биржийн үнэд үндэслэн 1 унци алтны үнийг зарлах боломж олгосон гэж үзэж байна. Б.-гийн мэдээлэлд дурдсанчлан Монголбанк нь нэг биржийн үнийг шууд өөрчлөлгүй зарлах нь учир дутагдалтай болно гэж үзэж байна. Нөгөө талаар Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 3.1.1 болон 4.1.4 дэх заалтад “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнэ” гэсэн хуулийн заалт нь өөрөө Монголбанкинд тухайн ханшийг зарлах эрх олгосон заалт болно.

Иргэн Б. мэдээлэлдээ Улсын Их Хурлын шийдвэр, үйл ажиллагаа нь “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн дагуу явагддаг. Гэтэл зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь дээрх хуулийн шаардлагуудыг зөрчсөн, хууль санаачлагч нь санаачилсан хуулийнхаа төслийн талаар Засгийн газрын болон холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг аваагүй гэсний тухайд:

Улсын Их Хурал үйл ажиллагаандаа Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай Улсын Их Хурлын тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрддөг бөгөөд Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зөвхөн нэгэн хэсэг буюу “...хууль санаачлагч хууль санаачлах эрхээ хэрэгжүүлж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг” зохицуулдаг билээ. Улсын Их Хурлын тухай хуулийн 32.1 дэх хэсэгт: Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд нэгдсэн болон байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой бусад асуудал хэлэлцэх, санал хураах, батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална гэж заасан байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хувьд уг хуулийн 6.1.1 дэх заалт болон 4.2 дахь хэсэг нь Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж гаргасан шийдвэр байсан юм. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн Цэцийн шийдвэрийг биелүүлэх тухай 36 дугаар зүйлд:

- Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурлын хуралдааны дэгд заасан журмын дагуу шийдвэрлэхээр заасан,
- Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн Гуч дахь хэсэгт Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журмыг тогтоосон бөгөөд 30.1.5-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна” гэсний дагуу хэлэлцүүлгийн дүнгээр тухайн өөрчлөлт орсон бөгөөд энэ хуулийг аль нэг гишүүн санаачлаагүй дэгийн дагуу Байнгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд боловсруулж чуулганд оруулсан болно.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн хэсэг заалт нь Үндсэн хуулийг зөрчсөн гэсэн анхны болон нэмэлт мэдээлэл нь бодитой биш түүнийг үндэслэх үндэслэл олдохгүй байгаа байдал харагдаж байна. Учир нь иргэн Б. өөрийн мэдээлэлд дээрх хуулийн зүйл нь Үндсэн хууль зөрчсөнийг тайлбарлаж үндэслэл гаргахдаа 1/ Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2006 оны дүгнэлтийн дагуу Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа тухайн төслөөр Засгийн газраас санал аваагүй гэжээ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэж, хүлээн авсны дүнд аливаа хуульд өөрчлөлт оруулах тохиолдолд хуульд өөрчлөлт оруулахдаа Засгийн газраас санал авах хуулийн заалт, дэг байхгүй учраас энд холбогдох хуулийн заалтыг зөрчөөгүй болно.

Иргэн Б. дараагийн үндэслэлдээ “Татвар давхардуулан ногдуулахгүй байх талаар татварын багц хуулиудад хуульчилсан бөгөөд тухайлбал Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн “Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал” гэсэн 12 дугаар зүйлийн 12.1.14 дэх заалтад “төсөвт төлөхөөр тайлагнасан онцгой, үл хөдлөх эд хөрөнгийн болон зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, үндсэн хөрөнгөөс бусад импортын бараа, материал, түүхий эдийн гаалийн албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамж” буюу дээрх татваруудыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөд давхардуулахгүй байх үүднээс хасч тооцохоор хуульчилсан байна” гээд цааш нь давхар татвараас иргэдэд үүсэх дарамтын талаар бичсэн байна. Энд дурдсан давхар татварын асуудал нь Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулийн 6 дугаар зүйл буюу дээрх хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөнтэй хамаагүй, Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхэд үл хамаарах асуудал гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-ийн “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг”, 6 дугаар зүйлийн 6.2-ын “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно”, 7 дугаар зүйлийн 7.1-ийн “Энэ хуулийн... 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шударга ёс, тэгш байдал...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-ын “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэсэн заалтыг зөрчөөгүй болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийн 30 дугаар зүйлийн 30.1.5-д “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна”, 30.1.7-д “энэ дэгийн 30.1.5-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг холбогдох байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй” гэж тус тус заажээ.

Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 11 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2006 оны 12 дугаар сарын 19, Төсвийн байнгын хорооны 2006 оны 12 дугаар сарын 20, түүнчлэн Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар

сарын 21-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзэхэд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтад буй “Лондонгийн металлын бирж дээрх” гэснийг “дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан” гэж өөрчлөн найруулахдаа Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авах шаардлагагүй болох нь тодорхой байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар “хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах” нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах бөгөөд Улсын Их Хурлын энэхүү онцгой бүрэн эрхийг Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна”, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Татварыг Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал... тогтооно” гэж тус тус нарийвчлан хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн заалт нь татварыг бий болгох, тэдгээрийн хувь, хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Гэвч Үндэсний татварын Ерөнхий газрын даргын 2006 оны 119 дүгээр тушаалаар баталсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-ын 4.3-т “олборлосон алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр... нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар ногдох орлогыг тодорхойлоход хамаарахгүй” гэж мөн дээрх татвар, төлбөрийг хэрхэн ногдуулж байгаа талаар Худалдаа, хөгжлийн банк, Анод банк, Зоос банк, Улаанбаатар банкнаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, шинжээчдийн дүгнэлтээс үзэхэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон үнийн өсөлтийн албан татварыг давхардуулан ногдуулж байгаа нь нотлогдож байгаа тул Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох яам, агентлаг хууль батлах, хэрэгжүүлэх ажиллагаандаа уг зөрчлийг арилгах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-ийн “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг; 6 дугаар зүйлийн 6.2-ийн “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно”, 7 дугаар зүйлийн 7.1-ийн “Энэ хуулийн..., 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шударга ёс, тэгш байдал...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-ын “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2-т заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.



## **Тэмдэглэл:**

Маргааныг шалгасан илтгэгч гишүүний хувьд Цэцийн дүгнэлтэд эргэлздэг. Өргөдөл, мэдээллийн дагуу маргаан үүсгэх “анхдагч” эрх нь тухайн маргааныг шалгаж буй Цэцийн гишүүнд олгогддог. Энэ ч утгаараа маргааныг шалгах явцад Үндсэн хууль зөрчсөн үндэслэл нотлогдохгүй байвал татгалзах эрх нь гишүүнд л байдаг. Гэхдээ маргаан үүсгэж Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа гишүүн бүр тухайн асуудалд Үндсэн хууль зөрчсөн гэх байр суурьтай байдаг гэж дүгнэж бас болохгүй. Давхар татвар ногдуулж байгаа нь олон зүйл, тайлбар, нотлох баримтаар батлагддаг.

Арилжааны банкуудаас авсан тайлбар ч татварыг давхардуулан авч байгааг тодорхой тайлбарласан байдаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.14-т орлогын албан татвараас хасч тооцох жагсаалтуудыг баталсан. Гэтэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 500 ам.долларын зөрүүнээс гарах үнийн өсөлтийн татварыг хураахдаа нэг сууриас давхардуулан авч байгаа нь тодорхой байсан.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.05.09 № 05**

**Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Б., М.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э., Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх О.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1992 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Татварын ерөнхий хууль<sup>89</sup>

- 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө”

### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

<sup>89</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, сэтгүүл, 1992 оны №4-5-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

1/ Энэхүү Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг дараах үндэслэлээр зөрчсөн гэж үзэж байна.

Төрөөс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, тэдэнд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг олгох нь зүй ёсны хэрэг боловч тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд Улсын Их Хурлаас баталсан татварын хууль тогтоомжийн “аливаа нэмэлт, өөрчлөлтүүд” тогтвортой байдлын гэрээ байгуулсан талд үйлчлэхгүй байхаар хуульчилсан нь Үндсэн хуулийн “тэгш байдал”, “хууль дээдлэх” зарчмыг алдагдуулж байгаа гэхээс аргагүй юм.

2/ Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэх заалтыг зөрчсөн тухайд:

Ардчилсан, хүмүүнлэг, энэрэнгүй нийгэм байгуулна гэж Үндсэн хуульдаа тунхагласан манай орны тухайд Үндсэн хуулийн дээрх заалт чухал ач холбогдолтой төдийгүй энэ ч утгаараа төрийн үүрэг үүнд чиглэгдэх учиртай. Бизнесийн тодорхой салбарт нэгэн ижил гарааны нөхцөл, боломжийг төрөөс бүрдүүлсэн хирнээ Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан гэх шалтгаанаар хуулийн үйлчлэл хэрэгжихгүй, бусдаас давуу ашигтай боломжийг гэрээний нэг талд шууд олгож үүнийг нь ч хууль тогтоогчийн зүгээс баталгаажуулж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна. Тогтвортой байдлын гэрээ байгуулж чадаагүй ижил салбарт төдий хэмжээний хөрөнгө оруулалт оруулсан дотоод гадаадын хуулийн этгээдүүд гэрээ байгуулсан талуудад атаархахаас өөр боломжгүй байдлыг бий болгож байгааг бодолцох учиртай. Иймд Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа дээрх заалтыг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

1/ Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” гэж заасан байна.

Татварын ерөнхий хуулийн дээрх хэсгийн “стратегийн хөрөнгө оруулагч” гэснийг “гадаадын хөрөнгө оруулагч” гэж ойлгох нь буруу бөгөөд мөн хуульд стратегийн хөрөнгө оруулагч гэдэг нь гадаадын хөрөнгө оруулагч гэж тайлбарлаагүй байна. Өөрөөр хэлбэл, өргөдөлд дурдсан шиг зөвхөн гадаадын хөрөнгө оруулагч дээрх хөнгөлөлтийг эдлээд дотоодын хөрөнгө оруулагч эдлэхгүй нь гэж ойлгож болохгүй. Ер нь энэ заалт бол улс орны эдийн засгийн хөгжлийн бодлогын нэг чухал хэсэг болох хөрөнгө оруулалтын талаарх заалт бөгөөд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихийн тулд тэдний үйл ажиллагаа явуулах орчин болон юуны өмнө татварын орчинг тогтвортой байлгах аргаар заадаг билээ. Хөгжиж байгаа улс орнууд гадаадын шилдэг тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх, удирдлага менежментийн арга туршлагаас суралцах асуудал нь хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлогын чухал хэсэг гэдэгтэй хэн ч маргахгүй нь тодорхой.

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн

ажуулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор дээрх хуулийн заалт батлагдсан юм. Өөрөөр хэлбэл, төрөөс улсын эдийн засгийг хөгжүүлж үр ашгийг нь нэмэгдүүлэх, улмаар ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд бүрэн чиглэгдсэн хууль гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих нь зүй ёсны хэрэг гэж өргөдөл гаргагч бичсэн байх ба энэ дэмжлэг юуны өмнө татварын орчинг тогтвортой байлгах үйлдлээр илэрхийлэгддэг олон улсын жишиг байдаг.

Тухайлбал, ОХУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулснаас хойш татварын хууль тогтоомжид өөрчлөлт орж татварын хувь, хэмжээ нэмэгдвэл уг гэрээний хүчинтэй байх хугацаанд нь шинэ хуулийн заалт үйлчлэхгүй” гэж заасан байна.

2/ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн “Тогтвортой байдлын гэрээ” гэсэн 19 дүгээр зүйлд: 1.Монгол Улсад 2.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж татварын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг байгуулж болно, 4.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн салбарыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дампууруулаагүй, эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь зогсоогоогүй, талууд харилцан тохиролцож хэлэлцээрийг цуцлаагүй байхад гадаадын хөрөнгө оруулагч өөрөө санаачлан тогтвортой байдлын гэрээнд заасан хугацаанаас өмнө үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд уг хөрөнгө оруулагчид татварын болон бусад чөлөөлөлт, хөнгөлөлтөөр олгосон хөрөнгийг нөхөн төлүүлнэ” гэж заасан байна.

Эндээс харахад хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж байгаа 2 талын эрх, үүргийг адил хэмжээнд тусгаж өгсөн байна. Хөрөнгө оруулагч эхний ээлжинд хүсэлтээ гаргах ёстой, 2 сая ам.доллароос дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх ёстой, гэрээнд заасан хугацаанаас өмнө үйл ажиллагаагаа зогсоовол татварын болон бусад чөлөөлөлт, хөнгөлөлтөөр олгосон хөрөнгийг нөхөн төлнө гэж хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхой заасан байна.

3/ Ашигт малтмалын тухай хуулийн “Хөрөнгө оруулалтын гэрээ” гэсэн нэртэй 29 дүгээр зүйлд: 29.1.Үйл ажиллагааныхаа эхний 5 жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт 50 саяас дээш америк доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: “29.1.1.татварын орчинг тогтвортой байлгах” гэж заасныг ч мөн анхаарах нь зүйтэй.

4/ Улсын Их Хурлаас 2006 онд татварын багц хуулиуд болох Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /энэ хуулиар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд олон тооны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлдэг байсныг хүчингүй болгосон/, Хувь хүний орлогын албан татварын тухай, Онцгой албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай гэсэн 4 хуулийг баталсан бөгөөд тэдгээртэй уялдуулан батлахаар хэлэлцэж эхлээд байгаа Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг төслийн 3.2-т “Засгийн газраас гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай байгуулах тогтвортой байдлын болон хөрөнгө оруулалтын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” гэж тусгасан байна.

Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч гэдгийг гадаадын дотоодын алин ч байхаар заасан бөгөөд тогтвортой байдлын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ хоёрыг адил хэмжээнд авч үзсэн болохыг ч анхаарах хэрэгтэй. Дээрх байдлуудаас дүгнэхэд

Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1.7-д заасан төрийн албан татварын бодлогыг тодорхойлох, татварыг ялгамжтай тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх чиглэлээр Татварын ерөнхий хуулийн дээрх заалтыг баталсан байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### 3. Үндэсний татварын ерөнхий газрын тайлбарын агуулга:

Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 4-т “Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж тогтвортой байдлын гэрээг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуулийн хүрээнд байгуулна”, мөн зүйлийн 5-д “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” гэж заасан байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн 29 дүгээр зүйлд: Үйл ажиллагааныхаа эхний 5 жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт 50 саяас дээш америк доллартой тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: татварын орчинг тогтвортой байлгах, тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнээр борлуулах, олсон орлогоо захиран зарцуулах эрхийг нь баталгаажуулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бусад төрлийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, бүс нутгийг хөгжүүлэх, ажлын байр шинээр бий болгох, учирсан хохирлыг нөхөн төлөх, эхний таван жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ 50 саяас дээш америк доллартой тэнцэх бол 10 жил, 100 саяас дээш америк доллартой тэнцэх бол 15 жил, 300 саяас дээш америк доллартой тэнцэх бол 30 жилийн хугацаагаар гэрээ байгуулах тухай заасан байна.

Монгол Улсын хэмжээнд тогтвортой байдлын гэрээ байгуулан ажиллаж байгаа 9 аж ахуйн нэгж, нийт 235.0 сая ам.долларын хөрөнгө оруулах үүрэг хүлээсэн байна.

Тогтвортой байдлын гэрээ байгуулах нэг үндсэн нөхцөл нь гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан татварын хуульд заасан татварын хувь, хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийг гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтвортой хадгалах тухай заалт байдаг бөгөөд уг заалтыг гэрээ байгуулсан талууд харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрч байгуулдаг байна. Тухайлбал, 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө байгуулсан Тогтвортой байдлын гэрээнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулсан бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3-10 жил чөлөөлөгдөж, импортын гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх хөнгөлөлтийг эдлүүлэхээр тусгаж өгсөн байна. Хэдийгээр мөрдөж байгаа татварын хуульд дээрх хөнгөлөлт, чөлөөлөлтүүд байхгүй боловч гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан татварын хуулийн заалтыг гэрээний хугацаанд тогтвортой мөрдөхөөр тохиролцсонтой холбоотой байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан Тогтвортой байдлын гэрээ болон уг гэрээнд татварын орчинг гэрээний хугацаанд хэвээр хадгалахаар туссан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчөөгүй байгааг дор дурдсан хуулийн үндэслэлээр тайлбарлаж байна. Үүнд:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг

хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Хорин тавдугаар зүйлийн 1-ийн 7-д “... төрийн санхүү, зээл, албан татвар, ... улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлох...” асуудлыг Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр заасан нь эдийн засгийг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн татварын бодлогоор хэрэгжиж байна.

2/ Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т “...эдийн засгийн харилцааг аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж...” байхыг Засгийн газрын бүрэн эрхэд хамруулсан болно.

#### 4. Монгол Улсын Сангийн сайд Б.-гийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн хуулийн Тавдугаар зүйлийн 7 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заалтууд нь төрийн эдийн засгийн үүргийг тусгаж өгчээ.

Өөрөөр хэлбэл, төрийн эдийн засгийн үүрэг нь улс орны эдийн засгийг үр ашигтай хөгжүүлэх, улмаар ард түмний материаллаг аж амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Энэхүү үүргээ хэрэгжүүлэх үүднээс гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оруулж буй хөрөнгө оруулалтыг бодит үр дүнтэй болгохын тулд эрх зүйн онцлог бүхий зохицуулалтыг тусгах зайлшгүй шаардлагатай байдаг. Тэрхүү эрх зүйн онцлог бүхий зохицуулалтын нэг нь “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” хэмээх заалт юм.

Иймд Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй юм.

#### 5. Иргэн Б.-гийн хариу тайлбарын агуулга:

Миний бие Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, зохих шатны төрийн байгууллагуудаас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, албан бичигт дараах тайлбарыг гаргаж байна.

#### 1/ Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан тайлбарын талаар:

Дээрх тайлбарыг албан ёсны гэхэд эргэлзээтэй ба албан хэвлэмэл хуудсан дээр бус, О. гишүүний гарын үсэг зурагдаагүй зэргээс харахад ийм ойлголт төрүүлж байна. Үүгээрээ төрийн албан хэрэг хөтлөлтийн зарчмыг зөрчихийн сацуу Үндсэн хуулийн цэц гэх төрийн байгууллагыг хүндлэхгүй, асуудалд хайхрамжгүй хандаж байгаагийн илрэл гэж үзэж байна. Мэдээлэл гаргагчийн зүгээс хөрөнгө оруулагч гэдэг ойлголтыг гадаад, дотоод гэж ялгаагүй бөгөөд Засгийн газраас нэр бүхий компаниудтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд хамааралтай байгаагаас өргөдөлд дурдсан гэж андуурч ойлгосон бололтой.

Тайлбарт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заалтыг тодорхойлоод үүнийг хэрэгжүүлэх зорилгоор дээрх хуулийн заалт батлагдсан ба төрөөс улсын эдийн засгийг хөгжүүлж үр ашгийг нь нэмэгдүүлэх, улмаар ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд бүрэн чиглэгдсэн хууль гэж үзэж байна гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан дээрх заалтаа зөв байсан зэргээр нотлохыг хичээжээ. Татварын ерөнхий хуульд 2001 оны 11 дүгээр сарын 16-нд дээрх заалт орсноос хойш багагүй хугацаа

өнгөрсөн хэдий ч тайлбарт дурдсан шиг эдийн засгийн үр ашиг нэмэгдсэн, ард түмний амьдрал дээшилсэн эсэх нь бодит байдал дээр ямархуу байгаагаар тайлбарлагдах бизээ. Өөрөөр хэлбэл, тогтвортой байдлын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид гэрээ байгуулснаас хойшхи татварын хууль, тогтоомж үйлчлэхгүй байгаагаараа хождог, хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа гэдгээрээ Монгол Улс хохирдог тийм л эрх зүйн зохицуулалт бий болчихоод байгаа юм. Үүнийг ч тухайн үед Э. гишүүн Төсвийн байнгын хорооны дүгнэлтийг танилцуулж байхдаа “тогтвортой байдлын гэрээ байгуулж байгаа хүмүүс нь хариуцлагатай хандаад байвал дахиж заавал Улсын Их Хурлаар хэлэлцэхдээ тэрний нөхцөлийг нь дахиж эргэж хянаж үзээд байх шаардлагагүй, тэгвэл гэрээний утга алдагдах юм. Ажлын хэсэг дээр танилцуулж ирсэн байдлаас үзэхэд хуучин Б., О. нарыг Сангийн сайд байх үед байгуулагдсан тийм тогтвортой байдлын гэрээнүүд байдаг юм байна. Сангийн яамны улсуудын үзэж байгаагаар Монгол Улсад үнэхээр ашиггүй, яаж байгаад ч байгуулагдсан нь мэдэгдэхгүй ийм гэрээ байдаг юм байна. Энэ гэрээг цааш үргэлжлүүлээд явуулна гэхээр бас их төвөгтэй зүйлүүд бий гэдгийг харж үзэж байгаад Засгийн газраас 2 дахь заалтыг оруулсан, энэ дээр манай гишүүд харгалзана биз дээ” гэж тодорхой хэлсэн нь тэмдэглэлд үлджээ. Үүнээс харахад Монгол Улсад ашиггүй гэрээ байгуулчихсан тэр хэвээр нь мөрдөх гэхээр явж өгдөггүй, иймээс Татварын ерөнхий хуульд урдын хийсэн алдаагаа халхлах байдлаар дээрх заалтыг зориуд нэмж оруулсан гэж үзэхэд хүргэж байна.

Үүгээр ч зогсохгүй Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3.2-т дээрх заалт утга агуулгын хувьд бараг хэвээр орно гэдгээ ч тодорхой хэлжээ. Мэдээлэл гаргаснаараа Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын албан татварын бодлогыг тодорхойлох бүрэн эрхийн асуудлыг хөндөөгүйн сацуу гагцхүү Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтын шударга ёс, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмуудыг зөрчсөнөөрөө Үндсэн хуультай зөрчилдөж байгааг дурдсан болохыг анхаарна уу.

#### 2/ Сангийн сайдын гаргасан тайлбарын тухайд:

Сангийн сайдын тайлбарт дурдсанаар асуудлыг хэт ерөнхийлсөн төрийн эдийн засгийн үүрэг нэрээр халхалсан оновчгүй зохицуулалт гэдэг нь өнөөдөр тодорхой харагдаж байгаа ба Сангийн сайд Б. Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлтийн 5 дахь хэсгийн заалтыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байх үед сайд байгаа үеийн байр сууринаасаа өөр үзэл бодолтой байсан нь тэмдэглэлд тусгагдсан байна. Иймд Сангийн яамны байр сууриас харахад төрийн татварын бодлогыг хэрэгжүүлэхдээ өөр өнцгөөс тухайлбал, улс орны эрх ашгаас илүүтэйгээр хөрөнгө оруулагчдын эрх ашгийг урьтал болгодог тийм зохицуулалтыг дэмждэг гэсэн ойлголтыг төрүүлж байна. Тогтвортой байдлын гэрээний хэрэгжилтийн байдлыг дээрх хуулийн заалттай хамтад нь аваад үзэхэд дан ганц аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт, хөрөнгө оруулагчид ашигтай байх нөхцөл нь шууд хэрэгждэг гэрээнд заасан улсад ашигтай зарим зүйл заалт хэрэгждэггүй нь харагдаж байна. Тухайлбал, Засгийн газар “Чин Хуа Мак Нарийн сухайт” ХХК-ийн хооронд байгуулсан 2005 оны гэрээнд “олборлосон буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулна “ гэж тодорхой заасан атал 2006 оны 10 дугаар сарын 9-нд Сангийн сайд нүүрсний үнийг 2006 оны 10 дугаар сарын 1-нээс 21.50 ам.доллар байхаар тогтоосон нь олон улсын зах зээлийн үнээс доогуур /шинжээчид 29.27 ам.доллар гэж үзсэн/ тогтоосон нь байгуулсан гэрээг зөрчсөн төдийгүй тогтвортой мөрдөгддөг гэхэд эргэлзээтэй байгаа юм.

#### 3/ Үндэсний татварын ерөнхий газрын гаргасан тайлбарын талаар:

Тус газар нь тогтвортой байдлын болон хөрөнгө оруулалтын гэрээг хоёр талын ашиг сонирхолд нийцсэн, харилцан зөвшилцлийн үндсэн дээр байгуулагддаг эрх зүйн баримт бичиг гэж үзжээ. Энэ нь нөгөө талаас төрөөс тодорхой чиглэлээр хөрөнгө оруулагчтай байгуулж буй иргэний эрх зүйн гэрээ гэдгийг ч давхар нотолж байна. Мөн гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан татварын хуулийн

заалтыг гэрээний хугацаанд тогтвортой мөрдөхөөр тохиролцсон гэсэн нь Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтын гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө гэсэн агуулгаас огт өөр ойлголт ба гэрээ байгуулагдаж байх үеийн эрх зүйн зохицуулалт бус гэрээ байгуулагдснаас хойш яригдах нөхцөл байдал юм.

Үндэсний татварын ерөнхий газар нь мэргэжлийн байгууллагынхаа хувьд тооцоо судалгаатайгаар хөрөнгө оруулалтыг дэмжсэнээрээ татварын орлогын бааз суурь нэмэгдсэн эсэх, татварын хууль тогтоомж болон гэрээний хэрэгжилтийн байдлын талаар тодорхой тайлбар гаргаагүйд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” (2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн) гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг тус тус зөрчсөн эсэх тухайд:

1. Төрөөс улсын эдийн засгийг хөгжүүлэх, үр ашгийг нь нэмэгдүүлэх, ингэснээрээ хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засаг, эрх зүйн бодлогыг хууль тогтоомжоороо зохицуулан тогтоож ялангуяа дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихийн тулд хөрөнгө оруулагчдад эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бий болгож, тодорхой хугацаанд оруулсан их хэмжээний хөрөнгийг эрсдлээс хамгаалах боломжийг олгодог байна.

Мэдээлэл гаргагч иргэн Б. ч мэдээлэлдээ “Төрөөс гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, түүнд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг олгох нь зүй ёсны хэрэг” хэмээн хүлээн зөвшөөрсөн байна.

2. Монгол Улсад хөрөнгө оруулж буй стратегийн хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээг харьцангуй урт хугацаагаар байгуулдаг учраас хөрөнгө оруулагчдыг төрийн зүгээс учруулж болох эрсдлээс хамгаалах үүднээс гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан татварын хууль тогтоомжид заасан татварын хувь, хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийг гэрээний хугацаанд тогтвортой мөрдөхөөр тогтоох нь тогтвортой байдлын гэрээний гол үндсэн нөхцөл юм. Энэ нь хөгжиж буй орнуудад ч нийтлэг байдаг жишиг болно.

3. Монгол Улсын Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна” гэсэн нь гэрээний талуудын эрх, ашиг сонирхлыг харилцан тэгш хамгаалсан, хууль буцаан хэрэглэхгүй байх нийтлэг зарчим бөгөөд ялангуяа тогтвортой байдлын гэрээнд удирдлага болгох зарчим гэж үзэж болно.

Монгол Улсын хууль тогтоомжид заасан хөрөнгө оруулалтын хэмжээ, нөхцөл, журмыг хангасан стратегийн хөрөнгө оруулагч тогтвортой байдлын гэрээ байгуулах хүсэлт гаргах, улмаар уг гэрээг байгуулах эрх нь хуулиар нээлттэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4-т “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсний дагуу хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн татварын бодлого хэрэгжүүлсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд уг гэрээний заалт нь түүнийг байгуулснаас хойш батлагдсан татварын хууль тогтоомжийн заалтаас үл хамааран тогтвортой мөрдөгдөнө” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш чуулганы хуралдаанаар 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай”

#### **Тэмдэглэл:**

Зарчмын хувьд Цэцийн дүгнэлт үндэслэлтэй гарсан. Тогтвортой байдлын гэрээ байгуулах үндсэн шалтгаан нь талууд эдийн засгийн хувьд /татварын бодлого/, улс төрийн хувьд /хууль тогтоомж/ тогтвортой байх нөхцөлийг харилцан тохиролцож байгаад оршдог. Гэхдээ стратегийн хөрөнгө оруулагч гэдгийг дотоод, гадаад гэсэн ялгаваргүйгээр авч үзэх нь илүү шударга ёсонд нийцнэ. Харамсалтай нь одоогийн мөрдөж байгаа хуулиар илүүтэй гадаадын хөрөнгө оруулагч талд чиглэсэн байдлаар энэхүү гэрээ хийгдэхээр хуульчилсан байдаг. Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас стратегийн хөрөнгө оруулагчидтай байгуулсан Тогтвортой байдлын зарим гэрээнд үндэсний эрх ашгийг хөсөрдүүлсэн, тэдэнд хэт тааламжтай нөхцөл байдал олгосон байгаа нь нууц биш. Мөн Засгийн газрын итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй ганцхан субъект нь Ерөнхий сайд боловч Засгийн газраас ямар ч зөвшөөрөл, эрх авалгүйгээр кабинетийн сайд нь Засгийн газрыг төлөөлж энэхүү гэрээ байгуулсан факт ч маргааныг шалгах явцад тогтоогдсон. Хуулийг хэрэгжүүлэх шатанд гарч буй алдаа дутагдлыг Цэц хянан шийдвэрлэх эрхгүй бөгөөд харин хөрөнгө оруулагчдыг татах байдлаар улсын эдийн засгийг хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хуульчилсан Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалт Үндсэн хууль зөрчөөгүй гэж Цэц дүгнэсэн.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.05.23 № 06

**Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хууль зөрчсөн эсэх,  
түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх тухай маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн Л., Б., Л., Б.;  
Улсын Их Хурлын дарга Н., Улсын Их Хурлын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч,  
Улсын Их Хурлын гишүүн П., Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга Н.

### **Үндсэн хууль зөрчсөн гэх албан тушаалтны үйлдэл:**

Улсын Их Хурлын дарга Н. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засварыг хийсэн байна

### **Үндсэн хуулийг зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Хорьдугаар зүйл “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”
- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын дарга Н. дараах хуулиудад Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиудаар олгогдсон эрхээ хэтрүүлэн эцсийн найруулгыг хянахдаа түүний агуулга, бодлого, зарчмыг алдагдуулан засвар оруулсан байна. Үүнд:

1/ 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулга, мөн Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуульд засвар хийсэн болох нь эдгээр хуулиудын хувийн хэрэгт авагдсан материалууд, Улсын Их Хурлын гишүүдэд тараасан болон Төрийн мэдээлэл эмхтгэлд албан ёсоор хэвлэсэн эхээс харьцуулан үзэхэд тодорхой болно.

Улсын Их Хурлын дарга дээр дурдсан хуулиудын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд сонсгосны дараа Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр засвар хийсэн, эсвэл найруулгыг Улсын Их Хуралд сонсоогүй, түүнчлэн уг хуулиудыг хугацаа хэтрүүлэн ёсчилсон нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг ноцтой зөрчсөн байна гэж үзэж байна.

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.1, 51.2, 51.4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн. Улсын Их Хурлын дарга энэ дэгийн 51.1.1, 51.1.2 дахь хэсэгт заасны

дагуу эцсийн найруулгыг хянахдаа түүний агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж болно гэж заасан эрх мэдлийг хэтрүүлэн агуулга, зарчмын өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Түүнчлэн уг дэгийн 51.4-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг энэ дэгийн 51.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно” гэсэн заалтыг дээр дурдсан хуулиудыг ёсчлох, батлах, хууль хүчинтэй болгох хүртэлх ажиллагаанд Улсын Их Хурлын дарга Н. өөрийн бүрэн эрхийг хэтрүүлэн ашиглаж Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхэд ноцтой халдсан байна.

Иймд Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хууль зөрчсөн эсэх, хэрэв Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдвол түүнийг албан тушаалаас нь огцруулах үндэслэл байгаа эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.

## 2. Иргэн Л., Б. нарын мэдээллийн агуулга:

1/ Улсын Их Хурлын дарга Н. “Ашигт малтмалын тухай” болон “Авлигын эсрэг” хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа тэдгээрт их хэмжээний засварыг өөрөө хийсэн буюу бусдаар хийлгэсэн, ингэх эрхийг Улсын Их Хурлаас шилжүүлж авч болдог мэтээр хууль зөрчсөн мэдэгдэл хийсээр ирсэн, дэгээ аль болох бага зөрчих үүднээс энэхүү засвараа ядаж Улсын Их Хуралд буцаан танилцуулж Улсын Их Хурлаас зөвшөөрөл авсны дараа ёсчлох дэгийн наад захын шаардлагыг үл хайхран шууд ёсчлон албан ёсоор нийтлүүлсэн зэрэг нь Үндсэн хуулиар, хуулиар болон Улсын Их Хурлын бусад шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээг санаатайгаар урвуулан ашигласан үйл ажиллагаа байсан юм.

2/ Үндсэн хуулиар тогтоосон ардчиллын үндсэн зарчимд бүдүүлгээр халддаг болсон Улсын Их Хурлын даргын энэхүү үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор энэхүү өргөдлийг бичигч нар болон бусад нэр бүхий иргэдийн мэдээлэл, гомдлын дагуу Цэцийн 2007 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 24 дүгээр магадлалаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн. Гэтэл үүний дараа 2007 оны 2 дугаар сарын 7-нд энэ хоёр хуулийн албан ёсоор нийтлэгдсэн бичвэрийг Улсын Их Хуралд танилцуулсан нь нэг талаасаа, “нэг бүдэрвэл долоо бүдэрнэ” гэгчээр хөгтэй явдал болсон боловч, нөгөө талаасаа хууль зөрчигдсөний яах аргагүй баримт болсон юм.

3/ Өмнө дурдсан магадлалын дагуу Цэцийн их суудлын хуралдааны 2007 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 3 дугаар дүгнэлт гарсан. Уг дүгнэлтээр Улсын Их Хурлын дарга Н.-ийн оройлон манлайлсан маргаанд холбогдох үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорьдугаар зүйлийн “Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэсэн заалтыг зөрчсөн болохыг тогтоосон.

4/ Цэцийн энэхүү дүгнэлтээр Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1-ийн “Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэж дүгнэжээ. Энэ нь, нэг талаасаа Улсын Их Хурлын дарга Н.-ийн эрх хэмжээгээ хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд холбогдож байгаа тул түүний иргэн болохын хувьд биш, албан тушаалтан гэдэгтэй нь, нөгөө талаас Улсын Их Хурлын дарга бол байгууллага биш гэж үзсэнтэй холбоотой дүгнэлт бололтой.

Харин Улсын Их Хурлын зарим гишүүн, жишээлбэл Сангийн сайд Б.гийн олсон шиг “Н. даргыг Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн гэх мөртлөө, түүний үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн” гэсэн утгатай дүгнэлтийг Цэц гаргаагүй.

5/ Цэцийн 3 дугаар дүгнэлтийн үндэслэл дотор “2. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргах асуудлыг Үндсэн хуулийн цэц эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хэлэлцэх тул өргөдөл гаргагч иргэдийн энэ талаар тавьсан хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байна”, мөн дүгнэлт гаргах хэсэг дотор “3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай” гэсэн нь Улсын Их Хурал болон Цэц Үндсэн хуулиар оноогдсон бүрэн эрхээ харилцан итгэлцлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлэхэд, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг хэрхэн биелүүлэхэд чиглэсэн маш чухал тайлбар байжээ.

Өргөдөл гаргагч иргэдийн зарим нь 3 дугаар дүгнэлтийг гарсан даруйд Цэц Үндсэн хуулиар иргэнд олгогдсон нэгэн төрлийн эрхийг хурааж авах оролдлого хийлээ гэж шүүмжилж байсан боловч Улсын Их Хурал дээр хийсэн Цэцийн тайлбар болон хариултуудаас ийм оролдлого хийгээгүй, харин ч Цэц маш зохистой шийдвэр гаргажээ гэсэн хувийн дүгнэлтэд хүрлээ. Учир нь, Үндсэн хууль зөрчсөн даргынхаа үйл ажиллагааг залруулах бололцоог юун түрүүн, даргаа сонгосон Улсын Их Хуралд олгосон байна. Хуулийн дагуу Улсын Их Хурал дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргах ёстой байлаа:

а/ Н. даргыг огцруулах эсэх асуудлыг шууд хэлэлцэх,

б/ Н. даргыг огцруулах үндэслэл байгаа эсэхийг тогтоолгохоор цэцэд хүсэлт гаргах,

в/ Н. даргаас ам өчгийг нь авах замаар цаашид Үндсэн хууль зөрчсөн ийм үйл ажиллагааг давтахгүй байх баталгааг бий болгох.

б/ Улсын Их Хурал энэ чиглэлд ганц ч алхам хийсэнгүй. Үндсэн хууль зөрчсөн даргынхаа үйл ажиллагааг залруулах буюу хариуцлага тооцохын оронд Цэцийн эсрэг улс төрийн ил болон далд дайралт хийхэд үйл ажиллагаагаа чиглүүллээ. Цэцийн 3 дугаар дүгнэлтээр Улсын Их Хурлын даргын тодорхой үйл ажиллагааг Үндсэн хууль зөрчөөд байна гэдгийг тогтоосон болохоос энэ зөрчил нь Улсын Их Хурлын ямар нэгэн шийдвэрээс болсон гэж дүгнээгүй юм. Гэтэл Улсын Их Хурлын олонхи асуудлын гол нь даргад биш, хууль болон шийдвэрүүдэд байгаа мэтээр, даргынхаа бурууг бусад руу чихэх арчаагүй аргаар хандав. Үндсэн хууль зөрчсөн энэ хууль бус хамгаалалтад эрдсэн Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн алдаагаа засах байтугай түүнийгээ улам лавшруулна гэж Улсын Их Хурлын индэр дээрээс, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ил тод мэдэгдэн сагсуурч танхайран, хажуугаар нь рекэтлэх маяг эсгэж, бас элдэв цуурхал тараах боллоо. Ийнхүү Улсын Их Хурал Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн байгууллагын шийдвэр, нийт байгууллагын үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчиж байна.

7/ Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа энэ тохиолдолд “Үндсэн хууль зөрчсөн нь нэгэнт тогтоогдвол Улсын Их Хурлын дарга Н.-ийн үйл ажиллагаа нь түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэхийг тогтоолгохоор Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах эрх” Үндсэн хуулиар иргэнд олгогдсон гэж үзэж байна. Үүнийг давхар нотлох Цэцийн дүгнэлт болон тогтоол хүчин төгөлдөр үйлчилж байгаа билээ. Цэцийн 3 дугаар дүгнэлтээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн болох нь нэгэнт тогтоогдсон Улсын Их Хурлын дарга Н.-ийн үйл ажиллагаа болон Цэцийн их суудлын хуралдааны энэхүү шийдвэрийг эсэргүүцсээр байгаа нь түүнийг Улсын Их Хурлын даргаас огцруулах үндэслэл болох эсэхийг тогтоож өгнө үү.

3. Улсын Их Хурлын дарга Н.-ийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр олгосон зөвшөөрөл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.2-т заасныг үндэслэн Нэмэгдсэн

өртгийн албан татварын хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй дараах засвар хийсэн болно. Энэ талаар нэр бүхий иргэдээс Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасантай холбогдуулан дор дурдсан нэмэлт тайлбар өгч байна. Үүнд:

а/ Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд хийсэн бүтцийн шинжтэй засвар:

Төслийн 1 дүгээр зүйлийг 2 зүйл болгон салгаж “иргэн хуулийн этгээдийн импортлолсон болон экспортлолсон бараа, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэн борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд” гэсэн хэсгийг 3 дугаар зүйл болгон томъёолсон. “Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх, тайлагнах” гэсэн 16 дугаар зүйлийг “Импортын бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах” гэсэн 17 дугаар зүйлтэй нэгтгэж 16 дугаар зүйлийг “Бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, төсөвт төлөх, тайлагнах” гэж гарчигласан. Энэ шалтгаанаар 18 зүйлтэйгээр батлагдсан хуулийн ерөнхий дугаар хэвээр хадгалагдсан боловч зүйлийн дэс дугаар болон зүйлийн доторхи ишлэл татсан дугаарууд өөрчлөгдсөн.

Найруулга, үг хэллэг, дэс дарааллын шинжтэй засвар

- 4.1.10-ын “нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа үйлдвэрлэж, ажил гүйцэтгэн, үйлчилгээ үзүүлэн” гэснийг “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлж” гэж найруулсан. Учир нь 3 дугаар зүйлд энэ бүх үг байгаа.
- 5.2-ын эхний 2 мөрний “бараа борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлснээс олсон” гэснийг “борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний” гэж найруулсан.
- 6.1-ийн “заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч болсон” гэснийг “заасан нөхцөл хангасан” гэж найруулсан /энэ нь 10 сая ба түүнээс дээш төгрөгийн орлого олсон гэдэг нөхцөл/
- 6.2-ын “хуульд заасан бараа борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн” гэснийг “хуулийн 4.1.10-т заасан” гэж найруулсан.
- 6.3-ын “нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн” гэснийг “энэ хуулийн 6.2-т заасан” гэж найруулсан.
- 6.5-ын “6.4.1, 6.4.2” гэснийг “6.4” гэж найруулан “орлогын албан татварын тайлан” гэдэг үгийн байрыг сольсон.
- 6.9, 6.10-ын “нэг бүлэгт хамаарах хуулийн” гэснийг “Энэ хуулийн 6.7-д заасан” гэж найруулсан.
- 7.1.1-д “бүх төрлийн” гэсэн үг оруулсан, энэхүү “бүх төрлийн” гэдэг үг нь 4.1.2, 7.1.3-т байгаа болно.
- 7.1.2-ын “гадна” гэдэг үгийг “гадаад улсад” гэж найруулан “бүх төрлийн” гэдэг үгийг энэ тайлбарт заасны дагуу болон 7.1.3-т заасан учраас оруулсан.
- 7.1.4 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул салгаж 7.1.4, 7.2 гэсэн 2 заалт болгосон, үүнээс шалтгаалан зүйлийн доторх дугаарууд өөрчлөгдсөн.
- 7.3.4-ийн “бусад этгээдэд өрийн төлбөрийг бараагаар гүйцэтгэх” гэснийг “өр төлбөрийг бараа шилжүүлэх замаар хаах” гэж найруулсан.
- 7.4.8-ын “бусад этгээдэд өр төлбөрийг ажил, үйлчилгээгээр гүйцэтгэх” гэснийг “өр төлбөрийг ажил, үйлчилгээ үзүүлэх замаар хаах” гэж найруулсан.
- 7.5.1 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсныг салгаж 7.5.1, 7.6 дахь хэсгийн заалт болгосон.
- 8 дугаар зүйлийн 8.1-д “дор дурдсан журмаар ногдуулна” гэсэн үг нэмж бусад хэсгүүдэд дахин дахин давтагдсан “нэмэгдсэн өртгийн албан татварт ногдуулна” гэснийг хураангуйлсан, түүнчлэн 5.1-д байгаад орхигдсон “экспортлолсон” гэдгийг нэмсэн.
- 8.2-ыг 2 салгаж 8.2, 8.3 болгон найруулсан.
- 9 дүгээр зүйлийн заалт болгонд “тодорхойлно” гэж давтагдсан тул ийм давталт

гаргахгүйн тулд “9.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг дор дурдсан журмаар тодорхойлно” гэсэн найруулга хийж бусад хэсэгт байсан “тодорхойлно” гэснийг хассан, түүнчлэн 9.5, 9.6-г 9.1.4, 9.1.5 болгон дэс дарааллын засвар хийсэн.

- 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4, 10.5-д “нэмэгдсэн өртгийн” гэж тодотгосон, учир нь 10.1-д ийм томъёоллоор орсон. Ер нь “нэмэгдсэн өртгийн албан татвар, албан татвар, татвар” гэсэн 3 өөр үг хэрэглэсэн байсан тул нэр томъёог жигдэлсэн. 12 дугаар зүйлийн 12.1-д мөн ингэсэн.

- 12 дугаар зүйлийн 12.1.1.а, 12.1.1.б, 12.1.2.в-г тус тус нэгтгэж 12.1.1, 12.1.2 болгож найруулсан, түүнчлэн 12.1.3-ын “Монгол Улсын гадна” гэдгийг “гадаад улсад” гэж найруулсан.

- 12.1.4 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул “Монгол Улсын нутаг дэвсгэрт байсан хөдлөх буюу үл хөдлөх хөрөнгөтэй шууд холбоотойгоор үзүүлсэн үйлчилгээнд мөн хуулийн 12.1.4 дэх заалт хамаарахгүй” гэсэн 12.1.4.а заалтыг 12.2 болгон 12.1.6-ын дараа шилжүүлсэн, мөн 12.1.6-ын “нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ “О” хувьтай тэнцүү байна” гэсэн нь 12.1-тэй давхардсан тул хасч найруулсан.

- 12.4.1, 12.4.2-ын “төлөөлөх” гэснийг “төлөөний” гэж найруулан 12.4.2-т “буюу байрладаг” гэж нэмсэн, учир нь 12.4-т “иргэн хуулийн этгээд” гэж байгаа бөгөөд “хуулийн этгээд” нь оршин суудаггүй харин байрладаг.

- 13.1.2-ын “төлөөлөгчийн” гэсний дараа “болон консулын газар” гэж нэмсэн, учир нь 13.1.3-т ийм нэр томъёо байсан тул жигдэлсэн. Түүнчлэн “олон улсын байгууллага” гэснийг “НҮБ, түүний төрөлжсөн салбарын” гэж найруулсан.

- “Арван мянган төгрөгөөс доош үнэтэй бараа, ажил, үйлчилгээг нэг удаа худалдан авахад энэ хуулийн 13.1.3 дахь заалт хамаарахгүй” гэсэн 13.1.3.а-г 13.3 болгон 13.2-ын дараа байршуулсан.

- 13.1.6 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул салгаж “энэ заалтад дээрх зориулалтын бус автомашинд хамаарахгүй” гэсэн хэсгийг 13.4 болгон “тусгай зориулалтын бус автомашин худалдаж авахад энэ хуулийн 13.1.6 дахь заалт хамаарахгүй” гэж найруулсан.

- 13.1.8 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул “худалдан борлуулах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байр буюу түүний хэсэгт 12.1.8 дахь заалт хамаарахгүй” гэсэн 13.1.8. а-г 13.5 болгон доош шилжүүлсэн. /Ер нь үсгийн дугааргүй болгох, түүнчлэн нэг заалтад 2 өгүүлбэр оруулахгүй байх зориулалтаар ийм техникийн засвар хийсэн/

- 13.6.6-д “мөнгөн хөрөнгийг байршуулсны” гэж тодотгол хийсэн. Учир нь “Сангийн хүүг олгох үйлчилгээ” гэж угаасаа байхгүй.

- 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул “эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагаанд 12.2.4 дэх заалт хамаарахгүй” гэсэн 13.2.4.а-г салгаж 13.8 болгож томъёолсон.

- 13.6.14 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул нэг өгүүлбэр болгон томъёолж уг заалтын сүүлчийн “Энэ заалтад жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй” гэсэн өгүүлбэрийг 13.9 болгон салгаж томъёолсон.

- 13.11-ийн хашилтанд байсан өгүүлбэрийг үндсэн өгүүлбэртэй нь нэгтгэн томъёолсон.

- 14.1.4 дэх заалт 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул сүүлчийн “харин хөдөө аж ахуйн анхдагч түүхий эдийг импортлох болон худалдан авч зуучлан борлуулахад энэ заалт хамаарахгүй” гэсэн хэсгийг 14.2 болгон салгаж томъёолсон.

- 14.4.1 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул /суудлын автомашин/ 14.3.1.а-г нь 14.5 болгон салгаж томъёолсон.

- 15 дугаар зүйлийн заалтуудын байршлыг дотор нь сольж цэгцэлсэн бөгөөд 15.3 /нэг бүлэгт хамаарах этгээд/-ыг 15.4, 15.4 /үйлдвэрлэгч-экспортлогч/-ийг 15.5 болгон байршуулсан.

- 16.1-ийг 2 салгаж “тухайн сард борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар” гэснийг 16.1.1 болгон салгаж томъёолсон.

- “импортын бараанд НӨАТ ногдуулах, төлүүлэх ажлыг гаалийн байгууллага хариуцна” гэж 16.2.1-д, “тайлангийн маягтыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга батална” гэж 16.3-т тус тус заасан учраас 16.2.3-т “Улсын Гаалийн ерөнхий газар” гэж тодотгосон болно.

б/ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд хийсэн бүтцийн шинжтэй засвар

- 4.1.8-ыг 6 дугаар зүйл болгон “Харилцан хамаарал бүхий этгээд” гэж гарчигласан /доторх заалтад агуулгын өөрчлөлт ороогүй/

- “Албан татвараас хөнгөлөх” гэсэн 19 дүгээр зүйлийг “Хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт” гэж 20 дугаар зүйлтэй нэгтгэсэн.

Бүтцийн шинжтэй дээрх өөрчлөлтөөс шалтгаалан батлагдсан хуулийн ерөнхий дугаар өөрчлөгдөөгүй, өөрөөр хэлбэл 22 зүйлээс бүрдсэн ерөнхий бүтэц нь хэвээр байгаа боловч зүйлийн дэс дугаар болон зүйлийн доторхи ишлэл татсан дугаарууд өөрчлөгдсөн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд хийсэн найруулга, үг хэллэг, дэс дарааллын шинжтэй засвар

- 3 дугаар зүйлийг дугаараар ангилж “төлөөлөх байрт” гэснийг “төлөөний газарт” гэж найруулсан.

- 4 дүгээр зүйлийн 4.1.1-ийн “Монгол Улсаас бусад” гэснийг “гадаад” гэж үг хэллэгийг зассан.

- 4.1.5-ын “татварын хууль тогтоомжийн дагуу” гэснийг “орлогын” гэж үг хэллэгийг зассан.

- 4.1.5-д “тэдгээртэй адилтгах хуулийн этгээдийг” гэж байсан тул 4.1.6-гийн “аж ахуйн нэгжийг” гэснийг “этгээдийг” гэж үг хэллэгийг зассан.

- 5 дугаар зүйлийн “оршин суугч, оршин суугч бус” гэснийг “байнга байрладаг, байнга байрладаггүй” гэж үг хэллэгийн засвар хийж Иргэний болон бусад хууль тогтоомжийн үг хэллэгтэй нийцүүлсэн, учир нь “хуулийн этгээд байрладаг”, “иргэн оршин суудаг” гэсэн ойлголт хуульд байдаг.

- 5.5-ыг 5.6-тай нэгтгэж “төлөөлөх газар” гэснийг “төлөөний газар” гэж үг хэллэгийн засвар хийсэн.

- 8.1.4 хоёр өгүүлбэрээс бүрдэж байсан тул салгаж 8.1.4, 8.1.5 болгосон.

- 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.2.5, 9.2. 6-гийн “ашиглах” гэснийг “ашигласны төлбөр” гэж үг хэллэгийн засвар хийсэн, түүнчлэн “эдэлсний төлбөр”, “ашигласны төлбөр” гэсэн 2 өөр үг байсан тул 9.2-оос “эрхүүдийг хууль тогтоомжийн дагуу эдэлсний төлөө төлж байгаа” гэснийг хассан.

- 11.1-д үг хэллэгийн засвар хийж 6 дугаар зүйлийг иш татсан, учир нь нэг үг, өгүүлбэрийг хэтэрхий олон давтсан тул зайлсхийх зорилгоор ингэсэн, түүнчлэн 11.2-т 7.5, 11.1-ийг иш татсан.

- 12.1.13, 12.1.16, 12.1.19, 12.1.25, 12.1.26 дахь заалтууд 2 өгүүлбэрээс бүрдсэн байсан тул салгаж 12.1.13-ын сүүлчийн өгүүлбэрийг 12.3, 12.1.16-ын сүүлчийн өгүүлбэрийг 12.4, 12.1.19-ийн сүүлчийн өгүүлбэрийг 12.5, 12.1.25-ын сүүлчийн өгүүлбэрийг 12.6, 12.1.26-гийн сүүлчийн өгүүлбэрийг 12.7 болгон тус тус томъёолсон.

- 12.8.1, 12.8.2-ын “албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд хамаарахгүй” гэсэн өгүүлбэр давхардсан тул “12.8. Дор дурдсан зардал албан татвар ногдох орлогоос үл хасагдана” гэсэн толгойн өгүүлбэр хийж дээрх 2 заалтын дээр дурдсан төгсгөлийн үгийг хассан.

- 13.2-ыг хүснэгтэд оруулсан.

- 12 дугаар зүйл нь “Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал” гэсэн гарчигтай бөгөөд үг зүйлийн 12.1.7-д зээлийн хүүг оруулсан /хасагдах зардалд/ тул 14 дүгээр зүйлийн гарчгийг 3 дугаар бүлэг болон 12 дугаар зүйлийн гарчигт нийцүүлэн “Албан татвар ногдох орлогоос хасч тооцох зардалд хамрах зээлийн хүү” гэж найруулсан. /Уг нь “Хүүгийн зардал” гэсэн гарчигтай байсан/

- 16.6-ын “төлбөрт таавар, бооцоот тоглоом, хонжворт сугалааны орлого”, 16.8-ын “хувьцаа, үнэт цаас” гэсэн үг тус бүр 2 дахин давтагдсан тул хасч найруулсан.
- 17.1-ийн татвар ногдуулах орлогын хэмжээг үгээр илэрхийлж найруулсан.
- 18.2-ын эхний 3 мөрийг “Энэ хуулийн 18.1.2-т заасан” гэж найруулан давталтыг арилгасан.
- 19.1-д нэрлэж заасан бүтээгдэхүүнийг дэс дараалалд оруулж дугаарласан.
- 19.2 нь 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул “тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар батална” гэснийг 19.7 болгон тусад нь томъёолсон.
- 20.2-ын “албан татвар төлөгчийн татварын тайлангаар гарсан” гэснийг “Энэ хуулийн 20.1-д заасан” гэж, 20.3-ын “албан татвар төлөгчийн татварын тайлангаар гарсан” гэснийг “энэ хуулийн 20.2-т заасны дагуу” гэж найруулан давталтаас зайлсхийсэн.
- 21.4-ийн “татварын жилд төлөх албан татвараа татварын албанаас” гэснийг “энэ хуулийн 21.3-т зааснаар” гэж найруулсан.
- 21.5 дахь заалт 2 өгүүлбэрээс бүрдэж байсан тул салгаж сүүлчийн өгүүлбэрийг “суутгагч нь энэ хуулийн 21.5, 21.6-д зааснаар суутгасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор улирал бүр өссөн дүнгээр, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж харьяалах татварын албанд тушаана” гэж 21.7 болгон шилжүүлсэн болно.

#### 4. Иргэн Л., Б. нарын нэмэлт тайлбарын агуулга:

1/ Ашигт малтмалын тухай хууль болон Авлигын эсрэг хуульд засвар хийн тэдгээрийг ёсчлохтой холбогдсон Улсын Их Хурлын дарга Н.-ийн үйл ажиллагаа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн гэдгийг Цэц 2007 оны 3 дугаар дүгнэлтээрээ тогтоосон. Энэхүү зөрчлийн гол цөм нь хийгдсэн засварыг Улсын Их Хуралд буцаан танилцуулж, Улсын Их Хурлаас зөвшөөрөл авахгүйгээр шууд ёсчилсонд байгаа юм. Бүрэн бус тооцоогоор, Ашигт малтмалын тухай хуулийн 130 заалтад, Авлигын эсрэг хуулийн 70 заалтад ямар нэгэн засвар хийгдсэн бөгөөд ийнхүү засварлагдсан зүйлс нь Улсын Их Хуралд танилцуулагдажгүй ёсчлогдсоноор үл барам “Төрийн мэдээлэл эмхтгэл”-д нийтлэгдсэн нь дур зоргоор авирласан үйл ажиллагаа байсныг Дэгийн 51.1-51.4 дэх хэсгийн заалтууд нотолж байна. Үндсэн хууль зөрчсөн энэ үйл ажиллагаанд Улсын Их Хурлын дарга Н. идэвхийлэн оролцож, түүнийг оройлон манлайлж байсныг нэгдсэн болон байнгын хороодын хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглүүд, Н. даргын зохион байгуулсан хэвлэлийн бага хурлуудын материалууд, тэдгээрийн дүрс бичлэгүүд давхар давхар нотолж байна.

2/ Хууль тогтоох болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарна гэж Үндсэн хуулиар тогтоосон. Гэтэл Улсын Их Хурлын дарга Н. мөн чанартаа энэхүү бүрэн эрхийг өөртөө эсвэл тодорхой хэсэг хүнд шилжүүлж болдог мэтээр, тэр ч байтугай Улсын Их Хурал энэхүү эрхээ өөрт нь шилжүүлсэн мэтээр ярьж байна. Энэхүү бүрэн эрхийг алх тогших төдийхнөөр байтугай, Улсын Их Хурал дээрх хамгийн хариуцлагатай санал хураалтаар ч шилжүүлэх хууль зүйн үндэслэл байхгүй. Ингэхийг Үндсэн хууль зөвшөөрөхгүй гэдгээ “онцгой” гэдэг тодотгоолоор илэрхийлсэн. Гэтэл Н. дарга түүнийг “шилжүүлж авсан” буюу өөрийн нь хэлдгээр “Улсын Их Хурлаас даргад эрх олгосон” гэж мэлзэн өөрийн үйл ажиллагааг зөвтгөхийг оролдож байна.

3/ Улсын Их Хурлын дарга Н. өөрийн үйл ажиллагааг зөвтгөхийн тулд Дэгийн 51.2 хэсгийн заалтыг мушгин гуйвуулж байгаа юм. Тэнд “...эцсийн найруулгыг хянахдаа /батлагдсан шийдвэрийн/ агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрлага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж болно” гэжээ. Эрхэм дарга “би агуулга, бодлого, зарчмыг алдагдуулсан ямар засвар хийсэн юм бэ”, “би шударга ёсыг яаж зөрчсөн юм бэ?” хэмээн эсэргүүцлээ илэрхийлсээр байгаа. Асуудлын гол нь ямар засвар хийсэнд биш, харин хийсэн засвараа Улсын Их Хуралд танилцуулж ёсчлох зөвшөөрөл авах тухай Дэгийн 51.1.3 заалтыг зөрчсөнд байгаа юм.

Дэгийн энэхүү заалт нь ард түмний элч нараас бүрдсэн Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхийг хамгаалахад чиглэсэн процессын зохицуулалт юм. Эрхэм даргын нийтэд зарлан мэдэгдэж байгаагаар, Улсын Их Хурлын энэ бүрэлдэхүүний хуулийн мэдлэг тааруу, өөрөө ерэн оноос хойш хууль гэдэг юмтай махран ноцолдож байгаа цөөхөн хуульчдын нэг, энэ мэт нөхцөл байдлаас болоод ийм эрхийг шилжүүлж авсан бөгөөд тэрээр Монголын парламентын анхны хуульч дарга, цаашид ийм даргатай байж ард түмэн хуультайгаа нөхөрлөж чадах эсэх талаар санаа зовдог аж. Парламентыг “бага ард түмэн” гэж ёжилдог нь ортой зүйл бөгөөд түүний гишүүдийн хуулийн мэдлэгийн дундаж түвшин өндөр биш байж болно. Улсын Их Хурлын Тамгын газар ямар үүрэгтэй билээ?, Улсын Их Хурал болон түүний гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх. Улсын Их Хурлын дарга ямар үүрэгтэй билээ?, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх ажлыг зохион байгуулах, гишүүдэд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлэх, Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах. Улсын Их Хурлын тухай хуульд ийм агуулгаар хуульчлан заажээ. Энд Улсын Их Хурал болон түүний гишүүдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслана, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулна гэснээс биш, энэхүү бүрэн эрхийг нь бусдад шилжүүлэн “хялбарчил” гэж заагаагүй байна. Энэхүү хялбарчилсан явдлыг нэгдүгээрт шударга ёсонд, хоёрдугаарт ардчилсан ёсонд, гуравдугаарт хуулиар удирдуулах зарчимд нийцэж байна уу? Мэдээж нийцэхгүй байна.

4/ Монголд Үндсэн хуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхийг Үндсэн хуулиар Цэцэд олгосон. Үндсэн хууль зөрчигдсөнийг Цэц тогтоосон бол холбогдох зөрчлийг залруулж Үндсэн хуульд нийцүүлэх үүргийг Үндсэн хуулиар Улсын Их Хуралд оногдуулсан. Энэхүү зөрчлийг шийдвэрийн, албан тушаалтны үйл ажиллагааны гэсэн хоёр хэсэгт болгоомжтойгоор хувааж болдог. Үндсэн хууль зөрчсөн шийдвэрийг Цэцийн дунд суудлын хуралдаанаар түдгэлзүүлэх бөгөөд хэрэв Улсын Их Хурал зөвшөөрөөгүй бол Цэцийн их суудлын хуралдаанаар хүчингүй болгодог. Хэрэв дунд суудлаар алдаатай дүгнэлт гарсан бол түүнийгээ их суудлынхаа хуралдаанаар залруулах боломж ч Цэцэд байдаг. Албан тушаалтны Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагааг Цэц шууд их суудлаараа тогтоон дүгнэлт гаргадаг тул түүнтэй төрийн байгууллага, албан тушаалтан маргах хууль зүйн үндэслэл байдаггүй учраас Улсын Их Хурал тухайн албан тушаалтанд огцруулах буюу эгүүлэн татах хүртэл хариуцлага тооцоход чиглэсэн бодитой арга хэмжээ авах хуультай. Цэцийн 3 дугаар дүгнэлтээр Улсын Их Хурлын дарга Н.-ийн үйл ажиллагааг Үндсэн хууль зөрчсөнийг тогтоосон байтал Улсын Их Хурал, мөн чанартаа энэ талаар авч хэлэлцсэнгүй. Ингэснээрээ Улсын Их Хурал Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1-ийн “Үндсэн хуульд аливаа байгууллагын үйл ажиллагаа нийцсэн байвал зохино”, мөн зүйлийн 2-ын “Үндсэн хуулийг мэдэгтүн, сахигтун” гэсэн заалтуудыг зөрчлөө.

5/ Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөл болон цөөнхийн зарим гишүүн огцруулах эсэх асуудлыг хэлэлцүүлэх санал оруулсан бол МАХН-ын бүлгийн гишүүд энэ саналын эсрэг зөрчлийг арилгуулах асуудлыг хэлэлцүүлэх альтернатив саналыг дэмжсэн байна. Мөн “Зөрчлийг арилгуулах” гэдгийн дор Хувьсгалт намын бүлгийн гишүүд хуулийн дагуу байвал зохихоос ихээхэн өөр зүйлийг, Улсын Их Хурлын даргад ямар нэгэн зэм хүлээлгэхгүй байх тийм зүйлийг шургуулахаар санаархаж байсан нь тэдний Байнгын хорооны болон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр хэлсэн үгнээс тодорхой байсан гээд зарим гишүүдийн хэлсэн үгнээс жишээ татжээ.

6/ Энэхүү “зөрчлийг арилгуулах” гэдэг оньсогыг тайлах ажлын хэсгийг Н. дарга хаврын чуулганы нээлт дээр санал болгосны дагуу дэд дарга Л.-ийн захирамжаар байгуулан, тодорхой санал оруулж ирэхийг Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороодод даалгажээ. Ер нь Цэцийн 3 дугаар дүгнэлттэй холбогдсон аливаа асуудлыг байнгын хороод болон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд Н. даргын оролцоо хэтэрхий их байсан нь яах аргагүй сонирхлын зөрчлийг дэврээж, асуудлыг хуулийн дагуу шийдэхэд саад учруулжээ.



7/ "Зөрчлийг арилгуулах" саналыг Улсын Их Хуралд оруулах үүрэг авсан Хууль зүйн байнгын хороо өмнө дурдсан ажлын хэсгийн саналыг хэлэлцсэн байна. Ажлын хэсэг Авилгалын эсрэг хуульд оруулсан 5 засварыг агуулгын, бодлогын буюу зарчмын хэмээн үзэж анхны батлагдсан байдлаар нь буцаан засах санал боловсруулсан байна. Гэтэл тус байнгын хороон дээр маргаан дэгдэж, даргынхаа эсрэг өөрсдөө баримт бүрдүүлж өгөх гэж байна, энэ чинь Улсын Их Хурал дээр гарсан шийдвэртэй зөрчилдөж байна, Цэцийн 3 дугаар дүгнэлт хууль буюу Улсын Их Хурлын ямар нэгэн шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг хөндөөгүй байхад ингэж болохгүй, шинээр хууль санаачилдаг ердийн журмаар явах ёстой, Улсын Их Хуралд оруулах санал байхгүй болсон гэх зэргээр маргалдсаар "зөрчлийг арилгуулах" оньсого тайлагдалгүй хоцров. Энэ нь ч Улсын Их Хурал дахь олонхийн хүсч байсан үр дүн, Цэцийн дүгнэлтийг далдуур эсэргүүцсэн нэг хэлбэр мөн бололтой. Ийнхүү "зөрчлийг арилгуулах" Улсын Их Хурлын шийдвэр дампуурах тийшээ хандлаа.

5. Улсын Их Хурлын дарга Н.- ийн хариу тайлбарын агуулга:

Нэг. Тайлбарын 1-д "Зөрчлийн гол цөм нь засварыг Улсын Их Хуралд буцааж танилцуулж, Улсын Их Хурлаас зөвшөөрөл авахгүйгээр шууд ёсчилсонд байгаа юм" гэжээ. Үүнийг дараах үндэслэлээр няцааж байна.

1/ 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, Ашигт малтмалын тухай, Авилгын тухай, Хүн амын орлогын албан татварын тухай зэрэг тухайн чуулганаар батлагдсан эдийн засгийн харилцааг зохицуулах гол хуулиудын найруулгыг танилцуулах үеэр гишүүдээс найруулга, үг хэллэг, дэс дарааллын шинжтэй санал гаргаагүй. Ийнхүү эцсийн найруулга танилцуулах үеэр миний бие "редакцыг сонссон гэж үзье. Эцсийн найруулгын явцад Байнгын хорооны даргатай ярилцана, ажлын хэсэгт орсон П. гишүүнтэй ярилцана, Тамгын газрынхантай ярилцана, бүр болохооргүй юмнууд байвал 10 дугаар сарын чуулганд танилцуулж байж ёсчлох шаардлага байж магадгүй шүү. Гайгүй бол цаашаа явуулна /"ёсчилно" гэсэн үг/ Ямар тохиолдолд би танилцуулах вэ? гэвэл Татварын ерөнхий хуульд гарсан зөрчил маягийн юм гарч ирвэл би хүлээж байгаад намар танилцуулна. Засварууд хийгдэнэ шүү. Хуульд редакц хийх хугацаа байхгүй учраас би иймэрхүү эрх Улсын Их Хурлаас аваад байгаа юм. Тэгэхдээ агуулгыг нь огт өөрчлөхгүй гэсэн нөхцөлтэйгээр найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй засвар хийж ёсчлох зөвшөөрөл авсан бөгөөд үүнийг чуулганы хуралдаанд оролцсон 57 гишүүн хүлээн зөвшөөрсөн.

Батлагдсан, маргаж буй хоёр хуульд хууль хоорондын болон хуулийн дотоод зөрчил байгаагүй тул Улсын Их Хурлаас өгсөн дээрх зөвшөөрөл, нөхцөлийнх нь дагуу ёсчилсон. Өөрөөр хэлбэл, хуулийн болон хууль хоорондын зөрчилгүй бол найруулгын засвар хийж редакцыг дахин танилцуулахгүйгээр ёсчлох зөвшөөрлийг Улсын Их Хурал надад олгосон нь тэмдэглэлийн дээрх үг үсгээр бүрнээ нотлогдож байна. Улсын Их Хурал ийм шийдвэр гаргаж би тэр дагуу нь ажилласан. Хэрэв үүнийг буруу гэж байгаа бол надтай биш Улсын Их Хуралтай холбож ярих асуудал гэж үзэж байна. Улсын Их Хурал засварыг болон редакцийг дахин танилцуулах шаардлагагүй гэж шийдвэрлэсэн байхад иргэн Л. нар "заавал танилцуулах ёстой" гэж дүгнээд төрийн эрх барих дээд байгууллагад "даалгавар" өгөөд байх эрхгүй гэдгийг тэмдэглэж байна. Иргэн Л. нар энэхүү үйлдлээрээ Үндсэн хуулийг хамгаалах биш, харин ард түмний сонгуулийн эрх, түүний сонгосон төлөөллийн байгууллага, гишүүдийнх нь эрхэд халдаж байна.

2/ 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлд дурдсан Татварын ерөнхий хуулийн тухайд 2 дахь хэлэлцүүлгээр /санал хураалтаар/ баталсны дараа эцсийн найруулгыг хянах үед хууль хоорондын зөрчил гарсан нь илэрсэн тул миний бие нөхцөл байдлыг дахин нэгдсэн хуралдаанд танилцуулан санал хураалт явуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан юм. Тухайлбал, Татварын албаны бүтцэд хэрэг бүртгэх алба байгуулах заалт нь Эрүүгийн байцаан шийтгэх

хуультай зөрчилдсөн байсныг залруулсан. Яг ийм нөхцөл байдал Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дээр гарвал намрын чуулганд танилцуулна, тийм зөрчил гарахгүй бол ёсчилно гэж Улсын Их Хурал дээр ойлголцсон бөгөөд дээрхтэй адил зөрчил байгаагүй тул холбогдох засварыг дэг, олгогдсон зөвшөөрлийн хүрээнд хийж ёсчилсон.

3/ Миний бие дээрх хуулиудад найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй холбогдох засвар хийхдээ татварын хуулиудын ажлын хэсэг ахалж ажилласан Улсын Их Хурлын гишүүн Л., түүнчлэн Тамгын газрын Нэгдүгээр нарийн бичгийн дарга Н., М., Д., Татварын ерөнхий газрын дарга З., хэлтсийн дарга Г., Сангийн яамны газрын дарга Г. зэрэг уг хуулиудыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаанд биечлэн оролцсон хүмүүстэй 2 удаа өрөөндөө уулзаж, хуулийн заалтад орсон ойлгомжгүй, эргэлзээтэй үг, өгүүлбэр, цэг, таслал бүрийн хуульд суусан жинхэнэ утга, агуулгын талаар асууж тодруулан хоорондоо ярилцаж ойлголцон засвар хийж, ийнхүү эцэслэн гарсан төслийг тэдгээрт өгч танилцуулан агуулга, бодлого, зарчим алдагдаагүй гэдгийг нь өөрсдөөс нь эцэслэн сонсож байж ёсчилсон болно. Өөрөөр хэлбэл төр, олон нийт, мэргэжлийн хүмүүс, хууль санаачлагчид, батлагчдаас нуугдаж ийм засвар хийгээгүй, бас дур зоргоор авирлаагүй, эрх мэдлээ хэтрүүлээгүй гэдгийг дурдахын тулд болсон үйл явдлыг ийнхүү тодруулж байна. Дээр дурдсан хүмүүсийг Цэцийн хуралдаанд ирүүлж асуух, тайлбар авах хүсэлт тавьж байна.

Хоёр. Нэмэлт тайлбарын 2-т дараах хариу өгч байна.

Хууль тогтоох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийг Улсын Их Хурал эдэлдэг гэдэгтэй хэн ч маргахгүй байгаа. Эдгээр өргөдөл гаргасан иргэд Улсын Их Хурлын хууль тогтоох ажиллагааны талаар буруу ойлголттой байгаагийн зэрэгцээ заримдаа асуудлыг зориуд мушгин гуйвуулж байна. Хоёрдахь санал хураалтаар батлагдаж, найруулгын засвар хийгдэж Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурж, төрийн тамга дарагдан дугаар авагдаж, Ерөнхийлөгчийн хоригийг давж, “Төрийн мэдээлэл сэтгүүл”-д нийтлэгдэн хүчин төгөлдөр болсон хууль, шийдвэрт хэн ч хууль санаачлахгүйгээр үзэг хүргэж, гар хүрэх ёсгүй гэдэг нь хэнд ч ойлгомжтой асуудал.

Гэтэл гомдогсод хууль батлагдах, хүчин төгөлдөр болох энэхүү олон шат дамжлагын зөвхөн нэг хэсэг нь болох найруулгын засвар хийх, ёсчлох үе шатанд хийгддэг ажлыг зориуд салган авч, Улсын Их Хурал онцгой эрхээ алдаж, Монголд ганц хүн дураараа хууль тогтоогоод байгаа гэсэн гүтгэлийг зохиож түүнийгээ үнэн гэж батлахын тулд ар араасаа цуварсан гомдол, зарга гаргаж байгаа нь зүйд, бас хууль, шударга ёс, үнэнд үл нийцнэ. Аливаа хууль, шийдвэрийг 2 дахь хэлэлцүүлгээр баталсны дараа ямар ч санал хураалт явуулахгүйгээр тэдгээрт найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй засвар хийдэг нь зөвхөн өнөөдөр мөрдөж байгаа хууль, дэг, өнөөгийн Улсын Их Хурал, түүний даргын хийгээд байгаа ажил бишээ. 1990 онд Улсын Бага Хурал байгуулагдснаас хойшхи 17 жилийн хугацаанд Улсын Бага Хурал, Улсын Их хурлын үйл ажиллагаа чухам ингэж л явж ирсэн, энэ нь ч буруу биш.

Ийм засварыг хууль тогтоох, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаа гэж үздэггүй бөгөөд хэрэв гомдогсод ийм ойлголттой байдаг бол мэдлэггүйн гачигдал бас хэтэрхий их эндүүрэл гэж дүгнэхэд хүргэж байна. Яагаад гэвэл хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал зөвхөн санал хураалтаар шийдвэрлэдэг, харин найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй засварыг ойлголцоод, санал хураахгүйгээр хийдэг. Хэрэв эдгээр иргэд хууль батлагдсаны дараа найруулгын засвар хийдэг одоогийн практикийг буруу гэж үзэж байгаа бол “2 дахь санал хураалт явагдаж хууль батлагдсаны дараа ямар ч засвар хийж болохгүй” гэсэн заалтыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд тусгах шаардлага гарна.

“Хууль батлагдсаны дараа Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газарын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын дарга найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын шинжтэй засвар хийж болно” гэж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.2-т заасан тул би хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор нэгэнт олгогдсон эрхийн хүрээнд ажилласан, энд эрх шилжүүлсэн зүйл байхгүй, харин дээрх эрхийн хүрээнд засвар хийж ёсчлох зөвшөөрөл Улсын Их Хурлаас авсан, үүний дагуу ажлаа хийсэн.

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн тухайд дээр дурдсан зөвшөөрлийн хүрээнд засвар хийхийг, бас хууль хоорондын болон дотоод зөрчилгүй бол ёсчлохыг зөвшөөрсөн юм. Би хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийг засаж өөрчлөөгүй, бас ганцаараа ямар нэгэн хууль баталж ёсчлоогүй.

Гурав. Нэмэлт тайлбарын гуравт дараах хариу өгч байна.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.1.3 дахь заалтыг зөрчсөн тухай дурджээ. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй” гэж шууд заасан, түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор баталсан. Хуулийн заалт, нөхцөл, орчин ийм байхад иргэн Л. нар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасан нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн үйлдэл болжээ. Учир нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлд “Үндсэн хуульд... байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэж заасан нь бий.

Дөрөв. Улсын Их Хурал 2006 оны 7 дугаар сарын 20-нд олон хуулийн эцсийн найруулгатай танилцсан, энэ бүхэлдээ нэг л процесс байсан. Ийнхүү танилцсан процесс нь ч маш товч байсан. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн найруулгатай танилцсан процесс 5 мөр 38 үгнээс, Хүн амын орлогын албан татварын хуулийн найруулгатай танилцсан процесс 3 мөр 20 үгнээс, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн найруулгатай танилцсан процесс 3 мөр 21 үгнээс, Авилгын эсрэг хуулийн найруулгатай танилцсан процесс 10 мөр 89 үгнээс бүрдэж байгаа бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс ямар нэгэн санал гаргаагүй, түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн найруулгыг танилцуулах үеэр гишүүн Б., Р., И. нар асуулт асууж, санал байр сууриа илэрхийлсэн, бусад нь санал гаргаагүй болно.

Энэ өдрийн хуралдаан бүхэлдээ 20-иод хуулийн эцсийн найруулгыг сонсох, чуулганы хуралдааныг хаах ажилд зориулагдсан, үдийн завсарлагааг эс тооцвол дундаа завсарлагагүй явагдаж хуулиудын редакц сонссон, танилцуулсан хуулиудыг найруулга, үг хэллэг, бүтэц, дэс дарааллын засварыг хэрхэн хийх, ёсчлох зарчмаа хэрхэн тогтох, найруулгын засвар хийж ёсчлох зөвшөөрлийг Байнгын хороо, Тамгын газар, Улсын Их Хурлын даргад ямар хэмжээ хязгаарын дотор өгөх, засвар хийсэн бол Улсын Их Хуралд дахин танилцуулах эсэхийг хэлэлцэж харилцан ойлголцон нэгдсэн байр суурьт хүрсэн ийм л хуралдаан болсон. Өөрөөр хэлбэл 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дээрх үйл явдалтай холбогдуулан маргаан гарах бол нэг л маргаан гарч эцэслэн нэг л шийдвэр гаргах асуудал.

Энэ маргаан нь ч үүссэн, Цэцийн эцсийн шийдвэр ч гарсан. Нэг маргаанаар хэд хэдэн гомдол гарч, бас нэг бус маргаан үүсгэж байгаа нь хуулийн зарчимтай, бас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн маш тодорхой заалттай зөрчилдөж байгааг тэмдэглэж байна. Энэ тухай үндэслэл тайлбараа би 2007 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд өгсөн бөгөөд энэхүү байр сууриа дахин нотолж байна. Энэ бол миний байр суурь гэхээсээ илүү хуулийн шууд заалт, зарчим юм. Энд өөр өөр хууль гэдэг ойлголт ач холбогдолгүй бөгөөд Улсын Их Хурал дээр нэг өдөр болсон, бас нэг л зарчим, асуудал хэлэлцэж нэгдсэн ойлголтоор нэгдмэл

байр сууринд хүрсэн /засварын болон ёсчлох асуудлаар/ шийдэл байсан гэдгийг тэмдэглэж байна.

4/ Улсын Их Хурал эдгээр хуулийн эцсийн найруулгатай танилцуулах үеэр миний бие редакц хийж ёсчлох, дахин танилцуулахгүй байх, хэрэв танилцуулах бол ямар нөхцөлд гэдгийг гишүүдэд танилцуулж зөвшөөрөл авахгүйгээр засвар хийсэн байсан бол хариуцлага ярих, тооцохыг бүрнээ ойлгоно, бас хүлээн зөвшөөрнө. Гэтэл Улсын Их Хуралд танилцуулж тийм зөвшөөрөл авчихаад байхад, илт улс төрждөг нэр бүхий 2-3 иргэн гомдол гаргаж, Цэц түүнийг нь ёсоор болгосон учраас би шударга биш шийдвэр, улс төрийн шалтгааны талаар яриад байгаа юм. Улсын Их Хурал хамтаараа, бүрэлдэхүүнээрээ гаргасан шийдлийн төлөө нэг хүнтэй хариуцлага ярьж болохгүй биз дээ. Тэгэхдээ Улсын Их Хурал түүний гишүүдэд буруу, тэр тусмаа хууль зөрчсөн үйлдэл энд байхгүй гэдгийг тэмдэглэж байна.

Үүнийг Үндсэн хуулийн цэцийн гишүүд байтугай жирийн иргэд ойлгож, намайг дэмжиж олон захидал ирүүлж байгааг дурдаж байна.

Улсын Их Хурал 2006 оны 7 дугаар сарын 20-нд хуулийн найруулгатай танилцах үед миний гаргасан засвар, ёсчлохтой холбогдсон саналыг хэн нэг гишүүн, эсхүл намын бүлэг, зөвлөл зөвшөөрөөгүй буюу эсэргүүцсэн бол би ямар ч засвар хийхгүй байсан. Засварыг хэн нэг гишүүн эсэргүүцвэл батлагдсанаар нь үлдээдэг нь Улсын Их Хуралд нэгэнт тогтсон заншил, бичигдээгүй хууль байдаг. Нэр бүхий иргэдийн нэмэлт тайлбартаа дурдсан бусад асуудалд хариулт өгөх шаардлагагүй гэж үзэв. Өөрөөр хэлбэл маргаж буй асуудалтай холбоогүй зүйлүүд бичсэн байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Нэг. Улсын Их Хурлын чуулганы 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулснаас хойш 2006 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр буюу ажлын 49 өдрийн дараа, 10 дугаар сарын 10-ны өдөр буюу ажлын 58 өдрийн дараа, 10 дугаар сарын 17-ны өдөр буюу ажлын 63 өдрийн дараа, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулснаас хойш 2006 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр буюу ажлын 35 өдрийн дараа, 9 дүгээр сарын 11-ний өдөр буюу ажлын 37 өдрийн дараа, 9 дүгээр сарын 19-ний өдөр буюу ажлын 43 өдрийн дараа, 9 дүгээр сарын 26-ны өдөр буюу ажлын 48 өдрийн дараа, 10 дугаар сарын 3-ны өдөр буюу ажлын 53 өдрийн дараа тус тус агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дараалал, бүтцийн чанартай олон тооны засварыг хийсэн болох нь хуулиудын хувийн хэрэг болон Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад шинжлэн судалсан бусад баримтаар нотлогдож байна.

Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-ийн “Улсын Их Хурал... хуралдаанаар хуулийн төсөл, ... хэлэлцэх, ... батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална”, мөн Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.4-ийн “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг энэ дэгийн 51.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Хоёр. Улсын Их Хурлын дарга Н. дээрх хуулиудын эцсийн найруулгыг танилцуулсны дараа тэдгээрт засвар хийх талаар Улсын Их Хурлын гишүүдээс зөвшөөрөл авсан гэх боловч энэ нь Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд зохицуулагдаагүй болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна:

1. Аливаа төрийн байгууллага, албан тушаалтанд хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглодог нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйт төрийн үндсэн зарчим мөн. Улсын Их Хуралд эцсийн найруулга танилцуулсан хуульд засвар хийх эрхийг Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлын гишүүдээс зөвшөөрөл авсан гэх тайлбар, түүнчлэн хуульд оруулсан засварыг Улсын Их Хуралд танилцуулалгүйгээр шууд ёсчилсон үйлдэл нь дээрх зарчимтай зөрчилдөж байна.

2. Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлаас зөвшөөрөл авсны дагуу ажилласан гэх боловч энэ нь Улсын Их Хурлаас гарч буй шийдвэр эрх зүйн актын хувьд хэлбэржсэн, түүнчлэн эрх зүйн холбогдох акттай зөрчилдөөгүй байх шаардлагыг хангаагүй байна.

Гурав. Улсын Их Хурлын дарга Н.-ийн хуульд эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн заалтыг зөрчин Улсын Их Хурлын бүрэн эрхэд удаа дараа халдаж, засвар хийсэн үйлдэл нь түүнийг Улсын Их Хурлын даргын албан тушаалаас огцруулах үндэслэл болж байна.

Дөрөв. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн баталсан байх тул уг асуудлаар Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Тав. Үндсэн хуулийн Далдугаар зүйлд заасан "... нийт байгууллага, иргэн" гэсэн ойлголтод Улсын Их Хурлын даргын албан тушаал үл хамаарах тул Үндсэн хуулийн уг заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засварыг хийснээрээ Улсын Их Хурлын дарга Н. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Хорьдугаар зүйлийн "... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах" нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудал болох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын дарга Н. Улсын Их Хурлын бүрэн эрхэд удаа дараа халдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн үйлдэл нь түүнийг Улсын Их Хурлын даргын албан тушаалаас огцруулах үндэслэл болно.

3. 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар батлагдсан "Хууль хүчингүй болсон тухай хууль"-ийн хүчин төгөлдөр болох хугацааг батлахдаа Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

4. Улсын Их Хурлын дарга Н. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

## **Тэмдэглэл:**

Эрх зүйт нийгэмд “нийтийн эрх зүйд хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглодог, хувийн эрх зүйд хуулиар хориглосноос бусдыг зөвшөөрдөг” гэсэн зарчим үйлчилдэг. Иймд “амаар зөвшөөрөл авах” гэсэн ойлголт энэ зарчимтай шууд зөрчилдсөн нь тодорхой. Цэц энэ удаа Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн гэх дүгнэлтээ урьд гаргасан Цэцийн 2007 оны 3 дугаар дүгнэлтэд зааснаас илүү үндэслэлтэй гаргасан.

Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Цэцийн хуралдаанаар 2 удаа авч хэлэлцэхдээ Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг хоёр өөрөөр тайлбарлаж, улмаар хоёр өөрөөр дүгнэлт гаргасныг тайлбарлах аргагүй. Өөрөөр хэлбэл, Цэцийн 2007 оны 3 дугаар дүгнэлтэд албан тушаалтныг огцруулах эсэх асуудлыг иргэдийн хүсэлтээр бус харин эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Цэц хянан хэлэлцэх тул энэ талаар дүгнэлт гаргах боломжгүй гэсэн атлаа энэ удаа Улсын Их Хурлын дарга хуульд удаа дараа засвар оруулсан нь түүнийг албан тушаалаас огцруулах үндэслэл болж байна хэмээн урьдын гаргасан дүгнэлтийн үндэслэлээ үгүйсгэсэн эсрэг шийдвэр гаргасан юм.

Цэц өмнөх шийдвэртээ хуудуутай дүгнэлт гаргасан болохоо ийнхүү хүлээн зөвшөөрч залруулж байгаа хэрэг үү, эсхүл Улсын Их Хурлын дарга хэд хэдэн хуульд Үндсэн хууль зөрчиж засвар хийсэн нь түүнийг сая огцруулах үндэслэл болно гэж дүгнэв үү, юутай ч иргэдийн хүсэлтээр албан тушаалтныг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Цэц хянан хэлэлцдэг эрх хэмжээтэй болохоо “ухаарсан” нь Цэцийн хувьд ололт байв. Мөн Үндсэн хуулийн зөрчил давтагдсан тохиолдолд тухайн албан тушаалтныг огцруулах үндэслэл Цэцээр хэлэлцэгдэх ёстой гэсэн санааг Үндсэн хуулиас хайгаад олохгүй л болов уу. Цэцийн урьд гаргасан болон энэхүү дүгнэлтийг үндэслэн засвар хийсэн хуулиудын засварлагдсан зүйл, заалтууд нь хуулийн дагуу Улсын Их Хурлаар эцэслэн танилцуулагдаагүй, ёсчлолдоогүй тул мөн л хууль бус хуулийн зохицуулалт болох нь гарцаагүй. Одоо хүртэл дур мэдэн гар хүрсэн олон хууль үйлчилсээр байгаа юм билээ. Цэцд өргөдөл гаргаагүй учир хэлэлцэх боломжгүй болж байгаа юм. Зөрчлийг хэрхэн арилгах, Үндсэн хуульд нийцүүлэх нь Цэцийн бус, хууль тогтоогчдын эрх хэмжээний асуудал билээ. Ийм онцгой бүдүүлэг явдал Монголын парламентат ёсны хөгжилд дахин гарахгүй байх гэж найдна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.06.13 № 07**

**Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д., О.,  
Улсын Их Хурлын Тамгын газрын зөвлөх О. нар

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хууль<sup>90</sup>

90 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 30-д нийтлэгдсэн

- 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно”

- 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэг “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө”

2. Улсын Их Хурлаас 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль<sup>91</sup>

- 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө”

### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... шударга ёс, ... тэгш байдал, ...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.- гийн мэдээллийн агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн болох нь:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү тунхаглалд харшлах аливаа үйлдэл, ялгаварлан гадуурхах явдал, тэгж ялгаварлан гадуурхах аливаа турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй”, 23 дугаар зүйлд “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга таатай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс сэргийлүүлэх эрхтэй”, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Энэ утгаар аливаа төрлийн ялгаварлан гадуурхлыг хуулиар хориглосон байх ёстой бөгөөд хуулиар бүх хүн ямар ч шинж тэмдгээр, тухайлбал, арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөлөөр, ялгаварлахын эсрэг тэгш, үр нөлөөтэй хамгаалалтыг баталгаатай болгоно”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 2-т “Энэхүү пактад оролцогч улсууд арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал байдал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал, бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү Пактад тунхаглан зарласан эрхийг хэрэгжүүлэх баталгаа гаргах үүрэгтэй”, 6 дугаар зүйлд “Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүр аж төрөхдөө ажил хөдөлмөрөө өөрөө чөлөөтэй сонгох, чөлөөтэй тохиролцох бололцоог олгосон хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрч, энэ эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн

91 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2001 оны № 17-д нийтлэгдсэн

зохистой алхам хийнэ”, 7 дугаар зүйлд “Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүр шударга, аятай таатай хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэх үндэслэлээр нотлогдож байна. Түүнчлэн Алагчилахгүй байх тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцод Монгол улс нэгдэн орсон бөгөөд энэхүү конвенцод “алагчилах” гэсэн нэр томъёо нь:

“а/ арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа буюу нийгмийн гаралд үндэслэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдэл.

б/ ажил олгогч, ажилчдыг төлөөлөх байгууллага болон холбогдох бусад байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр гишүүн улсад тогтоосон ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, үгүйсгэн гадуурхах, эсхүл давуу байдал олгох бусад үйлдэл” гэжээ.

Уг конвенцын “Бодлого боловсруулах болон түүнийг хэрэглэх” гэсэн 2 дугаар хэсгийн 2-т “Гишүүн улс бүр ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахаас урьдчилан сэргийлэх үндэсний бодлогыг боловсруулна. Энэхүү бодлого хууль тогтоомж болон ажил олгогч, ажилчдыг төлөөлөх байгууллагын хооронд байгуулсан хамтын хэлэлцээр, эсхүл үндэсний нөхцөл практикт тохирох бусад аргаар хэрэгжих бөгөөд түүнд дараах зарчмыг тусгасан байвал зохино:

а/ ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд тэгш боломж, хандлагыг дэмжихийг нийтийг хамарсан асуудал болгох.

б/ хүн бүрт дараах зүйлийн хувьд тэгш эрх, хандлага олгож алагчлахгүй байх. Энэ хүрээнд:

- мэргэжлийн баримжаа болон ажлын байрны үйлчилгээ үзүүлэх

- тухайн сургалт, ажилд хувь хүн тохирох эсэхэд үндэслэн сонголтынх нь дагуу ажил олгож, сургалтад хамруулах

в/ засгийн газрын байгууллагууд бүх үйл ажиллагаандаа хөдөлмөр эрхлэлтэд алагчилахгүй байх бодлогыг баримтална.

г/ ажил олгогч аливаа хүнийг ажилд авах, сургалтад хамруулах, албан тушаал дэвшүүлэх болон ажлын байрыг хадгалах, эсхүл ажлын нөхцөлийг тодорхойлохдоо алагчлах аливаа үйлдлийг гаргахгүй буюу дэмжихгүй бөгөөд энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд аливаа хүн, байгууллага ажил олгогчтой хамтран шууд болон шууд бусаар саад учруулах, эсхүл зөрчиж болохгүй.

д/ хамтын хэлэлцээ болон аж үйлдвэрийн харилцаанд талууд ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд тэгш эрх, хандлагатай байх зарчмыг хүндэтгэх бөгөөд хамтын хэлэлцээрт ажилд орох, сургалтад хамрагдах, албан тушаалд дэвших болон ажлын байрыг хадгалах, эсхүл ажлын нөхцөлийн хувьд алагчлах шинж бүхий заалт оруулахгүй байхыг хангана.

е/ ажил олгогч болон ажилчдын байгууллага нь ажилд авах, гишүүнчлэлийг хадгалах болон байгууллагын үйл ажиллагаанд оролцох асуудал дээр ялгавартай хандах аливаа үйл ажиллагааг явуулахгүй” гэсэн байна.

Мөн 5 дугаар зүйлд “Гишүүн улс бүр дээрх бодлогод үл нийцэх аливаа хуульчилсан заалтыг хүчингүй болгох, ийм төрлийн захиргааны зааварчилгаа, дадлыг өөрчилнө” гэж заасан.

Дээрх Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцын дагуу Монгол Улс нь “Хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүн бүрийг аливаа хэлбэрээр алагчлах, ялгаварлан гадуурхахгүйгээр хөдөлмөрлөх тэгш бололцоог хангах” үүрэг хүлээсэн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж “хүн бүр ажлаа чөлөөтэй сонгох, өөрт тохирсон ажил эрхлэх тэгш боломжоор хангагдах”



эрх зүйн орчин бүрдүүлэх үүргийг хүлээсэн. Хүний эрхийн билль болон хөдөлмөр эрхлэлтийн салбарт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод ялгаварлан гадуурхах явдлаас ангид байх, хөдөлмөрлөх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгоход тэгш бололцоогоор хангагдах талаар тусгахдаа зөвхөн тухайн улсын иргэнд бус, тухайн улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүрт энэхүү эрхийг тэгш эдлүүлэх талаар тусгасан.

Ашигт малтмалын тухай хуульд зааснаар гадаадын иргэнийг ажиллуулсны төлөө ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр төлөхөөр байгаа нь хэдийгээр ажил олгогчид ногдуулж буй төлбөр мэт боловч энэхүү төлбөрөөс шууд үүдэлтэйгээр гадаадын иргэдийг ажиллуулах, хөдөлмөрлөх аятай нөхцөлөөр хангагдах эрхийг эдлүүлэх боломжгүйд хүргэж байгаа болно.

Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно” гэснээс үзэхэд зөвхөн Монгол Улсын иргэнийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд гадаадын иргэдийг ажиллуулахад хувь, хэмжээний хязгаарлалт хийсэн нь харагдаж байгаа болно. Гадаадын иргэдийн хөдөлмөрлөх эрхийг шууд хориглох эрх зүйн үндэслэлгүй тул тэдгээрийг тухайн хуулийн этгээдэд 10-аас дээш хувиар ажиллуулахгүй байх үүднээс ажлын байрны төлбөрийг өндөр хувь, хэмжээгээр ногдуулах болсноор алагчласан, тэгш байдлыг алдагдуулсан хууль баталсан байна.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал, ...-ыг хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн болох нь:

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал ашиглахтай холбоотой салбар буюу уул уурхайн салбарт гадаадын иргэдийг авч ажиллуулахдаа нийт ажиллагсдын 10-аас дээшгүй хувиар ажиллуулахаар хязгаарласан ба үүнээс дээш гарсан тохиолдолд гадаадын иргэнийг ажиллуулж буй ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн төлбөр төлнө. Гэтэл бусад салбар /тухайлбал, барилгын салбар, үйлдвэрлэл, үйлчилгээ гэх мэт/-т ажиллаж буй гадаадын иргэд нь нийт ажиллагсдын хэдэн хувь байх талаар хуулиар ямар нэгэн хязгаарлалт тавиагүй, хоёрдугаарт гадаадын иргэд нийт ажиллагсдын хэдэн хувийг эзэлж байгаагаас үл шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сар тутамд 10 дахин нэмэгдүүлэх биш тогтмол 2 дахин нэмэгдүүлсэн төлбөр төлж байгаа нь Үндсэн хуулийн “шударга ёс, тэгш байдал, ...-ыг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хуулиар хүлээгээгүй бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын хэдэн хувь нь гадаадын иргэд ажиллуулах талаар ямар нэгэн хязгаарлалт тавигдаагүй, Түүнчлэн гадаадын иргэдийг ажиллуулсны ажлын байрны төлбөрт сар бүр “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр” төлж байгаа атал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хязгаарлалт тавьж, ажлын байрны төлбөрт сар бүр “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр” ногдуулж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, ... тэгш байдал, ...-ыг хангах, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг шууд зөрчсөн байна.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн болох нь:

Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.3-т “Татвар бий болгох, ногдуулах, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлүүлэхтэй холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна” гэж заасан. Гэтэл гадаадын иргэдийн ажлын байрнаас авч буй төлбөрийг Ашигт малтмалын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах хууль зэрэг татварын бус хуулиар авч байгаа нь Татварын ерөнхий хуулийн дээрх заалттай зөрчилдөж улмаар хууль тогтоомж нь нэг мөр ойлгогдох, өөр хоорондоо зөрчилгүй байх тухай “хууль дээдлэх зарчим”-ыг зөрчсөн байна.

4/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчсөн болох нь:

Хууль ёсоор оршин суугаа хүн бүр гэдэгт Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн багтах бөгөөд иргэний статусын хувьд өөр хэдий ч тус улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа тул Үндсэн хуулийн дагуу хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Гэтэл Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэдийн ажлын байр тутамд ажил олгогчид “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний ажлын байрны төлбөр” ногдуулж байгаа нь “хуулийн өмнө эрх тэгш байх” тухай Үндсэн хууль шууд зөрчих үндэслэл болж байна.

5/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэснийг зөрчсөн болох нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно” гэж заасан байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн салбарт хуулийн этгээд байгуулан ажиллахдаа ажиллагсдын 10-аас дээш хувьд нь гадаадын иргэн ажиллуулах нь үндэсний аюулгүй байдал, хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журамд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хэрэв уул уурхайн салбарт ажилладаг хуулийн этгээд нийт ажиллагсдынхаа 10-аас дээш хувиар гадаадын иргэдийг авч ажиллуулах нь үндэсний болон хүн амын аюулгүй байдал алдагдах, нийгмийн хэв журам зөрчигдөх нөхцөл байдалд хүргэнэ гэж хууль тогтоогч үзсэн бол 10-аас дээш хувийг төлбөртэйгээр ажиллуулахгүйгээр шууд хориглосон зохицуулалт хийх байсан.

Иймээс гадаадын иргэдийг 10-аас дээш хувиар авч ажиллуулах нь үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журамд харшлахгүй тул Үндсэн хуульд заагдсан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах” гэсэн иргэний үндсэн эрхийг гадаадын иргэд Монгол Улсын иргэний нэгэн адил эдлэх эрхтэй.

Түүнчлэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” заасан. Гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр төлөх болсон тул тэднийг ажиллуулахад эдийн засгийн хүндрэл учирч, ажилд авахаас ажил олгогч татгалзах, ингэснээр уул уурхайн салбарт ажиллах гадаадын мэргэжилтнүүдийн ажлын байранд хязгаарлалт хийж “хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах” иргэний үндсэн эрхийн эдийн засгийн баталгааг бүрдүүлээгүй байна.

Төрөөс Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэх нь зөв хэдий ч иргэдийг ажлын байраар хангахыг дэмжих, хөхиүлэх, хөнгөлөлт үзүүлэх зэргээр ажиллах ёстой байтал гадаадын иргэдийн эрхийг хязгаарлах хэлбэрээр дээрх бодлогыг хэрэгжүүлж байгаа нь буруу юм. Гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажил олгогчид ногдуулж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн төлбөр нь татвар гэхээсээ илүүтэйгээр торгуулийн хэлбэртэй, санкцын шинж чанартай “гадаадын иргэдийг авч ажиллуулахыг хориглосонтой адил” утгатай, тэгш байдлыг алдагдуулсан эдийн засгийн хориг болсон байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д., О. нарын тайлбарын агуулга:

Өргөдөлд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь зөвхөн Монгол Улсын иргэнийг ажиллуулах үүрэгтэй бөгөөд гадаадын иргэдийг ажиллуулахад хувь, хэмжээний хязгаарлалт хийсэн нь алагчласан, тэгш байдлыг алдагдуулсан хууль болсон, гадаадын ажиллагсдын тоо 10 хувиас илүү байх нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэтэл 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний төлбөр авах нь торгуулийн хэлбэртэй, тэгш байдлыг алдагдуулсан эдийн засгийн хориг болсон байна гэж тус тус дурджээ.

Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын “Ажиллах хүчний талаар тавигдах шаардлага” гэсэн нэртэй 43 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт:

“43.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно.

43.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө” гэж заасан бөгөөд энэ хуультай холбогдуулан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зарим хууль батлагдсаны нэг нь Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлд дараах агуулгатай 9.3 дахь хэсэг нэмсэн юм:

“9.3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө”.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох онцгой бүрэн эрхтэй” гэж тус тус заасан байна.

Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлж Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал тус тус батлагдан гарч гадаадын иргэний эрх зүйн байдлыг зохих хязгаар, хүрээний дотор тогтоон мөрдүүлж байна. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн “Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны бүтэц” гэсэн нэртэй 6 дугаар бүлэгт:

“6.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ.

6.2. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн, тус тусын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үүрэгтэй” гэж тус тус заасан.

Мөн хуулийн “Үндэсний аюулгүй байдлыг хангахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрх” гэсэн 8 дугаар зүйлд:

“8.1. Улсын Их Хурал нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг тодорхойлж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батална” гэж заасан.

Үүний дагуу Улсын Их Хурал 1994 оны 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг баталсан бөгөөд түүний 8-д “Монгол Улсад оршин суух гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн тоо, тэдний зорчин явах журмыг хуульчилан тогтоож, хяналт тавих, Монгол Улсад хууль бусаар оршин суух явдлыг гаргуулахгүй байх хяналтын тогтолцоотой болох”, 34-ийн 8-д “Эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох дотоод хүчин зүйлүүд: гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монголд олноороо суурьших, үндэсний мэргэжилтэй боловсон хүчин, ажиллах хүчин олноороо гадаадад цагаачлах”, 3-ын 10-т “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд дараах чиглэл баримтлах: нэг орноос авах стратегийн ач холбогдолтой түүхий эд, тоног төхөөрөмж, мэргэжилтэн, ажилчдын тоо хэмжээг үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүй байх хэмжээнд байлгах” гэж тус тус заасан.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т: “эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах эрхийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгосон байна.

Энэ хуулийн 8.1-т “Байгууллага нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахын өмнө асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрлийг урьдчилан авсан байна” гэж тодруулан заажээ.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг төрийн захиргааны албан тушаалд авч ажиллуулахыг хориглосон байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн тус улсын хууль тогтоомжоор өөрт нь олгогдсон эрх, эрх чөлөөг Монгол Улсын иргэний нэгэн адил эдэлж, үүрэг хүлээнэ”, 11.2-т: “Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв буюу түүний эрх олгосон байгууллагын зөвшөөрөлтэйгээр энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар хориглосноос өөр ажил, албан тушаал эрхлэх, гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа төрийн, эсхүл төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газарт ажиллах, аж ахуйн нэгж байгуулан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж болно” гэж тодорхой заасан.

Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасны дагуу тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно гэж заасан нь энэхүү тодорхой хувь, хэмжээнд тохируулан гадаадын иргэдийг ажиллуулж болох одоогийн нөхцөл байдалд тохируулсан заалт юм.

Харин энэ хуулийн 43.2-т “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг мөн хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө” гэж заасан асуудал бол ашигт малтмалын салбарын онцлогийг харгалзан тогтоосон төлбөр юм. Үүнийг өргөдөлд “эдийн засгийн хориг болжээ” гэж дурдсан тухайд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д Улсын Их Хурал нь “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох” бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн асуудал байна.

Ашигт малтмалын салбар дахь ажлын байрны төлбөр бусад салбарынхаас өндөр тогтоогдсон асуудлыг буруу гэж өргөдөл гаргагч үзэж байгаа бол энэ нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын асуудал биш, Улсын Их Хурал өөрөө хууль тогтоох эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэрлэх асуудал болно.

Татварын ерөнхий хуулийн 2.3-т татвар бий болгохтой холбогдсон харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулна гэж заасан заалт зөрчигдсөн гэж өргөдөлд бичсэн тухайд мөн хуулийн 16, 17 дугаар зүйлд зааснаар энэхүү төлбөр нь албан татвар биш тул ямар нэг хууль зөрчигдөөгүй байна.

Өргөдөлд дурдсан Монгол Улсын олон улсын гэрээнүүдийн заалт зөрчигдсэн гэсэн тухайд эдгээр заалтууд нь Монгол Улсад хууль ёсоор буюу холбогдох хууль тогтоомжийн дагуу оршин суугаа гадаадын иргэдийн эрх, үүргийг баталгаажуулсан заалтууд болохоос биш гадаадаас чөлөөтэй орж ирэн, ямар ч хязгаарлалтгүйгээр ажил, хөдөлмөр эрхлэх тухай ойлголт хараахан биш гэдэг нь тодорхой билээ. Тэгээд ч конвенцуудад дараах хязгаарлалт хийж болохыг шууд дурдсан байна:

а/ Хүний эрхийн түгээмэл тунхаглал:

8 дугаар зүйл “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”

29 дүгээр зүйл “2.Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй”

б/ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт:

6 дугаар зүйл “2.Энэ эрхийг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Пактад оролцогч улсуудын авах арга хэмжээ нь техник мэргэжлийн дадлага, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгэм, соёлын хэлбэрэлтгүй хөгжлийг хангах арга замыг хэрэгжүүлэх хувь хүний улс төр, эдийн засгийн үндсэн эрх чөлөөг баталгаажуулах нөхцөлд үр ашигтай ажлаар бүрэн хангах алхмыг хамаарна.

в/ Алагчилахгүй байх /ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц:

1 дүгээр зүйл “1.Гишүүн орон бүр бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийг устгах, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, түүний өсөлтийг урамшуулах зорилгоор үр ашигтай, бүрэн чөлөөт хөдөлмөр эрхлэлтийн сонголтод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн идэвхитэй бодлогыг гол зорилго болгон зарлаж, хэрэгжүүлнэ” гэх мэт.

Дэлхийн улс орнуудад ялангуяа, хөгжиж байгаа орнуудад гадаадаас ажиллах хүч авахад зохих хязгаарлалт, квот тогтоосон байдаг бөгөөд энд ОХУ, Казакстан, Беларусь зэрэг улсуудыг нэрлэж болно.

Ийнхүү дээр дурдсан Үндсэн хуулийн болон бусад хууль тогтоомжийн заалтууд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллах гадаадын иргэдийн эрх, үүргийг тодорхой зааглан тогтоож өгсөн болохыг харуулж байгаа тул Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.3, Ашигт малтмалын тухай хуулийн 43.1, 43.2 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтыг тус тус зөрчөөгүй байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактуудад дурдсан хүний угаас заяасан “салшгүй” эрхийг хязгаарлаж болохгүй гэдгийг эдгээр пактад нэгдэн орсон гишүүн орны хувьд Монгол Улс Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрсөн байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5-д “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болно” гэж заажээ.

Ийнхүү үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хүний салшгүй эрхээс бусад эрхийг дотоодын эрх зүйн хүрээнд зохих хэмжээгээр хязгаарлалт тогтоож болохоор заасан нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 3-ын “Хөгжиж байгаа улсууд хүний эрх болон үндэсний эдийн засгаа зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эдийн засгийн эрхийг өөрийн улсын иргэн бус хүмүүст хэрэгжүүлэх баталгааг ямар хэмжээгээр бий болгохоо тодорхойлж болно” гэсэн заалттай уялдаж байна.

Хөдөлмөрлөх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах нь хүний салшгүй эрхэд үл хамаарах бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно”, 43.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө”, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө” гэсэн нь Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсгийн заалтад нийцэж байна.

Иймд Ашигт малтмалын тухай хууль болон Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дээр дурдсан заалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно”, 43.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө”, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ...тэгш байдал, ...-ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, ... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэсэн заалтуудыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч 15 хоногийн дотор хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

“Хөдөлмөрлөх” эрх нь хүний үндсэн эрхэд үл хамаарна. Хүний жам ёсны буюу салшгүй эрхээс бусад эрхийг тодорхой хүрээнд, тодорхой цаг хугацаагаар хязгаарлалт тогтоох боломжтой. Гадаадаас ажиллах хүч авах тухай асуудалд тодорхой квот тогтоож жилд хэдий хэмжээний ажиллах хүч авах, аль салбарт ажиллуулах зэргийг тооцож байх нь хөдөлмөр эрхлэлтийн талаархи төрийн бодлогын хүрээнд явагдаж байгаа ажиллагаа юм. Мөн гадаадаас ажиллах хүчин авахыг хуулиар хориглоогүй бөгөөд зөвхөн тодорхой хязгаар тогтоосон нь угтаа үндэсний аюулгүй байдал, хүн ам зүйн бодлоготой ч холбоотой асуудал цаана нь хөндөгддөгөөс үүдэлтэй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.06.20 № 08**

**Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д., Б., Э.,  
Улсын Их Хурлын Тамгын газрын нэгдүгээр нарийн бичгийн дарга Н.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>92</sup>

92 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 8-д нийтлэгдсэн

- 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална”

2. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” 14 дүгээр тогтоол<sup>93</sup>

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”

- Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, ...төрийн байгууллагын бусад шийдвэр... бүрнээ нийцсэн байвал зохино”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 32.2-т “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэж заасан нь дор дурдсан байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байна.

Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заажээ. Ийнхүү чуулганы хэлбэрээр Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрх болон бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурлын үйл ажиллагааг хуулиар батлагдсан дэгээр бус тогтоолоор батлагдсан дэгээр зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын..., үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн заалтыг зөрчиж байна.

Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон энэ дэгээр зохицуулна” гэж зааснаас харахад тогтоолоор батлагдсан уг дэг нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд чуулганы хэлбэрээр бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурлын үйл ажиллагааг зохицуулж байгаа нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалттай шууд утгаараа ноцтойгоор зөрчилдөж байна. Ийнхүү Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Улсын Их Хурал 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг Үндсэн хууль, тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Улсын Их Хурлын тухай хуульд нийцүүлэн батлан гаргаж байжээ. Гэвч шинэ бүрэлдэхүүнтэй болсон Улсын Их Хурал 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэн батлахдаа Улсын Их Хурлын хуралдааны дэгийг хуулиар бус тогтоолоор баталж байх зохицуулалтыг хийж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын 61 дүгээр тогтоолоор баталсан нь 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байжээ.

93 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 9-д нийтлэгдсэн



Улсын Их Хурал 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэн батлахдаа чуулганы хуралдааны дэгийг мөн тогтоолоор тогтоож байхаар зохицуулж, чуулганы хуралдааны дэгийг 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан чуулганы хуралдааны дэг ийнхүү хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болгож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д., Б., Э. нарын тайлбарын агуулга:

Улсын Их Хурал нь парламентат орны нийтлэг жишгээр хууль тогтоох, улсын төсөв батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, түүнчлэн гүйцэтгэх засаглалд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төрийн төлөөллийн байгууллага бөгөөд энэхүү үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд парламент Үндсэн хуулиар өөрт нь олгогдсон онцгой бүрэн эрхийг эдэлдэг билээ. Улсын Их Хурал нь байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлэг зэрэг зохион байгуулалтын бүтэцтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй ажлын хэсгийг ч тодорхой хугацаанд байгуулан ажиллуулдаг юм.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурал хууль тогтоох, улсын төсөв батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих, түүнчлэн гүйцэтгэх засаглалд хяналт тавих үйл ажиллагаагаа чуулган, байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын... үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн нь Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг Улсын Их Хурлын гишүүд ямар бүрэн эрхтэй /эрх, үүрэг/, энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд ямар баталгаагаар хангагдсан байх, ямар тохиолдолд энэхүү бүрэн эрхээ алдах, Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтэц /хэдэн байнгын, дэд, түр хороотой байх, ямар чиг үүрэгтэй байх, хэдэн гишүүнтэй байх, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд хорооны даргыг ямар журмаар сонгох, Улсын Их Хурал дахь олонхи, цөөнх, нам, эвслийн бүлэг гэдгийг хэрхэн тодорхойлох, ямар бүрэн эрхтэй байх, Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ ямар хэлбэрээр хэрэгжүүлэх, ямар тохиолдолд Улсын Их Хурлын бүрэн эрх дуусгавар болох, Улсын Их Хурлын бусад шийдвэр гэдэг нь ямар хэлбэртэй байх, анхдугаар, ээлжит, ээлжит бус, онцгой, чуулган гэдгийг ямар тохиолдолд, ямар хугацаанд зарлан хуралдуулах/ зэрэг Улсын Их Хурлын үйл ажиллааны журмыг хуулиар тогтоох асуудал гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын үйл ажиллагааны тодорхой эрх зүйн хэм хэмжээг тогтоож өгсөн.

Харин Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг бол техникийн горимын асуудал гэж үзсэн, өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын нэгдсэн, байнгын хороодын хуралдааныг хэрхэн, яаж зохион байгуулах, /төсөл, тодорхой асуудлыг ямар үе шаттай, ямар дэс дараалалтай, хэрхэн хэлэлцэх, хуралдааны товыг хэрхэн тогтоох/, хяналтын үйл ажиллагаатай холбоотойгоор тайлан, мэдээлэл, асуулт, асуулгын хариуг сонсох, хэлэлцэх, хуралдаанд оролцогчдод /хуралдаан даргалагч, гишүүд, ажлын хэсэг, албан тушаалтанд/ субъектив эрх олгож, үүрэг хүлээлгэх /асуулт асуух, хариулт авах, хуралдаанаас завсарлага авах, санал хураалгах асуудлыг хэрхэн зохицуулах зэрэг/ замаар хуралдааны дотоод зохион байгуулалтын асуудалтай холбогдуулан дотоод дүрмийг тогтоож байгаа асуудал юм.

Иймд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хуулиар тогтоох шаардлагагүй гэж үздэг. 1997-2001 онд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны

дэгийг хуулиар батлан мөрдөж байсан практик байгаа хэдий ч энэ хуульд хэм хэмжээ тогтоосон олон заалт байсан. Улсын Их Хурал 2001 онд чуулганы хуралдааны дэгийг тогтоолоор батлахдаа хэм хэмжээ тогтоож байсан заалтуудыг Улсын Их Хурлын тухай хуульд шилжүүлж, дэгээр зөвхөн зохион байгуулалтын шинжтэй техникийн горимын асуудлыг зохицуулж байгаа юм.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд Засгийн газрын үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоохоор заасан бөгөөд Засгийн газар хуралдааныхаа дэгийг дээр дурдсан үндэслэлийн нэгэн адил дотоод дүрэм гэж үзэн Засгийн газрын тогтоолоор батлан мөрддөг билээ. Түүнчлэн парламентын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр болох чуулганы хуралдааны дэгээ хуулиар биш дүрэм, журмын хэлбэрээр батлан мөрддөг олон улс орон байна. Жишээ нь, ОХУ, ХБНГУ зэрэг улсад ийм байдлаар парламентын хуралдааны дэгийг тогтоосон байдаг.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн заалт, “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4-т “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж шууд утгаар заасан нь Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох чуулганы хуралдааны дэгд ч нэгэн адил хамаарч байна.

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн заалт, “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг үндэслэн МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн заалт, “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ... төрийн байгууллагын бусад шийдвэр... бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг”-ийг баталсан Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг үндэслэн Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолын үйлчлэлийг 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу мэдэгдэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн 32.2 дахь хэсэг, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин тавдугаар зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурал хуралдааны дэгээ хэрхэн тогтоож байсныг судалж үзэхэд 1990-1992 онд тогтоолоор, 1992-1997 онд хуулиар, 1997-2001 онд хуулиар, 2001-2005 онд тогтоолоор, мөн 2006 онд дэгээ шинэчлэн тогтоолоор баталсан байна. Эндээс дүгнэхэд Улсын Их Хурал өөрсдийн үйл ажиллагааг одоо болтол цэгцэлж чадаагүй, нэгдмэл ойлголтгүй, нэгдмэл байр суурьгүй байна гэж үзэж болно. Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4, Хорин наймдугаар зүйлийн 2 дах хэсгээс үзэхэд Улсын Их Хурал зохион байгуулалт, үйл ажиллагааны журмаа хуулиар зохицуулах үндэслэлтэй. Эрх зүйн онолын хувьд хууль гэдэгт илүүтэй хэлбэржсэн хэм хэмжээг ойлгодог. Энэ ч утгаараа Улсын Их Хурлын хуралдааны дэг тогтоолоор бус хуулиар хэлбэрших ёстой. Харин тэрхүү хуульдаа дэг байх тухай заагаад дэгээрээ дотоод журмын ямар ямар асуудлыг зохицуулахыг зааж өгч болох юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2007.12.12 № 03

### Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт, Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлаас ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2007 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 8/6586 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг “Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32.2 дахь хэсгийн заалтад “хуулиар” батлахаар өөрчлөлт оруулж, үүнтэй нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолыг тус тус баталсан болно”

2/ Мөн байнгын хорооны 2007 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 8/6820 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарын агуулга:

“Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 2007 оны 47 дугаар тогтоолыг хүчингүй болгоогүй байна, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад тус тус заасны дагуу уг асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

3/ Улсын Их Хурлын дарга Л.-ээс ирүүлсэн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1/1016 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-ын “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор батална” гэсэн заалт, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 6 дугаар арын 20-ны өдрийн 8 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр хэлэлцээд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн шийдвэрийг гаргасан юм. Харин Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалтад өөрчлөлт оруулж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг хуулиар баталж байхаар хуульчилсан болно. Ийнхүү хуульд оруулсан өөрчлөлтийн үндсэн дээр 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг баталж, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай” Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцлоо. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагааг хуулиар зохицуулах болж, маргаан

бүхий нөхцөл байдал үгүй болсон тул Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцох боломжгүй байна.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийн дагуу Улсын Их Хурал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "...Улсын Их Хурлын тогтоолоор..." гэснийг "...хуулиар..." гэж өөрчилсөн "Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль", "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль", "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай" Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон Улсын Их Хурлын 67 дугаар тогтоолыг тус тус батлан гаргаж маргаан бүхий нөхцөл байдал үгүй болсныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн байх тул мэдээлэл гаргагчийн мэдээлэлд дурдагдсан шаардлага хангагдсан гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Улсын Их Хурал дээр дурдсан холбогдох хууль, Улсын Их Хурлын тогтоолыг батлан маргаан бүхий нөхцөл байдлыг арилгасан боловч "Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 7 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тогтоолыг хүчингүй болгоогүй байх тул уг тогтоолыг хүчингүй болгох үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. "Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 8 дугаар дүгнэлтийн тухай" Монгол Улсын Их Хурлын 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн шүүх, парламент хоёрын хоорондын харилцаанд байнгын зөрчилдөөнт байдал үүсдэг нь зүй ёсны үзэгдэл. Парламент шийдвэрээ улс төрийн процессийн, "тэмцлийн" дүнд гаргадаг бол Үндсэн хуулийн шүүх аливаа маргаантай асуудлыг гагцхүү Үндсэн хуульд тодорхой бичигдсэн, эсхүл түүний дотор шууд бус утгаар агуулагдаж байгаа эрх зүйн үзэл баримтлал, үзэл санаа, зарчмыг мөрдлөг болгон шийдвэрлэдэг. Энэ ч утгаараа Цэц Үндсэн хуулийн шууд заалтыг баримтлан дээрх шийдвэрийг гаргасан.

Дээр дурдсан зүй ёсны "зөрчилдөөнт" харилцаа зарим тохиолдолд Цэц ба Улсын Их Хурлын үйл ажиллагаанд зүй бус "сөргөлдөөнт" харилцаагаар илэрч байгаа нь харамсалтай. Улсын Их Хурал хуралдааны дэгээ хуулиар баталж, Үндсэн хуулийн зөрчлийг арилгасан атлаа Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тогтоолоо хүчингүй болгоогүй нь эрх зүйн хувьд ойлгомжгүй, Цэц Улсын Их Хурлын хооронд үл ойлголцох сөргөлдөөнт харилцаа үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн. Эрх зүй, улс төрийн энэ мэт сөргөлдөөнт байдал нь Үндсэн хуулийг сахин хамгаалах, маргааныг магадлан шийдвэрлэх Цэцийн үйл ажиллагаанд эерэг гэхээсээ илүүтэй сөрөг үр дагаврыг бий болгодог. Цэцийн дүгнэлтийг үндэслэн дэгээ хуульчилж байгаа Улсын Их Хурлын үйлдэл, харин дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тогтоолоо хүчингүй болгохгүй байгаа Улсын Их Хурлын эс үйлдэхүй нь хоорондоо шалтгаант холбоогүй, утгаа зүй бус байдлыг үүсгэж байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.09.26 № 09

### Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Т.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>94</sup>

- 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэг “Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно”

- 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсэг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэж тогтоол гаргана”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “... шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй”

- Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно

- Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн”

- Тавьдугаар зүйлийн 1 хэсгийн 2 дахь заалт заасан “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх”

- Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:

Нэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д “Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно” хэмээн заажээ. Түүнчлэн мөн хуулийн 170 дугаар зүйлийн 170.2-т “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хэргийг

94 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 8-д нийтлэгдсэн

хянан шийдвэрлэсэн шүүх шийдвэрлэж тогтоол гаргана” хэмээн заасан байна. Эдгээр зүйл, заалтын агуулгыг авч үзвэл шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг иргэд давж заалдах эрхтэй байх талаар Үндсэн хуульд заасныг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” хэмээн иргэдийн эдлэх эрхийг тодорхойлон тогтоосон. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1-д зааснаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж гарсан үед уг тогтоол, захирамжийг зөвхөн тухайн шүүхэд гомдол гаргаж хянуулах бөгөөд дээд шатны, өөрөөр хэлбэл, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргаж хянан шийдвэрлүүлэх иргэдийн эрхийг хязгаарлан хаасан байна.

Анхан шатны шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх явцдаа ямар нэгэн алдаа дутагдалгүй ажиллана гэж үзэх нь өрөөсгөл ойлголт юм. Шүүх болон шүүгчийн гаргасан алдаа зөрчлийг тухайн шатны шүүх засахгүй байх ойлголтын үндэс нь давж заалдах болон хяналтын шатны шүүн таслах ажиллагаа байдаг бөгөөд үүнийг дээд шатны шүүх хэрэгжүүлдэг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 /хэрэг шилжүүлэх/, 65.1.4 /нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байх/, 65.1.5 /нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан/, 69.1 /шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах/, 80 дугаар зүйл /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх/, 92.4 /татгалзан гаргах тухай асуудлыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх/, 97.1 /хуульд зааснаар торгууль оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гарган зөрчил гаргасан этгээдийг торгох/, 100.2 /нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцаах/, 117 дугаар зүйл /энэ хуулийн 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-т заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох/, 124 дүгээр зүйл /энэ хуулийн 123.1-д заасны дагуу бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчлөх/ зэрэг хуульд дурдсан тохиолдлуудад шүүх буюу шүүгч алдаа зөрчил гаргавал /хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, бусдын нөлөөнд автсан г.м/ алдаатай шийдвэрийг дээд шатны шүүх, тэр тусмаа Улсын дээд шүүх хянах, засч залруулах боломжийг хуулиар ийнхүү хааж болохгүй.

Хоёр. Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн” гэдгийг зааж, мөн хэсгийн 2-т “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянаж үзэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” хэмээн заасан байдаг. Гэтэл энэхүү заалтын утга агуулгыг алдагдуулж, Улсын дээд шүүх нь доод шатны шүүхийн тогтоол, шийдвэрийг хянах боломжгүйд хүргэсэн заалт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оржээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж заасан байдаг.

Түүнчлэн Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ” гэж заасан байдаг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн энэхүү заалттай шууд харшилж байна. Учир нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн тогтоол,

шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг уул хэргийг хянан шийдвэрлэсэн тухай шүүх шийдвэрлэж тогтоол гаргаснаар уг тогтоол эцсийн шийдвэр болдог. Энэ байдлаараа Үндсэн хуулийн дээр дурдсан зүйл, заалтуудтай зөрчилдөж байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үндсэн үүрэг нь анхан шатны болон доод шатны шүүхийн аливаа тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн захирамж, шийтгэвэр зэрэг шүүн таслах ажиллагааны актуудын хууль ёсны болон үндэслэлтэй эсэх байдлыг хянан тогтоох, нөгөө талаар иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийг бүрэн хангахад оршино. Шүүхэд мэдүүлэх эрх нь анхан шатны шүүхэд төдийгүй давж заалдах болон хяналтын шатны шүүхэд мэдүүлэх эрхийг дотроо агуулж байдаг.

Гурав. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” гэж заасан.

Гэтэл иргэнд олгосон энэхүү эрхийг алдагдуулж шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхэд давж заалдах боломжийг зориуд хаасан байна. Шүүх аливаа шийдвэрийг иргэд давж заалдах, хянуулах боломжоор бүрэн хангагдаж, энэхүү эрхийг эдлэх явдал иргэдийн хувьд бүрэн нээлттэй байх учиртай. Энэ нь шударга шүүхийн үйл ажиллагааны нэг гол тулгуур нөхцөл мөн хэмээн үзнэ. Ийнхүү давж заалдах гомдол гаргах иргэдийн эрхийг хязгаарлаж буй нь анхан шатны шүүхэд иргэний зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, дээд шатны шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байгаа юм.

Дөрөв. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан. Түүнчлэн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” хэмээн заасан байдаг.

Энэ дагуу Шүүхийн тухай хууль 2002 онд батлагдан гарсан. Уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн”, түүнчлэн уг хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны шүүх мөн” гэж тус тус заажээ. Эндээс үзэхэд иргэд шүүхийн шийдвэрийг аймаг, нийслэлийн шүүхэд давж заалдах, харин хянуулах тухай гомдлыг Улсын дээд шүүхэд тус тус гаргах ёстой бөгөөд тэдгээрийг анхан шатны шүүхэд гаргах хууль зүйн үндэслэл алга байна. Ийм учраас Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 болон 170.2 дахь хэсгийн заалт нь “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 болон 170.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин наймдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно” гэж заасан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 /хэрэг өөр шүүхэд шилжүүлэх/, 65.1.4 /нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй байх/, 65.1.5 /нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан/, 69.1 /шүүхээс гарах шийдвэрийг



баталгаажуулах/, 80 дугаар зүйл /хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх/, 92.4 /атгалзан гаргах эсэх асуудлыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэх/, 97.1 /хуульд зааснаар торгууль оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх тогтоол, шүүгч шийтгэвэр гаргаж зөрчил гаргасан этгээдийг торгох/, 100.2 /нэхэмжлэгч түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол хариуцагчийн хүсэлтээр шүүх хэргийн нотлох баримт болон бусад нөхцөл байдлыг харгалзан түүний эзгүйд хянан шийдвэрлэх, эсхүл нэхэмжлэлийг буцаах/, 117 дугаар зүйл /энэ хуулийн 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-т заасан үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох/, 124 дүгээр зүйл /хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж энэ хуулийн 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх /процессын/ ажиллагаа явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбогдон бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар хүчингүй болгох буюу өөрчлөх/-д заасан шүүхийн тогтоол, захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно” гэж хуульчилсан билээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” түүнчлэн Дөчин наймдугаар зүйлийн 2-ын “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл үгүй байна.

Учир нь нэгдүгээрт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д болон Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д тус тус заасанчлан “шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ”. Мөн Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдана гэж заасныг баримтлан шүүх үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлаас 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдөр баталсан Шүүхийн тухай хууль нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуульчилсан материаллаг хууль болно. Ийнхүү материаллаг шинжтэй хуулийн тухай Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт агуулж байна. Тэгвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ийнхүү шийдвэртэй холбогдуулан гомдол гарсан тохиолдолд түүнийг нь хэрхэн шийдвэрлэх талаархи асуудлыг зохицуулж байгаа буюу иргэний процессын хууль билээ.

Хоёрдугаарт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170.1 дэх хэсгийн дээрх заалтад дурдсан гомдол нь дээд шатны шүүхэд хандаж гаргадаг давж заалдах болон хяналтын шатны гомдол биш болно. Учир нь түүнд иргэний процессын шинжлэх ухаанд шүүхээс иргэний хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлээд гаргасан баримт бичгийг ойлгоно. Өөрөөр хэлбэл анхан шатны шүүхээс иргэний хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргасан шийдвэрийн талаар давж заалдах шатны шүүхэд, эсхүл хяналтын шатны шүүхэд гомдлоо иргэн гаргах бүрэн эрхтэй билээ.

Тэгвэл 170.1-д заасан шүүхийн тогтоол нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагааны талаар шүүх бүрэлдэхүүнээс гаргасан анхан шатны шүүхийн хуралдааныхаас бусад, түүнчлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс дангаараа гаргасан баримт бичиг буюу шүүгчийн захирамж гэж тус тус ойлгоно.

Гуравдугаарт, 170.1 дэх хэсэгт заасан заалтын агуулга Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн бусад зүйл, заалттай нийцэж байгаа билээ. Тухайлбал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу хэргийг нэг шүүхээс нөгөө шүүхэд шилжүүлэх талаархи шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжтай холбогдсон гомдлоо тухайн шатны шүүхэд гаргаж байх, мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасанчлан хэрэг үүсгэн хянан шийдвэрлэж энэ хуулийн 115, 116 дугаар зүйлд зааснаар шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбогдон бичгээр гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь илт үндэслэл муутай бол тухайн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар өөрчлөх, эсхүл хүчингүй болгож байхыг хуульчилсан байдаг. Шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсгийн заалтыг хэрэгжүүлж ирсэн хугацаанд нарийвчлан зохицуулах шаардлагатай болсон юм. Иймд Засгийн газраас санаачлан боловсруулж өргөн мэдүүлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэж 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталжээ. Ийнхүү хуулийн дагуу зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 65.1.10, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлээс гадна 38.9, 65.1.1-65.1.3, 65.1.7, 65.1.8 дахь хэсэгт заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шүүхэд гомдол гаргаж байхаар нэмж өөрчлөн найруулав.

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар дээр дурдсан 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсон болно.

### 3. Улсын дээд шүүхээс ирүүлсэн тайлбарын агуулга :

1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 170 дугаар зүйлд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөлт орж, улмаар энэ зүйлийн 2, 3, 4 дүгээр заалтууд хүчингүй болж, харин 170.1 дүгээр заалт доорх агуулгатай болжээ:

“170.1. Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно”

Хуулийн энэ зүйлд өөрчлөлт оруулах болсон шалтгаан дээрх зүйлд шүүхийн зарим тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргаж болно гэж, заримд нь гаргаж болохгүй гэж тус тус заасан атлаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг бусад тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргаж болох эсэхийг огт заагаагүйгээр үл ойлгогдох байдал гарч, шүүхийн практик тогтворжих боломжгүй байсан явдал юм. Харин эдгээр тогтоол, захирамж, шийтгэвэрт гомдол гаргах журам нь давж заалдах гомдол гаргах журмаас өөрөөр зохицуулагдах, гомдлыг тухайн шатны шүүхийн өөр бүрэлдэхүүн шийдвэрлэх, ийнхүү шийдвэрлэсэн тогтоол эцсийнх байх зэрэг зарчмын ойлголтууд нэмэлт, өөрчлөлт орсон хуульд хэвээр үлдсэн тул хүчин төгөлдөр хуульд тусгагдсан дээрх зохицуулалтын талаар тайлбар хийх нь үндэслэлтэй гэж үзлээ.

2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх зохицуулалт Үндсэн хуулийн ямар нэгэн зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гардаг шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах нь хэргийн оролцогчийн эрх бөгөөд тухайн иргэний хэрэгт хэлэлцэгдэж буй эрх зүйн маргааныг шийдвэрлэхээс өмнө хэрэгжлээ олж, дуусгавар болдог юм. Эдгээр тогтоол, захирамж, шийтгэвэрт гаргаж

буй гомдлыг шүүхийн шийдвэрт гардаг давж заалдах гомдолтой адил гэж үзэх үндэсгүй юм. Энэ гомдол нь шүүхэд үүссэн иргэний хэргийг шийдвэрлэсэн байдалд биш харин шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай, шийдвэр гаргахаас өмнө урьдчилан явуулсан шүүхийн ажиллагаанд гардаг болно.

Тухайлбал, шүүхийн харьяалал зөрчсөн, эсхүл тухайн хэргийг бодитой шуурхай шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөр шүүхэд хэргийг шилжүүлэх /20.1/, нотлох баримт бүрдүүлэхээр шүүх хуралдааныг хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй нотлох баримтыг хэргийн баримтаас хасах /38.9/, хуульд заасан тодорхой үндэслэлээр иргэний хэрэг үүсгэх боломжгүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах /65.1.1-65.1.8, 65.1.10/, нэхэмжлэгчийн хүсэлтээр ирээдүйд гарах шүүхийн шийдвэрийг баталгаажуулах арга хэмжээ авах /69.1/, шүүгч болон шүүх хуралдааны зарим оролцогчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх /92.4/, шүүх хуралдаан дээр зөрчил гаргасан этгээдэд мөнгөн торгууль ногдуулах /97.1/, нэхэмжлэгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол нэхэмжлэлийг буцаах /100.2/, хуульд заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх /80 дугаар зүйл/, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах шалтгаан илэрвэл хэргийг хэрэгсэхгүй болгох /117 дугаар зүйл/, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид илэрхий алдаа байсныг тухайн шүүх бүрэлдэхүүн, эсхүл шүүгч залруулах /124 дүгээр зүйл/ зэрэг ажиллагаа нь шүүхэд үүссэн хэргийг эцэслэн шийдвэрлэдэггүй, нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй эсэхийг тодорхойлдоггүй, хэн нэгний гэм бурууг тогтоодоггүй, эрх зүйн маргааныг тасалдаггүй болно.

Шүүх хуульд заасан дээрх бүх актуудаар шүүхэд хандсан этгээдийн маргааныг шийдвэрлэж байгаа биш харин тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай ажиллагааг явуулж байгаа юм.

3/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэснээс хойш 60 хоног”-ийн дотор анхан шатны шүүх тухайн хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй. Шаардлагатай зарим тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоног сунгах боломжтойгоор мөн зүйлийн 71.2-т заажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт давж заалдах гомдлыг хуульд заасан 14 хоногийн дотор гаргаж, түүнийг давж заалдах шатны шүүх 30 хоногийн дотор хэлэлцэж, уг шүүхээс гарсан магадлалд 14 хоногийн дотор гомдол гаргаж, хяналтын шатны шүүх мөн 30 хоногийн дотор түүнийг хэлэлцэж, Улсын дээд шүүхийн тогтоолд 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж, Улсын дээд шүүхийн хуралдаан хуралдаж, эцсийн шийдвэр гаргах хүртэлх хугацааг хамгийн багаар тооцоход 5 сар болох үндэстэй. Энэ хугацаанд шүүхэд үүсгэгдсэн иргэний хэрэг шийдвэрлэгдээгүй, эрх зүйн маргаан таслагдаагүй, зөрчигдсөн эрх сэргээгдээгүй, хохирол арилаагүй, түүнийг шийдвэрлэхийн тулд анхан шатны шүүх ямар ч ажиллагаа хийх боломжгүй хүлээж сууснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий шүүхийн байгууллага хүний эрхийн баталгаа байх үндсэн зорилгоо хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үндэслэлгүй болно.

4/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах тусгай журам тогтоосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, бодитой, чирэгдэлгүй явуулах боломжоор хангасны зэрэгцээ шүүхээс гарч буй эдгээр актад хяналт тавих боломжийг мөн бүрдүүлсэн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Дөчин наймдугаар зүйлийн 2-т “шүүхийн зохион байгуулалт, үйл

ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйл зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.

Харин Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах Монгол Улсын иргэний эрхийг зөрчсөн эсэх асуудлыг илүү дэлгэрэнгүй авч үзэж болох юм. Үндсэн хуульд “давж заалдах эрх” гэж тусгагдсан ойлголт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “давж заалдах гомдол гаргах” гэж тодорхойлогдсон байна. Давж заалдах эрх нь тухайн эрх зүйн маргааныг тасалж, хэргийг агуулгаар нь хянан хэлэлцэж гаргасан шүүхийн шийдвэрт хамааралтай ойлголт юм. Нөгөө талаар “давж заалдах” гэдэг нь тухайн шийдвэр гаргасан байгууллагын дээд байгууллагад хандах, тухайн байгууллагаас давуу эрхтэй байгууллагад зарга мэдүүлэх гэсэн утгатай монгол хэлний холбоо үг юм.

Энэ утгаараа шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргаж буй гомдлыг давж заалдах гомдол гэж үзэхгүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан гомдол гаргах журам нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан иргэний давж заалдах эрхийг зөрчөөгүй болно. Тухайн иргэний хэргийн талаар гаргасан анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхээ иргэн энэ хуулийн 15 дугаар бүлэгт заасан зохицуулалтын дагуу эдлэх баталгаатай боломжийг хуулиар олгосон байна. Түүнчлэн хуулийн 170 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан “шүүхэд гомдол гаргах” эрхийг мөн зөрчөөгүй байна. Иргэн нь шүүхэд мэдүүлэх эрхээ эдэлсэн учир шүүх иргэний хэрэг үүсгэж, хуульд заасан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа болно. Шүүхэд иргэний хэрэг үүсгэх, түүнийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь эрх зүйн нэг бие даасан салбар болох иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг харилцаа тул түүнийг шүүх зөвхөн хуульд заасан журмын дагуу явуулдаг юм. Энэ утгаараа хуулийн 170 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2-т заасан шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож буй хуулийн зохицуулалтуудын нэг юм.

Анхан шатны шүүх тухайн маргааныг тасалж, иргэний хэргийг хянан хэлэлцсэний дүнд гаргасан шийдвэрийн талаар хэргийн оролцогч давж заалдах гомдол гаргах эрхтэй бөгөөд давж заалдах шатны шүүх нь уг шийдвэрийг л хянах үүрэгтэй болох нь хуулийн 15 дугаар бүлэгт туссан байна. Харин хяналтын шатны шүүх нь давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж, гаргасан магадлалыг хэргийн оролцогчдын гомдлын үндсэн дээр хянах үүрэгтэй юм. Хуулийн 170 дугаар зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хянаагүйгээр Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1, 2-т заасан Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг, шүүхийн эцсийн шийдвэр гаргах үүргийг хязгаарлаагүй юм. Шүүхийн эцсийн шийдвэр гаргах асуудал тухайн иргэний хэргийн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой болохоос уг хэргийг хянан шийдвэрлэх явцад хийгдэж буй шүүхийн болон шүүгчийн ажиллагаа бүрт хамааралгүй болно.

Дээрх үндэслэлүүдээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйл Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна. Хуулийн энэ зүйлд заасан зохицуулалтыг хэрэглэхэд өргөдөл гаргагчийн хүсэлтэд дурдсан үндэслэлээр шүүхийн практикт онцын хүндрэл учирч байгаагүй, харин учирч байсан тодорхой хүндрэлийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар арилгах боломжтой болсон юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид тухайн шатны шүүхэд гомдол

гаргахаар хуульчилсан нь хэрэг маргааныг агуулгаар нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг хязгаарлаагүй байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин наймдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д “Энэ хуулийн 20.1, 65.1.4, 65.1.5, 69.1, 80 дугаар зүйл, 92.4, 97.1, 100.2, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн...”, мөн хэсгийн 2-т заасан “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. 2002 оны 1 дүгээр сарын 10-нд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.2 дахь хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсон, түүнчлэн өргөдөл гаргагч нь өргөдлийн шаардлагын дээрх хэсгээс татгалзсаныг дурдсугай.

3. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын намрын чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Шүүх, шүүгчээс гаргасан процессийн шинжтэй тогтоол, захирамж, шийтгэврийг материаллаг эрхтэй холбоотой хэрэг, маргааныг шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолтой адилтган ойлгож болохгүй. Өөрөөр хэлбэл шүүхийн процессийн шинжтэй шийдвэрт гомдол гаргах, хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гомдол гаргах нь хууль зүйн хувьд өөр өөр үр дагавартай, тусдаа ойлголтууд. Харин эдгээр ойлголтыг нэгтгэн давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хавтгайруулан ойлгох тохиолдолд шүүхээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд асар их хүндрэл бэрхшээл учрах нь лавтай.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.10.24 № 10

### Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль<sup>95</sup>

- 225 дугаар зүйлийн 225.1.2 дахь заалт “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах”
- 230 дугаар зүйлийн 230.1.2 дахь заалт “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол”
- 230 дугаар зүйлийн 230.1.3 дахь заалт “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад энэ хуулийг ноцтой зөрчсөн бол”
- 230 дугаар зүйлийн 230.4 дэх хэсэг “улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн”
- 239 дүгээр зүйлийн 239.4.2 дахь заалт “хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах шаардлагатай гэж үзсэн”
- 315 дугаар зүйлийн 315.1.2 дахь заалт “тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах”
- 318 дугаар зүйлийн 318.2.3 дахь заалт “урьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэгт буцаасан захирамж, тогтоолын заалтыг биелүүлээгүй”
- 322 дугаар зүйл 1 дэх хэсэг “Давж заалдах шатны шүүх хэргийг буцаахдаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны ажиллагааны чухам аль шатанд шилжүүлж байгааг магадлалдаа заана”
- 322 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Хэргийг шүүхэд хэлэлцэх үед зөрчил гаргасны улмаас тогтоолыг хүчингүй болгож байгаа бол өөр бүрэлдэхүүнтэйгээр буюу өөр шүүхэд хэлэлцүүлэхээр хэргийг тогтоол гаргасан шүүхэд буцаана”
- 323 дугаар зүйлийн 323.1.2 дахь заалт “...бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийх буюу шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлгүй байвал”
- 350 дугаар зүйлийн 350.1.3 дахь заалт “тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах”
- 352 дугаар зүйл “Анхан шатны болон давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөнийг тогтоовол хяналтын шатны шүүх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаана”
- 353 дугаар зүйлийн 353.3 дахь хэсэг “Хяналтын шатны шүүхийн заалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхээр шинэчлэн хэлэлцэхэд заавал биелүүлнэ”

95 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 6-д нийтлэгдсэн

## **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Аравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”

- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

Үндсэн хуулийн үзэл санаа болон Монгол Улсын олон улсын гэрээ, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн тухай хуулийн зарчмаар мэтгэлцээний тал нь яллах болон өмгөөлөх талууд байж, шүүх үүнд хөндлөнгийн, хараат бус байр сууринаас хандан мэтгэлцэгч талуудын гаргасан баримт, тайлбарт үндэслэн шийдвэр гаргах явдал юм. Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дээрх заалтуудаас үүдэн шүүхээс ялангуяа давж заалдах шатны шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тогтоогдоогүй нотлох баримт, зүйлийг тогтоолгохоор, эсвэл хэргийг хүндрүүлж зүйлчлэн дахин хэлэлцүүлэхээр буцаах явдал гарч байна. Ингэснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн заалтыг ноцтойгоор зөрчиж шүүх шууд мэтгэлцээний нэг тал өөрөөр хэлбэл, яллах талд үйлчлэн ажиллах болов. Энэ нь иргэний “өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх” эрхийг боогдуулж “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн зарчмыг хөсөрдүүлж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн дагуу шүүх яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ уг зүйлийн 225.1.2-т заасны дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах нь хэргийн оролцогчдыг байлцуулахгүй гаргаж буй шийдвэр учир Үндсэн хуулийн зарчмыг шууд бөгөөд ил тодоор зөрчиж байна. Мөн уг хуулийн 230 дугаар зүйлийн /Хэргийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтад буцаах/ 230.1 дэх

хэсэг буюу “230.1.2.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол; 230.1.3.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад энэ хуулийг ноцтой зөрчсөн бол; 230.1.4.улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн... бол хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 болон Тавин зургадугаар зүйл, тухайлбал төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд зааглан хуваарилах, мөн шүүхийн байгууллага шүүн таслах ажиллагааг явуулах, прокурорын байгууллага хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох онцгой чиг үүргийг ногдуулсан заалтуудтай тус тус зөрчилдөж, шүүх, шүүгчид прокурорын үүргийг ногдуулж, тэр ч байтугай улсын яллагчийн үзэмжээр шийдвэр гаргахыг шаардсан байна.

Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах байгууллагууд түүний дотор гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд багтах байгууллагын хүлээсэн үүргийг шүүх өөрөө хэрэгжүүлэхэд хүргэж байна гээд үүнийхээ үндэслэл болгон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан прокурорын эрх, үүргийг дурдахдаа уг хуулийн 193 дугаар зүйлийн 193.1.13-т заасан “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулийн шаардлагыг биелүүлэх талаар бичгээр заалт өгч хэргийг буцаах”, 193.1.18-д заасан “нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаах”, 215 дугаар зүйлийн 215.2.3-т заасан “нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах” зэрэг прокурорын эрх хэмжээг онцолжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн /Магадлал гаргах/ 315.1.2 дахь заалт “Тогтоол, магадлалыг хүчингүй болгож хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах” гэсэн нь мөн л шүүхэд ногдуулах ёсгүй үүрэг, функцыг ногдуулж, хууль завхруулах, хүний эрх зөрчих нөхцөл бүрдүүлээд байна. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос ямар нэг хүсэлт гаргаагүй, шаардаагүй байхад давж заалдах шатны шүүх өөрөө хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэгт хэргийг буцаасан бол зөвхөн яллах талын ашиг сонирхлыг илүү илэрхийлдэг бөгөөд өөрт байх учиргүй яллах чиг үүргийг хэрэгжүүлснийг нь биелүүлээгүй бол “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг нэг талыг барьсан буюу гүйцэд биш гэж үзэж” улмаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 317.1.1 болон 315.1.2 дахь заалтуудыг баримтлан дахин дахин хэргийг буцаах нөхцөл бүрдээд байгаа ба давж заалдах шатны зарим шүүгчид үүнийг бурангуйгаар ашиглан заавал хүнд ялтай зүйл ангиар зүйлчлэн шийдэхээс өөр аргагүй байдалд анхан шатны шүүхийг оруулж хүний эрхийг ноцтойгоор зөрчиж байна.

Үүнтэй нэг адил 322 дугаар зүйл /Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхэд буцаах/ бүхэлдээ, 323 дугаар зүйлийн /Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох/, 323.1.2-ын “...бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийх буюу шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлгүй байвал” гэсэн заалт, 350 дугаар зүйлийн /Хяналтын шатны шүүхийн шийдвэр/ 350.3.1, 352 дугаар зүйл /Тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах/ бүхэлдээ болон 353 дугаар зүйлийн /Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ/ 353.3-ын “Хяналтын шатны шүүхийн заалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхээр шинэчлэн хэлэлцэхэд заавал биелүүлнэ” гэсэн заалтууд нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээс яллах талын үүргийг гүйцэтгэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр хийж гүйцэтгэх үүргийг нь урьдчилан заасан төдийгүй заавал биелүүлэхийг шаардсан заалт тул Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана” гэсэн зарчмыг шууд зөрчиж байна.



Зүй нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд тухайн хүний үйлдэл, гэм буруу нь тогтоогдохгүй байвал аль ч шатны шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож тухайн хүнийг цагаатгах эсвэл нотлох баримтаар тогтоогдож байгаа хөнгөн ялтай үйлдэлд нь ял шийтгэх нь шударга ёс хийгээд Үндсэн хуульд нийцэх билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 30, 193, 195, 215 дугаар зүйлүүдэд гэмт хэргийг нотлох, яллах талаархи прокурорын эрх, үүргийг хангалттай заасан атал нэгэнт ялын дүгнэлтээ үйлдэж, улмаар хэргийг шүүхэд шилжүүлэн шүүх хуралдаан эхэлсний дараа тус хуулийн 239.4.2-т зааснаар улсын яллагч хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүгдэгчийг яллахаас татгалзаж, саналаа бичгээр гаргах төдийгүй уг саналыг нь шүүгч харгалзан үзэж хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн нь шүүх зөвхөн яллах талд үйлчилсэн, шүүгдэгч, өмгөөлөгч талын эрх, ашгийг бүрэн үгүйсгэсэн заалт болсноороо Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхэд шилжүүлсэн хэргийг шүүгч хянаад мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан үндэслэл байгаа тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаадаг билээ. Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх тухай шийдвэрийг гаргахад талуудыг заавал байлцуулах шаардлагагүй бөгөөд энэ нь Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл үгүй юм. Ер нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийн оролцогч талуудыг байлцуулахгүйгээр гаргадаг шийдвэрүүд олонтаа байдаг билээ. Түүнчлэн өргөдөл гаргагч нь өргөдөлдөө шүүгчийн гаргаж байгаа энэхүү шийдвэр нь Үндсэн хуулийн ямар зарчмыг зөрчиж байгаа талаар тодорхой дурдаагүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230.1.2 дахь заалтад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх, Шүүхийн тухай хуулийн 3.2 дахь хэсэгт шүүх нь хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн гэж заасан байдаг бөгөөд энэхүү хуулиар олгосон онцгой эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ шүүх хэргийг тал бүрээс нь нягтлан үнэн зөв, бодитой шийдвэрлэх нь зүй ёсны хэрэг билээ.

Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хийгдээгүй зарим ажиллагааг шүүх хуралдааны явцад нөхөн гүйцэтгэх боломжгүй тохиолдолд шүүх эдгээр ажиллагааг нэмж гүйцэтгүүлэхээр хэргийг буцааж байгаа нь Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэлгүй бөгөөд харин хэргийн талаархи бодит үнэнийг тогтоох зорилгоор хэрэгжүүлж байгаа шүүхийн үйл ажиллагаа болно. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүргийг шүүхэд ногдуулсан байдаг билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230.1.3 дахь заалтад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн бол хэргийг мөрдөн байцаалтад буцаахаар хуульчилсан нь Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Ер нь эрүүгийн хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах тухай хэм хэмжээ нь байцаан шийтгэх ажиллагааны явцад гаргасан алдаа дутагдлыг залруулах чухал зохицуулалт мөн бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн алдааг зөвхөн мөрдөн байцаалтад буцааснаар шийдвэрлэх боломжтой байдаг.

Учир нь Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй нь эх газрын эрх зүйн тогтолцооны мөрдөн шалгах хэлбэрийн процессын ажиллагаанд хамаардаг бөгөөд энэ

нь урьдчилсан мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэг гэсэн бие даасан үе шатуудад хуваагддаг билээ. Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад эрүүгийн байцаан шийтгэх хууль ноцтой зөрчигдсөн тохиолдолд уг алдааг мөрдөн байцаалтын шатанд буцаахгүйгээр шүүхийн хэлэлцүүлгийн шатанд залруулах боломжгүй юм. Энэ ч үүднээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тухай заалт нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зайлшгүй байвал зохих зохицуулалт юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230.1.4 дэх заалтад улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн бол шүүх хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар заасан нь Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл үгүй болно. Учир нь прокурор нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд яллах чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохынхоо хувьд хэргийн талаар бодитой, үнэн зөв шийдвэр гаргах зорилгоор хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаахаар шүүхэд хүсэлт гарган шийдвэрлүүлж байгаа хэрэг юм. Хэрэв прокурор хэргийн талаархи шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэр бодит үнэнд нийцэхгүй байх, ингэснээр хэргийн оролцогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөхөд хүрэх юм. Түүнчлэн прокурор нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн хариуцлагыг хүндрүүлэх бус хөнгөрүүлэх нөхцөл байдлыг ч мөн адил тогтоох үүрэгтэй байдаг билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар прокурор нь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцох үүрэгтэй бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239.4.2 дахь заалтад заасны дагуу шүүх хуралдааны явцад үүсэн бий болсон тодорхой нөхцөл байдалтай холбогдуулан шүүгдэгчийг яллахаас татгалзан хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцааж шалгуулах хүсэлт гаргах нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй билээ. Учир нь дээр дурдсанчлан прокурор нь яллах чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохынхоо хувьд ийнхүү хүсэлт гаргах нь хууль ёсны бөгөөд энэ нь шүүхийн шийдвэр бодитой, үнэн зөв байх нөхцөлийг хангахад оршино.

Иргэн Б.-гийн мэдээлэлдээ дурдсан 315.1.2, 318.2.3 дахь заалт, 322 дугаар зүйл, 323.1.2, 350.1.3 дахь заалт, 352.1, 353.3 дахь хэсэг нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахтай холбоотой зохицуулалт бөгөөд давж заалдах болон хяналтын шатны шүүх нь дээр дурдсан зүйл, заалтыг үндэслэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон анхан шатны шүүхийн үе шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн аливаа алдаа зөрчлийг арилгуулах боломжтой байдаг бөгөөд ингэснээрээ хэргийн оролцогчдын зөрчигдсөн эрхийг сэргээж, шүүхийн шийдвэр нь хууль ёсны байх зарчмыг хангадаг билээ.

Иргэн Б. нь мэдээлэлдээ прокурорын байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хүрээнд багтааж, шүүх хэргийг мөрдөн байцаалтад буцааж байгаа нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байна хэмээн дурджээ. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэг буюу Шүүх эрх мэдэл гэсэн бүлгийн Тавин зургадугаар зүйлд Прокурорын байгууллагыг оруулсан байдаг бөгөөд шүүх, прокурорын байгууллагууд нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч төрийн институт юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эрүүгийн хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах тухай зохицуулалт нь хүний эрх, эрх чөлөөг хөндсөн ямарваа асуудал гаргаагүй болохыг хууль хяналтын байгууллагууд давхар нотолж байгаа билээ.

### 3. Монгол Улсын ерөнхий прокурор А.-гийн тайлбарын агуулга:

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй” гэж заасныг удирдлага болгон шүүх хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шийдвэр гаргах нь тухайн хэргийг бодит үнэнийг тогтоох, зорилгоос үүдэлтэй болно.

Шүүх эрүүгийн хэрэгт ажиллагаа дутуу хийгдсэн гэж үзээд хэргийг дахин шалгуулахаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцааж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1.2, 230 дугаар зүйлийн 230.1, 250 дугаар 250.2, 315.1.2, 322 дугаар зүйл, 350 дугаар зүйлийн 350.1.3, 352 дугаар зүйлийн 352.1-д заасан хуулийн зохицуулалтыг зөвхөн яллах талын нотлох баримтуудыг нэмж хийлгүүлэхээр буцааж байгаа тул Үндсэн хуулийг зөрчсөн гэж өрөөсгөлөөр дүгнэж болохгүй бөгөөд шүүх цагаатгах талын нотлох баримтуудыг ч мөн нэмж шалгуулахаар буцаах эрхтэй.

2/ Прокурор хэдийгээр шүүх хуралдаанд яллах чиг үүрэгтэй оролцдог боловч Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 30 дугаар зүйл, 193 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 12, 15 дугаар зүйлүүдэд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ цагаатгах болон яллах нотлох баримтуудыг тал бүрээс нь үнэлж хэргийг хянах үүрэгтэй юм.

Түүнчлэн шүүх хуралдаанд яллах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хангалттай бус нотлох баримтанд үндэслэн шүүгдэгчийг яллах бус харин ч хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.2-т зааснаар саналаа бичгээр гаргах төдийгүй уг саналыг нь шүүгч хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн нь шүүх зөвхөн яллах талд үйлчилсэн, шүүгдэгч, өмгөөлөгч талын эрх, ашгийг бүрэн үгүйсгэсэн заалт болсноороо Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэх боломжгүй бөгөөд харин байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчигдөхөөс хамгаалах үүргээ хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл гэж үзэж байна.

3/ Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно” гэсэн заалттай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 353 дугаар зүйлийн 353.3-т “Хяналтын шатны шүүхийн заалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхээр шинэчлэн хэлэлцэхэд заавал биелүүлнэ” гэж заасан нь бүрэн нийцэж байна.

### 4. Монгол Улсын дээд шүүхийн тайлбарын агуулга:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны түүхэн уламжлалын талаар авч үзэж Улс орнуудын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь 5 хэв маягтай байдаг бөгөөд Монгол Улс “мөрдөн шүүх” хэв маягаар байцаан шийтгэх ажиллагаа явуулдаг.

1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар байцаан шийтгэх ажиллагаа нь хэв маягийн хувьд мөрдөн шүүх буюу мөрдөн шалгах шинжтэй байхаар хуульчлан бэхжүүлсэн бөгөөд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь дээрх хэв маягийн шинжтэй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа Монгол Улсад явагдахыг хуульчилж өгсөн. Тухайлбал, уг хуулийн 6 дугаар зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг тодорхойлохдоо “...аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, явдлыг хангахад оршино” гэжээ.

Онол арга зүйн хүрээнд авч үзвэл, мөрдөн шалгах хэв шинжтэй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь хэргийн бодит байдлыг тогтоох зарчмыг баримтлах бөгөөд энэ нь төрийн үүрэг гэж үздэг. Харин мэтгэлцүүлэн шүүдэг хэв шинжтэй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь хэргийн бодит үнэнийг тогтооход биш, харин процессын үнэнийг тогтооход оршдог. Чухам ийм учраас мэтгэлцүүлэн шүүдэг тогтолцоотой улс орнууд яллах нотлох баримтыг прокурор, цагаатгах нотлох баримтыг өмгөөлөгч цуглуулж, шүүх хуралдаанд өөртөө байгаа нотлох баримтаа гаргаж танилцуулах ба шүүх уг нотлох баримтыг хуульд заасан арга хэрэгслээр цуглуулсан эсэхэд үнэлгээ өгч, хэрэв нотлох баримтыг цуглуулахдаа хууль зөрчсөн гэж үзвэл хэргийг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэдэг онцлогтой.

Мэтгэлцүүлэн шүүх зарчмаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагддаг улс орнуудад иргэдийн төлөөлөл болсон тангарагтны шүүх нь шүүгдэгч гэм буруутай эсэхийг бие даан шийдвэрлэх ба харин мэргэжлийн шүүгч ял оногдуулах асуудлыг шийдвэрлэдэг нь бас нэг онцлог нь байдаг.

2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино” гэсэн нь дээрх хэв маягийг сонгосны илрэл бөгөөд...16 дугаар зүйлийн 16.1-д, 21 дүгээр зүйлийн 21.1-д, 80 дугаар зүйлийн 80.1-д, 95 дугаар зүйлийн 95.1-д “... прокурор, шүүх нь тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлж авсан бүх нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ”, мөн зүйлийн 95.2-т “... прокурор, шүүх нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэж зааснаараа шүүх мөн нотлох үүрэгтэйг давхар хуульчилж өгсөн.

Иргэн Б.-гийн мэдээлэлд дурдсан заалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн бусад заалттай харьцуулснаар:

Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын дээд шүүх бүрэн эрхийнхээ хүрээнд... хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ” гэсэн Үндсэн хуулийн заалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тухайлбал, 350, 352, 353 дугаар зүйлүүдэд улам тодотгон заасан юм.

Бодит байдлыг тогтоох зарчимд тулгуурлан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явагддаг буюу эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын шүүх нь хэрэгт цугларсан баримтыг бүх талаас нь бодит байдлаар хянан үзэх үүрэг хүлээдэг. Энэ үүргийн хүрээнд шүүх тухайлбал, хяналтын шатны шүүх нь хэрэг, маргааныг хянаж тухайн хэргийн бодит байдал хэрхэн тогтоогдсоноос хамаарч 4 төрлийн шийдвэр гардаг атал өргөдөл гаргагч Б.-гийн ойлголтоор, шүүх хэрэг маргааныг хянаж үзээд гэмт хэрэг үйлдсэн гэвэл шийтгэх тогтоол, эсвэл хэргийн байдал тогтоогдохгүй байна гээд тухайн хэрэгт холбогдож байгаа хүнийг цагаатгах тогтоол л гаргана гэж үзэж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь хэргийн бодит байдлыг тогтоох зарчмын дагуу явагдахыг хүлээн зөвшөөрсний нэг илрэл нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230, 271-277, 293, 296 дугаар зүйлийн 296.1, 318, 319, 321, 348, 353 дугаар зүйлийн 353.1-д заасан заалтууд юм. Тухайлбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 353 дугаар зүйлийн 353.1 зааснаар шүүх хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхдээ хэргийн бүх ажиллагааг бүрэн хянаж үзэх үүрэгтэй.

## Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:

1. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмын хүрээнд шүүхээс явуулж байгаа ажиллагаа гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ” гэж заажээ.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1.2, 230 дугаар зүйлийн 230.1.2, 230.1.3, 230.1.4, 239.4.2, 315 дугаар зүйлийн 315.1.2, 318 дугаар зүйлийн 318.2.3, 322 дугаар зүйл, 323 дугаар зүйлийн 323.1.2-ын “...бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийх буюу шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлгүй байвал” гэсэн заалт, 350 дугаар зүйлийн 350.1.3, 352 дугаар зүйл, 353 дугаар зүйлийн 353.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлаж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван зургадугаар зүйлийн 14-ийн “... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дээрх заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс... төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1.2, 230 дугаар зүйлийн 230.1.2, 230.1.3, 230.1.4, 239.4.2, 315 дугаар зүйлийн 315.1.2, 318 дугаар зүйлийн 318.2.3, 322 дугаар зүйл, 323 дугаар зүйлийн 323.1.2-ын “...бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийх буюу шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлгүй байвал” гэсэн заалт, 350 дугаар зүйлийн 350.1.3, 352 дугаар зүйл, 353 дугаар зүйлийн 353.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 1, 2, 3, Арван зургадугаар зүйлийн 14, Дөчин есдүгээр зүйлийн 1, Тавин зургадугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай”

## **Тэмдэглэл:**

Онолын хувьд мэтгэлцээний зарчмыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж байгаа нөхцөлд шүүх аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хөндлөнгийн байр сууриас хандаж, нотлохын төлөө бус зөвхөн яллах, өмгөөлөх талын гаргасан нотолгоонд үндэслэн маргааныг шийдвэрлэдэг байх ёстой. Иргэний процессийн хувьд энэ хандлага хэрэгжиж байгаа ч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж байгаа нь “мөрдөн шүүх” болон “мэтгэлцүүлэх” зарчмыг хослуулан хэрэгжүүлж байгаа хэлбэр юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.11.16 № 11**

### **Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн У., Т., Б., С., О.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д., М., Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай” хууль<sup>96</sup>

- 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг “Улсын Их Хурал олон мандаттай тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн санал авах өдрөөс зургаан сараас доошгүйн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно”

- 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг “Тойрог байгуулах хүн амын тооны улсын дундажийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно”

- 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэг “Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит болон түүний бүрэн эрхийн хугацаан дахь нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд орохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ”

- 25 дугаар зүйлийн 25.10 дахь хэсэг “Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд түүний энэ хуулийн 25.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 25.6-д заасан төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг бүхэлд нь тарсан гэж үзнэ.

- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг “Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 29.1-д заасан сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байна”

96 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

- 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэг “Нам, эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно”

- 37 дугаар зүйлийн 37.11.3 дахь заалт “нам, эвслээс нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах”

- 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэг “Сонгогч нь саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүсч байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг хайрцагт хийнэ”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө”

- Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”

- Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”

- Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн У., Т. нарын мэдээллийн агуулга:

1/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2-т “Улсын Их Хурал олон мандаттай тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн санал авах өдрөөс зургаан сараас доошгүйн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно”, мөн зүйлийн 4-т “Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно” гэж заасан нь Улсын Их Хурлын гишүүд тодорхой, харьцангуй тэнцүү тооны сонгогчдын мандаттай байх, сонгогч нэг л элчийг төлөөллөө болгон сонгох, сонгогч, нэр дэвшигчдийн алинд ч давхардал гаргахгүйгээр нийт сонгогчдын элч байх зарчмыг гажуудуулсан гэж үзэж байна. Сонгогчдод аймаг, нийслэлд амьдарч байгаагаар нь ялгавартай хандаж, шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулж сонгогчдын Улсын Их Хуралд өөрийн элчийг сонгох эрхийг хясан боогдуулж, өөрийн сонгосон элчээс гадна хоёроос дээш хүнийг заавал сонгох албадлагыг бий болгосон байна. Дээрх заалтууд нь элч нар сонгогчдоо, сонгогчид элч нартаа ялгавартай хандан сөргөлдөх зэрэг сөрөг үр дагавартай байж болохыг үгүйсгэхгүй байна.

2/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25-р зүйлийн 9-д “Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит болон түүний бүрэн эрхийн хугацаан дахь нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд орохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ” мөн зүйлийн 10-т “Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд түүний энэ хуулийн 25.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 25.6-д заасан төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг бүхэлд нь тарсан гэж үзнэ” гэж заасан нь эвсэлд нэгдээгүй намууд өрсөлдөгчөө шахах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, цөөнхийг хүндэтгэх, олонхийн шийдвэр давуу байх ардчилсан, шударга ёсны зарчмыг алдагдуулж байна.

3/ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2-т “Бие даан нэр дэвшүүлэгч нь энэ хуулийн 29.1-д заасан сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байна” гэж заасан нь бие даан нэрээ дэвшүүлэгч нь 801 сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байхаар хуульчилж, харин 76 нэр дэвшигчийг тойргуудад томилж эрх бүхий нам байгуулах үйл явцад шаардагдах 801 хүний гарын үсгийг цуглуулахад тавигдах ямар ч саад шалгуур байхгүй байгаа нь намаас нэр дэвшигч иргэн хүнд илүү эрх олгож, бие даан нэрээ дэвшүүлэгч иргэн хүний эрхийг дордуулж, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, иргэний нийгмийн иргэн давуутай байх зарчмыг алдагдуулан нам төвтэй хуучны тогтолцоог сэргээх хандлагад чиглэсэн гэж үзэж байна. Мөн бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчийн дэмжлэг авахдаа тойргийн сум бүрийн, тойргийн хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулна гэж хүндрэл учруулсан нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх зарчмыг алдагдуулж байна.

4/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3-д “Нам эвслээс нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно”, 37 дугаар зүйлийн 11-ийн 3-т “Нам, эвслээс нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахыг хориглоно” гэж заасан нь нэр дэвшигч иргэн хүний итгэл үнэмшил, үзэл бодол, эрх, эрх чөлөө, тэгш байдлыг нэгэн хэвд цутгаж, намын мөрийн хөтөлбөрөөс дорд үзсэн нь хүний эрх



чөлөө, тэгш байдлыг алдагдуулж, шударга ёс, иргэний үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхсан, иргэний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхэд халдсан заалт болсон байна. Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч байж нийт сонгогчид, улс орны нийтлэг эрх ашгийг эрхэмлэхийн оронд зөвхөн нэрийг нь дэвшүүлсэн намын төлөөлөл байхаар эрхийг нь хязгаарласан байна. Дэвшүүлсэн намынхаа мөрийн хөтөлбөрийг дэмжин сурталчлахыг үгүйсгэх аргагүй ч тухайн тойргийн иргэд сонгогчдын ашиг сонирхол, санаа бодлыг үл тоомсорлон үгүйсгэх нь учир дутагдалтай юм.

5/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 3-т “Сонгогч нь саналын хуудаст бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүсч байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг хайрцагт хийнэ” гэсэн нь сонгогчдын төрийг удирдах төлөөллийн байгууллагад өөрийгөө төлөөлөх элчийг сонгох эрхийг хязгаарлаж, элч нарыг сонгохыг тулгаж, хэрэв нэг төлөөлөгчөө сонговол сонгуулийн хуудас нь хүчингүй болохоор байгаа нь ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөөний зарчмыг алдагдуулсан, сонгогчийн чөлөөтэй сонгох, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон Үндсэн хуулийн зарчмыг алдагдуулсан байна. Ийнхүү Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд нь дээрх үндэслэлүүдээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, 3 дугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 10, Арван есдүгээр зүйлийн 1, 2, 3, Хорин нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Иргэн Б., С., О. нарын мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Улсын Их Хурал олон мандаттай тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн санал авах өдрөөс зургаан сараас доошгүйн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно”, 12.4-т “Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно”, 29 дүгээр зүйлийн 29.2-т “Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 29.1-д заасан сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байна”, 47 дугаар зүйлийн 47.3-т “Сонгогч нь саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүсч байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотойтэнцэх нэр дэвшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг хайрцагт хийнэ” гэсэн зүйл, заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван есдүгээр зүйлийн 1, Хорин нэгдүгээр 2, 3, Хорин гуравдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д., Б., М. нарын тайлбарын агуулга:

1/ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.4-т зааснаар Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулж байгаа нь иргэдийн сонгох эрхийг хэрэгжүүлэх үүднээс тэднийг сонгуульд санал өгөх ажиллагааг зохион байгуулалтын талаас нь зохицуулсан эрх зүйн харилцаа юм. Улсын Их Хурлын гишүүн нь зөвхөн тойргийн сонгогчдын эрх ашгийг бус Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталдаг билээ. Иймээс хуулийн дээрх заалтууд нь нийт сонгогчдын элч байх зарчмыг гажуудуулсан, түүнчлэн аймаг, нийслэлд амьдарч байгаагаар нь ялгавартай хандаж шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан хэрэг биш юм.

2/ Аливаа улс төрийн намуудын гол зорилго нь өөрсдийн /үзэл баримтлал/ мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог олж авахын тулд сонгуульд оролцож Засгийн эрхийг авах явдал байдаг. Тийм ч учраас “улс төрийн нам” гэдгийг энэ утгаар нь тодорхойлдог. Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Улс төрийн намын тухай хуулийн 4.1-д “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж тодорхойлсон бөгөөд энэ ч утгаараа мөн хуулийн 12.1-д зааснаар улс төрийн нам нь Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байхаар заасан.

Өөрөөр хэлбэл, аливаа улс оронд явагддаг ардчилсан сонгуулийн загвар нь сонгогчид намд тодорхой хугацаанд засгийн эрх мэдлийг сонгуулиар өгснөөр илэрхийлэгддэг бөгөөд улс төрийн намууд ч энэхүү эрх мэдлийн төлөө өрсөлддөг. Хэрэв тэд сонгогдохын төлөө байгаа л бол зөвхөн сайн, шилдэг хүмүүсийг нэр дэвшүүлэхээс гадна сайн хөтөлбөртэй байх нь гол бөгөөд үүгээрээ сонгогчдын итгэлийг олж авах гол үндэслэл нь болдог. Тийм ч учраас Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “...Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх асуудлыг” намын их хурал, эсхүл намын их хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага нь шийдвэрлэхээр заасан.

Нөгөө талаар улс төрийн намуудын өөр хоорондын харилцаа, хамтын үйл ажиллагаа, улс төрийн бодлого, хөтөлбөр дээр зөвшилцөх чадвар нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Хамтын ажиллагааны нэгэн хэлбэр нь сонгуульд эсвэл байгуулж хамтран нэг мөрийн хөтөлбөртэй оролцох явдал байдаг. Улсын Их Хурлын тухай хуулийн 25.9 дэх заалт буюу “Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит болон түүний бүрэн эрхийн хугацаан дахь нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцох бөгөөд эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх”-ийг хориглосон явдал нь уг хуульд оруулсан эрх зүйн шинэ зохицуулалт биш бөгөөд 1992 онд баталсан Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар зохицуулж ирсэн харилцаа юм. Харин хуулиар зохицуулалт байхгүйгээс практик амьдрал дээр гарч байгаа ойлгомжгүй нөхцөл байдлыг тодорхой болгох, түүнчлэн бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагын үүднээс эвсэлтэй холбогдсон бусад харилцааг /тухайлбал, 25.10/ зохицуулахаар тусгасан юм.

Дээр дурдсан үндэслэлээр хуулийн 25.9, 25.10 дахь хэсгийн заалтууд нь эвсэлд нэгдээгүй намууд өрсөлдөгчөө шахах, өөрсдөдөө давуу байдал бий болгох зорилгоор намуудын эвслийг тараах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, цөөнхийг хүндэтгэх, олонхийн шийдвэр давуу байх ардчилсан, шударга ёсны зарчмыг алдагдуулж байгаа хэрэг бус харин ч сонгуульд нэгэнт эвсэл байгуулж хамтран нэг мөрийн хөтөлбөртэй оролцож түүнийгээ сонгогчдод хүргэж танилцуулсан л бол тухайн бүрэн эрхийн хугацаанд сонгогчдын өмнө хүлээсэн тэр л үүргээ хүлээх хариуцлагын асуудлыг хөндсөн хэрэг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хэмжээнд байгаа нийт сонгогчдын эрх ашгийн үүднээс хандсан эрх зүйн зохицуулалт гэж үзэж байна.

3/ Улс төрийн намын тухай хуулийн 9.3.7-д зааснаар намыг үүсгэн байгуулахад 801-ээс доошгүй гишүүний бүртгэлтэй байх шаардлага тавигдсан бөгөөд мөн хуулийн 5.1.6-д зааснаар нам үйл ажиллагаагаа нутаг дэвсгэрийн зарчмаар явуулдаг. Мөн хуулийн 11.2.8-д зааснаар “сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох” асуудлаа нам өөрийн дүрмээрээ зохицуулахаар хуульчилсан билээ. Өөрөөр хэлбэл, намаас нэр дэвшигч нь 801-ээс доошгүй гишүүнчлэлтэй, нутаг дэвсгэрийн зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг улс төрийн намаас нэр дэвшиж байгаа гэсэн үг. Нам нь ийнхүү нутаг дэвсгэрийн зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг тул сонгогчийн төлөөллийг илүү хангасан байх магадлалтай. Улс төрийн намын тухай хуульд заасан

эдгээр заалт нь эцсийн эцэст улс төрийн үйл ажиллагаа явуулах эцсийн зорилготой / сонгуульд оролцох/ намын эрх ашиг гэхээсээ илүү сонгогч, иргэний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Харин сонгуульд бие даан нэр дэвшигчид сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байхаар заасан нь дээрх нэгэн адил сонгогч иргэдийн эрх ашгийг илүүтэйд үзсэн хэрэг юм. Аливаа сонгох томилох албан тушаалтанд хуулиар тодорхой хязгаарлалт тогтоож болох бөгөөд харин нийт сонгогч иргэдийн эрх, эрх чөлөөг хохироож болохгүй юм. Иймд тухайн тойргийн нийт сонгогчдын эрх ашгийг дээгүүр тавих зайлшгүй хүчин зүйлс байгаа тул Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй болно.

4/ Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д зааснаар улс төрийн намын Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх асуудлыг намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага нь шийдвэрлэдэг. Нэгэнтээ нэр дэвшигч нь тухайн намын үзэл бодол, мөрийн хөтөлбөрийг дэмжиж намаас нэр дэвшихийг өөрөө хүлээн зөвшөөрч байгаа тул өөр мөрийн хөтөлбөр бие даан гаргах боломжгүй. Тэгээд ч бие даан нэр дэвшигч, намаас нэр дэвшигчийн гол зарчмын ялгаа нь энэ асуудалдаа байдаг.

5/ Төрийн элчийг бүх нийтээр сонгох зарчим нь сонгуульд сонгуулийн насны бүх иргэдийг бүрэн оролцуулах тухай асуудал юм. Гэхдээ амьдрал дээр бүх иргэнийг оролцуулах боломж байдаггүй бөгөөд зарим хязгаарлалтыг хуулиар тогтоосон байдаг. Тухайлбал, сонгуульд зөвхөн насанд хүрсэн иргэн оролцох, түүнчлэн иргэний харьяаллын, оршин суугаа газрын, эрх зүйн чадамжийн гэх мэт тодорхой хязгаарлалтуудыг тогтоосон.

Харин чөлөөтэй сонгох эрх чөлөөг хангах нь сонгуулийн зарчмуудын нэг бөгөөд энэ нь хууль зүйн хувьд иргэд сонгуульд заавал оролцох үүрэг, хариуцлага хүлээхгүй байх тухай ойлголт. Өөрөөр хэлбэл, сонгуульд оролцох, эсхүл оролцохгүй байх нь сонгогчийн өөрийн дурын асуудал гэж үздэг. Иймээс Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-ын “Сонгогч нь саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүсч байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг хайрцагт хийнэ” гэсэн заалт нь нийтээр, чөлөөтэй сонгох, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон заалт болох үндэслэл болохгүй, харин сонгогчийн саналаа илэрхийлэхийг арга зүйн талаас нь зохицуулсан асуудал гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 2 дугаар дүгнэлтээр “Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна” гэсэн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна” гэж шийдвэрлэжээ. 2006 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн цэцийн өмнө шийдвэрлэсэн маргаантай агуулгын хувьд ижил байна. Өөрөөр хэлбэл уг маргааны талаар Үндсэн хуулийн цэцийн урьд гаргасан дүгнэлт хүчинтэй байна.

Харин Улсын Их Хурал олон мандаттай тойрог байгуулахдаа Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэхээр хуульчилсан нь тус байгууллагын чиг үүрэгт хамаарч байна гэх үндэслэлтэй юм. Сонгуулийн ерөнхий хороо нь Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг улс даяар зохион байгуулж явуулах чиг үүрэгтэй байгууллага болно.

2. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Тойрог байгуулах хүн амын тооны улсын дунджийг аймаг, нийслэлд ялгавартайгаар тогтооно” гэсэн нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэсэн заалтын, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т “Бие даан нэр дэвшүүлэгч нь энэ хуулийн 29.1-д заасан сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойрогт хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байна” гэсэн нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол бүх ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн заалтын агуулгад тус тус нийцэж байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1-д нам, эвсэл нь тухайн сонгуулийн дүнд бий болохоор заасан бөгөөд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.9, 25.10 дахь хэсгийн заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Улс төрийн нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн иргэдийн нэгдэл байдаг. Аливаа намын үндсэн зорилго нь парламентад олонхи болж, өөрийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадамжийг бүрдүүлэх явдал юм. Иймд Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигчийг тухайн нам, эвслийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан мөрийн хөтөлбөртэй байхыг хориглохоор заасан нь Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

5. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн заалт нь сонгогчийг санал өгөхийг албадсан, түүнчлэн тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцэх нэр дэвшигчийн нэрийг огт дугуйлаагүй буюу бүрэн тэмдэглээгүй тохиолдолд уг саналын хуудас хүчингүй болно гэсэн агуулгыг илэрхийлэхгүй байна.

Дээрх заалтад мандатын тоотой тэнцэх хэмжээний нэр дэвшигчдийн нэрийг дугуйлахаар хуульчилсан ч энэхүү шаардлагыг биелүүлээгүйгээс тухайн саналын хуудас хүчингүй болох үр дагавар үүсэхгүй болох нь уг хуулийн 48 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зохицуулалт болон 49 дүгээр зүйлд заасан саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэлээр нотлогдож байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 2 дугаар тогтоолоор сонгогч саналын хуудсанд огт тэмдэглэл хийгээгүй тохиолдолд түүнийг хүчингүйд тооцох тухай зохицуулалтыг хүчингүй болгосон бөгөөд энэ нь ч 2006 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тусгагдсан гэх үндэслэлтэй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 4, 25 дугаар зүйлийн 25.9, 10, 29 дүгээр зүйлийн 29.2, 36 дугаар зүйлийн 36.3, 37 дугаар зүйлийн 37.11.3, 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 10, Арван есдүгээр зүйлийн 1, 2, 3, Хорин нэгдүгээр зүйлийн 2, Хорин гуравдугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Тэмдэглэл:**

Шүүх маргааныг хянан шийдвэрлэхдээ өмнө гаргасан буюу хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэл болгох жишгийг Цэц дүгнэлт гаргахдаа мөрдлөг болгосон. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг жишиг болгон шийдвэр гаргах явдал эрх зүйн онолын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт бөгөөд тэр тусмаа Үндсэн хуулийн шүүх агуулгын хувьд адил маргаанд ийм жишиг тогтоох нь шийдвэрийн уялдаа холбоог тогтооход чухал ач холбогдолтой. Сонгуулийн эрх зүйн үндсэн 5 зарчим байдаг. Нийтээрээ, чөлөөтэй, нууцаар сонгох, тэгш, шууд сонгох гэсэн суурь зарчмаас Үндсэн хуульд “тэгш” байдлын зарчмаас бусдыг нь хуульчлан баталгаажуулсан. Энэ нь ч санамсаргүй хэрэг бус. Учир нь тэгш байдлын зарчим гэдэгт сонгогч зөвхөн нэг л саналын эрхтэй байхыг ойлгодог.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2007.11.28 № 12**

**Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг  
хянан хэлэлцсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>97</sup>

- 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг “чуулган нь нэгдсэн хуралдаан, байнгын хороодын дагнасан буюу хамтарсан түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ”

**Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ”

- Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна”

97 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 8-д нийтлэгдсэн

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Чуулган нь нэгдсэн хуралдаан, байнгын хороодын дагнасан буюу хамтарсан түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас тус тус бүрдэнэ” гэж заасан нь дор дурдсан байдлаар Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ”, Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна” гэж тус тус заасан байдаг. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь ийнхүү Үндсэн хуульд заасны дагуу хууль тогтоох онцгой бүрэн эрхээ “чуулган” гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрээрээ хэрэгжүүлж байдаг бөгөөд харин чуулган /ээлжит/ нь хагас жилдээ нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулах талаар заасан байна.

Уг заалтад “Улсын Их Хурал чуулна” гэж заагаагүй байх бөгөөд харин “Улсын Их Хурлын чуулган... чуулна” гэж түүний зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг тодотгож заасан нь ихээхэн анхаарал татаж байдаг юм. “Чуулна” гэдэг үг нь өөрөө цуглана, хуралдана гэсэн үгнүүдтэй ижил утгыг илэрхийлж байдаг бөгөөд эдгээр утгын хүндэтгэсэн илэрхийлэл юм. Тиймээс “чуулган чуулна” гэснийг “чуулган хуралдана, өөрөөр хэлбэл чуулганы хуралдаан болно” гэж ойлгож болох юм.

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын зохион байгуулалтын үндсэн хэлбэрийг “чуулган” гэж нэрлэж байхаар тогтоосон бөгөөд уг зохион байгуулалтын хэлбэрийн заавал хуралдах өдрийн доод хязгаарыг тодорхой зохицуулан заажээ. “Чуулган” нь Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлдэг үндсэн хэлбэрийн хувьд зохион байгуулалтын бусад хэлбэрүүдээсээ ялгаатай байдаг. Тийм ч учраас Үндсэн хуулийн холбогдох заалтад “...чуулган ...чуулна” хэмээн зохион байгуулалтын бусад хэлбэрээс тодотгон заасан нь санамсаргүй орсон заалт биш бөгөөд Монгол Улсын Их Хурлыг байнгын ажиллагаатай парламент болгосон ихээхэн үнэ цэнэтэй заалт юм.

Чуулганы үйл ажиллагааны хэлбэр нь олноороо хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэдэг ардчилсан зарчимд тулгуурласан хуралдаан л байдаг учраас чуулган ба түүний хуралдаан /чуулганы хуралдаан/ гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаагүй нэг л ойлголт гэж үзэж байна. Иймд Улсын Их Хурлын гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болдог чуулган гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрт зохион байгуулалтын бусад хэлбэрийг багтаах болсон Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг шууд утгаараа зөрчиж байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн уг заалтад заасны дагуу байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуралдсан нь чуулганы үйл ажиллагааны нэг хэсэг болж улмаар тухайн өдөрт чуулган чуулснаар /хуралдсанаар/ тооцуулах болсон нь чуулганы заавал чуулах /хуралдах/ өдрийн доод хязгаарыг заасан Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна”, мөн уг зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы... хуралдааныг гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж...” гэсэн заалттай агуулгын хувьд нийцэхгүй байна.

“Байнгын хороо”-ны хуралдаан нь чуулган гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрийн нэг бүрэлдэхүүн болж, Улсын Их Хурлын тухай хуульд хуульчлагдсан нь байнгын хороо Улсын Их Хурлын бие даасан зохион байгуулалтын хэлбэр байх тухай Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал үйл ажиллагааныхаа зохих салбар чиглэлээр байнгын хороодтой байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ийнхүү Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

“Чуулган нь нэгдсэн хуралдаан, байнгын хорооны дагнасан буюу хамтарсан түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ” хэмээн зааснаас улбаалж “чуулганы нэгдсэн хуралдаан” гэсэн ойлголт бий болсон бөгөөд цаашлаад “чуулганы байнгын хорооны хуралдаан”, “чуулганы нам, эвслийн бүлгийн хуралдаан” гэсэн ойлгомжгүй нэр, томъёо үүсэх нөхцөл байдал бий болоод байгаа юм. Улсын Их Хурлын “...байнгын хороо”-ны хуралдаан, Улсын Хурал дахь нам, эвслийн бүлгийн хуралдаан гэж байхаас чуулганы байнгын хорооны хуралдаан, чуулганы нам, эвслийн бүлгийн хуралдаан гэсэн ойлголт байдаггүй билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд байнгын хороо гэсэн Улсын Их Хурлын зохион байгуулалтын бие даасан хэлбэр байх талаар заасан бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг нь зөвхөн Улсын Их Хурал тогтоож байхаар заасан байна. Нам, эвслийн бүлгийн хуралдаан нь чуулганы нэг хэсэг болсноороо нам, эвслийн бүлэгт харьяалагддаггүй гишүүдийн эрх ашиг хөндөгдөж байгаа бөгөөд тухайлбал Үндсэн хуульд заасны дагуу тодорхой хугацаанд чуулах /хуралдах/ ёстой чуулганы ажиллагаанд /хуралдаанд/ бүрэн гүйцэд оролцох боломжгүй болж байгаа юм. Анхны Улсын Их Хурлын тухай хуулиудад “байнгын хороодын хуралдааныг чуулганы ажиллагаанд тооцно” гэж зааж байсан бол 2001, 2006 онуудад шинэчлэгдэн батлагдаж гарсан Улсын Их Хурлын тухай хуульд байнгын хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаан нь чуулганы бүрэлдэхүүн байх тухай заасан байна. Тухайн үеийн Улсын Их Хурлын холбогдох заалт нь өөр хоорондоо адилгүй найруулагдсан байх боловч байнгын хороо болон нам, эвслийн бүлгийн хуралдааныг чуулганы үйл ажиллагаанд, өөрөөр хэлбэл чуулган чуулсанд /хуралдсанд/ тооцуулж байгаагаараа ижил агуулгатай юм”

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх аливаа асуудлаар байнгын хороо, нам, эвслийн бүлэг өөрийн байр сууриа илэрхийлж санал, дүгнэлт гаргах эрхтэй байдаг. Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг ийнхүү парламентын зохион байгуулалтын бүтцэд оруулсан нь манай улсад 1990 оноос эхэлсэн ардчилсан эрх зүйт төрийн тогтолцооны зарчмыг хэрэгжүүлж улмаар Үндсэн хуульдаа батлан тунхагласан юм. Өөрөөр хэлбэл нам төвтэй төрийн байгуулалтаас ардчилсан төрийн байгуулалтад шилжин Улсын Их Хурлыг ард түмний нэрийн өмнөөс төрийн эрхийг барьж тус орны гадаад, дотоод бодлогын үндсийг тогтоож буй төрийн эрх барих дээд байгууллага мөн гэж тогтоож өгсөн.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байдаг. Иймд Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг тухайн нам, эвслийн бүлгээс нэр дэвшин сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдээс бүрддэг бөгөөд Улсын Их Хуралд сонгогдоогүй гадуур байгаа хүчин төрийн бодлогыг тодорхойлохгүй.

Хоёрт нам, эвслийн бүлэг зөвхөн санал, дүгнэлт гаргах бөгөөд шийдвэрийг Улсын Их Хурал гаргадаг юм.

Иргэн А. “чуулган” гэдэг нь “хуралдаан” байна гэсэн үндэслэлийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байна. Улсын Их Хурал буюу парламентын үйл ажиллагааны гол чухал хэлбэр бол “хуралдаан” бөгөөд асуудлыг цөөнхийн саналыг харгалзан олонхийн санал хурааж шийдвэрлэдэг. Улсын Их Хурал өөрөө 76 гишүүнээс бүрддэг. Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1-д “Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна” гэж заасан. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган буюу “хуралдаан” гэсэн хэлбэрээр хэрэгжүүлнэ. Байнгын хороо, нам, эвслийн бүлэг гишүүдээс бүрдэнэ. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд хуралдана гэсэн үг юм.

Улсын Их Хурал чуулганаараа төрийн гадаад, дотоод бодлогын, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн, төрийн байгуулалтын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхдээ хуралдахаас гадна Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцүүлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын ажилтай танилцах, иргэдийг хүлээн авч уулзах, хүсэлтийг нь сонсож холбогдох арга хэмжээ авах зэргээр олон төрлийн асуудлыг шийдвэрлэдэг болно.

Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын чуулган бол хуралдаанаас гадна байнгын хороо, Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг нэгэн адил хамаардаг цогцолбор ойлголт юм. Нам, эвслийн бүлэг нь Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр бөгөөд Улсын Их Хурлын бүтцэд хамаарч байдаг тул түүний эрх, үүрэг, үйл ажиллагааны зохион байгуулалтын бусад асуудлыг нэгэн адил Улсын Их Хурлын тухай хуулиар зохицуулж байдаг. Тийм ч учраас эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй байхаар хуульчлан заасан. Бүлэг нь байнгын хороотой адил хуралдаан хийж байж төсөл болон бусад асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зэргээр тодорхой эрх, үүрэгтэйгээр ажилладаг тул аливаа чуулган зарлагдсан хугацаанд нам, эвслийн бүлэг тодорхой цаг хугацаанд хуралдаанаа хийх шаардлагатай байдаг.

Энэ утгаараа Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг гишүүдийн үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгож Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, ... зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасантай нийцнэ гэж үзэж байна”

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж зааснаас үзэхэд “чуулган” нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр болох нь тодорхой байна. Энэ нь ч Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т нэгэн адил хуульчлагджээ.

Аливаа улс төрийн намын зорилго нь сонгуульд дангаар буюу хамтран /эвсэл/ оролцож өөрийн дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадамж бүхий суудлыг парламентад бүрдүүлэх явдал байдаг. Түүнчлэн “нам, эвслийн бүлэг” гэх Улсын Их Хурлын зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Үндсэн хуульд хуульчилснаас гадна нам, эвслийн бүлэг нь зөвхөн тухайн сонгуулийн дүнд бий болж болохоор зохицуулсан байна. Нам, эвслийн бүлгийг Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслээс ийнхүү Үндсэн хуулиар ялгамжтайгаар хуульчилсан нь парламентат ёсны мөн чанар, парламентын намууд болон түүний эрх хэмжээ, чиг үүрэгтэй салшгүй холбоотой юм.



Монгол Улсын Үндсэн хуульд олон намын тогтолцоонд үндэслэсэн байнгын ажиллагаатай парламентын үндсийг бий болгосон бөгөөд Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэр болох “чуулган”-д нам, эвслийн бүлгийн хуралдааныг хамаарахгүй гэсэн үзэл баримтлал илэрхийлэгдэхгүй байна. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтцэд нэгэнт хамаарч байгаа тул түүний хуралдааныг чуулганы бүрэлдэхүүнд оруулсан нь үндэслэлтэй байна.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Чуулган нь... түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх,.. нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ”, 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Чуулган нь ... түүнчлэн нам, эвслийн бүлгийн хуралдаанаас бүрдэнэ” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Чуулганы үйл ажиллааны хэлбэр нь олонхиороо хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэдэг ардчилсан зарчимд тулгуурласан хуралдаан байдаг учраас чуулган ба түүний хуралдаан гэх ойлголтууд нь ялгаагүй нэг л ойлголт гэж үзэж болно. Улсын Их Хурлын олонхи нь хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болдог чуулган гэсэн зохион байгуулалтын үндсэн хэлбэрт зохион байгуулалтын бусад хэлбэрийг багтаах болсныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх нь учир дутагдалтай.

Нам, эвслийн бүлэг хуралдахгүй, байнгын хороогоор асуудлыг урьдчилан хэлэлцэхгүйгээр Улсын Их Хурлын чуулган хуралдах боломжгүй. Нөгөө талаас Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн бүлэг эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцдаггүй. Нам, эвслийн бүлэг нь байнгын хороотой адил хуралдаан хийх байдлаар төсөл, бусад асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зэргээр тодорхой эрх, үүрэгтэй ажилладаг тул чуулган чуулах хугацаанд эдгээр зохион байгуулалтын бүтцүүд хуралдаан хийх шаардлагатай байдаг. Мөн Үндсэн хуульд нам, эвслийн бүлэг гэх зохион байгуулалтын бүтцийг хуульчилснаас гадна нам, эвслийн бүлгийг зөвхөн тухай сонгуулийн үр дүнд бий болохоор зохицуулсан байдаг.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007.12.21 № 13

### Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 14-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль

- 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг “... дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй”
- 347 дугаар зүйлийн 347.5 дахь хэсэг “... эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол... эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэнэ”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”
- Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”
- Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Б., Э. нарын мэдээллийн агуулга:

1/ 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь урьд өмнө прокуророос төрийн бүхий л байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавих эрхтэй байсныг халж, зөвхөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаа, мөн ял эдлүүлэх ажиллагаанд тус тус хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэгтэйг хуульчлан бэхжүүлсэн юм. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Прокурорын байгууллагын тухай, Эрүүгийн байцаан шийтгэх болон Шүүхийн тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдаж, уг хуулиудыг Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцүүлж прокурорын чиг үүргийг улам тодорхой болгосон зарчмын заалтууд орсон юм. Прокурорын байгууллагаас хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалтай хэрхэн харилцах тухай заалтуудыг Прокурорын байгууллагын тухай хуулийн 19-23 дугаар зүйлүүдэд тодорхой тусган зохицуулсан болно. Тухайлбал, уг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Улсын ерөнхий

прокурор Улсын дээд шүүхийн хяналтын журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоолд хуульд харшилсан гэж үзвэл санал гаргана”, 23 дугаар зүйлийн 23.4-д “Улсын ерөнхий прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай баримт илэрвэл түүнийг шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхэд шилжүүлнэ”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор шүүх хуралдаанд оролцох чиг үүргээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эсэргүүцэл бичнэ” гэж;

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д “... улсын яллагч... хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл гаргах эрхтэй”, 347 дугаар зүйлийн 347.2-д “Энэ хуулийн 347.1-д заасан тогтоол хуульд харшилсан гэж үзсэн Улсын ерөнхий прокурор эсхүл Улсын дээд шүүхийн шүүгчийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан тохиолдолд хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан хэлэлцэнэ”, Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргавал хэрэг маргааныг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус заасан юм. 1992 оны Үндсэн хуульд Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, ...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээн тунхаглахын учир мөн нөгөө талаар дээр нэр дурдсан хуулийн заалтууд хүчин төгөлдөр үйлчилж нийгмийн харилцааг зохицуулж буйг үл харгалзан Улсын Их Хурлаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342, 347 дугаар зүйлд өөрчлөлт оруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн зарчимтай шууд зөрчилдөж байна.

2/ Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдах бөгөөд яллах тал нь прокурор, харин өмгөөлөх, цагаатгах тал нь шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч, түүний төлөөлөгч байна. Мөн талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна хэмээн зохицуулсан. Ийм ч учраас 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хяналтын шатны шүүхийн тогтоол хуульд харшилсан гэж үзвэл талууд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хандаж эрх тэгш байх зарчмынхаа дагуу өмгөөлөгч гомдлоо гаргаж, харин шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсон прокурор буюу улсын яллагч эсэргүүцэл бичиж болох ба уг асуудлаар гагцхүү Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан тохиолдолд хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр хянан хэлэлцдэг байв. Гэтэл 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг дүгнэлт гаргасан, эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэнэ” гэсэн заалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.5-д оруулсан байна. Энэхүү заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчиж байна.

3/ 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь засаглалын хуваарилалтыг нарийвчлан тогтоосны зэрэгцээ шүүх, шүүгчийн хараат бус байдлыг хангах явдлыг хуульчлан бэхжүүлсэн юм. Тухайлбал, “шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд... давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” гэсэн заалтуудыг Монгол Улсын Үндсэн хуулийн 49, 50 дугаар зүйлд хуульчлан заасан. Мөн Эрүүгийн байцаан

шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1, 347 дугаар зүйлийн 347.5-д зааснаар улсын яллагчаас гадна эрх зүйн байдал нь тодорхой бус “прокурор” гэх албан тушаалтан шүүн таслах ажиллагаанд оролцож, эсэргүүцэл бичих болсон нь нэг талаас хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож, нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр хэргийг шийдвэрлэдэг шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн үйлдэл төдийгүй, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож буй илрэл гэж үзэхээс өөр аргагүй. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д “... дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй”, 347 дугаар зүйлийн 347.5-д “эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол эсэргүүцэл бичсэнээс..” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

4/ Эрх зүйн түүхийг эргэн харвал социалист төр нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн тусгай байгууллагаар дамжуулж, төрийн бүхий л байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд ерөнхий болон тусгай хяналт тавьж байв. Энэхүү хяналтын тогтолцоо өмнөх Үндсэн хуулиудад хуульчлан бэхжүүлсэн нь түүх болон үлдсэн. Тухайлбал, 1940, 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулиудад прокурорын дээд болон ерөнхий хяналтыг хуульчилсан бөгөөд уг хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд прокурор төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж байсны нэгэн адил шүүх өөрийн гаргасан шийдвэрээ прокурорт хүргүүлж зохих шатны хэн нэгэн прокурор уг шийдвэрийг хянан үзсэний үндсэн дээр эсэргүүцэл бичиж, тухайн эсэргүүцэл эрх зүйн хувьд үндэслэлтэй эсэхийг үл харгалзан эсэргүүцлийн дагуу шүүх тухайн хэргийг дахин хянан хэлэлцдэг байв. Гэтэл 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн прокурорын хяналтын хүрээг хязгаарлаж зөвхөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох болсон юм. Өөрөөр хэлбэл, хэмжээгүй эрхт хяналтын гаж буруу тогтолцоог бүрэн халсан. Дүгнэж хэлбэл нэгэнт түүх болон үлдсэн прокурорын хяналтын хуучин тогтолцоог санагалзсан мэт 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсон улсын яллагчаас гадна тухайн хэргийн талаар харьяалал үл хамаарах дээд шатны прокурор хэмээх үл ойлгогдох албан тушаалтан эсэргүүцэл бичих болж байна. Дээд шатны гэх прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг заасан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1, 347 дугаар зүйлийн 347.5 дахь заалтыг утгачилан ойлговол,

Нэгдүгээрт: Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоогүй прокурор эсэргүүцэл бичнэ.

Хоёрдугаарт: Ийнхүү эсэргүүцэл бичихийн тулд аль нэг шүүхийн шийтгэх тогтоол, магадлал, тогтоолыг хөндлөнгөөс хянаж үзнэ. Өөрөөр хэлбэл шүүн таслах ажиллагаанд хяналт тавина.

Гуравдугаарт: Шийтгэх тогтоол, магадлал, тогтоолыг ямар нэгэн байдлаар олж авах, эсвэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1, 347 дугаар зүйлийн 347.5 дахь заалтыг практикт нэг мөр хэрэгжүүлэхийн тулд бүх шатны шүүх гаргасан шийдвэрээ прокурорын байгууллагад хүргүүлдэг хуучин журамд шилжих.

Дөрөвдүгээрт: Прокурорын байгууллага нь хуулиар олгосон эрхийхээ дагуу шүүхийн бүх шийдвэрийг хянаж, эсэргүүцэл бичихийн тулд одоогийн байгаа орон тоогоо нэмэгдүүлнэ гэсэн үг юм.

Чухамхүү ийм учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д "... эсхүл дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй", мөн хуулийн 347 дугаар зүйлийн 347.5-д "... эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол эсэргүүцэл бичсэнээс.." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтыг зөрчиж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342.1-д зааснаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл прокурор бусад оролцогчдын адил хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичих эрхтэй. Хяналтын шатны шүүхийн тогтоол хуульд харшилсан гэж үзвэл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих, эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347.4, 347.5-д заасан болно.

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн үүрэгтэй болохыг, прокурор шүүх хуралдаанд оролцох чиг үүргээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу эсэргүүцэл бичихийг Прокурорын байгууллагын тухай хуулийн 2, 31 дүгээр зүйлд тус тус заасан. Иймд Ерөнхий прокурор хяналтын шатны шүүхийн тогтоол хуульд харшилсан гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлд заасны дагуу эсэргүүцэл бичиж зөвтгүүлж байгаа нь эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх прокурорын үндсэн чиг үүрэгтэй бүрнээ нийцэж байгаа болно. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт, Ерөнхий прокурорын эсэргүүцлийг үндэслэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хэлэлцсэн аль ч тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд заасан прокурор болон өмгөөлөгч нар нь адил тэгш эрхтэйгээр шүүх хуралдаанд оролцож, хэрэгт ач холбогдол бүхий ямарч асуудлаар саналаа илэрхийлж эрх тэгш мэтгэлцэх боломжтой байгаа болно. Дээд шатны прокурор болон Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичиж байгаа нь шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн үйлдэл огтхон ч биш бөгөөд харин прокурор, шүүгч нарын хууль бус үйл ажиллагаа, алдаа зөрчлийг тухай бүр зөвтгүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, мөн гэм буруутай этгээдэд ял завшуулахгүй байх ач холбогдолтой гэж үзэж байна.

Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд "Прокурор... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно", Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5.1.7-д "яллах тал" гэж прокурорыг ойлгоно, 5.1.20-д "прокурор" гэж бүх шатны прокурорын газрын прокурорыг ойлгоно, 5.1.26-д "прокурорын дүгнэлт" гэж прокуророос шүүх хуралдаан дээр гаргасан саналыг ойлгоно, 17.2-т "шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээнэ", Прокурорын байгууллагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Прокурор шүүх хуралдаанд оролцох чиг үүргээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эсэргүүцэл бичнэ" гэж тус тус заасан байдаг. Түүнчлэн Улсын Их Хурал 2007 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хяналтын шатны шүүхийн тогтоолд Ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй болсонтой холбогдуулан Прокурорын байгууллагын тухай хуулийн 23.1, Шүүхийн тухай хуулийн 20.4 дэх хэсэгт холбогдох өөрчлөлтийг оруулсан. Мөн 1998 онд Үндсэн хуулийн цэц хуучин үйлчилж байсан буюу 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 362 дугаар зүйлд "Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хэлэлцээд Цэцийн 1998 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар дүгнэлтээр уг асуудал нь Үндсэн хуулийн

холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэж шийдвэрлэж байсан байна. Цэцийн дээрх дүгнэлт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн уг асуудлаарх холбогдох заалтын агуулга, зарчим нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд тусгагдсан байгаа болно.

### 3. Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарын агуулга:

1993 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулах үзэл баримтлалд дурдахдаа “Ерөнхий прокурорын бүрэн эрхийг Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж тусгав. Энэ хүрээнд Ерөнхий прокуророос Улсын дээд шүүхтэй харилцах харилцааны асуудлыг төсөлд тусгав” гэсэн байх бөгөөд энэ үзэл баримтлалын дагуу Прокурорын байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Улсын ерөнхий прокурор Улсын дээд шүүхийн хяналтын журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоол хуульд харшилсан гэж үзвэл санал гаргана” гэсэн заалт орсон юм. 2001 онд бичигдсэн “Прокурорын ном” гарын авлагын оршил хэсэгт доктор, профессор Б.Чимид “...Монгол Улсын Прокурорын газрууд бол Үндсэн хуулийн чиг үүргийнхээ дагуу эрүүгийн мөрдөн шалгах хүрээний байгууллага мөн. Ерөнхий хяналтыг шилжүүлснээр прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах аас эцэслэн шийдвэрлэх хүртэлх ажилд хууль хэрхэн биелүүлж байгааг хянаж, энэ хүрээнд хууль ёсыг хамгаалах ажлыг дагнаж эрхэлдэг мэргэшсэн байгууллага болж байгаа хэрэг. Энэ бол олон улсын нийтлэг жишиг юм” хэмээн Монгол Улсын Прокурорын байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байна. Одоогийн байдлаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1, 347 дугаар зүйлийн 347.5-д тус тус заасны дагуу дээд шатны прокуророос эсэргүүцэл бичсэн болон Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлээр Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүн хуралдсан тохиолдол гараагүй байна.

### 4. Улсын ерөнхий прокуророос ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь зөвхөн ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нараас хяналтын шатны шүүхийн тогтоол хууль зөрчсөн гэж үзэж гомдол гаргасан тохиолдолд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэргийг хэлэлцүүлэхээр дүгнэлт гаргахаар тусгагдсан. Энэ гомдол гараагүй тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гэмт этгээд ял завшсан эсхүл үндэслэлгүйгээр ял шийтгэгдсэн зэрэг хууль зөрчсөн шүүхийн тогтоолыг зөвтгүүлэхээр дүгнэлт бичих боломжгүй болгож байгаа юм. Прокурорын байгууллагын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий байгууллага”, мөн хуулийн 31 дүгээр зүйлд “Прокурор шүүх хуралдаанд оролцох чиг үүрэгээ биелүүлэхдээ хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу эсэргүүцэл бичнэ” гэж тус тус заасан байдаг. Иймд шүүхээс гэмт этгээдэд оногдуулсан ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдсэн арга, сэдэлт, учруулсан хор уршиг зэрэгтэй нийцээгүй хэт хөнгөн ял оногдуулсан, ял завшуулсан эсхүл үндэслэлгүйгээр ял шийтгэсэн талаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт бичигдээгүй тохиолдолд Улсын ерөнхий прокурор хяналтын шатны шүүхийн тогтоол хуульд харшилсан гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.4 дэх хэсэгт зааснаар эсэргүүцэл бичиж зөвтгүүлэх нь Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх прокурорын үндсэн чиг үүрэгтэй нийцэж байгаа төдийгүй Үндсэн хуулийн шударга ёсны болон хууль дээдлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй гэсэн зорилт, зарчмуудтай ч уялдаатай юм.

Ийнхүү хэргийг хүндрүүлж буюу хөнгөрүүлэн шийдвэрлүүлэхээр Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлд заасан хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн дүгнэлт, Улсын ерөнхий прокурорын эсэргүүцлийг үндэслэж нийт шүүгчдийн

хуралдаанаар хэргийг хэлэлцсэн аль ч тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд заасан прокурор болон өмгөөлөгч нар нь адил тэгш эрхтэйгээр шүүх хуралдаанд оролцож, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар илэрхийлж, эрх тэгш мэтгэлцэх боломжтой байгаа болно.

2/ 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303 дугаар зүйлийн 303.1, 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт гагцхүү шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцсон прокурор шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд эсэргүүцэл бичихээр хуульчлагдсан байсан. Ингэснээр улсын яллагч тодорхой хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /амралттай, өвтэй, гадаадад явсан зэрэг/ байгаагүй бол шүүхийн хууль зөрчсөн тогтоолыг зөвтгүүлэх боломжгүй болох эсхүл улсын яллагч үндэслэлгүйгээр яллахаас татгалзсанаар гэм буруутай этгээд ял завших, хохирогчийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөх явдал цөөнгүй гарч байна. Шүүх нь өөрийн санаачилгаар шүүгдэгчийн ялыг хүндрүүлэхгүй, яллах үүрэгтэй прокурор нь эсэргүүцэл бичих эрхгүй гэсэн хуучин хуулийн заалтуудаас болж гэмт этгээдүүд ял завших асуудал удаа дараа гарч байна. Эдгээр нөхцөл байдлууд болон Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлд заасан “прокурор... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн чиг үүргийг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар шүүхийн тогтоолд дээд шатны прокурор эсэргүүцэл бичиж болох тухай зохицуулалтыг шинээр хуульчилсан болно. Улсын ерөнхий прокурор болон дээд шатны прокурорын эсэргүүцлийг хүлээн авах эсэх нь гагцхүү шүүх, шүүгчийн хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож, нотлох баримтад тулгуурлан дотоод итгэл, бүрэн эрхийн хүрээндээ шийдвэрлэдэг асуудал тул шүүхийн үйл ажиллагаанд прокурор хяналт тавьж буй арга хэрэгсэл гэж үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл прокурорын эсэргүүцэл нь заавал биелэгдэх шинжгүй, шүүх хуралдаанд оролцогч нараас тавьдаг саналуудын нэг нь гэж ойлгож болно.

5. Эрүүгийн эрх зүйн доктор, профессор, эрдэмтэн Б.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Түүхэн үүднээс авч үзвэл Монгол Улсад прокурор давж заалдах болон хяналтын шатны шүүхийн магадлал, тогтоолын талаар эсэргүүцэл бичиж байсан буюу өөрөөр хэлбэл шүүн таслах үйл ажиллагаанд хяналт тавьж байсан нь прокурорын байгууллагаас яам, тусгай газар, албан тушаалтны гаргасан шийдвэрт ерөнхий хяналт тавьж байсантай холбоотой байсан байна. Харин 1992 оны шинэ Үндсэн хуулиар прокурорын ерөнхий хяналтыг халж зөвхөн прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг хуульчлан заасан байна.

Үндсэн хуулийн дээрх заалтын үзэл санаанд нийцүүлж 1993 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Улсын ерөнхий прокурор Улсын дээд шүүхийн хяналтын журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоол хуульд харшилсан гэж үзвэл санал гаргана”, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.2 дахь хэсэгт “... тогтоол хуульд харшилсан гэж үзсэн Улсын ерөнхий прокурорын... саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан тохиолдолд хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан хэлэлцэнэ” гэсэн заалтууд нь шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах, аль ч байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн Үндсэн хуулийн заалтаас урган гарч ирсэн зохицуулалт буюу шинэ Үндсэн хуулийн үзэл санаа, зарчмын бодит тусгал болсон юм. Харин Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сард батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1-д, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.4, 347.5-д, Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Улсын Их Хурал ямар үзэл баримтлал, зарчимд нийцүүлж дээрх нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан нь тодорхойгүй байна.

Харин прокурорын удирдлага Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342, 347 дугаар зүйлд өөрчлөлт оруулах шаардлагыг “Улсын яллагч үндэслэлгүйгээр яллахаас татгалзсан эсхүл тодорхой хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /амралттай, гадаад явсан зэрэг/ улсын яллагч шүүхийн хууль зөрчсөн тогтоолыг зөвтгүүлэх боломжгүй тохиолдолд гэм буруутай этгээд ял завших, хохирогчийн эрх ашиг ноцтойгоор зөрчигдөх явдал гарч байсан нь дээд шатны прокуророос эсэргүүцэл бичихэд хүргэж байгаа, ийнхүү прокурор эсэргүүцэл бичих явдал нь прокурор, шүүгч нарын хууль бус ажиллагаа, алдаа зөрчлийг тухай бүр нь зөвтгүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байхад ач холбогдол нь оршино” хэмээн тайлбарлаж байгаа нь үндэслэл муутай юм. Учир нь энэ асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 357-363 дугаар зүйлүүдээр тусгайлан зохицуулсныг анхааран үзсэнгүй. Тухайлбал, хууль зөрчсөн прокурор, хууль бус шийдвэр гаргасан шүүгчийн талаарх гомдлыг прокурор хүлээн авах, уг гомдлыг шалгаад энэ үндсэн дээр хууль бус шийтгэх тогтоол, магадлалыг хянуулахаар прокурор дүгнэлт бичиж Улсын дээд шүүхэд хүргүүлэх, уг дүгнэлтийн дагуу хяналтын шатны шүүх хэргийг хянаж үзээд хууль зөрчиж гаргасан шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгох, эсвэл дүгнэлтийг хэрэгсэхгүй болгох зэрэг харилцааг эдгээр зүйл, хэсгээр зохицуулсан юм. Гадаад улс орнуудын хууль тогтоомжийн лавлагааг харж үзвэл прокурор эсэргүүцэл бичдэг, энэ дагуу Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан болдог журам манайхаас өөр улс орнуудад үйлчилдэггүй байна. Харин хуучин ЗСБНХУ, түүний холбооны гишүүн улсуудад дээрх журам үйлчилж байжээ.

6. Эрүүгийн эрх зүйн доктор, профессор, эрдэмтэн Б.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Манай өнөөгийн шүүн таслах ажиллагаа нь мэтгэлцэх зарчимд тулгуурлан явагддаг, гэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарим уламжлалыг хадгалан үлдсэн, өөрөөр хэлбэл хэргийн бодит үнэнийг тогтоох, хэлбэрийн тэгш байдлаар зогсохгүй талуудын байцаан шийтгэх ажиллагаанд, түүний дотор шүүх хуралдаанд оролцох үүргийг бодит практиктэнцвэрт байдлыг дээд зэргээр хангаж Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах боломжтой гэгдэх тэр хүрээнд прокурорын үйл ажиллагаа явагдаж ирсэн байна. Гэтэл уг хуулийн 342.1, 347.5-д оруулсан нэмэлт, өөрчлөлт нь шинэ гэгдэх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үзэл баримтлалтай хэрхэн нийцэж байна вэ гэдэгт эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна. Учир нь, “дээд шатны прокурор” гэдэг томьёолол юуг агуулж байна, 347.1-д “хяналтын шатны шүүхийн тогтоол нь эцсийн шийдвэр байна” гэсэн заалттай атлаа түүнд яллагч нэг тал болох прокурор л эсэргүүцэл бичих эрхтэй гэсэн нь мэтгэлцэх зарчимд хэр нийцэх вэ зэрэг асуулт тавигдаж таарна. Иймд эдгээр нь тодорхой тайлбар шаардаж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д “... дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй”, 347 дугаар зүйлийн 347.5-д “...эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол... эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэнэ” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1. 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 1995 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт буюу уг хуулийн 362 дугаар зүйлийн “Улсын ерөнхий прокурор анхан шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналыг үндэслэн эсэргүүцэл бичих эрхтэй” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 3 дугаар



сарын 27-ны өдрийн 3 дугаар дүгнэлт хүчинтэй байгаа бөгөөд уг дүгнэлтээр прокурор эсэргүүцэл бичих эрхтэй болохыг Үндсэн хуулийн цэц хүлээн зөвшөөрсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлийн 347.5-д Хяналтын шатны шүүхийн тогтоолд Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэнэ гэх зохицуулалт нь шүүхийн хараат бус байдалд халдсан шинжийг агуулаагүй байна.

Хэдийгээр Улсын ерөнхий прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347.5-т заасны дагуу шүүхийн эцсийн шийдвэрт эсэргүүцэл бичиж Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааныг хуралдуулах боломжтой ч энэ нь шүүхийн шийдвэрт ямар нэг байдлаар нөлөөлөх хууль зүйн үндэслэл болохгүй байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар уг хуулийн 342 дугаар зүйлийн 342.1, 347 дугаар зүйлийн 347.5-д тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй", Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллаганы тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д тус тус заасныг үндэслэн МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д "...дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй", 347 дугаар зүйлийн 347.5-д "...эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол... эсэргүүцэл бичсэнээс хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр нэг удаа хянан шийдвэрлэнэ" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. 1998 онд Улсын ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй гэсэн заалтыг Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж Цэц дүгнэсэн. Өөрөөр хэлбэл прокурор эсэргүүцэл бичиж болох эсэх асуудалд Цэц дүгнэлтээ гаргачихсан, тэрхүү дүгнэлт нь Цэцийн хүчин төгөлдөр шийдвэр.

1963 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль 1993 онд шинэчлэгдсэн, мөн 1997 онд нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. 2002 онд мөн л шинэчлэн найруулсан. Хууль нь өөрчлөгдөөд байгаа хэрнээ прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг нь өөрчлөгдөхгүй байна. Энэ нь Парламентын хууль тогтоох үйл ажиллагаа дутагдалтай байгаагийн л илрэл. Эрүүгийн хэргийн оролцогч нь хохирогч, яллагдагч, тэдгээрийн өмгөөлөгч. Гэтэл хуулиар прокурор хэргийн оролцогч. Прокурор нэгэнт хэргийн оролцогч байх тохиолдолд талууд эрх тэгш байх нь Үндсэн хуулийн суурь зарчим. Прокурорын бичсэн эсэргүүцэл Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааныг хуралдуулах шууд үндэслэл болдог, харин хохирогч, яллагдагчийн бичсэн гомдол нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн “шүүлтүүр”-ээр ордог байдал нь Үндсэн хуулийн зөрчил гэж үзэж болно.

2. Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 3 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.02.15 № 01**

### **Улсын Их Хурал Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн П.;  
Гэрч - Хууль зүй, Дотоод хэргийн дэд сайд Т., Хүнс, Хөдөө аж ахуйн дэд сайд Г.,  
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Э.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”<sup>98</sup> хуулийг батлахдаа Үндсэн хууль зөрчсөн тухай

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”
- Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

98 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2004 оны № 47-д нийтлэгдсэн

Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж батлагдсан байна. Үндсэн хуулийн энэ заалтаар бол Улсын Их Хурал нь хуулиар тогтоосон журмыг ягштал биелүүлэх ёстойг тунхагласан. Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн “хууль дээдлэх” зарчмыг зөрчиж “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” болон “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” хуулиудын тодорхой зүйл заалтуудыг үл хэрэгсэн маргаж буй хуулийн төслийг авч хэлэлцэж баталсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4-т “Улсын Их Хурлын... үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Хорин долдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байдаг. Энэ нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны журмын нэг болох “хууль тогтоох” онцгой бүрэн эрхээ Улсын Их Хурал өөрөө хэрхэн, яаж эдлэхийг хуулиар тогтоох учиртайг тодорхойлж өгч байна гэсэн үг. Гэтэл Улсын Их Хурал дээрх журмыг тогтоосон “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-ийн “...Улсын Их Хурлын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газрын, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх”, 18 дугаар зүйлийн 18.10-ын “Улсын Их Хурлын гишүүн энэ хуулийн 3.1.4-т заасны дагуу Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад хуулийн төслөө явуулна”, 18.11-ийн “Засгийн газар энэ хуулийн 18.10-т заасан төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал дүгнэлтээ 30 хоногт багтаан хууль санаачлагчид хүргүүлэх..”, 18 дугаар зүйлийн 18.14-т “Энэ хуулийн 18.1-д заасан хугацаанд Засгийн газар хариу ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ” мөн хуулийн “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх” 20 дугаар зүйлийн 20.3.5-ын “Засгийн газар, холбогдох бусад байгууллагын санал дүгнэлт...”-ийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа хуулийн төсөлд хавсаргах ёстойг хуульчилсан заалтуудыг зөрчсөн. Түүнчлэн “Монгол Улсын Их Хурлын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-ийн “Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ гагцхүү чуулганаар хэрэгжүүлэх бөгөөд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан болон Байнгын хороодын хуралдааныг бэлтгэн явуулах, хуралдаанаар хууль болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, бусад асуудал хэлэлцэх санал хураалгах, батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын хуралдааны дэгийг баримтална” гэсэн заалт, “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” хуулийн 16 дугаар зүйлд заасан “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл хэлэлцэх журам” болон 18 дугаар зүйлийн 18.1-ийн “Өргөн мэдүүлсэн төслийг Улсын Их Хурлын дарга холбогдох байнгын хороонд шилжүүлэх бөгөөд уг хороо төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлт, гаргах нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бүх ажлыг хариуцна”, 18.2-ын “Энэ хуулийн уг төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө холбогдох Байнгын хороо нийт гишүүдэд хувилж хүргүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчиж, хэлэлцүүлгийн явцад зарим гишүүд сануулсаар байсан атал Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг хэлэлцэж баталснаараа Монгол Улсын Үндсэн Хуулийн дээрх 2 заалтыг зөрчлөө.

Нэгэнт ингэж Үндсэн хууль зөрчиж батлагдсан хууль нь өөрөө бүхлээрээ Үндсэн хуульд харшилсан хууль болох ёстой. Үүгээрээ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль зөрчсөн байгаа тул түүнийг хүчингүй болгуулахаар энэхүү гомдлоо гаргалаа.

Маргаж буй хуулийн төслийг хэлэлцэх үеийн материалтай танилцаж байхад энэ асуудлаар хуульд заасан нөхцөл журмын дагуу Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн

үйлдэл хийгээгүй, энэ асуудлаар Монгол Улсын Засгийн газар байр сууриа илэрхийлж, саналаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээгүй учир өргөн мэдүүлсэн хуульд хавсаргах ёстой холбогдох материалууд нь ч байхгүй байгаагаас гадна Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганаар нэгэнт хэлэлцэн баталсан хуульд нөхөж материал бүрдүүлэх ажил зохион байгуулж байгаа нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 1/3137, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2007 оны 12 дугаар сарын 21-ний 1/2714 дугаар албан бичгүүдээс тодорхой харагдаж байна.

Энэ бүхэнд үндэслэж Үндсэн хуулийн тодорхой заалт зөрчиж Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын хуулийг хүчингүй болгож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч П.-ийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх явцад төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үеэр онцгой албан татварын хэмжээг өөрчлөх асуудлаар санал хураан шийдвэрлэсэн бөгөөд үүнтэйгээ уялдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд “төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдвөл Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно” гэсний дагуу П., З., Б. нарын Улсын Их Хурлын 15 гишүүн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм.

Хууль санаачлагчид Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, журмын тухай хуулийн 18.11-д заасан Засгийн газрын саналыг авахаар мөн хуулийн 18.10-д заасны дагуу 2007.11.28-ны өдрийн 10/7115 дугаар бичгээр хуулийн төслийг хүргүүлсэн бөгөөд, Засгийн газар 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хуралдаж, Улсын Их Хурлын гишүүн П. нарын санаачлан боловсруулсан Онцгой албан татварын тухай хууль, мөн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн, 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭГ/2402 дугаар албан бичгээрээ Засгийн газрын нэгдсэн саналаа хууль санаачлагчид хүргүүлжээ. Хууль санаачлагч нар Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлсэн байна.

Улсын Их Хуралд Улсын Их Хурлын гишүүн П., Б. нарын 15 гишүүний санаачилсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлэгдэж, түүнийг хэлэлцэн баталсан бөгөөд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон Хүнс, хөдөө аж ахуйн сайдын албан бичгүүд нь Д., Б., С. нарын санаачлахаар боловсруулж байсан Онцгой албан татварын хуулийн төсөлд хамаарах бичгүүд байна. Иймд Онцгой албан татварын тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхдээ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 3.1.4, 16 дугаар зүйл, 18.10, 18.11, 18.14, 20.3.5-д заасныг зөрчөөгүй гэж үзэж байна.

Дээр дурдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.5 дахь хэсэгт заасан “төслийн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь бусад хуулийн заалттай зөрчилдвөл Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж болно” гэж заасны дагуу Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй хамтад нь хэлэлцүүлэх үүднээс Төсвийн байнгын хороо Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн

хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд улмаар мөн хуулийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр анхны хэлэлцүүлгээр нь баталсан юм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.5 дахь хэсэг нь аливаа хуулийн төслийг хэлэлцэх явцад дэмжигдсэн санал, бусад хуультай зөрчилдвөл холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хуулийн уялдаа холбоог хангах, бусад хуультай зөрчилдсөн хууль батлахгүй байх шаардлагын үүднээс эхний хуулийн төсөлтэй хамт хэлэлцүүлж, батлах асуудлыг зохицуулсан байдаг.

Түүнчлэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 33.5-д заасны дагуу Монгол Улсын төсвийн тухай хуулийг өмнөх оны 12 дугаар сарын 1-ний дотор багтаан баталдаг тул Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулийг 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталж, ингэхдээ хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналын дагуу Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт хэлэлцүүлэн батлуулсан байх тул Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн, батлахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.1, 18.1, 18.2 дахь хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.

Иймээс Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахдаа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрчөөгүй болно.

3. Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Т.-гийн Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд гэрчээр оролцож гаргасан тодорхойлолтын агуулга:

2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 8/7019 дугаар албан бичгээр Д. гишүүний бланкаар нэр бүхий 4 гишүүн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн. Хуулийн дагуу эхлээд энэ албан тоотоороо Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хандсан байгаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар манай яаманд хандсан. Хуулийн төсөлд яамдаас санал аваад манайх санал, дүгнэлт боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг журамтай. Тэр дагуу яамдад албан дугаар явуулсан нь энд дурдагдсан 1/3137 дугаар ч түүний нэг байгаа юм. Г. гишүүний хариу ирүүлсэн дугаар нь болохоор энэ 4 гишүүний санаачилсан хуулийн төсөлд санал ирүүлсэн 1/2714 дугаар байгаа. Тэгэхээр энэ нь Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар нэр бүхий 4 гишүүний санаачилсан хуулийн төсөлд манай яамнаас явуулсан албан дугаарын дагуу Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас ирүүлсэн хариу юм. Ганцхан Хүнс, хөдөө аж ахуйн яам биш энд бүх яамдуудаас санал ирүүлсэн байгаа.

2008 оны төсвийн тодотгол хэлэлцүүлэхтэй холбогдуулаад нэр бүхий 7 хуулийг П. гишүүний албан бланкан дээр Засгийн газраас санал авахаар ирүүлсэн. Түүн дотор дахиад Онцгой албан татварын хууль явж байсан. Энэ хуулийн бичлэг нь өөр, санаачлагчид нь бас өөр. Хоёр өөр хуулийн төсөл байгаа юм. Өөрөөр хэлбэл цаг хугацааны хувьд хойно урдаа гараад явж байсан гэсэн үг. Агуулга нь бол адилхан.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж санал дүгнэлт гарсан төсөл нь П. гишүүний тайлбарлаад байгаа нэр бүхий 7 хууль дотор явж байгаа төсөл юм. Манайх яамдаас санал аваад санал, дүгнэлт гаргаж байх шатанд энэ төсөл нь түрүүлээд батлагдчихсан болохоор дахиж эхнийхээр Засгийн газрын хуралдаан хийж хэлэлцүүлэх шаардлагагүй юм. Санал, дүгнэлт бэлтгэж байх явцад түрүүлээд батлагдчихлаа гээд энэ асуудлыг картаар хаасан. Өргөдөл гаргагч хоёр дахь хуулийн төсөл буюу багцаараа явж байгаа хуулийн төсөлд нөхөж санал аваад байна гэж ойлгоод байна. Яамдаас нөхөн санал авсан юм ерөөсөө байхгүй. Эхний хуулийн төсөл дээр санал авах процесс яамдуудад янз бүрийн хугацаанд явагдаж байсан байгаа юм. Засгийн

газрын хуралдаанаар хэлэлцэгдэж санал, дүгнэлт гарсан хуулийн төсөл нь бол сүүлд нэр бүхий 15 гишүүний санаачилсан 7 багц хууль юм. Энэ төсөл нь 11 дүгээр сарын 28-ны хуралдаанаар хэлэлцэгдээд 58 дугаар тэмдэглэл гараад 11 дүгээр сарын 29-нд Улсын Их Хуралд хүргэгдсэн.

4. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Э.-гийн Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд гэрчээр оролцож гаргасан тодорхойлолтын агуулга:

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн П. нарын санаачилж боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн. Энэ үеэр нэлээд олон хууль хамт хэлэлцэгдсэн. Яагаад олон хууль нэг дор хэлэлцэгдсэн бэ гэхээр Монгол Улсын төсөв батлагдах хугацаа тулсан байсан учраас төсөвтэй холбогдуулж зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг Улсын Их Хурлын гишүүд санаачлаад, яаралтай хэлэлцэж өгөөч гэж хүсэлт тавьж Засгийн газарт хандаад тэр асуудлуудыг хэлэлцсэний дотор Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байсан.

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төслүүдийг зарчмын хувьд дэмжиж байна гэдгээ Засгийн газар албан ёсоор илэрхийлсэн. Энэ дотор Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль орж байгаа. Улсын Их Хурал 2008 оны Монгол Улсын төсвийн төслийг хуулиар тогтоосон хугацаанд хэлэлцэн батлахад Засгийн газраас бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх болно гэдгээ тэмдэглэлд мөн тусгаж өгсөн.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Улсын Их Хурлаар 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Засгийн газрын санал авсан болох нь Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад гэрчүүдийн мэдүүлэг, бусад нотлох баримтаар тогтоогдож байна.

2. Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Улсын Их Хурлын... үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно", Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Улсын Их Хурал хууль тогтоох онцгой бүхэн эрхээ хэрэгжүүлэхдээ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хэм хэмжээг ягштал баримталж ажиллах нь зүйтэй болох нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурал 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг 2008 оны хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**Тэмдэглэл:**

1. Улсын Их Хурал хууль тогтоох онцгой бүхэн эрх хэрэгжүүлдэг субъектийнхээ хувьд нийгмийн хэрэгцээнд нийцсэн нийтэд хамааралтай шийдвэр гаргах хариуцлагыг Үндсэн хуулийн утга санааны дагуу өөрт хүлээсэн байдаг тул хууль болон бусад шийдвэрийг гаргахдаа ул суурьтай нарийн чамбай хандах шаардлагатай байдаг. Иймд хууль тогтоох үйл ажиллагааг нарийвчлан цэгцлэхийн үүднээс тусгайлсан хуулиуд гарган Улсын Их Хурлын үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

Тодруулбал, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль гэх мэт. Гэхдээ Улсын Их Хурал нь зарим нэг онцгой хууль, шийдвэрийг гаргахдаа тусгайлсан журмыг баримтлахаас өөр аргагүйд хүрэх тохиолдол байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал энэ маргаанд дурдагдсан Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хууль батлах зэрэгт тусгай журам мөрдөж болно.

Гэхдээ энэхүү тусгай журмыг тухайн хууль тогтоох үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хуульдаа тусгасан байх нь зүйтэй юм. Ер нь Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хэм хэмжээг ягштал баримталж ажиллах нь зүйтэй юм.

2. Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр дүгнэлт, 2000 оны 3 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.02.20 № 02**

**Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн М., П.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Ашигт малтмал, Газрын тосны Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.;

Гэрч - Гаалийн ерөнхий газрын хэрэг зөрчилтэй тэмцэх хэлтсийн дарга Д., Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, геологи уул уурхай, цацрагийн хяналтын газрын дарга С., Хүний эрхийн үндэсний комиссын ахлах референт Н.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 65 дугаар тогтоол

## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”
- Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”
- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах”
- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалт “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн М., П. нарын өргөдлийн агуулга:**

Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна. Засгийн газар нь энэхүү тогтоолыг гаргахдаа уг боомтуудыг мэргэжлийн боловсон хүчнээр болон зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаагүй нь Монгол Улсын хилээр их хэмжээний, онц аюултай химийн хор /цианит натри, мөнгөн ус зэрэг/ хяналтгүйгээр нэвтрэх нэг нөхцөлийг бүрдүүлсэн байна.

### **2. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:**

2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 15.3 дахь хэсгийн заалтыг үндэслэн Засгийн газар 2006 оны 296 дугаар тогтоолоор “химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт”-ыг баталсан. Энэ жагсаалтад Дорноговь аймаг дахь Замын-Үүд, Сэлэнгэ аймаг дахь Алтанбулагийн боомт, мөн аймгийн нутаг дахь Сүхбаатарын боомт, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын шалган нэвтрүүлэх боомтууд орсон байна.

Дээрх тогтоол батлагдсанаар алслагдсан бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй, үйл ажиллагаандаа зайлшгүй химийн бодис хэрэглэх шаардлагатай компаниудын хувьд дараах хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Дорнод аймгийн Тамсаг сав газарт үйл ажиллагаа явуулдаг “Петро-Чайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК-ийн өрөмдлөг, цооногийн туршилтын үйл ажиллагаанд шаардагдах химийн бодисыг зөвхөн Замын-Үүдийн боомтоор импортлох болсон. “Петро-Чайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК 2006 онд 1200 тонн химийн бодисыг Баянхошуу, Бичигтийн боомтоор тээвэрлэхэд 262,200 ам.доллар зарцуулж байсан бол тус компани 2007 онд хайгуулын ажлаа эрчимжүүлж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэнтэй холбогдон химийн бодисын хэрэгцээ 2006 оныхоос 5 дахин өссөн. “Петро-Чайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК-ийн агуулахаас Замын-Үүд боомт хүртэл 1800-2200 км, Замын-Үүдийн боомтоос Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь Тосон-Уул XIX талбай хүртэл 700-800 км газар тээвэрлэлт хийх шаардлагатай бөгөөд тээврийн зардал 8-9 дахин өсөх тооцоо гарч байсан. Энэ зардал нь өртөгт тосоор нөхөгдөх зардалд орж, уг зардал Монгол Улсын Засгийн газарт ногдох тосоор нөхөгдөх болно. Газрын тосны хайгуулын ажилтай холбоотойгоор Үйлдвэр, худалдааны яамны саналаар Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны 65 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Баянхошууны боомт, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтыг тус тус нэмж баталсанаар дээрх хүндрэлтэй асуудал шийдвэрлэгдсэн.



“Петро-Чайна Дачин Тамсаг(Монгол)” ХХК нь 2007 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 2007/53 дугаар зөвшөөрлөөр 72 төрлийн химийн бодис, мөн өдрийн 2007/54 дүгээр зөвшөөрлөөр 47 төрлийн химийн бодис, 2007 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн 2007/103 дугаар зөвшөөрлөөр 8 төрлийн химийн бодис, мөн өдрийн 2007/104 дүгээр зөвшөөрлөөр 9 төрлийн химийн бодис, 2007 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 2007/112 дугаар зөвшөөрлөөр 5 төрлийн химийн бодис тус тус импортолсон байна. Өргөдөлд дурдаад байгаа цианид натри, мөнгөн ус нь алт цэвэршүүлэхэд хэрэглэгддэг химийн бодис бөгөөд тэдгээрийг газрын тосны өрөмдлөгийн болон туршилт үйлчилгээний ажилд огт хэрэглэдэггүй төдийгүй Баянхошууны, Бичигтийн боомтуудаар цианит натри, мөнгөн усыг импортолж байгаагүй, цаашид ч дээрх боомтуудаар цианит натри, мөнгөн усыг импортлохгүй болно. Монгол Улсын Засгийн газар Монгол Улсад ашиглах химийн бодисын нэр төрөл, тоо хэмжээнд хяналт тавих, хортой, аюултай бодисыг ашиглахыг хориглох, хязгаарлах зорилгоор “Монгол улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт”-ыг 2007 оны 95 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, уг жагсаалтад 30 бодис хамрагдаж байсныг бодит байдалд нийцүүлэн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой 111 бодисыг оруулсан бөгөөд эдгээрээс 28 бодисын ашиглалтыг хязгаарлаж, үлдсэн 83-г бүрмөсөн хориглохоор шийдвэрлэсэн юм. Үүний дотор мөнгөн ус болон натрийн цианидыг Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн бодисын жагсаалтад багтаасан ба тэдгээр бодисыг зөвхөн тодорхой зорилгоор, тодорхой тоо хэмжээгээр импортолж, ашиглаж байхаар тусгасан байдаг.

3. Монгол Улсын Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Дээрх нэр бүхий иргэд тогтоолын энэхүү нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2-т заасан Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, эрх чөлөөг нь зөрчсөн гэж чухам ямар учраас үзэх болсон нь ойлгомжгүй байна. Тэдний бичсэн өргөдөлд Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолын улмаас хаанахын иргэдийн эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж, ямар хохирол учирсан талаар дурдаагүй байх бөгөөд Хонгорын иргэдийн эрхийг зөрчсөн гэж үзэж байгаа бол тэдэнд хэний буруутай үйл ажиллагаанаас ямар хохирол учирсныг нарийвчлан тогтоогоогүй, энэ талаар мэргэжлийн байгууллагын болон /олон улсын/ шинжээчдийн дүгнэлт хараахан гараагүй байна. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зааснаар иргэн өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог гаргаж өгсөн байх ёстой бөгөөд иргэн М., П. нар нь энэ удаа ямар ч нотолгоо баримтгүйгээр асуудлыг дутуу дулимаг судалж тавьсан байна. Дорнод аймаг дахь Баянхошууны болон Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтуудыг нээж ажиллуулах болсноор Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэд хордсон гэж өнгөцхөн авч үзэх нь учир дутагдалтай болно.

Аль ч улс орон хилээрээ химийн хортой болон аюултай бодисыг оруулахыг огт зөвшөөрөхгүй, хориглосон байдаггүй нь түүнийг хяналттайгаар ашиглах шаардлага байдагтай холбоотой юм. Манай улсын хувьд ч 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 15.3 хэсгийн заалтыг үндэслэн 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдөр химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газрын 296 дугаар тогтоолоор баталсан байна. Тэдний үзэж буйгаар Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгаа бол үүнтэй ижил утга бүхий улсын хилээр химийн хорт болон аюултай бодисыг нэвтрүүлэх тухай бусад тогтоолуудыг хэрхэн үзэх вэ гэдэг асуудал гарч ирэх болно. Байгууллага, хувь хүний хууль бус үйл ажиллагаанаас буй болсон нийгэм, ард иргэдэд аюултай хор уршиг бий болсон тэр хоёрын хоорондох бодит холбоог шалтгаант холбоо гэж үздэг бөгөөд мэдээлэлд дурдсан Засгийн газрын тогтоол гарснаар Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэд хохирсон гэж үзэх хоёрын хооронд шууд шалтгаант холбоо байхгүй байна. Тэгээд ч Хонгор суманд тархсан гэх цианит натри, мөнгөн ус

мэтийн химийн хорт бодисууд нь тогтоолд дурдсан хоёр боомтоор огтоос орж ирээгүй болох нь “Датамо” ХХК Тамсагийн сав газарт газрын тосны үйл ажиллагаанд ашиглах химийн бодисыг жагсаалт, бусад баримтуудаас тодорхой болно. Цианит натри, мөнгөн ус зэрэг нь алтыг цэвэршүүлэх зориулалттайгаар хэрэглэдэг химийн бодис тул газрын тос олборлолтод ашиглагддаггүй.

Баянхошуу, Бичигтийн боомтуудаар химийн бодисыг нэвтрүүлэхэд тээвэрлэлт зөвхөн нэг буюу хоёр аймгийн нутаг дэвсгэрээр дамждаг бол 3 аймаг, олон сумын нутаг дэвсгэрийг дамжин Замын-Үүдийн боомтоор оруулах нь химийн бодис тээвэрлэлтийн аюулгүй байдал, эрсдлийн хэмжээг нэмэгдүүлэх аюултай байв. Химийн бодисыг олон салбарт хэрэглэдгээс газрын тосны өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашиглах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ тохиолдолд химийн бодисыг цооногт 2500-3000 метрийн гүнд шахдаг, түүнийг эргүүлэн газрын гадаргууд буцаан гаргадаггүйгээс газрын тосны үйл ажиллагаанд ашиглагдаж буй химийн бодис, хаягдал нь газрын гадаргуу, гол мөрөн, нуур цөөрөм, усан санд орох нөлөөлөлгүй юм. Газрын тосны үйл ажиллагаанд ашигладаг химийн бодис, реагентийг зөвхөн өрөмдлөгийн ажилд хэрэглэдэг бөгөөд эдгээр нь өрөмдлөгийн технологийн гол материал болдог юм. Тус компани нь 2006 онд 30 гаруй төрлийн химийн бодис, реагентүүдийг холбогдох байгууллагаас зөвшөөрөл аван, Гаалийн төв лабораторт шинжилгээ хийлгэж, Дорнод аймгийн нутаг дахь Баянхошууны боомт, Сүхбаатар аймгийн нутаг дахь Бичигтийн боомтоор Монгол Улсын нутаг дэвсгэр рүү оруулж ашигласан бөгөөд өнөөг хүртэл зөрчил гаргаж байгаагүй болно.

Тус компани нь Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газраас тавьсан шаардлагын дагуу Тамсагийн сав газарт ажиллаж байгаа өрөмдлөгийн анги, бригад бүрийг химийн бодис хадгалах тусгай сав, агуулахтай болгосон бөгөөд химийн бодисын зарцуулалтын тайланг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлдэг журам тогтоогоод байна. Мөн химийн хортой бодис бүхий өрмийн шингэнийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар хийгдсэн хамгаалалтын дэвсгэр бүхий зумпфэнд хадгалж, тосыг соруулж, тос арилгах бактери, байгалийн шүү ашиглах замаар цэвэршүүлэх, хатаах аргаар байгаль орчинд сөрөг нөлөөгүй болгож байна. Газрын тосны үйл ажиллагаанд ашигладаг химийн бодисуудыг дотор нь химийн хортой ба хоргүй гэж ялгадаг. “Петро-Чайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК болон түүний туслан гүйцэтгэгч компаниудын өрөмдлөгийн үйл ажиллагаанд ашигладаг химийн бодисуудын зөвхөн 8 орчим хувь нь химийн хортой бодис, бусад нь үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх химийн хоргүй бодис ба бэлдмэлүүд юм. 2006 онд тус компанийн импортолсон химийн бодисуудыг Гаалийн төв лабораторид шинжлүүлэхэд калийн усан исэл, натрийн сульфат, калийн персульфат гэсэн 3 төрлийн бодис нь үйлдвэрлэлийн зориулалттай, хүчтэй үйлчилгээтэй хорт бодисууд, бусад нь үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглэгдэх химийн бодис ба бэлдмэлүүд болох нь тодорхойлогдсон.

#### 4. Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн тайлбарын агуулга:

Дорнод аймаг дахь Баянхошуу, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн хилийн боомтуудаар 2007 оны 3 дугаар сараас өнөөдрийг хүртэл 1762,572 тн химийн бодис “Петро-Чайна Дачин Тамсаг” ХХК, “Дачин Тамсаг Монгол” ХХК-уудын нэрээр орж, гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна. Замын-Үүд, Сэлэнгэ, Алтанбулаг боомтууд дээр өнөөдрийн байдлаар бүрэн тоноглогдсон лаборатори байдаггүй, Улаанбаатар хотод байрлалтай Гаалийн төв лабораторид дээж сорьцыг нь авчран шинжлүүлж байгаа бөгөөд Дорнод аймаг дахь Баянхошуу, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтууд дээр үүнтэй адилаар гаалийн хяналт тавигдаж байна. 2007 онд Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу дахь гаалийн салбар 5, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн хороо 13 хүний орон тоотой ажиллажээ.

#### 5. Улсын мөрдөн байцаах газраас ирүүлсэн албан бичгийн агуулга:

Химийн цианит, натри, мөнгөн ус зэрэг хорт бодисыг хууль бусаар ашигласнаар Дархан-Уул аймгийн Хонгор суманд ард иргэд, мал, газар, хордсон мэдээллийн

дагуу Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасагт “Цагаан бүрд” ХХК-ний захирал Т. нарын 4 хүнд /БНХАУ-ын иргэд/ Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлийн 200.3-т зааснаар эрүү үүсгэн шалгалт хийжээ. Т. нарт холбогдох 20723299 тоот эрүүгийн хэргийн шалгалтаар ард иргэд болон мал хөрөнгөнд 51 сая төгрөгний хохирол хорт бодисыг хууль бусаар хэрэглэснээс үүссэн нь тогтоогдож, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар хэргийг прокурорт шилжүүлсэн байна. Мөн Улсын мөрдөн байцаах газрын 5 дугаар хэлтэст Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг Цагаан цахир гэдэг газар “Цагаан цахир Гоулд”-ын хаягдлын далангаас цианиттай ус урсаж ямаа үхлээ гэсэн мэдээллээр Эрүүгийн хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т зааснаар 2006 оны 10 дугаар сарын 31-нд эрүү үүсгэн шалгажээ. БНХАУ-ын иргэн, Х., Ч. нарт холбогдох 20603319 тоот эрүүгийн хэргийг шалгахад цианит, амонит, хар тугалга уурхайн хаягдал усанд илэрч түүнээс 64 ямаа хордож үхсэн нь шалгалтаар тогтоогдсон тул яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар хэргийг прокурорт шилжүүлсэн байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоолоор Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоолын 1 дэх заалтад Дорнод аймаг дахь Баянхошууны боомт, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтыг “химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх” боомтын жагсаалтад оруулсан нь Монгол Улсын Засгийн газрын эрх хэмжээний асуудал бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 1, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 4, Гучин наймдугаар зүйлийн 2-ын 7 дахь заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Дээрх боомтуудаар химийн онц аюултай хорт бодис цианит натри, мөнгөн ус нэвтрүүлсэн гэх үндэслэл, нотолгоо тогтоогдохгүй байна.

3. Өргөдөл гаргагчаас хуралдааны явцад гаргасан нэмэлт шаардлагын талаар Үндсэн хуулийн цэц урьдчилан шалгалт хийж маргаан хянан шалгах ажиллагаа үүсгээгүй тул дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтын “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын “хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтын “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг 2008 оны Улсын Их Хурлын хаврын чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын иргэд ийм өргөдлийг Үндсэн хуулийн цэцэд өгөх болсон шалтгаан нь ноцтой үр дагавар тэнд бий болсны нэг илрэл юм гэж үзэж байна. Гэхдээ энэхүү маргаан бүхий асуудлыг судлан үзэхэд Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоолоор Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоолын 1

дэх заалтад Дорнод аймаг дахь Баянхошууны боомт, Сүхбаатар аймаг дахь Бичигтийн боомтыг “химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх” боомтын жагсаалтад оруулсан нь Дархан-Уул аймгийн Хонгор суманд ийм үйл явдал гарах, тодруулбал, иргэдийн эрүүл мэнд, байгал орчинд хор хохирол бий болохтой шалтгаант холбоотой болох нь тогтоогдохгүй байсан юм.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тухайн шийдвэрийн улмаас тус бүс нутагт химийн онц аюултай хорт бодис тархсан гэдэг нь нотлогдоогүй байгаа болно. Үүнийг өргөдөл гаргагч иргэд болоод Үндсэн хуулийн цэцээс нотолж чадаагүй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.02.27 № 03**

### **Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ө., Ө.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч -Улсын Их Хурлын гишүүн Д., Г.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан 102 дугаар “Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд оруулсан саналыг хэлэлцсэн тухай” тогтоол

#### **Үндсэн хуулийн зөрчсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”
- Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..”
- Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... Улсын Их Хурлын гишүүн, төр, нам, олон нийтийн байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Ө.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурлаас Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн тогтоохдоо “Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-гийн “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хуулиар хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн шийдвэр гаргаснаараа Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх

нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин есдүгээр дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчин Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн халдашгүй байдалд хууль бусаар халдах боломжийг бүрдүүлж, эрх зүйн буруу жишиг тогтоож байна.

## 2. Иргэн Ө.-гийн мэдээллийн агуулга:

Улсын Их Хурал дээрх тогтоолыг гаргаснаараа шүүх, прокурорын үүрэг гүйцэтгэж үнэн хэрэгтээ тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон гэж дүгнэж болно. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалттай харшилж байна. Зүй нь Улсын Их Хурал өөрт нь уг асуудлаар удаа дараа хандаж буй Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлаар байр сууриа илэрхийлсэн тогтоол гаргах ёстой байсан атал байцаан шийтгэх зарим ажиллагаа явуулах тодорхой заалт өгчээ. Харин энэхүү арга хэмжээг гагцхүү Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн нөхцөлд, мөн Улсын Их Хурал “тогтоолоор” бус харин зохих хуульд заасан журмаар хэрэгжүүлэх учиртай. Гэвч Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд хуульд заасан журмаар бус тогтоолоор халдаж болдог жишиг тогтоосноороо Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн алхам Улсын Их Хурал хийлээ.

Улсын Их Хурал дээрх тогтоолыг хэлэлцэн батлахдаа Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-г иш үндэс болгожээ. Өөрөөр хэлбэл хуулийн хориглосон заалтыг үндэслэж Улсын Их Хурал зөвшөөрөл олгосноороо Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчиж байна.

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал бол гишүүнээс эрх, үүргээ саадгүй хэрэгжүүлэх явдлыг хангах баталгаа юм. Парламентын гишүүний халдашгүй байдлын талаар дэлхийн улс орнуудад баримталдаг нийтлэг ойлголт бол парламентын аль нэг танхимын зөвшөөрөлгүйгээр тухайн гишүүний эсрэг эрүүгийн хэрэг үүсгэдэггүй байна. Энэ жишгээр гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хуулиар хориглосон байдаг.

Улсын ерөнхий прокурор гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд тавихдаа “нэр бүхий гишүүд гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нотлох зорилгоор” гэж тодорхойлон зөвхөн “гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэлд нэгжлэг, баримт бичгүүдэд үзлэг хийх шаардлагатай” гэсэн үндэслэлээр санал тавьсан. Мөн Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө бүрэн эрхийгээ түдгэлзүүлэх шаардлагагүй харин гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэлд үзлэг, нэгжлэг хийхийг сайн дураараа зөвшөөрсөн хүсэлтийг Улсын ерөнхий прокурорт тэр үед хандаж бичгээр гаргасан. Улсын ерөнхий прокурорын тавьсан саналын үндсийг нь Улсын Их Хурал зөвшөөрч өгсөн.

Ө., Ө. нар эдгээр гишүүдийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэнгүй гэсэн санааны үүднээс хуулиас янз бүрийн ишлэл авч түүнийгээ Үндсэн хууль зөрчсөн мэтээр тайлбарласан нь ойлгомжгүй байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдлыг хамгаалах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэхдээ эрхийг түдгэлзүүлэх нэрийн дор гишүүдийг нотлогдоогүй, нотлохоор ажиллаж байгаа үйлдлээр тэднийг хэрэгт холбогдуулан татахыг урьтал болгохгүйгээр, эрхээ хэрэгжүүлэх баталгааг аль болохоор

хангаж өгөхүйцээр шийдвэрийг гаргуулахаар санал тавьсан бөгөөд энэ талаар Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхгүй.

Гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг урьд нь Улсын Их Хурал тогтоолоор шийдэж байсан, ийм жишиг нэгэнт тогтсон билээ. Үүнийг хууль дээдлээгүй хууль зөрчсөн гэж хэн ч үзэж байгаагүй, ингэж үзэх үндэс ч үгүй юм. Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоол бол Улсын Их Хурлын тухай хуулийн гишүүний бүрэн эрхийн баталгаатай холбоотой тодорхой асуудлыг хэрэгжүүлж байгаа эрх зүйн акт юм. Улсын Их Хурал хуулиа хэрэгжүүлэх тогтоол гаргах эрхтэй. Энэ нь хуулиар шийдвэрлэх асуудлыг тогтоолоор шийдвэрлэсэн гэж маргах үндэсгүйг харуулж байна. Нэг талаас гишүүний халдашгүй байдал, нөгөө талаас бүрэн эрхийн асуудал хоёр тусдаа ойлголт юм. Гишүүний холбогдолтой асуудлаар үзлэг, нэгжлэг хийх нь заавал эрх түдгэлзүүлэх замаар шийдвэрлэгдэх ёстой мэтээр махран чармайж маргаан үүсгэх нь Үндсэн хуулиа зөв хэрэгжүүлэхэд саад болох, түүгээр ч үл барам хортой нөлөө үзүүлэх талтай гэж үзэх үндэс байна.

Улсын Их Хурлын гишүүн Б., З. нарт холбогдох хэргийг саяхан прокуророос хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Хэрэв Улсын Их Хурал энэ 2 гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гаргасан бол сонгогчдын эрх ашиг хохирох, гишүүд “хэлмэгдсэн” байх байлаа.

Ө.-гийн “эрх зүйн байдлыг дордуулсан”, “халдашгүй байдалд хууль бусаар халдах боломж бүрдүүлсэн” гэж хэлсэнтэй харьцуулбал харин ч эдгээр гишүүд хуулиар олгогдсон бүрэн эрхээ энэ хугацаанд эдэлсэн байна. Хуулийг догматикаар хэрэглэвэл ийм аюултай байж болохыг амьдрал өөрөө харууллаа. Улсын Их Хурлын гишүүн төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг илэрхийлдгийн хувьд үүргээ бүрэн эрхийн хугацаа дуустал хэрэгжүүлэхийг бид чухалд үздэг. Энэ нь Үндсэн хуулийн энэ талаархи заалтыг хэлбэрэлтгүй сахиж байгаагийн баримт мөн. Бид үүнийг үндэс болгон гишүүдийг сонгосон сонгогчдын төрд төлөөлөх эрхийг аль болохоор хамгаалсан. Ийнхүү Улсын Их Хурлын энэ удаагийн гаргасан шийдвэр нь “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд хууль бусаар халдах боломжийг бүрдүүлж, тэдний эрх зүйн байдлыг илт дордуулж, эрх зүйн буруу жишиг тогтоосон” гэсэн хийсвэр дүгнэлтэд амьдрал өөрөө бодитой хариу өгөв.

Иргэн Ө. “Улсын Их Хурал шүүх, прокурорын үүрэг гүйцэтгэсэн, үнэн хэрэгтээ үйл ажиллагаанд нь хутгалдан хөндлөнгөөс оролцсон”, “байцаан шийтгэх зарим ажиллагаа явуулах тодорхой заалт өгчээ” гэсэн дүгнэлт хийжээ. Асуудлыг ингэж ярих нь утгагүй бөгөөд тэгвэл прокурор өөрөө Улсын Их Хурлыг байцаан шийтгэх ажиллагаанд оролц гэсэн санал тавьсан юм шиг санаа цаана нь гарч байна.

Прокурорын зүгээс гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал тавих нь хуулийн дагуу хэнд ч ойлгомжтой, зүй ёсны зүйл. Харин энд асуудлыг тавихдаа “нэр бүхий гишүүнд гэмт хэрэг үйлдсэнийг тогтоох зорилгоор” гэж тодорхой тэмдэглэсэн байгаа. Гэтэл Цэцэд өгсөн Ө.-гийн мэдээлэл, Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох тухай Өн.-ийн өргөдлийн агуулгаас үзэхэд мөрдөн байцаалтын шатны ажлыг гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, тодорхой болсон нөхцөлтэй хутган, мэдэхгүйдээ, эсхүл мэддэг атлаа зориуд будилж асуудлыг тавьсан байна. Улсын Их Хурлын гишүүний гэм буруутай эсэхийг шүүх тогтоосноор л эрх түдгэлзүүлэх асуудал эцэслэн яригдах нь хэнд ч ойлгомжтой. Харин үзлэг, нэгжлэг хийхдээ гишүүний бүрэн эрхэд халдахгүйгээр шийдвэрлэгдэх арга зам байгааг амьдрал өөрөө харууллаа.

Үндсэн хуулийн заалтыг ишлэл болгон авч гишүүнийг түдгэлзүүлэх шаардлагыг хангасангүй гэж “гоморхон” түүнийгээ Үндсэн хууль зөрчлөө гэдгээр “халхалсан” байдал ч энд ажиглагдаж байна. Тэд бас тал засан гишүүдийн халдашгүй байдлыг дордуулж хүндрүүлсэн гэсэн дүр эсгэжээ.

Эдгээр өргөдөл, мэдээлэл нь заавал эрхийг түдгэлзүүлэхийг шаардсан агуулгатай юм. Жишээ нь: Ө.-гийн “зүй нь Улсын Их Хурал өөрт нь уг асуудлаар удаа дараа хандаж буй Ерөнхий прокурорын санал, хариуцлагыг иш үндэс болгон зарим гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлаар байр сууриа илэрхийлсэн тогтоол гаргах ёстой” гэж улаан цайм хэлснээс үзэхэд, удаа дараа Их Хурлын гишүүдийн эрхийг түдгэлзүүлсэнгүй гэж Улсын Их Хурлыг зэмлэсэн аястай юм. Хуулиараа бол “түдгэлзүүлэх эсэхийн” аль нэгээр Улсын Их Хурал өөрөө шийдвэрлэх эрхтэй.

Ардчилсан төрийн дархлаа, чадамжийг хомсдуулах бус харин ч гишүүдтэй холбогдсон асуудлаар үнэн мөнийг зөв шударгаар олох, олон улсын түвшинд ард түмний элч төлөөлөгчдийн эрхийг зөрчдөг улс болж хувирахгүй байх, төрөө улам бэхжүүлэх шаардлага өнөө үед анхаарал татахаар түвшинд байгаа бөгөөд үүнтэй зэрэгцэн гишүүдийн эрх түдгэлзүүлэхийг махран чармайх, нэр хүндийг нь гутаах оролдлого цөөнгүй гарч түүнийгээ Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн мэтээр халхавчлан тайлбарлах үзэгдэл гарах болсон нь нууц биш.

Улсын Их Хурлын 102 дугаар тогтоол бол Үндсэн хууль зөрчөөгүй, харин ч Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх түдгэлзүүлэх, эс түдгэлзүүлэхийн өмнөх шатанд асуудалд нухацтай хандах боломж байгаагийн илэрхийлэл, гишүүдийн бүрэн эрхийн баталгааг хангах талаас хандсан, Үндсэн хуулийн хүрээнд эрх түдгэлзүүлэх, эс түдгэлзүүлэх болон гишүүний бүрэн эрхийн баталгааны асуудлыг тодотгосон, цаашид зөв жишиг тогтоосон шийдвэр болсон юм. Үндсэн хуулийн цэц энэ асуудлаар маргаан үүсгэсэн нь үндэслэл багатай болохыг тэмдэглэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ...”; Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.13-т “Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг... нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэж тус тус зааснаас үзэхэд Улсын Их Хурал Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг л шийдвэрлэх эрхтэй болох нь тодорхой байна.

2. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-д хуульчилсан хирнээ хуулиар хориглосон зохицуулалтыг тогтоолоор зөвшөөрсөн нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

3. Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоолыг хуулийн ямар зүйл, заалтыг удирдлага болгон баталсан нь тодорхойгүй, түүнчлэн уг тогтоолыг Улсын Их Хурал баталснаараа Үндсэн хуулиар олгогдсон өөрийн бүрэн эрхээ хэтрүүлсэн гэх үндэслэлтэй байна.

4. Дээрх тогтоолоор Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг зөвшөөрсөн нь шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцсон гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Улсын ерөнхий прокурорын саналыг хэлэлцсэн тухай” 102 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Энэхүү тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...Улсын Их Хурлын гишүүн, төр, нам, олон нийтийн байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Улсын Их Хурлын 2007 оны 102 дугаар тогтоолын үйлчлэлийг 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 3 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 20 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд оруулсан саналыг хэлэлцсэн тухай" Улсын Их Хурлын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 102 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин есдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага /парламентаас баталсан хууль болон бодлогыг түүний хяналтад хэрэгжүүлдэг/-уудын зүгээс парламентын гишүүнийг хилс хэргээр эрүүгийн хариуцлагад татахаас хамгаалахад гишүүний халдашгүй байдлын зарчмын гол зорилго оршдог. Парламентын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт хэргийн үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд халдашгүй байдлын зарчим үйлчлэхгүй байх боломжтой.

Монгол Улсын хувьд Улсын Их Хурлын гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх зохицуулалтыг Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуульд тусгасан байдаг.

Харин үүнээс бусад тохиолдолд буюу тодруулбал, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлээгүй үед гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7-д зааснаар хориглоно. Гэтэл 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их



Хурал "Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд оруулсан саналыг хэлэлцсэн тухай" 102 дугаар тогтоол гаргахдаа энэхүү хориглосон зохицуулалтыг зөрчиж нэр бүхий гишүүдийн гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг зөвшөөрсөн нь Үндсэн хуулийн зөрчилд хүргэсэн байна.

Мөн түүнчлэн нийтийн эрх зүйн нийтлэг зарчим болох захирамжилсан шийдвэрийг гаргагч нийтийн эрх зүйн субъектын хувьд хуулиар зөвшөөрөөгүй буюу бүрэн эрх олгогдоогүй бүхэн хоригтой байх зарчмыг илт бүдүүлгээр зөрчсөн байгаа юм. Ер нь энэхүү нийтийн эрх зүйн зарчмыг сүүлийн жилүүдэд мушгин гуйвуулах, иргэнд хамаарах хувийн эрх зүйн үндсэн зарчим болох хориглоогүй бүхэн зөвшөөрөгдөнө гэсэн зарчимтай хольж хутгаж өөрсдөдөө ашигтайгаар хэрэглэж, илтэд зөрчих үзэгдэл газар авч байгаагийн тод жишээний нэг илрэл бол энэ юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.02.29 № 04**

### **Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль<sup>99</sup>

- 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт "Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох"

- 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт "энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..."

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"

- Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална"

99 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 оны № 39-д нийтлэгдсэн

- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах,”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Л., Б. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох” мөн 8.1.5-т “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр суурьнаас хандаж үг хэлэх, санал хураалтанд оролцох” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дараах зүйлийг зөрчсөн байна. Үүнд:

1/ Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

2/ Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”

3/ Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална”

4/ Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн байна.

Иймд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн “Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтуудыг хүчингүй болгож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Д. нарын тайлбарын агуулга:

Аливаа улс оронд “нийгмийн ашиг сонирхол болон өөрсдийн /хувийн/ үзэл бодлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдэж” нам байгуулах үйл ажиллагаа нь тухайн нийгмийн улс төрийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр байдаг. Тийм ч учраас 2005 онд батлагдсан Улс төрийн намын тухай Монгол Улсын хуулийн 4.1-д “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж тодорхойлсон. Энэ нь аливаа намын гол зорилго нь засгийн эрхийг барихын төлөө үйл ажиллагаа байдаг. Ялангуяа, улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөр нь нийт иргэн, улсын ашиг сонирхлыг хамгаалсан, нийгмийн амьдралын төлөө юу хийж чадах тэр бүхнийгээ төлөвлөн дэвшүүлэн тавьдаг. Тухайн намын энэхүү мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө ард түмнийгээ төлөөлөн парламентын гишүүн ажиллах шаардлагатай болдог. Энэ агуулгаар аваад үзэхэд сонгогч нэр дэвшигчийг дэмжиж санал өгч байгаа ч тэр нэр дэвшигчийн харьяалах намын мөрийн хөтөлбөрийг дэмжиж байгаа хэрэг гэж үздэг.

Тухайн нам нь Монгол Улсын хууль тогтоомж, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлсон мөрийн хөтөлбөртэй байдаг бөгөөд хувь хүн хувийн

үзэл бодол, санаагаараа тэдгээрийг дэмжиж, түүнтэй санал нэгдсэний үндсэн дээр гишүүн нь болж үйл ажиллагаанд нь оролцдог. Энэ байдал ч парламентад суудалтай намуудын үйл ажиллагаанд илэрхийлэгдэж байдаг. Улсын Их Хурал дахь намын бүлэг бүрээр хэлэлцэж байгаа асуудал нь сайн шүүгдэж, нэгдмэл санаанд хүрсэн бол чуулганы хуралдаан дээр үр ашиггүй маргаан, санал зөрөлдөх явдал бага гарна гэж үздэг. Энэ жишиг парламентад улс орнуудад нийтлэгээр дагаж мөрдөгдөж байна. Улс төрийн намын бүлэг нь парламентын ганц гишүүнээс илүүгээр Засгийн газар, нийгэм хоёрыг холбох гол үүргээ гүйцэтгэж чаддаг болох нь амьдралаар нотлогдсон гэж үздэг. Нөгөө талаар намын сахилга бат бол парламент дахь улс төрийн намын бүлгийн чадвар, түүний гишүүдийнх нь удирдлагынхаа бодлогыг хэр дэмжиж байгаад оршдог.

Олон улсын практикаас харахад ардчилсан либерал үзэл ихэвчлэн намын лидерүүд парламентын гишүүн болж байдаг буюу “удирдлагыг дамжуулдаг” тогтолцоо байдаг. Намын сахилга бат нь Вестминстер тогтолцооных шиг болон Англи, Канад, Австрали, Энэтхэг шиг их хатуу байх хандлагатай байдаг. Энэ нь Засгийн газрын эсрэг парламентад санал хураалгадаггүй байдал нь Засгийн газрын бодлогыг “унагах, сүйрэлд” оруулахгүй байхаар тохиролцохоос гадна намын байр суурийг гишүүд дэмжиж ажилладагтай холбоотой юм. Энэ нөхцөл байдалд өөрийн намын хүсэл, бодлогын эсрэг ажиллах гишүүд ховор байдаг. Тийм учраас намын байр суурийг харгалзан парламентын санал хураалтад оролцдог байна. Онолын хувьд парламентын гишүүн бол ард түмний элч, тэднийг төлөөлж байдаг. Гэхдээ практикт парламентын гишүүн нь намаас нэр нь дэвшигдэж, ард түмэн түүнийг сонгох, эс сонгохоо шийддэг. Тухайн нэр дэвшигч ард түмнээс сонгогдож гарч ирдэг боловч өөрийн харьяалах намтайгаа гэрээ байгуулж нэг талаас улс төрийн бодлогыг тодорхойлоход намын байр суурийг, нөгөө талаас ард түмний нийтлэг эрх ашгийг тус тус илэрхийлж оролцох шаардлагатай болдог. Энэ агуулгаар авч үзвэл ямарч нөхцөлд парламентын гишүүн хоёрдмол байр сууринд ирдэг. Иймээс ихэнх улс оронд парламентын гишүүний энэхүү хоёрдмол байр суурийг зохицуулах үүднээс тодорхой асуудлуудыг ялангуяа улс төрийн бодлогын үүднээс хандах асуудалд парламент дахь намын бүлгийн баримталж байгаа зарчим, бодлогыг дагаж мөрдөхөөр зохицуулдаг нь үүнтэй холбоотой юм.

Гэхдээ зөвхөн улс төрийн шалтгаанаар ийнхүү нэгдэж ажилладаг бөгөөд ийм ч учраас бүх асуудлаар бус зөвхөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, улсын төсвийг хэлэлцэхэд л Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгож гишүүн байр сууриа илэрхийлж байхаар тусгасан юм. Ялангуяа парламентад олонхи суудал авсан улс төрийн намын үйл ажиллагааны болон сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болдог бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг тул намын сахилга батыг илүү харгалзах шаардлага гарч байдаг.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д тусгайлан заасан асуудлаас бусад асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн өөрийн үзэл бодол, байр суурьнаас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцохоор заасан бөгөөд энэ заалтыг мөн адил Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн тухай өргөдөл гаргагчид үзсэн байна. Хуулийн 8.1.4-т тусгайлан заасныг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн атлаа өөрийн үзэл бодлоор хандах энэ заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хоорондоо зөрчилдөж байна. Улсын Их Хурлын гишүүний нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмаар, эсхүл өөрийн үзэл бодлоор хандахын аль алиныг нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь ойлгомжгүй байна.

Тэгвэл гишүүн асуудалд хэрхэн хандах ёстой вэ, өөр гурав дахь хандлагаар хандах хэрэг гарч байгаа биш үү. Тэгээд ч өргөдөл гаргагчид Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд нь ямар үндэслэлээр Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа талаар огт дурдаагүй байна. Өөрөөр хэлбэл, иргэн Л., Б. нар Цэцэд өргөдөл гаргахдаа түүнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд Үндсэн хуулийн тухайн заалтуудтай зөрчилдөж байгаа үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог тусгаагүй байна. Мөн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаж өргөдөл, мэдээлэл нь энэ хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж тогтоол гаргахаар заасан.

Дээр дурдсан үндэслэлээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлгүй гэж үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах Үндсэн хуулийн үүрэгтэй атал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэхэд “гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгож байхаар” хуульчилсан нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлтэй байна.

Харин дээрх заалтаар Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх хөндөгдсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох” мөн 8.1.5 дахь заалтын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох” мөн 8.1.5 дахь заалтын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний

бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” гэснийг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 8.1.5 дахь заалтын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад...” гэсэн хэсгийн үйлчлэлийг 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт, мөн хуулийн 8.1.5-ын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдөр буюу 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Өргөдөл гаргагч нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “...хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэхэд гишүүн өөрийн байр сууриас хандаж үг хэлэх, санал хураалтад оролцох” гэсэн хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалт зөрчсөн гэсэн шаардлагаасаа Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад татгалзсан байна.

Улсын Их Хурлын гишүүн нь төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах үүрэг бүхий төрийн өндөр албан тушаалтан юм. Энэ талаар ч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхой тусгасан байдаг.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгохыг үүрэг болгон хуульчилж /тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 8.1.5 дахь заалтыг зарим хэсэгт/ өгсөн нь тухайн асуудалд Улсын Их Хурлын гишүүн өөрийн үзэл бодлоор хандах эрхийг боогдуулж, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах үүргийг хөсөрдүүлж, улмаар намч байр сууриас буюу намын даалгаврыг биелүүлэгч болгох нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалт болсон байсан.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2008.05.07 № 02

**Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.1.4, 8.1.5 дахь заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л., Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., С.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, мөн хуулийн 8.1.5-ын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 4 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна.

2. Улсын Их Хурлын 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, мөн хуулийн 8.1.5-ын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад” гэсэн хэсэг нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна” гэсэн атлаа үндэслэлээ нотолж, нөхцөл байдлыг үгүйсгэж чадахгүй байгаа нь уг тогтоолыг хүчингүй болгох үндэслэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг томилох, чөлөөлөх, огцруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв зэрэг асуудлыг хэлэлцэхэд гишүүн нам, эвслийн бүлэг дээр тогтсон бодлого, зарчмыг удирдлага болгох”, мөн хуулийн 8.1.5 дахь заалтын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад ..” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэснийг тус тус зөрчсөн байх тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, мөн хуулийн 8.1.5 дахь заалтын “энэ хуулийн 8.1.4-т зааснаас бусад..” гэсэн хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 4 дүгээр дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 22 дугаар тогтоолыг 2008 оны 5 дугаар сарын 7-ны өдрөөс хүчингүйд тооцугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хөндсөн гэж үзэх боломжгүй байгаа юм. Учир нь тухайн зохицуулалтын үндсэн дээр нам, эвслийн бүлэг нь төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах эрхийг өөрт авч байна хэмээн хэт өргөн хүрээнд дөвийлгөн тайлбарлах боломжгүй.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.04.16 № 05**

**Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл,  
түүний тайлбар нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг  
зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Өргөдөл гаргагч - Монгол Улсын иргэн Г.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ш.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн тухай хууль<sup>100</sup>

- 263 дугаар зүйлийн 263.1 дэх хэсэг “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”

- 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэг “Энэ хэргийг давтан үйлдсэн, уг хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

**Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

<sup>100</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 5-д нийтлэгдсэн

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно”

- Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”

- Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэг “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно”

- Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Г.-гийн өргөдлийн агуулга:**

2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлан гаргасан Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, түүнд оруулсан тайлбар нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан заалтуудтай зөрчилдөж улс төрийн зорилгоор ашиглагдаж байх тул Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгүүлэн дүгнэлт гаргуулахыг хүсч байна.

Төрийн улс төрийн удирдах албан тушаалтнуудын гаргасан тушаал шийдвэрүүдээс болж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хэн нэгэн иргэний эрх ашиг, сонирхолд их хэмжээний хохирол учирсан мэтээр, тухайн албан тушаалтныг албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэрэгт улс төрийн зорилгоор, захиалгаар хууль хяналтын байгууллагад хэн дуртай нь гомдол гаргахад л Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд холбогдуулж болохоор байна.

Тэр ч байтугай төрийн улс төрийн удирдах албан тушаалтны гаргаагүй тушаал шийдвэрийг гаргасан мэтээр, мөн түүнээс болж иргэд, аж ахуйн нэгжид хохирол



учирсан мэтээр зориудаар болон захиалгаар гаргасан гомдлоос үүдэн энэ төрлийн гэмт хэрэгт хилсээр шалгагдаж тэр битгий хэл шийтгэгдэж байсан практик жишээ гадаадын улс орнуудад бий. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн тохиолдолд төрийн улс төрийн удирдах албан тушаалтан нь 5 жил хүртэл хугацаагаар төрийн тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхгүй болж байгаа нь улс төрч, удирдах албан тушаалтны хувьд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй..." гэсэнтэй зөрчилдөж байна.

Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл нь төрийн улс төрийн удирдах албан тушаалтнуудын хувьд шударгаар улс төрийн албан тушаал хашиж байсан, хашиж байгаа хүмүүсийн улс төрийн болон сонгуулийн үйл ажиллагаа, нэр хүнд зэрэгт сөргөөр нөлөөлж, цаашид Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдлэхэд харшилж байна.

Албан тушаалын гэмт хэргийн субъект нь байгууллага, албан газар, аж ахуйн нэгжид захирамжлах, зохион байгуулах, захиргаа, аж ахуйн албан үүрэгтэй этгээд, засгийн төлөөлөгч, тусгайлан олгосон бүрэн эрхтэй хүмүүс байдаг атал Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт улс төрийн... удирдах албан тушаалтан байна гэсэн тайлбар "нэмж" оруулсан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, 10 дахь заалтыг тус тус зөрчиж байна. Хуулийн энэ заалтыг улс төрийн захиалгат үйл ажиллагаанд эсрэгээр ашиглах, хууль хяналтын байгууллагынхныг энэхүү үйл ажиллагаандаа татан оролцуулах сөрөг үр дагавартай байгаа тул маргаан үүсгэн шалгаж дүгнэлт гаргаж өгнө үү.

2000 оны сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хуралд миний бие ганцаар цөөнх болж, улс төрийн тэмцлийг тасралтгүй явуулж ирсэн билээ. Тухайн үед надад эрүүгийн хэрэг үндэслэлгүйгээр үүсгэн шалгаж, цагдан хорьж байв. Гэвч би ямар нэгэн гэмт хэрэг үйлдээгүй тул намайг суллаж, хэргийг хэрэгсэхгүй болгож байсан нь улс төрийн захиалгат үйл ажиллагаа гэж үзэхээс өөр аргагүй юм.

2004 оны сонгуулиар миний бие нь Улсын Их Хуралд дахин сонгогдож улс төрийн тэмцлээ үргэлжлүүлсэн. Намайг мөрдөн мөшгих явдал төгсгөл болсонгүй, одоог хүртэл үргэлжлэн надаас өө сэв хайсаар 2006 онд Эрүүл мэндийн сайдаар томилогдон ажилласан үедээ гэмт хэргийн шинжтэй ямар нэгэн үйлдэл хийсэн байж болзошгүй гэсэн үндэслэлээр ХӨСҮТ-ийн захирлаар ажиллаж байсан О.-гийн хэрэгт намайг сэжигтнээр гэнэт татаж, төрийн улс төрийн удирдах албан тушаалтан хэн боловч субъект нь болж болох Эрүүгийн хуулийн 263-ын 2-ыг зориуд сонгосон нь надад ихээхэн хохиролтой байдлыг бий болгож байна. Энэ зүйл ангид заасан гэмт хэрэгт улс төрийн удирдах албан тушаалтан хэнийг ч болов холбогдуулан үүгээр далимдуулан улс төрийн тавцангаас буулгах, бүрмөсөн шахан зайлуулах, улс төрийн захиалгат үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглах боломжийг нээж өгсөн байна.

Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1-ийн "Улсын Их Хурал далан зургаан гишүүнтэй байна", Хорин есдүгээр зүйлийн 2-ын "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэсэн Улсын Их Хурлын гишүүн миний Үндсэн хуульд заагдсан эрхүүдийг зөрчин Авлигатай тэмцэх газраас Улсын Их Хурлын гишүүний эрхийг минь түдгэлзүүлэх, мөн гэр орон, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нэгжлэг, үзлэг хийхээр зөвшөөрөл авсан хэдий ч үзлэг, нэгжлэгийн алийг нь ч хийгээгүй ба Авлигатай тэмцэх газраас үзлэг, нэгжлэг хийхгүй гэсэн албан ёсны хариуг надад өгсөн билээ.

Үзлэг, нэгжлэг хийхгүй атлаа Улсын Их Хурлын гишүүний эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Улсын Их Хуралд оруулсан нь зохион байгуулалттай улс төрийн хэлмэгдүүлэлт мөн болохыг баталж байна. Мөн Улсын Их Хурлын зарим гишүүдийн эрхийг түдгэлзүүлэх

асуудлыг Улсын Их Хуралд оруулсан хэдий ч үзлэг, нэгжлэг хийхгүйгээр, мөн тэдэнд холбогдуулж буй эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж байгаа нь мөн л улс төрийн захиалга байгаа нь харагдаж байна.

2008 оны Улсын Их Хурлын сонгууль цаг хугацааны хувьд ойртож ирсэн өнөө үед намайг үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт холбогдуулан Эрүүгийн хуулийн 263-ын 2-оор яллуулахаар эрмэлзэж байгаа нь намын харьяаллаар нь ялгаварлан гадуурхаж, мөн Үндсэн хуульд заагдсан миний сонгогдох эрхийг хязгаарлаж, Улсын Их Хуралд дахин сонгуулахгүй байх, улмаар хэлмэгдүүлэх оролдлого, санаархлаа гүйцэлдүүлэхэд ашиглаж байгаа нь илэрхий байна.

Над руу чиглэсэн энэхүү зохион байгуулалттай үйл ажиллагаа нь дараах байдлуудаар тодорхой харагдаж байна. Үүнд: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд урьдаас хөтөлбөргүй үнэн гэж тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 95.3, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг задруулахыг хориглоно гэсэн мөн хуулийн 189 дүгээр зүйл, мөрдөн байцаалтын мэдээ баримтыг задруулахыг хориглох тухай Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйл, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэсэн Үндсэн хуулийн Арван зургадугаар 14 дэх заалтыг тус тус зөрчин намайг улсын өмч хөрөнгийг их хэмжээгээр ашиглан шамшигдуулсан аюултай гэмт хэрэгтэн мэтээр харуулахаар оролдож Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтад хүргүүлсэн нууц мэдээ, баримтуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тарааж миний нэр хүндийг олон нийтийн дунд, тэр тусмаа миний тойргийн сонгогчдын дунд унагах зорилго агуулсан үйл ажиллагаа явуулж байгаа байдлуудаар нотлогдож байна. Мөн Улсын Их Хурлаар миний болон бусад нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг оруулсан ч үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлаас гаргасан 102 дугаар тогтоол, Улсын ерөнхий прокурорын газраас зарим гишүүдийн хэргийг хэрэгсэхгүй болгосон зэрэг нь улс төрийн хэлмэгдүүлэлт ид явагдаж байгааг нотолж байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийг баримтлан энэхүү өргөдлийг бичиж байгаа ба Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл болон тайлбарыг хүчингүй болгож өгнө үү.

## 2. Иргэн Г.-гийн нэмэлт тайлбарын агуулга:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, түүнд оруулсан тайлбар болох "... төрийн албан тушаалтан гэдэгт төрийн улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг хамааруулна" гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэсэн үндэслэлээр өргөдөл гаргасан билээ.

Миний өргөдлийн гол агуулга нь гэмт хэрэг үйлдээгүй байхад санаатайгаар, улс төрийн зорилгоор улс төрийн албан тушаалтныг энэ хуулийн заалтад хамруулан хэлмэгдүүлэх, хилс хэрэгт гүтгэх, улмаар улс төрийн сонгуульд нэр дэвших, сонгох, сонгогдох эрхийг хязгаарлахад ашиглаж болохоор байна гэж үзэж Улсын Их Хурлын гишүүн надад тохиолдож байгаа үнэн жишээ баримтуудаар нотолсон болно.

Үүнийг маань ч нотолсон хэрэг болж, миний өмнө гаргасан өргөдлийн агуулгад дурдсан үндэслэлийг хууль тогтоогч харгалзан үзэж 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөрөө засаж, "улс төрийн удирдах... албан тушаалтан" гэснийг хуулиас хассан байна.

Гэтэл мөн хуулийн 263 дугаар зүйлийн болон тайлбарт, нэмэлт өөрчлөлт оруулж "энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулахаар" заажээ. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн тайлбараас "төрийн улс төрийн" гэснийг хассан нь

хэлбэрийн төдийд хасагдсан байх ба нэмэлт, өөрчлөлтөөр орсон тайлбарт улс төрийн албан тушаалтан нь агуулгын хувьд удирдах албан тушаалтанд багтаж байгаагаараа өмнө дурдсан зөрчил арилаагүй байна.

Мөн түүнчлэн дээрх тайлбарт гүйцэтгэх албан тушаалтнууд энэ гэмт хэргийн субъект байхаар хүрээг нь өргөжүүлсэн байна. Төрийн гүйцэтгэх албан тушаалтнууд Төрийн албаны хуулийн дагуу дээд шатны албан тушаалтныхаа үүрэг даалгаврын дагуу захирах захирагдах зарчмаар ажилладаг. Гүйцэтгэх албан тушаалтан нь дээд шатны албан тушаалтнуудын өмнөөс энэхүү гэмт хэрэгт хамрагдахаар заагдсан байна.

### 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ш.-ийн тайлбарын агуулга:

Иргэн Г. өргөдөлдөө “улс төрийн албан тушаалтнуудын гаргасан тушаал шийдвэрүүдээс болж аж ахуйн нэгж, байгууллага, хэн нэгэн иргэний эрх ашиг сонирхолд их хэмжээний хохирол учирсан мэтээр тухайн албан тушаалтныг албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэрэгт улс төрийн зорилгоор, захиалгаар хууль хяналтын байгууллагад хэн дуртай нь гомдол гаргахад л Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд холбогдуулж болохоор байна. Энэ зүйл улс төрийн удирдах албан тушаалтны улс төрийн болон сонгуулийн үйл ажиллагаа, нэр хүндэд сөргөөр нөлөөлж, цаашид Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдлэхэд харшилж байна” гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хууль нь Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэсэн бөгөөд ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоосон эрх зүйн акт юм.

Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд заасан хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, Арван зургадугаар зүйлд заасан амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх, хуульд зааснаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон, хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэм буруутайд тооцож үл болох зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан зарчмууд манай Эрүүгийн хуульд тусгалаа олсон билээ. Тухайлбал Эрүүгийн хуульд заасан Хууль ёсны зарчим /3 дугаар зүйл/, Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим /5 дугаар зүйл/, Шударга ёсны зарчим /6 дугаар зүйл/, Энэрэнгүй ёсны зарчим /7 дугаар зүйл/ зэргийг дурдаж болно. Үүнээс үзэхэд Эрүүгийн хуулийн бүхий л хэм хэмжээ нь Үндсэн хуультай бүрнээ нийцсэн гэж үзэж болно.

Эрүүгийн хуульд албан тушаалын гэмт хэргийн тусгай бүлэг бий /28 дугаар бүлэг/ Хуульд энэ төрлийн гэмт хэргийн талаар тодорхойлолт өгөөгүй ч гэсэн албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх, хуурамч баримт бичиг үйлдэх зэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг албан тушаалын гэмт хэрэг гэж үздэг. Албан тушаалын гэмт хэрэг “албан тушаалтан” гэсэн тусгай субьекттэй байдгаараа онцлог. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн тайлбарт “Энэ бүлэгт дурдсан гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна” гэж хуульчлан тайлбарласан байна.

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д төрийн албан тушаалыг төрийн улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилсан ба 5.3-т төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна гэж тодорхой заасан. Улсын Их Хурлаас 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн тайлбарыг өөрчлөн найруулахдаа Төрийн албаны хуулийн дээрх заалттай уялдуулсан болно.

Тухайн этгээдийн үйлдсэн хэрэг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар гэмт хэрэг болохыг тогтоон хэргийг зүйлчилдэг. Эрүүгийн хуулийн Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэсэн 263 дугаар зүйлийн объектив талын үндсэн шинж нь төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учруулсан байх явдал юм. Эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах хэлбэр нь үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрч болдог. Энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн нь давтан үйлдсэн, их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан гэсэн шинж болно.

Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”, 9 дүгээр зүйлийн 9.1-д “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага заавал хүлээлгэнэ”, 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно”, 10.2-т “Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу байгуулагдсан шүүхээс өөр байгууллага, албан тушаалтан, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхийг хориглоно” гэсэн заалт байгааг дахин энд дурдъя.

Энэ бүгдээс үзэхэд өргөдөл гаргагчийн бичсэнчлэн Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийг төрийн улс төрийн удирдах албан тушаалтны улс төрийн болон сонгуулийн үйл ажиллагаа, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, улс төрийн тавцангаас шахан зайлуулах хэрэгсэл, улс төрийн захиалгат үйл ажиллагаа болгон ашиглаж байна гэж үзэж болохгүй.

Иймд Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, тайлбар нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Иргэн Г. өргөдөлдөө “Авлигатай тэмцэх газар үзлэг, нэгжлэг, хийгээгүй атлаа Улсын Их Хурлын гишүүний эрхийг түдгэлзүүлэх асуудлыг Улсын Их Хуралд оруулсан, Улсын прокурорын газраас Улсын Их Хурлын зарим гишүүдэд холбогдуулж буй эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж байгаа нь мөн л улс төрийн захиалга, Улсын Их Хурлын сонгууль цаг хугацааны хувьд ойртож ирсэн үед намайг үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэгт холбогдуулан Эрүүгийн хуулийн 263.2-оор яллуулахаар эрмэлзэж байгаа, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн заалтуудыг зөрчин намайг улсын өмч хөрөнгийг их хэмжээгээр ашиглан шамшигдуулсан аюултай гэмт хэрэгтэн мэтээр харуулахыг оролдож Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаалтад хүргүүлсэн мэдээ, баримтуудыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тарааж миний нэр хүндийг унагах зорилго агуулсан, улс төрийн хэлмэгдүүлэлт ид явагдаж байгааг нотолж байна. Мөрдөн байцаалтын ажиллагаа дан ганц яллах, хүндрүүлэх талыг баримтлан, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардаж гэм бурууг надад оноохоор улайран зүтгэж байгаа нь зохион байгуулалттай ажиллагаа гэж үзнэ” гэж бичжээ. Хуулийн байгууллага хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллаж байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах нөхцөл, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих прокурорын байгууллагын тухай хуулиар тодорхой тогтоон өгсөн. Иймд энэ асуудлаар Улсын Их Хурал тайлбар өгөх шаардлагагүй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “... Хүнийг... үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”, Арван зургадугаар зүйлийн 9-д “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, Арван зургадугаар зүйлийн 10-т “... аль нэг

нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно”, Арван зургадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”, Арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно”, Арван зургадугаар зүйлийн 18-д “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” Хорин есдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах” гэсэн 263 дугаар зүйлийн 263.1 дэх хэсгийн “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”, мөн зүйлийн 263.2 дахь хэсгийн “Энэ хэргийг давтан үйлдсэн, уг хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, мөн зүйлийн тайлбарт: “Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна” гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9, 10, 13, 14, 18, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Энэхүү маргааны хувьд өргөдөл гаргагч үндэслэлээ тодорхой гаргаагүй байна. Өргөдлийн гол агуулга нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйл болон түүний тайлбар Үндсэн хууль зөрчиж байгаа тул хүчингүй болгуулах тухай байдаг. Монгол Улсад төр байгаа цагт төрийн албан хаагч байх нь тодорхой бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангид ийм төрлийн гэмт хэргийг хуульчлан өгөх нь зүй зохистой юм. Өргөдөл гаргагч нь тухайн зүйлийг Үндсэн хууль зөрчсөн тухай тайбарлахдаа Улсын

Их Хурлын гишүүнд хамаатуулан тайлбарласан байх бөгөөд практикт гарсан жишээг иш үндэс болгосон байгаа юм. Энэ бол цэвэр хууль хэрэглэх арга ажиллагааны тухай асуудал бөгөөд Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд үл хамаарах асуудал байжээ.

Хууль тогтоогч нь ялын бодлогын хүрээнд онцгой бүрэн эрхийнхээ дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл заалт буюу ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохыг хуульчлан тогтоож өгдөг.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008.05.14 № 06

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б., Ө.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль<sup>101</sup>

- 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт “Нэр дэвшигч нь... дараах шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3-т “ялгүй байх”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “...эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”
- Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй”
- Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Б., Ө. нарын мэдээллийн агуулга:

1/ Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа тус хуулийн 27 дугаар зүйлийн 4-т “Нэр дэвшигч нь... дараах шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3-т “ялгүй байх” гэсэн ойлголтыг тодорхойлсон. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны

<sup>101</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

үндсэн зарчим мөн”, Арван зургадугаар зүйлд ”Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд 9 дэх хэсэгт “... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй” гэснийг зөрчиж байна. Учир нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т заасан “ялгүй байх” гэсэн алдаатай шинэ томъёолол нь Монгол Улсын дээд шүүхээс 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 12 дахь заалтад “Ялгүй байх гэдгийг Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан “ялгүйд тооцох”, “ялгүй болох” гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй тул үүнийг өмнө нь огт “ял шийтгүүлж байгаагүй гэнэ” хэмээн буруу тайлбар гарах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ нь Монгол Улсын иргэн бүх насаараа ялтай үр дагаврыг бий болгоод зогсохгүй социалист эрүүгийн хуулиар гэмт хэрэг хэмээн үзэж байсан үйлдэл, эс үйлдэхгүйг хийж ял шийтгүүлсэн болон эсхүл огт гэмт хэрэг хийгээгүй мөртлөө хилсээр ял шийтгэгдсэний төлөө өнөөдөр Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэнийхээ үндсэн эрх, эрх чөлөөг эдэлж чадахгүйд хүрч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй” гэснийг зөрчиж байна. Монгол Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу Монгол Улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөгөө саадгүй эдлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой бөгөөд ингэхдээ Үндсэн хуулийн үзэл баримтлал, хэм хэмжээнд захирагдаж, түүний агуулгаас гажиж болохгүй байдаг. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагад “сонгогдох” эрхийг зөвхөн хуулиар “нас”-ны хязгаарлалт тогтоохоор зохицуулсан байтал Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчид “ялгүй байх” гэсэн Үндсэн хуульд заагаагүй шаардлага тавьснаар Үндсэн хуулийн агуулгаас хальж, иргэнийхээ “сонгогдох эрх”-ийг хасч, тэдний эрх зүйн байдлыг дордуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно гэсэн үндсэн шаардлага /болзол/, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигч нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон зээл, батлан даалтын болон бусад гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байх, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй байх, ялгүй байх гэсэн хууль зүйн тусгай шаардлага тус тус тавигдсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигчид тавигдсан “ялгүй байх” гэсэн шаардлагын тухайд, хууль санаачлагч анх хуулийн төсөлдөө нэр дэвшигч “санаатай үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаагүй байх” гэсэн шаардлагыг хангасан байхаар тусгасан байсныг Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлгийн явцад хууль тогтоогч “ялгүй байх” гэж өөрчилсөн, өөрөөр хэлбэл, уг ойлголтод “огт ял шийтгэгдэж байгаагүй”, түүнчлэн “ял шийтгэгдэж байсан боловч Эрүүгийн хуулийн 78.2-т заасны дагуу ялгүй болсон, мөн хуулийн 78.3-т заасны дагуу ялгүйд тооцогдсон байх” ойлголтуудыг багтаасан.

Гэтэл Улсын дээд шүүх 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдөр гаргасан тайлбартаа мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3-т заасан “ялгүй байх” гэдгийг “үүнийг өмнө нь огт “ял шийтгүүлж байгаагүй” гэж ойлгон хэрэглэнэ” гэж тайлбарласан. Улсын дээд шүүхээс мөн оны 5 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн албан бичигт “Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчид “ялгүй байх” шаардлагыг Улсын дээд шүүх тайлбараараа биш харин Улсын Их Хурал хуулиар тогтоосон тул Үндсэн хууль, сонгуулийн тухай хуулийн бусад заалтад байхгүй энэ шалгуур хүний сонгогдох эрхийг зөрчсөн байх магадлалтай” гэсэн байна. Улсын дээд шүүхийн энэхүү тайлбар нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, агуулгатай зөрчилдсөн тайлбар болсон гэж хууль тогтоогч үзэж байгаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т "... Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ" гэж заасан боловч Улсын дээд шүүхийн дээр дурдсан тайлбар хүчин төгөлдөр байгаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд байгаа "ялгүй байх" гэсэн ойлголтыг эрх зүйн цоо шинэ ойлголт, хэм хэмжээ болгож хууль санаачлагчийн үзэл баримтлалаас өөрөөр хэрэглэх болгож байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтыг гишүүд ойлгохдоо өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй болон Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ял шийтгэлгүй болох, ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусгавар болсон хүнийг хамааруулан ойлгосон. Энэ ойлголтоороо санал хураалгаж уг хууль батлагдсан. Гэвч Улсын дээд шүүхийн тайлбар "ялгүй байх" гэдгийг "өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй хүнийг ойлгоно" гэж гарсан, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь хууль санаачлагчийн үзэл баримтлалаас өөрөөр тайлбарлагдаж, ойлгогдож байгаа тул хуулийн уг заалт Үндсэн хууль зөрчсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд буй "Ялгүй байх" гэсэн ойлголт нь уг хуульд Улсын дээд шүүхийн хийсэн тайлбар, Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргагчдын тавьсан үндэслэл болон бусад нотолгооноос үзэхэд өмнө нь огт ял шийтгүүлж байгаагүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.

2. Хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад "Ялгүй байх" гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт эйрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т "Нэр дэвшигч нь... дараах шаардлагыг хангасан байна" гээд 27.4.3-т "ялгүй байх" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т "... эрх чөлөө, тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван есдүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтын "ялгүй байх" гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн



авснаас хойш 15 хоногийн дотор багтаан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 6 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 38 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т “Нэр дэвшигч нь... дараах шаардлагыг хангасан байна” гээд 27.4.3-т “ялгүй байх” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа тус хуулийн 27 дугаар зүйлд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хуульчлахдаа “ялгүй байх” гэсэн ойлголтыг анх тодорхойлсон.

Хууль тогтоомжийг судлан үзэхэд “ялгүй байх” гэсэн ойлголтыг бусад хууль тогтоомжид урьд тодорхойлж байгаагүй байх бөгөөд өөрөөр хэлбэл, “ялгүйд тооцох”, “ялгүй болох” гэсэн ойлголтоос ялгаатай байдлаар томъёологдсон нь ял шийтгэлгүйд тооцох журмыг хэрэглэх боломжгүй болгосон байгаа юм. Иймд Улсын дээд шүүхээс уг ойлголтыг 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 12 дахь заалтаар тайлбарласан байх ба “өмнө нь огт “ял шийтгүүлж байгаагүй гэнэ” хэмээн тайлбарласан. Энэхүү тайлбараас улбаалан Үндсэн хуулийн зөрчил үүссэн гэж хэлэхэд дэгс болохгүй.

Учир нь ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дууссан байхад ч “ялгүй байх” гэсэн ойлголтын дор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид урьд гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан этгээд гэдэг утгаар улс төрийн эрх буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байгаа юм. Энэхүү зөрчил бол хууль тогтоогчийн арга ажиллагааны алдааны нэг гэж хэлж болох бөгөөд хууль тогтоомжийн нэр томъёоны асуудал дээр нэгдсэн бодлого дутагдаж байгаагийн нэг илрэл гэж үзэж болохоор байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008.10.10 № 07

### Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль<sup>102</sup>

- 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт “... хууль зүйн туслалцаа авах... эрхтэй”
- Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй”, 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” хэмээн заасан байна. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах... эрхтэй” хэмээн иргэний Үндсэн эрхтэй холбогдуулан баталгаажуулжээ. Үндсэн хуулийн дээрх заалтыг улам бүр баталгаажуулж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “өмгөөлөгч нь... хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй” мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.7, 36 дугаар зүйлийн 36.3.3-т өмгөөлөгч авах эрхтэйг тус тус заажээ.

Гэтэл 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” хэмээн заасан нь Үндсэн хуулийн дээрх үзэл санааг зөрчсөн төдийгүй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл харшлах шалтгаангүй хэн боловч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож болохоор ойлгогдож байгаа юм.

Түүнчлэн мэргэжил /эрх зүйч, хуульч/-ийн бус хүмүүс эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож, хууль зүйн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт гаргаж чадахгүй, эр

<sup>102</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 6-д нийтлэгдсэн

нөлөөтэй хууль зүйн туслалцаа үзүүлж чадаагүйнхээ төлөө мэргэжлийн болон ёс зүйн ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа нь иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохирооход хүргэж байна. Үндсэн хуулийн дээрх зөрчлийг арилгах нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хамгаалах, шүүх эрх мэдлийн нэр хүндийг өргөж, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

1/ Хүний эрхийг хангах баталгааны чухал бүрэлдэхүүн хэсэг бол өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх бөгөөд Үндсэн хуулиар үүнийг баталгаажуулж өгсөн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалтыг дангаар нь авч үзэх боломжгүй бөгөөд хуулийн бусад заалтуудтай уяалдуулан авч үзэх хэрэгтэй юм. Хүн өөрийгөө өмгөөлөх эрхтэйгээс гадна өмгөөлөгчөө өөрөө сонгох, солих эрхтэй бөгөөд энэ нь тухайн этгээдийн чөлөөт сонголтоор шийдвэрлэгдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39.1-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно” гэж заасан. Шүүх энэ эрхийг хангах боломжийг бүрдүүлж өгөх ёстой. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тохиолдолд өөрөө итгэж байгаа, өөртөө хэрэгтэй тэр туслалцааг үзүүлж чадна гэсэн этгээдийг сонгож, өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжийг мөн хуулийн заалтаар олгож байгаа юм. Нэн даруй хууль зүйн туслалцаа авах нь өөрийгөө хамгаалуулах эрхээ хангах урьдчилсан нөхцөл болно. Иймд хуулийн дээрх заалт иргэн Б.-гийн тайлбарласнаар “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна” гэж үзэж болохгүй юм.

2/ Харин ч мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тухайн тохиолдолд шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгож авснаар өөрийгөө өмгөөлөх эрх нь бас давхар баталгаажиж байгаа юм. Энэ тохиолдолд иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохирооход хүргэж байгаа биш эсрэгээрээ давхар хамгаалалттай болох нөхцөл бүрдэж байгаа юм. Хууль тогтоогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль ёсыг дээдлэн хэрэгжүүлэх нөхцөл хангагдах ёстой гэж үзэж энэ заалтыг оруулсан болно. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “...хууль зүйн туслалцаа авах... эрхтэй...” гэсэн хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

#### **Үндсэн хуулийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн заалт нь хууль зүйн боловсролгүй, хуульчийн сонгон шалгаруулалт болон өмгөөлөгчийн мэргэшлийн шалгаруулалтад орж тусгай зөвшөөрөл аваагүй иргэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрхтэйгээр оролцох хууль зүйн үндэслэл бий болгосноор байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн Үндсэн хуульд заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах боломжийг хязгаарласан байна.

Аливаа иргэн мэргэжлийн өмгөөлөгчийн эрх эдэлж, үүрэг биелүүлж, хариуцлага хүлээн өмгөөлөгчийн талаар гаргасан хууль, журмыг мөрдөж, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжгүй юм. 1994 оны Өмгөөллийн тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулахдаа дээрх заалтыг хассан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шилжүүлэн нэмж оруулсан нь ойлгомжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг

удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... хууль зүйн туслалцаа авах... эрхтэй...” гэсэн хэсэг, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 10 дугаар 10-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 27 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... хууль зүйн туслалцаа авах... эрхтэй...”, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “хууль зүйн туслалцаа” авах эрхтэй, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” хэмээн тус тус заасан байгаа юм. Эндээс үзэхэд хууль зүйн туслалцаа, хууль зүйн мэргэжлийн туслалцаа хэмээн тусгайлан зааж өгсөн хэмээн үзэхэд хүргэж байна. Хууль зүйн бөгөөд мэргэжлийн туслалцааг хэн үзүүлэх вэ гэхээр мэргэшсэн этгээд үзүүлэх нь ойлгомжтой.

Мэргэшсэн этгээд гэдэгт Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг буюу өмгөөлөгчийг хамааруулан ойлгох нь зүйтэй юм. Харин хэн дуртай этгээд мэргэжлийн өмгөөлөгчийн эрх эдэлж, үүрэг биелүүлж, хариуцлага хүлээн

өмгөөлөгчийн талаар гаргасан хууль, журмыг мөрдөж, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжгүй билээ.

Иймд Үндсэн хуулийн цэц Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн заалтыг Үндсэн хуулийн дээр дурдсан нь заалтуудыг зөрчсөн хэмээн үзсэн.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2008.11.19 № 03**

### **Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн заалт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн боловсролгүй, мэргэжлийн хуульч бус дурын этгээд оролцох боломжийг бий болгосноор иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах Үндсэн хуулиар бэхжүүлсэн баталгааг дордуулсан байна.

Ингэснээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь заалтын үзэл санаатай зөрчилдөж байна.

2. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай үндэслэл, нотолгоог гаргаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар

зүйлийн 14-ийн "... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах... эрхтэй..", Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.." гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 27 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэр нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийн талаархи эрх зүйн баримт бичиг /олон улсын гэрээ/, онолын ном зохиолуудад мэргэжлийн өмгөөлөгчийг заавал оролцуулна, мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийг хангах, өмгөөлөгчөөс туслалцаа авна гэсэн зарчмыг тусгасан байдаг байна. Үүнийг Монгол Улс хэрэгжүүлэх үүрэгтэй юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2008.10.29 № 08**

**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М., Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

- 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй"

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй"

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн М., Ц. нарын мэдээллийн агуулга:  
Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Эрүүгийн

байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 48 дугаар бүлэг /хуулийн 414 дүгээр зүйлээс 419 дүгээр зүйл хүртэл/-т эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн шинэлэг зохицуулалт нэмэлтээр оруулсан. Ингэхдээ эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргахгүй байхаар хуульчилжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчиж байна. Тодруулбал:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2-т “Шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 72 цагийн дотор шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан хэргийг шийдвэрлэн тогтоол гаргах ба шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй” гэж заажээ.

2007 оны 8 дугаар сарын 9-нд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Улсын дээд шүүхээс уг хуулийг хэрэглэх журмын тухай 2007 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн № 35 дугаар тогтоолыг гаргасан. Уг тогтоолын 17-д “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2-т заасан “...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй гэдгийг хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргахгүй гэж ойлгоно” гэж тайлбарлажээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 307 дугаар зүйлд шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжид гомдол, эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдлыг хуульчилсан байдаг. Эдгээр нь таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг өөрчлөх, хэргийн харьяалал тогтоох, шүүхээс шүүх хуралдааны дэгийг зөрчсөнд хариуцлага хүлээлгэх, хэргийг түдгэлзүүлэх зэрэг асуудлаар гаргасан шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжид гомдол эсэргүүцэл бичиж болохгүй тохиолдол байдаг. Энэ нь Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал биш бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангахад чиглэгддэг.

Харин эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шүүхээр шийдвэрлээд гаргасан шүүхийн шийтгэх тогтоол болон цагаатгах тогтоолд гомдол, эсэргүүцэл, бичиж болохгүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг ноцтой зөрчсөн явдал мөн.

## 2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хуулийн 414 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд, гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, хохирогч нар харилцан зөвшөөрсөн, хүсэлт гаргасан, хохирогч хохирлын талаар маргаангүй байх эдгээр гол нөхцөл бүрдсэн тохиолдолд явагдана. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээс татгалзсан, нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, хохирлын хэмжээ болон ногдуулах ялын талаар маргаантай бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдахгүй ба хэргийг ердийн журмаар шийдвэрлэнэ. Үүнийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 415, 416 дугаар зүйл болон 417 дугаар зүйлийн 417.4-т “Сэжигтэн, яллагдагч, хохирогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, эсхүл хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээс татгалзсан, хохирогч ялын талаар санал зөрсөн бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр прокурор тогтоол гаргана”, 418 дугаар зүйлийн 418.6-д “Хэрэг хянан шийдвэрлэх явцад яллагдагч, хохирогч нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж тодорхой заасан байна. Эндээс үзэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд яллагдагч, хохирогч хүсэлтээ гаргаж хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэх эрхтэй байна. Шүүх хуульд заасан шаардлага хангагдсан нөхцөлд хэргийг хянан шийдвэрлэх товыг зарлаж, шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгч, прокурорыг байлцуулан хэргийг шийдвэрлэж байгаа болно. Нэгэнт

өөрсдийн хүсэлтээрээ хэргээ шийдвэрлүүлж байгаа тул давж заалдах эрх зөрчигдсөн гэж үзэх үндэслэлгүй юм. Оролцогч нараас эргэлзээ төрвөл хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэн гарсан шийдвэрт нь хуулийн дагуу давж заалдах бүрэн эрх нь нээлттэй байгаа болно.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсгийн "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах" гэсэн хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргахгүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "... шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж зааснаар эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжийг шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгчдийн хувьд хааж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад, ялангуяа шүүхийн шатанд процессын журам зөрчигдсөн, эсхүл эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, шүүхээс оногдуулсан ялтай санал нийлээгүй тохиолдолд Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулсан эрхээ хамгаалуулах, сэргээн тогтоолгохоор шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй байхаар хуульчилсан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оногдсон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй болохыг заасан байна. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй..." гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "... шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй..." гэснийг зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсгийн "...шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 10 дугаар 29-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.



**“Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 32 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт “шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “шүүхийн шийдвэрийг давж заалдах... эрхтэй” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2008 оны 11 дүгээр сарын 13 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тэмдэглэл:**

Хүний эрхийн үндсэн ойлголт болоод онолын талаас аваад үзэхэд хэргийг хянах ажиллагааны нэр нь ямар байхаас үл шалтгаалан түүнийг дахин хянах ажиллагаа нь тухайн хүний ял шийтгэлийн хууль зүйн үндэслэл болон хэргийн бодит байдал аль алины үүднээс авч үзэх ёстойг илэрхийлж байдаг. Өөрөөр хэлбэл, дахин хянах ажиллагаа нь цэвэр хууль зүйн асуудлын зэрэгцээгээр, нотлох баримт болон шүүхийн ажиллагааг бүрэн дүгнэх ёстой байдаг. Энэ нь онол болон практикийн аль аль талаас аваад үзэхэд шүүгч болон шүүхийн үйл ажиллагаанд алдаа гарах магадлалтай байдагтай холбоотой. Иймд Үндсэн хуулийн хүний эрхийн талаарх заалт болон олон улсын хүний эрхийн талаарх баримт бичгүүдэд шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхийг тусгайлан тодорхойлж оруулсан байдаг билээ.

Хууль тогтоогчийн байр суурь болон хууль тогтоомжийг судлан үзэхэд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт “... шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй” гэж заасныг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргахгүй гэсэн агуулгыг илэрхийлсэн байсан. Хууль тогтоогч энэхүү зохицуулалтыг уг хуульд оруулснаараа эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад, ялангуяа шүүхийн шатанд процессийн журам зөрчигдсөн, эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байгаа, эсхүл шүүхээс оногдуулсан ялтай санал нийлээгүй шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгчийн шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хязгаарлаж Үндсэн хуулийн зөрчил үүсгэсэн байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008.11.05 № 09

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ө.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль<sup>103</sup>

- 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэг “Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөр гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна”

#### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Ө.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлан гаргасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т “Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх, ...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг зөрчсөн гэх дараах үндэслэл байна. Үүнд:

1/ Субъектын хувьд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д заасан “... хүний...” гэдэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хамаарах бөгөөд хууль шүүхийн өмнө хэн боловч тэгш эрхтэй. Иймд хүн бүр энэхүү зүйлд заасан “төрийн хамгаалалтад” орох Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхээ саадгүй эдэлнэ.

2/ Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, албан ёсоор нийтэлсэн хуулийг хэрэглэж, Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр заавал биелэгдэх учиртай бөгөөд энэ нь эрх зүйт төрийн хууль дээдлэх Үндсэн

103 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 8-д нийтлэгдсэн

хуулийн зарчимд үндэслэгддэг. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрвээ иргэн, хуулийн этгээд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд тусгайлан чиг үүрэг бүхий төрийн байгууллага болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэж, энэхүү үүргийг төр, түүний байгууллага Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д заасны дагуу иргэнийхээ өмнө хариуцна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т заасан халдлага нь Үндсэн хуулийн “Төрөөс...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчиж, иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхээ хамгаалуулах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай үндсэн эрхийг хязгаарлаж, “Төр” Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-т “иргэнийхээ өмнө хариуцах үүргээс” зайлсхийсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулснаас үүсэх “урамшуулал”-ын төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т зааснаар “төлбөр авагч” иргэн, хуулийн этгээдээс гаргуулахаас зохицуулсан нь төр, түүний байгууллага “хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг иргэнийхээ өмнө хариуцах” үүргийг биелүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр нь эрх зүйн үр дагаврыг бий болгодог бөгөөд тухайлбал иргэний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр зохигчдод өмчлөх эрх үүсгэх, бий болгох эрх зүйн үр дагавар бий болгож болно. Энэ тохиолдолд төлбөр авагчид шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон цагаас өмчлөх эрх үүссэн байж болох ба төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрийг албадан биелүүлнэ. Гэтэл, энэхүү шийдвэрийг албадан биелүүлэхдээ төлбөр авагчийн шүүхийн шийдвэрийн дагуу бий болсон өмчлөх эрхийг хязгаарлан, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулахаар зохицуулсан нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-т заасныг зөрчсөнөөс гадна Тавдугаар зүйлийн 2-т “Төр... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасныг шууд бусаар зөрчжээ. Тодруулбал, хүчин төгөлдөр бүхий Монгол Улсын нэрийн өмнөөс гарсан шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр авагчид эрх зүйн үр дагавар үүссэн байхад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулахаар зохицуулсан нь төрд хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргээ биелүүлэхгүйгээр, хүний өмчлөх эрхийг хязгаарлах, хөндөх боломжийг олгосон байна. Энэ утгаараа маргааны хамаарлын хувьд энэхүү халдлага нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний өмчлөх эрхийг зөрчсөн гэж үзэж байгаа болно.

Шүүхийн шийдвэрийг хэрвээ иргэн, хуулийн этгээд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан үндэслэл журмын дагуу албадан биелүүлэх нь төрийн чиг үүрэг бөгөөд албадан биелүүлсэнтэй холбоотой “урамшууллын” төлбөрийг төр “өөрөө” биш төлбөр авагч иргэн, хуулийн этгээд хариуцах ёсгүй. Учир нь төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлсний үндсэн дээр хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй, энэхүү үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэдгийг дахин тэмдэглэж байна. Энэ нь төр, иргэн хоорондын “гэрээ” бөгөөд төр дээрх халдлагыг бий болгосноор “үүргээсээ” татгалзах эрхгүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т заасан хандлагаас үзэхэд энэ заалт нь амьдралд хэрэгжихдээ нэг талаас төлбөр авагч иргэн хуулийн этгээдтэй “урамшууллын” гэх гэрээг гэрээний чөлөөт байдлын болон талууд хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх зарчмыг зөрчиж, төлбөр авагчаас “заавал” гаргуулах сөрөг үр дагаврыг агуулж байна. Төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна гэж гэрээний үнийн талаар хувь тогтоож хуульчилсан нь хүний өмчлөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлаж буй хэлбэр юм. Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т

зааснаар төр нь өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах ёстой байтал дээрх хуулийн заалтад “урамшууллыг” шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна гэж заасан нь төлбөр авагч иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийг хамгаалах бус хязгаарласан байна. Дээрх байдлаар “урамшуулал”-ын гэх гэрээний үнийг хуулиар тогтоосон нь өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох зарчмыг алдагдуулсан байна.

3/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түргэн шуурхай, иргэдийг чирэгдүүлэхгүйгээр, хуульд заасан үндэслэл, журмын дагуу, зохих ёсоор гүйцэтгэх үүднээс шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах асуудлыг үгүйсгэхгүй. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д зааснаар төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх нь төрийн үүрэг бөгөөд энэхүү Үндсэн хуулийн үндэслэл тухайн халдлагыг зөвтгөх гол аргумент болно. Гагцхүү ийнхүү “урамшуулан”, төр уг үүргээ биелүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн үзэж, хүний эрхийг хязгаарлах, зөрчихөөс татгалзаж, өөр байдлаар зохицуулах ёстой. Жишээ нь, урамшууллыг төр өөрөө хариуцах зохицуулалт хийж болох юм. Нэгэн шийдвэр гүйцэтгэгчээс “урамшууллын” талаар асуухад “хэрвээ урамшуулал байхгүй бол цалин бага учир шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах хүн олдохгүй байх” гэж хариулж байсныг мөн анхаарах хэрэгтэй. Үндсэн хуулиар хүний зөрчигдсөн эрхийг сэргээх үүргийг иргэнийхээ өмнө төр хариуцахаар зохицуулагдсан учир заавал өөрийн байгууллагаараа дамжуулан энэхүү чиг үүргээ хэрэгжүүлнэ. Тодруулбал, зарим гадаадын орнуудад байдаг шиг шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Монгол Улсын хувьд хувийн эрх зүйн хуулийн этгээд байх боломжгүй юм.

4/ Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3-т “өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж заасан нь энэхүү халдлага Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэдийн өмчлөх эрхийг шууд бусаар хязгаарлаж байна гэдгийг зөвтгөх үндэслэл болохгүй учир үндсэн эрхийн хязгаарлалт манай өргөдлийн шаардлагад хамааралгүй гэж үзэж байна. Иймд дээрх үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т “...урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна” гэж заасан нь Үндсэн хуулийн дээрх холбогдох заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргахыг хүсье.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М.-ийн тайлбарын агуулга:

Иргэнд учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт этгээдийг илрүүлж шийтгэхээс дутуугүй чухал асуудал юм. Хохирлыг нөхөн төлүүлэх эрх нь хохирогч бүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тэгш, үр дүнтэй боломж эдлэх, хохирлоо хурдан шуурхай, бүрэн, дүүрэн, зохистой барагдуулах бололцоогоор хангагдах болон зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга зам, ажиллагааны талаар хангалттай мэдээлэлтэй байх нөхцөл бүрдсэний үндсэн дээр хэрэгжих боломжтой. Хохирлоо нөхөн төлүүлэх эрх хангагдах өөр нэг чухал нөхцөл бол хохирлыг хурдан, шуурхай, бүрэн барагдуулах бололцоотой байх явдал билээ. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль энэ асуудалд анхаарал хандуулж Герман зэрэг эх газрын эрх зүйн тогтолцоот бусад орнуудын жишгээр хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хохирогч, шийдвэр гүйцэтгэгч харилцан тохиролцож байгуулсан Иргэний гэрээний үндсэн дээр урьдчилан санхүүжүүлэхээр зохицуулсан нь шүүхийн шийдвэрийн түргэтгэх, хохирсон этгээдийн “хөндөгдсөн эрх”-ийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн ажиллагаа болсон гэж үзэж байна.

Шүүхийн үйл ажиллагааны зарим зардлыг зохигчоор нөхөн төлүүлэх зарчмыг баримталдгийг мөрдөж байгаа хуулиудаас харж болно. Тухайлбал:

1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар:

- шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс

- гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс

- үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал

- эд мөрийн баримт хадгалах зардал

- гэрчийн мэдүүлгийг очиж авсан зэрэг үйл ажиллагааны төсвөөс гарсан зардлыг зохигчдоор

2/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 100, 101 дүгээр зүйлд зааснаар:

- хохирогч, түүний төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, мэргэжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчид олгох тээвэр, байр, хоолны зардал, мэдүүлэг өгөхөөр шүүхэд дуудагдсан хугацаанд хохирогч, шинжээч гэрч, хөндлөнгийн гэрчийн хохирсон хөдөлмөрийн хөлс

- мэргэжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн ажлын хөлс

- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарсан зардал

- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнчлэн шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарсан зардлыг гэм буруутай этгээдээр тус тус нөхөн төлүүлэхээр тогтоожээ.

Энэ зарчмыг Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд баримталсан учраас шүүхийн шийдвэр биелүүлэгчид олгосон урамшууллыг мөнгө, эд хөрөнгө хүлээн авагчаас гаргуулсан хэмжээгээр гэм буруутай этгээдээс гаргуулах юм. Хуульд шийдвэр гүйцэтгэх байгууллагын зардлыг улсын төвлөрсөн төсвөөс, харин шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллаас санхүүжүүлэхээр тусгасан. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зайлшгүй гарах зардлыг төлбөр авагчаас тухай бүр гаргуулж шийдвэр гүйцэтгэгдсэний дараа төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулах юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарим зардлыг шүүхийн зардлын нэгэн адил зарчмаар гэм буруутай этгээдээс гаргуулахаар хуулийн үзэл баримтлалд тодорхойлж тухайн хуулийн 83.2, 83.3 дахь хэсэг энэ санаагаар томъёологдсон болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн санхүүжилтийн асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 208 дугаар тушаалаар зохицуулж байгаа учраас дээрх хууль, эрх зүйн актыг цогц байдлаар авч үзэх шаардлагатай. Энэхүү журамд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарим зардлыг төлбөр авагчаас урьдчилан гаргуулж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсны дараа төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулахаар заасан байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т “Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөр гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсгийн заалтын төлбөр авагчтай шийдвэр гүйцэтгэгч урамшууллын гэрээ байгуулахаар

заасан зохицуулалт нь Үндсэн хуулийн зөрчил биш боловч хуулийг боловсронгуй болгох тухай асуудал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т “Энэ хуулийн 83.1-д заасан урамшууллыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчлэн биелсэн болон дуусгавар болсны дараа гэрээний үндсэн дээр төлбөр авагчаас төлбөр гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс гаргуулна” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2-т “Төр... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх, ...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарим зардлыг тухайн хэргийн зохигчдоос гаргуулах жишиг дэлхийн улсуудын практикт байдаг. Үүний гол зарчим нь гэм буруутай этгээдээс тухайн ажиллагааны зардлыг гаргуулахад чиглэгддэг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эсрэгээрээ буюу төлбөр авагчаас төлбөр гаргуулахаар тусгалаа олсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг үзэхэд хууль тогтоогч шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны зардлын нэг хэсгийг төсвөөс, зарим хэсгийг төлбөр авагчаас гаргуулахаар хуульчилсан байна. Ийнхүү хуульчлахдаа төлбөр авагчтай байгуулах гэрээний зохицуулалтыг тодорхой биш бөгөөд оновчгүй зохицуулсан байна гэж үзэж болохоор байгаа юм. Эндээс дүгнэхэд тухайн маргаан гарах болсон гол шалтгаан нь хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2008.12.17 № 10

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>104</sup>

- 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг "...санал нэгдсэн дүгнэлт гарган..."

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"
- Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг "Улсын Их Хурлын чуулганы болон байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ"
- Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ"

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Н.- ийн мэдээллийн агуулга:

2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн заалтад "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна" гэж заасны "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д зааснаар Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дөрвөн гишүүн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гаргаж чадахгүй бол тус асуудал Байнгын хорооны болон чуулганаар хэлэлцэх боломжгүй байхаар хуульчилжээ. Өөрөөр хэлбэл дэд хорооны гишүүдээс Улсын Их Хурлын гишүүнийг түдгэлзүүлэх эсэх асуудлаар татгалзсан, түдгэлзсэн, зөвшөөрсөн зэрэг тохиолдолд санал нэгдэж, дүгнэлт гаргах боломжгүй болж байна.

104 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 8-д нийтлэгдсэн

Ийнхүү санал нэгдсэн дүгнэлтэд хүрч чадахгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалт хэрэгжих боломжгүй болж, улмаар Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх эрх зүйн үндэс бүрдэхгүй гацаанд орж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтад “... шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг илтэд зөрчихөд хүргэж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх талаар ямар нэгэн шийдвэр Улсын Их Хурлаас гаргах нөхцөлгүй болгож байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтад “Байнгын хороо эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ”, мөн 24 дүгээр зүйлд Байнгын хорооны бүрэлдэхүүнд дэд хороо байгуулж болно гэсэн нь дэд хороо нь байнгын хорооны нэг хэсэг буюу бүрэлдэхүүн байхаар шууд хуульчлан зааж өгсөн байна.

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.12 дахь хэсгийн заалтад “Дэд хороо асуудлыг хуралдаанаар хэлэлцэж оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргана” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6-д тунхагласан “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэсэн заалттай нийцсэн. Энэ утгаараа асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэж заасан бөгөөд өөрөөр хэлбэл дэд хороо асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцнэ.

Дэд хороо нь тэр дундаа Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь дурдсан хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 болон 24.12-т заасан заалтын аль алийг нь хэрэглэх боломж бүрдсэн. Ингэснээрээ хуулийн заалтууд хоорондоо зөрчилдөж төрийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдахад саад учран тэр дундаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна. Өөрөөр хэлбэл төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал хууль дээдлэх зарчмыг баримтлан үйл ажиллагаагаа хэвийн явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 болон 24.12-т заасан заалтуудын зөрчил саад учруулж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С.-ийн тайлбарын агуулга:

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болох тухай:

1/ Улсын Их Хурлын гишүүн бол нийт ард түмний төлөөлөл болон сонгогддог субъект. Өөрөөр хэлбэл ард түмнээс бүрэн эрх авсан элч байдаг. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” хэмээн заасан.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т Төрийн байгуулалтын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо байгуулахаар, 24.3.4-т түүнийг хэрэгжүүлэх чиг үүргийг, 24.7-д



үйл ажиллагаа, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө урьдчилан хэлэлцэж эцсийн шийдвэр бус, урьдчилсан санал, дүгнэлт гаргах журмыг тусгайлан хуульчлан заасан нь Үндсэн хуулиа дээдлэн, дээрх заалтыг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалсан явдал болно.

2/ Хууль тогтоох үйл ажиллагаанд зарим тухайлсан онцлог харилцааг тусгайлсан хэм хэмжээ тогтоон зохицуулах явдал байдаг. Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-гийн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо санал нэгдсэн дүгнэлт гаргах тухай заалт нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын тухай асуудлыг шийдвэрлэхэд тусгай журам тогтоосон хэм хэмжээ болно.

3/ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчим нь аливаа асуудал, түүний дотор хуулиар зохицуулж буй нийгмийн харилцаа нь өөр өөрийн мөн чанар, онцлогоос шалтгаалан ялгаатай зохицуулалттай байхыг үгүйсгэсэн зарчим биш.

Иймд хуулиар тусгайлан зохицуулж өгснөөрөө Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын тухайд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчмыг зөрчсөн бус харин хангаж өгч буй явдал болно.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ” гэснийг зөрчсөн гэх хууль зүйн үндэслэлгүй болох тухай:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь дөрвөн гишүүнээс бүрдэхээр заагаад “санал нэгдсэн дүгнэлт гарган” гэсэн нь Үндсэн хуулиар хамгаалагдсан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлын эрх зүйн баталгааг хангахад чиглэгдсэн. Мөн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар заавал хэлэлцдэг журмыг хуулиар тогтоосон. Эдгээр Байнгын хороод санал, дүгнэлтээ “олонхийн саналаар” гаргах бөгөөд Улсын Их Хурал /нэгдсэн хуралдаанаар/ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбоотой шийдвэрийг Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар “олонхийн саналаар” гаргана. Иймд Үндсэн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй болно.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ...” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болох тухай:

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны эрх хэмжээг “... гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар... эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдож, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан санал ирүүлсэн тохиолдолд уг асуудлыг Улсын Их Хурлын чуулган хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, бэлтгэл шатны үйл ажиллагааг хуульчлан тодорхойлсон болно. Хуулийн энэ заалтад Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхэд хориглох, саад учруулах ямар нэг ойлголт байхгүй байна. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд

хороо “санал нэгдсэн дүгнэлт гарган” гэсэн заалт нь уг дэд хорооны гишүүд санал нэгдэж дүгнэлт гаргах үүрэгтэй болохыг тодорхойлсноос бус “санал нэгдээгүй” гээд дүгнэлт гаргахгүй байж болох тухай заагаагүй.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж заажээ. Гэтэл “Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд оруулна” гэж заасан нь гишүүний халдашгүй байдлын дэд хорооны гишүүд санал нэгдсэн дүгнэлт гаргасны дараа уг асуудлыг Улсын Их Хурлын зохих Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэсэн агуулгыг илэрхийлж байна.

2. Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “... санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны гишүүдийн санал тэнцсэн, аль нэг нь өөр санал гаргасан тохиолдолд уг асуудлыг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах боломжгүй болгож байна. Энэ нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын... гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэсэн заалт тэр бүр хэрэгжиж чадахгүйд хүргэж байна. Түүнчлэн энэ хэсэг нь Улсын Их Хурлын болон Байнгын хорооны хуралдаан асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэдэг зарчмыг зөрчсөн нь илэрхий байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “... санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы болон байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ”, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “... санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногт багтаан хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **Тэмдэглэл:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн заалт нь Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны гишүүд санал нэгдсэн дүгнэлт гаргасны дараа уг асуудлыг Байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэсэн санааг илэрхийлж байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны гишүүд нь санал тэнцсэн, аль нэг нь өөр санал гаргасан тохиолдолд уг асуудлыг Байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх хууль зүйн үндэслэлгүй болж байгаа юм. Түүнчлэн энэ хэсэг бас Улсын Их Хурлын болон Байнгын хорооны хуралдаан асуудлыг гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэдэг зарчмыг зөрчсөн байгаа юм. Ер нь дэд хороо, Байнгын хорооны бүрэлдэхүүн хэсэг учраас Их Хурлын чуулганы хуралдаан, Байнгын хорооны хуралдааны дэгийн дагуу олонхийн саналаар асуудлыг шийддэг зарчим үйлчлэх ёстой.

Энэхүү зохицуулалт орсноор Байнгын хороо болон Чуулганы хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, улмаар эрх бүхий байгууллагуудын зүгээс Улсын Их Хурлын гишүүнийг шалгах нөхцөлийг хязгаарлах үндэслэлийг бүрдүүлж байсан юм.

2. Энэхүү дүгнэлтийн талаар Улсын Их Хурлаас ямар нэгэн шийдвэр гараагүй бөгөөд энэ тухай Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар тогтоол, холбогдох тэмдэглэлээс харна уу.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2009.06.10 № 03**

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Н.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гийн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаар Цэцийн дүгнэлтийг Хууль зүйн байнгын болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанд оруулдаг. Нэгдсэн хуралдаан Цэцийн дүгнэлт, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи Цэцийн дүгнэлтийг дэмжсэн бол түүнийг хүлээн зөвшөөрөх тухай, дэмжээгүй бол эс зөвшөөрөх тухай тогтоол баталдаг журамтай. Үүний дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны 2009 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Цэцийн 2008 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлсэн. Байнгын хорооны хуралдаан дээр Монгол Улсын Их

Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын тухай хуулийн Бүлгийн эрх үүрэг гэсэн 27 дугаар зүйлийн 27.1.4-т “нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах” гэж заасны дагуу албан ёсоор завсарлага авсан болно. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2009 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааны хэлэлцэх асуудалд дахин төлөвлөгдсөн боловч тухайн асуудлын талаар намын Бүлгээс авсан завсарлага үргэлжилж байгаа тул хойшлуулсан. Хууль зүйн байнгын хорооны хуралдаан мөн үндэслэлээр хойшлогдож өдий хүрсэн болно.

Улсын Их Хурлын тухай хуулийн 29.9-д “...нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг зохих байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана” гэж заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлт гарсны дараа асуудлыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг. Энэ бүхнээс үзвэл Улсын Их Хурал уг асуудлыг “санаатайгаар” хойшлуулсан гэх үндэслэл байхгүй болно.

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар гаргасан Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын гаргасан тогтоолын үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана. Цэцийн энэхүү эцсийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль Цэцийн тогтоол гармагц хүчингүй болдог. Улсын Их Хурал нэгдсэн хуралдаанаараа Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргаагүй байхад Цэц их суудлын хуралдаанаараа маргааныг дахин хэлэлцэх үндэслэлгүй болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “...санал нэгдсэн дүгнэлт гарган...” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ..., хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ..”, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ..” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар дүгнэлт нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 4, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, мөн хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо нь Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд тэрбээр Улсын Их Хурлыг хугацаанаас нь өмнө тараах, гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах талаар энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас Улсын Их Хуралд ирүүлсэн саналыг судалж санал нэгдсэн дүгнэлт гарган зохих Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оруулна”

гэж заасны "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ..., хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", мөн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", мөн хуулийн Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ..", Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн "...санал нэгдсэн дүгнэлт гарган..." гэснийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

#### **Тэмдэглэл:**

Дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлаас "асуудлыг гацаах" арга юм.

Улсын Их Хуралд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг нэн даруй буюу 24 цагийн дотор хүргүүлдэг. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд хэлэлцэж зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн талаар хариу ирүүлдэг. Гэтэл Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар дүгнэлтийн талаар тодорхой шийдвэр гаргаагүй 6 сар орчим хугацаа өнгөрсөн тул Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Маргааныг дараахь үндэслэлээр хуралдаанд бэлтгэх шатнаас эхлэн дахин хянан шийдвэрлэнэ гээд "урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан" гэж заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааныг хийхээр шийдвэрлэсэн байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2009.03.04 № 01**

**Төрийн албаны тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Д., Ш., Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Улсын Их Хурлаас 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль<sup>105</sup>

<sup>105</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 28-д нийтлэгдсэн

- 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт “баг, хорооны Засаг дарга”

2. Улсын Их Хурлаас 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль<sup>106</sup>

- 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг “...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг...”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”

- Тавин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”

- Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”

- Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ”

- Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн”

- Жардугаар зүйлийн 1 дэх хэсэг “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ”

- Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”

- Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Э.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуульд нутгийн удирдлагыг “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага” гэж томъёолоод удирдлагын хоёр эхлэлийг хослуулах үзэл баримтлалыг удирдлага болгосон. Энэ нь “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэсэн Үндсэн хуулийн заалт (Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг)-аар илэрч байгаа юм.

Үндсэн хуульд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гурван үндсэн хэлбэрийг тодорхойлсон. Үүнд:

106 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 оны № 2-д нийтлэгдсэн

а/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,  
б/ Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал,  
в/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгчид.

Нутгийн өөрийн удирдлагын анхан шатны нэгж болох баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь өөрийн эрх хэмжээний асуудлыг бие даан шийдвэрлэх, нэгжийн удирдлагыг төрийн удирдлагатай хослон хэрэгжүүлэх үүднээс баг, хорооны Засаг даргыг хурлаасаа нэр дэвшүүлэн дээд шатны засаг даргаар томилуулдаг. Үүнийг Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэсэн заалтаар баталгаажуулсан. Үндсэн хуулийн дээр дурдсан Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь нутаг орондоо нэр хүндтэй, ажил амьдралын баялаг туршлагатай, нэр хүнд бүхий итгэл даах чадвартай иргэнээ баг, хорооны засаг даргад нэр дэвшүүлж, томилуулж ирсэн бөгөөд энэ нь нутгийн өөрийн удирдлагыг бодитоор хэрэгжүүлэхэд чухал алхам болж байсан.

Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар баг, хорооны Засаг даргыг төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны албан тушаалд хамруулсан төдийгүй баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн Нийтийн Хуралд оролцож байгаа иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг нэр дэвшүүлж, нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгохоор заасан нь дээр дурдсан Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг ноцтой зөрчсөн, Үндсэн хуульд халдсан заалтууд боллоо гэж үзэж байна. Нэгэнт баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны албан тушаалд хамруулж байгаа болохоор Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх гэсэн шаардлага баг, хорооны Засаг даргад хамаарч байгаа болно. Төрийн албаны тухай хуульд заасан нэр дурдсан шаардлага хангасан нэр дэвшигч байхгүй шалтгааны улмаас Орон нутгийн сонгууль 2008 оны 10 дугаар сард явуулснаас хойш өнөөдрийг хүртэл баг, хорооны Засаг даргыг нэр дэвшүүлж, томилуулах асуудал шийдэгдэхгүй байгаа бөгөөд нөгөө талаар баг, хороонд Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1-д заасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12-ын “баг, хорооны Засаг дарга” гэсэн заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн хуралд оролцож байгаа иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг харьяалах сум дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”, мөн хуулийн

Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байх тул дүгнэлт гаргаж өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Д.-гийн тайлбарын агуулга:

Төрийн албаны тухай хуульд баг, хорооны Засаг даргын албан тушаалыг засаг төрийн төлөөлөгч болохынх нь хувьд хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл баталгааг нь тогтвортой байлгах, төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чадварыг бэхжүүлэх үүднээс төрийн улс төрийн албан тушаалын ангиллаас хасаж, төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамааруулсан. Баг, хорооны Засаг даргын албан тушаалыг төрийн албаны нэг ангиллаас өөр ангилалд хамааруулсан боловч уг албан тушаалын иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшигдэн, дээд шатны буюу харьяалах сум, дүүргийн Засаг даргаас 4 жилийн хугацаагаар томилогддог зарчим хэвээр хадгалагдаж байгаа болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэсэн нийтлэг үндэслэлийг заасан боловч баг, хорооны Засаг даргын томилогдож буй байдал нь бусад нэгжийн засаг дарга нарыг томилох зарчмаас агуулгын хувьд онцлог ялгаатай байдаг. Ийм учраас орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх анхан шатны нэгжийн хувьд баг, хорооны Засаг даргын албан тушаалыг улс төрийн сонгуулийн үр дүнгээс үл хамааран Үндсэн хуульд заасан 4 жилийн хугацаагаар чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс, түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д заасан “төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах” зарчмын хүрээнд төрийн улс төрийн албан тушаалаас төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамааруулсан болно. Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан “Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байгаа иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно” гэсэн зохицуулалтыг хийхдээ баг, хорооны засаг дарга нь тухайн орон нутагтаа нэр хүндтэй, ажил, амьдралын баялаг туршлагатай, нэр хүнд бүхий итгэл даах чадвартай иргэн байхаас гадна харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч гэдэг утгаараа төрийн албаны тодорхой шалгуурыг хангасан байх нь зүйтэй гэж үзсэн юм.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал болон дараах үндэслэлээр Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д заасан “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2-т заасны дагуу баг, хорооны Засаг дарга нь иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшин, харьяалах сум, дүүргийн Засаг даргаас томилогддог зарчим хэвээр хадгалагдаж байгаа болно. Иймд тухайн орон нутгийн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал зохих шаардлагыг хангасан иргэнийг



нэр дэвшүүлэх эрх нь нээлттэй байгаа юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно...” гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “Баг, хорооны Засаг даргад тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байгаа иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаанд оролцсон иргэд, төлөөлөгчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэж заасныг зөрчиж буй асуудал биш бөгөөд Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д заасны дагуу Төрийн албаны төв байгууллага нь “төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах” чиг үүргээ хэрэгжүүлэх бөгөөд харин тухайн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас хуульд заасан шаардлагыг хангасан иргэнийг томилуулахаар дээд шатны Засаг даргад санал болгох эрх нь зөрчигдөхгүй, уг бүрэн эрхийг нь дээд шатны байгууллагаас шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгаагүй болно. Ингэснээр уг зохицуулалт нь Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэснийг зөрчиж байгаа биш, харин ч уг нөхцөлийг хэрэгжүүлэх нэг баталгаа болж байна гэж үзэж байна.

Иймд 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх, томилох журмыг нэг адил зарчмаар хуульчилсан байна.

2. Баг, хорооны Засаг даргыг улс төрийн албан тушаалын ангиллаас хасч, Төрийн захиргааны албан тушаалын ангилалд оруулан төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлж, томилуулах санал оруулахаар хуульчилсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тухайн иргэдийн Нийтийн Хурлын баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, харьяалах сум, дүүргийн Засаг даргын баг, хорооны Засаг даргыг томилох бүрэн эрхийг явцууруулан хязгаарлаж, эдгээр бүрэн эрхэд Төрийн албаны төв байгууллага хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12-ын “баг, хорооны Засаг дарга” гэсэн заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн... баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, ... баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн

өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

3. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Тавин долдугаар зүйлийн 1, 2, Тавин есдүгээр зүйлийн 1, 2, Жардугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12-ын “баг, хорооны Засаг дарга” гэсэн заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн... баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, ...баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12-ын “баг, хорооны Засаг дарга” гэсэн заалтыг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2009 оны 3 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Тавин долдугаар зүйлийн 1, 2, Тавин есдүгээр зүйлийн 1, 2, Жардугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 24 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтын “баг, хорооны Засаг дарга”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “...төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 3 дугаар сарын 12 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тэмдэглэл:**

Төрийн захиргааны албан хаагч нь өрсөлдөөнт шалгаруулалтаар гарч ирж томилогддог, харин улс төрийн албан хаагч нь сонгуулийн үр дүнд томилогддог онцлогтой байдаг.

Өөрөөр хэлбэл бүх шатны Засаг даргыг тухайн шатны Хурлаас нэр дэвшүүлэн Ерөнхий сайд, харьяалах Засаг дарга томилдог учир Засаг дарга нь төрийн улс төрийн албан хаагч юм. Гэхдээ цаашдаа Засаг дарга нарыг дотор нь ангилж ч болох юм.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2009.03.11 № 02**

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн О.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль<sup>107</sup>

- 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно”

- 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг “... , эсхүл дээд шатны...”

- 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй”

- 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг “Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй”

**Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

107 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 оны № 2-д нийтлэгдсэн

- Жардугаар зүйлийн 2 дахь хэсэг “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”

- Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...”

- Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага шийдвэрлэж үл болно...”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн О.-гийн мэдээлэллийн агуулга:

1/ Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж хуралдаанаараа үзсэн, цаашид хурал үйл ажиллагаа явуулах бодит боломжгүй болсон, хамтран ажиллах нөхцөлгүй хэмээн үзсэн тохиолдолд хурлын бүрэн эрхийн хугацаа 2 жилээс дээш хугацаа өнгөрсөн л бол өөрсдөө хүссэн ч тарж чадахгүй байгаа нь иргэдийг төлөөлөх ардчилсан ёсны зарчим болон ард түмний өмнө улс төрийн хариуцлагаа хүлээн тарах талаархи шударга ёсны зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

Ерөөс аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал нь орон нутгийн түвшинд нутаг дэвсгэрийнхээ нийгэм, эдийн засгийн асуудлыг бие даан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин сууж байгаа сонгуулийн насны иргэдээс бүх нийтийн, чөлөөтэй, шууд саналаа өгөх эрхийн үндсэн дээр нууцаар сонгогддог. Төлөөллийн ардчиллын зарчим ёсоор Хурал бүрэн эрхийн хугацаандаа хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа, хууль бус үйл ажиллагаа явуулсан цаашид энэ байдлаараа хамтран ажиллах боломжгүй хэмээн тухайн сонгогчдын дийлэнх олонхи үзэж Хурлын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрхтэй билээ.

Иргэдийн энэхүү эрхээ хэрэгжүүлэх бодит боломжийг 2 жилээс дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд хугацаагаар хязгаарласан хамгаалалтын систем амь бөхтэй байж, улмаар хууль бус үйл ажиллагаа, хариуцлагагүй байдал газар авсан ч иргэд өөрсдийн сонгосон Хурлыг тараах эрхгүй болгосон нь Үндсэн хуульд заасан засгийн эрх ард түмнээс үүдэлтэй байх ардчилсан ёсны зарчим, хариуцлагагүй, хууль бус үйл ажиллагааны төлөө улс төрийн хийгээд, хууль зүйн хариуцлага хүлээх шударга ёсны зарчмыг зөрчсөн байх үндэслэлтэй хэмээн үзэж байна.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна” мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно...” хэмээн тус тус заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар олгосон тусгайлсан чиг үүрэг, эрх хэмжээтэй хийгээд тухайн бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодит эрхийн чадамжийг хангахын тулд дээд шатны байгууллага тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхгүй байх зарчмыг бэхжүүлсэн явдал юм. Гэвч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно”, мөн зүйлийн 25.5-д “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” хэмээн

заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтуудыг шууд зөрчсөн гэж үзэж байна. Учир нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх хийгээд, энэхүү эрх нь тухайн байгууллагаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлыг шийдвэрлээд батлан гаргасан аливаа шийдвэр, тогтоолыг бусад байгууллага, албан тушаалтан шууд хүчингүй болгох боломжоос хамгаалагдсан байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран гуравдугаар зүйлд Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байна хэмээн заасан боловч уг зүйлд орон нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг дээд шатны хурал эсхүл Улсын Их Хурал хүчингүй болгоно гэсэн агуулга байхгүй, байх ч боломжгүй. Хэрэв тухайн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй гэж үзвэл дээд шатны Хурал, эсхүл хууль тогтоох байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгох бус шүүхийн байгууллагаас хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь Хурал өөрийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлээд гаргасан шийдвэрийг дээд шатны Хурал, эсхүл Улсын Их Хурал хүчингүй болговол энэ нь өөрөө удирдах байгууллагын хэвтээ түвшний харилцааны зарчмыг зөрчин өөрөө удирдах ёсны тогтолцоонд харшилна гэж үзэж байна.

3/ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй” гэж заасан нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно” гэсэн заалтыг агуулгаараа зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуульд зааснаар Засаг дарга нь тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт засаг төрийн төлөөлөгч болдог. Өөрөөр хэлбэл Засаг дарга нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд хамаарах агуулгаараа заавал дээд шатны Засаг даргын шийдвэрээр томилогддог. Учир нь дээд шатны Засаг дарга, доод шатны Засаг даргатай харилцахдаа захирах, захирагдах ёсны зарчмаар ажилладаг бөгөөд хамтран ажиллах, харилцан итгэлцлийн улс төрийн зарчмыг авч үзэхгүйгээр өөр үнэлэмж, өөр бодлоготой албан тушаалтнууд төрийн үйл хэргийг захирах, захирагдах ёсонд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжгүй.

Иймээс л Үндсэн хуульд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг томилно хэмээн заасан. Гэтэл Монгол Улсын засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн агуулгаас харахад хэрэв Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг томилохоос татгалзсан тохиолдолд Хурал 15 хоногийн дотор Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга дараагийн нэр дэвшүүлсэн хүнийг шууд томилох үүрэгтэй байхаар тэр бүү хэл Хурал өмнө нь санал болгосон хүнээ дахин томилуулахаар санал гаргах эрхтэй бөгөөд тэрхүү санал болгосон Засаг даргыг Ерөнхий сайд болон дээд шатны Засаг дарга томилох үүрэгтэй байхаар заасан нь Үндсэн хуульд заагдсан Засаг даргыг томилох Ерөнхий сайд болон дээд шатны Засаг даргад Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг дордуулсан гэж үзэж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно” гэж заасан нь нэгэнт Хурал бүрэн эрхийнхээ хугацааны талаас илүү хувийг эдэлчихсэн тохиолдолд нутгийн өөрөө удирдах ёсны хэвийн үйл ажиллагааг хангах, өөрөөр хэлбэл удирдлагыг байнгын тасралтгүй явуулах үүднээс дараагийн Хурлын бүрэн эрх эхлэх хүртэл Хурал өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа хийгээд үүргийг зохицуулсан юм. Энэ нь ойр ойрхон сонгууль явуулснаас гарах төсвийн мөнгийг хэмнэх, нөгөө талаас Хурлын тэргүүлэгчид 4 жилийн хугацаанд хэвийн үйл ажиллагаа явуулах үүргийг хүлээн зөвшөөрч ард түмнийг төлөөлөх болсон, харин ард түмэн хуулиар тогтоосон энэхүү 4 жилийн хугацаанд Хурлын тэргүүлэгчдэд тодорхой үүргүүдийг гүйцэтгүүлэхээр нэгэнт сонгосон учир Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр Хурлыг тараахыг хориглож өгсөн юм.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” хэмээн нутгийн өөрөө удирдах байгууллагын хуулиар олгосон тусгайлсан чиг үүрэг хийгээд эрх хэмжээг бэхжүүлж өгсөн.

Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Гуравдугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Хурал, тэргүүлэгчид, Хурлын дарга, тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг нарийвчлан зааж өгсний зэрэгцээ эрх үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрт харшлахгүй байх учиртайг мөн адил хуульчилсан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5-д “Хурлаас гаргасан тогтоол бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал хүчингүй болгоно”, “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэж заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргахаас хамгаалсан зохицуулалт болсон.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т заасан “... дээд шатны хурал хүчингүй болгоно” гэсэн нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Гуравдугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд хамаарах асуудлыг шийдвэрлэж буй хэрэг бус харин нэгэнт гаргасан шийдвэрийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх хөшүүрэг юм.

3/ Монгол Улсын Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг засгийн гурван салаанд хуваарилж, удирдлагын босоо ба хөндлөн тогтолцоог хослуулах практикт нэвтрүүлсэн юм.

Тухайлбал, Засаг дарга нь дээрээс томилогдож тухайн нутаг дэвсгэрт хууль биелүүлэх ажлыг өөрөөр хэлбэл, гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газрын өмнөөс хэрэгжүүлдэг боловч хурлаас нэр дэвшигдэж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нэгэн зэрэг эрхлэн хариуцдагийн хувьд нутгийн өөрөө удирдах байгууллагын зарим шинжийг агуулсан байдаг.

Үүний илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална” гэж тус тус зааснаар баталгааждаг.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчих бус харин Үндсэн хуулийн Жардугаар зүйлийг амьдралд хэрэгжүүлэх, түүнийг хугацаа зааж баталгаажуулсан зохицуулалт юм.

Түүнчлэн орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтныг томилохдоо ард түмний төлөөлөл болсон нутгийн өөрөө удирдах байгууллагын саналыг үндэслэж шийдвэрлэх нь төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны харилцан хяналт, хамаарал бүхий тогтолцоог төлөвшүүлэхэд түлхэц болж байгаа билээ.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно” гэсэн заалт нь иргэдээс төлөөллийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхээ хэрэгжүүлэх боломжийг хэт урт хугацаагаар хязгаарлаж, улмаар өөрөө удирдах ардчилсан ёсны зарчим, аливаа хууль бус үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээлгэх шударга ёсны зарчмыг алдагдуулж Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “Хурлаас гарсан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсвэл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно”; мөн зүйлийн 25.5 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэсэн заалтууд холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хурал, Улсын Их Хурал нь өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлсэн байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэр хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн эсэх тухай асуудлаар гарсан маргаан нь шүүх харьяалан шийдвэрлэх асуудал байх тул Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэстэй байна.

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг нь тухайн Хурал, Ерөнхий сайд, дээд шатны Засаг даргын шийдвэр гаргах хугацааг зохицуулсан байх бөгөөд Үндсэн хуулийн

Жардугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдын холбогдох шатны Засаг даргад нэр дэвшигчийг томилох, томилохоос татгалзах бүрэн эрхийг дордуулсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “... эсхүл дээд шатны...” гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага шийдвэрлэж үл болно...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 26.2-т заасан нэр дэвшигчийг мөн хуулийн 26.3-т заасан эрх бүхий албан тушаалтан томилохоос татгалзвал зохих шатны Хурал 15 хоногийн дотор энэ хуулийн 26.2-т заасан журмаар Засаг даргад дахин нэр дэвшүүлэх бөгөөд томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш 5 өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “... , эсхүл дээд...” гэсэн хэсэг, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үйлчлэлийг түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын чуулганы хуралдаан эхэлснээс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 29 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн Хурлыг энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үндэслэлээр тараахыг хориглоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн байна” гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийн “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “..., эсхүл дээд шатны...” гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

1. Хурлын бүрэн эрхийн хугацааны 50-иас илүү хувь өнгөрсөн тохиолдолд тухайн хурлыг нийт сонгогчид нь ч тэр, хурлын төлөөлөгчид ч тэр тарааж чадахгүй байхаар зохицуулалт яагаад ч Үндсэн хуульд нийцэхгүй юм.

2. Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 9 дүгээр дүгнэлт болон 1996 оны 10 дугаар дүгнэлттэй маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2009.05.20 № 01**

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн О.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т.

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гийн тайлбарын агуулга:  
1/ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгээр тодорхойлж буй фактын нөхцөл /

гипотез/ нь “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол” гэж байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “бүрэн эрхт”, Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “нэгдмэл улс”-ынх нь хувьд, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 7, 8 дахь заалтад заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх, Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлд заасан Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн дагуу хууль тогтоомжийн нэг тогтолцоо, Засгийн газрын нэг бодлоготой байлгахад чиглэсэн зохицуулалт байна. Нөгөөтэйгүүр, энэ зохицуулалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ардчилсан ёс, ... хууль дээдлэх зарчим”, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “... засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Хорьдугаар зүйлд заасан “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэсэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

2/ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгүүдийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхдээ дурдсан Үндсэн хуулийн заалт нь Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхийг нь хязгаарлах буюу түүнтэй зөрчилдсөн утга бүхий заалт биш байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн ...нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулах талаар тодорхойлж өгсөн байгаа нь “хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй” шийдвэр гаргах эрхтэй тухай бус харин ч хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үүргийг хүлээсэн байна. Мөн зүйлийн 2 дахь хэсгийн хоёрдугаар өгүүлбэрт “Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрээс гадуур байх эрх мэдлийг тусгайлан тодорхойлсон байна. Үндсэн хуулийн эдгээр заалтаас үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллагад хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг зөрчсөн шийдвэр гаргах эрх мэдэл олгогдоогүй байх бөгөөд энэ асуудлыг хянан шалгаж шийдэх эрх мэдэл нь Улсын Их Хуралд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн зохих хэсгүүдээр олгогдсон байна.

3/ Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэр болох “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэсэн зохицуулалтын “дээд шатны байгууллага нь” гэх ойлголтод Улсын Их Хурлыг хамруулан ойлгох бололцоогүй байна. Нөгөөтэйгүүр, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудалд” тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэр үйлчлэх эсэх асуудлыг мэдэн шийдэх эрх багтахгүй байна.

4/ Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Улсын Их Хурал, Засгийн газрын хооронд гарсан маргааныг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсанчлан шүүх / захиргааны, иргэний, эрүүгийн шүүхийн журмаар/ харьяалан шийдэх боломжгүй байна. Харин Улсын Их Хурлын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хандах байдлаар шийдүүлэх нь нээлттэй байгаа тул Улсын Их Хурал нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох нь тэдний Цэцэд өргөдөл гаргах эрхийг нээж өгсөн зохицуулалт болж байна.

## **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "... эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 2 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох нь аливаа эрх зүйн маргааныг шүүхээр шийдвэрлэх зарчимтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "...эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "...эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 2 дугаар дүгнэлтийн тухай" 29 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

### **Тэмдэглэл:**

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд "дээд шатны" хурал гэж байдаггүй. Улсын Их Хурлын гишүүд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "дээд шатны хурал" нь Улсын Их Хурал гэж ойлгоод байх шиг байгаа юм. Энэ хоёр бол тэс өөр чиг үүрэгтэй, тэс өөр зохион байгуулалттай байгууллагууд юм. Нэг нь бол төрийн эрх барих дээд байгууллага, нөгөө нь бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009.04.15 № 03

### Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ц.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Б., Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б., Эрүүл мэндийн яамны хуулийн зөвлөх М.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр баталсан Эрүүл мэндийн тухай хууль<sup>108</sup>

- 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт “өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч,”

- 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг “Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”

- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”

- Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор бол хүн амын эрүүл мэндийг мэргэжлийн эмч буюу эмчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хамгаалуулах учиртай. Гэтэл тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д тусгай зөвшөөрөлгүй этгээд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр заасан байна. Эрүүл мэндийн тухай хуулийн дээрх заалтаас үзэхэд “дадлагажигч” гэсэн субъект гарч ирж байна. “Дадлагажигч” нь эмч мөн үү, өөрөөр хэлбэл эмчлэх үйл ажиллагаа явуулах, эмчийн хэмжээнд үүрэг, хариуцлага хүлээх эрх зүйн бүрэн чадамжтай субъект мөн үү хэмээх ээдрээтэй асуудал эндээс урган гарна.

108 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1998 оны № 7-д нийтлэгдсэн

Эрүүгийн хуулийн 197 дугаар зүйлд “эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй этгээд эмчилгээ эрхэлсний улмаас үйлчлүүлэгчийн биед хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх”-ээр заасан байна. Хуулиудын хүрээнд цогцлуулан авч үзвэл “дадлагажигч” нь эрх зүйн тусгай чадамжтай субъект / их эмч/ бус бөгөөд зөвхөн анхны тусламж үзүүлэх субъект юм. Гэтэл энэхүү анхны тусламж үзүүлэх эрх, үүрэг бүхий субъект нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д заасны дагуу нэг ба хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхээр заасан нь Эрүүлийн мэндийн тухай хууль нь зөвхөн Үндсэн хууль, Эрүүгийн хуулийн үзэл баримтлалыг зөрчсөн төдийгүй, уг хуулийн дотоод зүйл заалтууд нь хоорондоо зөрчилдөж байгааг харуулж байна.

Энэхүү шинэчилсэн найруулгын гол агуулга нь гэвэл шинээр төгсөн гарч буй залуу эмч нарыг дадлага туршлагажуулах, нөгөө талаас эмч хомсдолтой байдаг хөдөө орон нутгийн иргэдийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хямд төсөр аргаар хангах зорилгоор баталсан болов уу. Эмч хүн гэдэг нь анагаахын сургуулийг төгссөн л бол бүхнийг мэдэгч, чадагч болдоггүй харин тэд ажил, хөдөлмөрийн практикт өдөр тутам шинийг сурч, мэдэж, дадал туршлага суудаг юм. Тийм ч учраас дэлхийн жишгээс харахад анагаах ухааны салбарт төгсөлтийн дараах сургалт буюу резидентурын сургалт гэсэн ойлголт байдаг. Энэ сургалтад оролцож буй эмч нь лицензтэй байдаг учраас суралцахынхаа хажуугаар ажлаа хийгээд, цалингаа авдаг жишигтэй. Гэтэл хуулийн шинэчилсэн найруулга ёсоор бол энэ хоёр жилийн хугацаанд тэднийг дадлагажигч нэрийн дор үндсэндээ хаясан буюу ямар нэгэн мэдлэг мэргэжил дээшлүүлэх сургалт зохиогдох нь байтугай Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “иргэн хүн сурч боловсрох, ...эрхтэй” хэмээн заагдсан эрх нь өнөөдөр хаагдмал байна.

Анагаахын сургуульд суралцах хугацаандаа төрийн сангийн зардлаар суралцаж төгссөн бол өөрийн нь саналыг үл харгалзан орон нутагт томилдог, харин сургалтын төлбөрөө хувиараа төлсөн бол хотод аль нэг өрхийн эмнэлэгт хуваарилагдах магадлалтай байдаг нь яав ч ардчилсан нийгмийн жишиг биш буй заа. Гэсэн хэдий ч бакалаврын сургалтын төлбөрөө яаж төлснөөс үл хамааран хотод оршин суудаг төгсөгчдийг хөдөө орон нутагт хувиарласан тохиолдлууд цөөнгүй. Үүнээс бол хамгийн наад зах нь ямар эрсдэл учирч болох вэ гэвээс гэр бүл салалт, тэдний үр хүүхэд өнчрөхийг үгүйсгэхгүй (бусад салбарын их дээд сургуулийг бодвол анагаахын оюутнууд олон жил суралцаж төгсдөг учраас энэ хугацаанд тэд ихэнх нь гэр бүлтэй болдог) Энэ нь 1990-ээд оноос өмнөх захиргаадлын үеийн Намын Төв Хорооны тогтоол шийдвэрээр эмч, эмнэлгийн ажилтныг нутаг заан томилон ажиллуулдаг байсныг санагдуулах болжээ. Иргэд дадлагажигчид итгэл үнэмшилтэй ханддаггүй. Сэжгээр өвдөж, сүжгээр эдгэрдэг хэмээн монгол түмэн ярьдаг билээ. Тэгвэл иргэн хүн лицензгүй эмчид итгэл үнэмшилтэйгээр хандаж чадах болов уу. Дадлагажигч эмч бүр өдөрт багаар бодоход 20 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ба 2007, 2008 оны байдлаар тэд давхардсан тоогоор 2.4 сая хүн амд нэг болон хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн гэсэн албан бус тоо байдаг.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 90 дүгээр тушаалын хавсралтын 1.4-т “Дадлагажигчийн цалинг Засгийн газраас тогтоосон төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн сүлжээгээр олгох...”, мөн тушаалын 2.2-т: “Дадлагажигчийн цалинг Эрүүл мэндийн сайдын жил бүрийн төсвийн багцанд тусгана” хэмээн тус тус заасан байдаг. Тэгвэл энэ тушаал амьдрал дээр бодитой хэрэгжиж байгаа эсэх нь бас л эргэлзээтэй. Журмын дагуу бол дадлагажигчид ТҮ-3 (энэ ахлах зэрэгтэй сувилагчийн цалингийн зэрэглэл юм) зэрэглэлийн дагуу тэднийг цалинжуулах ёстой. Гэтэл дадлагажигч нарын цалин харилцан адилгүй байгаа нь эргэлзээ төрүүлж байна. 2008 оны 12 дугаар сарын 2-ны байдлаар 52 дадлагажигчийн цалингийн тодорхойлолт цугларснаас 5 дадлагажигч огт цалингүй ажилласан, 18 нь тодорхой хугацаанд цалингүй, 4 нь 108000 төгрөг, 10 нь 160000 төгрөг, 15 нь 208000 төгрөгөөр тус тус цалинжсан байна. Саяхныг хүртэл төгсөөд анх ажилд орсон цагаасаа

хoyш хагас жил гаруй хугацаанд огт цалин хөлс, хоол унааны зардал аваагүйгээр үл барам нийгмийн даатгалын шимтгэлийг дадлагажигч эмч хувиасаа төлж байсан тохиолдол ч бий. Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуульд хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй гэж заасан байдаг.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

2006 он хүртэл анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшүүлэх зөвшөөрөл бүхий сургууль төгсөж, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд ерөнхий мэргэжлийн зөвшөөрлийг эхний удаа 3 жилийн хугацаагаар олгож байхаар хуульчилжээ. Харин ерөнхий мэргэжлээр 2-оос доошгүй жил ажилласны дараа төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж эмнэлгийн нарийн мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд тухайн мэргэшлийн зөвшөөрлийг эхний удаа 5 жилийн хугацаагаар олгохоор заасан байлаа. Энэ нь эмнэлгийн мэргэжилтэн олон тооны зөвшөөрлийг хуульд заасан хугацааны дараа дахин дахин авахыг шаардаж байсан хүнд суртлын тогтолцоо болсон байв. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмж, гадаадын бусад орны нийтлэг жишгийн дагуу тодорхой хугацаанд практик дадлага хийж байгаад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх эрхээ баталгаажуулан авах тогтолцоонд шилжих нь зүйтэй болсон билээ.

Эмчилгээний шинэ арга, технологи нэвтэрч, хувийн эмнэлэг олноор байгуулагдаж, өвчний олон улсын ангилал шинэчлэгдсэн явдал нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтыг шинэ түвшинд гаргах, эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харгалзан Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг өрхийн, сум, сум дундын эмнэлэгт 2-оос доошгүй жил дадлагажигчаар ажиллаж мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд олгож байхаар, мөн 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар дээр дурдсан заалтыг уян хатан болгох зорилгоор эхний жилд өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт, хоёр дахь жилдээ аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмчид эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож байхаар тогтоосон юм.

Дадлагажигч нь ийнхүү эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахын тулд дор дурдсан нөхцөлийг заавал хангасан байвал зохино:

Нэгдүгээрт, анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн байх.

Хоёрдугаарт, Эрүүл мэндийн тухай хуулийн 17.3.1-д заасан эмнэлэгт 2 жил дадлагажигчаар ажилласан байх.

Гуравдугаарт, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн байх.

Дээрх шаардлага, нөхцөлийг хангасан дадлагажигч нь мэргэжлийн буюу эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах бүрэн эрхтэй. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг буюу “Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй” гэсэн заалт нь тусгай зөвшөөрөлгүй этгээд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр заасан. Өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг эмчлэх үйл ажиллагаа хэмээн ойлгохоор Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасан билээ. Дээрх заалтаас үзэхэд

өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан их эмч, бага эмч эрхэлнэ. Дадлагажигч энэхүү үүргийг гүйцэтгэхгүй юм. Харин хүний өвчин, эмгэг, гэмтлийг илрүүлэх, оношлох, магадлах, илааршуулах, сэргээн засах, сэргийлэх болон эх барихад чиглэгдсэн эмч, эмнэлгийн бусад мэргэжилтний дангаар буюу хамтран гүйцэтгэх үйл ажиллагааг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрахаар Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан билээ.

Энэхүү заалт ёсоор дадлагажигч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмчид туслах, түүнчлэн өвчтөнийг урьдчилан үзэж өвчин, эмгэгийн талаар тавьсан оношоо хянуулж, баталгаажуулан хамтран ажиллахаар заажээ. Харин дадлагажигч нь бие дааж өвчтөний өвчнийг оношлох, эмийн жор бичих эрх эдлэхгүй болно.

2/ Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал, ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын дагуу нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн магадлан итгэмжилсэн эмнэлэгт дадлагажигчаар ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн юм. Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар тушаалаар баталсан дадлагажигч их эмчийн ажиллах журмын дагуу аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын захиалга, мөн анагаах ухааны боловсрол олгох сургуулийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв дадлагажигч нарыг хуваарилж байна. Тухайлбал, 2007 онд улсын хэмжээнд нийт 400 дадлагажигчийг аймаг, нийслэлийн хэмжээний эмнэлгүүдэд байршуулж байснаас 205 дадлагажигч Улаанбаатарт хуваарилагдсан байжээ.

3/ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн “...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”, “...хүүхэд төрүүлэх, асрах”, “...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй”, “...сурч боловсрох эрхтэй”, “...оршин суух газраа сонгох, гадаадад явах” гэсэн заалтыг зөрчсөн гэх талаар:

Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14-т заасан ёсоор “хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг албадан хөдөлмөр” гэсэн ойлголтод хамааруулахаар хуульчилсан юм.

Дээр дурдсан тодорхойлолтоос харахад дадлагажигч хэсэг хугацаанд цалин хөлс, хоол, унааны зардал аваагүй, нийгмийн даатгалын шимтгэлийг хувиасаа төлж байсан зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудал түүнийг албадан хөдөлмөрлүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Иймд Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт болон 17.6 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл үгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцийн гишүүний тавьсан асуулгын дагуу Монгол Улсын Эрүүл мэндийн сайд Л.-ийн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн албан бичгийн агуулга:

Эрүүл мэндийн тухай хуульд дадлагажигч эмчийн талаар дараах өөрчлөлт орсон. 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад анагаах ухааны боловсрол олгох сургуулийг их эмчээр төгсөгчид нь өрх,

сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажиллах гэж өөрчлөн найруулсан. 2007 оны төгсөлтөөс эхлэн төгсөгчдийг дадлагажигчаар ажиллуулж байна.

Дадлагажигч эмчийг Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын хавсралт дахь сүлжээний ТҮЭМ-3 зэрэглэлээр цалинжуулж байгаа. Сар бүр 208691 төгрөг олгож байна. 2008 онд өрхийн эмнэлгүүдийн санхүүжилтэд өөрчлөлт орсноос нийслэлийн хэмжээнд дадлагажигч эмч нарт цалинг хугацаанд нь өгөөгүй тохиолдол гарсан боловч цалинг бүрэн нөхөж олгосон. 2009 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар Хөвсгөл аймгаас бусад Эрүүл мэндийн газарт харьяалагдаж буй дадлагажигчийн цалинг бүрэн шилжүүлээд байна. 2007 оны төгсөлтийн 433 дадлагажигч эмчээс 144 нь, 2008 оны төгсөлтийн 610 дадлагажигч эмчээс 186 нь нийслэлд ажиллаж байна. Дадлагажигч нар эмчлэх эрхийн зөвшөөрөлгүй атлаа эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй их эмчийн үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг үзүүлж байгаа талаар гомдол, санал үйлчлүүлэгчдээс ирээгүй болно.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 90 дүгээр тушаалаар батлагдсан “Дадлагажигч эмчийн ажиллах журам”-ын 7.1-д дадлагажигч нь дадлагажуулагчийн удирдлага дор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж, эмчлэгч эмчийн хэмжээнд оношлогоо, эмчилгээний талаар шийдвэр гарган хянуулж, баталгаажуулна, 7.2-т зайлшгүй шаардлагаар бие даан ажиллах тохиолдолд бусад дадлагажуулагч эмчээс зааварчилга авч ажиллана гэсэн заалтын дагуу дадлагажигч нь үйл ажиллагаагаа явуулж байна. Дэлхийн ихэнх улс оронд анагаах ухааны сургууль төгссөн их эмчийг тодорхой хугацаанд дадлага хийлгэж байж, эмчлэх эрхийн зөвшөөрөл өгч эмнэлэгт ажил эрхэлдэг туршлага байдаг.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт зааснаар эмчлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан их эмч, бага эмч эрхлэх эрхтэй байна. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтад “эмчлэх” гэж өвчнийг оношлох, илааршуулах, өвчтөнийг сэргээн засах, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг ойлгохоор заажээ.

Дадлагажигч их эмч нь дээрх цогц үйл ажиллагааг бие даан явуулах эрхгүй учраас дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүйн дээр эмчийн мэргэжлийн онцлог, хүн амын эрүүл мэндийг хамгаалах төрийн үүрэг зорилттой уялдуулан анагаах ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн хүмүүст эмчлэх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тодорхой шалгуур тавьдаг, мөн тэдгээрийг тодорхой хугацаанд дадлагажуулдаг олон улсын жишиг байдаг.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д “Өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч” 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт “Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 2, 4, 6 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч”, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт “Дадлагажигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван зургадугаар зүйлийн 2-ийн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ...эрхтэй”, 4-ийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”, 6-гийн “...эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэсэн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Өнөөдөр Монгол Улсад эмч, хуульч гэсэн мэргэжил эзэмшихээр их, дээд сургуульд элсэн суралцагч нарт эмчийн болон хуульчийн “тусгай зөвшөөрөл” гэсэн “даваа” сургуулиа төгссөний дараа учирдаг. Хүний амь нас, эрүүл мэндийг шийддэг мэргэжил болохоор зүй ёсны шаардлага тавихад буруу зүйлгүй.

Хамгийн гол нь эмчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй, хүлээх хариуцлага нь тодорхой бус дадлагажигч эмч нар өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэг, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн болон бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нүүр, ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажиллаж буй нь иргэдийн дунд таагүй сэтгэгдэл төрүүлж, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа юм. Сайн хуулийн нэг шалгуур нь амьдралд нийцсэн байх гэж би боддог.

Эрүүл мэндийн тухай хуулийг 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдөр шинээр батлан гаргасан. Эрүүл мэндийн тухай хуульд “дадлагажигч эмч” гэсэн нэр томъёо байхгүй бөгөөд цалингийн шатлал нь өөрчлөгдөж байгаа юм байна. Өргөдөл гаргагч маань Цэцийн гишүүдээс илүүтэйгээр асуудлыг мэдэрч чаджээ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009.11.04 № 04

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн С., Ч.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль<sup>109</sup>

- 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх заалт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”

- Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх”

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь хэсэгт зааснаар “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн заалтын дагуу нам, эвслийг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэхээс татгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар

<sup>109</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны №5-д нийтлэгдсэн

зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна.

Нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй, эвсэл хоцруулсан алдаатай үйлдлийнхээ төлөө Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийн заалтын дагуу 800000-1000000 хүртэл төгрөгөөр торгуулах шийтгэл хүлээж байгаа. Гэтэл энэхүү нэг удаагийн алдаатай үйлдлийнхээ төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулна гэдэг нь хууль зүйн шинжлэх ухааны нэг алдаанд нэг шийтгэл оногдуулах зарчмыг алдагдуулж байна. Аль нэг намын хариуцлагагүй ажилтны алдаанаас болж бусад гишүүд болон ирээдүйн гишүүд, дэмжигчдийн ардчиллын үнэт зүйлс болсон сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах нь утгагүй юм.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч С., Ч. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Нэг. Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл гэж заасан бөгөөд нам нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх, үйл ажиллагаагаа ил тод явуулах зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Сонгуулийн санхүүжилтийн үйл ажиллагааны бүх явц, үр дүнгийн нэг гол үндэслэл, хэлбэр нь сонгуулийн санхүүгийн тайлан юм. Энэ нь угтаа сонгуулийн хуулийн биелэлтийн мөнгөн илэрхийлэл, хяналтын гол хэлбэр болно.

Ийм ч учраас сонгуульд оролцсон нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөөгүй тохиолдолд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8-д заасны дагуу 800000-1000000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба харин мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6-д заасан Сонгуулийн ерөнхий хорооноос нам, эвслийг бүртгэхээс татгалзах зохицуулалт нь уг зөрчилд давхар оногдуулж буй шийтгэл бус харин дараагийн нөхөн сонгууль болон ээлжит сонгууль явагдахад өмнөх сонгуулийн дараа гарч байсан холбогдох зөрчил арилаагүй, үргэлжилсээр байх тохиолдолд, өөрөөр хэлбэл, өмнөх сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй хэвээр байгаа тохиолдолд авч буй хариуцлагын арга хэмжээ юм.

Хоёр. Хүний сонгох, сонгогдох эрхийг хангах, уг эрх хэрэгжих нэг үндэс нь сонгогчид бүхэлдээ сонгуулийн талаар мэдээллээр хангагдах явдал юм. Сонгуулийн шударга, ил тод байх, хууль дээдлэх зарчмыг хангах үндсэн зарчмын нэг болсон санхүүжилтийн ил тод байдлыг зөрчиж, хуульд заасан үүргээ дараагийн сонгууль зарлах хүртэл хугацаанд биелүүлээгүй улс төрийн намыг сонгуульд бүртгэхээс татгалзах талаар зохицуулсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа бус, харин ч иргэд шударга, чөлөөт сонгуулийн үндсэн дээр сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болж байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт болон Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу "...нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх", "...үйл ажиллагаагаа ил тод явуулах" зарчмыг хэрэгжүүлэх нь улс төрийн намын үүрэг байдаг.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар өмнөх сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөх үүргийг сонгуульд оролцсон улс төрийн намуудад бүгдэд нь нэгэн адил

хүлээлгэдэг бөгөөд харин хуулийн шаардлагыг дараагийн сонгууль хүртэлх хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан улс төрийн намыг Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэхээс татгалздаг зохицуулалт нь тухайн хууль зөрчсөн улс төрийн намд хуулийн дагуу хариуцлага оногдуулж байгаа асуудал бөгөөд үүнийг тухайн намын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхсан, хэлмэгдүүлсэн, аль нэг намд давуу эрх олгосон зохицуулалт гэх хууль зүйн үндэслэлгүй болно.

Гурав. Сонгуульд оролцогч улс төрийн нам, нэр дэвшигчид сонгуулийн дансанд оруулсан хөрөнгийг хуульд заасан зориулалт, хязгаарлалтын хүрээнд ашиглах, сонгуулийн санхүүжилт, зардлыг нээлттэй ил тод байлгах асуудал нь сонгуулийн тэгш, шударга байдлыг хангах, иргэний улс төрийн эрхийг баталгаатай хангах үндэс болно. Сонгогч нь сонгуульд нэр дэвшигч, сонгогдогчийн үйл ажиллагааны талаар аливаа мэдээлэл, түүний дотор сонгуулийн санхүүжилт, хандивтай холбоотой мэдээлэл авах эрхтэй. Энэ нь сонгуулиар далимдуулан хууль бусаар мөнгө хуримтлуулах, төсвийн хөрөнгийг ашиглах зэрэг санхүүгийн булхайг таслан зогсооход тун чухал.

Иймд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь сонгуулийг нээлттэй ил тод, шударга, үр дүн нь бодитой байх, улмаар иргэдийн сонгуулийн эрхийг хангах хууль зүйн нэг гол баталгаа болсон гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах эрхтэй төрийн байгууллага атал түүнд улс төрийн нам, эвслийг өмнөх сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй, хугацаанд нь ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзаж сонгуульд оролцох эрхийг хасах эрх хэмжээг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаар олгосон нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нам, эвслийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг заасан 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10 дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх",

Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын “хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн хэсгийн үйлчлэлийг 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 86 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10 дахь заалтын “Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Аливаа намын зорилго нь сонгуульд ялалт байгуулах буюу засгийн эрхийг авах явдал байдаг. Зардлын тайлангаа бүхэл бүтэн 1 сарын дотор гаргаж өгч чадахгүй байж яаж засгийн эрхийг барих том зорилгоо хэрэгжүүлэх вэ гэж та асууж магадгүй.

Хэн нэгэн эрх бүхий албан тушаалтан (жишээ нь: нягтлан бодогч)-ы хайхрамжгүй үйл ажиллагааны улмаас нэр дэвшигчид, мянга мянган сонгогчдын эрх хохирох нөхцөл байдалд ч хүрч болзошгүй юм. Өөрөөр хэлбэл хэдийгээр нам, эвсэл нь өмнөх сонгуулийн зардлын тайланг тогтоосон хугацаанд ирүүлэх үүрэг хүлээх боловч дээрх хугацаанд багтаагүй, эсхүл ирүүлээгүй гэсэн шалтгаанаар дараагийн сонгуульд оролцуулахгүй гэх үндэслэлээр тухайн нам, эвслийг дэмжигч, сонгогч нарын сонгуульд оролцох эрхийг хааж болохгүй гэж би бодож байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2010.01.22 № 01

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., О.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., О. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нь “сонгогдох” эрхээ дараах 2 арга замаар хэрэгжүүлж болох боломжийг тусгасан. Үүнд:

а/ Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам буюу намуудын сонгуулийн эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

б/ Монгол Улсын сонгогдох эрх бүхий иргэн тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.

Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын сонгуульд сонгогдох эрхээ улс төрийн намаар дамжуулж биш шууд бие даах замаар эдэлж байгаа бол сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцогч-бие даан нэр дэвшигч болон сонгуулийн байгууллагын хооронд шууд харилцаа үүсдэг. Харин Монгол Улсын иргэн сонгогдох эрхээ улс төрийн намаар дамжуулан хэрэгжүүлж байгаа бол намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн, намын Их Хурал, эсхүл түүнээс сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцоходоо бие даасан субъект болж оролцдог бөгөөд улс төрийн намаар дамжуулан сонгогдох эрхээ хэрэгжүүлж буй нэр дэвшигчийн хувьд тухайн этгээд болон сонгуулийн байгууллагын хооронд шууд харилцаа үүсдэггүй, улс төрийн намаар дамжуулан сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцож байдаг, улс төрийн нам нь тухай иргэний болон сонгуулийн байгууллагын хооронд харилцах “гүүр” болж, гишүүнийхээ сонгогдох эрхийг хангах талаар тодорхой хууль зүйн үүрэг хүлээдэг. Иргэний сонгогдох эрх нь тухайн сонгуулийн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг харгалзсан, хууль ёсны болзлыг хангасан байхыг шаарддаг бөгөөд уг хууль ёсны болзол шаардлагыг хангах талаар тухайн иргэнийг нэр дэвшүүлэх гэж буй улс төрийн нам мөн адил хууль зүйн үүрэг хүлээдэг. Улс төрийн нам уг хууль зүйн үүргээ биелүүлээгүйгээс болж сонгуульд тухайн намаас нэр дэвшиж оролцох эрхээ алдаж буй тухайн намын гишүүниргэнийхээ хувьд сонгогдох эрхээ өөр байдлаар хэрэгжүүлэх эрх нь нээлттэй хэвээр байна.

2/ Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж заасан бөгөөд нам нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс,

шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх, үйл ажиллагаагаа ил тод явуулах зарчмыг баримтлахаар заасан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтад “Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ” гэж заасан байна.

Улс төрийн нам бол тодорхой нарийн бүтэц, зохион байгуулалттай, хууль зүйн үүрэг хүлээж, эрх эдэлж буй хуулийн этгээд болохын хувьд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдохын тулд хуульд заасан шаардлагыг биелүүлэх, зөрчлөө арилгах чадвартай байх нь зүй ёсны хэрэг бөгөөд Улс төрийн намын тухай хуульд намын санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй нэгжийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавихаар заасан бөгөөд намын төв байгууллага нь харьяа байгууллагын санхүүгийн тайлан гаргасны дараа нэгдсэн тайлан гаргахаар тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх асуудлыг намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэхээр хуульд заасан. Нам, эвсэл сонгуульд оролцох тухайгаа санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлэх ба бүртгүүлэхдээ хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагыг хангасан байх талаар бүртгүүлэхээс өмнө тухайн намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага нь шийдвэрлэх бүрэн боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн хандив авахыг хориглосон этгээдийг тодорхой зааж өгсөн бөгөөд энэ заалтад заасан этгээдээс хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах хүртэл арга хэмжээг Сонгуулийн ерөнхий хороо авахаар хуульд заасан байна. Улс төрийн намын сонгуулийн хууль бус санхүүжилт нь санал худалдаж авах, улс төрийн нам, нэр дэвшигчид гадаад, дотоодын хандивлагчдын эрхшээлд орох, өөрөөр хэлбэл улс төрийн намд хандив өгөөд түүнийхээ хариуд хууль бусаар давуу тал олж авах, төрийн эрх мэдэл эх үүсвэрийг сонгуулийн ажилд урвуулан ашиглах зэрэг зүй зохисгүй үйлдэлд хүргэж авилгалын үр дагаврыг бий болгож, улмаар Үндэсний аюулгүй байдалд заналхийлэх нөхцөл байдлын гол шалтгааны нэг болдог байна. Иймд Сонгуулийн ерөнхий хороонд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй нам эвслийг бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах эрх олгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан “Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ” гэсэн нөхцөл хангагдах, улмаар Үндэсний аюулгүй байдлыг хангах нэг баталгаа болж байна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар өмнөх сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөх үүргийг сонгуульд оролцсон улс төрийн намуудад бүгдэд нь нэгэн адил хүлээлгэдэг бөгөөд харин хуулийн шаардлагыг дараагийн сонгууль хүртэлх хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан улс төрийн намыг Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэхээс татгалздаг зохицуулалт нь тухайн хууль зөрчсөн улс төрийн намд хуулийн дагуу хариуцлага оногдуулж байгаа асуудал бөгөөд үүнийг тухайн намын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхсан, хэлмэгдүүлсэн, аль нэг намд давуу эрх олгосон зохицуулалт гэж үзэхгүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн С., Ч. нарын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарыг дэмжиж байгаагаа мэдэгдье.

## **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах эрхтэй төрийн байгууллага атал түүнд улс төрийн нам, эвслийг өмнөх сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй, хугацаанд нь ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзаж сонгуульд оролцох эрхийг хасах эрх хэмжээг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаар олгосон нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10 дахь заалтын “...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 4 дүгээр дүгнэлт нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, мөн хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10 дахь заалтын “...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэснийг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү тогтоол нь гармагцаа хүчин төгөлдөр болно.

### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт “Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ”, мөн зүйлийн 40.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 40.2-40.4-т заасныг зөрчсөн нам, эвслийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас долоо дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 40.5-д заасныг зөрчсөн банкны захирлыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгоно” хэмээн заажээ.



Мөн дээрх хуулийн 23 дугаар зүйл, 25 дугаар зүйлд санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн нам буюу эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайланг Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр ирүүлээгүй бол тухайн нам, эвслийг бүртгэхээс татгалзах талаар зохицуулалт орсон байна.

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009.11.13 № 05

### Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Ц., Т., Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их хурлын гишүүн Б.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр баталсан Цөмийн энергийн тухай хууль<sup>110</sup>

- 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ”

- 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг “Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”

- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”

110 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2009 оны № 29-д нийтлэгдсэн

## Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

### 1. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:

Нэг. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчлагдсан төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчим нь Монгол Улсын төр, иргэн, хуулийн этгээд нь нийгмийн харилцаанд ямарваа ялгаваргүй, ижил тэгш нөхцөлөөр хангагдаж, хууль, шүүхийн өмнө адил эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох үндсэн агуулгыг илэрхийлдэг. Энэхүү агуулгаас үзэхэд “төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчим” гэдэг нь нийгмийн аливаа харилцаанд оролцож буй субъектүүдэд хууль, эрх зүйн тэгш нөхцөлийг бий болгох шаардлагыг төрд бий болгодог бөгөөд Улсын Их Хурал нь аливаа хуулийг батлан гаргахдаа тухайн нийгмийн харилцаанд оролцогчдын тэгш байдлыг алдагдуулахгүй байх ёстой.

Гэтэл Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтуудаар цацраг идэвхт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хувь, хэмжээг төр “үнэ төлбөргүй, шууд” авахаар зохицуулсан нь аливаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд ялгавартай байдлыг бий болгож, тэгш байдлыг олгоогүй байна.

Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хувь, хэмжээг Монгол Улсын төр “ямар нэг хэмжээний хөрөнгө оруулахгүйгээр, үнэ төлбөргүй, шууд” авч, өөрийн өмчлөлд шилжүүлэх гэсэн агуулга бүхий зохицуулалт хийсэн нь нийгмийн харилцаанд оролцогчдын хувьд тэгш бус, ялгавартай нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэх үндэслэл болж байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчлагдсан “хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” нь Монгол Улсын төр, иргэн, хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаандаа Үндсэн хууль болон бусад төрөлжсөн хуулиудыг хүндэтгэн сахин биелүүлэх, нийгмийн харилцаанд оролцогч талууд харилцан хариуцлага хүлээх, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хангах, аливаа зөрчигдсэн эрхийг хамгаалах, сэргээх, төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа зөвхөн хуулийн хүрээнд явагдах, байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хууль ёсыг чандлан сахих зэргээр хуулийн засаглал тогтоох агуулгыг илэрхийлдэг хэмээн онолын хувьд тодорхойлсон байдаг.

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт тусгагдсан заалтууд нь төр Үндсэн хуулиар тодорхойлогдоогүй аргаар бусдын өмчийг үнэ төлбөргүй авах зохицуулалтыг бий болгожээ. Иймээс Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Хоёр. Цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа гэдгийг тусгайлан тодорхойлсон хууль Монгол Улсад байхгүй. Харин “компанийн хувьцаа” гэдгийг хуульд зааснаар тодорхойлбол “тухайн компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас” /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг иш татсан/ бөгөөд “энэхүү үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байдаг” /Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 467.8 дахь хэсгийн заалтыг иш татсан/

Дээр дурдсанаас үзвэл компанийн хувьцааг “өмч” гэж тодорхойлсон ба энэ агуулгын хүрээнд “өмчлөгчийн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан байна”. Ийнхүү өмчлөх эрх хуулиар хамгаалагдсан хэдий ч өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “...гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж зохицуулжээ. Гэвч энэ заалт нь өмчлөгчийн өмчлөлийн зүйлээ эзэмших, ашиглах, захиран зарцуулах, мөн хамгаалах эрхүүдийг /Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсгийн заалтыг иш татсан/ хязгаарлахад хамаардаг. Өөрөөр хэлбэл, өмчлөгч өөрийн эрхээ хуульд заасан хэмжээ, хязгаарын дотор эдлэх, хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй байгаа нь нийтийн ашиг сонирхолд харшилж байгаа бол хуульд зааснаар өмчлөгчийн эрхийг хязгаарлах агуулга юм. Хэрэв Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт тус тус тусгагдсан зохицуулалт нь бусдын өмчийг дайчлан авч буй хэлбэр гэж үзвэл Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “...Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасны дагуу зайлшгүй нөхөн төлбөр төлөх шаардлагатай юм.

Иймээс Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “...Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Гурав. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар “Олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд, хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ” гэжээ.

2009 оны байдлаар Монгол Улс нь гадаадын 40 гаруй улстай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай гэрээ, хэлэлцээрийг байгуулсан бөгөөд Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд зааснаар тэдгээр 40 гаруй гэрээ, хэлэлцээрүүд нь Монгол Улсын олон улсын гэрээ мөн.

“Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 2 болон 5 дугаар зүйлүүд, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 3 дугаар зүйлийн 1 болон 4 дүгээр зүйлүүд, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйл, “Хөрөнгө оруулалтыг дэмжиж хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйл болон Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хоёр талын гэрээнүүдэд хөрөнгө оруулалтыг хамгаалах, тэрхүү хөрөнгө оруулалт буюу бусдын өмчийг дайчлан авах тохиолдолд эрх зүйн урьдчилсан тодорхой нөхцөл үүссэн байх, хэрэв тухайн нөхцөл үүссэн тохиолдолд төрөөс нөхөн олговор зайлшгүй олгох тухай тусгагдаж, баталгаажсан байдаг байна.

Дээрх гэрээнүүд Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, мөн Арван зургадугаар зүйлийн 3-т тус тус заасантай бүрэн нийцэж байгаа бөгөөд ийнхүү “бусдын

өмчийг хамгаалах, мөн аливаа хэлбэрээр дайчлан авсан тохиолдолд нөхөн олговор олгох тухай” зохицуулалтууд байсаар атал Цөмийн энергийн тухай хуулийн Тавдугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт бусдын өмчийг төр “үнэ төлбөргүйгээр, шууд” авах зохицуулалт бий болгосон нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

2. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:

Нэг. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудын зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулбал, Ашигт малтмалын тухай хуулийн Тавдугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгүүдэд зааснаар “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно”, “Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэжээ. Үүнээс үзвэл, газрын хэвлийд байдаг ашигт малтмал / алт, хүдэр, нүүрс гэх мэт/ болон цацраг идэвхт ашигт малтмалын хувьд, хоёулангийнх нь орд стратегийн ач холбогдолтой гэсэн ангилалд багтахын зэрэгцээ төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийх тохиолдолд төрийн оролцооны хувь, хэмжээ нь төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийгээгүй нөхцөлөөс их хэмжээтэй байх зэрэг адил нөхцөл байдал үүссэн буюу урьдчилсан нөхцөл нь нэгэн адил байхад ашигт малтмалын хувьд цацрагт идэвхт ашигт малтмалын зохицуулалтаас өөр байдлаар “тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь эзэмшихээр” зохицуулалт хийгдсэн байна. Энэ нь харилцаанд оролцогчдын ашиг сонирхлын байдал адил байхад, ашигт малтмалын болон цацрагт идэвхт ашигт малтмалын харилцааг ялгаатай байдлаар зохицуулсан нь тодорхой байна. Улмаар ашиг сонирхлын адил нөхцөлд байгаа этгээдүүдэд төрийн зүгээс адил боломж олгож, адил эрх зүйн зохицуулалт хийгээгүй нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан “шударга ёсны” зарчмыг зөрчиж байна гэж үзэх үндэслэл болно.

Хоёр. Цөмийн энергийн тухай хуульд хувьцааны тухай ойлголт, гүйцэтгэх чиг үүрэг зэрэг ойлголтуудыг тодорхойлох шаардлагагүй тул энэ ойлголтыг зохицуулсан холбогдох хуулиудад шууд хандвал, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу “Хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ”, түүнчлэн тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар “Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй”. Харин Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т заасны дагуу “Хувьцаа гэдэг нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас” гэж хувьцааны тухай ойлголтыг тодорхойлсон байна.

Харин Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудад хуульчилсан “үнэ төлбөргүйгээр” хамтарсан компанийн хувийг эзэмших зохицуулалт нь дээр дурдсан холбогдох хуулиудын хувьцааны тухай заалт, зохицуулалтыг зөрчиж буй нь илэрхий байна.

Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу “энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр”-ийг тусгай зөвшөөрөл хүсэгч нь бүрдүүлэн өгөх бичиг баримтад хавсаргах үүрэг хүлээж байгаа. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2, 3 дугаар зүйлүүдэд зааснаар “Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацрагт идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл журмын дагуу шинэчлэн бүртгэх” бөгөөд шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдөлдөө “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн тухай хуульд заасан төрийн оролцооны хувийг төрд эзэмшүүлэхийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэрийг хавсаргасан байна”. Нэгэнт үүсгэн байгуулагдчихсан, үйл ажиллагаагаа эрхлэн явуулж буй компанийн хувь нийлүүлэгчдийн хувьцаанаас холбогдох хуульд заасан тодорхой хувийг үнэ төлбөргүйгээр төрийн эзэмшилд шилжүүлж буй тохиолдолд энэ нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарах хэсгийг эрх бүхий субъектын хүсэл зоригоос хамааралгүйгээр төрийн өмчлөлд шилжүүлж буй явдал бөгөөд үүний хариуд үнэ төлбөр төлөхгүй байх нь Үндсэн хуульд тунхаглагдсан хууль дээдлэх, хууль ёсны байх зарчмыг зөрчиж байгаа билээ.

Үнэт цаас болж байгаагийн хувьд Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу “Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна”. Улмаар хувьцаа үнэт цаас болж байгаа учир хувьцаа эзэмшигч нь түүний өмчлөгч байх ба үнэт цаасны хувьд өмчлөх эрх эдлэх юм. Өмчлөх эрхийн тухай ойлголтыг хувийн эрх зүйд тодорхойлсон байдаг бөгөөд өмчлөх эрх субъектив эрх болж байдаг. Улмаар Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь субъектив эрх болж буй үнэт цаасыг өмчлөх эрх шилжих хувийн эрх зүйн догматикийг зөрчиж байгаа нь тодорхой байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэжээ. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудын дагуу цацрагт идэвхт ашигт малтмалын ордыг хамтарсан компани байгуулж, хувь нийлүүлэгч болж буй хуулийн этгээдийн хүсэл зоригоос гадуур, үл хамааран хувьцааны тодорхой хувийг төрийн мэдэлд шилжүүлнэ гэдэг нь Үндсэн хуульд тусгагдсан дайчлан авах үйлдэл мөн гэж үзэж болох юм. Гэхдээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу дайчлан авч буй тохиолдолд заавал нөхөн олговор, эсхүл төлбөр төлөх шаардлагатай.

Дөрөв. Цацрагт идэвхт ашигт малтмалыг ашиглах зорилгоор үүсгэн байгуулах хамтарсан компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хувиа оруулан өмчилж буй хувьцааг төр үнэ төлбөргүй авна гэдэг нь бусдын өмчлөлийн зүйлийг, тодруулбал, бусдын хөдөлмөр, зүтгэл, мөнгө, хөрөнгөөр олж авсан үнэт цаас болох хувьцааг хариу төлбөргүйгээр олж авч байгаа үйлдэл билээ. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг давхар зөрчиж байна гэж үзэх үндэслэл байгааг нотолж байна. Учир нь өмчийн баталгаа гэх ойлголтод аливаа зүйлсийг өөрөө хариуцлага хүлээх нөхцөлтэйгээр өөрийн үйлдэл, хөрөнгө, ажил хөдөлмөрөөр олж авна гэсэн үзэл санаа багтах бөгөөд өөрийн хөдөлмөр, ажил, хөрөнгө, мөнгө, хичээл зүтгэлээр олж авсан зүйлсийг өөр этгээд авч байгаа бол заавал хариу нөхөн төлбөр өгөх шаардлага урган гарч ирж байна.

Тав. Монгол Улс бусад улстай байгуулсан хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хоёр талын 40 гаруй олон улсын гэрээ байдгаас жишээ болгон дурдвал, Монгол Улс Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын гэрээ” бөгөөд тус гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Нийтийн ашиг сонирхлын

үүднээс ялгаварлан гадуурхахгүйгээр, хойшлуулахгүй зохих ёсны, үр ашигтай нөхөн төлбөр хийх үндсэн дээр зохих хууль болон хоёрдугаар зүйлийн 2-т заасан нөхцөлийн ерөнхий зарчмын дагуу гүйцэтгэхээс бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хураан авах, нийгэмчлэх /дайчлан гаргуулах/ буюу үүнтэй адилтгах аливаа арга замаар шууд буюу шууд бусаар хураан авах буюу нийгэмчилж болохгүй” гэсэн байна.

Иймд Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт болох “Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх” цацрагт идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг, түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээг, улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын дагуу “энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр”-ийг тусгай зөвшөөрөл хүсэгч нь бүрдүүлэн өгөх бичиг баримтад хавсаргах үүрэг хүлээж байгаа. Ийнхүү шийдвэрийг хавсаргаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлөө хураалгах, алдах нөхцөл байдал үүснэ. Гэтэл энэ нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж буй явдал билээ.

### 3. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ” гэсэн заалт, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийн “Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ” гэсэн заалтууд нь хуулийн хувьд ихээхэн учир дутагдалтай байгаад зогсохгүй Үндсэн хуулийг ноцтой зөрчсөн байна.

Энэ заалтуудад дурдсан хувьцаа гэдэг үгсийг анхаарч үзвэл энэ нь Иргэний хуулийн тодорхойлолтын дагуу өмч гэж тодорхойлогдсон байна. Компанийн хувьцаа яригдаж байгаа бол гарцаа байхгүй тухайн компанийн хувь эзэмшигчийн өмч, аж ахуйн баланс бүртгэл дээр нь тодорхой үнэ цэнэ агуулж байдаг үнэт цаас юм. Үндсэн Хуулийн Тавдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд тус тус ноцтойгоор зөрчигдлөө. Дээр дурдсаны дагуу хувьцаа бол өмч мөн. Үндсэн хууль бол хөдөлмөрчдийн өмчийг хамгаалах хамгийн том баталгаа байх ёстойн дагуу “шууд” бөгөөд “үнэ төлбөргүй” өмчөөс салгах үндэс байхгүй. Иймд дээрх хоёр хуулийн дурдсан заалт буюу Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалт, Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл тус тус Үндсэн хуультай зөрчилдөж байгааг тогтоож, улмаар хүчингүйд тооцож өгнө үү.

### 4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, мөн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”, түүнчлэн Иргэний хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмчид байна” гэж Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүний хэвлийд байгаа баялгийн өмчлөл төрд хадгалагдахаар тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 1/ хууль батлах...” гэж заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Цөмийн энергийн тухай хуулийг 2009 оны хаврын ээлжит чуулганаараа хэлэлцэж батлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт заасан бүрэн эрх, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасны дагуу холбогдох нөхцөл, журмыг хуулиар тодорхойлж хуулийн этгээдэд төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйл буюу энэ тохиолдолд газрын хэвлий, түүний баялгийг эзэмшүүлэх, ашиглуулахдаа төр өөрийн эзэмших хувь, хэмжээгээ тогтоосон. Уг хувь, хэмжээ нь газрын хэвлий, ой, ус, ан амьтан зэрэг баялгийг төр өмчлөх эрхийг хөндөөгүй харин тухайн баялгийн зарим хэсгийг зохих журмын дагуу ашиглах эрх бүхий хамтарсан өмчит хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хэсгийг өмчлөх эрхийг төрд олгосон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасны дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрт нь үе шаттайгаар хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт “цацраг идэвхт ашигт малтмал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эдийн засагт онцгой ач холбогдолтойг харгалзан цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулна” гэж тодорхойлсон.

Үүнээс дүгнэхэд төр өөрийн өмчийг, тодруулбал газар, газрын хэвлий, түүний баялаг буюу энэ тохиолдолд цацраг идэвхт ашигт малтмал - стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, ордыг хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн дагуу шаардлагатай нөхцөл, журмын дагуу буюу дотоод, гадаадын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ашиглуулахдаа хамтарсан компани байгуулж, түүний хяналтын багцыг эзэмшинэ. Төр өөрийн өмчийг ашиглуулахдаа буюу бусад хуулийн этгээдтэй хамтран нөөцийг ашиглахдаа улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувь, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр бэлэн бусаар буюу өөрийн өмч буюу газар, газрын хэвлий, түүний баялгаар хөрөнгө оруулж байгаа гэсэн ойлголт юм. Түүнчлэн, дээр дурдсанчлан цацраг идэвхт ашигт малтмал нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал учраас төр цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий хамтарсан компанийн хяналтын багцыг зайлшгүй өөртөө хадгалах шаардлага нь зүй ёсны бөгөөд энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой юм.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... газрын хэвлий, түүний баялаг төрийн өмч мөн” гэж заасан байна.

Цөмийн энергийн тухай Монгол Улсын хуульд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн болон улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хамтран эзэмшигч компанийн хувьцаанаас төр өөрийн эзэмших хувь, хэмжээ, нөхцөлийг тогтоосон нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ”, мөн зүйлийн 5.3 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван зургадугаар зүйлийн 3-ын “Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс ДҮГНЭЛТ гаргах нь:

1. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ”, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийн “Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 3, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ... төрийн өмч мөн” гэж заасан байдаг. Мөн цацраг идэвхт ашигт малтмалын харилцаанд төрийн оролцоо зайлшгүй байх шаардлагатай юм. Учир нь цацраг идэвхт ашигт малтмалын харилцаа нь өөрөө онцгой харилцаа /аюулгүй байдал, зохион байгуулалт, хяналтыг дээд зэргээр шаарддаг/ тул өмчийн эзний хувьд онцгой журам тогтоох нь зүйн хэрэг.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас онцгойлон анхаарч өгч байгаа бөгөөд цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбоотой харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар бус, харин тусгайлан баталсан Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулдаг, цацраг идэвхт ашигт малтмалын орд газар нь нөөцийн их багаас үл хамаарч бүгд стратегийн орд газарт хамаардаг зэргээр үүний ач холбогдол илэрдэг.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009.11.18 № 06

### Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., З.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>111</sup>

- 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг “Энэ хуулийн 8.1-д заасан нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлнэ”
- 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг “Аль ч нам, эвсэл энэ хуулийн 8.1-д заасан суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ”
- 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг “Энэ хуулийн 9.1, 9.2-т заасны дагуу нэр дэвшигчийг холбогдох Байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана”
- 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг “Энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаргасан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалтыг илээр явуулна”

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”
- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”
- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно”

111 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 28-д нийтлэгдсэн

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Л.-ийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн...” гэж заасныг, мөн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудын хэм хэмжээг тус тус зөрчсөн байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь энэхүү хуулийнхаа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг баталгаажуулсан 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтыг шууд утгаар зөрчиж байна. Монгол Улсын иргэний болон Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дээр дурдсан заалтуудыг хүчингүй болгож өгнө үү.

### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч З.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:**

Нэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлд “Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно” гэж заасан. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр Улсын Их Хурлын даргыг сонгох үйл ажиллагааг зохицуулсан. Хуулиар Улсын Их Хурлын даргыг томилдоггүй, төлөөллийн ардчилсан зарчмаар гишүүдийн дундаас нэр дэвшүүлэн, чуулганаар хэлэлцүүлж, санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авсан бол түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоол гаргадаг журамтай.

Парламентын сонгуульд оролцсон нам, эвсэл тухайн сонгуулийн үр дүнд авсан суудлын тоогоороо олонхи, цөөнх болж, нэр дэвшиж сонгогдсон гишүүд нь өөрийн нам, эвслийн бүлгийг парламентад байгуулдаг. Бүлэг нь парламентын үйл ажиллагаанд ард түмний эрх ашгийн үүднээс намынхаа бодлогыг тусгах гол үүрэгтэй. Үүнийг Улс төрийн намын тухай хуулийн 22 дугаар зүйлд “22.1.2. хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон бодлогын талаархи асуудлыг Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ, хэрэв намын бүлэггүй бол Улсын Их Хурлын гишүүнээрээ дамжуулан Улсын Их Хуралд оруулах; 22.1.3. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх санал тавих; 22.1.4. Улсын Их Хурал дахь намын бүлгээрээ дамжуулан Улсын Их Хурлын чуулганы нээлтийн ажиллагаанд улс орны бодлогын асуудлаар байр сууриа илэрхийлэх” гэж заасан.

Бүлэг бол Улсын Их Хурлын зохион байгуулалтын нэг хэлбэр. Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд “13.1. Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, байнгын болон дэд, түр хороо, намын бүлэг, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж тодорхойлсон. Улсын Их Хурлын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулах ба бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор дэвшиж сонгогдсон гишүүд орно. Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын даргыг сонгосноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ. Бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ. Хуулийн дагуу зохион байгуулагдсан бүлэг Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу чуулганаар хэлэлцэж байгаа бүхий л асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж

санал, дүгнэлтээ гаргах эрхтэй. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хуралд олонхи болсон нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлэх ба олонхи суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ. Нэр дэвшигч санал хураалтаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн дэмжлэг авсан бол түүнийг Улсын Их Хурлын даргаар сонгогдсонд тооцож тогтоол батална. Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Хоёр. Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь мөн хуулийн 7.1.6 дахь заалттай зөрчилдсөн эсэх талаар:

Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлд “Улсын Их хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан бөгөөд гишүүний бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлээр хуульчилсан. Бүлэг бол парламентын зохион байгуулалтын нэг хэлбэр бөгөөд гишүүн бүлэгт нэгдэн орох эсэхээ өөрөө шийдвэрлэдэг. Гишүүн Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэгт элсэн орсноороо түүний бүрэн эрх хязгаарлагддаггүй. Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн, байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаан дээр хэлэлцэгдэж байгаа аливаа асуудлаар асуулт тавьж хариулт авах, түүнчлэн үг хэлж байр сууриа илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх зэрэг бусад бүрэн эрхээ ямар нэгэн гадны нөлөөгүй, хуулийн дагуу хэрэгжүүлдэг. Улсын Их Хурлын тухай хуулийн 9.7-д “Гишүүд байнгын хороо, нам, эвслийн бүлгийн болон нэгдсэн хуралдаан дээр нэр дэвшигчид асуулт тавьж хариулт авах, үг хэлж байр сууриа илэрхийлэх эрхтэй” гэж гишүүний эрхийг давхар баталгаажуулсан болно.

Иймд Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд нь мөн хуулийн 7.1.6 дахь заалтын Улсын Их Хурлын гишүүн “Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульт бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх” эрхтэй гэсэн заалттай зөрчилдөөгүй болно.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгох үед байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлт гэж гардаггүй. Учир нь Улсын Их Хурлын даргаа эхэлж сонгосны дараа бүлэг, байнгын хороод зохион байгуулагддаг. Харин Улсын Их Хурлын тухай хуулийн 9.3, 9.4-ийн “нэр дэвшигчийг холбогдох байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Энэ санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалт явуулна” гэсэн заалт нь илүүтэй Улсын Их Хурлын даргын бүрэн эрх Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд шинээр дахин сонгохтой холбогдсон заалт юм.

Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвсэл Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэх эрхтэй ч Улсын Их Хурлын даргад заавал олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшсэн нь сонгогдох албагүй юм. Юуны өмнө нэр дэвшигч сонгогчдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа мэдэрч ойлгодог, Улсын Их Хурлыг төлөөлөх чадвартай, нас, мэдлэг, ёс суртахууны хувьд зохих шаардлагыг хангасан, олонхи болон цөөнхийн ашиг сонирхлын хооронд зуучлагч байх чадвартай, парламентын ёс зүй, улс төрийн соёлыг илэрхийлэгч тийм хүн байх ёстой. Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвсэл ийм үүднээс хандаж нэр дэвшүүлдэг тул гишүүдийн олонхийн дэмжлэгийг авдаг болно.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүдийн нэгдмэл саналыг чухалчилдаг. Улсын Их Хурлын дарга аль нэг нам, эвсэл, олонхийн улс төрийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалагч биш гэдгийг үүгээр харуулж байна. 1992-2008 оны хооронд Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэн сонгохдоо энэ зарчмыг баримталсан гэхэд болно.

Парламентын нэг онцлог нь гишүүд нь эрх тэгш гэж тооцогдоно. Тэдгээрийн зарим нь дотоод зохион байгуулалтын бүтэцтэй удирдах алба хаших онцгой үүрэг хүлээдэг болно, гэхдээ гишүүний санал ач холбогдлоор адилхан. Өөрөөр хэлбэл, парламент гадагш гаргах шийдвэрээ хамтаар гаргадаг байгууллага. Иймээс гишүүний эрх зүйн байдал нэлээд онцлогтой.

“Улсын Их Хурлын дарга, дэд дарга, байнгын, дэд, түр хорооны дарга, Улсын Их Хурлын сонгуульд бусад удирдах албан тушаалд сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх” гэсэн гишүүний бүрэн эрхийг Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.6-д онцгойлон заасан. Энэ эрх хөндөгдөөгүй. Улсын Их Хуралд олонхи цөөнх болсон гишүүний аль нь ч гишүүний үүрэг хариуцлагын хувьд ижил, адилхан бүрэн эрхтэй.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтаар “Улсын Их Хурлын дарга...-д сонгогдох, тэдгээрт өөрийн нэрээ дэвшүүлэх” эрхтэй байна. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтаар дээрх эрхийг хязгаарлаагүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Улсын Их Хурал дахь олонхи болсон нам, эвсэл Улсын Их Хурлын даргын сонгуульд нэр дэвшүүлнэ”, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “Аль ч нам, эвсэл энэ хуулийн 8.1-д заасан суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ”, 9.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 9.1, 9.2-т заасны дагуу нэр дэвшигчийг холбогдох байнгын хороо, түүнчлэн шаардлагатай гэж үзвэл нам, эвслийн бүлгүүд хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана”, 9.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаргасан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж санал хураалтыг илээр явуулна” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн... сонгоно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль... бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4 дэх хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын дарга, ...-ыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн... сонгоно”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль... бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **Тэмдэглэл:**

Үндсэн хуулиар тогтоосон Улсын Их Хурлын даргыг сонгох журмыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн зохицуулалтаар явцууруулсан гэж үзэж байна.

Учир нь Үндсэн хуулиар Монгол Улсын Их Хурлын гишүүн бүр Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлэх эрхтэй байхаар ойлгогдож байхад Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийн бүлэг, хэрэв аль ч нам, эвсэл 39 ба түүнээс дээш суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл нь бусад нам, эвсэлтэй зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлж болохоор ойлгогдож байна.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хуралд цөөнх болсон нам, эвслийн бүлэг, бие даан нэр дэвшигч Улсын Их Хурлын даргад нэрээ дэвшүүлэх эрхийг хязгаарласан зохицуулалт болсон байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2009.11.25 № 07**

### **Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Х., Ц., Б., А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн М., О.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хууль<sup>112</sup>

- 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт "...борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг"

- 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг "... байгалийн байдлаараа..."

- 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно"

- 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг "Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно"

112 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 30-д нийтлэгдсэн

- 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт “уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах”

2. Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Иргэний хууль<sup>113</sup>

- 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэг “Хууль...”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”

- Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн”

- Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

- Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Х., Ц., Б. нарын мэдээллийн агуулга:

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно”, 5.5 дахь хэсэгт “Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэж томъёолсон нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтын агуулгад харшилж байна.

Нэгдүгээрт, тус хуулийн 5.4-т заасан “50 хүртэл хувьтай байж болох”, 5.5-д “34 хүртэлх хувьтай тэнцэх” гэж хязгаар тогтоосон нь ард түмний мэдэл төрийн хамгаалалтад байх ёстой нийтийн өмчийг төрөөс захиран зарцуулах эрхийг хязгаарласан, уг эрхэд халдсан хэрэг гэж үзэж байна.

Хоёрдугаарт, энэ хоёр заалтын аль нь ч төр өмчөө захиран зарцуулах бүү хэл, стратегийн ач холбогдол бүхий орд газраас ашиг хүртэхгүй байхаар эрх зүйн үндэс хуульчлагдсан байна. Энэ нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн агуулга, үзэл санаанд ноцтой харшилсан байна.

Гуравдугаарт, 5.5 дахь хэсгийн агуулгыг үзвэл төр өмчөө бусдаас худалдан авах үр дагаварт хүргэж байна.

Дөрөвдүгээрт, 5.5-д ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч гэсэн томъёоллыг “орд эзэмшигч” болгон засварласнаар утгын өөрчлөлт

113 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 оны № 5-д нийтлэгдсэн

болгож хувийн хөрөнгө оруулагч этгээдэд давуу эрх олгох /ялангуяа гадаадын/, төөрөгдөлд оруулах эрх зүйн үндэс болсоор байна. Товчоор хэлбэл орд эзэмшигч, тусгай зөвшөөрөл эзэмшигч гэсэн хоёр томъёоллын агуулга нь ижил биш бөгөөд хууль зүйн өөр үр дагавартай ойлголт гэж үзэж байна.

## 2. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "... байгалийн байдлаараа...", 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад "уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах", Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт "Хууль..." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ... төрийн өмч мөн", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заасантай нийцэхгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт бүхэлдээ төрийн өмчлөх эрхийг зөрчжээ. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт байгалийн байдлаараа байгаа ашигт малтмал төрийн өмч байна хэмээн өмчлөгчийнх нь хүсэл зоригоос гадуур, эд юмсын шинж байдлаас хамааран өмчлөх эрхийг явцуу хүрээнд заасан нь өмчлөгчийн /төрийн/ өмчлөх эрхэд ноцтой халдсан зохицуулалт болжээ. Өөрөөр хэлбэл байгалийн бус байдалтай болсон тохиолдолд өмчлөгч, өмчөө өмчлөх эрхгүй болсон байна.

Хуулиар нийтийн ба хувийн гэсэн өмчийн төрлөөс үл хамаараад өмчлөгчийн өмчлөх эрхийг хамгаалах ёстой байтал Ашигт малтмалын тухай хуулийн 5.1 дэх хэсгийн "...байгалийн байдлаараа.." гэсэн заалт, төрийн өмчийг ашиглах эрх авсан этгээдэд ашиглалтаас үүдсэн бүтээгдэхүүнийг дангаар өмчлөх эрх олгож анхны өмчлөгчийн өмчлөх эрхийг хассан, уг хуулийн 27.1.4 дэх заалтад "уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах" гэсэн заалтууд нь төрийн өмчлөх эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ... төрийн өмч мөн", аливаа өмчлөгчийн өмчлөх эрхийг хуулиар хамгаалах тухай Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэсэн заалт, түүнчлэн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино" гэж заасантай нийцэхгүй байна.

Өмчлөх эрхээ өмч дагах тул өмчлөх эрхээ даган шинээр бий болсон эд хөрөнгө өмчлөгчийн өмчлөлд хэвээр хадгалагдана. Харин ийм хэлбэрийн ашиглах эрхээ өмчлөгч бусдад шилжүүлбэл түүний өмчлөх эрх ноцтойгоор зөрчигдөх магадлалтай. Учир нь ашиглалтаас үүссэн бүтээгдэхүүнийг ашиглах эрх шилжүүлж авсан этгээд хүртэхээр тэмүүлэх нь зүйн хэрэг боловч нөгөө талаас хуучин өмч үгүй болсон ч түүнийг өмчилж байсан этгээд өмчлөх эрхээ шилжүүлээгүй тул түүнд шинээр бий болсон бүтээгдэхүүнийг өмчлөх эрх үлдсэн гэдэг нь ойлгомжтой. Иймээс хэрэглэх хэлбэрээр хэрэгждэг ашиглах эрхээ шилжүүлсэн, уг эрхийг шилжүүлж авсан талууд ашиглалтын улмаас бий болсон бүтээгдэхүүнийг хэн нь өмчлөх тухайгаа гэрээгээр тодорхойлоогүй, түүнчлэн бусад хуульд өөрөөр заагаагүй бол уг асуудал Иргэний хуулийн 120.1 дэх хэсэгт зааснаар зохицуулагдахаар байна. Уг заалт нь анхны өмчлөгчийн эрхийг хамгаалсан хамгаалалт юм. Харин уг хэсэгт "Хууль.." гэж заасны дагуу Иргэний хуулиас бусад хуульд бусдын хөрөнгийг боловсруулах замаар ашигласнаас үүдэн гарах бүтээгдэхүүнийг талуудын аль нэг нь дангаар өмчлөх тухай заасан бол тэрхүү хууль үйлчилж аль нэгнийх нь өмчлөх эрх хасагдах болж байна. Цаашлаад "хууль"-д өөрөөр заасан тул өмчлөх эрхээ зөрчигдсэн гэж үзэж буй тал нь Иргэний хуулийн 120.2

дахь хэсэгт заасны дагуу эрхээ хамгаалуулах боломжгүй болсон байна. Тухайлбал: Ашигт малтмалын тухай хуульд зааснаар бусдаас өмчийг нь ашиглах эрхийг шилжүүлж авсан этгээд ашиглалтаас үүдсэн бүтээгдэхүүнийг дангаар өмчлөх эрхтэй байгаа тул тухайн харилцаанд Иргэний хуулийн 120.1, 120.2 дахь хэсэг үйлчлэхгүй болж улмаар анхны өмчлөгчийн /төрийн/ өмчлөх эрх хасагдаж, уул эрхээ хамгаалах, хамгаалуулах боломжгүй болсон байна.

Нийтийн өмчийн өмчлөгчийн өмчлөх эрхийг зөрчсөн маргаан бүхий хуулийн заалтууд Үндсэн хуультай нийцэж буй эсэхийг тогтоож, хүчингүй болгож өгнө үү.

3. Иргэн А.-гаас ирүүлсэн нэмэгдүүлсэн шаардлагын агуулга:

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад “ашигт малтмал ашиглах” гэдгийг “газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа” гэж томьёолсон байх бөгөөд эд хөрөнгийн ашиглах эрхэд захиран зарцуулах эрх хамаардаггүй талаар үндсэн мэдээлэлдээ дурдсан билээ. Нэгэнт ашиглах гэсэн эд хөрөнгийн эрхэд захиран зарцуулах эрхийг ийнхүү хамааруулан заасан тул ашигт малтмал ашиглах эрхийг өмчлөгчөөс шилжүүлж авсан этгээд олборлосон болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ захиран зарцуулах эрхтэй байх нь ойлгомжтой.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7 дахь заалтад “...борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг” гэж заасан нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцэхгүй байгаа тул Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шалгуулахаар шаардлагын зүйлээ нэмэгдүүлж байна.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч М., О. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэж заасан.

Үндсэн хуулийн цэцэд гаргасан Ашигт малтмалын тухай хуулийн 5.4-т заасан “50 хүртэл хувь байж болох”, 5.5-д заасан “34 хүртэлх хувьтай тэнцэх” гэж хязгаар тогтоосон нь ард түмний мэдэл төрийн хамгаалалтад байх ёстой нийтийн өмчийг төрөөс захиран зарцуулах эрхийг хязгаарласан, уг эрхэд халдсан хэрэг гэж үзэж байна” гэсэн байна. Гэтэл уг хувь, хэмжээ нь газрын хэвлий, ой, ус, ан амьтан зэрэг баялгийг төр өмчлөх эрхийг хөндөөгүй, харин ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн энгийн хувьцааны тодорхой хэсгийг өмчлөх эрхийг төрд олгосон юм.

Стратегийн орд газар дээр уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн энгийн хувьцааг төр эзэмшсэнээрээ газрын хэвлийг өмчлөх эрхээ алдах бус харин энэ хувьцаанд тэнцэх ногдол ашиг авах, төр нийтийн зориулалттай өмчөө бүрэн эрхийн хүрээнд захиран зарцуулж, уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, нэмэгдэл ашиг олох боломжтой болж байна. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгүүд Үндсэн хуулиар олгогдсон газрын хэвлий, түүний баялгийг төр өмчлөх эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй юм.

2/ Иргэн А. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд хэрэглэсэн “ашиглах” хэмээх ойлголтыг иргэний эрх зүйн үүднээс тайлбарласан нь буруу байна.

Тухайн хөрөнгийн ашигт чанараар дамжуулан үр шимийг нь хүртэх зорилгоор хэрэглэхийг ашиглах хэмээн иргэний эрх зүйд тайлбарладаг хэдий ч Ашигт малтмалын



тухай хуульд энэ томьёоллыг хэрэглэхдээ уул уурхайн эрх зүйн онцлогоос шалтгаалж цэвэр иргэний эрх зүйн ойлголтоос илүү өргөн хүрээнд авч үзсэн байна. Ийм ч учраас ашиглах эрхийн ойлголтыг тусдаа нэр томьёоны тайлбараар тодорхойлох хууль зүйн техникийг Ашигт малтмалын тухай хуульд хэрэглэж, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт “ашигт малтмал ашиглах” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг” гэж заасан билээ.

Төрийн ашигт малтмалын өмчлөх эрх бусдад шилжих үе, ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрөл олгох үе нь цаг хугацааны хувьд зөрүүтэй гэдгийг анхаарах нь зүйтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” хэмээн заасны дагуу өөрийн орны онцлогт нийцүүлж, ашигт малтмалын нөөц баялгаараа дамжуулан хөгжих шаардлагыг харгалзан Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан газрын хэвлий болон түүний баялгийг эргэлтэд оруулах зүй ёсны шаардлага байгаа бөгөөд ашигт малтмалыг “үүрд мөнх” төрийн өмч байхаар Үндсэн хуульд заасан мэтээр явцуу ойлгож тайлбарлах нь буруу юм.

Иргэн А.-гийнхаар Үндсэн хуулийн заалтыг тайлбарлавал Монгол Улсын төр ашигт малтмалаа хэзээ ч хэрэглэх боломжгүй болж тухайн ашигт малтмал байгалийн байдлаараа, олборлож боловсруулсан хэв шинжтэй байхдаа, түүнчлэн борлуулалтын зүйл, эцсийн бүтээгдэхүүн болсон үедээ ч төрөөс өөр хэн ч түүнийг өмчлөх боломжгүй, төр энэ бүтээгдэхүүнийг хэнд ч хэзээ ч борлуулж болохгүй болох байдал үүсэж байна. Ашигт малтмал газрын хэвлийд байж газартай салшгүй хэлбэрээр орших тухайн үед төрийн өмч байна гэдгийг бид Үндсэн хуульдаа заасан, энэ өмчлөх эрхийг Ашигт малтмалын тухай хуулийн аль ч зүйл, заалт зөрчөөгүй. Харин Үндсэн хуулийн болон иргэний эрх зүйн үүднээс газраас салган олборлож, боловсруулан борлуулалтын зүйл болсон тухайн шатнаас эхлэн ашигт малтмалын өмчлөх эрх төрөөс ашигт малтмалын олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжиж байгаа юм.

Иргэний эрх зүйд эд юмсыг хэрэглэгдэх ба үл хэрэглэгдэх хэмээн ангилдаг онолын тогтсон ойлголт байдаг. Тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласнаар дахин тухайн зориулалтаараа хэрэглэгдэх боломжгүй болдог зүйлийг хэрэглэгдэх эд юмс гэж тайлбарладаг бөгөөд ийм эд юмс эд хөрөнгийг эзэмших, ашиглах гэрээний зүйл болох боломжгүй байдаг. Газрын хэвлийн баялаг болох ус, нүүрс зэрэг олон төрлийн нөөцийг ашигт малтмалын нэгэн адил зориулалтын дагуу ахуйн болон үйлдвэрлэлийн зорилгоор хэрэглэгдэх төр өмчлөх эрхээ шилжүүлэхээс өөр аргагүй. Иймд Ашигт малтмалын тухай хуульд төр ашигт малтмалыг борлуулах эрх олгож өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдөхгүй. Уул уурхайн үйл ажиллагаа явуулах эрх авснаар шууд өмчлөх эрх шилжихгүй тул ашигт малтмалын өмчлөх эрх шилжих мөчийг бид тогтоох шаардлагатай. Хөдлөх хөрөнгө олж авч буй этгээдийн эзэмшилд шилжсэнээр болон гэрээнд тусгайлан заасан бол үнийг төлснөөр түүнчлэн дахин боловсруулагдаж, засан сайжруулснаар өмчлөх эрх шилжих зохицуулалт иргэний эрх зүйд түгээмэл байдгийн зэрэгцээ өмчлөх эрх олж авч буй этгээд уг хөрөнгийг бусад хөрөнгөнөөс тусгаарласнаар өмчлөх эрхийг өөртөө шилжүүлэх онолын ойлголт байдаг. Энэ тухай манай томоохон иргэний эрх зүйчид өөрсдийн бүтээлдээ дурдсан нь бий. Энэ онолын үүднээс авч үзвэл ашигт малтмал борлуулалтын шаардлага хангасан тухайн үеэс эхлэн төрийн өмчлөлөөс гарч борлуулах эрх бүхий этгээдийн өмчлөлийн зүйл болно.

Олборлон боловсруулагдаж, байгалийн байдлаа алдаж борлуулалтын бүтээгдэхүүн болсон ашигт малтмалыг төр биш тусгай зөвшөөрөлтэйгөөр олборлолт явуулж байгаа этгээд өмчилдөг. Үүнийг Үндсэн хуулиар хязгаарлаагүй бөгөөд хязгаарлах ч боломжгүй юм. Тухайлбал, Ан агнуурын тухай хуулийн дагуу иргэн, аж

ахуйн нэгж зохих байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлтэйгөөр, хуульд заасан төлбөр, хураамжийг төлсөн бол ан амьтан болон түүний гаралтай түүхий эдийг худалдах, ахуйн болон үйлдвэрлэлийн, түүнчлэн тусгай зориулалтаар хэрэглэх замаар захиран зарцуулах бүрэн эрхтэй байдаг бол Усны тухай хуулийн дагуу мөн л эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авч төлбөр, хураамж төлсөн бол ус хэрэглэгч этгээд түүнийг өөрөө хэрэглэхээс гадна хариу төлбөртэй буюу төлбөргүйгээр захиран зарцуулах бүрэн эрхтэй.

Ашигт малтмалын өмчлөх эрхийн эрхийг ихэнх улс орон тухайн улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдалтай холбон авч үзэж газар, түүний хэвлийд байгалийн байдлаараа байгаа нөөц баялаг төр, нийт ард түмний өмч хэмээн хуульчилсан байх хэдий ч ашигт малтмалын өмчлөх эрхийг төрөөс өөр этгээдэд шилжихийг хүлээн зөвшөөрч, харин ийнхүү шилжихдээ ямар арга замаар хэрхэн шилжихийг өөр өөрийн онцлогт тохируулан ялгамжтай зохицуулсан байна.

Газар, ашигт малтмал, ан амьтан, ус, ой мод зэрэг байгалийн нөөц нь улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдалтай салшгүй холбоотой учир хууль тогтоогч нь энэ асуудалд илүүтэй анхаарал хандуулан, иргэний гүйлгээнд оролцох нөхцөл байдлыг нь тусгай хуулиар нарийвчлан зохицуулж нийтийн эрх зүйн хэм хэмжээг түлхүү хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй бүрэн нийцэж байна.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлээр төрийн өмчлөлийн үндсэн объектын төрийн байгуулал, эдийн засгийн харилцаа, хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмын хүрээнд томьёолсон бол бусад органик хуулиуд тухайн ойлголтыг салбар эрх зүй хийгээд мэргэшлийн талаас нь Үндсэн хуулиар тогтоосон зарчмын хүрээнд нарийвчлан тодорхойлдог. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “ашигт малтмал” гэдгийг нарийвчлан тодорхойлж, Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн уг ашигт малтмалыг иргэний гүйлгээнд оруулах боломжийг өмчлөгчид олгосон заалт юм. Энэ заалтаар төр Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн эдийн засгийн хэвшлийг сонгох боломж бүрдэж байна.

Монгол Улсын газрын гадаргуу, түүний хэвлийд байгалийн байдлаараа оршихдоо төрийн өмч байж, олборлолтын дараа боловсруулагдан борлуулалтын шаардлага хангасан бүтээгдэхүүн болсон үеэсээ эхлэн төрийн өмчлөлөөс гарч олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд өмчлөх эрх шилжих нь ашигт малтмалын харилцаан дахь зүй ёсны үзэгдэл юм. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцсэн байна.

4/ Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт “Хууль...” хэмээн заасан нь мэдээлэл гаргагчийн тайлбарласанчлан төрийн өмчлөх эрхийг зөрчиж буй хэрэг бус харин эсрэгээрээ төрийн өмчлөх эрхийг хамгаалж, ашигт малтмалын харилцаанд борлуулалтын шаардлага хангасан шинэ өмчлөлийн зүйл бий болох хүртэл хугацаанд төрийн өмчлөх эрх хэвээр хадгалагдах боломж олгосон зохицуулалт юм.

Төрөөс өөрийн зарим чиг үүргээ хувийн хэвшилд шилжүүлэх үндсэн аргын нэг болж улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг Концессийн аргыг бид энд жишээ болгон дурдаж болох юм. Концессийн үйл ажиллагааны үр дүнд концесс эзэмшигч төрийн өмчийг засан сайжруулж, дахин боловсруулж шинэ бүтээгдэхүүн бий болгож болохын зэрэгцээ уг засан сайжруулагдсан эд хөрөнгийг төр өөрөө бүхэлд нь өмчлөх, эсвэл концессийн эрх эзэмшигч тал шууд өмчлөх арга хэлбэрийн аль нэгийг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хуулиар тодорхой зааж өгөх нь түгээмэл үзэгдэл бөгөөд энэ нь

Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсгийн “хуульд өөрөөр заасан” гэсэн нөхцөл заасан хэм хэмжээний дагуу зохицуулалт болох юм.

Түүнчлэн улс орнуудад зарим төрлийн ашигт малтмалын өмчлөх эрхийг бусдад шилжүүлэхийг хориглосон зохицуулалт байдаг бөгөөд ийм нөхцөл байдал үүссэн үед төрөөс хууль гарган уг ашигт малтмалыг олборлож боловсруулан шинэ бүтээгдэхүүн бий болгосон хэдий ч өмчлөх эрх шилжихгүй байхаар хуульчлах боломжийг нээсэн зохицуулалт болсон гэж үзэж байна. Энэ мэтчилэн ашигт малтмал, бусад байгалийн нөөц болон нийтийн зориулалттай төрийн бусад өмчийн харилцааны тодорхой тохиолдолд өөрийн өмчлөх эрхээ хэвээр хадгалах нөхцөл байдлыг хуулиар зохицуулах боломжтой байх үүднээс Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсгийн “Хууль..” хэмээн томъёоллыг тусгасан бөгөөд энэ нь Үндсэн хуульд бүрэн нийцэж байна.

Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлд “Ашигт малтмалын тухай хуулийн 5.4-т заасан “50 хүртэл хувьтай байж болох”, 5.5-д заасан “34 хүртэлх хувьтай тэнцэх” гэж хязгаар тогтоосон нь ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байх ёстой нийтийн өмчийг төрөөс захиран зарцуулах эрхийг хязгаарласан, уг эрхэд халдсан хэрэг гэж үзэж байна” гэсэн байна. Гэтэл уг хувь, хэмжээ нь газрын хэвлий, ой, ус, ан амьтан зэрэг баялгийг төр өмчлөх эрхийг хөнддөггүй, харин ашигт малтмалыг ашиглах тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн энгийн хувьцааны тодорхой хэсгийг өмчлөх эрхийг төрд олгосон юм.

Стратегийн орд газар дээр уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн энгийн хувьцааг төр эзэмшсэнээр газрын хэвлийг өмчлөх эрхээ алдах бус харин энэ хувьцаанд тэнцэх ногдол ашиг авах, төр нийтийн зориулалттай өмчөө бүрэн эрхийн хүрээнд захиран зарцуулж, уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, нэмэгдэл ашиг олох боломжтой болж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэгт улсын төсвийн хөрөнгөөр болон улсын төсвийн оролцоогүйгээр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ордыг хамтран ашиглах төрийн оролцооны хэмжээг 50 хүртэл, 34 хүртэлх хувьтай байж болохоор тогтоосон нь Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно”, мөн зүйлийн 5.5 дахь хэсэгт “Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэж заасан нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад “... борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг”, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад “уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах” гэж заасан нь газрын хэвлийд байгаа байгалийн баялагт хамаарахгүй байна. Олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх эрх нь төрд хадгалагдаж байна. Ашигт малтмалын тухай

хуулийн дээр дурдсан заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт “Хууль..” гэж зааснаараа өмчлөгчийн эрхийг зөрчиж байна гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно”, мөн зүйлийн 5.5 дахь хэсэгт “Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэснийг зөрчөөгүй байна.

2. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт “... борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг” 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “...байгалийн байдлаараа..”, 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад “уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ...төрийн өмч мөн”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино”, түүнчлэн Иргэний хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт “Хууль..” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Ашигт малтмалын тухай хууль гадаад, дотоодын аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч, улс төрийн хүчний “урхи” оролцсон хууль байдаг. Уг нь “цэвэр” байх тусам түүний улс орны эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө нэмэгддэг.

Ашигт малтмалын тухай хуулиар “... 50 хүртэл хувьтай ..”, “... 34 хүртэлх хувьтай ..” хэмээн хязгаар тогтоож өгсөн нь төр түүнээс дээш хувь эзэмшиж болохгүй гэсэн утга санаатай, Монгол Улсын иргэнд хохиролтой байж болох зохицуулалт болсон байхыг үгүйсгэхгүй.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010.03.24 № 01

**Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Т., Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Гэр бүлийн тухай хууль<sup>114</sup>

- 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг “60-аас дээш настай, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Т.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын иргэн 60 нас хүрмэгц иргэний унаган эрхээ алдаж, эрүүл мэнд, амьдралын бололцоо нөхцөл байсан ч хүсэл зорилгоо хуулиар хязгаарлуулж удам хойчоо залгуулах эрхээ алдаж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн “нас”-аар ялгаварлан гадуурхаж болохгүй, хүн бүр эрх зүйн этгээд байна гэсэн заалт ноцтой үр дагавартайгаар зөрчигдөж байгаа юм. Жаран нас хүрсэн иргэн нь “хүн” учир эрх зүйн этгээд байх Үндсэн хуулийн дээрх заалт ч мөн л зөрчигдөж байна. Монгол ёс заншилд хадгалагдан уламжилж ирсэн зүйлүүдийн нэг нь үр хүүхэд үрчлэн авч үр удмаа залгуулах, өв хөрөнгөө өвлүүлэх, төр нийгэмдээ хүн бойжуулж үлдээх явдал билээ. Энэ нь өмнөх хууль тогтоомжид ч хадгалагдсаар ирсэн.

Одоо мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуульд иргэнийг нас зааж хүүхэд үрчлэх эрхийг нь хассанаар удам залгуулах үр мөрөөдөн, боломж хайж байгаа биеийн эрүүл мэнд, эд хөрөнгийн боломжтой иргэнийхээ эрхийг хуулиар хасч байгаа төдийгүй эцэг, эх, асрамж хүсч байгаа өнчин хүүхдийн эрхийг давхар хязгаарлаж байна. Түүнчлэн

114 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 оны № 30-д нийтлэгдсэн

амьдралын золгүй явдлаас өнчирч үлдсэн хүүхдийг элдэв дарамт чирэгдэлгүй, ариун сайхан сэтгэл санаагаар өөрийн асрамждаа авч өсгөн бойжуулахаар үрчлэн авах иргэний үндсэн эрхийг боогдуулжээ. Миний бие ийнхүү ахмад настныг иргэнийхээ эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэснийг Үндсэн хуулиар тунхагласан иргэний үндсэн эрхийг зөрчсөн хэмээн үзэж байгаа бөгөөд харин хүүхэд үрчлэхэд харшлах заалтыг хуулиар тогтоохыг буруу хэмээн үзэхгүй байгаагаа дашрамд тайлбарлая. Иймд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтаас “60-аас дээш настай...” гэсэн үгийг хасч иргэний хүүхэд үрчлэн авах эрхийг сэргээн тогтоох боломж олгохыг хүсэж байна.

## 2. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай ... хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно” гэж заасан нь хүний эрх, эрх чөлөөг үл хүндэтгэн хязгаарласан, 60-аас дээш настай хүнийг эрх хасуулсан, хязгаарлуулсан, сэтгэцийн өвчтэй, олон удаагийн ял шийтгүүлсэн, шүүхээс эрхээ хасуулж хязгаарлуулсан хүмүүсийн хэмжээнд хүргэж басамжилсан, 60-аас дээш настай хүнийг насаар нь дарамтлан ямар ч үндэсгүй эрхийг нь хассан заалт болсон гэж үзэж байна. 60 настай хүн хүүхэд үрчилж авахад ямар ч харшлах зүйл байхгүй. Харин ч өнчин өрөөсөн, амьдрал нь муу хүүхдийг үрчлэн авч, түүнийг зөв өсгөн хүмүүжүүлэх, амьдрахад нь туслах, эд хөрөнгө өвлүүлэн үлдээх сайн талтай. Түүнчлэн 60 нас хүрээд үхэхгүй шүү дээ.

Учир иймд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчиж гарсан гэж үзэж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргаж байна”

## 3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О.-гоос ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг баталж, энэхүү хуулиар хүндэтгэн үзэх шалтгаанаар эцэг, эхийн асран хамгаалалтгүй болсон хүүхдийн эрхийг хамгаалах хэд хэдэн арга, хэлбэрийг тогтоож өгсөн билээ. Үүнд:

- а/ үрчлэлт,
- б/ асран хамгаалалт,
- в/ харгалзан дэмжих,
- г/ гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх.

Монгол Улс 1990 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон билээ. Ийнхүү конвенцын дагуу үрчлэлтийн тогтолцоог хүлээн зөвшөөрдөг улс орон болохын хувьд дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийг үрчлүүлж байх үүргийг оролцогч улс хүлээж байна. Мөн Монгол Улс соёрхон баталсан “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт”-ын 4 дүгээр зүйлд “аливаа улсаас энэхүү Пактын дагуу хангах ёстой эрхийг эдлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь тэдгээр эрхийн уг чанарт нийцсэн, ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой гэдгийг энэхүү Пактад оролцогч улсууд хүлээн зөвшөөрөхөөр” тунхагласан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2-т “Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэж заасан билээ. Конвенцын болон Үндсэн хуулийн дээрх заалтуудыг баримтлан Гэр бүлийн тухай хуулиар хүүхэд үрчлэн авагчид тавигдах шаардлагыг хуульчилжээ. Дэлхийн бусад орны жишгээр ч гэсэн үрчлэн авагчид тавигдах шаардлагад санхүүгийн чадавхи, эрүүл мэндийн боломжоос гадна үрчлэн авагч ба үрчлүүлэгч хоёрын насны зохистой зөрүүг хуульчилсан байдаг юм.

Монголчуудын зан заншил, уламжлалт ёсыг хууль тогтоогч харгалзан үзэж бүтэн өнчин хүүхдийг буюу эцэг, эх нь хоёулаа, эсхүл эрх толгойлсон ганц бие эх / эцэг/ нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй болсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хууль ёсны асран хамгаалагч үгүй үлдсэн хүүхдийг төрөл, садангийн аль ч насны хүн үрчлэн авч асран хүмүүжүүлэх эрхийг хэвээр үлдээсэн болно. Үүнийг гэр бүлийн тухай хуулийн 57.3 дахь заалтаар баталгаажуулсан юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Хуулиар тогтоосон хүүхэд үрчлэн авах шалгуурыг хангасан, эрх зүйн бүрэн чадамж бүхий Монгол Улсын иргэнийг “60-аас дээш настай” гэсэн үндэслэлээр түүний хүүхэд үрчлэн авах эрхийг хассан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ** нь:

1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... нас, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...Хүн бүр эрх зүйн этгээд байна”, Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн “60-аас дээш настай...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **“Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 1 дүгээр дүгнэлтийн “Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт “60-аас дээш настай...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... нас, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолыг эс зөвшөөрч гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг хуульд огт тусгаж өгөөгүй. Өөрөөр хэлбэл өргөдөл, мэдээлэл гаргагчийн гомдол гаргах эрх байнга хадгалагдаж байдаг гэсэн үг. Иргэн Т. нь 2006 оны 6 сард гарсан гишүүний маргаан үүсгэхээс татгалзсан тогтоолд 2010 оны 1 дүгээр сард гомдол гаргасан байна.

2. Гадаад орны практикийг үзэхэд ихэнх орон хүүхэд үрчилж авч болох насны доод хязгаарыг заасан байдаг. Жишээ нь: Австри улсад үрчлэгч эрэгтэй нь 30 нас, эмэгтэй нь 28 нас; Герман улсад үрчлэгч эрэгтэй нь 25 нас, эмэгтэй нь 21 нас; Дани улсад үрчлэгч нь 25 нас, Финланд улсад үрчлэгч нь 25 нас, Франц улсад үрчлэгчийн хэн нэг нь 50 нас хүрсэн байх шаардлагатай байдаг. Зарим оронд үрчлэгч үрчлүүлэгч хоёрын байж болох хоорондын насны зөрүүг хуульчилсан байдаг. Жишээ нь: Австрали улсад үрчлэгч нь үрчлүүлэгчээс хамгийн багадаа 18 насаар ахмад байх ёстой; Орос улсад үрчлэгч болон үрчлүүлэгчийн хоорондын насны зөрүү нь 16 наснаас багагүй байна хэмээн тогтоосон байдаг. Мөн олон улсын “хүүхдийн эрхийн конвенци”-ийн хүүхэд үрчлүүлэх харилцааг зохицуулсан 21 дүгээр зүйлд насны ямар нэгэн хязгаар зааж өгөөгүй байна.

Хэдийгээр хүүхэд үрчилж авч болох насны дээд хязгаарыг ихэнх орон зааж өгөөгүй боловч хэрэв үрчлэгч нь 40-өөс дээш настай бол түүнд хууль тогтоомжоор бусдаас илүү шаардлага тогтоох хандлага байдаг бөгөөд 40-өөс дээш насныханд хүүхэд үрчилж авах боломж бага байх явдал практик ажиглагддаг байна.

Угтаа 60-аас дээш насны хүнд хүүхэд үрчлүүлж болохгүй гэдэг нь хүнийг насаар нь ялгаварлан гадуурхаж буй хэрэг биш юм. Тухайн орны онцлог, заншил зэргээс хамаарч хүүхэд үрчлэх, үрчлүүлэх харилцаанд насны доод болон дээд хязгаарыг хууль тогтоогч ямраар ч тогтоож өгч болно. Энд хамгийн гол нь анхаарах зүйл бол үрчлэгдэж буй хүүхдийн эрх ашиг л нэн тэргүүнд тавигдах шаардлагатай.

Манай улсын хувьд хүүхэд үрчлэгдэхээс өмнө хяналт сайн боловч үрчлэгдсэний дараах хяналт сул юм шиг санагддаг. Өөрөөр хэлбэл нэгэнт үрчлэгдсэн тохиолдолд тухайн хүүхдийн хувь заяа цаашид хэрхэн өөрчлөгдөж байна гэдэг талаар анхаарал бага тавьж байна.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.04.02 № 02**

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай  
хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн  
эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э., Б.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль



- 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”
- 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно”
- 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”
- 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”
- Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”
- Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”
- Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна”
- Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана”
- Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар маргаантай асуудлаар Улсын Их Хуралд оруулсан дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний эзгүйд орлогч нь нэгдсэн болон байнгын хорооны хуралдаанд танилцуулж байх, түүнчлэн Цэцийн дүгнэлтийг танилцуулж буй этгээдээс асуулт асуух, хариулт өгөх хэм хэмжээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтжээ. Харин энэхүү хэм хэмжээ нь “шүүх” үндсэн чиг үүрэг бүхий Үндсэн хууль зөрчсөн маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллагаас Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлөхүйц зохицуулалт болсон байна. Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд тухайн маргааныг Цэц эцэслэн шийдвэрлэх тул Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс өөрийн үзэл бодлоо Үндсэн хуулийн цэцэд тулгах, улмаар хэнээс ч үл хараат байх Цэцийн гишүүдийн итгэл үнэмшилд нөлөөлөхийг оролдож болзошгүй нь Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн хэнээс ч хараат бус байх зарчимтай нийцэхгүй байна.

Цэцийн дүгнэлттэй холбоотойгоор дүгнэлт танилцуулж буй этгээдээс гишүүд асуулт асуух нь нөгөө талд хариулах үүргийг бий болгож байгаа бөгөөд энэ нь Цэц шийдвэрээ төрийн эрх барих дээд байгууллагын өмнө хамгаалах агуулгатай болсон байх тул Үндсэн хуулийн хэрэгжилтийг чандлан сахиулах баталгаа болсон Үндсэн хуулийн цэцийн онцгой статусыг зөрчсөн гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэц нь есөн гишүүнээс бүрдэж, хэн нэг гишүүн нь илүү эрх эдлэхгүйгээр шийдвэрээ олонхийн саналаар гаргадаг хамтын удирдлагатай байгууллага тул үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбоотой асуудал буюу Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаантай асуудлаар уул байгууллагыг нэг гишүүн нь тэр дундаа дарга эсвэл орлогч нь төлөөлөхгүй. Тиймээс Цэцийн шийдвэрийг Цэцийн дарга эсвэл орлогч нь дангаар Цэцийг төлөөлөн тайлбарлах, хамгаалах боломжгүй юм.

2. Иргэн А.-гаас ирүүлсэн нэмэгдүүлсэн шаардлагын агуулга:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Цэцэд гаргасан мэдээллийн шаардлагыг дараах байдлаар нэмэгдүүлж байна:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт мэдээлэлд дурдсан Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.

3. Иргэн Х.-гийн мэдээллийн агуулга:

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн тогтоолыг Улсын Их Хурлын Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхдээ Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, эсвэл орлогч дарга, шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч танилцуулж, Улсын Их Хурлын гишүүд асуулт тавьж, тайлбар авч байхаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ хэнээс ч хараат бус байж зөвхөн Үндсэн хуульд захирагдах, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохгүй байх зэрэг зарчмыг гажуудуулж байна гэж үзэж байна.

4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Мэдээлэл гаргагч нь мэдээллийн үндэслэлдээ Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байх, Цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, хариулт авах хэм хэмжээ нь Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн хэнээс ч хараат бус байх зарчимтай нийцэхгүй, Цэцийн гишүүний итгэл үнэмшилд нөлөөлөхийг оролдож болзошгүй, маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлөхүйц зохицуулалт болсон талаар бичсэн байна. Түүнчлэн мэдээлэл гаргагч “дүгнэлт танилцуулж буй этгээдээс асуулт асууж байгаа нь Үндсэн хуулийн цэцийн онцгой статусыг зөрчсөн” хэмээн үзжээ.

Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн хараат бус байна гэдэг нь дараах байдлаар нотлогдож байгаа билээ. Үүнд:

Нэгдүгээрт, Цэц есөн гишүүнтэй, тэдгээрт нэр дэвших хүнийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагаас тэнцүү тоогоор санал болгодог нь Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг тэнцвэржүүлж, улмаар баталгаажуулж байна.

Хоёрдугаарт, Үндсэн хуулиар Цэцийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орохыг хориглосон нь Цэцийг төрийн эрх мэдэл, улс төрийн нөлөөллөөс ангид байлгах эрх зүйн үндсийг тогтоосон.

Гуравдугаарт, Цэцийн даргыг гишүүд дотроосоо дэвшүүлэн, нууц санал хураалт явуулж, олонхийн санал авсан хүнийг сонгодог. Улсын Их Хурлаас шууд томилдоггүй.

Дөрөвдүгээрт, Цэцийн маргаан хянан шийдвэрлэсэн үйл ажиллагаатай нь холбоотойгоор хариуцлага ногдуулах, гаргасан шийдвэрийг нь хянах эрх бүхий байгууллага үгүй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналтыг Цэц хэрэгжүүлнэ.

Тавдугаарт, Цэц үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бие даасан төсөвтэй. Түүнийгээ өөрөө захиран зарцуулна.

Зургадугаарт, Цэцийн гишүүний халдашгүй байдлыг хуульчлан тогтоосон нь Цэцийн хараат бус байдлын баталгаа юм.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн өргөдөл, мэдээлэл хүлээн авах, Цэцийн хуралдаанд бэлтгэх, маргаан хянан хэлэлцэхэд нь хэн боловч дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох аливаа бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглосон заалтыг Улсын Их Хурлаас хэлбэрэлтгүй мөрдөж ирсэн. Ийнхүү Цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар тус тус хуульчлан баталгаажуулсан болно. Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болохын хувьд Улсын Их Хурал асуудлыг нь шийдвэрлэж байх тусгайлсан журам тогтоон мөрдөж байгаа билээ. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх, санал хураалт явуулах, дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах процедур журмыг хуульчилсан юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дээр дурдсан заалтууд Цэцээс маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлж болохуйц, Улсын Их Хурлын гишүүдээс үзэл бодлоо тулгасан, Цэцийн онцгой статусыг зөрчсөн гэж үзэхгүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар заасан, улмаар Улсын Их Хурал нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталдаг төлөөллийн байгууллагын хувьд тодорхой асуудал хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн сонсож, олонхийн саналаар шийдвэр гаргадаг ерөнхий зарчимтай болно. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасанчлан Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж, хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах бүрэн эрхтэй билээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан ерөнхий зохицуулалт ёсоор Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар үүний дотор Цэцийн дүгнэлтийн талаар асуулт асууж, хариулт авч байгаа явдлыг Үндсэн хууль зөрчсөн зохицуулалт гэж үзэхгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хэлбэр юм. Харин Цэцийн гишүүн маргааныг хянан шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдан дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэх билээ.

Мэдээлэл гаргагч Цэц есөн гишүүнтэй шийдвэрээ олонхийн саналаар гаргадаг хамтын удирдлагатай байгууллага тул Цэцийн дарга, эсвэл орлогч нь дангаараа Цэцийн төлөөлөн тайлбарлах, хамгаалах боломжгүй хэмээн үзжээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн ийнхүү зохицуулалтыг боловсруулахдаа Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулж байх /Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон Улсын Их Хурлын 2001 оны 61 дүгээр тогтоолын 15.1.1, 15.3.2 дахь заалт/-аар заасныг Цэцийн дарга, түүний эзгүйд орлогч нь танилцуулахаар тогтоожээ. Үндэслэл нь: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Цэцийн дарга Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцана мөн зүйлийн 6 дахь хэсэгт Үндсэн

хуулийн цэцийн орлогч даргаар Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн олон жил ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмадыг Цэцийн дарга томилж байхаар заасан зүйлтэй нийцүүлэх зорилгыг агуулсан юм.

Зөвлөлдөх тасалгаанд хамтын зарчмаар маргааныг хянан хэлэлцэж, олонхийн саналаар гаргасан шийдвэрийг Цэцийг төлөөлөн бусад байгууллага, албан тушаалтантай харилцах эрх хэмжээ бүхий субъект Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь Улсын Их Хуралд танилцуулж байгаа явдал бусад хууль тогтоомжийн заалтад нийцэж, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй зүйл юм. Харин хуулийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл гарч байгаа бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтыг өөрчлөх боломжтой юм.

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулж байдаг одоогийн зохицуулалт нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим болсон Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг зөрчөөгүй болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэж тодорхой заасан байтал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Цэцийн дүгнэлтийг “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд... танилцуулна” болгон өөрчилж, утга санааг нь гажуудуулжээ.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулах журам тогтоосон нь шүүхийн бие даасан байдал, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн хараат бус байдлын зарчмыг алдагдуулсан байна.

3. Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцсон Цэцийн аль нэгэн гишүүн Цэцийн дүгнэлтийг зөвхөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах нь Үндсэн хуульд харшлахгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, 32.1.9 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно”, 32.2.1 дэх заалтад “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна” гэсэн

нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, 32.1.9 дэх заалт, 32.2.1 дэх заалт, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”, Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц өсөн гишүүнээс бүрдэнэ. ...” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтын “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, 32.1.9 дэх заалтын “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно”, 32.2.1 дэх заалтын “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн 2010 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 2010 оны хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 22 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, 32.1.9 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно”, 32.2.1 дэх заалтад “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Байнгын хорооны

болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн шүүхийн олон улсын практикт Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг парламент хүлээн зөвшөөрөөгүй бол маргааныг дахин хэлэлцдэг журам Монголоос өөр хаана ч байдаггүй. Зөвхөн Монгол Улсад л Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь зарим тохиолдолд хоёр үе шатыг дамжиж байж эцсийнх болдог. Энэ нь монгол төрийн хууль тогтоох бодлогын онцлог, Үндсэн хуулийн цэцийн өөрийн гэсэн өвөрмөц шинж гэж хэлж болно.

Өмнө нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг нь Улсын Их Хурлын тогтоолоор зохицуулагддаг байсан. (Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг батлах тухай 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 61 дүгээр тогтоол, 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоол). 2001 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.1-т “Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн дарга, эсхүл аль нэг гишүүн Улсын Их Хуралд танилцуулна” гэж заасан байна. Харин Улсын Их Хурлын тэр үеийн даргын атгаг бодлын үүднээс хийсэн өөрчлөлтөөр 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 30.1.1-т “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна” болгон өөрчилснөөс гадна 30.1.9-т “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно” гэсэн заалтыг нэмж оруулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэж тодорхой заасан байгаа. Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан “оруулна” гэсэн утга санааг “танилцуулна” болгон өөрчилж дээрээс нь Цэцийн дарга, түүний орлогч л танилцуулна, мөн тэднээс гаргасан шийдвэртэй нь холбогдуулан асуулт асууж, “загнаж” болохоор зохицуулалтыг 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тусгажээ.

Энэ нь ямар ч эрх зүйт төрд байж боломгүй үзэгдэл бөгөөд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байх зарчимтай огт нийцэхгүй зүйл юм. Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 2 дугаар тогтоол гарсны дараагаар Үндсэн хуулийн цэцийн аль нэг гишүүн (Зүй нь бол маргааныг шалгасан гишүүн) Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр Цэцийн шийдвэрийг уншиж сонсоод явдаг практик тогтсон нь сайшаалтай. Ерөөс Цэц дүгнэлт, шийдвэрээ шуудангаар илгээхэд л болж байнаа юм шүү дээ, уг нь. Түүнийг нь Хууль зүйн байнгын хороо уншиж сонсоход л хангалттай юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2010.06.09 № 02

### Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А., Х.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Г.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Нэг. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар өмнө нь Цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Э., Б. нараас 2010 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 5/988 дугаар албан бичгээр тайлбараа хүргүүлсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэж тодорхой заасан байтал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Цэцийн дүгнэлтийг “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд... танилцуулна” болгон өөрчилж, утга санааг нь гажуудуулжээ” гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн заалтын дагуу Улсын Их Хурал үйл ажиллагааны дэгээ баталж, Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг хуульчилж өгсөн нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэсэн заалтыг өөрчилж, утга санааг нь гажуудуулсан гэж үзэж болохгүй. Үндсэн хуулийн тус заалтын органик хууль болох Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар нарийвчлан үйл ажиллагааны журмыг хуульчилж өгсөн хэрэг болно.

Иймд Монгол Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд дэгээ баталж, тухайн асуудлыг Улсын Их Хурлаар яаж хэлэлцэх эсэхээ тогтоосон дэгийн заалт нь Цэцийн хараат бус байдалд нөлөө үзүүлж байна гэсэн дүгнэлт хийх үндэслэлгүй байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар Цэцийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэх үед Үндсэн хуулийн цэцийн дарга Бя. “2006 он хүртэл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг зөвхөн нэгдсэн хуралдаанд оруулдаг. Илтгэгч гишүүн буюу урьдчилан шалгасан гишүүн оруулсан илтгэлийг сонгодог ийм л дэг журамтай явж байсан юм билээ. Энэ байдлыг 2006 оны оруулсан дэгийн хуулиар өөрчилсөн. Үүнээс болж Цэцийн хараат бус байдалд нөлөө үзүүлж байна гэж Цэц үзсэн” гэсэн тайлбар өгсөн нь үндэслэл болохгүй бөгөөд Улсын Их Хурлаар шийдвэр гаргадаг аливаа асуудлыг Байнгын хороогоор дамжуулан хэлэлцдэг нийтлэг зарчимтай нийцүүлсэн хэрэг мөн. Цэцийн 2010 оны 2 дугаар дүгнэлтэд дурдагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн холбогдох заалтууд нь Цэцээс маргааныг эцэслэн шийдвэрлэхэд нөлөөлж болохуйц, Улсын Их Хурлын гишүүдээс үзэл бодлоо тулгасан, Цэцийн онцгой статусыг зөрчсөн гэж үзэхгүй байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар заасан нь Цэцийн Үндсэн хуулийн үүрэг бөгөөд орж ирсэн асуудлыг ямар дэгээр хэлэлцэх нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал юм. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалтад заасанчлан Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж, хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах бүрэн эрхтэй билээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан ерөнхий зохицуулалт ёсоор Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар үүний дотор Цэцийн дүгнэлтийн талаар асуулт асууж, хариулт авч байгаа явдлыг Үндсэн хууль зөрчсөн зохицуулалт гэж үзэхгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хэлбэр юм. Харин Цэцийн гишүүн маргааныг хянан шийдвэрлэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдан дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэдэг билээ.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд “оруулна” гэж тодорхой заасан байтал 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Цэцийн дүгнэлтийг “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд... танилцуулна” болгон өөрчилж, утга санааг нь гажуудуулжээ.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, 32.2.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт зааснаар Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга, түүний түр эзгүйд орлогч нь тус тус танилцуулж, уг төлөөллөөс гишүүд асуулт асууж, хариулт авахаар тогтоосон нь шүүхийн бие даасан байдал, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчид хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг нээж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

3. Үндсэн хуулийн цэцийн аль нэгэн гишүүн Цэцийн дүгнэлтийг зөвхөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж уншиж сонсох нь Үндсэн хуульд харшлахгүй гэж үзэх үндэслэлтэй байна. Харин Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороогоор Цэцийн төлөөллийг байлцуулахгүйгээр хэлэлцэх эрх нь Улсын Их Хуралд нээлттэй байна.

4. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, 32.2.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 2 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:



1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, 32.1.9 дэх заалтад “Цэцийн дүгнэлтийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд Цэцийн дарга, түүний орлогчоос болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно”, 32.2.1 дэх заалтад “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлтийг Цэцийн дарга, түүний түр эзгүйд орлогч нь танилцуулна”, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт “Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаан дээр шүүхийн тогтоолыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цэцийн дүгнэлтийг дарга нь тус тус танилцуулж гишүүдийн асуултад хариулна” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусадхүнээс хараат бус байна”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, ...бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” 22 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Энэ шийдвэр бол Цэцийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой түүхэн шийдвэр болсон юм.

Тухайн маргааныг шалгасан гишүүн, эсхүл цэцийн аль нэг гишүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Цэцийн шийдвэрийг зөвхөн уншиж сонсох бөгөөд Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулж, санал дүгнэлтийг нь сонсох үүрэг хүлээхгүй болсон байна. Цаашид ч өмнөх тэмдэглэлд бичсэнээр сайжруулж цэгцлэх боломж бий.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.06.30 № 03**

### **Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Л.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Банкны тухай хууль<sup>115</sup>

115 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2010 оны № 7-д нийтлэгдсэн

- Банкны тухай хуулийн холбогдох этгээд гэсэн ойлголтыг тодорхойлсон 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт
- 57 дугаар зүйлийн 57.1.2 дахь заалт “банкнийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах”
- 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг “Банканд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 57.2-т заасны дагуу Монголбанкны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк нь банкнийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана”
- 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дарааллаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно”
- 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”
- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”
- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн Л.ийн мэдээллийн агуулга:**

Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “холбогдох этгээд” гэх хуулийн нэр томьёог а, б, в, г, д, е, ё, ж гэсэн найман дэд заалтаар тодорхойлжээ. Энэ нэр томьёо маш өргөн хүрээг хамаарснаас гадна, заримдаа таамаглан тогтоох, бүр сүүлдээ Монголбанкны үзэж байгаагаар энэ нэр томьёог хэрэглэхээр тодорхойлсон байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт “холбогдох этгээд гэж дор дурдсан иргэн, хуулийн этгээдийг” 3.1.2.а - 3.1.2.ж хүртэлх хэсэгт аливаа хуулийн этгээдийн хувьцаанд хамаарах үнэт цаасыг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшиж байгаа болон уг хувьцааг гаргагч, ирээдүйд эзэмших, гаргах этгээд, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, аливаа хуулийн этгээдийн бодлого, үйл ажиллагаанд хэлцлийн үндсэн дээр шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг, хяналт тавьдаг, түүнийг хүлээн зөвшөөрсөн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, тухайн хуулийн этгээдийн төлөөлөн

удирдах зөвлөлийн болон хянан шалгах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, тэдгээр нь шууд буюу шууд бус хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд, түүний нэгдмэл сонирхолтой этгээд болон эцэст нь Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн этгээдийг холбогдох этгээд байхаар маш өргөн хүрээнд хуульчилсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчиж байна.

Банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монголбанк, төрийн бусад байгууллага банкны үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд удирдлага, шийдвэрт нь хууль бусаар нөлөөлж болохгүй” хэмээн зохицуулсан боловч Монголбанк холбогдох этгээдийг дур мэдэн тодорхойлохоор заасан нь угтаа банкны зээлийн үйл ажиллагаа, шийдвэрт Монголбанк оролцох бололцоог нээж, хуулийн заалтууд агуулгын хувьд зөрчилдөж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн зарчим алдагдаж байна.

Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй”, мөн зүйлийн 17.3 дахь хэсэгт “Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн таван хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй” хэмээн заасан байна. Холбогдох этгээд гэсэн нэр томъёог хуульд хэтэрхий өргөн агуулгаар томъёолж, үүний дээр Монголбанк хүртэл өөрийн үзэмжээр тодорхойлох эрхийг олгосны сацуу тэдгээрт банкнаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээнд хэтэрхий өргөн хүрээтэй хязгаарлалт тавьсан нь банкны бизнесийн хэвийн үйл ажиллагааг хязгаарлан хөрөнгийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 14 банк байдаг бөгөөд эдгээрээс зээл олгох хөрөнгө, чадвартай, дээр нь орон нутагт өөрийн салбартай банк цөөхөн байна. Иймд дээрх зохицуулалт нь бодит байдалд төдийлэн нийцэхгүйн дээр зарим иргэдийн банкны үйлчилгээ авах эрх хумигдаж, улмаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах” эрх үндэслэлгүйгээр хязгаарлагдаж байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дарааллаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно”, 36.11 дэх хэсэгт “Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан банкны хувьцааг Монголбанк зөвшөөрснөөс бусад этгээдэд худалдахыг хориглоно”, 36.12 дахь хэсэгт “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэснийг зөрчиж байна.

Өмчлөх эрх нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдах” боловч уг хязгаарлалтын үндэс нь мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэсэн заалт хэмээн үзэж байна. Тодруулбал, хүний өмчлөх эрхийн хязгаарлалт нь бусдын эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал болон нийгмийн зайлшгүй шаардлага байх бөгөөд ийм шаардлагад тулгуурлаагүй хязгаарлалт бүхий хууль нь өөрөө өмчлөх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн дээрх хэсэгт заасан банкны хувьцааг захиран зарцуулах, эзэмших эрхийг хязгаарласан, хориглосон заалтууд нь хүний өмчлөх эрхийг хязгаарлах үндэслэл болж чадахгүй байна.

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Банк нь... үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат... байж болно” хэмээн заасан бөгөөд Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Нээлттэй буюу хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ” хэмээн заасан байна. Тодруулбал, нээлттэй компанийн хувьцаа нь хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагдах боломжтой бөгөөд хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа хараат бусаар чөлөөтэй захиран зарцуулах, бусад этгээд түүнийг эзэмших эрхтэй байхыг нээлттэй компани гэж үздэг. Тиймээс 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11 дэх хэсэгт заасан зохицуулалтууд нь хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтын үндэс болсон хувьцаа эзэмшигчийн чөлөөтэй захиран зарцуулах эрх болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулах, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчихөөр байгаа нь мөн Компанийн тухай хуулийн зүйлтэй зөрчилдөж, хууль дээдлэх зарчим алдагдаж байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт нөлөө бүхий саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд бусад банкинд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглосон бөгөөд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “холбогдох этгээд”-ийн агуулгад хууль тогтоогч хэтэрхий өргөн хүрээтэй тайлбар өгсөн нь үнэн чанартаа огт холбоогүй этгээдийн өмчлөх эрхэд хүртэл хавтгайруулан халдах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байна.

Аливаа этгээд, ялангуяа нээлттэй компанийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан чөлөөтэй захиран зарцуулах, түүнийг эзэмших (36.3, 36.4, 36.7, 36.11), мөн зүйлийн 36.12 дахь хэсэгт заасан банкны хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээдийн өөр банкинд нөлөө бүхий хувьцаа эзэмших зэрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байгаа учир Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасан өмчлөх эрхийг хязгаарлах хууль зүйн үндэслэлгүй байна.

Тус хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Банкны эрх хүлээн авах арга хэмжээг дор дурдсанаар хэрэгжүүлнэ” гээд 57.1.2 дахь хэсэгт “банкийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах”, мөн зүйлийн 57.3 дахь хэсэгт “Банканд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 57.2-т заасны дагуу Монголбанкны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банканд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк нь банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана” хэмээн заасан нь Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэхь хэсэгт “Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана” гэсэнтэй зөрчилдөж байна. Тодруулбал, компанийг татан буулгах субъект нь хуульд зааснаар хувь нийлүүлэгчдийн

хурал, шүүх гэж заасан байхад Банкны тухай хуулийн дээрх заалт, хэсэгт "...Монголбанк нь банкныг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана" хэмээн заажээ. Энэ нь улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрчжээ.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б.-гийн тайлбарын агуулга:

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчин холбогдох этгээд гэсэн нэр томъёог хуульд хэт өргөн агуулгаар томъёолж, үүний дотор Монголбанк хүртэл өөрийн үзэмжээр тодорхойлох эрхийг олгосны сацуу тэдгээрт банкнаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээнд хэтэрхий өргөн хүрээтэй хязгаарлалт тавьсан нь банкны хэвийн үйл ажиллагааг хязгаарлан хөрөнгийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна гэж үзэж иргэн Л. Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ.

2010 оны 1 дүгээр сард баталсан Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 1974 онд Бельги, Канад, Герман, Итали, Япон, Голланд, Швед, Швейцар, Их Британи, Америк зэрэг 10 орнууд хамтран байгуулсан эдүгээ нийт 27 орны гишүүнчлэлтэй боловч тогтоосон зарчим, бусад стандартыг нь дэлхийн 100-аад орон сайн дурын үндсэн дээр нэгдэж, хэрэгжүүлэхээ албан ёсоор зарлаад байгаа олон улсын байгууллага болох Базелийн хорооноос 1997 оны 9 дүгээр сард баталж 1999, 2006, 2007 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан "Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим"-д тулгуурлан боловсруулагдсан билээ.

Эдгээр Үндсэн зарчмууд нь банкны хяналт шалгалтыг зохистой хэрэгжүүлэхэд шаардлагатай, нийтлэг хэрэглэгдэх суурь хэм хэмжээнээс бүрддэг. Үндсэн зарчмуудыг дээр дурдсанчлан дэлхийн ихэнх орнууд хэрэгжүүлэхийг зорьдог бөгөөд дотоодын болон олон улсын санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулахаас гадна хяналт шалгалтын үр дүнг сайжруулах үндэслэл болно. Тус зарчмын 11-д "Холбогдох этгээдийн эрсдэл: Холбогдох этгээдтэй холбоотой санхүүгийн үүргээс (тэнцэл дээр болон тэнцлийн гадуурхи) учирч болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор хянан шалгагч нар банкнаас холбогдох этгээдэд зээл олгоход учирч болзошгүй эрсдлийг тогтоох, түүнээс сэргийлэх, учирсан алдагдлыг холбогдох хэм хэмжээний дагуу тэнцлээс хасах талаар тавигдах шаардлагуудыг тогтоох нь зүйтэй" гэж заасан байдаг. Олон улсын туршлагаас харахад ихэнх улс орнууд холбогдох этгээдийн хүрээг Холдингийн тухай хууль зэрэг төрөлжсөн хуульдаа нарийвчлан тогтоосон байдаг бөгөөд ингэхдээ олон улсын нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартад заасан тодорхойлолтыг ашиглаж байна.

Монгол Улс нь олон улсын аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг албан ёсоор мөрдөж эхлээд тодорхой хугацаа өнгөрч байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх" шаардлага тавьдаг бол Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын стандартыг мөрдөнө" гэж заасан байдаг.

Эдгээр стандарт тус бүрт "холбогдох этгээд" гэсэн ойлголтод тодорхойлолт өгсөн бөгөөд түүнд нийцүүлэн Банкны тухай хуульд "холбогдох этгээд"-ийн хүрээг тогтоосон билээ. Уг ойлголтыг байж болох бүхий л хүрээг хамарч тодорхойлох нь эдийн засгийн хувьд хянан шалгагч, аудитуруудад системийн эрсдэл, холбогдох этгээдийн гинжин холбоо, түүнээс үүдэн гарч болзошгүй эрсдэлийг тогтоон илрүүлэх, түүнийг ойлгох нөхцөлийг бүрдүүлдэг бол хууль зүйн үүднээс эрх зүйн зохицуулалтын аливаа хийдэл гаргахгүй байх боломж олгох юм.

Банкны тухай хуулийг бүхэлд нь авч үзвэл “холбогдох этгээд”-тэй холбоотой зохицуулалт үндсэн 2 бүлэг асуудлыг хамарч байгаа. Үүнд:

1/ Банкны тухай хуулийн 17 дугаар зүйл буюу банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалттай холбоотой бүлэг харилцаа - уг зохицуулалтын хүрээнд нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээл, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнд хязгаарлалт тогтооно.

2/ Тус хуулийн 36 дугаар зүйл буюу банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдтэй хамтран нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон үед тэдгээрийн хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарлахтай холбоотой бүлэг харилцаа.

Эдгээр бүлэг зохицуулалт нь Монголбанкны нэгдсэн хяналт шалгалтын талаар тус хуульд орсон хэм хэмжээг хэрэглэх болон банкны өмчлөл хэт монополь байдалтай болж банкны салбарын өрсөлдөөнийг хязгаарлах, ингэснээр харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг хохирохоос сэргийлэх суурь үндэслэл болох бөгөөд хүчингүй болсон Банкны тухай хуульд холбогдох этгээдийн хүрээг хэт явцуу тодорхойлж, тэдгээрийг бүхэлд нь хамарсан нэгдсэн хяналт шалгалт хийхтэй холбоотой харилцааг бүрэн зохицуулаагүйгээс үүдэлтэй практик үр дагаврыг дурдах шаардлагагүй бизээ.

Хоёр. Иргэн Л. мэдээлэлдээ Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсгүүд нь банкны хувьцаа эзэмшигчийн болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулан, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалттай нийцэхгүй байна гэж үзжээ.

1/ Үндсэн зарчмын 4-т “Нөлөө бүхий хувь нийлүүлэгчдийн бүтцийн өөрчлөлт - Банкны нөлөө бүхий хувьцаа буюу хяналтын эрхийг шууд болон шууд бусаар эзэмшиж буй этгээд уг эрхийг бусдад шилжүүлэхэд хянан шалгагч байгууллага нь хяналт тавих, шилжүүлэхээс татгалзах эрхтэй байх нь зүйтэй” гэж заасан байдаг.

Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орохоор бол банк энэ талаар тухай бүр нь Монголбанкинд бичгээр мэдэгдэнэ” гэж заасан бол 36.2, 36.3, 36.4 дэх хэсгүүдэд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийн хувьд түүнээс харьцангуй хатуу журам үйлчлэхээр буюу Төв банкнаас урьдчилан зөвшөөрөл авахаар заасан нь үндэсний аюулгүй байдал, улс орны эдийн засагт банк, санхүүгийн салбарын гүйцэтгэх онцгой үүрэгтэй уялдсан, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид төдийгүй дотоодын ба олон улсын санхүүгийн тогтолцооны харилцан нягт уялдаатай байдлаас хамааран дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж буй Базелийн хорооноос баталсан дээрх зарчимд нийцсэн зохицуулалт болсон юм.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд онцлог журам үйлчлэхээр Банкны тухай хуульд заасан явдал нь тэдгээрийг бусад хувьцаа эзэмшигчдээс ялгаварлан гадуурхсан хэрэг бус бөгөөд харин Монголбанк банкны системийг хянан зохицуулагчийн хувьд зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгийн хүрээнээс хальж бусдаас татан төвлөрүүлсэн хадгаламж, хуримтлалын олон зуун тэрбумын хөрөнгөөр бизнесийн харилцаанд оролцдог хуулийн этгээдийн нөлөө бүхий томоохон эздийг хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийн үүднээс ил тод байлгах, тэдгээрийн хөдөлгөөнд хяналт тавих үндсэн зорилго бүхий зохицуулалт юм.

2/ Иргэн Л. мэдээлэлдээ Банкны тухай хуулийн дээрх зүйл, заалтууд нь Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг зөрчсөн бөгөөд ингэснээрээ Үндсэн хуулийн хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим зөрчигдөнө гэж

үзжээ. Гэвч Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон асуудлыг бусад хуулиар, нийтлэг асуудлыг энэ хуулиар тус тус зохицуулна” гэж заасан байдаг.

Банкны зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, түүнд тавигдах тусгай шаардлага нь арилжааны банкны эрхлэх үйл ажиллагааны онцлогоос хамааран нарийвчилсан хуулиар зохицуулагдана. Банк үнэт цаас гаргах, түүнийг бусдад эзэмшүүлэх, тухайн үнэт цаасны өмчлөгч өөрчлөхтэй холбоотой харилцаа нь Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан нийтлэг асуудал гэхээс илүүтэй арилжааны банкууд санхүүгийн зах зээлд хөрөнгө татах банкны эрхлэх үйл ажиллагааны нэгэн хэлбэр болсон мэргэшлийн шинжтэй харилцаа юм.

3/ Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсэг нь тус хуулийн 22 дугаар зүйлд заасан гадаадын хөрөнгө оруулалттай банкинд үйлчилнэ. Тус заалтаар гадаадын хөрөнгө оруулалтыг банкны салбарт шууд хязгаарлаагүй бөгөөд гагцхүү гадаадын хөрөнгө оруулалттай банкны хувьцааг эзэмших этгээдийн талаар холбогдох мэдээллийг шаардан гаргуулах, хянан үзэх боломжийг бүрдүүлсэн. Энэ нь дээр дурдсан Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын Үндсэн зарчим”-ын 1-т заасантай нийцэж байгаа юм. Тус зарчмын 1-т заасны дагуу банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг байнга хянан шалгах эрхийг хянан шалгах эрх бүхий байгууллагад олгосон банкны хяналт шалгалтын зохистой эрх зүйн орчинг бүрдүүлсэн байхыг шаарддаг. Аливаа улс оронд бодлогын шинжтэйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг зарим салбаруудад шууд хязгаарладаг /гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмших дээд хязгаарыг тогтоох гэх мэт/ бөгөөд энэ тухай холбогдох хууль тогтоомждоо тусгасан байдаг. Манай улсын хувьд Банкны тухай хуульд шууд хязгаарлалтын аргыг хэрэглээгүй бөгөөд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд энэ нь нэг талаас үндэсний эрх ашгийг хөндөхүйц байдалд хүргэх үр дагавартай учир уг асуудлыг Төв банк хяналтдаа байлгаж, зөвшөөрөл өгөх нь зүйтэй гэж үзсэн.

4/ Дэлхийн хэмжээнд банкны салбарын өрсөлдөөнийг дэмжих, зохистой засаглалыг бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, санхүүгийн зуучлал, зээл олголтыг зохистой хэмжээнд байлгах, түүнчлэн, банкны ашигт ажиллагаа, удирдлагын чанарыг муутгаж байдаг ашиг сонирхлын зөрчилдөөнийг бууруулах үүднээс санхүүгийн системийн хамгийн гол салбар болох банкны системийн хувь нийлүүлэгчдийн бүтцэд нэлээд нухацтай хандаж, тодорхой хязгаалалтуудыг хэрэглэдэг байна. Энэ үүднээс Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно” гэсэн заалт оруулсан билээ. Ихэнх улс орнуудад банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн нэг этгээд болон түүний холбогдох этгээдийн хамтран эзэмшиж байгаа хувь, хэмжээний дээд хязгаарыг тогтоож өгдөг. Тухайлбал, Тайландад арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээшгүй хувийг хувийн салбарын нэгж хөрөнгө оруулагч эзэмшихийг зөвшөөрдөг бол Чехэд үүнийг 20 хувиар хязгаарладаг байна. Харин Япон, Солонгос зэрэг орнуудад давхар эзэмшлийг хориглодог байна.

Бусад орнуудтай харьцуулахад хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нарт илүү уян хатан хандаж, нэг банкны томоохон хувь нийлүүлэгч байхад ямар нэг хязгаарлалт байхгүй бөгөөд харин өөр нэгэн банкны давхар эзэмшлийг хязгаарлаж байгаа билээ. Хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг нэг банкинд төвлөрүүлснээр хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтойн зэрэгцээ том банкнаас нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ. Иймд Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй, харин ч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг болон 4 дэх хэсэгт

“Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасантай бүрэн нийцсэн зохицуулалт болсон юм.

Гурав. Иргэн Л. Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.2 дахь заалт, 57.3 дахь хэсэг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана” гэсэнтэй нийцэхгүй байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчиж байна гэжээ. Банкны тухай хуулийн дээрх заалтууд нь өмнө дурдсанчлан Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн дагуу өөрөөр зохицуулагдсан хэлбэр бөгөөд энд санхүүгийн хэвийн байдалтай үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг татан буулгах тухай бус, харин банкинд тавигдах өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг 80-аас дээш хувиар хангаж чадахгүй болсон арилжааны банкинд авах онцлог төрлийн албадлагын арга хэмжээний талаар зохицуулсан байна. Арилжааны банкаас бусад бүх төрлийн ашгийн төлөө болон ашгийн бус хуулийн этгээдэд дампуурлын нэг хууль үйлчилдэг бөгөөд арилжааны банк төлбөрийн чадваргүй болох асуудал нь уг хуулийн үйлчлэлийн хүрээнд багтдаггүй. Иймд уг харилцааг нийтлэг зохицуулалтад хамаарах ерөнхий ойлголт гэж үзэх нь буруу бөгөөд Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь хэсэг нь Үндсэн хуульд нийцэж байна.

3. Иргэн Л.-ээс Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт ирүүлсэн хариу тайлбарын агуулга:

Нэг. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс ирүүлсэн тайлбарт Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлахдаа хяналт шалгалтын хувьд Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим” хэмээх зөвлөмжийг удирдлага болгосон гэх тайлбарыг өгсөн байна. Гэтэл Монгол Улс нь Базелийн хороонд албан ёсоор гишүүнээр элсээгүй тул уг хорооноос баталсан эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх үүрэг хүлээгээгүйн дээр түүнийг биелүүлээгүй гээд хууль зүйн үр дагавар бүхий аливаа хариуцлага хүлээх үндэслэлгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байдаг. Базелийн хорооны зөвлөмж нь Монгол Улсын олон улсын гэрээ биш юм. Иймд Банкны тухай хуульд тусгагдсан боловч Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, зүйл, заалтыг зөрчсөн банкны хяналт шалгалтын тогтолцоог уг зөвлөмжийн шинжтэй зарчмуудаар зөвтгөх хууль зүйн үндэслэлгүй юм. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хувьд уг гэрээнд заасан үүргээ шударгаар биелүүлэх нь зүйн хэрэг. Үндсэн хуулийн үзэл баримтлал, үндэсний онцлог, эрх ашгийг харгалзан үзэхгүйгээр Монгол Улс гишүүнээр нэгдэн ороогүй олон улсын байгууллагаас баталсан зөвлөмжийн шинжтэй (зайлшгүй дагаж мөрдөх шинжтэй биш) баримт бичигт нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг өөрчилснөөр нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар бүхий нөхцөл байдал үүсгэхээр байна.

Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим” хэмээх зөвлөмжийг хэрэгжүүлэх, баримтлах нэрийдлээр арилжааны банкны салбарт төрийн оролцоог хэт ихэсгэж, ингэснээр Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах”, мөн зүйлийн 4-т заасан “... хувийн аж ахуй эрхлэх” иргэний үндсэн эрхийг хязгаарласан байна.

Хоёр. Банкны тухай хууль нь иргэний эдийн засгийн үндсэн эрх болох өмчлөх эрхийг хязгаарласан талаар тодорхой үндэслэл бүхий тайлбар хүргүүлсэн. Үүнийг



Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт үгүйсгээгүй байх бөгөөд түүний тайлбарт "...банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдтэй хамтран нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон үед тэдгээрийн хувьцаагаа захиран зарцуулахыг хязгаарлахтай холбоотой бүлэг харилцаа" хуульд бий гэснээр тодорхой илэрсэн байна. Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг", мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох" талаар хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмших нь өмчлөх эрх (хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх)-ээ хэрэгжүүлэх нэг хэлбэр болдог. Гэтэл иргэний энэхүү үндсэн эрхийг төрийн байгууллага, албан тушаалтан шууд хязгаарлах боломжийг Банкны тухай хуулиар олгосон байна.

Тухайлбал, Банкны тухай хуулийн Банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгох гэсэн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно" гэж зааснаар иргэний эд хөрөнгө өмчлөх, аж ахуй эрхлэх эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Энэ нь энгийн үгээр "нэг хүн 2 дэлгүүр ажиллуулж болохгүй" гэсэнтэй утга агуулга, мөн чанарын хувьд ижил байгаа юм. Түүгээр ч зогсохгүй цаашид "салбарын онцлог" гэх халхавчийн доор иргэний хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарладаг буруу жишиг тогтоох, ийм хуулийн орчин бүрдүүлэх эх үндсийг тавьж байгааг ч мөн анхааран үзэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр банкинд эзэмшиж буй хувьцааны хувь, хэмжээнээс шалтгаалан нөлөө бүхий болон бусад гэсэн ангилал үүсгэн ялгаварлаж, тэгш байдлыг алдагдуулсан, улмаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл олгодог төдийгүй өөр бусад банкинд хувьцаа эзэмших эрхийг шууд хязгаарласнаар алагчлан хандаж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "тэгш байдал... хангах... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг алдагдуулсан байна. Аливаа иргэн аж ахуй эрхлэх замаар хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах үндсэн хэлбэр нь ашгийн төлөө хуулийн этгээд байгуулж түүнийхээ хувьцааг эзэмших явдал юм. Гэтэл эд хөрөнгө өмчлөх, хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарласнаар арилжааны банк нь бие даасан байдлаа хэт алдаж, Монголбанк нь арилжааны банкийг хянах биш өөрийн харьяа байгууллага шиг ажиллуулах хуулийн боломж бүрдсэн байна. Эдийн засгийг зохицуулна гэдэг нь иргэний өмчлөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлана гэсэн үг биш, тэр дундаа хувийн хэвшлийн аж ахуй эрхлэх эрхийг хааж боогдуулах, түүнийг шалтгаангүй "зөвшөөрөлжүүлэх", хязгаарлах тухай асуудал биш юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг Монгол Улсад банк үүсгэн байгуулах, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, банкны хувьцааг эзэмшихэд зөвшөөрөл олгох харилцааг тусгайлан зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг агуулсан хууль гэж үзэх үндэслэлтэй байна. Улс орны эдийн засагт банк, санхүүгийн салбарын гүйцэтгэх онцгой үүрэг, олон улсын банк, санхүүгийн тогтолцооны харилцан нягт уялдаатай байдал зэргийг харгалзан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд нийцүүлэн Монголбанкинд зөвшөөрөл олгох, хяналт тавих, албадлагын арга хэмжээ авах, эрсдлээс сэргийлэхтэй холбоотой зарим хязгаарлалт тогтоох эрх олгож хуульчилснаараа Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.4, 36.12 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг, мөн 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Банкны тухай хуулийн холбогдох этгээд гэсэн ойлголтыг тодорхойлсон 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 3-ын "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй" гэснийг, 57 дугаар зүйлийн 57.1.2-т "банкнийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах", 57.3 дахь хэсэгт "Банканд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 57.2-т заасны дагуу Монголбанкны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк нь банкнийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана" гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэснийг болон Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн дээр дурдсан холбогдох заалтыг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт "Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дарааллаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно" гэсэн заалт, 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно" гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Банк, санхүүгийн салбар нь эдийн засгийн хөдөлгөгч хүч байдаг. Монгол Улсын хувьд банк, санхүүгийн салбарын хяналт сул байж таарахгүй. Учир нь аливаа жижиг улсын Банк, санхүүгийн зах зээлийг эзэлснээр тухайн орны эдийн засгийг хялбархан гартаа оруулна гэсэн үг. Иймд 2010 оны банкны тухай хуульд оруулсан хяналт, шалгалт, хязгаарлалт, хоригтой холбоотой дээрх заалт нь цаг үеэ олсон зөв зохицуулалт болсон байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг хянан шийдвэрлэхдээ зарим зүйлийг орхигдуулсан гэж би дүгнэдэг юм. Учир нь өргөдөл гаргагч Үндсэн хуулийн цэцэд хандаж Банкны тухай хуулийн 3.2.1 дэх заалт Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн өргөдөл гаргасан боловч өргөдлийг анхааралтай унших юм бол Банкны тухай хуулийн 3.2.1.ж заалт Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн утга санааг харж болно. Өөрөөр хэлбэл өргөдөл гаргагч зөв асуудал гаргаж ирсэн боловч өргөдлийн шаардлагаа тайлбарлахдаа учир дутагдалтай хандсан, Үндсэн хуулийн буруу зүйл заалтыг барьсан тул Цэцийн шийдвэр "зөрчөөгүй байна" хэмээн гарсан байна. Үндсэн хуулийн цэцэд хандаж буй иргэд бүгд хуульч мэргэжилтэй биш, тийм байхыг ч шаарддаггүй. Тийм учраас асуудлыг зөв олж харсан боловч үндэслэлээ тааруу гаргаснаас болж Үндсэн хуулийг зөрчиж буй уг хуулийн заалт "хүчинтэй" үлдэж болохгүй юм.

Хууль тогтоогч Банкны тухай хуулийг батлан гаргаж 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтад “холбогдох этгээд” гэдэгт хэн хэнийг багтаах вэ гэдгийг жагсааж өгсөн байна. Жагсаалтын эцэст буюу 3.1.2.ж заалтад “Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд” хэмээн томъёолжээ. Өөрөөр хэлбэл Монголбанк л холбогдох этгээд гэж үзсэн бол хэн ч байсан холбогдох этгээд болж дээрх жагсаалт хэд хүртэл ч үргэлжилж болохоор нөхцөл байдал үүссэн байна. Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байдаг. Гэтэл зарим талаараа Банкны тухай хуулийн 3.2.1 дахь заалтад “нэмэлт” хийх эрхтэй болсноороо Монголбанк хууль тогтоогчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдаж байгааг Үндсэн хуулийн цэц харах ёстой байсан болов уу.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.07.07 № 04**

### **Засгийн газрын 2009 оны 86 дугаар тогтоолын заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд А.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоол

- 2 дахь заалт “Эрдэс баялаг, эрчим хүчний сайд 3.-д даалгах нь:

а) улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан 2 дугаар хавсралтад заасан талбайн геологийн судалгааны дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий газарт Ашигт малтмалын тухай хуулийн 19.12-т заасны дагуу сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулж, явцад нь байнгын хяналт тавьж ажилласугай

б) тусгай хамгаалалттай газар нутагт зураглалын ажил, геологийн судалгаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж ажилласугай”

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”

- Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”

- Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэг “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”

- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”

- Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна”
- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна”
- Далдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:**

Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 86 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан 25 талбайд тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн заалтыг үндэслэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгохыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд 3-д даалгаж шийдвэрлэсэн байна.

Гэтэл сонгон шалгаруулалтын журмаар олгохоор шийдвэрлэсэн эдгээр талбай улсын тусгай хамгаалалттай газарт багтаж байгаа бөгөөд Засгийн газрын 86 дугаар тогтоолоор нөөцөд авах нэрээр улсын тусгай хамгаалалттай газарт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг зөвшөөрчээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлон 9.1.3-т “улсын тусгай хамгаалалттайгаас бусад тусгай хэрэгцээний газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх”, 8 дугаар зүйлд Улсын Их Хурлын бүрэн эрхийг тодорхойлон 8.1.3-т “улсын тусгай хамгаалалттай газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах асуудлыг шийдвэрлэх” гэж маш тодорхой хуульчилсан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах талаар төрийн бодлогыг тодорхойлох” гэсэн асуудлыг Улсын Их Хурлын бүрэн эрхэд, мөн Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогыг тодорхойлох” гэдэг асуудлыг Улсын Их Хурлын бүрэн эрхэд тус тус хамааруулж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанчлан “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох” бөгөөд мөн зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар аль ч салбарын төрийн дотоод бодлогын үндсийг тодорхойлох асуудлууд нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарч хадгалагдан шийдвэрлэгдэхээр заагдсан байна. Үүнийг нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дахь заалтууд ч бүрнээ нотлож байгаа бөгөөд дээрх заалтууд нь тус хуулиудын Улсын Их Хурлын бүрэн эрх гэдэгт хамаарч байгаа асуудлуудын үндэс гэж ойлгогдохоор тодорхойлогдсон байна. Иймээс 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн “Талбайг нөөцөд авах тухай” Засгийн газрын 86 дугаар тогтоол буюу Засгийн газрын шийдвэрийг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан шийдвэр үзэж байна.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталсан Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд ашигт малтмалын асуудлаар Засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлохдоо мөн зүйлийн 9.1.3-т “улсын тусгай хамгаалалттайгаас бусад тусгай хэрэгцээний газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах

асуудлыг шийдвэрлэх” гэж тодорхой заасан атал Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтаар улсын тусгай хамгаалалттай газар нутагтай бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар давхцаж байгаа зарим талбайд сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахаар тогтоож Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэсэн нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна. Нэр бүхий зарим талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутагтай бүхэлдээ болон хэсэгчилсэн байдлаар давхцаж байгаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Г.-гийн 2010 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 1/615 дугаар албан бичиг, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд З.-гийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн а/1771 дүгээр албан бичиг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Г.-гийн 2010 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 1/2102 дугаар мэдээлэл, зураглал бүхий албан бичиг болон Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч, Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайд А.-гийн Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад хүлээн зөвшөөрснөөр нотлогдож байна.

2. Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан 2 дугаар хавсралтын “3/ Тал нуур, 4/ Их хорго, 6/ Дөшхайрхан, 10/ Ембүү-Уул, 11/ Зост-Өндөр, 17/ Улаан даваа, 19/ Баян-Уул, 23/ Нөмрөгийн гол” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3. Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан 2 дугаар хавсралтын “3/ Тал нуур, 4/ Их хорго, 6/ Дөшхайрхан, 10/ Ембүү-Уул, 11/ Зост-Өндөр, 17/ Улаан даваа, 19/ Баян-Уул, 23/ Нөмрөгийн гол” гэсэн заалтаас бусад хэсэг болон “б” заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд... төрийн бусад байгууллагын шийдвэр, ... үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан “Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан талбай” гэсэн 2 дугаар хавсралтын “3/ Тал нуур, 4/ Их хорго, 6/ Дөшхайрхан, 10/ Ембүү-Уул, 11/ Зост-Өндөр, 17/ Улаан даваа, 19/ Баян-Уул, 23/ Нөмрөгийн гол ..” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж

гаргах.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд... төрийн бусад байгууллагын шийдвэр, ...үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан 2 дугаар хавсралтын“...3/ Тал нуур, 4/ Их хорго, 6/ Дөшхайрхан, 10/ Ембүү-Уул, 11/ Зост-Өндөр, 17/ Улаан даваа, 19/ Баян-Уул, 23/ Нөмрөгийн гол” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Энэхүү тогтоолын 2-ын “а” заалтад заасан “Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан талбай” гэсэн 2 дугаар хавсралтын “... 3/ Тал нуур, 4/ Их хорго, 6/ Дөшхайрхан, 10/ Ембүү-Уул, 11/ Зост-Өндөр, 17/ Улаан даваа, 19/ Баян-Уул, 23/ Нөмрөгийн гол” гэсэн заалтын үйлчлэлийг 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Засгийн газрын “Талбайг нөөцөд авах тухай” 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан 2 дугаар хавсралтад дахь энэ дүгнэлтийн 1 дүгээр хэсэгт зааснаас бусад заалт болон “б” заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд... төрийн бусад байгууллагын шийдвэр, ...үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

5. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 49 дүгээр тогтоолын агуулга:**

“Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4, 32.1.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Талбайг нөөцөд авах тухай” Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” заалтад заасан “Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан талбай” гэсэн 2 дугаар хавсралтын “3/Тал нуур, 4/Их хорго, 6/Дөшхайрхан, 10/Ембүү-Уул, 11/Зост-Өндөр, 17/Улаан даваа, 19/Баян-Уул, 23/Нөмрөгийн гол” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн

“Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд... төрийн байгууллагын бусад шийдвэр, ... үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. “Талбайг нөөцөд авах тухай” Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2-ын “а” дэд заалтад заасан “Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан талбай” гэсэн 2 дугаар хавсралтын “3/Тал нуур, 4/Их хорго, 6/Дөшхайрхан, 10/Ембүү-Уул, 11/Зост-Өндөр, 17/Улаан даваа, 19/Баян-Уул, 23/Нөмрөгийн гол” гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд Улсын Их Хурлаас зарим бүрэн эрхээ Засгийн газарт шилжүүлж болно гэсэн утга санаа харагддаггүй, гэхдээ хориглосон утга санаа ч мөн харагддаггүй.

Онолоор бол Улсын Их Хурлаас Засгийн газарт зарим бүрэн эрхээ хуульд зааснаар шилжүүлж өгч болно (хэмжээ хязгаарыг маш тодорхой тогтоож өгөх ёстой), гэхдээ онцгой бүрэн эрхэд хамааруулсан асуудлыг бол ямар ч тохиолдолд шилжүүлж болохгүй нь ойлгомжтой.

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх нь гэдэг нь Улсын Их Хурлаас өөр хэн ч хэрэгжүүлж үл болох бүрэн эрх боловч хуулиар эрх хэмжээнд нь нийцүүлж, тогтоол, журам гаргах нрх олгох нь онолын төдийгүй практикийн чухал асуудал. Энэ нь хууль батлах эрхээ шилжүүлж байгаа хэрэг биш. Өөрт нь хуулиар тодорхой эрх олгож байгаа явдал юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.10.27 № 05**

**Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Их Хурлаас 1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль<sup>116</sup>

<sup>116</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1994 оны № 8-д нийтлэгдсэн

- 8 дугаар зүйл “Дараах нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасна:

1/ өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан;

2/ хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Нийгмийн даатгал нь иргэн /цаашид “даатгуулагч” гэх/ болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн” гэж нийгмийн даатгалын үйлчилгээг, түүний дотор ажилгүйдлийн үйлчилгээг тодорхойлсон байна. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын байгууллага нь төрийн нэгэн үүргийг иргэний өмнө хүлээж даатгалын үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс иргэнд үзүүлдэг байна. Тийм учраас төр иргэдийнхээ амьдралын баталгааг найдвартай хангах зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүрийг нийгмийн даатгалд заавал хамруулахаар хуульчилжээ / Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/ Төр нэгэнт заавал даатгуулах үүргийг иргэндээ хуулиар оногдуулсан бол түүний зүгээс иргэнд үзүүлэх даатгалын үйлчилгээ нь гарцаагүй байх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг шударга ёсны зарчим мөн. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээ цуцалсан” болон “хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан” гэх шалтгаан нь даатгуулагчийн авбал зохих ажилгүйдлийн тэтгэмжийг хасах үндэслэл болох ёсгүйн дээр “хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан” гэх шалтгаан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.3 дахь хэсэгт “Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй” гэж заасантай зөрчилдөж байна.

Хэрэв төр нь даатгалын шимтгэлийг хураан авсан хэр нь даатгалын үйлчилгээгээ ямар нэг шалтгаанаар үзүүлэхгүй байх эсвэл хасах нь Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг шударга ёсны зарчим зөрчигдөхөд хүрнэ. Мөн нийгмийн даатгалын байгууллага бол ажил олгогч биш, түүнд ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах хуулиар оногдсон эрх хэмжээ байхгүй. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг тус тус зөрчиж байна. Үүний зэрэгцээ Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэнд үндэслэн Монгол Улсын олон улсын зарим гэрээг үзвэл: Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй”, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ажилгүйдэх... шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд “Энэхүү пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэсэн байна. Энд мөн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ



шударгаар сахин биелүүлнэ” гэсэн Үндсэн хуулийн заалт болон Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 27 дугаар зүйлд “Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно” гэснийг харгалзан үзвэл Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэснийг зөрчиж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Хөдөлмөрийн тухай хуулийн бүх заалт болон үүний дотор хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн бүх хэлбэрүүдийг тогтоосон 131 дүгээр зүйл нь ажил олгогч буюу түүнийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтан болон ажилтан хоёрын харилцааг зохицуулж байгаа юм. “Сахилгын нэг зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулж болохгүй” гэсэн Хөдөлмөрийн тухай хуулийн 131.3 дахь хэсгийн заалт нь мөн хуулийн 131.1 дэх хэсэгт заасан сануулах, үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, ажлаас халах гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах хэлбэрүүдэд хамаарна. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан “хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасах” тухай заалт нь сахилгын нэг зөрчилд хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж байгаа тохиолдол гэж үзэхгүй бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.3 дахь хэсгийн заалт хамаарахгүй юм.

Түүнчлэн, Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байх нөхцөлийг хуулиар тогтоож болно” гэж заасан байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн энэхүү заалтыг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасанчлан ажилгүйдлийн тэтгэмжээс зарим хэсгийг олгохгүй байх нөхцөлийг хуульчилсан болно. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2/ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй”, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй”, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн “Энэхүү пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэснийг иш үндэс болгож, улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтыг баримтлан Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай зэрэг хуулийг батлан мөрдүүлсэн билээ.

Түүнчлэн 2001 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталсан юм. Энэ хуульд ажилгүйдлийн даатгалд хамрагчийн хүрээг өргөтгөх, иргэн бүрийг ажилгүйдлээс хамгаалах төрийн бодлого хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэ бодлогын хүрээнд ажилгүй, эсхүл ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг мэргэжил олгох, давтан сургалтад

хамруулах, хувиараа болон шинээр ажлын байр бий болгоход нь зориулан зээл олгох, улмаар ажилгүй иргэнийг авч ажиллуулсан ажил олгогчийг дэмжих зэрэг үйл ажиллагаа явуулахаар заажээ. Монгол Улс нь олон улсын хөдөлмөрийн байгууллагад 1968 онд гишүүнээр нь элссэн билээ. Тус олон улсын байгууллагын гишүүн орны хувьд манай улс тухайн байгууллагаас баталсан гэрээ, конвенц, зөвлөмжийг нь дагаж мөрдөх, дотоодын хууль тогтоомжоо тэдгээртэй нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсээр ирсэн юм.

Улсын дээд шүүхээс 2008 оны 2 дугаар 28-ны өдөр баталсан 9 дүгээр тогтоолоор Монгол Улс олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тайлбар гаргав. Тухайлбал, ийнхүү тайлбар ёсоор зөвхөн соёрхон баталсан олон улсын гэрээ дотоодын хуулиас дээгүүр хүчин чадалтай, харин Монгол Улсын хуулиар соёрхон батлаагүй олон улсын гэрээ түүнийг байгуулсан төрийн тухайн байгууллагын хууль тогтоомжийн эрхийн актуудаас дээгүүр хүчин чадалтай байхаар тус тус заажээ. Үүнээс үзэхэд Монгол Улсын хуулиар соёрхон батлаагүй ч гэсэн Үндсэн хуульд харшлаагүй, олон улсын хэм хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн стандарт, хэм хэмжээг дагаж мөрдөх боломжтой байна. Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл үгүй байна. Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхийг хангахуйц эдийн засаг, хууль зүйн болон бусад баталгааг төрөөс бүрдүүлж байгаа билээ. Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд нийгмийн даатгалын төрөл тус бүрээр /тухайлбал тэтгэврийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгалын зэрэг/ нийт 5 төрлийн мөнгөн хөрөнгийн сантай байхаар заасан юм. Нийгмийн даатгалын сангийн орлого нь даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо төлсөн, ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоосоо төлсөн шимтгэлүүд түүнчлэн улсын төсвөөс олгох хөрөнгө зэрэг эх үүсвэрээс бүрдэж байхаар хуульчилжээ. Мөн хуулиар даатгуулагч, ажил олгогчоос ажилгүйдлийн даатгалд тус бүр 0,5 хувиар шимтгэл төлөх юм.

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан мэдээгээр бол 2009 оны байдлаар 11203 ажилгүй хүнд 6.1 тэрбум төгрөг олгосон байна. Хууль зүйн баталгаа бүрдүүлсэн талаар энэ тайлбарт өмнө нь тодорхой дурдсан болно. Ийнхүү Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй болно.

3. Иргэн Б.-гийн Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт гаргасан хариу тайлбарын агуулга:

“Нэгдүгээрт: Ажилгүйдлийн тэтгэмжийг хасах, эсвэл олгохгүй байх нь төр иргэнийхээ шударга хөдөлмөрийг “луйвардаж”, эсвэл иргэнээ боолчилж буй хэрэг болно. Иймд төрийн үйл ажиллагаа нь зайлшгүй шударга байх /Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2/ ёстой болж байна. Учир нь Монгол Улсын иргэн хууль зүйн эх сурвалж болох Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд томъёологдон, батлагдсан хүний үндсэн эрхийн нэг “ажилгүйдлээс хамгаалуулах эрх”-ээ эдлэхээр өөртөө тусалж хуримтлал бий болоход оролцдог. Энэхүү хуримтлал бол хүний өөрийнх нь шударга хөдөлмөрийн үр шим, түүний өмч мөн.

Хоёрдугаарт: Зөвхөн хүний эрх л гэж бий. Түүнээс биш хамт олны ч юмуу, нийгмийн эрх гэж байхгүй. Тиймээс хувь хүний эрхээс өөр эрх угаас байхгүй хэрэв байх юм бол хэн ч эдэлж чадахгүйд хүрнэ. Иймд ажилгүйдлээс хамгаалуулах эрхээ эдлэх тухайд эв нэгдэл /солидарность/ яригдахгүй. Харин эрхээ эдлэхдээ бусдын эрхийг зөрчиж болохгүй тухай л яригдана.

Гуравдугаарт: Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн бөгөөд “Мэдэгтүн, сахигтун!” хэмээн төгссөн байна. Мөн Монгол Улсын олон улсын гэрээ болох Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 27 дугаар зүйлд “Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно” гэжээ. Энд мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэснийг дурдъя. Иймд Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг зөвтгөж боломгүй байна. Хэрэв дээр дурдсан хууль зүйн эх сурвалжийг үл анхаарвал Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчих болно.

Дөрөвдүгээрт: Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй.

Иймд олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1934 оны Ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 44 дүгээр Конвенцыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг баталгаажуулсан байх бөгөөд уг зүйлийн 3 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй байх нөхцөлийг хуулиар тогтоож болно” гэж заасны дагуу ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хэмжээг хасах нөхцөлийг тогтоох нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байна.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасахаар заасан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан, эсхүл хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан нөхцөлд даатгуулагчид олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжээс ажлын 36 өдөрт оногдохыг нь хасахаар заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

## **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хөдөлмөрийн харилцааны салбарын хандлагаар өрөөсгөл гарсан байхыг үгүйсгэхгүй. Нийгмийн даатгалын сангийн ажилгүйдлийн санг бүрдүүлэн ажилласан хүн ямар үндэслэлээр ажлаас халагдсанаас үл хамааран хуульд заасан нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах эрхтэй болох нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл өөрөө хүсэлт гаргаад ажлаас халагдсан хүнд олговол зохих ажилгүйдлийн тэтгэмжийг хасдаг нь /36 хоногт оногдох/ хуулийн буруу зохицуулалт бөгөөд Үндсэн хуулийн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг зөрчиж байгаа юм.

Ажилгүйдлийн тэтгэмж нь ажилгүй болсноор авдаг тэтгэмж юм. Харин хэрхэн ажилгүй болсон нь тэтгэмж авах эрхэд нөлөөлдөг нь буруу юм. Учир нь та нийгмийн даатгалын шимтгэл төлсний утга учир нь ажилгүй болсон үедээ амьжиргаандаа зарцуулах явдал юм. Ажилгүйдлийн тэтгэмж нь тухайн хүнд тодорхой хэмжээгээр дараагийн ажлаа мөнгөнд хавчигдалгүй хайж олох боломжийг олгодог ач холбогдолтой юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.11.10 № 06**

**Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дахь заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Б.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн О.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, шийдвэр түүний зүйл заалт:**

Улсын Их Хурлаас 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Гэр бүлийн тухай хууль<sup>117</sup>

- 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг “Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно:
- 40.1.1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;
- 40.1.2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр”

### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”

<sup>117</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1999 оны № 30-д нийтлэгдсэн

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг ..., нас, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”

- Арван долдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”

- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

#### **1. Иргэн Б.-гийн мэдээллийн агуулга:**

1/ Засгийн газраас тогтоосон амьжиргааны доод түвшин нь Монгол Улсын иргэний хэвийн амьжиргааг тодорхойлсон үзүүлэлт биш. Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 11 дүгээр зүйлийн 1-д “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний эрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцөлөө байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө” гэсэн байна. Хүүхдийн тэтгэлгийг тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр жишиг болгон тогтоосон болон гэр бүл цуцалсан шүүхийн шийдвэр гарахаас өмнөх хугацааны тэтгэлгийг нөхөн олгох хүсэлтийг шийдвэрлэсэн заалт Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд байхгүй байгаа нь Үндсэн хуулийн зарим заалт болон Монгол Улсын олон улсын зарим гэрээний заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Тухайн хүүхэд амьдралын чанарын ямар түвшинд амьдарч байсныг үл харгалзан хүүхдийн тэтгэлгийг түүний амьдарч байгаа бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр жишиг болгон тогтоосон нь хүүхдийн амьдралын чанарын түвшинг дордуулах нөхцөлийг хуульчлан баталгаажуулсан байна. Зүй нь хүүхдийн амьдралын чанар өмнөхөөсөө дордох биш харин наанадаж өмнөхөөсөө дордохгүй байх нөхцөлийг хуульчлан баталгаажуулж өгвөл шударга ёсонд нийцнэ.

2/ Гэрлэлт цуцлуулахаар шүүхэд хандахаас өмнөх хугацааны тэтгэлгийг нөхөн гаргуулах хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хэрхэн шийдвэрлэх заалт Гэр бүлийн тухай хуулийн дээрх зүйлд байхгүй байгаа нь хүүхдийн амьдралын чанарыг дордуулж, эрхийг нь зөрчих нэг нөхцөл болсон байна.

Дээр дурдсан нөхцөл байдлаас үзвэл Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дах заалтууд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна. Үүний зэрэгцээ хуулийн заалт нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1-д “...хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна”, 6 дугаар зүйлийн 2-т “Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасныг зөрчиж байна.

3/ Хуулийн заалтад хүүхдэд олгох тэтгэлгийг тогтоохдоо нас харгалзсан нь үндэслэл муутайн дээр уг заалт нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хууль зүйн орчин болж чадсангүй. Хүүхдийн амьжиргааны зардлыг насаар нь ялгавартай тогтоосон нь бодит байдалд нийцэхгүйн зэрэгцээ насаар нь алагчилсан хууль зүйн орчныг бий болгосон байна. Үүнээс үзвэл хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг... нас...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасныг зөрчиж байна.

4/ Хүүхдийн тэтгэлгийг тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтоон хуульчилсан нь эцэг эх хүүхдээ тэжээн тэтгэхэд санхүүгийн зувьд адил тэнцүү үүрэг хүлээх нөхцөлийг хаасан, тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс зайлсхийхэд ашигтай байдал бий болгосон эрх зүйн орчин болж хувирсан байна. Үүнээс үзвэл хуулийн заалт нь Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” гэсэн заалт зөрчигдөж байна. Үүний зэрэгцээ Хүүхдийн эрхийн тухай конвенцын 27 дугаар зүйлийн 2-т “Эцэг эх буюу хүүхдийн төлөө үүрэг хариуцлага хүлээж байгаа бусад хүн хүүхдийг хөгжүүлэхэд шаардагдах амьдралын нөхцөлийг өөрсдийн чадавхи, санхүүгийн боломжийн хэрээр хангах үндсэн үүрэг хүлээнэ”, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 16 дугаар зүйлийн d-д “гэрлэлтийн байдлаас үл хамаарч эцэг эх хүүхэдтэй холбоотой асуудлаар адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд бүх тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина” гэснийг зөрчиж байна.

Эндээс үзвэл хуулийн заалт нь дээр дурдсан Монгол Улсын олон улсын гэрээг зөрчиж улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь заалтыг мөн зөрчиж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч О.-гоос ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулан, хүүхдийн тэтгэлэг тогтоож болохоор заасан бөгөөд ийнхүү тохиролцож гэрээ байгуулаагүй бол мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан хэмжээгээр хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоодог. Өөрөөр хэлбэл Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасны дагуу тодорхой орлого байхгүй, ажилгүй тэтгэлэг төлөгчөөс гаргуулж болох тэтгэлгийн хэмжээг тогтоосон. Харин цалингаас өөр орлогогүй хариуцагчаас 40.2-т заасны дагуу тэтгэлэг гаргуулах асуудлыг зохицуулж байна.

Ингэж хүүхдийн тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцож тогтоох эрх, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг тус хуулийн 40.1 дэх хэсэгт зааснаар шүүх тогтоохоор хуульчилсан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэг, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна. Мөн Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлэх бөгөөд энэ нь Монгол Улсын иргэний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээ буюу хэвийн амьжиргааны хамгийн доод түвшинг тодорхойлдог. Түүнчлэн тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн хөлс, нөхөн олговрын хэмжээг тогтоох, төрөөс иргэдэд эд, мөнгөний туслалцаа үзүүлэхэд хүн амын амьжиргааны доод түвшинг жишиг болгон зохих хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасны дагуу Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн 40.1.1, 40.1.2 дахь заалтад хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг тогтоохдоо тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшинг жишиг болгосон нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1, 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

2/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2-т “Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэж заасан

билээ. Үндсэн хуулийн дээрх заалтыг баримтлан Монгол Улсын хүн амын сар, өдөр тутмын хэрэглээ буюу нас насны хүүхдийн хэрэглээтэй уялдуулж Гэр бүлийн тухай хуулийн 40.1.1, 40.1.2-т хүүхдэд олгох тэтгэлэгийг насны ялгавартай тогтоосон байна. Хэдийгээр насны ялгавартай тэтгэлгийн хэмжээ тогтоосон ч яаж төлөх талаархи эрх нь Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлээр ч нээлттэй, шүүхийн практик ч байгаа. Монгол Улсын Иргэний хуулийн 16-18 дугаар зүйлүүдэд иргэнийг насаар нь ангилж, ялгавартай заасан байдаг бөгөөд Иргэний хуулиа удирдлага болгоод үзсэн ч Гэр бүлийн тухай хуулийн 40.1.1, 40.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

3/ Төр хүүхдийн ашиг сонирхлыг хамгаална гэсэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасныг баримталж Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн тэтгэлэгийн асуудлыг зохицуулсан. Ажилгүй, тодорхой орлогогүй гэсэн нэрийдлээр хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийж байгаа хариуцагч олон байна. Хүүхдийн тэтгэлгийг амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр, улмаар хүүхдийн насыг нь харгалзан ялгамжтай тогтоосон явдал өөрийн учир шалтгаантай юм. Үүнд:

1973 оны Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн тэтгэлгийг шүүхээс хуульд заасан хувь, хэмжээгээр тогтоож, хариуцагчийн сар бүрийн цалин, бусад орлогоос гаргуулдаг байсан нь бодит нөхцөл байдлаас шалтгаалан шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэхгүй байсан тул 1999 онд амьжиргааны доод түвшний хэмжээгээр насны ялгавартай тогтоодог болжээ. Түүнчлэн иргэдийн дунд хэрэглээ өндөртэй, амьжиргааны баталгаажих түвшингээс дээгүүр орлоготой нэг хэсэг байдаг боловч жил бүрийн статистик тоо баримтаас харахад Монгол Улсын хүн амын гуравны нэг орчим хувь нь хэрэглээ багатай, амьжиргааны доод түвшингээс доогуур амьдарч байна. Иймээс амьжиргааны доод түвшингээс доогуур орлого, амьдралтай нөгөө хэсэг байгаа гэдгийг анхаарч, хүний хэрэгцээ үзэх нь зүйтэй болов уу. Ийм нөхцөлд хүүхдийн язгуур эрх ашгийг гэдгийг бодолцож үзэх нь зүйтэй болов уу. Ийм нөхцөлд хүүхдийн язгуур эрх ашгийг хамгаалах зорилгоор хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийж буй хариуцагчаас хамгийн багаар буюу амьжиргааны баталгаажих түвшингээр тогтоож, тэтгэлэг гаргуулж байхаар хуульчилжээ. Харин хүүхдийн насыг нь харгалзан ялгамжтайгаар тогтоосон нь оновчтой бус байж болох талтай ч энэ нь үүсээд байгаа бэрхшээлийг даван туулах нэг арга зам болно. Цаашид Гэр бүлийн тухай хуулиар зохицуулж байгаа харилцааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох байгууллагууд ажиллаж байна.

3. Иргэн Б.-гээс Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт гаргасан хариу тайлбарын агуулга:

Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасны дагуу тодорхой орлого байхгүй, ажилгүй тэтгэлэг төлөгчөөс гаргуулж болох тэтгэлгийн хэмжээг тогтоосон гэжээ. Энэхүү тайлбартай нь холбогдуулан хуулийг үзвэл:

1/ Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-ийн 40.1.1, 40.1.2 дахь хэсгийн шууд утга санаа нь итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбартай дүйхгүй байна.

2/ Хуулийг зөв хэрэглэх талаар тайлбар гаргах бүрэн эрхийг гагцхүү Монгол Улсын дээд шүүх хэрэгжүүлдэг тул дээрх тайлбарыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд хууль зүйн үндэслэл бүхий тайлбар гэж хүлээн авах боломжгүй юм. “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн заалтыг үндэс болгон Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 3 дугаар зүйлийн 1, 6 дугаар зүйлийн 2-ыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна” гэж итгэмжилсэн төлөөлөгч тайлбарласан тухайд:

Гэрлэлт цуцлуулсан эцэг, эхээс сард нэг удаа хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан тогтоосныг дээрх тайлбараар зөвтгөх боломжгүй юм. Учир нь гэрлэлт цуцлахаас өмнө тухайн хүүхэд амьдралын чанарын ямар түвшинд амьдарч байсныг харгалзан үзэхгүйгээр болон 11 нас хүрээгүй тул “хагас хүн” гэж тооцон түүнд өөрийнх нь эцэг эсвэл эхээс олгох тэтгэлгийг хүн амын амьжиргааны доод түвшингийн 50 хувиар тогтоосон нь шударга бус, хуулийн албадлагаар насаар ялгаварласан, амьдралын чанарыг нь дордуулсан явдал болж байна.

Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнд онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай болдог. Үүний учир Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” хэмээн онцлоод 11 дэх хэсэгтээ “...хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан. Иймд төр иргэнээ насаар үл ялгаварлан, адил тэгш нөхцөлөөр хамгаалалдаа авахаар иргэнийхээ өмнө үүрэг амлалт авсан. Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд хүүхдийн ... төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй, энэхүү конвенцод заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана” гэсэн байна. Иймээс итгэмжилсэн төлөөлөгчийн дээрх тайлбарыг хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлгүй байна. Учир нь аливаа хууль, хуулийн заалт хууль зүйн эх сурвалжид бүрнээ нийцсэн байх ёстой бөгөөд тэдгээрт томъёологдон, бататгагдсан хүний эрхийг зөрчих ёсгүй. Мөн Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 27 дугаар зүйлд “Оролцогч улс гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтыг баримтлан зааж үл болно гэсэн байна. Энэхүү заалтыг үл анхаарваас Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт зөрчигдөхөд хүрнэ.

Итгэмжилсэн төлөөлөгч “Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2-т “Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэж заасан билээ” гэжээ. Үндсэн хуулийг үзвэл “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно” гэсэн байна. Үүнээс үзвэл:

1/ Итгэмжилсэн төлөөлөгч Үндсэн хуулийг дур зоргоор өөрчлөн тайлбарласан байна. Ийм эрх одоогоор хэнд ч олгогдоогүй бөгөөд Үндсэн хуулийг зөвхөн мэдэж сахиx үүрэг бүх хүнд адил тэгш оноогдсон болно.

2/ Итгэмжилсэн төлөөлөгч Үндсэн хуулийг “хуульд бүрнээ нийцүүлэн” тайлбарлаж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг эсрэгээр нь ойлгон хэрэглэжээ.

Итгэмжилсэн төлөөлөгчийн дурдсан “нийтээр хүлээн зөвшөөрсөн дэлхийн жишиг”-ийн тухайд, эрх зүйд “нийтээр хүлээн зөвшөөрсөн дэлхийн жишиг”-ийг дагах бус харин “олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэх” тухай ойлголт бий. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд “нийтээр хүлээн зөвшөөрсөн дэлхийн жишиг”-т үндэслэж хийсэн тайлбарыг хүлээн зөвшөөрөх боломжгүй.

3/ Хүүхдийн эрхийн тухай конвенцын 2 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд хүүхдийн... төрсөн болон бусад байдлаар үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү конвенцод заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана” гэж тус тус заасан байна. Иргэний хуулийн 16-18-р зүйлд заасан насны байдал нь “иргэний эрх зүйн чадамжийг буюу иргэний харилцаанд орж, үйлдлийнхээ төлөө ухамсартайгаар хариуцлага хүлээх чадварт үндэслэсэн насны хязгаар болохыг онцлон тэмдэглэе.



## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн 40.1.1, 40.1.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 11, Арван долдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх бөгөөд Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Гэр бүлийн тухай хуулийн “хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан, тухайн бүс нутгийн амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтоох тухай” заасан 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 11, Арван долдугаар зүйлийн 2, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

Хүүхдэд олгох тэтгэлгийг амьжиргааны доод түвшингээр тогтоох нь хэр зөв бол? Харин тэтгэлэг нь юуны өмнө тэтгэлэг олгогчийн сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээтэй харилцан уялдаатай байх нь илүү оновчтой байж болох юм. Эд хөрөнгийн байдалтай холбох зэрэг олон шалгуур байж болохыг үгүйсгэхгүй.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2010.11.17 № 07**

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн  
50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг үндсэн хуулийн  
холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн З.

### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, шийдвэр түүний зүйл заалт:**

Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль<sup>118</sup>

118 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2006 оны № 5-д нийтлэгдсэн

- 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг "... эцэслэн .."

#### **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... эрхтэй"
- Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ"
- Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх"

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

##### **1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:**

Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргааныг сонгуулийн дунд шатны байгууллага болох тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байхаар заажээ. Өөрөөр хэлбэл санал хураалтын дүн сонгуулийн хэсгийн болон тойргийн хэмжээнд маргаантай байгаад саналын хуудас дахин тоолуулахтай холбогдон гарсан маргааныг тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байх хэм хэмжээ Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд "тогтоогджээ". Нэгэнт сонгуулийн санал хураалтын дүн буюу саналын хуудсыг дахин тоолох тухай маргааныг Сонгуулийн төв байгууллага хянан шийдвэрлэх эрх зүйн үндэслэлгүй тул тухайн асуудлаар үүссэн маргаан нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын бус. Өөрөөр хэлбэл санал тоолох ажиллагаа нь хууль бус байснаас санал хураалтын дүнгийн талаар маргаан гарч дахин санал тоолох тухай маргаан гарвал уг асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл Үндсэн хуулийн цэцэд алга байна. Харин Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоолуулахтай холбогдсон хэрэг маргааныг шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх энэхүү шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр заасан нь Монгол Улсын иргэний зүгээс улс төрийн эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж, улмаар шүүхийн "шүүх" эрх мэдлийг хязгаарласан байна. Гэвч Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоолохтой холбогдсон хэрэг маргаан шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай 50.7-д туссан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... эрхтэй", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

##### **2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч 3.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д заасан "санал хураалтын дүн" гаргах ажиллагаа нь саналын хуудас тоолох ажиллагаа бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тусгайлан эрх олгосон сонгуулийн байгууллага болох хэсгийн хороонд олгосон бөгөөд өөр ямар ч байгууллагад энэхүү эрхийг олгоогүй байна. Харин тойргийн хороо хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргадаг.

Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаарх маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй

удаашрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан. Санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн "...эцэслэн..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

### 3. Иргэн А.-гаас ирүүлсэн нэмэгдүүлсэн шаардлагын агуулга:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан байгаа нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар гаргасан мэдээллийн шаардлагыг 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг бүхэлдээ Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт зөрчсөн эсэхийг хянуулахаар, шаардлагын зүйлээ хянаж байгаа асуудлын хүрээнд нэмэгдүүлж байна. Нөгөө талаас тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага. Цэцийн гишүүний 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолд дурдсанчлан тойргийн хорооны шийдвэрт гомдогч шүүхэд гомдол мэдүүлэх боломжтой байлаа ч тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал, түүнчлэн татан буугдсаных нь дараа эрх нь зөрчигдсөн тухай мэдсэн этгээд нь тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна.

### 4. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч 3.-гээс ирүүлсэн нэмэлт тайлбарын агуулга:

Тойргийн хороо саналын хуудас тоолдоггүй бөгөөд зөвхөн тухайн тойргийн хороонд харьяалах салбар болон хэсгийн хорооны санал хураасан дүнгийн тухай шийдвэрийг үндэслэн тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг нэгтгэх үйл ажиллагаа явуулдаг сонгуулийн байгууллага юм.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 дэх хэсэгт "Тойргийн хороо нь салбар болон хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргана" гэж заасан. Тойргийн хороо тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргаж байж тухайн тойрогт хамгийн олон, гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож, түр үнэмлэх олгоно. Энэ нь тойргийн хорооны бүрэн эрх бөгөөд сонгогдох эрхийн баталгаа болж байдаг онцлогтой. Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй удаашрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, төрийн залгамж чанар алдагдах, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Өргөдөл гаргасан иргэн А.-гийн мэдээлэлд “тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна” гэжээ. Санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бөгөөд санал хураалтын дүн, түүнтэй холбоотой аливаа гомдол, маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ гэж хугацаа зааж өгч байгаа нь харин ч түр ажиллагаатай байгууллага тул тодорхой хугацааны дотор гарсан гомдол маргааныг шийдвэрлэж байх үүрэг ногдуулсан байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна. Энд “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 5 дугаар дүгнэлтийн Үндэслэл хэсэгт “Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж товлосон цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийг улс даяар нэгэн зэрэг саадгүй явуулах үндэс болдог хэмээн үздэг. Иймд сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэгэн өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна” гэж тэмдэглэснийг онцлох нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг шийдвэрлэх эрхийг тойргийн хороонд хамааруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо “эцэслэн” шийдвэрлэж байхаар заасан нь тухайн асуудлаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх сонгогч, сонгогдогчийн эрхийг зөрчихөд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “...эцэслэн...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “...эцэслэн...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... шударга шүүхээр шүүлгэх...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн “...эцэслэн...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх

ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 7 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 70 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн “...эцэслэн...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх”, мөн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс “бүх зүйлийг заавал шүүх шийдэх ёстой юм уу” хэмээн давтан хэлж байсан.

Цэцийн гишүүн хуралдааны танхимд асууж тодруулах үүрэгтэй болохоос хариулах үүрэг хүлээдэггүй. Уг нь бол бүх маргаан заавал шүүхэд очиж эцэслэн шийдвэрлэгдэж байх албагүй. Гэхдээ хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөнтэй холбоотой маргаан заавал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэж байх учиртай. Хууль тогтоогч нар сонгуулийн санал тоолохтой холбоотой маргааныг “хурдан” шийдвэрлэхийн тулд “тойргийн хороонд” маргааныг харьяалуулах бус, харин шүүх 14 хоногийн дотор шийдвэрлэж байхаар онцгой журам тогтоож болно шүү дээ. Үндсэн хуульд зааснаар Дээд шүүх анхан шатны журмаар үтэр түргэн шийдэх боломжтой.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2011.01.05 № 01**

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн  
50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн зарим заалт Үндсэн  
хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн З.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан

өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ” гэсний “... эцэслэн...” гэж заасан нь шүүхэд хандах хүний үндсэн эрхийг хязгаарласан байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “...эцэслэн...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэж хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 7 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт “Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ” гэсэн заалтын “... эцэслэн...” гэснийг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 7 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 70 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын шүүхээс өөр байгууллага, тэр дундаа байнгын үйл ажиллагаатай бус, тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулаад тардаг байгууллага болох Сонгуулийн тойргийн хороо ард түмний сонголтын талаарх асуудлыг эцэслэн шийдвэрлэх нь буруу юм. Одоогийн практикаас харахад Сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийг хянаж байх үүрэгтэй Сонгуулийн Ерөнхий хороо ч тэр, шүүх ч тэр нэгэнт тойргийн хороо тухайн маргааныг “эцэслэн” шийдвэрлэчихсэн тул бид шийдвэрлэх боломжгүй гэдэг. Өөрөөр хэлбэл шүүх эрх мэдэлд халдсан, сонгуулийн санал хураалтын дүнгийн талаарх маргаан эзэнгүйдэх асуудлыг Үндсэн хуулийн цэц таслан зогсоосон юм.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010.11.24 № 08

**Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;

Хүсэлт гаргагч - Улсын дээд шүүх, түүний итгэмжилсэн төлөөлөгч Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн З., Иргэний хэргийн танхимын тэргүүн А.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т.

**Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, шийдвэр түүний зүйл заалт:**

Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 2-ны өдөр баталсан Хуульч сонгон шалгаруулах тухай хууль<sup>119</sup>

- Арван долдугаар зүйлийн 17.1 дэх хэсэг “Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ”
- Арван долдугаар зүйлийн 17.3 дахь хэсэг “Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”
- Арван долдугаар зүйлийн 17.4 дэх хэсэг “Хуульчийн сургалтад хамрагдах журмыг Зөвлөл тогтооно”
- Арван наймдугаар зүйлийн 18.1.2 дахь заалт “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй”

### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”
- Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна”
- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”
- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”
- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “...хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ...эрхтэй”
- Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй”
- Арван зургадугаар зүйлийн 7 дахь заалт “сурч боловсрох эрхтэй”

119 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2007 оны № 33-т нийтлэгдсэн

## Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

1/ Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэж заан, хуульчийн гэрчилгээ хүчингүй болох үндэслэлийг заажээ. Хуульд ийнхүү заасны улмаас уг сургалтад хамрагдаагүй шүүгч, өмгөөлөгч, нотариатч, прокурорын ажил хийж байгаа хүмүүс уг ажлаа гүйцэтгэх боломжгүй болохын зэрэгцээ тухайн ажил, албан тушаалаас чөлөөлөгдөх эрх зүйн үндэслэл болжээ. Мөн уг хуулийн заалтыг үзэхэд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж хуульчийн гэрчилгээ авсан боловч шүүгч, өмгөөлөгч, нотариатч, прокурорын ажил, албыг хараахан эрхлээгүй, ирээдүйд эрхлэх сонирхолтой бусад хуульчид нь уг сургалтад хамрагдахгүй бол мэргэшлийн шалгалтад хамрагдах боломжгүй болсон байна.

Нэгэнт өөрийн мэдлэг чадвараа эрх бүхий этгээдээр хянуулан хуульчийн гэрчилгээ авсан хуульч зүйн дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй хүнийг түр сургалтад хамрагдаагүйн төлөө түүний “хуульчийн хүчин төгөлдөр гэрчилгээ”-г хүчингүй болгох тухай хэм хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний эрхийг зөрчсөн байна. Үүнд: Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “... хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх... эрхтэй”, 4-т “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох... эрхтэй”, 7-д “сурч боловсрох эрхтэй” гэж заасныг зөрчиж байна.

Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн маргаан бүхий уг заалт нь хуульч зүйн дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй хүнийг албадан сургах шинжийг агуулж байгаагаараа тухайн хүний сурч боловсрох эрхэд халдсан байна. Мөн тухайн сургалт нь төлбөртэй байх бөгөөд, төлбөртэй сургалтад заавал хамрагдах шинжийг агуулсан маргаан бүхий энэ хуулийн зохицуулалт нь тухайн хүний хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх иргэний эрхийг мөн зөрчжээ. Иргэний хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт “аливаа этгээд нь ... эдийн бус баялаг болох ... эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно” гэсний дагуу нотариатч, өмгөөллийн мэргэшлийн шалгалтанд тэнцэн, нотариатч, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тусгай зөвшөөрөл нь тухайн хүний хувьд хөрөнгө юм. Иймд Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заагдсан түр сургалтад хамрагдаагүйн төлөө өмгөөлөгч, нотариатч нь өмгөөлөх, нотариатын ажил эрхлэх эрхээ алдахад хүрч байгаа нь тухайн хүний Үндсэн хуулиар баталгаажсан хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхтэй нийцэхгүй байна.

2/ Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт төрийн алба хашиж байгаа хуульч хүний сургалтын зардлыг төр дааж байхаар заажээ. Шүүх, прокурорын байгууллагад ажиллаж байгаа хүний зардлыг нь төр / төсөв/, өмгөөлөгч, нотариатчийн ажил хийж байгаа хүн болон хуульчийн гэрчилгээ авсан боловч хараахан шүүгч, прокурор болоогүй байгаа иргэд нь хуульд заагдсан түр сургалтын зардлаа өөрөө даана гэсэн агуулга бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Улсын дээд шүүхийн хүсэлтийн агуулга:

Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль анх 2003 оны 5 дугаар сарын 22-нд батлагдснаар Монгол Улсад шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчаар ажиллах эрх зүйчид дэлхий нийтийн жишгийн дагуу хуульчийн сонгон шалгаруулалтад орж, тэнцсэн байх шаардлагатай болсон. Эрх зүйн аль ч тогтолцоотой улс хуульчдаа



сонгон шалгаруулах өөрийн журамтай байдаг боловч зөвхөн сонгон шалгаруулалтад тэнцсэн, улмаар хуульч цолтой болсон этгээд л цаашид шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчөөр ажиллах эрхтэй байдаг нь энэхүү шалгалтын гол агуулга болдог.

Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2007 оны 8 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж, энэ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ”, 18 дугаар зүйлийн 18.1.2-т “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” бол хуульчийн гэрчилгээг хүчингүй болгохоор заасан нь Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1., 3 дугаар зүйлийн 3.1.1., 16 дугаар зүйлийн 16.3., Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3., 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөж байгаагаас гадна Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан зарчмуудтай нийцэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно” гэж заажээ. Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар шүүгчид нэр дэвшихэд Үндсэн хуулийн дээрх болзлыг хангасан байхаас гадна ял шийтгүүлж байгаагүй, хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх шаардлагыг тавьжээ. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль батлагдснаар Дээд боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй бөгөөд уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан тодорхойлолттой нийцэхгүй хэдий ч Үндсэн хуульд заасан “хууль зүйн дээд боловсролтой” гэдэгт эрх зүйч мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн, хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн гэх хоёр болзлыг нэгтгэн ойлгож, Шүүхийн тухай хуулиар тогтоосон шаардлагыг Үндсэн хуультай зөрчилдөөгүй гэж хүлээн зөвшөөрдөг юм гэхэд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн тухайн гэрчилгээ хүчинтэй болохыг 3 жил тутам, шүүгчээр ажиллах дээд талын 35 жилд 15 удаа баталсан байх шаардлагыг Үндсэн хуульд нийцсэн гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Нөгөө талаар шүүгчээр ажиллах хүнд Үндсэн хуулиар тавигддаг шаардлагыг агуулгынх нь хэмжээнд өргөжүүлж, нэмэлт болзол тавьсан нь хуулиар тогтоосон журам ба түүнийг даган мөрдөх нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчимд харшлаагүй гэж үзэж болно. Гэтэл Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заагдаагүй нэмэлт болзол буюу хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн гэрчилгээг Хуульч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах орон тооны бус зөвлөл 3 жил тутам баталгаажуулсан байх бодит нөхцөлийг бүрдүүлж буй Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн дээрх хоёр заалт Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасантай нийцээгүй гэж үзэж байна.

Шүүгчид нэр дэвшигчид тавигддаг шаардлага шүүгчээр ажиллаж буй этгээдэд хамааралтай гэдэг нь ойлгомжтой ба шүүгчид нэр дэвшиж, томилогдох үед ял шийтгэлгүй байсан, эсхүл дээд боловсрол эзэмшсэн диплом хуурамч нь илэрвэл шүүгчийн ажлаас огцруулах нь тодорхой билээ. Тэгвэл хуульчийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд тухайн шүүгч нь шүүгчид нэр дэвшигчийн байр сууринд ч хүрэхээргүй болох тул мөн л шүүгчийн албан тушаалд үлдэх боломжгүй болно. Гэтэл шүүгчийг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тодорхойлсон Шүүхийн тухай хуулийн 58, 59 дүгээр зүйлд уг үндэслэл тусгагдаагүй учир Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасан зохицуулалт агуулгын хувьд Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэхээр байна. Үндсэн хуулийн уг заалтыг зөрчихгүйгээр шүүгчийг албан тушаалд хэвээр үлдээвэл Шүүхийн тухай хууль болон Хуульч сонгон

шалгаруулах тухай хуулийн шаардлагыг зөрчиж, хуульч биш этгээдээр шүүн таслах ажиллагааг эрхлүүлэх үндэслэл бүрдэж, улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх зарчмыг зөрчихөд хүргэнэ. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль, шүүхийн өмнө бүгд тэгш эрхтэй байх шаардлага ч зөрчигдөх болно.

Эцэст нь шүүгчийн хараат бус байдлын үндсэн баталгааны нэгд түүний халдашгүй, хугацаагүй томилгоо ордог ба шүүгчээр томилогдоход тавигддаг болзол, шүүгчээс чөлөөлөх, огцруулах үндэслэлүүд зөвхөн хуульд заасан, туйлын тодорхой байх шаардлагатайг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн, 1985 оны 12 дугаар сарын 13-ны өдрүүдийн 40/32, 40/146 дугаар тогтоолоор зөвшөөрөгдсөн “Шүүхийн байгууллагын хараат бус байдлын талаарх үндсэн зарчим”-уудад онцгойлон тусгасан байдаг. Тийм учраас эдгээр асуудлаар тодорхой бус байдал үүсэх үндэслэлийг бүрдүүлсэн хуулийн дээрх заалт Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг зөрчснөөр Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тунхагласан шүүгчийн хараат бус байдлын баталгааг хөндөнө гэж үзэж байна.

Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1., 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.

3. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

1/ Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэж заасан нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал, хэний ч нөлөөнд автахгүй байх чухал ач холбогдлыг нь харгалзан Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн байна. Мөн Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийг хуульчдаас сонгох, нэр дэвшүүлэх, бүртгэх, шалгалт авах, хэлэлцэх, томилох асуудлыг зохион байгуулах талаар тодорхой заасан ба Шүүхийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд шүүгчийг огцруулах үндэслэлийг заасан байна.

Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаагүй бол гэрчилгээ хүчингүй болохоор заасан нь шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчийн эрх олгох шалгалтад орох, шүүгч, прокурор, нотариатч, өмгөөлөгчөөр ажиллаж байгаа бүх хуульчдын мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхэд тавигдаж байгаа шаардлага болохоос бус тэр хүнийг тухайн ажил мэргэжлээс нь огцруулах үндэслэл болно гэсэн агуулгаар оруулаагүй болно. Тухайлбал: Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-д шүүгчид нэр дэвшүүлэхэд Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан байхыг шаардсан болохоос бус Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцээгүй тохиолдолд гэрчилгээ нь хүчингүй болж байгаа нь шүүгчийг огцруулах үндэслэл болно гэж заагаагүй болохыг анхаарна уу.

Улсын дээд шүүхийн хүсэлтэд “Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1., 3 дугаар зүйлийн 3.1.1., 16 дугаар зүйлийн 16.3., Шүүхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3., 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасан заалтуудтай зөрчилдөж байна” гэжээ. Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд зааснаар хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй ба энэ эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үргэлжлэн явагддаг байнгын ажиллагаатай болно. Цаашид хуулийг боловсронгуй болгох зорилгоор хууль санаачлагчаас Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнд холбогдох хуулиудын

төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан тохиолдолд хуулийг боловсронгуй болгох ажил хийгдэх бүрэн боломжтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй байна. Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасан байна. Мөн түүнчлэн Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”, Прокурорын байгууллагын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Прокурорын байгууллагын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана”, мөн зүйлийн 34.2 дахь хэсэгт “Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна” гэж заасан байна. Шүүхийн болон прокурорын төсвийг жил бүр Улсын Их Хурал баталж, улсын төвлөрсөн төсөвт тусгайлан тусгаж, Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн нь хүний эрхийг хамгаалах хараат бус, хариуцлагатай, шударга байх үндэс болно.

Иргэн А. мэдээлэлдээ: “Шүүгч, прокурор нь бага орлоготой тул түр сургалтын төлбөрийг нь төр, өмгөөлөгч, нотариатч нь их орлоготой тул сургалтын зардлаа өөрөө даана гэсэн агуулгыг илэрхийлж болзошгүй уг зохицуулалт нь Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна”, “энэ нь... шүүгч, прокурорын хувийн ур чадвараа дээшлүүлэх түр сургалтад хамаарахгүй..” гэжээ. Үүнтэй санал нийлэхгүй байна. Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчид төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг бүх шатны шүүхийн шүүгч, прокурорыг хамруулсан ба төрийн албаны мөн чанарыг ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино гэж тодорхойлоод төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх, төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах зарчмуудаар баталгаажуулсан байна. Мөн түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг тусгасан 13 дугаар зүйлд төрийн албан хаагч нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэшлээ дээшлүүлэх, төрийн хөрөнгөөр давтан сургахаар заасан байгаа нь шүүгч, прокурорын тухайн ажилдаа мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх хуульчийн давтан сургалтыг хувийн ур чадвараа дээшлүүлэх түр сургалт гэж үзэх үндэслэлгүй юм. Нотариатч, өмгөөлөгч нарын үйл ажиллагаа нь хүний эрхийг хамгаалах чиг үүрэгтэй хэдий ч төрийн нэрийн өмнөөс бус ашгийн төлөө ажил үйлчилгээ эрхлэхээр хуульчилсан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг зөрчсөн гэх үндэслэлгүй юм.

2/ Улсын дээд шүүхийн хүсэлтэд “Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна” гэжээ.

Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн агуулга нь хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн /шүүгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад орох, нотариатын болон өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэшлийн шалгалтад оролцох, прокуророор ажиллах эрх авах шалгалтад орох, мөн дээрх мэргэжлүүдээр ажиллаж байгаа бүх хүн хамаарна/-ний мэргэжил мэдлэгийг тасралтгүй сургалтаар дээшлүүлэх, цаашлаад хууль хэрэглэх төвшинд ажиллах боломжтой боловсон хүчин бэлтгэх үндсэн зорилгыг агуулсан ба хуульчийн сургалтад хамрагдах журмыг Хуульч сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл тогтоож байхаар хуульчилсан нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудтай зөрчилдсөн гэх үндэслэлгүй байна. Энэ нь шүүгчээр ажиллах хүнд Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулиар тавигддаг шаардлагыг агуулгынх нь хэмжээнд өргөжүүлж байгаа ач холбогдол бүхий заалт юм.

4. Иргэн А.-гаас Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт гаргасан хариу тайлбарын агуулга:

1/ Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарлаж байгаачлан хуульчийн гэрчилгээ гэдэг нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатын ажил эрхэлж байгаа хүний хувьд хүчинтэй байх эсэх нь тийм ч ач холбогдолтой биш, харин эдгээр ажил албаны “гадна” байгаа эрх зүйч мэргэжилтэй хүний хувьд чухал ач холбогдолтой гэж ойлгогдлоо. Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Нотариатын тухай хуульд тухайн албан тушаалыг эрхлэх эрхээ алдах тохиолдлуудыг тоочихдоо “хуульчийн гэрчилгээ хүчингүй болсон” гэсэн нөхцөл заагаагүй тул эдгээр алба ажлыг эрхэлж байгаа хүний хуульчийн гэрчилгээ хүчингүй болсон ч тухайн ажил, албандаа ажиллаад байх боломжтой тул шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч нь Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаагүйн улмаас хуульчийн гэрчилгээ нь хүчингүй болсон ч тухайн албанаасаа чөлөөлөгдөхгүй юм байна.

Энэ нь шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн ажил эрхэлж байгаа хүнд давуу байдал, харин уг ажил албан тушаалын гадна байгаа хуульч хүнд гэрчилгээгээ хүчинтэй байлгахын тулд хууль зүйн үргэлжилсэн гэх төлбөртэй сургалтад заавал хамрагдах гарцаагүй байдал үүсгэж байна.

2/ Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхтэй. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч болохоор тухайн мэргэшлийн сонгон шалгаруулалтад орж байгаа хүнийг заавал хуульч байхыг хуулиар шаардаж байгаа нь эдгээр албан тушаалтнууд заавал хуульч буюу хуульчийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх шаардлагыг цаанаа агуулж байна. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль болон Шүүхийн тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Нотариатын тухай хууль хооронд байгаа зөрчилдөөнийг хууль тогтоогч “залруулж”, хуульчийн гэрчилгээ нь хүчингүй болсон бол шүүгч огцрох, прокурор халагдах, өмгөөлөгч, нотариатчийн тусгай зөвшөөрөл хүчингүй болох үндэслэл гэж “ирээдүй”-д зааж өгөх аваас эдгээр ажил алба эрхэлж байгаа хүмүүсийн Үндсэн хуулиар баталгаажсан эрх ашиг шууд хөндөгдөнө.

3/ Хууль зүйн үргэлжилсэн сургалт нь шүүх болон прокурорын байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахад чиглэгдэж байна уу? Эсвэл хувь хүний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэж байна уу гэдгийг анхаарах шаардлагатай. Хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдахгүй байх нь мэдлэг, ур чадварын хувьд хоцорно гэсэн хууль тогтоогчийн “шийдэл”-тэй мэдээлэл гаргагч санал нийлэхгүй байгаа тул Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн хүрээнд хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл тогтоох хэсгийн агуулга:**

1. Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд зааснаар шүүгчид хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэхдээ зохих багц цагийг хангаагүйн төлөө орон тооны бус зөвлөлөөс хуульчийн гэрчилгээг нь хүчингүй болгохоор зохицуулсан нь шүүгчид тавих Үндсэн хуулийн шаардлагыг хэт явцууруулж, Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна. Хуульч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах орон тооны бус зөвлөл гэрчилгээг хүчингүй болгосноор шүүгч ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болохоор байгаа нь шүүгчийг огцруулах, чөлөөлөх талаарх Үндсэн хуулийн заалтад нийцээгүй байна.

Үргэлжилсэн сургалтын багц цагийг хангах үүргээ биелүүлээгүй нь хуульчийн гэрчилгээг хүчингүй болгох үндэслэл биш боловч шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч энэ үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд энэ нь мэргэжлийн ёс зүйг баримтлах, ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингээ байнга дээшлүүлэх хуулийн шаардлагад нийцэж байна. Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж байгаа хуульч үүргээ биелүүлэх хууль зүйн хариуцлагыг Улсын Их Хурлаас оновчтой тогтоох шаардлагатай байна.

2. Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсад нь төрийн албан тушаал эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдаж буй төрийн албан хаагч тул Үндсэн хуульд заасны дагуу улсын төсвөөр үргэлжилсэн сургалтад хамрагдах эрхтэй байна.

3. Төрөөс хуульч, түүний дотор шүүгчийн мэдлэг, мэргэшлийг байнга дээшлүүлэх, хууль хэрэглэх ур чадварыг нь дээшлүүлэх сургалт зохион байгуулахаар зохицуулсныг, мөн сургалтад хамрагдах журмыг тогтоох субъект нь хуульч сонгон шалгаруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх орон тооны бус зөвлөл байхаар хуульчилсныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно” гэснийг зөрчөөгүй байна.

2. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль... өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал, ...аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг зөрчөөгүй байна.

3. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Хуульчийн сургалтад хамрагдах журмыг Зөвлөл тогтооно” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэснийг зөрчөөгүй байна.

4. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...хууль дээдлэх...” гэснийг, Арван зургадугаар зүйлийн 3 “... хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй”, 4 “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй”, 7 “сурч боловсрох эрхтэй” гэснийг зөрчөөгүй байна.

5. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд

шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

6. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 71 дүгээр тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 8 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Хуульч өөрөө байнга сурч, боловсорч байдаг мэргэжил. Гэхдээ ийнхүү сурч боловсорч, тодорхой багц цаг хангаагүй гэсэн үндэслэлээр шууд албан тушаалаас нь чөлөөлөх агуулгатай хуулийн заалт учир дутагдалтай юм.

Шүүгчийн хувьд хугацаагүй томилогддог, Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан үндэслэлээр л огцруулж болохоор Үндсэн хуульд заасан. Гэтэл Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан багц цаг хангаагүй гэсэн үндэслэлээр албан тушаалаас нь огцруулахаар заасан нь Үндсэн хуулийг зөрчихөд хүргэсэн байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2011.01.07 № 02

### Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Хүсэлт гаргагч - Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч Захиргааны хэргийн танхимын тэргүүн З., Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Т.

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Т.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:  
Цэцийн дээрх шийдвэр нь Үндсэн хуулийн цэцээр эцэслэн батлагдвал хуульчдын дунд болоод нийгэмд олон сөрөг үр дагаврыг авчрах тул уг байдлаас сэргийлэх зорилгоор Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Нотариатын тухай, Өмгөөллийн тухай хуулиудад нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж байсан болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар маргааныг хянан хэлэлцэх явцад Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч “хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж 3 жил тутам сургалтын тодорхой багц цагаа хангаагүйгээс хуульчийн гэрчилгээг нь хүчингүй болгохоор заасан зохицуулалтыг Шүүхийн тухай хуулийн 58, 59 дүгээр зүйлд тусгаж өгөөгүйгээс тухайлбал, шүүгч болохоор зорьж байгаа хүн шүүгчид нэр дэвших боломжоо алдах, шүүгчээр ажиллаж байгаа шүүгч тухайн ажилдаа үлдэх боломжгүй болно” гэсэн тайлбар, Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч “Хуулийн дээрх зохицуулалт нь Үндсэн хуулийн зөрчил гэхээсээ илүү хууль хоорондын уялдаа холбоо, хуулийг боловсронгуй болгох асуудал байгаа тул Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд нэн яаралтай Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Нотариатын тухай, Өмгөөллийн тухай хуулиудын хариуцлагын тогтолцоонд дээрх хуулийн зохицуулалт хийх нь зүйтэй юм” гэсэн хариу тайлбаруудыг хийж байсныг анхаарвал зохино.

Улсын дээд шүүх 2007 онд батлагдсан Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд зааснаар нийт хуульчид 3 жил тутмын хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдсан эсэх, багц цагаа хангасан эсэхийг дүгнэн үзээд хууль хоорондын зөрчлийг арилгуулахаар Улсын Их Хуралд хандах байтал өөрсдийн эрх ашгийн үүднээс энэ цаг үеэс өрсөж мэргэшил, ур чадвар, мэдлэгээрээ дулимаг, мэргэшлийн сургалтад хамрагдаагүй шүүгчдийг тухайн эрхэлж байгаа ажилд нь авч үлдэх, хуульчдын дунд явуулж байгаа сургалтыг үл ойшоосон байдал гаргаж шууд Үндсэн хуулийн цэцэд хандаж Үндсэн хуулийн зөрчил байна гэсэн дүгнэлт гаргуулан хүчингүй болгох гэж байгаа нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалтыг зөрчихөд хүргэж байна.

Ийм учраас Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг зөрчөөгүй байх тул Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийг хүчингүй болгох шийдвэр гаргаж өгнө үү.

## **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 8 дугаар дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй” гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно”, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 8 дугаар дүгнэлтийн тухай” 71 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

### **Тэмдэглэл:**

Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь хүчингүй болгосон тохиолдолд шүүгчийн бүрэн эрх дуусгавар болохоор зохицуулалт оржээ.

Энэ нь нэг хуульд бий болсон Үндсэн хуулийн зөрчлийг нөгөө хуульд оруулсанаар арилгаж байгаа мэт боловч цаад агуулга нь адил юм.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2011.06.14 № 01

### Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн З.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Ч.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

- 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого"

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"  
- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй"  
- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"

#### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

1. Иргэн З.-гийн мэдээллийн агуулга:

2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдаж, 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн албан татвараас чөлөөлөх орлогын зохицуулалт болох 16 дугаар зүйлийн 16.1.12-т "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого."-оос татварын чөлөөлөлт эдлүүлнэ гэж хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөгдөх тухай заасан байдаг. Гэтэл хувь хүн анх удаа зээлийн хөрөнгөөр орон сууцтай болж, татвараас чөлөөлүүлнэ гэхэд уг хуулийн дээр дурдсан "...банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр..." гэсэн заалт нь тухайн этгээдийн банк санхүүгийн байгууллага бус, өөр этгээдээс буюу ажил олгогч байгууллагаасаа авсан зээлийн хөрөнгөтэй тэнцэх орлогод ногдох татварын чөлөөлөлтөд хамрагдах боломжгүй байхаар хуульчилсан байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дээрх зүйл, заалттай холбогдуулан хувь хүний орлого олж болох эрх зүйн үндэс боломжуудыг судлаад үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн зээлийн гэрээний зохицуулалт болох 281 дүгээр

зүйлийн 281.1 дэх хэсэгт “Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ” гэж заасан байна. Мөн тус хуульд зээлдэгч, зээлдүүлэгчийг тодорхойлохдоо зээлдүүлэгч нь зөвхөн “банк санхүүгийн байгууллага” байхаар зохицуулаагүй. Ингэж зохицуулах ч боломжгүй. Харин тус хуулийн 451 дүгээр зүйлээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ зохицуулалтыг ойлгож хэрэглэхдээ зээлийг зөвхөн банк болон банк бус санхүүгийн байгууллага олгоно гэж байгаа мэтээр Татварын алба үзэж хэрэглэх хууль зүйн үндэслэлгүй юм. Татварыг зөвхөн хуулиар ногдуулах, чөлөөлөх татварын эрх зүйн үндсэн зарчмаар татварын албаны албан хаагчид хандаж, татварын хуулиудыг хэрэглэж байгаа гэж ойлгогдох учраас тэдний үйл ажиллагааг шууд буруутган үгүйсгэх аргагүй болж байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтаар “...банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр...” гэж онцгойлон заасан байгаа нь татварын хуулийн уг заалтын дагуу хувь хүн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас л зээл аваагүй бол хууль ёсоор, гэрээний үндсэн дээр өөр бусад этгээдээс зээлээр олж авсан өөрийн хөрөнгөд ногдох орлогоосоо татварын чөлөөлөлт эдлэх эрхгүй харагдаж байна. Энэ нь татварын хуулиар зээлийн хөрөнгийн эх үүсвэрт ялгавартай хандсанаас Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хувь хүний эдлэх ёстой үндсэн эрх зөрчигдөж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-д заасан “...хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр...” гэсэн хэсгийн “банк, санхүүгийн байгууллагаас” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн болох нь тухайн хувь хүний хөрөнгө, орлогын хууль ёсны эх үүсвэрт үндэслэлгүй ялгаварлал тогтоосноороо банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан хүмүүст татварын чөлөөлөлт эдлэх боломж олгоод харин эдгээрээс бусад этгээдээс зээл авч хөрөнгөтэй болсон хувь хүнд үйлчлэхгүй байхаар зохицуулсан байна. Хууль хүн бүрт тэгш үйлчлэх Үндсэн хуулийн зарчим, заалт ноцтой зөрчигдсөнийг нэн даруй засч залруулахад анхаарах нь ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг хайрлан хамгаалах учиртай хүн бүрийн эрхэм үүрэг мөн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй” гэж заасан байдаг. Аливаа хувь хүн ажилладаг байгууллагаасаа орон сууцны зээл аваад, тэр зээлийнхээ хөрөнгөд ногдох орлогоосоо татварын чөлөөлөлт эдлэх нь хувь хүний өөрийн өмчлөлийн зүйлээ шударгаар эзэмших, өмчлөх эдийн засгийн эрхэд хамаарна. Гэтэл татварын хуулиар хүн бүрт адил тэгш боломж олгохгүй зөвхөн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөд ногдох орлогыг татвараас чөлөөлж байгаа нь Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байдаг. Хувь хүнд татвар ногдуулах, татвараас чөлөөлөх, хөнгөлөх эрх зүйн харилцаанд Үндсэн хуулийн дээрхи зүйл, заалтад байгаа “...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн хэсгийг Татварын хуулиар зөрчиж, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлж чадахгүй байгаа нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байна.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ч.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг 2006 онд шинэчлэн батлахдаа хувь хүнийг орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх зарим нөхцлийг тогтоож өгсөн. Үүний дотор хувьдаа анх удаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгийн 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний орлогыг албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

Хуулийн дээрх заалтад “банк, санхүүгийн байгууллагаас” гэсэн тодотгол хийсэн нь хувь хүний хөрөнгө, орлогын эх үүсвэрт үндэслэлгүй ялгавар тогтоосон, хүн бүхэнд адил тэгш боломж олгоогүй, хувь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг хангаж чадаагүй тухай мэдээлэгч тал мэдээлэлдээ дурдаад энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзжээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын “хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого” гэсэн заалтад “банк, санхүүгийн байгууллага” гэж зааснаараа үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах, эзэмших, захиран зарцуулах, төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх Үндсэн хуулийн үзэл санааг зөрчөөгүй гэж үзэж дараахь үндэслэлийг гаргаж байна.

Нэг. Татварын бодлого, түүний хөнгөлөлт, чөлөөлөлт нь эдийн засаг, нийгмийн хөгжилд зохицуулалт, дэмжлэг, урамшуулал, хязгаарлалтын үүргийг гүйцэтгэдэг төрийн зохицуулалтын онцгой арга хэрэгсэл юм. Зохицуулалтын энэ арга хэрэгсэл нь иргэдийнхээ эдийн засгийн эрх чөлөөг хангах, бүрдүүлэх, хууль зүйн баталгааг бий болгох, тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэхэд шууд чиглэгддэг.

Хүн амын орон сууцны хангамжийг сайжруулах, иргэдээ орон сууцтай болгох нь төрийн бодлогын нэг чухал хэсэг бөгөөд энэ бодлогыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлэхдээ ил тод, иргэдэд илүү ойлгомжтой, эрсдэл багатай, найдвартай, баталгаатайгаар хэрэгжүүлэх арга замыг сонгох нь төрийн өөрийнх нь үндсэн үүрэг. Өнөөдрийн түвшинд иргэд орон сууцны төлбөрийг бэлэн мөнгөөр төлөх төлбөрийн чадвар муу, нэн ялангуяа хадгаламжийн эх үүсвэргүй нэг талаас, нөгөө талаас санхүүгийн зах зээлд мөнгөн хөрөнгө босгоход гэрээний оролцогч талуудын хариуцлага, сахилга сул, түүнээс хүлээх эрсдэл өндөр хэвээр байгаа бодит байдалд үндэслэн санхүүгийн зах зээлд байр сууриа олсон найдвартай санхүүгийн зуучлагч байгууллагаар дамжуулан иргэд орлогын нэг эх үүсвэрээ бүрдүүлэх, түүнд татварын чөлөөлөлт үзүүлэн дэмжих нь иргэдэд найдвартай төдийгүй хүн амаа орон сууцжуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд бодитой үр дүнтэй арга зам гэж үзсэнд оршиж байгаа юм. Ингэхдээ ч “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэл болгосон.

Татвар төлөгчдөөс цуглуулсан төрийн сан хөмрөгийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт хэлбэрээр иргэддээ буцааж хөрөнгө оруулалт хийх бодлого нь иргэний өмчлөх эрхийг шударгаар олж авах эрхийг хязгаарласан бус харин өмчлөх эрхийг олж авахад төрөөс дэмжлэг үзүүлж байгаа хэлбэр мөн бөгөөд энэ утгаараа Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах” боломжийг бүрдүүлж, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц, эдийн засаг, нийгэм,

хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм.

Иргэн хүн Иргэний хуулийн 281 дүгээр зүйлд заасны дагуу иргэд хоорондоо зээлийн гэрээ байгуулан мөнгөн хөрөнгө зээлэх замаар орон сууцтай болохыг хуулийн энэ заалтаар хориглож, хязгаарласан зүйлгүй бөгөөд харин энэ заалтаар орон сууцтай болох иргэдийн хөдөлгөөнийг өнөөдрийн санхүүгийн зах зээлийн бодит байдлын үнэлгээнд тулгуурлан урамшуулж байгаа урамшуулал, дэмжлэгийн хэлбэр юм. Нөгөөтэйгүүр энэхүү дэмжлэгийг эрх тэгш бус байдлыг бий болгосон, шударгаар өмчтэй болох эрхийг зөрчсөн хэмээн сэргүүлэн тавих нь тухайн асуудалд илт өнгөц хандсан гэж үзэхээр байна. Харин ч өнөөгийн түвшинд санхүүгийн зах зээлд гарч болзошгүй эрсдлийг харгалзан үзэж, хуулийн өмнө эрх тэгш байх, шударгаар өмч хөрөнгө олж авах, түүний хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд уг заалтын агуулга, мөн чанар чиглэгдэж байгаа болно.

Хоёр. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын “...банк, санхүүгийн байгууллагаас авсан...” гэж тусгайлан заасан нь Монгол Улсад орлого олж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь хэн нэгэн этгээдэд зээл олгосон тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухай болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд уг олгосон зээлээ албан татвар ногдох орлогоос хасуулах эрхтэй байдагтай ч бас холбогдолтой гэж үзэж болно. Учир нь зээл олгох байгууллагыг тогтоож өгснөөрөө Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.12-т зааснаас бусад зээл олгогч татвар төлөгчийг Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлтэй холбогдолтой эрсдэлд орохоос сэргийлж байдаг юм. Энэ утгаараа “...банк, санхүүгийн байгууллагаас авсан...” гэдэг нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын “...зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний...” гэж заасан хязгаарлалттай нэг санаа агуулсан, нийгэмд тэгш, шударга байдлыг хангах зорилготой урьдчилан сэргийлсэн заалт юм.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т орлогын зохих хэсгийг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт эдлүүлэхээр заахдаа тодорхой хязгаарлалт тогтоосноороо тэгш эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т “...банк, санхүүгийн байгууллагаас авсан...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтад “хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого” гэж заасны “...банк, санхүүгийн байгууллагаас авсан...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх

тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Татварын асуудал бол өөрөө ихээхэн зөрчилдөөнтэй байдаг. Учир нь нэг талаас татварыг бүрэн хураах, нөгөө талаас татвар дутуу төлөх сонирхол зөрчилддөг. Үүнээс үүдэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхэд маш тодорхой нөхцөл, болзлыг тавих шаардлагатай. Чухам ямар нөхцөл, болзол тавих нь хууль тогтоогчийн бүрэн эрхийн асуудал юм.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-ын “хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого” гэсэн заалт нь “банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр” гэснээс гадна “анх удаа”, “хувьдаа”, “30.0 сая төгрөгөөс дээшгүй” г.м олон нөхцөл, болзлыг заасан байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2011.06.15 № 02**

**Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Хүсэлт гаргагч - Улсын дээд шүүх, Улсын дээд шүүхийн итгэмжилсэн төлөөлөгч Иргэний хэргийн танхимын тэргүүн А.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Д.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль

- 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлэгдэл, далбааг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно”

## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалт “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын дээд шүүхээс ирүүлсэн хүсэлтийн агуулга:

Монгол Ардын нам иргэн М.-д холбогдуулан Сүхбаатар дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ МАХН-ын түр штаб нэрийн дор МАХН-ын нэр, бэлэгдэл, далбааг ашиглаж буй хууль бус үйлдлийг таслан зогсоох, цаашид МАХН-ын нэр, бэлэгдэл, далбааг ашиглахгүй байхыг үүрэг болгох, хуульд заасан хариуцлага ногдуулах, МАХН-ын түр штаб гэгчийн хэрэглэж байгаа Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/ гэсэн үг орсон хаяг, намын бэлгэ тэмдэг, туг далбааг хураан авах гэсэн шаардлагуудыг тавихдаа Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг үндэслэл болгожээ.

Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2011 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 1697 дугаар захирамжаар тухайн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Нам энэ хуульд заасны дагуу... нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... нэр ...-г дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн хэсэг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэсэн заалтыг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу Улсын дээд шүүхэд гаргажээ. Улсын дээд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.-т зааснаар уг саналыг нийт шүүгчдийн хуралдаанаар хянан хэлэлцээд үндэслэлтэй гэж үзэж, 2011 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 3 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэхээр тогтсон юм.

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн намын нэртэй холбоотой зохицуулалт утга, агуулгаараа Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зохицуулалттай ижил байгаа нь тухайн эрх зүйн хэм хэмжээний бүтцээс харагдаж байна. Нийгмийн харилцааг зохицуулагч хэрэгслийн хувьд эрх зүйн хэм хэмжээ бүр агуулгынхаа илрэл болсон дотоод бүтэцтэй байдаг ба Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6. дахь хэсэг болон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр хүчингүй болсон 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн бүтцийг авч үзвэл агуулгын хувьд ижил шинжтэй байгааг тодорхойлох боломжтой юм. Хуулийн дээрх хоёр заалт хоёулаа хориглосон агуулгатай тул тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хариуцлага, эрхийн хязгаарлалтын үр дагавар адил үүсэх нь тодорхой.

Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолд “Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон хязгаарлалт хийсэн нь иргэдийн нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх үндсэн эрхэд халдсан шинжийг агуулжээ. Намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж

үзвэл дээрх хуулиар тогтоосон хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон байна” гэж дүгнэжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт нам зөвхөн нэгдэх замаар бус харин нийлэх замаар ч өөрчлөн байгуулагдсан тохиолдлыг багтаасан төдийгүй зөвхөн шинээр байгуулагдсан болон бусад өөр намд бус харин тухайн намын гишүүд, гишүүн бус бусад бүх иргэд, аливаа хуулийн этгээдэд хориглосон хэм хэмжээг хамааруулснаас гадна тухайн хориг хугацаагүйгээр үйлчлэх агуулгатай байгаа нь Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т зааснаас илүү өргөн хүрээгээр Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг эерчсөн гэж үзэхээр байна.

а/ Хуулийн хүчингүй болсон 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт намыг өөрчлөн байгуулах хэлбэрүүдээс зөвхөн нэгдэх замаар өөрчлөн байгуулах хэлбэрийг тухайн хэм хэмжээний хэрэгжих нөхцөлд заасан бол хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д “энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан” гэж заасныг энэ зүйлийн 15.1-д “намыг хуульд заасны дагуу нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулж болно” гэж зааснаар нийлүүлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан гэж ойлгох үндэслэлтэй. Мөн зүйлийн 15.4-т “нийлэх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа намууд нь аль нэг намынхаа нэрийг шинээр байгуулсан намын нэр болгон хэрэглэж болох бөгөөд нийлсэн намуудын нэртэй холбогдсон харилцааг энэ хуулийн 6.3-т зааснаар зохицуулна” гэж заасан хэсэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэдий ч хуулийн хүчингүй болсон заалтыг иш татсан уг зохицуулалтыг шүүхүүд бүрэн эрхийнхээ хүрээнд тайлбарлан хэрэглэх боломжтой гэж үзэн энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлээгүй болно. Гагцхүү нийлүүлэх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа намууд аль нэг намынхаа нэрийг шинээр байгуулсан намын нэр болгон хэрэглэхдээ нэртэй холбогдсон харилцааг хүчингүй болсон 6.3-т зааснаар бус харин хүчинтэй байгаа 15 дугаар зүйлийн 15.6-д зааснаар зохицуулах болно. Энэ тохиолдолд нийлүүлэх, нэгдэх аль ч замаар өөрчлөн байгуулагдсан намын нэрийг шинээр байгуулагдсан нам, эсхүл өөр нам хэзээ ч хэрэглэж болохгүй болно.

Улс төрийн намын тухай хууль 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдаж байх үед хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 15 дугаар зүйлийн 15.4, 15.6 гэсэн зүйл, заалтууд бүгд энэ хуулийн бүтцэд багтаж байсан ба тэдгээрийн зохицуулалт хоорондоо логик холбоотой, харилцан уялдаатай байсан нь харагдаж байна. Тийм ч учраас 6 дугаар зүйлийн 6.3-т тусгагдаагүй нийлүүлэх замаар өөрчлөн зохион байгуулагдсан намын нэрийн асуудлыг 15 дугаар зүйлийн 15.4-т, намын нэрээс бусад асуудал буюу эд хөрөнгө, тамга, тэмдэг, гишүүнчлэл, бэлэгдэл, туг, далбаа зэргийг объектын хувьд, намаас бусад хуулийн этгээд болон иргэдийг субъектийн хувьд 15.6-д тус тус багтаан зохицуулсан болов уу. Нэгэнт хуульд заасан арга хэлбэрээр үгүй болсон намын нэрийг өөр нам хэрэглэхийг тодорхой хугацаагаар хязгаарласан зохицуулалт Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд дээрх зохицуулалттай адил утга агуулгатай бусад зохицуулалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудал тавигдах нь гарцаагүй юм.

б/ Хуулийн хүчингүй болсон 6 дугаар зүйлийн 6.3-т заасан хэм хэмжээнд хамаарах субъект нь шинээр байгуулагдсан болон өөр бусад нам байна. Харин 15 дугаар зүйлийн 15.6-д заасан хэм хэмжээгээр зохицуулагдах харилцааны субъект бол өөрчлөн байгуулагдсан, эсхүл нэрээ өөрчилсөн намын гишүүн, аливаа бусад иргэд болон хуулийн этгээд юм. Хэдийгээр хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т зөвхөн намыг тухайн зохицуулалтад хамааруулсан боловч нам гэдэг нь хуулийн этгээд мөн болохыг үгүйсгэх хууль зүйн үндэслэлгүйгээс гадна Улс төрийн намын тухай хууль нь хуулийн этгээд дотроос зөвхөн улс төрийн намтай холбоотой харилцааг зохицуулдаг учир субъектийн хувьд тусгайлсан зохицуулалттай байсан зүйл, заалт хүчингүй болсноор

нийтлэг агуулгаар бүх хуулийн этгээдэд хамаарах ерөнхий зохицуулалт үйлчлэх үндэслэлтэй болж, шинээр байгуулагдсан болон өөр бусад нам өөрчлөн байгуулагдсан, эсхүл нэрээ өөрчилсөн намын нэрийг 24 жил байтугай хэзээ ч хэрэглэж болохгүй гэсэн агуулгаар хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д заасан намын нэртэй холбоотой хэсгийг ойлгох эрх зүйн үндэслэл гарч байна.

Түүнчлэн хуулийн дээрх хориглосон заалт зөвхөн хуулийн этгээдэд бус харин тухайн намын гишүүд болон аливаа бусад иргэдэд хамааралтай болсноор хэм хэмжээний үйлчлэлийн хүрээ илүү өргөн болжээ. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолын үндэслэлийг хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д хамааруулан ойлгох нь буруу биш гэж үзэж байна.

в/ Хуулийн хүчингүй болсон 6 дугаар зүйлийн 6.3-т хориглосон хэм хэмжээний хугацааг 24 жилээр тодорхойлсныг Үндсэн хуулийн цэц 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолдоо буруу гэж үзэж байсан бол хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д хязгаарлалтын хугацааг огт заагаагүй байгаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд нийцэхгүй гэж үзэхээр байна.

г/ Хуулийн хүчингүй болсон 6 дугаар зүйлийн 6.3-т хуульд заасан арга хэлбэрээр үгүй болсон намын нэрийг өөр нам дахин хэрэглэхийг хориглосон бол хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хоригложээ.

Хуулийн этгээдийн нэр бол өмчлөх эрхийн объект болох үндэслэлгүй тул “аливаа хэлбэрээр өмчлөх” гэдэг хязгаарлалт нэртэй холбоотой харилцаанд хамааралгүй, харин “үргэлжлүүлэн хэрэглэх” гэсэн хэсэг хамааралтай гэж үзэхээр байна. Өөрчлөн байгуулагдсан, эсхүл нэрээ өөрчилсөн намаас өөр хуулийн этгээд тухайн намын нэрийг хэрэглэх болбол уг нэрийг ямар шалтгаанаар /үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх, сэргээх, шинэчлэх г.м/ авах болсноос үл хамааран түүнийг дахин хэрэглэх асуудал тавигдана. Учир нь, нам өөрчлөн байгуулагдснаар өөр нэртэй болсноо, эсхүл нэрээ өөрчилснөө улсын бүртгэлд бүртгүүлснээр шинэ нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах хууль зүйн үндэслэлтэй болно. Улсын бүртгэлээс дээрх шалтгаанаар байхгүй болсон нэрийг өөр хуулийн этгээд буюу нам авах тохиолдолд нэрийг дахин хэрэглэх асуудал тавигдах нь ойлгомжтой. Иймд намын нэрийг “үргэлжлүүлэн хэрэглэх”, “дахин хэрэглэх” гэсэн томъёолол ижил утгатай гэж үзэхээр байна.

Улсын дээд шүүх нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д зааснаар улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэх байгууллага юм. МАХН нэрээр улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг Улсын дээд шүүх 2011 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан. Улсын дээд шүүх улс төрийн намын бүртгэлийн асуудлыг шийдвэрлэхдээ Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан намыг бүртгэхээс татгалзах үндэслэлүүд байгаа эсэхийг шалгах үүрэгтэй байдаг бөгөөд тэдгээрийн дотор энэ зүйлийн 10.1.6-д заасан тухайн намыг бүртгэхэд харшлах “хуульд заасан бусад үндэслэл” байгаа эсэхийг зайлшгүй тогтоох шаардлагатай юм.

Нам нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний нэрийг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тухайн намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглосон Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн зохицуулалт МАХН нэрээр улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн улс төрийн намын бүртгэлийн асуудлыг шийдвэрлэхэд шууд хамааралтай байх тул Улс төрийн намын тухай хуулийн дээрх зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх хүртэл МАХН-ыг улсын бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах аль нэг шийдвэрийг шүүх гаргах боломжгүй гэж үзэж, бүртгэлийн ажиллагааг Үндсэн хуулийн цэцээр асуудал шийдвэрлэгдтэл түдгэлзүүлсэн болохыг мэдэгдэх нь зүйтэй гэж үзлээ.



Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хүсэлт болгох нь:

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлэгдэл, далбааг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэж заасны “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... нэр ...-г дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн хэсэг “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх” иргэдийн эрхийг тодорхойлсон Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Д. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Нэг. “улс төрийн нам” гэсэн субъектийн эрх зүйн байдлыг хууль тогтоомжийн дагуу хэрхэн тодорхойлох боломжтойг авч үзэх нь зүйтэй билээ. Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” хэмээн хуульчилсан. Улмаар хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болох, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоож байхаар заажээ. Тухайлбал, Компанийн тухай хуулиар хуулийн этгээд болох компани оноосон нэртэй байх, ийнхүү нэр нь бусад компани, аж ахуйн нэгжийн оноосон нэртэй давхардаагүй байх, уг нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр энэхүү оноосон нэрээ хэрэглэх онцгой эрх авахаар хуульчилсан байна.

Түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн” гэж тодорхойлсон байна.

Эдгээр хуулийн заалтуудаас үзэхэд нам нь улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгоор сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн зохион байгуулалтын нэгдэл болох хуулийн этгээд болж буй учир аливаа хуулийн этгээдийн адил өөрийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг тусгасан нэртэй байна. Намууд өөрийн нэрээрээ уламжлан намаа үүсгэн байгуулсан мөн чанар, зарчим, зорилго, зорилтыг сонгогч нарт болон гишүүддээ зөв ойлголт өгөх, тодорхой хүргэхийг зорилгоо болгодог. Иргэний хуулийн 27 дугаар зүйлд заасанчлан “хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөлдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэжээ. Өөрөөр хэлбэл хууль тогтоогч эрхийн хязгаарлалтыг хуулийн хэм хэмжээгээр тогтоож өгсөн болно. Иймд Улс төрийн намын тухай хуулийн 15.6 дахь заалт нь нэгэн адил хуульчлан тогтоосон эрх зүйн хязгаарлалтын хэм хэмжээ болно.

Түүнчлэн Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.5-д хуулийн этгээд нэрээ хуульд заасан журмын дагуу бүртгүүлэхээр хуульчилсан юм. Улмаар хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой асуудлыг холбогдох хуулиар зохицуулж байгаа бөгөөд Улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа мэдээлэлд /хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, үүсгэн байгуулагч, үүсгэн байгуулах баримт бичиг зэрэгт/ өөрчлөлт оруулах тохиолдолд өмнө нь орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл хэвээр хадгалагдаж байхаар заажээ. Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдөх явдал нь тухайн хуулийн этгээдийн

төрөл, хэлбэр, зорилго, чиг үүрэг хэвээр хадгалагдан, оршин тогтносон хэвээр байгаа болно. Өөрөөр хэлбэл улс төрийн нам нэрээ өөрчилсөн /улсын бүртгэлийн жагсаалтаас хасагдаагүй/ тохиолдолд түүний нэрийг бусад аливаа этгээд үргэлжлүүлэн хэрэглэх үндэслэлгүй юм.

Хоёр. Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйлд “1. Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх... эрхтэй. 2. Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуульд зааснаас өөр хязгаарлалт хийж болохгүй” талаар заажээ.

Дэлхийн бусад оронд үүний дотор тухайлбал, Франц Улсын Үндсэн хуульд улс төрийн нам байгуулах эрх чөлөөг нь тунхаглахын зэрэгцээ түүнийг үүсгэн байгуулах хүрээ, чиг үүргийг тодорхойлон заадаг байна. Францын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд “Улс төрийн нам, бүлэглэл нь үндэсний бүрэн эрхт байдал болон ардчиллын зарчмыг сахин биелүүлэх үүрэгтэй” гэж заасан байна. Үндсэн хуулийн эрх зүйн зарчим ёсоор эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх нь өөрийн гэсэн хязгаартай байдаг оршино. Улс төрийн эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг эрх, эрх чөлөөний ерөнхий хязгаарлалтын хүрээнд л байх боломжтой гэж үздэг байна. Төр, нийгэм нь хэвийн оршиж буй нөхцөлд зарим эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг зөвхөн хуулиар, эсхүл хуулийн үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам сахих, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор тогтоож болно. Түүнчлэн зарим орны Үндсэн хуулийн онцлог бол тодорхой нэг улс төрийн эрх, эрх чөлөөг урвуулан ашиглах явдалд “хаалт” хийсэн зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг юм. Тухайлбал Германы Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд ноцтойгоор урвуулан ашиглах тохиолдол буй болбол зарим эрхийг хязгаарлах боломжийг хуульчилсан байна. “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үүний дотор хэвлэлийн эрх чөлөө, хуран цуглах эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг ардчилсан байгууламжийн эсрэг ашиглаж байгаа аливаа этгээд эдгээр үндсэн эрхээ алдах болно” гэж заасан байна.

Улс төрийн намын тухай хуулийн 15.6 дахь хэсгийн заалт ч гэсэн Иргэний хуулийн болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцын холбогдох заалттай бүрнээ нийцсэн бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл үгүй болно.

Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд мэдүүлсэн хүсэлтэд Улс төрийн намын тухай хуулийн 15.6-гийн холбогдох заалтын зохицуулалт утга агуулгаараа Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн агуулгатай ижил шинжтэй байгаа тул Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг илүү өргөн хүрээгээр зөрчсөн гэж үзэх талаар дурджээ.

Намыг энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулсан тухайлбал: хоёр буюу түүнээс дээш намын үйл ажиллагааг зогсоож нийлүүлсэн, нэг намын үйл ажиллагааг зогсоож өөр намтай нэгтгэсэн тохиолдолд намын үйл ажиллагаа дуусгавар болж, эрх залгамжлалын асуудлыг Улс төрийн намын тухай хуулийн 15.3, 15.4, 15.5 дахь заалтуудаар зохицуулсан. Энэ зохицуулалтыг хуулийн 15.6 дахь хэсгийн заалтаар улам тодруулж өгсөн. Тухайлбал, нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан /нийлүүлэх, нэгтгэх замаар/ бол түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, бэлэгдэл, далбааг бусад этгээд өмчлөх, аливаа хэлбэрээр ашиглан хэрэглэхгүй байхаар зохицуулжээ. Мөн хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах арга замд тухайн этгээд нэрээ өөрчлөх тохиолдол хамаарахгүй юм. Үүнийг ч баталгаажуулж Улс төрийн намын тухай хуулийн 15.6-д заасан заалтын нам нэрээ өөрчилсөн тохиолдол нь хуулийн этгээдийн эрх залгамжлалын асуудал яригдахгүй гэдгийг тодруулж өгсөн зохицуулалт болжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн заалтыг “намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж үзвэл дээрхи хуулиар тогтоосон хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон байна гэсэн үндэслэлээр Үндсэн хуулийн цэц 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр тогтоолоороо хүчингүй болгосон юм. Үндсэн хуулийн цэцийн гаргасан ийнхүү үндэслэлээр намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт байж болох юм гэж үзсэн боловч, “24 жилийн турш” гэсэн хугацаа нь хязгаарлалтын хэмжээ хэтрүүлж, Үндсэн хуулийн эрх зүйн зарчимд харшилсан гэжээ. Үүний үр дүнд хууль тогтоогчоос “ямар хугацаа” тогтоож өгвөл “хязгаарлалтын хэмжээ хэтрээгүйд” тооцох вэ гэсэн асуудал Улс төрийн намын тухай хуулиар нээлттэй үлдэж байгаа болно.

Гурав. Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-ийн намын нэртэй холбоотой харилцаанд харин “аливаа хэлбэрээр өмчлөх”-ийг хориглосон хязгаарлалт нь хамааралгүй юм гэсэн Улсын дээд шүүхийн саналтай санал нэг байгаа болно. Гэвч “үргэлжлүүлэн хэрэглэх”-ийг хориглосон хязгаарлалт намын нэртэй холбоотой харилцаанд хамаарна. Иймд намын нэрийг “дахин хэрэглэх” болон намын нэрийг “үргэлжлүүлэн хэрэглэх” гэсэн хуулийн нэр томъёоны агуулгын талаар дараахь тайлбар өгч байна.

Улсын дээд шүүхийн хусэлтэд дурдсанаар намын нэрийг “үргэлжлүүлэн хэрэглэх”, “дахин хэрэглэх” гэсэн нэр томъёо ижил утгатай гэж үзсэн байна. Үүнтэй бид санал нийлэхгүй байна. Хэл зүйн шинжлэх ухааны талаас нь авч үзэхэд тухайлбал, “Я.Цэвэлийн Монгол хэлний тайлбар тольд заасанчлан “дахин” гэдэг нь аливаа бүрэн тасалдсан зүйлийг давтан хэрэглэх ойлголт мөн. Харин “үргэлжлүүлэх” гэдэг нь үргэлж юмны хагас, тасралтгүй, залгалдаагаар болох буюу аливаа нэг тасралтгүй үргэлжлэн хэрэгжиж байгааг тайлбарласан байна.

Үндэсний хууль тогтоомжид ийнхүү нэр томъёоны ойлголтыг ялгамжтай агуулгаар тусгаж байдаг болно. Тухайлбал, Иргэний хуулийн хөөн хэлэлцэх хугацаа тасалдах асуудлыг зохицуулж буй 79 дүгээр зүйлийн 79.7-д хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан бол өмнө өнгөрсөн хугацааг тооцохгүй, хугацааг дахин шинээр эхлэн тоолно гэж иргэний журмаар нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан тохиолдолд нэхэмжлэл гаргахаас өмнө өнгөрсөн, тасалдсанаас хойш тоологдсон бүх хугацааг тооцохгүйгээр тасалдал зогссон үеэс хөөн хэлэлцэх хугацааг дахин шинээр тоолохоор зохицуулсан байна.

Түүнчлэн Иргэний хуулийн эрх залгамжлал дахь хөөн хэлэлцэх хугацааг зохицуулж буй 81 дүгээр зүйлийн 81.1-ийн нэхэмжлэгдвэл зохих эд хөрөнгө нь эрх залгамжлалын журмаар гуравдагч этгээдэд шилжсэн бол өмнөх эзэмшигчийн эзэмшилд байх үеэс хөөн хэлэлцэх хугацааг үргэлжлүүлэн тоолно гэж үүрэг бүхий этгээд өөрчлөгдсөнөөр хөөн хэлэлцэх хугацаа тоолох журамд өөрчлөлт орохгүй байдлыг зохицуулсан жишээг дурдаж болно.

Иймд намын нэрийг “үргэлжлүүлэн хэрэглэх” гэдэг нь тухайн намын эрх залгамжлагч субъектийн хувьд, харин “дахин хэрэглэх” гэсэн ойлголт нь нэгэнт хэрэглэж байсан нэрийг хэрэглэхээ зогсоосны дараа аливаа өмчлөгч сэргээн хэрэглэх талаар агуулж байгаа тул энэ хоёр ойлголт ижил утгатай гэж үзэх боломжгүй юм.

Ийнхүү үндэслэлүүдээр Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-гийн “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... нэр...-г дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчөөгүй болно.

## **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2005 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1/01 тоот тогтоол гаргаж, Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Нам үйл ажиллагаагаа зогсоосон, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдсан, түүнийг тараасан, түүнчлэн нам нэрээ өөрчилсөн бол тэдгээрийн бүтэн болон товчилсон нэрийг шинээр байгуулагдсан болон өөр бусад нам 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглоно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэж үзэн хүчингүй болгосон байна.

Үндсэн хуулийн цэц Улс төрийн намын тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгосон үндэслэлдээ намын нэрийг хэрэглэхэд цаг хугацааны хязгаарлалт хийж болох юм гэж үзвэл хуулиар тогтоосон дээрх хугацаа нь “аливаа хязгаарлалт хэмжээ хэтрээгүй байх ёстой” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн нийтлэг зарчимд харшилсан шинжтэй болсон байна гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, намын нэрийг 24 жилийн турш хэрэглэж болохгүй гэсэн цаг хугацааны хязгаарлалтыг хэт урт байна гэсэн үндэслэлээр хүчингүй болгожээ.

2. Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн агуулга бүхий өргөдөл иргэн А., Ш., В., Б., С., М. нараас Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргаж байжээ. Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б. урьдчилан шалгаж, Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна гэж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоол гаргасан байна. Уг тогтоолын үндэслэл хэсэгт “Монгол Улсын Иргэний хуулийн /27 дугаар зүйл/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /16 дугаар зүйл/, Улс төрийн намын тухай хууль /6 дугаар зүйл/-иудад заасны дагуу намын бүтэн болон товчилсон нэр нь бусад хуулийн этгээдийн нэртэй давхардах, бусдыг төөрөгдүүлэхээр ижил төстэй байх, хүний нэр байхыг хориглодог. Өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн, намын шийдвэртэй санал нийлээгүй тухайн намын гишүүд /мөн бусад иргэн, хуулийн этгээд/ өөрсдийн үзэл бодлоороо эвлэлдэн нэгдэж дахин нам байгуулах эрхтэй бөгөөд дээрх шаардлагуудыг хангасан нэрээр байгуулсан намаа нэрлэх эрхтэй байна” гэж заажээ.

3. Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлгэдэл, далбааг дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн хязгаарлалт тогтоосон нь “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” байх Үндсэн хуулийн заалтад харшлаагүй байна.

4. Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулиар тогтоосон хязгаарлалтаас бусад тохиолдолд нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгоор Монгол Улсын иргэд эвлэлдэн нэгдэж, нам байгуулах нь Улс төрийн намын тухай хуулиар нээлттэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний өмч, хөрөнгө, гишүүнчлэл, тамга, тэмдэг, нэр, бэлэгдэл, далбааг дээрх

шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэж заасны “Нам энэ хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан болон нэрээ өөрчилсөн тохиолдолд түүний... нэр ...-г дээрх шийдвэртэй санал нийлээгүй тус намын гишүүн болон бусад иргэн, хуулийн этгээд аливаа хэлбэрээр өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно” гэсэн хэсэг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/06 дугаар дүгнэлт, мөн оны 1/01 дүгээр тогтоолтой маргаан, холбогдох тэмдэглэлийг харьцуулан үзнэ үү.

2. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлт нь 2005 оны 2/06 дугаар дүгнэлт, мөн оны 1/01 дүгээр тогтоолтой логикийн хувьд зөрчилддөг. Өөрөөр хэлбэл, намын нэрийг 24 жилийн турш дахин хэрэглэхийг хориглосон зохицуулалтыг уг хугацаа хэтэрхий урт байна гэсэн үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн шийдвэр гаргасан мөртлөө намын нэрийг үргэлжлүүлэн хэрэглэхийг бүрмөсөн хориглосон агуулгатай хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчөөгүй хэмээн үзсэн байна.

3. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэсэн шийдвэр гаргасан хэдий ч Улсын дээд шүүх 2011 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 7 дугаар тогтоолоор Монгол Ардын Хувьсгалт Намыг бүртгэсэн байна.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2011.10.21 № 03**

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Э.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Б.

#### **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль

- 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан”

## **Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт:**

- Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

### **1. Иргэн Э.-гийн мэдээллийн агуулга:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” хэмээн заажээ. Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай заажээ.

Энэхүү заалт нь тухайн гишүүн гэмт үйлдлийнхээ явцад, эсвэл хэрэг үйлдсэн газартаа эд мөрийн баримттайгаа баривчлагдсан тохиолдолд л бүрэн эрхийг нь түдгэлзүүлж, хууль тогтоомжийн дагуу хэрэг үйлдсэн эсэхийг нь тогтоох ажиллагааг явуулж болно гэх агуулгыг илэрхийлж байна. Гэтэл эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нь тогтоохын тулд хуульд заасан ажиллагааг явуулах шаардлагатай болдог. Гэмт хэрэг үйлдсэн гэх нотлох баримтад үндэслэн тухайн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсны дүнд хэрэг үйлдсэн эсэх нь тогтоогдож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал гарч ирдэг байтал Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэлгүйгээр энэ ажиллагаа явагдах боломжгүй болж байна. Учир нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно” гэж заасан байна. Иймд хэрэв гишүүний эрхийг түдгэлзүүлэлгүйгээр дээрх ажиллагааг явуулсан тохиолдолд хууль зөрчсөн үйлдэл болно. Нэгэнт хэрэг үйлдсэн болохыг нотлох хангалттай нотлох баримтад үндэслэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгах гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтыг үндэслэн хэрэг үйлдэж байх үед нь, эсвэл хэргийн газарт нь баривчлаагүй л бол гэмт хэрэг үйлдсэн байсан ч түүнийг тогтоох боломжгүй болгож байгаа нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг зөрчиж, гэмт хэрэгтнийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг зөрчсөн гэж үзэх дараах үндэслэл байна. Үүнд:

Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж тус тус заажээ. Гэвч Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дээрх заалтаас үзэхэд энгийн иргэд гэмт хэрэг үйлдсэн бол заавал хэргийн газар нотлох баримттайгаа, гэмт үйлдлийнхээ явцад баривчлагдсан байх шаардлагагүйгээр нотлох баримтад үндэслэн

эрүүгийн хэрэг үүсгэж, буруутай эсэхийг нь тогтоодог. Гэтэл Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн байхад дээрх хуулийн заалтаар халхавч хийж буруутай эсэхийг нь тогтоож, хариуцлага хүлээлгэхээр гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй болж байгаа юм. Иймд Үндсэн хуульд заасан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэсэн заалт зөрчигдөж жирийн иргэн, Улсын Их Хурлын гишүүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлаж байгаа нь дээрх хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн болохыг илтгэж байна. Мөн 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалтыг хүчингүйд тооцсон. Энэ хэсэгт гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлд “гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулсан” гэх заалт хамрагдаж байсан. Гэвч энэ заалтыг хүчингүйд тооцсоноор эрх түдгэлзүүлэх үндэслэл бүхий ганц заалт (6.9.1) үлдэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэлийг хэт явцууруулж, тухайн заалт өөрөө Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн утга агуулгыг илэрхийлж байгаа болно. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Г., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхээр хуульчилсан билээ.

Дээр дурдсан хуулийн “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна гэсэн заалтыг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэснийг тус тус зөрчсөн гэж үзжээ. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийг анх Улсын Бага Хурлаас Монгол Улсын Их Цааз нэртэйгээр ард нийтээр хэлэлцүүлэхээр болсон бөгөөд уг төслийн Гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр (гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний бие, гэр орон, албан тасалгаа, эд хөрөнгө, унаанд халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн тухай асуудал гарвал түүнийг гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар шүүн хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурал уг гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн татаж Улсын Дээд шүүхэд шилжүүлнэ” гэж тус тус заасан байсан. Энэхүү төсөл нь ард нийтийн хэлэлцүүлгээр орж дээрх заалтуудыг өөрчлөн төслийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тухайд гагцхүү Улсын Их Хурлын чуулганаар хянан хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл тогтоовол эгүүлэн татаж шүүхэд шилжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Дараагаар нь дээрх Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийг “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар тэрхүү гишүүний бүрэн эрхийг

түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Ийнхүү гишүүний эрхийг түдгэлзүүлсэн шийдвэр нь шүүхийн шийдвэр гартал хүчин төгөлдөр байна” гэж томъёолсон байсан бөгөөд энэхүү заалтуудыг эцэслэн батлахдаа Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж тус тус баталсан байна. Дээрх томъёолуудыг харахад Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг шууд томъёолж байсан бөгөөд хэлэлцүүлгийн явцад уг асуудлыг Үндсэн хуулийн хэмжээнд томъёолохоо больж “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тусгахаар болж харин гэмт хэрэгт холбогдсон бол хэрхэх тухай асуудлыг Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тусгасан байна.

Халдашгүй байдлыг бусад улс орнууд янз бүрээр авч үздэг бөгөөд манай улсын хувьд энэхүү халдашгүй байдлыг тогтоохдоо дээр дурдсан хэлбэрээр тогтоосон байна. Үүнээс харахад халдашгүй байдлыг анх Монгол Улсын Үндсэн хуулийг батлахад хэрхэн авч үзэж байсан нь ойлгомжтой байгаа бөгөөд халдашгүй байдлыг хэрхэн тогтоох асуудлыг хууль тогтоох байгууллагын бүрэн эрхэд үлдээж өгсөн байна. Иймд одоогийн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг томъёолсон томъёолол нь Үндсэн хууль зөрчсөн томъёолол биш бөгөөд Үндсэн хуульд анх оруулахаар төсөлд тусгаж байсан заалт юм. Монгол Улсын Их Хурал бол хууль тогтоох болон төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд түүний гишүүн болох Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлан ажилладаг тул түүний халдашгүй бүрэн эрхийг Үндсэн хуульд зааж өгсөн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэгш эрхийн зарчмыг алдагдуулаагүй гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль (16 дугаар зүйл), Монгол Улсын Засгийн газрын тухай хууль (25 дугаар зүйл), Шүүхийн тухай (78 дугаар зүйл) хуулиудад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасантай адил агуулгаар тухайн байгууллагын холбогдох албан тушаалтны Үндсэн хууль болон бусад хуульд заасан халдашгүй байдлыг бататган заасан хуулийн заалт байгаа нь тэдгээрийг хувь хүнийнх нь хувьд бус харин эрхэлж буй албан тушаалынх нь хувьд ийнхүү халдашгүй бүрэн эрхийг тогтоож өгдөг байна. Иргэн Э.-гээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн өргөдөлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг зохицуулж байсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалтыг хассанаар хэт явцууруулж байна гэж дурдсан байгаа бөгөөд энэ тохиолдолд явцуурсан байж болох боловч энэ нь Үндсэн хууль зөрчсөн асуудал биш юм.

Ийнхүү үндэслэлүүдээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй тухай тайлбарыг хүргүүлж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэж заасан. Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын



Их Хуралд оруулсан” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтын агуулгыг хэт явцууруулан, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нийтлэг зарчимд харшилсан шинжийг агуулжээ.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “... Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэснийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “... Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэснийг зөрчөөгүй байна.

3. Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 3 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 5 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэхүү тогтоолыг 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэж заасан Улсын Их Хурлын гишүүнийг дэндүү эрх дархтай, хуулиас гадуур амьдрах эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2012.02.15 № 02**

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн Э.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Г., Б.  
**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Р., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч бид уг асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбар хэвээр байгааг онцлоод дараах товч тайлбарыг нэмэлт болгож байна:

1/ Монгол Улсын Үндсэн хуульд тусгайлан халдашгүй байдлыг хуулиар тогтоохыг заасан нь тухайн хүнийг бусдаас ялгаварласан бус, харин тухайн байгууллага, албан тушаалтны чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгосон зохицуулалт юм. Иймд тухайн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгүүдийг зөрчсөн гэх үндэслэл байхгүй гэж үзсэн. “Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх”, “ялгаварлан гадуурхах” гэсэн эрх зүйн ухагдахууны тайлбар ч ингэж дүгнэх үндэслэл болно гэж үзэж байна.

2/ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан тохиолдолд бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчөөгүй бөгөөд энэ хоёр заалтын хооронд зөрчил байхгүй гэж үзэж байна.

Нөгөө талаас уг заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн эцсийн шийдвэр гарсан тохиолдолд тухайн заалт хүчингүй болж үүнтэй адил болон сулруулсан заалт дахин хуулиар тогтоогдох боломжгүй болж Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хэт туйлчилсан хэлбэрт хүргэх үр дагавар үүсэх болно.

### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэж заасан. Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтын агуулгыг хэт явцууруулан, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нийтлэг зарчимд харшилсан шинжийг агуулжээ.

Мөн гэмт хэрэгт холбогдсон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх, улмаар Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоох боломжийг хязгаарлаж байгаа нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх эрүүгийн эрх зүйн суурь зарчим зөрчигдөхөд хүргэсэн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 3 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

3. Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 5 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 3 дугаар дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан” гэсэн нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 3 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 5 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтын зохицуулалттай холбоотой хууль тогтоомжийн талаарх судалгааг уншигч танд толилуулъя.

Нэр	Батлагдсан огноо	Холбогдох зүйл
БНМАУ-ын Бага хурлын тухай хууль / <u>Хүчингүй болсон</u> /	1991.1.4	<p><b>21 дүгээр зүйл. Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа</b></p> <p>2.Улсын Бага Хурлын гишүүнийг Улсын Бага Хурлын зөвшөөрөлгүйгээр /түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилнаас бусад тохиолдолд/ албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний гэр, албан тасалгаа, биед нэгжлэг, үзлэг хийхийг хориглоно.</p> <p>3.Улсын Бага Хурал тухайн гишүүнийхээ халдашгүй дархан эрхийг хөндөх тухай мэдэгдэл хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор албан ёсны хариу өгөөгүй бол холбогдох байгууллага, албан тушаалтан дээрх арга хэмжээг авах эрхтэй. Улсын Бага Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Бага Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.</p>
Монгол Улсын Их Хурлын тухай хууль / <u>энэ хуулийг 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон</u> /	1992.7.6	<p><b>19 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа</b></p> <p>3.Үндсэн хуулийн хорин есдүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлж болно.</p> <p>5.Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тохиолдолд Улсын Их Хурал түүнийг эгүүлэн татах шийдвэр гаргана.</p> <p><b>21 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа</b></p> <p>2.Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр Улсын Их Хурлын гишүүнийг цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.</p>

<p>Монгол Улсын Их Хурлын тухай хууль /<u>энэ хуулийг 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u></p>	<p>1997.2.6</p>	<p><b>21 дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүн, түүний эрх, үүрэг</b> Улсын Их Хурлын гишүүний эрх, үүрэг, бүрэн эрхийн баталгааг Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.</p>
<p>Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль /<u>энэ хуулийг 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u></p>	<p>1997.2.6</p>	<p><b>10 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа</b> 7. Улсын Их Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор нэн даруй мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, биед нь нэгжлэг хийхийг хориглоно. <b>13 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, түүнийг чөлөөлөх, эгүүлэн татах</b> 1. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх, түүнийг чөлөөлөх, эгүүлэн татах эсэх асуудлыг зөвхөн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ. 2. Дараахь тохиолдолд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ: 1/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар баривчлагдсан; 2/ эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд тухайн гишүүнийг сэжигтэнээр цагдан хорих зөвшөөрөл олгохыг хүссэн. 3/ эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд ял сонсгосон бөгөөд түүнийг уагдан хорих зөвшөөрөл олгохыг хүссэн.</p>
<p>Монгол Улсын Их Хурлын тухай хууль /<u>энэ хуулийг 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u></p>	<p>2001.6.21</p>	<p><b>25 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх</b> Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, түүний баталгааг Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.</p>

<p>Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль</p>	<p>2001.06.21</p>	<p><b>1 дүгээр зүйл.</b> Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд дараахь зүйл, заалт, хэсэг, өгүүлбэр нэмсүгэй.  <b>8/ 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэр:</b>  “Ингэхдээ Улсын Их Хурлаас уг асуудлаар ажлын хэсэг байгуулахгүй бөгөөд хяналтын үйл ажиллагаа явуулахгүй.”  <b>2 дугаар зүйл.</b> Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл, заалтыг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай.  <b>5/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтыг:</b>  2/эрх бүхий байгууллага Улсын Их Хурлын гишүүнд холбогдох эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлж өгөхийг Улсын Их Хурлаас хүссэн.</p>
<p>Монгол Улсын Их Хурлын тухай хууль / шинэчилсэн найруулга/</p>	<p>2006.01.26</p>	<p><b>6 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүн</b>  6.9. Дор дурдсан тохиолдолд гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлнэ:  6.9.1. гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;  6.9.2. гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан. /Энэ заалтыг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p>

\* \* \*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2011.12.07 № 04

**Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Э., Ч.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хууль

- 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг "...нийгмийн даатгалын шимтгэл..."
- 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт "Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1"
- 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг "...нийгмийн даатгалын шимтгэл..."
- 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт "...20.1.1, 20.1.2, 20.1.3..."
- 4 дүгээр зүйлийн 4.2 дэх хэсэг "...нийгмийн даатгалын шимтгэл..."
- 4 дүгээр зүйлийн 4.3.11 дэх заалт "...нийгмийн даатгалын шимтгэл..."
- 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг "...нийгмийн даатгалын шимтгэлийн..., шимтгэл ногдох..."

#### **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй"
- Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй"

#### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

1/ 2007 оны Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1.1-д зааснаар уг хууль нь зарим албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуульд заасан албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, мөн түүнчлэн хариуцлага /эрүү, иргэн, захиргааны/-аас чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой юм байна. Ийнхүү уг хуулиар Нийгмийн даатгалын тухай хуульд заасан нийгмийн даатгалын шимтгэл, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл хугацаандаа төлөгдөөгүйн улмаас тооцох алдангийг /иргэний хариуцлага/ тус тус чөлөөлөхөөр заасан нь нийгмийн даатгалд даатгуулагч иргэний Үндсэн хуулиар баталгаажсан эрхэд ноцтой хохирол учруулсан байна.

Монгол Улсын аливаа иргэний Үндсэн хуулиар баталгаажсан "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах" эрхээ хэрэгжүүлэх гол үндэслэл нь нийгмийн даатгалын тодорхой сангуудад тухайн иргэн буюу ажилтан даатгагдсанаар буюу мөнгөн хөрөнгө төвлөрүүлснээр үүсдэг. Нийгмийн даатгалын санд төвлөрүүлж байгаа энэхүү мөнгөн хөрөнгийг Нийгмийн даатгалын тухай хуульд "нийгмийн даатгалын шимтгэл" гэж томъёолдог. Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын шимтгэлээр бүрдсэн нийгмийн даатгалын сан нь иргэн буюу ажилтны дээр дурдсан Үндсэн хуульд заасан эрхийн баталгаа болдог. Ийнхүү Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх үүднээс даатгуулагч иргэн нь нийгмийн даатгалын сангуудад төвлөрүүлж буй /тодорхой тохиолдолд өөрийн нэр дээр/ нийгмийн даатгалын шимтгэлээ ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд хөдөлмөрийн хөлсний 10 хувиар тооцон өөрөө, 10 хувиар тооцон ажил олгогчоор төвлөрүүлдэг билээ. Үүнээс үзэхэд ажилтан буюу иргэний нэрийн өмнөөс тэдгээрийн нэр дээр болон нийтлэг байдлаар даатгалын санд зохих нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хэмжээгээр буюу ажилтны цалингийн 10 хувиар төвлөрүүлэх нь ажил олгогчоос ажилтан буюу иргэний өмнө /төрийн өмнө бус/ хүлээсэн үүрэг байна.

Гэтэл 2007 оны Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулиар иргэн буюу ажилтны нэрийн өмнөөс ажил олгогчийн нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх үүргээс төр чөлөөлсөн нь тэтгэврийн нэрийн данстай иргэн буюу ажилтан бүрийн, бусад тохиолдолд сангийн хуримтлалыг үүсгэсэн нийт иргэн буюу ажилтны "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах" Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг

зөрчжээ. Иргэн буюу ажилтны нэрийн өмнөөс төр хууль гаргах замаар ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргээс чөлөөлснөөс шалтгаалж иргэн буюу ажилтны тэтгэврийн нэрийн данс, түүнчлэн нийгмийн даатгалын санд чөлөөлөгдсөн хөрөнгийн хэмжээгээр хоосон орон зай үлдэж байгаа бөгөөд энэхүү хөрөнгийг төр нөхөн төлөх үүрэг хүлээгээгүй байна.

2/ Нийгмийн даатгалын хуульд зааснаар нийгмийн даатгал нь “тэтгэврийн”, “тэтгэмжийн”, “эрүүл мэндийн”, “үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний”, “ажилгүйдлийн” гэсэн даатгалын төрөлтэй байдаг. Эдгээрээс “үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ыг ажил олгогч бүрнээ төлөх үүрэгтэй байтал нийгмийн даатгалын шимтгэл гэсэн ерөнхий томъёоллын дор үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл чөлөөлөгдөж байгаагийн улмаас уг санг бүрдүүлдэг, нийгмийн нийт даатгуулагчдын эрх ашигт нийцэхгүй байна. Нэгэнт “үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэл төлөгдөөгүй тул төлөх ёстой байсан иргэн буюу ажилтан тухайн сангаас даатгалын тохиолдол болсон үед мөнгөн хөрөнгө буюу даатгалын эргэн төлбөр шаардах эрхгүй болж байна. Хэрэв шаардан авах эрхтэй гэж үзэхэд энэ нь бусад “үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэл төлж уг санг бүрдүүлдэг нийт даатгуулагч иргэн буюу ажилтны эрх ашигт нийцэхгүй байна. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд зааснаар 1960 оноос хойш төрсөн иргэн буюу ажилтан нь тэтгэврийн даатгалын санд өөрийн нэр дээр тэтгэврийн данстай бөгөөд тухайн нь дансанд нь өөрийнх нь болон ажил олгогчоос төлсөн мөнгөн хөрөнгө тэтгэврийн даатгал болон хуримтлагдах болсон. Гэтэл нийгмийн даатгалын буюу тэтгэврийн даатгалын шимтгэлээс ажил олгогчийг чөлөөлөх тухай холбогдох хуульд зааснаас шалтгаалж эдгээр иргэдийн дансанд цугларах ёстой мөнгөн хөрөнгө, хуулиар чөлөөлөгдсөн хэмжээгээр багасч байгаа нь тухайн иргэдийн өндөр насалсны дараа эд, мөнгөний тусламж авах эрхийг зөрчсөн гэж үзнэ. Харин 1960 оноос өмнө төрсөн иргэн буюу ажилтны хувьд тэтгэврийн даатгал төлсөн хугацаа нь ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлснөөс шалтгаалан багасч болзошгүй байгаа бөгөөд хамгийн өндөр шимтгэл төлж байсан дараалсан 5 жилээр тэтгэврээ тогтоолгох боломж үгүйсгэгдэж болзошгүй.

Нийгмийн даатгалын ерөнхий томъёолол дор нийгмийн даатгалын бусад төрөл болох “тэтгэмжийн”, “эрүүл мэндийн”, “ажилгүйдлийн” даатгал хамаарч байгаа ба эдгээр даатгалд төлөгдөх мөнгөн хөрөнгө мөн чөлөөлөгдсөнөөр тухайн иргэн буюу ажилтны даатгалын улмаас эд мөнгөний тусламж авах эрхээ алдах болж байна. Хэрэв тухайн иргэн буюу ажилтан “тэтгэмжийн”, “эрүүл мэндийн”, “ажилгүйдлийн” даатгалын сангаас эд мөнгөний тусламж авах боломжтой, эсхүл тухайн иргэн буюу ажилтанд даатгалын тохиолдол үүсээгүй байлаа ч сангуудыг бүрдүүлдэг нийт даатгуулагч иргэн буюу ажилчны эрх ашигт нийцэхгүй юм. Аливаа даатгалын сан нь тодорхой хөрөнгийг өөртөө цугларуулж, даатгалын тохиолдол үүсвэл тухай бүрт нь даатгалын эрсдлийг хариуцах, даатгалын тохиолдол үүсээгүй бол ирээдүйд бий болох эрсдлийг “өөртөө” үүрэн даатгалын шимтгэл төлөгчдийн хөрөнгөөр улам бүр нэмэгдэх зүй тогтолтой байдаг. Гэтэл зарим ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргээс “өршөөсөн нь” нийгмийн даатгалын сангууд буюу эдгээр сангаар баталгааждаг иргэний Үндсэн хуулиар баталгаажсан эрхэд тодорхой хэмжээний хохирол учруулсан гэж үзнэ.

3/ 2011 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын эдийн баялагтай холбогдсон харилцаа нь захиргааны хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа тул энэ төрлийн эдийн баялагтай холбогдсон харилцаанд Иргэний хууль үйлчлэхгүй гэж үзнэ. /Иргэний хуулийн 1.3/ Өөрөөр хэлбэл нийгмийн даатгал шимтгэл төлүүлэхтэй холбогдсон шаардах эрх хэрэгжихэд Иргэний хууль үйлчлэхгүй. Нэгэнт Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийг шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоогоогүй, энэ харилцаанд Иргэний хууль үйлчлэхгүй тул нийгмийн даатгалын шимтгэлийг шаардах эрх хугацааны хязгаарлалтгүй.



Нийгмийн даатгалын тухай хуулийн 18.1.2, 18.4-т заасанчлан ажил олгогч татан буугдсан, дампуурсан тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг “автомат”-аар дуусгавар болдог. Дээрхээс үзэхэд “эргэж төлөгдөх найдваргүй өр” гэсэн ойлголт нийгмийн даатгалын эрх зүйд байхгүй болно. Харин ажил олгогч буюу нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь төлбөрийн чадваргүй байгаа нь нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд тухайн этгээд хөрөнгөтэй болсон хугацаанаас эхлэн “өр”-өө төлөх үүргийг төлбөр авагч буюу нийгмийн даатгалын сан, даатгуулагчийн өмнө хүлээнэ.

4/ “Алданги” гэдэг нь эд мөнгөнөөс үүсдэг иргэний хариуцлага. Төр буюу Улсын Их Хурлаас өршөөх эд мөнгөнөөс үүдэлтэй иргэний хариуцлагаас чөлөөлөх эрх хэмжээ нь өөр /төр/-ийн өмчлөх эрхэд хамааралтай эд мөнгөөр хязгаарлагдана гэж үзнэ. Нийгмийн даатгалын санд төвлөрсөн мөнгөн хөрөнгө нь төрийн өмч биш бөгөөд нийт нийгмийн даатгал төлөгчдийн мөнгөн хөрөнгө тул нийгмийн даатгалын санд төлөх мөнгөн хөрөнгийн хугацаа хэтрүүлсэн алдангийг Улсын Их Хурал өршөөх хууль ёсны өмчлөгчийн эрх байхгүй гэж үзнэ. Нийгмийн даатгалын санд хуримтлагдсан мөнгөн хөрөнгө болоод иргэн буюу ажилтны дансан дээр байгаа мөнгөн хөрөнгө нь эрх бүхий этгээдийн бизнесийн үйл ажиллагаагаар “өсч” байдаг. Ийнхүү мөнгөн хөрөнгө нь өсөх боломжийг хааж, хугацаандаа төлбөрөө төлөөгүй этгээдэд иргэний хариуцлага ногдуулах /шаардах/ нь тухайн сан буюу сангийн үйл ажиллагааг эрхлэгч этгээд, цаашлаад нийт даатгуулагчийн бүрэн эрх. Гэтэл төр өөрт хамааралгүй мөнгөн хөрөнгөнөөс үүдэлтэй иргэний хариуцлагаас, нийгмийн даатгалын сан, даатгуулагчдын өмнө хариуцлага хүлээх этгээдийг “өршөөсөн” нь нийгмийн даатгалын сангуудыг тодорхой мөнгөн хөрөнгөөр хохироож, цаашлаад нийгмийн даатгалын сангаар баталгааждаг иргэний эрхийг зөрчсөн гэж үзнэ.

2007 оны Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1.1-д “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 3.1.5-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1”, 3.2-т “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 4.1.5-д “...20.1.1, 20.1.2, 20.1.3...”; 4.2-т “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 4.3.11-д “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 6.2-т “...нийгмийн даатгалын шимтгэлийн..., шимтгэл ногдох...” гэж тус тус заасан байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах... эрхтэй”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасныг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.

2. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Э., Ч нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг тус тус 2006 онд, түүнчлэн Татварын ерөнхий хууль, Онцгой албан татварын тухай хуулийг 2008 онд батлан мөрдүүлж хүн амын орлого, амьжиргааны түвшинг татвартай уялдуулах, татварын суурийг өргөтгөх, татвар тэгш, шударга байх зарчмыг хэрэгжүүлэх, салбараар ялгаварласан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах чиглэлээр татварын эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлжээ.

Ийнхүү татвартай холбогдсон харилцааг иж бүрнээр шинэчилж боловсронгуй болгосонтой холбогдуулан хувийн хэвшлийн аж ахуй эрхлэгч нарт татварын хуулийн орчинд үйл ажиллагаагаа эрхлэх, олсон орлогоо татвараас нуухгүй байх, хөрөнгөө эдийн засгийн эргэлтэд ил тодоор оруулах боломж олгох зорилгоор татварын өршөөлийн асуудлыг шийдвэрлэхээр Улсын Их Хурлаас тогтоосон билээ. Тухайлбал, энэ асуудал Улсын Их Хурлын 2005 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгалаа олсон болно. Дээр дурдсан шийдвэрийн заалтыг үндэслэн татварын болон нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн аж ахуйн хөгжлийг

дэмжихэд чиглэсэн татварын орчин бүрдүүлэх, далд эдийн засгийг багасгах үүднээс нэг удаагийн арга хэмжээ болгон Улсын Их Хурлаас 2007 онд Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай, улмаар 2008 онд Татварын өршөөл үзүүлэх тухай хуулийг тус тус баталсан болно.

Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргагч Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.5, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт буюу 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд ажил олгогчоор бүртгүүлсэн байвал зохих, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг нуун дарагдуулсан иргэн, хуулийн этгээд дээр дурдсан хууль батлагдсан өдрөөс хойш 6 сарын дотор нийгмийн даатгалын орон нутгийн салбарт бүртгүүлсэн, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчилсэн тайлангаа гаргаж ийнхүү салбарт мэдүүлсэн бол Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хариуцлагаас чөлөөлөгдөхөөр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэжээ.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5, 6-д заасан хүний эрхийг зөрчөөгүй нь дараахь үндэслэлтэй болно.

Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулиар “Монгол Улсын нэгдсэн төсөв нь Монгол Улсын төсөв, орон нутгийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэхээр” заасан юм. Улмаар нийгмийн даатгалын сангийн төсөв гэдэгт Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эх үүсвэрээр бүрдэж, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу зарцуулагдах тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг олгохоор хуульчилсан болно. Өөрөөр хэлбэл төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцэл нь Монгол Улсын нэгдсэн төсөв байна. Иймд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал баталж байхаар хуульчлагдсан билээ. Улмаар сайн дураар бүртгүүлсэн албан татвар төлөгчийг холбогдох хуульд заасан хариуцлагаас, түүнчлэн албан татвар төлөхөөс төр өөрийнхөө бодлогоор чөлөөлөх боломжтой билээ. Тэгвэл үүнтэй адилтган улсын төсвийг бүрдүүлдэг албан татварын нэг адил нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс ажил олгогчийг нэг удаа чөлөөлж улмаар нөхөн ногдуулахгүй байх асуудлыг хуульчилсан юм.

Хоёрдугаарт, Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулиар иргэн, хуулийн этгээдийг нийгмийн даатгалын төлбөр төлөхөөс, түүнчлэн Татварын өршөөл үзүүлэх тухай хуулиар нийгмийн даатгалын өр, төлбөрийн тодорхой хувиас нэг удаа л чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа болно. Энэ бол ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс бүрэн бөгөөд тогтмол хугацаанд чөлөөлж байгаа асуудал биш юм.

Гуравдугаарт, Нийгмийн даатгалын тухай хуульд даатгуулагчийн болон бусад иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан өөр бусад зохицуулалт байгаа билээ. Жишээлбэл, дээр дурдсан хуулийн 6 дугаар зүйлд заасанчлан ажил олгогчийн буруугаас нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй нь тухайн даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд тэтгэвэр, тэтгэмж олгохгүй байх үндэслэл болохгүй. Энэ шалтгааны улмаас даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч Иргэний хууль тогтоомжийн дагуу хариуцахаар үүрэг хүлээж байгаа болно. Улсын дээд шүүхийн 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 47 дугаар тогтоолд тухайн асуудлаар “ажил олгогч бүрэн хариуцна” гэж ажил олгогчийн буруутай ажиллагаанаас шалтгаалан даатгуулагч болон түүний гэр бүлийн гишүүдэд нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын дагуу тэтгэвэр, тэтгэмж олгогдох үндэслэлгүй болсон бол олгогдвол зохих

тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээгээр, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ багассан, олгогдох хугацаа хойшлогдсон бол зөрүүгээр, хохирсон этгээдээс гарсан нэмэгдэл зардлын хэмжээгээр ажил олгогч Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн холбогдох зохицуулалтаар эд хөрөнгийн хариуцлага хүлээхийг хэлнэ гэж тодорхой тайлбар гаргажээ.

Иргэн А. мэдээлэлдээ даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлж байх ёстой боловч ийнхүү шимтгэл төлөхөөс чөлөөлөгдөж байгаа нь “нийгмийн нийт даатгуулагчдын эрх ашигт нийцэхгүй бөгөөд Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхэд ноцтой хохирол учруулсан байна” гэжээ.

Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлж байхаар зохицуулагдсан билээ. Улмаар Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг өмчлөлийн хэлбэрээс үл хамааран хоёр хувиар төлөх ажил олгогчийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний чиглэлийг батлан мөрдүүлжээ. Даатгуулагч даатгалын тохиолдол үүссэн бөгөөд ажил олгогчийн буруугаас өөрт нь учирсан хохирлоо Иргэний хуулийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж арилгуулах бүрэн боломжтой юм. Хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас буй болсон хохирлыг ажил олгогч барагдуулахаар зохицуулагдаж байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасанчлан ажил олгогч нь дээр дурдсан тохиолдол үүссэн нөхцөлд нийгмийн даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд ийнхүү чадвар алдалтын хувь хэмжээнээс нь шалтгаалж 5 сараас 18 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно.

Түүнчлэн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой /51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээд татан буугдсан, төлбөрийн чадваргүй болж дампуурсны улмаас хариуцагчгүй болсон тохиолдолд ажилтанд олгох нөхөн төлбөрийн асуудлыг Засгийн газар, нутгийн захиргааны байгууллага тусгайлан шийдвэрлэж болно. Улсын Их Хурлаас 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг баталсан билээ. Энэхүү хуулиар аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.0 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулж байхаар үүрэг болгов.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Нийгмийн даатгалын шимтгэл нь нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд даатгалын санд төлж буй урьдчилсан төлбөр бөгөөд тухайн шимтгэлийг төлсөн байх нь даатгуулагчийн хувьд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах хуулиар олгогдсон эрхээ эдлэх үндэслэл болно.

Харин Улсын Их Хурал 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 3 дугаар зүйлийн 3.1.5-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1.”, мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “... нийгмийн даатгалын шимтгэл ...”, мөн зүйлийн 4.3.11-д “нийгмийн даатгалын шимтгэл.” гэж тус тус заахдаа ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх хуулиар тогтоосон үүргээс чөлөөлөхдөө даатгуулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг

зохицуулалтгүй үлдээсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэсэн заалтад харшилж, олгогдвол зохих тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг авч чадахгүй болох, эсхүл тогтоогдвол зохих тэтгэвэр тэтгэмж бага хэмжээгээр тогтоогдох зэргээр даатгуулагчийн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх зөрчигдөхөд хүргэсэн гэх үндэслэлтэй байна.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэлийн...”, мөн “...шимтгэл ногдох...” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 3 дугаар зүйлийн 3.1.5-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1.”, мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэл...”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэл...”, мөн зүйлийн 4.3.11-д “нийгмийн даатгалын шимтгэл” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “...нийгмийн даатгалын шимтгэлийн...”, мөн “...шимтгэл ногдох...” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6-д “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй.” гэснийг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 3 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1”, мөн

зүйлийн 3.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэл”, мөн зүйлийн 4.3.11 дэх заалтын “нийгмийн даатгалын шимтгэл” гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтын “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, мөн зүйлийн 6 дахь заалтын “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтэд заасныг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 7-д зааснаар төрийн санхүү, албан татварын үндсэн чиглэлийг тодорхойлох, Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т зааснаар татварыг чөлөөлөх бүрэн эрхтэй. Гэхдээ Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулиар нийгмийн даатгалын санд төвлөрөх ёстой байсан нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлснөөрөө иргэдийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг зөрчиж байгаа юм.

Учир нь Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалд даатгуулсан иргэн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй байдаг.

\* \* \*

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

**2012.2.8 № 01**

**Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

**Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн А.;  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Б., Э.

**Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч - Б., Э. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч нарын тайлбар, үндэслэл, саналаас өөр нэмэлт болгох үндэслэл үгүй байна.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 4 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын гишүүд дараах санал гаргаж байв. Үүнд:

Татварын эрх зүйн орчинг шинэчлэн боловсронгуй болгосон явдал үүний дотор олон шатлалтай тогтолцооноос нэг шатлалтай тогтолцоонд шилжүүлсэн нь аж ахуйн нэгж, байгууллагаас эрхэлж буй үйл ажиллагаагаа татварын байгууллагад бүртгүүлж, давхар баланс хөтөлдөг тогтсон жишгийг халж, далд эдийн засгийг ил тод болгоход тус дөхөм болсон явдал билээ. Үүнийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагыг албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлээс Монголын төр нэг удаа чөлөөлж, өршөөл үзүүлсэн нь өөрөө зөв арга хэмжээ болсон гэж үзэж байна. Тухайлбал, энэ асуудлыг шийдсэнээр Монгол Улсад 4 их наяд, 510 тэрбум 887 сая төгрөг ил болжээ.

Харин 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд албан татвар төлөгч, ажил олгогчоор бүртгүүлсэн байвал зохих иргэн, хуулийн этгээд 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш 6 сарын дотор сайн дурын үндсэн дээр холбогдох алба, салбар нэгжид бүртгүүлсэн бол албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс нэг удаа чөлөөлсөн харилцаа өөрөө Үндсэн хуулийн зөрчлийн харилцаа биш юм. Гэвч ийнхүү харилцаанаас иргэн хохирсон тохиолдолд тухайн хохирлыг нь төр хариуцаж барагдуулах зарчим үйлчлэх ёстой билээ. Өөрөөр хэлбэл, зохицуулах ёстой байсан харилцааг хуулиар зохицуулахгүй орхигдуулж иргэнийг хохироосон нь Улсын Их Хурлын алдаа болжээ. Улмаар хуулийн зохицуулалтгүй үлдээсэн хэм хэмжээний хийдлээс болж хохирсон иргэдийг ямар арга механизмаар хохирлыг нь барагдуулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй бөгөөд ийнхүү зохицуулалтгүй үлдээсэн харилцааг зохицуулсан шийдвэрийг төр нөхөж гаргах шаардлагатай билээ.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.2, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.2, 4.3.11, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчөөгүй болно.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

Хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлж, нийгмийн даатгалд хамрагдах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалт, мөн зүйлийн 6 дахь заалтад заасан эд мөнгөний тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах иргэний эрх хангагдах нэг баталгаа болно.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан хуулиар уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх хуульд заасан үүргээс чөлөөлөхдөө даатгуулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг орхигдуулж, улмаар даатгуулагчийн нийгмийн даатгалд хамрагдах эрхийг хязгаарласан нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "...нийгмийн даатгалын шимтгэл...", 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1.", мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт "...нийгмийн даатгалын шимтгэл...", 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн "... нийгмийн даатгалын шимтгэл...", мөн зүйлийн 4.3.11-д "нийгмийн даатгалын шимтгэл" гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтын "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй", мөн зүйлийн 6 дахь заалтын "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй" гэснийг тус тус зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 4 дүгээр дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурал 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийг батлан гаргахдаа уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "...нийгмийн даатгалын шимтгэл...", 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1.", мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт "...нийгмийн даатгалын шимтгэл...", 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт "...нийгмийн даатгалын шимтгэл...", мөн зүйлийн 4.3.11-д "нийгмийн даатгалын шимтгэл" гэж тус тус зааж, ажил олгогчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөх хуулиар тогтоосон үүргээс чөлөөлөхдөө даатгуулагчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг зохицуулалтгүй үлдээснээрээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтын "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй", мөн зүйлийн 6 дахь заалтын "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй" гэснийг тус тус зөрчсөн байх тул Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн дээрх зүйл, заалтын холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2011 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай" 3 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

#### **Тэмдэглэл:**

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны явцад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчид Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтын улмаас зарим иргэд хохирсон гэдгийг хүлээн зөвшөөрсөн ба иргэдэд учирсан хохирлыг төр барагдуулах учиртай гэж байсан.

Гэхдээ хохирсон иргэдийн тэтгэвэр, тэтгэмж авах эрхийг сэргээх болсноор Үндсэн хуулийн зөрчилтэй байсан хууль зөрчилгүй болно гэсэн үг биш юм.

\* \* \*

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

**2011.12.27 №05**

**Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт  
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

#### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн М.;

Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч - Геологийн бодлогын газрын орлогч дарга Б., Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны байгалийн нөөцийн газрын дарга Э.

## **Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:**

Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 299 дүгээр тогтоол

- 3 дахь заалт “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг зогсоохыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасугай”

## **Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:**

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”,

- Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”,

- Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”

- Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”

- Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”

- Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”

- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах”

## **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Иргэн М.-ийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурал 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталсан.

Гэхдээ уг хуулийн биелэлтийг хангах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх зохицуулалт шаардлагатай олон харилцаа болон үр дагаврын асуудлыг уг хууль болон уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулаагүй орхисон. Тухайлбал, ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг цуцлах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хэрхэн хамгаалах, нөхөх олговрын үнэлгээг хэн, ямар шалгуур, аргачлалыг баримтлан, ямар хүчин зүйлсийг харгалзан тогтоовол зохих, нөхөн олговрыг төлж барагдуулах хэлбэр, нөхцөл зэрэг олон чухал асуудлыг зүй нь дээрх хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай байсан боловч Засгийн газар холбогдох журмыг гаргана гэх нэрээр хууль тогтоогч асуудлыг нээлттэй орхижээ.

Мөн түүнчлэн Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө мөн



хуулийн 4.3-т заасан хилийн заагийн дотор олгогдсон тусгай зөвшөөрлийг энэ хууль батлагдсанаас хойш 5 сарын хугацаанд цуцална” гэж заасан байх боловч Засгийн газар нөхөх олговор олгох журмыг дөнгөж 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 299 дүгээр тогтоолоороо баталсан.

Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалтад “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг зогсоохыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасугай” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3, Зургадугаар зүйлийн 4, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2, Арван зургадугаар зүйлийн 3, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн Үндсэн хуулийн бус буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэр болсон байна. Эдгээрийн хууль зүйн үндэслэлийг нэг бүрчлэн доорхи байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

Нэг. Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчсөн тухай:

Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж тус тус заажээ.

Үндсэн хуулийн үзэл санаа, зохицуулалтын дагуу төр, түүний байгуулал нь эрх мэдлийн гурван салаа мөчрийн нэгдэл байх бөгөөд түүний нэгэн салаа мөчир нь гүйцэтгэх эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч институци нь Засгийн газар билээ. Иймд энд дурдагдаж буй төр гэдэгт Засгийн газар хамаарна. Үндсэн хуулийн эл заалтын дагуу өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах, өмчлөгчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх, зөрчихгүй байх үүрэг Засаг газарт ногдож байна.

Олон улсын хэмжээнд тогтсон ойлголтоор ашигт малтмал эрэх /mineral prospecting or search from mineral or placer mineral/, хайх /mineral exploration/ үйл ажиллагаа явуулах, эл ажлын үр дүнд олж илрүүлсэн ашигт малтмалыг олборлох / mineral mining/, улмаар боловсруулах буюу үйлдвэрлэх /the production of a mineral or placer mineral/ зэрэг үйл ажиллагааг нийтэд нь mining activity буюу олборлох үйл ажиллагаа гэдэг ажээ.

Дээр дурдсан үйл ажиллагааг эрхлэх эрхийг олборлох эрх буюу mining right гэнэ. Уг эрхийг үнэлж, бусдад шилжүүлж, барьцаалж болдог явдал нь түүнийг эдийн засгийн эргэлтэд ордог хөрөнгө буюу өмчлөлийн зүйл байж болохыг нотолж байгаа хэрэг юм. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олж авсан олборлох эрх тухайн этгээдийн субъектив эрх буюу өмчлөх эрхэд хамаарах бөгөөд Үндсэн хуулийн дээрх зүйл заалтын дагуу хуулиар хамгаалагдана. Тэгэхээр олборлох эрхийг хамгаалах, хүндэтгэх, зөрчихгүй байх үүрэг Засгийн газарт ногдоно. Олборлох эрх бүхий этгээд буюу өмчлөгч этгээд өөрөө хүссэн /бусдад худалдсан гэх мэт/, эсхүл уг эрхийг хүчингүй болгоход хүргэх үр дагавар бүхий зөрчил гаргаснаас бусдаар өмчлөх эрхийг хязгаарлах, дуусгавар болгох тохиолдолд энэ тухай тусгайлсан хууль гаргах буюу хуульд эрхийг хязгаарлах, дуусгавар болгох үндэслэлийг заах шаардлага зүй ёсоор тавигддаг.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.6-д “Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно” гэж заасан. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.3-т “хайгуулын болон уурхайн талбайг энэ хуулийн 13.1.3-т заасны дагуу нөөц болон тусгай хэрэгцээнд авах нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн” бол тусгай зөвшөөрлийг цуцлахаар заажээ. Аливаа субъектив эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр, хуульд заасан журмын дагуу хязгаарлаж, түүнд халдаж болно. Олборлох эрх нь дээрх өгүүлсэнчлэн өмчлөлийн зүйл болох учир гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу, зохих нөхөх олговор олгосны үндсэн дээр уг эрхийг хязгаарлах буюу дуусгавар болгоно. Иймд Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлээр нөхөх олговрын үнэлгээг тооцоолон тогтоож, тогтоосон хэмжээний нөхөх олговрыг олгохоос өмнө олборлох эрх бүхий этгээдийг “...уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг...” тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулахыг хориглосон нь бодит байдалд олборлох эрх буюу тусгай зөвшөөрлийг цуцалснаас өөрцгүй үр дагаврыг бий болгож байх бөгөөд ингэснээрээ Засгийн газар өөрт нь хуулиар ногдуулсан үүргийг “зөрчиж гүйцэтгэсэн”, Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтуудыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

Хоёр. Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн тухай.

Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэжээ.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно”, мөн зүйлийн 4.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй” гэж тус тус заажээ.

Хуулийн дээрх заалтаас үзэхэд дурдсан шинж байдал бүхий газар нутагт аливаа төрлийн ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, харин энэхүү хориглолтод гагцхүү стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд л хамаарахгүй ажээ. Гэтэл Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалтад “...бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт... үйл ажиллагаа зогсоохыг...” хэмээн зөвхөн алт, тэр дундаа шороон ордод олборлох эрхээ хэрэгжүүлж байгаа этгээдүүдэд хамааралтай байдлаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлж байгаа нь хүн бүр хууль, шүүхийн эрх тэгш байх, аливаа ялгаварлан гадуурхлаас ангид байх хүний эрх, эрх чөлөөний тулгуур баталгааг үгүйсгэж, зөрчсөн үйл ажиллагаа болсон байна.

Гурав. Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг тус тус зөрчсөн тухай.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх

заалтад “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллага бөгөөд төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүрэгтэй байгууллага юм. Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоол нь уг тогтоолыг гаргах үндэслэл болсон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуультай нийцээгүй, уг хуулиар олгогдоогүй эрхийг эдэлж, уг хуулиар ногдуулсан үүргийг зөрчиж гүйцэтгэсэн шийдвэр болсон. Засгийн газар нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх зарчмыг хөдөлбөргүй баримтлан ажиллах үүрэгтэй боловч энэ тохиолдолд ингэж ажилласангүй. Засгийн газрын 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь уг тогтоолыг гаргах үндэслэл болсон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг зөрчиж, олборлох эрх бүхий этгээдийг ялгаварлан гадуурхаж, зөвхөн алтны шороон ордод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн үйл ажиллагааг хориглон зогсоосон, нөхөх олговрыг олгохоос тусгай зөвшөөрлийг цуцалснаас өөрцгүй үр дагавар бүхий хориглолтыг тогтоосон хууль бус үйл ажиллагаа юм.

Иймд Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 болон 3, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2, Нэгдүгээр зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг тус тус зөрчсөн болохыг тогтоолгох шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргаж байна.

#### **2. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Б., Э. нарын тайлбарын агуулга:**

Алтны шороон ордын үйл ажиллагааг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно” гэж заасныг үндэслэн зогсоосон. Ийнхүү зогсоохоос өмнө 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор хилийн заагийг хэсэгчлэн тогтоосон. Ашигт малтмалын газраас өгсөн 254 зөвшөөрөл бүхий алтны шороон ордын жагсаалтын дагуу бид энэ шийдвэрийг гаргасан. Хуулийн дагуу таван сарын хугацаанд хийж гүйцэтгэх ёстой ч Засгийн газрын нөөц бололцоо, хүн хүч хүрэлцээгүй учраас бид хилийн зааг тогтоох ажлыг 2 жилийн хугацаанд хийж дуусгасан.

Энэ хуулийн хүрээнд Засгийн газраас гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг тогтоох, хилийн заагт ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох, байгаль орчныг нөхөн сэргээх, нөхөн олговор олгох журам баталж, хэрэгжүүлэх зэрэг ажлыг үе шаттайгаар хийх үүргийг холбогдох яам, агентлагт өгч, хяналт тавьж ажиллаж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Засгийн газрын “Журам батлах тухай” 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 299 дүгээр тогтоолын 3-т “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр

олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг зогсоохыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасугай” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын “Журам батлах тухай” 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 299 дүгээр тогтоолын 3 дахь заалтад “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг зогсоохыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасугай” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах”, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

#### **Тэмдэглэл:**

Засгийн газрын “Журам батлах тухай” 2010 оны 299 дүгээр тогтоол нь Улсын Их Хурлаас 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хүрээнд, түүнийг хэрэгжүүлэх үүднээс гарсан тогтоол юм.

Харин Засгийн газар нь Улсын Их Хурлаас 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан 5 сарын хугацаанд тусгай зөвшөөрлийг цуцлах, нөхөн олговрыг олгох ажлыг зохион байгуулж амжаагүй юм.

Миний бодлоор хууль тогтоогчоос баталсан “5 сарын хугацаа” нь өөрөө дээрх ажлыг гүйцэтгэхэд хангалтгүй, богино хугацаа байсан.

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2012.01.25 № 01

## Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч - Монгол Улсын иргэн У.;  
Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын  
дэд сайд Г.

### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Монгол Улсын Засгийн газрын “Ахмад дайчдын орон сууцны тухай” 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоол

- 3 дахь заалт “Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх...”

### Үндсэн хуулийн зөрчигдсөн гэх зүйл, заалт

- Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах...”

### Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

#### 1. Иргэн У.-гийн мэдээллийн агуулга:

Газрын тухай хууль болон Газрын тухай хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудад газар эзэмших эрх олгохдоо бусдын өмчлөлийн зүйлийг авах талаар ямар нэгэн зохицуулсан эрх зүйн акт байхгүй билээ. Иймээс Засгийн газар дээрх тогтоолыг гаргасан нь Үндсэн хуулийн энэхүү заалтыг зөрчиж байна гэж үзэх үндэслэл болж байна. Газрын тухай хуульд газар эзэмших, ашиглах эрхийг иргэн аж ахуйн нэгж байгууллагад олгох журмыг хуульчилсан байдаг бөгөөд энэхүү хуульд уг газрыг ашиглахад ашиглаж байгаа этгээдийн хөрөнгөөс үнэ төлбөргүй гаргуулах талаар зохицуулалт байхгүй билээ. Гэтэл Засгийн газар тогтоол гаргахдаа ямар нэгэн хуульд үндэслэлгүйгээр эрх хэмжээгээ хэтрүүлэн гаргасан байна. Иймд хууль зүйн үндэслэлгүй 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Ахмад дайчдын орон сууцны тухай” тогтоол нь Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Засгийн газар бодлого хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн гаргах ёстой юм. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Засгийн газар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоол гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг иш үндэс болгоно” гэж заасан байдаг. Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоол нь тодорхой хэм хэмжээ тогтоосон байх бөгөөд үүнийг нийтээр даган мөрдөх шинжтэй акт байна.

#### 2. Засгийн газрын итгэмжилсэн төлөөлөгч Г.-гээс ирүүлсэн тайлбарын агуулга:

Монгол Улсын Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Тухайлбал: Засгийн газрын тухай хуулийн

9 дүгээр зүйлийн 5-д "... хүн амын бодлого, ... ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх...", мөн зүйлийн 6-д "...иргэдийн ахуй, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах" нь Засгийн газрын үндсэн бүрэн эрхэд хамаарахаар заасан байна. Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын 3 дахь заалт нь улсаас орон сууц авч байгаагүй ахмад дайчид болон бага орлоготой иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, эдгээр иргэдийг орон сууцаар хангах зорилгоор орон сууцны фонд бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм. Засгийн газар нь ахмад дайчдыг орон сууцтай болгох ажлын хүрээнд дээрх тогтоол болон "Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай" Засгийн газрын 2009 оны 212 дугаар тогтоол, "Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 170 дугаар зарлигийн дагуу 2011 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1600 гаруй ахмад дайчдад орон сууцны дэмжлэг үзүүлээд байгаа болно.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл, тогтоох хэсгийн агуулга:**

Монгол Улсын Засгийн газрын "Ахмад дайчдын орон сууцны тухай" 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоолын 3 дахь заалтад "Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх..." гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын "Ахмад дайчдын орон сууцны тухай" 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 250 дугаар тогтоолын 3 дахь заалтад "Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад орон сууц барих зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа барих орон сууцны 2.0 хувийг үнэ төлбөргүйгээр, 20.0 хүртэл хувийг өөрийн өртгөөр нь тооцож тусгай санд шилжүүлэх..." гэж заасан нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах..." гэснийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

### **Тэмдэглэл:**

1. Үндсэн хуулийн цэц дээрх дүгнэлтийг гаргахдаа Үндсэн хуулийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна гэснээс өөр тайлбар хийгээгүй. Мэдээлэл гаргагч У. уг дүгнэлтээс яагаад Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоол Үндсэн хуулийг зөрчөөгүй юм бол гэдэг талаар хариулт авч чадаагүй л болов уу.

2. Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоол нь ямар нэгэн хуулийн зүйл, заалтыг үндэслээгүй, шууд "Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь" гээд тогтоох хэсэг үргэлжилдэг.

3. Мэдээлэл гаргагчийн дурдсанчлан газрын харилцааг зохицуулсан эрх зүйн актуудад Засгийн газарт орон сууцны зориулалтаар газар олгох, гэрээ байгуулахдаа баригдах орон сууцнаас үнэ төлбөргүй, өөрийн өртгөөр нь тооцож авах эрх олгогдоогүй байна.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2012.03.28 № 02

### Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

#### Маргагч талууд:

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн О., Ц., А., Ч., Б., С., Э., Б.;

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Б., Г., С., О.

#### Үндсэн хуулийг зөрчсөн гэх хууль, бусад шийдвэр:

Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

- 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг "...энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан..."

- 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалт "энэ хуулийн 48.2-т заасан "А" жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид "В" жагсаалт" гэх/-ыг гаргах."

- 49 дүгээр зүйлийн 49.1.5.а заалт "санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;"

- 49 дүгээр зүйлийн 49.1.5.б заалт "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;"

- 49 дүгээр зүйлийн 49.1.5.в заалт "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч."

- 49 дүгээр зүйлийн 49.1.6 дахь заалт "тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан "В" жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, "В" жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа..."

#### Үндсэн хуулийн зөрчигдсэн гэх зүйл, заалт:

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"

- Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"

- Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"

- Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй..."

- Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно"

## Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:

### 1. Иргэн Ц.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан ...28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд... шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа өгөх зарчмыг зөрчиж байна. Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгох заалтыг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох хангалттай санал авч чадаагүй, өөрөөр хэлбэл шууд сонгогдоогүй нэр дэвшигчдээс бүрдэх “Г” жагсаалтын эхнээс нам, эвсэлд хуваарилагдсан суудалд дүйцүүлэн хуваарилахаар байгаа нь шууд бус замаар сонгогдож байгаа хэлбэр юм. Түүнчлэн босго даваагүй намуудын төлөө өгсөн саналуудыг өөрчилж, өөр намууд дээр тэнцүүлэн хуваахаар байгаа нь хүний эрх, шударга ёсонд гаж, сонгогчийн эрхэд ноцтойгоор халдсан үйлдэл болжээ.

### 2. Иргэн Ч., Б. нарын мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно” гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг...эрхэлсэн ажил, ...үзэл бодол, -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 9-д “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, ...эрх чөлөөтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”, Хорин гуравдугаар зүйлийн 1-д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэсэн заалттай тус тус зөрчилдөж байна. Сонгуулийн тухай хуулийн 49.1.5.6-д сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан бие даан нэр дэвшигчийг хасч түүний дотор байгаа /намын нэрээр яваа/ нөхрийг сонгуульд ялсанд тооцох нь шударга өрсөлдөөний утгыг алдагдуулаад зогсохгүй ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа юм.

### 3. Иргэн О.-гийн мэдээллийн агуулга:

Хууль тогтоогчоос Сонгуулийн тухай хуулийг батлахдаа ямар тогтолцоог сонгох нь түүний бүрэн эрхийн асуудал боловч сонгуулийн олонхийн /мажоритар/ болон хувь тэнцүүлэх /пропорциональ/ тогтолцооны аль нэгийг үү, эсхүл аль алиных нь шинжийг агуулсан холимог тогтолцоог сонгосон уу гэдгээс үл хамааран Үндсэн хуулийн дээрх сонгуулийн суурь зарчим, үзэл санаанууд зөрчигдөх ёсгүй.

Нэг. Үндсэн хуульд заасан иргэний шууд сонгох болон сонгогдох /санал авах/ эрхийг зөрчиж буй тухайд.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9-д заасан “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын



сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно.”, 27.1-д заасан “Нам, эвсэл Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг тухайн нам, эвслийн гаргасан дарааллын дагуу нэрийн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.”, 27.5.4-т заасан “энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтыг гаргахдаа эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг тойргийн дарааллаар, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 24.1, 27.4-т заасан хуралдаанаар нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, хувиар нь эрэмбэлэн дараалалд оруулах;” гэсэн зохицуулалт нь дараах байдлаар ойлгогдож байна.

Улсын Их Хурлын сонгуульд нэг намаас нийт 76 нэр дэвшигч өрсөлдөх бөгөөд эхний 48 нь сонгуулийн мажоритар системээр 48 мандатын төлөө /26 тойрог/ өрсөлдөнө, харин үлдсэн 28 нэр дэвшигч нь эхний буюу дээрх 48 нэр дэвшигчийн хамтаар 76-гуулаа нэрсийн нэг жагсаалтанд бичигдэж пропорциональ системээр 28 мандатын төлөө улсын хэмжээний нэг тойрогт өрсөлдөхөөр болж байна. Гэтэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх зүйл, заалт нь иргэдийн, сонгогчийн санал ижил тэгш үнэлэгдэх зарчмыг алдагдуулж байна. Учир нь эхний 48 нэр дэвшигчид дэмжсэн санал нь бодит байдал дээр хоёр дахин (тойрог болон намын суудал дээр) үнэлэгдэж байхад сүүлийн 28 нэр дэвшигчид сонгогчдын саналын үнэлгээ ирэхгүй байна. Энэ нь бодит байдал дээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалт Улсын Их Хурлын сонгуулийг сонгуульд оролцогч нэг нам, улс төрийн хүчний хувьд 48 хүний сонгууль болгон хувиргах төдийгүй намын жагсаалтын сүүлд бичигдсэн 28 нэр дэвшигчийн Үндсэн хуулиар олгогдсон санал авах эрхийг үгүйсгэж буйгаараа пропорциональ сонгуулийн тогтолцоон дахь шууд сонгох эрхийн агуулгыг бүрэн гажуудуулж байна.

Хоёр. Үндсэн хуулийн тэгш эрхийн зарчим болон ардчилсан ёс, шударга ёс, ард түмний төлөөллийн зарчмыг зөрчиж буй тухайд.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.1.6-д заасан “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа тойрогт нэр дэвшигчдээс бусад тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийг энэ хуулийн 27.5.4-т заасан жагсаалтад байгаа дарааллаар нь эрэмбэлж жагсаалт /цаашид “Г” жагсаалт” гэх/-ыг нам, эвсэл бүрээр нь гаргах;” гэсэн зохицуулалт нь дараах байдлаар ойлгогдож байна.

Тойрогт нэр дэвшээд сонгогчдын 28 хувиас дээш санал авсан боловч сонгогдож чадаагүй нэр дэвшигч нь /нэрийн жагсаалтын эхний 48-аас/ намын нэрийн сонголтоор дахин сонгогдох боломжийг агуулсан байна. Нэр дэвшигч бүрийн хувьд сонгогдох буюу ялах боломж нь адил тэнцүү байх ёстой. Гэтэл дээрх зохицуулалт эхний 48 нэр дэвшигчид Улсын Их Хурлын гишүүний суудалд 2 удаа өрсөлдөх боломжийг олгосноороо үлдсэн 28 нэр дэвшигчээс давуу байдалтай болгож Үндсэн хуулийн тэгш эрхийн зарчмыг зөрчиж байна.

Сонгуулийн нэг системээр үнэлэгдсэн саналыг буюу тойрогт авсан хувь нэр дэвшигчийн саналын хувийг өөр системд шилжүүлэн үнэлж буюу намын санал авсан саналд үнэлж нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг хөдөлгөөнд оруулж байгаа нь тухайн системийн хувьд Үндсэн хуулийн шууд сонгох, төрийн үйл ажиллагаан дахь шударга ёсны зарчмыг зөрчихөд хүргэж, улмаар тухайн системийн бүтцийг эвдэж байна.

#### 4. Иргэн А.-гийн мэдээллийн агуулга:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.в, 49.1.6-д тус тус зааснаас үзэхэд санал хураалт дууссаны дараа Улсын Их Хурлын мажоритар хэлбэрт ялагдал хүлээсэн нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг тусад

нь жагсаан, улмаар уг жагсаалтыг сонгуулийн пропорциональ үндсэн хэлбэрээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад оруулахаар байгаа нь Үндсэн хуулийн зарим заалттай нийцэхгүй байна.

Улсын Их Хурлын сонгуулийн мажоритар хэлбэрт ялагдал хүлээсэн нэр дэвшигчдийг сонгууль дууссаны дараа Улсын Их Хурлын пропорциональ хэлбэрээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигч иргэдтэй хамт, бүр тэдгээрийн дээр нь байрлуулж, нэр дэвшигчийн шинэ жагсаалт гаргахаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн маргаан бүхий заалтад заасан байгаа нь Үндсэн хууль зөрчсөн байна.

Маргаан бүхий заалт нь хэн нэгэн хүнд давуу байдал, зарим хүнд “дутуу” байдлыг үүсгэсэн хэм хэмжээ болжээ. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль...-ийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн зүйлийн 1 дэх хэсгийн 9-д “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд...чөлөөтэй, ...сонгох эрхийн үндсэн дээр... сонгоно” гэж заасныг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү.

5. Иргэн С., Э., Б нарын мэдээллийн агуулга:

Ардчилсан улс орнуудад иргэдийн төрийн үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд мажоритар, пропорциональ, холимог гэсэн 3 хэлбэрээр явуулдаг бөгөөд зарим улс орнуудын нэгэн адил холимог системийг хэрэглэх оролдлого хийж байгаа нь сайн талтай боловч процедурын алдаатай байгаа нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчих үндэслэлийг бий болгож байна. Ямар ч сонгуулийн системийг сонгосноос үл хамаарч Үндсэн хуулийн суурь зарчим, хүний үндсэн эрх зөрчигдөх учиргүй.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9, 27.1, 27.5.4, 49.1.5-р заалт нь ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдлын зарчим болон Монголын ард түмэн төрийн үйл ажиллагаанд шууд оролцож улс төрийн эрхээ эдлэх, сонгох, сонгогдох зарчим ба сонгуулийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох шууд сонгох эрхийг зөрчиж байна.

49.1.5-д энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт гаргах гэдэг нь 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт гаргаснаар намын нэрийн сонголтоор дахин сонгогдох боломжийг хуульчилсан байна. Дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн шууд сонгох эрхийг болон сонгуулийн үйл ажиллагаанд адил тэгш эрхтэй оролцох, ялгаварлан гадуурхуулахгүй байх эрхийг зөрчсөн байна.

6. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Б., Г., С., О. Нарын тайлбарын агуулга:

1/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээд байгаа Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтууд нь зөвхөн сонгуулийн дүнг хэрхэн гаргахтай холбогдох заалтууд болно. Сонгуулийн тойргийн хороод

сонгуулийн дүнгээр тухайн тойргоос сонгогдох нэр дэвшигчийг тодруулах бөгөөд Сонгуулийн ерөнхий хороо улсын хэмжээгээр сонгуулийн дүн нэгтгэн гаргаж намуудад өгсөн саналаар сонгогдох нэр дэвшигчдийг тодруулах бөгөөд үүнтэй холбогдох зохицуулалтууд нь дээр заасан Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэсэн заалт болно. Эдгээр заалтууд нь тойрогт нэр дэвшигчийн авсан саналын хувиар тооцон, уг нэр дэвшигчийн төлөө өгсөн сонгогчдын саналыг гээхгүйгээр сонгох, сонгогдох боломжийг олгосон зохицуулалт болно.

Өөрөөр хэлбэл, нам бүрийн 76 нэр дэвшигчийг нэгдмэл нэг жагсаалтаар сонгогчдоос авсан саналаар нь эрэмблэлтэнд оруулж, энэ эрэмбийн дагуу намын авсан суудлын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хорооноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож үнэмлэх олгохтой холбогдсон зохицуулалт болно. Энэ нь сонгогчдын санал сонгуулийн дүнд илүү үр дүнтэй тусах боломжийг нээж өгсөн зохицуулалт болно. Ийнхүү нэр дэвшигчдийг эрэмблэн жагсаах нь сонгогчдын санал сонгуулийн дүнд тусаж, тэдгээрийн сонгох, сонгогдох эрх илүү хангагдаж байгаа болно. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх зохицуулалт нь тойрогт нэр дэвшигчдийг тухайн тойргийн сонгогчдоос авсан саналыг нь харгалзан нам бүрээр нь нэр дэвшигчдийн нэгдсэн нэг жагсаалтад эрэмблэж оруулахдаа тойргийн сонгогчдын тоо, нэр дэвшигчдийн тоо, мандатын тооноос хамаарч болох ялгаатай байдлыг арилгасан болно.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан нь төрийн үйл ажиллагаанд ямар ч нөхцөлд заавал удирдлага болгох зарчмууд билээ.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн дүнг эцэслэн гаргахдаа сонгогчдын саналыг гээхгүйгээр, тойргийн хүн амын тоо, тойрогт ногдсон мандат, нэр дэвшигчдийн ялгаатай байдлыг арилган суудал хуваарилан сонгох, сонгогдох эрхийг хангаж байгаа нь Ардчилсан ёс, шударга ёсыг төрийн үйл ажиллагаанд удирдлага болгосон байх зарчмыг хангаж байна гэж үзсэн болно. Ардчилсан ёсны зарчим нь төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмэн өөрсдөө сонгон байгуулах, түүний үйл ажиллагаанд нь оролцох, хяналт тавих, олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хангах зэрэг олон хэлбэрээр илрэн хэрэгждэг. Харин сонгуулийн дүнг сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилж байгаа нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ард түмний өөрсдийнх нь сонгох эрхийг ханган, тэдгээрийн саналыг аль болох гээхгүйгээр ард түмний хүсэл зоригийг тусгасан, ардчилсан үзэл санаанд нийцсэн томоохон шинэлэг зохицуулалт юм. Нөгөө талаар сонгуулийн холимог тогтолцооны үндсэн шинж нь сонгуулийн мажоритар болон пропорциональ тогтолцооны дүн гаргах аргачлалыг нэгтгэн нэг дүнг гаргахад оршино. Сонгуулийн дүнг нэгтгэхгүйгээр мажоритар болон пропорциональ тогтолцоо тус бүрээр нь гаргах нь сонгуулийн холимог тогтолцоо бус, харин паралель сонгууль болно.

Ардчилсан ёс гэдэг олонхиор бүх асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үг биш бөгөөд сонгуулийн дүнг гаргахад нам, эвслийн авсан саналаар тухайн нам, эвсэлд ногдох мандатын тоог урьдчилан гаргах бөгөөд уг дүнгээр нам, эвслээс сонгогдох нэр дэвшигчдийг сонгож байгаа нь тойргийн сонгогчдын төлөөлөл болон сонгогчдын саналыг гээлгүйгээр Үндсэн хуулийн шударга ёсны зарчмыг хангасан болно.

Сонгуулийн мажоритар тогтолцоо нь сонгогчдын санал гээдэг гэсэн томоохон шүүмжлэлийг дагуулдаг. Жишээ нь нэг тойрогт 100 мянган сонгогчтой, 2 мандат ногдож байхад тухайн тойрогт 36 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч, 35 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч, 34 мянган сонгогчийн санал авсан нэг нэр дэвшигч байхад уг 34 мянган сонгогчийн санал авсан нэр дэвшигч сонгогдож чадахгүй үлдэх бөгөөд уг тойргийн 34 мянган сонгогчийн санал шууд гээгдэн шударга бус байдал

үүсдэг. Энэхүү шударга бус асуудлыг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн сонгуулийн дүнг сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилж байгаа нь төрийн үйл ажиллагаанд шударга ёсыг сахисан өөрчлөлт юм.

Шударга ёсыг хэрэгжүүлдэг үндсэн арга бол аливаад алагчлалгүй хандах бөгөөд сонгогчдын саналыг гээлгүй тэдгээрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн сонгогдох боломжийг хангаж байгаа нь шударга ёсыг хэрэгжүүлж байгаа хэлбэр мөн. Төрийн үйл ажиллагааны эрх чөлөө, тэгш байдлын зарчим нь шударга ёсны зарчмаас эх үүсвэртэй бөгөөд сонгуулийн дүнгээр сонгогчдын саналыг гээхгүйгээр шилжүүлэх нь шударга ёсны зарчмыг хангаж байгаа тул төрийн үйл ажиллагаанд эрх чөлөө, тэгш байдлын зарчим зөрчигдөөгүй гэж үзэж байна. Сонгуулийн дүнгээр холимог тогтолцооны үндсэн шинжийг агуулан суудал хуваарилж, сонгогчдын саналыг гээхгүйгээр суудал хуваарилах нь ард түмний улс төрийн, үзэл суртлын зөвшилцөөг бүрдүүлэх хэлбэрээр төрийн үйл ажиллагаанд үндэсний эв нэгдлийн үндсэн зарчмыг удирдлага болгож байгаагийн илэрхийлэл болно. Үндэсний эв нэгдэл нь тухайн орны нийт ард түмний улс төрийн, үзэл суртлын түгээмэл зөвшилцөө, эдийн засгийн тэнцвэртэй, тогтвортой хөгжил, ёс суртахуун, зан заншлын харилцан хүндэтгэл зэргээр илэрхийлэгдэн хэрэгждэг.

Сонгогчдын саналыг гээхгүйгээр сонгуулийн дүнгээр нэгтгэсэн нэг дүн гарган суудал хуваарилах нь төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмыг зөрчөөгүй болно. Учир нь төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх гэдэг нь төрийн засаглах эрх мэдлийг хуваарилалт дахь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэж ангилсан гурван салаа нь тус тусдаа хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд бие даан үйл ажиллагаа явуулахыг ойлгох ба энэ нь сонгуулийн үйл ажиллагаанд хууль баримтлаж ажиллах хэлбэрээр илэрхийлэгддэг. Иймд сонгуулийн үйл ажиллагаанд хууль баримтлан суудал хуваарилах нь хууль дээдлэх зарчмыг зөрчөөгүй болно.

2/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх зарчмыг хуульчилсан нь төрийн засаглах эрх мэдлийн эх сурвалж нь ард түмэн гэснийг нотолж байгаа хэлбэр бөгөөд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэдэг бол ардчилал гэдэг ухагдахууны бүрэн хэмжээний илрэл юм. Ардчиллыг төлөөлөх болон шууд гэж ангилдаг бөгөөд шууд ардчиллыг хэрэгжүүлэх нь боломжийг хэр болохыг бүгд мэднэ. Харин төлөөлөх ардчилал гэдэг бол ард түмний сонгон байгуулсан төрийн байгууллагаараа дамжуулж төрийн засаглах эрх мэдлийг хэрэгжүүлдэг удирдлагын арга бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын засгийн бүх эрх мэдлийг ард түмний мэдэлд байх зарчмыг зөрчөөгүй ба ард түмэн төрийн хэрэгт шууд оролцох боломжийг нь ямар нэг байдлаар хөндөөгүй болно. Түүнчлэн сонгуулийн холимог тогтолцооны суудал хуваарилах асуудал нь сонгогчид төрийн үйл ажиллагаанд шууд оролцож, сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эрхээ эдэлж байгааг зөрчөөгүй болно. Учир нь ард түмний хүсэл зоригийг зөвхөн олонхийн саналаар шийдвэрлэх хэт хатуу тогтолцоог эвдэн шударга ёсыг сахин, ард түмний зарим хэсгийн хүсэл зоригийг гээлгүй, орхигдуулалгүй асуудлыг зөв талаас нь тайлбарлан танилцуулан шийдвэрлэсэн болно.

3/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9 дахь заалт, түүнтэй холбогдох заалт нь сонгууль зохион байгуулан нэр дэвшигчдэд сонгуулийн дүн гарган тооцож, суудал хуваарилах асуудлыг зохицуулж байгаа бөгөөд уг асуудал нь хэн нэг нэр дэвшигчийн хуулийн өмнө эрх тэгш байдлыг алдагдуулсан зүйл байхгүй юм. Учир нь нэр дэвшигч бүр хуулийн өмнө эрх тэгш байх бөгөөд хуульд заасны дагуу нам, эвслийн авсан саналын хувиар ногдсон мандатыг хуваарилах нь тухайн тойргийн сонгогчдын саналыг тэгш хадгалагдах боломжийг нээж өгсөн болно. Өөрөөр хэлбэл, сонгогчдын санал гээгдэх нь хуулийн өмнөх эрх тэгш байдлыг алдагдуулж байсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд сонгуулийн хоёр тогтолцооны дүнг нэгтгэн суудал хуваарилах асуудлыг зохицуулсан нь илүү оновчтой Үндсэн хуульд нийцсэн зохицуулалт болсон гэж үзэж байна.

4/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9-д "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй" гэснийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд нь Монгол Улсын иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчөөгүй гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хуралд улс төрийн нам, эвслээс 76-аас илүүгүй хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг 76 нэр дэвшигчийн 48-аас илүүгүйг нь тойрогт нэр дэвших ба Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд пропорциональ тогтолцоогоор 28-аас илүүгүй нэр дэвшигчид суудал хуваарилахдаа тухайн нам, эвслийн авсан саналын хувиар нь нэр дэвшигчдийн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй нь хамааралгүйгээр тооцон гаргах бөгөөд энэхүү суудал хуваарилан нэр дэвшигчдийн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг нь зөрчөөгүй болно. Мөн төрийн удирдах хэрэгт иргэдийн оролцох нь тэдгээрийн улс төрийн үндсэн эрх бөгөөд иргэд төрийн удирдах хэрэгт шууд шийдвэрлэх эрхтэй буюу эсхүл өөрсдийн сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан энэ эрхээ эдэлдэг. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянах ажиллагаа явагдаж байгаа холбогдох заалт нь иргэний сонгох, сонгогдох эрхэд халдсан зүйл байхгүй юм. Нэр дэвшигчийн сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдаагүй бөгөөд тэдгээрийн сонгогдох нь тухайн тойргийн сонгогчдын нэр дэвшигчид үзүүлж байгаа үнэлгээ, түүнчлэн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт олон түмнээс өгсөн үнэлгээтэй холбогдон гаргасан саналтай нь шууд хамааралтай тул уг асуудлыг шууд Үндсэн хуулийн иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй.

5/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, ...сонгоно" гэсэн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгоход ямар нэг хязгаарлалт агуулаагүй тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн уг заалтууд нь Үндсэн хуулийн Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй сонгох зарчмыг зөрчөөгүй болно. Түүнчлэн дээрх маргаантай заалтууд нь сонгогчийн саналаа нууцаар гаргахад нь хамааралгүй билээ.

Уг заалтыг сонгогчийн шууд сонгох эрхийг зөрчиж байна гэж үзэх нь эрх зүйн хувьд үндэслэлгүй юм. Шууд сонгох гэдэг нь нэгд: сонгогч сонгуульд ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өөрөө гаргах, хоёрт: сонгогчдын саналын үндсэн

дээр сонгуулийн дүнг хуулиар тогтоосон журмын дагуу шууд гардаг гэсэн агуулгатай тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалт нь Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурлын гишүүнийг...шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, ...сонгоно” гэснийг зөрчөөгүй төдийгүй, сонгуулийн дүн нь шууд гарч байх хуулийн журмыг тогтоож байгаа юм.

Ийнхүү үндэслэлүүдээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй болно.

### **Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилснаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2. Түүнчлэн сонгуулийн эрх бүхий иргэд нэгэнт сонголтоо хийсэн байтал дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлын 26 тойрогт нэр дэвшээд тус тусын тойрогт ялагдал хүлээсэн боловч 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч улс төрийн нам, эвслийн жагсаалтад шилжин орсноор Улсын Их Хурлын гишүүний мандат буюу суудлыг нам, эвсэлд тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах агуулгатай сонгуулийн хувь тэнцүүлэх хэлбэр хэрэгжих боломжгүйд хүрч, улмаар иргэдийн шууд сонгох эрхийг алдагдуулсан байна.

3. Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн, улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн, тэдгээрийн сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг бий болгон хуульчилсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт “...энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”, 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр

дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах.”; 49.1.5.а заалтад “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтад “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”; 49.1.6 дахь заалтад “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”; Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”; Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”; Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн “...энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...”; 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтын “энэ хуулийн 48.2-т заасан “А” жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид “В” жагсаалт” гэх/-ыг гаргах.”; 49.1.5.а заалтын “санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;”, 49.1.5.б заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;”, 49.1.5.в заалтын “санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.”; 49.1.6 дахь заалтын “тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан “В” жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, “В” жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа...” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**“Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 2 дугаар дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолын агуулга:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт "...энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...", 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад "энэ хуулийн 48.2-т заасан "А" жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид "В" жагсаалт" гэх/-ыг гаргах:", 49.1.5.а заалтад "санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;", 49.1.5.б заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;", 49.1.5.в заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.", 49.1.6 дахь заалтад "тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан "В" жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, "В" жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа..." гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно." гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

#### **Тэмдэглэл:**

Монгол Улсын Их Хурлын цөөнгүй гишүүн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байсан боловч цэцийн дүгнэлтийн хүлээн авах уу, үгүй юу гэдэг шийдвэр гаргахын тулд нэг асуудлыг шийдэх шаардлагатай тулгарсан.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д "Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно" гэж заасан байдагтай холбоотой. Хэрэв Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хүлээн авсан тохиолдолд Улсын Их Хурлаас сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй бөгөөд ингэснээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийн заалтыг зөрчихөд хүргэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлаас 4 гишүүнийг томилсон нь ховорхон тохиолдол байсан ба энэ нь дээрх асуудалд Улсын Их Хурлын зүгээс хэрхэн анхаарал тавьж байсныг илтгэж байсан.



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2012.05.02 № 03

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

### **Маргагч талууд:**

Мэдээлэл гаргагч – Монгол Улсын иргэн О., Ц., А., Ч., Б., С., Э., Б.  
Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч - Улсын Их Хурлын гишүүн Ж., Б.

### **Маргагч талуудын тайлбар, үндэслэл, байр суурь:**

1. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Ж., Б. нараас ирүүлсэн тайлбарын агуулга:

Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид Улсын Их Хурлын гишүүн Б., Г., О., С. нарын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүргүүлсэн тайлбарыг дэмжиж байгаагаа илэрхийлэн Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд оролцохоор Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч бид дараах тайлбарыг хүргүүлж байна:

1/ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны дээрх дүгнэлт Үндсэн хуулийн тулгуур зарчим болсон Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдэл зөвхөн Улсын Их Хуралд хадгалагдана гэсэн зарчимтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалт нь Үндсэн хуулийн маргааны асуудал биш юм. Нөгөө талаар Үндсэн хуулийн цэц хэрэв асуудлыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг өөрчилвөл хууль тогтоох эрх мэдэл зөвхөн Монгол Улсын Их Хуралд хадгалагддаг байх Үндсэн хуулийн дээд зарчмыг зөрчсөн үйл явдал болно гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалтыг хүчингүй болгож байгаа нь “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэсэн Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дугаар заалттай илт зөрчилдөж байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээс харахад Улсын Их Хуралд орж ирж байгаа 76 хүний 48 нь ард түмний санал авч мандат авсан гишүүд байх бөгөөд 28 нь намаасаа мандат авсан гишүүд сонгогдохоор байна. Намын нэрээр сонгогдсон Их Хурлын гишүүд, ард түмнээс сонгогдсон Их Хурлын гишүүд гэсэн хоёр статустай гишүүдтэй болж байна.

2/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх заалтын холбогдох зохицуулалт, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох зохицуулалт нь Үндсэн хуулийн заалтуудыг зөрчжээ гэдэг зөрчил нь Үндсэн хуулийн зөрчил биш юм. Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн эдгээр заалт нь ардчилсан ёс, шударга ёс, эрх тэгш, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах зарчмыг хангасан зохицуулалт юм.

3/ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж заасан байгаа. Энэ заалт нь Улсын Их Хурал хууль тогтоогчид хамааралтай болохыг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд тайлбарласан байна.

Гэтэл Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах,” гэж заасан заалтыг Үндсэн хуулийн цэц зөрчиж байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар тайлбар гаргах бүрэн эрхтэй байхад Үндсэн хуулийн цэц Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд халдаж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтыг зөвхөн Улсын Их Хуралд хамааралтай болохыг тайлбарласан байна. Энэ талаар Улсын дээд шүүх тайлбар гаргаагүй байгаа болно.

4/ Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнө зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно” гэсэн хориглолт байдаг. Үүнийг дагасан заалт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд орсон.

Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнө зургаан сарын дотор Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд аливаа нэг субъект нэмэлт, өөрчлөлт оруулах эрхгүй. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль нь Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа тул Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг төрийн бүх байгууллага нэг мөр ойлгон гуйвалтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй.

Ийнхүү үндэслэлүүдээр Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 2 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, 49.1.6 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсгийн, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна гэж Улсын Их Хурал үзсэнийг уламжилж байна.

#### **Үндсэн хуулийн цэцийн тогтоолын үндэслэх, тогтоох хэсгийн агуулга:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь Улсын Их Хурлын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдах хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох боломжийг олгож байгаагаараа зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгон Үндсэн хуульд заасан хуулийн өмнө эрх тэгш байх болон сонгуулийн шууд сонгох зарчмын агуулгыг алдагдуулсан байна.

2. Мөн Улсын Их Хуралд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчид өгсөн санал хоёр удаа буюу сонгуулийн олонхийн болон хувь тэнцүүлэх хэлбэрт тус тус үнэлэгдсэнээр, намын нэрээр өгсөн сонгогчдын санал эзэнгүйдэн улс төрийн нам, намуудын сонгуулийн эвслийн жагсаалтад орсон 28 нэр дэвшигчид өгсөн саналыг бодитойгоор үнэлэх боломжгүй байдалд хүргэн иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсгийн зохицуулалт нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулснаараа ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх Үндсэн хуулийн суурь зарчимд харшилсан байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9, 49 дүгээр зүйлийн 49.1.5, 49.1.5.а, 49.1.5.б, 49.1.5.в, мөн зүйлийн 49.1.6 дахь заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Гуравдугаар зүйлийн 1, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, Арван зургадугаар зүйлийн 9, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэгт "... энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан...", 49 дүгээр зүйлийн 49.1.5 дахь заалтад "энэ хуулийн 48.2-т заасан "А" жагсаалтаас дараах нэр дэвшигчдийг хасаж, хасагдсан нэр дэвшигчдийн авсан саналын хувиудын нийлбэрийг тухайн жагсаалтад үлдсэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчдээс бусад нэр дэвшигчид тэнцүү хуваан шилжүүлэн нэмж жагсаалт /цаашид "В" жагсаалт" гэх/-ыг гаргах.", 49.1.5.а заалтад "санал өгсөн сонгогчдын 28-аас доош хувийн санал авсан нэр дэвшигч;", 49.1.5.б заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бие даан нэр дэвшигч;", 49.1.5.в заалтад "санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан боловч энэ хуулийн 48.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй бөгөөд улсын хэмжээнд таваас доош хувийн санал авсан нам, эвслээс нэр дэвшигч.", 49.1.6 дахь заалтад "тойрог бүрээр гаргасан 49.1.5-д заасан "В" жагсаалтад орсон, энэ хуулийн 48.2, 48.5-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчдийг нам, эвсэл бүрээр нь, "В" жагсаалт дахь авсан саналын хувиар нь дараалалд оруулах ба тэдгээр нэр дэвшигчдийн дараа..." гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж... сонгоно" гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээрх заалтуудыг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.5.в заалтад хамаарах "Тайлбар: Энэ хуулийн 48.5-д заасны дагуу дахин санал хураалтад орсон боловч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцогдоогүй нэр дэвшигчийн "В" жагсаалт дахь өөрийн авсан саналын хувь нь анхны санал хураалтын саналын хувь байна" гэснийг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 2 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

4. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**Тэмдэглэл:**

Сонгуулийн тогтолцооны олон хэлбэр, загвар дэлхийн улсуудад хэрэгжиж байна. Улсын Их Хурлаас баталсан Улсын Их Хурлын сонгуулийн хуульд ард түмнээс сонгогдоогүй нэр дэвшигч “гулсаж” намын жагсаалтаар гарч ирж Улсын Их Хурлын гишүүн болох “гажиг” хэм хэмжээг тогтоосныг Үндсэн хуулийн цэц хүчингүй болгосон. Нэг нэр дэвшигч нэг сонгуулиар хоёр удаа нэр дэвшиж сонгогдох эрх зүйн ямар ч үндэслэл байж болохгүй юм.